



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:
Дэлхий дахинд

Бодлого
Нөхцөл байдал
Үйл ажиллагаа
Үйл явдал
Сайн туршлага

*Авлигатай тэмцэх газрын Судалгаа шинжилгээний албанаас
2020, 2021 онд орчуулсан гадаад мэдээ, нийтлэлийн эмхэтгэл*

Улаанбаатар
2022 он



АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

Хянан тохиолдуулсан:

Ц.Шинэбаяр

– *США-ны дарга, ахлах комиссар*

Эмхэтгэсэн:

Х.Оюунбаатар

– *США-ны ахлах ажилтан, ахлах комиссар*

Тоймлон орчуулсан:

Д.Жаргалан

– *США-ны ахлах ажилтан, ахлах комиссар*

Х.Оюунбаатар

– *США-ны ахлах ажилтан, ахлах комиссар*

Б.Баярсайхан

– *США-ны ахлах ажилтан, ахлах комиссар*

Ц.Бадам

– *США-ны ажилтан, комиссар*

Л.Анхныбаяр

– *США-ны ажилтан, комиссар*

Р.Энх-Амгалан

– *США-ны ажилтан, комиссар*

А.Золзаяа

– *США-ны ажилтан, комиссар*

Л.Хангарьд

– *США-ны ажилтан, комиссар*

О.Эрхэмжаргал

– *США-ны ажилтан, комиссар*

А.Билгүүн

– *Тамгын хэлтсийн ажилтан, комиссар*

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
АНЭУ	Арабын Нэгдсэн Эмират Улс
АТИ	Авлигын төсөөллийн индекс (CPI)
АУБ	Америкийн улсуудын байгууллага (OAS)
АХБ	Азийн хөгжлийн банк (ADB)
АЭНҮБК	Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц (UNCAC)
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГАҮАТХ	Гадаад авлигын үйл ажиллагааны тухай хууль (FCPA)
ГРЕКО	Европын улсуудын Авлигын эсрэг бүлэг (GRECO)
ДБ	Дэлхийн банк (WB)
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн (GDP)
ДЭЗФ	Дэлхийн эдийн засгийн форум (WEF)
ДЭМБ	Дэлхийн эрүүл мэндийн байгууллага (WHO)
ЕХ	Европын Холбоо (EU)
МБГХТА	НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага (UN)
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр (UNDP)
ОУВС	Олон улсын валютын сан (IMF)
ОУЭССК	Олон улсын эрэн сурвалжлах сэтгүүлчдийн консорциум (ICIJ)
ОХУ	Оросын Холбооны Улс
ӨАБНУ	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс
ТИ	Транспэрэнси Интернэшнл (TI)
ФАТФ	Санхүүгийн хориг арга хэмжээ авах олон улсын байгууллага (FATF)
ХМТ	Холбооны мөрдөх товчоо (FBI)
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
АГУУЛГА	4
1. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОДЛОГО	19
Олон улсын байгууллага	19
НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга дэлхийн баялгийн тэн хагас хэний мэдэлд байгааг хэлэв	19
Авлига хөгжил дэвшилд саад учруулдаг	19
НҮБ-ын Ерөнхий Ассамблей авлигын эсрэг 2021: Гол үр дүн ба амлалт	20
Олон улсын авлигын эсрэг шүүх байгуулахыг уриалав	20
Их 20-ийн орнуудын удирдагчид авлигын эсрэг төлөвлөгөө батлав	21
Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын товч танилцуулга.....	21
Австрали ба далайн орнууд.....	24
Өмнөд Австралийн Авлигатай тэмцэх комиссарын эрх хэмжээг бууруулсан “ер бусын” хууль батлагдлаа	24
Ази тив.....	24
Японы засгийн газар ажлын байрны дарамтын эсрэг шийтгэлийг чангаруулна	24
Авлигатай тэмцэх хорооны ёс зүйн дүрэм бусад байгууллагатай хамтран ажиллахыг дэмжинэ.....	25
Авлигын эсрэг амжилттай түүх: Энэтхэгийн Аам Аадми нам Дели хотын улс төрийг цэвэрлэжээ	25
Энэтхэгийн зарим их сургууль тус улсын Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарахаар болов.....	26
Монгол Улс авлигатай тэмцэхийн тулд хэвлэл мэдээллийн шинэчлэл хийхийг Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллага уриалав	27
Йордан улс Авлигатай тэмцэх газрынхаа бүрэн эрхийг өргөжүүлэв.....	27
Төрд 100 тэрбум ба түүнээс дээш рупигийн хохирол учруулсан этгээдэд бүх насаар нь хорих ял оногдуулж байх тухай шийдвэрийг Индонез улсын Дээд шүүх гаргажээ.....	28
Бизнесийн салбар дахь авлигатай тэмцэнэ	29
БНХАУ-д мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж байна.....	29
Бүх нийтийн хөрөнгө, орлогын мэдүүлэг нь Казахстан улсын авлигын асуудлыг шийдэж чадахгүй	30
Узпромстройбанканд авлигын эсрэг шинэ системийг нэвтрүүлнэ	31
Засгийн газрын худалдан авалт дахь авлигыг анхаарах хэрэгтэй гэж МАТХ-ны дарга хэллээ.....	32
Авлигач төрийн албан хаагчид ажлаасаа чөлөөлөгдөж, гэм буруугаас зугтахыг Дутерте зөвшөөрөхгүй	32
Узбекистан улс ирэх жилээс төрийн байгууллага, бүс нутгийн далд эдийн засаг, авлигын үнэлгээг нэвтрүүлэхээр боллоо.....	33
Шударга ёсыг хурдавчлах нь: Авлигын эсрэг Энэтхэг улсын шинэ стратеги	34
Энэтхэг улсын Керала муж Авлигатай тэмцэх шинэ системийг 01 дүгээр сарын 26-наас эхлүүлнэ	36
Авлигатай тэмцэх хүчирхэг шинэ агентлаг Өмнөд Солонгост удахгүй нээгдэнэ	36

Индонез улсын Авлигыг устгах хороо хүнд байдалд байна	37
Солонгосын Авлигатай тэмцэх байгууллагаас боловсруулсан хууль батлагдав	39
Америк тив	40
Мөнгө угаахтай холбоотойгоор биткойны АТМ-ууд чанга зохицуулалттай болно.....	40
Бразилийн засгийн газар авлигатай тэмцэх шинэ нэгж байгуулахаар төлөвлөж байна	40
Авлигын эсрэг Ерөнхийлөгч Теодор Рузвельтийн тэмцлийн ач холбогдол.....	41
Дэлхийн санхүүгийн авлигыг мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан Уоррен мэдэгдэл хийв.....	41
2014 онд батлагдсан Бразил улсын Авлигын эсрэг хуулийн амжилтыг хэмжих нь	42
Улс дамнасан авлигын эсрэг тэмцэлд АНУ манлайлж байна	43
Бразил Авлигын эсрэг таван жилийн төлөвлөгөө хэрэгжүүлж эхэллээ	44
ХМТ гадаад улсын авлигын хэрэг шалгах ажиллагааг өргөжүүлж байна.....	44
Трампын захиргаа уул уурхайн магнат Гэртлэрт тавьсан хориг арга хэмжээг зөөлрүүлжээ	46
Авлигын гэмт хэрэгт холбогдон гэм буруутай нь тогтоогдсон төрийн албан хаагчийн тэтгэврийн төлөвлөгөөг цуцлах талаар Нью Мексикогийн хуулийн төсөлд тусгажээ	47
Авлигын эсрэг Apple компанийн иж бүрэн бодлого.....	47
АНУ-ын авлигын эсрэг хууль тогтоомж Африкийн хөдөө орон нутгийн эдийн засгийн өсөлтийг хэрхэн дэмжив?	48
Дэлхийн мөнгө угаахтай тэмцэх хүчний дараагийн давалгаа.....	50
Авлига Үндэсний аюулгүй байдалд заналхийлэгч. Үүнтэй тэмцэх ухаалаг шийдэл бол CROOK хууль	51
Арбитрын шүүх дэх авлигын эсрэг Перу улсын хэрэгжүүлж буй арга хэмжээ байгаа онохгүй байна	52
Авлигатай тэмцэх нь АНУ-ын үндэсний аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхол болох тухай Санамж бичиг.....	54
Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй тэмцэх хууль ба гэм буруугийн зарчим	57
АНУ-ын Конгресс авлигач, ардчилсан үзэл баримтлалын эсрэг этгээдүүдийн жагсаалтыг шинэчилнэ	58
Африк тив	58
Хууль тогтоогчдод халдашгүй эрх олгох нь авлигын эсрэг Бухаригийн төлөвлөгөөг нураана хэмээн Колаволе Оланиан бичжээ	58
Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөлд авлигатай тэмцэхэд шаардагдах зүйл, заалт хангалттай тусгагдаагүй	59
Нигери улсын ойн аж ахуй болон загас агнуурын салбар дахь авлигатай тэмцэх ажиллагаа	60
Өмнөд Африкийн эрх баригч Африкийн үндэсний конгресс нам авлига болон бусад хэрэгт холбогдсон албан тушаалтнуудын албан тушаалыг түдгэлзүүлнэ.....	62
Европ тив	63
Украины засгийн газар авлигын эсрэг стратеги боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.....	63
Мөнгө угаахтай тэмцэх нэгдсэн зохицуулалт шаардлагатай	63
Украины засгийн газраас авлигын эсрэг үндэсний стратегийг батлав	63
Европын зөвлөлийн авлигатай тэмцэх байгууллага шүүх засаглалын бүтцийн шинэчлэл хийхийг уриалж байна	64

2024 он хүртэлх Украин улсын авлигын эсрэг стратегийг нэн яаралтай батлахыг Ерөнхийлөгч Зеленский хууль тогтоогчдод уриалав.....	64
Улс төрийн хүсэл эрмэлзэл болон чөлөөт сонгууль. ОХУ-д авлигатай тэмцэхэд юу саад болж байгаа талаар ТИ онцлов	65
Украины парламент гадаадын зээл авах зорилгоор авлигатай тэмцэх газрын бүрэн эрхийг сэргээлээ.....	66
Европын зөвлөлийн гишүүн орнууд авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх ёстой.....	67
ОХУ-ын Севастополь хотын депутатууд криптовалютыг мэдүүлэгтээ бүртгүүлэх шаардлагатай гэж үзэв.....	68
Өргөн бариад байгаа хуулийн төсөл Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газрын үйл ажиллагаанд саад учруулах талаар гомдоллож байна	68
Меркель бизнес форумыг нээж, Украинд газрын шинэчлэл хийж, авлигатай тэмцэхийг уриалав	69
Төрийн Дум авлигач албан тушаалтнуудын хөрөнгө, орлогыг хураах талаар хэлэлцэнэ.....	69
Брутер: Майя Санда ба авлига	70
Швед улс яагаад эрх зүйн салбарт шинэчлэл хийх шаардлагатай вэ?	70
2. УЛС ОРНУУДЫН АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ	72
Австрали ба далайн орнууд.....	72
КОВИД-19-ийн улмаас хахууль, авлигын хэмжээ нэмэгдэж болзошгүйг Deloitte анхааруулав.....	72
Засгийн газар КОВИД-19-ийг дарж чадах ч авлигыг устгаж чадахгүй гэж иргэд үзэж буй нь тайлангийн үр дүнгээс харагдаж байна.....	72
АТИ-ийн өндөр онооны ард орших Шинэ Зеландын түгшүүр.....	73
Викториягийн хорих байгууллагын албан хаагчдын дунд авлига нэмэгдэж байгааг судалгааны үр дүн харуулав.....	75
Ази тив.....	76
Японы улс төр дэх эрх мэдэл ба мөнгө	76
Филиппинд авлига, хахууль өсжээ	77
Авлигад хамгийн их өртсөн Казахстаны их, дээд сургуулиудыг нэрлэжээ	78
Энэтхэг улс гадаадын хахуулийн хэргийн тоогоор дэлхийд 2 дугаарт эрэмбэлэгдлээ	79
Малайзын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын зөвхөн 59 хувь нь авлигын эсрэг бодлого баримталдаг.....	79
Дунд боловсролын салбар дахь авлигын асуудалд хийсэн дүн шинжилгээ.....	80
Пакистан улсын авлигатай тэмцэх байгууллагын стратеги үр дүнгээ өгч байна	82
АНУ-ын прокурорууд Хойд Солонгос, Хятадын иргэдийг олон сая долларын мөнгө угаасан асуудлаар буруутгав.....	82
Хүний эрх, сайн засаглал нь Зүүн өмнөд Ази дахь цар тахлын дараах сэргэлтийн гол түлхүүр юм.....	82
Афганистаны засгийн газрын санхүүгийн байгууллагуудын авлига өндөр түвшинд хүрч байна.....	83
Эрүүл мэндийн салбар дахь авлигатай тэмцэхэд хариуцлагатай байдал болон хатуу хяналт шалгалт шаардлагатай	84
Хахуулийн морь: Тажикстан дахь авлигын асуудлын талаар Хакимов.....	85
Азербайжаны Ерөнхийлөгч орон нутгийн албан хаагчдад авлигын асуудлаар анхааруулга өгөв	85

Казахстанд 2020 он гарсаар авлигын хэчнээн хэрэг бүртгэгдсэн бэ?	86
Казахстан: Хятадын хил дээрх цахим систем авлига, ачааллыг нэмэгдүүлсэн.....	86
БНСУ-ын сөрөг хүчний удирдагч өмнөх Ерөнхийлөгчийн авлигын хэрэгт уучлал гуйв.....	87
Клептократ үйлдэл Монгол Улсад цохилт өгөв үү? Батболдын зөвлөх хариулав.....	88
Авлигыг гэмт хэрэг гэж үзэхгүй байна: Ерөнхий сайд Имран	90
БНСУ АТИ-ээр зургаан байр урагшилжээ.....	90
Удирдах албан тушаалтны холбогдон шалгагдаж буй авлигын гэмт хэрэг нь компанийн үйл ажиллагаанд хамааралгүй талаар Тенсент компани мэдээлэв.....	91
2020 оны Ази-Номхон далайн бүс нутгийн авлигын эсрэг зэрэглэл: ТИ байгууллагын АТИ ба TRACE Интернэшнл байгууллагын Авлигын эрсдлийн матриц.....	92
Их Британи улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэл бүхий 21 орны жагсаалтад Пакистан улс нэмэгдлээ.....	94
The Economist: Авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр дүнд илүү олон хятад залуус төрийн албанд орохыг хүсэж байна.....	94
Шри Ланка улсыг хэрхэн нэг гэр бүл эрхшээлдээ авж байна вэ?.....	95
Америк тив	96
Коронавирусний тархалт Гондураст өөр нэгэн “тахал”-ыг ил болгов.....	96
АНУ: 2018, 2022 оны хөлбөмбөгийн ДАШТ-ний эрхийг авахын тулд хахууль ашигласан.....	97
Орос, Катар улсууд ДАШТ-тэй холбоотой хахуулийн талаарх мэдэгдлийг няцаав	97
Латин Америк дахь коронавирусний тархалт авлигыг нэмэгдүүлж байна	98
Авлигын эсрэг Ерөнхийлөгч Лопез Обрадорын үйл ажиллагаа амжилтгүй байна	99
Мексикийн удирдагч авлигын хэрэгт буруутгагдаж буй өмнөх үеийнхнийгээ яллах эсэх асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулахыг санал болгов	99
Байдены гэр бүлийн авлигын хэргийг нуун дарагдуулсанд Трамп Америкийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг буруутгав	100
Авлигын асуудалд холбогдоод байсан Бразил улсын Ерөнхийлөгч асан Лулагийн талаар шүүхээс буруугүй гэсэн шийдвэр гаргасан нь тус улсад ямар нөхцөл байдлыг дагуулах бол?	100
Лула да Силва дахин Ерөнхийлөгч болж чадах болов уу?.....	102
Эл Сальвадорын Ерөнхийлөгч “засгийн эрхийг дангаар авах төрийн эргэлт” хийв. Бий болж буй авлига, дарангуйллыг ажиглая.....	103
Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Төв Америкийн албан тушаалтнуудыг АНУ хар жагсаалтад оруулав	105
Африк тив	105
Ангол дахь авлигатай тэмцэх, эдийн засгийн харилцааг бэхжүүлэхээ Помпео илэрхийлэв	105
Өмнөд Африк дахь усны хомсдолыг авлига улам нэмэгдүүлж байна	106
Өмнөд Дарфур дахь авлигын эсрэг суулт 12 дахь өдрөө үргэлжилж байна.....	107
Санхүүжилтийн маргааны улмаас Ливийн засгийн газар авлигатай тэмцэх байгууллагын албан тушаалтныг хулгайлав	108
Зимбабвэ улсын дэд ерөнхийлөгч Эрүүл мэндийн сайдын албан тушаалыг хаших болов.....	108
КОВИД-19 халдвартай холбоотой авлигын улмаас АУКН-ын засаглал төгсгөл болж болзошгүй гэж Туту сан үзэж байна.....	109

Авлига, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хүний эрхийг зөрчих явдлыг шүүмжилсэн католик шашны хамба лам нарын шүүмжлэлийг Зимбабвэ улсын засгийн газар үгүйсгэж байна.....	109
Авлигатай тэмцэхгүйгээр цар тахлын дараах эдийн засгийг сэргээх талаар яриад хэрэггүй	110
Өмнөд Африкийн хотуудад илрэх авлигын хэлбэрүүд	111
Ливи: Төрийн үйл ажиллагаан дахь авлига болон иргэдээ орхигдуулсан байдалд эгдүүцсэн Мисрата хотын иргэд хоёр дахь өдрөө жагсаж байна	112
Европ тив	113
Словак улс авлигын “хар нүх”-нээс ангижрах арга зам эрэлхийлж байна	113
Худал хэлэхийг хуулиар зөвшөөрөв. Чех улс дахь шударга ёсыг дэнслэх мөч мөн үү?.....	113
Оросууд бага хэмжээний хахууль өгөх нь түгээмэл болжээ.....	113
2019 онд авлигын улмаас учирсан хохирлын талаар ОХУ-ын Ерөнхий прокурорын газар мэдээлэв	114
Хөрөнгө, орлогын мэдүүлэг дэх хачирхалтай зүйлс: Шорлог бэлтгэх төхөөрөмжөөс нисэх онгоц, том гараажаас см ² хэмжээтэй эзэмшил газар хүртэлх эд хөрөнгө.....	114
Өмнөд Солонгос дахь авлига манайхаас арай дөнгүүр юм.....	115
Өнөөдрийн асуулт: Орос улсад авлигагүйгээр амьдарч болох уу?	116
ОХУ-ын Дээд шүүхээс авлигын талаарх статистик мэдээллийг танилцуулав.....	117
Сербийн авлигатай тэмцэх байгууллага сайдын нөхрийн гэрээг шалгахгүй байна	118
Орос дахь авлигын нөхцөл байдал	119
Гүрж улсад төрийн өндөр албан тушаалтнуудын оролцоотой авлигын хэрэг асуудал хэвээр байна.....	119
Латви улсын хүн амын 39% нь авлигыг тэвчихгүй гэсэн байна.....	119
ЕХ-ны гишүүн орнуудын дунд төв болон зүүн өмнөд европчууд авлигыг хүлээн зөвшөөрөх байдал хамгийн өндөр байна.....	120
Авлига хамгийн өргөн тархсан ОХУ-ын 10 бүс нутгийн жагсаалтыг гаргажээ	120
Новосибирск мужид авлигын түвшин 60 хувиар өссөн байна	122
Мальта улсын цахим казино гэмт хэргийн байгууллага болох Ндрангетагийн мөнгийг угаасан байж болзошгүй байна	122
ОХУ-д илрээгүй хахуулийн хэрэг гурав дахин өссөн байна.....	122
2020 онд Украины үл хөдлөх хөрөнгийн салбар дахь авлигын түвшин өссөн байна	123
Косовогийн засгийн газар Авлигатай тэмцэх ажлын хэсгийг татан буулгалаа	123
Грекийн Авлигатай тэмцэх прокурорын газар татан буугдаж магадгүй	124
Дэлхийн банк Герман улсын нэгэн үйлдвэрийн эзнийг залилан болон авлигын хэрэгт буруутгаж байна	125
Украин дахь авлигын эсрэг тэмцэл Үндсэн хуулийн шинэ хямрал болж хувирав.....	125
Литва улсын иргэд эрүүл мэндийн салбар авлигад хамгийн их өртсөн гэж үзжээ.....	127
2021 оны 01 дүгээр сарын тойм: Ротенберг Путиныг аварч, Жириновский авлигын төлөө зогсож байна	127
Кипр улсад өрнөж буй авлига, цар тахлын хөл хорионы эсрэг жагсаалын үеэр мөргөлдөөн үүсэв	129
Авлигын гүтгэлэг вакцин худалдан авах ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн талаар Украины сайд мэдээлэв.....	130
2020 онд Петербург хотод хахуулийн дундаж хэмжээ 300 мянган рубльд хүрчээ.....	130

Украинд Спутник V вакцин үйлдвэрлэхгүй байгаагийн шалтгаан нь эрх баригчдын түвшин дэх авлига гэж мэргэжилтнүүд дүгнэжээ.....	131
Болгарын парламентын сонгууль европчуудад хамаатай, учир нь	131
2021 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг: Путин ямар хэмжээний цалин авдаг болон хамгийн баян албан тушаалтан хэн бэ?	132
АНУ-ын тэрбумтан Орос улс дахь авлигын үндсэн шалтгааныг нэрлэв.....	134
АУСТТ: Латвийн таван иргэн тутмын нэг нь хахуулийг байх ёстой зүйл гэж үздэг	135
Авлигын эсрэг Герман улсын тэмцлийг Европын Зөвлөл “хангалтгүй” гэж үнэлэв.....	136
Авлига хайгчид дэлхий нийтийн мөнгө угаах эрсдлийг нэмэгдүүлдэг	136
Их Британийн засгийн газар Консерватив намын хандивлагчидтай холбоотой авлигын хэргийг үгүйсгэж байна	137
3. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	139
Төрийн байгууллагын шударга байдлыг дэмжихэд албан хаагчийн сонгон шалгаруулалтын ач холбогдол: Энэтхэгийн зарим баримт	139
Авлигын эсрэг боловсролын санаачилгын ард нуугдаж буй бэрхшээл	140
Авлигыг дэмжигч соёл ба авлигын эсрэг боловсрол	142
Авлигын эсрэг боловсролыг ажил хэрэг болгох нь: Хийх зүйлсийн жагсаалт	144
Мөнгө угаахтай тэмцэх ирээдүйн арга зам: Блокчэйн технологи урсгалыг эргүүлж чадах уу?	145
Авлигын эсрэг бодлогод нэмэр болох ёс суртахууны сэтгэл зүйн сургамжууд	147
Худалдан авах ажиллагаан дахь авлигатай тэмцэхэд блокчэйнийг ашиглах нь	149
Украин улсын оюутан сурагчдын авлигын талаарх үзэл бодолд видео бичлэг нөлөөлж буй байдал	150
Авлига ба коронавирус	151
Хорватын засгийн газар, хууль хяналтын байгууллагуудыг шударга байдлаа нэмэгдүүлэхийг ГРЕКО уриалжээ	154
Илүү их мөнгө, илүү их хяналт	155
Умард Казахстан мужийн иргэд авлигын талаарх судалгаанд цахимаар оролцох боломжтой	155
Цар тахлын үеийн авлигаас хэрхэн сэргийлэх вэ?	157
АХБ авлигын эсрэг хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийн тулд инноваци, үр ашгийг дэмжив	158
ГРЕКО КОВИД-19-ийн үеийн авлигын эрсдлийг анхааруулав.....	159
Латви улс авлигатай тэмцэх үйл ажиллагааны 2 жилийн төлөвлөгөөгөө батлав	159
Авлигыг таслан зогсоох зорилгоор Ватикан тендерийн шинэ хууль гаргав	159
Малайзад компанийн сайн засаглалыг дэмжих хууль хэрэгжиж эхэллээ	160
Европын улс орнуудын парламентын гишүүдийг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд илүү ихийг хийх шаардлагатай байна	160
Хятад улс “доллар болон биткоинийг устгагч”-ийг эхлүүлж магадгүй.....	161
НҮБ-ын МБГХТА АЭНҮБК-ын Хэрэгжилтийн үнэлгээний механизмын үр дүнд үндэслэн авлигын эсрэг бодлого боловсруулагч болон энэ чиглэлээр ажиллаж буй хүмүүст зориулан заавал хэрэгжүүлэх бус шинжтэй зөвлөмж гаргав.....	161
“Үндэстэн дамнасан гэмт хэрэг ба авлига: Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах нь” сэдэвт чуулга уулзалт Чили улсад нээлтээ хийлээ.....	162

Бирм улсад хувийн хэвшил дэх авлигатай тэмцэхэд туслах зорилгоор гарын авлага гаргав	163
“КОВИД-19 цар тахлын эсрэг нийгэм-эдийн засгийн нөлөөллийн шинжилгээнд ил тод, хариуцлагатай байдал болон авлигын эсрэг үйл ажиллагааг тусгах нь” сэдэвт гарын авлага гарчээ	163
Фижид эмэгтэйчүүдэд зориулсан авлигын эсрэг гарын авлага гарав	164
Зарлал: ЭЗХАХБ-ын тайлан, компанийн авлигын эсрэг комплаенсийн талаарх цахим семинар	164
Цар тахлын үед авлигыг таслан зогсоох нь урьд өмнөхөөс илүү чухал ач холбогдолтойг шинэ тайланд тэмдэглэжээ	165
Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль - Сербид авлигатай тэмцэх шинэ найдвар байна уу?	166
КОВИД-19: Их 20 ба НҮБХХ-ийн хамтарсан мэдэгдэл	166
Мөнгө угаахтай тэмцэх зах зээл 2025 онд 1.99 тэрбум доллароор үнэлэгдэнэ	167
Байшин барилгын хананд авлига, хахуулийн эсрэг зураг зурж олон нийтийг соён гэгээрүүлнэ	168
НҮБ-ын тэргүүн Антониу Гуттереш: Цар тахалтай тэмцэж буй тэмцэл авлигажих, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хөрсийг бий болгож байна	169
Кипр улсын Ардчилсан намаас авлигатай тэмцэх чиглэлээр 11 санал гаргажээ	169
НҮБ-ын МБГХТА авлигын эсрэг блокчэйн технологи ашиглахыг Кени улсад зөвлөж байна	170
Цар тахлын үе дэх улс орнуудын төрийн байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаа	170
Дуссоуба Конатэ, Мусса Кондо нарын оролцсон шинэ подкаст цуврал	171
Ажлын байран дахь хахууль ба авлигын зургаан шинж тэмдэг	172
Цар тахлын үед авлигыг бууруулах 5 хэрэгсэл	174
Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд туслах 4 зөвлөгөө	176
КОВИД-19 тахлын эдийн засгийн үр дагаврыг даван туулахдаа авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхийг ГРЕКО улс орнуудад уриалав	177
Авлигын эсрэг иргэдийн оролцоог дэмжих зах зээлийн судалгааны арга хандлага	178
Авлигын эсрэг Олон улсын өдөр	180
4. АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	181
Папуа Шинэ Гвинейн парламент шүгэл үлээгчийн хуулийг батлав	181
Авлигыг илчилснийхээ төлөө 53 удаа ажил нь өөрчлөгдсөн Энэтхэгийн төрийн албан хаагчийн талаар ном бичжээ	181
Хахуулийн талаар мэдээлснээр хэр их мөнгө авж болох вэ?	182
Авлигыг илчилсэн сэтгүүлчийг Беларусийн хуулийн байгууллага баривчлав	182
АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо нэг шүгэл үлээгчид 5 сая доллар олгоно	183
Авлигын талаарх мэдээлэл бэлтгэхийн тулд сэтгүүлчид илүү ихийг золиосолсоор	183
Украины Авлигатай тэмцэх товчоо Ерөнхий прокурорт хэрэг үүсгэв	184
Шүгэл үлээгчийн гомдолд Трампын засаг захиргааны хэрэгжүүлж байгаа цар тахлын эсрэг үйл ажиллагаан дахь авлига болон гажуудлыг илчилжээ	185
Бразил улс шүгэл үлээгчийн тогтолцоогоо сайжруулж байна	185
Хятад: Авлигыг илчилснийхээ төлөө гурван сэтгүүлч хорих ял авлаа	186
Авлигын асуудлаар бичдэг сурвалжлагчийг хөнөөжээ	187

КОВИД-19 халдварын үеэр шүгэл үлээгчид нэмэгдсэн байна	188
Тоглогч авлигын талаар мэдээлсний дагуу Пакистаны крикетийн байгууллагыг шалгахаар болов.....	189
Данске банкны шүгэл үлээгч Олон улсын шударга байдлын төлөөх Аллардын шагналыг хүртэв	189
2020 оны “Шилдэг хуульч” жагсаалтад Phillips & Cohen-ийн хоёр түнш багтжээ.....	190
Авлигын талаар мэдээлэх төрийн албан хаагчид тун цөөхөн байна гэж Малайзын Авлигатай тэмцэх хороо үзэж байна	191
АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо шүгэл үлээгчдэд 1.1 сая гаруй долларын шагнал өгдөг	192
Оросын шүүх Навальныйгийн авлигатай тэмцэх бүлэглэлд хориг тавьжээ	193
Аэробус компанийн салбар авлигын хэрэгт буруутгагдаж, 28.1 сая фунт стерлингээр торгуулав.....	194
Авлигыг илчилж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудад олгох мөнгөн шагнал	195
5. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	198
Австрали ба далайн орнууд.....	198
Австрали: Иракийн газрын тосны хахуулийн хэргээр эрэн сурвалжлагдаж байсан этгээдүүдийг баривчиллаа.....	198
Ази тив.....	198
Хятадын төв банк мөнгө угаахын эсрэг хяналтаа хангалтгүй хэрэгжүүлсэн санхүүгийн гурван байгууллагыг торгов.....	198
Өмнөд Солонгосын давж заалдах шатны шүүхээс Ерөнхийлөгч асан Ли-д авлигын хэргээр 17 жилийн хорих ял оногдууллаа	199
Иракийн авлигатай тэмцэх байгууллага 2019 онд 2 тэрбум гаруй ам.долларыг төрийн санд төвлөрүүлэв.....	199
Арменийн Ерөнхийлөгч асан авлигын хэргээр шүүхэд дуудагдав	200
Филиппиний криптовалютын зохицуулагчийг олон сая долларын авлигын хэрэгт сэжиглэв	200
Цагдаагийн 12 алба хаагчийг хахуулийн хэргээр шүүхэд шилжүүлэв	201
Хятадын үүрэн телефоны ZTE компани хахуулийн хэрэгт шалгагдаж байгаа талаар NBC агентлаг мэдээллээ	201
Нетаньяхугийн холбогдсон авлигын хэргийн шүүх ажиллагааг коронавирусний улмаас хойшлуулав	202
Саудын Арабт төрийн олон зуун албан хаагчийг саатууллаа.....	203
Гүлнара Каримова авлига, эдийн засгийн гэмт хэргээр дахин ял сонслоо.....	203
Хоригдож буй Ерөнхий сайд асан Каледиа Зиа-г гэрийн хорионд байх нөхцөлд 6 сарын хугацаагаар суллаж болох талаар Бангладеш улсын засгийн газар мэдэгдэв	204
Хонконгийн хөрөнгийн биржийн ажилтан асан IPO-тэй холбоотой хахуулийн хэрэгт буруутгагдав	205
Индонез авлигын хоригдлуудыг суллах төлөвлөгөөгүй байна.....	205
Европол, Сингапурын цагдаа нар коронавирусний асуудалтай холбоотой 6 сая еврогийн мөнгө угаах схемийн сэжигтнийг баривчлав.....	205
Хятадын CITIC банкны ерөнхийлөгч асныг хахуулийн хэргээр баривчлав.....	206
Цагдаагийн 8 албан хаагчийг авлигын хэргээр албан тушаалаас нь түдгэлзүүлэв.....	206
Мальдивын Авлигатай тэмцэх хороо КОВИД-19-тэй холбоотой авлигын хэргийг шалгаж байна.....	207

Саудын Арабын авлигатай тэмцэх байгууллага авлигач шүүгч болон түүний хамтрагчдыг баривчилжээ.....	207
Малайзын төрийн сангаас хулгайлагдсан 300 сая долларыг АНУ тус улсад буцаан өглөө	207
Батлан хамгаалах салбар дахь өргөн хэмжээний авлигын хэргийг Хойд Солонгост илрүүлэн шалгаж эхэллээ	208
Бенгал мужийн засаг захиргаанаас 300 орчим хүнс түгээгчийг авлигын хэрэгт буруутган баривчилж, хулгайлагдсан хүнсний зүйлийг буцаан гаргуулахаар боллоо.....	209
Вьетнамын Барилгын яамны Ерөнхий хянан шалгагч нарын хахуулийн дуулиан.....	209
Индонезийн парламентын гишүүн асан саримсны импортын зөвшөөрөлтэй холбоотой авлигын хэрэгтээ 7 жилийн хорих ял авлаа	210
Халдварт өвчний үед ядуу өрхүүдэд зориулсан цагаан будааг шамшигдуулсан асуудалд буруутгагджээ.....	211
Нико компанитай холбоотой шүүх хурал эхлээгүй ч байгалын хий алдсаныхаа төлөө Бангладеш улсад нөхөн олговор төлөхөөр болов	211
Авлигын хэргийн улмаас олон арван төрийн албан хаагчийг баривчлав.....	211
Шэньси мужийн Коммунист намын хорооны дарга асны хахууль авсан хэргийн шүүх хурал болов.....	212
Булакан тосгоны 3 албан тушаалтан авлигын хэрэгт холбогджээ	212
Пусан хотын орлогч даргыг Сөүл хотын шүүх авлигын хэргээр шийтгэсэн байна	213
Биньямин Нетаньяхугийн хэргийн шүүх хурал эхэллээ	213
Зочид буудлуудыг хөл хорионы төв болгон сонгох явцад хахууль нэхсэн асуудлыг шалгаж эхлэв	213
Киргиз улсын Ерөнхий сайд асанд авлигын хэргээр 18 жилийн хорих ял оногдуулав.....	214
Японы Kansai Electric компани өмнөх удирдлагуудаа хахуулийн хэргээр шүүхэд өглөө ..	214
БНХАУ-д төрийн албан тушаалтанд авлигын хэргээр ял оногдуулжээ	215
Ял шийтгэлтэй этгээдийг Хууль зүйн сайдын зөвлөхөөр томилох гэж байгааг Тайландын Авлигатай тэмцэх үндэсний хороо эсэргүүцлээ.....	215
Батлан даалтад байсан Малайзын парламентын гишүүн болон түүний ах хахууль, мөнгө угаасан хэргээр давж заалдах шатанд гаргаад байсан гомдлоо буцаан татлаа	216
Казахстаны гааль, хорио цээрийн албан хаагчдыг авлигын хэргээр саатуулаад байна	217
Авлигын асуудалд холбогдсон албан хаагчдад 7 жилийн ял оноожээ	217
Голдман Сакс групп 3.9 тэрбум ам.долларын тооцоог Малайз улстай хийж дуусгалаа.....	217
Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Хятадын цагдаагийн 19 ажилтныг албан тушаалаас нь чөлөөлөв	218
Казахстанд авлигын хэргийн илрүүлэлт нэмэгджээ	218
Саудын Арабын Зэвсэгт хүчний командлагч авлигын хэрэгт сэжиглэгдэн албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна	218
11 жилийн хорих ял авсан Киргизийн Ерөнхийлөгч асан Атамбаев өөрийн гэм бурууг хүлээгээгүй байна.....	219
БНХАУ-д төрийн шинжлэх ухааны сэтгүүлийн Ерөнхий редакторт авлигын хэргээр 10 жил хорих ял оногдуулсан байна.....	219
СИАА албан тушаалтнуудыг хахуулийн хэргээр баривчлав	220
Авлигын эсрэг чангатгасан үйл ажиллагааны хүрээнд шилдэг их сургуулийн 30 гаруй албан хаагч шалгагдав	220
Киргизийн Гаалийн албаны дэд дарга асан Матраймовыг авлигын хэрэгт холбогдуулан баривчилжээ.....	221

Одиша мужийн засгийн газрын гүйцэтгэх инженерийн туслах 48 орон сууцтай байжээ...	221
Төрийн 21 албан хаагч авлигын гэмт хэрэгт холбогдон ял авахаар боллоо	222
Улсын хөрөнгийг хувьдаа завшсан хэргээр Хорватын Ерөнхий сайд асанд 8 жилийн хорих ял оноолоо	222
Хятад улс оргон зугтсан 7,831 иргэнийг буцаан авчирлаа.....	223
Тайландын Аялал жуулчлалын газрын дарга асанд 50 жилийн хорих ял оноолоо	223
БНХАУ-ын авлигатай тэмцэх байгууллагаас АНУ-ыг авлигын гэмт хэрэгтэй тэмцэхийг уриалжээ.....	223
Киргиз улсын халамж, татварын байгууллагын албан хаагчид оролцсон авлигын сүлжээг илрүүлсэн байна	224
2 сая ам.долларын хахууль авсан хоёр этгээдийн хорих ялын хэмжээг шүүхээс бууруулж 201 мянган ам.долларын торгууль ногдуулжээ.....	224
Узбекистан улсын Ерөнхийлөгч асны охины хөрөнгийг царцаасан шийдвэрийг цуцлахаар болов.....	225
Төв азиас БНХАУ руу баригдаж буй хийн хоолой барих ажлаас хэдэн арван саяар тоологдох мөнгө завшсан байна	225
Индонезийн сайдыг цар тахлын үеийн тусламжтай холбоотой авлигын хэргээр баривчиллаа	226
Ин Ли группийн гүйцэтгэх захирлыг хахуулийн хэрэгт холбогдуулж саатууллаа	227
Саудын Араб авлигатай хатуу тэмцэж байна	227
Тайпэй хотын зөвлөлийн гишүүн асан авлигын хэрэгт холбогдож 7.5 жилийн хорих ял сонслоо	228
Пакистаны авлигатай тэмцэх байгууллага сөрөг хүчний удирдагчийг баривчлав.....	228
Афганистаны Эрүүл мэндийн сайд авлигын хэрэгт холбогдож албан тушаалаасаа огцорчээ	229
Хятадын банкир асан авлига, хахуулийн хэрэгт холбогдон цаазаар авах ял сонсов.....	230
Израилын алмазны магнат Бени Штайнметцын холбогдсон авлигын хэргийн шүүх хурал Женев хотод болно.....	231
Мьянмар улсын нисэх хүчний дарга авлигын хэрэгт холбогджээ	231
Туркийн тагнуулын алба батлан хамгаалах салбар дахь авлигын хэргийг шалгах явцдаа зургаан хүнийг баривчилжээ.....	232
Ли Жэ Ён: Самсунг компанийн өв залгамжлагч хахуулийн хэргээр хорих ял авжээ.....	232
Мөрдөх төв товчоо төмөр замын ахлах албан тушаалтан болон өөр хоёр этгээдийг 1 крор рупийн хахуулийн хэргээр баривчлав	233
Мөрдөх төв товчоо өөрийн 2 ажилтныг хахуулийн хэргээр баривчлав	235
Хятадад төрийн өмчит компанийн даргыг авлигын хэргээр цаазлав.....	235
Казахстанд таван дэд сайдыг авлигын хэрэгт буруутгажээ	236
Нетаньяхугийн шүүх хурал сонгууль болохын өмнөхөн товлогдлоо.....	236
Афганистан улсын 321 албан тушаалтан авлигын хэргээр халагджээ.....	237
2020 онд 24 албан хаагчтай холбоотой авлигын асуудлыг шалгажээ.....	237
Саудын Арабт хэдэн зуун хүнийг авлигын хэрэгт холбогдуулан саатуулаад байна.....	237
Нетаньяху авлигын хэрэгт холбогдон дахин шүүхэд дуудагдав.....	238
Малайзын Ерөнхий сайд асан Нажиб Разак олон нийтийн хөгжлийн сангийн хөрөнгийн мөнгө угаасан хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон тул давж заалдах шатны шүүхэд гомдол гаргажээ.....	240

Авлигын хэргээр эрэн сурвалжлагдаж байсан этгээд хууль бус орлогоо хүлээлгэн өгөхөөр Хятад улсад эргэн иржээ	240
Ливаны Төв банкны ерөнхийлөгчийг авлигын хэрэгт буруутгалаа	241
Киргизийн экс Ерөнхий сайдыг уул уурхайн авлигын хэргээр саатуулав	242
Төрийн албан тушаалтнууд хахуульд виски, хонины мах, сари, ширээний сэнс шаарджээ	242
КОВИД-19 цар тахалтай холбогдолтой авлигын хэргээр Индонезийн сайд асан 12 жилийн хорих ял сонсжээ	243
БНХАУ-ын Хууль зүйн сайд асан Ши Жиньпиний авлигын эсрэг кампанит ажлын бай болсон бололтой	244
Энэтхэгийн Махараштра мужийн Дотоод хэргийн сайд асан Анил Дешмухтай холбоотой авлигын хэрэг дээр Мөрдөн шалгах товчоо эхний баривчилгаагаа хийлээ	244
Америк тив	245
Мексикийн Ерөнхийлөгч асан Пена Нието авлигын хэргээр шалгагдаж байна	245
Эквадорын экс Ерөнхийлөгч Корреаг авлигын хэргээр эчнээ шийтгэв	246
Гватемалын эрүүл мэндийн ажилтнууд халагдаж, авлигын хэргээр шалгагдаж байна	246
Авлигын хэрэгт яллагдсан Филадельфи хотын Тойргийн прокурор асан хугацаанаасаа өмнө шоронгоос суллагдав	247
Алексион Фармасевтикалс хахуулийн хэрэгтээ 25 сая доллар төлөх тохиролцоонд хүрэв	247
2020 оны 04 дүгээр сард олон улсад авж хэрэгжүүлсэн авлигын эсрэг томоохон 10 арга хэмжээ	248
Венесуэлийн авлигачдын 2 сая долларыг угаасан хэрэгт Америкийн профессор гэм буруугаа хүлээн зөвшөөрөв.....	250
Эквадор улсын Ерөнхийлөгч асан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахтай холбоотой авлигын хэргээр гэрийн хорионд орсон байна	250
АНУ-ын Дээд шүүх Макаогийн тэрбумтаны давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгов..	251
Панамын Ерөнхийлөгч асан Рикардо Мартинелли авлигын хэрэгт холбогдлоо	252
АНУ-ын Охайо мужийн хууль тогтоох байгууллагын даргыг авлигын хэргээр баривчилсан байна.....	252
Хотын зөвлөлийн гишүүнд хахууль өгснөө хүлээн зөвшөөрөв.....	253
Авлига, хахуулийн асуудалд холбогдсон 1,040 төрийн албан хаагчийг ажлаас чөлөөлжээ	253
Хотын хуучин дарга, түүний туслах нарын авлигын хэргийг 01 дүгээр сард шүүнэ	254
60 сая долларын хахуулийн хэрэгт холбогдсон гүйцэтгэх захирал үүрэгт ажлаасаа халагдлаа	254
Рио-де-Жанейро хотын даргыг авлигын гэмт хэрэгт холбогдуулан баривчилжээ	255
Айова хотын удирдлага олон жилийн турш үргэлжилсэн авлигын гэмт хэрэгт холбогдон баривчлагдав.....	256
Португалийн Ерөнхий сайд асныг мөнгө угаасан хэргээр шүүхээр болжээ	258
Венесуэлийн газрын тос, байгалийн хийн төрийн өмчит компанийн албан хаагчид хахуулийн хэргээр 2 жилийн хорих ял оноожээ	258
Мөнгөөр дүн тавьдаг байсан Балтиморын математикийн профессор нэг жилийн хорих ялаар шийтгэгджээ	259
Олон улсын хөлбөмбөгийн холбооны авлигын хэрэгт Эл Сальвадорын Хөлбөмбөгийн холбооны Ерөнхийлөгч асан гэм буруугаа хүлээв.....	260

Олон улсын хөлбөмбөгийн холбоо авлигын гэмт хэргийн хохиролд 201 сая гаруй ам.долларын нөхөн төлбөр авахаар болжээ.....	261
23 насандаа сонгогдож байсан хотын дарга асан авлигын хэрэгт холбогдон 6 жилийн хорих ял авлаа.....	261
Африк тив	262
Суданы Ерөнхийлөгч асан Баширыг авлигын шинэ хэрэгт буруутгаад байна	262
Египетийн парламентын гишүүнийг хахуулийн хэргээр баривчилжээ	262
Эрүүл мэндийн сайд асанд авлигын хэргийн улмаас 5 жилийн хорих ял оноожээ	263
Хууль бус баривчилгааны хохирогчдод тус бүр 15 сая шиллингийн нөхөн төлбөр өгөхөөр шүүх шийдвэрлэв	263
Конго улсын Ерөнхийлөгчийн ойрын туслах 50 сая ам.долларын авлигын асуудалд холбогджээ	264
Конго улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хахууль авсан асуудлыг шүүх хурлын эхэнд үгүйсгэв	264
Сахилгын хяналт шалгалтын дагуу авлигын 139 тохиолдлыг илрүүлэв	265
Зимбабве улсын авлигатай тэмцэх байгууллага чинээлэг иргэдийг шалгаж эхэллээ	265
Конго улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга авлигын хэргээр ял сонслоо	266
Авлигач цагдаа нарын хувьд хар баасан гараг болж өнгөрлөө.....	267
Өмнөд Африкийн эрх баригч намын өндөр албан тушаалтан авлигын хэрэгт холбогджээ	267
Авлигын хэрэгт буруутгагдаад байсан Шелл, Эни компаниудыг шүүхээс цагаатгасанд Нигери улс сэтгэл дундуур байна.....	268
Олон арван машин, байшин цуглуулсан бие хамгаалагч	269
Өмнөд Африкийн Зума шоронд хоригдохоор болов	272
Тунис улсын авлигатай тэмцэх байгууллагын дарга асныг гэрийн хорионд оруулсан байна	272
Мали улсын Ерөнхий сайд асан Бубэй Майга авлигын хэрэгт холбогдон баривчлагджээ.....	273
Өмнөд Африкийн Ерөнхийлөгч асан Зумагийн авлигын хэргийн шүүх хурал 10 дугаар сарын 26-ны өдөр хүртэл хойшиллоо.....	274
Авлигын асуудалд холбогдсон уул уурхайн компанийн захирлыг ажлаас нь чөлөөлөв	274
Европ тив	276
Красноярскийн депутат авлигын хэргээр 8 жилийн хорих ял авлаа	276
Прокурор их хэмжээний хахууль авсан хэрэгт сэжиглэгдэж байна.....	276
Гүрж улсын Боржоми хотын дарга болон захиргааны зөвлөлийн дарга нар авлигын хэргээр баривчлагдав.....	277
Дэлхийн банк авлигын улмаас Шведийн компаниудыг хар жагсаалтад оруулав.....	277
Албани улсын Ерөнхий прокурор асан авлигын гэмт хэрэгт буруутгагдаж байна	278
Барселоны тоглогч асан Роналдиног мөнгө угаасан хэрэгт холбогдуулан шалгаж эхэллээ	278
Молдавын иргэн хахууль өгөхийг завдсан хэргээр Латвид торгуулийн ял авлаа	279
Испанийн засгийн газарт 20 сая еврогийн үнэтэй амны хаалт зарсан компанийг авлигатай тэмцэх байгууллагаас шалгаж байна	279
Хахууль авж байгаад газар дээрээ баривчлагдсан хяналтын хоёр ажилтанд 10 жил хорих ял тулгаж байна	280

Приморийн хязгаар дахь төмөр замын өртөөний даргыг авлигын хэрэгт буруутгаж байна	280
Албанийн Авлигатай тэмцэх прокурорын тусгай албанаас засгийн газрын хүнсний тусламжийн 1.5 сая еврогийн тендерийг шалгаж байна.....	280
Украины Ерөнхий прокурор асан Рябошаклад эрүүгийн хэрэг үүсгэв.....	281
Албани улсын шүүгч, прокуророор ажиллаж байсан 20 хүнийг авлигын хэрэгт буруутгажээ	281
Башкирт цагдаагийн ажилтанд хахууль өгсөн үндэслэлээр торгосон байна.....	282
Сайд Криклийн нууц эхнэр болон олон саяын өмч хөрөнгийг сэтгүүлчид олж илрүүлжээ	282
Мөнгө угаах асуудалд холбогдсон төрийн банкныг Польш улс шалгаж байна	283
Молдавт хүмүүнлэгийн тусламж үзүүлэхдээ хахууль авсан гэж Румыны эрх баригчдыг буруутгаж байна	283
Одесс хотын захирагч Трухановын хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт дууссан байна.....	284
Москва хотын Прокурорын газраас тус хотын Төрийн Думын дарга, тэрбумтан Алексей Шапошниковын хөрөнгө, орлогын мэдүүлэгт шалгалт явуулж байна	285
Беларусийн Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны дарга асан хахуулийн хэргээр 12 жилийн ял авлаа	285
Гурван талт хэлэлцээр нь Украины авлигатай тэмцэх үйл ажиллагаанд шинэ боломж авчирна	286
Испани улсын хаан асан авлигын асуудал дэгдсэн үеэр улсаа орхин явахаа мэдэгдээд байна	286
Украины Батлан хамгаалах салбарын авлигын асуудалд холбогдсон этгээд хахууль өгсөн байж болзошгүй байна.....	286
ОХУ-ын Ненецийн дунд сургуулийн захирал асныг хахууль авсан хэрэгт сэжиглэж байна	287
Жолооч замын цагдаад хахууль өгөхийг завджээ	287
Төрийн Думын гишүүн тэрбумын хахууль авсан хэргийг шүүхээр болжээ	287
ОХУ-ын Мособлэнерго компанийн удирдлагыг баривчилжээ.....	288
Оросын Эрчим хүчний дэд сайд авлигын хэргээр баривчлагджээ.....	288
Чехийн цагдаа нар хөлбөмбөгийн авлигын хэрэгт холбогдуулан шалгахаар 20 хүнийг саатуулжээ.....	289
Нижний Новгород мужийн Сангийн яамны албан тушаалтныг авлигын хэргээр саатуулжээ	289
Сибирийн хотын захирагчийг авлигын хэрэгт холбогдуулан баривчилж, албан тушаалаас нь чөлөөлөв.....	290
Австри улсын Сангийн сайд асанд авлигын хэрэгт холбогдуулан 8 жилийн хорих ял оногдуулжээ.....	291
ОХУ-ын төрийн албан хаагч асан авлигын хэрэгт холбогдож 15 жилийн хорих ял сонслоо	292
Айварс Лембергс: Латви улсын хамгийн баян хүмүүсийн нэг хахууль, мөнгө угаах хэргээр шоронд хоригдож байна	293
Военторга компанийн Ерөнхий захирлын орлогч асан Тейф буруугаа хүлээсэн бөгөөд 5 жилийн хорих ял оногдуулжээ.....	294
Польшид хахууль өгөхийг завдсан Украины иргэнийг саатуулжээ	295

Авлигатай тэмцэх ажилд ЕХ гар дүрэхгүй байхыг Монтенегро улс уриалав	295
Авлигын хэрэгт холбогдсон Украины шүүгчийг хулгайлж, эх оронд нь буцаасан талаар Молдав улс мэдээлэв.....	296
ОХУ-д авлигатай тэмцэх үүрэг бүхий албан тушаалтан хахууль авсан байна	297
Хорватын авлигатай тэмцэх цагдаа нар төрийн телевизийн захирлыг баривчилжээ.....	297
Албани улсын Ерөнхий прокурор асан авлигын хэрэгт холбогдож хорих ял сонсжээ.....	297
Австри улсын канцлер хахуулийн асуудалд сэжиглэгдэн шалгагдаж байна	298
Боловсролын дэд сайд асан Раковаг залилангийн хэрэгт буруутгажээ	299
Швейцарийн прокурор Испани улсын цөлөгдсөн хаан Хуан Карлосын авлига, хахуулийн хэргийг хэрэгсэхгүй болгожээ	299
6. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН АМЬДРАЛ БА АВЛИГА	300
Бэлгийн сүрдүүлэг: Авлига эмэгтэйчүүдэд өвөрмөцөөр нөлөөлдөг болох нь	300
Авлигын нийгмийн сэтгэл зүй	301
Авлигад автсан институц шударга хүмүүсийг хэрхэн эвддэг вэ?	302
Нөхцөл байдлыг бүхэлд нь тольдохуй: Санхүүгийн нууцлалын индекс ба АТИ.....	304
Панамын баримтаас хойш 4 жил: Нууцлаг компаниуд ба дэлхийн баялаг	306
Хятадын арми дахь авлига болон Донгфенг компанийн чанаргүй автомашин Галван хөндий дэх цэргийн албан хаагчдыг үхэлд хүргэсэн	307
Мөнгө угаалт, банк, криптовалютын цаана нуугдаж байгаа үнэн.....	308
Дэлхийг хамарсан татварын зөрчлүүд, мөнгө угаах гэмт хэрэг, авлига зэрэг нь дэлхийн ядуу иргэдэд хамгийн их хохирол учруулдаг гэж НҮБ-ын тайланд дурджээ.....	308
Авлига болон авлигатай тэмцэх үйл ажиллагааны чиг хандлагаас бид юу суралцав?.....	309
Корпорацын авлигын талаар судалгаа хийх шаардлага их байна	312
Голдман Сакс ба эдийн засагт үзүүлэх авлигын нөлөөлөл	313
Дэлхий дахинаараа сэргээгдэх эрчим хүч рүү шилжихэд авлига саад болж байна	314
Цар тахлын үеийн авлига	315
Эмзэг улсууд дахь авлига: АТИ-ийн илэрхийлж чаддаггүй зүйлс.....	317
Хөгжиж буй орнууд дахь авлигын сэтгэлзүйн өртөг.....	318
Эрүүл мэндийн салбар дахь авлига нь өвчтөнүүдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн чанарыг улам бүр доройтуулдаг	320
Нийгмийн харилцаанд зай барьснаар авлига ч мөн буурчээ.....	321
Үндэстэн байгуулах ажиллагаа ба авлига: Франц Вьетнамын сануулга	322
Улс төрч ба бизнес эрхлэгчдийн харилцан хамаарлын харанхуй хэвлий: үүнийг эвдэж болох уу?	324
Авлигатай тэмцэх ажиллагаа бол пуужин хөөргөх шинжлэх ухаан биш	326
АНУ-ын хөлбөмбөгийн дээд лиг: гэмт бүлэглэлийн үндсэн бай эсэх?	327
Авлигач бөгөөд хүчирхэг: Хятад улсын эдийн засгийн өсөлтийн парадокс	329
Цар тахал ба авлига 2021 онд.....	334
7. СУДАЛГАА, НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ	335
Эрүүл мэндийн салбар дахь авлигатай тэмцэх нь - Афганистаны таван сургамж.....	335
Дэлхийн авлигатай тэмцэх байгууллагуудын зураглал (тойм) нэртэй тайлан гарчээ	337
Их сургууль дахь авлига: мөсөн уулын орой юу?.....	337

Узбекистаны их, дээд сургуулиадад авлигын шалтгаан, нөхцөлийг тодруулах үүднээс судалгаа зохион байгуулсан байна	339
Үзэл бодол: Эрүүл мэндийн салбар дахь худалдан авах ажиллагааны авлигыг хэрхэн хязгаарлах вэ.....	339
Израил улсын шүгэл үлээгчдийг дэмжих хуулийн хоёр өөрчлөлт.....	341
БНХАУ болон Казахстан улс авлигатай хэрхэн тэмцэж байгаа талаар харьцуулалт хийсэн байна.....	342
Таргалалттай улс төрчид авлигын шинж болохыг судалгаа харуулав <i>Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан авлига ихтэй улс орнууд тарган улс төрчидтэй</i>	343
Төрд итгэх олон нийтийн итгэл алдарч байна.....	344
Бизнес дэх хахуулийн нөлөөллийн талаарх судалгаа	344
Жеймс Вассерстромын оролцсон шинэ подкаст цуврал	345
Төрийн худалдан авах ажиллагаан дахь авлига	346
Цар тахал авлигыг газар авхуулж байна. Эрэн сурвалжлах сэтгүүлчид мөшгиж чадах уу?	349
Нийгмийн хэм хэмжээ авлигад боломж олгодог, гэхдээ залуу идэвхтнүүд үүнийг эсэргүүцэж байна.....	350
Авлигын хохирогч хэн болохыг танин мэдэхүйд гарсан ахиц	351
Лондон хотын тансаг байшингуудын арилжааны цаана бохир мөнгөө нууж байна	355
Банкны дээрэмчин болгонд зугтах машин хэрэгтэй: Банкны удирдах ажилтан мөнгө угаасан хэргээр шалгагдаж байна	355
Гадаадын албан тушаалтны хахуулийн хэрэгт хохирол барагдуулах зарчим.....	357
Мөнгө угаалт: Дэлхийн оффшор санхүүгийн системийн бараан тал – дүн шинжилгээ	358
Корпорацын залилан ба авлига 2021	360
Цагдаагийн байгууллага дахь авлигын асуудлыг мэдсэнээр донор байгууллага юу ойлгов	362
Судалгаа: Аж ахуйн нэгжүүд ил тод байдал, авлигын эрсдлийн асуудлаар илүү ихийг хэрэгжүүлэх хэрэгтэй.....	365
Олон улсын авлигын талаарх статистик мэдээллийн үнэн зөв байдал хэр баталгаатай вэ?	366
Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухаан нөлөөлж чадах уу?	369
Дэлхийн авлигын хэмжүүр судалгаа - ЕХ: албан тушаалын байдлаа урвуулан ашиглах явдал хяналтгүй байгаад олон нийт сэтгэл зовниж байна.....	371
Эрдэмтэн, судлаачид авлигатай тэмцэх чиглэлд бүтэлгүйтэж буй гурван шалтгаан: Ротштайны өгүүлэлд тайлбар өгөх нь	373
Татварын салбар дахь авлигын эрсдэл	377
Гана улс дахь хувийн хэвлэл мэдээллийн зарим байгууллага юуны учир авлигатай тэмцэж байна вэ? Шалтгаан, дүрэм, нөөц	381
ИНДЕКС	385
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ	393

1. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ БОДЛОГО

Олон улсын байгууллага

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга дэлхийн баялгийн тэн хагас хэний мэдэлд байгааг хэлэв¹

2020.07.19. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш дэлхийд шударга ёсыг бий болгох, тэгш бус байдалтай тэмцэх чиглэлээр дэлхийн хэмжээний шинэ гэрээ байгуулах саналыг дэвшүүлсэн байна.

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш ӨАБНУ-ын Ерөнхийлөгч асан Нельсон Манделагийн мэндэлсний ойд зориулж 07 дугаар сарын 18-ны өдөр хэлсэн үгэндээ дэлхийн хүн амын 70% нь тэгш бус нөхцөлд амьдарч байна, ертөнцийн бүх баялаг дэлхийн хамгийн баян 26 хүний мэдэлд байна, энэ нь дэлхийн хүн амын тэн хагасын орлоготой дүйцэж байгаа талаар дурдсныг [Tvnet.lv](https://www.tvnet.lv) сувгаар мэдээлжээ.

Антонио Гутерриш тэгш бус байдлын гол хэмжүүр нь хүйс, гарал угсаа, арьсны өнгө, хөгжлийн бэршээл зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа санхүүгийн түвшин юм гэсэн байна.

“Эх дэлхий дээр амьдарч байгаа олон сая хүмүүсийн амьдрал тэднийг төрөх үед угтан авж, хүрээлж байгаа хүчин зүйлсээр тодорхойлогдож байна. Санхүүгийн ялгавартай байдал өндөр түвшинд байгаагийн улмаас дэлхий дахинд эдийн засгийн тогтвортой бус байдал, авлига, санхүүгийн хямрал, гэмт хэргийн өсөлт нэмэгдсэнээр хүний бие бялдрын болон сэтгэцийн эрүүл мэнд муудсаар байна” гэж тэрээр хэлсэн байна.

Мөн 20 жилийн өмнө хүний хөгжил бага улс оронд төрсөн хүүхдүүдийн 17% нь нас барсан талаар мэдээлсэн байна. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антонио Гутерриш нь тэгш бус байдалтай тэмцэх өргөн хүрээтэй санаачилгыг танилцуулж шударга ёсыг бий болгох зорилго бүхий дэлхий дахины шинэ гэрээ байгуулах саналыг дэвшүүлсэн байна.

Авлига хөгжил дэвшилд саад учруулдаг²

2020.12.09. UNDP. *“Авлига нь хөгжлийг доройтуулан, эдийн засгийн өсөлтийг сааруулж, сайн засаглал, хууль дээдлэх ёсыг алдагдуулан, төрийн үйлчилгээ үзүүлэхэд саад болж байна”* хэмээн Соломоны арлуудын Гизо хотноо 12 дугаар сарын 09-ний өдөр олон улсын авлигатай тэмцэх өдрийг тохиолдуулан хийсэн арга хэмжээнд оролцогчид дүгнэлээ.

2003 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан Авлигын эсрэг конвенцын хэрэгжилтийг сурталчлах, авлигатай тэмцэх талаар олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэх зэргээр Авлигын эсрэг олон улсын өдрийг дэлхийн өнцөг булан бүрд тэмдэглэн өнгөрүүлдэг болсон. Энэхүү арга хэмжээ нь олон үндэстнийг нэгтгэн, авлигатай тэмцэх үйл хэрэгт дэлхий нийтийг уриалж байна.

Энэ жил НҮБ-ын “Шударгаар сэргэцгээе” компани ажлын уриан дор Ерөнхий сайдын ажлын алба, хууль сахиулах байгууллага, Омбудсмэний алба, Удирдлагын ёс зүйн хороо, Эрх зүйн шинэчлэлийн хороо, Ерөнхий прокурорын алба, Аудиторын газар, иргэний нийгмийн салбар, орон нутгийн захиргааны нэгжүүд НҮБХХ-тэй хамтран авлигын эсрэг олон улсын өдрийг Гизо хотноо анх удаа тэмдэглэжээ.

Тус хөтөлбөрийг олон нийтэд сурталчлах ажлыг Гизо хотын захад амьдардаг Титианагийн уугуул иргэдээс эхлүүлсэн ба Гизо хотод бүх нийтийг хамаарсан жагсаал зохион байгуулж, авлигын хортой үр дагавар, авлигатай тэмцэхэд хууль сахиулах байгууллага болон олон нийтийн оролцооны талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Шадар сайд Дерек Мане нээлтийн үгэндээ *“Авлигыг бага байлгаж, авлигатай тэмцэхийн тулд бүх нийтийн хамтын хүчин чармайлт шаардлагатай”* гэжээ.

¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://lv.sputniknews.ru/world/20200719/14071055/Gensek-OON-rasskazal-u-kogo-nakhoditsya-polovina-bogatstv-mira.html>

² Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.solomontimes.com/news/corruption-is-the-opposite-of-development/10490>

Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд болон оршин суугчид авлигын эсрэг үйл хэрэгт идэвхтэй оролцож, орон нутгийн үйл ажиллагааны талаарх шийдвэрүүдийг өөрийн хэрэгцээ шаардлагадаа нийцүүлэх хэрэгтэй. Шинээр байгуулагдсан Авлигатай тэмцэх бие даасан хороо нь засгийн газрын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийн илэрхийлэл гэж нэмж хэлсэн байна.

НҮБ-ийн төслийн зохицуулагч ноён Ворда Хока Соломоны арлуудын засгийн газрын хамтын ажиллагаа, түншлэлийг онцлон дурдаад “*Авлига бол бүх улс оронд нөлөөлөх, нийгэм, улс төр, эдийн засгийн цогц үзэгдэл юм. Энэ нь ардчиллын хүчийг сулруулж, эдийн засгийн хөгжлийг удаашируулж, засгийн газрын тогтворгүй байдлыг үүсгэдэг тул авлигатай тэмцэхэд тууштай арга хэмжээ, бат бөх хамтын ажиллагаа шаардлагатай*” гэжээ.

Авлига бол тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд тулгардаг хамгийн том саад бэрхшээлүүдийн нэг нь юм гэж ноён Хока хэлэв. Дээрх арга хэмжээг НҮБХХ, Соломоны арлуудын Ерөнхий сайдын ажлын албатай хамтран хэрэгжүүлж буй “Ил тод байдал, хариуцлага” төслийн хүрээнд зохион байгуулсан байна.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей авлигын эсрэг 2021: Гол үр дүн ба амлалт³

2021.05.17. НҮБ. Авлига улам бүр үндэстэн дамнасан шинжтэй болж байгаатай холбоотойгоор уг асуудалд дэлхийн хэмжээнд анхаарлаа хандуулах, мөн авлигаас үр дүнтэй урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргийн эсрэг тэмцэхэд олон улсын хамтын ажиллагаа шаардлагатай байна.

Авлигын асуудалд анхаарлаа хандуулах, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор 2021 оны 06 дугаар сарын 02-04-ний хооронд тусгайлан авлигын асуудлаар НҮБ-ын Ерөнхий Ассамблей чуулав.

Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх чиглэлээр НҮБ-ын Ерөнхий Ассамблейн чуулганаар төр, засгийн тэргүүн, сайд нар, гишүүн улс орнуудын төлөөлөгчид, АЭНҮБК-ын оролцогч талууд амлалт өгсөн байна.

Уг амлалтыг бүрэн эхээр нь <https://undocs.org/A/S-32/2/ADD.1> -ээс үзнэ үү.

Тухайлбал, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн энэхүү тусгай чуулганаар АЭНҮБК-ын бүх оролцогч талууд авлигаас урьдчилан сэргийлэх, эрүүгийн хариуцлагыг нэмэгдүүлэх, хууль сахиулах, олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх, хөрөнгө буцаах, техникийн тусламж үзүүлэх замаар авлигын эсрэг тэмцэхээ амлав.

Олон улсын авлигын эсрэг шүүх байгуулахыг уриалав⁴

2021.06.10. Дэлхийн дөч гаруй улс орны зуу гаруй төлөөлөгч, удирдагчид Олон улсын авлигын эсрэг шүүх байгуулахыг уриалсан тунхаг бичигт гарын үсэг зураад байгааг АНУ-д төвтэй, авлигатай тэмцэх үйл ажиллагаа явуулдаг Integrity Initiatives International байгууллагаас мэдэгдэв. Энэхүү мэдэгдэлд дурдсанаар уг шинэ шүүх нь “ардчилал, хүний эрхийг дэмжих, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, олон улсын энх тайван, аюулгүй байдлыг дээшлүүлэхэд нэн даруй шаардлагатай байна”.

Гарын үсэг зурсан төр, засгийн тэргүүнүүдийн дотор Колумбын Ерөнхийлөгч асан, Нобелийн шагналт Хуан Мануэль Сантос, Тунисийн Ерөнхийлөгч асан Монсеф Марзуки, Шведийн Ерөнхий сайд асан Карл Билдт, Нобелийн шагналт шүүгч асан Ширин Эбади, Канадын Гадаад хэргийн сайд асан Ллойд Аксворти, Канадын Хууль зүйн сайд асан Петер Маккей, НҮБ-ын Хүний эрхийн дээд комиссар асан Нави Пиллай, Зейд Раад Ал Хуссейн, Гватемалийн шүүгч асан Клаудиа Эскобар Межиа, Олон улсын өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Стернфорд Мойо нар байгаа юм.

³ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.lexology.com/library/detail.aspx?g=35491849-1a64-4639-8fc3-4f563135303d>

⁴ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.democracywithoutborders.org/17123/statement-an-international-anti-corruption-court-is-urgently-needed/>

“Клептократизм⁵ болон өндөр түвшиний авлигад шийтгэл хүлээлгэхгүй байгаа байдал нь олон улс оронд улам бүр даамжирч, нөхцөл байдал дордож байна. Хохирогчид нь ядуу, сул дорой хүмүүс байгаа бөгөөд үр дүнд нь тэднээс асар их хэмжээний хөрөнгийг хулгайлж байна. Тиймээс клептократизмыг таслан зогсоох, хариуцлагад татах, шийтгэл хүлээлгэх, мөн хууль бус хөрөнгийг буцаах, зориулалтыг өөрчлөхийн тулд Олон улсын авлигын эсрэг шүүх байгуулах зайлшгүй шаардлагатай байна” хэмээн ӨАБНУ-ын шүүгч, хуучин Югослав болон Руандагийн асуудлыг хэлэлцсэн олон улсын эрүүгийн шүүхийн анхны прокурор, Integrity Initiatives International байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн Ричард Голдстоуны хэлснийг дээрх мэдэгдэлд эш татсан байна.

Их 20-ийн орнуудын удирдагчид авлигын эсрэг төлөвлөгөө батлав⁶

2021.11.01. Итали улсын нийслэл Ром хотод Их 20-ийн дээд хэмжээний уулзалтаар “төрийн болон бизнесийн салбарт авлигыг үл тэвчих үзлийг тууштай дэмжих, дэлхийн авлигын эсрэг үйл ажиллагаанд нэгдмэл зорилгодоо хүрэх үүднээс 2022-2024 оны авлигатай тэмцэх төлөвлөгөөг бид дэмжин хэрэгжүүлэхээр болов. Цаашид эрдэмтэн судлаачид, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, бизнесийн салбар зэрэг оролцогч талуудтай хамтын ажиллагааг хөгжүүлэх, тэдний идэвхтэй үйл ажиллагааг хангах чиглэлээр ажиллах болно” хэмээн Их 20-ийн дээд хэмжээний уулзалтын үр дүнгийн талаарх хэвлэлийн мэдээнд онцолжээ.

Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын товч танилцуулга⁷

2021.12.09. АЭНҮБК-ыг Ерөнхий Ассамблей 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдөр баталж, 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн ба 2021 оны байдлаар 189 гишүүн орон соёрхон баталсан байна. АЭНҮБК-д авлигыг тодорхойлоогүй бөгөөд харин авлигын хэлбэрийг нэг бүрчлэн тусгаж өгсөн байдаг. Конвенцод нэгдэн орсон улс орнууд гэмт хэрэг мөрдөн шалгах ажиллагаа, иргэний ба захиргааны туслалцаа болон техникийн туслалцаа үзүүлэх үүрэг хүлээдэг. Түүнчлэн, конвенцын хүрээнд иргэний нийгмийн байгууллагууд эгэх хариуцлагыг хэрэгжүүлэх бүрэн эрхийг зохицуулж, мэдээллийн тод байдлыг хангахын ач холбогдлыг баталгаажуулсан юм. НҮБ-ын МБГХТА тус конвенцын нарийн бичгийн даргын үүргийг хэрэгжүүлж байна.

Авлигын эсрэг конвенц 8 бүлэг, 71 зүйлээс бүрдэх бөгөөд ихэнх зүйл нь заавал биелүүлэх шинжтэй бол зарим зүйл нь гишүүн орныг хэрэгжүүлэхэд анхаарал хандуулахыг хүсдэг. Одоогийн байдлаар нийт 11 улс орон тус конвенцод нэгдэн ороогүй байна. Үүнд: Андорра, Барбадос, Эритрей, Монако, Хойд Солонгос, Сент Китс ба Невис, Сент Винсент ба Гренадин, Сан Марино, Суринам болон Сири.

Гадаад хамтын ажиллагаа

Олон улсын хамтын ажиллагааны талаар АЭК-ын дөрөвдүгээр бүлэгт тусгасан. Энэ хүрээнд үндэстэн дамнасан конвенцод заасан авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагаанд гишүүн орнууд хамтран ажиллаж, туслалцаа үзүүлэхээр зохицуулсан. Үүнд, сэжигтнийг шилжүүлэх /44-р зүйл/, ялтан шилжүүлэх /45-р зүйл/, мэдээлэл солилцох, гэмт хэргийн улмаас олсон орлогыг илрүүлэх, царцаах, хураан авах ажиллагаанд харилцан туслалцаа үзүүлэх /46-р зүйл/, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг буцаан шилжүүлэх /47-р зүйл/, хууль сахиулах хамтын ажиллагаа, мөрдөн шалгах ажиллагааг хамтран гүйцэтгэх болон мөрдөн шалгах тусгай арга техник /48-50-р зүйл/-ийг тусгасан.

Мөрдөн шалгах болон хохирлыг буцаан шилжүүлэх иргэний болон захиргааны ажиллагаанд гишүүн орнууд хамтран ажиллах нь заавал гүйцэтгэх шинж чанаргүй юм. Харин гишүүн орнууд тус ажиллагааг гүйцэтгэх талаар анхаарал хандуулах ёстой байдаг/43-р зүйл/.

⁵ Оксфордын толь: Удирдагчид эрх мэдлээ ашиглан засаглаж буй улсаасаа мөнгө, нөөцийг хулгайлдаг төрийн хэлбэр. Кембрижийн толь: Ард түмнээс хулгай хийх замаар удирдагчид нь өөрсдөө баян, хүчирхэг болдог нийгэм.

⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://ria.ru/20211031/g20-1757093988.html>

⁷ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.u4.no/publications/uncac-in-a-nutshell-2021.pdf>

Мөн конвенцод зааснаар мөрдөн шалгах ажиллагаанд туслалцаа хүсэхэд тус гэмт хэрэг нь хоёр оронд адил гэмт хэргийн шинж чанартай байх шаардлагатай байдаг нь мөрдөн шалгах ажиллагаанд хүндрэл бэрхшээл учруулдаг байдлыг хөнгөвчилсөн байна.

Хөрөнгө буцаах

Хөрөнгө буцаах ажиллагааг конвенцын 5 дугаар бүлэгт тусгасан ба АЭНҮБК-ын суурь зарчмын нэг юм. Гишүүн орнууд авлигын гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг буцаах чиглэлд хамтын ажиллагааны өргөн хүрээний дэмжлэг, боломжийг санал болгохыг шаарддаг. Авлигын гэмт хэргээс шалтгаалан хөрөнгийг тухайн улсад, өмнөх хууль ёсны өмчлөгчид, эсхүл, хохирогчид шилжүүлдэг/57-р зүйл/.

- Гишүүн орнууд гэмт хэргийн улмаас олсон хөрөнгийг шилжүүлэхээс сэргийлэх, шалган тогтоох үүрэгтэй. Энэ нь мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх болон санхүүгийн мэдээллийг ил тод байлгах арга хэмжээ гэсэн хоёр үндсэн төрөлд хуваагдана.
- Бусад улсад авлигын гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгийг хураан авах, буцаан шилжүүлэх тогтолцоог засгийн газрууд төлөвшүүлнэ.

АЭЖ-ын хэрэгжилтийг хангахад түгээмэл гардаг маргаан нь нөхцөл байдлын үнэлгээ юм. Ихэвчлэн өрнийн орнуудаас гэмт хэргийн хөрөнгийг буцаан шилжүүлж буй орнуудыг аливаа шаардлага, нөхцөл тавилгүй шууд бүрэн бүтнээр шилжүүлэхийг хүсдэг боловч өндөр хөгжилтэй орнууд тус хөрөнгө нь дахин авлигын улмаас алдагдах нөхцөл байдал өөрчлөгдөөгүй байгаа гэх үндэслэлээр буцаан олгох ажиллагааг гүйцэтгэлгүй, урт хугацааны турш царцаах тохиолдол элбэг байдаг.

Техникийн туслалцаа ба мэдээлэл солилцоо

Техникийн туслалцааг конвенцын хэрэгжилтийг хангахад чиглэсэн дэмжлэг гэж АЭЖ-д ойлгодог. Зургаадугаар бүлэгт зааснаар техникийн туслалцаа гэдэгт сургалт, эдийн болон хүний нөөц, судалгаа болон мэдээлэл солилцох ажиллагааг тодорхойлсон. Конвенцын дагуу авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлд мөрдөн шалгах ажиллагааны арга техник, төлөвлөлт болон бодлого боловсруулалт, эрх зүйн харилцан туслалцааны хүсэлт бэлдэх, төсвийн зохицуулалт болон гэрч, хохирогчийг хамгаалах эрх бүхий албан тушаалтныг чадваржуулах сургалт зохион байгуулахыг тусгасан.

Гишүүн орнууд өөрсдийн нөөц бололцооны хүрээнд бусад гишүүн орнуудад, нэн ялангуяа, хөгжиж буй орнуудад техникийн туслалцаа үзүүлэх, хэрэгжилтийн үнэлгээг гүйцэтгэхэд харилцан туслалцаа үзүүлэх, авлигын шалтгаан, нөхцөл, үр дагавар, хохирлыг тодорхойлох үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх болно.

Элчин сайдын яам болон донор байгууллагууд конвенцыг хэрэгжүүлэх нь

Конвенцын дагуу гишүүн орнууд хөгжиж буй улс орнуудтай хамтын ажиллагааг эрчимжүүлж авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх хүчин чадлыг нэмэгдүүлэхийг даалгадаг. Гэвч аливаа улс орны шийдвэр гаргах түвшний албан тушаалтнууд дээрх зорилгод хүрэхэд шаардлагатай үйл ажиллагааг тодорхойлж, хэрэгжүүлэх хэрэгтэй байдаг. Харин донор байгууллагууд конвенцын хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсөл, хөтөлбөрийг тухайн улсын эрх бүхий байгууллагатай хамтран хэрэгжүүлэх боломжтой байдаг. Түүнчлэн конвенцын хэрэгжилтийн тайланг үнэлэхэд улс орнууд өөрсдийн тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, өргөн хүрээтэй хариу арга хэмжээ авдаг болно.

Авлигын эсрэг конвенц нь техникийн туслалцааны орчин болох нь

АЭНҮБК нь гишүүн орнуудад техникийн туслалцаа үзүүлэх эрх зүйн орчныг бий болгодог. Элчин сайдын яамд болон донор байгууллагууд нь богино хугацааны үнэлгээ хийж төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх зорилго, шаардлагыг тодорхойлох, эсхүл, урт хугацааны санаачилга гаргаж авлигыг бууруулах чиглэлд шат дараатай үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжтой.

Иргэний нийгмийн байгууллагын хамтын оролцоо

АЭНҮБК-ын эвсэл буюу дэлхийн 350 гаруй төрийн бус байгууллагын нэгдэл нь конвенцын хэрэгжилтийг хянах зорилгоор Австри улсын Вена хотноо байрлан ажиллаж байна. Ингэхдээ иргэний нийгмийн байгууллагын оролцоог хангаж, тус байгууллагуудын олсон сайн туршлага,

судалгааны үр дүнг гишүүн орнуудтай хуваалцдаг байна. Эвсэл нь үндэсний иргэний нийгмийн байгууллагуудад техникийн болон санхүүгийн дэмжлэг олгож конвенцын хэрэгжилтийн үнэлгээг боловсруулахад туслалцаа үзүүлдэг. Цаашлаад, Вена хотноо байрлаж гишүүн орнуудын төлөөлөгчидтэй санал солилцох байдлаар авлигатай тэмцэх ажиллагааг эрчимжүүлж ажилладаг.

Авлигын эсрэг конвенцын давуу ба сул тал

Боломж

1. АЭНҮБК дэлхийн ихэнх улс оронд хүчин төгөлдөр хэрэгждэг бөгөөд хамтын ажиллагааны олон улсын эрх зүйн баримт бичиг болохоос гадна эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх, хулгайлагдсан хөрөнгийг буцаах болон улс орнуудын хооронд улс төрийн хэлэлцээр хийх үндэс болдог;
2. Конвенцын хүрээнд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн авлигын хэлбэрийг тодорхойлж нэг эрх зүйн баримт бичиг дор зохицуулснаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд тулгамдаж байсан асуудлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээг оновчтой байдлаар зохицуулсан;
3. Олон улсын түвшинд сайн туршлага, мэдээлэл солилцох орчныг бий болгосноор авлигын эсрэг олон улсын түвшинд хэрэгжүүлэх арга хэмжээг нэгтгэсэн;
4. Конвенцын хэрэгжилтийг дүгнэх нь тухайн улс оронд тулгамдаж буй асуудлыг тодорхойлж хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээг санал болгож, авлигын эсрэг үйл ажиллагааг эрчимжүүлэх давуу талтай;
5. Олон улсын түвшинд авлигын эсрэг хэлэлцүүлэг, форум, уулзалт зохион байгуулах эрх зүйн баримт бичиг болж олон улсын бусад хамтын ажиллагааг өргөжүүлэх үндэс суурь болдог.

Хүндрэл бэрхшээл

1. АЭНҮБК-ын хүрээнд хийгдэж буй уулзалт, хэлцэл нь “Венийн хүсэл эрмэлзэл” буюу тодорхой ойлголцолд хүрэх бус санал зөрөлдөх асуудалгүй болох зорилготойгоор ихэвчлэн хийгддэг учраас зарим гишүүн орнуудад хүсээгүй үүрэг, даалгавар оногдуулах сул талтай. Үүнээс шалтгаалж конвенцын ил тод байдал, эгэх хариуцлагын хангалтгүй байдал бий болж, иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоо улам бүр хумигдаж байна. Тухайлбал, конвенцын хэрэгжилтийг дүгнэж буй улс орнуудыг нууцлах, улс хоорондын харилцаанаас шалтгаалж конвенцыг хэрэгжүүлэх ажиллагааг царцаах зэрэг асуудал тулгамдсаар байгаа юм.
2. АЭНҮБК нь авлигатай тэмцэх иж бүрэн стратеги төлөвлөгөө бус харин авлигын эсрэг хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны нэгдэл юм. Авлигын эсрэг шинэчлэл хийхэд тухайн улсад тохирсон онцгой төлөвлөгөө, хөтөлбөр шаардлагатай байдаг билээ. Гэвч дээр дурдсанчлан конвенцын хэрэгжилтийн тайланг дүгнэх үед ийнхүү хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох боломжтой юм. Хэдийгээр АЭНҮБК нь авлигын эсрэг үйл ажиллагааны суурь эрх зүйн баримт бичиг боловч улс орон бүр өөрсдийн нөхцөл байдал, онцлогт тохирсон төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай.
3. Конвенц нь асуудлыг нуун далдлах зорилгоор ашиглагдаж болзошгүй юм. Тухайлбал, зарим улс орнууд конвенцын хэрэгжилттэй холбогдуулан улс төрийн өрсөлдөгч, эсхүл, донор байгууллагын үйл ажиллагааг шүүмжлэх тохиолдол байдаг.

Австрали ба далайн орнууд

Өмнөд Австралийн Авлигатай тэмцэх комиссарын эрх хэмжээг бууруулсан “ер бусын” хууль батлагдлаа⁸

2021.09.23. Өмнөд Австралийн Авлигатай тэмцэх бие даасан хороо (Independent Commissioner Against Corruption)-ны тухай хуульд оруулсан өөрчлөлтийг 09 дүгээр сарын 23-ны өдөр тус улсын парламент батлав.

Парламентын гишүүн Франк Пангаллогийн өргөн барьсан уг хуулийн төсөл нь тус мужийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны эрх мэдлийг бууруулах болно гэж тус хорооны дарга Энн Вэнстоун (Ann Vanstone) хэлсэн юм.

Түүний хэлснээр тус хороо нь зөвхөн авлигын хэргийг мөрдөн шалгах бөгөөд албан тушаалын байдал, эрх мэдлээ урвуулан ашигласан хэргийг шалгах боломжгүй болжээ. Комиссар Вэнстоун уг үйл явцыг “ер бусын” гэж тодорхойлов.



Өмнөд Австралийн Авлигатай тэмцэх бие даасан хорооны комиссар Энн Вэнстоун.
(ABC News: Майкл Клементс)

Ази тив

Японы засгийн газар ажлын байрны дарамтын эсрэг шийтгэлийг чангаруулна⁹

2020.03.08. Япон улс ажлын байрны дарамт, эрх мэдлээ урвуулан ашигласан төрийн албан хаагчдад хатуу шийтгэл ногдуулахаар төлөвлөж буй талаар эх сурвалжууд мэдээллээ.

Сэтгэл санааны хохиролд хүргэсэн ноцтой тохиолдолд буруутай төрийн албан хаагчийг ажлаас халах хүртэл арга хэмжээ авахаар Үндэсний хүний нөөцийн агентлаг (National Personnel Authority) төлөвлөж байна.

Уг хуулийн зохицуулалт нь ирэх 06 дугаар сараас хэрэгжиж эхэлснээр ажлын байран дахь дарамт шахалтаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах үүргийг томоохон компаниудад ногдуулах юм. Зөрчсөн компанид торгуулийн арга хэмжээ ногдуулахаар төлөвлөж байна.

Өнгөрсөн оны 03 дугаар сард дуусгавар болсон 2018 оны санхүүгийн жилд ажлын байрны дарамт шахалтын талаар төрийн албан хаагчдаас зөвлөгөө авахаар хамгийн олон буюу 230 хүсэлт хүлээн авсны дараа энэхүү алхмыг хийж байгаа юм.

Уг зохицуулалттай холбоотойгоор ажлын байран дахь дарамт нь зөвхөн нэг ажлын орчинд үүсэхээс гадна бусад байгууллагуудыг дамнасан шинжтэй байж болно гэж Үндэсний хүний нөөцийн агентлагаас мэдэгдэж байгаа юм.

Төрийн үйлчилгээ авж буй хүмүүсийн гаргаж байгаа үл хүндэтгэсэн үйлдэл нь төрийн албан хаагчдын хувьд мөн ажлын байран дахь дарамт гэж үзэхээр байна.

Үндэсний хүний нөөцийн агентлаг дарамт шахалтаас хамгаалах зорилгоор зөвлөгөө өгөх системээ боловсронгуй болгох, албан хаагчдаа сургахыг бусад төрийн байгууллагуудад уриалахаар төлөвлөж байгаа юм.

⁸ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.abc.net.au/news/2021-09-23/sa-icac-bill-passes-parliament/100487668>

⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.japantimes.co.jp/news/2020/03/08/national/social-issues/japan-power-harassment-penalties/#.XmhJqKgzblV>

Авлигатай тэмцэх хорооны ёс зүйн дүрэм бусад байгууллагатай хамтран ажиллахыг дэмжинэ¹⁰

2020.03.09. Индонезийн Авлигатай тэмцэх хороо (АТХ)-ны Хяналтын зөвлөлөөс бусад байгууллагатай хамтран ажиллахыг дэмжсэн агуулга бүхий тус хорооны ёс зүйн дүрмийн төслийг шинэчлэн боловсруулаад байна.

Шинэчилсэн ёс зүйн дүрэм нь 10 дугаар сард баталсан АТХ-ны шинэ хуультай нийцэж байгаа хэмээн Хяналтын зөвлөлийн дарга Тамбак Хаторанган Панггабин (Tumpak Hatorangan Panggabean) мэдэгдсэн юм. АТХ-ны шинэ хуульд үндэсний хэмжээнд бусад байгууллагатай түншлэх, хамтран ажиллах, хяналт тавих, хамтран үйл ажиллагаа явуулах асуудлыг зохицуулсан байдаг.

Өмнө нь АТХ-ны ёс зүйн дүрэмд шашин шүтлэг, шударга байдал, ёс зүй, мэргэжлийн ур чадвар болон манлайллын асуудлууд тусгагдсан байсан юм.

Шинэчилсэн Ёс зүйн дүрмийн төсөлд нууц мэдээллээс бусад асуудлаар бусад байгууллагаас мэдээ, мэдлэг олж авах, мэдээлэл солилцох, хамтран ажиллах асуудлыг тусгасан байна.

Мөн шинэчилсэн дүрэмд АТХ-ны удирдлага болон албан хаагчтай холбоотой ёс зүйн аливаа зөрчил, мэдээллийг шалгах, хэлэлцэхтэй холбоотой Хяналтын зөвлөлийн чиг үүргийг тусгайлан зааж өгсөн байна. Харин Хяналтын зөвлөл дэх ёс зүйн зөрчлийн асуудлыг Авлигатай тэмцэх хорооны Ёс зүйн зөвлөлийн дээд зөвлөлөөр хэлэлцэх аж.

Шинэчилсэн ёс зүйн дүрмийг хяналтын зөвлөл зөвшөөрөн, дэмжсэн бөгөөд Хууль, хүний эрхийн яаманд хүргүүлж баталгаажуулахаар болсныг АТХ-ны дарга Фирли Бахури (Firlir Bahuri) мэдэгдэв.

АТХ-ны шинэ хуулийн дагуу байгуулагдсан Хяналтын зөвлөл нь утас чагнах, хөрөнгө хураах, нэгжлэг хийх зөвшөөрөл олгох, түүнчлэн мөрдөн шалгах ажиллагаанд хориг тавих эрхтэй юм. Харин энэхүү хориг тавих эрх нь мөрдөн шалгах ажиллагааг удаашруулах боломжтой гэж шүүмжлэгдээд байна.

Сонгуулийн ерөнхий хорооны комиссар Вахью Сетиаван (Wahyu Setiawan), Индонезийн Ардчилсан намын улс төрч Харун Масику (Harun Masiku) нарын холбогдсон сүүлийн үеийн хахуулийн нэгэн хэргийг мөрдөн шалгах үеэр Хяналтын зөвлөл нэгжлэг хийх зөвшөөрлийг хойшлуулсан явдлыг шүүмжилж, ил тод байдал хангалтгүй байна гэж үзжээ.

Авлигын эсрэг амжилттай түүх: Энэтхэгийн Аам Аадми нам Дели хотын улс төрийг цэвэрлэжээ¹¹

2020.03.09. Энэтхэг улс түүхэндээ хамгийн том авлигын эсрэг арга хэмжээг 2011 онд эхлүүлж, хэдэн зуун мянган хүн авлигын эсрэг жагсаж, парламентад хэдэн арван жил дарагдсан авлигын эсрэг үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэхийг шахаж эхэлсэн.

Хэдийгээр уг жагсаал цуглаан нь төдийлөн амжилттай болоогүй ч уг хөдөлгөөнөөс шинэ улс төрийн нам болох Аам Аадми (Aam Aadmi Party) үүссэн. Аам Аадми нам (ААН) 2013 онд байгуулагдаж, үндсэн зорилгоо авлигыг арилгахад чиглүүлэн, Энэтхэгийн засгийн газрыг цэвэрлэнэ гэдэг утгаар хог шүүрддэг шүүрийг намынхаа билэгдлээр сонгожээ.

ААН анхны ялалтаа 2015 онд авж, Энэтхэгийн нийслэл Дели хотын улс төрийн сонгуульд давуу ялалт байгуулжээ. Үүний дараа ААН 19 сая хүн амтай хотыг удирдаж чадах эсэх, авлигын эсрэг арга хэмжээ авж намынхаа зорилгыг биелүүлж чадах эсэхэд маш олон хүн эргэлзэж байсан юм.

Тус намын амжилтын зам дардан байсангүй, эхний хэдэн сард нам доторх үл ойлголцлын улмаас үйл ажиллагаа зогсонги байдалд хүрч байсан ч эдгээр асуудлыг даван туулж, 2020 оны 02 дугаар

¹⁰ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.thejakartapost.com/news/2020/03/05/kpks-new-code-of-ethics-promotes-synergy-with-other-institutions-supervisory-council.html>

¹¹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/03/09/an-anticorruption-success-story-indias-aam-aadmi-party-has-made-delhi-politics-much-cleaner/#more-15493>

сарын сонгуульд чадварлаг ялалт байгуулан ирэх 5 жилд ажиллах олонхын саналыг авж чадсан юм.

Намын амжилтын гол хүчин зүйл нь боловсролын салбарт зарцуулах мөнгөний хэмжээг нэмэгдүүлж, цахилгааны болон усны үнийг багасгах бодлого байсан юм. Мөн сонгуулийн санал хураалтад амжилт гаргасан явдал нь авлигын эсрэг боловсруулсан мөрийн хөтөлбөртэй нь шууд холбоотой. Хэдийгээр авлигын эсрэг үйл ажиллагааны амжилтыг хэмжихэд хэцүү ч улс төрийн бохирдлыг цэвэрлэхээр хийсэн ААН-ын томоохон алхмуудыг илтгэх 2 үндсэн баримт байна. Үүнд:

- *Нэгдүгээрт*, Дели хотын улс төрд ААН орсноор улс төрчдийн хэтэвчнийхээ хэмжээгээр өрсөлдөх байдал үгүй болсон. Үүнийг сонгуульд нэр дэвшигчдийн хөрөнгө, орлогын мэдүүлгээс харах боломжтой. Нэр дэвшигчид олон удаа дараалан сонгуульд өрсөлддөг тул улс төрийн албан тушаал хаших хугацааны өмнөх болон дараах хөрөнгийг харьцуулан үзэж болох юм. Жишээ нь: 2008 оны сонгуульд нэр дэвшиж байсан 66 улс төрчийн 5 жилийн дараа буюу 2013 оны сонгуульд нэр дэвшихдээ гаргасан хөрөнгө, орлогын мэдүүлгээс харахад 5 жил улс төрийн албан тушаал хашсаны дараа хөрөнгө, орлого нь санаанд багтамгүй буюу дунджаар 259% (7.53 крор буюу 1.05 сая ам.доллар)-аар өссөн байна.

Харин 2020 онд ААН-ыг улс төрд орсноос хойш гаргасан хөрөнгө, орлогын мэдүүлэгт дунджаар 13% (92.12 лах буюу 129 ам.доллар)-аар өссөн нь намын авлигын эсрэг үйл ажиллагаа Дели хотын засгийн газар, улс төрд амжилттай хэрэгжиж буйн нэг жишээ болж байна.

- *Хоёрдугаарт*, Энэтхэгийн Төв хянан шалгах хорооноос хийсэн судалгаагаар 2015-2016 оны хооронд авлигын талаарх өргөдөл, гомдол 81%-аар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь ААН Дели хотод эрх барьж эхэлсэн эхний жилийн үзүүлэлт юм. Мөн Дели хотын хэмжээнд авлигын тохиолдол 2015 онд 31 байсан бол 2017 онд 9 болж буурсан байна. ТИ байгууллагын 2019 оны судалгаагаар Дели хот Энэтхэг улсын хэмжээнд хамгийн бага авлигын үзүүлэлттэй хотын нэгээр шалгарсан байна.

ААН Дели хотын авлигыг бүрэн арилгаагүй ч бодит өөрчлөлт хийсэн болохыг баримт харуулж байна.

Дели хотын хувьд ААН-ын гол өрсөлдөгч нь BJP (Bharatiya Janata Party) бөгөөд тус намаас нэр дэвших улс төрчдийн хувьд 2013 онд хөрөнгө, орлого нь 313%-ийн өсөлттэй байсан бол 2020 онд ердөө 14%-аар өссөн гэж мэдүүлсэн байна. Улс төрчид авлигад өртөх үзэгдэл харьцангуй багассан ба ААН улс төрийн эрүүл тогтолцоог бий болгож буйг харуулж байна. Энэ жишээгээр, зөвхөн Энэтхэг гэлтгүй, дэлхийн бусад улс орнууд ч улс төрийн авлигыг багасгах боломж байгаа нь харагдаж байна.

Энэтхэгийн зарим их сургууль тус улсын Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарахаар болов¹²

2020.04.30. Энэтхэгийн Дээд шүүхийн шийдвэрээр тусгайлан нэр заасан зарим их сургууль 1988 онд батлан гаргасан Авлигын эсрэг хуулийн үйлчлэлд хамаарах субъект болж байна. Энэхүү Авлигын эсрэг хуулиар хахууль болон авлигын гэмт хэргүүдийг эрүүгийн хэрэгт тооцож ял оноодог. Түүнчлэн тэдгээр нэр заагдсан их сургуулийн аливаа албан тушаалтан, ажилтан нь нийтийн албан тушаалтан гэж тооцогдохоор болж байна.

Хахуулийн хэрэгт холбогдсон их сургуулийг гэм буруугүй гэж үзсэн Гужарат мужийн Хяналтын шатны шүүхийн шийдвэрийг Дээд шүүхийн 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хуралдаанаар хянан үзээд энэхүү шийдвэрийг гаргажээ.

¹² Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.indiatoday.in/education-today/news/story/deemed-universities-will-now-fall-under-ambit-of-anti-corruption-act-1988-sc-1672914-2020-04-30>

Монгол Улс авлигатай тэмцэхийн тулд хэвлэл мэдээллийн шинэчлэл хийхийг Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллага уриалав¹³



2020.06.02. Удахгүй болох УИХ-ын сонгуульд оролцох улс төрийн нам, нэр дэвшигчдэд хандан авлигатай тэмцэхийн тулд хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг дэмжих амлалт өгөх, хэвлэл мэдээллийн шинэчлэл хийхийг Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагаас уриалсан байна.

Монгол Улс эрх чөлөөний зарчим, олон ургалч хэвлэл мэдээллийг хүлээн зөвшөөрдөг ч тус улсын хууль эрх зүйн орчин нууц эх сурвалжийг хамгаалах явдал хангалтгүй, мөн гүтгэхтэй холбоотой одоогийн зохицуулалт нь сэтгүүлчдэд цензур тавих, улмаар торгох ял оногдуулах зэрэгт хүргэдэг юм.

Монгол Улс нь Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний 2020 оны индексээр 180 улсаас 73 дугаарт эрэмбэлэгдэж байна.

Уг уриалгыг бүрэн эхээр нь Өнөөдөр сонинд монгол хэлээр, UB Post сонинд англи хэлээр нийтэлсэн гэжээ.

Йордан улс Авлигатай тэмцэх газрынхаа бүрэн эрхийг өргөжүүлэв¹⁴

2020.06.14. Йорданы засгийн газраас авлигатай тэмцэх хууль эрх зүйн арга хэмжээг чангатгаж, татвар хураалт болон татвараас зайлсхийхээс сэргийлэх талаар илүү их хүчин чармайлт гарган ажиллахаа ням гарагт мэдэгдлээ.

Шударга байдал, Авлигатай тэмцэх хорооны хууль (Integrity and Anti Corruption Commission Law)-д 2020 онд оруулсан нэмэлт өөрчлөлтүүд нь болзошгүй гэмт хэргийг илүү өргөн цар хүрээтэй шалгахад Авлигатай тэмцэх хороонд бие даасан байдал болон эрх зүйн хувьд дэмжлэг үзүүлэх болно гэж засгийн газрын хэвлэлийн бага хурал дээр мэдэгдсэн юм.

Уг хуулийн гол нэмэлт өөрчлөлт нь Йорданы Шударга байдал, Авлигатай тэмцэх хороо (ШБАТХ)-ны засгийн газраас хараат бус, санхүүгийн болон засаг захиргааны хувьд бие даасан байдлыг илүү нэмэгдүүлж, саяхан батлагдсан Эдийн засгийн гэмт хэргийн тухай хуулийн дагуу авлигын хэргийг шүүж, шийдвэрлэх эрх мэдлийг тус хороонд олгож байгаа явдал юм.

Парламентаар батлуулахаар өргөн барьсан уг хуулийн өөрчлөлтийн дагуу ШБАТХ нь мөнгө угаах, татвараас зайлсхийх, ашгаа нуун дарагдуулсан зохисгүй үйлдэл зэргийг бие даан мөрдөн шалгах эрхтэй болох бөгөөд мөнгө завшсан хувь хүн болон бүлгүүдийн хэргийг мөн бие даан шийдвэрлэх боломжтой болох юм.

¹³ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://rsf.org/en/campaigns/mongolia-rsf-calls-media-reform-tackle-corruption>

¹⁴ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.thenationalnews.com/world/mena/jordan-expands-powers-of-anti-corruption-agency-1.1033627>

Энэхүү нэмэлт өөрчлөлтүүд нь тус хороонд улс төрийн авлига, түүний дотор хахууль, зохисгүй бэлэг, хөнгөлөлт үзүүлэх зэрэг асуудлыг шалгахад чиглэсэн хууль эрх зүйн дэмжлэг, арга замыг улам бүр нэмэгдүүлэх болно.

Хуулийн өөрчлөлтийн зарим хэсэг нь төрийн албан хаагч албан тушаалын байдлаа урвуулан ашиглах болон хувийн ашиг сонирхлын үүднээс бусдын эрх мэдлийг урвуулан ашиглах явдлыг илрүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхэд чиглэсэн.

“Нөлөөллийг урвуулан ашиглах гэдэг нь ажил, үйлчилгээ, гэрээ, нийлүүлэлтийн тендер, эсвэл аливаа шийдвэр гаргахад давуу тал олгохын тулд төрийн албан тушаалыг ашиглах явдал юм” гэж Йорданы Хэвлэл мэдээллийн сайд Амжад Адаиле (Amjad Adaileh) хэлсэн юм.

Энэ нэмэлт өөрчлөлтийн дагуу ШБАТХ нь албан тушаалтан, хувь хүн болон бүлэглэлүүдийн өмч хөрөнгө, түүнд орсон гэнэтийн өөрчлөлт, эргэлзээтэй байдлаар ашиг олж байгаа эсэхийг хянах боломжийг олгоно.

Засгийн газар татвар хураах үйлчилгээг өргөжүүлж, татвараас зайлсхийсэн хүмүүсийг илрүүлэх зорилгоор хяналт шалгалт хийж байгаа талаар мэдэгдэв. Сангийн сайд Мохаммад Ал Иссисс (Mohammad Al Ississ) шинэ төрлийн татвар бий болгохгүй, дундаж орлоготой иргэдэд ногдох татварыг нэмэхгүйгээр төсвийн орлогыг нэмэгдүүлж, түүний алдагдлыг арилгах нь энэ нэмэлт өөрчлөлтийн гол зорилго хэмээжээ.

Орлогын албан татварыг 2019, 2020 онд удаа дараа нэмэгдүүлж, хувь хүний орлогын албан татварыг хөнгөлөлтгүй болгосны дараагаар засгийн газар корпорацуудаас орлогын албан татвар хураах үйл ажиллагаанд анхаарлаа хандуулаад байна.

Йордан даяар 2018 онд хийгдсэн судалгаагаар дор хаяж 132 мянган компани татвараас зайлсхийх ямар нэгэн оролдлого хийдэг болохыг тогтоосон бөгөөд үүний хохирол нь нэг жилд 100-200 сая ам.доллар ба түүнээс ч их байж болно хэмээн тооцоолж байна. КОВИД-19 цар тахал эдийн засагт нөлөөлөхөөс өмнө Йордан улсын өр ДНБ-ий 96%-тай тэнцэх хэмжээтэй байсан ба 1.2 тэрбум ам.долларын төсвийн алдагдалтай тулгарч, улсын зардлыг багасгахын төлөө тэмцэж байжээ.

[Төрд 100 тэрбум ба түүнээс дээш рупигийн хохирол учруулсан этгээдэд бүх насаар нь хорих ял оногдуулж байх тухай шийдвэрийг Индонез улсын Дээд шүүх гаргажээ¹⁵](#)

2020.08.03. Төрд учирсан хохирлоос шалтгаалан дээрх шийтгэлийг ногдуулж байх тогтоолыг даргалагч шүүгч Мухаммад Сярифуддин (Muhammad Syarifuddin) шийдвэрийг баталжээ. Улсад хохирол учруулсан тохиолдолд уг тогтоолын дагуу доод тал нь 10 жилийн хорих ял ногдуудах аж. Авлигын улмаас төрд 25-100 тэрбум рупигийн хохирол учирсан нөхцөлд 8-16 жилийн хорих ял ногдуулна. Тогтоолыг ирэх долоо хоногоос хэрэгжүүлнэ хэмээн тус Улсын Дээд шүүхийн хэвлэлийн төлөөлөгч Энди Самсан Нганро (Andi Samsan Nganro) мэдэгдэв. Хэдийгээр энэхүү тогтоол нь төрд хохирол учруулаагүй зарим гэмт хэрэгт хамааралгүй боловч Авлигатай тэмцэх хороо тус зохицуулалтыг сайшаасан байна. *“Сайн ч бай, муу ч бай энэхүү шинэ зохицуулалт авлигын эсрэг арга хэмжээнд*



Ерөнхий шүүгч Мухаммад Сярифуддин Дээд шүүхийн байранд цацагдаж буй видео бичлэг дээр харагдаж байна. (Фото: Антара/Хафидз Мубарак)

¹⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://jakartaglobe.id/news/supreme-court-encourages-judges-to-deliver-life-sentence-in-major-graft-cases>

түлхэц өгнө” хэмээн Авлигатай тэмцэх хорооны хэвлэлийн төлөөлөгч Али Фикри (Ali Fikri) мэдэгдэв. Энэхүү тогтоолыг боловсруулахад тус хороо мөн оролцсон ба одоогийн байдлаар тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгууллагын дотоод зохицуулалтыг боловсруулна хэмээн тэрээр нэмж хэлэв.

Авлигын хэрэгт ногдуулж буй шийтгэл харилцан адилгүй, анхан шатны, хяналтын шатны болон Дээд шүүхийн шийдвэрүүд эсрэг тэсрэг гардаг байсныг энэхүү зохицуулалт нэг мөр болгоно хэмээн эрх зүйн шинжээч Абдул Фикар Хаджар (Abdul Fickar Hadjar) онцолсон байна. Ямар нэгэн зохицуулалт байхгүй, шүүхийн тогтолцоо авлигад автсан зэргээс шалтгаалан шүүгчийн гаргасан шийдвэр харилцан адилгүй байдаг байсан. “Нэг хэргийн талаар шүүгчид өөр өөр шийдвэр гаргадаг мөнгөний хүчин зүйл чухал үүрэг гүйцэтгэдэг” хэмээн Трисаки их сургуулийн хуулийн багш мэдэгдэв.

Индонез улсын Эрүүгийн хуулиар бүх насаар хорих ял ногдуулахыг зөвшөөрдөг ч практикт ийм шийдвэр гаргах нь ховор байдаг. Жакарта хотын шүүхээс 2014 онд Үндсэн хуулийн шүүхийн дарга асан Акил Мохтар (Akil Mochtar)-m бүх насаар нь хорих ял оноосон нь хамгийн сүүлийнх байсан юм.

Бизнесийн салбар дахь авлигатай тэмцэнэ¹⁶

2020.08.04. Малайз улсын Авлигатай тэмцэх хороо (АТХ)-ноос тус улсын бизнесийн салбар дахь авлигын асуудал сэтгэл түгшээж буй талаар удаа дараа мэдээлж байсан. 2019-2020 онд бизнесийн салбарын 390 этгээдийг баривчилсан нь нийт баривчлагдсан этгээдийн 26.1 хувийг эзэлж байна. 2020 онд арилжааны байгууллагуудтай холбоотой 800 гаруй этгээдийг баривчилж, тэрбум гаруй рингитын¹⁷ хууль бус орлогыг битүүмжилжээ. Хувийн салбар дахь авлигатай тэмцэхтэй холбоотойгоор хуульд орсон гол өөрчлөлт нь АТХ-ны тухай хуулийн 17А дугаар зүйл юм. Үүнд бизнесийн байгууллага авлигаас урьдчилан сэргийлэх үүргээ биелүүлээгүй бол эрүүгийн хариуцлага ногдуулахаар заасан. Тус хуулийн 17А дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “а) арилжааны байгууллагын этгээд бизнесийн үйл ажиллагаа эрхэлж эхлэх, эсхүл, эрхэлж буй бизнесийн үйл ажиллагаагаа хэвээр хадгалах; эсхүл, б) давуу байдлаар бизнесээ эрхлэн явуулах, давуу байдлаа хадгалах зэрэг зорилгоор аливаа этгээдэд шан харамж өгөх, өгөхийг зөвшөөрөх, өгөхийг амлах” асуудлыг гэмт хэрэгт тооцно. Үүний дагуу захирлууд, хамтран эзэмшигчид, арилжааны байгууллага, компанийн удирдлагууд өөрийн байгууллагын албан хаагчдаа авлигын аливаа үйлдэлд оролцуулахгүйн тулд байгууллагадаа авлигын үйлдлийн эсрэг зохих дүрэм, журмыг хэрэгжүүлж буйгаа нотлох ёстой болсон.

Малайзын АТХ-ны үзэж байгаагаар энэ зүйл заалттай холбоотойгоор бизнесийн авлигын талаарх мэдээлэл нэмэгдэх болно. Тухайн улсын болон гадаадын бизнесийн байгууллагууд сайн засаглалыг хэрэгжүүлснээр Малайзын АТХ-ны энэхүү хүчин чармайлтыг дэмжих болно гэж итгэж байгаа юм. Авлигын эсрэг соёлыг дэмждэггүй компаниуд ашгийн 5 хүртэлх хувийг алдах болно хэмээн Санхүүгийн гэмт хэргийн мэргэшсэн шинжээчдийн холбооны 2020 оны тайланд дурдсан байна. Иймд хахууль, авлигаас урьдчилан сэргийлэхэд компаниуд анхаарах хэрэгтэй болж байна. Ингэснээр тэд ашгийнхаа 2-3 хувиа алдахгүй байж чадна хэмээн АТХ үзэж байна.

БНХАУ-д мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг эрчимжүүлж байна¹⁸

2020.09.01. БНХАУ-д 2020 оны эхний хагас жилийн байдлаар мөнгө угаах хэрэгт 370 сая юань /54 сая ам.доллар/-ийн торгууль оногдуулсан нь 2019 оны бүтэн жилийн байдлаарх хэмжээнээс их байна.

Энэ нь торгуулийн тогтолцоо өөрчлөгдсөнтэй холбоотой бөгөөд өмнө нь мөнгө угаах хэрэгт бүхэлд нь нийт дүнгээр торгууль оногдуулдаг байсан бол одоо уг хэргийн үйлдэл бүрд торгууль оногдуулдаг болжээ. Түүнчлэн торгуулийн хэмжээг хязгаарлаагүй байна.

¹⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.thestar.com.my/opinion/letters/2020/08/04/fighting-private-sector-corruption>

¹⁷ Малайзын мөнгөн тэмдэгт, 1 рингит 0.238207 ам.долларын ханштай.

¹⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://ekd.me/2020/09/novosti-kitaya-utro-borba-s-otmyvaniem-deneg-i-gazoximiya-v-rossii/>

Дээрх шийдвэр гарахын өмнө энэ гэмт хэрэгт оногдуулж байсан торгуулийн дээд хэмжээ 100 сая юань /14.5 сая ам.доллар/ байв.

Тус улс Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульдаа нэмэлт өөрчлөлт оруулахаар бэлтгэж байгаа бөгөөд уг өөрчлөлтөд мөнгө угаах гэмт хэргийн талаарх ойлголтыг дэлгэрүүлэх, оногдуулах шийтгэлийг чангатгах саналыг тусгахаар төлөвлөжээ. 2018 оноос БНХАУ-д хэрэгжүүлж эхэлсэн зохион байгуулалттай гэмт хэргийг таслан зогсоох үйл ажиллагааны хүрээнд мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх явдалд чухал ач холбогдол өгсөн.

Тус улсад 2018 оноос хойш зохион байгуулалттай гэмт хэргийн 3,291 бүлэглэл, 10,418 гэмт бүлгийг устгаж, гэмт бүлэглэлийн 411 мянган гишүүнийг хяналтдаа авсан байна.

**Бүх нийтийн хөрөнгө, орлогын мэдүүлэг нь
Казахстан улсын авлигын асуудлыг
шийдэж чадахгүй¹⁹**

2020.09.21. Jason Kohn. 2019 оны 03 дугаар сард Кассым-Жомарт Токаев олон жил ажилласан Ерөнхийлөгч Нурсултан Назарбаевыг орлож, тусгаар тогтносон Казахстан улсын хоёр дахь төрийн тэргүүнээр сонгогдсон. Ерөнхийлөгч Токаев Казахстан улсын авлигын асуудлын цар хүрээг хүлээн зөвшөөрсөн бололтой авлигатай тэмцэх ажлыг мөрийн хөтөлбөрийнхөө гол анхаарлын төвд оруулсан. Тэрбээр авлигатай тэмцэх нь нэн тэргүүний зорилт гэдгийг онцолсоор байгаа юм.

Төрийн тэргүүнүүд авлигын эсрэг хоосон үг ярих нь хэвийн зүйл биш хэдий ч үүний талаар арга хэмжээ авалгүйгээр орхидог. Харин Ерөнхийлөгч Токаев энэ асуудалд нухацтай хандаж байна. Сүүлийн жил хагасын хугацаанд Казахстаны засгийн газар авлигатай тэмцэх чиглэлээр хэд хэдэн тодорхой арга хэмжээг авж хэрэгжүүлсэн.

Европын Зөвлөлөөс удирддаг авлигын хяналтын байгууллага болох Авлигын эсрэг улсуудын бүлэгт Казахстан улс 2020 оны 01 дүгээр сард элссэн. Мөн 2019 оны 12 дугаар сард батлагдсан хуулиар доод албан тушаалтнууд нь авлигатай холбоотой хэргээр ял шийтгүүлсэн тохиолдолд төрийн захиргааны удирдах албан тушаалтнуудыг ажлаас нь чөлөөлөх тухай заасан байдаг. Хамгийн сүүлд Ерөнхийлөгч Токаев төрийн өндөр албан тушаалтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдийг гадаадын банканд данс эзэмшихийг хориглох талаар шинэ бодлого хэрэгжүүлэхээ мэдэгдсэн. Түүнчлэн иргэд Казахстаны Авлигатай тэмцэх газрын ажилтнуудтай шууд ярилцах боломжтой “Авлигатай тэмцэх төв”-үүдийг бий болгосон. Эдгээр арга хэмжээ нь Казахстаны авлигын асуудлыг шийдвэрлэхэд үр дүн өгөх эсэхийг харах л үлдлээ.

Эдгээрээс гадна нэг нэмэлт арга хэмжээ нь авлигыг бууруулахад тийм ч их өөрчлөлт авчрахгүй бололтой. Энэ нь Казахстаны засгийн газраас хэрэгжүүлж эхэлсэн бүх нийтийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэ систем юм. Казахстан улс 1996 оноос хойш төрийн албан хаагчдаас хөрөнгө, орлогоо мэдүүлэхийг шаардаж байсан бол шинэ санаачилгаар энэхүү шаардлагыг ойрын хэдэн жилийн хугацаанд Казахстаны бүх иргэд болон гадаадын байнгын оршин суугчдад үе шаттайгаар нэвтрүүлэхээр төлөвлөж байна.

2025 он гэхэд бүх казахстанчууд орлогын албан татварын мэдүүлгээс гадна үл хөдлөх хөрөнгө, автомашин, банкны данс, үнэт эдлэл зэрэг хөрөнгө, өр төлбөрийн үнийн жагсаалтыг мэдүүлэх шаардлагатай болно. Засгийн газрын зүгээс бүх нийтийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэ систем нь далд эдийн засагтай тэмцэх, татварын хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэмэгдүүлэх, авлигыг бууруулахад тусална гэж үзэж байна.

Хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэ системийг татварын бодлогын хувьд эсвэл далд эдийн засагтай тэмцэх арга хэмжээний хувьд зөвтгөж болох хэдий ч цэвэр авлигын эсрэг арга хэмжээ гэж үнэлсэн нь бодлогыг буруу чиглүүлж байгааг илтгэх дараах үндсэн хоёр шалтгаан байна.

Нэгдүгээрт: Хөрөнгөө ил болгох шаардлагыг бүх иргэдэд тавих нь нэмэлт авлигыг илчлэхэд тус болохгүй. Төрийн албан хаагч биш хүмүүсээс хөрөнгө, өр төлбөрөө мэдүүлэхийг шаардах нь авлигын эрэлт талыг илрүүлж чадахгүй. Учир нь тэд хахууль өгөхийг шаардах боломжгүй юм. Жирийн иргэд авлигын “нийлүүлэлт” талд оролцдог боловч замын хөдөлгөөний дүрмийн

¹⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/09/21/universal-asset-declarations-will-not-solve-kazakhstans-corruption-problem/#more-16685>

зөрчлийг дарагдуулахаар цагдаагийн албан хаагчид, эсвэл сайн дүн авахын тулд сургуулийн багшид өгсөн хахууль бага хэмжээний үнийн дүнтэй байдаг тул хөрөнгө, орлогын мэдүүлгээр илрүүлэх магадлал багатай юм.

Хоёрдугаарт: Казахстаны татварын албанаас 400 мянга гаруй төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянаж шалгуулахаар 260 орчим аудитор ажиллуулж байгаа нь судалгаанд хамрагдсан бусад орнуудтай харьцуулахад хамгийн бага байна гэж ЭЗХАХБ 2011 оны тайландаа тэмдэглэжээ. Бүх нийтийн хөрөнгө, орлогын мэдүүлгийн шаардлагыг 2025 онд бүрэн хэрэгжүүлсний дараа мэдүүлгийн тоо жилд сая саяд хүрч, хянаж шалгах ажилтнууд ачаалал ихтэй ажиллах болно. Хэдийгээр аудиторчуудын тоог нэмэгдүүлсэн ч төрийн албан хаагчдын илүү чухал мэдүүлгийг үнэлэх хугацааг барилгын ажилчин, таксины жолооч нарын ирүүлсэн мэдүүлгийг хянахад зарцуулснаар аудиторын тооны өсөлтөөс үүсэх давуу талыг үгүй хийж байна. Энэ нь жинхэнэ авлигач этгээдийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт аудитын шалгалт хийж, илрүүлэх магадлалыг бууруулна.

Узпромстройбанканд авлигын эсрэг шинэ системийг нэвтрүүлнэ²⁰

2020.09.25. Узбекистан. Ташкент. Узпромстройбанк хувьцаат капитал бүхий арилжааны банкны системийн авлигын эсрэг бодлогыг үндсээр нь шинэчлэн, олон улсын стандартад суурилан өөрчлөх гэж байна.

Узбекистан улсын Ерөнхийлөгч Шавкат Мирзиёев энэ оны 01 дүгээр сард хэлсэн үгэндээ нийгмийн бүх гишүүд авлигын эсрэг “шударга ёсны вакцин”-ы дархлаажуулалтгүй байдаг бөгөөд авлигаас цаг тухайд нь урьдчилан сэргийлэхийн оронд авлигын үр дагавартай тэмцэж ирсний улмаас бид зорилгодоо хүрч чадахгүй байна гэжээ.

Узпромстройбанк нь авлигын шалтгаан, нөхцөл байдлыг тодорхойлох, тэдгээрийг устгах үр дүнтэй системийг бий болгох, ажилтнуудын чиг үүрэг, ажлын гүйцэтгэлээс үүдэн гарах авлигын эрсдлийг үнэлэх системийг боловсронгуй болгоход нэн тэргүүнд анхаарч байна.

Энэ зорилгоор БНУУ-ын Авлигатай тэмцэх газар, Хууль зүйн яам, Төв банк зэрэг төрийн байгууллага, Олон улсын стандартчиллын байгууллага гэх мэт олон улсын байгууллагууд, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг гадаадын нэр хүндтэй байгууллагуудад ажиллаж буй элэг нэгтнүүдтэйгээ хамтран 2020-2021 онд далд эдийн засаг, авлигатай тэмцэх, урьдчилан сэргийлэх стратеги төлөвлөгөө боловсруулсан.

Авлигатай тэмцэх зорилгоор тус банканд комплаенсийн хяналтын тогтолцоог нэвтрүүлэх, орчин үеийн мэдээллийн технологийн хэрэглээг цаашид өргөжүүлэх, төрийн худалдан авалт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад ил тод, үр ашигтай системийг нэвтрүүлэх, олон нийтийн хяналтын үр нөлөөтэй хэлбэрийг ашиглан үр ашгийг дээшлүүлэх замаар үйлчлүүлэгчдэд үйлчилгээ үзүүлэх болон ажилтнуудыг ажилд авах зэрэг арга хэмжээг уг стратеги төлөвлөгөөнд багтаасан.

Одоо тус банкны системд авлигын эсрэг тусгай хороо болон тусдаа бүтцийг бий болгож, шардга ёсны стандартыг нэвтрүүлэх ажлыг тогтмолжуулах болно. Одоогийн байдлаар дотоод хяналтын систем (“комплаенсийн хяналт”) болон эрсдлийн удирдлагын үйл ажиллагааг үндсээр нь шинэчилж, одоо мөрдөж буй зохицуулалтын эрх зүйн актуудыг судалж, бодлого, дотоод журам болон бусад зохицуулалтын эрх зүйн актуудыг боловсруулж байна.

Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд авлигын эсрэг комплаенсийн чиг үүргийг хэрэгжүүлж буй ажилтнууд энэ чиглэлээр онолын мэдлэг, практик ур чадвартай байхыг шаарддаг гэдгийг онцлох хэрэгтэй.

²⁰ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: http://www.uzdaily.uz/en/post/60258?fbclid=IwAR1ZQOsS97WbXfNAJ-GjePhwF_gh_PbILHd5bE9rf1dA9hjTtW_HWfEZIRO

Засгийн газрын худалдан авалт дахь авлигыг анхаарах хэрэгтэй гэж МАТХ-ны дарга хэллээ²¹



МАТХ-ны тэргүүн Азам Баки эрх баригчдын ихэнх нь шамшигдуулах, эрх мэдлээ урвуулан ашиглах хэрэгт холбогдсон гэв.

урвуулан ашиглах явдал түгээмэл байна. Засгийн газрын худалдан авалттай холбоотой алдаа дутагдлын улмаас засгийн газрын худалдан авалтын тодорхой зардлыг нэмэгдүүлэхэд хүргэдэг авлигын төрөл байгаа нь бидний мөрдөн байцаалтын үр дүнд харагдлаа” хэмээн тэрээр хэлэв.

Мөн түүний хэлснээр худалдан авалтын дүн нэмэгдэх хэрээр хахуулийн хэмжээ нэмэгдэж байгаагийн дээр төслийн чанарт нөлөөлж байна. Жишээлбэл, Саравак дахь авто замыг шинэчлэх төсөлтэй холбоотой авлигын хэргийн улмаас уг төслийн дагуу сайжруулсан гэх замын чанар нь муудаж эвдрэн, засгийн газарт олон сая рингитийн алдагдал авчирсан.

МАТХ-ны зорилго нь засгийн газрын худалдан авалттай холбоотой хоёр тал (төр ба хувийн хэвшил) -ыг шалгаж, шүүхэд өгөх зорилготой юм.

МАТХ нь авлигатай тэмцэх чиглэлээр хууль сахиулах, урьдчилан сэргийлэх, олон нийтийн боловсролыг багтаасан бүх үйл ажиллагаагаа төлөвшүүлэх хэрэгтэй гэж тэрээр үзсэн.

Өнөө үед КОВИД-19 цар тахалтай нүүр тулах үеийн шинэ хэм хэмжээг судлахын зэрэгцээ ойрын хэдэн жилд авлигаас ангид нийгмийг бий болгох МАТХ-ны тэмцэлд нэлээд бэрхшээл тулгарч болзошгүй гэж тэрээр үзэж байгаагаа илэрхийлсэн.

КОВИД-19 цар тахлаас өмнө МАТХ-ны зүгээс газар дээр нь очиж мэдээлэл хийн, олон нийтийн дунд авлигын эсрэг кампанит ажил явуулж байсан. Харин цар тахлын дэгдэлтээс хойш МАТХ видео болон олон нийтийн сүлжээг ашиглаж иржээ.

Авлигач төрийн албан хаагчид ажлаасаа чөлөөлөгдөж, гэм буруугаас зугтахыг Дутерте зөвшөөрөхгүй²²

2020.10.27. Авлигын хэрэгт холбогдсон төрийн албан хаагч ажлаасаа чөлөөлөгдсөн ч хариуцлагаас зугтаж чадахгүй гэдгийг Филиппиний Ерөнхийлөгч Дутерте санууллаа.

Ерөнхийлөгч Дутерте гэм буруутай төрийн албан хаагчид ажлаасаа чөлөөлөгдсөн ч эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээх боломжтой. Ажлаас гарсан нь хариуцлагаас зугтах нөхцөл болохгүй гэдгийг мэдээлэв.

Филиппиний Эрүүл мэндийн даатгалын корпорацын хэд хэдэн албан хаагч авлигын хэрэгт холбогдсоны дараа өөрсдийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөнтэй холбогдуулж Ерөнхийлөгч Дутерте ийнхүү мэдээлсэн байна.

²¹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.freemalaysiatoday.com/category/nation/2020/10/01/corruption-in-govt-procurement-critical-says-macc-chief/>

²² Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://mb.com.ph/2020/10/27/duterte-wont-allow-corrupt-public-servants-to-resign-to-escape-culpability/>

“Би төрийн албанд ажиллаж буй бүх хүнд сануулъя. Ажлаас гарах нь хариуцлагаас зугтах үндэслэл болохгүй. Хэрэгт холбогдон шалгагдаж байх хугацаанд ажлаас гарах нь хориотой” хэмээн тэрээр мэдэгджээ.

Ерөнхийлөгчийн мэдээлсний дагуу, төрийн ямар ч албан хаагч авлигын хэрэгт холбогдсон тохиолдолд шалгагдаж, баривчлагдаж, эсхүл, хоригдох боломжтой юм.

Ерөнхийлөгч Дутерте төрийн байгууллагад авлига даамжирсан нөхцөл байдалд харамсаж буйгаа илэрхийлж, авлигатай тэмцэх өргөн хэмжээний хяналт шалгалтын ажил хийхийг даалгасан байна.

Хууль зүйн яам энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх, холбогдох албан хаагчдад хариуцлага тооцохоор болжээ. Түүнчлэн тус яамнаас хүсэлт тавьсан тохиолдолд Омбудсмэний алба хянан шалгах юм.



Ерөнхийлөгч Родриго Роа Дутерте 2020 оны 10-р сарын 26-ны өдөр Шинээр гарч буй халдварт өвчний эсрэг агентлаг хоорондын ажлын хэсэг (IATF-EID)-ийн үндсэн гишүүдтэй Давао хотын Матина анклавт уулзсаныхаа дараа ард түмэнтэй ярилцаж байна.

(Фото: Жоей Далумпинс / Presidential photo / Manila Bulletin)

Узбекистан улс ирэх жилээс төрийн байгууллага, бүс нутгийн далд эдийн засаг, авлигын үнэлгээг нэвтрүүлэхээр боллоо²³

2020.11.30. Узбекистан улс 2021 оноос төрийн байгууллага, бүс нутгийн засаг захиргааны авлига, далд эдийн засагтай тэмцэх чиглэлээрх үнэлгээг зохион байгуулж үр дүнг олон нийтэд мэдээлж байхаар болов. Энэ нь тухайн төрийн байгууллага, бүс нутгийн засаг захиргааны удирдлагын хувийн хариуцлагыг мөн дээшлүүлэх ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Энэ үнэлгээг Эдийн засгийн судалгаа, шинэчлэлийн төв (ЭЗСШТ) болон Авлигатай тэмцэх байгууллага хоёр хамтран зохион байгуулахаар болсон байна. Судалгааны мэдээллийг бүх бүс нутагт орон даяар иргэдээс санал асуулга авах хэлбэрээр зохион байгуулах юм байна.

Узбекистан улсын хувьд өнөөдрийг хүртэл олон тооны судалгаа хийгдэж байсан ч гэсэн зөвхөн улсын хэмжээнд зохион байгуулагдаж байжээ. Салбар, бүс нутгийн түвшний судалгаа тогтмол бус, тохиолдлын шинж чанартай байсан ба авлигын асуудлыг цаг хугацааны хувьд харуулах боломжгүй байсан хэмээн ЭЗСШТ-ийн шинжээч Б.Хамидов онцлов.

Авлигыг салбар, бүс нутгийн түвшинд тодорхойлохыг шинэчлэлийн үйл явц шаарддаг. Учир нь авж хэрэгжүүлж буй арга хэмжээг үр ашиггүй болгож байдаг үндсэн хүчин зүйл бол авлига юм. Иймд иж бүрэн арга хэмжээ авахын тулд тухайн салбар, бүс нутагт авлигын түвшин ямар байгаад хариулт авах зайлшгүй хэрэгтэй болдог.

Дэлхийн практикт авлигын түвшнийг үнэлэх олон арга ашигладаг. Энэ нь авлигын асуудал хүнд, нууц, далд байдагтай холбоотой байдаг. Нөгөө талаас, хэмжилтийн олон арга ашиглах нь асуудлыг олон талаас харах боломж олгохоос гадна илүү тодорхой хариулт авах боломжийг бий болгодог. Мөн арга, хэрэгслүүдийг үр ашигтай ашиглах нь тодорхой салбар, бүс нутгийн шинэчлэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийх, үнэлгээ өгөхөд туслалцаа дэмжлэг болдог хэмээн тэрээр нэмж яриув.

Далд эдийн засгийн түвшнийг бууруулснаар бизнест нэмэлт нөхцөл бүрдүүлэхийг зорьж олон төрлийн арга хэмжээ авж байна. Тухайлбал валютын зах зээлийг либералчлах, татварын шинэ тогтолцоо нэвтрүүлэх, 100 орчим төрлийн лиценз, зөвшөөрлийг хүчингүй болгох зэрэг арга

²³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж:

<https://podrobno.uz/cat/obchestvo/v-uzbekistane-zapuskayut-reyting-korrupsii-i-tenevoy-ekonomiki-dlya-gosorganov-i-regionov/>

хэмжээ авсан. Эдгээрийн үр дүнд далд эдийн засгийн хувь хэмжээ сүүлийн 5 жилд 20 хувиас 6 хувь болж буурлаа хэмээн Авлигатай тэмцэх байгууллагын ажилтан У.Номозбаев ярих. Дараагийн 5 жилд далд эдийн засгийг хоёр дахин бууруулах зорилго тавиад байгаа бөгөөд энэ нь тодорхой арга хэмжээ шаардаж байна. Үүний нэг нь авлига, далд эдийн засагтай тэмцэх удирдлагуудын хувийн хариуцлагатай байдлыг дээшлүүлэх асуудал юм. Иймд дараа жилээс эхлэн Авлигатай тэмцэх байгууллага болон ЭЗСШТ бусад төрийн бус байгууллагуудыг татан оролцуулан бүс нутаг, тодорхой салбаруудын нөхцөл байдлыг тогтмол судлах юм. Судалгааны үр дүнгээр тодорхой төрийн байгууллага, төрийн өмчит үйлдвэр, бүс нутгийн авлигын түвшнийг олон нийтэд мэдээлж байх юм хэмээн тэрээр ярих.

Шударга ёсыг хурдавчлах нь: Авлигын эсрэг Энэтхэг улсын шинэ стратеги²⁴

2020.12.11. Laurel Zigerelli. Улс төрчидтэй холбоотой бөгөөд эхнийх нь бараг 40 шахам жил дарагдаж буй авлигын 6,000, эрүүгийн 5,000 хэргийг түдгэлзүүлээд байгаа асуудлыг Та байсан бол хэрхэн шийдвэрлэх вэ? Энэтхэгийн Дээд шүүхийн хувьд улс төрчдөд холбогдох түдгэлзсэн хэргүүдийг нэг жилийн дотор нэг мөр болгон шийдвэрлэх нь хуримтлагдсан асуудлыг шийдэх гарц гэж харж байна.

Дээд шүүхээс өнгөрсөн 09 дүгээр сард “Нийтийн ашиг сонирхлын маргаан”²⁵-ы талаар гаргасан шийдвэр нь шүүх ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх, Энэтхэг улсад өргөн тархаад байгаа улс төрийн авлигыг шийдвэрлэх хууль эрх зүйн тогтолцоог илүү үр дүнтэй болгоход чиглэсэн юм.

Энэтхэг улсын авлигад автсан улс төрчид хууль ёсны мөрдөн шалгах ажиллагааг удаашруулж чаддаг. Жишээ нь, шүүхэд өргөдөл гаргах төвөгтэй дүрэм, журмыг ашиглан хэргүүдийг хэдэн 10 жилээр сунгахад хүргэж байна.

Ингэж хэргийг удаашруулснаар гол нотлох баримтууд алдагдах, эсвэл хэрэг бүрхэг болох магадлалыг нэмэгдүүлдэг. Мөн яллагдагч бусдад хахууль өгөх, айлган сүрдүүлэх, тэр ч байтугай гэрчийг хөнөөх боломжийг олгодог. Авлигад автсан улс төрчид ял шийтгэл авахаас зайлсхийж, бодит байдал дээр ял шийтгэлгүй үлдэх хандлагыг бий болгосон. Энэ асуудал нь одоогийн парламентад хурцаар тавигдаж байгаа бөгөөд 2019 онд шинээр сонгогдсон гишүүдийн 43% нь эрүүгийн хэрэгт татагдсан бөгөөд тэдэнд холбогдох хэргийг түдгэлзүүлжээ. Дээд шүүхийн захирамж нь энэ болон бусад асуудлыг шийдвэрлэх зорилготой юм.

Дээд шүүхээс 2011 онд авлига, хахуульд идэгдсэн Конгресс нам парламентыг удирдаж байх үед улс төрчдийг цаг тухай бүр нь шүүж байхыг уриалсан боловч хэргүүдийн шийдвэрлэлт удааширсаар байв. Гэхдээ энэ үе өөрчлөгдөнө гэдэгт итгэх шалтгаан бий юм.

Одоогийн эрх баригч Бхаратия Жаната нам авлигын эсрэг үйл ажиллагааг нэн тэргүүний үйл хэрэг гэж үзсэн нь тэднийг засгийн эрхийг авахад нөлөөлсөн юм. Авлигатай тэмцэх талаарх Бхаратия Жаната намын гол амлалт нь нэг жилийн хугацаанд авлигын хэргийг шийдвэрлэх тухай Дээд шүүхийн захирамж гарахад нөлөө үзүүлсэн байх магадлалтай юм.

Дээд шүүхийн шийдвэрийн дагуу ихэнх муж улсын Дээд шүүхүүд хэргийг шүүхэд шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө ирүүлсэн бөгөөд Энэтхэг улсын Ерөнхий прокурор шүүх хурлуудыг нэг жилийн хугацаанд хийж дуусгах тал дээр “100% нухацтай”²⁶ хандаж байгаагаа мэдэгдэв.

Энэхүү түргэвчилсэн хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд зарим ноцтой саад бэрхшээл тулгарч байгаа хэдий ч Энэтхэг улсын шударга ёсны төлөө гаргасан тус шийдвэр нь авлигад автсан улс төрчдөд хариуцлага тооцох, шүүх ажиллагаанд итгэх олон нийтийн итгэлийг сэргээхэд хүчтэй нөлөө үзүүлэх болно.

²⁴ Орчуулсан: Р.Энх-Амгалан.Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/12/11/fast-tracking-justice-indias-newish-strategy-to-curb-corruption/>

²⁵ <https://citizenmatters.in/a-guide-to-filing-a-public-interest-litigation-pil-4539>

²⁶ <https://www.thehindu.com/news/national/supreme-court-for-time-bound-trial-of-criminal-cases-against-politicians/article32624000.ece>

Нэг жилийн төлөвлөгөөний үр өгөөжөөс гадна энэхүү нэг жилийн зорилгод хүрэхэд бэрхшээлтэй үндсэн хоёр шалтгаан байна.

- *Шүүхийн байгууллагын нөөцийн хомсдол:* Нэг жилийн хугацаанд зорилгыг хангахад тулгарч буй хамгийн том саад тогтор нь одоогийн шүүхийн дэд бүтэц юм. Дээд шүүхийн захирамжид өнөөгийн шүүх байгууллагын тоо уг хэргүүдийг шийдвэрлэхэд хангалтгүй байгааг тэмдэглэжээ. Энэтхэгт тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн олон зуун тусгай шүүх байдаг ч цөөхөн хэд нь улс төрчдийн авлига болон бусад эрүүгийн хэргийг шийддэг. Зарим муж улсад эдгээр тусгай шүүх байхгүй заримд нь хэтэрхий цөөн байдаг. Тусгай шүүх байдаг мужид ч гэсэн улс төрчдийн авлигын хэргийг шийдвэрлэхэд хэтэрхий хүнд байдаг. Шүүх байгууллагын тоог нэмэгдүүлэхийн тулд аль хэдийн ховор нөөц болсон шүүгчдийн тоог нэмэх шаардлагатай болно. Энэтхэг улс АНУ-аас дөрөв дахин олон хүн амтай боловч шүүгчийн орон тоо нь АНУ-ын шүүгчдийн тооны аравны нэгд ч хүрдэггүй. Шүүгчийн хомсдолыг олон хүн цалин муутай, дэвших боломж хомс байгаатай холбон тайлбарлаж байна. Хэрэв Энэтхэг улс нэг жилийн зорилгоо биелүүлэхийг хүсэж байгаа бол одоо ажиллаж байгаа шүүгчдийн хувьд дэмжлэг тусламж ихээхэн хэрэгтэй болох буй за.
- *Мөрдөн шалгах байгууллагын нөөцийн хомсдол:* Улс төрчдийн авлигын болон бусад гэмт хэргийг мөрдөн шалгах үүрэг бүхий байгууллага болох Энэтхэгийн Тагнуулын төв товчоо (ТТТ) мөрдөн шалгах ажиллагааг цаг хугацаа алдалгүйгээр явуулах гэж ихэд хичээж байна. Хүний нөөцийн болон мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай бусад нөөцийн хомсдол нь нарийн төвөгтэй мөрдөн шалгах ажиллагаа шаардагдах авлигын хэргийг үр дүнтэй шийдвэрлэхэд хүндрэл учруулж байна гэж ТТТ мэдээлсэн. Нэг жилийн хугацаанд хэргийг шийдвэрлэх нь эдгээр асуудлыг улам даамжруулж болзошгүй бөгөөд зарим мөрдөн шалгах ажиллагааг хугацаанаас нь өмнө зогсооход хүргэж болзошгүй юм.

Эдгээр нөөцийн хомсдол нь бэрхшээлийг бий болгож байна. Гэхдээ Энэтхэгт шаардлагатай улс төрийн хүсэл зориг байгаа л бол эдгээрийн аль нь ч даван туулах боломжгүй асуудал биш юм. Мөн өөдрөг байх шалтгаан ч хангалттай бий. Улс төрчдөд холбогдох хэргийг шүүн хэлэлцэх тусгай шүүхүүдийг мужуудад шинээр байгуулж эхэлсэн. Засгийн газраас шүүх байгууллагын тоног төхөөрөмж болон ажилтнуудад зориулж нэмэлт санхүүжилт санал болгож, шүүгчдийн цалинг нэмэгдүүлэх замаар илүү олон шүүгчдийг элсүүлэх хууль тогтоомжийг танилцуулсан. Энэтхэг улс КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авж байгаа нь шүүх хуралдаанд шаардагдах хэд хэдэн шинэчлэлийг хурдасгаж байна. Засгийн газраас ТТТ-ны жилийн төсвийг нэмэгдүүлж, өөрийн үр ашгийг дээшлүүлэх шинэлэг арга замыг судалж байна. Жишээлбэл: Төрийн болон орон нутгийн хууль сахиулах байгууллагуудтай хамтын ажиллагаагаа нэмэгдүүлж, мэдээлэл солилцох ажлыг сурталчлах ажлыг эхлүүлж, тэтгэвэрт гарсан цагдаагийн албан хаагчдыг орон нутгийн зарим мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулахаар томилж, илүү үр дүнтэй ажиллагаа явуулах зорилгоор зохион байгуулалтыг шинэчлэх ажлыг эхлүүлжээ. Түүгээр ч зогсохгүй дээд түвшний улс төрчидтэй холбоотой авлигын хэргийг ТТТ мужийн засгийн газраас урьдчилан зөвшөөрөл авалгүйгээр шалгаж болох бөгөөд энэ шийдвэр нь маргаан дагуулсан, цаг хугацаа шаардсан харьяаллын асуудлыг хөнгөвчлөх төлөвтэй байгааг саяхан Дээд шүүхээс мэдээлсэн.

Улс төрчдөд холбогдох хэргүүдийг нэг жилийн дотор шийдвэрлэх тухай Дээд шүүхийн захирамж болон энэ бүрэн эрхийг хэрэгжүүлэх шүүх, мөрдөн шалгах ажиллагаанд шаардлагатай хүчин чадлыг нэмэгдүүлэх нь Энэтхэг улсын авлигатай тэмцэх системд удаан хугацаанд эерэг нөлөө үзүүлэх магадлалтай юм. Уг захирамжийг зөв зохистой хэрэгжүүлснээр нэг жилийн хязгаарлалт нь шүүгдэгч нар хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хойшлуулах, хөндлөнгөөс нөлөөлөх гэсэн оролдлогоос шүүхийн байгууллагыг хамгаалахад тусална. Харин олон нийтэд шүүх засаглал нь улс төрийн авлигын асуудлыг шийдвэрлэх үүрэгтэй бөгөөд чадавхтай гэсэн хүчтэй мессежийг хүргэх юм. Ингэснээр улс төрчид өөрсдийн буруутай үйлдлийнхээ төлөө жинхэнэ хуулийн хариуцлага хүлээх ёстой гэсэн ойлголтыг авах болно.

Энэтхэг улсын Керала муж Авлигатай тэмцэх шинэ системийг 01 дүгээр сарын 26-наас эхлүүлнэ²⁷

2021.01.12. Засгийн газар 2021 оны 01 дүгээр сарын 26-нд Бүгд найрамдах улсын өдрийг тохиолдуулан авлигаас ангид Керала хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар Ерөнхий сайд Пинараяи Вижаяан (Pinarayi Vijayan) мэдэгдэв.

Энэхүү систем нь олон нийтийг авлига, хахуулийн талаар мэдээлэхийг уриалах зорилготой юм. Тэрээр даваа гарагт болсон цахим хурлаар дамжуулан Гэмт хэрэгтэй тэмцэх газар болон Авлигатай тэмцэх, сэрэмжлэх хороо нь тус хөтөлбөрийн суурийг тавьсан талаар хэлсэн юм.

Ноён Вижаяаны үзэж байгаагаар 01 дүгээр сарын 01-нд зарласан хөтөлбөр нь ард иргэдийн гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагад мэдэгдэхээс өмнө бүртгүүлэх боломжтой байхаар зохион байгуулсан. Өргөдөл, гомдлыг эрх бүхий байгууллагад хүргүүлж, цагдаагийн өндөр албан тушаалтнууд хянаж үзсэний дараа түүний мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэх болно.

75 мянган метр квадрат талбай бүхий таван давхар Вигиланс цогцолборт Авлигатай тэмцэх, сэрэмжлэх хорооны таван байрыг нэгтгэн үйл ажиллагаа явуулах бол Гэмт хэрэгтэй тэмцэх газрын цогцолбор нь 34.5 мянган м² талбай бүхий дөрвөн давхар барилга байх юм.

Авлигатай тэмцэх хүчирхэг шинэ агентлаг Өмнөд Солонгост удахгүй нээгдэнэ²⁸

2021.01.20. Өмнөд Солонгос улсад авлигын эсрэг зохицуулагч шинэ байгууллага удахгүй ажиллаж эхлэх ба уг байгууллага нь төрийн өндөр албан тушаалтнууд, нөлөө бүхий хувийн компаниуд, тэдний ажилтнуудын оролцоотой хэргийг хариуцан ажиллах болно.

Солонгос улс төрийн өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах, эрүүгийн хариуцлага хүлээлгэх эрх бүхий бие даасан мөрдөн шалгах чиг үүрэг бүхий байгууллага болох Өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг мөрдөн шалгах алба (АХМША)-ыг байгуулах ажлыг түргэтгэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг өнгөрсөн сард баталсан.

Энэхүү АХМША-ыг байгуулах нь тус улсын Ерөнхийлөгч Мүн Жэ Инийг 2017 онд албан тушаалд томилогдсоноос хойш хэрэгжиж буй түүний мөрийн хөтөлбөрт тусгагдсан “*төрийн өндөр албан тушаалтнууд болон тэдний гэр бүлийн гишүүдийн үйлдсэн гэмт хэргийн үндсийг таслан зогсоох, улс орны ил тод байдал, төрийн албан хаагчдад итгэх итгэлийг сэргээх*” гэсэн зорилгод нийцсэн арга хэмжээ байсан юм.

Дээрх шинэ хуулийн дагуу ажиллаж байгаа болон тэтгэвэрт гарсан төрийн өндөр албан тушаалтнууд (жишээлбэл, Ерөнхийлөгч, прокурор, шүүгч, Үндэсний Ассамблейн гишүүд) болон тэдний гэр бүлийн гишүүдтэй холбоотой гэмт хэрэг, тэр дундаа хахууль, эд хөрөнгө шамшигдуулах, итгэлцэл зөрчих, зүй бус орлогыг нуун дарагдуулах зэрэг гэмт хэргийг мөрдөн шалгах эрхийг АХМША-нд олгожээ. АХМША-ны мөрдөн шалгах эрх мэдэл нь бусад мөрдөн шалгах байгууллагуудын үйл ажиллагаанаас давамгайл байх ба тус байгууллагын мөрдөх үйл ажиллагааны хүрээнд багтсан аливаа гэмт хэргийн мэдээллийг бусад агентлагууд нэн даруй АХМША-нд мэдэгдэх ёстой. Мөн шаардлагатай үед АХМША нь бусад агентлагийн хэргийг өөрийн байгууллагад шилжүүлэн авах боломжтой ажээ.

АХМША-ны үйл ажиллагааны нэг онцлог нь уг байгууллага зөвхөн өндөр албан тушаалтнууд болон тэдний гэр бүлийн үйлдсэн гэмт хэргээс гадна төрийн өндөр албан тушаалтнуудад хахууль өгсөн этгээдүүдэд болон өндөр албан тушаалтнуудын үйлдсэн гэмт хэргийн хамсаатан болсон этгээдүүдэд хамааралтай гэмт хэргийг ч мөрдөн шалгах болно.

²⁷ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.thehindu.com/news/national/kerala/new-anti-corruption-scheme-to-be-launched-on-jan-26/article33554005.ece>

²⁸ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://fcablog.com/2021/01/20/korea-powerful-new-anti-corruption-agency-to-launch-soon/?fbclid=IwAR2luHu8CGfKblfqhntB4Cg8nBIGy9MMukHgAQfZiruO4CsdMfEQYfrX62Q>

Өөрөөр хэлбэл, зөвхөн өндөр албан тушаалтнууд, тэдний гэр бүлийн гишүүд төдийгүй бусад этгээдүүд, тухайлбал хувийн компаниуд, тэдний ажилчид АХМША-ны мөрдөн шалгах ажиллагаанд хамрагдана гэсэн үг юм.

Мөн тус байгууллага нь прокурор, шүүгч, цагдаагийн өндөр албан тушаалтнуудын (болон тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн) үйлдсэн гэмт хэрэг болон тэдгээртэй холбоотой аливаа хэргийг мөрдөн шалгаж яллах бүрэн эрхтэй. Энэ чиг үүргийг өмнө нь зөвхөн Прокурорын газар хэрэгжүүлж ирсэн.

Дээрх хуулийн шинэчилсэн найруулгын дагуу АХМША-ны даргыг сонгон, томилох ажил явагдаж байгаа бөгөөд нэр дэвшүүлж буй хүнийг баталгаажуулах сонголт энэ долоо хоногт болсон.

АХМША-ыг ойрын хэдэн сард эмхлэн байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх тул Солонгос улсад үйл ажиллагаа явуулдаг компаниуд тус улсын өндөр албан тушаалтнуудтай харилцах харилцаатай холбоотой эрсдэл байгаа эсэхийг үнэлэн үзэж, цаашид илүү болгоомжтой харилцах шаардлагатай болсон байна.

[Индонез улсын Авлигыг устгах хороо хүнд байдалд байна](#)²⁹

2021.03.16. Jeremy Mulholland, Zainal Arifin Mochtar. Нэгэн цагт хүчтэй байсан Авлигыг устгах хороо (АУХ) зүгээр нэг төрийн захиргааны байгууллага болов. Засаг барьж буй Ерөнхийлөгч Жокко Видодо (Joko 'Jokowi' Widodo) болон Индонезийн тэмцлийн Ардчилсан намын тэргүүн Мегавати Сокарнопутри (Megawati Soekarnoputri) нарын эвслийн улс төрийн өш хонзонгоор 2019 оны сүүлээр АУХ-ны хуулийг шинэчилсэн.

АУХ нь тус улс дахь улс төрийн авлигыг устгах тэмцэлд ялагдал хүлээж, улс төрийнхэн удирддаг бас нэг төрийн байгууллага болон хувирлаа.

Шинэ АУХ-ны талаар зарим улс төрч, шинжээчид ташаа өөдрөг горьдлого илэрхийлж буй, эсхүл сүүлд хэд хэдэн хүн саатуулсан явдал нь хороог авлигын том хэргүүдийг шалгах боломжтой гэх боловч тааруу гүйцэтгэл нь тус байгууллагын “шинэ хэм хэмжээ” болоод байгаа юм. Зарим нэг хэргийг шалгасан нь өмнөх АУХ-ны хийсэн ажлын үлдэгдэл юм.

ТИ байгууллагын Авлигын төсөөллийн 2020 оны судалгааны үр дүнгээс үзэхэд АУХ-ны нэр хүнд, үр дүн унасан байна. Ихэнх шалгах ажиллагаа удааширч эсхүл үр дүн гарахгүй байна. Шалгаж буй хэргийн тоо эрс буурсан ба уул уурхай, байгалийн баялаг, төрийн өмчит компаниуд, бизнесийн салбар, парламент, хууль хяналтын байгууллагыг хамарсан том хэргийг шалгах ажиллагаа бараг байхгүй болсон. АУХ-ноос гаргаж буй мэдэгдлүүд улс төрийн хэргүүдийн сэжиг бүхий этгээдийг хамгаалсан, авлигатай тэмцэх шийдэмгий арга хэмжээний эсрэг байр суурьтай байна.

АУХ-ны шинэ дарга Фирли Бахури (Firli Bahuri) 2019 оны 12 дугаар сард шинээр батлагдсан хуулийн дагуу зохион байгуулалтыг өөрчилсөн байна. Энэ нь 2021 оны 10 дугаар сар гэхэд хараат бусаар үйл ажиллагаа явуулж байсан хорооны албан хаагчдыг эргэн ангилахаар болсон байна. Фирли АУХ-ны хуучин мөрдөгч, прокуроруудыг цагдаагийн байгууллагын өөрийн танил албан хаагчдаар хольж солих ажлыг гүйцэтгэж байна. 2020 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сарын хооронд 38 албан хаагч ажлаа орхиод байна.

Гэтэл яахаараа муу гүйцэтгэлтэй АУХ сүүлийн үед хэд хэдэн ач холбогдол бүхий баривчилгаа хийж, тусгай үйл ажиллагаа явуулж чадав? Эдгээр амжилтууд нь элит хоорондын өрсөлдөөнтэй давхцаж буй АУХ-ны дотоод хагарлын үр дүн юм.

2020 оны дунд үе гэхэд Индонезийн эрх баригч өрсөлдөгчид АУХ-ны хараат бус мөрдөгч Новел Басведан (Novel Baswedan)-ыг дутуу үнэлж байсан нь тодорхой болов. Новелыг саармагжуулах үйл ажиллагаа 2017 оны 04 дүгээр сард эхэлж 2020 оны 07 дугаар сарын дундуур болсон хуурамч шүүх хурлаар төгсөх байсан юм. Гэтэл Новел бууж өгөхийн оронд авлигатай тэмцэх ажлыг улам эрчимжүүлсэн байна.

²⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.eastasiaforum.org/2021/03/16/indonesias-corruption-eradication-commission-in-dire-straits/>

Новел Фирли нарын сөргөлдөөн улам эрчимжсэн байна. Новел болон түүний хамтрагчид албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж буй улс төрчдийн эсрэг мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлжээ. КОВИД-19-ийн эсрэг Индонезийн засгийн газрын үйл ажиллагаа тааруухан байхын зэрэгцээ Агуу Индонезийн төлөөх хөдөлгөөн намын³⁰ орлогч дарга, Загас агнуурын сайд Эди Прабово (Edhy Prabowo)-г хавчны авгалдайн экспортын тусгай зөвшөөрөл олгохдоо улс төрийн зорилготой хөрөнгө завшсан асуудалд буруутгасан байна. Мөн Индонезийн тэмцлийн ардчилсан намын санхүү хариуцсан дэд дарга, Нийгмийн халамжийн сайд Жулиари Батубара (Juliani Batubara)-г мөн халамжийн тусламжийн гэрээ, хэлцлийн үнийг өсгөн хөрөнгө завшсан асуудалд буруутгасан байна.

Авлигатай тэмцэх хорооны мөрдөгч Новел болон түүний хамтрагч Андре Деди Найнголан (Andre Dedy Nainggolan) нар гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааг эрчимжүүлэх явцад эрх мэдлийн төлөөх тэмцэл, АУХ-ны сул дорой байдалд дургуйцаж буй сайд нар, сэтгэл дундуур гишүүдийг чөлөөлж буй асуудлын талаарх нотлох баримтыг илрүүлжээ

Тухайн үед шалгах ажиллагааг эсэргүүцэх явдал улс төрийн тэмцлээс шалтгаалан бага байв. Исламын шашны санваартан Ризик Шихаб (Rizieq Shihab)-ыг цөллөгөөс буцаан авчрахтай холбоотой дотоод маргаан ихтэй байв. Мөн тэр үед Жоковигийн ойрын хамтрагч Листё Сигит (Listyo Sigit)-ийг Үндэсний цагдаагийн газрын даргаар томилоход Индонезийн тэмцлийн ардчилсан намын төлөөлөгч³¹, Үндэсний тагнуулын газрын дарга Буди Гунаван (Budi Gunawan) саад хийхийг оролдсон ч бүтэлгүйтсэн юм.

Хөдлөшгүй баримтууд болон АУХ-ны дэд дарга Навави Помоланго (Nawawi Pomolango)-гийн шийдэмгий дэмжлэгийн ачаар Новел “Эди, Жулиари нарыг аварч чадаагүй” Фирлигийн багийн эсрэг зогсож чадав. Эдгээр эмгэнэлтэй үйлдлүүдийн үр дүнд Новел Эди-г Жакартагийн онгоцны буудалд 2020 оны 11 дүгээр сарын 25-нд баривчилж чадсан юм. Новелын хамтрагч Андре нь Жулиарийг 12 дугаар сарын 06-нд баривчилсан.

Үүний хариуд Далайн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын сайд, Ерөнхийлөгч Жоковигийн улс төрийн эрх бүхий хамтрагч Лухут Панжайтан (Luhut Pandjaitan) мөрдөн шалгах ажиллагааг “хэтрүүлэн” хэрэгжүүлж байгаа талаар далдалсан сүрдүүлэг мэдэгдэл гаргав. Үүний дараа Фирли АУХ-ны дуудах, мөрдөх журмыг өөрчилж, хэргийг шалгах боломжгүй болгосон байна.

Хавчны эспортын тусгай зөвшөөрөл олгох ажиллагааны ашгийг хүртэгчид болох Агуу индонезийн төлөөх хөдөлгөөн намын дарга, Батлан хамгаалах яамны сайд Прабово Субианто (Prabowo Subianto) болон Антам Новамбар (Antam Novambar) нар ямар нэгэн ял шийтгэлгүй хоцорсон хэмээн *tempo.co* мэдээлсэн байна. “Нийгмийн халамж”-ийн хэргийн хувьд Индонезийн тэмцлийн Ардчилсан намаас сонгогдсон гишүүн Херман Хери (Herman Hery) болон Исан Юунус (Ihsan Yunus) нарыг тус намын өрсөлдөж буй эрх бүхий бүтцүүдийг хамгаалах зорилгоор шалгах ажиллагаанаас авж үлдсэн байна. Эдгээрт КОВИД-19-тэй тэмцэх чиглэлээр расгийн газраас санхүүжүүлж буй хөрөнгөөр худалдан авах гэрээ хэлцлүүдийг зарсан хэрэгт Мегаватигийн охин Пуан Махрани (Puan Maharani), Жоковигийн хүү Гибран Ракабуминг Рака (Gibran Rakabuming Raka) нарын нэр багтжээ.

АУХ буцалтгүй хүчгүйдлээ. Новел Басведаны “авлигыг устгах ажил” 7 сарын дотор дуусах төлөвтэй байна. Эдгээр үр дагаврууд нь вакцин худалдан авалт, татварын орлого, үндэсний баялгийн сан болон бусад үлэмж өртөг бүхий төрийн төслүүдийг авлигад эмзэг болгож байна.

Үндсэн хуулийн шүүх дэх шүүгч нарын өрсөлдөөн АУХ-ны тухай хуулийн ач холбогдолгүй зүйлийг өөрчлөхөд хүргэх талтай. Харин тус байгууллагыг хянаж буй эрх баригч Жокови, Мегавати нарын эвслийн улс төрийн хяналт сулрахгүй, улам бүр ширүүсэх хандлагатай байна.

³⁰ Gerindra буюу Great Indonesia Movement Party.

³¹ “Political fixer” гэдэг хэллэг нь “намын даалгаврыг гүйцэтгэдэг эсвэл бусдын асуудлыг шийдвэрлэх чадвартай хүн”, “асуудлыг шийдэж, ажил амжуулдаг хүн” гэх мэт утгаар хэрэглэгддэг.

Солонгосын Авлигатай тэмцэх
байгууллагаас боловсруулсан хууль
батлагдав³²

2021.04.12. Солонгосын Авлигатай тэмцэх, иргэний эрхийн хороо (АТИЭХ)-ноос төслийг нь боловсруулсан *"Нийтийн албан дахь сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль"* Үндэсний Ассамблей (ҮА)-н чуулганы хуралдаанаар батлагдав. Энэ хууль ирэх жилийн 05 дугаар сараас мөрдөгдөж эхлэх юм.

Солонгосын АТИЭХ-ны дарга Чон Хён-Хой (Jeon Hyun-Heui)-гийн мэдэгдсэнээр хууль хэрэгжихээс өмнө нэг жилийн бэлтгэл хангасны дараа ирэх оны 5 дугаар сараас шинэ хууль хэрэгжинэ.

Уг хуулийн төслийг анх АТИЭХ-ноос 2013 онд 19 дэх ҮА-д өргөн барьсан бөгөөд 8 жилийн дараа 21 дэх ҮА-гаар батлагдаж байна.

Удаан хугацааны турш НҮБ, ЭЗХАХБ зэрэг олон улсын байгууллагууд гишүүн улс орнуудаа нийтийн албан дахь авлигыг бууруулах зорилгоор сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх механизмыг бий болгох шаардлагатайг онцолж байсан юм. АНУ, Франц, Канад зэрэг ЭЗХАХБ-ын гишүүн өндөр хөгжилтэй улс орнууд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийг баталж төрийн албан хаагчдынхаа ашиг сонирхлыг хатуу хянах үйл ажиллагааг хэдийнээ нэвтрүүлсэн юм.

Энэ хуулийг баталснаар Солонгос улсад олон улсын стандартын дагуу сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх механизм бүрдэж байгаа юм. Энэ нь нийгэм дэх шударга ёсны түвшнийг шинэ шатанд хүргэх боломж юм.

АТИЭХ-ноос хуулийг батлуулах талаар олон талын хүчин чармайлтыг гаргасан. Хорооны зүгээс ҮА-н 19-21 дэх чуулганд хуулийн төслийг өргөн барьсан. 2018 оны 04 дүгээр сард Нийтийн албан тушаалтны ёс зүйн дүрэмд ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах анхны зохицуулалтыг Ерөнхийлөгчийн зарлигаар нэмж хэрэгжүүлсэн.

Сүүлийн үед болсон Солонгосын Газар, орон сууцны корпорацын хэргээс хойш нийтийн алба хаших явцад олж авсан мэдээлэл, тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн төлөв байдлын талаарх мэдээлэл болон эрх мэдлийг хувийн зорилгоор ашиглах явдлаас урьдчилан сэргийлэхийг олон нийтийн зүгээс шаардаж байсан билээ.

Эцэст нь Солонгосын Газар, орон сууцны корпорацын хэрэг шиг хэрэг дахин гарахаас урьдчилан сэргийлэх, төрийн албан хаагч хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх явдлаас урьдчилан сэргийлэх институцийн механизм шаардлагатайг АТИЭХ онцлон ҮА, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус хуулийн шийдвэрлэх үүрэгтэйг таниулах тал дээр идэвхтэй ажилласан.

АТИЭХ-ны дарга Чон Хён-Хойгийн удирдлагад тус хорооны бүх гишүүд ҮА-н гишүүд (эрх барих болон сөрөг хүчний)-тэй биечлөн уулзаж, мэдээлэл өгөх, ач холбогдолыг ухуулан ойлгуулах ажлыг гүйцэтгэсэн юм.

Мөн нийгмийн бүх давхаргынхан дэмжлэг, сонирхлоо илэрхийлж байв. Тухайлбал, 32 байгууллагын төлөөлөл буюу төрийн бус байгууллага, бизнесийн болон худалдааны нийгэмлэг, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, шинжлэх ухааны салбарынхан зэрэг нэгдсэн Шударга нийгмийн төлөөх Хувийн болон Нийтийн зөвлөлдөх зөвлөл нь хуулийг цаг алдахгүй батлахыг дэмжин мэдэгдэл гаргаж байв.

Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хуулийг батлах тал дээр ҮА дэд хороодын 8 хурал зохион байгуулж, олон нийтийн сонсгол явуулах зэргээр хүчин чармайлт гаргасан байна.

Ирэх жилийн 05 дугаар сараас хэрэгжиж эхлэх уг хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүхий л арга хэмжээг АТИЭХ хэрэгжүүлэх юм. Тухайлбал, хуулийн талаар сургалт зохион байгуулах, хуулийг мөрдөх албан хаагчдад ойлголт бий болгох, сурталчилах ажлыг хэрэгжүүлнэ.

³² Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж:
<https://www.acrc.go.kr/en/board.do?command=searchDetail&method=searchDetailViewInc&menuId=020501&confId=62&conConfId=62&conTabId=0&currPageNo=1&boardNum=87260>

Америк тив

Мөнгө угаахтай холбоотойгоор биткойны АТМ-ууд чанга зохицуулалттай болно³³

2020.06.03. Шинжээчдийн үзэж байгаагаар биткойны АТМ-уудын эрх зүйн зохицуулалт дэлхий дахинаа улам бүр чангарах бөгөөд Канад, Герман улсууд мөнгө угаахтай тэмцэх зорилгоор аль хэдийнээ холбогдох зохицуулалтыг чангаруулаад байна.

06 дугаар сарын 02-нд CipherTrace компаниас гаргасан тайланд дурдсанаар 2019 онд АНУ дахь биткойн АТМ-уудаас хийгдсэн гүйлгээний 74 хувь нь тус улсаас гадагш хийгдсэн байна. Мөн АНУ дахь крипто АТМ-уудаас виртуал валютын арилжаанд орсон мөнгөний 88 хувь нь гадаадад шилжсэн болохыг дурдсан байна. Энэхүү дүн нь сүүлийн жилүүдэд ихээхэн нэмэгдэж байгаа бөгөөд 2017 оны жилийн дүнгээс хоёр дахин нэмэгдсэн байна.

CipherTrace компанийн технологийн ахлах ажилтан Жон Жефферисийн (John Jefferies) үзэж байгаагаар биткойны АТМ-ууд “илүү зохицуулалт шаардах” бөгөөд цаашид крипто АТМ-уудтай холбоотой “жигд зохицуулалт болон хяналтыг бий болгох шаардлагатай” байгааг онцолсон байна.

Канад улс биткойны АТМ-уудтай холбоотой зохицуулалтаа чангаруулав

Канад улс виртуал валюттай холбоотой үйл ажиллагаа явуулж байгаа компаниудын талаар шинэ зохицуулалт гаргаснаас хоёр өдрийн дараа CipherTrace-ийн тайлан гарсан юм.

Канадын биткойны холбооны ажилтан Фрэнцис Пулиот (Francis Pouliot) болон орон нутгийн криптовалют арилжааны BullBitcoin компанийн үзэж байгаагаар дээрх шинэ зохицуулалт нь криптог бэлэн мөнгө болгож буй компаниудад голлон нөлөөлөх бөгөөд ялангуяа биткойны АТМ-ны операторуудад илүү нөлөөлөх аж. Биткойны АТМ-ын операторууд 10,000 болон түүнээс дээш дүн бүхий канад доллартой тэнцэх бүх гүйлгээг мэдээлэх ёстой болсон.

Мөнгө угаах асуудалтай холбоотойгоор биткойны АТМ-уудыг хотын хэмжээнд хориглох тухай Ванкувер хотын захирагчийн уриалгатай зэрэгцэн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 06 дугаар сард баталсан билээ.

CoinATMradar-ын үзэж байгаагаар одоогийн байдлаар Канадад 778 крипто АТМ ажиллаж байгаа бөгөөд энэ нь дэлхийн нийт 7,958 АТМ-ын бараг 10%-тай тэнцүү байгаа юм.

Бусад улсын зохицуулалт

2019 оны 07 дугаар сард Испанийн цагдаа нар орон нутгийн нэгэн гэмт бүлэг Биткойны АТМ-уудыг ашиглан 10 орчим сая ам.доллар угаасныг илрүүлсний дараа Европын мөнгө угаахтай тэмцэх зохицуулалтад крипто АТМ-ууд сул цэг болж байгааг онцолсон байдаг.

Өнгөрсөн оны 11 дүгээр сард АНУ-ын Дотоод орлогын алба (Internal Revenue Service)-наас криптовалютын хууль бус ашиглалтад шалгалт хийсэн нь Биткойны АТМ-уудыг ашигласнаас үүдэлтэй татварын асуудал байгааг харуулсан.

Германы Санхүүгийн зах зээлийн байгууллага (BaFin) энэ оны 03 дугаар сард зөвшөөрөлгүй Биткойны АТМ-уудын эсрэг арга хэмжээ авсан. Тус улсад өмнө нь хэрэгжиж байсан криптовалютын зохицуулалт дахь сул орон зайг арилгах зорилгоор мөнгө угаахтай тэмцэх шинэ зохицуулалт бий болгосны дараа уг арга хэмжээг авсан байдаг.

Бразилийн засгийн газар авлигатай тэмцэх шинэ нэгж байгуулахаар төлөвлөж байна³⁴

2020.07.29. Бразилийн Холбооны прокурорын газраас тус улсын авлигатай тэмцэх чиг үүргүүдийг нэгтгэсэн шинэ байгууллага байгуулахаар хэлэлцэж байгаа аж. Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх үндэсний алба гэж нэрлэгдэх тус байгууллага нь төрийн

³³ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://cointelegraph.com/news/bitcoin-atms-face-tighter-regulations-over-money-laundering>

³⁴ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.gazetadopovo.com.br/wisep-news/brazilian-government-plans-on-creating-new-anti-corruption-unit/>

байгууллагаас илүү мэргэшсэн, төвлөрсөн арга хэмжээ авах боломжийг олгоно гэж үзэж байгаа юм. Харин зарим шүүмжлэгчид уг алхмыг авлигын мөрдөн шалгах үйл ажиллагаанд улс төрийн нөлөө орох, сулруулах боломж олгож болзошгүй гэж үзэж байгаа аж.

Авлигын эсрэг Ерөнхийлөгч Теодор Рузвельтийн тэмцлийн ач холбогдол³⁵

2020.09.14. Matthew Stephenson. АНУ-д 1865-1941 оны хооронд явуулсан авлигын эсрэг шинэчлэлийн асуудлаар шүүгч Мариано-Флорентино Куэллар (Mariano-Florentino Cuellar)-тай хамтран бэлтгэсэн мэдээллийн талаар өнгөрсөн долоо хоногт нийтэлсэн билээ³⁶.

Уг нийтлэлд дэвшүүлсэн гол санааны нэг бол АНУ-д хэрэгжүүлсэн авлигын эсрэг шинэчлэлийн үйл явц урт хугацаанд аажмаар хэрэгжсэн бөгөөд бүхий л талуудыг оролцуулсан үйл явц байсан гэдгийг тодорхойлсон юм.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд чухал үүрэг гүйцэтгэсэн удирдагчдын нэг нь яахын аргагүй Ерөнхийлөгч Теодор Рузвельт юм. Ерөнхийлөгч Рузвельт ээдрээтэй өвтэй хүн хэдий ч авлигатай тэмцэх тал дээр тэрээр шинэчлэлийн хөдөлгөөний чухал удирдагч байсан юм.

Өнөөдөр (09 дүгээр сарын 14-нд) Теодор Рузвельт Ерөнхийлөгчийн албан тушаалд томилогдсоны 119 жилийн ой тохиож байгаа тул авлигын эсрэг түүний хэлсэн зарим үгсийг хуваалцъя. 1903 оны 12 дугаар сард Конгресст хандан хэлсэн эдгээр үгсийн доторх агуулга нь хахуульд холбогдон эх орноосоо оргон зайлсан гэмт хэрэгтнүүдийг шилжүүлэн өгөх тухай асуудал байсан юм. Гэхдээ Ерөнхийлөгч Рузвельтийн хэлсэн үг яриа нь орчин үеийн авлигатай тэмцэх албан тушаалтны үйлдэлтэй холбогдож болохоор байна:

Хахуулиас илүү ноцтой гэмт хэрэг гэж үгүй. Бусад гэмт хэрэг нэг л хуулийг зөрчиж байхад, авлигын гэмт хэрэг нь бүх хуулийн тулгуур зарчимд харшилдаг. Манай улсын засаглалын бүх эрх мэдэл ард түмэнд байдаг бөгөөд тэднийг албан ёсоор төлөөлж буй хүмүүсээр дамжуулан хэрэгжүүлдэг. Гэтэл эдгээр хүмүүс өөртөө давуу байдал үүсгэх, хөрөнгөжих сонирхлын үүднээс ард түмний хүлээлгэсэн итгэлийг алдаж байгаа нь хүнд гэмт хэрэгт тооцогдох бөгөөд мөн хахууль өгч буй этгээдүүдийн гэм бурууг хөнгөрүүлж үзэх боломжгүй юм. Хулгайч нь хувь хүнийг дээрэмддэг бол авлигач нь бүхэл бүтэн хот, улсыг дээрэмддэг учир тэд бол хулгайчдаас дор юм. Авлигач бол алуурчинтай адил. Алуурчин ихэнхдээ нэг хүний амь насыг хөнөөсөн байдаг бол авлигач нь улс орны эсрэг аллага хийдэг. Засгийн газар, ард түмэн бүгд хахуулийг хүлээн зөвшөөрвөл хүн төрөлхтөн үгүй болох болно. Хахууль өгч байгаа, авж байгаа бүх хүн гутамшигтай. Төрийн байгууллагын авлигыг илчилж, шийтгэх нь үндэстний нэр төрийн хэрэг болохоос гутамшиг биш юм. Ичгүүртэй байдал нь залруулгад биш тэвчихэд оршдог. Хэрэв бид авлигыг таслан зогсоохын тулд бүх зүйлээ дайчилж чадахгүй бол бид гэм буруугийнхаа төлөө хариуцлагаас мултарч чадахгүй. Амжилттай засаглалын анхны шаардлага бол хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, авлигыг таслан зогсоох явдал юм.

Дэлхийн санхүүгийн авлигыг мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан Уоррен мэдэгдэл хийв³⁷

2020.09.21. Вашингтон. АНУ-ын мэдээллийн томоохон вэб сайт болох BuzzFeed News-ийн мөрдөн шалгах ажиллагааны үеэр дэлхийн санхүүгийн системд гүн гүнзгий нэвтэрсэн авлигыг илчилсэн доорх мэдэгдлийг АНУ-ын сенатор Элизабет Уоррен хийв.

“Томоохон банкууд болон компаниуд гэмт хэрэгтэн, террористуудын хууль бус гүйлгээнээс ашиг олохын тулд хуулийн цоорхой, зохицуулагч байгууллагуудын сул талыг урвуулан ашиглаж байна. Бид санхүүгийн сүлжээний ил тод байдлыг бэхжүүлж, дэлхийн санхүүгийн урсгалаар явж буй бохир мөнгийг зогсоох замаар энэхүү авлигыг үндсээр нь таслах ёстой. Түүнчлэн бид том

³⁵ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/09/14/president-theodore-roosevelt-on-the-importance-of-fighting-corruption/>

³⁶ <https://globalanticorruptionblog.com/2020/09/08/new-working-paper-on-anticorruption-reform-in-u-s-history/>

³⁷ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.warren.senate.gov/newsroom/press-releases/warren-statement-on-buzzfeed-news-investigation-of-global-financial-corruption>

банкуудын удирдлагуудад хариуцлага тооцохын тулд цаашид их зүйл хийх хэрэгтэй байна” гэж сенатор Уоррен хэлэв.

Сенатор Уоррен 2018 онд санхүүгийн байгууллагуудын гэмт хэргийг мөрдөн шалгах байнгын ажиллагаатай хууль сахиулах алба бий болгохын тулд хорих ажиллагааны тухай хууль санаачилж³⁸, 10 тэрбум ба түүнээс дээш долларын хөрөнгөтэй банкны удирдах албан тушаалтнууд ёс зүйтэй ажиллаж, тухайн санхүүгийн байгууллага иргэний болон эрүүгийн хэрэгт оролцоогүй тухайгаа жил бүр гэрчлэн, мэдэгдэхийг шаардаж байсан. Мөн үйл ажиллагаа эрхэлдэггүй боловч банканд данс эзэмшдэг компаниудын эздийг ил болгохыг шаардсан АНУ-ын үндэсний батлан хамгаалахын эрх олгох тухай хуулийн заалтыг дэмжиж байгаагаа тэрээр мэдэгдсэн.

Сенатор Уоррен 2018 онд мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийг сайжруулах хэрэгтэй байгаа тухай ярьж байхдаа Ситигруп банк (Citigroup) торгууль ногдуулсан боловч мөнгө угаах гэмт хэргийг таслан зогсоохын тулд юу ч хийхгүй байгааг онцолж байв. 2013 онд тэрээр HSBC-ийн захирлуудыг зэмлээд өнгөрөхийн оронд шоронд хорихыг уриалж байв.

2014 онд батлагдсан Бразил улсын Авлигын эсрэг хуулийн амжилтыг хэмжих нь³⁹

2020.11.02. Luiz Santiago. Хавтгайрсан авлигын талаарх түгшүүртэй байдлаас үүдсэн үндэсний хэмжээний эсэргүүцлийн жагсаалын⁴⁰ дараагаар Бразилийн Конгресс Авлигын эсрэг шинэ хуулийг баталсан.

2014 оны Авлигын эсрэг хууль нь хахууль авдаг хувь хүмүүст анхаарлаа хандуулах уламжлалт хандлагаас хахууль өгдөг корпорацууд руу чиглэсэн гэдгээрээ онцлог юм.

Өмнөх хууль тогтоомжуудад хахууль өгсөн байж болзошгүй хувь хүмүүсийн үйлдлийг хөнддөг байсан бол энэхүү хуульд хахууль өгч буй компаниудад илүү хатуу шийтгэл ногдуулахаар тусгасан (үүнд, тухайн компанийн өмнөх жилийн нийт орлогын 20 хүртэлх хувийн торгууль ногдуулах, онцгой тохиолдолд компанийг татан буулгах).

Авлигын эсрэг хууль хэрэгжиж эхлээд 6 жил гаруй хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд уг хууль үр дүнтэй байсан уу? Ерөнхийдөө хууль сахиулах ажиллагааны тоо бага байгаа нь Бразилийн ихэнх бүс нутагт хахууль өгдөг корпорацуудад хориг арга хэмжээ авахдаа хуулийг эрс шийдэмгий байдлаар хэрэгжүүлээгүйг харуулж байна. Гэсэн хэдий ч уг хуулийг үр нөлөөгүй, эсвэл хэрэгжээгүй гэж дүгнэх нь эртэднэ гэж үзэх олон янзын шалтгаан байна.

Хуулийн хэрэгжилтийн талаарх зарим статистик мэдээллээс эхлэе.

Урьдчилсан судалгаагаар 2018 оны 01 дүгээр сар гэхэд (хууль батлагдсанаас хойш дөрвөн жилийн дараа) засгийн газар 183 захиргааны хэрэг нээж 30 хуулийн этгээдэд шийтгэл ногдуулжээ. Гэхдээ зөвхөн засгийн газрын шийдвэр гүйцэтгэх ажиллагааны статистикийг харах нь хангалтгүй юм. Учир нь Авлигын эсрэг хуулийн дагуу мужийн болон хотын захиргааны байгууллагууд ч мөн адил чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Тус хуулийн хэрэгжилтийн талаар үндэсний хэмжээний мэдээлэл цуглуулахын тулд өнгөрсөн жил 27 муж, 26 нийслэл хотын хэмжээнд судалгаа явуулсан. Судалгааны мэдээллийн сан дутуу байгаа хэдий ч хуулийн хэрэгжилтийг илүү гүнзгий үнэлэх боломжийг олгосон юм.

2019 оны 01 дүгээр сарын байдлаар Бразилийн мужууд 306 хуулийн этгээдийн эсрэг 132 захиргааны хэрэг, нийслэл хотууд 49 хуулийн этгээдийн эсрэг 42 захиргааны хэрэг нээжээ. Гэхдээ Авлигын эсрэг хуулийн дагуу нээсэн захиргааны хэргийн тоо, ногдуулсан шийтгэлийн тоо нь зөвхөн хахуулийн эсрэг ашиглах сайн үзүүлэлт биш юм. Учир нь тус хууль нь тендерийн асуудал, холбогдох хууль зөрчсөн гэмт хэрэг зэрэг бусад үйлдлүүдэд мөн үйлчилдэг.

³⁸ <https://www.warren.senate.gov/newsroom/press-releases/on-tenth-anniversary-of-financial-crisis-warren-unveils-comprehensive-legislation-to-hold-wall-street-executives-criminally-accountable>

³⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/11/02/measuring-the-success-of-brazils-2014-anticorruption-law/#more-16879>

⁴⁰ <https://www.reuters.com/article/us-brazil-protests-idUSBRE95J15020130621>

Судалгааны дүнгээр мужуудын нээсэн 132 хэргээс 21 нь хахуультай холбоотой, 94 нь тендерийн будилаантай холбоотой хэрэг байсан бол нийслэл хотуудын нээсэн 42 хэргээс зөвхөн 2 нь хахуультай холбоотой, 18 нь тендерийн будилаантай холбоотой хэрэг байжээ.

Бразилийн олон муж, нийслэл хотууд хахууль өгсөн корпорацуудад хариуцлага хүлээлгэхийн тулд Авлигын эсрэг хуулийг эрс шийдэмгий ашиглахгүй байгаа нь мэдээжийн хэрэг сэтгэл түгшээж байгаа боловч бид энэ хууль хэрэгжихгүй байна гэж дүгнэж болохгүй юм. Үүнд хэд хэдэн шалтгаан бий:

- *Нэгдүгээрт*, Авлигын эсрэг хууль 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд үүнээс өмнө гарсан хэрэгт уг хууль үйлчлэхгүй юм. Жишээ нь, хууль хүчин төгөлдөр болохоос өмнө гарсан Лава Жато (Машин угаалга)-той холбоотой хэрэгт шалгагдсан байгууллагуудад тус хууль үйлчлэхгүй гэсэн үг юм.
- *Хоёрдугаарт*, Бразилийн авлигатай тэмцэх үйл ажиллагаа зөвхөн Авлигын эсрэг хуулиар хязгаарлагддаггүй. Бразилийн прокурорууд авлигын хэрэгт холбогдсон хувь хүмүүсийг эрүүгийн хуулийн бусад хэсэгт заасны дагуу хариуцлага хүлээлгэдэг бол хуулийн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэхдээ захиргааны зөрчлийн тухай хууль зэрэг бусад хууль тогтоомжийг ашигладаг.
- *Гуравдугаарт*, Авлигын эсрэг хуулийн үндсэн заалтуудыг хэрэгжүүлэхэд анхаарч байгаа нь уг хуулийн бас нэг чухал хэсэг болох хэргийг хялбаршуулсан байдлаар шийдвэрлэх зөвшөөрлийн асуудлыг орхигдуулж байна. Авлигын эсрэг хууль нь хуулийн үйлчлэлд хамааралгүй авлигатай холбоотой хэргийг шийдвэрлэхэд ашиглаж болох эрх зүйн зохицуулалтыг тусгасан байдаг. Жишээ нь, Лава Жатогийн мөрдөн байцаалтын явцад олж илрүүлсэн олон чухал хэрэг, тэр дундаа Odebrecht болон J&F-ийн хэргийг 2014 оны Авлигын эсрэг хуулиар зөвшөөрсөн хэргийг хялбаршуулах байдлаар шийдвэрлэсэн байна.
- *Дөрөвдүгээрт*, Бразилийн Авлигын эсрэг хуулийн үр нөлөөний талаар дүгнэлт хийхэд эрт байна. Жишээ нь, АНУ-ын ГАУАТХ бодитой үр дүнд хүрэхийн тулд 20 гаруй жилийн хугацаа зарцуулсан.

Цаашид сайжруулах зүйлүүд бий. Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллагуудад хэрэг шалгахад түгээмэл хэрэглэгддэг гэрчүүдийн утсыг хураан авах, шүүхээр хэлэлцэх зэрэг мөрдөн шалгах ажиллагааны арга техникүүд дутагдалтай байна.

Бразилд эдгээр арга техникийг зөвхөн эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд ашиглах боломжтой байдаг. Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх нь захиргааны шинжтэй тул уг хуулийг хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага нь мөрдөн шалгах ажиллагааны явцад олж илрүүлсэн нотлох баримтад үндэслэн хэргийг шийдвэрлэж байна.

Бодит байдал дээр Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх нь хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа, үр дүнтэй мэдээлэл солилцохоос хамаарах юм.

Харамсалтай нь Бразилийн хууль сахиулах байгууллагууд авлигын эсрэг тэмцэлд анхаарлаа хандуулахын тулд өөр хоорондоо өрсөлддөг нь харагдаж байна. Энэ бэрхшээлийг даван туулахын тулд агентлагууд нэгэн зорилгын төлөө хамтран ажиллаж, Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлэх төдийгүй авлигатай тэмцэхэд нь урт хугацаандаа амжилтад хүрэхэд чухал үүрэг гүйцэтгэнэ.

[Улс дамнасан авлигын эсрэг тэмцэлд АНУ манлайлж байна](#)⁴¹

2020.12.07. Олон улсын авлигатай тэмцэх бүлгийн зүгээс АНУ-ыг хахууль, авлигын эсрэг дэлхийн тэргүүлэгч орон хэмээн магтсан байна.

ЭЗХАХБ-ын Хахуулийн асуудлаарх ажлын хэсгийн 11 дүгээр сарын 17-ны илтгэлд дурдсанаар АНУ авлигатай тэмцэх хууль тогтоомжоо амжилттай хэрэгжүүлэхийн зэрэгцээ бусад улс орныг ЭЗХАХБ-ын гаргасан Олон улсын бизнесийн гүйлгээтэй холбогдуулан гадаадын төрийн албан хаагчдын хахуультай тэмцэх тухай конвенцыг дагаж мөрдөхийг уриалсан байна.

⁴¹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://share.america.gov/us-leads-in-fight-against-transnational-corruption/?fbclid=IwAR2g87_YDNJ2YH2HpDBmiPpGb00FGu8sSuUUeUCJy985i-VQpBblgyZvHDM



Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага гадаадын албан тушаалтнуудын авлига, хахуультай тэмцэж буй АНУ-ын хүчин чармайлтыг өндрөөр үнэлэв.
(© Shutterstock)

ЭЗХАХБ-ын Хахуулийн асуудлаарх ажлын хэсгийн тайланд АНУ 2010-2019 онуудад ГАУАТХ-ийн хүрээнд гадаадын хахууль болон бусад гэмт хэрэгтэй холбогдуулан 174 компани, 115 хүнд ял шийтгэл оногдуулсан болохыг тусгажээ.

Дээрх ажлын хэсэгт 44 гишүүн улс багтсан бөгөөд энэ нь авлигатай тэмцэх арга хэмжээг улс орнууд хэр сайн хэрэгжүүлж байгааг хянах юм. Ажлын хэсгийн зүгээс АНУ-ын авлигатай тэмцэх чиглэлээр олж авсан туршлага, нөөц бололцоог сайшааж, хэргийг мөрдөн байцаах, шийдвэрлэх үйл ажиллагааны уялдаа холбоо, авлигын эсрэг хүчин чармайлтаа бэхжүүлэх гадаадын түншүүдийг сургах зэрэг амжилттай бодлогыг онцолсон.

АНУ нь ЭЗХАХБ-тай нягт хамтран ажиллаж, авлигатай тэмцэхэд үлгэр дуурайлал үзүүлэхийг эрмэлздэг хэмээн АНУ-ын Төрийн департаментын дэд дарга Кэйл Браун хэлсэн байна. Тэрээр 11 дүгээр сарын 17-ны өдөр хийсэн мэдэгдэлдээ “АНУ гадаадын хахуультай тэмцэх чиглэлээр манлайлагч байсаар ирсэн бөгөөд бидний хүчин чармайлт АНУ-ын авлигын эсрэг үйл ажиллагааны гол тулгуур багана юм. Хахууль нь дэлхийн эдийн засгийн цэвэр өрсөлдөөнд саад учруулж, зах зээлийг гажуудуулж, дэлхийн өнцөг булан бүрд бизнес эрхлэх зардлыг нэмэгдүүлдэг” гэж онцолсон юм.

Бразил Авлигын эсрэг таван жилийн төлөвлөгөө хэрэгжүүлж эхэллээ⁴²

2020.12.10. Бразилийн засгийн газар өнгөрсөн лхагва гарагт Авлигын эсрэг 2020-2025 оны төлөвлөгөөгөө хэрэгжүүлж эхэлсэн байна.

Засгийн газрын ордонд удирдах албан тушаалтнуудын оролцсон ёслолын үеэр Ерөнхийлөгч Жайр Болсонаро (Jair Bolsonaro) баримт бичигт гарын үсэг зуржээ.

Тус төлөвлөгөөнд НҮБ, ЭЗХАХБ болон АУБ-ын гаргасан олон улсын зөвлөмжүүдийг тусгажээ.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын мэдээлснээр дээрх авлигын эсрэг төлөвлөгөөг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд нэгт нь яамд хоорондын авлигатай тэмцэх хорооны тусламжтайгаар нөхцөл байдлыг үнэлэх, хоёрдугаарт богино, дунд хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээг бэлтгэх юм.

ХМТ гадаад улсын авлигын хэрэг шалгах ажиллагааг өргөжүүлж байна⁴³



Майами дахь Холбооны мөрдөх товчооны оффис. Тус товчоо Латин Америктай холбоотой хууль бус үйл ажиллагааг илүү нарийн хянах зорилгоор олон улсын авлигын эсрэг багийг 2019 онд Майамид байгуулсан.
(Фото: Matias J. Ocnor / Zuma Press)

2020.12.30. АНУ-ын ХМТ өөрийн бүрэлдэхүүнд байдаг Олон улсын авлигатай тэмцэх хэлтэс (ОУАТХ)-ээ байнга өргөжүүлж, үйл ажиллагааг нь эрчимжүүлж байна.

Гадаад улсын нутаг дэвсгэрт монопол, клептократ, авлигын гэмт хэрэгт холбогдсон АНУ-ын хувь хүн, хуулийн этгээдийг мөрдөн шалгах зорилготой ОУАТХ-ийн бүрэлдэхүүнд шинээр гурван тасаг бий болгожээ.

Өнгөрсөн жил Майами хотод шинээр байгуулагдсан Олон улсын авлигатай тэмцэх тасаг (ОУАТТ) нь АНУ-ын ГАУАТХ-ийг хэрэгжүүлэх замаар гадаад улсын хахуультай хэрхэн үр дүнтэй тэмцэх боломжтойг харуулж байна. Майами хотын тус тасаг нь нийтэд мэдэгдсэнээр гэмт хэргийн таван үйлдэл

⁴² Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: http://www.xinhuanet.com/english/2020-12/10/c_139577143.htm

⁴³ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.wsj.com/articles/fbi-increasingly-probes-for-corruption-overseas-11609434000>

мөрдөн шалгасан бөгөөд үүнээс хэд хэд нь 2020 онд өндөр торгуультай тохиролцоонд хүргэсэн байна.

“ХМТ эдгээр мөрдөн шалгах ажиллагаанд олон жилийн турш оролцсон бөгөөд ГАУАТХ-д заасан асуудлын хүрээнд илүү чухал, төвлөрсөн үүрэг гүйцэтгэж байгаа гэж дүгнэж байна” хэмээн олон улсын авлигын хэргээр мэргэшсэн өмгөөлөгч Маттесон Еллис мэдэгджээ. ГАУАТХ-д зааснаар АНУ-ын хувь хүн, аж ахуйн нэгж нь бизнесийн үйл ажиллагаанд давуу байдал олж авах зорилгоор гадаад улсын төрийн албан хаагчдад бэлэг өгөх болон санал болгохыг хориглодог байна.

Майами хотын ОУАТТ Латин Америкийн бүс нутагт илүү төвлөрсөн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Нью Йорк, Лос Анжелес, Вашингтон хотуудад байрлах тасгуудтай мөн хамтран ажилладаг байна. Майами хотод авлига, мөнгө угаах гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа эрс нэмэгдсэн тул тус хотод шинэ тасаг байгуулах зайлшгүй шаардлага тулгарсан талаар ОУАТХ-ийн дарга Лесли Бэксчис (Leslie Backschie) мэдэгджээ.

“Бид Өмнөд Америк руу тогтмол нислэг үйлддэг байсан бөгөөд Майами хотоор байнга дамжин өнгөрдөг байв. Тухайн үед бид хууль бус орлого ашиглан хөрөнгө худалдаж авах зэрэг гэмт хэргийн мэдээлэл байнга авдаг байсан. Үүнээс улбаалан мөрдөгч бүр Майами хот руу нисэж мөрдөн байцаалт авах шаардлага үргэлж тулгардаг байв. Тиймээс Майами хотын тасгийг байгуулсан бөгөөд 2019 оны 03 дугаар сараас үйл ажиллагаа явуулж эхлээд байна” гэж Лос Анжелес хотын ОУАТТ-ийн даргаар ажиллаж байсан Лесли Бэксчис мэдээлэв.

ХМТ тухайн үед Хьюстон хотод байрлах газраас орон нутаг болон олон улсын гэмт хэргийг прокурорын багтай хамтран мөрдөн шалгаж байсан туршлагатай мөрдөгчдийг сонгон шалгаруулж Майами хотын ОУАТТ-т шилжүүлсэн талаар хэлтсийн дарга Лесли Бэксчис хэлэв. ХМТ-ны ОУАТТ одоогоор тусгай ажилтан, тагнуулын ажилтан, шинжээч болон шүүхийн нягтлан бодогчдоос бүрдсэн 51 ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байгаа нь 2010 онд Вашингтон хотод ердөө 13 мөрдөгч, 1 шинжээчтэй ажиллаж байсан үетэй харьцуулбал хүчин чадлаа хэд дахин нэмэгдүүлсэн байна.

Майами хотод байрлах тасаг нь Испани, Португал хэл, соёлын өндөр чадамжтай албан хаагчид сонгон шалгаруулж авсан талаар тус тасгийн дарга Рик Симпсон мэдээлэв. Мөнгөн гүйлгээний авлигатай тэмцэх алба нь гадаад улсын засгийн газрууд болон прокурорын байгууллагатай тогтмол хамтран ажилладаг бөгөөд ихэвчлэн хамтарсан мөрдөн шалгах ажиллагаа явуулдаг. Латин Америкийн бүс нутагт Бразил, Колумб, Эквадор улсын хууль сахиулах байгууллагатай тус тасгийн мөрдөгчид нягт хамтран ажилладаг талаар Рик Симпсон мөн хэлэв.

Тусгай зориулалтын тасаг байгуулснаар ХМТ илүү олон гэмт хэрэг шалгаж байна. ОУАТХ нь ГАУАТХ-д заасан гэмт хэргийг мөрдөн шалгах ажиллагааг хариуцан ажилладаг бөгөөд Хууль зүйн яамны прокурортой тогтмол хамтран ажиллаж, гэмт хэрэгт холбогдсон компани болон тэдний хуульчидтай уулзалт зохион байгуулж мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талаар мөн мэдээлэв.

Өнгөрөгч 09 дүгээр сард ГАУАТХ-ийг зөрчсөн гэм буруугаа хүлээсэн Флорида хотод байрлах асфальт үйлдвэрлэгч Саржеант Маринь корпорацийн хэргийг⁴⁴ мөрдөн шалгахад Майами хотод байрлах тасаг мөн туслалцаа үзүүлжээ. ХМТ-ны мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд ГАУАТХ зөрчсөн гэм буруугаа 10 дугаар сард хүлээж, 128 сая ам.долларын торгууль төлөхийг зөвшөөрсөн Жэй Би Эс Эс Эй махны сав үйлдвэрлэгч компанийн холбогдох хэргийг мөн илрүүлсэн байна.

ГАУАТХ-ийн хэрэгжилтэд хяналт тавьж, болзошгүй зөрчлийг илрүүлэх, мөрдөн шалгах ХМТ-ны ажиллагааг Олон улсын авлигын эсрэг хяналтын байгууллагын 11 дүгээр сарын тайланд өндрөөр үнэлж, үндэстэн дамнасан авлигын гэмт хэрэгтэй тэмцэхэд манлайлж буй АНУ-ын үйл ажиллагааг сайшаажээ.

ЭЗХАХБ-ын харьяа Олон улсын бизнесийн үйл ажиллагааны хахуулийн ажлын хэсгийн тайланд ХМТ-ны ОУАТТ-ийн үйл ажиллагаа өргөжиж, дэлхийн 75 улс оронд байрлах өөрсдийн төлөөлөгчөөр дамжуулан ГАУАТХ-ийг зөрчсөн гэмт хэргийг илрүүлэх чадварыг онцолжээ.

⁴⁴ https://www.wsj.com/articles/florida-asphalt-company-agrees-to-pay-16-6-million-to-resolve-bribery-case-11600823217?mod=article_inline

Цахим орчинд мөрдөн шалгах ажиллагаа явуулах нь одоогоор тус хэлтэст тулгарч буй хамгийн том сорилт болж байгаа талаар тасгийн дарга Симпсон мэдээлжээ. Цар тахлын үед мөрдөгчид зарим тохиолдолд цахимаар ажиллах шаардлагатай тулгарч байгаа бөгөөд гадаад улсад зорчихоо түр зогсоосон тухай хэлтсийн дарга хатагтай Бэкшис мэдэгдэв.

“Мөрдөгчид цахим видео хурал болон онлайн сервер ашиглан баримт бичиг хүлээн авж, ярилцлага хийж байна. Мэдээж бид хүмүүстэй биечлэн уулзаж мэдээлэл солилцохыг хүсэж байгаа боловч цар тахлын үед ийнхүү ажиллах боломжгүй байна. Иймээс бид цахим програм ашиглан онлайн хурал хийж байгаа бөгөөд тус бэрхшээлийг даван туулж чадсан” хэмээн ОУАТТ-ийн дарга Симпсон хэлэв.

Трампын захиргаа уул уурхайн магнат Гэртлэрт тавьсан хориг арга хэмжээг зөөлрүүлжээ⁴⁵

2021.01.25. АНУ-ын Ерөнхийлөгч асан Доналд Трампын засаг захиргаа албан тушаалынхаа сүүлчийн долоо хоногт Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс (БНАКУ)-д авлигын хэрэгт буруутгагдсан Израилийн уул уурхайн магнат Дэн Гэртлэрийн эсрэг тавьсан хориг арга хэмжээг АНУ-ын Сангийн яамнаас олгосон зөвшөөрлийн дагуу зөөлрүүлсэн байна.

Олон нийтэд дэлгэгдээгүй энэхүү зөвшөөрлийг Сангийн яамны Гадаад активыг хянах газар (ГАХГ) олгосон болохыг 01 дүгээр сарын 15-ны өдөр Гэртлэрийн өмгөөлөгчид бичсэн захидлыг нь олж авсан Вашингтонд байрладаг авлигын эсрэг The Sentry групп олж мэдсэнийг Ройтерс мэдээллийн агентлаг лавласан байна.



Дэн Гэртлэр хэвлэлийн төлөөлөгчөөрөө дамжуулан Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Мутандагийн зэс, кобальтын уурхайд бизнес эрхлэх зөвшөөрлийг нь сэргээх алхамыг сайшааж байгаа бол гэмт хэргийн эсрэг тэмцэгчид энэхүү зөвшөөрлийг цуцлахыг Ерөнхийлөгч Байдены Сангийн яаманд уриалав. (Bloomberg)

Яагаад энэхүү зөвшөөрлийг олгосон нь тодорхойгүй байгаа юм. Гэртлэрийн хэвлэлийн төлөөлөгч энэ алхмыг нааштай хүлээж авсан боловч хахуулийн эсрэг тэмцэгчид энэхүү зөвшөөрлийг цуцлахыг Ерөнхийлөгч Жо Байдены Сангийн яаманд уриалав.

Сангийн яамны төлөөлөгчийн хэлснээр Байдены засаг захиргаа энэхүү арга хэмжээг мэдэж байсан авч шийдвэрийг буцаах эсэх талаар мэдээлэл өгөхөөс татгалзсан байна.

Гэртлэрыг БНАКУ-ын экс Ерөнхийлөгч Жозеф Кабилатай үүсгэсэн нөхөрлөлөө ашиглан тэрбум гаруй ам.долларын үнэтэй ашигт малтмалын нууц гэрээ байгуулсан хэмээн буруутгаж, Сангийн яамнаас 2017 оны 12 дугаар сард болон 2018 оны 06 дугаар сард хориг тавьсан байдаг.

Энэхүү хориг арга хэмжээ нь Гэртлэрийг АНУ-ын иргэн, аж ахуйн нэгж, банкуудтай бизнес эрхлэх, ам.доллараар гүйлгээ хийхийг хориглосон байсан юм.

Гэртлэр аливаа буруутай үйлдлээ үргэлж үгүйсгэсээр ирсэн ба БНАКУ-д оруулсан хөрөнгө оруулалт нь тус улсын хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үздэг.

Дээрх зөвшөөрөл нь Гэртлэрийг хориглоос бүрмөсөн гаргаж буй хэрэг биш бөгөөд түүний хамтрагч болон 30 гаруй компанийг нь хориг арга хэмжээний жагсаалтаас хасаагүй, харин

⁴⁵ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/economy/2021/1/25/11th-hour-trump-eased-sanctions-on-israeli-mining-mogul-gertler>

түүний эсрэг авсан хориг арга хэмжээгээр хориглосноос бусад “бүх гүйлгээ болон үйл ажиллагаа” -г 2022 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр хүртэл зөвшөөрч байгаа юм.

Түүнчлэн 90 хоног тутам санхүүгийн үйл ажиллагааны талаарх нарийвчилсан тайлангаа ГАХГ-т ирүүлж байхыг шаардаж байна.

“Ноён Гэртлэр бизнес болон хүмүүнлэгийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг нээсэн зөвшөөрөл олгосонд ГАХГ-т талархаж байна”, “Тэрээр тайлагнах шаардлагыг талархан хүлээн авж, ишлэдэг хяналтын багийн хараан дор түүний бүхий л үйл ажиллагаа ГАХГ-ын зөвшөөрөл, хууль тогтоомжийн агуулга, үзэл баримтлалд бүрэн нийцэж байгааг харуулахыг хүсэж байна” хэмээн хэвлэлийн төлөөлөгч нь мэдэгдэлдээ дурджээ.

Харин The Sentry-ийн гүйцэтгэх захирал, Сангийн яамны ажилтан асан Брэд Брүүкс-Рүбин *“геостратегийн болон үндэсний аюулгүй байдлын тодорхой зорилгогүй”*-гээр зөвшөөрөл олгосон гэж мэдэгджээ. Мөн тэрээр *“Өршөөл үзүүлэх болон зохицуулалтын өөрчлөлтийг нээлттэй хийхээс, эсвэл Сангийн яамны хориг арга хэмжээг цуцлах ердийн аргуудаас ялгаатай нь, үүнийг олон нийтэд төдийгүй, засгийн газрын олон мэргэжлийн хүмүүсээс ч хаалттай хаалганы цаана хийсэн”* гэж хэлсэн байна.

Sentry Байдены Сангийн яамыг энэхүү зөвшөөрлийг цуцлахыг уриалж байгаа юм.

2018 онд Конгресст ирүүлсэн мэдээллийн маягтаас харахад өнгөрсөн онд Сенатын өмнө Трампыг төлөөлж импичментийн анхны шүүх хуралд оролцсон Алан Дершовиц Гэртлэрийн өмнөөс ГАХГ-ыг лоббидсон хуульчдын нэг байжээ.

Дершовиц цахим шуудангаар тайлбар авах хүсэлтэд хариу өгөөгүй байна.

[Авлигын гэмт хэрэгт холбогдон гэм буруутай нь тогтоогдсон төрийн албан хаагчийн тэтгэврийн төлөвлөгөөг цуцлах талаар Нью Мексикогийн хуулийн төсөлд тусгажээ⁴⁶](#)

2021.02.15. АНУ-ын Нью Мексико мужийн хууль тогтоогчид авлигын гэмт хэрэгт холбогдон гэм буруутай нь тогтоогдсон албан хаагчийн төрийн албанд ажилласан хугацааны тэтгэврийн төлөвлөгөөг цуцлах талаар тусгасан хуулийн төслийг өргөн барьсан байна.

Орон нутгийн мэдээллийн агентлаг KQRE анх мэдээлснээр энэхүү хуулийн төсөлд хахууль, баримт бичиг хуурамчаар үйлдэх зэрэг гэмт хэрэгт холбогдон гэм буруутай нь тогтоогдсон хууль тогтоогчид болон мужийн хэмжээний бусад төрийн албан хаагчийн тэтгэврийн төлөвлөгөөг цуцлах талаар тусгажээ.

Ардчилсан намаас сонгогдсон Сенатч Мэттью Маккуин болон Бүгд найрамдах намаас сонгогдсон Сенатч Марк Моорс нарын өргөн барьсан энэхүү хуулийн төсөл нь 2012 онд батлагдсан авлигын гэмт хэрэгт холбогдуулан шүүгчийн шийдвэрээр төрийн албан хаагчид торгууль ногдуулах ажиллагааг зохицуулсан мужийн хуульд тулгуурласан байна.

Энэхүү хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтад шүүх байгууллага, хотын захиргаа, сургуулийн удирдах зөвлөлийн албан хаагч зэрэг зарим төрийн албан хаагчид хамаарахгүй юм.

[Авлигын эсрэг Apple компанийн иж бүрэн бодлого⁴⁷](#)

2021.03.01. Өнгөрсөн долоо хоногт Apple компани нийцлийн өргөн хүрээтэй сэдвийн бодлогын баримт бичгүүдийн линк буюу холбоосыг агуулсан шинэ ёс зүй, нийцлийн сайтынхаа нээлтийг хийлээ. Тус компанийн авлигын эсрэг бодлогод зарим сонирхолтой заалт багтсан байна.

1. Хөнгөвчлөх төлбөрт тавигдах хориг

⁴⁶ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://thehill.com/homenews/state-watch/538907-new-mexico-bill-would-forfeit-retirement-plans-of-public-officials-found>

⁴⁷ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://fcpablog.com/2021/03/01/benchmarking-alert-heres-apples-full-anti-corruption-policy/?fbclid=IwAR0aWlvsIY0IXzNXA6iTI58-9uYKQ6y12ycJRpAYxPcBMsx3g0zQ6Ws1Jyg>

Хөнгөвчлөх төлбөр нь засгийн газраас байнга хэрэгжүүлдэг үйл ажиллагааны үед тохиолддог хахуулийн төрөл юм. Ихэвчлэн анхан шатны түвшний үйл ажиллагааг гүйцэтгэж буй албан тушаалтнууд ийм төрлийн хөнгөлөлт, төлбөрийг авж, ердийн бөгөөд түгээмэл үйлчилгээг үзүүлдэг. Apple компани ийм төлбөрийг зөвшөөрөхгүй бөгөөд хатуу хориглоно.

2. *“Цуу ярианд учир бий.” Гуравдагч этгээдтэй холбоотой тодорхой нөхцөл байдалд сэрэмжлүүлэх гурван анхааруулга*

Та гуравдагч этгээд болон туслан гүйцэтгэгч компаниудтай харилцахдаа доорх гурван анхааруулгыг санаж байх хэрэгтэй ба дараах зүйлсийн аль нэгийг олж мэдвэл сэрэмжлүүлэх хэрэгтэй:

- Хахуулийн тухай цуу яриа гарах эсвэл нэр хүндээ хадгалах;
- Төрийн албан хаагчид, эсвэл төрийн байгууллагуудтай холбоотой нэхэмжлэх, зардлын нэхэмжлэлийн талаарх нарийвчилсан мэдээлэл, тухайлбал, тогтмол дүнтэй төлбөрийн хүсэлт, том дүнтэй төлбөрийн хүсэлт, эсвэл гуравдагч этгээд, эсвэл өөр улсаар дамжуулан хийсэн төлбөр;
- Төрийн албан хаагч, эсвэл яамтай ойрын холбоотой байх, эсвэл тусгай зөвлөх, эсвэл нэмэлт үнэ цэн багатай зөвлөхөөр ажиллуулахыг шаардах.

3. *Төрийн албан хаагч нь өргөн цар хүрээтэй ойлголт*

“Төрийн албан хаагч” гэж төрийн чиг үүргийг гүйцэтгэж, төрийн хөрөнгөөр цалинждаг хүнийг хэлнэ. Үүнд орон нутаг, муж/аймгийн удирдлага, үндэсний засгийн газар, олон улсын байгууллагад ажилладаг хувь хүмүүс, төрийн өмчит сургууль, эмнэлгийн албан хаагчид, төрийн өмчит аж ахуйн нэгжийн ажилтнууд багтана. Ийм байгууллагын ажилтнуудыг ямар албан тушаалд ажиллаж байгаагаас үл хамааран төрийн албан хаагч гэнэ.

4. *Төрийн албан хаагчдын хоолны зардлын хязгаарлалтыг улс бүрээр харуулсан хүснэгт*

АНУ-ын төрийн албан хаагчид болон албан тушаалтнуудад зарцуулах хоолны зардал нь АНУ-ын төрийн албан хаагчдын албан ажлаа гүйцэтгэх үеийн хоолны зөвшөөрөгдөх хязгаарыг улс бүрээр харуулсан хүснэгтэд нийцсэн байх ёстой.

5. *Төрийн албан хаагчдын томилолтын зардлыг зөвшөөрдөг боловч үүнийг урьдчилан баталсан байх ёстой*

Холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн нөхцөлд Apple компани нь бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, танилцуулах, тайлбарлахтай шууд холбоотойгоор төрийн албан хаагчид болон албан тушаалтнуудын томилолтын зохих зардлыг төлж болно. Гэхдээ томилолтын зардлыг зохих журмын дагуу урьдчилан баталсан байх ёстой.

[АНУ-ын авлигын эсрэг хууль тогтоомж](#)

[Африкийн хөдөө орон нутгийн эдийн](#)

[засгийн өсөлтийг хэрхэн дэмжив?](#)⁴⁸

2021.03.03. Rose Jacobs. Засгийн газрын авлигыг олж тогтооход амаргүй ба улмаар түүний эдийн засгийн хөгжилд учруулж буй үр нөлөөг хэмжихэд хэцүү байдаг. Гэвч Чикаго Бут их сургуулийн судлаач Ханс Б.Кристенсен, Марк Г.Маффетт, Томас Раутер нар авлигатай тэмцэх арга хэмжээний үр нөлөөг хэмжих, тэдгээрийг бодитоор харах арга замыг тодорхойлон гаргасан бөгөөд тэд авлигыг зогсоосны дараа бий болж буй боломжуудыг эдийн засгийн үйл ажиллагааны хэмжүүр болгон авж үзсэн.

АНУ-д дөчин жил үйлчилсэн авлигатай тэмцэх хуулийг өөрчилсний улмаас Африк дахь уурхай, газрын тосны цооногуудтай холбоотой эдийн засгийн идэвхжил 14 хувиар өссөн болохыг дээрх аргачлалыг ашиглан тогтоосон юм. Энэхүү судалгааны үр дүнгээс харахад нийтийн албаны хахууль, сүрдүүлж мөнгө нэхэх, хөрөнгө завших явдлыг бууруулахаар авж хэрэгжүүлсэн аливаа

⁴⁸ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://review.chicagobooth.edu/accounting/2021/article/how-us-anti-corruption-law-boosted-economic-growth-rural-africa?fbclid=IwAR3wHGyIUEVCvcgqvRj5mVHVO7ESbsIf04FSHXgP_NdYAd8Z6IQHlqDJh8

арга хэмжээ нь байгалийн баялаг ихтэй боловч улс төрийн институт султай улс орнуудад түгээмэл ажиглагддаг “баялгийн хараал”-ыг арилгахад туслах болно.

АНУ-д 1970-аад онд гарсан Уотергейтийн улс төрийн дуулианы дараа буюу 1977 онд АНУ-ын Конгресс ГАУАТХ-ийг баталж, Америкийн корпорацууд болон хувь хүмүүс өөрсдийн бизнесийн үйл ажиллагаанд таатай байдал үүсгэхийн тулд гадаадын албан тушаалтнуудад хахууль өгөхийг хориглосон. Уг асуудалд дотоодын дэмжлэг дутагдалтай, олон улсын хамтын ажиллагаа хязгаарлагдмал байгаагаас шалтгаалан уг хууль хэдэн арван жилийн турш бараг хэрэгждэггүй байсан гэж Кристенсен, Маффетт, Раутер нар онцолсон. 2005 онд хахуулийн тодорхойлолтыг өргөжүүлэн өөрчилж, дээрх хуульд хамаарах хэргүүдийг хойшлуулж, ял шийтгэлгүй орхиж байгааг олж тогтоосноор нөхцөл байдал өөрчлөгдсөн бөгөөд энэ үед хувьцаат компаниудын нягтлан бодох бүртгэлд шинэчлэл хийсэн Сарбанес-Окслийн тухай хууль батлагдсан байдаг.

Дээрх судлаачид Африкийн 34 улсын 487 уурхай, 113 газрын тос, байгалийн хийн цооногийг түүвэрлэн судалж, АНУ-ын Агаарын цэргийн хүчний хиймэл дагуулын гэрэлтүүлгийн уншилтыг ашиглан шөнийн цагаар гэрэл багатай байдаг газар нутгийн зургийн мэдээллийг нэгтгэсэн. Тэд гаргасан мэдээллээ ашигт малтмалын олборлолтын байгууламжуудын байршил, өмчлөл, бараа бүтээгдэхүүний өгөгдөлтэй нэгтгэн ГАУАТХ-ийн зохицуулалт эдгээр уурхай, цооногийн эзэмшигчид хамааралтай эсэхийг тогтоосон.

Шөнийн цагаар хэрэглэж буй гэрэлтүүлгийг ашиглан эдийн засгийн үйл ажиллагааг тооцоолж буй өмгөөлөгчдийн үзэж байгаагаар энэ нь ДНБ-ий мэдээллийн сул талыг нөхөж, илүү нарийн үнэлгээ хийх боломжийг олгож байна. Кристенсен, Маффетт, Раутер нар түүвэрлэн авсан ашигт малтмалын олборлолтын талбайгаас 10-50 км-ийн зайд орших бүс нутгуудийн эдийн засгийн өсөлтийг дээрх аргаар хэмжжээ.

Тэдний олж тогтоосноор 2004-2013 онд хуулийн зохицуулалтад хамааралтай олборлолтын талбайгаас 50 км-ийн зайд гэрэлтүүлэг илт нэмэгдсэн бол уг хуулийн зохицуулалтад хамааралгүй этгээдүүдийн хувьд гэрэлтүүлэг бага зэрэг өөрчлөгдсөн, эсвэл огт өөрчлөгдөөгүй байжээ. Хуулийн зохицуулалтад хамааралтай олборлох байгууламжаас 10 км-ийн зайд орших газрууд 14%-ийн өсөлттэй байсан бол 25 км-ийн зайд буй газрууд ердөө 3%-ийн өсөлттэй байв.

Шинэ хуулийн зохицуулалт хэрэгжихээс өмнө улс төрийн сул институттэй байсан улс орнуудад эдийн засгийн үйл ажиллагааны хамгийн том өсөлт ажиглагдаж байгаа ба үүнийг уул уурхайн үйл ажиллагаа нийлбэрээрээ буурсан, эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөн зэрэг бусад хүчин зүйлтэй холбоотой байж болохыг үгүйсгэж байна.

Олборлох салбарт ажил эрхлэлт буурсан гэсэн нотолгоо байхгүй бөгөөд олборлолтын компаниуд үйл ажиллагаа явуулж буй орон нутагтаа илүү ашигтай, эсвэл бага хөнөөлтэй бизнесийн үйл ажиллагаанд шилжих замаар эдийн засгийн үйл ажиллагааны өсөлтийг бий болгожээ. Одоо олборлох үйл ажиллагаа ба орон нутгийн эдийн засгийн үйл ажиллагааны хоорондын хамаарал 40 хувиар нэмэгдсэн.

Дээрх судлаачдын үзэж байгаагаар авлигатай тэмцэх хууль тогтоомж нь эдийн засгийг хэрхэн өдөөж болохыг энэ судалгааны үр дүн харууллаа. Тухайлбал, авлигыг таслан зогсоосноор гадаадын хөрөнгө оруулалтын томоохон хэсгийг хахуульд бус харин дотоодын бизнес эрхлэгчид, хувь хүмүүст хүргэх боломжтой юм. Олон улсын компаниуд өөрсдийн улс төрийн холбооноос илүүтэйгээр чадварыг нь харгалзан гадаадын түншүүдээ сонгож эхэлж магадгүй юм. Хахуульгүй нөхцөлд уурхайн эзэд орон байр барих эсвэл цалин хөлс нэмэгдүүлэх замаар орон нутгийн иргэдэд илүү тааламжтай ажиллаж болзошгүй юм.

Үүний зэрэгцээ эдгээр судлаачид африкчуудаас авлигын талаарх тэдний ойлголтыг асууж, судалсан Афробарометрийн хийсэн судалгаанд дүн шинжилгээ хийжээ. 2004 оноос хойш ГАУАТХ-ийн зохицуулалтад хамрагдсан олборлолтын байгууламжуудын ойролцоо амьдардаг ард иргэдийг бусад иргэдтэй харьцуулахад төрийн албан хаагчдыг авлигад идэгдсэн гэж үзэж буй нь 8%-аар бага байсан бөгөөд орон нутгийн засаг захиргаандаа 18% илүү сэтгэл хангалуун байдгийг тэд олж тогтоожээ. Энэ байдал нь авлига буурах хэрээр эдийн засгийн идэвхжил өндөр болдог гэсэн санааг дэмжиж байгаа юм.

Ерөнхийд нь дүгнэж үзэхэд, энэхүү судалгаа нь ГАУАТХ-ийн зохицуулалт юуг өөрчилж чадахыг харуулав. “Хөгжингүй орнуудын гаргасан авлигын эсрэг зохицуулалт” нь компаниудын үйл

ажиллагааны зардлыг нэмэгдүүлж болзошгүй гэж Кристенсен, Маффетт, Раутер нар үзжээ. Гэхдээ энэ нь “хөгжиж буй улс орнуудын эдийн засгийн нөхцөл байдалд эерэг нөлөө үзүүлж чадна”.

Дэлхийн мөнгө угаахтай тэмцэх хүчний дараагийн давалгаа⁴⁹

2021.03.03. Sven Stumbauer. Санхүүгийн үйлчилгээний салбарт хүчтэй шуурга дэгдэж байна. Хууль тогтоомжийн нарийн төвөгтэй шаардлага, хуучин тогтолцоо, үйл ажиллагааны хуучирсан загвар, дижитал инновац, финтек (санхүүгийн технологи) нь дэлхийн хэмжээний санхүүгийн олон байгууллагуудыг хурдацтай өөрчилж байна.

Нэмж гарсан зохицуулалт, геополитикийн өөрчлөлт, мэдээллийн хэрэглээтэй холбоотой мөнгөн торгууль зэрэг нь мөнгө угаахтай тэмцэх эрсдлийн менежментийг авж хэрэгжүүлэхийг дэлхийн хэмжээний санхүүгийн байгууллагуудаас шаардах болсон.

Аливаа санхүүгийн байгууллагын хувьд эрсдэл мундахгүй их байдаг. Дэлхийн хэмжээнд хэрэгжүүлж буй зохицуулалтын арга хэмжээний улмаас мөрдөн шалгалт нэмэгдэж, торгууль тавигдаж, лиценз цуцлагдаж, дээд түвшний удирдлага, зохицуулагчид огцрох гэх мэтээр гол хүмүүс биечлэн хариуцлага хүлээх болжээ.

Санхүүгийн байгууллагуудын мөнгө угаах гэмт хэрэгт оногдуулсан торгуулийн өсөлт 2020 онд 14 тэрбум гаруй ам.долларт хүрсэн байна. Дэлхийн янз бүрийн зохицуулах байгууллагууд хууль тогтоомжид томоохон өөрчлөлт оруулж байгаа нь санхүүгийн байгууллагуудын дарамтыг нэмэгдүүлж байна. Мөнгө угаахтай тэмцэх шинэ зохицуулалт нь ФАТФ-аас гаргасан дэлхийн стандартад нийцэж байгаа.

Дэлхий нийт мөнгө угаахтай тэмцэхэд анхаарал хандуулж, санхүүгийн байгууллагууд давтан болон шинээр алдаа гаргасан тохиолдолд шийтгэл ногдуулсан хэвээр байгаа тул шийдвэр гүйцэтгэх ажиллагаа, торгуулийн хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Зохицуулалтыг өөрчлөхийн зэрэгцээ зохицуулалтад тавигдах хяналтыг нэмэгдүүлснээр мөнгө угаахтай тэмцэх эрсдлийн менежментийг сайжруулах шаардлага тулгарч байна.

2020 онд батлагдсан АНУ-ын Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль нь тус улсын санхүүгийн байгууллагууд төдийгүй тэдний хамтрагчид, харилцагчдад шинэ эрин үеийг эхлүүллээ.

Шинээр мөрдөгдөж эхэлсэн энэхүү хууль нь 2001 онд батлагдсан Терроризмыг таслан зогсоох, хориглоход шаардагдах зохих арга хэмжээг хэрэгжүүлэн Америкийг нэгтгэн, хүчирхэгжүүлэх тухай 2 дахь хуулиас хойш мөнгө угаахтай тэмцэх ажилд хамгийн их нөлөө үзүүлж болзошгүй бөгөөд үүний үр дүнд Банкны нууцын тухай хуульд нэлээд шинэчлэлт хийсэн байна.

АНУ-ын Мөнгө угаахтай тэмцэх тухай хууль нь одоогоор үйлчилж байгаа холбогдох дүрэм, журамд ихээхэн өөрчлөлт оруулсан боловч дараах гурван гол өөрчлөлт байгаа бөгөөд эдгээр нь ирэх саруудад компаниудын дээд түвшний удирдлагын зүгээс анхаарал хандуулах асуудал болж байна. Үүнд:

- Мөнгө угаахтай тэмцэх тухай хуулийг зөрчсөн үйлдэлд ногдуулах шийтгэлийг чангатгах,
- Одоогийн мөнгө угаахтай тэмцэх мэдээлэгчийг идэвхжүүлэн, дэмжих,
- АНУ-ын зохицуулах байгуулага гадаадын санхүүгийн байгууллагуудаас баримт бичиг авах эрх мэдлийг нэмэгдүүлэх.

ЕХ-ны хувьд сүүлийн хоёр жилийн хугацаанд АНУ-ын зохицуулах байгууллагуудын санаачилга, оролцооны үр дүнд мөнгө угаасан хэргүүд, хууль сахиулах ажиллагааны тухайд нэлээд асуудалтай тулгарч байна. Европыг донсолгосон банкны янз бүрийн дуулианыг дагаад ЕХ бүс нутгийн хариу арга хэмжээг илүү нягт уялдуулж, хянахыг оролдож байна.

ЕХ 2021 онд Мөнгө угаахтай тэмцэх 6 дахь удирдамжийг нэвтрүүлснээр томоохон өөрчлөлтүүд гарах болно. Санхүүгийн байгууллагууд болон тэдгээрийн удирдах зөвлөл мөнгө угаахтай тэмцэх үр нөлөөтэй хяналт, тогтолцоог хангаагүйн улмаас анх удаа эрүүгийн хариуцлагад

⁴⁹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://internationalbanker.com/finance/the-next-wave-of-anti-money-laundering-enforcement-globally-is-on-the-horizon/?fbclid=IwAR3cVSuWMmPu4EX94CYa2dFz_zVsbcaWHHgsiOJmh4kcdx6e4za5pdYjHbQ

татагдаж болзошгүй юм. Гэхдээ ЕХ-ны хэмжээнд мөнгө угаахтай тэмцэх асуудлыг хянах ерөнхий зохицуулах байгууллага дутагдалтай байгаа тул санхүүгийн байгууллагууд өөр өөрсдийн улсын хууль тогтоомж, гишүүн орнуудын зохицуулагчдын янз бүрийн түвшинд боловсруулсан зохицуулалтын дунд зүг чигээ алдаж байна.

Авлига Үндэсний аюулгүй байдалд заналхийлэгч. Үүнтэй тэмцэх ухаалаг шийдэл бол CROOK хууль⁵⁰

2021.03.23. Хэдэн жилийн өмнө АНУ-д тулгамдаж байсан хамгийн аюулт заналхийлэл нь коммунист үзэл суртал байсан билээ. Харин өнөөдөр энэхүү заналхийлэл нь авторитор удирдагчид засгийн газрын эрх мэдлийг ашиглан ашиг хонжоо, давуу байдал олж, улс төрийн өрсөлдөгчийг дарамталж буй улс төрийн авлига болсон байна.

Авлигач удирдагчид түүнийг дэмжигч сүлжээний тусламжтайгаар эрх мэдэл авж, хууль дээдлэх ёсыг уландаа гишгэж, хулгайлсан хөрөнгөө нуун далдалж байна. Эдгээр авлигач удирдагчид мөн стратегийн авлигыг гадаад бодлогын хэрэгсэл болгон ашиглаж заншжээ.

Авлига энгийн ард иргэдэд хамгийн их хохирол учруулдаг бөгөөд ардчиллыг алдагдуулж, хууль дээдлэх ёсыг үнэгүйдүүлж, төрийн үйлчилгээг үр дүнтэй, шуурхай хүргэх боломжийг үгүй хийж байгаа нь цар тахлын үеийн нөхцөл байдалтай холбогдуулан нийтэд цацагдаж буй мэдээллээс харагдаж байна. Мөн энэ нь нийгмийн хуваагдлыг ашиглах, эрх чөлөөг хясан боогдуулах, төрийн эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд ашиглах зорилготой авторитар оппортунистуудад эерэгээр нөлөөлж байна.

Үүнээс гадна авлига нь АНУ-ын ардчилал, хөгжил цэцэглэлт, тус улсын холбоотнуудын хөгжилд илүү өргөн аюул заналхийлэл учруулж байгаа юм. Хүний наймаа, хар зах, терроризм гэх мэт үндэстэн дамнасан бараг бүхий л аюул заналхийлэл авлигатай салшгүй холбоотой байдаг.

Авлигатай тэмцэх үйл ажиллагаа аажмаар боловч гарцаагүй байдлаар дэлхий дахинд эрчимжиж байна. ОХУ-д активист Алексей Навальныйгийн илчилсэн авлигын хэргийн мэдээллийн улмаас тус улсад системтэйгээр ард иргэдээс хулгай хийдэг улс төрийн өндөр албан тушаалтнуудын эсрэг олон нийтийн эсэргүүцэл бий болсон. Сүүлийн 3 жилийн хугацаанд дэлхийн 32 улсад авлигын эсрэг эсэргүүцэл өрнөжээ⁵¹.

Хэдийгээр авлигатай тэмцэх үйл ажиллагаа эрчимжиж буй шинж тэмдэг илэрч байгаа боловч авлигыг үндсээр нь устгах боломж хязгаарлагдмал хэвээр байна. Энэхүү тэмцлийн үр нөлөөг нэмэгдүүлэх зорилгоор АНУ авлигын эсрэг шинэчлэл хийгчдэд богино хугацаанд туслахад бэлэн байх шаардлагатай.

Шинэчлэлийн боломжийг ашиглах

АНУ одоогийн байдлаар 115 сая ам.долларыг олон улсын авлигатай тэмцэх хөтөлбөрт зарцуулдаг⁵². Гэвч бид олон улсын эрүүл мэндийн тусламжийн хөтөлбөрт 9.5 тэрбум ам.доллар зарцуулж байна⁵³. Харамсалтай нь авлигатай тэмцэх хөтөлбөрт зарцуулж буй ихэнх санхүүжилт засаглалын үйл ажиллагааг шинэчлэлийн гэнэтийн боломжуудад хариу үйлдэл үзүүлэх боломжгүй урт хугацааны техникийн хөтөлбөрт ордог.

Эрдэмтэн, мэргэжилтнүүд авлигатай тэмцэх үйл ажиллагааны шинэчлэлийг үргэлжлүүлэхэд түргэн шуурхай арга хэмжээ авах нь нэн чухал болохыг мэдэгдэж байна. Тус шинэчлэл хийгдэх боломж олдсон тохиолдолд реформ санаачилагчид олон нийтийн эрч хүчийг үр дүнтэй ашиглах үүднээс хурдан бөгөөд зоригтой ажиллаж, авлигач төрийн албан хаагчид нөлөөллөө дахин тогтоохоос сэргийлэх ёстой.

Хэрэв энэхүү үйл ажиллагаанд АНУ хувь нэмрээ оруулж, шинэчлэл хийгчдэд туслалцаа үзүүлэхгүй бол авлигын эсрэг шинэчлэл хийхэд улам хүндрэлтэй болж, клептократ авторитарууд

⁵⁰ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.justsecurity.org/75468/corruption-is-a-national-security-threat-the-crook-act-is-a-smart-way-to-fight-it/>

⁵¹ <https://carnegieendowment.org/2020/07/01/regaining-u.s.-global-leadership-on-anticorruption-pub-82170>

⁵² <https://sgp.fas.org/crs/row/R46373.pdf>

⁵³ <https://www.foreignassistance.gov/categories/Health>

байр сууриа улам бүр бэхжүүлэх болно. АНУ түүхэн боломжийн мөчид үр дүнтэй ажиллах үүднээс түргэн хэрэгжих боломжтой хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай байна.

АНУ-ын авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх “ОХУ болон бусад улсын клептократ үйлдэлтэй тэмцэх тухай буюу CROOK”⁵⁴ хууль нь татвар төлөгчдөд нэмэлт дарамт учруулахгүйгээр активистүүд олон нийтийн санаа бодлыг хөшүүрэг болгон урт хугацааны тогтвортой шинэчлэл хийхэд туслалцаа үзүүлэх авлигатай тэмцэх үйл ажиллагааны сан бий болгох юм. Энэхүү санг ГАУАТХ-ийн дагуу 50 сая ам.долларын торгууль ногдуулсан аж ахуйн нэгжээс 5 сая ам.долларын нэмэлт төлбөр авах замаар санхүүжүүлэх юм.

Сүүлийн 10 жилийн мэдээллийг үндэслэн үзвэл энэхүү хууль авлигатай тэмцэх олон улсын хөтөлбөрт жил бүр 16 сая ам.долларын санхүүжилт нэмэлтээр төвлөрүүлэх боломжтой. Авлигын эсрэг үйл ажиллагаанд шинэчлэл хийх боломж үүсэх хүртэл тус сангийн хөрөнгө хуримтлагдах бөгөөд шаардлага тулгарсан тохиолдолд хууль дээдлэх ёс тогтоох зорилгоор түргэн шуурхай ашиглах юм.

ГАУАТХ-ийн хэрэгжилтийг сайжруулах

ГАУАТХ нь авлигыг хэзээ ч гадаад улсад экспортлохгүй гэсэн АНУ-ын амлалтыг илэрхийлдэг. Энэ нь Бүс ба Зам санаачилгаар дамжуулан авлигыг гадаад улсад чадварлаг экспортдог БНХАУ зэрэг клептократ гүрнүүдээс АНУ эрс ялгаатай болохыг харуулж байна. Харамсалтай нь ГАУАТХ бол АНУ-ын халаасыг түнтийлгэх хэрэгсэл юм гэсэн худал мэдэгдлийг зарим холбоотнууд хийсэн. CROOK хууль ГАУАТХ-ийн дагуу оногдуулсан торгууль, төлбөрийн тодорхой хувийг АНУ-ын холбоотнуудад авлигатай тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор туслалцаа үзүүлж, энэхүү мэдэгдлийн хуурамч гэдгийг батлах болно.

Цаашлаад, ГАУАТХ нь зөвхөн хахууль өгч буй аж ахуйн нэгжийг хянан шалгаж, авлигын эх үүсвэр болсон авлигач албан тушаалтнуудыг орхигдуулдаг гэх олон жилийн турш шүүмжлэл дагуулж байсан үзэл бодлыг үгүйсгэх юм. Мөн CROOK хууль нь хууль дээдлэх ёсыг бататган бэхжүүлж, албан тушаалтнуудыг хахууль нэхэхээс урьдчилан сэргийлж, АНУ-ын бизнес эрхлэгчдэд илүү тэгш бололцоог бүрдүүлнэ.

ТИ Америк, Санхүүгийн хариуцлага ба байгууллагын ил тод байдлын эвсэл (FACT)⁵⁵ зэрэг олон улсын нэр хүнд бүхий авлигатай тэмцэх чиг үүргийн байгууллагууд бүгд тус хуулийг дэмжсэн байна. АНУ-ын Хельсинкийн хорооноос гарсан олон хууль тогтоомжтой адил энэхүү хуулийн төсөл Танхим болон Сенатад хоёр намын дэмжлэгийг авсан юм.

Авлигатай тэмцэх ажиллагаа нь АНУ-ын хувьд зайлшгүй шаардлагатай хэрэгжүүлэх үйл ажиллагаа юм. Энэхүү тэмцэлд тохирсон нөөцийг хуваарилах нь гадаад улсад сайн засаглалыг ахиулж, илүү тогтвортой ертөнцийг бий болгох багахан хэмжээний төлбөр юм. Энэхүү хуулийг батлах нь зөв чиглэлд ажиллах үндсэн алхам болно.

Арбитрын шүүх дэх авлигын эсрэг Перу улсын хэрэгжүүлж буй арга хэмжээ байгаа онохгүй байна⁵⁶

2021.05.28. astridmedianero. Перу улсын шүүхийн тогтолцоо бусад олон орны адил авлигад идэгдсэн, найдваргүй байдаг. Энэ шалтгааны улмаас компаниуд арилжааны шинжтэй маргаанаа шийдвэрлүүлэх зорилгоор арбитрын байгууллагыг сонгох нь илүү дээр хувилбар гэж үздэг бөгөөд арбитрын байгууллагыг шүүхээс хямд өртөгтэй, хурдан шуурхай гэдгээр нь биш харин арбитрчид шүүгчдийг бодвол бага авлигажсан гэж үздэгтэй холбоотой юм.

Харамсалтай нь Перу улс дахь арилжааны арбитрын шүүхэд ч авлигын хэрэг гардаг. Энэ нь Бразилийн барилгын фирм болох Одебрехт Перугийн засгийн газартай холбоотой маргаанаа нааштайгаар шийдвэрлүүлэхийн тулд арбитрчдад хахууль өгсөн гэх хэргээс тодорхой харагддаг.

Энэ оны 02 дугаар сард Перу улсын Конгресст нэгэн хуулийн төслийг өргөн барьсан бөгөөд үүнийг дэмжигчдийн үзэж байгаагаар уг хууль тухайн асуудлыг шийдвэрлэх юм. Энэхүү

⁵⁴ <https://www.csce.gov/international-impact/press-and-media/press-releases/cardin-wicker-introduce-bill-counter-corruption>

⁵⁵ <https://thefactcoalition.org/fact-welcomes-bipartisan-bills-to-counter-kleptocracy-and-combat-global-corruption/>

⁵⁶ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/05/28/peru-misguided-proposal-for-countering-corruption-in-arbitration/>

хуулийн төсөлд Перу улсын Арбитрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах замаар дотоодын хэргийг хянан хэлэлцэж буй олон улсын бүх арбитрчид 30 хоногийн хугацаатай улсын боловсролын зохицуулагч байгууллагаас баталгаажсан гэрчилгээтэй, мэргэшсэн байх шаардлагатай гэсэн шаардлагыг нэмж оруулсан байна. Өнгөц харахад энэхүү шаардлага нь авлигатай хамааралгүй юм шиг харагдах боловч энэ шинэ дүрмийг Перу улсад арбитрын үйл ажиллагаа явуулахад авлигаас урьдчилан сэргийлэх арга зам гэж ойлгох ёстой гэж хуулийн төслийг санаачлагчид тодорхой хэллээ. Хуулийн төслийг дэмжигчдийн үзэж байгаагаар гадаадын арбитрчид Перу улсын авлигын эсрэг хуулийг ойлгодоггүйгээс арбитрын шүүхэд авлига үүсдэг гэж үзэж байна. Тиймээс энэхүү маргаан үргэлжилж байгаа бөгөөд төрийн захиргааны байгууллагаас эдгээр гадаадын арбитрчдын итгэмжлэлийг баталгаажуулах, Перугийн системийг ойлгох, арбитрын систем дэх авлигын хориглолт, авлигын талаарх зохицуулалтыг ерөнхийд нь авж үзэхийг шаардав.

Энэхүү хуулийн төсөл Перу улсын арбитрын шүүх дэх авлигын бодит эх үүсвэрийг шийдвэрлэж чадахгүй төдийгүй байдлыг улам дордуулж ч болзошгүй юм. Арбитрын шүүх дэх авлига нь Перу улсад тулгарч буй бодит асуудал болж байгаа боловч үүнийг шийдвэрлэх зөв арга нь хуулийн өөрчлөлт биш юм.

Перуд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулдаг зарим гадаадын арбитрчдын авлигад өртсөн шалтгаан нь эдгээр арбитрчид Перугийн хуулийг мэдэхгүй байсантай холбоотой биш гэдгийг хүлээн зөвшөөрөхийн тулд гүн гүнзгий дүн шинжилгээ хийх шаардлагагүй. Үнэхээр ч Одебрехтийн хэрэгт хахууль авсан гэх арбитрчид Перу улсын хууль тогтоомжийг зөрчиж байгаагаа мэдээгүй гэдэг нь утгагүй зүйл юм (Авлигын хэрэгт холбогдсон арбитрчдын ихэнх нь гадаадын хуульчид биш Перу улсын иргэд байсан тул энэ нь хоёр дахин утгагүй зүйл). Энэхүү авлига нь арбитрчид Перу улсын дүрэм журамд юу шаардлагийг ойлгоогүйгээс бус, харин эдгээр дүрмийг дагаж мөрдөхгүй байхыг сонгосноос үүдсэн юм.

Үнэн хэрэгтээ, энэхүү хүнд суртлын нэмэлт шаардлагыг тавьснаар илүү их чирэгдэл үүсгэж, боломжтой арбитрчдын тоог цөөрүүлэхээс гадна авлигын шинэ хэлбэрийг бий болгож магадгүй юм. Гадаадын арбитрчид итгэмжлэх гэрчилгээг 30 хоногийн дотор баталгаажуулах боломжгүй тохиолдолд гэрчилгээ олгох эрх бүхий байгууллага болох SUNEDU-гийн албан тушаалтнуудад хахууль өгөх замаар үйл явцыг хурдасгах болно. Ийм хахууль өгөхөд бэлэн байгаа арбитрчид шүүхэд оролцогч талуудаас хахууль авах, эсвэл бусад төрлийн ёс зүйгүй авир гаргах хандлагатай байдаг.

Тиймээс энэхүү хуулийн төсөл нь асуудлыг шийдвэрлэх буруу шийдэл юм. Гэсэн хэдий ч асуудал бодитой тул үүнийг шийдвэрлэх шаардлагатай байна. Хахууль авсан арбитрчид болон хахууль өгсөн талуудад хоёуланд нь хатуу шийтгэл оногдуулахаас гадна арбитрын тогтолцоог ил тод болгох замаар арбитрын шүүх дэх авлигын асуудлыг хэсэгчлэн шийдвэрлэж болно.

Перу улсын Арбитрын тухай хуулиар арилжааны арбитрын хэргийн нууцлалын анхдагч дүрмийг тогтоосон байдаг. Нууцлалын дүрэм нь ерөнхийдөө үндэслэлтэй боловч эцсийн эцэст талууд арбитрын шүүхэд нотлох баримт болгон танилцуулсан арилжааны нууц мэдээллийг олон нийтэд нээлттэй зарлахаас татгалзаж магадгүй юм. Арбитрын зарим ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх боломжтой бөгөөд ил болгох ёстой. Магадгүй хамгийн чухал нь арбитрын шүүгчдийн талаарх мэдээлэл, үүнд арбитрч нар урьд нь хохирол, нотлох баримт гаргаж өгөх, сөрөг дүгнэлт, сөрөг нэхэмжлэл гаргах гэх мэт асуудлаар хэрхэн шийдвэр гаргасан, мөн арбитрын ажиллагааг ерөнхийд нь хэрхэн явуулсан зэрэг статистик мэдээлэл орно. Перуд олон арбитрч хэдэн зуун хэрэгт оролцдог бөгөөд зарим арбитрчид хэвийн бус байдал гаргаж байгааг тогтооход хангалттай хэмжээний мэдээлэл байдаг гэсэн үг юм.

Эдгээр бүх мэдээллийг хялбархан олж авах боломжтой мэдээллийн санд байршуулах нь арбитрын ажиллагаанд оролцогч талууд өөрсдөө хянан шалгах ажиллагаагаа явуулахад хялбар болгож, арбитрчдад нэр хүндээ өсгөх, хадгалах боломжийг нэмэгдүүлэх болно.

Перу улсын хууль тогтоогчид авлигыг нэмэгдүүлэхэд хүргэж болзошгүй хүнд суртлын тогтолцоонд гадаадын арбитрчдыг албадан оролцуулахаас илүүтэйгээр одоо байгаа авлигын эсрэг хууль тогтоомжийг чанд мөрдөж, арбитрын тогтолцоог илүү ил тод болгоход анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

Авлигатай тэмцэх нь АНУ-ын үндэсний аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхол болох тухай Санамж бичиг⁵⁷

2021.06.04. Ерөнхийлөгч Байден Авлигатай тэмцэх нь АНУ-ын үндэсний аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхол болох тухай Санамж бичгийг 2021 оны 06 дугаар сарын 03-ны өдөр гаргав.

Тэрээр Үндэсний аюулгүй байдлын зөвлөх Жэйк Салливанд дэлхийн авлигатай тэмцэх нийгэмлэгийн тодорхойлсон асуудлуудад чиглэсэн АНУ-ын дотоод болон гадаад дахь авлигатай тэмцэх Ерөнхийлөгчийн стратеги боловсруулахыг даалгажээ. Салливан 2019 оны 09 дүгээр сард Вашингтон Пост сонинд “АНУ хулгайлагдсан хөрөнгийг нуун дарагдуулах, хууль ёсны болгох дэлхийн тэргүүлэгч орнуудын нэг болсон” хэмээн илэн далангүй илчилсэн “Бохир мөнгө АНУ руу урсахыг зогсоохыг хүсэж байна уу? Энэ хуулийг батал гэж Конгресст хэл”⁵⁸ нийтлэлийг Ребекка Брокатотай хамтран бичсэн бөгөөд “гадаадын авлига нь манай ардчилал, аюулгүй байдал, эдийн засаг, мөн үнэт зүйлсэд заналхийлж байна” хэмээн бичиж байв.

Санамж бичиг нь дэлхийн авлигатай тэмцэх нийгэмлэгүүдийн нэн чухал гэж тодорхойлсон асуудлуудад чиглэсэн байна. Эдгээр нь: хууль бус санхүүгийн урсгалтай тэмцэх; хөрөнгө буцаах хүчин чармайлтыг нэмэгдүүлэх, хулгайлагдсан хөрөнгийг хохирогч улсад буцааж өгөх; гадаад улсын удирдагчдын өндөр түвшний авлигад чиглэсэн; иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл болон хариуцлагын бусад төлөөлөгчдийг бэхжүүлэх; авлигатай тэмцэх арга хэмжээг гадаадын тусламжийн хөтөлбөрт тусгах; хахуулийн эрэлт талд анхаарлаа хандуулахыг олон улсын агентлаг, байгууллагуудад шахах; мөн авлигыг мөрдөн шалгадаг гадаадын хууль сахиулах байгууллагуудад үзүүлэх АНУ-ын тусламжийг нэмэгдүүлэх зэрэг юм.

Ерөнхийлөгч Байден авлигатай тэмцэх нь “АНУ-ын үндэсний аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхол” бөгөөд “ардчиллаа хадгалахад чухал ач холбогдолтой” гэж тунхаглахдаа дэлхийн хэлэлцүүлэгт нэгэн том санаа дэвшүүлсэн юм. Тэрээр клептократуудын⁵⁹ эсрэг тулалдаанд Тагнуулын төв газар, Үндэсний аюулгүй байдлын агентлаг, Сангийн яам, цэргийнхэн зэрэг АНУ-ын засгийн газрын бүх агентлагуудыг дайчлахыг үүрэг болгосон юм.

Вашингтон Пост сонины гадаад харилцааны тэргүүлэгч тоймч Дэвид Игнатиус “Хэрэв Байден нухацтай хандаж байгаа бол, шулуухан хэлэхэд энэ үнэхээр том “хэрэв” мөн бол, энэ нь АНУ-ын гадаад бодлогод мэдэгдэхүйц өөрчлөлт авчрах болно. Учир нь авлигад идэгдсэн дэлхийн олигархиуд доллароор бизнесээ хийдэг нь гашиуун үнэн юм. АНУ-д бэлтгэгдсэн хуульчид халхавч компаниудыг бий болгодог; АНУ-д боловсрол эзэмшсэн банкирууд хөрөнгөө нуухад нь тусалдаг; АНУ-ын гадаад бодлого ихэнхдээ тэдний хулгайчийг хүлцэн тэвчдэг, бүр өөгшүүлдэг. Энэ бол үнэхээр эх орноосоо эхлэх ёстой загалмайтны аян дайн юм” гэжээ. Уг Санамж бичигт “Нэр нь үл мэдэгдэгч компаниуд, санхүүгийн ил тод бус систем, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь хууль бус баялгийг зөөвөрлөх, угаах, тэр дундаа АНУ болон хууль дээдлэх зарчимд суурилсан бусад ардчилсан орнуудад үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байна” гэсэн нь АНУ энэхүү үл үзэгдэх залилангийн сүлжээг идэвхжүүлэхэд тусалж байгаагаа хүлээн зөвшөөрсөн хэрэг юм. Энэхүү санаачилга нь Женев, Кайманы арлууд, мөн Нью Йорк хот зэрэг газарт байрлах зарим банкир болон хуульчдад хүндээр тусах ёстой гэж найдаж байгаагаа Дэвид Игнатиус бичсэн байна.

“Авлига бол бидний цаг үеийн дэлхийн бодит байдал юм. Хар нисдэг тэрэг хөлөглөсөн алан хядагч бүлэглэлүүд, корпорацууд, олон улсын байгууллагууд улс үндэстний эрх мэдлийг авсангүй. Харин улс дамнасан хулгайн эзэнт гүрнийг бий болгосон олигархи, луйварчдын анархи засаглал түүнийг халж орхисон” хэмээн Байденy санаачилгыг амжилттай хэрэгжүүлэх хэтийн төлвийн тухай

⁵⁷ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.whitehouse.gov/briefing-room/presidential-actions/2021/06/03/memorandum-on-establishing-the-fight-against-corruption-as-a-core-united-states-national-security-interest/>

⁵⁸ <https://www.washingtonpost.com/opinions/2019/09/10/want-stop-dirty-money-flowing-into-us-tell-congress-pass-this-law/>

⁵⁹ Клептократ гэдэг нь хувьдаа баяжиж хөлжихийг нэн тэргүүнд тавьдаг, төрийн албан тушаалыг хувийн ашиг хонжоо олох зорилгоо хэрэгжүүлэх, авлига авахад ашигладаг хангалттай эрх мэдэл бүхий улс орны удирдагч, Засгийн газрын өндөр албан тушаалтанд хамаарах нэр томъёо юм.

“Авлигатай тэмцэх Байдены төлөвлөгөөнд шүд байх шиг байна. Хазаж чадна л гэж найдъя”⁶⁰ нэртэй нийтлэлдээ Дэвид Игнатиус бичжээ.

Уг Санамж бичиг нь луйварчдын талаар илүү сайн тагнуулын мэдээлэл цуглуулах, тэдний компани, үйл ажиллагааг илчлэх, хулгайлагдсан хөрөнгийг буцаах шинэ арга хэрэгслийг санал болгож байна. Манай улс АНУ-ын холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, ялангуяа, хөрөнгө буцаах ажиллагааны тал дээр эхний алхмууд хийгдсэн. Цаашид зөвхөн хөрөнгө буцаах төдийгүй авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх бусад чиглэлээр Ерөнхийлөгч Байдены засаг захиргаатай хамтран ажиллахад энэхүү Санамж бичиг өргөн боломж нээж өгч буй юм.

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ НЬ АНУ-ЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ҮНДСЭН АШИГ СОНИРХОЛ БОЛОХ ТУХАЙ САНАМЖ БИЧИГ

1-р хэсэг. Бодлого. Авлига нь олон нийтийн итгэлийг алдагдуулдаг; үр дүнтэй засаглалыг сулруулдаг; зах зээл, үйлчилгээний тэгш хүртээмжийг гажуудуулдаг; хөгжлийн хүчин чармайлтыг бууруулдаг; үндэсний хэврэг байдал, хэт даврагч үзэл, шилжилт хөдөлгөөнийг өөгшүүлдэг; мөн дэлхий даяар дарангуйлагч удирдагчдын ардчиллыг сүйрүүлэх арга хэрэгсэл болдог. Удирдагчид улс орныхоо иргэдээс хулгай хийх юм уу олигархиуд хууль дээдлэх ёсыг зөрчихөд эдийн засгийн өсөлт удааширч, тэгш бус байдал улам бүр нэмэгдэж, засгийн газарт итгэх итгэл буурдаг.

Зөвхөн санхүүгийн хувьд л гэхэд авлигын хохирол асар их байна. Авлигын үйлдлүүд дэлхийн ДНБ-ий 2-5 хувийг эзэлдэг гэсэн тооцоо бий. Энэ зардал дэлхий даяар жигд хуваарилагддаггүй ч эрх мэдлээ хувийн ашиг сонирхлын үүднээс урвуулан ашиглах, төрийн өмчийг завших, хахууль болон бусад төрлийн авлигын хэлбэрүүд улс орон, нийгэм бүрд нөлөөлдөг. Эдгээр үйлдлээс олсон орлого нь улсын хилийг давж, анх үүссэн газраасаа хол байгаа эдийн засаг, улс төрийн тогтолцоонд ч нөлөөлж болзошгүй. Нэр нь үл мэдэгдэгч компаниуд, санхүүгийн ил тод бус систем, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгчид нь хууль бус баялгийг зөөвөрлөх, угаах, тэр дундаа АНУ болон хууль дээдлэх зарчимд суурилсан бусад ардчилсан орнуудад үйл ажиллагаа явуулах боломжийг олгож байна.

Авлига нь АНУ-ын үндэсний аюулгүй байдал, эдийн засгийн тэгш байдал, ядуурлын эсрэг болон хөгжлийн төлөөх дэлхий нийтийн хүчин чармайлт хийгээд ардчилалд өөрт нь заналхийлж байна. Гэхдээ авлигаас үр дүнтэй урьдчилан сэргийлж, тэмцэж, ил тод, хариуцлагатай засаглалын давуу талыг харуулснаар бид АНУ болон бусад ардчилсан орнуудын хувьд чухал давуу талыг баталгаажуулж чадна.

Энэхүү Үндэсний аюулгүй байдлын санамж бичгийг гаргахдаа би авлигатай тэмцэх үйл ажиллагааг АНУ-ын үндэсний аюулгүй байдлын үндсэн ашиг сонирхол гэж тодорхойлсон. Миний засаг захиргаа сайн засаглалыг дэмжих хүчин чармайлтыг удирдан чиглүүлэх болно; АНУ-ын болон дэлхийн санхүүгийн системд ил тод байдлыг бий болгоно; дотоодод болон гадаадад авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэнэ; мөн авлигачдыг үйл ажиллагаагаа хамгаалахад улам төвөгтэй болгоно.

2-р хэсэг. Стратеги. Иймд, би Ерөнхийлөгчийн Эдийн засгийн бодлогын туслах, Ерөнхийлөгчийн Дотоод бодлогын туслахтай хамтран Үндэсний аюулгүй байдлын санамж бичиг/ҮАБСБ-2 (Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тогтолцоог шинэчлэх)-ын хүрээнд агентлаг хоорондын шинжилгээ хийхийг Ерөнхийлөгчийн туслах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөхөд даалгаж байгаа ба Ерөнхийлөгчийн стратегийг боловсруулж, хэрэгжүүлснээр АНУ-ын засгийн газрын дараах боломжийг нэмэгдүүлэх болно:

- (a) Гүйцэтгэх засаглалын үндсэн хэлтэс, агентлагууд, тэр дундаа шинжилгээнд хамрагдсан болон доор жагсаасан агентлагуудын сайн засаглалыг дэмжих, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх чадамжийг шинэчлэх, нэмэгдүүлэх, зохицуулах, нөөц бүрдүүлэх, бусад хэлбэрээр сайжруулах, үүнд шаардлагатай бол холбогдох хууль тогтоомжийг Конгресст санал болгох;
- (b) АНУ болон олон улсын санхүүгийн систем дэх хууль бус санхүүжилтийн бүх хэлбэртэй тэмцэх, тэр дундаа АНУ-ын компаниуд өөрсдийн ашиг хүртэгч өмчлөгч буюу эзэмшигчийг Сангийн яаманд тайлагнаж байхыг шаарддаг Холбооны хуулийг баттай хэрэгжүүлэх; оффшор

⁶⁰ <https://www.washingtonpost.com/opinions/2021/06/03/bidens-trying-crack-down-international-corruption-lets-hope-it-works-this-time/>

санхүүгийн нууцыг багасгах; мэдээлэл солилцох чадварыг сайжруулах; шаардлагатай бол шинэ шинэчлэл хийх хэрэгцээг тодорхойлох;

- (с) Авлигач хүмүүс, үндэстэн дамнасан гэмт хэргийн байгууллага, тэдгээрийн зохион байгуулагчдад хариуцлага тооцох, түүний дотор, шаардлагатай бол, мэдээлэл солилцох, тагнуулын мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, эрүүгийн болон иргэний хууль сахиулах ажиллагаа, зөвлөгөө, шийтгэл болон бусад эрх бүхий байгууллагын тусламжтайгаар хулгайлагдсан хөрөнгийг илрүүлэх, царцаах, эргүүлэн авах; боломжтой бөгөөд тохиромжтой бол, буцаан авсан хөрөнгийг авлигын улмаас хохирсон иргэдийн ашиг тусын тулд эргүүлэн олгох;
- (d) Авлигатай тэмцэх дэлхий нийтийн хэм хэмжээг тогтоох, хөрөнгө буцаах, санхүүгийн ил тод байдлыг дэмжих, нээлттэй засаглалыг сайшаах, хөгжлийн санхүүжилтийн төслүүд дэх авлигаас урьдчилан сэргийлэх санхүүгийн институцийн хүрээг бэхжүүлэх, мөнгө угаах, хууль бус санхүүжилт, хахууль, түүний дотор боломжтой бол, хахуулийн эрэлт талтай тэмцэхэд чиглэсэн дотоодын болон олон улсын институцууд, олон талт байгууллагуудын чадавхыг нэмэгдүүлэх;
- (e) Авлигын чиг хандлагын талаар судалгаа, дүн шинжилгээ хийх, урьдчилан сэргийлэх, авлигыг мөрдөн шалгах, илрүүлэх үйл ажиллагааг дэмжих, удирдагчдад хариуцлага тооцох, засгийн газрын хариуцлага, шинэчлэлийн хүчин чармайлтыг мэдээлэх, дэмжихэд иргэний нийгэм, хэвлэл мэдээлэл болон бусад хяналт, хариуцлагын оролцогчдын чадавхыг дэмжиж, бэхжүүлэх, эдгээр оролцогчид дотоодод болон олон улсын хэмжээнд аюулгүй, нээлттэй үйл ажиллагаа явуулах орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллах;
- (f) Гадаадын удирдагчид, гадаадын төрийн өмчит болон хамаарал бүхий аж ахуйн нэгжүүд, үндэстэн дамнасан гэмт хэргийн байгууллага, бусад гадаадын оролцогчид болон тэдгээрийн дотоодын хамтран ажиллагсдын стратегийн авлигатай тэмцэхийн тулд АНУ болон хилийн чанад дахь ардчилсан үйл явцад хөндлөнгөөс оролцоход эдгээр оролцогчдын ашиглаж буй цоорхойг хаах замаар олон улсын түншүүдтэй хамтран ажиллах;
- (g) Авлигыг бууруулах хүсэл эрмэлзэлтэй байгаа гадаад орнуудад үзүүлэх мөрдөн шалгах, санхүү, техник, улс төрийн болон бусад тусламжийн АНУ-ын болон түншийн нөөцийг хурдан бөгөөд уян хатнаар нэмэгдүүлэх хүчин чармайлтыг өсгөх;
- (h) Авлигатай тэмцэх болон засгийн газрын хөтөлбөр, бодлого, зардлын талаарх хүртээмжтэй, хэрэгцээтэй мэдээллээр иргэдээ хангах ил тод байдал, хяналт, хариуцлагын арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь дотоодын (муж болон орон нутгийг оролцуулан) эрх баригчид, байгууллагууд, түүнчлэн түнш болон бусад гадаадын засгийн газруудад бүх түвшинд туслах, чадавхыг бэхжүүлэх;
- (i) Авлигатай тэмцэх арга хэмжээг дэмжих, авлигаас урьдчилан сэргийлэх зорилгоор хувийн хэвшил, иргэний нийгмийн түншлэлийг дэмжих; болон
- (j) Гадаадын тусламж, аюулгүй байдлын хамтын ажиллагааны үйл ажиллагаанд авлигаас урьдчилан сэргийлэх цогц арга хэмжээг агуулсан шилдэг туршлага, хэрэгжилтийн механизмыг бий болгох.

3-р хэсэг. Агентлаг хоорондын шинжилгээ. Энэхүү санамж бичигт заасны дагуу агентлаг хоорондын шинжилгээнд шинжээчдийн судалгааны зөвлөмжийг харгалзан үзэж, дараах агентлаг, газрын төлөөлөгчдийг оролцуулна:

- (a) Дэд ерөнхийлөгчийн Тамгын газар;
- (b) Төрийн департамент;
- (c) Төрийн сангийн яам;
- (d) Батлан хамгаалах яам;
- (e) Хууль зүйн яам;
- (f) Худалдааны яам;
- (g) Эрчим хүчний яам;

- (h) Дотоодын аюулгүй байдлын яам;
- (i) Удирдлага, төсвийн алба;
- (j) Нэгдсэн Үндэстний Байгууллага дахь АНУ-ын Төлөөлөгчийн газар;
- (k) Үндэсний тагнуулын газрын даргын алба;
- (l) Тагнуулын төв газар;
- (m) Штабын дарга нарын нэгдсэн хорооны даргын алба;
- (n) АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг; болон
- (o) Үндэсний аюулгүй байдлын агентлаг.

Гүйцэтгэх яам, агентлагууд Ерөнхийлөгчийн туслах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөхөөс агентлаг хоорондын шинжилгээтэй холбоотой мэдээлэл, дүн шинжилгээ, туслалцаа хүссэн бүх хүсэлтийг хариуцан ажиллана. Байгууллага хоорондын шинжилгээг энэхүү санамж бичигт гарын үсэг зурснаас хойш 200 хоногийн дотор хийж дуусгах бөгөөд Ерөнхийлөгчийн туслах, Үндэсний аюулгүй байдлын зөвлөх нар тайлан, зөвлөмжийг Ерөнхийлөгчид хүргүүлж цаашид чиглэл, арга хэмжээ авна.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй тэмцэх хууль ба гэм буруугийн зарчим⁶¹

2021.07.27. Andrew Dornbierer. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт үйлдэлд чиглэсэн хууль олон улсын түвшинд өргөн дэлгэрсэн байдаг. Өнөөдрийн байдлаар 98 шүүхийн харьяалалд үндэслэлгүйгээр хөрөнгөжихийг зохицуулсан ямар нэг хууль үйлчилж байна. Энэхүү хуулийн хамрах хүрээ болон зохицуулалт нь олон шинж чанартай байдаг, жишээлбэл, зарим хуульд гэмт хэрэгт тооцож ял оногдуулдаг байхад зарим тохиолдолд иргэний хуулиар зохицуулж, хөрөнгийн эх үүсвэрийг тодорхойлж чадахгүй тохиолдолд засгийн газраас тус хөрөнгийг хураах арга хэмжээг авдаг байна. Эдгээр хуулийн нийтлэг чанар нь прокурор хууль бус үйл ажиллагааны үр дүнд үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэдгийг тогтоох шаардлагагүй байдаг юм. Харин үндэслэлгүйгээр олж авсан хөрөнгө тус этгээдийн хууль ёсны орлого биш гэдгийг л засгийн газар нотлох шаардлагатай байдаг.

Энэхүү шинж чанар нь удаан хугацаанд шүүмжлэлд өртсөөр байгаа юм. Шүүмжлэгчдийн үзэж буйгаар хууль бус үйл ажиллагааны үр дүнд тус хөрөнгийг олж авсан гэдгийг нотлох шаардлагагүй байгаа нь хэрэгт холбогдогчдод өөрийн гэм буруугүйг нотлох үүрэг олгодог сөрөг талтай болно. Үүнээс улбаалан, зарим орон үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй тэмцэх хуулийг батлахаас татгалзаж байна. АЭНҮБК-д дурдсанаар оролцогч орнууд үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй тэмцэх хуулийг батлахыг зөвлөсөн байдаг боловч хэлэлцээрийн үед багагүй улсын төлөөлөгчид өөрийн улсын үндсэн хуульд заасан эрхийн дагуу энэхүү хуулийг батлахад хүндрэл бэрхшээл үүсч буйг илэрхийлсэн байдаг. Авлигатай тэмцэх тухай Америкийн улс хоорондын конвенцын⁶² төслийг боловсруулах явцад мөн үүнтэй төстэй асуудал үүсч байсан бөгөөд төгсгөлд нь мөн л тус хуулийг батлахыг зөвлөсөн байдаг. АНУ тус конвенцод нэгдэн орох үед “*Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт үйлдэл нь хэргийн холбогдогч этгээдэд өөрийгөө гэм буруугүйг нотлох үүрэг хүлээлгэдэг. Энэ төрлийн гэмт хэрэг нь АНУ-ын Үндсэн хуулийн ерөнхий зарчим болон эрх зүйн системд үл нийцэж байна*” гэх тодорхой тайлбар хийсэн байна. Түүнчлэн 2019 оны 02 дугаар сард Украин улсын үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй тэмцэх дотоодын хуулийг гэм буруугийн зарчимтай зөрчилдөж байгаа тул Үндсэн хуулийн шүүхээс хүчингүй болгожээ.

Үндэслэлгүйгээр хөрөнгөжихтэй тэмцэх хууль нь хэргийн холбогдогчид өөрийн гэм буруугүйг нотлох үүргийг шударга бусаар олгож, гэм буруугийн зарчмыг үнэхээр алдагдуулж байгаа юу?

Товчоор хариулбал, “үгүй”.

⁶¹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/07/27/guest-post-illicit-enrichment-laws-and-the-presumption-of-innocence/>

⁶² Inter-American Convention Against Corruption (IACAC)

Энэхүү асуудлыг шалган шийдвэрлэсэн ихэнх улсын шүүх байгууллагаас тус хууль нь гэм буруугийн зарчимтай зөрчилдөөгүй гэж дүгнэсэн байдаг. Жишээлбэл, Аргентин улсын Эрүүгийн хэргийн үндэсний шүүхээс тус хууль нь гэм буруугийн зарчмыг алдагдуулж буй гэх гомдлыг шалгаж удаа дараа буцаасан байдаг. Үндэслэлгүйгээр хөрөнгөжих гэмт хэрэг нь хэргийн холбогдогч эд хөрөнгө хууль бусаар олж авж буй шууд үйлдэлтэй бөгөөд, эс үйлдэхгүйгээр үйлддэг гэмт хэрэг биш тул өөрийн гэм буруугийг нотлох үйлдэл нь хуульд заасан үүргийг хэргийн оролцогчид шударга бусаар оногдуулж буй арга хэрэгсэл биш гэж шүүхээс үзсэн байна. Иймээс прокурор нь хэргийн холбогдогчийн үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн хөрөнгө нь түүний хууль ёсны орлогоос үүсэлтэй биш гэдгийг л нотлох шаардлагатай юм. Иймд гэм буруугийн зарчим огт алдагдаагүй байна хэмээн тайлбарласан байна.

Бусад улс орнуудын шүүх байгууллага тус хуулийг олон үндэслэлээр тайлбарласан байдаг. Аргентины шүүхийн тайлбараас гадна эдгээр улсын шүүхүүд өөрийн гэм буруугийг нотлох үүргийг хэргийн холбогдогчдод оногдуулах нь оновчтой бөгөөд энэ тохиолдолд гэм буруугийн зарчмыг үгүйсгэх онцгой нөхцөл үүссэн байдаг гэж үзсэн байна. Хэдийгээр олон хуульч энэ тайлбартай санал нийлдэггүй боловч Европын хүний эрхийн шүүхээс тус тайлбарыг дэмжиж, гэм буруугийн зарчим нь халдашгүй эрх биш гэж үзжээ. Цаашлаад, АНУ-ын Дээд шүүхээс энэхүү арга хэмжээ нь онцгой нөхцөл байдалд хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагаа гэж тайлбарласан байдаг.

[АНУ-ын Конгресс авлигач, ардчилсан үзэл баримтлалын эсрэг этгээдүүдийн жагсаалтыг шинэчилнэ⁶³](#)

2021.09.20. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга авлигач, ардчилсан үзэл баримтлалын эсрэг этгээдийн жагсаалт гэж нэрлэгдэх Хойд гурвалжингийн оролцоог сайжруулах тухай хуульд заасны дагуу холбогдох жагсаалтыг шинэчилж, Конгресст шилжүүлсэн тухай мэдэгдэв. Уг шинэчлэлд ардчилсан үйл явц, институцийг сүйтгэсэн гэх Эл Сальвадорын Дээд шүүхийн үндсэн хуулийн танхимын таван шүүгч (Оскар Альберто Лопес Жерез, Элси Дуенас Ловос, Хосе Ангел Перез Чакон, Луис Хавьер Суарез Магана, Эктор Нахун Мартинес) багтсан байна.

Авлигач, ардчилсан үзэл баримтлалын эсрэг этгээдүүдийн жагсаалт нь 2020 оны 12 дугаар сард АНУ-ын Конгрессоор батлагдсан бөгөөд Эл Сальвадор, Гондурас, Гватемал дахь ардчиллыг дордуулж буй авлигын гэмт хэрэгт холбогдсон хүмүүстэй тэмцэхэд зориулагдсан хэрэгсэл юм.

Дээрх хуульд заасны дагуу уг жагсаалтад нэр нь орсон этгээд АНУ-ын виз авах, хилээр нэвтрэх боломжгүй болдог.

Африк тив

[Хууль тогтоогчдод халдашгүй эрх олгох нь авлигын эсрэг Бухаригийн төлөвлөгөөг нураана хэмээн Колаволе Оланиан⁶⁴ бичжээ⁶⁵](#)

2020.03.03. 2018 онд Нигерийн Ерөнхийлөгч Мухаммеду Бухари (Muhammadu Buhari)-ийг Африкийн Холбооноос анх “Африкийн авлигын эсрэг үйл ажиллагааны аварга” гэж нэрлэсний дараа тэрээр ил тод байдал болон хариуцлагыг бататгахад хөрөнгө оруулахыг гишүүн орнуудад уриалсан. Гэвч түүний харьяалагддаг улс төрийн намын⁶⁶ олон хууль тогтоогчийн зүгээс өөрсдийгөө шүүхийн мөрдлөг болон авлигын хэрэгт яллагдахаас дархлахыг шаардаж буй нь авлигатай тэмцэх тухай Ерөнхийлөгчийн амлалтыг ганхуулж байна.

⁶³ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://sv.usembassy.gov/u-s-congress-updates-corrupt-and-undemocratic-actors-list-section-353/>

⁶⁴ Kolawole Olaniran, “Африк дахь авлига ба хүний эрхийн хууль” номын зохиогч, Лондон дахь Эмнести Интернэшнлийн Нарийн бичгийн дарга нарын газрын хуулийн зөвлөх.

⁶⁵ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.thisdaylive.com/index.php/2020/03/03/immunity-for-lawmakers/>

⁶⁶ All Progressives Congress Party (APCP)

1999 онд батлагдсан Нигерийн Үндсэн хуулийн 308 дугаар зүйл буюу хууль тогтоох байгууллагын удирдах ажилтнуудын халдашгүй эрх олгох тухай заалтыг шинэчилсэн хуулийн төсөл нь төлөөлөгчдийн танхимын хурлын 2 дахь хэлэлцүүлгийг даваад байна. Энэхүү хуулийн өөрчлөлтөд Үндэсний Ассемблей (ҮА)-н бүх удирдлага болон орон нутгийн удирдлагуудыг ажиллаж байх хугацаанд нь халдашгүй эрх олгохоор тусгасан.

308 дугаар зүйлд Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, хотын дарга, орон нутгийн дарга болон орлогч дарга нарын эсрэг иргэний болон эрүүгийн хэрэг үүсгэж шалгахыг тэдний үүрэгт хугацаанд хориглосон байна.

Анх 2016 онд энэ асуудал яригдаж эхэлсэн ч олон нийтийн дургүйцлээс шалтгаалан буцаагдсан. Хэрэв Үндсэн хуульд энэхүү өөрчлөлт орвол ТИ байгууллагаас гаргадаг АТИ-т муугаар нөлөөлөөд зогсохгүй Нигерийн хүний эрхийн асуудалд сөрөг нөлөө үзүүлнэ.

Энэ баримт бичиг батлагдсанаар 1999 оны ардчиллын дараа ҮА-д шургалсан хууль тогтоогчид түүний дотор авлигын хэрэгт холбогдсон засаг дарга нарыг дархлах болно. Зарим хууль тогтоогчид энэхүү баримт бичиг батлагдсанаар тэднийг үндэслэлгүйгээр буруутган сүрдүүлэх хэргээс хамгаална гэж үзэж байна.

Парламентын гишүүд нь парламентын хурал дээр хэлсэн зүйлдээ иргэний болон эрүүгийн хуулийн хариуцлага хүлээхгүй гэсэн хууль 2018 онд батлагдсан. Энэ нь парламент дахь нээлттэй мэтгэлцэх боломжийг олгох давуу талтай бөгөөд АНУ болон Их Британийн улс төрчдийн нөхцөл байдалтай ижил байна.

Гэсэн хэдий ч, энэ үйлдэл нь хууль тогтоогчдийг авлигын болон бусад онц ноцтой гэмт хэрэгт холбогдуулан яллахаас бүрэн хамгаалж чадахгүй.

Харин одоо хэлэлцэгдэж буй Үндсэн хуулийн 308 дугаар зүйлийн нэмэлт өөрчлөлт нь хууль тогтоогчдийг иргэний болон эрүүгийн хэрэгт шүүх ажиллагаанаас хамгаалж, халдашгүй эрх олгох юм.

Хууль тогтоогчдод халдашгүй эрх олгох нь Нигери улсын авлигын түүх, өв уламжлал, хүний эрхийн асуудлыг үл тоомсорлосон хэрэг бөгөөд энэ нь мөн НҮБ-ын болон Хамтын нийгэмлэгийн (Commonwealth) гишүүн орон болох Нигерийн хувьд олон улсын өмнө хүлээсэн үүрэгтэй зөрчилдөж байна.

Төлөөлөгчдийн танхимын гишүүд Үндсэн хуулийн 308 дугаар зүйлийг хасах, эсвэл авлигын болон бусад ижил төрлийн гэмт хэргүүдийг хязгаарлахыг зогсоох хэрэгтэй гэж үзэж байна.

Эдийн засаг, нийгэм, соёл, иргэний, улс төрийн эрхээс үл хамааран хүний эрхийг авлигын замаар хязгаарлаж болно. Авлига их байх тусам хүний эрхийг хамгаалах түвшин бага байна. Жишээ нь, хүний нөөцийн болон нийтийн үйлчилгээний менежмент дэх авлига хүмүүсийн боловсрол, эрүүл мэнд болон бусад эрхийг хязгаарладаг.

Ерөнхийлөгч Мухаммеду Бухари авлигын эсрэг амлалтдаа хүрч, энэ хуулийн төслийг няцаах ёстой. Ноён Бухари засгийн газар болон олон улсын өмнө хүлээсэн үүрэг хариуцлага, хууль тогтоомжийг дагаж мөрдөх цаг болсон.

[Худалдан авах ажиллагааны тухай хуулийн төсөлд авлигатай тэмцэхэд шаардагдах зүйл, заалт хангалттай тусгагдаагүй](#)⁶⁷

2020.11.02. Өмнөд Африк. Худалдан авах ажиллагаа (ХАА)-нд бодит шинэчлэл хийх шийдвэр гаргах нь улс төрийн хувьд бэрхшээлтэй байдаг хэдий ч нийгмийн шударга ёсонд зорьж буй тохиолдолд бол хялбар зүйл юм.

Хөгжиж буй орнуудын хувьд төрийн ХАА нь авлигын хамгийн том эрсдэл байдаг⁶⁸. ТИ байгууллагын тооцоолсноор бага болон дунд орлоготой орнуудын засгийн газрууд төсвийн хөрөнгийнхөө 50 орчим хувийг хувийн хэвшлээс бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулдаг

⁶⁷ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://citizen.co.za/news/south-africa/society/2378452/draft-procurement-bill-falls-short-of-whats-required-to-fight-corruption/>

⁶⁸ https://www.oecd-ilibrary.org/governance/oecd-foreign-bribery-report_9789264226616-en;jsessionid=nODEosMJdBbEvHg8b9Lh0sYN.ip-10-240-5-45

бол өндөр орлоготой орнуудын хувьд 30 орчим хувийг ийм төрлийн бараа, үйлчилгээ худалдан авахад зарцуулдаг байна.

Тиймээс хөгжиж буй орнуудын төрийн ХАА-ны систем нь авлигын асуудалд нэн эмзэг байдаг нь гайхах зүйл биш юм.

Энэ асуудал ӨАБНУ-д ч мөн хамаатай. ХАА-ны асуудлыг зохицуулсан хуулиудын хуваагдмал байдал нь үр ашиггүй зохицуулалт, олон нийтийн хяналтад нөлөөлсөн нь дамжиггүй.

Тус улсын саяхан өргөн барьсан төрийн ХАА-ны тухай хуулийн төсөл нь нэгдсэн зохицуулалтын тогтолцоог бий болгохыг зорьж байгаа нь сайшаалтай юм. Гэсэн хэдий ч хуулийн төсөлд нууцлалтай холбоотой заалтууд оруулсан нь эсрэгээрээ, эргэлзээ төрүүлж байна.

Уг хуулийн төсөлд судлаачид болон иргэний нийгмийн байгууллагууд санал өгөхдөө одоогийн энэ хэлбэрээр байвал авлига болон үр ашиггүй худалдан авалт хийх боломж үргэлжилсээр байх болно гэжээ.

Шинээр гарч ирж буй ардчиллын хөгжлийн хэрэгцээг хангахад шаардлагатай олон нийтийн хяналтыг дэмжих үүднээс хуулийн төслийг засахад оройтоогүй байна.

Хуулийн төсөлд нууцлалыг нэмэгдүүлэх, олон нийтийн оролцоог хязгаарлахын оронд ил тод байдал, олон нийтийн хяналтыг тусгах ёстой.

ӨАБНУ төсвийн үйл явцыг ил тод байлгах чиглэлээр ахиц дэвшил гаргасан. Жишээлбэл, Нигерийн Сангийн сайд асан Нгози Оконжо-Ивеала саяхан ӨАБНУ-ын засгийн газрын төсвийн ил тод байдлын түвшнийг өндрөөр үнэлсэн юм.

Гэсэн хэдий ч зөвхөн төсвийн ил тод байдал нь удирдлагын буруу шийдвэр болон хууль бус үйлдлийн эсрэг тэмцэхэд хангалтгүй.

Нээлттэй, ил тод байдал нь худалдан авалт, зарцуулалтын дата мэдээллээр өргөжих ёстой. Энэ нь олон нийтийн идэвхтэй оролцоо, хяналтыг дэмжсэн механизмд суурилсан байх шаардлагатай юм.

Худалдан авалт нь үндсэн зорилгодоо нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах хамгийн сайн арга бол бүх тендер, гэрээг олон нийтэд нээлттэй байршуулах явдал юм. ӨАБНУ үүний зарим хэсгийг л хэрэгжүүлж байна.

Гэхдээ нийтэд тархаасан КОВИД-19-тэй холбоотой худалдан авалтын талаарх мэдээлэл нь иж бүрэн биш юм. Үүнтэй холбоотойгоор Ерөнхийлөгч Кирилл Рамафоса Тусгай мөрдөн байцаах албанд төрийн байгууллагуудын КОВИД-19-тэй холбоотой бараа, үйлчилгээний бүх худалдан авалтыг шалгахыг зөвшөөрсөн тунхаг бичигт гарын үсэг зурсан.

Үүний дараа төрийн байгууллагуудад КОВИД-19-тэй холбоотой тендерийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл ирүүлэх шаардлага тавих болсон. Энэхүү худалдан авалтын мэдээллийг тархах нь чухал алхам боловч илүү ихийг хийх шаардлагатай байна.

Ерөнхий аудиторуудын тусгай тайланд хийсэн шалгалтаар “хэт өндөр үнийн шинж тэмдэг, шударга бус үйл явц, гарч болзошгүй залилан, нийлүүлэлтийн сүлжээний менежментийн хууль тогтоомжийг орхигдуулж” байгаа зэрэг зөрчлүүд тогтоогдсон. Ерөнхий аудиторуудын хийсэн дүгнэлт нь төрийн байгууллагуудын ХАА-н дахь хяналт сул, найдваргүй орчинд явагдаж байгааг харуулж байна.

[Нигери улсын ойн аж ахуй болон загас агнуурын салбар дахь авлигатай тэмцэх ажиллагаа](#)⁶⁹

2021.02.19. Ubong Udoye. Нигери улс газрын тос, байгалийн хий олборлодог гэдгээрээ дэлхий дахинд алдартай боловч хөдөө аж ахуйн салбар түүний дотор ойн аж ахуй болон загас агнуурын салбар нь тус улсын ДНБ-ий 21 гаруй хувийг бүрдүүлж байна. Нигери улсын хөгжилд ойн аж ахуй болон загас агнуур нь үр өгөөжөө өгч байгаа хэдий ч эдгээр салбар дахь авлига, хахуулиас үүдсэн хууль бус үйл ажиллагаа орон нутгийн иргэдийн тогтвортой байдлыг алдагдуулж, байгаль

⁶⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/02/19/fighting-corruption-in-nigerias-forestry-and-fishery-industries/#more-17414>

орчинд хор хөнөөл учруулж болзошгүй болоод байна. Хууль бус үйл ажиллагааны дараах хоёр чиглэл онцгой анхаарал татаж байна.

Хууль бус мод бэлтгэл

Нигери улс дэлхийн болон Африк тивийн хэмжээн дэх хамгийн том мод экспортлогч орнуудын нэг юм. Гэхдээ Нигерийн хилээр дамжин гарч буй бараг бүх экспортын сарнай мод (Rosewood)-ыг хууль бусаар бэлтгэсэн байдаг. Нутгийн амхари хэлээр косо гэгддэг сарнай модыг Ховордсон зүйлийн олон улсын худалдааны тухай конвенц (ХЗОУХТК)-д⁷⁰ бүртгэсэн байдаг бөгөөд косогийн бүх экспортыг ХЗОУХТК-ын үндэсний эрх бүхий байгууллагаас албажуулсан албан ёсны баримт бичгийг дагалдуулахыг шаарддаг. Энэхүү баримт бичиг нь модыг хууль ёсны дагуу бэлтгэсэн болохыг баталгаажуулдаг бөгөөд уг баримт бичиггүй бол импортлогч улсын гаалийн ажилтнууд хураан авах ёстой юм. Гэхдээ Байгаль орчны хэргийг мөрдөн шалгах газрын 2017-2018 оны тайланд дурдсанаар хууль бусаар мод бэлтгэгчид эдгээр болон бусад хязгаарлалтаас зайлсхийхийн тулд их хэмжээгээр авлигадаа арга замыг ашиглаж байна. Жишээлбэл, Байгаль орчны хэргийг мөрдөн байцаах газрын байцаагчид Нигери улсын болон БНХАУ-ын нөлөө бүхий бизнесменүүд ХЗОУХТК-ын дагуу шаарддаг баримт бичгийг хууль бусаар гаргуулсныхаа төлөө Нигери улсын өндөр албан тушаалтнууд түүний дотор сайд, конгрессын гишүүдэд нэг сая гаруй долларын хахууль өгч байсныг илрүүлжээ. Нэмж дурдахад, хууль бусаар мод бэлтгэгчид орон нутгийн албан тушаалтнуудад хахууль өгч тусгай хамгаалалттай бүсэд мод бэлтгэх зөвшөөрөл авсан байна. Энэхүү хууль бус ажиллагаанаас ашиг олох гэсэн Нигерийн цагдаагийн алба хаагчид сарнай мод тээвэрлэж буй жолооч нараас хахууль авахын тулд хяналтын цэгүүдийг ажиллуулж эхэлжээ. Нигери улсын ойн аж ахуйн салбарт бугшсан авлигын нүсэр тогтолцоо нь ой модны хэмжээг хурдацтай доройтуулж, улмаар дэлхийн цаг уурын өөрчлөлтөд нөлөөлнө гэж үзэж байна.



Хууль бус загас агнуур

Нигери улсын хууль тогтоомжоор Нигерийн усан хилд үйл ажиллагаа явуулдаг бүх загас агнуурын хөлөг онгоцыг тусгай зөвшөөрөлтэй байхыг шаарддаг бөгөөд далайд тор тавьсан хөлөг онгоц бүр барьсан загасныхаа тоон мэдээллийг холбогдох газарт хүргүүлэх ёстой байдаг. Эдгээр мэдээллийг загас агнуурын нөхцөл байдалд хяналт тавихад ашигладаг байна. Гэсэн хэдий ч Интерполоос явуулсан загас агнуурын гэмт хэргийн талаарх судалгаанаас үзэхэд Нигери улсын нутаг дэвсгэрийн усанд загасчлах хөлөг онгоцууд далайн эргүүлийн ажилтнуудад хахууль өгөх замаар эдгээр шаардлагаас зайлсхийдэг байна. Мөн компаниуд тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий албан тушаалтнуудад хахууль өгч хууль бусаар тусгай зөвшөөрөл авдаг гэсэн мэдээлэл байна. Авлигаас үүдэлтэй хууль бус загас агнуур нь загасны нөөцийг багасгаж, улмаар далайн эрэг орчмын ард иргэдийн уламжлалт амьжиргаанд аюул учруулж байна.

Нигери улсын засгийн газар авлигатай тэмцэх талаар үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа хэдий ч ойн аж ахуй болон загас агнуурын салбар дахь авлигатай тэмцэхэд илүү их зүйлийг хийх хэрэгтэй байна. Эдгээр салбар дахь авлигатай илүү өргөн хүрээнд тэмцэхийн тулд Нигери улсын засгийн газраас хэрэгжүүлэх ёстой хоёр алхмыг энд дурдъя.

- *Нэгдүгээрт*, Засгийн газар ойн аж ахуй болон загас агнуурын бүс нутгийн холбогдох газруудаас тусгай зөвшөөрөлтэй компаниудын жагсаалтыг тэдгээр компаниудын талаарх мэдээллийн хамт олон нийтэд дэлгэхийг шаардах замаар тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх боломжтой. Ийм жагсаалтыг ил тод

⁷⁰ Convention on International Trade in Endangered Species (CITES)

болгосноор иргэний нийгмийн хяналтын байгууллагууд болон Нигерийн засгийн газарт тусгай зөвшөөрөлтэй компаниудын тусгай зөвшөөрөл авахад тавигдах шаардлагыг хангасан эсэхийг шалган тогтоох боломжийг бүрдүүлэх бөгөөд албан тушаалтнууд хахууль авж тусгай зөвшөөрөл олгодог явдлыг бууруулж болох юм. Түүнчлэн, хэрэв компани шаардлага хангаагүй нь тогтоогдвол тусгай зөвшөөрөл олгосон албан тушаалтанд мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хууль бус үйл ажиллагаа илэрсэн тохиолдолд тухайн албан тушаалтанд шийтгэл ногдуулах боломжтой.

- *Хоёрдугаарт.* Орон нутгийн түвшний албан тушаалтнууд хахууль авдаг, хууль бус үйл ажиллагааг нүдээ анин өнгөрүүлдэг, албан үүргээ биелүүлэхээс зайлсхийдэг байдлыг шийдвэрлэхийн тулд засгийн газар мөрдөн шалгах нууц ажиллагааг өргөжүүлэх хэрэгтэй. Нигерийн засгийн газраас бусад нөхцөл байдалд ашигласан тагнуулын үйл ажиллагааг орон нутгийн албан тушаалтнуудын шударга байдлыг шалгахад ашиглаж болох юм. Жишээлбэл, хууль бус мод бэлтгэл, засаг агнуурын үйл ажиллагаа явуулах хүсэлтэй бизнес эрхлэгч гэж өөрсдийгөө итгүүлэх нууц ажилтнуудыг илгээж, албан тушаалтнуудад хахууль санал болгож болно. Ийм тусгай ажиллагаа нь зөвхөн авлигад холбогдсон албан тушаалтнуудыг илчлээд зогсохгүй энэ төрлийн хэргүүд болон засгийн газраас явуулж буй ажиллагааг нийтэд мэдээлэх болно. Энэ нь албан тушаалтнуудыг авлига, хахуулийн шинжтэй үйлдлээс урьдчилан сэргийлэх ч боломжтой.

Өмнөд Африкийн эрх баригч Африкийн үндэсний конгресс нам авлига болон бусад хэрэгт холбогдсон албан тушаалтнуудын албан тушаалыг түдгэлзүүлнэ⁷¹

2021.05.04. Хахуулийн эсрэг тус намын байр суурь иргэдийн итгэлийг дээшлүүлнэ хэмээн шинжээчид үзэж байна. Авлига болон бусад ноцтой гэмт хэрэгт холбогдсон ч огцрох хүсэлгүй байгаа намын удирдлагуудаа түдгэлзүүлэхээ Африкийн үндэсний конгресс намаас мягмар гарагт мэдэгдсэн байна. Мөн Үндэсний ажлын хорооноос дээрх шийдвэрт хамааралтай бүх гишүүдэд албан захиа хүргүүлэхээ мэдэгдээд байна.

Авлигын хэрэгт холбогдсон албан тушаалтнууд дотор тус намын өдөр тутмын үйл ажиллагааг удирддаг, намын нөлөө бүхий улс төрч, намын ерөнхий нарийн бичгийн дарга “Эйс” Магашуле (“Ace” Magashule) багтсан байна.

2009-2018 онд Ерөнхий сайдын албыг хашиж байсан Магашулэг Фри стэйт мужийн ядуусын хорооллын байшингуудаас нурангийн чулуу зайлуулах 15 сая долларын гэрээтэй холбон буруутгаж байгаа аж. Тэрээр өөрийгөө авлигын асуудалд хамааралгүй гэж мэдэгдсэн.

Африкийн үндэсний конгресс намын Гүйцэтгэх зөвлөлийн гуравдугаар сарын 26-29-нд болж өнгөрсөн хуралдаанаас авлига болон бусад ноцтой гэмт хэрэгт холбогдсон намын гишүүнийг албан тушаалаас чөлөөлөх тухай тогтоол гарсан байна. Гэтэл тус намын зарим албан тушаалтнууд уг тогтоолыг хэрэгжүүлэхгүй байгаа бөгөөд үүнд Магашулэ ч багтсан.

Африкийн үндэсний конгресс намын Ёс зүйн хороо өнгөрсөн жил Магашулэгийн холбогдсон авлигын хэрэг шийдвэрлэгдэх хүртэл албан тушаалаа өгөхийг түүнд зөвлөж байв.

Намын Гүйцэтгэх зөвлөлийн шийдвэрийг заавал биелүүлэх ёстой ба биелүүлээгүй албан тушаалтныг огцруулна хэмээн мэдэгдсэн. Арьс өнгөөр ялгаварлах үзэлтэй тэмцэн, Африк тивийн хамгийн өндөр хөгжилтэй эдийн засаг бүхий улсад ардчилал авчирсан тус нам засгийн эрхийг 1994 оноос хойш барьж байгаа бөгөөд намын хэд хэдэн албан тушаалтнууд авлигын хэрэгт холбогдсон нь тус намын нэр хүндийг унагаж байгаа аж.

Авлигын талаар тус намын баримталж буй хатуу байр суурь нь орон нутгийн сонгуулийн өмнө өөрийн эгнээг ужиг болсон авлигын асуудлаас салгах, олон нийтийн дэмжлэгийг олж авах алхам хэмээн шинжээчид үзэж байна.

⁷¹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/africa/south-africa-s-ruling-anc-to-suspend-officials-facing-corruption-other-cases/2229687>

Европ тив

Украины засгийн газар авлигын эсрэг стратеги боловсруулж, хэрэгжүүлэхээр төлөвлөж байна⁷²

2020.06.15. Украины засгийн газар авлигын эсрэг стратеги боловсруулж, парламентад өргөн барихаар төлөвлөж байгаа талаар сайд нарын танхимын үйл ажиллагааны хөтөлбөрт дурдсан гэж Укринформ мэдээлж байна.

Авлигын эсрэг засгийн газрын төлөвлөгөөнд иргэд, бизнес эрхлэгчид болон засгийн газар хоорондын харилцаанд хамгийн сүүлийн үеийн технологийг ашиглах замаар авлигаас урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлэх, авлигач албан тушаалтнуудыг батлан даалтгүйгээр баривчлах, эд хөрөнгийг нь хураах, төрийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасах зэрэг асуудлуудыг багтаасан байна.

Засгийн газраас аюулгүй байдал, батлан хамгаалах салбар дахь авлига, хахуулийн хэрэгт ногдуулах торгуулийн ялын хэмжээг чангаруулахаар төлөвлөж байна.

Үүний үр дүнд авлигын хэргээс үүдэн гарах хохирол хоёр дахин буурч, АТИ хамгийн багадаа 60 болно гэж засгийн газрын албан тушаалтнууд үзэж байна. Өнгөрсөн онд тус улсын АТИ 30 байсан юм.

Мөнгө угаахтай тэмцэх нэгдсэн зохицуулалт шаардлагатай⁷³

2020.09.11. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх явдалтай илүү үр дүнтэй тэмцэхийн тулд ЕХ-ны гишүүн улс орнууд зайлшгүй хэрэгжүүлэх шинжтэй нэгдсэн зохицуулалтыг бий болгох шаардлагатай хэмээн Европын банкны газраас (The European Banking Authority) мэдэгдлээ.

Тус газраас мэдэгдэхдээ ЕХ-ны нэгдсэн хууль тогтоомжийг бэхжүүлж мөрдөх нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх асуудлаар улс орнуудын олон ялгаатай арга, хандлагуудыг арилгах, хийдлийг нөхөх боломжтой гэсэн юм.

Одоогийн байдлаар ЕХ-ны гишүүн 27 улсын хууль тогтоомж мөрдөгдөж байгаа ч зохицуулалтын хувьд нэгдсэн бус байна.

ЕХ-ны хэмжээнд нэгдсэн зохицуулалт бий болгосноор мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор Холбооны санхүүгийн системийг ашиглахаас урьдчилан сэргийлэх, улс орнууд хоорондын уялдааг хангах боломжтой гэжээ.

Украины засгийн газраас авлигын эсрэг үндэсний стратегийг батлав⁷⁴

2020.09.17. Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газар (АУСҮГ)-аас боловсруулсан 2020-2024 онд хэрэгжүүлэх Авлигын эсрэг үндэсний стратеги (АЭҮС)-ийн техникийн болон хууль эрх зүйн нэмэлт өөрчлөлтийг харгалзан үзэж Украины засгийн газар дэмжив.

Энэхүү шийдвэрийг 09 дүгээр сарын 16-нд болсон засгийн газрын хуралдаанаас гаргасан гэж Укринформын сурвалжлагч мэдээлэв.

Өмнө нь хэлэлцэх асуудлын хөтөлбөрийг танилцуулах үеэр АЭҮС дээр бүх яам ажилласан болохыг АУСҮГ-ын дарга Олександр Новиков мэдэгдэж байсан юм.

⁷² Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://menafn.com/1100328596/Ukraine-Government-plans-to-elaborate-anti-corruption-strategy>

⁷³ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.reuters.com/article/eu-banks-moneylaundering/eu-banking-watchdog-calls-for-single-set-of-anti-money-laundering-rules-idUSL8N2G73JK>

⁷⁴ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.ukrinform.net/rubric-economy/3100814-ukrainian-government-approves-national-anticorruption-strategy.html>

“Өмнөх стратеги нь бодит тооцооллоор ДНБ-ийг 6 хувиар нэмэгдүүлж байсан. Энэхүү стратеги нь бидний тооцооллоор авлигын зардлыг 200 тэрбум гривенээр бууруулах болно” гэж Новиков хэлсэн байна.

Тэрээр авлигын эсрэг стратегийг шүүхийн байгууллагаас ирүүлсэн зарим саналыг харгалзан үзэж, аль болох өөрчлөлт оруулахгүйгээр дэмжихийг засгийн газрын гишүүдээс хүссэн байна.

Стратегийг боловсруулахдаа иргэд, бизнес эрхлэгчид, шинжээчдийн санал бодол, авлигын эсрэг бодлого, шинжээчдийн судалгаа, олон улсын туршлага, АЭНҮБК, Европын конвенц болон олон нийтийн хэлэлцүүлэг зэрэгт тулгуурласан. Энэхүү дүн шинжилгээний үр дүнд АЭҮС-ийн найман тэргүүлэх чиглэлийг тодорхойлжээ.

Европын зөвлөлийн авлигатай тэмцэх байгууллага шүүх засаглалын бүтцийн шинэчлэл хийхийг уриалж байна⁷⁵

2020.09.29. ГРЕКО-гийн зүгээс улс төрийн нөлөөг хязгаарлахын тулд Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахыг Сан Марино улсад зөвлөж байна. Тус байгууллагаас энэ оны 09 дүгээр сарын 29-ний өдөр нийтэд зориулан гаргасан үнэлгээний 4 дүгээр үе шатны тайланд шүүхийн үйл ажиллагааг сайжруулах, оновчтой болгох үүднээс шүүхийн ажлын ачаалал, дотоод журам, нөөцийг дахин үнэлэхийг уриалав. Мөн шүүхийн үйл ажиллагааны талаарх олон нийтийн мэдээллийн ил тод байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзсэн.

Шүүхийн хариуцлагатай холбогдуулан илүү олон зүйл хийх боломжтой бөгөөд, тухайлбал, шүүх засаглалын шударга байдал, түүний бодитой, пропорциональ болон үр нөлөөт байдлыг дээшлүүлэх сахилгын шийтгэлийг сайжруулах зохицуулалтыг цогцоор нь боловсруулж болно. ГРЕКО хэрэг хуваарилалтын уялдаа холбоо болон бодитой, ил тод, шударга байдлыг хангахыг уриалсан байна.

Дээрх тайланд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх механизмыг авж үзээд, парламентын гишүүдийн ёс зүйн дүрмийг батлах, хөрөнгө, ашиг сонирхлоо олон нийтэд мэдүүлэх тогтолцоог нэвтрүүлэхийг зөвлөсөн. Сан Марино улсад хаягласан 14 зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны II улиралд ГРЕКО-гийн нийцлийн горим журмын дагуу үнэлэх болно.

ГРЕКО нь Европын Зөвлөлийн нэг байгууллага бөгөөд гишүүд нь авлигын эсрэг стандартад нийцэж буй эсэхэд хяналт тавьж, авлигатай тэмцэх чадавхыг нь сайжруулах зорилготой юм. Тус байгууллагын зүгээс улс орнуудын авлигын эсрэг үндэсний бодлогын дутагдалтай талыг илрүүлэхэд тусалдаг бөгөөд шаардлагатай хууль тогтоомж, институцийн болон практик шинэчлэлийг явуулдаг. Тус байгууллагад одоогийн байдлаар Европын Зөвлөлийн гишүүн 47 улс, Беларусь, Казахстан, АНУ нэгдсэн байна.

2024 он хүртэлх Украин улсын авлигын эсрэг стратегийг нэн яаралтай батлахыг Ерөнхийлөгч Зеленский хууль тогтоогчдод уриалав⁷⁶

2020.09.29. Украины Ерөнхийлөгч Володимир Зеленский хууль тогтоогчдод хандан 2020-2024 оны авлигын эсрэг стратегийг богино хугацаанд батлахыг уриалав.

Ерөнхийлөгчийн хэвлэлийн албанаас мэдээлснээр 2020-2024 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг төрийн бодлогын зарчмын тухай хуулийн төсөлд тусгагдсан стратегийн төслийг Ерөнхийлөгчөөр ахлуулсан Авлигын эсрэг бодлогын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн аж.

Украинд 2018 оноос хойш авлигатай тэмцэх чиглэлээр ийм стратегийн баримт бичиг байхгүй байгаа нь авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн муу байгаагийн нэг шалтгаан болж байна гэж Зеленский хэлжээ.

⁷⁵ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.coe.int/en/web/portal/-/san-marino-council-of-europe-anti-corruption-body-calls-for-a-structural-reform-of-the-judiciary>

⁷⁶ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.unian.info/politics/anti-graft-strategy-zelensky-calls-on-lawmakers-to-quickly-approve-respective-bill-1163239.html>

Түүний үзэж байгаагаар нийгэм тэр аяараа авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр системтэй, уялдаа холбоотой арга хэмжээ авахыг болон Украины авлигатай тэмцэх байгууллагуудын үйл ажиллагаа үр дүнгээ гаргахыг хүлээж байна.

Энэхүү уулзалтад Ерөнхий сайд Денис Шмигал, Украины Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газар (АУСҮГ)-ийн дарга Олександр Новиков, Ерөнхий прокурор Ирина Венедиктова нар оролцов.

Уг стратегийн гол онцлогийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- 2020-2024 онд хэрэгжүүлэх авлигын эсрэг төрийн бодлогын зарчмын тухай хуулийн төслийг 09 дүгээр сарын 16-ны өдөр засгийн газар батлаад, 4135 дугаар хуулиар парламентад бүртгэсэн.
- Энэхүү стратеги нь таван үндсэн зарчмыг агуулдаг. Үүнд: төрийн байгууллагуудын чиг үүргийг оновчтой болгох, дахин шилжилт ба нээлттэй өгөгдөл, хуульд суурилсан тохиромжтой үйлчилгээ, иргэд авлигыг үл тэвчих, зайлшгүй шийтгэх.
- Өөрчлөх шаардлагатай найман үндсэн чиглэлийг уг стратегид тодорхойлсон. Үүнд: шүүх, прокурор, цагдаа; эдийн засаг дахь төрийн зохицуулалт; эдийн засаг дахь төр ба хувийн хэвшил; татвар ба гааль; барилга, газар, дэд бүтэц; батлан хамгаалах салбар; эрүүл мэнд, нийгмийн хамгаалал; авлигаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх ерөнхий тогтолцоо.
- Хууль тогтоогчид холбогдох хуулийн төслийг 10 дугаар сарын эхээр батлах ёстой бөгөөд гурван сарын дотор АУСҮГ засгийн газартай хамтран уг стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах болно гэж Новиков хэлсэн.
- Уг баримт бичиг хэрэгжиж эхэлсний дараа авлигаас үүдэлтэй хохирол жилд 200 тэрбум Украин гривна (7 тэрбум орчим ам.доллар) -аар буурна гэж тэр хэлсэн. Энэ нь эргээд хөрөнгө оруулалт татахад тусална.
- Түүний хэлснээр, олон улсын зөвлөмж, шилдэг туршлага, амлалт, тэр дундаа ОУВС, ЕХ-той хамтран ажиллах санамж бичигт заасан амлалт зэргийг энэхүү стратегид тусгасан ажээ.
- Стратегийг Дээд танхимаар батлуулсны дараа орон нутгийн болон үндэсний түвшинд засгийн газрын бүх байгууллагууд заавал дагаж мөрдөх болно.

Улс төрийн хүсэл эрмэлзэл болон чөлөөт сонгууль. ОХУ-д авлигатай тэмцэхэд юу саад болж байгаа талаар ТИ онцлов⁷⁷

2020.10.15. Эрх баригчид авлигатай тэмцэх шаардлагын талаар их ярьдаг ч бодит байдал дээрх үйл хэрэг нь авлигатай тэмцэж буй дүр үзүүлэх байдлаар хязгаарлагдаж байна хэмээн ТИ байгууллагын Орос дахь салбараас зохион байгуулсан судалгаанд дурджээ. Шинжээчдийн үзэж байгаагаар авлигатай бодитоор тэмцэхэд саад болж байгаа зүйл бол засаглалын эрх мэдэл тогтонги байгаа болон улс төрийн хүсэл эрмэлзэл байхгүй байгаа нөхцөл байдал юм.

Лобби хийх тухай хуулийг 30 гаруй жил, төрийн албан хаагчдын хууль бусаар баяжих асуудлыг хуульчлах, авлигыг мэдээлэх тухай хуулийн төсөл зэргийг 14 жил ярьж байна.

Владимир Путиныг ОХУ-ын Ерөнхийлөгчийн албан тушаал хаших цаг хугацаанд тус улс ТИ байгууллагаас гаргадаг АТИ-ийн судалгаагаар 82 дугаар байраас 137 дугаар байр хүртэл буурч Ливан, Кени зэрэг улстай ижил түвшинд байна.

Авлигатай тэмцэх санаачилгууд хэрхэн бүтэлгүйтэж байгааг судалгааны тайланд дурджээ. Тухайлбал, 2013 онд Путин оросын эдийн засгийг оффшор бүсээс гаргах асуудлыг хөндөж байсан. Гэтэл цар тахлын үед төрийн дэмжлэг шаардлагатай байгаа аж ахуйн нэгжийн жагсаалтад оффшор бүстэй холбоотой хэд хэдэн аж ахуйн нэгж багтсан байна. Үүнээс гадна, Төрийн Дум 04 дүгээр сард 12 хоногийн дотор аж үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүн экспортлогч оффшор



Ерөнхийлөгч Украинд 2018 оноос хойш ийм баримт бичиг байгаагүй гэж мэдэгдэв. (Фото: president.gov.ua)

⁷⁷ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://pasm.ru/archive/285454/>

компаниудад төдийгүй бусад бараа нийлүүлэгч компаниудад төрөөс батлан даалт гаргах талаарх нэмэлт, өөрчлөлтийг баталсан байна.

ОХУ 2007 онд ГРЕКО-д элссэн бөгөөд энэхүү байгууллагаас шүүхийг хахуульдах, нөлөөллийг урвуулан ашиглахад хариуцлага тооцохыг уриалсан билээ. Гэтэл энэ асуудлаар холбогдох хуулиудын төслийг Төрийн Думд оруулсан байснаа буцаан татан авсан байна.

ОХУ АЭНҮБК-ын хоёр зүйлийг өнөөг хүртэл хэрэгжүүлээгүй байна. Эдгээр нь төрийн албан хаагчийн хууль бусаар баяжих асуудал болон авлигыг мэдээлэгчийг хамгаалах асуудлууд юм.

Лобби хийх тухай хуулийн хувьд Думын Авлигын эсрэг хорооны гишүүн Николай Езерский хэлэхдээ “*Бүх асуудлыг урьдчилан харж чадахгүй байна. Хуулийн төслийг боловсруулах гэж хэд хэдэн удаа оролдсон ч тодорхой томъёолол дээр мухардалд ордог. Ер нь энэ хуулийн талаар ярих нь манай хувьд эрт байгаа бөгөөд хэрэв ийм хууль батлагдвал том бизнесийн төлөөлөл орон нутгийн хуралд орж ирэн өөрсдийн аж ахуйн нэгжийн эрх ашгийг хамгаалах гэж оролдоно. Энэ нь лобби бус авлига болно*” гэжээ.

Кремль авлигын эсрэг үйл ажиллагааг удирдах газрыг 2013 онд байгуулсан боловч үр дүн гарахгүй байгаа нь улс төрийн бодит хүсэл эрмэлзэлгүй байгааг харуулж байна. Дараа нь батлан хамгаалах салбар дахь авлигын эсрэг үйл ажиллагаа зохион байгуулсан боловч эсрэгээрээ уг салбар дахь ил тод байдал буурсан. Орон нутгийн хурлын төлөөлөгчдөөс хөрөнгө, орлогоо худал мэдүүлэх болон дутуу хагас мэдүүлэх явдалд хүлээлгэх хариуцлагыг зөөлрүүлсэн. Ер нь улс төрийн өрсөлдөөн, шударга сонгуульгүйгээр төрийн удирдлагын үйл ажиллагааны хэвийн түвшний талаар ярих шаардлагагүй хэмээн ТИ-ийн ОХУ дахь салбарын тэргүүн Илья Шуманов мэдэгдэв.

Путины засаглалын үед гарсан зарим нэг өөрчлөлтийг дурдахгүй байж болохгүй. Эдгээр нь ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль, төрийн албан хаагчид болон парламентын гишүүд хөрөнгө, орлогоо мэдүүлэх болсон, мөн төрийн худалдан авалтын цахим хуудсанд тендерийн талаар мэдээлэх болсон зэрэг юм.

Украины парламент гадаадын зээл авах зорилгоор авлигатай тэмцэх газрын бүрэн эрхийг сэргээлээ⁷⁸

2020.12.15. Украины парламент ОУВС-гаас зээл авж КОВИД-19 цар тахлаас шалтгаалсан эдийн засгийн уналттай тэмцэх зорилгоор 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газар (АУСҮГ)-ын бүрэн эрхийг сэргээн тогтоолоо.

Энэ оны 10 дугаар сард тус улсын Үндсэн хуулийн шүүхээс албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлэгт хуурамч мэдээлэл өгсөн тохиолдолд оноох ялын хэмжээг хэтэрхий их хэмээн үзэж Авлигын эсрэг хуулийн зарим зүйл заалтыг хүчингүй болгосон байв. Түүнчлэн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг шалгах эрх бүхий байгууллага болох АУСҮГ-ын зарим бүрэн эрхийг хязгаарлажээ.

Энэхүү шийдвэр нь Украины шинэчлэл болон Төв банкны бие даасан байдлаас шалтгаалж зогсонги байдалд орсон ОУВС-гийн 5 тэрбум ам.долларын хэлэлцээрийг бүр мөсөн царцаагаад байсан юм.

Ерөнхийлөгч Володимир Зеленский авлигын эсрэг шинэчлэлийг сэргээхгүй бол Украин эмх замбараагүй байдалд орох, цаашлаад ЕХ-ны гишүүн улсад визгүй зорчих эрхээ цуцлууль болзошгүй талаар нийтэд анхааруулсан байна.

Украины эдийн засаг КОВИД-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалж энэ жил 5 хувиар агших төлөвтэй байгаа юм. Тус улсад цар тахлын нөхцөл байдал энэ оны 09 дүгээр сараас эхлэн хүндэрсэнтэй холбогдуулан засгийн газраас 2021 оны 01 дүгээр сараас эхлэн чангатгасан хөл хорионы дэглэмд шилжих талаар нийтэд зарлажээ.

⁷⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.reuters.com/article/us-ukraine-politics-corruption/ukraine-parliament-restores-powers-of-anti-corruption-agency-in-bid-for-foreign-loans-idUSKBN28P12P>

Хэдийгээр зарим хууль тогтоогч шүүмжилж байгаа боловч албан тушаалтан хөрөнгө, орлогын мэдүүлэгт хуурамч мэдээлэл өгсөн тохиолдолд оноох ялыг сэргээсэн хуулийн төслийг парламентаас 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан байна.

Европын зөвлөлийн гишүүн орнууд авлигатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх ёстой⁷⁹

2021.01.19. Авлига, хахууль, хулгай, татвараас зайлсхийх зэрэг нь хөгжиж буй улс орнуудад жил бүр 1.6 их наяд ам.доллараас багагүй хохирол учруулдаг. Энэ дүн нь зургаан жилийн хугацаанд 1.4 тэрбум хүнийг ядуурлаас гаргахад хүрэлцэх юм.

Энэ тухай Европын зөвлөл (ЕЗ)-ийн Хүний эрхийн комиссар Дунья Миятовичийн хэвлэлийн мэдээнд дурджээ. Тэрээр мөн шүүх болон хууль сахиулах байгууллагууд авлигад хамгийн их өртсөн гэв.

“Авлигыг нийгмийн хамгийн хортой үзэгдлийн нэг гэж зүй ёсоор үздэг. Авлигын улмаас төрийн байгууллагуудад итгэх итгэл буурч, эдийн засгийн хөгжилд саад учирч, хүний эрх, ялангуяа цөөнх, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, дүрвэгсэд, цагаачид, хоригдол зэрэг гадуурхагдсан, нийгмийн эмзэг бүлэгт багтдаг хүмүүсийн эрх ашигийг хангахад сөрөг нөлөө үүсдэг. Авлига нь эмэгтэйчүүд, хүүхэд, ядууралд нэрвэгдсэн хүмүүст илүүтэй нөлөөлж, ялангуяа тэдний эрүүл мэнд, орон сууц, боловсрол зэрэг нийгмийн үндсэн эрхийг хэрэгжүүлэхэд саад тотгор үүсгэж байна” гэж комиссар Миятович бичжээ.

Зарим улсад шүүхийн шинэтгэлийг яаравчлан хэрэгжүүлсний улмаас үр нөлөө нь үлэмж буурсныг тэрээр онцолсон.

“ЕЗ-ийн гишүүн хэд хэдэн улс шүүхийн шинэтгэлийг яаравчлан хийсний үр дүнд парламентаар дамжуулан гүйцэтгэх засаглалын хүчтэй нөлөөллийг бэхжүүлж, шүүхийн хараат бус байдлыг ноцтойгоор алдагдуулж, гүйцэтгэх засаглалд шүүхээс тавих хяналтыг сулруулж, улмаар авлигатай тэмцэх чадавхыг сулруулсан” гэж тэрээр үзсэн байна.

Шүүгчид улс төрийн ашиг сонирхлоос ангид байх зэргээр шүүгчийн хараат бус байдлыг хангах нь шүүхийн шийдвэрийг улс төрд бус ард түмний ашиг сонирхолд нийцүүлэхэд чухал ач холбогдолтой юм.

Түүнчлэн улс орнуудын төр засгийн зүгээс сэтгүүлчдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, аюулгүй байдлыг хангах, хамгаалах шаардлагатай байгааг онцлов. Сэтгүүлчид сөрөг нөлөө үзүүлж, зохисгүй хяналтыг үүсгэж байна гэсэн үндэслэлгүй шүүмжлэл, шахалтаас улс төрчид зайлсхийх хэрэгтэй. Улс орнуудын төр засаг олон нийтийн оролцооны эсрэг стратегийн заргын эсрэг арга хэмжээ авахдаа заргыг шуурхай шийдвэрлэхийг зөвшөөрч, шүүхэд гомдол гаргасан хүмүүст дэмжлэг үзүүлэх зэрэг зүй бус үйлдэлд хариуцлага хүлээлгэх замаар тэмцэх ёстой.

Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль тогтоомжийг үр дүнтэй бөгөөд үр нөлөөтэй хэрэгжүүлэх зорилгоор байгууллагууд албан ёсны баримт бичгийг үзэж судлах эрхийг хүмүүст өгөх ёстой.

Мөн түүний үзэж байгаагаар, цагдаа нар шударга ёс болон ёс зүйн талаар сургалтад байнга хамрагдах ёстой ба тэднийг хянаж шалгах үр нөлөөтэй бөгөөд санхүүжилт сайтай тогтолцоог бүрдүүлэх хэрэгтэй.

Төрийн албан хаагчид шударга ажиллаж, ашиг сонирхлын зөрчил, авлигын эрсдлийг нэмэгдүүлдэг харилцаанаас зайлсхийх ёстой.

Миятовичийн үзэж байгаагаар авлигатай тэмцэх хүчтэй стандартууд үйлчилж, ЕХ-ны зүгээс өөрийн гишүүн орнуудын эдгээр стандартад нийцэж буй байдалд үр нөлөөтэй хяналт тавьж байгаа боловч авлига нь ЕЗ-ийн бүс нутагт хууль дээдлэх ёс, хүний эрхэд ноцтой аюул занал учруулсаар байна.

⁷⁹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://exit.al/en/2021/01/19/council-of-europe-member-states-should-step-up-fight-against-corruption/?fbclid=IwAR3EiakKNOMPuXxu8PVKu1tFXFAPieYRzLXD410SnOHSICSK18f-jH6jma0>

Авлигатай үр дүнтэй тэмцэхийн тулд ЕЗ-ийн гишүүн орнууд ЕЗ болон авлигаас урьдчилан сэргийлэх, шударга байдлыг дэмжихтэй холбоотой олон улсын стандартуудыг бүрэн дагаж мөрдөн, ГРЕКО-гийн зөвлөмжийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ёстой гэж тэрээр тэмдэглэжээ.

ОХУ-ын Севастополь хотын депутатууд криптовалютыг мэдүүлэгтээ бүртгүүлэх шаардлагатай гэж үзэв⁸⁰

2021.02.02. Севастополь хотын хууль тогтоох хурлаар депутатын статусын тухай орон нутгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Нэмэлт, өөрчлөлт нь ард түмний төлөөлөл болсон одоогийн депутатуудын худалдан авсан цахим хөрөнгө (цифровой активы) болон цахим валют (цифровой валюты) нь түүний өөрийн болон гэр бүлийн гишүүдийн 3 жилийн орлогоос илүү байх тохиолдолд хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ бүртгүүлэх шаардлагатай гэж тусгажээ.

Түүнчлэн депутатын гэр бүлийн гишүүн эхнэр /нөхөр/, насанд хүрээгүй хүүхэд дээр дурдсан худалдан авалтыг хийсэн тохиолдолд мөн хамаарах болно. Гагцхүү уг худалдан авалтын эх үүсвэрийг үнэн зөв тайлбарлах ёстой.

Хуулийн төсөл санаачлагч депутат Алексей Климов “Цахим санхүүгийн хөрөнгө, цахим валютын тухай ОХУ-ын хууль 2020 оны 07 дугаар сард батлагдсан. Цахим валютын тухай ойлголт Авлигын эсрэг хуульд орсон. Иймд орон нутгийн хууль тогтоомжийг ОХУ-ын хууль тогтоомжид нийцүүлэх шаардлагын үүднээс төслийг хүлээн авах ёстой” гэж тайлбарласан байна.

Өнөөдөр шударга бус хүмүүсийн үйлдэл нарийн болж, цахим валюттай холбоотойгоор орлогоо нууж байна. Үүнтэй уялдан хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах, давхар хянах, татвар, хяналтын байгууллагууд бий болсон гэж тэрээр мэдэгджээ.

Криптовалютыг мэдүүлэхтэй холбоотой бэрхшээлийн талаар Холбооны улсын түвшинд ярьж байна. Тодруулбал, Төрийн Думын Санхүүгийн зохицуулах хорооны тэргүүн Анатолий Аксаков үүнийг мэдүүлэгтээ мэдүүлэх шаардлагатай эсэхэд эргэлзэж байна гэдгээ РБК-ийн сэтгүүлчдэд өгсөн ярилцлагадаа илэрхийлжээ⁸¹.

Өргөн бариад байгаа хуулийн төсөл Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газрын үйл ажиллагаанд саад учруулах талаар гомдоллож байна⁸²

2021.03.18. Украин. Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газар улс төрийн намуудын санхүүгийн хуурамч зардлыг хянах зохицуулалтад саад учруулах №5253 хуулийн төслийг депутатууд өргөн бариад байна. Улс төрийн намууд зардлыг, эсхүл, орлогыг хуурамчаар өсгөсөн, бууруулсан асуудлыг хянах хуулийн зохицуулалтыг цуцлах хуулийн төсөл нь тус байгууллагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжихэд саад учруулна хэмээн мэдэгджээ.

Хуулийг баталсан тохиолдолд, бид асуудлыг олж тогтоосон ч гэсэн улс төрийн намын санхүүжилтийг зогсоож чадахгүйд хүрнэ. Тус байгууллагын 2020-2021 оны хугацаанд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр Бүх Украины “Батькивщина” нийгэмлэг, Дуу хоолой, Ардын зарц зэрэг намын санхүүжилтийг зогсоосон байна.

Энэхүү хуулийн төслийг парламентад суудалтай бүх нам, эвслийн төлөөлөл санаачилсан байна.

⁸⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://sevastopol.su/news/sevastopolskih-deputatov-obyazali-deklarirovat-kriptovalyutu>

⁸¹ <https://www.rbc.ru/crypto/news/5f6df25e9a794788b30121ac>

⁸² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.pravda.com.ua/rus/news/2021/03/18/7287043/>

Меркель бизнес форумыг нээж, Украинд газрын шинэчлэл хийж, авлигатай тэмцэхийг уриалав⁸³

2021.03.19. Украин улс бол Германы худалдааны гол түншлэгч бөгөөд хөрөнгө оруулалт хийх шаардлагатай улс мөн гэж Германы канцлер мэдэгджээ.

Германы канцлер Ангела Меркель цаашид улс оронд шүүхийн болон газрын шинэчлэлийг эрчимжүүлж, авлигын эсрэг үйл ажиллагааг үргэлжлүүлэхийг Украины Ерөнхий сайд Дэнис Шмыгельд уриалав.

Энэ талаар Меркель Берлин хотод зохион байгуулагдсан Украины Ерөнхий сайд Дэнис Шмыгель тэргүүтэй төлөөлөгчид оролцсон Украин-Германы бизнес форумыг нээх үеэр цахимаар мэдэгдсэн талаар засгийн газрын цахим хуудсанд мэдээлсэн байна.

Түүнчлэн хөрөнгө оруулалттай холбоотой, хөрөнгө оруулагч нарт хөрөнгөө хамгаалах баталгаа өгсөн Украины хуулиудыг Канцлер сайшаасан талаар Украины үнэн сонинд нийтэлжээ⁸⁴.

“Тендер, худалдан авах үйл ажиллагаа, цахимжуулалттай холбоотой шинэчлэлд тодорхой дэвшил гарсныг бид харж байна. Гэвч зарим нэг алхам хийх шаардлагатайг онцолмоор байна. Тухайлбал, авлигатай тэмцэх, шүүхийн үйл ажиллагаа, газрын шинэчлэлийг миний зүгээс цохон тэмдэглэж байна” хэмээн Меркель хэлжээ.

Өнгөрсөн жилийн үр дүнгээс харахад тус улсын худалдааны түнш орны дотор Герман улс тэргүүлж байгаа бөгөөд Украины эдийн засгийн томоохон хөрөнгө оруулагчдийн нэг юм хэмээн Украины Ерөнхий сайд мэдэгдсэн байна.

Тус бизнес форумын нээлтийн үйл ажиллагаанд Украины Ерөнхийлөгч Володимир Зеленский цахимаар оролцсон юм.

КОВИД-19 цар тахалтай холбоотой хүндрэлүүд үүсэж байгаа хэдий ч хоёр тал хамтын ажиллагаагаа харилцан хөгжүүлж, гүнзгийрүүлэх сонирхолтой байгаа, мөн өргөн хүрээтэй цахимжуулалт нь украинчууд авлигатай тэмцэхэд туслах болно гэдгийг В.Зеленский тэмдэглэсэн байна.

Сүүлийн жилүүдэд Украин олон чухал шинэчлэл хийж байгаа боловч “өргөн тархаж буй авлига” нь томоохон саад болж байгаа хэмээн Европын зөвлөлийн дэд тэргүүн Валдис Домбровскис хэлсэн байна⁸⁵.

Төрийн Дум авлигач албан тушаалтнуудын хөрөнгө, орлогыг хураах талаар хэлэлцэнэ⁸⁶

2021.03.22. ОХУ-ын засгийн газар төрийн албан тушаалтны эх үүсвэрээ тайлбарлаагүй орлогыг улсын орлого болгох тухай хуулийн төслийг Төрийн Думд өргөн барьсан талаар 03 дугаар сарын 22-ны өдөр Регнум агентлаг мэдээлэв.

Хөрөнгө, орлогоо мэдүүлэх албан тушаалтан нь тайлант хугацаа болон сүүлийн 2 жилийн нийт орлогоос илүү гарсан хадгаламж, бэлэн мөнгө, харилцах дансны мөнгөн хөрөнгөө хэрхэн олсон талаар нотолж тайлбарлаж чадахгүй бол түүний уг мөнгөн хөрөнгийг улсын орлого болгохоор зохицуулсан байна.

Түүнчлэн, ОХУ-ын Ерөнхий прокурор болон харьяа прокурорууд төрийн албан хаагчийн хөрөнгө, орлогын мэдүүлэгт хяналт тавих журмыг тусгажээ.

Прокуророос улсын орлого болгох шийдвэрийг шүүхэд шилжүүлэхдээ эх үүсвэрээ тайлбарлах шаардлагагүй хөрөнгийн доод хэмжээг 10 мянган рубль байхаар заасан байна.

⁸³ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://focus.ua/politics/477645-merkel-otkryla-biznes-forum-prizvav-ukrainu-k-borbe-s-korrupciy-i-zemelnoy-reforme>

⁸⁴ <https://www.pravda.com.ua/rus/news/2021/03/19/7287190/>

⁸⁵ <https://focus.ua/politics/474219-povsemestnaya-korrupciya-tormozit-process-reform-v-ukraine-vice-predsdatel-avrokomissii>

⁸⁶ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/polit/3221952.html>

Брутер: Майя Санда ба авлига⁸⁷

2021.03.23. Улс төр судлаач В.Брутер Молдав улсын хамгийн ноцтой асуудлыг тус улсын Ерөнхийлөгч шийдвэрлэж чадаж байгаа эсэх тухайд байр сууриа илэрхийлжээ.

Барууныхан авлигач албан тушаалтантай ялгамжтай харьцдаг байдлаас шалтгаалж Ерөнхийлөгч Майя Санда авлигатай тэмцэх үндсэн амлалтаа биелүүлж чадахгүй байна хэмээн улс төр судлаач Владимир Брутер Sputnik Молдова студийн шууд эфирт үзэл бодлоо илэрхийлсэн байна.

“Төрийн департаментаас Игорь Коломойны эсрэг хийсэн мэдэгдлийг эргэн саная. Энэ нь олигархиудтай хийж буй тэмцлийн нэг хэсэг, гэтэл яагаад Порошенко, Ахметов, Пинчук нарыг дээрх мэдэгдэлд хамруулаагүй вэ гэвэл тэд өнөөдрийн Украинд хамгийн баян, төр засгийн эрх мэдэлд ойр байна” хэмээн мөнхүү судлаач хэлжээ.

Тусламж, дэмжлэг, шагналын тогтолцоо нь авлигад нөлөөлөгч бусад хүчин зүйлсийн адил улс төрчдийг эвдэж байна гэж шинжээч баталж байна.

“Нэгдмэл санаатай барууны үзлээр бол авлига үргэлж зөв ба буруу байдаг. Зөвшөөрөл эзэмших нь ч авлига. Хэрэв чи зөвшөөрөл эзэмшиж, хажуугаар нь улс төр хийж байгаа бол чамд мөнгө төлдөг үйлчлүүлэгч, бас чамаас ямар ч авлагагүй ард түмэн байх л болно” гэдгийг Брутер онцолжээ.

Молдав авлигатай хатуу гараар тэмцэх боломжгүй гэдэгт улс төр судлаач итгэлтэй байна.

“Авлигатай тэмцэх нь тогтолцооны асуудал юм. Түүнчлэн, юуг зөвшөөрөх, юуг хориглохыг заасан институцийн шинжийг ч өөртөө агуулдаг” хэмээн тэрээр дүгнэжээ.

Швед улс яагаад эрх зүйн салбарт шинэчлэл хийх шаардлагатай вэ?⁸⁸

2021.05.13. Aiysha Varraich. Өнгөрсөн нэгдүгээр сард ТИ олон улсын байгууллагаас АТИ-ийг шинэчлэн олон нийтэд зарласан билээ. Урьдын адил Швед улсын индекс өндөр байсан буюу дэлхийн хэмжээнд авлигын түвшин багатай улс орнуудын нэгээр нэрлэгдэж, гуравдугаар байрт Финланд, Швейцари болон Сингапур улстай хамт эрэмбэлэгдсэн. АТИ-ээр дэлхийн 180 улсаас дээгүүр эрэмбэлэгдэж, шударга байдал болон сайн засаглалын олон улсын бусад индексээр өндөр оноо авсан байгаа нь Швед улсыг авлигаас ангид улс хэмээн харагдуулж байна. Гэвч энэ нь төөрөгдөл юм. Швед улс нь өдөр тутмын жижиг авлигын үйлдэл багатай боловч тус улсад өндөр түвшний авлига болон санхүүгийн гэмт хэрэг үйлдэгдсэн хэвээр байна. Хэдий тийм боловч ихэнх тохиолдолд гэмт этгээдүүд хариуцлагаас зугтсаар байгаа юм. Өндөр түвшний гэмт хэргийн жишээг дурдвал:

- Арав гаруй жилийн өмнө, Гётебург хотод төрийн албан хаагчид олон жилийн турш хувийн байгууллагаас хахууль авж гэрээ байгуулдаг байсан авлигын сүлжээг сэтгүүлчид илрүүлсэн байдаг. Хэдийгээр, тэдгээр төрийн албан хаагчдыг мөрдөн шалгасан боловч нотлох баримт хангалтгүй гэх шалтгаанаар ямар нэгэн хариуцлага оногдуулаагүй юм.
- Хоёр жилийн өмнө, Шведийн шүүхээс Телиа компанийн удирдах албан тушаалтнуудыг гадаад авлигын хэрэгт холбогдуулан ял оноохоос татгалзсан. Гэвч тус компанийн удирдлага АНУ-ын Хууль зүйн яаманд гэм буруугаа хүлээж 965 сая ам.долларын торгууль төлсөн байдаг. Хэдийгээр Телиа компани гэм буруугаа хүлээсэн боловч Швед улсын шүүхээс тус хэрэгт нотлох баримт хангалтгүй гэж үзэн ял оногдуулаагүй байна.
- Швед улсын томоохон банкны нэг болох Шведбанкны удирдах албан тушаалтан арав гаруй жилийн турш 50 гаруй банкны өндөр түвшний харилцагч, төрийн өндөр албан тушаалтан нарын хамт 10.2 тэрбум ам.долларын мөнгө угаасан хэрэг илэрсэн. Санхүүгийн эрх бүхий байгууллагаас тус банканд 480 гаруй сая ам.долларын торгууль оногдуулсан. Хэдийгээр тус улсын түүхэн дэх хамгийн өндөр хэмжээний торгуулийг оногдуулж, Шведийн Хувьцаа эзэмшигчдийн холбооноос тус банкны удирдах албан хаагчдыг хуулийн хүрээнд мөрдөн шалгахыг хүссэн боловч тэдгээр албан хаагчид эрүүгийн болон иргэний

⁸⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://ru.sputnik.md/20210322/bruter-maia-sandu-i-korrupsiya-34064931.html>

⁸⁸ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/05/13/guest-post-why-sweden-needs-to-clean-up-its-act/>

ямар нэгэн хариуцлага хүлээгээгүй. Шведбанкны захирлын хэлснээр, тус банкны удирдах албан хаагчдыг хуулийн хүрээнд шалгуулах нь их хэмжээний цаг болон хөрөнгө шаардах тул шалгуулаагүй байна. Түүнчлэн Швед улсын хуулийн дагуу тус этгээдүүдийн гэм бурууг нотлоход холбогдох нотлох баримт хангалтгүй байгаа талаар мөн мэдэгджээ.

Дээр дурдсан жишээ нь Швед улсын Авлигын эсрэг хуульд ноцтой дутагдал байгааг харуулж байна. Санхүүч Билл Бровдер зэрэг шүүмжлэгчид Швед улс нь дотооддоо авлига болон мөнгө угаах гэмт хэргийн үйлдэлтэй тэмцэж чаддаггүй, түүнчлэн гадаад улсын төрийн байгууллагад хахууль өгч буй үйлдлийн эсрэг хариу арга хэмжээ авдаггүй хэмээн шүүмжилсэн. Телиа болон Шведбанкны хэрэг нь тус улсын шүүх байгууллагын нотлох баримтыг үнэлэх ажиллагааны алдаа дутагдлыг харуулж байна. Эдгээр гэмт хэрэгт ял оногдуулах шаардлагатай нь тодорхой байсан боловч холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж чадаагүй юм. Ерөнхийдөө, Швед улсын эрх зүйн тогтолцоо нь тус улсад өндөр хэмжээний албан тушаалтныг гэм буруутайд тооцож хариуцлага оногдуулахад нэн хүндрэлтэй байгааг харуулж байгаа юм.

Иймээс, Швед улсад өндөр хэмжээний авлигын гэмт хэрэг үйлдсэн этгээдэд хариуцлага оногдуулах бололцоог баталгаажуулсан хууль, бодлоготой болох зорилгын хүрээнд өөрсдийн эрх зүйн тогтолцоог шинэчлэх шаардлага тулгарч байна. Учир нь авлигын гэмт хэргийг ихэнх тохиолдолд шийдвэр гаргах түвшний өндөр хэмжээний албан тушаалтнууд үйлддэг. Тус улс нь авлига болон шударга байдлын олон улсын индексээр өндөр оноо авж байгаа нь биеэ тоож, авлигын эсрэг тэмцлийг эрчимжүүлэхгүй байх шалтгаан болох ёсгүй юм. Төрийн байгууллага болон эрх зүйн тогтолцоонд итгэх Швед улсын иргэдийн итгэл өндөр тул тус улсын засгийн газар тогтвортой ур чадвартай байж, эрүүл мэнд, боловсрол, хууль сахиулах салбарт жишиг болох үйлчилгээ үзүүлсээр ирсэн. Энэхүү итгэлцэл нь нийгмийн хэм хэмжээний чухал хүчин зүйл гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм. Хэрэв авлигач албан тушаалтнуудад хариуцлага оногдуулж чадахгүй бол иргэдийн итгэл буурах магадлалтай. Учир нь энгийн иргэд хуулийг чандлан сахиж, зөрчсөн тохиолдолдоо хариуцлага хүлээдэг байтал өндөр албан тушаалтнууд хуулийг уландаа гишгэж хариуцлагаас бултдаг байх нь энэхүү итгэлцлийг бууруулж, Швед улсын улс төрийн үндэс суурийг ганхуулж болзошгүй юм.

2. УЛС ОРНУУДЫН АВЛИГЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Австрали ба далайн орнууд

КОВИД-19-ийн улмаас хахууль, авлигын хэмжээ нэмэгдэж болзошгүйг Deloitte анхааруулав⁸⁹

2020.03.24. Мэргэжлийн үйлчилгээ үзүүлдэг Делойт компанийн өнөөдөр гаргасан Хахууль, авлигын 2020 оны тайланд дурдсанаар коронавирусний тархалтын улмаас компаниуд, албан хаагчид, удирдлагын хувьд хахуулийн аюул өсөхийг анхааруулж байна. “КОВИД-19-ийн нөлөөллийг зах зээл мэдрээд эхэлсэн тул тодорхойгүй байдал эрсдэлтэй үйлдлийг нэмэгдүүлэх талтай” хэмээн Делойт компанийн ажилтан Оливер Мэй мэдэгдсэн байна. Делойтын судалгаанд бизнесийн, төрийн болон төрийн бус байгууллагын 159 удирдах албан тушаалтныг хамруулсан байна. Судалгаагаар дараах дүгнэлт гарсан:

- Австралийн 20 компани тутмын нэг нь хахуулийн эсрэг тодорхой бодлого байхгүй байна.
- Австралийн компаниуд хахууль өгч байгаа болов уу гэхээс илүүтэйгээр албан хаагчид нь хахууль авдагт санаа зовдог байна.
- Сүүлийн таван жилд ашиг сонирхлын зөрчил ихээхэн өссөн.

“Миний зүгээс Австрали болон Ази, Номхон далайн бүс нутагт бизнесийн удирдагч нарыг өөрсдийн бизнесийн ёс зүйг шалгах цаг үе гэдгийг хүлээн зөвшөөрөхийг уриалж байна” хэмээн Делойт компанийн удирдлагын нэг Крис Нобле мэдэгдэв. Тэрээр цааш нь хэлэхдээ “Компанийн удирдлагын өнөөдрийн гаргаж буй шийдвэр хямрал өнгөрсөн ч гэсэн компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөөр байх болно. Бид зөв шийдвэр гаргаж байх ёстой. Тайланд хөндсөн асуудлууд танай бизнес, танай албан хаагчдыг хамгаална гэдэгт итгэж байна” гэжээ. Делойт компаниас гүйцэтгэсэн Австрали, Шинэ Зеландын хахууль, авлигын 2020 оны тайланд дурдсанаар Австралийн нэр хүнд сүүлийн хоёр жилийн хугацаанд унасан байна.

Засгийн газар КОВИД-19-ийг дарж чадах ч авлигыг устгаж чадахгүй гэж иргэд үзэж буй нь тайлангийн үр дүнгээс харагдаж байна⁹⁰

2020.11.29. Австрали. Авлигын асуудал нь даруй шийдвэл зохих, хамгийн хүндрэлтэй асуудлуудын нэг болсон, түүнчлэн авлигатай тэмцэх талаарх Холбооны засгийн газар (ХЗГ)-ын үйл ажиллагаанд австраличуудын итгэх итгэл суларч байгааг Гриффины их сургууль болон ТИ-ийн Австрали дахь салбар байгууллагын хамтран зохион байгуулсан “Австралийн үндэсний шударга ёсны систем” гэсэн нэртэй судалгааны тайланд дурджээ.

Авлигыг “том асуудал”, эсхүл “харьцангуй том асуудал” гэж 2018 онд судалгаанд оролцогчдын 61% нь үзэж байсан бол 2020 оны 10 дугаар сарын сүүлээр судалгаанд хамрагсдын 66% нь ингэж үзэж байна. Мөн ХЗГ энэ асуудлыг “маш муу” шийдвэрлэж байна хэмээн үзэж буй иргэдийн хувь хэмжээ дээрх хугацаанд 15-аас 19% болж нэмэгджээ.

Ерөнхийдөө, иргэдийн төрд итгэх итгэл 2020 онд нэмэгдсэн байна. Энэ нь ХЗГ болон мужийн Засгийн газарт хоёуланд нь хамааралтай байна. Судалгаанд оролцогчдын 17% нь ХЗГ-т “маш их итгэдэг” гэснийг 2017 оны 6.7%-тай харьцуулахад өссөн үзүүлэлт болж байна. Энэ нь ихэнхдээ КОВИД-19-ээс үүдэлтэй хямралтай холбоотой юм.

Судалгааны үр дүнгийн дагуу үндэсний шударга ёсны системийг сайжруулах 10 зүйл бүхий зөвлөмж боловсруулсан байна. Тухайлбал, авлигатай тэмцэх талаарх Холбооны төлөвлөгөө болон парламентын гишүүдийн ёс зүйн дүрмийг боловсруулан батлах замаар парламентын

⁸⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.miragenews.com/deloitte-warns-of-a-potential-spike-in-bribery-corruption-due-to-covid-19/>

⁹⁰ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.theguardian.com/australia-news/2020/nov/30/australians-trust-government-to-handle-covid-but-not-corruption-report-finds>

стандартын хэм хэмжээг дагаж мөрдөх, хандивыг тухай бүрд нь мэдүүлдэг системийг бий болгох гэх зэрэг асуудлыг зөвлөмжид тусгажээ.

Дээрхээс гадна, сонгуулийн кампанит ажлын шударга байдлыг хангах зорилгоор зардлыг бууруулах, улс төрийн хандивт хязгаар тогтоох, төрийн албан дахь шүгэл үлээгчийг хамгаалах явдлыг нэмэгдүүлэх, лобби хийх системийг эргэн харах асуудлыг зөвлөмжид тусгажээ.

Шударга ёсыг хангуулах байгууллага, тухайлбал, аудитын байгууллагын санхүү, төсвийг тогтвортой байлгах, парламентаас 4 жилээр шууд санхүүжүүлэх, Холбооны шударга ёс, авлигаас урьдчилан сэргийлэх, шүгэл үлээгчийг хамгаалах байгууллагын жилийн төсвийг 100 сая доллар болгох зэрэг зөвлөмжийг тайланд онцолжээ. Мөн олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, мэдээллийг нээлттэй болгох чиглэлээр хууль тогтоомж боловсруулан батлах шаардлагатайг тэмдэглэсэн.

АТИ-ийн өндөр онооны ард орших Шинэ Зеландын түгшүүр⁹¹

2021.04.19. Zachary Meskell. Энэ оны эхээр ТИ байгууллагаас жил бүр гаргадаг АТИ-ийг зарласнаар сүүлийн арван таван жилийн арван гуравт нь ийнхүү Шинэ Зеланд улс “дэлхийн хамгийн авлигагүй улс”-аар шалгарсан⁹² билээ. Шинэ Зеландад энэ мэдээг тэмдэглэлт баяр гэхээсээ илүүтэй болгоомжилж хүлээн авсан нь санаандгүй гэмээр зүйл байсан байж магадгүй юм. Шинэ Зеландын хамгийн эерэг мэдээллийн агентлагууд хүртэл “*шүгэл үлээгчдийг хамгаалах хамгаалалт хангалтгүй, улсад бүртгэлтэй компаниудад хэн эцсийн хяналт тавьж, ашиг хүртэж байгааг харуулсан бүртгэл байхгүй*” гэх зэргээр тус улс авлигын эрсдэлтэй тулгарч буй тухай сэрэмжлүүлж байв. Бусад агентлагууд ч гэсэн “*Засгийн газар авлигаас ангид статусыг сүйтгэхгүй байхыг анхааруулж байна*” гэх мэт гарчгийг баяр хүргэсэн гарчгаас илүүд үзэж байв. Шинэ Зеландын нэгэн хэвлэл товчхон хэлсэнчлэн, “*Шинэ Зеланд бол дэлхийн хамгийн бага авлигад автсан улс. Гэвч энэ мэдэгдлийг “боловч” гэдэг үг үргэлж дагаж явдаг*” ажээ.

Авлигатай тэмцэх арга хэмжээний талаар Шинэ Зеландын хэвлэлүүдийн бараг хаа сайгүй ярьдаг таагүй зүйлс нь гаднын ажиглагчдийн зүгээс “Яагаад ийм гутранги байна вэ?, Авлигын талаарх “зэрэглэл тогтоодог бүхий л томоохон байгууллага, индексүүд”⁹³ болон Шинэ Зеландын иргэдийн өөрсдийнх нь ойлголт, төсөөллийн хоорондын зөрүүг хэрхэн тайлбарлах вэ? гэж асуухад хүргэдэг.

2002 онд профессор Роберт Грегоригийн тайлбарласнаар, хэдийгээр Шинэ Зеландад “ужиг авлига” бага байсан ч 20 дугаар зууны сүүлийн хэдэн арван жилд тус улс зах зээлийн шинэчлэлээс эгалитарианизмд⁹⁴ огцом унасан зэрэг нийгэм, улс төрийн хэд хэдэн хурдацтай өөрчлөлттэй нүүр тулсан. Барууны ардчилсан орнуудын ерөнхий чиг хандлагыг тусгасан эдгээр өөрчлөлтүүд нь Шинэ Зеландын иргэдийн зүгээс улс төрчид болон улс төрийн байгууллагуудад итгэх итгэл буурч, төрийн албан хаагчид улс орныхоо эрх ашгийн үүднээс ажиллана гэдэгт гүнээ эргэлзэж эхлэхэд хүргэсэн байдаг. Тиймээс АТИ гэх мэт олон улсын индексүүдийн анхаарлыг татдаг, ихэнх улсын иргэд “авлига” гэж боддог авлигын сонгодог хэлбэрүүд Шинэ Зеландад бага байсан (одоо ч хэвээр байгаа) боловч тэд найдваргүй төрийн албан хаагчид эсвэл засгийн газрын шударга бус байдлын талаарх ерөнхий тохиолдлуудын талаар, эдгээр үйл явдлууд нь хахууль гэх мэт авлигын сонгодог хэлбэрт багтах эсэхээс үл хамааран хэт их төсөөлдөг байж магадгүй юм.

Эцэст нь, профессор Грегоригийн 2002 онд тодорхойлон хэлж байсанчлан АТИ зэрэг олон улсын индексүүд болон Шинэ Зеландын засгийн газар явцуу тодорхойлогдсон авлигын маш бага түвшинд анхаарлаа хандуулж байхад олон нийтийн зүгээс “авлигыг хаа сайгүй олж хардаг” гэснээр тус улс дахь авлигын талаарх ойлголтын ихээхэн зөрүү гарч ирэв.

Авлигатай тэмцэх олон улсын нийгэмлэг Шинэ Зеландыг хахууль, бусад ужиг хэлбэрийн авлига бараг байхгүй хэмээн сайшааж байхад шинэ зеландчууд өөрсдөө засгийн газрын “эд баялгийн

⁹¹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/04/19/new-zealands-discomfort-at-the-top-of-the-corruption-perception-index/>

⁹² <https://www.transparency.org/en/cpi/2020/index/nzl>

⁹³ <https://www.ganintegrity.com/portal/country-profiles/new-zealand/>

⁹⁴ Egalitarianism гэдэг нь франц хэлний égal буюу тэгш(equal) гэсэн үгээс гаралтай үг бөгөөд бүх хүмүүс адил тэгш бөгөөд тэгш эрх, боломжийг хүртэх ёстой гэсэн үзэл.

төвлөрлийн зохисгүй нөлөөнд туйлын эмзэг⁹⁵ улс төрийн намууд, хууль тогтоомж, бодлого”, хувийн хэвшил болон төрийн салбарын хоорон дахь эргэдэг хаалга⁹⁶, ашиг сонирхлын зөрчил гэх мэт “баян ертөнцийн авлига”⁹⁷-ын бусад хуульчлагдсан хэлбэрүүдэд санаа зовж байв. Энэ төрлийн авлигын талаарх олон нийтийн ойлголт буруу, эсвэл хэтрүүлэг байж болох ч авлигын талаарх ойлголт, төсөөлөл нь засгийн газрын хууль ёсны байдлыг үгүй хийж, хүмүүсийг шударга бус зан байдал гаргахад хүргэдэг болохыг туршлагаас⁹⁸ харж болох тул энэ нь өөрөө асуудал үүсгэж болзошгүй юм.

Бас нэг асуудалтай зүйл нь Шинэ Зеландын засгийн газар эдгээр ёс суртахууны хувьд аль ч тал руу нь тайлбарлаж болох бүрхэг асуудлуудтай холбоотой олон нийтийн санаа зовнилд хариу арга хэмжээ авах тал дээр удаан хойрго ханддаг байсан явдал юм. Шинэ Зеландын Онц ноцтой луйврын алба (Serious Fraud Office⁹⁹) нь улс төрийн хууль бус хандивтай холбоотой тохиолдлуудад хэрэг үүсгэсэн¹⁰⁰ ч уг алба нь өөрөө санхүүжилт хангалтгүй байгаа талаар хэл үг гаргасан бөгөөд санхүүжилтээс болоод хэргийн тоо хэмжээтэй холбоотой ачааллыг даахад бэрх болж байгаа талаар мэдэгдсэн юм. Шинэ Зеланд улс авлигатай тэмцэх хараат бус агентлаг байгуулах¹⁰¹ уриалгыг ч эсэргүүцсэн байна. Ашиг сонирхлын зөрчлийн тухай хууль тогтоомж нь ЭЗХАХБ-ын ихэнх гишүүн орнуудын жишигт нийцэхгүй байгаа¹⁰² бөгөөд “төрийн албан дахь зохисгүй үйлдэл”¹⁰³-ийг хязгаарлах хууль ч байдаггүй аж.

Хачирхалтай хэдий ч, Шинэ Зеландын АТИ-ийн байнгын эерэг үнэлгээ нь засгийн газарт эдгээр асуудалд анхаарал бага хандуулахад нөлөөлдөг хүчин зүйл болдог байж магадгүй юм. Нэг талаас, Шинэ Зеланд улс АТИ-ийг олон жилийн турш тэргүүлж ирсэн нь авлигын оноо өгдөг мэргэжилтнүүд Шинэ Зеланд зэрэг “амжилтын арвин түүх” бүхий орнуудад байгаа авлигыг олж харахгүй байхад хүргэдэг өөрийгөө гүйцэлдүүлэх гогцоо¹⁰⁴-г (магадгүй ухамсаргүйгээр) бий болгосон байж болно. Магадгүй, илүү чухал зүйл бол Шинэ Зеландын засгийн газар болон улс төрчид, төрийн албан тушаалтнуудын олонх нь улс орны, ялангуяа, улс төрчид болон төрийн албан хаагчид ашиг тусыг нь хүртдэг хууль эрх зүй, ёс зүйн “саарал бүс”-тэй холбоотой асуудлыг үл тоомсорлох, дарагдуулах томоохон шалтгаантай байх магадлалтай. Удаан үргэлжилсэн идэвхгүй байдлыг АТИ-ээр жил бүр, магадгүй ухамсаргүй, санамсаргүй байдлаар баталгаажуулдаг бөгөөд энэ нь төвийг сахисан ажиглагчийн зүгээс өгч буй аливаа асуудал тийм ч муу биш гэсэн дохио болдог. Эцэст нь, Шинэ Зеландын засгийн газар дэлхийн хамгийн бага авлигатай улс гэсэн нэр хүндээ хадгалахад хангалттай статус кво байсаар байхад яагаад авлигатай тэмцэх өндөр өртөгтэй ажилд хөрөнгө оруулах хэрэгтэй гэж?

Мэдээжийн хэрэг шинэ зеландчууд дэлхийн ихэнх улсуудад өргөн тархсан ужиг төрлийн авлигыг устгасан гэдгээрээ бахархаж болох бөгөөд тэгэх ч ёстой. АТИ зэрэг авлигын уламжлалт индексүүд ашиг тустай боловч авлигын явцуу тодорхойлолтыг л хэмждэг байна. Тус улсын иргэдийн хувьд янз бүрийн ёс суртахуунгүй, тааламжгүй улс төрийн зан байдлыг “авлига” гэж үзэх хандлага өргөн тархсан байж болох ч тэдний тавьж буй асуудал бодит бөгөөд чухал юм. Шинэ Зеландын улс төр дэх “сэжигтэй мөнгө”-ийг тайлбарлахын тулд ил тод байдлын нэмэлт арга хэмжээ шаардлагатай байна. Тус улс ашиг сонирхлын зөрчлийн тухай хуулийнхаа цоорхойг арилгаж, хувийн хэвшил ба засгийн газар хоорондын “эргэдэг хаалга”-ыг зохицуулах шаардлагатай байна. Онц ноцтой луйврын албанд илүү их санхүүжилт шаардлагатай бөгөөд авлигатай тэмцэх хараат бус, бие даасан байгууллага байгуулах хэрэгтэй. АТИ-ийн хувьд өндөр

⁹⁵ <https://thespinoff.co.nz/politics/06-03-2020/reputation-vs-reality-how-vulnerable-is-new-zealand-to-systemic-corruption>

⁹⁶ Өндөр түвшний албан тушаалтныг төрийн албанаас хувийн хэвшилд, эсвэл эсрэгээр, хувийн хэвшилээс төрийн албанд шилжүүлэн томилох үйл явцыг “Revolving Door” буюу “Эргэдэг хаалга” гэж нэрлэдэг (Х.О).

⁹⁷ <https://www.newsroom.co.nz/nz-must-guard-transparent-reputation>

⁹⁸ <https://www.vanderbilt.edu/lapop/news/092410a.pdf>

⁹⁹ Хахууль, авлига зэрэг санхүүгийн хүнд, эдрээтэй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, хууль сахиулах байгууллага юм (Х.О).

¹⁰⁰ <https://www.stuff.co.nz/national/politics/119687399/the-serious-fraud-office-takes-months-on-big-political-decisions-heres-why>

¹⁰¹ <https://www.scoop.co.nz/stories/PO2010/S00028/new-zealand-needs-an-anti-corruption-agency-urgently.htm>

¹⁰² <https://www.scoop.co.nz/stories/PO2101/S00120/penny-bicknell-saga-demonstrates-why-new-zealand-needs-better-anti-corruption-laws.htm>

¹⁰³ https://www.victoria.ac.nz/_data/assets/pdf_file/0009/1286280/WP13-03-Assessing-good-governance.pdf

¹⁰⁴ Self-fulfilling prophecy, self-fulfilling effect, self-fulfilling loop гэх мэтээр бичдэг. Ямар нэг зүйлийг “урьдчилан таамаглаж”, хүлээж буй хүн өөрөө түүндээ итгэж найдаж байгаа учраас тэрхүү “урьдчилсан таамаглал”, хүлээлт нь биелэх болно гэж үздэг, мөн тухайн хүн итгэл үнэмшлээ биелүүлэхэд зан байдлаа чиглүүлж, тохируулдаг нийгэм-сэтгэлзүйн үзэгдэл юм (Х.О).

байр суурьтай байгаа нь сайшаалтай боловч энэ нь сайжруулах шаардлагатай зүйлсийг үл тоомсорлох шалтгаан байж болохгүй юм.

Викториягийн хорих байгууллагын албан хаагчдын дунд авлига нэмэгдэж байгааг судалгааны үр дүн харуулав¹⁰⁵

2021.06.21. Австрали. Виктория мужийн хорих байгууллагуудад авлига, хууль бус ажиллагаа зогсохгүй байна. Зарим шоронгийн харуулууд хоригдлуудтай хайр сэтгэлийн холбоо тогтоосон, тэдний эсрэг хүч хэрэглэсэн, хууль бус бараа шоронд оруулдаг болохыг авлигатай тэмцэх байгууллага нь тогтоожээ.

Авлигын эсрэг хараат бус хороо(АЭХБХ¹⁰⁶)-ны тайланд дурдсанаар Викториягийн хорих байгууллагын албан хаагчид дүрмээр зөвшөөрөгдөөгүй хувцас тайлуулах үйлдэл хийх, хориглосон мансууруулах бодис хэрэглэх, дотоод мэдээллийн сангаас хувийн мэдээлэлтэй танилцах, камерын бичлэгийг өөрчлөх зэрэг зөрчил гаргадаг гэжээ.

Хүмүүжигч болон харгалзагч нарын тоо ихсэх тусам биеэ авж явах байдал дордох эрсдэл нэмэгдэж байгааг тайланд онцолсон байна. Иймд чиг үүрэг бүхий төрийн байгууллагууд ажиллах шаардлагатай байгааг АЭХБХ-ны комиссар Роберт Редлих мэдэгдэв.

Викториягийн Хууль зүйн яам болон Олон нийтийн аюулгүй байдал, засан хүмүүжүүлэх газар илрүүлсэн авлигын эрсдлийг арилгахад хэд хэдэн алхмыг аваад байна. Тусгай тайланд дурдсан асуудлууд тасрахгүй байна. Цаашид шийдэмгийн үйл ажиллагаа хэрэгжүүлэхийг шаардаж байна хэмээн Роберт Редлих яриу.

Сүүлийн үед хоригдлууд руу халдах явдал ихэссэн

АЭХБХ-ноос хорих байгууллагуудад хийсэн 4 удаагийн шалгалтын үр дүнг тусгай тайланд оруулсан байна. Хорих байгууллагууд дахь ноцтой зөрчлүүдийг нуун далдлах, АЭХБХ-нд хүргүүлэхгүй удаах зэргээс гадна хорихын хөдөлмөрийн соёлыг дээшлүүлэх шаардлагатайг тайланд дурджээ.

Төрийн болон хувийн хорих газруудын албан хаагчдын зүй бус үйлдлийг мэдээлдэггүй, хаана үйлдсэнийг нь нуун далдалдаг соёл бол хамгийн хэцүү, шийдвэрлэвэл зохих чухал асуудал болоод байгааг Редлих онцлов.

Сүүлийн жилүүдэд хоригдлууд руу албан хаагчид халдах явдал нэмэгдсэн талаар тайланд онцолсон байна. АЭХБХ 2019 онд энэ талаар 63 гомдол хүлээн авсан бол 2020 онд 101 болж нэмэгдсэн ба зарим албан хаагч хоригдлуудын эсрэг хүч хэтрүүлэн хэрэглэх явдал түгээмэл болжээ.

Порт-Филиппийн шоронд 2017 онд дүрэм зөрчин эмэгтэй харгалзагчийн нүдэн дээр хоригдлыг 7 минутын турш нүцгэлэн шалгасан тохиолдол гарсан байна. Мөн тархи толгойг нь өшиглөн зодож байхад нь хажууд нь хараад зогсож байжээ.

Оюун ухааны хомсдолтой хоригдол харгалзагч руу дайрсан өөр нэг тохиолдолд хоригдлыг 4 удаа бие рүү нь өшиглөсөн байна.

Энэ хоёр тохиолдолд харгалзагчид биедээ авж явдаг камерын бичлэгийг унтраах, эсхүл хүчирхийлэл үйлдэж байхдаа бодит нөхцөлөөс өөр асуудлаар ярих зэргээр ирээдүйн камерын бичлэг үзэгчийг төөрөгдүүлэх зорилготой байна. Мөн харгалзагчид хүчирхийллийг ихэвчлэн камерын харагдахгүй бүсэд, эсхүл хоригдлыг зодож байхад камерыг өөр тийш харуулдаг байжээ.

Хоригдлуудыг нүцгэлэн шалгах асуудлыг эрх мэдлийн нэгэн хэлбэр болгон ашиглах асуудлыг зохицуулах хууль тогтоомжийг сайжруулах шаардлагатай хэмээн Нутгийн уугуул иргэдэд эрх зүйн үйлчилгээ үзүүлэх албаны Андреа Лакц мэдэгдэв.

Засгийн газраас хорих байгууллагуудад хараат бус хяналт шалгалт явуулахаар болов

¹⁰⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.abc.net.au/news/2021-06-22/anti-corruption-watchdog-report-corrections-victoria-prisons/100234520>

¹⁰⁶ The Independent Broad-Based Anti-Corruption Commission

Хахууль авж шорон руу оруулах хориотой тамхи оруулах, хоригдлуудтай, эсхүл тэдний гэр бүлийнхэнтэй зохисгүй харилцаанд орох зэрэг асуудлыг тайланд дурджээ.

Ази тив

Японы улс төр дэх эрх мэдэл ба мөнгө¹⁰⁷

2020.02.16. Японы улс төрд хахууль, авлигын гэмт хэрэг үе үе гарч байдаг. Хамгийн сүүлийнх нь парламент дахь Либерал ардчилсан намын гишүүн, засгийн газрын сайд асан Цукаса Акимото (Tsukasa Akimoto) Хятадын мөрийтэй тоглоомын 500.com компаниас хахуульд 3.7 сая иен авсан хэргээр өнгөрөгч 12 дугаар сарын 25-ны өдөр баривчлагдсан явдал болж байна.

Хахуультай холбоотой казиногийн дуулиан Акимотогийн баривчилгаагаар ч зогссонгүй. Парламентын гишүүн, Японы инновацийн намын гишүүн Микио Шиможи (Mikio Shimoji) мөн дээрх компанийн нэгэн зөвлөхөөс хахуульд 1 сая иен авснаа хүлээн зөвшөөрөв. Мөн Батлан хамгаалахын сайд асан Такеши Ивэйа (Takeshi Iwaya) зэрэг Либерал ардчилсан намын өөр дөрвөн гишүүн тус компаниас мөнгө авсан хэрэгт сэжиглэгдээд байна.

Парламентын гишүүд бол ард түмний төлөөлөл бөгөөд хууль тогтоох үйл ажиллагаа болон тодорхой бизнес, салбарын үйл ажиллагаанд улс төрийн нөлөө үзүүлэх эрх мэдэл бүхий этгээд байдаг. Харин тэдний авж буй цалингийн талаар энд дурдах шаардлагагүй байх.

Иймд яагаад парламентын зарим гишүүд авлига, хахуулийн гэмт хэрэгт холбогдоод байна вэ?

Японы парламент буюу Дайт нь “төрийн эрх барих хамгийн дээд байгууллага” бөгөөд “төрийн хууль тогтоох цорын ганц байгууллага” юм. Дайт нь доод, дээд танхимаас бүрддэг бөгөөд эдгээр танхимыг бүрдүүлж буй гишүүд нь “бүх ард түмний төлөөлөл болж сонгогддог”.

Дайтын гишүүний хувьд гурван үндсэн давуу эрх байдаг. Нэгдүгээрт, тэд төрийн сан хөрөнгөөс “жил бүр хангалттай хэмжээний цалин” авдаг. Хоёрдугаарт, парламентын гишүүдийг хуралдааны үеэр “баривчлах боломжгүй” бүрэн эрхтэй байдаг. Гуравдугаарт, “чуулганы танхимын дотор хэлсэн үг, мэтгэлцээн, санал хураалтын асуудлаар танхимын гадна хариуцлага хүлээх” боломжгүй байдаг.

Мэдээж хэрэг парламентын гишүүнд нэмэлт боломжууд байдаг. Жишээлбэл, парламентын гишүүд нь 1) японы галт тэргэнд үнэгүй зөрчих эрх, 2) Японы гал тэргээр зөрчих эрхээс гадна нэг сард гурван удаа (ирж, буцах) онгоцны тийзийн купон, эсхүл 3) нэг сард дөрвөн удаа (ирж, буцах) онгоцны тийзний купоноос сонгох эрхтэй байдаг.

Дээр дурдсанчлан, хууль тогтоогчид “жил бүр хангалттай хэмжээний цалин” авдаг. 2019 оны мэдээллээс харахад парламентын гишүүний жилийн дундаж орлого 2018 онд 26.57 сая иен байсан бөгөөд тухайн оны хамгийн их орлоготой нь Жиро Хатояма (Jiro Hatoyama)-гийн орлого 1.74 тэрбум иен байв. Мөн орлогынхоо хэмжээгээр 27 дугаар байрт эрэмбэлэгдсэн Ерөнхий сайд Шинзо Абэгийн орлого 40.28 сая иен байсан билээ.

Гэхдээ парламентын гишүүдийн жилийн орлого яг хэд вэ?

Сарын үндсэн цалин нь 1,294,000 иен (жилдээ 15,528,000 иен), Үүнээс гадна, жилийн урамшуулал нь 6,350,000 иен байдаг. Тиймээс нийт жилийн орлогын дүн нь 21,878,000 иен болдог. Харьцуулах зорилгоор ам.долларт шилжүүлж үзэхэд Японы хууль тогтоогчдын жилийн цалин (\$201,800) АНУ (\$174,000), Өмнөд Солонгос (\$105,000), Герман (\$102,600), Их Британи (\$91,200)-ийн хууль тогтоогчдынхоос өндөр байна.

Японы хууль тогтоогч нар бусад улс орнуудын парламентын гишүүдээс, мөн Японы дундаж ажилчдаас өндөр цалин авна гэдэг нь илэрхий.

Хамгийн сонирхолтой нь парламентын гишүүн бүр “*bunsho tsūshin kōtsu taizaihi*” гэж нэрлэгдэх 1 сая иенийн татваргүй хөнгөлөлт (баримт бичиг, холбоо, тээвэр, байрны зардалд зориулан)-ийг сар бүр авж байгаа нь нэг жилд нийтдээ 12 сая иен болно. Парламентын гишүүд энэхүү хөнгөлөлтийг өөрсдийн албан ёсны үйл ажиллагаанд зарцуулах ёстой ч, үүнийг хэрхэн

¹⁰⁷ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.japantimes.co.jp/opinion/2020/02/16/commentary/japan-commentary/power-money-japanese-politics/#.XkpHiGgzaUk>

зарцуулсан талаар баримт бүрдүүлж, тайлагнах шаардлагагүй байдаг. Мэдээж хэрэг парламентын гишүүд үйл ажиллагаанаас үлдсэн хөнгөлөлтийг хэмнэх боломжтой бөгөөд хэрэв хүсвэл татваргүй орлогын томоохон эрх үүсвэр гэж үзэж ч болно. Иймд, парламентын гишүүний жилийн нийт орлого нь 33,878,000¹⁰⁸ орчим иен болж байна.

Японы парламентын гишүүний жилийн орлого ийм өндөр байхад яагаад Японы улс төрд авлига, хахуулийн гэмт хэрэг гардаг вэ? Шалтгаан нь одоогийн парламентын гишүүн дараагийн сонгуульд ялна гэсэн баталгаа байхгүй, мөн сонгуульд өрсөлдөхөд их хэмжээний мөнгө шаарддаг (нэр дэвших барьцаа/орлого нь 3-6 сая иен байдаг). Энэ байдлаар сонгуулийн дараа тухайн парламентын гишүүн ажилгүй болох боломж өндөр байдаг. Гиймээс тэд албан тушаал эрхэлж буй богинохон хугацаандаа боломжит хамгийн их мөнгийг цуглуулах, хадгалах хандлагатай байдаг.

Парламентын доод танхимын бүрэн эрхийн хугацаа 4 жил байдаг ч Ерөнхий сайд танхимыг тараавал дээрх хугацаа илүү богино болох юм. Бодит байдалд доод танхимын гишүүд аль ч сонгуулийн бүрэн эрхийн хугацаа дунджаар 3-аас бага жил байгаа юм. Харин Дээд танхимын бүрэн эрхийн хугацаа 6 жил байдаг ч гишүүдийн хагас нь 3 жил тутамд сонгогдож байдаг. Зарим хууль тогтоогч, ялангуяа Доод танхимын гишүүдийн зүгээс бүрэн эрхийнхээ хугацаанд улс төрийн үйл ажиллагаа болон сонгуулийн санхүүжилтийг зохион байгуулахад тэдний жилийн орлогын хэмжээ хангалттай бус байна гэсэн гомдол үе үе гаргасаар байдаг.

Энэ шалтгааны улмаас улс төрийн намууд жилд хэд хэдэн удаа санхүүжилт босгох арга хэмжээ зохион байгуулж байна. Парламентын гишүүний дэмжигчийн хувиар донорууд нь хөрөнгө босгох нэг тасалбарыг 20,000 иен болон түүнээс дээш үнээр худалдан авдаг. Энэ нь парламентын зарим гишүүнд өдөрт 10 сая иен болон түүнээс дээш хөрөнгө босгох боломж олгодог. Намууд улс төрийн санхүүжилт босгохыг Улс төрийн санхүүжилтийн хяналтын хууль (Political funds control act)-ийн 8.2-т хүлээн зөвшөөрч хуульчилсан байдаг. Мөн үүнтэй адил улс төрийн бүлэгт хандив өгөхийг хүлээн зөвшөөрч хуульчилсан байдаг ч гадаадын иргэн, гадаадын аж ахуйн нэгжээс улс төрийн дэмжлэг авахыг дээрх хуулийн 22.5 дугаар зүйлээр хязгаарласан байдаг.

Парламентын гишүүн болохын тулд нэр дэвшигч нь хуульд заасан шалгуур (Доод танхимд 25-аас дээш настай, Дээд танхимд 30-аас дээш настай Японы иргэн байх)-ыг хангасан байх ёстой бөгөөд арьс өнгө, итгэл үнэмшил, хүйс, нийгмийн байдал, гэр бүлийн гарал үүсэл, боловсрол, өмч хөрөнгө, орлогын байдлаар нь ялгаварладаггүй.

Энэ бүхнийг дурдаж байгаагийн шалтгаан бол парламентын гишүүнээр хоёр дахь удаагаа сонгогдсон, эсхүл удам дамжсан хууль тогтоогчдоос ялгаатай нь, ихэнх залуу болон эгэл жирийн шинэ нэр дэвшигчдийн хувьд өөрсдөө мөнгө хадгалж, ажилгүй болох эрсдэлд бэлтгэх шаардлагатай байдаг.

Мэдээж хэрэг ямар ч тохиолдолд хахуулийг хүлээн зөвшөөрөх, зөвтгөх ёсгүй бөгөөд энэ нь эцсийн эцэст улс төрч бүрийн шударга байдал, хувь хүний ёс суртахууны асуудал юм. Хэдий тийм ч, парламентын гишүүдийн дээрх тодорхойгүй нөхцөл байдлууд болон эдийн засгийн чадавхын харилцан ялгаатай байдал нь Японы улс төр дэх авлига, хахуулийн шууд бус шалтгааны нэг болж байна гэж үзэж болох юм.

Нийтлэл бичсэн: Японы парламентын Доод танхим дахь Төрийн сангийн сайдын албан ёсны нарийн бичгийн дарга, Сока их сургуулийн Энх тайвны судалгааны хүрээлэнгийн туслах профессор асан Дайсукэ Акимото.

Филиппинд авлига, хахууль өсжээ¹⁰⁹

2020.03.03. Хахууль, авлигын асуудал Филиппин улсад сүүлийн хоёр жилийн хугацаанд эрс өссөн гэдгийг PricewaterhouseCoopers (PwC) байгууллагаас гаргасан судалгааны үр дүн илтгэж байна. Филиппиний 101 аж ахуйн нэгж хамрагдсан тус судалгааны үр дүнгээр бизнес эрхлэгчид 5-50 сая ам.доллар хүртэл хөрөнгийг алддаг гэсэн ба энэ нь 2018 онтой харьцуулахад 254 сая песогоос 2.54 тэрбум песод хүрсэн байна.

¹⁰⁸ Энэ нь 80 сая орчим төгрөгтэй тэнцэнэ.

¹⁰⁹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.cnnphilippines.com/news/2020/3/3/Bribery-corruption-fraud-PwC.html>

Судалгаанд оролцогчдын 43% нь авлигын тохиолдолтой 2 удаа таарч байсан гэж хариулсан бол 10% нь 6-12 удаа тохиолдож байсныг дурджээ. 2018 оны судалгаанд 63 компани хамрагдсан ба эдгээрийн 54% нь авлигын асуудалтай тулгарч байсан бол 2020 оны судалгаагаар 52% болжээ. Филиппиний компаниудын 21% нь хахууль нэхсэн явдалтай тулгарч байсан гэж хариулсан бол 14% нь “бизнесийн боломжоо алдсан” хэмээн хариулжээ. Учир нь өрсөлдөгч компаниуд нь ихээхэн хахууль өгсөн байна. Үүнээс гадна, үйлчлүүлэгчдийг залилах (24%), худалдан авалтын залилан (21%), кибер гэмт хэрэг (19%), бизнесийн луйвар (19%) зэрэг хүндрэлтэй асуудлууд бизнесийн салбарт оршиж байгааг судалгааны үр дүн харуулжээ.

Судлаачдын тэмдэглэж буйгаар технологи хөгжих тусам кибер гэмт хэргийн аюул өсөж, зөвхөн цахим шуудангаар хязгаарлагдахгүй, цахим луйвар, цахимаар хувийн мэдээллийг хулгайлах, зөвшөөрөөгүй цахим мөнгөн гуйвуулга, төлбөр гүйцэтгэх, интернэт худалдан авалт гэх мэт хэргүүд гарах болсон гэнэ.

ТИ байгууллагын 2019 оны АТИ-ийн судалгааны үр дүнгээр Филиппин улс өмнөх онтой харьцуулахад 14 байраар ухарч, 180 улсаас 113 дугаар байрт, харин оноо нь 2 пунктээр буурч, 34 болжээ.

Авлигад хамгийн их өртсөн Казахстаны их, дээд сургуулиудыг нэрлэжээ¹¹⁰

2020.03.03. Найман оюутан тутмын 1 нь дотоодын их, дээд сургуулиуд авлигад өртөмтгий гэдэгт итгэлтэй байдаг. Нур Отан намын Жас Отан залуучуудын жигүүрийн удирдагч Елнур Бейсенбаев хэвлэлийн бага хурлын үеэр “Шударгаар сурцгаая” сэдэвт аяны ажлын үр дүнг танилцуулав. Казахстаны 64 хувийн их, дээд сургуульд суралцаж буй 20 мянга гаруй оюутан судалгаанд хамрагдсан талаар Liter.kz мэдээлэв.

“Оюутнуудын ихэнх нь хахууль өгснөөр их, дээд сургуульд суралцахгүйгээр төгсөх боломжтой гэж үздэг. Үүний зэрэгцээ багш нар нь ийм орчинд сурч байгаа оюутнуудын ирээдүйн хувь заяа, цаашид ямар хүн болох тухай бодохгүй байна. Манай Жас Отан жигүүрээс тусламж хүсэн олон оюутнууд ханддаг.

Их, дээд сургууль дахь авлигын талаар оюутнуудаас авсан судалгааны үр дүнгээс үндэслэн авлигатай холбогдсон хувийн 7 их, дээд сургуулийн жагсаалтыг гаргасан. Үүнд:

1. Нур-Султан хотын Анагаахын их сургууль
2. Жетысай хотын Сырдария их сургууль
3. Туркестан мужийн Алмата хот дахь Казахын аялал жуулчлал, спортын академи
4. Шымкент хотын Бүсийн нийгэм-инновацийн их сургууль
5. Алматын Төв-Азийн их сургууль
6. Алматы их сургууль
7. С.Баишевын нэрэмжит Актюбинскийн их сургууль

Судалгаанд оролцогчид авлигатай холбоотой асуудал шалгалт, шүүлгийн явцад (23.8%), дипломын ажил хамгаалах үед (8.7%) хамгийн ихээр гардаг гэж үзжээ. Харин “Оюутнууд хэнд ихэвчлэн хахууль өгдөг вэ?” гэсэн асуултад судалгаанд оролцогчдын 30% нь багш нарт гэсэн бол 4.4% нь захирлуудад хахууль өгдөг” гэжээ.

Хахуулийн хэмжээнд онцгойлон анхаарах хэрэгтэй. Улсын хэмжээнд улирлын шалгалт, шүүлэг өгөхөд хахуулийн хэмжээ дунджаар 22 мянган тэнгэ, 1 хичээлийн шалгалт өгч хаалгахад 14 мянган тэнгэ, курсийн ажил бичихэд 32 мянган тэнгэ байдаг байна.

“Дипломын ажлаа хамгаалахад 150 мянган тэнгэгийн хахууль өгөхөд хангалттай бол хувийн зардлаар буюу төлбөртэй сургалтын төрлөөс улсын буюу тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахад 400 мянган тэнгэ шаардлагатай байдаг. Энэ бол асар их мөнгө” гэж Жас Отан байгууллагын удирдлага дургүйцлээ илэрхийлэв.

¹¹⁰ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://liter.kz/nazvany-samye-korrumpirovannye-vuzy/>

Судалгааны мэдээлэл, үр дүнгийн талаар Жас Отан байгууллагаас Казахстан улсын Боловсрол, шинжлэх ухааны яаманд хүргүүлэх зөвлөмжид тусгахаар болжээ.

Энэтхэг улс гадаадын хахуулийн хэргийн тоогоор дэлхийд 2 дугаарт эрэмбэлэгдлээ¹¹¹

2020.03.19. Дэлхий дахинаа 2019 онд үндэстэн дамнасан хахуулийн хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа удааширсан боловч Энэтхэг улсын хувьд гадаадын компаниудаас хахууль авсан дотоодын албан хаагчидтай холбоотой мөрдөн шалгах ажиллагааны талаарх тоон үзүүлэлтээрээ Бразилийн дараа буюу 2 дугаар байрт бичигдлээ.

Дэлхийн авлигын эсрэг мөрдлөг, мөрдөн шалгах ажиллагааны чиг хандлагыг судлах ашгийн төлөө бус бизнесийн холбоо болох ТРАСЕ байгууллагын 10 дахь удаагийн *Дэлхийн хууль сахиулах ажиллагааны жилийн тайланд* дурдсанаар хил дамнасан авлигын тархалт өндөртэй улсаар Хятад улс орсон бол үүний дараа Ирак, Бразил, Нигери, Энэтхэг зэрэг улс орсон.

Дээрх тайланд дурдсанаар 2019 онд үндэстэн дамнасан хахуулийн эсрэг авж хэрэгжүүлж буй арга хэмжээний хувьд харьцангуй удаашралтай жил байсан бөгөөд АНУ болон дэлхий дахинд гадаадын албан хаагчдын хахуультай холбоотой хэргийн тоо буурсан байна.

Санхүүгийн үйлчилгээний салбарынхан АНУ-ын авлигатай тэмцэх байгууллагын гол анхаарлын төвд байдаг боловч 2019 онд олборлох үйлдвэрлэлийн салбартай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа илүү их байлаа. Мөн түүнчлэн тус улсын сансар судлал, батлан хамгаалах, аюулгүй байдлын салбарынханыг үндэстэн дамнасан хахуулийн хэрэгт холбогдуулан шалгах мөрдлөгийн тоо нэмэгдсэн байна.

2019 оны эцсийн байдлаар Бразил улсын үндэстэн дамнасан хахуулийн хэрэгт шалгагдсан дотоодын албан тушаалтнуудын тоо хамгийн их байсан ба үүний дараа Энэтхэг, Хятад улс эрэмбэлэгдлээ гэж тус тайланд дурджээ.

1977 оноос хойш Хятад улс үндэстэн дамнасан авлигын хэрэгт авж хэрэгжүүлж буй 110 гаруй мөрдөн шалгах ажиллагаа явуулсан үзүүлэлтээрээ хамгийн тархалт өндөртөйд тооцогдсон ба Ирак улс дээрх арга хэмжээний тоогоороо удаалж, Бразил, Нигери, Энэтхэг зэрэг улс араас нь багтжээ.

Малайзын хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын зөвхөн 59 хувь нь авлигын эсрэг бодлого баримталдаг¹¹²

2020.04.16. 2009 онд батлагдсан Малайзын Авлигатай тэмцэх хорооны тухай хуулийн 2020 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдөгдөж эхлэх компанийн хариуцлагын тухай заалт (17А3 хэсэг)-ын дагуу хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниудын авлигын эсрэг бодлогыг хянаж үзсэн талаар Үнэт цаасны хороо (ҮЦХ)-ны 2019 оны тайланд тусгасан тухай танилцууллаа.

Хяналтын явцад компаниудын 59% нь авлигын эсрэг бодлого баримталж байгааг тогтоосон бөгөөд дийлэнх нь эдгээр бодлогыг Ерөнхий сайдын Тамгын газраас гаргасан холбогдох журамд нийцүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай байна гэж үзжээ.

2019 онд хэрэгжүүлэх хамгийн чухал арга хэмжээний нэг нь Ерөнхий сайд асан Махатир Мохамедын эхлүүлсэн “Авлигатай тэмцэх үндэсний төлөвлөгөө 2019-2023”-ын дагуу ҮЦХ болон хөрөнгийн зах зээлд авлигын эсрэг цогц арга хэмжээ хэрэгжүүлэх явдал байсан юм.

Авлигатай тэмцэх үндэсний төлөвлөгөөнд 6 тэргүүлэх чиглэл, 115 санаачилгыг тодорхойлсон бөгөөд эдгээрт төрийн үйлчилгээний үр өгөөжийг бэхжүүлэх, аж ахуйн нэгжийн сайн засаглалыг нэвтрүүлэх зэрэг асуудал багтаж байгаа юм.

¹¹¹ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: https://www.business-standard.com/article/pti-stories/india-2nd-for-investigations-into-foreign-bribery-enforcement-action-slows-down-globally-120031900264_1.html

¹¹² Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.theedgemarkets.com/article/sc-only-59-malaysia-public-listed-companies-have-anticorruption-policies-place>

ҮЦХ-ны Авлигатай тэмцэх нэгж нь 2019 оны 04 дүгээр сарын 01-нд байгуулагдсан бөгөөд засаглал, шударга ёс, авлигын эсрэг арга хэмжээг бэхжүүлэх боломжийг тодорхойлох чиг үүрэгтэй юм.

Дунд боловсролын салбар дахь авлигын асуудалд хийсэн дүн шинжилгээ¹¹³

2020.04.21. ТИ Казахстан байгууллагаас хийсэн судалгаагаар боловсролын салбар нь авлигад өртөмтгий “шилдэг” 5 салбарын тоонд орсон байна.

Атырау мужийн төсвөөс боловсролын салбарт жил бүр дунджаар 72 тэрбум тэнгэ (2018 онд 62.6 тэрбум тэнгэ, 2019 онд 87 тэрбум тэнгэ) зарцуулж байгаа нь тус мужийн нийт төсвийн 1/5 болж байна.

Харамсалтай нь, Атырау мужийн Авлигатай тэмцэх алба (АТА)-ны статистик мэдээллээр боловсролын салбар нь авлигын эсрэг хууль тогтоомж зөрчсөн үзүүлэлтээр дээгүүр байр эзэлж байна.

Тус мужид сүүлийн хоёр жилийн хугацаанд авлигын эсрэг хууль тогтоомж зөрчсөн 65 (2018 онд 15, 2019 онд 50) хэрэг бүртгэгдсэнээс 64 (2018 онд 10, 2019 онд 54) хэргийн хэрэг бүрдэлт дууссан, 62 (2018 онд 10, 2019 онд 52) хэргийг шүүхэд шилжүүлсэн, шүүхээс 6 (2018 онд 1, 2019 онд 5) албан тушаалтны буруутай нь тогтоогдсон байна. Учруулсан хохирлын хэмжээ 136.2 сая тэнгэ болсон бөгөөд 134.3 сая тэнгэгийн хохирлыг барагдуулж 26.7 сая тэнгэгийн эд хөрөнгийг хураан авсан байна.

Их, дээд сургуульд элсүүлэх зорилгоор хахууль авах, хийгдээгүй ажил, үйлчилгээг хууль бус гарын үсэг, хуурамч бичиг баримт бүрдүүлэн хийсэн болгох, туршилт шинжилгээг хууль бусаар явуулах, төсвийн хөрөнгөөр хийх худалдан авалтаас мөнгө завших зэрэг үйлдлүүд түлхүү гарсан байна.

АТА-наас Атырау мужийн 195 дунд сургуулийн 10-т нь авлигатай холбоотой асуудлаар судалгаа, дүн шинжилгээ хийсэн байна.

Сургуулиудын үйл ажиллагаанд хийсэн дүн шинжилгээгээр элсэлтийн хорооны үйл ажиллагаанд эрх зүйн зохицуулалт байхгүй, сургуулийн удирдлагаас баталсан үйл ажиллагааны дотоод дүрэм, журамд боловсон хүчний бодлогыг хэрэгжүүлэхдээ дураараа аашлах боломжийг удирдлагуудад олгосноороо сул орон тоон дээр шударгаар өрсөлдөх эрхийг хаасан, дунд боловсролын байгууллагын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын эрх зүйн зохицуулалтад хийдэл оруулж, маргаан үүсгэх боломжийг санаатайгаар бий болгосон зэрэг авлига гарч болзошгүй эрсдэлүүд илэрсэн байна.

Тухайлбал, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 57 дугаартай “Дунд боловсролын байгууллагын удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтын журам батлах тухай” тушаалд удирдах дээд шатны байгууллагаас дараах тохиолдолд сонгон шалгаруулалт явуулна гэж заасан байна. Үүнд, “тухайн сургуулийн удирдах албан тушаалтны орон тоо сул байвал, удирдах албан тушаалтан нь уг албан тушаалдаа таваас дээш жил ажиллаж байгаа тохиолдолд сонгон шалгаруулалт зохион байгуулж болно” гэж заасан байна.

Дээрх сонгон шалгаруулалт зохион байгуулах тухай заалт нь Казахстан улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 2-т заасан “Сул орон тоо байгаа төрийн болон шуурхай удирдлагын байгууллага нь сонгон шалгаруулалтыг зохион байгуулж явуулна” гэсэн эрх зүйн зохицуулалттай зөрчилдөж байна.

Дээр дурдсан журамд сонгон шалгаруулалтын явц, түүний үр дүнг ямар аргаар дүгнэх талаар заагаагүй, мөн шалгаруулалтын чухал хэсэг болох ярилцлагын шалгалтын талаар тусгаагүй байна.

Дүн шинжилгээний явцад дунд сургуулийн захирлууд тухайн албан тушаалд 3-35 жил ажиллаж байгаа дүн гарчээ. Тухайлбал, Еркинкалиний дунд сургуулийн захирал 35 жил, Абайн нэрэмжит сургуулийн захирал 21 жил захирлаар ажиллаж байна. Энэ нь сургуулийн захиралтай байгуулсан

¹¹³ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: https://dknews.kz/inner-news.php?id_cat=15%20&&%20id=82866

хөдөлмөрийн гэрээнд захирлын ажиллах хэм хэмжээ, хугацааг заах талаар холбогдох дүрэм журамд тусгаагүйтэй холбоотой байна.

Дунд сургуулийн захирлыг томилох үйл ажиллагаа 4 үе шатаас бүрддэг байна. Журмын 25 дугаар зүйлд зааснаар сургуулийн захирлын албан тушаалд нэр дэвшигч нь тухайн мужийн боловсролын байгууллагаас зохион байгуулдаг хууль зүйн мэдлэгийн шалгалтад орох ёстой.

Нэр дэвшигчдэд сонгон шалгаруулалт явагдах газар, хугацааны талаар зохион байгуулж буй байгууллагаас мэдэгддэг. Дурын сургуулийг сонгон, аудио, видео бичлэг хийх төхөөрөмжөөр ханган шалгаруулалтыг явуулах ёстой. Гэвч уг шалгаруулалтыг ёс төдий явуулах эрсдэл байдаг.

Сонгон шалгаруулалтын хоёрдугаар шатанд Боловсролын байгууллагаас томилогдсон сонгон шалгаруулалтын хороо шалгалтын үнэлгээ болон уг албан тушаалд томилуулахаар санал болгож буй этгээдийн талаарх хүсэлтээ итгэмжлэгдсэн зөвлөлд ажлын 2 өдрийн дотор хүргүүлдэг байна.

Атырау мужийн дунд сургуулийн итгэмжлэгдсэн зөвлөлийн бүрэлдэхүүнд орсон эцэг эхчүүдээс авсан асуулгаар тэдэнд сургуулийн удирдах албан тушаалд нэр дэвшигчдийн ирүүлсэн бичиг баримтуудыг танилцуулдаггүй, мөн сургуулийг хөгжүүлэх төлөвлөгөөг үзүүлдэггүй байжээ.

Судалгааны үр дүнгээр дунд сургуулийн захирлуудын сонгон шалгаруулалт, томилгоо нэр төдий явагддаг болох нь тодорхой болжээ.

Мөн судалгааны явцад сургуулийн захирлаар 15-20 жил ажиллаж байгаа хүмүүсийн дунд тэтгэврийн насны хүн цөөнгүй байсан байна. Тухайлбал, нэг сургуулийн тэтгэвэрт гарсан захирал тухайн сургуульдаа биеийн тамирын багшаар давхар ажилладаг байсан бөгөөд энэ нь ашиг сонирхлын зөрчил үүсгэжээ. Долоо хоногт 18 цагийн ачаалалтай байхад захирал гэдэг утгаар нь илүү ажилласан цагийн мөнгө олгох нөхцөл байдал үүссэн байна.

Дараагийн нэг асуудал бол дунд сургуулиудад “амьгүй албатууд” бий болсон явдал. Жишээлбэл, нэг сургуулийн захирал өөрийн хүүгээ сургуулийнхаа программчаар ажиллуулж, сул цалин өгдөг байжээ. Мөн нэг захирал өөрийн танил компанийн захирлыг лоббидож, сургуулийн өдрийн цайны хөтөлбөрт 3 жил дараалан шалгаруулсан байна.

Дээр дурдсан жишээнүүдээс сургуулийн захирлуудын эрх мэдэл өргөн цар хүрээтэй нь харагдаж байна.

Боловсролын байгууллагын удирдлагууд дотоод дүрэм журамдаа боловсон хүчний бодлого хэрэгжүүлэхэд эдлэх эрх мэдлийг маш өргөнөөр тусгадаг байна. Тухайлбал, сургуулийн захирал хүмүүсийг өөрийн үзэмжээр, сонгон шалгаруулалтгүйгээр ажилд авж байна. Мөн багш нарыг ажлаас чөлөөлөх, илүү цагийн мөнгө олгох, хуваарь гаргах, жижүүрээр томилох, анги даасан багшаар томилох зэрэг нь захирлын шийдвэрээр шийдэгддэг байна.

Бас нэг асуудал бол сургуулийн сурагчдын тоо юм. Б.Насанбаевийн нэрэмжит дунд сургууль 600 сурагчийн багтаамжтай боловч 1,300, 1,200 сурагчтай байх ёстой 30 дугаар гимназид 2,090 сурагч хичээллэж байна.

Энэ нь Казахстан улсын Эрүүл мэндийн яамны 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 611 дүгээр “Боловсролын байгууллагад тавигдах эрүүл ахуй, халдвар хамгааллын шаардлага”-ыг зөрчиж байна. Уг тушаалд дунд сургуулийн нэг ангид 25-аас дээш тооны сурагч суралцах ёсгүй бөгөөд үүнийг зөрчсөнөөрөө хүүхдийн боловсрол эзэмших нөхцөлийг алдагдуулж байна.

Эдгээр асуудлыг шийдвэрлэх тодорхой арга замууд байж болохоор байна. Тухайлбал, хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн баримтыг даган мөрдөж, авлигын шалтгаан нөхцөлийг тогтоох, авлига үүсэх эрсдлийг арилгах шаардлагатай байна.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд саад тотгор болж байгаа албан тушаалтнуудын эрх мэдлээ урвуулах, захиргааны байгууллагын хүнд суртал, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдлыг арилгах хэрэгтэй юм.

Авлигатай тэмцэх талаарх олон улсын үйл ажиллагааны туршлагыг судлан, үндэсний хэмжээнд тохирох шилдэг туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байна.

Пакистан улсын авлигатай тэмцэх байгууллагын стратеги үр дүнгээ өгч байна¹¹⁴

2020.04.30. Пакистаны Үндэсний хариуцлагын товчоо (National Accountability Bureau) нь авлигачдыг илрүүлэх, тэдний хулгайлсан хөрөнгө мөнгийг хураан авж, улсын төсөвт оруулах зорилготойгоор 1999 онд байгуулагджээ.

Тус байгууллага 2019 онд нийт 51,591 гомдол хүлээн авснаас 46,123 гомдлыг хэрэгсэхгүй болгож, 13,299 гомдлыг нягтлан үзэж байна.

Байгууллагын удирдлагаас 2019 онд нийтдээ 1,464 гомдолд шалгалтын ажиллагаа явуулахаар шийдвэр гаргаснаас 1,362 гомдлын шалгалтын ажиллагааг дуусгасан бөгөөд одоогоор 770 гомдол дээр шалгалтын ажиллагаа явуулж байна.

Нийтдээ 574 гомдол дээр хэрэг бүртгэлтийн хэрэг нээн шалгах зөвшөөрлийг 2019 онд авсан бөгөөд одоо нийт 658 хэрэг бүртгэлтийн хэрэг дээр ажиллаж байна. Түүнчлэн 221 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулах зөвшөөрөл авж, 217 хэргийн мөрдөн шалгах ажиллагааг дуусгасан ба 335 хэргийн мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж байна. 2019 онд нийт 150 тэрбум рупиг шууд болон шууд бус байдлаар хураан авсан бөгөөд одоогийн даргын ажиллах хугацаанд 178 тэрбум рупигийн хөрөнгийг шууд болон шууд бус байдлаар хураан авж улсын төсөвт оруулжээ.

АНУ-ын прокурорууд Хойд Солонгос, Хятадын иргэдийг олон сая долларын мөнгө угаасан асуудлаар буруутгав¹¹⁵

2020.05.29. АНУ-ын хуулийн хариуцлагаас зайлсхийх зорилгоор 2013 оноос хойш дэлхийн санхүүгийн системээр дамжуулан 2.5 тэрбум гаруй ам.долларыг Хойд Солонгосын Гадаад худалдааны банк руу хууль бусаар шилжүүлсэн хэрэгт олон тооны этгээдийг буруутгаж байгаагаа тус улсын Холбооны прокурорууд мэдэгдлээ.

Хойд Солонгосын цөмийн болон баллистик пуужингийн хөтөлбөрт дэмжлэг үзүүлсэн асуудлаар тус улсын Гадаад худалдааны банканд АНУ-ын Сангийн яамнаас хориг тавьсан байсан юм. Прокурорын мэдэгдэлд дурдсанаар “АНУ-аар дамжуулсан” төлбөрийг угаахын тулд “250 гаруй халхавч компани”-ийг ашигласан Хойд Солонгосын 28, Хятадын 5 иргэнийг буруутгаад байгаа аж. Эдгээр хүмүүсийн дунд Гадаад худалдааны банкны Ерөнхийлөгч асан Ко Чол Ман болон Ким Сонг Уй нар багтаж байгаа юм.

Хойд Солонгосын удирдагч Ким Жон Ун өөрийн улсын цөмийн зэвсгийг “бэхжүүлэх” асуудлаар зэвсэгт хүчний удирдагчидтайгаа уулзсан талаар тус улсын төрийн мэдээллийн хэрэгслээр энэ долоо хоногийн эхээр дамжуулсны дараагаар буюу АНУ, Хойд Солонгосын хооронд хийж буй цөмийн хэлэлцээр тодорхойгүй байдалд байгаа энэ цаг мөчид дээрх мэдэгдлийг хийж байгаа юм.

Хүний эрх, сайн засаглал нь Зүүн өмнөд Ази дахь цар тахлын дараах сэргэлтийн гол түлхүүр юм¹¹⁶

2020.07.31. Цар тахлын дараах сэргэлтэд Зүүн өмнөд Ази, ялангуяа, Филиппин улсын хувьд нийгэм дэх тэгш бус байдлыг шийдвэрлэх, ногоон эдийн засгийг хөгжүүлэх асуудал чухал болохыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Маниуэль де Гутерриш мэдэгдэв. Цар тахал дэлхийн бусад улс орнуудын эрүүл мэнд, эдийн засаг, улс төрд зогсохгүй Зүүн өмнөд Азийн улс орнуудын эмзэг бүлгийнхэнд ихээр нөлөөлсөн. Тэгш бус байдал гүнзгийрсэн, удирдлагын сул талуудыг цар тахал тодруулж өгсөн ба тогтвортой хөгжлийн арга зам шаардлагатайг харуулж байна. Энэ нь энх тайван, аюулгүй байдлын шинэ сорилтуудыг олж

¹¹⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.thenews.com.pk/print/651899-nab-s-anti-corruption-strategy-yielding-excellent-results>

¹¹⁵ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://abcnews.go.com/Politics/us-charges-north-koreans-chinese-nationals-multi-billion/story?id=70932712>

¹¹⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.philstar.com/headlines/2020/07/31/2031890/hr-good-governance-key-covid-19-recovery-sea>

мэдэхэд тус боллоо хэмээн тэрээр мэдэгдсэн. Улс төрийн зогсонги байдлаас улбаатай маргаантай байсан асуудлуудыг шийдвэрлэлгүй, улмаар, хямрал, нийгмийн хурцадмал байдалд хүргэж байгаа нь өнөөгийн нөхцөл байдал юм. Тус бүс нутгийн бүх улс орнууд гал зогсоох уриалгад нэгдсэн бөгөөд Зүүн өмнөд Азийн улс орнууд энэхүү үүргээ газар дээр нь хэрэгжүүлж, үлэмж өөрчлөлт гарна гэж итгэж байна хэмээн тэр нэмж хэлэв. Цар тахлын өмнө тус бүс нутгийн улс орнууд 2030 он хүртэл хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийн зорилтуудаас хоцорч байсан юм. Зүүн өмнөд Азийн улс орнууд тэгш бус байдал, нийгмийн сул халамж, албан бус сектор их байгаа болон энх тайван, шударга бус байдлын тал дээр ахиц гарахгүй зэрэг олон асуудал байгааг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга онцолжээ.

Экосистемд учирч буй хохирол, биологийн төрөл зүйлийн хорогдол, хүлэмжийн хийн хаягдал, агаарын чанар зэрэг нь түгшүүрийн түвшинд байгааг НҮБ онцлов. Дэлхийн бусад өнцөг булантай харьцуулахад тус бүс нутаг цар тахалтай эрт тулсан ч бүс нутгийн засгийн газруудын зүгээс шуурхай арга хэмжээ авж хэрэгжүүлсэн тухай Гутерриш тэмдэглэв. КОВИД-19-ээр өвчилсөн 50 тохиолдол батлагдан, онц байдал зарлахад дунджаар 17 хоног шаардагдсан гэжээ. Улс хоорондын хамтын ажиллагааг өндрөөр үнэлж буйг мөн Гутерриш онцлоод, нэн яаралтай хөл хорио тогтоосон нь эдгээр улс орнуудыг гарч болзошгүй гамшгаас хамгаалсан гэв.

Тус бүс нутагт Бруней, Камбож, Лаос, Индонез, Малайз, Мьянмар, Филиппин, Сингапур, Тайланд, Зүүн Тимор, Вьетнам багтдаг.

Афганистаны засгийн газрын санхүүгийн байгууллагуудын авлига өндөр түвшинд хүрч байна¹¹⁷

2020.08.08. Афганистан улсын засгийн газар авлигатай идэвхтэй тэмцэх амлалт, үүрэг авсан ч тус улсын санхүүгийн байгууллагууд дахь авлигын түвшин дээд цэгтээ хүрээд байгааг шинжээчид онцолж байна.

Афганистан улсын Худалдаа, хөрөнгө оруулалтын танхимаас гаргасан тайланд дурдсанаар засгийн газар авлигатай тэмцэх стратегийг хэрэгжүүлж чадахгүй байна гэжээ. Улсын хөрөнгө, санхүүг шамшигдуулсан этгээдтэй хатуу тэмцэнэ хэмээн Ерөнхийлөгч Ашраф Гани амлалт өгч байсан ч сүүлийн жилүүдэд төрийн өндөр албан тушаалтнуудын албан тушаалын хэрэг ихсэж байна хэмээн уг тайланд мөн дурдсан байна.

Томчуудын оролцоотой гэмт хэрэг өссөөр байхад засгийн газар арга хэмжээ авахгүй байна. Өндөр түвшинд, тэр дундаа сайд нарын түвшинд энэ асуудал яригдаж байгаа нь хамгийн аюултай юм хэмээн Худалдаа, хөрөнгө оруулалтын танхимын тэргүүн Хан Ян Алокизай мэдэгдэв. Мөн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлд Авлигатай тэмцэх эрүүгийн хууль зүйн төв үүргээ хэрэгжүүлж чадахгүй байна хэмээн Авлигатай тэмцэх үйл ажиллагааны үнэлгээ, мониторингийн хараат бус хорооны ажлын албаны тэргүүн Майванд Роухани онцлов.

Авлигатай тэмцэх чиглэлээр засгийн газар олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө олон удаа амлалт үүрэг авсан ч хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйг Афганистан улсын шударга ёсны төлөөх төрийн бус байгууллага тэмдэглэв. Авлигатай тэмцэх чиглэлээрх Брюсселийн хурал дээр Афганистаны засгийн газрын амлалтууд зөвхөн хууль тогтоомжийг өөрчлөх асуудлаар хязгаарлагдаж байгаа ба өнөөг хүртэл авлигатай тэмцэх, хууль дээдлэх, хүмүүсийн амьжиргааг дээшлүүлэх чиглэлд дорвитой өөрчлөлт ороогүй хэмээн дээрх байгууллагын Насер Таймури мэдэгдэв.

Үүнээс гадна, авлигатай тэмцэх чиглэлээр засгийн газар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хэмээн Афганистан улсын Доод танхимын (Волеси Жирга) хэд хэдэн хууль тогтоогч онцолсон байна.

Хахуулийн түвшин нэмэгдэж байна. Авлигатай тэмцэе гэвэл өндөр түвшний авлигатай тэмцэх шаардлагатай хэмээн парламентын гишүүн Мохамед Азим Кибрзани Толо ньюс сонинд өгсөн ярилцлагадаа дурдсан байна. Гэвч Афганистаны засгийн газар амлалт, үүргийнхээ 80 хувийг биелүүлсэн хэмээн мэдэгдээд байгаа юм. Афганистаны засгийн газар 2016 онд Брюсселийн хурлын үеэр ирэх дөрвөн жилд олон улсын хамтын нийгэмлэгийн тусламжийг нэмэгдүүлэх

¹¹⁷ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.dtnext.in/News/World/2020/08/08142507/1244927/Corruption-reaches-new-high-in-Afghan-govts-financial-.vpf>

зорилгоор авлигатай тэмцэхэд шийдвэртэй арга хэмжээ авах амлалт өгсөн. Харин Ерөнхий прокурорын газар нь авлигатай тэмцэх чиглэлээр, ялангуяа авлигад холбогдсон төрийн өндөр албан тушаалтнууд, хуучин сайд нарын эсрэг ямар нэгэн арга хэмжээ авж чадаагүй хэмээн Авлигын эсрэг хараат бус мониторинг, үнэлгээний хороо өнгөрсөн сард мэдэгдсэн.

Эрүүл мэндийн салбар дахь авлигатай тэмцэхэд хариуцлагатай байдал болон хатуу хяналт шалгалт шаардлагатай¹¹⁸

2020.08.08. Бангладеш. Эрүүл мэндийн салбар дахь олон жилийн бугшсан асуудлыг шийдвэрлэхийн тулд Бангладеш улс ил тод, хариуцлагатай байдал, зохих хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах шаардлагатай хэмээн шинжээчид үзэж байна. Маш буруу үйл ажиллагааны улмаас тус улсад коронавирусний нөхцөл байдал улам хүндэрсэн хэмээн эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудал, КОВИД-19-тэй холбоотой асуудлаарх хурлын үеэр онцлов.

Үндсэн эрхийг хамгаалах хороо, иргэний нийгмийн платформ дээрх уулзалтыг зохион байгуулсан ба коронавирусний халдвартай холбоотой хямрал тус улсын эрүүл мэндийн салбар ямар ядмаг байгааг харууллаа хэмээн уулзалтыг даргалагч хуульч Шахдин Малик(Shahdeen Malik) онцлов. Хямралын эерэг тал гэвэл, эрүүл мэндийн салбарын сул талуудыг нээж харуулсан ба тус салбар дахь асуудлыг шийдвэрлэхэд тэднийг оролцуулахад хүргэсэн ажээ. Цар тахалтай тэмцэж буй энэ үед засгийн газар эрүүл мэндийн салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх гэж оролдож буй боловч өнөөгийн байдлаар амжилтад хүрэхгүй байна. Мөн тэрээр Эрүүл мэндийн сайд Захид Малек(Zahid Maleque)-ийг тус салбар дахь зөрчлүүд, сул дорой байдалд буруутгав. “Засгийн эрх барьж буй намд Эрүүл мэндийн яамыг тэргүүлэх түүнээс өөр хүн байдаггүй бололтой” хэмээн тэр дургүйцлээ илэрхийлэв.

Цар тахалд бэлэн бус байснаас шалтгаалан коронавирусний халдвар аваагүй өвчтөнүүд хохирч байгааг Дакагийн их сургуулийн профессор Асиф Назрул(Asif Nazrul) коронавирусний нөхцөл байдлын танилцуулгадаа дурдав. Коронавирусийг оношлох, тус вирусээс хамгаалах амны хаалт болон бусад асуудалтай холбоотойгоор тэрээр хэлэхдээ “хамгийн санаа зовоож буй асуудал бол тус салбарын ил тод байдал алдагдаж, мэдээлэл авах боломжгүй болсон явдал юм” гэжээ. Энэхүү нөхцөл байдалд буруутай этгээдэд зохих байгууллагууд хариуцлага тооцож байхыг тэрээр шаардав. Хэрэв эрүүл мэндийн салбарын оролцогч талуудад хариуцлага тооцохгүй бол хямралд орсон эрүүл мэндийн салбарыг сэргээхэд хүнд байх болно гэж тэр үзэв.

Бангладеш улсад КОВИД-19 халдвар гуравдугаар сарын эхээр тархаж эхэлсэн. Гэтэл тус улс үүнтэй тэмцэхэд бэлэн бус байсан хэмээн нийгмийн эрүүл мэндийн салбарын шинжээч Тауфик Жоардер(Taufique Joarder) яриу. Цар тахал эхлэхээс өмнө буюу өнгөрсөн оны 10 дугаар сард нийтлэгдсэн дэлхийн эрүүл мэндийн салбарын дүр зургийг гаргахад Бангладешийн эрүүл мэндийн салбар таруухан дүр зурагтай гарч байсан хэмээн тэрээр мэдэгдэв. Тус үнэлгээгээр Бангладеш 113 дугаар байрт байгаа нь тус улсын эрүүл мэндийн салбар ямар түвшинд байгааг илтгэж байна хэмээн Жоардер нэмж яриу. Салбар дахь хамтын ажиллагааны дутмаг байдлаас гадна, муу үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд хариуцлага тооцох зорилгоор тус салбарын эрх зүйн орчныг боловсронгуй болгох шаардлагатайг тэрээр онцлов.

Бангладеш улс эрүүл мэндийн салбарт төсвийн хөрөнгийн өчүүхэн хэсгийг зарцуулдаг нь дэлхийд доогуур тооцогддог. Улсын хэмжээнд 16,000 эмнэлэг байдаг ба эдгээрийг зохицуулдаг хууль байхгүйг экологийн чиглэлээр ажилладаг Сайеда Резуана Хасан(Syeda Rezwana Hasan) яриу. Хэрэв бүх зүйлийг зохих ёсоор төлөвлөсөн байсан бол хямрал нүүрлэхээс өмнө эмнэлгүүд эрүүл мэндийн тусламж үзүүлж чадах байсан юм хэмээн тэрээр хэлсэн байна. Цаашид эрүүл мэндийн салбарын үйлчилгээг сайжруулах үүднээс эрүүл мэндийн салбарт зөрчил гарахаас урьдчилан сэргийлж, иргэний нийгмийн байгууллагын платформ байгуулахыг Сайеда Резуана Хасан уриалав.

Яамдын авж хэрэгжүүлж буй арга хэмжээнүүд Халдварт өвчний тухай 2018 оны хуулийн зүйл заалтад (Урьдчилан сэргийлэх, хянах, устгах) нийцэхгүй байгааг Барристер Сара Хоссэйн(Barrister Sara Hossain) онцлов. Орлого багатай, эмзэг бүлгийнхний эрүүл мэндийн

¹¹⁸ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.dhakatribune.com/bangladesh/2020/08/08/accountability-strict-monitoring-imperative-to-fight-corruption-in-health-sector>

үйлчилгээ авах эрх зөрчигдөж, ихэнх санаачилгууд хууль тогтоомжид нийцэхгүй байгааг тэрээр онцлов. Үүнээс гадна, КОВИД-19-ийг оношлох, эмчлэхэд учирч буй хүндрэлүүдийн талаар ихэнх тохиолдолд олон нийт мэдээлэлгүй байгааг тэрээр нэмж яриу.

Эрүүл мэндийн салбар дахь авлигын асуудлыг нуун дарагдуулах явдалд засгийн газар анхаарч байгаа боловч зөрчлүүдийг таслан зогсоох чиглэлд ажиллахгүй байна хэмээн ТИ Бангладеш байгууллагын гүйцэтгэх захирал Ифтехаруззаман (Iftekharuzzaman) тэмдэглэв. Мөн тэрээр засгийн газар иргэдэд үйлчлэх бус эрүүл мэндийн салбарын асуудлаас үүдэлтэй маргаанаас урьдчилан сэргийлэхэд анхаарал хандуулж байна хэмээн шүүмжлэв. Төрөл бүрийн төсөл санхүүжүүлж буй донор байгууллагууд ч хариуцлагатай хандах ёстойг тэрээр онцлов. Хэрэв тэд төслийн шаардлагыг хангах өөрсдийн үүргийг хэрэгжүүлж байсан бол авлига гарах боломж бага байсныг мөн онцлов.

Хахуулийн морь: Тажикстан дахь авлигын асуудлын талаар Хахимов¹¹⁹

2020.08.13. Тажикстан улсын засгийн газар хөрөнгө, орлогын мэдүүлгийн шинэ маягтыг баталлаа. Шинэ журмын дагуу төрийн албан хаагчид үл хөдлөх хөрөнгө, үнэтэй автомашин, банкны хадгаламж, эзэмшиж буй газар ашиглалт, хувийн мал, амьтан зэргийг мэдүүлэх ёстой. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн маягтыг шинэчилж байгаа нь Тажикстанд дугтуйтай мөнгө, үнэтэй бэлэг зэрэг уламжлалт байдлаар хахууль өгөхөөс гадна мал, амьтан бэлэглэх явдал түгээмэл байдаг. Төрийн албан хаагчдад хахуульд морь бэлэглэх явдал их гардаг.

Тус улсад морин спорт, морьдын бооцоот уралдаан хөгжиж байна хэмээн хуульч, улс төр судлаач Шокиржа Хахимова яриу. Үүнээс гадна, орон нутагт төрийн албан хаагчид өөрсдийн малыг малчдад өгч маллуулах явдал байдаг. Үүнийг мөн хахуулийн хэлбэрт тооцож үзэх хэрэгтэй. Донор байгууллагуудаас тусламж авахын тулд тэдний шахалтаар зарим нэг өөрчлөлт хийж байгаа боловч авлигатай тэмцэхийн тулд улс төрийн хүсэл зориг дутаад байна гэдгийг тэрээр онцлов.

Азербайжаны Ерөнхийлөгч орон нутгийн албан хаагчдад авлигын асуудлаар анхааруулга өгөв¹²⁰



Азербайжаны Ерөнхийлөгч Илхам Алиев орон нутгийн шинээр томилогдсон удирдлагуудад авлигын талаар мэдээлэл хийж байна. (Фото: president.az)

2020.09.20. Азербайжаны Ерөнхийлөгч Илхам Алиев (Ilham Aliyev) орон нутгийн шинээр томилогдсон удирдлагуудыг авлигаас ангид байхыг анхааруулаад байна. Мөн энэ үеэр авлигатай тэмцэх кампанит ажлын үеэр баривчлагдсан албан тушаалтнуудыг шүүх хурал үргэлжилж байна.

Ерөнхийлөгч Алиев 09 дүгээр сарын 14-нд Шамкир, Жалилабад дүүргийн шинэ удирдлагуудтай онлайн уулзалт хийсэн бөгөөд тус

дүүргүүдийн өмнөх удирдлагууд сүүлийн нэг жилийн дотор ажлаасаа халагдаж, гэмт хэрэгт буруутгагдаад байгаа билээ.

Уг уулзалтаар Алиев сүүлийн хоёр жилийн хугацаанд авлигатай тэмцэх кампанит ажлын улмаас албан тушаалаа өгсөн өндөр албан тушаалтнуудын шүүх хурал үргэлжилж байгааг онцолсон байна.

¹¹⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://tj.sputniknews.ru/radio/20200813/1031725873/vzyatka-korrupciya-chinovniki-tajikistan.html>

¹²⁰ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://eurasianet.org/azerbaijani-president-warns-local-officials-against-corruption>

“Би олон удаа хэлж байгаа. Та нарт болон бусад албан тушаалтнуудад дахин давтаж хэлэхийг хүсэж байна. Төрийн албан хаагчид албан тушаалаа ашигласан эдгээр муухай үйлдлээ зогсоохгүй бол бүгд ижил хувь заяа хүлээж байгаа” гээд цааш үргэлжлүүлэн *“хэрэв шударгаар ажиллахыг хүсэхгүй байгаа бол энэ ажлыг бүү хий, үүнийг хүлээн зөвшөөрөхгүй бол та амьдралаа сүйтгэх болно”* гэж хэлсэн байна.

2019 оноос хойш Азербайжан улс засгийн газрын болон орон нутгийн удирдах албан тушаалтнууд, зэвсэгт хүчний өндөр албан тушаалтыг хамруулсан авлигач албан тушаалтнуудад хариуцлага хүлээлгэх кампанит ажиллагаа зохион байгуулж байгаа юм.

Зөвхөн 2020 оны эхний хагас жилд зургаан дүүргийн удирдлагууд баривчлагдаж, халагдсан байна. Үүний дараагаар тухайн үед соёлын сайд байсан Абулфас Гараевыг ажлаас нь халж, дэд сайд нар болон улсын хилийн албаны өндөр албан тушаалтнуудыг баривчилсан юм. Эдгээр албан тушаалтнуудын холбогдсон хэргийн мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаа үргэлжилж байгаа бөгөөд ихэнх нь хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах зэрэг хэрэгт буруутгагдаад байна.

Казахстанд 2020 он гарсаар авлигын хэчнээн хэрэг бүртгэгдсэн бэ?¹²¹

2020.10.23. Авлигын хэргийн улмаас улс төрийн 9 албан тушаалтныг албан тушаалаас нь чөлөөлсөн байна.

Стратеги, үйл ажиллагааны төлөвлөлтийн хэлтсийн дарга Нурлан Жаксимбетов 2020 он гарсаар авлигын 2,140 хэрэг бүртгэгдсэн, үүнээс авлигын хүнд гэмт хэрэг 15%-аар өссөн талаар мэдээлсэн тухай Liter.kz. цахим сүлжээнд дурджээ.

Тогтолцооны шинжтэй авлигын 102 хэрэг, бизнесийн хүрээний хууль зөрчсөн авлигын 154 хэргийг тус тус таслан зогсоосон бөгөөд хохирлын хэмжээ нь 39.5 тэрбум тэнгэ болсон нь өмнөх оноос өссөн байна.

Он гарснаас хойш авлигын хэргээр улсын хэмжээний 34, бүс мужийн 72, хотын болон дүүргийн түвшний 89 удирдах албан тушаалтан эрүүгийн хэрэгт холбогджээ.

Дунд шатны албан тушаалтнуудын авлигын хэргийн улмаас улс төрийн 9 албан тушаалтан чөлөөлөгдсөн байна.

Янз бүрийн түвшний 34 удирдах албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан бол улс төрийн 14 албан тушаалтан чөлөөлөгдөхөөр байна.

Цар тахлын үеийн авлигын эсрэг 170 гаруй үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийсэн бөгөөд 800 орчим санал хүсэлтийг төрийн байгуулагуудад хүргүүлсэн байна.

Казахстан: Хятадын хил дээрх цахим систем авлига, ачааллыг нэмэгдүүлсэн¹²²

2020.11.16. Казахстан, Хятадын худалдаа, хилийн хөдөлгөөнийг шинэчлэх зорилготой суурилуулсан цахим систем нь ердөө л авлигыг өөгшүүлж, хэвийн үйл ажиллагааг удаашруулж байгаа талаар Нурсултан дахь хууль санаачилагчид мэдээлжээ. Зарим тохиолдолд ачааны машин хилээр гарахын тулд олон сарын турш хүлээх шаардлагатай болсон байна.

365info цахим хуудсанд мэдээлснээр, 11 дүгээр сарын 16-ны өдөр парламентын бага танхимын төлөөлөгчид энэхүү асуудлыг дарааллын цахим системээс үүдэлтэй хэмээн мэдэгдсэн байна. Уг програм нь зөвхөн тээврийн хэрэгслийн дарааллын дугаарыг харуулдаг бөгөөд тухайн тээврийн хэрэгслийн өмнө болон хойно ямар автомашин байгааг харуулдаггүй байна. Үүнээс улбаалан дараалалд зогсож буй зорчигчдын хооронд үл итгэлцэл үүсч байгаа юм. Учир нь, зарим тээврийн хэрэгсэл олон сар дараалалд хүлээж байхад зарим нь долоо хоног бүр саадгүй зорчдог талаар бага танхимын төлөөлөгчдөөс Ерөнхий сайд Аскар Маминд хаягласан захидалд тусгажээ.

¹²¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://liter.kz/skolko-korrupcionnyh-prestuplenij-zaregistririvali-v-kazahstane-v-2020-godu/>

¹²² Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://eurasianet.org/kazakhstan-it-system-at-china-border-increases-corruption-and-lines>

Дарааллын цахим системийн дагуу Казахстаны хил дээр 6,000 гаруй ачааны машин хилээр гарахаар хүлээж байгаа юм. Бизнес эрхлэгчид ийнхүү удаан хугацаагаар хүлээснээр бараа хүргэх хугацаа хэтэрч, зарим гэрээ цуцлагдахад хүрч буй талаар гомдол гаргажээ.



Фото: President.az

2018 оны 09 дүгээр сард шинэчлэгдсэн Нур Жоли-Хоргос боомтыг ихээхэн хүлээлттэйгээр үйл ажиллагаанд оруулжээ. Казахстаны Сангийн яам уг байгууламжийг “дэвшилтэт технологи, инновацийн шийдэл” ашиглаж барьсан бөгөөд боомтын үйл ажиллагааг 30 дахин нэмэгдүүлж, өдөрт 2,500 автомашин зорчих боломжтой болсон талаар онцолж байв. Хилээр зорчих иргэдийн тоо 18 дахин өсөж, 15 мянгад хүрэхээр төлөвлөсөн байна.

Ложистикийн удирдлагын автомат систем нь бүрэн автомат байдлаар ажиллаж, үйл ажиллагааг хурдасгах байв. Албан хаагчид хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан тусгай зам, эх хүүхдэд зориулсан өрөө, 250 м.кв хүлээлгийн өрөө, кафе, татвараас чөлөөлөгдсөн бүс болон дээд зэрэглэлийн лоунжтай талаар сайшааж байв.

Гэвч бодит байдал дээр шинэ шалган нэвтрүүлэх цэг нь өмнөх асуудалтай дахин нүүр тулгарчээ. Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хилийн боомт дээр ачааны машинууд бөөгнөрч буй талаар мэдээлсэн байна. Тухайн үед Сангийн яамнаас энэхүү бөөгнөрлийг цар тахлаас хамаарч Хятадын эрх баригчдын хэрэгжүүлж буй арга хэмжээнээс үүдэлтэй талаар мэдэгдсэн.

Гэвч хоёр сарын дараа “улсын хилээр саадгүй зорчуулах хүрээнд системтэйгээр хахууль авсан” гэмт хэрэгт холбогдуулан гаалийн албан хаагчдыг авлигатай тэмцэх байгууллага баривчилжээ. Ачаа тээврийн жолоочид өмнөх дарааллын системд эргэн орохыг шаардсан байна.

БНСУ-ын сөрөг хүчний удирдагч өмнөх Ерөнхийлөгчийн авлигын хэрэгт уучлал гуйв¹²³

2020.12.15. Өмнөд Солонгосын сөрөг хүчин болох Ардын эрх намын түр удирдагч Ким Чон Ин 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Ерөнхийлөгч асан Паг Гын Хе, И Мён Баг нарыг авлигын хэрэгт холбогдсон явдалд албан ёсоор уучлал гуйжээ.

Үндэсний Ассамблейн хэвлэл мэдээллийн хуралд “Ерөнхийлөгч асан хоёр хүн нэгэн зэрэг хоригдож байна. Би өнөөдөр иргэдээс чин сэтгэлийн уучлал гуйхаар энд зогсож байна” хэмээн Ардын эрх намын түр удирдагч Ким Чон Ин мэдэгдэв.

Ерөнхийлөгч асан Паг Гын-Хе нь 2016 оны 12 дугаар сард өөрийн үнэнч туслах Чой Сун Силтэй хамтарсан авлигын сүлжээг ашиглан бизнес эрхлэгчдээс олон сая ам.долларын хахууль авсан, эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашигласан хэрэгт буруутгагдаж, 20 жил хоригдох ял сонссон байна. Түүний



Ял эдэлж буй хоёр экс Ерөнхийлөгч болох Паг Гын Хе, И Мён Баг нарын авлигын хэргийн талаар Ардын эрх намын түр удирдагч Ким Чон Ин мягмар гарагт албан ёсоор уучлал гуйлаа.

(Фото: Томас Мареска / UPI)

¹²³ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: https://www.upi.com/Top_News/World-News/2020/12/15/South-Korean-opposition-leader-apologizes-for-corruption-of-ex-presidents/5551608018171/

өмнөх Ерөнхийлөгч асан И Мён Баг мөн адил, хэд хэдэн авлигын хэрэгт холбогдож 17 жил хоригдох ял сонссон юм.

“Ерөнхийлөгчийн харьяалагдах улс төрийн нам нь улс орныг зөв удирдан чиглүүлэхийн тулд бусадтай хамтран ажиллах үүрэг, хариуцлагатай юм. Манай нам тухайн үед эрх баригч нам байсан боловч энэхүү үүргийг биелүүлж чадаагүй. Ерөнхийлөгчийн буруутай үйл ажиллагаа нь мөн эрх баригч намын алдаа болно” хэмээн Ким Чон-ин мэдэгдсэн байна.

Консерватив нам авлигын асуудалтай холбогдож, олон нийтийн дунд нэр хүндээ алдсанаас шалтгаалж Ерөнхийлөгч Мүн Жэ Ин 2017 оны 05 дугаар сард Ардчилсан намаас сонгогдсон билээ. Ардчилсан нам мөн парламентын сонгуульд амжилттай оролцож, 300 суудлаас 180 суудал авсан юм.

Клептократ үйлдэл Монгол Улсад цохилт өгөв үү? Батболдын зөвлөх хариулав¹²⁴

2021.01.06. Richard Messik. 12 дугаар сарын 08-ны өдөр globalanticorruptionblog.com блогт байршуулсан “Клептократ үйлдэл Монгол Улсад цохилт өгөв үү? Батболдын хэрэг” гэх нийтлэлд олон уншигч сэтгэгдэл үлдээсэн байна. Энэхүү нийтлэлд Сүхбаатарын Батболд нь Ерөнхий сайдаар ажиллаж байх хугацаандаа Өмнөд Солонгосын харьяат гэр бүлийн хосуудтай хамтран олон зуун сая ам.долларын хөрөнгө хувьдаа завшиж, тус хөрөнгөөр Нью Йорк хотод үл хөдлөх хөрөнгө худалдан авсан үйлдэлд холбогдох саяхан үүсгэсэн Нью Йоркын иргэний хэргийг мэдээлсэн юм. Хэдийгээр Өмнөд Солонгос улсын тус иргэд нь олон улсын барааны биржид үйл ажиллагаа эрхэлж байсан туршлагагүй боловч С.Батболдын Ерөнхий сайдаар ажиллаж байх хугацаанд Монгол Улсын төрийн өмчийн уул уурхайн хүдрийг давуу эрх олгосон нөхцөлөөр их хэмжээгээр худалдан авсан байна. С.Батболдын хүүхдүүд одоогоор Өмнөд Солонгос хосын нэр дээр бүртгэлтэй орон сууцанд амьдардаг юм.

Энэхүү нийтлэлийг уншигчдын тал нь тус хэргийг зохиомол гэсэн бол нөгөө тал нь С.Батболдын гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дуусгавар болсон гэсэн сэтгэгдэл үлдээжээ. Гэвч тус нийтлэлд дурдсан гэмт хэргийн талаар хэн ч дурдаагүй тул 12 дугаар сарын 23-ны өдрийн нийтлэлд, уншигчдад хэргийн агуулгын талаар ярилцахыг уриалсан юм. Үүнтэй холбогдуулан С.Батболдын зөвлөхөөс тус нийтлэлийг устгахыг хүссэн тухай захидал бидэнд ирсэн юм. Globalanticorruptionblog.com блогийн Ерөнхий редактор Мэттью Стефенсон тус захидлын хариуд аливаа нийтлэлийг хүлээн зөвшөөрөөгүй гэх шалтгаанаар устгахгүй бөгөөд харин залруулга хийх боломжтой талаар мэдэгдсэн.

Зөвлөхийн захидалд С.Батболдын хэргийг үгүйсгэж, тухайн хэрэг нь улс төрийн зорилготой гэж мэдэгдсэн байна. Хэдийгээр нийтлэлтэй холбогдуулан залруулга хийхийг хүсээгүй боловч С.Батболдод холбогдох хэргийн нийтлэл тавигдсаны дараагаар Монгол Улсын төрийн байгууллагаас түүний хэргийг хэрэгсэхгүй болгосон талаар дурджээ. Захидалд дурдсанаар шүүхээс түүнийг цагаатгасан гэжээ. Гэвч энэ нь худал мэдээлэл юм. Шүүхээс тус гэмт хэрэгт холбогдуулан аливаа шийдвэр гаргаагүй. С.Батболд нь төрийн албан хаагчийн хувьд бүх шатны шүүхийн байгууллагад халдашгүй дархан байдал эдэлдэг бөгөөд үүнтэй холбогдуулан Монгол Улс түүний холбогдох гэмт хэргийн шүүн таслах ажиллагааг зогсоосон байж болзошгүй юм. С.Батболдын зөвлөхийн захидлыг дор байршуулав.

Ноён Мессик танаа,

Миний бие С.Батболдын зөвлөхөөр ажилладаг бөгөөд globalanticorruptionblog.com блогт 12 дугаар сарын 08 болон 23-ны өдөр байршуулсан нийтлэлтэй холбогдуулан цахим шуудан илгээж байна. Ерөнхий редактор Мэттью Стефенсон мөн энэ талаар мэдээлэл авах ёстой гэж үзэж байгаа тул түүнд хуулбарыг хүргүүлэв.

Тухайн хоёр нийтлэлийг зөвхөн нэг талыг барьж, бодит байдлыг үл мэдээлсэн явдалд миний хувьд эмзэглэж байна. 12 дугаар сарын 23-ны өдөр байршуулсан нийтлэлд, С.Батболдын талд шийдвэрлэгдсэн Нью Йорк хотын иргэний хэрэгт үндэслэн, шаардлагатай судалгаа шинжилгээ

¹²⁴ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/01/06/kleptocracy-strikes-mongolia-a-batbold-advisor-replies/>

хийлгүйгээр бичсэн Таймс сонинд байршуулсан нийтлэлээс эш татсан байна. Энэ талаар танай блогт дурдаагүй болно.

Аливаа судалгаа шинжилгээ хийлгүйгээр, мөн бидэнтэй холбогдолгүйгээр Таймс сониноос таны авсан Лондонгийн хэргийн талаарх мэдээлэл нь Шүүгч Пэллингийн шийдвэрт бүрэн тулгуурласан болно. Таймс сонин болон таны нийтлэлийн аль алинд тус шүүн таслах ажиллагаанд С.Батболд оролцох боломжгүй байсан талаар дурдаагүй байна. Хэрэв С.Батболд тус шүүх хуралд оролцсон бол хэрэгт холбогдох үл хөдлөх хөрөнгийг өмчилдөггүй бөгөөд цаашлаад шууд болон шууд бусаар өмчлөх аливаа сонирхол байхгүй талаар шүүгч Пэллинг бүрэн ойлгох байсан юм. С.Батболд нь Лондон хотын шүүхэд тус шүүхийн харьяалалд хамаарах аливаа үл хөдлөх хөрөнгөгүй талаар мэдүүлэг хүргүүлсэн болно.

Танд мэдэгдэхэд, С.Батболдод холбогдох худал хуурмаг нэхэмжлэлүүд хэд хэдэн шүүхийн байгууллагад илгээгдсэн. Эдгээр нэхэмжлэлийг гаргасан нөхцөл байдал нь ихэд өвөрмөц байгаа юм. Лондонгийн шүүх хуралд оролцсон гурван нэхэмжлэгч нь С.Батболдын эсрэг ямар нэгэн нэхэмжлэл гаргаагүй талаар мэдэгдсэн бөгөөд Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга мөн үүнийг баталсан болно.

Иймд, С.Батболдын эсрэг гаргасан нэхэмжлэл нь улс төрийн зорилготой гэж харагдаж байна. Дараа жил С.Батболд нь Ерөнхийлөгчийн сонгуульд оролцож одоогийн Ерөнхийлөгч Х.Баттулгатай өрсөлдөх магадлалтай улс төрчийн нэг тул дээрх таамгийг илүү баталгаажуулж байна. Ирэх жилийн Ерөнхийлөгчийн сонгуулийн үр дүнд нөлөөлөх зорилгоор С.Батболдын нэр хүндийг гутаан доромжлох улс төрийн зорилготой үйлдлийг globalanticorruptionblog.com блог өөрийн мэдэлгүй ашигласан явдалд харамсаж байна.

С.Батболд нэхэмжлэлийн хүрээнд өөрийн эрхийг хамгаалах боломжтой цорын ганц харьяалал нь Нью Йорк хот байсан бөгөөд тус хотын шүүхээс С.Батболдын талд хэргийг шийдвэрлэсэн боловч энэ талаар таны нийтлэлд мөн дурдаагүй байна. Шүүгч С.Батболдын эсрэг гаргасан нэхэмжлэлтэй холбогдуулан шүүн таслах ажиллагаа явуулсны үр дүнд тус нэхэмжлэлийн шаардлагыг хангахаас татгалзаж, түүний эд хөрөнгийг царцаах тухай шийдвэрийг цуцалсан юм.

С.Батболдын эсрэг гаргасан нэхэмжлэлийг 12 дугаар сарын 09-ний өдөр эргүүлэн татсан талаарх мэдээлэл олон нийтэд нээлттэй байсан боловч энэ талаар яагаад та бүхэн мэдээлээгүй талаар би гайхаж байна.

С.Батболд нь ямар нэгэн байдлаар улсын төсвөөс хөрөнгө завшаагүй бөгөөд 250 сая ам.долларын хохирол нөхөн төлөхийг Монгол Улсын Засгийн газар шаардаагүй байгаа юм. Та хэт нэг талыг баримталсан мэдээлэл нийтэлжээ. Энэхүү гүтгэлэг нь 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр К2 мэдээллийн фирмийн үүсгэн байгуулагч, дарга Жюль Кроллын гаргасан мэдүүлэгт үндэслэсэн байна. К2 мэдээллийн фирм нь Монгол Улсад байрлаж буй өөрийн захиалагчийн эрх ашгийн төлөө ажиллаж буй хувийн мөрдөх байгууллага юм. К2 мэдээллийн фирмд төлсөн төлбөр нь Монгол Улсын төрийн худалдан авах ажиллагааны холбогдох хууль, журамд нийцэж буй эсэх нь мөн эргэлзээтэй юм. Ямар ч тохиолдолд тус байгууллагыг бие даасан, хараат бус мэдээллийн эх сурвалж хэмээн үзэх боломжгүй.

Жюль Кроллын мэдүүлэгт дурдсан гүтгэлгийг шүүх хуралдаанд хэлэлцээгүй. Тус гүтгэлэг нь баримт нотолгоогүй, таамаглал шинжтэй болно. Тухайн мэдүүлэгт С.Батболдыг татвараас зайлсхийсэн гэх хуурамч мэдээллийг дурдаж, түүнийг 250 сая ам.долларын хохирол учруулсан хэмээн гүтгэсэн юм.

Таны хувьд тус мэдүүлэгт дурдсан нөхцөл байдлыг тодорхойлж чадаагүй байна. Таны нийтлэл шударга, үнэн зөвийг мэдээлээгүй байна.

Таны мэдэж байгаачлан, одоогийн Ерөнхийлөгчийн үед Монгол Улсын хууль дээдлэх зарчим алдагдаж байгаа талаар ЕХ-ноос гадна олон улсын түвшинд ихээхэн шүүмжлэл дагуулж байгаа.

С.Батболд өөрт холбогдох энэхүү хэргийн хүрээнд Монгол Улсын шүүхээс ямар нэгэн бичиг баримттай танилцаагүй болно. Ерөнхий прокурор, Авлигатай тэмцэх газрын дарга болон Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг томилох бүрэн эрхтэй Ерөнхийлөгчийн эсрэг дараа жилийн сонгуульд өрсөлдөх магадлалтай улс төрчийн хувьд энэхүү асуудал ихээхэн сэтгэл түгшээж байна.

Дээр дурдсан мэдээллийг харгалзан үзэж тус нийтлэлийг устгахыг танаас хүсэж байна. Үүнээс гадна яагаад хэргийн бодит байдлыг мэдээлээгүй талаар бид асуухаас өөр аргагүйд хүрлээ.

Таны нийтлэлд ноён С.Батболд ихээхэн бухимдаж байгаа гэдгийг миний захидлын өнгө аясаас харж байгаа гэдэгт тань найдаж байна. Цахим шууданд хариу ирүүлэхийг хүсье. Баярлалаа.

Хүндэтгэсэн,

Ш.Батбаяр

Авлигыг гэмт хэрэг гэж үзэхгүй байна:
Ерөнхий сайд Имран¹²⁵

2021.01.11. Пакистан. Авлигыг нийгмээрээ хэвийн үзэгдэл хэмээн хүлээн зөвшөөрсөн бөгөөд үүнийг гэмт хэрэг гэж үзэхгүй гэсэн байр суурь дэлгэрч байна хэмээн Ерөнхий сайд Имран Хан ням гарагт өгсөн ярилцлагадаа хэлсэн юм.

Түүний хэлснээр, авлигыг зөвхөн хууль сахиулах замаар арилгах боломжгүй. Тиймээс хүмүүсийн ухамсар, нийгмийн сэтгэлзүйг өөрчлөхийн тулд үндэстнээрээ авлигыг муу муухай зүйл гэж ойлгох нь зүйтэй. Үндэсний эвлэрлийн тухай тогтоол нь сөрөг хүчний удирдагчдын амьдралыг авлигын хэргийн хувьд тайван байлгах боловч улс орныг сүйрэлд хүргэх болно гэж тэр хэллээ.

“Сүүлийн 10 жилийн хугацаанд тэд бие биедээ Үндэсний эвлэрлийн тухай тогтоол гарган өгч, үүний үр дүнд улсын өр дөрөв дахин өссөн байна. Тухайн үед Үндэсний хариуцлагын товчоо хэнээс ч хариуцлага нэхэж байгаагүй” гэж Ерөнхий сайд хэвлэл мэдээллийн байгууллагууд болон нэвтрүүлэгчидтэй ярилцахдаа хэлсэн юм.

Тэд улс орондоо өр төлбөрийн ачаалал үүсгэж, орлогын тал хувийг өр төлөхөд ашиглаж байна. Үүний үр дүнд засгийн газар нийгмийн халамжийн төлөө зарцуулах хөрөнгийн нөөцөөр хомсдож байна. Сөрөг хүчний удирдагчдын хийсэн энэ үйлдэл нь үндэсний ёс суртахууны хэм хэмжээг доройтуулж байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр олон сая рупигийн авлигын хэргийг хэвийн мэтээр мэдээлж байгаа нь хэвлэл мэдээллийн хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдаж байна. Иргэншсэн ямар ч улс оронд ерөнхий сайд, эсвэл гадаад хэргийн сайдаа мөнгө угаахын тулд ажилладаг гэж бодож чадахгүй гэж хэлсэн юм.

Аль ч үндэстний хувьд ёс суртахууны доройтол нь эдийн засгийн уналтаас ч өмнө байсан. *“Байгалийн арвин их нөөцтэй орнууд ядуу байгаа нь тэдний удирдагчид авлигад идэгдсэнтэй л холбоотой байдаг”*. Мэдээж энэ байгаа байдлыг эсэргүүцэх нь цаг хугацаа шаардсан, хүнд ажил. Жишээ нь, Хятад улс 400 гаруй төрийн албан тушаалтнаа авлигын хэргээр баривчилж, улмаар ядуурлаас ангижирч чадсан. Авлига багатай засгийн газар л улс орноо цэцэглэн хөгжүүлдэг.

БНСУ АТИ-ээр зургаан байр урагшилжээ¹²⁶

2021.01.29. БНСУ 2020 оны АТИ-ээр 33 дугаар байрт орсон талаар ТИ байгууллагын судалгаанд үндэслэн Yonhap News мэдээлсэн байна.

Уг мэдээнд БНСУ нэг жилийн хугацаанд зургаан байр ахисныг дурдсан бөгөөд тус улс 2017 онд 51, 2018 онд 45, 2019 онд 39 дүгээр байрт тус тус жагсаж байжээ.

ЭЗХАХБ-ын гишүүн 37 орноос 23-т жагсан нэг жилийн хугацаанд дөрвөн байр ахижээ.

АТИ-ээр Дани, Шинэ Зеланд улс 88 оноо аван тэргүүлж, Финланд, Швед, Швейцари (85 оноо), Норвеги (84 оноо), Нидерланд (82 оноо), Герман, Люксембург (80 оноо), Австрали, Канад, Их Британи (77 оноо) улсууд удаалсан байна.

Хамгийн бага үнэлгээг Сомали, Өмнөд Судан (179 дүгээр байр), Сири (178 дугаар байр), БНАСАУ, Конго, Айти улс (170 дугаар байр) авжээ.

Тус улсын индекс сайжрахад засгийн газрын зүгээс коронавирүсний цар тахалтай тэмцэх чиглэлээр авж хэрэгжүүлж буй үр дүнтэй арга хэмжээ, төрийн өндөр албан тушаалтнуудын

¹²⁵ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.thenews.com.pk/print/772259-society-has-accepted-corruption-pm?fbclid=IwAR01-MY8nnaZVasXQI1JHZVK-iHL0C4ckmLcoRfiansAvFia10Sqw0xhHKJs>

¹²⁶ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/economy/3176778.html>

авлигатай тэмцэх үйл ажиллагаа, авлигын эсрэг хууль тогтоомж болон орон нутгийн эрх баригчдын хүчин чармайлт нөлөөлсөн гэдгийг Авлигатай тэмцэх, хүний эрхийн хороо онцолжээ.

АТИ-ийг Дэлхийн эдийн засгийн форум, Дэлхийн банк, Германы Бертелсман сан, Их Британийн Economist Intelligence Unit зэрэг олон улсын 9 байгууллагын шинжээчдийн судалгаа, үнэлгээнээс тооцон гаргадаг. Уг судалгаанд хөрөнгө оруулалтын эрсдэл, үг хэлэх эрх чөлөө, амьжиргааны түвшин болон авлигатай холбоотой бусад үзүүлэлтийг хамруулдаг байна.

Удирдах албан тушаалтны холбогдон шалгагдаж буй авлигын гэмт хэрэг нь компанийн үйл ажиллагаанд хамааралгүй талаар Тенсент компани мэдээлэв¹²⁷

2021.02.11. Хятадын технологийн салбарын томоохон компани болох Тенсент Холдингийн удирдах албан тушаалтны холбогдон эрх бүхий байгууллагад шалгагдаж буй авлигын гэмт хэрэг компанийн үйл ажиллагаатай хамааралгүй талаар тус компаниас мэдээлжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тус хэрэг нь цахим сүлжээний алдартай програм болох Wechat дахь хэрэглэгчийн хувийн мэдээллийг бусдад түгээсэн байж болзошгүй үйлдэлтэй холбогдолтой талаар мэдээлсэн бөгөөд тус компаниас ийнхүү тайлбар өгсөн байна.

Бээжингийн удирдлагууд өмнө нь дотоодын интернет платформуудад ийнхүү хяналт шалгалт хийж байгаагүй бөгөөд одоогоор технологийн салбарын шилдэг мэргэжилтнүүд болон хувийн салбарын тэргүүлэх компаниудын мэдээллийн нууцлалын тухай зохицуулалт зөрчсөн байж болзошгүй үйлдлийг шалгаж байгаа юм.

Хэрэглэгчийн мэдээллийг хамгаалах тухай зохицуулалтыг зөрчсөн ямар нэгэн үйлдэл нь олон жилийн дараа анх удаа хатуу хянан шалгагдаж буй дотоодын технологийн компаниудад ихээхэн хүндрэл учруулах нь ойлгомжтой.

The Wall Street Journal хэвлэл мэдээллийн байгууллагаас Тенсент компанийн удирдах албан тушаалтан нь хууль сахиулагч, төрийн өндөр албан тушаалтан асаны өндөр хэмжээний авлигын хэрэгт холбогдон шалгагдаж буй талаар мэдээлсэн байна.

Тенсент компани “Энэхүү авлигын хэрэг нь Wechat цахим сүлжээний програмтай ямар нэгэн холбоо хамааралгүй болохыг үүгээр мэдэгдэж байна” гэсэн мэдэгдлийг Ройтерс агентлагт хүргүүлжээ.

Тенсент компанийн удирдах албан тушаалтан Жан Фен 2020 оноос эхлэн Wechat програм хэрэглэгчийн хувийн мэдээллийг бусдад түгээсэн хэрэгт холбогдон, Хятадын авлигатай тэмцэх байгууллагад шалгагдаж буй талаар Уолл Стрийт Журнал мэдээлсэн юм.

Хэдийгээр тус авлигын хэрэг нь Wechat програмтай ямар нэгэн холбоо хамааралгүй талаар Тенсент компани мэдээлсэн боловч холбогдох бусад тайлбарыг өгөөгүй байна.

“Энэ нь Бээжин технологийн томоохон компаниудад өөрийн эрх мэдлийг тогтоосон үйлдэл юм. Тус үйлдэл нь улс төрийн албан хаагчдын авлигын эсрэг өмнөх үйл ажиллагааны үргэлжлэл мэт харагдаж байна” хэмээн ЛайтСтрийм байгууллагын судлаач Мио Като мэдээлжээ.

Жан Фен Коммунист намын дүрмийг зөрчсөн хэргээр шалгагдаж буй Нийгмийг аюулаас хамгаалах яамны дэд сайд асан Сүн Лижүнд Wechat програмын мэдээллийг өгсөн хэрэгт холбогдон шалгагдаж байгаа талаар Уолл Стрийт Журнал мэдээлсэн юм.

Мөрдөгчид Жан Фений өгсөн байж болзошгүй мэдээллийг шалгаж байгаа бөгөөд мөн Сүн Лижүний гэмт үйлдлийн зорилгыг мөрдөн шалгаж байна.

Хятадын технологийн салбарын компаниуд хэрэглэгчийн эрхийг зөрчиж, тэдний хувийн мэдээллийг ашиглан бараа үйлчилгээ худалдах зэргээр бизнесээ өргөжүүлж буй үйлдэлд тус улсын хууль тогтоогчид болон төрийн хэвлэл мэдээллийн байгууллагууд ихээхэн шүүмжлэлтэй хандаж байгаа юм.

¹²⁷ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.reuters.com/article/us-tencent-holdings-china-idUSKBN2AB07X>

БНХАУ-ын дарга Ши Жинпиний хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх хөтөлбөрийн хүрээнд сүүлийн жилүүдэд тус улсын технологийн компаниудыг авлигын хэрэгт холбогдуулан шалгах ажиллагаа нэмэгджээ.

Энэ сарын эхээр 100 гаруй ажилтныг хахууль авсан, эд хөрөнгө шамшигдуулсан тул ажлаас халсан талаар Тенсент компани мөн мэдээлсэн байна.

The Wall Street Journal-ын мэдээллийн дараа 900 тэрбум гаруй ам.долларын зах зээлийн үнэлгээтэй Хонконг дахь хамгийн үнэ цэнэтэй компани болох Тенсентийн хувьцааны үнэлгээ 1.6 хувиар буурсан боловч удалгүй 0.5 хувиар өссөн байна.

Бээжингийн ойролцоо орших Жанжиакоу хотын захиргааны 2018 оны мэдэгдэлд Жан Фен нь тус компанийн дэд ерөнхийлөгч гэж тодорхойлогдсон боловч Тенсент компаниас түүнийг дэд ерөнхийлөгч болон удирдах албан тушаалтан биш хэмээн Ройтерс агентлагт мэдээлжээ.

[2020 оны Ази-Номхон далайн бүс нутгийн авлигын эсрэг зэрэглэл: ТИ байгууллагын АТИ ба TRACE Интернэшнл байгууллагын Авлигын эрсдлийн матриц¹²⁸](#)

2021.02.22. Авлигын эсрэг хоёр чухал судалгааны 2020 оны үр дүнг 2020 оны 11 дүгээр сар болон 2021 оны 01 дүгээр сард танилцуулсан. Тус судалгаануудын үр дүн хоорондоо ерөнхийдөө нийцэж байгаа боловч ТИ байгууллагын 2020 оны АТИ болон TRACE Интернэшнл байгууллагын 2020 оны Авлигын эрсдлийн матриц (TRACE Matrix) хоорондын үр дүнгийн зарим ялгаатай байдал, чухал дэвшилттэй талууд болон зарим бууралтууд ажиглагдаж байна. Эрсдлийг цогцоор нь ойлгох, Ази-Номхон далайн бүс нутагт санал болгож буй боломжуудыг ашиглахын тулд дээрх 2 судалгааг аль алиныг нь судалж, ойлгох хэрэгтэй юм.

Ази-Номхон далайн бүс нутгийн АТИ-ийн дундаж оноо дэлхийн дунджаас сайн байгаа хэдий ч (45:43 харьцаатай) тус бүс нутгийн улс орнуудын талаас илүү хувийг авлига, хахуулийн өндөр эрсдэлтэй гэж үздэг. Харин TRACE бүс нутгийн улс орнуудын дөрөвний гурваас их хувийг маш өндөр эрсдэлтэй гэж үздэг. Дээрх хоёр судалгааны 2020 оны үр дүнг эндээс харж болно.

Товч үр дүн

Тус бүс нутгийн АТИ-ийн оноо болон байр ерөнхийдөө жилээс жилд тогтвортой байсан боловч 2020 оны үр дүнгээр бүсийн хамгийн бага үзүүлэлттэй байсан орнууд бага зэрэг буурч (Индонез 17 байраар ухарсныг эс тооцвол), өндөр үзүүлэлттэй орнууд бага зэрэг өссөн (Мальдив 55 байраар урагшилсныг эс тооцвол)-ийг онцлов.

TRACE-ийн Матрицаар тус бүс нутгийн ихэнх орнуудын оноонд мэдэгдэхүйц ахиц гарч, зарим улс орнууд өндөр эрсдлээс бага эрсдэлтэй ангилалд шилжсэн байна. (Жишээлбэл, Бруней 78 байраар урагшилж, өндөр эрсдлээс дунд эрсдэлд шилжсэн, Зүүн Тимор 27 байраар урагшилж өндөр эрсдлээс дунд эрсдэлд шилжсэн байна). Мөн зарим мэдэгдэхүйц бууралт гарсан орнууд байна (Жишээлбэл, Хонконг, Филиппин хоёулаа 10 байраар ухарсан).

Сонирхолтой нь, зарим оронд ТИ-ийн АТИ буурч байхад TRACE-ийн Матриц өссөн байгаа нь үр дүнгүүд хоорондоо тохирохгүй байгааг харуулж байна (Жишээлбэл, Вьетнам, Мьянмар гэх мэт). Мөн зарим оронд ТИ-ийн АТИ өссөн байхад TRACE-ийн Матриц буурсан тохиолдол байна (Жишээлбэл, Афганистан, Хонконг, Шинэ Зеланд).

Аргачлал

ТИ-ийн АТИ болон TRACE-ийн Матриц хоёулаа гүйцэтгэлийг үнэлж, улс орнуудыг 1-ээс 100 оноогоор үнэлж, оноонд үндэслэн байр эзлүүлдэг. АТИ-ийн хувьд эрсдлийн оноо нь эзлэх байрын эсрэг байдаг бол TRACE-ийн Матрицын хувьд өндөр оноо өндөр эрсдэлтэй ангилалд тооцогддог. Жишээлбэл, тус бүс нутгийн хамгийн бага авлигад өртсөн улс болох Шинэ Зеланд нь 1 болон 5 дугаар байрт бичигдсэн боловч АТИ-ээр 88 оноо, TRACE-ийн Матрицаар 8 оноо

¹²⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.lexology.com/library/detail.aspx?g=c745b113-92d9-4172-a584-2c696580c6d4>

авсан. Эсрэгээрээ, авлигын эрсдэл өндөртэй улс болох Хойд Солонгос 170 болон 194 дүгээр байрт бичигдэж, АТИ-ээр 18 оноо, TRACE-ийн Матрицаар 93 оноо авсан.

Бас нэг гол санаж байх ялгаатай тал нь ТИ-ийн АТИ олон нийтийн авлигын талаарх ойлголт (бага, дунд, өндөр)-ыг хэмждэг бол TRACE-ийн Матрицад арилжааны хахууль багтдаг ба 4 үзүүлэлтээр оноог үнэлдэг. Үүнд, хахууль үүсгэх боломж (засгийн газрын харилцан үйлчлэл, хүлээлт, хөшүүрэг), таслан зогсоох (татгалзах, хэрэгжүүлэх), ил тод байдал (засгийн газар ба төрийн алба), хяналт (хэвлэлийн эрх чөлөө, иргэний нийгэм) гэсэн үзүүлэлтүүдийг дараах байдлаар 5 үнэлгээгээр үнэлдэг (маш доогуур, доогуур, дунд, өндөр, маш өндөр).

Тэмдэглэл

БНХАУ. ТИ-ийн АТИ-д 1 оноо, 2 байраар, TRACE-ийн Матрицад 5 оноо, 8 байраар урагшилж амжилтаа үргэлжлүүлсэн үзүүлэлттэй байна.

Хонконг. ТИ-ийн АТИ-д 1 оноо нэмж 5 байр ахисан боловч TRACE-ийн Матрицад 3 оноо буурч 10 байраар ухарчээ. TRACE-ийн зүгээс үүнийг Хонконгийн хахуулийг таслан зогсоох чадвар болон хотын захиргаа, төрийн үйлчилгээний ил тод байдал тус тус буурсан нь оноо болон байрыг ухраахад нөлөөлсөн гэж тайлбарлажээ. Хонконг нь АТИ болон TRACE-ийн Матрицын хамгийн бага авлигын эрсдэлд тооцогддог ангилалд багтсан хэвээр байна.

Индонез. 2020 онд ТИ-ийн АТИ-д 3 оноо буурч 17 байр ухарсан. Уг ухралтыг 2019 оны үр дүнд үндэслэн урьдчилан тооцоолох боломжтой байсан боловч авлигатай тэмцэх байгууллагын хууль, эрх зүй сул байгааг тусгаж чадаагүй байна. Нэг гайхмаар зүйл бол Индонез улс TRACE-ийн Матрицаар 6 оноогоор нэмэгдэж, 16 байраар урагшилсан бөгөөд засгийн газрын болон санхүүгийн ашиг сонирхлын ил тод байдал, хэвлэл мэдээллийн эрх чөлөөний үзүүлэлт нь сайжирсан байна.

Мальдив. ТИ-ийн АТИ болон TRACE-ийн Матрицад аль алинд нь илт сайжирсан нь харагдаж байна. Тус улс нь ТИ-ийн АТИ-д 14 оноо, 55 байраар урагшилж, өндөр эрсдэлтэй ангиллаас дунд эрсдэл рүү шилжсэн бол TRACE-ийн Матрицад 11 оноо, 39 байраар урагшилжээ. ТИ байгууллага хэлэхдээ тус улсын энэхүү өсөлт нь 2018 оны сонгуультай холбоотой бөгөөд өнөө үед авлига, мөнгө угаасан хэргээр яллагдагчаар татагдаад байгаа хэд хэдэн улс төрчийг суудлаас нь чөлөөлсөн, өмнө нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сөрөг хүчнийг заналхийлж, яллах зорилгоор ашиглаж байсан эрүүгийн нэр хүндэд халдах тухай хууль гэх мэт хэлмэгдүүлэлтийн хуулиудыг хассантай холбон тайлбарлав. Үүнтэй адилаар, TRACE нь 2020 онд Мальдивын хахуулийн хязгаарлалт, хяналт тавих нийгмийн чадвартай холбоотойгоор сайжирсан гэж мэдээлсэн.

Бруней Даруссалам. ТИ-ийн АТИ-д оноо болон байраа хадгалсан бол TRACE-ийн Матрицад 18 оноо, 78 байраар урагшилжээ. TRACE тус улсын хахуулийг таслан зогсоох, хахуулийн эсрэг хяналт тавих чадвар сайжирч, тус улсын засгийн газартай харилцах харилцаанд мэдэгдэхүйц ахиц дэвшил гарч байгааг ажигласан гэжээ.

Мьянмар. Тус улсын ТИ-ийн АТИ-ийн 2020 оны үр дүн 2021 онд гарсан. Хэдийгээр тус улс өнгөрсөн оноос 1 оноогоор доогуур үнэлгээ авж, 7 байраар ухарсан ч өнгөрсөн найман жилийн хугацаанд 13 оноогоор ахижээ. ТИ байгууллагын мэдээлснээр тус улс 2020 онд дээд түвшний албан тушаалтнуудын эсрэг мөрдөн шалгах ажиллагаа явуулсан зэрэг төрөл бүрийн шинэчлэлтийг хэрэгжүүлсэн гэх мэт авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй засгийн газрын хүчин чармайлтын талаар иргэд нааштай хандаж байгааг харуулж байна. Тус үзүүлэлт нь АТИ-д мөн тусгагдсан байж магадгүй бөгөөд 8 оноо, 23 байраар урагшилжээ.

Дүгнэлт

ТИ-ийн АТИ болон TRACE-ийн Матриц нь улс орнуудын авлигын ерөнхий эрсдлийг үнэлэхэд хамгийн хэрэгцээтэй хэрэгслүүд хэвээр байна. Хэдийгээр 2020 оны TRACE-ийн Матрицад Ази-Номхон далайн бүс нутгийн улс орнууд ерөнхийдөө сайжирсан ч авлигын өндөр болон бага эрсдэлтэй улс орнуудын хоорондын ялгаа нэмэгдэж байгааг харуулж, АТИ нь тухайн бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй компаниуд тодорхой харьяаллын хүрээнд авлигаас сэргийлэх ёстойг сануулж байна. Нэмж дурдахад, компаниуд эрсдэлд суурилсан уян хатан, тохиромжтой хандлагыг баримтлан, нягтлан шалгах ажиллагаа болон бусад дагаж мөрдөх журмыг ашиглан өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой эрсдлийг үнэлэх хэрэгтэй юм.

Их Британи улсын мөнгө угаах,
терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэл
бүхий 21 орны жагсаалтад Пакистан улс
нэмэгдлээ¹²⁹

2021.04.11. Их Британи улсын засгийн газраас Пакистан улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх чиглэлд хяналт хангалтгүй, өндөр эрсдэлтэй 21 орны жагсаалтад оруулав.

Их Британийн засгийн газраас энэхүү жагсаалтыг ФАТФ-ын жагсаалтад орсон орнуудаас өндөр эрсдэлтэй, эсвэл хяналтад нэмэгдсэн эсэхээр нь гаргасан байна.

Пакистан улс энэхүү жагсаалтын 15 дугаарт Сири, Уганда, Йемен, Зимбабве зэрэг зөрчилдөөнд автсан орнуудтай хамт жагсаж байна.

Их Британийн засгийн газрын мэдэгдсэнээр энэ ангилалд багтсан улс орнууд татварын хяналт сул, терроризмыг санхүүжүүлэх, мөнгө угаах үйл ажиллагааны хяналт шалгалт муу зэрэг нь аюул дагуулж байна гэжээ.

Их Британийн засгийн газрын Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхийн эсрэг 2021 оны тогтоол нэмэлт өөрчлөлт оруулж, шинэ жагсаалтыг гарган өндөр эрсдэлтэй гуравдагч орнуудыг тодорхойлсны дараа 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болсон юм.

Их Британийн засгийн газар үйлчлүүлэгчдийн нягт нямбай ажиллах шаардлагыг сайжруулах зорилгоор өндөр эрсдэлтэй гуравдагч орнуудын жагсаалтыг гаргасан гэж мэдэгдэв.

2020 оны 12 дугаар сард Их Британийн засгийн газрын тайланд хууль бус мөнгө Пакистан болон Их Британийн хооронд саадгүй шилжиж байгааг тэмдэглэжээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үндэсний эрсдлийн үнэлгээ – 2020 тайланд “Авлигад идэгдсэн гадаадын элитүүд авлигын орлогоо нуун далдлахын тулд Их Британи улсын үл хөдлөх хөрөнгийн зах зээлд, ялангуяа Лондон хотод татагдсаар байна” гэжээ.

Санхүү, дотоод хэргийн яамнаас нэгтгэн гаргасан энэхүү тайланд хамгийн их мөнгөний урсгал орж ирдэг орнуудаар Пакистан, БНХАУ, Хонконг, ОХУ, АНЭУ нэрлэгдэж байна.

Пакистаны тухай тус тайланд дурдахдаа: Их Британи улс Пакистантай эдийн засгийн нягт холбоотой хэвээр байгаа бөгөөд энэхүү мөнгөний урсгалд хоёр улсын хоорондын мөнгөн гуйвуулгын дүн орж байгаа юм. Энэ дүн 2017 онд ойролцоогоор 1.7 тэрбум доллартой тэнцэж байна.

Уг тайланд “Гэмт хэрэгтнүүд Пакистанаас Их Британи руу шилжүүлсэн хууль бус мөнгийг угаах зорилгоор үл хөдлөх хөрөнгө, үнэт чулуу, үнэт эдлэл зэрэг өндөр үнэ бүхий хөрөнгө худалдаж авсаар байна”. “Үүнд авлига, мансууруулах бодисын наймаанаас олсон орлого орно. Мөн Их Британиас Пакистанд хууль бусаар хил давуулсан бэлэн мөнгө, мөнгөний үйлчилгээний бизнесээр дамжуулан мөнгө угаах эрсдэл хэвээр үргэлжилсээр байна” гэжээ.

Мөн 2018 онд Пакистан улс нь “саарал жагсаалт” гэж нэрлэдэг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стратегийн дутагдалтай орнуудын жагсаалтад нэр дэвшиж байсан талаар тус тайланд дурджээ.

The Economist: Авлигатай тэмцэх үйл
ажиллагааны үр дүнд илүү олон хятад
залуус төрийн албанд орохыг хүсэж
байна¹³⁰

2021.05.16. Хятад улсад хэрэгжүүлж буй авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр дүнд төрийн албанд итгэх итгэл нэмэгдэж, олон залуус төрийн албан хаагч болох хүсэлтэй байгааг Лондонд төвтэй Экономист сэтгүүлээс онцолсон байна.

¹²⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.geo.tv/latest/344769-pakistan-added-in-uks-list-of-21-high-risk-countries-over-money-laundering-terror-financing>

¹³⁰ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: http://www.xinhuanet.com/english/europe/2021-05/16/c_139949486.htm

Төрийн албанд орохоор 2020 онд 1 сая орчим хүн Хятадын үндэсний төрийн албаны шалгалт өгсөн нь өмнөх жилийнхээс ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн болохыг тус сэтгүүлээс гаргасан мэдээнд дурдсан байна.

Үүнээс ч олон хүн орон нутгийн болон бүсийн төрийн байгууллагын албан хаагч болохоор шалгалт өгсөн байна.

Хятадын төрийн албан хаагчдад итгэх итгэл нэмэгдэж байна хэмээн Хятадын шилдэг их сургуулиудын өндөр өрсөлдөөнтэй магистрын хөтөлбөрийг өнгөрсөн жил дүүргэсэн Жу Линг хэлснийг тайланд онцолжээ.

Шри Ланка улсыг хэрхэн нэг гэр бүл эрхшээлдээ авж байна вэ?¹³¹

2021.07.29. Liz David-Barrett. 26 жил үргэлжилсэн иргэний дайны дараагаар бий болсон ардчилсан улс нь Ражапаксагийн гэр бүлийн үйл ажиллагааны үр дүнд нэг гэр бүлийн эрхшээлд орж байна. Готабаяа Ражапакса нь 2019 оны сүүлээр Ерөнхийлөгчөөр сонгогдсон ба тэрээр өөрийн дүү Махиндаг Ерөнхий сайд болон Сангийн сайдын албан тушаалд зэрэг томилжээ. Эцэст нь Махиндаг Сангийн сайдын үүрэгт ажлаас чөлөөлсөн боловч мөн л өөрийн дүүг тус албан тушаалд томилсон байдаг. Түүний дөрөв дэх дүү нь Усны аж ахуйн сайд, түүнчлэн Махиндагийн хүү хоёр яамыг зэрэг удирдан ажилладаг байна. Цаашлаад, Ражапаксагийн гэр бүл төсвийн хөрөнгийн 24 хувийг зохицуулан ажиллаж байна. Түүнчлэн, парламентын 6 гишүүн мөн л тус гэр бүлийн гишүүд юм. Ражапаксагийн гэр бүл өөрсдийн хамсаатнуудыг төрийн албаны болон төрийн өмчит компанийн удирдах албан тушаалтнаар томилж, өөрсдийн нөлөөллийг нэмэгдүүлжээ.

Шри Ланка улсын засгийн газарт эрх мэдлээ баталгаажуулсан Ражапаксагийн гэр бүлийн эдгээр үйлдлээс гадна, тэд тус улсыг эрхшээлдээ авах дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж буй нь улам их хор хөнөөл дагуулж байна. Үүнд:

- Төрийг эрхшээлдээ авах ажиллагааны үндсэн зарчмын нэг нь институцийн дүрмийг өөрчилж, засгийн газрын хяналт шалгалтыг устгахад оршдог. Авлигатай тэмцэх болон санхүүгийн зарцуулалтыг хянах эрх бүхий байгууллага нь төрийг эрхшээлдээ оруулахаар санаархаж буй этгээдэд саад болж байдаг. Иймээс 2020 оны 10 дугаар сард Ражапакса парламентын олонхыг ашиглаж үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Нэмэлт өөрчлөлтөөр Авлигатай тэмцэх хороонд Үндсэн хуулиар олгогдсон эрхийг цуцалж, мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлэх эрхийг хассан байна. Түүнчлэн, тус нэмэлт өөрчлөлтөөр Үндэсний худалдан авалтын хороо болон Аудитын хороог татан буулгажээ.
- Төрийн хяналт шалгалтыг хязгаарласны дараагаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа ихэвчлэн иргэний нийгэм болон чөлөөт хэвлэлийг хааж боогдуулах явдал байдаг. Үүнийг бид мөн Шри Ланка улсаас харж болно. Төрийн үйл ажиллагааны талаар шүүмжлэлтэй хандаж байсан идэвхтэн 2020 оны 04 дүгээр сараас эхлэн баривчлагдан, хоригдож байна. Өөр нэгэн идэвхтэн Асела Сампат өөрийн орон байрнаас баривчлагдсан бөгөөд хожим батлан даалтаар суллагдсан байдаг. Бусад идэвхтэн иргэд цахим сүлжээнд төрийн үйл ажиллагааг шүүмжилснийхээ төлөө олон сарын турш баривчлагджээ. Иргэний нийгмийн байгууллагуудад батлан хамгаалахын тагнуулын ажилтан гэнэтийн айлчлал хийж тусламж, дэмжлэг хүсэхээс өмнө тус байгууллагад нэн түрүүнд мэдэгдэх шаардлагатай гэж хэлжээ. Цаашлаад, Ражапаксагийн гэр бүл хэвлэл мэдээллийн салбартай тогтоосон найрсаг харилцаагаа ашиглаж чөлөөт хэвлэлийг боогдуулсан юм. Жишээлбэл, хүнийг алах гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон этгээд болох Думинда Силвад уучлал үзүүлжээ. Энэхүү үйлдэл нь хэвлэл мэдээллийн салбарын нөлөө бүхий этгээд болох түүний ахаас дэмжлэг авах зорилготой байж болзошгүй билээ.

Үүнээс дүгнэхэд, Шри Ланка улс эрх чөлөөт бус авторитар дэглэмд шилжиж байна. Энэхүү үйл ажиллагааг олон улсын нийгэмлэгүүд анхааралдаа авж эхэлсэн бөгөөд Европын парламентаас ЕХ-ны худалдааны нөлөөг ашиглаж тус улсын засгийн газрын эрх зүйт төр болон хүний эрхийн

¹³¹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/07/29/guest-post-how-one-family-is-capturing-the-sri-lankan-state/>

эсрэг үйлдэж буй үйл ажиллагаатай тэмцэхээр ажиллаж байна. Хэдийгээр энэхүү үйл ажиллагаа нь сайшаалтай боловч тус улсын хүчирхэг удирдагчдын төрийг эрхшээлдээ авах ажиллагааг зогсооход илүү оновчтой, олон тооны арга хэмжээ авах шаардлагатай юм.

Америк тив

Коронавирусний тархалт Гондурас тив нэгэн “тахал”-ыг ил болгов¹³²

2020.03.28. Энэ долоо хоногт Гондурас улсад КОВИД-19 халдварын тохиолдол 67 болж, нас барсан эхний тохиолдол бүртгэгдсэний сацуу тус улсын хүн амын эрүүл мэндийн нөхцөл байдлыг доройтуулж байгаа өөр нэг “тахал” нь авлига болохыг шинжээчид анхаарууллаа.

Тус улсын нийслэл Тегусигалпад төвтэй хүний эрх, ил тод байдлыг хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Илүү шударга нийгмийн холбоо ТББ-ын тэргүүн Карлос Эрнандэс хэлэхдээ, *“Бид маш хэврэгхэн эрүүл мэндийн тогтолцоотой. Харамсалтай нь манай үе үеийн засгийн газрын хувьд энэ асуудлыг хэзээ ч нэн тэргүүнд анхаарч үзэх асуудал гэж тооцож байгаагүй. Тэгээд бас өөр нэг шалтгаан нь мэдээж авлига юм”* гэжээ.

Жонс Хопкинсийн их сургуулийн Дэлхийн эрүүл мэндийн аюулгүй байдлын үзүүлэлтээр бол Гондурас нь эрүүл мэндийн хамгийн тааруухан хөгжилтэй орнуудын тоонд багтдаг бөгөөд цар тахалтай тэмцэх чадваргүй юм. Тус улс ДНБ-ийхээ дөнгөж 8.5%-ийг эрүүл мэндийн салбартаа зарцуулдаг нь бүс нутгийн хэмжээний дундаж болох 14%-тай харьцуулахад тун бага үзүүлэлт юм. Үүнээс гадна, эрүүл мэндийн салбар дахь авлига, эм, эмнэлгийн хэрэгслийг хэт хөөрөгдсөн үнээр худалдан авдаг тогтолцоо, улсын төсвийн хөрөнгийг шамшигдуулдаг байдал зэрэг нь дээрх асуудлыг улам бүр даамжруулсаар байгаа билээ.

Гондурасын эрүүл мэндийн тогтолцоо нь тус салбарт жилийн жилд давтагддаг төсвийн хөрөнгийн дутагдал гачигдал, тэрхүү багахан хэмжээний төсвийг нь ашиглан завшсан удаа дараагийн авлигын гэмт хэргүүдийн улмаас дампуурлын ирмэгт ирээд байна. Эмнэлгүүд нь эм, эмнэлгийн хэрэгсэл, ор, наад захын хэрэгцээт зүйлсээр дутмаг байгаа нь өдөр тутам нэмэгдэж буй цар тахлын нөхцөл байдлын аюулыг нэмэгдүүлсээр байна.

Вирусний тархалтын эсрэг авах аливаа хариу арга хэмжээ нь засгийн газарт байгаа завшигчдад мөнгө хулгайлах боломжийг улам бүр бүрдүүлж, нөхцөл байдлыг дордуулах болно гэж шинжээчид үзэж байна.

Эрнандес *“түүхэн сургамжаас харахад улс оронд гамшиг, хямралын үе тохиолдоход авлигачид л завшиж байдаг”* гэв.

Маш олон жилийн өмнөөс эхлэн Гондурасын эрүүл мэндийн салбар авлигад идэгдэж эхэлсэн. Гэвч 2015 онд илэрсэн нэгэн хэрэг нөхцөл байдал хэрээс хэтэрснийг харуулж, гондурасчуудыг гудамжинд гарч эсэргүүцлээ илэрхийлэхээс аргагүй байдалд оруулсан юм.

Нийтийн эрх ашгийг зөрчсөн гэмт хэргийг мөрдөн шалгах эрх бүхий байгууллага болох Гондурасын Нийтийн албаны яамны ажилтнууд эрүүл мэндийн салбараас хэдэн зуун сая долларыг ашиглан завшихад ашиглагддаг, өөр хоорондоо нягт уялдаатай ажилладаг хуурамч компаниудын сүлжээг илрүүлсэн билээ.

Баячууд тансаг орд харш, үнэтэй машин худалдан авж байхад дундаж иргэд нь эм тариагаар дутагдаж, эмнэлэгт ч хэвтэж чадахгүй байлаа. Дээрх хэргээр 45 орчим хүн шалгагдаж, 10 хүн ял авжээ.

“Эрүүл мэндийн салбар дахь авлига нь новишийн улс төрчид, ашиг хөөсөн новишийн бизнес хийгчид, новишийн түшмэлүүдийн холбоо сүлбээ юм. Тэд л энэ салбарыг тонон дээрэмдсэн” гэж Эрнандэс өгүүлэв.

¹³² Орчуулсан: А.Билгүүн. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/03/coronavirus-crisis-exposes-pandemic-honduras-analysts-200327183808256.html>

АНУ: 2018, 2022 оны хөлбөмбөгийн ДАШТ-ний эрхийг авахын тулд хахууль ашигласан¹³³

2020.04.07. Орос, Катар улсууд 2018 болон 2022 оны хөлбөмбөгийн ДАШТ-ийг зохион байгуулах эрх олж авахын тулд хахууль санал болгож, өгсөн хэмээн АНУ-ын хууль хяналтын байгууллагууд мэдэгдлээ.

Олон улсын Хөлбөмбөгийн холбоо (ОУХБХ)-ны авлигын асуудалтай холбоотой мөрдөн шалгах ажиллагааны хэсэг болгож Нью Йорк хот дахь Холбооны прокуроруудын гаргасан баримтад 2018, 2022 оны хөлбөмбөгийн ДАШТ-ийг зохион байгуулах улсыг шалгаруулах санал хураахтай холбоотойгоор ОУХБХ-ны удирдах хорооны нэр бүхий гишүүдийг хахууль авсан хэмээн буруутгажээ.

Мөн АНУ-ын Хууль зүйн яамнаас 2018, 2022 оны хөлбөмбөгийн ДАШТ-ийг телевизээр дамжуулах эрх олгох нууц санал хураалтын мэдээллийг олж авах зорилгоор хахууль өгсөн хэрэгт 21st Century Fox компанийн хоёр захирлыг буруутгасан байна.

21st Century Fox компани нь ДАШТ-ий 2018, 2022 оны эрхийг 2011 онд ESPN компанийг ялж авсан бөгөөд улмаар 2026 оны тэмцээний эрхийг санал хураалтгүй авсан юм. Харин ESPN компанийн хувьд англи хэлээр дамжуулах эрхийг 1994-2014 онд эзэмшиж байсан юм.

2026 оны хөлбөмбөгийн ДАШТ-ийг АНУ, Мексик, Канад улсууд зохион байгуулахаар төлөвлөж байгаа бөгөөд 1994 оноос хойш тус тэмцээн Хойд Америкт болж байгаа хамгийн анхны тохиолдол юм.

Орос, Катар улсууд ДАШТ-гэй холбоотой хахуулийн талаарх мэдэгдлийг няцаав¹³⁴

2020.04.09. 2018 болон 2022 оны хөлбөмбөгийн ДАШТ-ийг зохион байгуулах эрхийг авахын тулд хахууль өгсөн гэх АНУ-ын прокуроруудын мэдэгдлийн эсрэг мягмар гарагт Орос, Катар улсууд тус бүртээ няцаалт хийв.

Даваа гарагт АНУ-ын Хууль зүйн яамнаас гаргасан баримтад ОУХБХ-ны Удирдах зөвлөлийн албан тушаалтнууд Орос, Катар улсын төлөө санал өгөхдөө хахууль авсан гэж дурдсан юм.

Кремлийн хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песков “*Эрхийг хууль ёсны дагуу авсан*” гэсэн бол “*Баримтад агуулагдаж байгаа мэдэгдлийг хүчтэй няцааж*” байна гэсэн мэдэгдлийг Дохагаас гаргаад байна.

АНУ-ын хууль хяналтын байгууллагуудаас гаргасан сүүлийн мэдэгдэл нь тухайн үеийн ОУХБХ-ны Ерөнхийлөгч Зепп Блаттерыг албан тушаалаа өгөхөд хүргэсэн 2015 оны авлигын хэрэгтэй холбоотой билээ. Улмаар АНУ-ын хууль хяналтын байгууллагуудаас нийт 45 хүн болон компанийг хахуульд 200 гаруй сая ам.доллар авсан, өгсөн зэрэг 90 гаруй хэрэгт буруутгаад байгаа юм.



Катар улс 2022 оны дэлхийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахаар Лусаил дахь үүнтэй ижил цэнгэлдэх хүрээлэнг барихад асар их мөнгө зарцуулаад байна. (Фото: Reuters)

¹³³ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.goal.com/en/news/bribes-used-to-secure-fifa-2018-2022-world-cup-rights-us-dept-of-/13o6by2w7ax2610murkypeqmnq>

¹³⁴ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.straitstimes.com/sport/football/russia-and-qatar-reject-world-cup-bribery-claims>

2020.05.27. Цар тахлын үед ч авлигачдын үйлдэл буурахгүй байна. Амьсгал дэмжих аппарат, амны хаалт, бусад эмнэлгийн хэрэгслийн нийлүүлэлттэй холбоотой авлигын хэргүүдээс үүдэлтэй албан тушаалаа орхиж буй албан тушаалтнууд Аргентинаас Панам хүртэл байна. Үйлдвэрлэгч нарын үнийн хөөрөгдөлөөс үүдэн, улс төрөөр холбогдсон, хямралыг боломж гэж харагч зуучлагчид ашиг хонжоо олж байна. “*Ямар нэгэн хүнд нөхцөл үүсэхэд зардлын хяналт сулардаг ба энэхүү боломжийг олз ашиг олохын тулд ашиглах сонирхолтой хэн нэгэн гарч ирдэг*” хэмээн Перу улсын Ерөнхийлөгч асан Алберто Фужиморийг яллаж байсан прокурор асан, 2014-2017 онд ТИ байгууллагын даргаар ажиллаж байсан Хосе Угас мэдэгдсэн байна. Латин Америкт цар тахал тархаж буй энэ үед нас барагсдын тоо нэмэгдэх, эмнэлгүүд дүүрч, эдийн засаг унах аюул тулгараад байна.

Хээрийн эмнэлэг барих хөрөнгөнөөс 150 сая ам.доллар шамшигдуулсан хотын захирагчийн гэрт Рио де Жанейрогийн Цагдаагийн газар мягмар гарагт нэгжлэг хийв. Харин Колумб улсад 32 хотын захирагчаас 14 нь хөрөнгө шамшигдуулсан, худалдан авах ажиллагааны хууль зөрчсөн зэрэг асуудалд шалгагдаж байна. Аргентинд улс төрийн нөлөө бүхий этгээд 15,000 ширхэг N95 амны хаалт худалдан авахад оролцсон асуудлыг прокурор шалгаж байна. Эдгээр амны хаалтыг 10 дахин өндөр үнээр худалдан авжээ.

Хамгийн том хэрэг Боливи улсад гарсан байна. Тус улсын Эрүүл мэндийн сайд амьсгал дэмжих 170 ширхэг аппаратыг хэт өндөр үнээр авсан хэрэгт буруутгагдан баривчлагдсан юм. Тус аппаратыг нэгийг нь 28,000 ам.доллаар авсан гэсэн боловч Испанийн үйлдвэрлэгч нь 6,000 евро буюу 6,500 ам.доллаар борлуулсан гэж мэдэгдсэн байна. Гэтэл эдгээр аппаратыг удаан хугацаанд ашиглах боломжгүй юм.

Иймэрхүү асуудал Панам улсад мөн гарсан. Ерөнхийлөгчийн туслах ажлаасаа халагдаж, дэд ерөнхийлөгч огцрохоор болов. Тэд 100 ширхэг амьсгал дэмжих аппаратыг нэг бүрийг нь 50,000 ам.доллаар худалдан авсан хэрэгт буруутгагдсан юм.

Цар тахалтай холбоотой гарч буй нотлогдсон гэмт хэргийн тоогоор Бразил дэлхийд хоёрт орж байна. Бразилийн цагдаагийн байгууллагад Корона жато гэх цар тахалтай холбоотой гэмт хэргийг мөрдөн шалгах хэсэг байгуулагдаад байна.

Цар тахал зөвхөн Латин Америкт төдийгүй, дэлхийн өнцөг булан бүрд гэмт хэрэг гарах шалтгаан болж байна. Испани, Итали болон бусад улс орнуудад цар тахлын үед байж боломгүй гэмт хэргүүд гарч байна. АНУ-д Катарина хар салхины улмаас учирсан хохирлыг буруулахад зориулсан 1 тэрбум ам.долларын 16%-ийг шамшигдуулсан гэсэн тооцоолол байдаг. Гэтэл баян ядуугийн ялгаа ихтэй, нийгмийн халамж хүнд байдаг Латин Америкт төсвийн хөрөнгийг шамшигдуулах асуудал нь байж боломжгүй зүйл юм. Учир нь, Латин Америкийн ихэнх улс оронд нийт ажиллагсдын тал хувь нь эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн хангамжгүй, албан бус хөдөлмөр эрхэлдэг.

“Бид ялагдлаа. Авлигын цомыг хэн хожив?” нэртэй тус бүс нутгийн хамгийн ноцтой авлигын хэргүүдийн талаар өгүүлэх номын зохиолч Мартин Капарос “*Энэ бол асуудал хэмээн*” хэмээн мэдэгдсэн. Энгийн үед дэлхийн эрүүл мэндийн салбарын зардлын 10%-25% буюу тэрбум тэрбумаар тоологдох хөрөнгө авлигын улмаас алдагддаг хэмээн Америкийн улс орнуудын хөгжлийн банкны авлигын шинжээч Роберто де Мишелэ тэмдэглэсэн. Гэтэл байгалийн гамшгийн үед, эсхүл онцгой нөхцөл байдлын үед авлигын эрсдэл улам нэмэгддэг байна.

¹³⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.clickorlando.com/news/world/2020/05/27/spread-of-coronavirus-fuels-corruption-in-latin-america/>

Авлигын эсрэг Ерөнхийлөгч Лопез Обрадорын үйл ажиллагаа амжилтгүй байна¹³⁶

2020.06.30. Мексик. Ерөнхийлөгч Лопез Обрадор Мексикийн хамгийн том баялаг бол “тус улсын ард түмний шударга байдал” хэмээн тодорхойлж байсан ч түүнийг ажиллаж эхэлснээс хойших 18 сарын хугацаанд Мексик дэх авлигын түвшин нэмэгдсэнийг хараат бус судалгаа харууллаа.

Өнгөрсөн жил төрийн албанд нэг хүний төлсөн дундаж хахуулийн хэмжээ 2017 оныхоос 70 орчим хувиар нэмэгдсэн болохыг тус улсын статистикийн институт Inegi-ээс гаргасан судалгаа харууллаа. Өөрөөр хэлбэл, дундаж хахуулийн хэмжээ 2017 онд 2,273 песо байсан бол энэ удаагийн судалгаагаар 3,822 песо болж өссөн бөгөөд энэ хэмжээ нь Мексикчүүдийн 40 хувийн сарын цалинтай тэнцэх дүн юм.

Мөн Америкийн нийгэм/Америкийн зөвлөл байгууллагаас гаргасан Авлигатай тэмцэх чадавхын индексээр Мексик улс 10 оноо авахаас 4.55 оноо авсан нь өнгөрсөн жилийн түвшнээс 0.1 нэгжээр буурчээ.

Мексикийн удирдагч авлигын хэрэгт буруутгагдаж буй өмнөх үеийнхнийгээ яллах эсэх асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулахыг санал болгов¹³⁷

2020.09.15. Өнгөрсөн даваа гарагт Мексикийн Ерөнхийлөгч Андрес Мануэль Лопес Обрадор авлигын хэрэгт буруутгагдаж буй өмнөх ерөнхийлөгчдийг яллах эсэх асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулах хүсэлт гаргахад бэлэн байгаагаа мэдэгдэв. Тэрээр хэлэхдээ, хэрвээ олон нийтийн санал асуулга явуулах ажлыг дэмжих хангалттай гарын үсэг цуглуулж чадахгүй бол ийм санал хураалт явуулахыг Сенатаас өөрөө хүсэх болно гэжээ.

Тэрбээр “*Би санал асуулга явуулах хүсэлт гаргах баримт бичгийн төслийг боловсруулсан*” гэдгээ сэтгүүлчдэд хандан хэлсэн байна.

Мөн “*Хуулийн дагуу надад ийм эрх мэдэл байгаа тул маргааш иргэдийн гарын үсгийг цуглуулж чадахгүй бол ийм шийдвэр гаргах болно*” гэж мэдэгдэв.

Лопес Обрадорын Морена нам өмнөх ерөнхийлөгч Карлос Салинас, Эрнесто Зедилло, Висенте Фокс, Фелипе Кальдерон, Энрике Пена Нието нарыг шүүх эсэх асуудлаар санал асуулга явуулахыг шаардаж байгаа юм.

Тэдэнд ямар шийтгэл хүлээлгэх нь тодорхойгүй байгаа ч Лопес Обрадор өөрөөсөө өмнөх ерөнхийлөгчдийг авлигын хэрэгт буруутгадаг.

Пена Ниетогийн зөвлөх асан, нэг үе газрын тосны томоохон компани байсан ПЭМЭКС-ийн тэргүүн байсан Эмилио Лозоягийн дэлгэсэн авлигын баримтууд Мексикийн улс төрийн элитүүдийг гарах гарцгүй болгоод байна.

Бразилийн барилгын томоохон компани Одебрехттэй холбоотой авлигын хэргийг шүүх явцад Лозоя нь Пена Нието, Кальдерон, Салинас нарыг энэ хэрэгт холбоотой гэж мэдүүлж байв.

Ерөнхийлөгч Лопес Обрадор хэлэхдээ, хуулийн дагуу бүх нийтийн санал асуулга явуулахыг дэмжсэн 2 сая орчим иргэний гарын үсэг шаардлагатай байгаагаас 800 мянга орчим гарын үсэг цуглаад байна гэв.

Зүүн төвийн популист удирдагч Лопес 2018 онд засгийн эрхэд гарснаас хойш “Маяа галт тэрэг” төмөр замын төсөл болон Мексик хотын нисэх онгоцны буудлыг цуцлах зэрэг маргаантай асуудлаар хэд хэдэн удаа олон нийтийн санал асуулга явуулж байсан юм.

¹³⁶ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://anticorruptiondigest.com/2020/06/30/president-lopez-obradores-anti-corruption-push-is-failing/#axzz6QpcX2IJl>

¹³⁷ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://en.mercopress.com/2020/09/15/mexican-leader-proposes-referendum-whether-to-prosecute-his-predecessors-accused-of-corruption?fbclid=IwAR2qFvDq40qZiKUWaf21JZXTTKLECOUR98Uh63ExV4xdG8ehUgGfMnwLwF8>

Байдены гэр бүлийн авлигын хэргийг нуун дарагдуулсанд Трамп Америкийн хэвлэл мэдээллийн байгууллагуудыг буруутгав¹³⁸

2020.10.25. Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшигч Жозэф Байдены гэр бүлийн авлигын үйлдлийг нуун дарагдуулахыг оролдсон Вашингтоны засаг захиргааны тэргүүн Доналд Трамп хэвлэл мэдээллийн байгууллагуудыг буруутгасан байна.

Охайо мужид зохион байгуулсан сонгуулийн кампанит ажлын үеэр Трамп АНУ-ын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс орон дахь коронавирусний нөхцөл байдалд хэтэрхий их анхаарч, бусад асуудалд бага анхаарч байгаа талаар мэдэгдсэн байна.

Тэрээр сонгуулийн урьдчилсан санал хураалтын үеэр хэвлэл мэдээллээр зөвхөн КОВИД-19-ийн тухай дурдаж, америкчуудыг айлгахыг оролдсон гэжээ. Түүний энэ мэдэгдлийг Америкийн мэдээний сувгууд шууд дамжуулсан байна.

“Энэ бүгд Байдены гэр бүлийн авлигын хэргийг нуун дарагдуулах оролдлого байсан” гэж АНУ-ын Ерөнхийлөгч мэдэгдсэн байна. Түүнчлэн тэрээр New York Post сонинд Байдены хүү Хантерийн цахим шууданг нийтлэхээс татгалзсан нь “авлигыг нуун дарагдуулахад бэлэн байгааг” нотлон харуулж байна гэжээ.

Цахим шууданд Байдены хүү Хантер эцгийгээ тус улсын дэд ерөнхийлөгч байх үед Украины эрчим хүчний Burisma Holdings компанийн төлөөлөгчидтэй уулзуулсан, уг компанийн төлөөлөл Хантерээс эцгийнх нь нөлөөг хэрхэн ашиглаж болох талаар зөвлөгөө өгөхийг асуусан талаар мэдээлжээ. Трамп Байденыг хууран мэхлэгч, Украин, Хятадад авлигын хэрэгт холбоотой гэж буруутгасан байна.

Харин пүрэв гарагт Трамштай хийсэн мэтгэлцээний үеэр хүү Хантер нь гадаадын улс орны харилцаа холбоонд ёс суртахуунаас ангид зүйл байхгүй гэж Жозэф Байден мэдэгджээ.

Хантер Байден нь 2014-2019 онд Burisma компанийн удирдах зөвлөлийн гишүүн байсан бөгөөд уг компанийн үйл ажиллагааг шалгах ажлыг эхлүүлсэн Украин улсын Ерөнхий прокурор Виктор Шокиныг ажлаас нь чөлөөлөх хүсэлтийг түүний эцэг дэд ерөнхийлөгч байхдаа гаргаж байжээ. В.Шокин ажлаасаа чөлөөлөгдсөн, мөн компанийг хянан шалгах үйл ажиллагаа зогссон байна. Украины Мөрдөн шалгах улсын хороо Жозэф Байден ажилд нь саад учруулж байсан тухай В.Шокины гаргасан мэдэгдлийн дагуу 2020 оны 02 дугаар сард эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

Авлигын асуудалд холбогдоод байсан
Бразил улсын Ерөнхийлөгч асан Лулагийн
талаар шүүхээс буруугүй гэсэн шийдвэр
гаргасан нь тус улсад ямар нөхцөл байдлыг
дагуулах бол?¹³⁹

2021.03.14. Өнгөрсөн долоо хоногт Бразилийн Дээд шүүхээс авлигын аливаа хэрэгт гэм буруугүй гэж үзэн, хэргийг нь хэрэгсэхгүй болгосноор Ерөнхийлөгч асан Луис Инасио Лула да Силва 2022 онд болох Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох боломжтой болсон хэдий ч олон асуулт нээлттэй үлдэж байгааг шинжээчид онцолж байна.

Зүүний чиглэлийн Ажилчны намын тэргүүн, 75 настай Лула дараа жил болох сонгуульд оролцоно гэдгээ мэдэгдээгүй ч түүний хамтрагчид шүүхийн шийдвэрийг Лулагийн буруугүйн нотолгоо гэж үзэж байна.

Өөрт нь холбогдуулсан авлигын асуудлыг “Бразилийн 500 жилийн түүхэн дэх шүүхийн хамгийн томоохон хуурмаг зүйл” хэмээн тэрээр лхагва гарагт ард түмэнд хандан хэлсэн үгэндээ онцлов.

Гэвч шүүгчийн шийдвэр өөрчлөгдөх боломжтой ба цаашид хэрхэх нь тодорхойгүй олон асуулт байгааг хуулийн салбарын шинжээчид онцолж байна.

¹³⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://tass.ru/mezhdunarodnaya-panorama/9809683>

¹³⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2021/3/14/brazil-what-next-after-lula-corruption-convictions-annulled>

“Хэрэв сонгууль өнөөдөр болж байсан бол Лула Ерөнхийлөгчид нэр дэвшигч байж болох байв. Гэвч 2022 оны наймдугаар сард Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг бүртгэх хүртэл ямар нэгэн асуудалд яллагдахгүй байх ёстой” хэмээн Сан Паулугийн Политехникийн дээд сургуулийн сонгуулийн хууль, төрийн эрх зүйгээр мэргэшсэн хуульч Ренато Бибейро де Алмейда яриу.

Авлигын хэргүүд

Лула авлигын 4 хэрэгт буруутгагдаж байсан. Үүнээс 2 асуудлын талаарх шүүхийн шийдвэр гараагүй байгаа ба гуравдугаар сарын 08-ны өдрийн шүүх хурлаар шүүгч Эдсон Фачин өмнөх 2 шийдвэрийг гаргасан шүүх харьяаллын бус асуудлыг шийдсэн хэмээн үзжээ.

Ерөнхийлөгч асантай холбоотой хэргийг тус улсын өмнөд хэсэгт орших Куритиба хотын шүүх шийдвэрлэх чадамжгүй байсан хэмээн тэрээр мэдэгдсэн.

Лулаг барилгын компаниас Сан Паулугийн эрэг орчимд байр авсан гэх авлигын болон мөнгө угаасан хэргийг шүүх 2017 оны долдугаар сард шийдвэрлэсэн юм. Тэрээр 580 хоног хоригдсон ба түүнийг 2019 онд давж заалдах шатны шүүхийн шийдвэрээр сулласан юм.

Мөн түүнийг Бразил улсыг тухайн үед доргиосон, олон улс төрч, бизнесийн хүрээнийхэн хамрагдсан “Машин угаалга” хэмээн нэрлэгдсэн авлигын хэрэгт буруутгасан. Тухайн үед авлигын хэргийг шалгах ажиллагааны төвд Куритиба хот байсан юм.

Гэтэл өмгөөлөгчдийн олон жил ярьсан, тус хэрэг гарах үед Лула Ерөнхийлөгчөөр ажиллаж, Бразилдаа оршин сууж байсан нь түүнийг Петробрасын хэрэгт, өөрөөр хэлбэл, “Машин угаалга”-ын хэрэгт холбогдолгүй гэсэн аргументийг шүүгч Фачин хүлээн зөвшөөрсөн юм. Иймд хэргийг Бразилийн Холбооны шүүхэд шилжүүлж, дахин авж хэлэлцэх хэрэгтэй гэсэн юм.

Гэвч шүүгч Фачины шийдвэрийг эсэргүүцэн, 03 дугаар сарын 13-нд прокуророос Дээд шүүхэд гомдол гаргасны дагуу шийдвэрийг хүлээж байна. Дээд шүүхийн шүүгч Фачины шийдвэр өөрчлөгдөхгүй л болов уу хэмээн Рио де Жанейрогийн хуулийн Брада энд Фернандес хуулийн фирмийн эрүүгийн эрх зүйч, эрүүгийн хэрэг шийдвэрлэх эрх зүйгээр мэргэшсэн Бруно Фернандес мэдэгдэв.

Сонгууль болох хугацаа дөхсөн болон Бразилийн шүүхийн ачаалал зэрэг нөхцөл байдлаас үзэхэд 1.6 жилийн хугацаанд хэргийг шийдвэрлэж чадна гэдэгт цөөхөн хүн итгэж байна.

Гэтэл Бразилийн сонгуулиар мэргэшсэн, сонгууль, улс төрийн хуулийн академийн гишүүн Марильда Сильвейра Лулаг дахин хэрэгт холбогдуулах боломжтой ба үүнтэй холбоотойгоор Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох боломжгүй гэдгийг онцлов.

“Нөхцөл байдлыг өөрчлөх олон хүчин зүйл бий. Сонгуулийн тухай хууль өөрчлөгдөх, Дээд шүүхийн байр суурь өөрчлөгдөх, Ерөнхийлөгчийг батламжлах хугацаа өөрчлөгдөх боломжтой. Тэгэхдээ зарим зүйлд маш их хугацаа шаардлагатай” хэмээн тэрээр Ал Жазирад ярьсан байна.

Давтан шүүх хурал цагтаа эхэлсэн ч Лулагийн хэргийг шүүж байсан холбооны шүүгч Сержио Моро хараат бусаар асуудлыг шийдвэрлээгүй гэх нотлох баримт цуглуулах, Лулаг буруутгасан асуудлыг эргүүлэн татах асуудлаар шүүхэд хүсэлт гаргах зэрэгт цаг хугацаа хэрэгтэй болох аж.

Шүүгч Моро нь прокуроруудыг идэвхтэй удирдаж байсан гэсэн мэдээллийг 2019 онд Интресепт (The Intercept) гарсан. Моро 2018 оны сонгуульд нэр дэвших эрхгүй гэсэн шийдвэр гарсны хэдхэн сарын дараа буюу 2019 оны нэгдүгээр сараас барууны чиг баримжаатай Жайр Болсонаро Ерөнхийлөгчийн засгийн газарт Хууль зүйн сайдын албыг хашиж байсан нь хэргийг шийдвэрлэх явц улс төрийн шалтгаантай байсан гэсэн асуудлыг дагуулдаг.

Бразилийн хуулиар хэргийн холбогдогчид шүүх ажиллагаанд нөлөөлөхөөс урьдчилан сэргийлж, шүүгчийг санамсаргүй байдлаар томилдог. Тэгэхдээ хэргүүд хоорондоо холбоотой нөхцөлд тус журмыг баримтлахгүй байж болно.

Анхлан прокурорууд Лула болон Петробрасд холбогсдын хооронд ямар нэгэн харилцаа байхгүй тул Куритибад шүүх ажиллагааг явуулах ёстой хэмээн онцолж байсан. Гэвч ил гарсан мэдээллээр прокурорууд хүртэл энэ хоёрын хоорондох харилцаа эргэлзээтэй гэдгийг хүлээн зөвшөөрч буй юм.

“Лулагийн өмгөөлөгчид шүүхийн харьяаллын асуудлыг 5 жилийн турш хөндөж тавьсан, шүүхийн өмнө ижил тэгш байх Лулагийн эрхийг хязгаарласан явдал болсон” хэмээн Фернандес нэмж ярьжээ.

Лулагийн шүүх хурлыг шүүсэн шүүгч Морог шүүхэд татах, шүүх хуралд оролцохдоо хараат бусаар шийдвэрлэсэн эсэх талаарх санал хураалтад Дээд шүүхийн шүүгч Гилмар Мендес асуудлыг шүүхэд шилжүүлэх нь зөв гэдэгт санал өгсөн.

Хэрэв Морог буруутайд тооцох нөхцөлд түүний цуглуулсан бүх нотлох баримтыг хэрэгсэхгүй ба дараа жилийн сонгуулиас өмнө Лулагийн хэргийг бүрэн эргэн харах хугацаа хангалтгүй юм.

Тэрээр хэвлэлүүдээр гарч буй мэдээлэл уран зөгнөлт таамаг хэмээн, өөрийн бурууг хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм. Нөгөө талаас Интресептийн сурвалжлагч Глен Грийнвалдыг шүүхэд өгнө хэмээн Болсонаро мэдэгдсэн байна.

Морогийн үйл ажиллагаа маш ёс зүйгүй хэмээн Сан Паулу их сургуулийн Ёс зүй, философийн профессор Ренато Жанин Рибейро мэдэгдсэн байна. Мөн 2018 оны сонгуульд ялж чадахгүй байх ганц хүнийг тус асуудалд оруулан, Болсонарогийн засгийн газарт сайдын албан тушаал хаших болсон зэрэг нь ёс суртахууны дутагдалтайг нь харуулж байна хэмээн тэрээр яриу.

Гэвч шүүгч Фачины шийдвэрийн хугацаа, үндэслэлд эргэлзэж байгаагаа шинжээчид илэрхийлж байна. Нөгөө талаас, шүүгч Фачиныг Лулагийн улс төрийн намтай холбоотой хэмээн Болсонаро мэдэгдсэн байна.

Лула да Силва дахин Ерөнхийлөгч болж чадах болов уу?¹⁴⁰

2021.03.25. Лула да Силваг авлигын хэрэгт ялласан шүүгчийг Дээд шүүхээс хэт “нэг талыг барьж” шийдвэр гаргасан хэмээн үзсэн байна.

Лула да Силва бол Бразилийн хамгийн нэр хүндтэй хүмүүсийн нэг юм. Түүнд 2017 онд тус улсын шүүхээс авлигын гэмт хэрэгт холбогдуулан ял оноосон нь олон нийтийг хоёр талд хуваагдан зөрчилдөхөд хүргэжээ.

Дэмжигчид нь зүүний удирдагч Лулаг улс төрийн хэлмэгдүүлэлтийн золиос болсон хэмээдэг бол Ерөнхийлөгч асны хувьд өөрийг нь 2018 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас холдуулахын тулд хэрэглэсэн башир арга гэж үзэж буй ажээ. Энэхүү сонгуулиар хэт барууны үзэлтэй Жаир Болсонаро ялалт байгуулсан билээ.

Одоогийн байдлаар Бразилийн дээд шүүхээс ерөнхийлөгч Лулад холбогдох авлигын хэргийг шийдвэрлэсэн шүүгч хэт нэг талыг барьсан байр сууринаас хандсан хэмээн үзэж мөрдөн шалгах ажиллагааны үед цуглуулсан нотлох баримтуудыг ирээдүйд болох аливаа нэгэн шүүх ажиллагаанд ашиглахгүй хэмээн шийдвэрлэжээ.

Дээд шүүхийн энэхүү шийдвэрийн дараа Ерөнхийлөгч асан Лулад оноосон ялыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгох тухай Дээд шүүхийн бас нэг шийдвэр энэ сарын эхээр гарсан байна. Нэг үгээр бол тус улсын шүүхээс улс төрийн амбицаа хэрэгжүүлэх боломжийг улсын тэргүүн асандаа нээж өгсөн явдал байлаа.

Түүнийг 2022 онд болох Бразилийн Ерөнхийлөгчийн сонгуульд одоогийн Ерөнхийлөгч Болсонаротой өрсөлдөх хэмжээний хүчтэй байр суурьтай хэвээр буй гэж олон хүн үзэж байгаа аж.

Гэхдээ Ерөнхийлөгч асан Лула да Силва бразилчуудын дэмжлэгийг дахин авж, сонгуульд ялалт байгуулж чадах болов уу?

¹⁴⁰ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/program/inside-story/2021/3/25/can-lula-da-silva-be-president-of-brazil-again>

Эл Сальвадорын Ерөнхийлөгч “засгийн эрхийг дангаар авах төрийн эргэлт” хийв. Бий болж буй авлига, дарангуйллыг ажиглая¹⁴¹

2021.05.20. Manuel Meléndez-Sánchez, Steven Levitsky. Эл Сальвадорын 39 настай Ерөнхийлөгч Найиб Букеле 05 дугаар сарын 01-нд Конгресс дахь дийлэнх олонх байдлаа ашиглан тус улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч болон Ерөнхий прокурорыг ажлаас нь халж, маргааш нь үнэнч хүмүүсээрээ солив. Ингэснээр нэг удаагийн үйлдлээр Букеле Эл Сальвадор улсын төрийн гурван эрх мэдлийг бараг л бүхэлд нь олж авав.

Энэ бол сонгодог *autogolpe*¹⁴² буюу ардчилсан замаар сонгогдсон Ерөнхийлөгч төрийн бусад эрх мэдэлд халдан, тараах, эсхүл устгах үйл ажиллагаа буюу “засгийн эрхийг дангаар авах төрийн эргэлт” хийсэн ажиллагаа болов.

Эл Сальвадорыг цаашид ямар ирээдүй хүлээж байна вэ? Алберто Фухиморигийн 1992 онд амжилттай хэрэгжүүлсэн төрийн эргэлт буюу Перу улсын түүх нэгийг сануулж байна.

Фухимори Перу улсын хяналт, тэнцвэрийг хэрхэн унагав

Авлигад идэгдсэн, үр ашиггүй улс төрийн ноёрхол хэмээн сонгогчдын үзэж байсан нөхцөл байдлыг устгахаа амлаж, 1990 онд Перу улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Алберто Фухимори ялсан.

Улмаар 1992 оны 04 дүгээр сарын 05-нд Фухимори Үндсэн хуулийг хүчингүй болгож, сөрөг хүчин давамгайлсан Конгрессоо тарааж, шүүх эрх мэдлийг “дахин байгуулсан”. Үр дүнд нь зарим улс төр судлаачдын хэлдгээр “хэвтээ хариуцлагын тогтолцоо” буюу Үндсэн хууль бүхий хяналтын тэнцвэртэй байдал тэр даруй үгүй болсон юм.

Фухимори болон түүний талыг баримтлагчид 1993 онд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, түүнийг дахин сонгогдож болохуйцаар шинэчилсэн. Тэрээр 1995 онд “шударга бус” байдлаар дахин сонгогдсон. Түүнийг дэмжигчид мөн Конгресст хяналт тогтоосноор Фухимори өөрсдийн хүнээр Дээд шүүх болон сонгуулийн байгууллагыг дүүргэх боломж олгосон юм. Улмаар Фухимори дангаараа засагласан.

Перучуудын ихэнх нь түүнийг дэмжиж байсан тул зарим талаараа Фухимори амжилтад хүрсэн. Тэрээр гиперинфляцид идэгдсэн, “Маоист” үймээн самуунтай улсыг уламжилж авсан юм.

Тухайн цаг үеийн нөхцөл байдалд туйлдсан ихэнх перучууд түүний үйл ажиллагааг шинэ эхлэл гэж хүлээн авсан. Үнэхээр төрийн эргэлт хийсний дараа Фухиморигийн нэр хүнд 80% хүртэл өссөн байв. Тус улсын гиперинфляцийг эцэс болгож, Shining Path гэх партизануудыг ялсан нь түүний амжилтыг улам бататгасан.

Түүнчлэн Фухимори олон улсын түвшинд ч дэмжлэг авж байв. Хэдийгээр АНУ болон АУБ анхандаа төрийн эргэлтийг буруутгаж байсан ч АНУ-ын албан тушаалтнууд Фухиморигийн эдийн засгийн шинэчлэл болон хар тамхины эсрэг дайны хамтын ажиллагааг нь үнэлсэнтэй холбоотойгоор олон улсын шахалт намжиж, АНУ болон АУБ Перугийн ардчиллыг хамгаалах хөшүүргээ ашиглахгүй байхаар шийдсэн юм.

Хариуцлагыг устгасны төлөөс

Перуг илүү дутуугүй ардчилсан улс болгож байна хэмээн Фухимори мэдэгдэж байв. Хариуд нь сонгогчид түүнийг дахин дахин сонгож байлаа. Энэ байдал нь дотоодын болон олон улсын ардчилсан ёс шаардагчдыг алмайруулж байв.

Гэвч ардчилал гэдэг нь сонгуулиас гадна олон зүйлийг шаарддаг. Ардчилалд сонгуулийн өрсөлдөөн шударга байх ёстой. Засгийн эрхийг дэмжигчид болон шүүмжлэгчид өөрсдийн үзэл бодлыг тархаах, зохион байгуулах боломжтой байх ёстой, өөрөөр хэлбэл, иргэний эрх чөлөө

¹⁴¹ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.washingtonpost.com/politics/2021/05/20/el-salvadors-president-launched-self-coup-watch-creeping-corruption-authoritarianism/>

¹⁴² *Autogolpe* - испани гаралтай үг. 1946-2020 онд 148 удаа төрийн эргэлт хийх оролдлого гарснаас 110 нь автократ засаглалтай улсад болсон бол 38 нь ардчилсан засаглалтай улсад тохиолджээ.

хамгаалагдсан байх ёстой юм. Шударга сонгууль болон иргэний эрхийг хангахын тулд шүүх, сонгуулийн байгууллага нь бие даасан, хараат бус байх ёстой.

Хэдийгээр “ардчиллын төлөө” гэсэн нэр хүндтэй ч гэсэн Ерөнхийлөгч энэхүү гүйцэтгэх засаглалын хяналтын тогтолцоо алдагдах нөхцөлд ардчилал аюулд орж буй юм. Хэвтээ хариуцлагын тогтолцоо байхгүй бол удирдагчид эрх мэдлээ урвуулан ашигладаг. Үр дүнд нь илэрхий авлига, автократ засаглал бий болдог.

Энэ бол Перу улсад тохиолдсон явдал. Тус улсын эдийн засаг болон аюулгүй байдлын хямралыг шийдвэрлэхийн тулд Фухиморид хяналтгүй эрх мэдэл хэрэгтэй хэмээн түүний дэмжигчид үзэж байсан юм. Хэдий тийм ч, хэмжээ хязгааргүй эрх мэдэл эдийн засгийг өсгөх, эсхүл авлигын эсрэг тэмцэхэд ардчилсан засаглалаас амжилттай байдаг гэх нотолгоо бага байдаг. Харин гэмт хэрэг, инфляцын түвшинтэй сайн тэмцдэг гэдгийг нотолдоггүй ч мөн үгүйсгэдэггүй.

Хяналтгүй байдал дээр дөрөөлөн, Фухимори болон түүний тагнуулын зөвлөх Владимиромонтесинос нар төрийн тогтолцооны зэрэгцээ мафи улсыг байгуулсан юм. Монтесинос нь Дээд шүүхийн шүүгч, төрийн албан хаагч, хууль тогтоогч, армийн албан хаагч, бизнес эрхлэгч, хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид, сөрөг хүчний удирдагчид зэрэг, Фухимориг эсэргүүцэж болзошгүй этгээдүүдийг тагнах, хахуульдах, айлган сүрдүүлэх үйл ажиллагаандаа Үндэсний тагнуулын газрыг ашигласан. Улмаар төрийн байгууллагуудаас хамгийн багадаа 164 сая ам.доллартой тэнцэх хөрөнгийг Фухиморигийн сонгуулийн кампанит ажилд шилжүүлсэн. Фухиморигийн засгийн газар нийтдээ 600 сая ам.долларыг шамшигдуулсан бөгөөд дэлхийн “бүх цаг үеийн хамгийн авлигач засгийн газар”-ын нэг гэж Форбес сэтгүүлээс нэрлэж байв.

Перугийн засгийн газар 1996-2001 оны хооронд уугуул нутгийн эмэгтэйчүүдийн хүүхэдтэй болох боломжийг хүчээр хааж байв. Яагаад?

Хяналт, хариуцлага үгүй болсноор үлэмж хэмжээний автократ тогтолцоо бий болсон юм. 1996 онд Фухиморигийн Конгресс шинэ Үндсэн хуулийн “жинхэнэ тайлбар” гэгчийг баталж, хууль бусаар гурав дахь удаагаа нэр дэвших боломжийг түүнд олгов. Үндсэн хуулийн шүүхийн гурван гишүүн уг хуулийг Үндсэн хуулийн бус гэж үзэх үед Конгресс тэднийг албан тушаалаас нь халсан юм. Энэхүү үйл явц 2000 онд Фухимори хууль бусаар дахин сонгогдох замыг зассан. Энэ үеэс Фухимори олон нийтийн дэмжлэгийг алдаж эхлэв. Гэвч түүний тагнуулын байгууллага сөрөг хүчний нэр дэвшигчид болон төрөөс санхүүжих ихэнх хэвлэл мэдээллийн байгууллагыг дарамталж байсан тул дэмжлэгээ алдах нь тийм ч чухал биш байв. Түүний өрсөлдөгчдөд ямар ч боломж байгаагүй юм.

Нэг үгээр хэлбэл, энэ үйл явц нь “ардчилал хэрхэн устахыг харуулсан” том сургамж байв.

Эл Сальвадорын Ерөнхийлөгч Букеле Фухиморигийн араас замнаж байна уу?

Фухимори болон Букеле нарыг харьцуулахад ер бусын адил. Хоёул популист, улс төрийн институцээ цэвэрлэхээр сонгогдон гарч ирсэн. Букеле Фухимори шиг сонгуулиар олж авсан эрх мэдлээ өөрөө төрийн эргэлт хийхэд ашигласан. Энэ хоёр төрийн эргэлт нь Перугийн хувьд гиперинфляци болон бослого хөдөлгөөн, Эл Сальвадор дахь цар тахал, гэмт хэрэг хяналтгүй болсон хүнд нөхцөл байдалд явагдсан.

Улмаар, Эл Сальвадор дахь нөхцөл байдлаас харахад Букеле ирэх хэдэн сар, хэдэн жилийн хугацаанд Фухиморигийн замналыг амархан дагаж болохоор байна.

Нэгдүгээрт, Букеле Фухимори шиг алдартай. Санал асуулгын дүнгээр Букеле 90 гаруй хувийн дэмжлэг авж байгаа. 2019 онд сонгогдохдоо 53 орчим хувийн саналаар гарч ирж байсан бөгөөд түүний нам хоёрдугаар сард болсон хууль тогтоох байгууллагын сонгуулиар нийт саналын гуравны хоёроос дээш саналыг авсан.

Фухиморигийн нэгэн адил энэ их алдар хүндийн ачаар Букеле сонгууль, бүх нийтийн санал асуулгыг ашиглан эрх мэдлийг нэгтгэх, өөрийн авторитар хандлагыг зөвтгөхөд ашиглах боломжтой болсон. Хэрэв тэр Үндсэн хуулиар бүх нийтийн санал асуулга явуулах, эсхүл хоёр дахь удаагаа нэр дэвшсэн нөхцөлд Букеле ялах нь тодорхой юм.

Хоёрдугаарт, Эл Сальвадорын нөхцөл байдал Фухимори маягийн авлигын сүлжээ бий болгох нөхцөл бүрэн бүрдсэн. Шинэ байгуулагдсан Конгресс хамгийн багадаа 730 сая ам.долларын олон улсын зээл авахыг Букелед зөвшөөрч, КОВИД-19-д зарцуулах хөрөнгийн хяналтыг хязгаарласан

хууль тогтоомж баталсан. Мөн энэ оны эхээр өмнө нь орон нутгийн хөгжлийн сангуудын шууд орон нутгийн удирдлагад очдог байсан хөрөнгийг төвлөрүүлнэ гэдгээ Букеле мэдэгдсэн. Хариуцлага, хяналт, институцууд ихээхэн хэмжээгээр сулрах нь Букелед асар их мөнгийг хяналтгүй зарцуулах эрхийг олгож байна.

Эцэст нь, Перу улсад ардчиллыг хамгаалах явдалд олон улсын хамтын нийгэмлэг төдийлөн оролцоогүй. Олон улсын түвшинд “санаа зовж” байгаагаа илэрхийлж байгаа ч, Букелегийн эрх мэдлийг сааруулах алхам хийхгүй байна. Бушийн засаг захиргаа Перугийн ардчиллаас илүүтэйгээр хар тамхины эсрэг тэмцлийг чухалчилж байсантай адил Байдены засаг захиргаа Эл Сальвадорын тогтолцооны асуудлаас цагаачлалын бодлогоо илүүд үзэж байна.

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Төв Америкийн албан тушаалтнуудыг АНУ хар жагсаалтад оруулав¹⁴³

2021.07.02. Авлигын гэмт хэрэг үйлдсэн, шударга ёсыг зөрчсөн, ардчиллыг дордуулсан асуудлаар АНУ-ын засгийн газраас буруутгаж байгаа албан тушаалтнуудын нэрсийг пүрэв гарагт Төрийн департаментас гаргасан бөгөөд уг жагсаалтад төв америкийн ерөнхийлөгчийн туслахууд, тэргүүн шүүгчид, экс ерөнхийлөгч ороод байна.

Тухайн үеийн АНУ-ын конгрессын төлөөлөгч Элиот Энгелийн дэмжлэгтэйгээр 12 дугаар сард Конгрессоос батлагдсан хуулийн дагуу “Энгелийн жагсаалт” гэж нэрлэгдэх энэхүү жагсаалтыг гаргасан байна. Уг хуулиар Эл Сальвадор, Гондурас, Гватемал (Хойд гурвалжин) дахь авлигач өндөр түвшний албан тушаалтнуудын жагсаалтыг Төрийн департаментас 180 хоногийн дотор гаргахаар болсон юм.

Уг жагсаалтад орсон этгээдүүдэд АНУ-аас олгосон визийг цуцлах бөгөөд АНУ-д нэвтрэх боломжгүй болно гэж Төрийн департаментас мэдээлсэн юм.

Ерөнхийлөгч Найб Букелегийн Хөдөлмөрийн сайд Роландо Кастро, засгийн газрын танхимын дарга Каролина Рекинос болон Хууль зүй, аюулгүй байдлын сайд асан Рожелио Ривас зэрэг Эл Сальвадорын одоогийн болон хуучин өндөр албан тушаал хашиж байсан 7 албан тушаалтан уг жагсаалтад орсон байна.

Түүнчлэн Гондурасын арав гаруй хууль тогтоогч, Гватемалын тэргүүн зэргийн хоёр шүүгч жагсаалтад орсон бөгөөд тэдний дунд саяхан томилогдсон Үндсэн хуулийн цэцийн шүүгч Нестер Васкес багтаж байна.

Гватемал, Гондурас, Эл Сальвадор дахь АНУ-ын тусгай элч Рикардо Зунига сэтгүүлчдэд хэлэхдээ бүс нутаг дахь авлигатай тэмцэх нь АНУ, Мексик рүү чиглэсэн шилжих хөдөлгөөнийг бууруулахад туслах болно гэжээ.

Жагсаалтад орсон 55 этгээдийг санаатайгаар авлигын хэрэг үйлдсэн, авлигын мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулсан, ардчилсан үйл явц, тогтолцоог дордуулсан зэрэг шалтгаанаар гаргасан хэмээн АНУ-ын засгийн газраас мэдэгдсэн юм.

Үйл явдалтай холбоотойгоор Ройтерс агентлаг тайлбар хүссэн боловч Эл Сальвадор, Гондурас, Гватемалийн засгийн газрууд хариу өгөөгүй байна.

Африк тив

Ангол дахь авлигатай тэмцэх, эдийн засгийн харилцааг бэхжүүлэхээ Помпео илэрхийлэв¹⁴⁴

¹⁴³ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.reuters.com/world/americas/central-american-aides-judges-former-presidents-us-corruption-list-2021-07-01/>

¹⁴⁴ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: https://www.voanews.com/a/africa_pompeo-stresses-economic-ties-fight-against-corruption-angola/6184365.html



Анголын Ерөнхийлөгч Жоао Лоуренко АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майк Помпеотой 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр Луанда дахь Ерөнхийлөгчийн ордонд уулзав. (Фото: Reuters)

2020.02.17. АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Майк Помпео даваа гарагт Анголын Ерөнхийлөгч Жоао Лоуренко (Joao Lourenco)-той уулзаж, эдийн засгийн харилцааг бэхжүүлэх, авлигатай тэмцэхэд анголчуудыг дэмжихээ илэрхийлэв.

Тус улсыг 40 орчим жил удирдсан Ерөнхийлөгч Хосе Эдуардо дос Сантос (José Eduardo dos Santos) албан тушаалаа өгсний дараа буюу 2017 онд Лоуренко тус улсын Ерөнхийлөгч болсон юм.

Одоогоор Ангол улсад өмнөх Ерөнхийлөгчийн охин буюу Африкийн хамгийн баян эмэгтэйд тооцогдож байгаа Исабел дос Сантос (Isabel dos Santos)-ыг

санхүүгийн томоохон гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгаж байгаа билээ.

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Помпео Сенегал, Америкийн компаниудын хооронд хувийн хэвшлийн түншлэлийн харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээнд оролцсоныхоо дараа, ням гаргийн үдээс хойш Сенегалаас Анголд хүүлцэн ирсэн юм.

Помпео болон Сенегалын Гадаад хэргийн сайд Амадоу Ба (Amadou Ba) нар Баруун Африкт терроризм өсөн нэмэгдэж байгаа явдалд санаа зовниж буйгаа илэрхийлсэн байна.

Помпео Анголын Ерөнхийлөгчтэй уулзсаныхаа дараа, хөтөлбөрийн дагуу Этиоп, Саудын Араб, Оман улсаар айлчлах юм.

Өмнөд Африк дахь усны хомсдолыг авлига улам нэмэгдүүлж байна¹⁴⁵

2020.03.17. 2017 оны ган гачгийн үеэр ӨАБНУ-ын хамгийн том хот - Кэйп Таун усгүй болох шахсан юм.

Авлигын харуул (Corruption Watch) болон Усны шударга сүлжээ байгууллага (Water Integrity Network)-аас өнгөрсөн 7 хоногийн сүүлээр хамтран гаргасан тайланд ган гачиг нь усны хомсдолын цор ганц шалтгаан биш бөгөөд усны хомсдол үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл нь авлига болж байгааг дурджээ.

Мөн нийтэд зориулагдсан мөнгөнөөс хувьдаа завшиж буй авлига нь үйлчилгээний нөөц болон чанарыг бууруулахад шууд нөлөөлж байгааг дээрх тайланд дурдсан байна.

Ямар нэг тендер зарлахгүйгээр гэрээ байгуулж болдог бөгөөд хахууль авсан албан тушаалтнууд үүнийгээ ихэвчлэн “онцгой байдлын стратеги” гэх ба тэдний улс төрийн санхүүжилтийг бүрдүүлдэг нөлөө бүхий, том компаниудад гэрээ хэлэлцээрийг өөрсдийн дураар хуваарилдаг талаар мөн нэмж дурджээ.



85 жилийн түүхтэй Кланвильямын далангийн сэргээн засварлах ажил авлигын улмаас олон жил хойшлогджээ. (Фото: Needpix)

¹⁴⁵ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.ocrp.org/en/daily/11832-report-corruption-fuels-water-shortage-in-south-africa>

Төрийн аудитаас олж тогтоосноор, Ус сувгийн удирдах газар (Water and Sanitation Department) зөвхөн 2018 онд 384 сая ам.долларыг хууль бусаар зарцуулсан байна.

Жишээлбэл, Йоханнесбургийн хойд зүгт байрлах Мотутлунг (Mothutlung)-д зөвхөн усны насос эвдэрсэн үед яаралтай арга хэмжээ авж, солих шаардлагатай байдаг. Гэвч орон нутгийн усны компани холбогдох албан хаагчдад хахууль өгч, солих шаардлагагүй насосыг сольсонд нутгийн оршин суугчид хүчтэй эсэргүүцэн, бослого гаргаж, тус мөргөлдөөнд 3 хүн амиа алдсан юм.

Эрх баригчдын олж тогтоосноор Лимпопо (Limpopo) мужид хотын албан хаагчид ган гачгийн үеэр хотын захиргаанд усны савыг түрээслэх, мөн иргэдэд 1 литр усыг 0,06 ам.доллаароор зарах зорилгоор усны савуудыг худалдаж авсан байв.

2009 оны хүнд ган гачиг нь Гияани (Giyani)-гийн 250,000 орчим хүн амыг усаар хангах ус дамжуулах хоолойг засгийн газар яаралтай байгуулахад хүргэсэн байна.

Хэдийгээр их хэмжээний мөнгө зарцуулсан ч олон тооны газар усгүй хэвээр байгаа юм. Тендер шалгаруулалтгүйгээр гэрээ байгуулсан нь хууль бусаар 132 сая ам.доллар зарцуулах үндэслэл болсныг мөрдлөгийн үеэр илрүүлсэн.

Хиймэл усан сангаас хулгайлагдсан усны хар зах бий болоод байгаа Нелсон Мандала Бэй (Nelson Mandela Bay)-д усны хомсдол үүсэх нөхцөл байдал нь ноцтой түвшинд хүрээд байгаа талаар Авлигын цаг байгууллагын дарга уламжилсан юм.

Мөн тайланд “авлигын улмаас” цөөн тооны хүмүүс баталгаат усан хангамжтай байхад маш олон иргэд, тэр дундаа бага насны хүүхдүүд, өндөр настан зэрэг дархлаа суларсан иргэд баталгаат бус ус ууснаар өвдөж байгаа талаар дурджээ.

Эцэст нь, “Өмнөд Африкийн усны салбарын авлига үхэлд хүргэж байна” хэмээн тайланд дүгнэсэн байна.

Өмнөд Дарфур дахь авлигын эсрэг суулт 12 дахь өдрөө үргэлжилж байна¹⁴⁶

2020.04.12. Суданы Өмнөд Дарфур мужийн Эл Радум суурин дахь Эсэргүүцлийн хорооноос зохион байгуулж буй суулт 12 дахь өдрөө үргэлжилж байна.

Баасан гарагт эсэргүүцлийн хорооны гишүүн Мунир Карам (Munir Karama) Дабанга радиогоор хэлэхдээ, суулт 03 дугаар сарын 31-ний өдрөөс хойш орон нутгийн захиргааны байгууллагын байранд үргэлжилж байна гэв.

Орон нутгийн захиргаанаас суурингийн удирдагч болон албан тушаалтнуудыг ажлаас нь түдгэлзүүлсэн ч тэднийг орлох хүнийг хараахан томилоогүй байгааг тэрээр тайлбарласан юм.

Карам хэлэхдээ, эсэргүүцэгчид өөрсдийн шаардлагыг биелэх хүртэл жагсаалаа үргэлжлүүлэхээр шийдсэн бөгөөд суурингийн удирдагч болон нутгийн захиргааны байгууллага дахь түүний хамтрагчдыг зайлуулах, тус нутагт үйл ажиллагаа явуулж байгаа алт олборлолтын компанийн үйл ажиллагааг шалгах, орлогынхоо тодорхой хэсгийг орон нутгийн иргэдэд хуваарилж өгөх, тухайн нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн сөрөг нөлөөлөлд анхаарлаа хандуулахыг эрх баригчдаас шаардаж байна гэжээ.

Шуурхай туслах хүчний¹⁴⁷ Ерөнхий командлагч бөгөөд Суданы Бүрэн эрхэт зөвлөлийн¹⁴⁸ орлогч дарга Мохамед Хамдан нь АНЭУ-д төвтэй Эл Жунайд компанид хувь эзэмшдэг. Тус компани нь Нуба уулын бүс нутагт болон Хойд Дарфур дахь Жебел Амер алтны уурхайд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна.

¹⁴⁶ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.dabangasudan.org/en/all-news/article/south-darfur-anti-corruption-sit-in-into-12th-day>

¹⁴⁷ Суданы засгийн газрын удирдлага дор үйл ажиллагаагаа явуулдаг хагас цэрэгжсэн байгууллага

¹⁴⁸ Судан улсын шилжилтийн үед улс орныг удирдах эрх бүхий 11 гишүүнтэй зөвлөл

Санхүүжилтийн маргааны улмаас Ливийн
засгийн газар авлигатай тэмцэх
байгууллагын албан тушаалтныг
хулгайлав¹⁴⁹

2020.05.05. Ливийн авлигатай тэмцэх гол байгууллага болох Аудитын товчооны Захиргааны асуудал хариуцсан захирал Реда Гергабыг тус улсын Дотоод хэргийн сайдтай холбоотой зэвсэгт бүлэглэл хулгайлан авж явсан байна. Аудитын товчоо бол удирдлага нь парламентаас томилогддог, бие даасан байгууллага бөгөөд газрын тосны асар их нөөцтэй энэ улсын санхүү, хөрөнгө мөнгөний зарцуулалтад хяналт тавьдаг цөөн тооны субъектийн нэг юм.

Аудитын товчоо “ард иргэдийн зүгээс хуулийг хэрэгжүүлэх чиг үүргийг итгэмжлэн хүлээлгэсэн байгууллага өөрөө хууль зөрчиж байгаа нь харамсалтай хэрэг юм” гэж мэдэгдэж байна. Тус байгууллагын зүгээс Гергабыг хулгайлсан нь түүнийг Дотоод хэргийн сайдын санхүүгийн хууль бус ажиллагааг илрүүлж, их хэмжээний сэжигтэй гүйлгээг нь таслан зогсоох оролдлого хийсэнтэй холбоотой гэж үзэж байна.

Нийслэл Триполид төвлөрч байгаа Ливийн засгийн газар хэдийгээр НҮБ-ын дэмжлэгтэйгээр байгуулагдаж, барууны орнуудад хүлээн зөвшөөрөгдсөн ч Дотоод хэргийн яам зэрэг олон тооны харьяа байгууллагууд нь зэвсэгт бүлэглэлүүдийн гишүүдээр дүүрсэн бөгөөд үнэндээ тэдний хяналтад үйл ажиллагаагаа явуулдаг.

Зимбабвэ улсын дэд ерөнхийлөгч Эрүүл
мэндийн сайдын албан тушаалыг хаших
болов¹⁵⁰

2020.08.05. Коронавирусний халдварыг илрүүлэх тестийн худалдан авалттай холбоотой авлигын асуудалд буруутгагдсан Эрүүл мэндийн сайд асан Обадиа Моёо (Obadiah Moyo) албан тушаалаасаа огцорсноос хойш сарын дараа тус улсын дэд ерөнхийлөгч Константино Чивенга (Constantino Chiwenga) Эрүүл мэндийн сайдын албыг орлон гүйцэтгэх болов.

Коронавирусний халдварыг илрүүлэх 20 сая ам.долларын тестийн хууль бус тендерт холбогдсон Моёог саатуулаад байсан боловч шүүх хурал хүртэл батлан даалтад гаргаад байгаа юм. Дэлхий дахинд цар тахал гарч шинэ сорилттой тулгарч буй энэ үед үндэсний эрүүл мэндийн салбарыг тогтворжуулах, бүтцийн өөрчлөлт хийх, шинэчлэх зайлшгүй шаардлага тулгараад байна хэмээн тус улсын Ерөнхийлөгч Эммерсон Мнангагва (Emmerson Mnangagwa)-гийн ажлын албаны мэдэгдэлд дурдсан байна. Гол сөрөг хүчин болох Ардчиллын төлөөх хөдөлгөөн энэхүү томилгоонд шүүмжлэлттэй хандаж, тус улсад цар тахал дэлгэрсэн нөхцөл байдалд Чивенга энэ албан тушаалд тохиромжгүй гэж үзсэн.

Зимбабвэ улсын эрүүл мэндийн систем орхигдоод олон жил болж байгаа ба коронавирусний халдварын 4,000 гаруй тохиолдлыг бүртгэж, 80 орчим хүний амь нас эндсэн гэж байгаа боловч шинжилгээний тест хүрэлцэхгүй байгаагийн улмаас энэ тоо баримт бодит байдалтай нийцэхгүй байгаа аж. Сая орчим тохиолдолд хүрээд буй Африк тив дэх цар тахлын дэгдэлт дээд түвшиндээ хүрээгүй байгаа тул тус улсад өвчлөгсдийн тоо цаашид өсөх хандлагатайг эрүүл мэндийн шинжээчид онцолж байна. Өмнөх сайд албан тушаалаасаа огцорсны улмаас төрийн ихэнх эмнэлгүүдэд бүтцийн өөрчлөлт хийгдэж, удирдлага томилогдож хараахан амжаагүй байгаа юм. Хувийн хамгаалалтын хэрэгсэл, коронавирусний халдварыг илрүүлэх тест авахаар Саудын Арабын компанитай хийсэн гэрээнд албан тушаалын байдлаа урвуулан ашигласан хэргээр Моёог албан тушаалаас нь огцруулсан юм. Эмнэлгийн хэрэгслүүдийг хэт өндөр үнээр худалдан авсан асуудлыг сөрөг хүчнийхэн буруутгасан тул засгийн газар гэрээ, хэлцлийг хүчингүй болгосон хэмээн тус улсын хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлсэн. Эдийн засгийн хямрал, цар тахалтай тэмцэхийн тулд эмч, сувилагч нар цалин, хөлсөө нэмэгдүүлэх, хамгаалах хэрэгслээр хангагдах талаар шаардлага тавьж буй цаг үед энэ асуудал олон нийтийн анхаарлыг ихээхэн татаж байна.

¹⁴⁹ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.taiwannews.com.tw/en/news/3928284>

¹⁵⁰ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/08/zimbabwe-vp-named-health-minister-coronavirus-graft-scandal-200805053439951.html>

Албаны этгээдийн мэдэгдэж байгаагаар Чивенга нь өнгөрсөн онд дөрвөн сарын турш БНХАУ-д үл мэдэгдэх өвчнөө эмчлүүлж байсан бөгөөд түүнээс хойш 3 удаа тус улсад зорчин, эмнэлгийн үзлэг хийлгэж байжээ.

КОВИД-19 халдвартай холбоотой авлигын улмаас АҮКН-ын засаглал төгсгөл болж болзошгүй гэж Туту сан үзэж байна¹⁵¹



Хяналтгүй авлига АҮКН-д аюул учруулж болзошгүйг Хүндэт хамба Десмонд Тутугийн сан анхаарууллаа.
(Фото: Halden Krog)

2020.08.08. ӨАБНУ-ын эрх баригч нам болох Африкийн үндэсний конгресс нам (АҮКН) гишүүдийнхээ авлигыг таслан зогсоож чадахгүй бол төрийн эрхээ алдаж болзошгүйг Африкийн хамба лам Десмонд Тутугийн сангийн зүгээс санууллаа.

“Төр төмөр нүүр гарган, хэн байхаас нь үл хамааран гэмт хэрэгтнүүдэд зоригтойгоор хариуцлага хүлээлгэх боломж хаагдаж байна. Хэрэв энэ боломж хаагдвал бид тэмцэл хийхээс өөр аргагүй болно. Ардчилсан орнуудад ард түмэн бэлэн байх үед засгийн газар өөрчлөгддөг” хэмээн Десмонд ба Лиан Туту Легаси сангийн гүйцэтгэх захирал Пиюши Котеча (Piyushi Kotecha) хэлсэн байна.

КОВИД-19 халдварын үеийн яаралтай худалдан авалттай холбоотой авлигын хэрэг гарсан байж болзошгүйг тус сан Өмнөд Африкийн сүмүүдийн зөвлөл, Нельсон Мандела сан болон иргэний нийгмийн бусад байгууллагуудтай хэлэлцсэнээс хойш нэг өдрийн дараа уг мэдэгдлийг хийжээ.

Тус байгууллагууд “авлигын эсрэг нийгмийн цогц хариу арга хэмжээ авахын тулд” эрдэмтэн судлаачид болон хуулийн мэргэжилтнүүдтэй зөвлөлдөж байгаагаа мэдэгдэв. Эдгээр байгууллагууд хамтран авлигын талаар мэдээлэл авах зорилгоор шүгэл үлээгч, төрийн албан хаагчдад зориулсан “ачаа хөнгөлөх самбар”-ыг дахин нээж ажиллуулахаас гадна, “зөвхөн мөнгө хөрөнгө дээрэмдэх төдийгүй, түүний үр дагаварын тухайд эсэргүүцлээ илэрхийлэхийг олон нийтэд уриалсан” байна.

Котечагийн үзэж байгаагаар энэхүү болзошгүй авлигын хэрэг нь ӨАБНУ-ыг ичгэвтэр байдалд оруулж байгаа бөгөөд эдийн засгийн тэгш бус байдлыг бууруулах боломжийг устгаж байна. Мөн тус улсыг КОВИД-19-ийн халдвараас хамгаалах нь улс төрчдийн хувьд бизнесийн боломж болж хувирсан нь цар тахлын дараах эдийн засгийг босгох ажилд төдийгүй, улс орны тусгаар тогтнолд хор хохирол учруулна.

Авлига, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах, хүний эрхийг зөрчих явдлыг шүүмжилсэн католик шашны хамба лам нарын шүүмжлэлийг Зимбабвэ улсын засгийн газар үгүйсгэж байна¹⁵²

2020.08.16. Улс төрийн болон өөр ямар нэгэн хямрал байхгүй хэмээн засгийн газрын хэвлэлийн төлөөлөгч Ник Мангвана (Nick Mangwana) мэдэгдэв. Тэрээр Зимбабвэгийн католик сүмийн хамба лам нарын хурлыг “хямрал өдөөгчид” хэмээн нэрлэсэн байна. Хамба лам нар тус улсын эдийн засаг, улс төрийн асуудлыг яаралтай шийдвэрлэхийг уриалсан. “Тус улс дахь зөрчил тэмцлийн үр дүнд эдийн засгийн уналт, ядуурал гүнзгийрч, хүнсний аюулгүй байдал, хүний эрхийг

¹⁵¹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.timeslive.co.za/politics/2020-08-08-covid-19-corruption-could-end-anc-rule-says-tutu-foundation/>

¹⁵² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.bbc.com/news/world-africa-53798787>

зөрчих зэрэг олон давхаргат хямрал бий болсон” хэмээн тус улсын томоохон хотуудын 7 хамба ламын илгээсэн захидалд дурдсан байна. Авлига аюулт түвшинд хүрээд байна хэмээн тэд онцолжээ.

Зимбабвэгийн иргэд төрийн албаны авлига, 700 гаруй хувьд хүрээд буй инфляцийн түвшин, гүнзгийрсэн эдийн засгийн хямрал зэргийг эсэргүүцэн жагсаж буй юм. Гэвч тус улсын Ерөнхийлөгч Эммерсон Мнангава гаднынхантай нийлэн улсын тогтвортой байдлыг алдагдуулж байна хэмээн өөрийн өрсөлдөгч нарыг буруутгаж байна.

Засгийн газрыг шүүмжлэн жагсагчдын эсрэг хатуу арга хэмжээ авж, хэд хэдэн жагсагчийг баривчилсан зэргийг олон нийт эсэргүүцэж байна. Олон нийтийг хүчирхийлэлд уриалсан хэргээр нэртэй сэтгүүлч Хопевел Чиноног өнгөрсөн сард баривчлаад байгаа юм. Тэрээр коронавируст халдвартай тэмцэхэд зориулсан худалдан авалтын явц дахь эрүүл мэндийн салбарын авлигын асуудлыг илчлэн нийтлэл бичсэн юм.



Жагсагчдын эсрэг хүчтэй зэвсэг хэрэглэсэн хэмээн цагдаа нарыг буруутгаж байна. (Фото: AFP)

Жагсагчдын эсрэг цагдаагийнхан дайрч буй зургуудыг интернетэд нийтэлсэн ба хүний эрхийг бүдүүлгээр зөрчиж байгааг олон нийт эсэргүүцэн #ZimbabweanLivesMatter хэштаг ашиглан олон нийтийн сүлжээгээр түгээж байна.

“Олон хүн айдаст автаж байна. Өөр үзэл бодлыг даран нугалах явдал урьд өмнө үзэгдээгүй хэмжээнд хүрээд байна” хэмээн тус улсын католик шашины хамба лам нарын захидалд онцолжээ. Зимбабвэд хүний эрхийг ноцтойгоор зөрчиж байгаа нөхцөл байдлын талаар гадаад улсын засгийн газрууд, ЕХ, Африкийн холбоо, НҮБ зэрэг байгууллагууд хүлээн зөвшөөрч байгаагаас гадна #ZimbabweanLivesMatter хэштагт нэгдэх шаардлагатайг онцолжээ.

Гэвч ноён Мангвана төрийн мэдлийн The Herald сонинд бичихдээ засгийн газрыг хамгаалсан байна. Дэлхийн бусад улс оронтой нэгэн адил Зимбабвэ ган гачиг, цар тахал, хууль бус үйл ажиллагаатай тэмцэж байна хэмээн Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч мэдэгджээ. Өндөр албан тушаалтнуудыг баривчлах, авлигатай тэмцэх байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх зэргээр Ерөнхийлөгч авлигатай тэмцэх амлалт, үүргээ биелүүлж байгаа хэмээн тэрээр мэдэгдэв.

Авлигатай тэмцэхгүйгээр цар тахлын дараах эдийн засгийг сэргээх талаар яриад хэрэггүй¹⁵³

2020.08.17. Өмнөд Африк. Засгийн газрын Санхүү, төсвийн хороо (СТХ) эдийн засаг, төсвийн өсөлтийн төсөөллийг бодит орлогод үндэслэсэн тооцохыг уриалав. Тус хороо нь засгийн газар, парламентад санхүү, төсвийн асуудлаар зөвлөгөө, зөвлөмж өгч ажилладаг. Иргэдийн амьжиргаа, эдийн засгийн тогтвортой байдалд урьд өмнө үзэгдээгүй цочрол болсон цар тахлын үед эдийн засгийг аврахын тулд авлигыг устгах шаардлагатайг СТХ анхааруулав.

Эмзэг бүлгийнхэнд тусламж үзүүлэх, цар тахалтай тэмцэхэд шаардлагатай бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авахад зориулсан хөрөнгө, мөнгийг авлигын улмаас алдаж байна хэмээн СТХ даваа гарагт мэдэгдсэн байна. 2020/2021 оны төсвийн тухай хуулийг өнгөрсөн 07 дугаар сард парламентад оруулсан юм.

Хууль эрх зүйн, захиргааны, эсхүл системийн шийдвэртэй өөрчлөлт, арга хэмжээ авахгүйгээр ӨАБНУ хямралаас гарч, эдийн засгийн болон нийгмийн тогтвортой байдлаа хангаж чадахгүй. Цар тахлын нөлөөллийг бууруулах чиглэлээр засгийн газар арга хэмжээ авахгүй бол өрхийн орлого цаашид улам бүр буурсаар байх болно хэмээн анхааруулав.

¹⁵³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://businesstech.co.za/news/business/425942/without-action-against-corruption-economic-recovery-is-unlikely-commission/>

Зарим үзүүлэлтийг авж үзвэл:

Ажилгүйдэл

Тус Хорооны үзэж буйгаар ӨАБНУ-д 2020 оны эхний улиралд 38 мянган ажлын байр байхгүй болж, 306 мянган ажил хайгч нэмэгдсэн байна. Гэтэл өмнө нь 7 сая гаруй өмнөд африкчууд ажилгүй болсон байжээ. Үүний шалтгаан нь арьс өнгөөр ялгаварлах дэглэмээс өвлөн авсан эдийн засгийн тогтолцоо, уламжлалт түүхий эдээс “хэт хамааралтай байдал” гэж үзэж байгаа юм. 1994 оноос хойш төр эдийн засгийг төрөлжүүлж чадаагүй, бүтцийн ажилгүйдэл, тэгш бус байдлыг бүрэн устгаж чадаагүй юм. Энэ нь цар тахлаас үүдэлтэй өрнөж буй хямралын явцад илүү мэдрэгдэж байна хэмээн СТХ-ны тайланд дурджээ.

Дотоодын эдийн засаг, хөдөө аж ахуйг бүтцээр нь өөрчлөх шаардлагатайг онцолсон байна. Хөдөө аж ахуй (ХАА) нь хүнсний аюулгүй байдлыг хангах, эдийн засгийн бүх салбарт бүтээмж, орлого, ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх чадвартайг тэмдэглэсэн. 2020 оны нэгдүгээр улиралд ХАА-н салбарын бараа эргэлт нэмэгдсэн ч ДНБ хоёр хувиар буурсан юм.

Нийгмийн эрүүл мэнд

Эрүүл мэндийн салбарын зардлыг нөхөх хэрэгцээ, шаардлагад нийцсэн хандлагыг хэрэгжүүлэхийг СТХ зөвлөж байна. Мөн өвчтөн, эмч нарын мэдээллийг агуулсан үндэсний мэдээллийн систем хөгжүүлэх хэрэгтэйг онцолсон байна. Гэвч үүнийг хэрэгжүүлэхэд найдвартай, баталгаатай мэдээлэл байхгүйг анхааруулсан.

Боловсролд хөрөнгө оруулах

Хүүхдүүдэд хөрөнгө оруулахгүйгээр эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахгүйг СТХ анхааруулав. Одоогийн байдлаар хамгийн эмзэг бүлгийнхэн, ядуу өрхийн бага насны хүүхдүүд хамрагддаг албан бус төвүүд, номын санд төрөөс санхүүжилт хийж байна. Гэтэл төрийн санхүүжилт авахад олон тооны баримт, бичиг шаардагддаг. Иймд төрийн санхүүжилт ихээр шаардлагатай байгаа жижиг хөтөлбөрүүд санхүүжилт авж чадахгүйд хүрдэг хэмээн онцолсон байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд

Одоогийн байдлаар хөгжлийн бэрхшээлтэй 597,953 хүүхэд сургуульд хамрагдаж чадаагүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй 119,000 хүүхэд 6 тусгай сургуульд суралцаж байна. Тус нөхцөл байдалд нэн тэргүүн хяналт шалгалт, аудит хийснээр нотолгоонд үндэслэсэн бодлогын хэрэгжилтийг хангах нь үр ашгийг дээшлүүлнэ хэмээн тус Хороо үзэж байна. Нөгөө талаар, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалтын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, хариуцлага тооцох асуудал зохицуулагдаагүйг онцлов.

Авлига

Харамсалтай нь, цар тахлын үед эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбарын төрийн худалдан авалтын явцад авлига, хахууль оршиж байгааг Хороо онцлов. Цар тахалтай тэмцэх, эмзэг бүлгийнхэнд хүрэх ёстой хөрөнгө үр ашиггүй алдагдахад хүрч байна.

ӨАБНУ дээрх олон тооны хямралыг даван гарч, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад авлигатай тэмцэх хууль эрх зүй орчин, захиргааны, эсхүл системийн түвшинд шийдвэртэй арга хэмжээ авахгүйгээр амжилтад хүрэхгүй юм. Авлигыг буруушааж, устгах хэрэгтэй хэмээн тус Хорооны мэдэгдэлд онцолсон байна.

Өмнөд Африкийн хотуудад илрэх авлигын хэлбэрүүд¹⁵⁴

2021.08.19. Авлигын харуул (Corruption Watch) байгууллагаас шинээр гаргасан тайланд ӨАБНУ-ын орон нутгийн засаг захиргааг сүүлийн арван жилийн турш залхааж буй авлигын асуудлуудыг онцолжээ. Өмнөд Африкт апартейд дэглэм нурснаас хойших зургаа дахь удаагийн орон нутгийн сонгууль 2021 оны 10 дугаар сарын сүүлээр төлөвлөгдөөд байна.

¹⁵⁴ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://businesstech.co.za/news/trending/514352/types-of-corruption-you-can-expect-in-every-major-metro-in-south-africa/>

Хэрэв чөлөөтэй, шударга сонгууль явуулах орчин бүрдсэн гэж үзвэл олон нийт тус улсын 8 муж, 44 дүүрэг болон 200 хорооны удирдлагыг сонгох санал хураалтад оролцох юм.

Авлигын харуул “Коронавирусний тахал дэлхий нийтэд сөргөөр нөлөөлсөн тул энэ чухал сонгууль болно” гэв. Тус байгууллага үйл ажиллагаа явуулаад 9 жил болж байгаа бөгөөд энэ хугацаанд 33,000 шүгэл үлээгчээс мэдээлэл авсны 16% нь орон нутгийн засаг захиргааны нэгжийн авлигын асуудал байжээ. Авлигын талаарх эдгээр мэдээлэл нь орон нутгийн засаг захиргааны байгууллагууд үндсэн үйлчилгээгээ ард иргэдэд хүргэж чадахгүй байгааг харуулж байна.

“Авлигын ихэнх тохиолдол орон нутгийн удирдлагатай холбоотой байгаа нь Өмнөд Африкт ерөнхийдөө удирдлагын хямрал нүүрлэснийг илтгэж байна” хэмээн тус байгууллагын судлаач, тайланг боловсруулагч Мелуси Нкала мэдэгдэв.

Улс төрчид, төрийн удирдлага хувийн, хэсэг бүлгийн ашиг сонирхолд үйлчилж байгаа нь тус улсын ардчилал хамгаалагдаагүйг илтгэж байна. Дэлхийг хамарсан цар тахал ч тэднийг зогсоож, ард түмэндээ үйлчилнэ хэмээн амласан амлалтыг нь сануулж чадахгүй байна. Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, өндөр настнууд, ажилгүй залуучууд төрийн үндсэн үйлчилгээ авж чадахгүй байхад тэд улангассаар л байна.

Ихэнх гомдол Гаутенгаас (41%), дараа нь КваЗулу-Наталаас (11%), 8% нь Лимпопо, Мпумаланга болон Баруун хойд мужаас ирсэн байна.

Орон нутгийн засаг захиргаатай холбоотой хамгийн их буюу 857 өргөдлийг 2020 онд хүлээн авсан нь өмнөх жилтэй харьцуулахад 50 хувиар өссөн байна.

Йохансбург хотын захиргаа хамгийн ихээр авлигын асуудалд буруутгагдаж, 700 орчим өргөдөл бүртгэсэн бол удаах байранд Экурхулени хоттой холбоотой 354, Тшване хоттой холбоотой 325, Текюини хоттой холбоотой 166, Кэйп Таун хоттой холбоотой 125 өргөдөл тус тус бүртгэсэн байна.

Орон нутгийн засаг захиргаанд авлигын дараах хэлбэрүүд зонхилж байна. Үүнд: хахууль 28%, төрийн худалдан авах ажиллагааны зөрчил 24%, ажил эрхлэлтийн зөрчил 11%, эрх мэдлээ урвуулан ашиглах 9%, хөрөнгө шамшигдуулах 8% тус тус байна.

Танил тал харах, хахууль өгөх, хууль тогтоомж зөрчихөөс гадна эдгээрийг үйлдэгсдэд хариуцлага тооцох асуудал учир дутагдалтай байгааг тайланд онцолжээ.

Ливи: Төрийн үйл ажиллагаан дахь авлига болон иргэдээ орхигдуулсан байдалд эгдүүцсэн Мисрата хотын иргэд хоёр дахь өдрөө жагсаж байна¹⁵⁵

2020.08.25. Ливийн гурав дахь том хот болох Мисратад жагсаал хийж байгаа иргэд төрийн үйл ажиллагаан дахь авлига болон гажуудалд бухимдан эсэргүүцлээ илэрхийлж байна.

“Бид энд авлигын эсрэг...өөрсдийн эрхийн төлөө, төрийн үйлчилгээний сул дорой байдалтай тэмцэхээр жагсаж байна. Бидэнд юу ч алга. Коронавирус гарснаас хойш олон зуун саяын хөрөнгийг төрийн байгууллагууд зарцуулсан ч өвчтэй хүмүүс эмчилгээ хийлгэж чадахгүй байна. Эрүүл мэндийн салбарт зарцуулагдах мөнгийг хувьдаа завишж хулгайлсан учир хүмүүс үхэж байна” хэмээн нэгэн жагсагч Ал Жазира агентлагт ярилцлага өгсөн байна.

Одоогийн байдлаар тус улсад коронавирусний халдварын 11,000 гаруй тохиолдол бүртгэгдэж, 199 хүн нас бараад байгаа юм.

¹⁵⁵ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/08/libya-2nd-day-misrata-protests-corruption-poor-services-200824184617498.html>

Европ тив

Словак улс авлигын “хар нүх”-нээс ангижрах арга зам эрэлхийлж байна¹⁵⁶

2020.02.26. Словакт удахгүй болох гэж байгаа сонгуулийн хувьд авлигын асуудал голлох асуудал нь биш, харин цорын ганц асуудал болоод байна. Энэ сарын 29-нд сонгуулийн санал хураалт болох бөгөөд словакчууд төр засагтаа гүн цэвэрлэгээ хийхийг хүсэж байна.

Эрүүл мэндийн салбарын төсөв туйлийн хангалтгүй, багш нарын цалин бага, хөгжил дорой зүүн бүсийг холбосон замын нөхцөл тааруу байгаад ард иргэдийн сэтгэл дундуур байгаа боловч энэ бүхнийг шийдвэрлэх ёстой төр засгийн үйл ажиллагаанд зөвхөн авлигын механизм үйлчилж байна.

Худал хэлэхийг хуулиар зөвшөөрөв. Чех улс дахь шударга ёсыг дэнслэх мөч мөн үү?¹⁵⁷

2020.02.26. Өнгөрсөн баасан гарагт Чех улсын шүүх иргэний нийгмийн хөдөлгөөнд цохилт өгөв. Чех дэх ТИ байгууллагыг авлигад автсан газар гэж нэг бус удаа мэдэгдсэн нь гүтгэлгийн шинжтэй гэж үзэн тус байгууллага Ерөнхий сайд Андрей Бабишийг шүүхэд өгөөд байсан юм.

Анхан шатны шүүхийн зүгээс Ерөнхий сайдын мэдэгдлийн үнэн, худлыг шүүх авж хэлэлцээгүй ба харин ийм мэдэгдэл хийж болох эсэх асуудлыг хэлэлцээд А.Бабишийн талд шийдвэрлэжээ.

ТИ-ийн Чех дэх салбар байгууллага Ерөнхий сайд Андрей Бабишийг ашиг сонирхлын зөрчилд автсан, ЕХ-ны болон Чехийн засгийн газрын хөнгөлөлт, урамшууллыг өөрийн үүсгэн байгуулсан бөгөөд одоо өмчилсөөр байгаа хувийн компанидаа олгосон асуудалд буруутгаж буй юм. Тус байгууллагын зүгээс шүүхийн шийдвэрийг давж заалдахаа мэдэгдээд байна.

Оросууд бага хэмжээний хахууль өгөх нь түгээмэл болжээ¹⁵⁸

2020.02.28. ОХУ-д бага хэмжээний (10 мянган рубль¹⁵⁹ хүртэлх) хахуультай холбоотой гэмт хэргийн тоо нэмэгджээ. ОХУ-ын Ерөнхий прокурорын газар (ЕПГ)-аас гаргасан “ОХУ дахь 2020 оны 01 дүгээр сарын байдлаарх гэмт хэргийн нөхцөл байдал” статистикийн эмхэтгэлд энэ талаар дурдсан байна.

Статистикийн мэдээгээр, энэ төрлийн гэмт хэргийн тоо 364 байснаас 521 болж, 43.1 хувиар өссөн. Үүнээс, Киров мужид 1-ээс 11, Крымд 2-оос 13, Оренбург мужид 2-оос 13, Москвад 5-аас 32, Башкортостан Автономит Улсад 7-оос 34 хүртлээ нэмэгдсэн нь хамгийн өндөр хэмжээтэй байгаа бол Тверь мужид 5-аас 0, Ленинградын бүс 2-оос 0, Алтайн бүс 3-аас 0, Чувашийн Автономит Улсад 18-аас 1 хүртэл тус тус буурсан байна.

Кабардино-Балкарын Автономит улс, Брянск, Омск, Волгоград мужуудад хахуулийн хэргийн илрүүлэлт нэмэгдсэн байна. Ерөнхийдөө хахууль авахтай холбоотой гэмт хэрэг 0.9 хувиар (445 байсан бол 441) буурсан талаар эмхэтгэлд тэмдэглэжээ.

ЕПГ-ын статистик мэдээллээс гадна, ОХУ-ын Мөрдөн шалгах хороо (МШХ)-ноос 2019 оны 12 дугаар сард авлигын гэмт хэргийн талаарх статистик мэдээг танилцуулсан.

2019 онд авлигатай холбоотой 6.5 мянган эрүүгийн хэрэгт холбогдсон сэжигтнүүдийн дунд Дотоод явдлын яамны 752 ажилтан, нутгийн өөрөө удирдах байгууллагын 476, Холбооны шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 181, Холбооны шүүхийн эрэн сурвалжлах албаны 84

¹⁵⁶ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/02/slovakia-seeks-escape-corruption-black-hole-200226135428581.html>

¹⁵⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: https://www.transparency.org/news/feature/a_moment_of_truth_for_the_czech_republic

¹⁵⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://iz.ru/981290/2020-02-28/rossiiane-stali-chashche-davat-melkie-vziatki>

¹⁵⁹ 1 рубль 41.90 /Монголбанкны ханш, 2020.03.04./

ажилтан сэжигтнээр татагдсан байна. Түүнчлэн МШХ-ны 27 ажилтан авлигын гэмт хэрэгт холбогдсон байна.

2019 онд авлигын улмаас учирсан хохирлын талаар ОХУ-ын Ерөнхий прокурорын газар мэдээлэв¹⁶⁰

2020.03.30. 2019 онд ОХУ-д үйлдэгдсэн авлигын гэмт хэргийн улмаас 55.1 тэрбум рублийн¹⁶¹ хохирол учирсан талаар ОХУ-ын Ерөнхий прокурорын газрын мэдэгдэлд дурдсан байна.

2019 онд үйлдэгдсэн бүх төрлийн гэмт хэргийн улмаас учирсан хохирлын нийт дүнгийн 8.8 %-ийг авлигын гэмт хэргийн улмаас үүссэн хохирол эзэлж байна. Үүний 4.1 тэрбум рублийн хохирлыг сайн дураар төлсөн бол 1.5 тэрбум орчим рублийн хөрөнгө, мөнгө, үнэт зүйлийг хураан авж нөхөн төлбөр хийжээ. Мөн яллагдагчдын 18.2 тэрбум рублийн үнэтэй эд хөрөнгийг хураан авсан байна.

Өнгөрсөн жилийн хугацаанд авлигын улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх прокурорын 312 нэхэмжлэлийг шүүхээс шийдвэрлэсэн. Үүнээс 2 тэрбум рублийн хохирлыг нөхөн төлүүлжээ.

Хөрөнгө, орлогын мэдүүлэг дэх хачирхалтай зүйлс: Шорлог бэлтгэх төхөөрөмжөөс нисэх онгоц, том гараажаас см² хэмжээтэй эзэмшил газар хүртэлх эд хөрөнгө¹⁶²

2020.04.02. ОХУ. Авлигатай тэмцэх албад төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хянан шалгах ажилд ханцуй шамлан орж байна.

Төрийн албан хаагчид, ялангуяа, доод албан тушаалтнуудын хувьд хөрөнгө, орлогын мэдүүлгээ жил бүр мэдүүлэх нь ёс төдий зүйл болжээ. Албан тушаалтнууд мэдүүлгээ тэгсгээд бөглөөд өгдөг, авлигатай тэмцэх албаны ажилтнууд мэдүүлгийг үзэж сонирхдоггүй бололтой. Хөрөнгө, орлогын мэдүүлэгт дурдсан үнэтэй автомашин, хувийн онгоцны цуглуулга хэрхэн бий болсон, шорлог хийх төхөөрөмж, нохойны үүр зэргийг мэдүүлсэн, мөн орон сууцаа цэнгэлдэх хүрээлэн, эзэмшлийн газраа хэрхэн шуудангийн марк болгон хувиргасныг мэдэхгүй, тодруулахгүй байна.

Эд хөрөнгийн аварга

ТИ байгууллагаас ОХУ-ын 137,404 депутат, албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлэгтэй танилцан судлах явцдаа зарим мэдүүлэг гаргагчийн эд хөрөнгө санаанд багтамгүй их хэмжээтэй байгааг мэдсэн байна. Тухайлбал, Ямало-Ненецийн автономит тойргийн Хууль тогтоох хурлын гишүүн асан, нисэхийн тээврийн Ямал компанийн Ерөнхий захирал Василий Крюкийн эзэмшлийн газар нь Словени улсын нутаг дэвсгэрээс ч илүү, 22.9 мянган км² байна.

Төрийн Думын гишүүн Андрей Палкин 2015 оны мэдүүлэгтээ хагас тэрбум рублийн орлого мэдүүлж, орлогоороо хууль тогтоогчдын дунд дээд амжилт тогтоож байжээ. А.Палкин депутат болохоосоо өмнө 90 гаруй орон сууц, 200 орчим тээврийн хэрэгсэлтэй байжээ. Төрийн Думд Дагестаныг төлөөлж гишүүнээр ажиллаж байсан, талийгаач Владимир Ашурбеков 2015 онд мэдүүлэгтээ 627,606 м² талбайтай шилтгээнтэй гэж мэдүүлсэн байна. Архангельское эдлэн газрын музейн захирал Вадим Задорожний 11 ширхэг нисэх төхөөрөмжтэй гэж мэдүүлэгтээ дурдсан байв.

Орхигдсон таслал

Дээр дурдсан их хэмжээний хөрөнгийн тухай сонссон Оросын жирийн иргэдэд тэднийг хаанаас, хэрхэн ийм их хөрөнгөтэй болсон тухай асуулах хүргэж, бодит байдалд эргэлзээ төрүүлж байна. Жишээлбэл, Санкт-Петербург мужийн Хууль тогтоох хурлын гишүүн Ольга Романовская хоёр га (19,728 м²) талбай бүхий машины гаражтай байна. Батлан хамгаалах яамны албан тушаалтан Мальцев 42,154 м² талбай бүхий орон сууцтай гэж мэдүүлсэн (цэргийн байгууллагын албан

¹⁶⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/2899153.html>

¹⁶¹ 2.26 орчим их наяд төгрөгтэй тэнцэнэ.

¹⁶² Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://pasm.ru/archive/264218/>

хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлэг нууцлалын зэрэглэлтэй). Мөн цэргийн албан тушаалтан Тереховын эхнэр 42,147 км² талбай бүхий зуслангийн байртай байна.

Новосибирск мужийн Бжуско хотын боловсролын байгууллагын нягтлан бодогч 2015 онд 43,178 м² талбай бүхий орон сууцтай гэж мэдүүлсэн байна. Свердловск мужийн 45 дугаар шоронгийн орлогч дарга Константин Арафаилов мөн 43,338 м² талбайтай орон сууцтай талаараа мэдүүлжээ.

ТИ байгууллагын шинжээчид дээрх мэдүүлсэн хөрөнгө, орлогын тоонд алдаа гаргаж, орон андууран таслалыг орхигдуулсан гэж үзсэн байна. Энэ нь, мэдүүлэг гаргагчид хөрөнгө, орлогоо мэдүүлэхдээ хайнга ханддаг, мөн авлигатай тэмцэх албаны ажилтнууд мэдүүлгийг нягтлан шалгахгүй, ажилдаа хариуцлагагүй хандаж байгааг нотолж байна.

Их, бага

Зарим албан тушаалтнуудын мэдүүлэгтэй танилцахад ургуулан бодохоор (пофантазировать) зүйлүүд гарч ирдэг байна. Тухайлбал, Эрхүү хотын баян депутатуудын нэг болох Нина Чекотова мэдүүлэгтээ “туршилтын лаборатори” мэдүүлжээ. Батлан хамгаалах яамны албан тушаалтан Н.Г.Легенькая мэдүүлэгтээ өөрийн овгийг мэдүүлсэн байна.

Санкт-Петербург хотын Улсын орон сууцны газрын даргын орлогч, байцаагч Егор Тратников мэдүүлэгтээ 20 км² талбайтай “амьтан тэжээх байр” мэдүүлснийг авлигатай тэмцэх албаны шинжээчид эдлэн газраа ийнхүү мэдүүлсэн гэж үзжээ.

Зарим албан тушаалтан мэдүүлэгтээ хэт нямбай хандах тохиолдол гардаг. Крымский агрохимийн үйлчилгээний төвийн нягтлан бодогч 2014 оны мэдүүлэгтээ эхнэрийнхээ эзэмшлийн 22,49 см² хэмжээтэй газрыг мэдүүлсэн бол Томск мужийн захирагчийн орлогч Андрей Кнорр чимэглэлийн модон шон, Приморийн хязгаарын Улсын бүртгэлийн газрын дарга Евгений Русецкий нүүрсээ хадгалах амбаар, шорлог бэлтгэх төхөөрөмжтэй гэж мэдүүлсэн байна.

Чечень улсын Цагдаагийн дарга, хошууч генерал Апт Алаудинов олон хүүхэдтэй, жилд 2-4 сая рублийн орлоготой гэсэн мөртлөө мэдүүлэгтээ зөвхөн эхнэрийн эзэмшлийн орон сууцнаас өөр зүйл мэдүүлээгүй байна.

Алдааг хэрхэн засах вэ?

Авлигатай тэмцэх албаны хариуцсан байгууллага нь хуулиар тогтоосон хяналт шалгалтын үйл ажиллагаандаа ёс төдий хандаж байгаагаас албан тушаалтнууд хөрөнгө, орлогоо мэдүүлэхдээ хайнга хандаж байна гэж ТИ олон улсын байгууллагын шинжээчид үзсэн байна.

“Дээрх алдаанууд нь мэдүүлэг дэх хөрөнгө, орлогыг эд хөрөнгийн бүртгэлийн лавлагаа мэдээлэлтэй харьцуулан шалгаж байгаа эсэх, эд хөрөнгийн өсөлт нь орлого, хуримтлалтай тохирч байгаа, мэдүүлгээ үнэн, зөв, бодитой мэдүүлж байгаа эсэхэд эргэлзэхэд хүргэж байна. Тиймээс мэдүүлгийг тодорхой хэмжээнд цахимжуулж, дээр дурдсан алдааг гаргахгүй байж болно” гэсэн саналыг ТИ байгууллагаас гаргажээ.

Мэдүүлэг дэх мэдээллээс ажил хэргийн, мэргэжлийн, хувийн ашиг сонирхлын шинж чанар, байдлыг мэдэх боломжтой бөгөөд сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх боломж нээгдэх юм.

Өмнөд Солонгос дахь авлига манайхаас арай дөнгүүр юм¹⁶³

2020.04.19. Павел Вернивский. Учир нь, тэднээс ялгаатай нь, бид шинэ зүйл бий болгохыг огт оролдож байсангүй.

Өмнөд Солонгос дэвшингүй хөгжсөн нь тэнд авлига байгаагүй дээ биш, харин ч эсрэгээрээ. Тэнд авлига байсан.

Солонгосчууд ашгаас хулгайлж байснаас биш, алдагдлаас хумсалж байгаагүй гэж зарим хүн тайлбарладаг. Ер нь бол үнэн, гэхдээ нэмэлт тайлбар хиймээр байна.

Солонгосчууд шинэ бизнес бий болгож сурсан хүмүүс. Энэхүү шинэ бизнес бий болгож буй мөнгөний урсгалаас хулгайлж байсан юм.

¹⁶³ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://strana.ua/opinions/262354-korejskaja-korrupsija-vse-taki-vyhlyadit-poluchshe-nashej.html>

Солонгосчууд төмөрлөг, машин, усан онгоц, зурагт, хожим нь хагас дамжуулагч, ухаалаг утасны үйлдвэрлэлийг тэгээс эхэлсэн гэдгийг мартаж болохгүй. Дахин давтан хэлэхэд, тэд бүгдийг тэгээс эхэлсэн юм.

Солонгосчууд аль хэдийн бий болсон мөнгөний урсгалд хяналт тавих бус, чухамдаа шинэ мөнгөний урсгалыг бий болгож, түүнээс ашиг олж байлаа. Тэд зөвхөн ашиг олохын төлөө биш, харин ирээдүйдээ хөрөнгө оруулалт хийж байсан. Зөвөөр ойлгоорой, би авлигыг ямар ч тохиолдолд зөвтгөхгүй.

Манай болон Солонгосын авлигын хооронд ямар ялгаа байна вэ? гэвэл, манайд хэзээ ч шинэ зүйл бүтээн байгуулахыг оролдож байсан удаагүй. ЗСБНХУ-ын уналтын дараа бидэнд өв болж маш их хөрөнгө уламжлагдан ирсэн. Чухамдаа тэр их хөрөнгөд хяналт тавих гэсэн санаархал нь авлигад хүргэсэн.

Хамгийн харамсалтай нь, тэр их хөрөнгийг хяналтдаа авсан ч солонгосчууд шиг Hyundai болон Samsung корпорацаа ашиглан, дэлхийн хэмжээний өөрийн үнэт зүйлийн сүлжээ, эсхүл дэлхийн хэмжээний үнэт зүйлийн хэсгийг үүсгэхийг хэн ч оролдоогүй юм. Үүний оронд Зөвлөлтийн үед тогтсон байсан хуучин харилцаа холбоогоо буцаан хэрэглэх нь хамгийн энгийн, боломжийн шийдвэр гэж үзсэн. Харин энэ тогтвортой байдал нь оросын зах зээлийг алдсаны дараа эргээд асар том алдаа болсон юм.

Төрийн зүгээс хяналтдаа авсан хэдэн арван тэрбум ам.долларын тэр их хөрөнгө хөрөнгө оруулалт байсныг ойлгоогүй нь гол асуудал юм.

Урт хугацааны хөрөнгө оруулалтын ач холбогдлыг төр ойлгоогүй өнгөрсөн. Төр эдгээр хөрөнгө оруулалтын ач холбогдлыг ойлгоогүйгээс ирээдүйд хөрөнгө оруулалт хийж сураагүй юм.

Энэ л бидний гол ялгаа.

Өнөөдрийн асуулт: Орос улсад авлигагүйгээр амьдарч болох уу?¹⁶⁴

2020.04.24. Анатолий Выборный, Төрийн Думын Авлигатай тэмцэх хорооны гишүүн:

- *Муу зүйлийг ялах гэж байгаа бол өөрөөсөө эхэл. Жудагтай бизнесменүүд, албан тушаалтнууд байна. Тэд хахууль авахгүй, өгөхгүйгээр амьдарч, ажиллаж байна. Хүмүүс өөрийн эрхээ мэдэхгүй болохоороо асуудлаа хурдан шийдүүлэхээр албан тушаалтанд хахууль өгдөг. Гэхдээ шударгаар амьдрах нь илүү дээр. Манайд авлигагүйгээр ажиллах боломж байна. Үүнийг Ерөнхий прокурорын газраас гаргасан авлигын гэмт хэрэг, зөрчлийн талаарх мэдээллээс харж болно.*

Василий Мельниченко, Уралаас ирсэн бизнес эрхлэгч:

- *Орос улсад хэвийн амьдрахад авлига саад болж байна. Бид хэдэн сая амны хаалт үйлдвэрлэх хүчин чадалтай нэхмэлийн үйлдвэрээ хаалаа. Засаг даргын орлогчид 300 сая рублийн хөнгөлөлттэй зээл олгож, нөгөөх нь амны хаалтыг өөрийн өртгөөс нь 10 дахин илүү үнэтэйгээр улсад зарж байна.*

Сергей Осинцев, Санкт-Петербург хот, сэргээн засварлагч:

- *Бид авлигыг дийлэхгүй, бидний сэтгэлгээ тийм байна. Хүмүүс хийсэн ажлынхаа үр дүнд тохирсон цалин авж хэвшээгүй байна. Тэд хийснээсээ илүү их мөнгө шаардаж байна. Хүн гэдэг сул дорой юм.*

Сергей Гончаров, Ахмад дайчдын Альфа холбооны хүндэт ерөнхийлөгч:

- *Ахуйн хүрээний авлигыг арилгах боломж байхгүй. Харин төр засгийн түвшинд авлигыг багасгаж болно. Хятадад буудан хороодог, Сингапурт шоронд хорьдог. Удирдах албан тушаалтнуудын улс төрийн хүсэл зорилгоос шалтгаалах асуудал юм.*

Максим Сурайкин, ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч асан:

- *Авлигыг багасгаж болно. Гэхдээ капиталист нийгмийн үед бол боломжгүй. Зөвлөлтийн үед социалист нийгмийн өмчийг хулгайлдаг байсан. Тэр нь одоогийн үнэлэмжээр инээдтэй бага*

¹⁶⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.kp.ru/daily/27121/4204525/>

байжээ. Хүмүүсийг багаас нь хулгай хийх нь муу, албан тушаалын байдлаа ашиглаж болохгүй гэж сургадаг байсан. Авлигын онцгой хүнд хэрэгт цаазын ял оноодог байсныг сэргээх хэрэгтэй байна.

ОХУ-ын Дээд шүүхээс авлигын талаарх статистик мэдээллийг танилцуулав¹⁶⁵

2020.04.30. Өнгөрсөн жилд 15,000 гаруй авлигын хэрэгт ял оноожээ. Тухайлбал 500 гаруй хүн хахууль авсан, 400 гаруй хүн авлигад зуучилсан, 2.5 мянган хүн авлигын хэргээр, үүнээс арай илүү тооны хүн бага хэмжээний хахууль авсан хэргээр ял сонссон байна.

Улсын дээд шүүхийн Шүүхийн хэлтсээс 2019 онд гарсан авлигын хэргийн статистик мэдээллийг нийтэлсэн байна. Статистик мэдээллээр өнгөрсөн оны хэмжээнд авлигын гэмт хэргээр 15,562 ялын тогтоол гарсан байна.

Нийт 1,463 хүнд хорих ял оногдуулсан байна. Үүнээс:

1 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар 190;

1-2 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар 252;

2-3 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар 344;

3-5 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар 383;

5-8 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар 261;

8-10 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар 31;

10-15 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар 2 хүн тус тус шийтгүүлсэн байна.

Мөн 43 хүн эрх чөлөөгөө хязгаарлуулсан бол засан хүмүүжүүлэх ажил хийх шийтгэлээр 164, зайлшгүй болон албадан гүйцэтгүүлэх ажил хийх шийтгэлээр 17 хүн тус тус шийтгүүлсэн байна. 3,746 хүн торгууль төлсөн, 2,656 хүн тэнсэн авснаас 400 нь гурваас дээш жилийн ял авсан байна.

Авлигын гэмт хэргийн улмаас 76 хүн албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол 1,465 хүн албан тушаал хаших, тодорхой үйл ажиллагаа явуулах эрх хязгаарлах нэмэгдэл ялаар шийтгүүлсэн байна. 122 албан тушаалтны тусгай, цэргийн буюу хүндэт цол, албаны зэрэг дэв, төрөөс олгосон шагналыг хураан авжээ. Мөн 305 этгээдийн эд хөрөнгийг хураасан бол гэмт хэрэг хийхээр завдаж байсан 2,225 этгээдэд шийтгэл оногдуулсан байна.

Улсын батлан хамгаалах салбарын захиалгыг биелүүлэх үйл ажиллагааны явцад албан тушаалаа урвуулан ашигласан хэргээр 1, урьдчилан тохиролцож гэмт хэрэг үйлдсэн 5, залилангийн хэрэг болон мөнгө угаасан хэргээр тус бүр 8 хүн шийтгэл хүлээсэн байна. Мөн 26 хүн гэмт хэрэг үйлдэх талаар урьдчилан үгсэн тохирч, хууль бус үйлдлийг таслан зогсоогоогүй гэмт хэрэг үйлджээ. Түүнчлэн 10,000 рублиас доош хэмжээний хахууль авсан хэргээр 286 хүнийг ялласан байна.

Түүнчлэн, статистик мэдээнд, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд 116 хүн хууль зөрчин оролцсон талаар дурдсан байна. Тус улсын бие даасан муж, тойргийн буюу орон нутгийн өөрөө удирдах байгууллагын удирдах 2 албан тушаалтан хахууль авсан хэргээр шийтгүүлсэн байна.

Эрүүгийн хуулийн 1 дүгээр зүйл (Төрийн албан хаагч, олон улсын байгууллагын ажилтан хахууль авах)-д заасан гэмт хэрэг үйлдсэн 149, мөн хуулийн 2 дугаар зүйл (Их хэмжээний хахууль авах)-д заасан гэмт хэргээр 301, хуулийн 3 дугаар зүйл (Хууль бус үйл ажиллагааны төлөө хахууль авах)-д заасан гэмт хэрэг үйлдсэн 1,021 хүнд тус тус шийтгэл оногдуулсан байна.

Хахууль авсан хэргээр 1,742, авлигад зуучилсан 418, бага хэмжээний хахууль авсан хэргээр 2,674 хүн тус тус шийтгэл хүлээсэн бол 6 хүн энэ гэмт хэргийн ангиллаар өөр төрлийн шийтгэл авсан байна.

Түүнчлэн, эрх чөлөөгөө хасуулсан 32 хүнд өршөөл үзүүлж, 21 хүн шийтгэлийн бусад төрлөөр өршөөлд хамрагдсан мэдээлэл байна.

¹⁶⁵ Эх сурвалж: <https://pravo.ru/news/221264/>

Дээд шүүхийн Шүүхийн хэлтсээс гаргасан статистик мэдээллийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад 2019 онд эдийн засгийн үйл ажиллагааны салбар дах гэмт хэргийн тоо өссөн бол төрийн байгууллагын албан хаагчдыг доромжилсон хэргийн тоо буурсан байна.

Сербийн авлигатай тэмцэх байгууллага сайдын нөхрийн гэрээг шалгахгүй байна¹⁶⁶



Нела Кубурович. (Фото: ЕРА-ЕФЕ/Жастин Лэйн)

2020.05.07. Сербийн Хууль зүйн сайд Нела Кубурович (Nela Kuburovic)-ийн нөхөр Бояан Кисич (Bojan Kistic)-тэй холбоотой компани 2013 оноос хойш олон удаагийн тендерт ялж, 26.8 сая еврогийн гэрээг засгийн газартай байгуулсан талаар Балканы эрэн сурвалжлах сэтгүүлчдийн сүлжээ (Balkan Investigative Reporting Network буюу BIRN) байгууллагаас мэдээлсэн боловч тус улсын Авлигатай тэмцэх газар (АТГ) ямар нэгтү хариу үйлдэл хийхгүй байна.

Хууль зүйн сайдын нөхөр Чех улсад бүртгэлтэй NITES A.S компанийн гүйцэтгэх захирлаар ажилладаг бөгөөд энэ компани Сербид одоо засгийн эрхийг барьж байгаа улс төрийн намтай нягт холбоотой төрийн өмчит болон хувийн компаниудтай хамтарсан консорциум байгуулж, засгийн газраас зарласан дор хаяж 27 удаагийн тендерт оролцож, ялсан байна.

Засгийн газартай холбогддог Бояан Кисичийн өөр нэг сэжим бол тэрээр цар тахалтай тэмцэх гол үүргийг гүйцэтгэж байгаа Улсын онцгой комиссын голлох гишүүдийн нэг болох, халдвар судлаач, доктор Дариа Кисич Тепавсевич (Darija Kistic Tepavsevic)-ийн ах нь юм.

Зөвхөн өнгөрсөн дөрөвдүгээр сард гэхэд Кисич гүйцэтгэх захирлаар нь ажилладаг NITES компани Сербийн Эрүүл мэндийн яамнаас зарласан 3.2 сая еврогийн үнийн дүн бүхий 3 удаагийн тендерт ялалт байгуулжээ.

Сербийн Авлигын эсрэг хууль онолын хувьд л ЕХ-ны хууль тогтоомж, стандартад нийцдэг боловч бодит байдал дээр бүрэн хэрэгждэггүй байна.

2019 оны 05 дугаар сард Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийг шинэчлэн баталсан бөгөөд засгийн газрын зүгээс тайлбарлахдаа АТГ-ын эрх хэмжээ болон бие даасан байдлыг нэмэгдүүлсэн гэж үздэг.

Шинэ хуулийн дагуу мөн төрийн албан хаагчид өөрийн хөрөнгийг төдийгүй албан ёсоор гэрлэсэн болон гэрлээгүй хамтрагчийнхаа, мөн 18-аас доош насны хүүхдийнхээ хөрөнгийг мэдүүлэх үүрэгтэй болсон. Түүнчлэн, эцэг, эх, ах, эгч, дүү зэрэг хамаарал бүхий этгээдийнх нь талаарх мэдээллийг АТГ шаардаж, авах эрхтэй гэж хуульд заасан боловч энэ хууль 2020 оны 09 дүгээр сараас хэрэгжиж эхлэх юм.

Сербийн АТГ нь улс төрийн намын гишүүн бус хүнээр удирдуулж, хараат бус байдлаар ажиллахаар байгуулагдсан юм. Гэсэн хэдий ч улс төрчидтэй холбоотой хэрэг дээр тус байгууллага байнга л улс төрийн дарамтад орж, буланд шахуулж байдаг. Сүүлийн үед гарсан төрийн өндөр албан тушаалтнуудтай холбоотой олон асуудал дээр нүдээ анин өнгөрөөсөн гэж олон удаа шүүмжлүүлээд байна.

¹⁶⁶ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://balkaninsight.com/2020/05/07/serbias-graft-agency-ignores-birn-probe-into-ministers-husbands-deals/>

Орос дахь авлигын нөхцөл байдал¹⁶⁷

2020.06.05. Оросын эдийн засгийн сургуулийн (ОЭЗС) профессор, эдийн засагч Михаил Другов цахим лекцийн үеэр авлигатай холбоотой асуудлаар ярилцсан байна.

Авлигатай тэмцэх энгийн жор гэж байхгүй, гэхдээ янз бүрийн улс орон, бүс нутаг бүрд төрөл бүрийн аргууд байдаг. *“Авлигын тухай таны мэддэг бүх зүйлс нийгэмд байсаар байна. Хамгийн гол нь тэвчээр, улс төрийн хүсэл зориг, зөв хандлага, системчилсэн арга хэрэгтэй байна”* гэсэн зөвлөгөөг Другов өгсөн байна.

Манай улсын авлигын түвшин болон улс төрийн дэглэм дэх ардчиллын түвшний хооронд шууд хамаарал байгаа эсэхийг тухай бүр тодорхойлох боломж байхгүй байна. Тухайлбал, Сингапурт ХХ зууны хоёрдугаар хагаст Ерөнхий сайд Ли Куан Ю-гийн ганцаараа захирах дэглэмийн ачаар авлигатай тэмцэх үйл ажиллагаанд тодорхой амжилт гарсан. *“Дэлхийн хэмжээнд ардчилсан орнуудад авлигын түвшин харьцангуй бага байдаг”* гэж эдийн засагч тэмдэглэсэн байна.

Друговын хэлснээр, Орос улсад авлигын эсрэг зохион байгуулалттай, системчилсэн тэмцэл хийхгүй байна. Албан тушаалтан өөрийн орлогоос их хэмжээгээр давсан өмч хөрөнгөтэй бол зөрчилд тооцно гэж тусгасан НҮБ-ын холбогдох конвенцод Москва одоог хүртэл нэгдээгүй байгаа нь авлигатай тэмцэхгүй байгаагийн шууд бус нотолгоо юм.

Орос улсад олон үйлчилгээг цахимд шилжүүлсэнээр сүүлийн жилүүдэд ахуйн түвшинд авлига буурч байна. *“Үүнийг та өөрийнхөө жишээн дээр мэдэрч болно. Та шинэ гадаад паспорт авахдаа ОУТ (олон үйлдэлт төв)-өөр үйлчлүүлж байгаа. Урьд нь паспорт авахын тулд албаны тусдаа өрөөнд ордог байсан бол одоо бүх зүйл нээлттэй байна. Ийм нөхцөл байдал бий болсноор олон үйл ажиллагааны ил тод байдал сайжирч, хахууль өгөх шаардлагагүй болж байна”* гэж эдийн засагч Другов дүгнэсэн байна.

Гүрж улсад төрийн өндөр албан тушаалтнуудын оролцоотой авлигын хэрэг асуудал хэвээр байна¹⁶⁸

2020.06.10. Кавказын судалгааны нөөцийн төвөөс 2020 оны 02 дугаар сарын 27-ноос 03 дуаар сарын 18-ны өдрүүдэд зохион байгуулсан судалгаагаар Гүржид төрийн өндөр албан тушаалтнуудын оролцоотойгоор үйлдэгдэж буй авлигын хэрэг анхаарал татсан хэвээр байгаа тухай дүгнэлт гарсан байна. Уг судалгааг “Гүрж улс – Олон улсын ил тод, нээлттэй байдал” байгууллагын захиалгаар явуулжээ.

Судалгаанд хамрагдагчдын 63% нь албан тушаалтнуудын зүгээс албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах байдал түгээмэл байдаг, 57% нь төрөөс худалдан авалт зохион байгуулах үйл ажиллагаанд албан тушаалтнууд компаниудад давуу эрх олгох байдал их байдаг гэж үзжээ.

Түүнчлэн, төрийн өндөр албан тушаалтан болон эрх баригч намын нөлөө бүхий этгээдүүдтэй холбоотой авлигын хэргийг хуулийн дагуу шалгадаггүй гэж судалгаанд оролцогчдын 47% нь үзсэн байна.

Латви улсын хүн амын 39% нь авлигыг тэвчихгүй гэсэн байна¹⁶⁹

2020.06.12. ЕХ-ноос нийтлүүлсэн мэдээллээр, тус тивийн иргэдийн дунджаар 69 хувь нь авлигыг тэвчихгүй, зүй зохисгүй үйлдэл гэж үздэг байхад Европын авлигын судалгааны байгууллагаас саяхан Латви улсад хийсэн судалгаагаар иргэдийн 39 хувь нь авлигыг тэвчихгүй гэж үзсэн дүн гарсан байна.

ЕХ-ны улсуудын дотор авлигатай эвлэрэх үзүүлэлтээр Латви улсын дээр Унгар улс орж байгаа буюу хүн амын 38% нь авлигыг тэвчиж болохгүй гэж үзжээ. Европын бусад улс орны тухайд, тухайлбал, Португал улсад дээрх үзүүлэлт 88%-тай байна. Латви улсад явуулсан судалгаанд

¹⁶⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://lenta.ru/news/2020/06/05/corruption>

¹⁶⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.apsny.ge/2020/pol/1591820848.php>

¹⁶⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/2980113.html>

оролцсон иргэдийн 84% нь авлига тус улсад өргөн тархсан энгийн үзэгдэл болсон гэсэн хариулт өгчээ. Европын улс орнуудад уг үзүүлэлт 71% байна. Латви улсын иргэд төрийн байгууллагын зүгээс хийх худалдан авалт болон барилга, байгууламж барих зөвшөөрөл авах, улс төрийн намуудын үйл ажиллагаанд авлига илүү дэлгэрсэн гэж үзсэн байна.

Латви улсад хийсэн уг судалгаанд 1,002 иргэн хамрагдсан байна.

ЕХ-ны гишүүн орнуудын дунд төв болон зүүн өмнөд европчууд авлигыг хүлээн зөвшөөрөх байдал хамгийн өндөр байна¹⁷⁰

2020.06.14. ЕХ-нд 2004 оноос хойш нэгдсэн шинэ гишүүн орнууд (үүнд хуучин социалист орнууд бүгд багтдаг)-ын иргэдийн дунд төрийн захиргааны байгууллага болон төрийн үйлчилгээний байгууллагаас ямар нэгэн үйлчилгээ авахын тулд бэлэг өгөх эсвэл мөнгө өгөх нь байж болох зүйл гэж үзэх түвшин баруун европын иргэдийг бодвол өндөр байгааг Eurobarometer-ийн шинэ судалгаа харуулж байна.

Eurobarometer ЕХ-ны 27.5 мянган хүний дунд явуулсан судалгаанд үндэслэн авлигыг хүлээн зөвшөөрөх байдлын индексийг гаргажээ. Судалгааны дүнгээр, авлигыг хүлээн зөвшөөрөх байдал хамгийн өндөр улс Унгар байна. Тус улсаас судалгаанд оролцогчдын зөвхөн 38% нь албан тушаалтнуудад хахууль санал болгох хэлбэрийн авлигыг байж болохгүй зүйл гэж үзсэн байна.

Унгар улсын дараагаар Латви (39%), Чех (41%), Хорват (46%) жагссан байна. Харин авлигыг хүлээн зөвшөөрөх байдал хамгийн бага улсуудад Португал (88%), Финланд (83%), Испани (81%) оржээ.

Зүүн Европын гишүүн улсуудын хувьд Словени (73%), Польш (71%), Эстони (70%) авлигыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь ЕХ-ны гишүүн орнуудын дунджаас дээгүүр байв.

Бүс нутгийн хувьд харилцан адилгүй байгаа ч судалгаанд оролцогчдын дийлэнх нь авлигын ямар нэгэн үйлдлийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн хэвээр байна.

Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний байгууллагаас ямар нэгэн үйлчилгээ авахын тулд бэлэг өгөх, мөнгө өгөх нь байж болох зүйл гэж судалгаанд оролцогчдын дийлэнх нь үзсэн ЕХ-ны 2 улс нь Унгар, Словак болж байна.

Гэсэн хэдий ч 2017 оны 10 дугаар сарын судалгаанаас хойш авлигыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй гэж үзэж байсан хувь хэмжээ ЕХ-ны зүүн хэсгийн зарим улсын хувьд нэмэгдсэн байна.

Үүнтэй адилаар, Латви, Унгар, Чех улсаас санал асуулгад оролцогчдын дийлэнх нь төрийн захиргааны байгууллага, эсвэл төрийн албанаас ямар нэгэн үйлчилгээ авахын тулд бэлэг өгөхийг хүлээн зөвшөөрсөн байна. Дахин хэлэхэд, авлигыг хэзээ ч хүлээн зөвшөөрдөггүй гэж хариулсан хүмүүсийн хувь хэмжээ хэд хэдэн улсад буюу ялангуяа Польш, Словак, Латви зэрэг улсад нэмэгдсэн байна.

ЕХ-ны орнуудаас судалгаанд оролцогчдын 71% нь авлигыг өргөн тархсан гэж үзэж байгаа бөгөөд энэ нь 2017 оны судалгааны дүнгээс 3 пунктээр өссөн үзүүлэлт юм. Хорват улсаас судалгаанд оролцогчдын 97% нь авлигыг өргөн тархсан гэж хариулжээ.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 26% нь өдөр тутмын амьдралдаа авлигын асуудалд биечлэн өртдөг гэж хариулсан. Энэ үзүүлэлт Румынд хамгийн өндөр буюу 64% байжээ.

Авлига хамгийн өргөн тархсан ОХУ-ын 10 бүс нутгийн жагсаалтыг гаргажээ¹⁷¹

2020.06.19. ОХУ-ын Ерөнхий прокурорын газраас тус улсын авлига хамгийн өргөн тархсан бүс нутгийн жагсаалтыг гаргасан талаар РИА Новости агентлагаас мэдээлсэн байна.

¹⁷⁰ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.intellinews.com/central-and-southeast-europeans-have-highest-tolerance-for-corruption-among-eu-members-185354/?source=croatia>

¹⁷¹ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <http://www.volbusiness.ru/news-page/12837>

Дээрх мэдээлэлд дурдсанаар, 2019 онд ОХУ-д авлигын түвшин өссөн дүнтэй гарсан байна. Тухайлбал, өнгөрсөн онд 100 мянган хүнд ногдох авлигын гэмт хэргийн хувь 21.1 болсон ба 2018 онд уг үзүүлэлт 20.8% байжээ.

Авлига хамгийн өргөн тархсан бүс нутгийн жагсаалт:

- Мордовын Бүгд найрамдах улс;
- Чувашийн Бүгд найрамдах улс;
- Камчаткын хойг;
- Архангельск муж;
- Брянск муж;
- Магадан муж;
- Новгород муж;
- Оренбург муж;
- Саратов муж;
- Тюмень муж.

Дээр дурдсан бүс нутагт 100 мянган хүнд ногдох авлигын гэмт хэргийн хувь 26.31-29.68 байна.

Авлига бага тархсан бүс нутгууд:

- Ингушийн Бүгд найрамдах улс;
- Хакасын Бүгд найрамдах улс;
- Алтайн хязгаар;
- Вологода муж;
- Москва муж;
- Мурманск муж;
- Пензь муж;
- Санкт-Петербург хот;
- Севастополь хот;
- Ямало-Ненецийн өөртөө засах тойрог.

Эдгээр бүс нутагт авлигын гэмт хэргийн хувь 6.41-9.94 байна.

Ерөнхий прокурор Игорь Красновын танилцуулсан илтгэлд төсвийн хөрөнгийг зарцуулах, төрийн худалдан авах ажиллагаа, эд хөрөнгө захиран зарцуулах, хяналт шалгалт хийх, хууль хяналтын үйл ажиллагаа явуулах, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний үйл ажиллагаанд авлигатай холбоотой гэмт хэрэг түлхүү гарч байгаа талаар дурджээ.

ОХУ-д авлигын гэмт хэргийн түвшин 2 жил дараалан өссөн, худалдан авах ажиллагаатай холбоотой гэмт хэрэг 2 дахин, хахуулийн хэрэг 11%-аар тус тус нэмэгдсэн, түүнчлэн, авлигатай холбоотойгоор олсон албан тушаалтнуудын хөрөнгийн хэмжээ жилийн хугацаанд 70 дахин өсөж, 2019 онд 20 тэрбумаас давсан талаар Ерөнхий прокурор И.Краснов өмнө нь мэдээлж байсан юм.

Новосибирск мужид авлигын түвшин 60 хувиар өссөн байна¹⁷²

2020.07.16. Хууль сахиулагчдын үйлдэж буй авлигын хэргийн тоо огцом өсөж байгаа талаар Новосибирск мужийн Прокурорын газрын авлигатай тэмцэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналтын хэлтсийн дарга Павел Илык хэвлэлийн бага хурал дээр мэдэгдсэн байна.

Тэрээр тус мужид үйлдэгдэж байгаа авлигын гэмт хэргийн тоон мэдээ, үзүүлэлтийг хэвлэл, мэдээллийн ТАСС агентлагт гаргаж өгчээ.

Мөн “Хориглолт, хязгаарлалт хийсээр байхад авлигачдын хүрээ тэлсээр байна. Сүүлийн 6 сарын хугацаанд хахуулийн тоо 60 хувиар өссөн байна. Энэ нь хахууль авж буй этгээдтэй холбоотойгоор нэмэгдсэн. Бид авлигатай холбоотой 43 баримтыг илрүүлсэн” гэв.

Павел Илык дээр дурдсан тоон мэдээг өнгөрсөн оны авлигын гэмт хэргийн тоон үзүүлэлттэй харьцуулан гаргажээ. Авлигын хэргийн 90%-ийг хууль сахиулах байгууллагын албан хаагчид үйлдсэн байна. Холбооны шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтнууд шоронд хориглосон эд зүйлсийг оруулж, хариу төлбөр авсан тохиолдол гарсан.

Новосибирск мужийн Прокурорын газрын авлигатай тэмцэх, хууль тогтоомжийн хэрэгжилтийн хяналтын хэлтэс нь албан тушаалтнуудын албан үүргийн биелэлтэд хяналт тавих үүргийг хэрэгжүүлдэг. Хөрөнгө, орлогын мэдүүлгээ гаргаж өгөөгүй 481 ажилтанд сахилгын шийтгэл оногдуулсан байна.

Мальта улсын цахим казино гэмт хэргийн байгууллага болох Ндрангетагийн мөнгийг угаасан байж болзошгүй байна¹⁷³

2020.08.03. Европын хамгийн аюултай мафийн байгууллагын нэг болох Ндрангетагийн мөнгийг Мальта улсын цахим казино угааж байжээ. Мальта улсын мөрийтэй тоглоомын СенчюринБет компани Итали улсаас бэлэн мөнгө гаргаж, мөнгө угаах томоохон сүлжээ ашиглаж байсан тухай Италийн хуулийн байгууллагуудын эх сурвалжтай мэдээллийг Файнаншл Таймс нийтэлжээ. ЕХ-ноос санхүүждэг Европ дахь Хойд Африкийн дүрвэгсдийг хүлээж авах хамгийн том төвүүдийн нэгнийх нь сая сая евротой тэнцэх хөрөнгөөс Өмнөд Италийн гэмт бүлэглэл болох Ндрангета ашиг олдог байжээ. Энэхүү гэмт бүлэглэл нь Европ дахь зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүдийн дунд нөлөө бүхийд тооцогддог. Уг бүлэглэл нь Латин Америкийн хар тамхины картелиудтай хамтран хууль бус кокаины эргэлт, хууль бус зэвсгийн наймаа, мөнгө угаах, хүний амь хөнөөх зэрэг хэргүүдийг үйлдэж ирсэн.

Ингэхдээ Ваеркард гэх Панамын компаниар дамжуулан гүйлгээ хийдэг байсан байна. Ваеркард нь Мальта улсад 2017 он хүртэл буюу Мальтын засгийн газраас мөрийтэй тоглоомын үйл ажиллагааг зогсоох хүртэл СенчюринБет компанитай холбоотой ажиллаж байжээ. Тухайн үед Мальтад мафийн эсрэг арга хэмжээ авсны үр дүнд 68 хүнийг баривчилсан юм. Тэдгээрээс мафитай холбоотой 30 этгээдийг шийтгэсэн. СенчюринБет компанийн ашиг орлого Ваеркардын орлоготой харьцуулахад өчүүхэн хэсгийг эзлэх боловч Германы Ваеркард компанийн бизнесийн загварын талаар тодруулах шаардлага урган гарч байна. Тус компани мөнгө угаахтай тэмцэх үүднээс дүрэм журмын дагуу ажиллаж, тайлан, мэдээллээ зохих байгууллагад гаргаж байх ёстой юм.

ОХУ-д илрээгүй хахуулийн хэрэг гурав дахин өссөн байна¹⁷⁴

2020.08.08. 2020 оны эхний хагас жилийн байдлаар хахуулийн 780 гаруй хэрэг илрээгүй байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 200%-аар өссөн байна. Тус улсын Прокурорын ерөнхий газрын 2020 оны эхний хагас жилийн тайланд дурдагдсанаар, ОХУ-д хагас жилийн байдлаар

¹⁷² Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://novos.mk.ru/social/2020/07/16/korrupciya-v-novosibirskoy-oblasti-vyros-la-na-60.html>

¹⁷³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.ft.com/content/b3eb9a37-ed8a-4218-9064-685b181740f0>

¹⁷⁴ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.rbc.ru/society/08/08/2020/5f2e319b9a794729919876f5r>

хахуулийн илрээгүй хэрэг 3 дахин нэмэгдсэн гэжээ. Энэ оны эхний хагас жилийн байдлаар 8,503 хэрэг бүртгэгдсэн ба өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3.6 хувиар өсжээ. Үүнээс 6,749 хэрэгт урьдчилсан мөрдөн шалгах ажиллагаа явуулжээ.

2020 онд Украины үл хөдлөх хөрөнгийн салбар дахь авлигын түвшин өссөн байна¹⁷⁵

2020.08.31. Украинд жил бүр зохион байгуулдаг авлигын түвшний судалгаагаар барилгын салбар дахь барилга, байгууламжийн эхний үе шат буюу барилга барих зөвшөөрөл авах үйл ажиллагаан дахь авлигын түвшин 58.3%-аас 86.7% болж өссөн байна.

Дээрх дүгнэлтийг тус улсын Барилагчдын холбооны удирдах зөвлөлөөс явуулсан судалгаанаас гаргажээ.

Барилга байгууламжийг ашиглалтад хүлээлгэн өгөх шатны үйл ажиллагаанд авлигын түвшин 7 дахин буюу 60% болж өссөн байна.

Судалгааны үр дүнг бүс нутгаар үзвэл, нийслэл Киев хот 66.7%-аар нэгдүгээрт /2019 онд 58%/, Одесс хот 20%-аар хоёрдугаарт /2019 онд 8%/ орсон байна. Мөн энэ оны судалгаанд Львов хот, Полтав болон Киев муж, Борисполь хот, Черкасс муж 6.7%-ийн үзүүлэлтээр нэмэгдэж орсон байна.

Төрийн байгууллагаас авлигад хамгийн их өртсөн байгууллагаар архитектур, барилгын байгууллага 53.3%, нутгийн удирдлагын байгууллагууд 6.7%-тай байна.

Түүнчлэн байгууллагын дарга, удирдлагын түвшинд авлигын хэмжээ буурч 2019 онд 70% байснаас 53,3% болсон эерэг үнэлгээг гарчээ. Харин байгууллагын нэгж хэлтсийн дарга нарын хүрээнд авлигын түвшин хоёр дахин өссөн буюу 2019 онд 10% байснаас 20% болжээ.

Авлигад юу өгөхийг шаарддаг вэ?

Санал асуулгад оролцогчдын 80% нь “бэлэн мөнгө” гэсэн бол 13.3% нь барилга, байгууламжийн тодорхой м² талбайг үнэгүй өгөхийг шаарддаг гэсэн байна.

Судалгаанд оролцогчдын 53% нь хяналт шалгалт явуулдаг төрийн байгууллагын албан хаагчдын авлигын түвшин буурахгүй /2019 онд 50%/, 66.7% нь барилгын салбарын үйл ажиллагааны бүх шатанд эерэг өөрчлөлт гарахгүй гэж үзжээ.

Уг судалгаагаар ажил гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулах үйл ажиллагаанд авлигын түвшин буурч, 20% болсон, мөн мөнгөн шагнал авах /авлига, хахууль авах/-аас татгалзана гэж судалгаанд оролцогчдын 26.7 % нь үзсэн эерэг дүн гарсан байна.

Косовогийн засгийн газар Авлигатай тэмцэх ажлын хэсгийг татан буулгалаа¹⁷⁶

2020.10.20. 10 жилийн турш үйл ажиллагаа явуулсан Авлигатай тэмцэх ажлын хэсгийг Косовогийн засгийн газар 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдөр татан буулгалаа.

Ажлын хэсэг нь засгийн газраас хэтэрхий хараат тул үр дүнтэй ажиллах боломжгүй байсан бөгөөд тус ажлын хэсгийг татан буулгах шийдвэр нь эрх мэдлийн хуваарилалтыг сайжруулах зорилготой талаар засгийн газар мэдээлэв.

Авлигатай тэмцэх ажлын хэсэг нь нийт 30 албан хаагч болон даргын бүрэлдэхүүнтэй ажиллаж байсан бөгөөд Косовогийн Цагдаагийн газрын Мөрдөн шалгах газарт өөрсдийн үйл ажиллагааг тайлагнадаг байна.

Хууль зүйн сайд Селим Селими тухайн ажлын хэсгийг татан буулгах эсэх талаарх санал хураалтад санал өгөөгүй бөгөөд өөрийн цахим хуудсанд “...Бидэнд илүү сайн төлөвлөгөө

¹⁷⁵ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://delo.ua/business/v-2020-godu-korrupcija-v-sfere-nedvizhimosti-vyr-372198/>

¹⁷⁶ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://exit.al/en/2020/10/19/kosovo-government-ends-anti-corruption-task-force/>

хэрэгтэй... Мөн авлигын томоохон хэргүүдийг шалгах ажиллагаанд саад тотгор учруулах эрсдэл ч бий” хэмээн мэдэгджээ.

Косовогийн Хууль зүйн институт тус шийдвэрийг хяналт шалгалтын эсрэг хийж байгаа улс төрийн үйлдэл хэмээн тодорхойлжээ. Ажлын хэсэг нь 10 жилийн хугацаанд үйл ажиллагаа явуулахдаа хэд хэдэн томоохон авлигын хэргийг шалгаж шийдвэрлэсэн.

Косовод суугаа ЕХ-ны Хууль дээдлэх төлөөлөгчийн газар (ЕХХДТГ¹⁷⁷) тус алба авлигыг илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаанд чухал үүрэгтэй байсан талаар дүгнэжээ. Цаашлаад “Ажлын хэсэг нь улс төрд нөлөө бүхий, нэр хүндтэй хүмүүстэй хамааралтай томоохон авлигын хэргүүдээс гадна төрийн өмчийн хувьчлал, нийтэд зарласан тендер зэрэг улсын төсөвт 7 сая гаруй еврогийн хохирол учруулсан санхүүгийн ээдрээтэй хэргүүдийг илрүүлэн, мөрдөн шалгасан” тухай ЕХХДТГ-ын Хууль зүйн хяналт шалгалтын тайланд тусгасан байна.

Мөн тайланд дурдснаар, хэд хэдэн өндөр албан тушаалтнууд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан байна. Мөн “Зарим хэргийг мөрдөн шалгах ажиллагааны эхэн үед гацаах хандлага ажиглагдсан байна. Хэрэг нээх ажиллагааг Косовогийн Тусгай прокурорын газраас хуульд заасан эцсийн хугацаа хүртэл хойшлуулж байсан нь тухайн хэргийн мөрдөн шалгах ажиллагаанд санаатайгаар хүндрэл учруулж, гэмт хэргийг хөөн хэлэлцэх 2 жилийн хугацааг өнгөрөөх, эсхүл өөр төрлийн дарамт үзүүлэх сэдэлтэй байсан байж болзошгүй” гэжээ.

Косово дахь Авлигатай тэмцэх ажлын хэсгийн үйл ажиллагааг дэмжих нь авлигыг илрүүлэх, мөрдөн шалгахад онцгой ач холбогдолтой талаар ЕХХДТГ-ын тайланд тусгагдсан зөвлөмжид дурдсан байна.

Грекийн Авлигатай тэмцэх прокурорын газар татан буугдаж магадгүй¹⁷⁸



Грекийн Авлигатай тэмцэх прокурорын газрын прокурор Элэни Тулуपाки.

(Фото: Элэни Тулупакигийн зөвшөөрлөөр оссgr.org)

2020.10.24. Грекийн Авлигатай тэмцэх прокурорын газрын прокурор Элэни Тулупаки (Eleni Touloupaqi) ажлаасаа чөлөөлөгдөж магадгүй болжээ.

2019 оны 07 дугаар сард түүний идэвхтэй шалгаж байсан албан тушаалтны харьяалагдах улс төрийн нам засгийн эрх авснаас хойш Тулупаки ажлаа авж үлдэх хүндхэн даалгавартай тулгарчээ.

Хууль зүйн яамнаас 10 дугаар сарын 21-ний өдөр парламентад танилцуулсан хуулийн төсөлд түүний хамаарах газрыг татан буулгаж, Санхүүгийн гэмт хэргийн газраар орлуулах санал гаргасан байна. Шинээр байгуулагдах

Санхүүгийн гэмт хэргийн газар нь улс төрийн өндөр албан тушаалтнууд Новартис гэх Швейцарийн эмийн үйлдвэрээс хахууль авсан байж болзошгүй хэргийн мөрдөн шалгах ажиллагааг зогсоох болно гэж шүүмжлэгчид үзэж байна.

АНУ-д үйл ажиллагаа явуулдаг Новартис үйлдвэр нь 2019 онд Грекийн эрүүл мэндийн салбарын албан хаагчдад хууль бус мөнгөн гуйвуулга хийж, ГАУАТХ-ийг зөрчсөн хэргээр шалгагдаж, улмаар АНУ-ын Хууль зүйн яам болон Үнэт цаас, биржийн хороотой тохиролцон, 347 сая ам.долларын торгууль төлсөн байна.

Гэвч Тулупаки АНУ-ын эрх бүхий байгууллагатай хамтран тус гэмт хэрэгт Грекийн хоёр Ерөнхий сайд асан болон бусад албан тушаалтан холбогдсон байж болзошгүй үйлдлийг 2017 оноос хойш үргэлжлүүлэн шалгажээ.

¹⁷⁷ The European Union Rule of Law Mission

¹⁷⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.occrp.org/en/daily/13307-greece-s-top-anti-corruption-prosecutor-faces-removal>

Энэхүү авлигын хэргээс шалтгаалан Новартис үйлдвэр өөрсдийн эмийн бүтээгдэхүүнийг өндөр үнээр борлуулах, Грекийн эмийн зах зээлд давуу байдал олж авсан байж болзошгүй юм. Тухайн үед Грект санхүүгийн гүн хямрал тулгарсан бөгөөд тус авлигын хэргээс шалтгаалан 3.4 тэрбум еврогийн алдагдал хүлээсэн байна.

“Гүтгэлэг бол хулчгаруудын зэвсэг, тэдний гүтгэлэг надад нөлөөлөхгүй. Тэдгээр гүтгэгчид болон тэдний ард байгаа хүмүүс хууль ёсны өмнө хариуцлага хүлээнэ гэдэгт итгэлтэй байна” хэмээн тус хэрэгт шалгагдаж буй Ерөнхий сайд асан Антонис Самарас 2018 онд мэдэгдэж байв.

Тоулоупакийг эрх мэдлээ урвуулан ашигласан зэрэг үйлдэлд холбогдуулан прокуророос 2019 онд эрүүгийн хэрэг үүсгэжээ. Уг хэргийг хэрэгсэхгүй болгох хүсэлтийг тэрээр Афины Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх зөвлөлд хүргүүлсэн боловч хүсэлтийг хангахаас татгалзсан байна.

Өөрийн улсын шүүх түүнд ял оноох нь тодорхой болсон бөгөөд шударгаар шүүх хуралдаан хийх боломжгүй байна хэмээн Тулупаки Европын хүний эрхийн шүүхэд давж заалджээ.

Дээрх үйлдэл нь Новартис үйлдвэртэй холбоотой авлигын хэргийг шалгуулахгүй байх үйлдэл ба тэрээр одоо амь насандаа ихэд санаа зовох болсон талаар мэдээлэл хийсэн байна. Парламентаар хэлэлцүүлсэн хууль нь түүний олон жилийн турш хийсэн мөрдөн шалгах ажиллагааны төгсгөл байж болзошгүй гэдгийг түүний өмгөөлөгч Чирдарис мэдэгдсэн байна.

Мөн Чирдарис *“Авлигатай тэмцэх прокурорын газрыг Санхүүгийн гэмт хэрэгтэй нэгтгэж Санхүүгийн гэмт хэргийн газар байгуулах нь зөвхөн Тулупакийг төрийн албанаас чөлөөлөхөөс гадна авлигын гэмт хэргийг шалган шийдвэрлэх мэргэисэн албан хаагчдыг мөн чөлөөлж байгаа үйлдэл юм”* хэмээн мэдээлжээ.

Дэлхийн банк Герман улсын нэгэн үйлдвэрийн эзнийг залилан болон авлигын хэрэгт буруутгаж байна¹⁷⁹

2020.11.04. ДБ-наас Герман улсын усан хангамжийн тоног төхөөрөмж үйлдвэрлэгч компанийн гэрээг Мьянмар улсад хэрэгжүүлсэн төсөлтэй холбоотой залилангийн болон авлигын хэргээр 30 сарын хугацаатайгаар түдгэлзүүлжээ.

Харен хотод байрладаг Berky GmbH компани болон түүний 5 охин компани 30 сарын хугацаанд ДБ-ны санхүүжилттэй төслүүдэд оролцох эрхгүй болсон юм. ДБ-наас бүрэн санхүүжүүлсэн 100 сая долларын өртөгтэй уг төсөл нь Мьянмар улсын Айяарвади голын сав газар болон үндэсний усны нөөц, менежментийг сайжруулах зорилгоор хийгдсэн юм.

ДБ-наас мэдээлснээр Berky GmbH компани төслийн менежментийн хэлтсийн 3 албан тушаалтныг гэрээнд заасан тоног төхөөрөмжийг хүлээн авахад зүй бусаар нөлөөлөх зорилгоор Европ руу аялуулсан нь авлигын шинжтэй үйл ажиллагаа гэж үзжээ.

Герман улсын компани уг гэрээнээс ашиг хүртэх боломжийг нэмэгдүүлэх зорилгоор охин компанийнхаа нэрийг ашиглан 2 дахь гэрээг байгуулахаар ирүүлсэн бөгөөд энэ нь тохиролцсон асуудал байсан юм.

Мөн Мьянмарын орон нутгийн төлөөлөгчдөд анх төлсөн үнийн дүн болон гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулсны дараа төлсөн шимтгэлийг ил болгож чадаагүй нь залилангийн шинжтэй гэж ДБ мэдээлэв.

Украин дахь авлигын эсрэг тэмцэл Үндсэн хуулийн шинэ хямрал болж хувирав¹⁸⁰

2020.11.15. Өнгөрсөн жил олонх болж, авлигыг үндсээр нь устгах бүрэн эрхтэйгээр засгийн эрхийг авсан Ерөнхийлөгч Володимир Зеленский авлигын эсрэг тэмцэлд сөргөөр нөлөөлсөн хэд хэдэн шийдвэрийг гаргасан шүүгч нарыг албан тушаалаас нь буулгахыг парламентаас шаардсанаар улс орноо Үндсэн хуулийн хямралд оруулах эрсдлийг бий болгожээ.

¹⁷⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://fcpublog.com/2020/11/04/world-bank-debars-german-manufacturer-for-fraud-collusion-and-corruption/>

¹⁸⁰ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.geopoliticalmonitor.com/corruption-fight-devolves-into-a-new-constitutional-crisis-in-ukraine/>

Шүүхээс Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газар (АУСҮГ)-ын нийтийн албан тушаалтны хөрөнгө, орлогын мэдүүлгийг баталгаажуулах ажиллагаа, авлигатай тэмцэх томоохон шинэчлэлт болон зарим бүрэн эрхийг хүчингүй болгох шийдвэр гаргаснаар ОУВС-гийн чухал хэлэлцээрүүд болон ЕХ-ны визгүй зорчих нөхцөлийг эрсдэлд оруулсанд Украины удирдлагууд санаа зовж байна.



Үндсэн хуулийн шүүхийн энэхүү шийдвэрээс гадна Авлигатай тэмцэх үндэсний товчооны даргыг Ерөнхийлөгч томилсныг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн нь Украины авлигатай тэмцэх шинэчлэлд томоохон саад учруулжээ.

Ерөнхийлөгч Зеленски Үндсэн хуулийн шүүхийг татан буулгаж, шинэ шүүгчдийг сонгох, гаргасан зарим шийдвэрийг хүчингүй болгох хуулийн төслийг өнгөрсөн сард парламентад өргөн барьжээ. Энэхүү үйлдэл нь Үндсэн хуулийн хямрал бий болгож болзошгүй юм. Учир нь, Ерөнхийлөгч болон парламент Үндсэн хуулийн шүүхийн шүүгчийг татан буулгах, чөлөөлөх бүрэн эрхгүй билээ.

Украины Үндсэн хуулийн шүүхийн дарга тус хуулийн төсөл нь “*Үндсэн хуулийг зөрчсөн шинэ тэмдэг*” агуулсан бөгөөд дуулгавартай шүүх бий болгох зорилготойг дурджээ. Ерөнхий сайд асан Юлия Тимошенко энэхүү хуулийн төслийг Ерөнхийлөгчийн гарт эрх мэдлийг төвлөрүүлж, “*Төрийн эргэлт хийх*” зорилготой гэж мэдэгджээ. Улс төрийн сөрөг хүчин тус хуулийн төслийн эсрэг санал өгөх талаар мэдэгдсэн байна.

Шинэчлэл хийх үйл ажиллагаанд саад тотгор болж буй шүүхтэй Ерөнхийлөгч Зеленски нүүр тулахаар шийдсэн нь илт байна. Олон нийтийн дунд түүний нэр хүнд буурч байгаа энэ үед өөрийн эрх мэдлээ баталгаажуулж авах шаардлага түүнд тулгарчээ. Өнгөрсөн жил Ерөнхийлөгчийн сонгуульд ялалт байгуулснаас хойш олон иргэд түүний авлигатай тэмцэх үйл ажиллагаанд итгэл алдарсан бөгөөд орон нутгийн сонгуульд түүний нам тааруухан амжилт үзүүлсэн байна.

Ерөнхийлөгч Зеленскигийн хамгийн том сорилт нь Украины авлигын үндсэн шалтгааны нэг буюу улс төрчдийг хамгаалж буй шүүх засаглал өөрөө юм. Авлигын хэргийг шийдвэрлэх болон шүүхийн хязгаарлагдмал шинэчлэлийг эсэргүүцэж байгаа шүүхийн үйлдэл нь өөрсдийн бүрэн эрх, байр суурийг хэвээр авж үлдэхийг хүссэн, шүүх засаглалын албан хаагчдыг системтэйгээр гартаа оруулсан олигархууд болон чинээлэг хүмүүсийн хүсэл зориг юм.

Өнгөрсөн жил батлагдсан хууль нь шүүгчдийг томилох, чөлөөлөх үйл ажиллагааг илүү ил тод болгосон боловч зарим заалт нь хараат бус байдал, шүүхийн шинэтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй тухай шүүмжлэл дагуулж байна. Одоогоор Үндсэн хуулийн шүүх нь Ерөнхийлөгч Зеленскигийн овоо хараанд байгаа боловч үнэн хэрэгтээ шүүх засаглал нь өөрөө нэн яаралтай шинэчлэл хийх шаардлагатай, ихээхэн алдаа дутагдалтай байгаа юм.

Литва улсын иргэд эрүүл мэндийн салбар авлигад хамгийн их өртсөн гэж үзжээ¹⁸¹

2020.12.06. Литва улсад сүүлийн 6 жилд авлигын түвшин гурав дахин буурсан тухай Eurobarometer-ийн судалгаанд үндэслэн Мөрдөн шалгах тусгай алба (МШТА) мэдээлжээ.

Авлигын талаарх тус улсын иргэдийн ойлголт нь ЕХ-ны улсуудын дундаж түвшнээс дээгүүр байна.

МШТА-ны захирал Жидрунас Барткус “*Авлигатай тэмцэх талаарх олон нийтийн мэдлэгийг дээшлүүлэхдээ авлигын талаар мэдээлэл хүргэхээс айх бус, шударга үйлдлийн давуу тал, ашиг тусыг ойлгуулахын төлөө бид зүтгэх хэрэгтэй*” гэжээ.

Литва улсын нийт хүн амын 92% нь улсын хэмжээнд авлигын асуудал өргөн тархсан гэсэн бол 8% нь сүүлийн жилүүдэд авлигад өртсөн буюу гэрч болсон гэсэн судалгааны дүн гарчээ.

Авлига, хахууль, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдэл нь эрүүл мэндийн салбар, улс төрийн намууд, худалдан авах ажиллагаа, тендер сонгон шалгаруулах эрх бүхий албан тушаалтнуудын дунд өргөн тархсан гэж тус улсын иргэд үзжээ.

Иргэдийн дийлэнх нь эрүүл мэндийн салбарт авлигатай тулгарч байсан бөгөөд эрүүл мэндийн даатгалаас гадна эмч, сувилагч нарт нэмэлт төлбөр төлж, үнэтэй бэлэг өгдөг байна.

Эрүүл мэндийн байгууллага дахь албан бус төлбөрийг хахууль гэж үзэхгүй, харин үйлчилгээ үзүүлсний төлөө өгөх, авах ёстой зүйл гэж үздэг нь судалгааны дүнгээс харагдаж байна.

Тус улсын 3 хүн тутмын нэг нь эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлсний дараа эмчид талархах болон нэмэлт төлбөр төлөхийг хахууль гэж тооцдоггүй гэсэн судалгааны дүнгээс иргэдийн авлигын тухай ойлголт, мэдлэгт анхаарал хандуулах шаардлагатай талаар МШТА-ны мэдээлэлд дурджээ.

2021 оны 01 дүгээр сарын тойм: Ротенберг Путиныг аварч, Жириновский авлигын төлөө зогсож байна¹⁸²

2021.02.01. 2021 оны 01 дүгээр сарын авлигатай тэмцэх бодлого

Авлигатай тэмцэх чиглэлээр 01 дүгээр сард ОХУ-ын эрх баригчдын зохион байгуулсан үйл ажиллагаа нь авлигыг илчилсэн хүмүүстэй сөргөлдөх нөхцөл байдалд хүрчээ. Дмитрий Песков болон Владимир Путин нар Алексей Навальныйгийн зүгээс мэдээлсэн ордон харшийн асуудлыг няцаав. Үүссэн таагүй нөхцөл байдлын үед Ерөнхийлөгчийн ойрын хүрээлэлд тооцогдох тэрбумтан Аркадий Ротенберг 100 тэрбумаар үнэлэгдэх уг үл хөдлөх хөрөнгө өөрийх нь өмч бөгөөд ордон биш, зочид буудал гэж мэдэгдсэн байна. Энэ эгзэгтэй үед Владимир Жириновский тус улсын Дум нь өөрөө хууль зөрчигчдөд уучлал үзүүлдэг учраас Орос орон авлигагүй байх боломжгүй. Манай улс АТИ-ээр Африкийн орнуудын түвшинд байна гэж мэдэгдлээ. ПАСМИ-аас сар тутам тоймлон хүргэдэг дараах нийтлэлээс эдгээр болон бусад үйл явдлын талаар үзнэ үү.

1. “*Байхгүй, хэзээ ч байгаагүй*”: Путин Геленжик дэх ордон тойрсон шуугиантай холбоотой мэдэгдэл хийв

ОХУ-ын Ерөнхийлөгчтэй цахимаар хийсэн уулзалтын үеэр нэгэн оюутан Геленжик дэх ордонтой холбоотойгоор үүссэн Алексей Навальныйгийн гаргасан баримтын талаар Владимир Путинээс асуулт асуусан байна.

Улсын тэргүүн Навальныйгийн түүний өмч гэж тодорхойлсон нэг ч зүйл өөрт нь болон ойр дотны хэн нэгэнд нь байхгүй гэдгийг “*байхгүй, хэзээ ч байгаагүй*” хэмээн мэдэгдэв.

¹⁸¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://lt.sputniknews.ru/society/20201206/13877065/Zhiteli-Litvy-schitayut-meditsinu-odnoy-iz-samykh-korrumpirovannykh-sfer-v-strane.html>

¹⁸² Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://pasmi.ru/archive/299049/>

Тэрээр цаг зав бага тул уг мэдээллийн баримттай бүрэн танилцаж чадаагүй бөгөөд туслахууд нь түүнд хэсэгчилсэн байдлаар үзүүлсэн гэдгээ хэлжээ. Үзэгчдийн тархийг угаах зорилготой, эвлүүлж хийсэн кино байсан, *“Уйтгартай зүйл, залуусаа”* хэмээсэн байна.

Түүнчлэн төрийн тэргүүн орд харштай холбоотой хэл ярианаас гадна усан үзмийн тариалангийн талаар тайлбар хийжээ. Тэрээр ашиг олох зорилгогүйгээр усан үзэм дуртайяа тариалах байсан гэжээ.

Авлигатай тэмцэх сан /ОХУ-д гадаадын тагнуулын алба гэж хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага/-гаас өнгөрсөн долоо хоногт гарсан баримтад Путин Геленжик цайз дахь ордноо төрийн болон хувийн компаниудын хөрөнгө мөнгөөр босгосон гэж баталсан байна. Сан нийт зардлыг нь 100 тэрбум рублиэр үнэлжээ.

Ерөнхийлөгч Путины нарийн бичгийн дарга Дмитрий Песков Алексей Навалныйг “луйварчин”, түүний үүсгэн байгуулсан “Авлигатай тэмцэх сан”-гийн хандивын хөрөнгийг “луйвар” хэмээн мэдэгджээ. Кремлийн хэвлэлийн төлөөлөгчийн хэлж буйгаар, *“байхгүй өмчийг Путинд эзэмшүүлж байгаа”* аж.

2. Эзэн тодров: Аркадий Ротенберг өөрийгөө “Путины ордон”-ы эзэмшигч гэдгийг зарлалаа

Оросын тэрбумтан Аркадий Ротенберг өөрийгөө Геленжик дэх ордны эзэмшигч хэмээн нэрлэжээ. Ерөнхийлөгч Владимир Путины хамтрагч асан тэрээр Навалныйгийн зүгээс Путины өмч гэж тодорхойлсон нэг ч зүйл өөрт нь болон ойр дотны хэн нэгэнд нь байхгүй гэдгээ *“байхгүй, хэзээ ч байгаагүй”* хэмээн улсын тэргүүн олон нийтэд мэдээлсний дараа дээрх мэдэгдлийг хийжээ.

Аркадий Ротенберг Авлигатай тэмцэх сангаас баримт дэлгэсэнтэй холбогдуулан Хар тэнгис дэх үл хөдлөх хөрөнгөө удахгүй цэгцлэнэ хэмээн мэдэгдэж, *“Цэвэр хүний хүчин зүйл. Энэ талаар шуугиан дэгдээд байна”* хэмээн Mash Telegram сувагт өгсөн ярилцлагадаа онцолжээ.

“Зээлдүүлэгчид олон байсан ч би эзэмшигч нь болж чадсан. Энэ бол олз. Сайхан ч газар” хэмээн Идокопас хошуунд байрлах үл хөдлөх хөрөнгөө худалдаж авсан талаар тэрбумтан ярьжээ. Уг үл хөдлөх хөрөнгийг хэзээ өөрийн болгосон талаар тодорхой хэлээгүй байна.

Тэрээр уг газрыг апарта-зочид буудал болгохоор төлөвлөж байгаа бөгөөд 2 жилийн дараа барилгын ажил дуусна гэжээ.

3. Авлигыг олон ангит кино болгож хувиргав: Засгийн газар албан тушаалтнууддаа хариуцлага тооцуулахаас татгалзаж байна

Төрийн Думын Зөвлөл 01 дүгээр сарын 18-ны өдөр засгийн газрын кабинетаас боловсруулсан авлига, ашиг сонирхлын зөрчил гаргасан төрийн албан хаагчид, парламентын гишүүд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүд болон бусад эрх бүхий албан тушаалтнуудыг хариуцлагаас чөлөөлөх хуулийн төслийг хэлэлцэхээр хуралдсан байна.

Мөрдөн шалгах ажиллагааны явцад тухайн этгээдээс хамааралгүй нөхцөл байдлын улмаас хуулийн хориглолт хязгаарлалтыг зөрчсөн нь тогтоогдсон тохиолдолд хариуцлага тооцуулахаас татгалзаж болох юм. Тухайлбал, үүнд байгалийн гамшиг, гал түймэр, тахал, дайн, алан хядах үйл ажиллагаа, төрийн байгууллагуудын хязгаарлалтын арга хэмжээ, ажил хаялт гэх мэт нөхцөлийг багтаасан байна. Эрх бүхий хариуцсан албан тушаалтан өөртэй нь хамаарал бүхий этгээд гэдгийг мэдэлгүйгээр албан тушаалд орсон тохиолдолд хуулийн дээрх заалтыг хэрэглэж болно гэж хууль санаачилагчид үзэж байна.

Өнгөрсөн оны 12 дугаар сарын дундуур нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг өргөн барьсан боловч хойшлуулах санаачилга гарсантай холбоотойгоор Думын Авлигын эсрэг хорооны хуралдаан намрын чуулганаар хэлэлцээгүй байна. Энэ 03 дугаар сард хэлэлцэнэ гэсэн хүлээлттэй байна. Тайлбар бичигт Авлигын эсрэг үндэсний төлөвлөгөөний дагуу баримтыг боловсруулсан хэмээн Коммерсант-д дурджээ.

“Давагдашгүй хүчин зүйл, нөхцөл байдал” гэдгийг Албаны үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмыг хэрэгжүүлэх хороо тогтоох аж. Эрх баригчдын төлөөлөл *“давагдашгүй нөхцөл байдал”* дууссан өдрөөс хойш сарын дотор авлигатай тэмцэх хэвийн үйл ажиллагааг баталгаажуулах үүрэгтэй байна.

ТИ байгууллагаас үүнийг “хэвийн, ухаалаг” гэж үзэж болох ч уг нөхцөл бодит байдалд ямар байгаа талаар байнга хянах хяналт байхгүй гэж тэмдэглэжээ.

4. Жириновский авлигыг “Удирдлагын арга” хэмээн зөвтгөв

Хяналттай байхын зэрэгцээ авлигажсан байх нь хүн амыг үр дүнтэй удирдахад зайлшгүй шаардлагатай гэж Оросын Либерал ардчилсан нам /ЛДПР/-ын дарга Владимир Жириновский мэдэгдэв.

Бүхэлд нь хяналт тавих, эсхүл хяналтыг үгүй хийж, хүссэн бүхэнд боломж олгох хоёрын аль нь илүү сайн болох нь улс төрчийн хувьд тодорхойгүй байна. Эхний тохиолдлын хувьд “Оросын эсрэг баримт материал бага байгаа” гэж тэрээр мэдэгдэв.

Хяналтгүй, авлигагүй байх бололцоогүй бөгөөд энэ бол хүмүүсийг удирдах арга мөн гэсэн санааг намын тэргүүн санал болгожээ. Хэрэв энэ мэт аргыг хэрэглэхгүй бол түүний үзэж буйгаар оросууд нэг нэгнээ хөнөөж эхлэх аж хэмээн Регнум агентлаг мэдээлсэн байна.

Владимир Жириновский 2024 онд болох Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөхөөр төлөвлөж байгаа талаараа өнгөрсөн оны намар зарласан. Социологийн санал асуулгын дүнгээр тэрээр өндөр рейтингтэй улстөрчдийн хоёрдугаарт бичигдсэн байна.

Кипр улсад өрнөж буй авлига, цар тахлын хөл хорионы эсрэг жагсаалын үеэр мөргөлдөөн үүсэв¹⁸³

2021.02.14. Авлига болон КОВИД-19 цар тахлын хөл хорионы эсрэг жагсаалын үеэр цагдаа болон жагсагчдын хооронд мөргөлдөөн үүссэн талаар гэрчүүд мэдээлэв.

Улсын нийслэл Никосиа хотод олон зуун жагсагчдыг тараах зорилгоор цагдаагийн албан хаагчид ус шүршигч, нулимс асгаруулагч ашигласан талаар Ройтерс агентлагийн гэрчүүд мөн мэдээлсэн байна.

Мөргөлдөөний үеэр нэг жагсагч цагдаагийн албан хаагчид толгойн тус газраа цохиулсны улмаас бэртэл авж эмнэлэгт хүргэгдсэн байна.

Кипр улсын төрийн өндөр албан тушаалтан өмнө нь гэмт хэрэг үйлдэж байсан бүртгэлтэй БНХАУ-ын хөрөнгө оруулагчид паспорт олгохыг нууцаар санал болгосон бичлэг шуугиан дэгдээгээд байсан юм. Тус улсад хөрөнгө оруулагчид иргэншил олгох хөтөлбөр хэрэгжиж байсан бөгөөд 2020 оны 11 дүгээр сард буюу энэхүү бичлэг нийтэд цацагдсаны дараагаар тухайн хөтөлбөрийг цуцалсан байна.

Үүний дараа хууль бусаар иргэншил олгож байсан гэмт хэргийн сүлжээг таслан зогсоосон боловч ард иргэдийн дунд тус мэдээлэлтэй холбогдолтой дургуйцэл үргэлжилсэн хэвээр байна. Энэхүү гэмт хэргийн сүлжээнд холбогдуулан улс төрийн сөрөг хүчин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ард иргэд цахим сүлжээнд тус улсын авлигын нөхцөл байдлын талаар өөрсдийн санал бодлыг илэрхийлжээ.

Кипр улсын хуваагдлыг илэрхийлж “Хуваагдал болон авлига нь салшгүй юм” хэмээн бичсэн самбарыг нэгэн жагсагч өргөсөн байсан бөгөөд мөн нэг жагсагч “Энэ бол капитализм” гэж бичсэн самбарыг тус улсын паспортын зурагтай хамт өргөсөн байжээ.

Кипр улсад эсэргүүцлийн жагсаалын үед хүч хэрэглэх нь тун ховор үзэгдэл байдаг байна. Эрх баригчид цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан иргэдийг олноор цугларахыг хориглосон бөгөөд зайлшгүй шаардлагаар өдөрт хоёр удаа гэрээсээ гарах боломжтой байгаа юм.

¹⁸³ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.reuters.com/article/us-cyprus-protests-idUSKBN2AD0IO>

Авлигын гүтгэлэг вакцин худалдан авах
ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн талаар
Украины сайд мэдээлэв¹⁸⁴

2021.02.17. Авлигын гэмт хэрэгт холбогдуулан гүтгэснээс шалтгаалан Эрүүл мэндийн яамыг эрх бүхий байгууллагаас мөрдөн шалгасан бөгөөд энэ нь тус улсын КОВИД-19 цар тахлын эсрэг вакцин худалдан авах ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн талаар Эрүүл мэндийн сайд 02 дугаар сарын 16-ны өдөр мэдэгджээ.

БНХАУ-ын Синовак вакциныг зуучлагч импортлогч Лехимаар дамжуулан худалдан авж буй Эрүүл мэндийн яамны үйл ажиллагаанд Авлигатай тэмцэх үндэсний товчоо (АТҮТ) мөрдөн шалгах ажиллагаа явуулсан бөгөөд Эрүүл мэндийн сайд Максим Степанов өөрийгөө гэм буруугүй талаар нийтэд зарлажээ.

Украин улсын вакцин худалдан авах ажиллагаа нь ЕХ-ны ихэнх улс орнуудаас хоцорч байгаа бөгөөд одоогоор ард иргэдийг вакцинжуулах ажиллагаа эхлээгүй байгаа юм.

Эрүүл мэндийн сайд Степановын хэлснээр авлигын гэмт хэрэгт холбогдуулан гүтгэж байгаа нь улс оронд ихээхэн сөрөг үр дагавар бий болгож байгаа юм.

“Хуурамч гүтгэлэг, мэдээллээс шалтгаалан бид вакцин үйлдвэрлэгч байгууллагатай хамтран ажиллахад хүндрэл бэрхшээл үүсч байна” хэмээн Эрүүл мэндийн сайд мэдээлжээ.

Тэрээр мөн энэхүү авлигын гэмт хэргийн талаар гүтгэлэг, худал мэдээлэл нь Украин улсын вакцинжуулалтын үйл ажиллагааг тасалдуулж, ОХУ-аас Спутник V вакцин худалдан авахаас өөр аргагүйд хүргэх ажиллагаа болох талаар мэдэгдсэн байна. Украины эрх баригчид ОХУ-ын Спутник V вакциныг худалдан авахаас татгалзаад байгаа юм.

Гэвч мөрдөн шалгах ажиллагаа нь вакцин худалдан авах ажиллагаанд сөрөг нөлөө учруулахгүй талаар АТҮТ мэдээлжээ. *“Одоогийн байдлаар мөрдөгчид вакцин худалдан авах ажиллагаанд саад учруулж болзошгүй ямар нэгэн ажиллагаа явуулаагүй. Мөн нийгмийн бүхий л салбарт хууль зөрчсөн байж болзошгүй үйлдлийн баримт мэдээллийг АТҮТ үргэлжлүүлэн шалгах болно”* хэмээн 2 дугаар сарын 16-ны өдөр тус газраас мэдэгдсэн байна.

Украины худалдан авж буй Синовак вакцины тээвэрлэлт 04 дүгээр сар хүртэл хойшилж болзошгүй талаар Ройтерс агентлаг өнгөрсөн долоо хоногт мэдээлсэн юм.

2020 онд Петербург хотод хахуулийн
дундаж хэмжээ 300 мянган рубльд хүрчээ¹⁸⁵

2021.03.19. Петербург хотод өнгөрсөн жил хахуулийн 250 гаруй баримт тогтоогдсон талаар ОХУ-ын Дотоод хэргийн яамны Петербург, Ленинград муж хариуцсан даргын үүрэг гүйцэтгэгч Дмитрий Баранов хотын парламентын тайлангийн үеэр мэдээлсэн байна.

“Санкт-Петербург хотод хахуулийн дундаж хэмжээ 2020 онд 287 мянган рубль болсон” гэж Баранов мэдэгдэв.

Энэ нь 2018 онд албан тушаалтанд хахуульд санал болгож байсан 104 мянган рубль /дунджаар/-ээс даруй гурав дахин их байгаа юм.

“Хэрэв хахууль энэ мэт өссөөр байвал дэг журмыг чангатгах шаардлага үүсэх бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд улам хэцүү болно. Энэ бол дэг журам ямар байгаагийн илэрхийлэл юм” хэмээн Баранов хэлжээ.

Тус хотод өнгөрсөн жилд авлигын 488 хэрэг бүртгэгдсэн байна.

¹⁸⁴ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.euractiv.com/section/europe-s-east/news/ukrainian-minister-says-corruption-accusations-hit-vaccine-procurement/>

¹⁸⁵ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/3217688.html>

Украинд Спутник V вакцин үйлдвэрлэхгүй
байгаагийн шалтгаан нь эрх баригчдын
түвшин дэх авлига гэж мэргэжилтнүүд
дүгнэжээ¹⁸⁶

2021.03.22. Украин өдөрт 700,000 тун Спутник V вакцин үйлдэрлэх боломжтой гэж мэргэжилтнүүд үзэж байна.

Чанаргүй Covishield вакцин худалдан авах гэрээнд Украины нэгдүгээр хүн “хувь нэмэр” оруулсан нь эргэлзээгүй. Украины Эрүүл мэндийн сайд Максим Степановын зүгээс Covishield вакцин нь судасны бөглөрөл бий болгодог нь албан ёсоор нотлогдвол тус улс уг вакцинаас татгалзахад бэлэн байна гэсэн мэдэгдэлд улс төр судлаач Вячеслав Азаров facebook-ээр дамжуулан дараах тайлбарыг хийжээ.

“Судасны бөглөрөл үүсгэдэг нь албан ёсоор нотлогдсон тохиолдолд Украин Covishield вакцинаас татгалзана хэмээн Эрүүл мэндийн сайд М.Степанов мэдэгдлээ. Татгалзана гэдгийг юу гэж ойлгох вэ, бараа худалдан авахад туслалцаа үзүүлсэн зуучлагч компанид төлсөн хөлсийг буцаан олгохыг Энэтхэгийн үйлдвэрлэгч компаниас шаардана гэсэн үг үү? Улсын нэгдүгээр хүн гэрээнд хувь нэмрээ оруулж, үүн дээр муугүй ажилласан гэдэгт эргэлзэх зүйл алга” хэмээн улс төр судлаач тэмдэглэжээ.

“Цар тахлын дэглэм өөрчлөгдөхөд уг луйвар мөрдөн шалгах ажиллагааны эхний объект болно. Украинд хийж буй цар тахалтай тэмцэх кампанит ажил, Ковид сан болон томоохон барилга байгууламжийн хөрөнгийн зарцуулалт бүгд үүнд хамаарна” гэсэн таамаглалыг В.Азаров гаргажээ.

Түүнчлэн, улс төрийн тоймч Семен Правденко Зеленский тэргүүтэй Украины эрх баригчдыг “элэг нэгтэй, ердийн нэг зуучлагчид” хэмээн нэрлэжээ.

“Зеленский болон түүний багийг ердийн нэг зуучлагчид гэдгийг ойлгоход бүх зүйл тодорхой болно. Барууны эм ханган нийлүүлэгч компаниудын сонирхол юунд байгаа вэ? Дэлхийн түүхий эдийн зах зээлийг дангаар ноёрхож, өрсөлдөгч оруулахгүй байхад оршино” хэмээн сэтгүүлч тайлбарласан байна.

Амьдралын төлөө-Сөрөг хүчний платформ намын дарга Виктор Медведчукийн санал болгосноор Зеленский тэргүүтэй удирдлагууд тус улсад Спутник V вакцин үйлдвэрлэхийг зөвшөөрөхгүй байгаа нь барууны вакцин үйлдвэрлэгчдийн эрх ашигт нийцүүлж буй үйлдэл хэмээн улс төрийн тоймч С.Правденко мэдээлжээ.

“Энэ бол барууны эм ханган нийлүүлэгч компаниудын эрх ашигт үйлчилж байгаа Медведчук Путин нарын тохиролцоо бөгөөд Украинд Спутник V вакцин үйлдвэрлэх боломжийг хэзээ ч олгохгүй” гэж сэтгүүлч бичсэн байна.

Харьков хотод байрлах Биолек үйлдвэрт сард 700 мянга орчим тун Спутник V үйлдвэрлэх бололцоотой бөгөөд зөвшөөрөл, технологи шилжүүлэх зэрэг бүх асуудлыг Медведчук шийдвэрлэсэн болохыг тоймч С.Правденко дурджээ.

“Украинд өнөөдөр ч Спутник V вакциныг Харьков дах Биолек үйлдвэрт үйлдвэрлэх боломжтой, технологи, зөвшөөрөл, түүхий эд бүгд шийдвэрлэгдсэн. Энэ юу гэсэн үг вэ? Үнэндээ, Pfizer, AstraZeneca, Moderna тэргүүтэй үйлдвэрлэгчдэд өрсөлдөгч огтоос хэрэггүй. Иймд тэд засаг төрийн эрхэд гарсан зуучлагчдаараа дамжуулан Украинд вакцин үйлдвэрлэх боломжийг хааж байна” хэмээн улс төрийн тоймч Семен Правденко дүгнэжээ.

Болгарын парламентын сонгууль
европчуудад хамаатай, учир нь¹⁸⁷

2021.04.01. Болгарт коронавирусний халдвар ихсэж, улмаар олон сарын турш үргэлжилж буй засгийн газрын эсрэг иргэдийн жагсаалын эцэст тус улсын парламентын сонгууль ням гарагт

¹⁸⁶ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.capital.ua/ru/news/153626-korrupsiya-vo-vlasti-istinnaya-prichina-pochemu-zelenskiy-co-ne-dayut-proizvodit-v-ukraine-sputnik-v-kak-predlagaet-medvedchuk-eksperty>

¹⁸⁷ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.euronews.com/2021/04/01/bulgaria-s-general-election-matters-for-europeans-here-s-why>

болох бөгөөд иргэд энэхүү сонгуульд санал өгөхөөр бэлдэж байна. Одоогоор тус улсын Ерөнхий сайд Бойко Борисовын тэргүүлдэг, баруун-төвийн үзэлт Болгарын Европын хөгжлийн төлөөх иргэд нам (БЕХТИН) олон нийтийн санал асуулгаар тэргүүлсэн хэвээр байна. europeelects.eu үндэсний санал асуулгын 2021 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн дүнгээс харвал, 3 удаа сонгогдоод байгаа одоогийн Ерөнхий сайд 28.4 хувиар тэргүүлжээ.

Харин лхагва гарагт явуулсан шинэ санал асуулгаар Корнелия Нинова тэргүүтэй социалист сөрөг хүчин (Болгарын социалист нам) 22.9%-аар санал асуулгыг удаалж байна. Нөгөөтээгүүр, тус улсын сонгуулийн түүхэнд анх удаа олон нам, тэр тусмаа жижиг намуудын төлөөлөл сонгогдох магадлал өндөр хэмээн ажиглагчид үзэж байна.

Санал асуулгын дүнд урьдчилсан байдлаар таамаглахад, энэ удаагийн сонгууль тус улсад тодорхойгүй үр дүн гаргах эрсдэл өндөр байгаагийн зэрэгцээ эвслийн хэд хэдэн хувилбар гарах магадлалтай, мөн сонгууль ямар нэгэн байдлаар бэрхшээлтэй тулгарч, улс төрийн мухардалд хүрвэл сонгуулийг намар дахин явуулахад хүргэж болзошгүй байна.

Хэдийгээр Болгар 7 сая хүн амтай Балканы хойгт орших жижиг улс боловч ЕХ-ны хамгийн хөгжил буурай орон бөгөөд олон улсын тавцанд тус улсын талаарх мэдээлэл төдийлөн их байдаггүй. Гэсэн хэдий ч европчууд Болгарын сонгуульд анхаарал хандуулах ёстой хэд хэдэн шалтгаан бий. Тухайлбал, хууль дээдлэх, шударга хуулийн засаглалыг хамгаалах, цаашлаад Умард Македонтой нэгдэх талаар нээлттэй яриа хэлцэл өрнүүлэх, түүнчлэн Балканд нүүрлээд байгаа цар тахлын хүнд хэцүү цаг үеийг даван туулах, халдварыг зогсоох зэрэг яаралтай авах арга хэмжээ их байгаа юм.

Түүнчлэн тус улсад нүүрлээд байгаа бас нэгэн хүндрэлтэй асуудал нь авлига юм. Авлигын эсрэг үйл ажиллагаа явуулдаг ТИ байгууллагаас гаргадаг АТИ-ээр Болгар улс ЕХ-ны гишүүн 27 орноос “хамгийн их авлигад өртсөн” оронд тооцогдож байгаа. Тодруулбал, өнгөрсөн зунаас эхэлсэн мянга мянган болгарчууд хэдэн сарын турш өдөр бүр зохион байгуулагдсан жагсаал цуглааны гол үндэс нь тус улсад авлига улам бүр гүнзгийрэн, тархаж байгаагаас улс орны хууль дээдлэх ёс доройтож, ард иргэдийн амьдрал ахуй өдрөөс өдөрт муудаж буйтай холбоотой юм.

Жагсагчид одоогийн Ерөнхий сайд Борисовын тэргүүлж буй засгийн газар, мөн улсын Ерөнхий прокурор Иван Гешев нарыг тус улсыг бүхэлд нь хяналтдаа авах боломжийг олигарх бүлэглэлд олгосон гэсэн үндэслэлээр даруй огцрохыг уриалж буй ажээ. Эсэргүүцэгчид мөн 2009 оноос хойш Болгарын засгийн эрхийг барьж байгаа Борисовын засаглалын хэв маягаас залхаж буйгаа мэдэгдээд байна.

2021 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг:

Путин ямар хэмжээний цалин авдаг болон хамгийн баян албан тушаалтан хэн бэ?¹⁸⁸

2021.04.16. Кремль болон засгийн газрын албан тушаалтнууд өнгөрсөн жилийн хөрөнгө, орлогын мэдүүлгээ мэдүүлэв. Хэн хамгийн их цалин авдаг вэ?

- ОХУ-ын Ерөнхийлөгч Владимир Путины өнгөрсөн оны орлого 9.99 сая рубль байсан бөгөөд энэ нь 2019 онд мэдүүлж байсан 9.72 сая рублиэс 270 орчим мянган рублиэр илүү байна. Мэдүүлэг дэх түүний өмчлөлд бүртгэлтэй хөрөнгийн хэмжээ өнгөрөгч нэг жилийн хугацаанд өөрчлөгдөөгүй, 77 м² талбай бүхий байр, 18 м² гараж болон ГАЗ М21, Нива төрлийн тээврийн хэрэгсэлтэй байна.

Засгийн газар

- Путинтай харьцуулахад тус улсын Ерөнхий сайд Михаил Мишустины орлого 19.8 сая рубль байгаа нь 2019 онд мэдүүлж байсан 18.2 сая рублиэс 1.6 сая рублиэр нэмэгдсэн байна.

Мэдүүлэг дэх түүний хөрөнгийн хэмжээ өмнөх оныхтой мөн адил ашиглах эрх бүхий 5,500 м² хэмжээтэй газар, 861 м², 141 м² талбайтай орон сууцтай байна. Мэдүүлэгтэй гэр

¹⁸⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.forbes.ru/newsroom/obshchestvo/426523-deklaracii-2021-skolkto-zarabotal-putin-i-kto-stal-samym-bogatym>

бүлийн гишүүд болох эхнэр, хүүгийн хөрөнгө, орлогыг мэдүүлсэн бөгөөд Ерөнхий сайдын эхнэрийн өнгөрсөн оны орлого 63.9 сая рубль байна.

- Засгийн газрын бүрэлдэхүүн дэх хамгийн өндөр орлоготой албан тушаалтнаар Үйлдвэр, худалдааны сайд Дэнис Мантуров нэрлэгджээ. 2020 оны мэдүүлэгт түүний орлого 740.4 сая рубль байгаа нь өмнөх оноос 145 сая рублиэр нэмэгджээ. Гэр бүлийн хүний орлого мөн нэмэгдэж 9.1 сая байснаас 13.6 сая рубль болж өсжээ. Орлогын нийт хэмжээ нь өмнөх оноос 595.2 сая рублиэс 754 сая рубль болж өссөн байна.

Тэрээр өмнөх мэдүүлгийн тээврийн хэрэгсэл хэсэгт Land Rover, Lada Vesta, Москвич 408 загварын 3 тээврийн хэрэгсэл мэдүүлж байсан бол өнгөрсөн оны мэдүүлэгтээ Lada Vesta-гаас гадна шинэ Tesla Model X загварын автомашинаа бүртгүүлжээ. Москвич 408 загварын тээврийн хэрэгслээ төрөл садангийн хүндээ шилжүүлсэн талаар Үйлдвэр, худалдааны яамны Интерфакс эх сурвалжаас мэдээлсэн байна. Сайд машины хэрэгцээгээ үндэсний үйлдвэрийн Augus загварын албаны машинаараа хангадаг талаар яамны хэвлэл мэдээллийн албанаас мэдээлжээ. Мантуровын үл хөдлөх хөрөнгийн жагсаалтад 4 газар, орон сууц, зочин хүлээн авах байр, автомашины 4 гараж орсон байна. Тэрээр хөрөнгө, орлогынхоо талаар “*Надад нуух зүйл байхгүй*” гэжээ.

- Засгийн газрын бүрэлдэхүүнээс хөрөнгө, орлогын хэмжээгээрээ 2 дугаарт Зам, тээврийн сайд Виталий Савельев бичигдсэн бөгөөд тэрээр 2020 оны 11 дүгээр сард уг албан тушаалд томилогдсон байна.

Нислэгийн Аэрофлот компанийн тэргүүнээр ажиллаж байсан тэрээр мэдүүлэгтээ өөрийн орлого 359.4 сая рубль, 6 газар, 5 хувийн байшин, 3 орон сууц, бусад барилга байгууламж болон BMW, Bentley загварын тээврийн хэрэгсэл мэдүүлжээ. Савельевийн эхнэрийн орлого 35.6 сая рубль бөгөөд түүний эзэмшилд 3 газар, 2 хувийн байшин, 4 орон сууц, 2 гараж, Mercedes Benz загварын 2 машин багтаж байна.

Ерөнхийлөгчийн Тамгын газар

- Ерөнхийлөгчийн Тамгын газрын хамгийн их орлоготой албан тушаалтнаар Ерөнхийлөгчийн туслах Игорь Левитин тодорсон бөгөөд түүний орлого 43 сая рубль байгаа нь өмнөх оноос 17.6 сая рублиэр их байна.
- Ерөнхийлөгчийн Тамгын газрын албан тушаалтнуудын гэр бүлийн гишүүний орлогоор 1 дүгээрт Ерөнхийлөгчийн Хэвлэл мэдээллийн албаны дарга Дмитрий Песков бичигджээ. Тэрээр мэдүүлэгтээ өөрийн болон эхнэр олимпын аварга Татьяна Навкагийн нийт орлогыг 225.4 сая рубль гэж мэдүүлсэн бөгөөд үүнээс эхнэр Татьянагийн орлого 212.8 сая рубль байгаа нь нөхрөөсөө 17 дахин их орлоготой байна.
- ОХУ-ын Ерөнхий сайд асан, Аюлгүйн зөвлөлийн орлогч дарга Дмитрий Медведевийн орлого өнгөрсөн оны эхээр засгийн газар огцрох үеэр 7 сая рублиэр нэмэгдсэн байна. Тэрээр 2020 оны зун орлогоо 11 сая рубль гэж мэдүүлж байсан бол одоо 18.1 сая болж өсжээ.

Холбооны зөвлөл

- Холбооны зөвлөлийн спикер Валентин Матвиенко мэдүүлэгтээ 17.4 сая рублийн орлого мэдүүлсэн нь өмнөх оныхоос 700 мянган рублиэр илүү байна. Түүний хөрөнгө нь өмнөх оныхоос өөрчлөгдөөгүй бөгөөд зуслангийн газар, байшин, автомашины зогсоол, 3 барилга байгууламж, 1 дуусаагүй барилга бүхий орон сууцтай байна.
- Холбооны зөвлөлийн гишүүдээс хамгийн өндөр орлоготой гишүүнээр Камчатк мужаас сонгогдсон сенатор Валерий Пономарев байсан бөгөөд түүний орлого 2.7 тэрбум рубль байснаас 4.18 тэрбум рубль болж өссөн байна. Харин Пономаревын эхнэрийн орлого 31.9 саяаас 25.3 сая рубль болж буурчээ.

Төрийн Дум

- Төрийн Думын дарга Вячеслав Володин 2020 онд орлогоо 84 сая рубль гэж мэдүүлсэн бөгөөд өмнөх онд түүний орлого 100.3 сая рубль байжээ.

- Гишүүдээс хамгийн өндөр орлоготой гишүүнээр 2.7 тэрбум рублийн орлого мэдүүлсэн Нэгдсэн орос намын гишүүн Григорий Аникеев тодорчээ. Түүний үл хөдлөх хөрөнгийн жагсаалтад 588 м² талбай бүхий орон сууцны хороолол барих газар, 159 м² талбай бүхий авто зам, инженерийн шугам сүлжээ барих газар, мөн 200 болон 357.6 м² хэмжээтэй 2 орон сууц багтсан байна. Түүнчлэн, гишүүнд хамаарах тээврийн хэрэгслүүдэд AS 350 B3 нисдэг тэрэг, Hagglunds BV 206 хуурай замын тээвэрлэгч, эмнэлгийн үйлчилгээний AMS-49415N загварын 2 автомашин байна.
- Төрийн Думын тэрбумтан 2 гишүүний орлого өмнөх оныхоос нэмэгдсэн байна.
- Гишүүн Леонид Симановскийн мэдүүлэг дэх орлого 1.6 тэрбум рубль байгаа нь өмнөх оноос 427 сая рублиэр өсжээ. Харин түүний хөрөнгийн хэмжээ өөрчлөгдөөгүй бөгөөд 2 газар, 2 орон сууц, зочид буудал болон бусад барилга байгууламжтай мөн Mercedes Benz загварын 2 машин, жижиг 2 усан онгоцтой байна. Форбес сэтгүүлд дэлхийн хамгийн баян хүмүүсийн рейтинг жагсаалтыг гаргахдаа Симановскийн хөрөнгийг 1.6 тэрбум ам.доллаар үнэлжээ /2021.03.05-ны өдрийн байдлаар/.

Харин гишүүн Андрей Скочийн жилийн орлого 40%-аар өсөж, 305.6 саяас 427.4 сая рубль болсон байна. Тэрээр тус бүр 2 газар, хувийн байшин, орон сууцтай байна. Форбес сэтгүүлд Скоч болон түүний гэр бүлийн хөрөнгийг 8.6 тэрбум ам.доллаар үнэлжээ.

АНУ-ын тэрбумтан Орос улс дахь авлигын үндсэн шалтгааныг нэрлэв¹⁸⁹



2020.04.29. *Bridgewater хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулагч, Америкийн тэрбумтан Рэй Далио Орос дахь авлигын үндсэн шалтгааныг нээн илрүүлжээ. Тэрээр Оросын үйлдвэр эрхлэгчдийн хамтран ажиллах чадвар сул байдаг нь авлига хөгжих үндэс болсон гэжээ.*

Рэй Далио гэж хэн бэ

Рэй Далио нь дэлхийн томоохон хөрөнгө оруулалтын сан болох Bridgewater Associates компанийг 1975 онд үүсгэн байгуулсан. Тус сан 140 орчим тэрбум ам.долларын хөрөнгөд менежмент хийдэг байна. 71 настай хөрөнгө оруулагчийн нийт хөрөнгө 20.3 тэрбум ам.доллаар үнэлэгддэг.

¹⁸⁹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://secretmag.ru/news/milliarder-iz-ssha-nazval-glavnyu-prichinu-korruptsi-v-rossii.htm>

Далио эдийн засгийн чиг хандлагыг урьдчилан тааварлах чадвартай гэдгээрээ алдартай юм. Тухайлбал, тэрээр 2008 оны санхүүгийн хямралыг урьдчилан хэлж, ирж буй аюулын тухай АНУ-ын Сангийн яаманд сануулж байжээ.

Орос дахь авлигын үндсэн шалтгаан

Үр дүнтэй эдийн засгийн тогтолцоо бүрдүүлэх тал дээр Орост ихээхэн хүндрэлтэй байдаг талаар РБК компанийн сэтгүүлчид өгсөн ярилцлагадаа АНУ-ын хөрөнгө оруулагч тэмдэглэсэн байна. Түүний үзэж буйгаар, тус улсын иргэд нэг нэгэнтэйгээ хамтарч ажиллах тал дээр анхаарах шаардлагатай байна.

Далио мөн Хятадад авлига тулгамдсан асуудлын нэг байсан талаар дурдсан бөгөөд БНХАУ-аас ялгаатай нь, Орост асуудал нь авлигад автах гэхээс илүүтэйгээр, хамтран ажиллах, илүү үр бүтээлтэй тогтолцоог бий болгох явдал байдаг гэжээ.

“Танай улсын бүтээн байгуулагч, үйлдвэр эрхлэгчид нэг нэгэнтэйгээ хамтран ажиллаж сураагүй. Тэд хамтран ажиллахаасаа илүүтэйгээр тогтолцоондоо тойрон эргэлдсээр байна” хэмээн тэрбумтан мэдэгджээ.

Түүнчлэн Рэй Далио ОХУ-ын эдийн засагт тулгарч буй бусад үндсэн асуудал нь хөрөнгийн зах сул хөгжсөн, боловсрол зэрэг дэд бүтцийн салбарт хөрөнгө оруулалт муу байдаг зэргийг нэрлэсэн байна.

Орос дахь авлигын өсөлт

ОХУ-ын Ерөнхий прокурорын газраас 2021 оны 01, 02 дугаар сард тус улсын авлигын гэмт хэргийн тоо өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 11.8 хувиар өсөж, 7,100 болсон талаар 03 дугаар сард мэдээлжээ. Үүний тал хагас буюу 3,500 орчим нь хахуулийн хэрэг байна. Нэг жилийн хугацаанд уг үзүүлэлт 21.1 хувиар өссөн бөгөөд хахуультай холбоотой гурван хэрэг тутмын нэг нь 10,000 рублиас ихгүй байна.

Сурган хүмүүжүүлэгч, багш нар болон шийдвэр гүйцэтгэгч, цагдаагийн байгууллагын албан хаагчид бага хэмжээний /10,000 рубль хүртэлх/ хахууль авдаг байна. Ихэвчлэн хууль зөрчсөн хариуцлагаас мултрах, эсхүл шалгалтад сайн үнэлгээ авах үүднээс хахууль өгдөг байна.

Тус улсад 2020 оны байдлаар авлигын гэмт хэргийн улмаас 63 тэрбум рублийн хохирол учирсан талаар Ерөнхий прокурорын газраас мэдээлжээ.

АУСТТ: Латвийн таван иргэн тутмын нэг нь хахуулийг байх ёстой зүйл гэж үздэг¹⁹⁰

2021.05.08. Латви улсын Авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх товчоо (АУСТТ)-ноос зохион байгуулсан олон нийтийн судалгааны үр дүн тус улсын таван иргэн, үйлдвэр эрхлэгч тутмын нэг нь төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хахууль өгсөнөө хүлээн зөвшөөрснийг харуулсан байна. Түүнчлэн, таван иргэн тутмын нэг нь сүүлийн 2 жилийн хугацаанд ахуйн болон ажил мэргэжлийн асуудлаа шийдвэрлүүлэхийн тулд хувийн харилцаагаа ашигласан, бэлэг өгсөн, албан бусаар төлбөр хийснээ хүлээн зөвшөөрчээ.

Хэдийгээр, хахууль өгөх нь буруу гэсэн үзэл санаа нийгэмд байгаа боловч иргэдийн 21%, үйлдвэр эрхлэгчдийн 19% нь төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын эрх бүхий албан тушаалтанд хахууль өгөх боломжоо хүлээн зөвшөөрснийг санал асуулгын дүн харуулжээ.

Судалгаанд хамрагдсан дээрх хоёр бүлгийн оролцогчид уг үйлдэл нь асуудлыг шийдэж, эрх бүхий албан тушаалтан эерэг хариу үйлдэл үзүүлнэ гэсэн итгэлээр тайлбарласан байна.

Үйлдвэр эрхлэгчдийн хувьд хуулийн зохицуулалт ойлгомжгүй, ярвигтай, хэрэгжүүлэхэд албан тушаалтны оролцоо, туслалцаа ихээр шаарддаг болохыг онцолжээ.

Судалгаанд хамрагдсан иргэдийн 20%, үйлдвэр эрхлэгчдийн 21% нь тус тус сүүлийн 2 жилийн хугацаанд асуудлаа шийдвэрлэхийн тулд бэлэг сэлт, мөн хувийн харилцаагаа ашиглаж байсан дүн гарчээ.

¹⁹⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://bnn-news.ru/bpbk-kazhdvj-pyatvj-zhitel-latvii-schitaet-vzyatki-priemlemymi-248748>

Иргэд эрүүл мэндийн үйлчилгээ авах, эсвэл төрийн байгууллагад ажилд орох болон үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд ийм аргыг хэрэглэдэг байна.

Харин үйлдвэр эрхлэгчдийн тухайд барилга, байгууламж барих, төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, лиценз, зөвшөөрөл авахтай холбоотойгоор ийм хандлага гаргадаг байна.

Судалгаанд оролцогчдын үзэж буйгаар, төрийн албаны дээд болон доод шатны албан хаагчдын хүрээнд хахуулийн асуудал илүү тархсан байна. Иргэдээс ялгаатай нь, үйлдвэр эрхлэгчид сүүлийн 4 жилийн хугацаанд Латви улсад хахууль буурч байна гэж үзжээ.

Судалгаанд оролцогчдын 92% нь тус улсын авлигын асуудлыг багасгахын тулд төрийн байгууллагын шийдвэр гаргах үйл явцыг нээлттэй, ил тод болгох шаардлагатай, 89% нь худалдан авах үйл ажиллагаанд хатуу хяналт тогтоох ёстой гэж үзжээ. Түүнчлэн, хахуулийн хэрэгт хатуу шийтгэл оногдуулах хэрэгтэй гэж судалгаанд оролцогчдын 52%, албан тушаалтныг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилдог байх ёстой гэж 44% нь үзсэн байна.

Авлигын эсрэг Герман улсын тэмцлийг Европын Зөвлөл “хангалтгүй” гэж үнэлэв¹⁹¹

2021.05.10. Герман улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа төдийлөн амжилт олохгүй байна гэж ARD мэдээллийн төвөөс мэдээлэв. Европын Зөвлөл (ЕЗ)-ийн тайланд Бундестаг дахь хахууль, лоббизмтой хийх тэмцлийг “бүхэлд нь авж үзвэл хангалтгүй” гэж үнэлсэн бөгөөд 2015 онд гаргасан заавар, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна гэжээ.

ЕЗ-ийн шинжээчид Герман урьдын адил Бундестаг дахь авлигатай тэмцэхэд хүчин чармайлт гаргахгүй байна гэж үзжээ.

Тус улс ГРЕКО-гоос 2015 онд гаргасан парламент болон шүүх засаглал дахь хахуулийн эсрэг чиглэсэн заавал хэрэгжүүлэх заавар зөвлөмжийг зохих ёсоор хэрэгжүүлээгүй гэж ЕЗ-ийн тайланд дурджээ.

2017, 2019 оны тайлангуудад мөн “ерөнхийдөө хангалтгүй” гэж тодорхойлогдсон бөгөөд 2022 оны 03 дугаар сард ЕЗ дахь Германы төлөөлөгчид ажлын явцын тайланг хүргүүлэх ёстой аж.

ГРЕКО “зөвлөмжийн хэрэгжилтийн ерөнхий түвшин доогуур” байна гэж үзсэн бөгөөд парламентын үйл ажиллагаанд нөлөөлөх зорилготой лоббичид болон гуравдагч этгээдтэй гишүүдийн зүгээс хамтран ажиллах тодорхой дүрэм байхгүй талаар шүүмжилжээ. Түүнчлэн Герман улс гишүүдийн хувийн ашиг сонирхол, сонсголын үеэр хэлэлцсэн асуудал хоорондын зөрчлийн талаарх мэдээллийг ил болгох шаардлагыг биелүүлээгүй байна.

Христийн ардчилсан холбоо болон Христийн нийгмийн холбоо эвслийн Бундестаг дахь хэд хэдэн гишүүнийг хахууль авсан, эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэж буруутгасан бөгөөд тэднийг хамгаалалтын хэрэгсэл нийлүүлэх засгийн газрын захиалгад зуучилсны төлөө хахууль авсан гэж мэдээлсэн байна. Түүнчлэн, Христийн ардчилсан холбоо намын гишүүн Марк Хауптманыг Азербайжаны ашиг сонирхлын төлөө лобби хийсэн хэмээн сэжиглэж байгаа юм байна.

ЕЗ нь Францын Страсбург хотод төвтэй бөгөөд хүний эрхийг хамгаалах үүрэгтэй юм. 1999 онд үүсгэн байгуулагдсан ГРЕКО нь ЕЗ-ийг бүрдүүлэгч 47 улс, болон АНУ, Беларусь, Казахстаныг багтаадаг бөгөөд авлигатай тэмцэх чиглэлээр улс орнуудын хийж буй үйл ажиллагаа, хүчин чармайлтыг үнэлдэг байгууллага юм гэж мэдээлжээ.

Авлига хайгчид дэлхий нийтийн мөнгө угаах эрсдлийг нэмэгдүүлдэг¹⁹²

2021.09.13. Швейцари. Мөнгө угаахтай тэмцэх индексээр дэлхийн эрсдлийн зэрэглэл 10-аас (эрсдлийн хамгийн өндөр оноо) 5.22 байснаас 5.3 болж өссөн гэж Базелийн засаглалын институт мэдээлэв.

¹⁹¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://russian.rt.com/inotv/2021-05-10/ARD-Sovet-Evropi-postavil-Germanii>

¹⁹² Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.swissinfo.ch/eng/corruption-trackers-flag-increased-global-money-laundering-risks/46943650>

Мөнгө угаах эрсдлийг 110 улсад хараат бусаар судлан, жил бүр гаргадаг бөгөөд энэхүү үнэлгээгээр Швейцари улс 2020 онд 4.74 оноо, 2021 онд 4.89 оноо авсан нь өмнөх онтой харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Одоо 43 дугаар байрт бичигдэж байна. Илтгэлд дурдсанаар, ахиц дэвшил гаргасан орнууд ч гэсэн хамгийн бага ахиу ашиг олсон байна.

Базелийн мөнгө угаахтай тэмцэх индексийн тайлангийн 10 дахь хэвлэлд виртуал хөрөнгөөс үүдэлтэй аюул заналхийллийн эсрэг илүү хүчтэй хариу арга хэмжээ авах, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэхэд илүүтэйгээр анхаарлаа хандуулах шаардлагатай байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Мөн “Хууль ёсны болон хууль бус зорилгоор криптовалюта гэх мэт виртуал хөрөнгийн хэрэглээ хурдацтай өсөж байна” гэж тайланд дурджээ.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дэлхийн хүчин чармайлтын тоймоос харахад “Үр дүнгүй систем бол ерөнхий дүрэм” гэж үздэг бөгөөд улс орнууд урьдчилан сэргийлэх тал дээр хууль сахиулахаас илүү муу ажилладаг.

Эрсдлийн оноог ФАТФ, ТИ, ДБ, ДЭЗФ зэрэг олон нийтийн 17 эх сурвалжаас цуглуулсан мэдээлэлд үндэслэн гаргадаг.

Энэ нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, хахууль, авлигын эрсдэл, санхүүгийн ил тод байдал, олон нийтэд хариуцлага хүлээлгэх боломж, хууль эрх зүй, улс төрийн эрсдэлт хүчин зүйлсийн талаарх улс орнуудын хууль эрх зүйн орчныг үнэлдэг.

Энэхүү тайланд дэлхийн өнцөг булан бүрд эцсийн өмчлөгчдийн мэдээллийн ил тод байдал үр дүн муутай байгааг онцлон тэмдэглэжээ. Энэ нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчид, өөрөөр хэлбэл, компани, сан болон бусад аж ахуйн нэгжүүдийн сүлжээг хянадаг хувь хүмүүсийн тухай мэдээллийг олон нийтэд ил болгохыг хэлнэ.

Санхүүгийн салбараас гадуур урьдчилан сэргийлэх арга хэмжээг сул хэрэгжүүлдэг (жишээлбэл, үл хөдлөх хөрөнгө гэх мэт бизнесийн салбарууд) бөгөөд гэмт хэргийн оролцогчид ашиглаж болох хуульч, нягтлан бодогч зэрэг зуучлагчийн үүрэг оролцоо анхаарал татсан асуудал юм.

Их Британийн засгийн газар Консерватив намын хандивлагчидтай холбоотой авлигын хэргийг үгүйсгэж байна¹⁹³



2021.11.07. *Хандивлагчдад парламентын дээд танхимд суудал санал болгосныг тус сонин олж мэдсэний дараагаар үүссэн авлигын хэргийг тус улсын засгийн газар үгүйсгэв.*

Их Британийн Ерөнхий сайд Борис Жонсоны Консерватив нам зарим томоохон хандивлагчдад парламентын дээд танхимын суудал санал болгосон нь эрэн сурвалжлах сэтгүүл зүйн мөрдлөгөөр илэрсэний дараа засгийн газар энэхүү мэдээллийг няцаасан юм.

Sunday Times сонинд бичсэнээр, өнгөрсөн хорин жилийн хугацаанд Консерватив намын сангийн даамал асан 16 хүний нэгээс бусад нь намдаа 3

Өнгөрсөн долоо хоногт засгийн газар авлигатай холбоотой маргаанд хутгалдсан бөгөөд Ерөнхий сайд Борис Жонсон лобби хийх дүрэм зөрчсөн нь тогтоогдсон парламентын гишүүдийнхээ нэгийг хамгаалахын тулд парламентаар хэлэлцүүлэх байсан төлөвлөгөөгөө орхиоос өөр аргагүйд хүрчээ.

(Их Британийн Парламент / Жессика Тейлор / Reuters)

¹⁹³ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2021/11/7/uk-denies-corruption-accusations-over-conservative-party-donors>

сая гаруй фунт стерлинг (4.05 сая доллар)-ийн хандив өгсөн бөгөөд үүнийхээ хариуд Лордын танхимийн гишүүн болох санал авж байжээ. Консерватив намын сангийн даамал бол Их Британид хамгийн өндөр дээд зиндааны ажил хэмээн үнэлэгддэг бөгөөд тус улсын төрийн байгууллагууд, буяны сангийн удирдлага, тэр байтугай экс Ерөнхий сайд нараас ч дээгүүр хүндлэгддэг.

“Борис Жонсоны тэргүүлдэг Консерватив нам бол авлигад идэгдсэн, шударга бус, ёс зүйгүй, хахууль горьддог” хэмээн сөрөг хүчин болох Хөдөлмөрийн намын дэд дарга Анжела Райнер твиттер хуудсандаа бичжээ.

Тэгвэл, Байгаль орчны сайд Жорж Эстис уг мэдээллийг худал хэмээн үгүйсгэв. Тэрбээр *“тэдгээр хүмүүс (хандивлагчид) олон арван буяны үйлсэд их хэмжээний хандив өгөхөөс гадна бизнест их амжилтад хүрсэн хүмүүс учраас эл үндэслэлээрээ Лорд хэмээн тооцогдох боломжтой”* хэмээн олон нийтийн хэрэгслээр мэдэгджээ.

Энэхүү дуулианаас үүдэлтэйгээр Борис Жонсоны ёс зүйн талаарх шинэ асуултууд төрөн гарав. Тухайлбал, тэрбээр намын хандивлагчдыг Даунинг-стрит дэх орон сууцныхаа тансаг засварт нууцаар дэмжлэг үзүүлэхийг хүсэх зэрэг олон гэм буруутай үйлдэл хийсэн гэх мэдээлэл цацагдсан боловч тэрбээр үүнийгээ засгийн газар засварын дүрмийг дагаж мөрдсөн төдий гэж мэдэгдсэн байна.

Observer сэтгүүлээс явуулсан санал асуулгаар Ерөнхий сайд Жонсоны ард нийтийн үнэлгээ урьд өмнө байгаагүй хамгийн доод түвшинд хүрч буурсан бол, Консерватив намын үнэлгээ Хөдөлмөрийн намаас нэг хувиар өндөр үзүүлэлттэй гарсан байна. Үүсээд байгаа энэхүү нөхцөл байдалтай холбогдуулан Хөдөлмөрийн намын удирдагч Кир Стармер ням гарагт BBC агентлагт өгсөн ярилцлагадаа *“Ерөнхий сайд манай ардчилал, улсын нэр хүндийг унагаж байна”*, цаашилбал *“... олон нийтийн амьдралд стандартыг хэрхэн барихаа мэддэггүй Ерөнхий сайдын үнэн дүр төрх мөн”* хэмээн мэдэгджээ.

3. АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Төрийн байгууллагын шударга байдлыг
дэмжихэд албан хаагчийн сонгон
шалгаруулалтын ач холбогдол: Энэтхэгийн
зарим баримт¹⁹⁴

2014.06.26. Matthew Stephenson. Төрийн байгууллагын хүнд сурталтай холбоотой авлигатай тэмцэх үйл ажиллагаа нь төрийн албан хаагчдыг албан тушаалд томилогдсоны дараа зохих урамшууллыг бий болгоход ихээхэн анхаарал хандуулж байна. Зорилго нь шударга зан үйлийг өдөөж, хууль бус, буруу үйлдлийг таслан зогсоох урамшуулал ба шийтгэлийн тогтолцоо, улмаар мэргэжлийн соёлыг бий болгох явдал юм. Эдгээр урамшууллыг бий болгох нь үнэхээр чухал боловч төрийн албан хаагч болон албан тушаалтныг сонгон шалгаруулах асуудлыг анхаарч үзэх нь бас чухал юм. Эцсийн эцэст, үнэнч шударга хүнд авлигыг эсэргүүцэхэд нь туслах нь махчин оппортунистыг¹⁹⁵ албан тушаалаа урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхээс хамаагүй хялбар байдаг. Түүгээр ч барахгүй буруу хүмүүсийг төрийн албанд сонгох нь гаж буруу тойргийг үүсгэж болзошгүй юм. Авлигын асуудалд нэр холбогддог төрийн байгууллага албан тушаалаа урвуулан ашиглах сонирхолтой хүмүүсийг татах хандлагатай байдаг бол шударга, нэр хүндтэй байгууллага нийтийн сайн сайхны төлөө үйлчлэх сонирхолтой хүмүүсийг татах магадлал өндөр байдаг.

Гэхдээ, энэ бол сэжиг таамаг юм. Шинээр орж ирж буй төрийн албан хаагчдын үнэнч шударга байдлын талаар эмпирик нотлох баримт цуглуулах маш хэцүү бөгөөд энэ нь ажил дээрх бодит зан төлөвт үзүүлэх хувийн шударга байдлын нөлөөллийг үнэлэх явдал юм. Харин миний хамтрагч Харвардын Рема Ханнагийн өөр хоёр судлаач (Шин-И Ван¹⁹⁶, Икбал Даливал¹⁹⁷)-тай хамтран Энэтхэгт хийсэн туршилтын судалгаа¹⁹⁸ (1) хууран мэхлэх хандлагатай хүмүүс төрийн байгууллагад ажиллах илүү сонирхолтой, мөн 2) хууран мэхлэх хандлагатай төрийн албан хаагчид ажил дээрээ үүрэг хариуцлагаас зайлсхийх магадлал өндөр байдаг гэсэн дүгнэлтийг дэвшүүлсэн байна. Судалгааны үр дүнг болгоомжтой тайлбарлах ёстой хэдий ч тэд авлигатай тэмцэх стратегитай холбоотой хэд хэдэн чухал асуудлыг хөндсөн байна.

Би туршилтуудын нарийн ширийн зүйлийг энд нэгтгэн дүгнэхийг оролдохгүй, харин гол санааг нь хэлье. Туршилтын эхний хэсэгт Ханна, Ван нар коллежийн оюутнуудад нэг шоог нууцаар 42 удаа орхиж, орхилт бүрд буусан тоог бүртгэхийг даалгажээ. Дараа нь уг тооны нийлбэртэй тэнцүү мөнгийг оюутнуудад өгнө гэдгийг хэлсэн байна. Оюутнууд хууран мэхлэх боломжтой байсан (их тоо буусан гэж мэдээлэх замаар) төдийгүй судлаачид ийнхүү хууран мэхлэхийг шууд ажиглах боломжгүй байсан хэдий ч шоо буух магадлалд (өөрөөр хэлбэл, том тоо олон буух) үндэслэн аль оюутан хууран мэхэлсэн байж болзошгүйг тооцоолсон байна. Мөн судлаачид оюутнуудаас ирээдүйн ажил мэргэжлийнх нь хэтийн төлөвлөгөөний талаарх асуултууд асуужээ.

Өөр нэг туршилтаар Ханна, Даливал нар Энэтхэгийн төрийн албанд харьяалагдах сувилагчдаар мөн дээрхийн ижил тоглоомын хувилбараар тоглуулсан байна. Дараа нь, ажил дээрээ байгаа гэж мэдэгдсэн (мөн цалин авсан) боловч эзгүй байсан ямар сувилагч байгааг олж мэдэхийн тулд эмнэлгүүдэд санамсаргүй байдлаар шалгалт хийжээ.

Үр дүн: (1) шударга бус оюутнууд (шоо орхих тоглоомонд хууран мэхэлсэн байх магадлал өндөртэй хүмүүс) төрийн албанд ажиллах сонирхолтой гэдгээ илэрхийлэх хандлагатай байсан; (2) шударга бус сувилагчид (мөн л, шоо орхих тоглоомонд хуурч мэхэлсэн байх магадлалтай хүмүүс) ажил дээрээ эзгүй байх, ажлаа хийхгүйгээр цалин авах магадлал өндөр байв.

Илүү гүнзгий дүгнэлт гаргахын тулд эдгээр туршилтуудын үр дүнг нэгтгэхдээ болгоомжтой хандах хэрэгтэй. Мөн Энэтхэгийн төрийн бүх албан хаагчийг гутаан доромжлохоос болгоомжлох хэрэгтэй. Туршилтын үр дүнд гарсан статистик дундаж дээр үндэслэн хэлэхэд, тэдний олонх нь

¹⁹⁴ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2014/06/26/the-importance-of-personnel-selection-in-promoting-government-integrity-some-evidence-from-india/>

¹⁹⁵ A venal opportunist. Оппортунист гэдэг бол аливаа нөхцөл байдалд эрх мэдэл, давуу байдал олж авахыг хичээж байдаг хүн.

¹⁹⁶ <https://bepp.wharton.upenn.edu/profile/was/>

¹⁹⁷ <https://www.povertyactionlab.org/person/dhaliwal>

¹⁹⁸ <https://www.aeaweb.org/articles?id=10.1257/pol.20150029>

хүнд хэцүү нөхцөлд эх орондоо үйлчлэхийн тулд чадах бүхнээ хийдэг туйлын үнэнч хүмүүс юм. Гэсэн хэдий ч судалгааны эдгээр үр дүн нь Энэтхэгт авлигын ноцтой асуудлууд (хахууль авах, ажил хийдүүлэх гэх мэт) үүсч байгаа нь төрийн албаны ажлын байрыг зарим хүмүүс авлигын боломж олгодог гэж үздэгтэй холбоотой гэсэн таамаглалтай нийцэж байгаа юм. Үүний үр дүнд зарим шударга ажиллагсад төрийн албан тушаалд ажиллахаас татгалзаж, харин шударга зан чанар багатай нэр дэвшигчид энэ ажлыг хайж байна.

Хэрэв бусад улс оронд үүнтэй ижил төстэй судалгаа хийх юм бол тэдгээр улс орнуудын авлигын нөхцөл байдалтай нягт уялдаатай өөр өөр хэв маягийг илрүүлж, олж харах болно. Би Рема болон бусад хүмүүсийг үүнийг хэрэгжүүлэхийг уриалж байна. (Жишээлбэл, АНУ-д бүх луйварчид төрийн албанд бус санхүүгийн салбарт орохыг хүсдэг гэж би хардаж байна.) Үүнтэй ижил төстэй судалгааг нэг улсын төрийн байгууллагуудын хооронд ялгаа байгаа эсэхийг олж мэдэхэд ашиглах нь ч сонирхолтой байж магадгүй: жишээлбэл, ямар хүмүүс цагдаа, гаалийн байцаагч, ойн менежер болохыг хүсдэг вэ?

Миний бодлоор, цаашдын судалгаагаар авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг төрийн албанд амжилттай хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулагч нь боловсон хүчнийг сонгон шалгаруулах явдал юм. Үүнээс ямар үр дүн гарах вэ? Энэ бол хожим хөндөх илүү том сэдэв боловч хоёр урьдчилсан санааг хэлье.

- *Нэгдүгээрт*, төрийн зарим агентлаг нэр дэвшигчдийг зөвхөн авьяас чадвар, танин мэдэхүйн чадвараар нь бус, ёс зүйн хувьд шалгах арга зам байгаа эсэхийг илүү нухацтай авж үзэж магадгүй юм. Үүнийг хийхэд хэцүү байдаг, учир нь хүмүүс үнэнч шударга байдлынхаа талаар шалгагдаж байгааг мэдсэний дараа тэдний зан төлөв өөрчлөгдөх магадлалтай байдаг. Гэхдээ энэ нь боломжгүй зүйл биш ч байж магадгүй бөгөөд авлигатай тэмцэх зарим байгууллагууд, тухайлбал Индонезийн АУХ хүний нөөцийн зөвлөхөөс боловсруулсан шударга байдлын компьютержсэн тест ашиглан нэр дэвшигчдийг шалгах ажлыг аль хэдийн хийжээ.
- *Хоёрдугаарт*, албан тушаалаа урвуулан ашигласан этгээдүүдийг зөвхөн шийтгээд өнгөрөх бус, харин шахан зайлуулах илүү түрэмгий оролдлогууд гарч ч магадгүй юм. Энэ бол төвөгтэй сэдэв, учир нь төрийн албан хаагчдын хөдөлмөр эрхлэлтийн хууль ёсны хамгаалалтыг хангах асуудал гарч ирдэгээс гадна улстөржсөн байдлаар ажлаас халах явдал байнга гардаг. Гэхдээ авлига газар авсан тохиолдолд шударга бус хүмүүсийг, тэр байтугай шударга бус авир нь харьцангуй хөнгөн мэт санагдах хүмүүсийг ч төрийн албанаас аль болох хурдан гаргахад тэнцвэрт байдал чиглэх болно.

Авлигын эсрэг боловсролын санаачилгын ард нуугдаж буй бэрхшээл¹⁹⁹

2014.11.25. Matthew Stephenson. Авлигын эсрэг хөдөлгөөн дэх эрдэмтэн судлаачдын үүрэг оролцоог тусгасан өмнөх нийтлэлдээ²⁰⁰ би “ур чадварт сургахуй” (оюутнуудыг сайн хуульч, бодлогын шинжээч, шүүмжлэлт сэтгэгч болоход нь туслах гэх мэт) хийгээд “үнэт зүйлд сургахуй” (авлигын эсрэг хэм хэмжээг хэвшүүлэх, авлигын соёлыг хүлцэн тэвчих явдлыг үгүй болгох зорилгод боловсролыг ашиглах) хоёрын ялгааг авж үзсэн билээ. Харин энэхүү бичлэгт авлигатай тэмцэгчид болон бодлого боловсруулагчдын хувьд улам чухал болж байгаа сүүлийн сэдвийг нь хөндөхийг хүслээ. “Авлигын соёл”-той тэмцэхийн тулд зөвхөн өдөөлт идэвхжүүлэлт, албан ёсны институцийг өөрчлөхөөс гадна хэм хэмжээ, үнэт зүйлийг өөрчлөх шаардлагатай байгааг олон хүн үнэмшилтэйгээр нотолж байна. Үнэт зүйлийг өөрчлөх нэг арга зам бол боловсрол бөгөөд энэ нь бүх шатны албан ёсны танхимын боловсрол төдийгүй боловсролын кампанит ажлын бусад хэлбэрүүд байж болно. Жишээлбэл, Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хорооны амжилтыг хууль сахиулах ажлын хүчин чармайлтаас гадна Хонконгийн ард түмний хандлагыг өөрчлөх өргөн цар хүрээтэй боловсролын кампанит ажилтай холбон тайлбарлаж байна. Олон улс орнууд энэхүү “авлигын эсрэг сурталчилгаа”-ны кампанит ажлын зарим хувилбарыг дуурайхыг оролдсон байдаг.

¹⁹⁹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2014/11/25/the-hidden-dangers-of-anticorruption-education-initiatives/>

²⁰⁰ <https://globalanticorruptionblog.com/2014/09/23/the-role-of-academics-in-anticorruption-some-tensions/>

Гэхдээ авлигын эсрэг боловсролын иймэрхүү хүчин чармайлтыг нарийвчлан боловсруулахгүй бол үр дүнгүй байх төдийгүй зорилгодоо хүрэхэд саад болдог ажээ. Саяхан би улс төр судлаач Фредерик Чарльз Шафферын Филиппин болон Тайландад сонгуулийн санал худалдан авахын эсрэг кампанит ажлын нарийвчилсан судалгаа (case study)-нд үндэслэн хийсэн аятайхан дүн шинжилгээтэй²⁰¹ таарлаа. (Профессор Шафферын 2008 онд хэвлэгдсэн “Цэвэр сонгуулийн төлөөх шинэчлэлийн далд зардлууд” (*The Hidden Costs of Clean Election Reform*) номыг унших боломж надад хараахан олдоогүй байгаа боловч би илүү гүнзгийрүүлэн, бусад асуудлууд болон улс орнуудын талаарх хэлэлцүүлгүүдийг нэгтгэн цуглуульж байгаа.) Энэхүү өгүүлэл 2005 оных тул зарим нэг тодорхой жишээ, шүүмжлэлүүд одоо тохиромжгүй байх магадлалтай юм, гэхдээ миний бодлоор цаад том санаа нь маш их хамааралтай хэвээр байгаа бөгөөд авлигатай холбоотой иргэдийн хандлага, зан үйлийг өөрчлөхийн тулд нийтийн боловсрол / сурталчилгааны кампанит ажил ашиглахыг хүсэж буй авлигын эсрэг шинэчлэгчдэд маш чухал юм. Миний бие профессор Шафферын бүх нарийн тооцооллыг нэгтгэн дүгнэхийг хичээгээгүй, харин зайлшгүй чухал аргумент болох тул энд дурдав.

Ангийн хуваагдал нь илт тодорч буй улс болох Филиппинд санал худалдаж авах, ялангуяа ядуу иргэдийн саналыг худалдан авах (буюу шуудхан хэлэхэд, улс төрчид, эсвэл намын ажилтнууд хариуд нь санал ирнэ гэсэн хүлээлт бүхий тодорхой материаллаг ашиг тус хүртээх) нь өргөн тархсан асуудал болж байна (Энэ бол үнэхээр хавтгайрсан асуудал бөгөөд төрийн бодлогын үр дүн, ялангуяа ядуу иргэдийн хувьд илүү муу үр дагаварт хүргэх болно гэдэг нь хангалттай баримттай билээ). Үүнийг шийдвэрлэхийн тулд Филиппиний ТББ-ууд католик сүм хийдтэй хамтран санал худалдаж авахад саад учруулах зорилготой хэд хэдэн санаачилга гаргасан байна. Тэдгээр нь, жишээлбэл “Сонгуульд нэр хүндээ битгий зар, саналаа битгий худалд”, “Та эх орондоо хайртай юу, эсвэл мөнгөнд үү?“, “Мөнгөөр нүдээ бүү сохол. Өөрийн ухамсраар саналаа өгөөрэй” гэх мэт үгс бүхий сэтгүүл, сонин, телевизийн сурталчилгаа, зурагт хуудас байв.

Гэвч энэ нь үр дүнд хүрээгүй (ядаж л, ийм зүйл хийсэн дээ гэх шинж ч байсангүй) байна. Үүний шалтгааныг олж мэдэхийн тулд профессор Шаффер болон түүний хамтран зүтгэгчид ядуу филиппинчүүдээс санамсаргүй түүврийн аргаар ярилцлага авжээ. Ингээд тэд зарим зүйлийг олж мэдсэн байна.

Нэгдүгээрт, чинээлэг эх орон нэгтнүүд нь тэднийг хүндэтгэдэггүй гэж олон ядуу филиппинчүүд үздэг бөгөөд тэднийг бузар, мунхаг, шунахай, эсвэл бүр хүн биш гэж хардаг. Тэд маш их доромжлол мэдэрдэг бөгөөд үүнд гүнээ дургүйцдэг аж.

Хоёрдугаарт, Филиппин улсад шууд санал худалдаж авах магадлал өндөр байдгийн зэрэгцээ улс төрчид, эсвэл намын ажилтнууд ихэнх ядуу филиппинчүүд чинээлэг, хүчирхэг хүмүүсээс тэр бүр мэдэрдэггүй мэдрэмжүүд болох өөрсдийн сайн сайхан байдалд хүндэтгэлтэй хандаж байгаагийн шинж гэж үнэлдэг тэтгэмж, тусламж (хурим, оршуулгын зардал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэх мэт) өгдөг байна.

Гуравдугаарт, дунд болон дээд ангийн идэвхтнүүд ядуу хүмүүст “Мөнгөөр нүдээ бүү сохол”, “Та эх орондоо хайртай юу, эсвэл мөнгөнд хайртай юу?”, “Таны санал чухал байна, халаасны мөнгөөр бүү зар” гэх мэт уриа үг хэлэхэд энэ нь тэдний бодлыг өөрчилдөггүй, харин ч илүү эгдүүцэл, дургүйцлийг нь өдөөдөг байна. Тэд эдгээр мессежийг үл тоомсорлож, “Энэ сурталчилгаа уур хүргэж байна; намайг санал өгөхөд мөнгөний төлөө л гэж тэд бодно”, “Энэ сурталчилгаа хахууль авж болно гэсэн сэтгэгдэл төрүүлж байна. Энэ бол доромжлол”, “Гомдмоор үг; тэд [ядуу] сонгогчдыг шуналтай гэж хэлж байна” гэх зэрэг сэтгэгдэл хэлсэн байна.

Энэ нь сонгогчид боловсролын кампанит ажилд хариу үзүүлдэггүй, оролцдоггүйтэй холбоотойгоос гадна энэхүү хол хөндий байдал нь байдлыг улам дордуулж болзошгүй байдагтай ч холбоотой юм. Ерөөс баян чинээлэг филиппинчүүд тэднийг (ядуу хүмүүсийг) ойлгодоггүй, хүндэлдэггүй гэх бусдаас хөндийрөн холдох мэдрэмж нь дээд давхаргын үнэт зүйл ядуучууд болон тэдний дэмжиж буй нэр дэвшигчийг шүүмжлэхэд уриалж буй мэт санагддаг авлигын эсрэг үйл ажиллагаанаас үүдэн ялзарсан хэм хэмжээг угтаа улам өөгшүүлдэг аж.

Энд авлигын эсрэг боловсролын кампанит ажил үр ашиггүй гэж хэлж байгаа юм биш, харин ч ёс зүйн хэм хэмжээг хэвшүүлэхэд нэн чухал юм. Үнэхээр ч, дээр дурдсанчлан, Хонконг дахь ийм

²⁰¹ https://polsci.umass.edu/uploads/profiles/sites/schaffer_frederic_c/Files/paper21.pdf

хөтөлбөрүүд нэлээд амжилттай байсан. Гэхдээ Шафферын нотолгоо нь эдгээр хөтөлбөрийг боловсруулахад болгоомжтой, бодолтой хандах хэд хэдэн шалтгааныг тодруулан өгч байна. Шафферын өгүүлэлдээ бичсэн цөөн хэдэн санал болон өөрийн хэдэн бодлыг оруулав.

- Иймэрхүү боловсролын болон сурталчилгааны кампанит ажил зохиохдоо төсөөлөл, хэвшмэл ухамсарт найдахаас илүүтэйгээр авлигын шинжтэй үйл ажиллагаа хэрхэн (баталгаатай) илэрч байгаа, мөн кампанит ажлын зорилтот бүлгийн гишүүд энэ талаар хэр зэрэг мэддэг тухай тодорхой ойлголттой байх ёстой.
- Оношлогоо үнэн зөв байсан ч, өөрөөр хэлбэл, хүмүүс саналаа бэлэн мөнгөөр зарж байгаа нь үнэн байсан ч гэсэн ичээх хандлага үргэлж үр дүнд хүрээд байдаггүй, учир нь, энэ нь тэдний дургүйцлийг төрүүлж няцаалт, хариу цохилттой тулгардаг. Үүний оронд зорилтот бүлгийн хүмүүсийн өмнө үүссэн асуудлын талаарх илүү өргөн хүрээтэй хэлэлцүүлгийн дундуур авлигын эсрэг мэдээ мэдээллийг оруулж өгөх нь илүү үр дүнтэй.
- Боломжтой бол зорилтот бүлгийн гишүүдийг кампанит ажил, түүний хэрэглэгдэхүүний төсөл, зохион байгуулалтад тэргүүлэн оролцох боломж олгох буюу үүрэг өгөх хэрэгтэй.
- Аливаа медиа кампанит ажлыг фокус бүлгүүдэд урьдчилан туршиж үзэх хэрэгтэй.
- Санал асуулга, фокус бүлгээс гадна санамсаргүй туршилтыг ашиглан хэсэгчилсэн сорил (боломжтой бол, зан үйлийн хэмжигдэхүйц үр дүнд) хийх нь юу нь үр дүнгээ өгч, юу нь үр дүнгүй болох талаар найдвартай мэдээлэл гарган авах хамгийн сайн арга байж болох талаар би өмнөх нийтлэлдээ²⁰² онцолсон билээ.

Авлигыг дэмжигч соёл ба авлигын эсрэг боловсрол²⁰³

2015.03.30. Shinta Nurfauzia. Индонез улсын хувьд системийн авлигыг устгах асуудал томоохон сорилт болж байна. Индонезийн Авлигыг устгах хороо (Komisi Pemberantasan Korupsi буюу КРК) 2002 онд байгуулагдснаар тус улсын авлигатай тэмцэх стратегийн цөм хэсэг нь авлигатай тэмцэх институцүүдийг бэхжүүлэх явдал болж ирсэн. АУХ сүүлийн арван жилийн хугацаанд нэлээд амжилттай ажиллаж байгаа боловч Индонезийг авлигад автсан улс²⁰⁴ гэж үзсээр байна. Үүний нэг шалтгаан нь Индонезийн өөрийн авлигыг дэмжигч соёл байж болох юм.

Төрийн албан хаагчид хахууль нэхэхээс ичдэггүй, олон нийт, хөрөнгө оруулагчид ч өгөхөөс буцдаггүй. Үнэн хэрэгтээ Индонезийн төрийн зарим албан хаагч өөрсдийн авлигын үйлдлийг хууль бус, буруу зүйл гэж үздэггүй. Жишээлбэл, Индонезийн Шашны сайд Суриадхарма Али²⁰⁵-г Хажж сангаас мөнгө завшсан хэргийн сэжигтнээр татахад тэрээр өөрийн үйлдлийг авлига гэдгийг мэдээгүй хэмээн АУХ-нд мэдүүлж байв. Авлигын хэрэгт сэжиглэгдсэн өөр нэг сайд Жеро Васик ч мөн үүнтэй ижил зүйлийг АУХ-нд мэдүүлсэн байдаг. Ингэж заргалдаж буй нь утгагүй мэт санагдаж болох ч үнэндээ индонезчууд зарим зүй бус (хууль бус) үйлдэл нь авлига гэдгийг мэддэггүй гэж олон хүн хэлдэг. Тухайлбал, үндэсний үнэмлэх (иргэний үнэмлэх) олгох ажлыг түргэвчилж өгсөн төрийн албан тушаалтанд “талархал” хэмээн бага сага бэлэн мөнгө өгөхийг олон индонез хүн авлига гэж үздэггүй.

Индонезид авлигын соёл шингэсэн нь гайхмаар зүйл биш юм. Ерөнхийлөгч Сусило Бамбанг Юдхойоногийн²⁰⁶ засаглалын үед засгийн газар авлигыг устгах чиглэлээр дорвитой алхам хийж эхэлсэн нь саяхан. Хэрэв асуудлын нэг хэсэг нь Индонезийн авлигыг дэмжигч соёл гэж үзвэл “зөвхөн” эрх зүйн болон институцийн шинэчлэл, илүү эрчимтэй хууль сахиулах үйл ажиллагаанаас гадна маш олон алхам хийх хэрэгтэй юм. Энэхүү соёл хэмээх зүйлийг анхааралдаа авж, түүнийг өөрчлөх авлигын эсрэг боловсролын хөтөлбөр хэрэгжүүлэн, авлигыг үндсээр нь устгах шинэ стратеги, хандлагыг бий болгох шаардлагатай байна. Авлигын эсрэг боловсролын

²⁰² <https://globalanticorruptionblog.com/2014/08/28/should-we-use-randomized-trials-for-anticorruption-education-and-training/>

²⁰³ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2015/03/30/anti-corruption-education-versus-pro-corruption-culture/>

²⁰⁴ Индонез улс 2020 оны Авлигын төсөөллийн индексээр 37 оноотой 102 дугаар байрт эрэмбэлэгдсэн.

²⁰⁵ <https://www.indonesia-investments.com/news/todays-headlines/corruption-in-indonesia-suryadharma-ali-suspect-in-haji-pilgrimage-case/item2029>

²⁰⁶ Тэрээр Индонезийн улс төрч, чөлөөнд гарсан генерал бөгөөд 2004-2014 онд тус улсын 6 дахь ерөнхийлөгчөөр ажиллаж байсан.

ямар арга хэмжээ Индонезийн авлигыг дэмжих соёлыг урт хугацаанд үр дүнтэй өөрчилж болох вэ? Засгийн газар анхааралдаа авж болох гурван саналыг энд оруулав.

Нэгдүгээрт, засгийн газар төрийн бүх албан тушаалтнуудаас авлигын эсрэг боловсрол эзэмшихийг шаардах ёстой. Саяхан АУХ засгийн газрын албан тушаалтнуудад зориулсан авлигын эсрэг боловсролын аппликэйшн²⁰⁷ бүтээсэн боловч хамрах хүрээ хязгаарлагдмал, төрийн албан хаагчдаас үүнийг ашиглахыг шаардаагүй тул авлигын эсрэг боловсролын хангалттай хэрэгсэл болж чадахгүй байна. Авлигад үгүй гэж хэлэх өндөр түвшний мэдлэг олж авах, хариуцлагаа ухамсарлахын тулд төрийн бүх байгууллагууд ажилтнууддаа авлигын эсрэг цуврал хичээл, семинар зохион байгуулахыг шаардах ёстой. Мөн засгийн газар холбогдох төрийн байгууллагуудаас ажилчдынхаа боловсролын хөтөлбөрийн төгсгөлд шалгалт өгөхийг (тэнцсэн / тэнцээгүй) заавал шаардах хэрэгтэй. Хэрэв тэнцээгүй албан тушаалтан байгаа бол түүнд дахин шалгалт өгөх ганц л боломж олгох ёстой бөгөөд хоёр дахь удаагаа унасны дараа ажлаас нь халах хэрэгтэй. Төрийн байгууллагуудыг энэхүү хөтөлбөрийг бий болгохыг шаардсан хууль эрх зүйн нарийн чанд зохицуулалт бий болгох ёстой.

Хоёрдугаарт, засгийн газар АУХ-гоор дамжуулан олон нийтэд боловсрол олгох (соён гэгээрүүлэх) ажлыг үргэлжлүүлэн хийх ёстой. Ирээдүйтэй зарим санаачилга хэдийнээ хэрэгжиж эхлээд байна.



Авлигатай тэмцэх сургалтын төв (ACLC) автобусыг Жакарта хотод 10 дугаар сарын 14-ний мягмар гаргаас ажиллуулж эхлэв. Фото: Антара/Рено Эснир

Тус хорооноос 2014 оны 10 дугаар сард Йогьякарта хотод (Индонезийн боловсролын төв гэдгээрээ алдартай хот) авлигын эсрэг явуулын сургалтын төвийн үүрэг гүйцэтгэдэг “авлигын эсрэг автобус”²⁰⁸ нэвтрүүлж, хүмүүс авлигын эсрэг видео, тоглоом, ном, бусад мэдээллийг авах боломжтой болжээ. Засгийн газар энэхүү ирээдүйтэй санаачилгыг үнэлэх, тууштай хэрэгжүүлэх арга хэмжээ авах ёстой. Мөн засгийн газар энэхүү хөтөлбөр үнэхээр авлигын эсрэг боловсролын үр дүнтэй арга байж болох эсэхийг судлах, магадгүй жил бүр судалгаа хийх

ёстой. Хэрэв хариулт нь эерэг байвал хөтөлбөрөө өргөжүүлж, алслагдсан арлуудыг оруулаад Индонезийн бүх чиглэлд хүрэхийн тулд автобусны паркыг нэмэгдүүлэх хэрэгтэй юм. Хэрэв энэ нь үр дүнгүй болох юм бол өөр аргад шилжих ёстой, жишээлбэл, оргил цагуудад авлигын эсрэг сурталчилгаа, кино нэвтрүүлэх, байрлуулахыг телевиз, радио, вэбсайтаас шаардах хэрэгтэй.

Гуравдугаарт, Индонез улс бага, дунд, ахлах сургуулиудад авлигын эсрэг сургалтын хөтөлбөртэй байхыг шаардах хэрэгтэй. Бага сургуулийн түвшинд авлигын эсрэг боловсрол илүү “хүүхдэд эвтэйхэн” байж, бага насны сурагчдад өдөр тутмын ямар үйлдэл, үйл ажиллагаа авлига болохыг ялган тогтоох чадвартай болоход нь тусалдаг байх хэрэгтэй. Түүнээс дээд түвшинд авлигын эсрэг сургалтын хөтөлбөр илүү төвөгтэй байж болно, жишээ нь, ахлах сургуулийн сурагчид авлигын эсрэг хууль тогтоомжийн агуулгын талаар болон урьд болж өнгөрсөн авлигын тохиолдлуудтай танилцах боломжтой юм. Эдгээр сургалтын хөтөлбөрийн гол зорилго нь авлигыг үзэн ядах сэтгэлгээг бий болгох явдал юм. Одоо байгаа авлигыг дэмждэг соёлыг нураахыг хүсэж байгаа л бол энэ маш чухал. Гиймээс хөтөлбөр заавал байх ёстой. Сургалтын

²⁰⁷ <https://theworld.org/stories/2014-11-25/wondering-if-you-re-corrupt-indonesia-there-s-app>

²⁰⁸ <https://www.republika.co.id/berita/en/national-politics/14/10/14/ndfbb3-kpk-launches-anticorruption-learning-center-bus>

хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө багш нарыг сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд бэлтгэхийн тулд тэдэнд авлигын эсрэг боловсрол зайлшгүй олгох ёстой.

Дээрх авлигын эсрэг боловсролын хөтөлбөрүүдийн үр нөлөөг хангахын тулд эдгээр хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх бүрэн хариуцлага, эрх бүхий агентлагийг тодорхойлон нэрлэх шаардлагатай байна. Хамгийн зүй ёсны нэр дэвшигч бол АУХ-ны Боловсрол, олон нийтийн үйлчилгээний газар (Directorate of Education and Community Service) юм. Индонезийн институтуудын хооронд олон жилийн турш байсан эрх мэдлийн зөрчлийг тооцвол нэг хариуцлагатай агентлагийг тодорхой томилох нь чухал байна. Гэсэн хэдий ч засгийн газар АУХ болон холбогдох бүх яамд, төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хангах шаардлагатай. Тиймээс, Ерөнхийлөгч зарлиг гаргаж, холбогдох бүх яам, төрийн байгууллагуудыг авлигын эсрэг боловсролын хөтөлбөр бий болгох, хэрэгжүүлэхэд АУХ-той хамтран ажиллахыг шаардах хэрэгтэй. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг хамтран боловсруулахыг АУХ, Боловсрол, соёлын яам, Хууль зүй, хүний эрхийн яаманд уг зарлигаар даалгах ёстой.

Дээр дурдсан томоохон хөтөлбөрт ихээхэн цаг хугацаа, хүчин чармайлт, зардал шаардагдах нь мэдээж юм. Санал болгож буй шинэчлэлийн багц арга хэмжээг тэр даруй хэрэгжүүлсэн ч шууд үр дүн гарахгүй. Гэсэн хэдий ч авлигын эсрэг үр дүнтэй, өргөн хүрээтэй боловсролын үйл ажиллагаа байхгүй тохиолдолд авлигыг дэмжигчид байсаар л байх болно. Энэ соёл удаан орших тусам түүнтэй тэмцэхэд илүү хэцүү бэрх байх болно. Тиймээс засгийн газар, АУХ авлигын эсрэг боловсролыг Индонезийн авлигатай тэмцэх эн тэргүүний хөтөлбөр болгох ёстой.

Авлигын эсрэг боловсролыг ажил хэрэг болгох нь: Хийх зүйлсийн жагсаалт²⁰⁹

2015.04.20. Shinta Nurfauzia. Өмнөх нийтлэлдээ соёлын хэм хэмжээ нь авлигыг устгахад бэрхшээл болдог талаар болон авлигын соёлыг өөрчлөх урт хугацааны механизм болох авлигын эсрэг боловсролын хөтөлбөрийг бага, дунд, ахлах сургуульд дэмжин хэрэгжүүлэх ёстой талаар өгүүлсэн билээ. Дээрх нийтлэлд Индонез улсын талаар онцолсон ч Филиппин²¹⁰, Энэтхэг²¹¹, Хятад²¹² болон бусад олон улс орнууд авлигын хүчирхэг соёлд автсан байдаг. Тиймээс тэдгээр улс орнууд энэхүү соёлыг өөрчлөхөд нэмэр болохуйц авлигын эсрэг боловсролын санаачилгыг тохируулан хэрэглэх хэрэгтэй.

Гэвч авлигын эсрэг үр дүнтэй боловсролын хөтөлбөрийг боловсруулахад юу шаардлагатай вэ? Ямар хүчин зүйлсийг харгалзан үзэх ёстой вэ? Авлигын эсрэг боловсрол үнэхээр үр дүнтэй байна гэдгийг хэрхэн батлах вэ? Эдгээр асуудлууд төвөгтэй бөгөөд олонх нь тухайн улс орны онцлог шинжээс хамаарах ч авлигын эсрэг боловсролын амжилттай хөтөлбөрийн зургаан чухал бүрэлдэхүүн хэсгийг онцлохыг хүслээ.

Нэгдүгээрт, авлигын эсрэг сургалтын хөтөлбөрийг сургуулиудад хэрэгжүүлэхээс өмнө сургуулиудыг эдгээр сургалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхийг шаардах хууль эрх зүйн үндсийг бүрдүүлэх хэрэгтэй. Учир нь авлигын эсрэг сургалтын шинэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сургуулиуд нэмэлт зардал, цаг хугацаа, эрч хүч зарцуулах шаардлагатай болдог тул олон сургууль хуулиар зохицуулагдаагүй шаардлагаас татгалзах болно (жишээлбэл, тодорхой хугацаанд хөтөлбөрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд тухайн сургуулийн сургалтын үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг хүчингүй болгох).

Хоёрдугаарт, авлигын эсрэг боловсролыг зөвхөн семинарын нэг хэлбэр, эсвэл нэг удаагийн сургалт хэлбэрээр зохион байгуулах бус, сургуулийн сургалтын хөтөлбөрт суулгах хэрэгтэй. Авлигын эсрэг боловсролын зорилго нь авлигыг тэвчих, эсвэл хүлээн авах гэхээсээ илүү түүнийг жигшдэг иргэдийн бүхэл бүтэн үеийг хүмүүжүүлэх явдал бөгөөд ингэснээр соёлд хадгалагдаж буй авлигын магадлалыг бууруулна. Учир нь, сургууль бол хүүхдүүдийн ихэнх цагаа өнгөрүүлдэг газар тул аль болох эрт үе шатанд нь хүүхдийг нийгмийн зөв хэм хэмжээнд сургах

²⁰⁹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2015/04/20/making-anticorruption-education-work-the-to-do-list/>

²¹⁰ <http://philair.ph/publication/index.php/ijgc/article/view/231>

²¹¹ <https://www.forbes.com/sites/riskmap/2014/06/25/indias-corruption-culture-a-dangerous-game-for-businesses/?sh=349f519c1334>

²¹² <https://www.theglobalist.com/just-how-deeply-ingrained-is-corruption-in-china/>

үр дүнтэй хэрэгсэл болдог. Гэхдээ үр дүнтэй байлгахын тулд авлигын эсрэг мессежийг бага сургуулийн түвшинээс эхлээд сургалтын хөтөлбөрт бүхэлд нь шингээх ёстой.

Гуравдугаарт, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхээс өмнө боловсролын сэтгэл зүйч болон бусад мэргэжилтнүүдийн ур чадварыг ашиглан авлигатай тэмцэх хэм хэмжээг хэвшүүлэх хамгийн үр дүнтэй аргыг олохын тулд сайтар судалж үзэх ёстой. Ингэснээр янз бүрийн насны хүүхдүүдэд авлигын эсрэг боловсрол олгоход чиглэсэн оновчтой арга замыг олох, улмаар сургалтын агуулга, хэрэглэгдэхүүнийг хэтэрхий эрт, эсвэл оройтож, хэт хурдан, эсвэл удаанаар танилцуулахгүй байх боломж бүрдэнэ. Бага сургуулийн сурагчдад авлигын эсрэг боловсрол олгоход Бүгд Найрамдах Македон Улсын²¹³ боловсруулсан хөтөлбөр, багшийн гарын авлага, сурталчилгааны материалаас суралцах боломжтой. Шаардлагатай бол аймаг, муж бүр сургалтын хөтөлбөрөө тухайн газар нутгийн нөхцөл байдалд тохируулан боловсруулж болно.

Дөрөвдүгээрт, авлигын эсрэг сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх чадварт нь итгэлтэй байхын тулд багш нарыг бэлтгэх шаардлагатай. Энэ маш чухал, учир нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх нь багш нар сурагчдад сургалтын хөтөлбөрөө хэрхэн хүргэх чадвараас хамаарна.

Тавдугаарт, засгийн газар хэмжилт, үнэлгээний асуудалд анхаарал хандуулах ёстой бөгөөд ингэснээр хөтөлбөрүүд хэр сайн хэрэгжиж байгааг тодорхойлж, үр дүнгүй бол тохируулах боломжтой болно. Жишээлбэл, сурагчдыг математик, түүх гэх мэт “үндсэн” хичээлүүд дээр эзэмшсэн мэдлэгийг тодорхойлох ижил төстэй тест, арга техникийг ашиглан тогтмол үнэлэх хэрэгтэй. Хөтөлбөрийн ерөнхий нөлөөллийг хянахдаа ТИ-ээс АТИ-дээ ашигладаг үнэлгээний загварыг өөрийн улсын нэр хүнд бүхий байгууллагуудын цуглуулсан судалгаа, авлигын үнэлгээг хослуулан хэрэглэж болно. ТИ-ийн АТИ нь дэлхий даяар хамгийн өргөн хэрэглэгддэг авлигын үзүүлэлт юм. Хэдийгээр зарим хүмүүс, тухайлбал энэ²¹⁴ блог дээр түүний хэрэглээний талаар асуулт, шүүмжлэл дэвшүүлдэг боловч хөтөлбөрийн амжилтыг хэмжих нь төвөгтэй ажил бөгөөд хаа нэг газраас эхлэх хэрэгтэй билээ. Нэмж дурдахад, үнэлгээ, үнэлгээний схемийг боловсруулахдаа улс орнууд хэт том ч биш, хэт жижиг ч биш, хэрэгжих боломжтой зорилтуудыг дэвшүүлэх хэрэгтэй.

Зургаадугаарт, авлигын эсрэг мэдээллийг хамгийн ихээр үнэгүйдүүлж байдаг зүйл нь сургууль доторх авлига өөрөө юм. Иймд засгын газраас сургуулийн авлигын үйлдэлд гэм буруутай этгээдэд хатуу чанга хариуцлага хүлээлгэх хэрэгтэй, ялангуяа, тус этгээд нь багш байгаа тохиолдолд бүр ихээр анхаарал хандуулах хэрэгтэй юм.

Хэрэв бат бөх суурь тавьж чадвал авлигын эсрэг боловсрол нь авлигыг дэмжигч соёлыг нураах иргэдийн шинэ үеийг бий болгох хамгийн тохиромжтой, үр дүнтэй арга замуудын нэг болж чадна.

Мөнгө угаахтай тэмцэх ирээдүйн арга зам:

Блокчэйн технологи урсгалыг эргүүлж чадах уу?²¹⁵

2016.11.07. Christoph Nedopil. Санхүү, мэдээллийн технологийн сүүлийн арван жилийн хамгийн сэтгэл хөдөлгөөм өөрчлөлтүүдийн нэг бол блокчэйн технологи юм. Блокчэйн гэдэг нь нэг юмуу олон сервер дээр байрласан гэхээсээ илүүтэй компьютерүүдийн сүлжээнд тархсан мэдээллийн сан юм. Блокчэйн технологийн анхны бөгөөд хамгийн алдартай практик хэрэглээ бол цахим валют болох биткойн юм. Блокчэйн технологийг ашигладаг биткойн болон түүнтэй адилтгах криптовалютууд нь хэрэглэгчдэд нэрээ нууцалсан бэлэн мөнгөний гүйлгээтэй ижил үйлчилгээ санал болгодог бөгөөд хар тамхи, зэвсэг, биеэ үнэлэлтийн хууль бус гүйлгээтэй ч холбогддог. Тиймээс санхүүгийн гэмт хэрэг болон авлигатай тэмцэгчид блокчэйн технологийг заримдаа асуудал, сорилт гэж үздэг нь гайхах зүйл биш юм.

Гэхдээ блокчэйн технологийн өөр олон төрлийн хэрэглээ бий бөгөөд үнэн хэрэгтээ ихэнх нь эдгээр гэмт хэрэгтэй тэмцэхэд тусалдаг. Энэ блог дээр бичсэн өмнөх нийтлэлдээ Jeanne Jeong

²¹³ https://www.unodc.org/documents/corruption/WG-Prevention/Art_13_Awareness-raising_measures_and_Education/Macedonia.pdf

²¹⁴ <https://globalanticorruptionblog.com/2014/12/04/transparency-international-makes-its-data-less-transparent-why-ti-should-be-ashamed-of-its-2014-cpi-report/>

²¹⁵ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2016/11/07/the-road-ahead-in-anti-money-laundering-aml-can-blockchain-technology-turn-the-tide/>

блокчэйн технологийг газрын бүртгэлд хэрхэн ашиглах талаар хэлэлцсэн байна²¹⁶. Үе үе дурдагддаг (эндээс²¹⁷ болон эндээс²¹⁸ үзнэ үү) боловч хараахан хангалттай хэрэгжүүлээгүй байгаа блокчэйний өөр нэг хэрэглээ бол мөнгө угаахтай тэмцэхтэй холбоотой. Одоогийн байдлаар банкууд мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээнд жилд ойролцоогоор 10 тэрбум ам.доллар зарцуулж буй боловч мөнгө угаах ажиллагаа асар өргөн хүрээнд явагдсаар байна. Мөнгө угаах ажиллагааны зорилго нь хууль бусаар олж авсан мөнгөө (жишээ нь, авлигын замаар) “цэвэр” мөнгө болгон “угааж”, улмаар мөнгөний гарал үүслийг мөшгих аргагүй болгох явдал юм. Блокчэйн технологи нь мөнгө угаахтай тэмцэх хүчин чармайлтыг илүү үр дүнтэй, өртөг багатай болгох таван онцлог шинж чанартай:

- *Зөвшилцөл*: Блокчэйний тархмал бүртгэлийн технологийн ачаар хүн бүр (эсвэл дор хаяж, оролцсон хүмүүс) гүйлгээний талаарх ижил мэдээллийг шууд харж болно. Бие биетэйгээ харилцаж, тус тусдаа шинэчлэгддэг мэдээллийн сангаас ялгаатай нь блокчэйний шинэчлэлүүд нэгэн зэрэг хийгддэг. Өөрөөр хэлбэл, “Би таны харж байгаа зүйлийг харж байгаа”, “Миний мэдэж байгаа зүйлийг та мэдэж байгаа гэдгийг би мэдэж байгаа” гэх мэтэд банкууд итгэлтэй байж болно. Энэ бол итгэлцлийн үндэс бөгөөд гүйлгээний дундын зуучлагчийг шахан гаргах боломжтой юм.
- *Хүчин төгөлдөр байдал*: Блокчэйн технологи нь гүйлгээний дүрмийн талаарх нийтлэг зөвшилцлөөр хангадаг тул систем дэх шинэчлэлт бүр хүчин төгөлдөр байх баталгааг өгдөг. Энэ нь, мэдээллийн баазын алдааг нэхэх зэрэг аргаар системээр тоглоход²¹⁹ төвөгтэй болгодог.
- *Цор ганц байдал*: Блокчэйний системд зөрчилтэй хоёр оролт үүсгэх боломжгүй бөгөөд мөнгийг хууль бусаар олж авсан хэр нь хууль ёсны эх үүсвэртэй гэсэн дүр эсгэх боломжгүй болгож байгаа юм.
- *Өөрчлөгдөшгүй байдал*: Блокчэйн бүртгэлийг төвлөрсөн мэдээллийн санд бус бүх сүлжээгээр тархсан бүртгэлийн системд тараасан байдаг тул нэгэнт бүртгэгдсэн блокчэйн гүйлгээ бараг л “өөрчлөгдөшгүй” байдаг. Өмнөх гүйлгээний өгөгдлийг өөрчлөх боломжгүй, зөвхөн шинэчилж болох бөгөөд өмнөх гүйлгээний өгөгдөл үргэлж хүчинтэй хэвээр байна. Тиймээс, гүйлгээний өгөгдлийг нэгэнт бүртгэсний дараа (мөнгөний өмнөх эзэн, шинэ эзэн, гүйлгээний үндэслэлийг оруулаад) эдгээр өгөгдлийг хуурамчаар үйлдэх боломжгүй.
- *Баталгаажуулалт*: Гүйлгээ бүр дор хаяж хоёр нууц түлхүүртэй холбогдсон байдаг ба “мастер түлхүүр” гэсэн ойлголт блокчэйний нэг хэсэг биш юм. Энэ нь администратор эсвэл “super-user” мэдээллийн баазыг дангаар нь өөрчилж болдог одоогийн мэдээллийн сангийн системээс эрс ялгаатай бөгөөд энэ нь аюулгүй байдлын үүднээс эрсдэлтэй юм.

Дүгнэж хэлэхэд, блокчэйн технологиор мөнгө шилжүүлэх нь систем дэх зоос бүрийн түүхэн болон одоогийн эзэмшлийг хянах боломжийг олгодог. Энэ бол долларын дэвсгэрт бүрийн серийн дугаарыг хараад тэр долларыг эзэмшиж байсан бүх хүнийг болон хэзээ, хаана, яагаад шилжүүлснийг олж мэдэх боломжтой гэсэнтэй ижил юм.

Онолын хувьд

Өнөөдрийн байдлаар блокчэйн нь ихэнх зохицуулагч, банк, бизнес эрхлэгчид, тэр ч байтугай олон технологийн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд “хар хайрцаг”²²⁰ хэвээр байна. 2008 онд биткойныг танилцуулснаас хойш энэхүү технологи санхүүгийн салбарт хэрхэн хувьсгал хийх

²¹⁶ <https://globalanticorruptionblog.com/2016/01/08/bitcoin-blockchain-and-land-reform-can-an-incorruptible-technology-cure-corruption/>

²¹⁷ <https://infocastinc.com/market-insights/technology/blockchain-for-enterprise-focus-on-kyc-aml-and-regulatory-compliance-are-we-calling-it-regtech/>

²¹⁸ <https://news.bitcoin.com/blockchain-prevent-money-laundering/>

²¹⁹ “Gaming the system”: 1) Бусад хэрэглэгчдээс илүү давуу байдал олж авахын тулд тухайн системийг удирдах зориулалттай дүрмийг гуйвуулах, ашиглах [WhatIs]. 2) Хүссэн үр дүндээ хүрэхийн тулд системийг хамгаалах зорилготой дүрэм, журмыг ашиглах [Wiki].

²²⁰ “Black box” гэдэг хэллэгийг маркетингийн салбарт “хэрэглэгчийн шийдвэр гаргах үйл явц бүрэн ойлгогдохгүй буюу урьдчилан таамаглах боломжгүй” байгаа тохиолдолд ашигладаг байна.(X.O)

талаар ажиглагчид хэлэлцсээр байгаа (жишээлбэл, энэ²²¹ болон энэ²²²) боловч одоогоор цөөн тооны програм л санхүүгийн гол гол институцад нэвтэрсэн байна. Санхүүгийн салбарт блокчэйн технологитой хамт урагшлахад хамгийн их тулгамдаж буй асуудал бол, зохицуулагчид болон банкуудын тэмдэглэснээр, блокчэйн протоколын стандартчилал юм. Одоогийн байдлаар олон тооны криптовалют, блокчэйн сүлжээ, протоколууд гарч ирсэн бөгөөд санхүүгийн технологийн олон зуун тоглогчид зах зээлийг хувааж байна. Өөр өөр сүлжээнүүд хоорондоо нэгэн зэрэг харилцах боломжгүй болох тул стандартчилал хийхгүй л бол блокчэйний ихэнх давуу талыг ашиглаж чадахгүйд хүрэх юм. Түүнчлэн, технологийн талаар гүн гүнзгий ойлголтгүйгээр нийтийн болон мэргэжлийн салбар дахь хэрэглэгчдийн технологид итгэх итгэлийг олж авахад бэрх байх болно. Итгэл бол санхүүгийн гүйлгээний хамгийн чухал элемент юм.

Гэхдээ юмс маш хурдан өөрчлөгдөж байна. Жишээлбэл, 10 дугаар сарын 24-нд Австралийн Хамтын нөхөрлөлийн банк болон Веллс Фарго компаниуд хэд хэдэн блокчэйн технологийг ашигласан банк хоорондын анхны хил дамнасан арилжаа амжилттай болсныг зарлалаа²²³. Мөн 2016 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр дэлхийн 70 гаруй санхүүгийн байгууллагуудын консорциумын боловсруулсан блокчэйн технологийн бүртгэл болох Corda²²⁴ нээлттэй эх болох бөгөөд, ингэснээр эх код нь үнэ төлбөргүйгээр олон нийтэд нээлттэй болох юм. Санхүүгийн янз бүрийн тоглогчид Кордаг хэрхэн нэгтгэхийг ажиглах нь сонирхолтой бөгөөд чухал үйл явдал байх болно. Бусад ихэнх нээлттэй эхийн стандартаас ялгаатай нь Корда хэд хэдэн онцлог шинж чанартай байна:

- Стандартад хамгийн сайн нийцсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжийг банкуудад олгоно;
- Бүх өгөгдлийг блокчэйний оролцогчдод хуулбарлахгүй байх замаар ил тод байдлыг бий болгохын оронд пүүсүүдийн хооронд байгуулсан хувийн хэлэлцээрт анхаарал хандуулдаг (энэ нь хувийн нууцлалыг хамгаалах боломжийг олгох юм);
- Маргааныг ил тод, шуурхай шийдвэрлэх боломжийг олгохын тулд хэлэлцээрт өөрөө өөрийгөө төлөөлөх заалтыг оруулсан байдаг;
- Бизнесийн логикийг²²⁵ одоо байгаа код руу бичих боломжийг олгодог.

Хэрэв энэ стандартыг өргөн хүрээнд нэвтрүүлэх боломжтой болвол энэ нь зохицуулагчид, аудиторуд, шүүгчдэд хууль ёсны гүйлгээнд хяналт тавих зорилгоор банкны болон нийт салбарын блокчэйн системд шаардлагатай боловсруулалтад хүчин чармайлтаа чиглүүлэх боломжийг олгох болно. Энэхүү технологийн хэрэглээ өргөжих нь хууль тогтоох болон гүйцэтгэх байгууллагуудад аливаа хууль бус гүйлгээг бүхэлд нь шууд, үнэн зөв олж харах замаар мөнгө угаахтай тэмцэх шинэ, хүчирхэг гүйцэтгэх механизмыг бий болгож, авлигатай тэмцэх дэлхий нийтийн үйл ажиллагаанд томоохон алхам болох нь гарцаагүй юм.

[Авлигын эсрэг бодлогод нэмэр болох ёс суртахууны сэтгэл зүйн сургамжууд²²⁶](#)

2017.09.18. Luana Vargas Macedo Хүлээж буй төлөөс нь хүртэж болох үр ашгаас давсан тохиолдолд эрсдэл бүхий хүмүүс авлигатай холбоотой үйл ажиллагаанд оролцохоос татгалздаг зүй тогтлын дагуу ихэнх улс орнууд ялын хэмжээ болон ял авах магадлалыг өсгөх бодлогоор төрийн албан дахь авлигатай тэмцэхийг хичээдэг. Эл хандлага, мэдээжийн хэрэг, тодорхой үр дүнд хүргэдэг боловч хангалттай биш бөгөөд авлигад өртөж болзошгүй төрийн албан тушаалтнуудыг “ухаалаг тоглогч” гэж үзэх үзэл дээр зөвхөн үндэслэсэн авлигатай тэмцэх стратеги бүрэн үр дүнтэй байх магадлал багатай юм. Учир нь хүн төрөлхтөн бол зөвхөн ухаалаг

²²¹ <https://bravenewcoin.com/insights/moodys-new-report-identifies-25-top-blockchain-use-cases-from-a-list-of-120>

²²² <http://www.blockchaintechnologies.com/>

²²³ <https://ca.news.yahoo.com/major-banks-mark-first-ever-international-trade-using-053746319--sector.html>

²²⁴ <https://www.corda.net/>

²²⁵ Компьютерын програм хангамжийн хувьд бизнесийн логик буюу домэйны логик нь өгөгдлийг хэрхэн үүсгэх, хадгалах, өөрчлөхийг тодорхойлдог бодит ертөнцийн бизнесийн дүрмийг кодчилдог програмын хэсэг юм. (X.O)

²²⁶ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2017/09/18/lessons-of-moral-psychology-for-anticorruption-strategy/>

төдийгүй, бас ёс суртахуунтай амьтан. Энэ блог дээр нэгэнт ярьсанчлан (эндээс²²⁷ болон эндээс²²⁸ үзнэ үү) авлигад өртөж болзошгүй төрийн албан тушаалтны шийдвэр гаргах үйл явцад түүний хүлээж буй (материаллаг) төлөөс хийгээд үр ашгийн тооцооноос гадна, түүний ёс суртахууны үнэлэмж, өөрийн төсөөлөл (self-image) нь мөн нөлөөлдөг.

Чухамдаа хүмүүс өөрсдийн ёс суртахууны хэм хэмжээний дагуу үйл ажиллагаа явуулж байх үед тэдний тархийг урамшуулах төвүүд идэвхждэг бөгөөд энэ нь хүмүүс яагаад шударга байдал, ёс суртахуунлаг амьдралыг эрхэмлэдэг болохыг тайлбарлаж болох юм. Гэсэн хэдий ч, ёс суртахууны хувьд тэгш шударга хүмүүс ч авлигад өртөж болзошгүй. Тэгвэл ашигтай хэр нь шударга бус үйлдэл хийх, эсвэл ёс суртахууны хэм хэмжээгээ баримтлан өөрийн эерэг төсөөлөл (positive self-image)-ийг хадгалах эсэхээ сонгохдоо хувь хүмүүс юуг анхаарч үздэг вэ?

Ёс суртахууны сэтгэл судлал (moral psychology) болон тархи судлал (neuroscience)-ын өсөн нэмэгдэж байгаа судалгаа нь хүмүүс өөрсдийгөө “хууран мэхлэгч” гэж тооцохгүйгээр тодорхой түвшинд хууран мэхлэх боломж олгодог сэтгэлзүйн зарим механизмыг, тухайлбал рационалчлал ашигладгийг харуулж байна; энэ нь, тэд өөрийн эерэг төсөөлөлдөө харшлахгүйгээр шударга бус зан авираас ашиг хүртэх боломжийг олгодог аж. Гэхдээ хүмүүс ёс суртахуунлаг бус зан авираа өөртөө зөвтгөхөд илүү хэцүү болох тусам тэд шударга бус үйлдэл хийх магадлал буурдаг байна. Шударга бус зан авир гаргах хандлагад урхинд орсон үедээ өөрийгөө хянах тухайн хүний чадвар, өөрөөр хэлбэл, урт хугацааны зорилгодоо хүрэхийн тулд богино хугацааны үр ашиг хүртэх хүслээ дарах чадвар нөлөөлдөг.

Эдгээр ойлголтуудад анхаарал хандуулснаар рациональчлал ашиглахыг зогсоох, шударга бус үйлдэл хийх нөхцөлд өөрийгөө хянах чадварыг дээшлүүлэхэд аль алинд нь тохиромжтой авлигатай тэмцэх бодлогын загвар боловсруулах боломжтой болно. Жишээлбэл, төрийн байгууллагууд (ялангуяа төрийн худалдан авах ажиллагаа гэх мэт авлига ихтэй салбаруудад) дараах алхмуудыг хийж болох юм:

- *Нэгдүгээрт*, удирдах ажилтнууд төрийн албан хаагчдын бие даасан үйл ажиллагаа бусдын үйл ажиллагаатай хамсран авлигад хувь нэмэр оруулдаг болохыг албан ёсны/уламжлалт хуулийн хариуцлагаас үл хамааран ойлгуулах замаар тэдний хариуцлагатай байдлыг дээшлүүлж, ёс суртахууны хариуцлагын мэдрэмжийг хөгжүүлж чадна.
- *Хоёрдугаарт*, байгууллагууд ажилтан сонгон шалгаруулахдаа ёс суртахууны хяналт багатай/гэм буруугийн мэдрэмж багатай хүмүүсээс зайлсхийх зорилгоор зөвхөн мэдлэг чадвараас гадна, мөн ёс суртахууныг хэмждэг шударга байдлын сорилыг нэвтрүүлж болно. (Шударга байдлын сорилыг ашиглах талаар өмнө нь энд²²⁹ болон энд²³⁰ авж үзсэн болно.) Авлигатай тэмцэх үндэсний агентлагтаа ажилтан сонгон шалгаруулж авахдаа шударга байдлын сорил ашиглаж байсан Индонез гэх мэт улсын туршлага ёс суртахуунлаг бус зан авир гаргах хандлагатай хүмүүсийг тодорхойлоход энэхүү сорил ач холбогдолтой болохыг нотолж байгааг дурдах нь зүйтэй юм. Энэ төрлийн арга хэмжээг болгоомжтой боловсруулж, хэрэгжүүлэх шаардлагатай (энэ нь ажил хөдөлмөр эрхлэх эрхийн зөрчилд тооцогдож магадгүй юм) боловч системийн авлигад автсан орнуудад үр дүн нь ирээдүйтэй байж болох юм.
- *Гуравдугаарт*, байгууллагууд өдөр тутмын ёс зүйн асуудалд шийдэл санал болгох тогтмол зохион байгуулагддаг ёс зүйн сургалт болон ёс зүйн дүрэмтэй байх ёстой. Энэ нь ёс суртахууны хэм хэмжээний талаарх өөрийн ухамсрыг өдөөж, шударга бус зүйлийг зөвтгөхийг улам төвөгтэй болгодог. Үр дүнд нь, ийм нөхцөл байдалд үйлдсэн ёс суртахуунлаг бус үйлдэл тухайн хувь хүний өөрийн үзэл баримтлалд илүү их хохирол учруулж, шударга бус зүйлийн төлөөх сэтгэлзүйн төлөөсийг улам нэмэгдүүлдэг. Дахин хэлэхэд, Индонезийн авлигатай тэмцэх газрын богинохон, гэхдээ маш хатуу ёс зүйн дүрмийн талаар удирдлага, ажилтнууд үе үе хянаж, хэлэлцэж байдаг жишээг дурдах нь зүйтэй.

²²⁷ <https://globalanticorruptionblog.com/2015/08/28/the-social-psychology-of-corruption-lack-thereof/>

²²⁸ <https://globalanticorruptionblog.com/2016/02/11/guest-post-a-behavioral-science-approach-to-preventing-corruption/>

²²⁹ <https://globalanticorruptionblog.com/2014/06/26/the-importance-of-personnel-selection-in-promoting-government-integrity-some-evidence-from-india/>

²³⁰ <https://globalanticorruptionblog.com/2014/07/01/a-greater-role-for-hr-and-ethics-screening-in-corporate-anticorruption-compliance/>

Эдгээр нь хүмүүс бол ёс суртахуунтай амьтан гэдгийг хүлээн зөвшөөрөх нь авлигын эсрэг энгийн, хямд төсөр бодлогын шинэ чиглэл болохыг харуулсан цөөн хэдэн жишээ юм. Авлигын эсрэг аливаа бодлого нь хүний хэм хэмжээнээс гажсан зан үйлийг хязгаарлахад чиглэгддэг тул дэлхий дахинаа авлигыг таслан зогсоохын тулд хүний оюун ухаан хэрхэн ажилладгийг ойлгож ухаарах нь зайлшгүй чухал билээ.

Худалдан авах ажиллагаан дахь авлигатай тэмцэхэд блокчэйнийг ашиглах нь²³¹

2019.08.19. Marvellous Ikekwumere. Тендерийн будилаан, далд худалдаачид, улс төртэй холбоотой пүүсүүдтэй гэрээ байгуулах зэрэг худалдан авах ажиллагаан дахь авлига нь дэлхий нийтийн өмнө тулгарч буй асар том асуудал бөгөөд татвар төлөгчдөд жил бүр 2 их наяд долларын хохирол учруулдаг²³². Шинэ технологиуд нь бүхнийг эмчлэгч шидэт үрэл биш хэдий ч энэ төрлийн авлигатай тэмцэх шинэ арга техникийг санал болгож буй юм. Ийм технологийн нэг бол блокчэйн.

Биткойн гэх мэт криптовалютуудын үндсэн технологи гэдгээрээ алдартай блокчэйн бол тархмал бүртгэлийн технологи²³³ (ТБТ) бөгөөд үйл явдлын цагийн дардас бүхий, тархмал компьютерын сүлжээгээр баталгаажуулсан, хөндлөнгөөс оролцох, өөрчлөх боломжгүй бүртгэл юм. ТБТ нь гүйлгээ бүрийг бүрэн хянах боломжийг олгодог мэдээллийн мөрийг бий болгож, гүйлгээний он цагийн жагсаалтыг шифрлэгдсэн бүртгэлд хадгалдаг. Гүйлгээг найдвартай, танигдахуйц блок болгон нэгтгэж, дараа нь харгалзах сүлжээнд нэмнэ²³⁴. Блокчэйнийг тархмал хэрэглэгчид хянаж, баталгаажуулдаг бөгөөд ингэснээр шат дараалал, төвлөрсөн эрх мэдэл, дундын зуучлагчийг алга болгоно. Блокчэйн нь криптовалютыг хэрэгжүүлэх боломж олгодог гэдгээрээ алдартай боловч авлигын эсрэг үйл ажиллагаанд ашиглах зэрэг өөр олон төрлийн хэрэглээтэй юм. Жишээлбэл, Танзани улс энэхүү технологийг ашиглан төрийн байгууллага дахь “үл үзэгдэх ажилчид”-ыг цэвэрлэж, цаасан дээр л байдаг хуурамч ажилчдад сар бүр 430 тэрбум танзани шиллинг (ойролцоогоор 195.4 сая ам.доллар)-ийг тэдний цалинд зарцуулж байсныг зогсоожээ²³⁵. Мөн Нигерийн гаалийн алба санхүүгийн гүйлгээний мэдээллийг хадгалах, эдгээр гүйлгээг компьютерын сүлжээгээр хуваалцах зорилгоор блокчэйн технологийг ашигласан байна²³⁶.

Худалдан авах ажиллагаан дахь авлигын нийтлэг хэлбэрүүдтэй тэмцэхэд блокчэйн технологийг ашиглаж болно. Систем дараах байдлаар ажиллана:

- Засгийн газар тендер зарлахдаа гэрээний талууд хоорондоо харилцааар тохиролцсон дүрмийг тогтоодог өөрөө ажилладаг компьютерын код (Self-executing computer code) болох “ухаалаг гэрээ” хэлбэрээр зарладаг. Тендерийг үнэлгээний код, тендер шалгаруулалтад оролцох эцсийн хугацааны хамт блокчэйн дээр онлайнаар байрлуулна.
- Боломжит оролцогчид тендерийн хариуг (шаардлагатай нэмэлт баримт бичгийн хамт) байршуулах бөгөөд эдгээр тендер, баримт бичгийг шифрлэж, ухаалаг гэрээний блокчэйнд нэмж оруулна. Тендер болон холбогдох материалыг байршуулж, хугацааны дардас дарах тул үүнээс хойш баримтыг өөрчлөх боломжгүй болно. Тиймээс, жишээлбэл, анхны мэдүүлгийн дараа тендерээ өсгөх, бууруулах оролдлого нь блокчэйнд автоматаар бүртгэгдэх бөгөөд энэ нь нууцаар хуйвалдах оролдлого хийх болон бусад эргэлзээтэй зан үйлийг олж тогтооход хялбар болгодог.
- Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахад блокчэйн дээрх ухаалаг гэрээ нь шинэ тендер хүлээн авахаа болино. Дараа нь засгийн газар ирүүлсэн бүх тендерийг татаж аваад, үнэлгээний кодыг ажиллуулж, өгөгдлийг хамгийн сайн хангасан тендерийг сонгоно. Мэдээлэл нь блокчэйн дээр аль хэдийн хадгалагдсан байдаг тул төрийн албан тушаалтнууд тодорхой оролцогчдод давуу байдал олгох зорилготой луйврын

²³¹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2019/08/19/leveraging-blockchain-to-combat-procurement-corruption/>

²³² <https://cointellegraph.com/news/spain-tackles-corruption-with-blockchain-ai-and-amendments-to-its-anti-corruption-laws-expert-take>

²³³ <https://knowledgehub.transparency.org/assets/uploads/helpdesk/Blockchain-bitcoin-and-corruption-2018.pdf>

²³⁴ <https://www.ozy.com/html/fast-forward/wtf-is-blockchain-inside-the-most-disruptive-tech-since-the-internet/81567/>

²³⁵ <https://globalanticorruptionblog.com/2017/06/13/tanzanias-president-magufuli-bulldozes-the-civil-service-is-this-an-anticorruption-breakthrough/>

²³⁶ <https://www.ozy.com/around-the-world/to-curb-ghost-workers-and-coffee-corruption-africa-turns-to-blockchain/91029/>

өөрчлөлтийг бүртгэх ба үүнийг хожим илрүүлэх боломжтой юм. Цаашилбал, програм нь эцсийн хугацаа дуустал төрийн худалдан авах ажиллагааны ажилтнууд тендерийг өөрчлөх, харахаас сэргийлдэг ба авлигач албан тушаалтнуудад тэдний ашиг сонирхол бүхий компаниудын төлөө тендерийн үйл явцыг удирдахад ихээхэн бэрхшээлтэй болгодог.

- Нэмж дурдахад блокчэйн нь тендер болон сонгон шалгаруулалтын явцын бүрэн бүртгэлийг хадгалдаг. Тиймээс гүйлгээ бүрийг бүрэн хянах боломжтой бөгөөд шаардлага тохиолдолд нэмэлт аудит хийхэд хялбар байдаг (эндээс²³⁷ болон эндээс²³⁸ үзнэ үү).
- Эцэст нь блокчэйн технологи нь тендер шалгаруулалтын үйл явцын шударга байдлыг хадгалахаас гадна гэрээг хэрэгжүүлэх явцад авлигаас урьдчилан сэргийлэхэд тусалдаг. Жишээлбэл, зарим тохиолдолд гүйцэтгэгч тодорхой материалын баримт бичдэг боловч үнэндээ ажлыг дуусгахын тулд хямд, чанар муутай материал ашигласан байдаг. Гүйцэтгэгчийн бусад компанитай (материал нийлүүлэгчид гэх мэт) хийсэн гүйлгээг блокчэйн дээр хадгалдаг бөгөөд бүртгэлийг төрийн аудитын шалгалтад оруулах боломжтой байдаг тул засгийн газар зөв материал, зөв үйлчилгээг зөв газар, зөв цагт худалдаж авсан эсэхийг баталгаажуулахад илүү хялбар байдаг.

Ерөнхийдөө цаасан систем төдийгүй уламжлалт цахим худалдан авалтын системтэй харьцуулахад блокчэйний давуу тал бол илүү ил тод бөгөөд өөрчлөх боломжгүй юм. Энэхүү технологи нь туршилтын шатандаа явж байгаа²³⁹ бөгөөд гүйцэтгэлийн хувьд бэрхшээлтэй тулгарч²⁴⁰ магадгүй юм. Гэсэн хэдий ч блокчэйн технологи нь төрийн худалдан авах ажиллагаан дахь авлигын хамгийн ноцтой хэлбэрүүдийг таслан зогсоох технологийн хэрэгсэл болохын хувьд өөрийн гэсэн онцлогтой найдварыг төрүүлж байна.

Украин улсын оюутан сурагчдын авлигын талаарх үзэл бодолд видео бичлэг нөлөөлж буй байдал²⁴¹

2019.09. Elena Denisova-Schmidt, Martin Huber, Yaroslav Prytula. Авлигын талаарх аливаа улс орны хүүхэд, залуучуудын үзэл бодол тэдний ирээдүйн ажил хөдөлмөр, амьдралд ихээхэн нөлөөлөл үзүүлдэг бөгөөд авлигыг хүлээн зөвшөөрөх байдал нэмэгдэх нь тухайн улсын эдийн засагт сөргөөр нөлөөлж болзошгүй. Иймээс оюутан, сурагчдад авлигын хор хөнөөлийг таниулах боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Швейцари улсын Сэинт Галлены их сургууль Украин улсын гурван мянга гаруй оюутан, сурагчдад тус хөтөлбөр хэрхэн нөлөөлж буй талаар судалгаа боловсруулсан байна.

Судалгаанд гурван төрлийн видео бичлэг ашиглажээ. Нэгдүгээр бичлэг нь 1 минут 4 секундийн урттай бөгөөд авлигаас шалтгаалан нийгэмд ур чадваргүй эмч бэлтгэгдэж, тухайн эмчийн ур чадварын алдаанаас шалтгаалан хүүхдийн эрүүл мэнд хохирч буй талаар харуулсан байна. Хоёрдугаар бичлэг нь 1 минут 14 секундийн урттай ба улс орны авлигын эсрэг үйл ажиллагааны үр дүнг сурвалжлагч тоон мэдээ үндэслэн тайлбарлаж буй бичлэг аж. Сүүлийн бичлэг нь 1 минут 38 секундийн урттай бөгөөд цахим орчноос хуулбарласан судалгааны материалыг өөрөө боловсруулсан мэтээр багшдаа хураалгаж буй оюутан сурагчийн талаар харуулсан байна.

Дээрх видео бичлэгүүд нь судалгаанд оролцогчдод дараах байдлаар нөлөөлөл үзүүлжээ.

1. Нэгдүгээр бичлэг нь судалгаанд оролцогчдод авлигын сөрөг нөлөөг үр дүнтэй таниулжээ. Судалгаанд оролцогчдоос авсан асуумжийн дагуу авлига бол гэмт хэрэг мөн гэх хариулт 5 хувиар, эрүүл мэндийн салбарт сөрөг нөлөө үзүүлж байна гэх хариулт 1 хувиар, Украины эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна гэх хариулт 10 хувиар тус тус нэмэгдсэн байна. Түүнчлэн авлига бол мөнгө олох хэрэгсэл мөн гэх хариулт 1 хувиар, бага цалинтай албан хаагчийн мөнгө олох хэрэгсэл мөн гэх хариулт 10 хувиар тус тус буурсан байна.

²³⁷ https://www.sun.ac.za/english/Documents/newsclips/InauguralLecture_ProfSopeWilliamsElegbe_23Oct2018.pdf

²³⁸ <https://www.coindesk.com/markets/2018/04/05/mexico-tests-blockchain-to-track-public-contract-bids/>

²³⁹ https://ssir.org/articles/entry/will_blockchain_disrupt_government_corruption

²⁴⁰ <https://www.dlapiper.com/en/uk/insights/publications/2017/06/blockchain-background-challenges-legal-issues/>

²⁴¹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: https://www.researchgate.net/publication/336156023_The_effects_of_anti-corruption_videos_on_attitudes_toward_corruption_in_a_Ukrainian_online_survey

2. Хоёрдугаар бичлэг нь судалгаанд оролцогчдын асуумжид дараах байдлаар нөлөөлжээ. Авлига бол шаардлагатай зүйл бөгөөд асуудлыг шийдвэрлэх хэрэгсэл мөн гэх хариулт 1 хувиар, бага цалинтай албан хаагчийн мөнгө олох хэрэгсэл мөн гэх хариулт 5 хувиар, амьдралын нэг хэсэг гэх хариулт 10 хувиар өссөн байна. Мөн авлига нь үндэстний онцлог чанар мөн гэх хариулт 5 хувиар буурчээ.
3. Гуравдугаар бичлэг нь судалгаанд оролцогчдын асуумжид бага зэргийн нөлөөлөл үзүүлжээ. Авлига бол гэмт хэрэг мөн гэх хариулт 5 хувиар нэмэгдсэн бол авлига бол шаардлагатай зүйл мөн гэх хариулт 10 хувиар буурсан байна.

Дүгнэхэд, нэгдүгээр видео бичлэг нь бусад бичлэгтэй харьцуулахад авлигын хор хөнөөлийг оюутан сурагчдад үр дүнтэй таниулж, авлига бол гэмт хэрэг бөгөөд хэрхэн шууд бусаар хүний амьдралд сөргөөр нөлөөлж буйг ойлгуулсан байна. Хоёрдугаар видео бичлэг нь судалгаанд оролцогчдод мэдээлэл өгөх байдлаар авлигын хор хөнөөлийг тайлбарласан боловч оюутан сурагчдын авлигыг жигших үзэл бодлыг нэмэгдүүлэх бус, харин эсрэгээрээ авлигын талаар эерэг сэтгэгдэл үлдээсэн байна. Гуравдугаар бичлэг нь судалгаанд оролцогчдод төдийлөн нөлөөлөл үзүүлээгүй юм. Төрийн албан хаагчид хахууль өгөх зэрэг бидний амьдралд тохиолдох боломжтой жишээ авж, сэтгэл хөдөлгөсөн видео бичлэг ашиглаж авлигын сөрөг нөлөөг оюутан, сурагчдад таниулах нь ихээхэн үр дүнтэй болохыг судалгааны үр дүн харуулж байна.

Авлига ба коронавирус²⁴²

2020.03.18. Коронавирусний тархалт цар тахлын хэмжээнд хүрч дэлхийн хэмжээнд эрүүл мэндийн салбар хямралтай нүүр тулж буй үед засгийн газрууд хүн амынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахын төлөө арга хэмжээ авж байна. Энэ нөхцөл байдал нь эрүүл мэндийн салбарын сул тал, авлигын эрсдэл, боломжийг бий болгож буй юм. Ийм хүнд нөхцөл байдалд эрүүл мэндийн салбарт авлига газар авбал цар тахлын эсрэг авж буй арга хэмжээний үр дүнг бууруулж, иргэд эрүүл мэндийн тусламж авж чадахгүйд хүрэх юм.

Ердийн үед эрүүл мэндийн салбар нь авлигын улмаас жилд 500 тэрбум ам.доллар алддаг гэсэн тооцоо байдаг.

Эрүүл мэндийн салбар нуран унахын даваан дээр байна

Дэлхийн хэмжээнд 164 улс цар тахалтай тулаад байна. 200,000 гаруй хүн өвчилж, 8,000 гаруй хүн нас барж, цаашид энэ тоо өдөр тутам өсөх хандлагатай байна.

Эрүүл мэндийн үйлчилгээ шаардлагатай байгаа иргэдийн тоо огцом өсөн нэмэгдэж буй энэ үед тогтвортой бус үндэсний эрүүл мэндийн салбарууд нуран унахад бэлэн байна. Ихэнх улс орнууд иргэдийнхээ амь насыг аврахад шаардлагатай эрүүл мэндийн албан хаагчдаар дутмаг байгаа бөгөөд коронавирuсийг оношлох, эмчлэх боломж хязгаарлагдмал байна.

Авлигын эрсдэлүүд

Харамсалтай нь хямралын үед хяналт суларч, авлига нэмэгдэх байдал ажиглагддаг. Дэлхийн эрүүл мэндийн салбарт өмнө нь учирч байсан онц байдлын үед, тухайлбал, Эбола вирус, гахайн ханиадны үед хүний зовлонгоор ашиг хонжоо ологчид гарч ирдгийг хүмүүс мэдэж авсан билээ. Эдгээр эрсдлийг урьдчилан тодорхойлох нь эрүүл мэндийн тусламж нэн шаардлагатай энэ үед дэлхийн хэмжээнд авж хэрэгжүүлж буй хүчин чармайлтад дэмжлэг болно.

Эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт

Эрүүл мэндийн салбар дахь эм, эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалт авлигын өндөр эрсдэлтэй байдаг.

Дэлхийн хэмжээнд худалдан авалтын 10%-25% нь авлигын улмаас алдагддаг хэмээн НҮБ-ын МБГХТА тооцоолсон байна. ЕХ-ны эрүүл мэндийн салбар дахь авлигын хэргийн 28% нь

²⁴² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж:

https://www.transparency.org/news/feature/corruption_and_the_coronavirus?utm_medium=email&utm_campaign=The%20week%20in%20corruption%2020%20March%202020&utm_content=The%20week%20in%20corruption%2020%20March%202020+CID_d047cad7b46c9b00b3ea13dedb122cc9&utm_source=Email%20marketing%20software&utm_medium=several%20critical%20anti-corruption%20measures

эмнэлгийн тоног төхөөрөмжийн худалдан авалттай холбоотой байна. Гэтэл нь энэ ердийн үеийн тооцоо юм.

Үнийн хөөрөгдөлөөс урьдчилан сэргийлэх нь

Коронавирусний улмаас дэлхийн хэмжээнд эм, эмнэлгийн хэрэгслийн хүрэлцээ муудаж буйг улс орнууд мэдээлж байна. Энэ нь худалдан авалтын эмзэгхэн процесст нэмэлт ачаалал болохоос гадна худалдан авахаас өөр ямарч сонголтгүй болсон засгийн газруудаас нийлүүлэгч компаниуд үнэ нэмэн мөнгө нэхэх эрсдлийг нэмэгдүүлнэ.

Худалдан авалтыг нээлттэй, ил тод байлгаснаар авлигын эрсдлийг бууруулах ач холбогдолтой. Авлигажсан субъектууд үнэ хөөрөгдөх боломжгүй болж засгийн газруудад боломжит үнэ санал болгоно.

Амны хаалт, бээлий, гар ариутгагчийн эрэлт, хэрэгцээ нь мөн эм, эмнэлгийн хэрэгслийн хомсдолд тодорхой хувийг эзэлдэг. Олон нийтийг хамарсан айдсыг далимдуулан ашиг олохын тулд худалдаачид ердийн хэрэглэгчдэд үнэ нэмэх асуудал гардаг.

Энэтхэгт жижиглэнгийн үнээс дээгүүр үнээр борлуулж буй бараа, бүтээгдэхүүний талаар мэдээлэл хүлээн авах утсыг иргэддээ зориулан бий болгосон. Amazon цахим худалдааны компани АНУ-д болон дэлхийн даяар коронавирсийг эмчилдэг, эсхүл тус вирусээс хамгаалдаг гэсэн хуурамч бүтээгдэхүүний жагсаалтыг интернэтэд устгаж байна.

Засгийн газрууд болон компаниуд ёс зүйгүй ашиг олох явдлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр илүү ихийг хийх ёстой ба хувийн компаниуд ашиг хөөцөлдөх асуудлыг эн тэргүүнд тавихаас татгалзах хэрэгтэй.

Дутагдалтай байгаа эмийн талаарх мэдээлэл солилцох

КОВИД-19 өвчний улмаас БНХАУ, Энэтхэг болон бусад улсын эм үйлдвэрлэгч компаниуд жороор олгодог эм, бусад эмэнд ордог бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг бууруулж байна. Чухал эм хүрэлцэхгүй байгаа ч төрийн байгууллагууд, тухайлбал, АНУ-ын Холбооны хүнс, эмийн хяналтын газар эдгээр эмийн жагсаалтыг олон нийтэд нээлттэй нэрлэхгүй байна. Энэхүү нээлттэй бус байдал нь нийлүүлэгч, хэрэглэгч, өвчтөнүүдийн сэтгэлийг зовоож байна. Нээлттэй мэдээлэл байхгүйгээс ямар эм хомсдохыг мэдэхгүй тул эрүүл мэндийн салбар цаашдын шийдвэрээ боловсруулах, боломжит эмийн үйлдвэрлэгчийг олох зэрэгт хүндрэл учирч болзошгүй юм.

Хямралын үед компанийн эрх ашгийг бодохоос илүүтэйгээр амин чухал эмийн хангалтыг боломжтой байлгах үүднээс засгийн газрууд хомсдолтой байгаа эмийн жагсаалтыг нээлттэй байлгах хэрэгтэй.

Эмчилгээ болон вакцин бүтээхэд шаардлагатай санхүүжилт

Улс орнууд цар тахалтай тэмцэж байхад эрдэмтэн, судлаачид КОВИД-19-ийн эсрэг вакцин гаргаж авах өрсөлдөөнөө эхлүүлээд байна. Үр дүнд нь засгийн газрууд вакцин хөгжүүлэх, гаргаж авахад ихээхэн хөрөнгө оруулж байна.

Тухайлбал, АНУ гэхэд 2002 оноос 700 сая ам.долларыг коронавирс, тухайлбал, амьсгалын замын цочмог халтай хам шинж (SARS) болон Ойрх Дорнодын амьсгалын замын цочмог хам шинж (MERS) зэргийг судлахад зарцуулаад байна. Гэтэл саяхан Англи коронавирс судлахад 20 сая фунт стерлингийг амлаад байгаа бөгөөд ЕХ энэ чиглэлийн өөрийн төсвийг 47.5 сая евро болгож өсгөв.

Засгийн газрууд орон нутаг, муж, бүс нутаг ба улсын хэмжээнд онцгой байдлын нөхцөлд тусламж үзүүлэх, хуваарилах зорилгоор нөөцөө өсгөж буй энэ үед авлигын эрсдлийг бууруулахын тулд анхаарал, болгоомжтой байх шаардлагатай.

Авлигачдын халаасыг зузаатгахгүйн тулд засгийн газрууд мөнгөн хөрөнгийн урсгалд мониторинг хийж, хөрөнгийг хянах хэрэгтэй юм.

Клиникийн туршилтын мэдээллийн ил тод байдал

АНУ-ын Анагаах ухааны хүрээлэнгийн 2009 оны тайланд анагаах ухааны судалгаа, боловсрол, үйлчилгээнд санхүүгийн ашиг сонирхол, хувийн нөлөөлөл ихээр тархсан байдаг талаар дурдсан байдаг. Вакцин гаргах асуудалд хувийн судалгааны байгууллагаас туршилт, судалгааны мэдээллийг санаатайгаар өөрчлөх явдал гардаг. Олон нийтийн эрүүл мэндийн иймэрхүү асуудалд

хувийн бизнесийн байгууллага, салбарын нөлөөлөл иргэд, гэр бүл, олон нийтийг эрсдэлд оруулах талтай байна. Иймд коронавирусний эсрэг гаргаж авах вакцин, эмийн үйлдвэрлэл нь хувийн компаниуд, эсхүл улс орнуудын нууц өрсөлдөөний талбар байх ёсгүй бөгөөд ил тод, хамтарсан ажил байх ёстой юм.

Энэ долоо хоногийн эхээр олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр коронавирусний эсрэг вакцин гаргах асуудлаар АНУ болон ХБНГУ-ын талаар мэдээллүүд (германы CureVac компанийн вирусны эсрэг вакцин гаргахаар ажиллаж буй судлаачдад ихээхэн хэмжээний мөнгө амласан талаар) гарч байсан нь хямралын үед эдгээр улсын тэргүүнүүдэд итгэх итгэлийг бууруулахаас гадна дэлхийн бусад улс орнуудад муу үлгэр дуурайлал болж буй юм.

Гахайн ханиаднаас авсан сургамж

Английн анагаах ухааны сэтгүүлийн мэдээлэлд дурдсанаар 2009-2010 оны гахайн ханиадны дэгдэлтийн үед Тамифлю эмийг зөвлөж байснаас үүдэлтэй тус эмэнд дэлхийн хэмжээнд зарцуулсан хөрөнгө 18 тэрбум ам.долларт хүрсэн гэжээ. Гэтэл 4 жилийн клиник туршилтын мэдээлэлд хийсэн үнэлгээгээр Швейцарийн эм үйлдвэрлэгч Роше компанийн Тамифлю эм нь гахайн ханиаданд парацетомолоос илүүгүйг тогтоожээ.

Хуурамч мэдээллээс урьдчилан сэргийлэх болон шүгэл үлээгчийг хамгаалах нь

Эрүүл мэндийн салбарын өмнө тулгараад буй онцгой нөхцөл байдлын үед хуурамч мэдээлэл тархах болон КОВИД-19-ийн бодит аюул, хөнөөлийн тухай дуугарч буй эрүүл мэндийн салбарын албан хаагчдын эсрэг арга хэмжээ авах вий гэсэн болгоомжлол төрж байна. Төрөөс нь мэдээлэл өгөхгүй, чимээгүй байхад цар тахлын цөм болсон БНХАУ-ын Ухань хотын эмч, шүгэл үлээгч Ли Венлянг цар тахлын ноцтой байдлын талаар цаг алдалгүй эрт анхааруулах гэж оролдож байв.

Мэдээллийн ил тод бус байдал нь засгийн газарт итгэх итгэлийг бууруулах, хуурамч мэдээлэл тархах аюултайг ДЭМБ онцолсон.

Хахуулийн эрсдэлүүд

КОВИД-19-ийн улмаас эмнэлгүүд, албан хаагчид эмнэлгийн ор, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр дутагдаж байна. Энэ нь авлигын эрсдлийг бий болгож байна. Эмнэлгийн албан хаагчид өнөөдөр хэнийг эхэлж эмчлэх ёстой вэ, хэн нь илүү хүнд байна вэ гэдгийг тодорхойлох хэцүү сонголттой тулгарч байна. Энэ нь хахуулийн орчныг бий болгож байна. ЕХ-ны 2017 оны тайланд дурдсанаар эрүүл мэндийн үйлчилгээ авахын тулд ЕХ-ны иргэдийн 19% нь хахууль өгдөг гэсэн бол энэ үзүүлэлт ХБНГУ, Франц, Испани улсад 29% болж өссөн байна. Дэлхийн авлигын хэмжүүр 2019 оны судалгааны дүнгээр Африк, Ойрх Дорнод, Хойд Африкийн улсуудад эрүүл мэндийн төв, эмнэлэгт хахуулийн хэмжээ 14%-д хүрдэг байна. Латин Америк болон Карибын тэнгисийн бүс нутагт энэ үзүүлэлт 10%-тай байна. Эмнэлгийн тусламж үйлчилгээг аль болох эрт авахын тулд хахууль өгөх хүсэлтэй өвчтөнүүдийн улмаас төлбөрийн чадваргүй, эмзэг давхаргынхан жагсаалтын сүүлд үлдэх эрсдэлтэй байна.

Эболагаас авсан сургамж

Хямралын үе дэх, тухайлбал, 2014-2016 онд болсон Эбола вирусны дэгдэлт, тархалт болон түүнийг тогтоон барихаар оролдож байсан үйл явц нь авлигын талаар ихээхэн сургамж дагуулсан. Гвиней, Сиерра-Леон дахь Эболагийн дэгдэлтийн үед авлигын улмаас 6 сая ам.долларын хохирол амссан тухай Олон улсын Улаан загалмайн нийгэмлэг мэдээлж байсан. Эболагийн үед хөрөнгө завших, урвуулан ашиглах, цалингийн тайланг буруу гаргах, давхар санхүүжилт хийх, эрүүл мэндийн албан хаагчдад хахууль өгөх, хорионы бүсээс гарах зэрэг зөрчлүүд гарч байсан талаар тайланд дурджээ.

SARS-аас авсан сургамж

Амьсгалын замын цочмог халтай хам шинж (SARS) өвчний 2003 оны дэгдэлттэй холбоотой эрүүл мэндийн салбар дахь ирээдүйд үүсэж болох онцгой байдлыг зохицуулах, уялдааг хангах үндэсний удирдлагын төвийг Тайваньд байгуулсан. Ил тод байдлыг бэхжүүлж, шинэ технологи нэвтрүүлж, урьдчилан сэргийлэх найдвартай төлөвлөгөө боловсруулснаар тус улс коронавирус зэрэг томоохон цар тахлын эсрэг илүү сайн хариу арга хэмжээ авах боломжтой болсон.

Баруун Африк дахь Эбола болон Ази дахь амьсгалын замын цочмог халтай хам шинж (SARS) өвчний дараа эрүүл мэндийн салбарыг бэхжүүлэхэд зориулан нэмэлт хөрөнгө гаргаж, хяналтыг чангатгах зэрэг арга хэмжээ авснаар эрүүл мэндийн салбарын дэд бүтэц сайжирсан талтай.

Хэтийн төлөв

КОВИД-19 цар тахал үргэлжлэн тархаж буй энэ нөхцөлд эрүүл мэндийн салбарын эмзэг байдлын талаар нээлттэй хэлэлцэж байх нь чухал юм.

ТИ байгууллага амин чухал эм тариа, вакцины худалдан авалтыг сайжруулах, гэрээ, хэлцлийн нээлттэй байдлыг нэмэгдүүлэх, эм, эмнэлгийн хэрэгслийн үнийн хөөрөгдөлтөөс урьдчилан сэргийлэх, шаардлагатай эмийн талаарх мэдээллийг цаг тухай бүрд нь солилцож байх талаар засгийн газруудыг уриалж байна.

Үүнээс гадна, засгийн газрууд клиник туршилтын мэдээллийн нээлттэй байдлыг хангах нь эрдэмтдэд тэгээс эхлэх бус, харин нэгэнт хийгдсэн судалгаанд тулгуурлах боломж олгох юм.

Засгийн газрууд хуурамч мэдээлэл тархахаас урьдчилан сэргийлэх, эмнэлэг, эрүүл мэндийн төвүүд дэх хахуулийн эрсдлийг бууруулахын тулд шүтэл үлээж байгаа мэдээлэгчийг хамгаалах талаар арга хэмжээ авах нь мөн чухал гэдгийг онцолж байна.

Эцэст нь олон нийтийн эрх ашгийн төлөө зөв шийдвэр гаргахын тулд том бизнесийн болон хувийн ашиг сонирхлын нөлөөллийг бууруулах нь чухал юм. Улс төрийн, эсхүл том бизнесийн эрх ашиг бус, харин олон нийтийн эрүүл мэнд ямагт нэгдүгээрт тавигдах ёстой.

Хорватын засгийн газар, хууль хяналтын байгууллагуудыг шударга байдлаа нэмэгдүүлэхийг ГРЕКО уриалжээ²⁴³

2020.03.24. ГРЕКО засгийн газар (төрийн дээд удирдлага), хууль хяналтын байгууллага дахь авлигаас урьдчилан сэргийлэх Хорват улсын үйл ажиллагааны талаарх тав дахь удаагийн үнэлгээний тайланг гаргаад байна.

Хорват улс нь төрийн албанд шударга байдлыг бэхжүүлэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох орчныг бүрдүүлсэн талаар уг тайланд дурдсан байна. Хэдий тийм ч, мөн тайланд эрх зүйн орчин болон практик хэрэгжилтийг хангуулах шаардлагатай байгааг онцолсон байна. Нэн тэргүүнд, сүүлийн жилүүдэд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдээс үүдэлтэйгээр Хорватын засгийн газарт тэргүүлэх чиг үүрэгтэй ажиллаж буй хүмүүсийн ёс зүйн стандартыг хангах хэрэгтэй байгаа талаар тайланд тусгасан байна. Ялангуяа, засгийн газрын гишүүн, төрийн нарийн бичгийн дарга, сайдын туслах нарт зориулсан ёс зүйн дүрэм, түүнчлэн дүрмийг хэрэгжүүлэх зөвлөмжийг баталж мөрдүүлэх шаардлагатай байгааг онцолсон байна. Үүнээс гадна, дээд шатны албан тушаалтныг ажилд томилох, ажлаас халагдах талаарх зохицуулалтыг илүү өргөжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн лоббитой холбоотой байдлаа мэдүүлэх, лоббидсон асуудлыг тайлагнахтай холбоотой хууль эрх зүйн зохицуулалт хязгаарлагдмал байгааг анхааруулжээ. Шударга байдлыг дээшлүүлэхийн тулд эдгээр асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байна. Мөн гүйцэтгэх засаглалын өндөр эрх мэдэлтэй этгээдийн хувийн эрх ашиг нь албаны чиг үүрэгтэй зөрчилдөх нөхцөлд Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хороонд санхүүгийн мэдүүлэгтэй мэдүүлж байх зохицуулалттай болох шаардлагатайг дурджээ. Хороо тус чиг үүргийг хэрэгжүүлэхэд туслах зорилгоор засгийн газрын гишүүн, төрийн нарийн бичгийн дарга, сайд нарын туслахуудын санхүүгийн мэдүүлгийг хянаж, шалгахад шаардлагатай мэдээллийг авдаг байх талаар илүү ихийг хийх шаардлагатай юм. Үүнтэй холбоотойгоор эрхэлж буй албан тушаалаас нь үл хамааран бие даасан байгууллагууд, тухайлбал, Хороотой, хамтран ажиллах хүсэл эрмэлзэлтэй байхын чухлыг ГРЕКО онцолсон байна.

Цагдаагийн байгууллагад итгэх итгэл доогуур байдаг, цагдаагийн авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх талаар тайланд дурдсан байна. Цагдаагийн байгууллагын хувьд авлигын эсрэг стратеги батлан хэрэгжүүлэхийн тулд авлигад автах эрсдэлтэй үйл ажиллагааны талаар цогц эрсдлийн үнэлгээ хийхээс эхлэх шаардлагатай байна. Мөн цагдаагийн албан хаагчдын одоогийн

²⁴³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж:

https://search.coe.int/directorate_of_communications/Pages/result_details.aspx?ObjectId=09000016809d0d00

мөрдөж буй ёс зүйн дүрэмд шударга байдлын бүх асуудлыг хамруулахаас гадна, практикт дагаж мөрдөх гарын авлагаар хангах хэрэгтэй хэмээн тайланд онцолсон байна. Цагдаагийн байгууллагад томилогдох, албан тушаал дэвших процесс болон цагдаагийн албанаас халагдсаны дараах ажил эрхлэлт зэрэгт анхаарах хэрэгтэй байна. Эцэст нь, албан үүргээ гүйцэтгэх явцад шударга бус зүйл, дүрэм журам зөрчсөн албан хаагчдын талаар мэдээлж байх асуудлыг ГРЕКО зөвлөсөн байна.

Илүү их мөнгө, илүү их хяналт²⁴⁴

2020.03.27. Коронавирусний цар тахал илүү олон оронд тархаж байгаатай уялдуулан өчигдөр Латин Америкийн бүс нутгийн 13 улсын ТИ байгууллагын үндэсний салбарууд зөвлөмж гаргав. Энэхүү зөвлөмж нь онц байдлын үед зарцуулагдах мөнгө, хөрөнгийг авлигын замаар урсан алга болох явдлыг таслан зогсооход нь засгийн газруудад туслах зорилготой юм.

Мөн өнгөрөгч долоо хоногт ТИ байгууллагын АНУ дахь төлөөлөгчийн газраас короновирустай тэмцэхэд гаргаж байгаа багц хөтөлбөртөө авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгуулах тухай саналыг тус улсын Конгресст хүргэлээ. Тус саналд засгийн газрын зүгээс цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд авж хэрэгжүүлж буй дотоод болон гадаад ажлын гэрээ хэлцэлд авлигын шинжтэй, зориулалтын бус зүйлд зарцуулагдахаас сэргийлэх тухай тусгасан юм.

Цар тахалтай тэмцэх нэмэлт эх үүсвэрийн санхүүгийн хуваарилалт нь хулгайн замаар орж, оффшор бүсэд хадгалагдах бус, хямралыг арилгахад зориулагдан, олон нийтэд зарцуулагдах нөхцөлийг бүрдүүлэх ёстой. Тиймдээ ч бид өнгөрөгч долоо хоногт банкуудыг мөнгө угаахтай тэмцэх хяналтаа улам үр дүнтэй хэрэгжүүлж, илүү чанга, тууштай байхыг уриаллаа.

Үүнээс гадна, Швед улсын хамгийн том банк болох Шведбанк Азербайжан, ОХУ, Украины сангуудын хөрөнгийг угаахад хэрхэн таатай орчин бүрдүүлж өгч байсан талаар нэмэлт баримт, нотолгоо ил болсоор байгаа билээ.

Шведбанк болон түүний Балтын салбарууд 2014-2019 онд мөнгө угаахтай тэмцэхэд хүлээсэн үүргээ үл тоомсорлон, дор хаяж 40 тэрбум ам.долларын өндөр эрсдэл бүхий санхүүгийн профайлтай үйлчлүүлэгчдийн гүйлгээг гүйцэтгэсэн болохыг хараат бус тайлангуудад тусгажээ.

Дээрх банкны салбарын засаглал, хяналтын алдааг дараагийн эрсдэл бүхий саруудад дахин давтахгүй байх үүднээс Эстони, Латви, Литва, Швед улсын үндэсний салбарууд хамтран энэ төрлийн алдааг засах, шийдвэрлэх арга замуудыг ч мөн санал болголоо.

Умард Казахстан мужийн иргэд авлигын талаарх судалгаанд цахимаар оролцох боломжтой²⁴⁵

2020.03.30. Авлигатай тэмцэх бодлогыг боловсронгуй болгоход судалгааны үр дүнг цаашид хэрхэн ашиглах талаар Бүгд Найрамдах Казахстан Улсын Авлигатай тэмцэх газрын Умард Казахстан муж дахь хэлтсийн нэгдүгээр орлогч дарга Нурлан Жахин дэлгэрэнгүй өгүүллээ гэж петропавловск.news мэдээлэв.

“Энэхүү судалгаа нь Авлигатай тэмцэх газар болон авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий төрийн байгууллагуудын ажлыг бодитой үнэлэхэд зайлиггүй шаардлагатай байна. Мөн манай мужийн авлигын түвшнийг үнэлэхэд туслана. Цаашид энэ судалгааг улирал тутамд явуулах бодолтой байна. Жилийн эцэст судалгааны ерөнхий дүн гарна. Уг судалгаанд оролцохыг хүссэн хүн бүр хотод болон хөдөө орон нутагт амьдарч байгаагаас үл хамааран хамрагдах боломжтой бөгөөд асуултууд нь тийм ч хүндрэлтэй биш” гэж Нурлан Жахин хэлжээ.

Судалгааны асуулга нь шууд болон шууд бус асуултаас бүрдсэн байна. Судалдаанд оролцогч нэрээ тавих шаардлагагүй бөгөөд харин амьдарч буй хот, тосгоноо нэрлэж бичих шаардлагатай юм байна.

²⁴⁴ Орчуулсан: А.Билгүүн. Эх сурвалж: <https://voices.transparency.org/more-money-more-oversight-e994a607f6b8>

²⁴⁵ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://pkzsk.info/zhiteli-severo-kazakhstanskoji-oblasti-mogut-projiti-onlajjn-opros-po-vosprivyatiyu-korruptcii/>

Авлигатай тэмцэх байгууллага нь олон улсын судалгааны үр дүнгээс гадна өөрийн гэсэн судалгааны мэдээлэлтэй болох зорилгоор уг судалгааг явуулж байгаагаа Нурлан Жахин онцлов.

Судалгааг 03 дугаар сарын 30-наас 04 дүгээр сарын 15-ны хооронд явуулна.

Судалгаанд оролцохыг хүссэн хүмүүст зориулж холбогдох линкийг тавьжээ:

<https://docs.google.com/forms/d/e/1FAIpQLSeprpQ-dvjedWSm9Xce-zHDWOPWjfwRn2x8L1AIMcL53M66Ig/viewform>

Санал асуулга:

УМАРД КАЗАХСТАН МУЖИЙН АВЛИГЫН ТҮВШИН

Таныг манай санал асуулгад оролцож, бүс нутгийн авлигын түвшнийг үнэлэхэд хувь нэмрээ оруулахыг урьж байна. Дараах асуултуудыг уншиж хариултаа өгнө үү. Бид мэдээллийг ерөнхий дүн гаргахад ашиглана. Нэрээ нууцлан бөглөх ба нууцлалыг хадгална.

1. Та аль ангилалд хамаарах вэ? (Ажил мэргэжил)
 - Бизнесийн салбарын ажилтан
 - Ажил эрхэлдэггүй
 - Оюутан
 - Төрийн албан хаагч
 - Тэтгэвэр авагч
 - Бусад
2. Таны нас
3. Оршин суугаа газар
4. Таны бодлоор бүс нутаг дахь авлигын түвшин:
 - Өндөр (төрийн байгууллага бүрд албан тушаалын байдлаа ашиглахад бэлэн ажилтнууд байдаг)
 - Дунд (төрийн олон байгууллагад албан тушаалын байдлаа ашиглахад бэлэн ажилтнууд байдаг)
 - Бага (төрийн зарим байгууллагад албан тушаалын байдлаа ашиглахад бэлэн ажилтнууд байдаг)
 - Огт байхгүй (төрийн байгууллагуудад албан тушаалын байдлаа ашиглахад бэлэн ажилтнууд огт байхгүй)
5. Таны бодлоор аль салбар авлигад хамгийн их өртсөн бэ (ялангуяа төрийн байгууллагууд)? (та нэгээс дээш хариултыг сонгож болно)
 - Автозам, тээврийн салбар
 - Газрын харилцааны салбар
 - Хөдөө, аж ахуйн салбар
 - Орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээ, эрчим хүч, ахуйн үйлчилгээний салбар
 - Боловсролын салбар (цэцэрлэг, сургууль, коллеж, их дээд сургууль гэх мэт)
 - Архитектур, барилга, хот төлөвлөлтийн салбар
 - Эрүүл мэндийн салбар (эмнэлэг, поликлиник гэх мэт)
 - Биений тамир, спорт, соёл урлагийн салбар (хүүхэд залуучуудын спортын сургууль, театр, соёлын ордон гэх мэт)
 - Хүн амын нийгмийн хамгааллын салбар
 - Хууль сахиулах, татвар ба гаалийн байгууллагуудын үйл ажиллагааны хамрах хүрээ
 - Шүүх, прокурорын байгууллагын үйл ажиллагааны хамрах хүрээ
 - Бусад
6. Та Авлигатай тэмцэх албанд итгэдэг үү?
 - Бүрэн итгэдэг
 - Дунд зэрэг
 - Огт итгэдэггүй
7. Та авлигын эсрэг үйл ажиллагаанд өөрийн хувь нэмрийг оруулахад бэлэн үү?
 - Тийм, мэдээж авлигын эсрэг тэмцэхэд өөрийн хувь нэмрээ оруулах нь миний үүрэг гэж бодож байна.

- Ерөнхийдөө тийм, хэрвээ энэ нь миний хүсэл сонирхолд хор нөлөө учруулахгүй бол
 - Үгүй, нэг хүн нийтийн асуудлыг шийдэж чадахгүй.
8. Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ямар аргуудын тухай та сонссон бэ?
- “Қызылжар – адалдық алаңы” төслийн үйл ажиллагаа
 - “Antikor ortalygy” үйлчилгээний төвд зохиогддог семинар, товч танилцуулга мэдээлэл, лекцүүд
 - Олон нийтийн оролцоотой хяналт, дүн шинжилгээ хийх
 - “РВИ” төслийн хүрээнд бизнес, хөрөнгө оруулалтыг хамгаалах
 - “Худалдан авалтын нэг цонх” дүн шинжилгээний систем
 - “Төсвийн ил тод байдлын интерактив зураглал” төсөл
 - “Адал жол” төслийн үйл ажиллагаа
 - “Саңалы ұрпақ” төсөл
 - Бусад
9. Та төрийн албан хаагчдын зүгээс гаргасан авлига, хахууль, хүнд сурталтай тулгарч байсан уу?
- Тийм
 - Үгүй
10. Төрийн байгууллагын ажилтнуудын авлигын талаар удирдлагад нь болон хууль сахиулах байгууллагад мэдээлж байсан уу?
- Тийм
 - Үгүй
11. Та авлигын талаар мэдээлсэн этгээдийг урамшуулдаг талаар сонсож байсан уу?
- Тийм
 - Үгүй
12. Авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулах тухай таны санал:

...

Цар тахлын үеийн авлигаас хэрхэн сэргийлэх вэ?²⁴⁶

2020.04.03. Латви улсад онцгой байдлын дэглэм үйлчилж байгаа бөгөөд эрх баригчид шийдвэрийг шуурхай гаргаж, хэрэгжүүлэн ажиллаж байна. Гэхдээ одоогийн нөхцөл байдалд сэтгэлгүй, ухамсар дорой албан тушаалтнууд түр хугацаанд олж авсан эрх мэдэл, албан тушаалаа урвуулан ашиглах хүсэл улам нэмэгдэж магадгүй талаар “Нээлттэй байдлын төлөө Delna нийгэмлэг”-ийн захирал Лиене Гатере хэлж байна.

Делна нийгэмлэгээс засгийн газар, бизнес эрхлэгчид болон олон нийтэд зориулж дараах арван зөвлөмж гаргажээ.

- Тендерийг хуульд нийцсэн, чанартай байдлаар зохион байгуулж, шударга өрсөлдөөн, нээлттэй байдлыг хангах;
- Тендер болон өрсөлдөөнийг хянах ажлыг үргэлжлүүлэх, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлэх;
- Хүн ам, бизнес эрхлэгчдэд төсвийн зарцуулалтыг хянах боломж олгох үүднээс КОВИД-19-тэй тэмцэхтэй холбоотойгоор хийгдэж байгаа худалдан авалтын бүх мэдээллийг засгийн газрын www.covid19.gov.lv сайт дээр (эсвэл өөр, тусдаа сайт дээр) байршуулах ёстой;
- Шударга бус өрсөлдөөн, бараа үйлчилгээний үнийг үндэслэлгүйгээр өсгөсөн болон үүнтэй ижил төстэй бусад зөрчлийн талаар Авлигаас урьдчилан сэргийлэх, авлигатай тэмцэх товчоо, Цагдаагийн газар, Худалдан авах ажиллагааны хяналтын товчоо, Өрсөлдөөний зөвлөл, Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах төвд мэдээлэх;
- Эрүүл мэндийн салбар болон олон нийт хахуульд автахгүй байх зарчмыг тууштай баримтлах;
- Эмнэлгийн ажилтнуудад өгөх цалин хөлсний нэмэгдлийн талаарх мэдээллийг www.covid19.gov.lv сайтад байршуулах;

²⁴⁶ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://bnn-news.ru/korruptsiya-v-period-pandemii-kak-zashhititsya-230742>

- Онцгой байдлын дэглэм, хорионы улмаас ажилтнуудад өгөх тэтгэмжийн хэмжээг хуулийн этгээдийн мэдээллийн хамт улсын орлогын цахим сайт болон засгийн газрын www.covid19.gov.lv сайт дээр байршуулах;
- Эдийн засгаа амжилттай сэргээх үүднээс хямралын оргил үеэс хойших нөхцөл байдал, мөн авлига, залилан мэхлэлтээс урьдчилан сэргийлэх зорилгоор авж хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар мэдээлж байх;
- Парламентын хороо ба орон нутгийн удирдлага алсын зайнаас ажиллаж байгаагаас үл хамааран хууль тогтоох үйл ажиллагаанд олон нийтийг оролцуулах боломжоор хангах;
- Сеймийн гаргасан шийдвэрийг нээлттэй байлгах, түүнийг богино хугацаанд дагаж мөрдөх зорилгоор лоббиг илрүүлэхтэй холбоотой хууль тогтоомжийг хэлэлцэх ажлыг үргэлжлүүлэх шаардлагатай байна.

Одоогийн байдлаар нөхцөл байдлыг хянахын тулд засгийн газар, Сейм, Хямралын удирдлагын зөвлөл олон зүйл хийж байгаа боловч нээлттэй байдлаа улам сайжруулснаар Латви улс Европ болон дэлхийн бусад оронд сайн үлгэр дуурайлал болж чадна гэж Делна үзэж байна.

АХБ авлигын эсрэг хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийн тулд инноваци, үр ашгийг дэмжив²⁴⁷

2020.04.06. Азийн хөгжлийн банкны Авлигатай тэмцэх, шударга ёсыг бэхжүүлэх газар (АТШЁБГ)-ын 2019 оны жилийн тайлан гарчээ. Уг тайланд дурдсанаар АХБ нь авлигын эсрэг хүчин чармайлтаа нэмэгдүүлэхийн тулд инноваци, үр ашгийг дэмжиж байгаа аж.

“Бид АХБ-ны урт хугацааны Стратеги 2030-тай нийцүүлэхийн тулд өөрийн нөөцөө дахин үнэлж зохион байгуулалт хийсэн. Үүний үр дүнд бидний шалган шийдвэрлэсэн хэрэг, гомдлын тоо нэмэгдсэн” хэмээн АТШЁБГ-ын дарга Жон Версантворт мэдэгдсэн байна.

Тайланд дурдсанаар 2019 онд АХБ шударга ёсны зөрчилтэй холбоотой 110 мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх оныхоос 93%-аар өссөн, мөн 219 гомдлыг шалгаж, шийдвэрлэсэн нь өмнөх оныхоос 16 хувиар өссөн дүнтэй байна. Мөн АХБ-наас тус банкны Авлигын эсрэг бодлогыг зөрчсөн 69 байгууллага, 62 хувь хүний эрхийг хассан байна.

Хөгжиж буй гишүүн орнуудад үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх зорилгоор засаглал, институцийн чадавхыг бэхжүүлэх нь тус банкны Стратеги-2030-д заасан долоон тэргүүлэх чиглэлийн нэг юм.

Афганистан, Бутан, Гүрж, Индонез, Казахстан, Мьянмар, Балба, Палау улсад АХБ-наас санхүүжүүлсэн төслүүдийн санхүүгийн менежмент, худалдан авалт, хөрөнгийн зарцуулалт зэрэг асуудалд АТШЁБГ урьдчилсан үнэлгээ хийж, зөвлөмж өгсөн байна. Мөн АХБ нь Монгол, Филиппин, Вьетнам улс дахь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. Түүнчлэн, Армен, Камбож, Мальдив, Маршалын Арлууд, Микронезийн Холбооны Улсууд, Папуа Шинэ Гвиней, Самоа, Тайландын татварын системийн шударга байдлыг нэмэгдүүлэх чиглэлээр техникийн тусламж үзүүлэх зэргээр ажилладаг байна.

Тайлан үзэх холбоос: <https://www.adb.org/sites/default/files/institutional-document/577186/oai-annual-report-2019.pdf>

²⁴⁷ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: https://www.business-standard.com/article/news-ani/adb-promotes-innovation-and-efficiency-to-bolster-anti-corruption-efforts-120040600449_1.html

ГРЕКО КОВИД-19-ийн үеийн авлигын эрсдлийг анхааруулав²⁴⁸

2020.04.21. Европын зөвлөлийн авлигын эсрэг байгууллага болох ГРЕКО-оос КОВИД-19-ийн тархалт “авлигын эрсдлийг нэмэгдүүлж байгаа”-г мягмар гарагт анхааруулж гишүүн улс орнууддаа зориулан удирдамж²⁴⁹ гаргасан байна.

Засгийн газрууд болон байгууллагууд эрүүл мэндийн үйлчилгээн дэх хахууль болон худалдан авах ажиллагааны системд тусгайлан анхаарал хандуулах ёстой болохыг ГРЕКО-гийн тэргүүн Марин Мрчела (Marin Mrčela) мэдэгдлээ.

Мөн түүний мэдэгдэж байгаагаар улс орнууд шинэ бүтээгдэхүүний судалгаа, хөгжүүлэлттэй холбоотой авлигаас урьдчилан сэргийлэх, КОВИД-19-тэй холбоотой төр, хувийн хэвшил дэх луйврын эрсдлээс зайлсхийх, эрүүл мэндийн салбар дахь шүгэл үлээгчийн хамгаалалтыг нэмэгдүүлэх асуудалд анхаарах ёстой юм.

Эрүүл мэндийн салбарын эрсдэл нь эмнэлгийн хэрэгслийн яаралтай хэрэгцээ, худалдан авах ажиллагааны журмыг хялбарчлах асуудал болон эмнэлэг, эрүүл мэндийн ажилчдын ачаалал зэргээс болж нэмэгдэж байна.

ГРЕКО-гоос гаргасан дээрх удирдамжид улсын болон бүс нутаг, орон нутгийн байгууллагууд цар тахлын эсрэг тэмцэл явуулахдаа ил тод байх, мөн өөрсдөө хяналттай, хариуцлагатай байх асуудлыг тусгасан байна.

“КОВИД-19 бидний ил тод, хариуцлагатай байх үнэт зүйл, стандартыг алдагдуулахыг бид хүлээн зөвшөөрөх ёсгүй. Ил тод байдлыг хангахад чиглэсэн портал буюу дижитал мэдээллийн платформыг бий болгох нь авлигаас урьдчилан сэргийлэх, мөн хууль дээдлэх ёсыг хамгаалах чухал арга хэрэгсэл болно” хэмээн Мрчела мэдэгдсэн юм.

Латви улс авлигатай тэмцэх үйл ажиллагааны 2 жилийн төлөвлөгөөгөө батлав²⁵⁰

2020.04.28. Авлигатай тэмцэх, авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр ЭЗХАХБ-аас Латви улсад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тус улсын засгийн газар мягмар гарагт батлав. Төлөвлөгөөг Хууль зүйн яам болон холбогдох бусад байгууллага хамтран боловсруулжээ.

Тус улсад өгсөн зөвлөмж нь үндсэндээ хахууль, мөнгө угаах болон авлигад холбогдох бусад хэргийг илрүүлэх, мөрдөх, яллах үйл ажиллагааг илүү үр дүнтэй зохион байгуулахад чиглэгдсэн практик үйл ажиллагааг санал болгосон байна.

Зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд шүүгч, прокурор, мөрдөгчдийг давтан сургах, хахуулийн хэрэгт оноох ял шийтгэлийг чангатгах чиглэлээр бодлогын шинжтэй өөрчлөлт хийх, эдийн засгийн гэмт хэргийг шүүн таслах тусгайлсан шүүх байгуулах зэрэг асуудал тусгагджээ.

Авлигыг таслан зогсоох зорилгоор Ватикан тендерийн шинэ хууль гаргав²⁵¹

2020.06.01. Ватиканаас тендерийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, өрсөлдөөнт сонгон шалгаруулалт явуулж, зардлыг бууруулах зорилгоор шинэ хууль гаргаад байна. Даваа гарагт хэвлэгдсэн уг хууль нь Пап Францисаар удирдуулсан 4 жилийн ажлын үр дүн юм.

2013 онд сонгогдсон Аргентин Пап лам Францис нь Ватиканы санхүүгийн сахилга батад анхаарлаа хандуулж ирсэн бөгөөд энэ нь зарим санваартны эсэргүүцэлтэй тулж байсан юм.

²⁴⁸ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.occrp.org/en/daily/12160-greco-warns-of-corruption-risks-during-covid-19-crisis>

²⁴⁹ <https://rm.coe.int/corruption-risks-and-useful-legal-references-in-the-context-of-covid-1/16809e33e1>

²⁵⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://eng.lsm.lv/article/society/crime/latvia-agrees-anti-corruption-roadmap-for-next-two-years.a357756/>

²⁵¹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/05/george-floyd-curfews-extended-protests-spread-live-200531204512954.html>

“Шинэ хууль авлигын аюулыг үлэмж бууруулна” гэж хуулийн танилцуулгад дурдсан байна.

Уг хуульд зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлтэй холбоотой хэрэгт ялагдсан хүмүүсээс ирүүлсэн тендерээс татгалзах, тендер шалгаруулалтын үйл ажиллагаанд ёс зүйн зарчмыг баримтлах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх асуудал тусгагдсан байна.

Малайзад компанийн сайн засаглалыг дэмжих хууль хэрэгжиж эхэллээ²⁵²

2020.06.01. Өнөөдрөөс эхлэн дагаж мөрдөгдөж буй Малайзын Авлигатай тэмцэх хорооны 2009 оны хуулийн 17А дугаар бүлэг (2018 онд нэмэлт, өөрчлөлт орсон)-ийн зохицуулалт нь шударга ёс, компанийн сайн засаглал бүхий бизнесийн үйл ажиллагааг дэмжинэ гэж үзэж байна.

Уг хуулийн нэмэлт, өөрчлөлтөд зааснаар арилжааны байгууллагын ажилтан, эсхүл, арилжааны байгууллагын салбар авлигын гэмт хэрэгт холбогдвол тухайн байгууллагад мөн шийтгэл хүлээлгэх юм.

Парламентаас уг хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2018 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр баталсан бөгөөд шинэ хуулийг мөрдөж эхлэхээс өмнө арилжааны байгууллагуудад холбогдох бэлтгэлийг хангуулах зорилгоор хэрэгжүүлж эхлэх хугацааг хоёр жилээр хойшлуулсан аж.

Хэрэв тухайн арилжааны байгууллага буруутай болох нь тогтоогдвол, хуулийн 17А-ийн (2) дахь хэсгийн дагуу хүлээлгэх шийтгэл нь тухайн хахуулийн хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэн хэмжээнээс багагүй, эсхүл, 1 сая малайз рингитээр торгох, эсхүл, 20 хүртэлх жилийн хорих ял оногдуулах юм.

Хэдий тийм ч тухайн арилжааны байгууллага өөрийн үйл ажиллагаа, эсхүл, бизнестээ авлигаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай процедурыг бий болгосон гэдгээ нотолсон бол дээрх шийтгэлээс зайлсхийх боломжтой аж.

Шинэ хуулийн талаар: <https://www.sprm.gov.my/>, мөн нэмэлт зөвлөмжийн талаар: <https://giacc.jpm.gov.my/garis-panduan-tatacara> -аас мэдээлэл авна уу.

Европын улс орнуудын парламентын гишүүдийг авлигаас урьдчилан сэргийлэхийн тулд илүү ихийг хийх шаардлагатай байна²⁵³

2020.06.03. Европ дахь авлигатай тэмцэх үйл ажиллагаа эерэг хандлагатай байгаа ч хэрэгжүүлэх шаардлагатай олон асуудал байна.

ГРЕКО-оос гаргасан сүүлийн үнэлгээний тайланд дурдсанаар 2019 онд тус бүлгийн авлигын эсрэг зөвлөмжийн хэрэгжилт гишүүн улс орнуудын түвшинд бага зэрэг ахиц гарсан байна.

Гэвч анхаарал хандуулах шаардлагатай хоёр асуудал байна. Нэгдүгээрт, парламентын гишүүдийн авлигатай тэмцэх асуудлаар улс орнууд хангалтгүй байна. Өөрөөр хэлбэл, улс төрчдийн дундах авлигаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой ГРЕКО-ийн зөвлөмжийн хэрэгжилт 26%-тай байна.

Улс төрчдөд чиглэсэн дээрх зөвлөмжид бэлэг, хандив болон бусад үнэ бүхий зүйл хүлээн авахтай холбоотой асуудал багтаж байсан юм. Хэрэв бэлэг, хандив зэргийг хүлээн авсан бол түүний төрөл, өгч буй этгээдийн талаарх мэдээллийг бүртгүүлэх, ил тод болгох ёстой байсан юм.

Анхаарал татаж буй хоёр дахь асуудал бол зарим гишүүн улс орон дахь шүүхийн хараат бус байдал руу халдаж байгаа явдал юм.

“Энэ нь зөвхөн шударга ёсны зарчмаас гадна, улс төрд итгэх иргэдийн тоо хэмжээ бага түвшинд байгааг харуулж байна” хэмээн ГРЕКО-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга Жанлука Эспозито энэ үеэр мэдэгдсэн юм.

²⁵² Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.malaymail.com/news/malaysia/2020/06/01/section-17a-of-macc-act-2009-in-force-today/1871398>

²⁵³ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.euronews.com/2020/06/03/do-more-to-prevent-corruption-among-european-mps-says-new-report>

Энэхүү тайлан нь Мальта, Чех, Польш, Румын зэрэг ЕХ-ны улс орнуудад өнгөрсөн жил авлига, луйврын эсрэг олон нийтийн эсэргүүцлийн жагсаал болсны дараа гарч байгаа юм.

Хятад улс “доллар болон биткойнийг устгагч”-ийг эхлүүлж магадгүй²⁵⁴

2020.06.06. Цахим юань Америкийн мэргэжилтнүүдийг айлгаж байна.

БНХАУ-ын Төв банкаас мөнгөн тэмдэгийг криптовалютаар орлуулах, мөнгөн дэвсгэртийг банкны гүйлгээнээс гаргах шийдвэр гаргасан талаар Bloomberg мэдээлсэн байна.

Энэхүү “цахим юань” нь банкны системээс цаасан дэвсгэртийг шахан гаргах бөгөөд Хятадын засгийн газрын бүрэн хяналтад байх болно. Шинэ мөнгөн тэмдэгт нь ам.долларын аюултай өрсөлдөгч болж болзошгүй гэж барууны шинжээчид үзэж байна.

Түүнчлэн, АНУ-аас зарим оронд тавьж байгаа эдийн засгийн хориг арга хэмжээг тойрч, бусад улс оронтой хийх төлбөр тооцоог АНУ-д мэдэгдэхгүйгээр хийх боломжийг нээж байгаа бөгөөд энэ нь аливаа санхүүгийн урсгалыг АНУ-ын зүгээс саатуулах нөхцөлийг хааж байна.

БНХАУ-аас гаргахаар төлөвлөж байгаа уг шинэ хэрэгсэл нь аюулгүй байдлыг хангаж, бодит мөнгөтэй холбосон тул мөнгийг бодитойгоор орон, санхүүгийн эргэлтийг хурдасгаж, төрөөс бүрэн хянах боломжийг олгож байна. Цаасан мөнгөн дэвсгэртэй харьцуулахад шинэ хэрэгслийн санхүүгийн урсгал хурдтай, тэдгээрийн хөдөлгөөнийг бүрэн хянах боломжтой байна.

Шинэ хэрэгслийг нэвтрүүлснээр олон асуудлыг шийдэж болохыг үүнийг дэмжигчид олж харж байна. Жишээ нь, “шинэ цахим мөнгөн тэмдэгт” нь рейтинг, хөрөнгийн хэмжээ зэрэг дэлхийн санхүүгийн байгууллагуудаас гаргадаг үнэлгээнээс хамаарахгүй тул улс орны санхүүгийн салбарын эрсдлийг бууруулна. Үүнээс гадна авлига болон хуурамч схем зэрэг луйврын оролдлогын эсрэг сайн хамгаалалт болно.

Шинэ цахим юань нь биткойнийг ч “бут цохиж” магадгүй гэж шинжээчид үзэж байна. АНУ-ын улс төрчид, санхүүчид цахим юань гарснаар үүсэх эрсдлийг судалж, долларын эсрэг заналхийлэл гэж үзэхгүй байгаа нь бусад шинжээчдээс ялгаатайг уг нийтлэлд дурдсан байна.

НҮБ-ын МБГХТА АЭНҮБК-ын Хэрэгжилтийн үнэлгээний механизмын үр дүнд үндэслэн авлигын эсрэг бодлого боловсруулагч болон энэ чиглэлээр ажиллаж буй хүмүүст зориулан заавал хэрэгжүүлэх бус шинжтэй зөвлөмж гаргав²⁵⁵

2020.06.26. НҮБ-ын МБГХТА-наас авлигын гэмт хэрэгтэй тэмцэх, хууль сахиулах болон олон улсын хамтын ажиллагааны чиглэлээр ажиллаж буй хүмүүс, бодлого боловсруулагч нарт зориулан нийтлэг сорилт, сайн туршлагад тулгуурлан багц зөвлөмж гаргасан байна.

“АЭНҮБК-ын III, IV дүгээр бүлгийн хэрэгжилтийн сургамжид үндэслэсэн багц зөвлөмж, дүгнэлт” нэртэй уг бүтээлийг конвенцын хэрэгжилтийн үнэлгээний механизмаас цуглуулсан болон конвенцын нэгдүгээр үе шатны (2010-2019) үнэлгээнд хамрагдсан улсуудын мэдээлэлд үндэслэн гаргажээ.

Уг бүтээл нь АЭНҮБК-ын III (гэмт хэрэгт тооцох, хууль сахиулах) болон IV (олон улсын хамтын ажиллагаа) бүлгийн хэрэгжилтийн үнэлгээнд хамрагдсан 169 улсын үр дүнд үндэслэсэн бөгөөд авлигатай тэмцэх хүрээнд конвенцын гишүүн орнуудын хувьд хэрэгжүүлж болохуйц багц арга хэмжээнүүдийг багтаасан байна.

²⁵⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://liter.kz/kitaj-mozhet-zapustit-ubijczu-bitkoina-i-dollara/>

²⁵⁵ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.unodc.org/unodc/frontpage/2020/June/unodc-releases-non-binding-recommendations-for-anti-corruption-policymakers-and-practitioners-based-on-results-of-the-implementation-review-mechanism.html>

Бүтээлийг татах холбоос: https://www.unodc.org/documents/corruption/Publications/2020/20-00843_Ebook.pdf

“Үндэстэн дамнасан гэмт хэрэг ба авлига:
Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах
нь” сэдэвт чуулга уулзалт Чили улсад
нээлтээ хийлээ²⁵⁶



2020.08.08. Чили улсын Дээд шүүхийн ерөнхийлөгч Гильермо Силва Гүнделах (Guillermo Silva Gundelach) “Үндэстэн дамнасан гэмт хэрэг ба авлига: Шүүхийн хараат бус байдлыг хамгаалах нь” сэдэвт чуулга уулзалтын нээлтэд оролцов. Тэрээр авлига болон шүүхийн гэмт хэргээс сэргийлэхийн ач холбогдлыг онцлоод, хэрэв уг асуудалд анхаарал хандуулахгүй бол бид ирээдүйгээ эрсдэлд оруулж байгаа гэж ойлгох хэрэгтэй хэмээн цохон тэмдэглэжээ.

Энэхүү чуулга уулзалтыг Дэлхийн хуульчдын холбоо, Дэлхийн хуулийн сангийн ерөнхийлөгч Хавьер Кремадес (Javier Cremades) даргалж, илтгэгчдэд талархал илэрхийлэн хэлсэн үгэндээ шүүгчдийн хараат бус байдал, гэмт хэрэг, авлигатай тэмцэх нь хэр чухал болохыг онцлон тэмдэглэв.

“Бид авлигын эсрэг конвенцыг хэрэгжүүлэхийн тулд чадах бүхнээ хийж байна. Үүнд улс орнуудын хамтын ажиллагаа чухал бөгөөд прокурорын байгууллагууд уламжлалт хүрээнээс илүү гарч, хамтран ажиллах хэрэгтэй” гэж Дэлхийн Прокуроруудын холбооны ерөнхийлөгч Чеол-Кю Хван (Cheol-Kyu Hwang) онцолсон. Хэлэлцүүлгийн үеэр Испанийн Ерөнхий прокурор Долорес Делгадо (Dolores Delgado) “ардчиллын бохир тоглоом” гэж нэрлэдэг авлига, хахуультай тэмцэх зорилгоор шүүх, прокурорын байгууллагын чиг үүрэг, төсвийн бие даасан байдлыг илүүтэй анхаарч, арга хэмжээ авах шаардлагатай байгааг онцоллоо.

Испанийн Дэлхийн хуульчдын холбооны ерөнхийлөгч, Барселонагийн Хуульчдын холбооны дарга Мариа Южения Гей (María Eugenia Gay)-ийн онцолж хэлснээр, улс төрийн намууд олон нийтийн эрх ашгийн төлөө ил тод, хатуу чанд ажиллах ёстой бөгөөд ингэснээр улс төрийн байгуулал эрх мэдлийн хазайлтыг дахин чиглүүлж, ард иргэдийг төлөөлөх бүрэн эрхт байдлыг бэхжүүлэх чадвартай болно. Ирээдүйн томоохон сорилт нь ардчиллын хамгийн дээд илэрхийлэл болох бүтцийг хөгжүүлэхийг шаарддаг.

²⁵⁶ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://worldjurist.org/2020/09/opening-session-chile-transnational-crime-and-corruption-protecting-judicial-independence/?fbclid=IwAR2srxBH6EeGUMp6lBwdOLNbtIXkqAEkIK-Vrch08bMhulCDeO4bdcVM2Fg>

Чилийн Хуульчдын холбооны ерөнхийлөгч Хектор Хумерес Ногер (Héctor Humeres Noger)-ын хэлснээр “*Авлигын аюулаас урьдчилан сэргийлэх, түүнийг устгах, мэдээллээр хангахад хувь нэмрээ оруулах нь хуульчдын холбооноос гадна бүх эрх бүхий байгууллага, яамдын үүрэг юм. Шударга ёсыг хэрэгжүүлэхтэй холбоотой авлига нь хүний эрхийг хамгаалахад нөлөөлдөг тул нийгэмд ноцтой хохирол учруулж, улс орны үндсийг доройтуулж болзошгүй юм*”.

Чилийн үндэсний прокурор, Айберо-Америкийн прокуроруудын холбооны ерөнхийлөгч Хорхе Эбботт Чарме (Jorge Abbott Charme) прокурорын байгууллагуудын бие даасан байдал, хараат бус байдалд итгэж, олон улсын хамтын ажиллагааг дэмжиж байсан. Мэтгэлцээний үеэр Олон улсын эрүүгийн шүүхийн шүүгч Луз Ибанес (Luz Ibáñez) “авлига болон шүүгчийн хараат бус байдлын асуудал нь хэн нэг шүүгчийн асуудал бус, харин бүтцийн асуудал тул үүний мөрөөр авах хариу арга хэмжээ нь нэгдмэл, бүтцийн шинжтэй байх ёстой” гэдгийг хүлээн зөвшөөрсөн.

НҮБ-ын МБГХТА-ны Шүүхийн шударга байдлын багийн ахлагч Роберта Солис (Roberta Solis) хэлэлцүүлгийг хааж үг хэлэхдээ “*Шүүгчдийг дэмжих нь шүүхийн авлигаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой тул шүүгчдэд дэмжлэг үзүүлэх хэрэгтэй*” гэжээ.

Энэхүү чуулга уулзалтын нээлт 2021 оны 11 дүгээр сарын 17-18-ны өдрүүдэд Картагена де Индиас хотод тэмдэглэх Дэлхийн хууль эрх зүйн конгрессын өмнөх хоёрдахь хуралдаан байв. Колумбын Ерөнхийлөгч Иван Дюк энэ хуралдаанд цахимаар оролцсон бөгөөд “*Колумб улс нийгмийн эрх чөлөө, дэг журам, энх тайван, эв найрамдлын баталгаа болох хууль дээдлэх ёсыг хамгаалах хүчин чармайлтыг үнэлж, энэхүү конгрессыг хүлээн зөвшөөрч байна*” хэмээн мэдэгджээ.

Бирм улсад хувийн хэвшил дэх авлигатай тэмцэхэд туслах зорилгоор гарын авлага гаргав²⁵⁷

2020.08.19. Бирмийн Авлигатай тэмцэх хороо, Бирмийн Худалдаа, аж үйлдвэрийн танхим хамтран “Бизнесийн шударга ёс: Бирмийн бизнес эрхлэгчдэд зориулсан гарын авлага” гаргасан байна.

Уг гарын авлагад авлигатай тэмцэх зорилгоор компаниудын хэрэгжүүлэх шаардлагатай асуудлыг тусгасан байна. Тухайлбал, авлигатай тэмцэх үйл ажиллагаан дахь дээд түвшний удирдлагын хүчтэй, үр дүнтэй бодлого, дэмжлэг; авлигын нөхцөл байдал, эрсдлийг тодорхойлох зорилготой эрсдлийн үнэлгээ хийх; эрсдэл бүхий асуудлуудад чиглэсэн өргөн хүрээтэй, цогц арга хэмжээ хэрэгжүүлэх; бизнесийн харилцаанд авлигын эсрэг арга хэрэгслүүдийг ашиглах; нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв хөтлөх; хүний нөөцийн бодлогоо авлигатай тэмцэх бодлоготой уялдуулах; авлигын тохиолдлыг мэдээлэх боломж бүхий механизмыг бүрдүүлэх; авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд тогтмол үнэлгээ хийж хэвших зэрэг асуудлыг тусгасан байна.

Гарын авлагыг татах холбоос: https://www.myanmar-responsiblebusiness.org/pdf/resources/business-integrity_en.pdf

“КОВИД-19 цар тахлын эсрэг нийгэм-эдийн засгийн нөлөөллийн шинжилгээнд ил тод, хариуцлагатай байдал болон авлигын эсрэг үйл ажиллагааг тусгах нь” сэдэвт гарын авлага гарчээ²⁵⁸

2020.09.02. КОВИД-19 цар тахал нь дэлхийн эдийн засагт эмх замбараагүй, тодорхойгүй байдлыг бий болгож, нийлүүлэлтийг тасалдуулж, олон хүний амь нас, амьжиргаанд нөлөөлж, улмаар хямралын эсрэг хариу арга хэмжээ авж буй засаглалын тогтолцоо, институц, механизмын уян хатан байдалд сорилт болж байна. КОВИД-19 цар тахлын эсрэг явуулах нийгэм-эдийн засгийн хариу арга хэмжээний хүрээнд НҮБХХ болон түүний салбар нэгжүүд КОВИД-19 цар тахлын

²⁵⁷ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.mmtimes.com/news/myanmar-launches-handbook-help-firms-combat-corruption.html>

²⁵⁸ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.undp.org/publications/integrating-transparency-accountability-and-anti-corruption-socio-economic-impact>

эсрэг үр дүнтэй стратеги боловсруулан хэрэгжүүлэх зорилгоор улс орнууд дахь цар тахлын үзүүлж буй нийгэм-эдийн засгийн нөлөөллийг үнэлэхээр ажиллаж байна. Гэвч нийгэм-эдийн засгийн нөлөөллийн дүн шинжилгээг хийхэд ил тод, хариуцлагатай байдал болон авлигын эсрэг үйл ажиллагааг хэрхэн нэгтгэх талаар мэдлэг, гарын авлага дутмаг, мөн ихэнх нийгэм-эдийн засгийн шинжилгээнүүд нь засаглал болон авлигатай тэмцэх байр сууринаас КОВИД-19 цар тахлын нөлөөллийг үнэлэхгүй байна. Үүнээс гадна, авлигатай тэмцэх байгууллагууд болон нийгэм-эдийн засгийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг институцуудын хоорондын хамтын ажиллагаа хангалтгүй байна.

НҮБХХ-өөс гаргасан энэхүү гарын авлага нь КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ болон нийгэм, эдийн засгийн үнэлгээнд ил тод, хариуцлагатай байдал болон авлигын эсрэг асуудлыг хэрхэн нэгтгэх талаар практик арга зүй, үнэлгээний асуулга зэргийг тусгасан байна.

Гарын авлагыг татах холбоос: <https://www.undp.org/publications/integrating-transparency-accountability-and-anti-corruption-socio-economic-impact#modal-publication-download>

Фижд эмэгтэйчүүдэд зориулсан авлигын эсрэг гарын авлага гарав²⁵⁹

2020.09.10. НҮБ-ын Номхон далайн бүс нутгийн авлигатай тэмцэх төслөөс Фижи улсад бичил, жижиг, дунд аж ахуй эрхэлж буй эмэгтэйчүүдэд зориулсан авлигын эсрэг гарын авлага гаргаад байна.

“Уг гарын авлагад АЭНҮБК болон Тогтвортой хөгжлийн зорилт 16 дахь олон улсын сайн туршлагад тулгуурлан Фижи дэх авлига юунаас бүрддэг болох, авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэхийн тулд ямар хууль тогтоомж байдаг, ямар байгууллага ажилладаг болох, асуудал тулгарсан үед хаанаас тусламж авж болох талаар практик мэдээллийг тусгасан” хэмээн НҮБ-ын ХХ-ийн Авлигатай тэмцэх асуудал хариуцсан зөвлөх Соня Стефановска-Траяноска мэдэгдсэн юм.

Энэхүү гарын авлагыг Фижи дэх бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан авлигын эсрэг уулзалтад оролцсон 51 эмэгтэй бизнес эрхлэгчид анхлан санаачилсан байна.

Гарын авлагыг татах холбоос:

<https://www.pacific.undp.org/content/pacific/en/home/library/eg/anticorruption-toolkit-for-women-owned-micro-small-medium-businesses-fiji.html>

Зарлал: ЭЗХАХБ-ын тайлан, компанийн авлигын эсрэг комплаенсийн талаарх цахим семинар²⁶⁰

2020.09.15. Дараа долоо хоногт “Авлигын эсрэг комплаенсийг юу хамгийн их сэдэлжүүлдэг вэ? Сэдвээр хийгдэх ЭЗХАХБ-ын цахим семинарын талаар тус газрын Авлигатай тэмцэх хэлтсийн хууль эрх зүйн ахлах шинжээч Франц Чейнийн зарлал.

ЭЗХАХБ-ын Хахуулийн эсрэг конвенц 1999 оноос хэрэгжиж эхэлснээс хойш хахуулийн эрсдлийг удирдах асуудал нь үндэстэн дамнасан бизнесүүд дэх комплаенсийн хамгийн бэрхшээлтэй асуудлын нэг болсон. Сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд комплаенстай холбоотой асуудал ихээр гарч байгаа бөгөөд эдгээртэй холбоотой гадаадын хахуулийн томоохон хэргүүд асар их хэмжээний торгуулиар шийдвэрлэгдэж байна.

ЭЗХАХБ-ын Гадаадын хахуулийн тайлангаас харахад гадаадын хахуулийн хэргийн 40 гаруй хувьд нь удирдлагын түвшний ажилтнууд хахууль өгөх, эсхүл хахууль өгөх зөвшөөрөл олгох зэргээр холбогдсон бол 12%-д нь гүйцэтгэх захирлууд холбоотой байна. Үүний зэрэгцээ компаниуд авлигыг илрүүлэх, хариу арга хэмжээ авахад гол үүрэг гүйцэтгэж чадна гэдгээ харуулсан. ЭЗХАХБ-ын гадаадын хахуулийг илрүүлэх тухай 2017 оны тайланд сүүлийн 20

²⁵⁹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж:

<https://www.scoop.co.nz/stories/WO2009/S00066/womens-anti-corruption-toolkit-launched-in-fiji.htm>

²⁶⁰ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/09/15/guest-announcement-oecd-report-and-webinar-on-corporate-anticorruption-compliance/>

жилийн хугацаанд тодорхой шийтгэл хүлээлгэсэн гадаадын хахуулийн хэргийн 23%-ийг компаниуд өөрсдөө тайлагнах замаар илрүүлсэн болохыг онцолсон байдаг.

Гэвч үр дүнтэй комплаенсийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь хялбар биш бөгөөд КОВИД-19 цар тахал дээрх сорилтуудыг улам бүр нэмэгдүүлж байна. Санхүүгийн асар өндөр дарамтад байгаа компаниудын авлигын эсрэг алба, хэлтсүүд урьд өмнө нь тулгарч байгаагүй том сорилтын өмнө нүүр тулаад байна.

Эдгээр сорилтуудыг ил болгох, цаашдын хөгжлийн замыг тодорхойлохын тулд ЭЗХАХБ-аас нээлт хийх “Компанийн авлигын эсрэг комплаенсийн чиглэл, механизм, үзэл санаа”-ны талаарх судалгаа нь авлигын эсрэг комплаенсийг хэрэгжүүлэхэд юу түлхэц болох, жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд хэрхэн хэрэгжих зэрэг асуудлыг гаргаж ирэх юм.

Энэхүү судалгаа нь авлигын эсрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр ажиллаж буй компаниудад тулгардаг гол бэрхшээлүүдийг тодорхойлох, боломжит шийдлийг санал болгох юм.

Судалгааны албан ёсны нээлт 09 дүгээр сарын 23-ны өдөр болох бөгөөд “Авлигын эсрэг комплаенсийг юу хамгийн их сэдэлжүүлдэг вэ?” сэдвээр цахим семинар хэлэлцүүлэг зохион байгуулна. Цахим семинарыг төв Европын цагаар 09 дүгээр сарын 23-нд 15:00-16:30 хооронд зохион байгуулна.

Семинарт

оролцох: https://meetocd1.zoom.us/webinar/register/WN_kURiKAHPQh2Yc3YSbQDAxQ

[Цар тахлын үед авлигыг таслан зогсоох нь урьд өмнөхөөс илүү чухал ач холбогдолтойг шинэ тайланд тэмдэглэжээ](#)²⁶¹

2020.09.23. АНУ. ДБ-ны шинэ тайланд дурдсанаар хамгийн хүнд хэцүү нөхцөлд ч авлигын эсрэг ахиц дэвшил гаргаж болно. КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авахаар урьд өмнө байгаагүй их хэмжээний онцгой байдлын хөрөнгийг дайчлан ажиллаж байгаа энэ цаг үед засгийн газрын хариуцлагыг дээшлүүлэх хамгийн үр нөлөөтэй арга, хэрэгслүүдийн талаарх шинэлэг мэдээллийг уг тайланд танилцуулсан байна.

“КОВИД-19 цар тахлын улмаас засгийн газрууд эдийн засгаа сэргээх, мөн ядуу, эмзэг бүлгийнхнийг хамгаалахын тулд асар их хэмжээний онцгой байдлын зардлыг гаргалаа. Улс орнууд илүү уян хатан, хүртээмжтэйгээр сэргэж байгаа тул ховор нөөцийг ил тод байдлаар ашиглах нь нэн чухал юм” хэмээн ДБ-ны гүйцэтгэх захирал Мари Пангесту хэлжээ.

КОВИД-19 халдварын эсрэг урьд өмнө гарч байгаагүй онцгой байдлын зардлын зарим нь байнгын хяналтгүйгээр зарцуулагдсан. Хэдийгээр уг зарцуулалтыг нэн яаралтай хийх шаардлагатай байсан боловч зохих хяналтыг тавиагүй нь засгийн газарт авлигын эрсдэл үүсгэж, хариу арга хэмжээний үр нөлөөг бууруулж болзошгүй юм. Хариуцлагыг улам бүр нэмэгдүүлэхийн тулд засгийн газрын зүгээс үйл ажиллагаагаа ойлгомжтой томьёолох, хууль тогтоомжийг мөрдөх, зөрчлийг арилгах, үүссэн бэрхшээлийг аль болох хурдан бөгөөд ил тодоор шийдвэрлэхийг уг тайлангаар уриалав.

Энэхүү тайланд төрийн худалдан авах ажиллагаа, дэд бүтэц, төрийн өмчит аж ахуйн нэгж, гаалийн удирдлага, төрийн үйлчилгээ зэрэг таван асуудлыг багтаасан. Мөн энэ нь төрийн байгууллагын албан тушаалтнууд болон иргэний нийгмийн байгууллагуудад зориулан өөрийн орны онцлог нөхцөлд тохируулан боловсруулж, дагаж мөрдөх арга хандлагыг тодорхойлоход туслах болно.

Тайланд багтсан бодит жишээнүүдээс дүгнэхэд авлигыг хязгаарлах арга хэмжээ нь ихэвчлэн барууны үзэл баримтлалтай байдаг бөгөөд улс төрийн оролцоо шаардлагатай эмзэг асуудалд чиглэгдсэн байдаг ажээ.

²⁶¹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.worldbank.org/en/news/press-release/2020/09/23/curbing-corruption-in-the-midst-of-a-pandemic-is-more-important-than-ever-new-report-says>

Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль
- Сербид авлигатай тэмцэх шинэ найдвар
байна уу?²⁶²

2020.09.28. 2020 оны 09 дүгээр сараас Серби улсад Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн бөгөөд уг хуулиар авлигатай тэмцдэг гол байгууллага болох Сербийн Авлигатай тэмцэх газар нэрээ өөрчилж, Авлигаас урьдчилан сэргийлэх газар болгосон. Авлигатай тэмцэхэд үр дүн гарахгүй байгаа нь улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн хөгжил, ЕХ-нд элсэхэд тулгарч буй хамгийн ноцтой саад бэрхшээлийн нэг тул энэ хуулиар зөвхөн уг агентлагийн нэрийг өөрчлөөд зогсохгүй байх гэсэн найдлага хүмүүст төрж байна.

Тус улсын авлигатай тэмцэх тогтолцоонд тулгамдаж буй асуудлууд зөвхөн урьдчилан сэргийлэх тал дээр төдийгүй, шийдэгдсэн хэргүүдийн түүхийг шүүх, прокурорын байгууллага сайн хөтөлдөггүй тул шийдэгдсэн хэргүүдтэй холбоотойгоор хэлмэгдүүлэлт гарсан байж болзошгүй тухай яригдаж байна. Эрх баригч намын удирдлагыг авсан элитүүдийн бүлэглэл 2012 онд тэднийг засгийн эрхэд гаргах үед өгсөн авлигын эсрэг амлалтаа бүрмөсөн мартаж, Серби улсыг улс төрийн хүсэл зориггүй, институцийн ажиллагаа сул, сайн засаглалд хүрэх замыг бүдэгрүүлсэн нөхцөл байдалд оруулсан.

Иймээс энэ нь Фрийдом Хаус (Freedom House²⁶³)-ын зүгээс Серби улсын статусыг 2020 оны эхээр “хагас нэгтгэсэн ардчилал” (semi-consolidated democracy)-аас “холимог дэглэм” (hybrid regime) болгон бууруулсан шалтгаан бөгөөд үүнийг “дээд түвшний албан хаагчдын дунд гардаг авлигын хуримтлагдсан өсөлт”-өөр тайлбарласан юм. Дээрх дүн шинжилгээнд Серби улсын засгийн газар нэн даруй хариу өгч, тус улсын статусыг бууруулж, ардчилсан бус орнуудын түвшинд авж үзсэн нь зөвхөн авлигаас болсон гэсэн тайлбар өгсөн юм.

КОВИД-19: Их 20 ба НҮБХХ-ийн
хамтарсан мэдэгдэл²⁶⁴

2020.09.30. Саудын араб. Рияд. КОВИД-19 цар тахлын улмаас дэлхийн өнцөг булан бүрд янз бүрийн аюул учирч байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн эрч буурч, ядуурлыг арилгах, тэгш бус байдлыг бууруулах, уян хатан нийгмийг бий болгох хүчин чармайлтад саад тотгор үүсч байна. Энэхүү цар тахал нь хамтын ажиллагаа, шийдэл шаардлагатай засаглалын тулгамдсан асуудлуудыг ил болгов. Хариуцлага, шударга байдалд анхаарч, төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын ёс зүйн хэм хэмжээг өндөр түвшинд байлгах замаар Их 20-ийн удирдагчид хариу арга хэмжээ авах, сэргээн босгох ажлыг сайжруулах, төр, бизнес дэх авлигатай тэмцэх, илүү хүртээмжтэй, тэгш нийгэм байгуулах боломжтой. Их 20-ийн удирдагчид 2030 он гэхэд Их 20-ийн улс орнууд болон бусад улс орнууд хямралаас хурдан гарч, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэхэд нь тусалж, хамтран ажиллах бүрэн боломжтой юм.

Их 20 ба НҮБХХ нь Их 20-ийн удирдагчдын ээлжит бус дээд хэмжээний уулзалтын үеэр гаргасан дараах амлалтыг сайшааж байна. Үүнд: (i) хүний амь нас аврах бараа бүтээгдэхүүнийг боловсруулж, түгээх чиглэлээр төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг дэмжих; (ii) эдийн засгийг сэргээх явцад аж ахуйн нэгж, хувь хүнийг хамгаалах; (iii) “чөлөөт, шударга, ялгаварлан гадуурхалгүй, ил тод, урьдчилан таамаглах боломжтой, тогтвортой худалдаа, хөрөнгө оруулалтын орчныг бий болгох”

КОВИД-19 цар тахлын эсрэг хариу арга хэмжээ авах, сэргээн босгох ажлын үр дүн, үр нөлөөт байдлыг хангахын тулд хариуцлагатай байх болон авлигатай тэмцэх ажилд илүү тодорхой үүрэг өгөхийг уриаллаа. Дэлхийн цар тахлын үед гарч буй авлигыг бууруулах болон шударга байдлыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авж хэрэгжүүлэхийг Их 20-ийн удирдагчдаас хүссэн:

²⁶² Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://europeanwesternbalkans.com/2020/09/28/law-on-prevention-of-corruption-the-new-hope-for-fighting-corruption-in-serbia/?fbclid=IwAR2ae456Nv9ZIAWzTMA-CMTrXEZVT3skNiMAVvj8yUt480lI9Lbv5VGLVml>

²⁶³ Ардчилал, улс төрийн эрх чөлөө, хүний эрхийн талаар судалгаа, сурталчилгааны ажил эрхэлдэг, ашгийн бус, голчлон АНУ-ын засгийн газраас санхүүждэг, Вашингтон ДС-д байдаг байгууллага. Freedom House нь 1941 оны 10 дугаар сард байгуулагдсан бөгөөд анхны хүндэт даргаар Вендел Виллки, Элеонор Рузвельт нар ажиллаж байжээ.

²⁶⁴ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.undp.org/content/undp/en/home/news-centre/news/2020/b20-undp-joint-statement.html>

1. Ил тод байдал, хариуцлагыг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэнд, яаралтай худалдан авалтын хүрээнд гарч буй авлигатай тэмцэх

КОВИД-19 цар тахал нь төсвийн санхүүгийн удирдлагад хариуцлага, ил тод байдлыг хангахын ач холбогдлыг дахин харууллаа. Төрд итгэх олон нийтийн итгэл нь өдөр тутмын олон шийдвэр, арга хэмжээний үр дүнд бий болдог.

Цар тахлын үед яаралтай хариу арга хэмжээ авах шаардлагатай байгааг харгалзан Их 20-ийн засгийн газрууд авлигын эсрэг тусгай арга хэмжээ авж хэрэгжүүлэх, засгийн газрын худалдан авалт болон бусад төрийн үйлчилгээг дижитал хэлбэрт оруулах гэх зэргээр онцгой нөхцөл байдал дахь үйл ажиллагааны санхүүжилт, эрүүл мэндийн хөтөлбөрүүдийн үр ашиг, шударга байдлыг дэмжих хүчтэй хяналтын механизм болон бусад арга хэмжээг дэмжиж ажиллахыг Их 20 ба НҮБХХ-өөс зөвлөсөн.

2. Авлигын эсрэг үндэсний стратеги боловсруулж, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх

Их 20-ийн засгийн газруудын хэрэгжүүлж, авлигаас урьдчилан сэргийлэх, авлигын эсрэг боловсрол олгох, холбогдох хууль тогтоомжийг сахиулах асуудлыг хамарсан олон талт зөвлөлдөх уулзалтуудад үндэслэсэн авлигын эсрэг тууштай, өргөн цар хүрээтэй, хэрэгжүүлэх боломжтой стратегийг дэлхийн хэмжээнд дэмжиж ажиллахыг Их 20 ба НҮБХХ-өөс зөвлөсөн. Уг стратеги нь хүртээмжтэй, үндэсний хөгжлийн зорилгод нийцсэн бөгөөд тогтвортой хөгжлийн зорилгыг дэмжиж байх ёстой.

3. Авлигын эсрэг мэдээлэл, харилцаа холбооны технологи, нээлттэй өгөгдлийг ашиглахад дэмжлэг үзүүлэх

Их 20-ийн засгийн газрууд цар тахлын үед болон дараа хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологийг илүү үр дүнтэй ашиглах замаар дэлхийн хэмжээнд авлигын эсрэг үйл ажиллагааг дэмжиж, бэхжүүлэх арга хэмжээ авж байхыг Их 20 ба НҮБХХ-өөс зөвлөсөн. Ил тод байдал, мэдээлэл солилцох, засгийн газрын худалдан авалт болон засгийн газрын бусад үйлчилгээг сайжруулах нь төрийн болон хувийн хэвшлийн авлигын эрсдлийн удирдлагыг төгөлдөржүүлж, хариуцлагыг дээшлүүлэхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх боломжийг олгоно.

Мөнгө угаахтай тэмцэх зах зээл 2025 онд 1.99 тэрбум доллароор үнэлэгдэнэ²⁶⁵

2020.10.14. Дэлхийн мөнгө угаахтай тэмцэх зах зээлийн хэмжээ 2025 он гэхэд 1.99 тэрбум долларт хүрч, 2019-2025 оны урьдчилсан тооцоотой харьцуулахад жилийн өсөлтийн түвшин 13.6% болох таамаглалыг Миллион инсайтс байгууллагын гаргасан тайланд дурджээ. Хууль сахиулах үйл ажиллагаатай хавсруулсан нөхцөлд мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэх ажиллагаа амжилттай хэрэгжиж байгаа ба тиймээс авлигачид, гэмт хэрэгтнүүд хууль бус хөрөнгийнхөө эх үүсвэрийг нуун дарагдуулахад ихээхэн анхаарал хандуулж байна.

Терроризм, авлига, зохион байгуулалттай гэмт хэрэг нэмэгдэж, дэлхийн аюулгүй байдал, энх тайван, хөгжилд сөргөөр нөлөөлж байгаагийн улмаас засгийн газрын зүгээс цогц арга хэмжээг авж хэрэгжүүлэх болсон. Тиймээс засгийн газраас тогтоосон хэм хэмжээг хангахын тулд аж ахуйн нэгжүүд мөнгө угаах, залилан мэхлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх шийдлийг гаргах шаардлага тулгарсан юм. Тухайлбал, авлигачид болон цахим гэмт хэрэгтнүүдийн үйл ажиллагааг хянах журмыг боловсруулж, хууль бус орлого олсон хөрөнгийг нуух, эсвэл хөрвүүлэх явдлыг багасгахад туслахаар төлөвлөж байна.

Мөнгө угаахтай тэмцэх арга хэмжээнүүд нь мөнгө угаах аливаа гүйлгээ болон нэрээ нууцалсан гүйлгээ хийх эрсдлийг бууруулахад засгийн газарт тусалдаг. Энэхүү арга хэмжээ нь хүний наймаа, хүн хил дамжуулан худалдаалах, хар тамхины наймаа, хар тамхи хил давуулах гэмт хэрэг гэх мэт мөнгөнд суурилсан үйл ажиллагааг бууруулдаг. Түүнчлэн мөнгө угаахтай тэмцэх арга

²⁶⁵ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.prnewswire.co.uk/news-releases/anti-money-laundering-market-to-be-valued-at-1-99-billion-by-2025-based-on-rising-adoption-of-advanced-technologies-for-authentication-through-smartphones-biometrics-amp-behaviour-analysis-million-insights-816342822.html>

хэмжээ нь хил дамнасан гүйлгээ, цахим валютаар хийгдэх авлигад тулгарах аюулыг ч мөн бууруулдаг.

Онлайн банкны платформ, P2P арилжаа, онлайн төлбөрийн вэбсайт зэрэг дэвшилтэт технологи гарч ирсэнтэй холбогдуулан сүүлийн хэдхэн жилд дэлхий даяар цахим гүйлгээний тоо өссөн байна. Эдгээр хөгжил дэвшлийн улмаас хоёр талын хооронд мөнгө шилжүүлэхэд хялбар болсон боловч энэ байдал нь хууль бусаар мөнгө шилжүүлэх янз бүрийн арга замыг тодорхойлох, илрүүлэхэд илүү төвөгтэй байдал үүсгэсэн. Түүнчлэн гэмт хэрэгтнүүд прокси сервер, эсвэл нэрээ нууцлах програм ашиглан IP хаяггүйгээр мөнгө шилжүүлж, эсвэл татан авж байна. Тиймээс мөнгө угаах гэмт хэргийг мөрдөх, илрүүлэх нь маш хэцүү болж байгаа юм.

Санхүүгийн байгууллага болон бизнес эрхлэгчдийг дээрх аюулаас хамгаалахын тулд томоохон улс орнууд мөнгө угаахтай тэмцэх шаардлагыг хэрэгжүүлэхийг санхүүгийн байгууллагуудаас шаардсан.

Үүнээс гадна, олон засгийн газар санхүүгийн гэмт хэргийг мэдээлэх, илрүүлэхэд финтек (FinTech) арга замыг ашиглахад анхаарах болсон. Санхүүгийн гэмт хэрэг, хууль бус худалдааны үйл ажиллагааны давтамж нэмэгдэж байгаатай холбогдуулан хуучин арга замаар аюулгүй байдлыг хангах боломжгүй гэж үзсэн тул аж ахуйн нэгжүүд дэвшилтэт технологи нэвтрүүлж байна.

Түүнчлэн, дэвшилтэт технологи нэвтрүүлснээр мэдээллийн аюулгүй байдал болон санхүүгийн үйл ажиллагааны ил тод байдал улам бүр нэмэгдсэн. Тиймээс ухаалаг гар утас, биометрик, зан үйлийн анализ зэрэг технологи нь мөнгө угаахтай тэмцэх зах зээлийг ойрын хэдэн жилд нэмэгдүүлэх хандлагатай байна.

Байшин барилгын хананд авлига,
хахуулийн эсрэг зураг зурж олон нийтийг
соён гэгээрүүлнэ²⁶⁶



(Фото: Бүгд Найрамдах Казахстан Улсын авлигатай тэмцэх байгууллагын хэвлэлийн алба)

2020.10.15. Казахстан улсын авлигатай тэмцэх байгууллагын мэдээлснээр тус улсын хот, тосгоны төв гудамжны байшин барилгын хананд авлига, хахуулийн хор уршгийг таниулах зураг байрлуулан олон нийтийг соён гэгээрүүлнэ гэжээ. Тус зургууд нь олон нийтийг зөв үйлдэл хийх, биеэ авж явах зөв загварт сургана гэж үзэж байна.

²⁶⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж <https://politics.nur.kz/1879943-borotsa-s-korrupciej-s-pomосу-muralov-namereny-v-kazahstane.html>

Эхний зургийг Алмата хотод энэ зун гаргажээ. Одоогийн байдлаар ийм төрлийн 35 төсөл хэрэгжиж хот, тосгоны олон давхар орон сууцны хананд байршуулаад байна. Авлигын эсрэг зургуудын үндсэн сэдвүүдэд шударга ёс, эх оронч үзэл зэргийг агуулсан олны танил хүмүүсийн хэлсэн үгийг оруулжээ.

НҮБ-ын тэргүүн Антониу Гуттереш: Цар тахалтай тэмцэж буй тэмцэл авлигажих, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хөрсийг бий болгож байна²⁶⁷

2020.10.15. Цар тахалтай тэмцэж буй тэмцэл нь авлигажих, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах хөрсийг бий болгож байгаа бөгөөд энэ нь эргээд коронавирусийг бүрэн ялахад саад болж болзошгүй хэмээн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Антониу Гуттереш мэдэгдэв.

Цар тахалтай тэмцэж буй нөхцөл байдлын үед улс орнуудын засгийн газруудын зүгээс хүний амь насыг аврахын тулд яаралтай шийдвэр гаргаж байгаа бөгөөд барааны чанар, үнэ зэрэг мэдээлэл болон нийлүүлэгчдийг шалгаж нягтлах цаг хугацаа гарахгүй байна. Үүний үр дүнд зах зээлд чанаргүй эрүүл мэндийн хэрэгсэл, эм, КОВИД-19-ийн тест нийлүүлэгдэх аюултай юм.

“Бараа, бүтээгдэхүүн нийлүүлэгчдийн үгсэн хэлцэх хуйвалдаан нь шаардлагатай бараа бүтээгдэхүүний үнийг байж болохгүй түвшинд хүртэл өсгөж, зах зээлийн нөхцөл байдлыг гажуудуулж, олон хүнд шаардлагатай амин чухал эмчилгээ, үйлчилгээ хүрэлцэхгүй байх нөхцөлийг бий болгож байна” хэмээн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга мэдэгдэв.

Тэрээр улс орнуудыг дээрх байдалтай хамтран тэмцэх, хувийн салбарынхныг үүрэг хариуцлагаа ухамсарлаж ёс зүйн зохих түвшинд ажиллах, улс орны тэргүүнүүдийг ард иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээхийг уриалав. Түүний хэлснээр энэхүү хүндрэлтэй нөхцөл байдалд мэдээллийн ил тод байдал, нээлттэй байдал асар чухал ажээ.

Авлига бол олон нийтийн итгэлийг алдагдуулсан, ёс зүйгүй гэмт үйлдэл бөгөөд авлигын эсрэг институцуудыг дэмжиж бэхжүүлж байх ёстойг Ерөнхий нарийн бичгийн дарга хэлсэн үгэндээ анхааруулав.

Кипр улсын Ардчилсан намаас авлигатай тэмцэх чиглэлээр 11 санал гаргажээ²⁶⁸

2020.11.02. Кипр улсын Ардчилсан намаас авлигатай тэмцэх чиглэлээр 11 санал хүргүүлжээ. Тухайлбал:

- 1) Ерөнхий аудиторын газраас шалгахыг хүссэн бүх баримт бичиг, анхан шатны мэдээлэлд саадгүй нэвтэрч байх
- 2) Ерөнхий сайд, парламентын гишүүн, хотын даргаар өмнө нь ажиллаж байсан хүмүүсийг Ерөнхий прокурор, ерөнхий прокурорын туслахын албан тушаалын томилгоонд нийцэхгүй гэсэн албан тушаалын шалгуурыг тогтоох
- 3) Засгийн газраас томилдоггүй, парламентаас баталдаг бие даасан авлигатай тэмцэх байгууллага байгуулах
- 4) Мэргэжилтнүүдийг багтаасан авлигатай тэмцэх тусгай зөвлөх байгууллагыг байгуулах.
- 5) Жил бүр улс төрчид, хараат бус албан тушаалтнууд, өндөр албан тушаалтнууд, хотын дарга нарын өмч, хөрөнгийг шалгах
- 6) Парламентын гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлгийг шинэчлэх, сайжруулах
- 7) Шүтэл үлээгчийн тухай хууль тогтоомжийг нэн даруй сурталчилах
- 8) Төрийн өмчит хувьцаат компанийн захиргааны зөвлөлийг шалгах гүйцэтгэх бус гишүүдийг томилох
- 9) Сайд нарын Зөвлөлийн Ерөнхийлөгч, сайд нар, тэдний гэр бүлийн холбоотой бүх шийдвэрийг нэн даруй зарлах
- 10) Сайд нарын Зөвлөлийн Ерөнхийлөгч, сайд нар, тэдний гэр бүлийн гишүүдтэй холбоотой сүүлийн долоон жилийн хугацаанд гаргасан бүх шийдвэрийг нэн даруй зарлах

²⁶⁷ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://news.un.org/en/story/2020/10/1075432>

²⁶⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://in-cyprus.philenews.com/diko-submits-11-proposals-to-combat-corruption/>

11) Төрийн албанд сэлгэн ажиллах чадвар бүхий хэлтсүүдийн жагсаалтыг гаргах

Үүний зэрэгцээ, авлигын эсрэг нэмэлт арга хэмжээний талаарх аливаа үйл ажиллагаа, хэлэлцүүлэгт Ардчилсан нам бэлэн байгаа гэдгээ мэдэгджээ.

Сүүлийн жилүүдэд Кипр улсын Ерөнхийлөгч Никос Анастасиадисын удирдаж буй засгийн газар улс орныг авлигын шинжтэй болгох, албан байгууллагуудыг үл хүндэтгэх, бие даасан хуулийн байгууллагад дарамт үзүүлэх, тэр ч байтугай сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх зэргээр буруу тал руу өөрчилж байгааг тус намаас тэмдэглэв. Үүний үр дүнд улс орон олон улсын түвшинд нэр хүндгүй болж, байгууллагуудын үйл ажиллагааг доройтуулж, улсын мөнгийг үр ашиггүй зарцуулж, олон нийтийг төр, улс төрчдийн эсрэг чиглүүлж байна гэжээ.

НҮБ-ын МБГХТА авлигын эсрэг блокчэйн технологи ашиглахыг Кени улсад зөвлөж байна²⁶⁹

2020.11.03. Блокчэйн технологи нь Кени шиг улсуудад авлигын улмаас олон тэрбум доллар алдахгүй байхад туслах болно гэж НҮБ-ын МБГХТА-ны зөвлөх мэдээлэв.

Блокчэйн гэх мэт шинэ технологиуд нь Кени улсад засгийн газрын авлига болон бусад эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэхэд туслах болно гэж НҮБ-ын МБГХТА-ны авлигатай тэмцэх бүс нутгийн зөвлөх Дэвид Робинсон үзэж байна.

11 дүгээр сарын 03-ны өдрийн Nation Media Group-ийн нийтлэлд бичсэнээр блокчэйн технологид суурилсан шийдлүүд нь гүйлгээг бүрэн хянах боломжийг бүрдүүлж, олон нийтийн бүртгэлийг залилан мэхлэлт болон хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалах боломжтой гэж Робинсон мэдэгджээ. Тэрээр *“Блокчэйн технологи нь авлигаас урьдчилан сэргийлэх, олон нийтийн бүртгэлийг залилан мэхлэлт болон хөндлөнгийн нөлөөллөөс хамгаалахад ашиглаж болох хэрэгсэл тул дэлхийн хамтын нийгэмлэг, олон улсын байгууллагуудын сонирхлыг татдаг”* гэжээ.

Робинсон, авлига нь олон нийтийн итгэлийг эвдэж байгаа тул блокчэйн технологи нь итгэлцлийг бэхжүүлэх чухал хэрэгсэл юм гэжээ.

Авлигатай тэмцэх орчин үеийн техник технологи байхгүйгээс шалтгаалан Кени улс жил бүр улсын төсвийнхөө гуравны нэг хүртэлх хувийг авлигад алддаг гэсэн мэдээлэл байна. Мөн авлигын хэргүүдийг хянаж чадаагүйгээс тус улс жил бүр 6 тэрбум долларын алдагдал хүлээдэг гэсэн мэдээлэл байна.

Дэлхийн хэд хэдэн улс орон блокчэйн технологи болон криптовалют хоёрыг авлигатай тэмцэхэд боломжит хэрэгсэл гэж үзэж байна.

2020 оны 09 дүгээр сард Дани улсын Гадаад хэргийн яамнаас авлигатай тэмцэхэд блокчэйн технологийг ашиглах талаар шинжилгээ хийсэн тайланг гаргажээ. Харин 2020 оны 07 дугаар сард Казахстан улсын Авлигатай тэмцэх газрын дарга тус улсад авлигатай тэмцэх зорилгоор үндэсний дижитал валютыг хөгжүүлэхийг уриалжээ.

Цар тахлын үе дэх улс орнуудын төрийн байгууллагуудын авлигатай тэмцэх үйл ажиллагаа²⁷⁰

2020.11.18. Aneta Wierzynska, David Clarke, Mark Dibiase, Anga R. Timilsina, Srinivas Gurazada. КОВИД-19 цар тахал тархсанаас хойш зарим бараа бүтээгдэхүүний үнэ ханш 20 дахин нэмэгдсэн байх бөгөөд үүнийг бараа бүтээгдэхүүний гэнэтийн эрэлт өссөн, нийлүүлэлт тасалдсан, түүнчлэн зах зээл дэх хууран мэхлэх үйл ажиллагаа, авлига зэргээс болж байгаад ДБ-ны зүгээс санаа зовниж байна гэж мэдээлжээ.

Зарим улс оронд хөл хорио аажмаар суларч эхэлснээр эрүүл мэндийн салбарын үйлчилгээ, худалдан авалт, төсвийн зарцуулалттай холбоотой асуудлууд үүсч байна. Судалгаагаар

²⁶⁹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://cointelegraph.com/news/un-drugs-and-crime-wing-advises-kenya-to-use-blockchain-against-corruption>

²⁷⁰ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://blogs.worldbank.org/governance/tackling-corruption-governments-covid-19-health-responses>

тогтоосноор хэвийн үед ч дэлхийн эрүүл мэндийн салбарт авлигын улмаас жилд 500 тэрбум ам.долларын хохирол учирдаг. ЭЗХАХБ-ын судалгаагаар дэлхий дахинд авлигын улмаас худалдан авалтын явцад 2 их наяд ам.доллар алддаг байна.

Цар тахалтай тэмцэхийн зэрэгцээ эрүүл мэндийн салбар дахь авлигаас урьдчилан сэргийлэх ажлыг явуулснаар нөөц хөрөнгө зорилтот бүлэгт хүрэхээс гадна төрийн байгууллагуудад итгэх иргэдийн итгэлийг нэмэгдүүлдэг.

ДБ, НҮБХХ, Глобал сан, ДЭМБ хамтран цар тахалтай үед төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх, улс орнуудын засгийн газарт дэмжлэг үзүүлэх тухай журам баталсан байна. Уг журам нь улс орны засгийн газруудын төсөв, худалдан авалт, тэдгээрийн үр дүнг ил тод, нээлттэй байлгах зорилго агуулжээ.

Хэдийгээр цар тахалтай тэмцэх нэгдсэн арга хэмжээ байхгүй ч ийм цаг үед ил тод, хариуцлага, нээлттэй байдлыг хангах нь чухал болохыг онцолжээ. Ингэснээр олон нийтийг татан оролцуулж, хяналтыг сайжруулах боломжтой юм.

Товчхондоо, засгийн газруудаас эрүүл мэндийн салбарт хаана, ямар эрсдэл байгааг тодорхойлон, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, яам, агентлаг, авлигатай тэмцэх байгууллага, иргэний нийгэм, хувийн хэвшлийн төлөөллийг багтаасан хяналтын баг ажиллуулах, иргэдийн хяналтыг нэмэгдүүлэх замаар иргэдэд авлигыг мэдээлэх эрхийг хангах, өмнөх алдаа, дутагдлуудаасаа дахин суралцах, давтахгүй байх зэрэг арга хэмжээнүүд авахыг зөвлөжээ.

Түүнчлэн эрүүл мэндийн салбар дахь авлигын эсрэг зохистой арга хэмжээг явуулах зорилгоор ДЭМБ, Глобал сан, НҮБХХ, ДБ хамтран эрүүл мэндийн салбар дахь авлигын эсрэг, ил тод, хариуцлагатай байдлын төлөө эвсэл байгуулсан байна.

Дээрх эвсэлтэй acta@who.int цахим шуудангаар холбогдон нэмэлт мэдээлэл авах боломжтой.

Дуссоуба Конатэ, Мусса Кондо нарын оролцсон шинэ подкаст цуврал²⁷¹

2020.12.15. Matthew Stephenson. Дэлхийн авлигын эсрэг подкаст нэвтрүүлгийн шинэ цуврал гарлаа. Энэ долоо хоногийн дугаарт Малигийн Эгэх хариуцлагын лабораторийн газрын захирал Дуссоуба Конатэ (Doussouba Konaté), программын ажилтан Мусса Кондо (Moussa Kondo) нартай ярилцлаа. Эгэх хариуцлагын лаборатори нь авлигатай тэмцэх, эгэх хариуцлага, шударга байдлыг дэмжихэд чиглэсэн орон нутгийн эгэх хариуцлагын лабораторийн сүлжээ хэлбэрээр зохион байгуулагдсан иргэний нийгмийн бүлгэм юм. Бидний ярилцлагад оролцсон Дуссоуба, Мусса нар авлигатай тэмцэхэд Эгэх хариуцлагын лабораторийн баримталж буй “Хүн төвтэй” байх хандлагын талаар тайлбарлаж, зарим гол санаачилгынхаа талаар ярилцав.

Шударга байдлын зураглал төсөл нь үнэнч шударга төрийн албан хаагчийг “нэрлэж, алдаршуулах”-ыг зорьдог бол иргэний үйл ажиллагааны баг нь хуурамч мэдээлэлтэй тэмцэхийн зэрэгцээ хамтын үйл ажиллагааг эрчимжүүлж, эгэх хариуцлагыг нэмэгдүүлэхийн тулд орон нутгийн нийгэмлэгүүдэд мэдээлэл цуглуулах, тэдэнд мэдээлэл түгээхэд тусалдаг.

Малигийн Эгэх хариуцлагын лаборатори нь КОВИД-19 цар тахлын тусламжийн сангийн зарцуулалтыг хэрхэн хянаж буй талаар манай ярилцлага онцолсон юм. Эдгээр тодорхой санаачилгуудаас гадна бид Малигийн улс төрийн нөхцөл байдал, улс орны өмнө тулгараад буй улс төрийн бэрхшээлүүд авлигын асуудалтай хэрхэн уялдаж байгаа болон одоо Малид авлигын эсрэг үйл ажиллагааны шинэчлэлийн гол тэргүүлэх чиглэлүүд юу болох талаар өргөн цар хүрээнд ярилцана.

Подкастыг сонсох: <https://soundcloud.com/kickback-gap/44-doussouba-konate-moussa-konda-on-anti-corruption-activities-by-accountability-lab-in-mali>

²⁷¹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/12/15/new-podcast-episode-featuring-doussouba-konate-and-moussa-kondo/>

2021.02.04. Их Британи. Хахууль, авлигын улмаас жил бүр олон их наяд ам.долларын хохирол учирч байна. Үүний тэн хагас нь байгууллагын ажилтнууд болон гүйцэтгэгч этгээдтэй холбоотой байдаг.

2010 онд батлагдсан Их Британи улсын Хахуулийн тухай хууль болон ГАУАТХ-д гэм буруутай этгээдэд нэн хүнд хариуцлага ногдуулахаар хуульчилсан байдаг. Гэвч НҮБ-аас гаргасан тооцооллоор жил бүр нэг их наяд ам.доллар хахуульд төлөгдөж, хоёр их наяд гаруй ам.долларын хохирол авлигын улмаас учирч байна.

Дэлхийн томоохон аудитын компаниудын нэг болох Пи Даблю Си (PwC) компанийн хийсэн Дэлхийн эдийн засгийн гэмт хэргийн судалгаанаас харахад Их Британи улсад эдийн засгийн гэмт хэрэг сүүлийн 24 сарын хугацаанд дээд хэмжээндээ хүрчээ. Судалгаанд хамрагдсан Их Британийн бизнес эрхлэгчдийн 56% нь залилан, авлига, бусад эдийн засгийн гэмт хэрэгт өртсөн гэж мэдэгджээ. Хачирхалтай нь 2020 оны энэхүү үзүүлэлт нь уг судалгаанд бүртгэгдсэн хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд дэлхийн дундаж үзүүлэлтээс 47%-аар илүү байна.

Засаглал, ил тод байдлаар дэлхийн хэмжээний үйл ажиллагаа явуулдаг Кролл байгууллагын гаргасан Дэлхийн 2019, 2020 оны залилан ба эрсдлийн тайланд хахууль, авлигын гэмт хэрэгтнүүдийн 27% нь аж ахуйн нэгж, байгууллагын ажилтнууд, 22% нь гүйцэтгэгч этгээд байдаг хэмээн дурдсан байна.

Тэгэхээр компаниуд өөрсдийн үйл ажиллагаан дахь хахууль, авлига, ялангуяа ажилтан, гүйцэтгэгч этгээдийн хоорондын авлигаас хэрхэн урьдчилан сэргийлэх вэ? Үүний тулд юуны өмнө хахууль, авлига байж болзошгүй дараах шинж тэмдгийг анхаарах хэрэгтэй.

1. Шаардлагагүй, эсвэл тохиромжгүй бараа, үйлчилгээ худалдан авах

Авлигын төлбөрийг бодит зардал гэж нуун дарагдуулсан байж болно. Хэрэв ажилтан илт хэрэгцээ шаардлага үүсээгүй байхад бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгч компаниас онцын шаардлагагүй, эсвэл тохиромжгүй зүйлс худалдаж авах нь авлига байж болзошгүй харилцааны илрэл гэж үзэж болох юм.

Бага хэмжээгээр байнга хийгддэг захиалга болон их хэмжээний худалдан авалтыг анхааралтай судалж үзэх хэрэгтэй. Ялангуяа худалдан авсан зүйлтэй холбоотой ямар нэгэн эрэлт хэрэгцээ гараагүй үед уг худалдан авалтыг анхааралтай судлах хэрэгтэй.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Худалдан авалтын захиалгыг давхар шалгаж байх, бараа хүлээн авсан баримтыг шалгаж, баталгаажуулж байх
- Тодорхой шалгуур тавиад, уг шалгуурыг давсан бүх худалдан авалтын хувьд бодит хэрэгцээ үүссэн эсэхийг шалгах

2. Эргэлзээтэй нэхэмжлэл

Авлигын төлбөр, хахуулийг нэхэмжлэлээр нуун дарагдуулсан байж болно. Жишээлбэл, ямар нэгэн бодит ажил хийгдээгүй, ямар нэгэн дагалдах баримт бичиггүй нөхцөлд бичигдсэн нэхэмжлэл нь аж ахуйн нэгж, байгууллагын хөрөнгийг бусдад шилжүүлэх нэг арга зам байж болзошгүй. Түүнчлэн нэмэлт төлбөр, зардал, хураамж хэлбэрээр нэхэмжилсэн дүн нь авлигын төлбөрийг нуун дарагдуулсан байж болзошгүй юм.

Хэт өндөр дүнтэй нэхэмжлэл болон эцсийн үр дүн буюу гарц нь тодорхойгүй, эсвэл үл тохирох ажлын нэхэмжлэл зэргийг анхаарч үзэх хэрэгтэй. Түүнчлэн аливаа төлбөр, хураамж, зардлыг дагалдах баримт бичиггүй нэхэмжилсэн бол анхааралдаа авах шаардлагатай. Дээр дурдсан эргэлзээтэй нэхэмжлэлийн шинж тэмдэг ажиглагдсан тохиолдолд тухайн нэхэмжлэлийг хахуулийн төлбөрийг санхүүжүүлэхэд ашиглаж байгаа гэж үзэх боломжтой юм.

²⁷² Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.skillcast.com/blog/6-red-flags-workplace-bribery-corruption?fbclid=IwAR1MgzI4BqLxC45t0fMoxycgze0gVNd2aYPkXJuZy-gOjOASr4LOBTHY0>

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Аливаа бэлтгэн нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч компани, зөвлөхтэй гэрээ байгуулахаас өмнө тэднийг судалж, шалгаж байх. Тэдний өмнөх түүх баталгаатай бөгөөд санал болгож буй бараа, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай нөөц, туршлагатай эсэхийг нягтлах
- Зах зээлийн ханшнаас хэт өндөр үнэ бүхий нэхэмжлэхийг анхаарч үзэх
- Бизнесийн бүх харилцаанд зохистой хяналт, мониторинг хэрэгжүүлэх
- Тайлбаргүй зардал, төлбөрийг баталгаажуулж, гарын үсэг зурахаас өмнө асууж лавлаж байх

3. Чанар муутай бараа, үйлчилгээг хүлээн авсаар байх

Хэрэв бараа, үйлчилгээтэй холбоотой гомдол гаргах ёстой боловч ажилтан үүнийг үл тоож, уг бараа, үйлчилгээг хүлээн авсаар байвал энэ нь авлига байж болзошгүйг илтгэх шинж тэмдэг юм.

Энэ тохиолдолд тухайн ажилтан бэлтгэн нийлүүлэгч, эсвэл туслан гүйцэтгэгчээс шан харамж авж байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй.

Залруулах арга хэмжээ:

- Худалдан авалтын гэрээтэй холбоотой хамтын шийдвэр гаргахыг шаардах
- Ажилтны томилгоог хэн нэг албан тушаалтан дан ганцаар хянадаггүй байх
- Гаргасан бүх шийдвэрийг ахлах түвшний удирдлага зөвшөөрч, баталгаажуулдаг байх
- Нийлүүлэгчтэй харилцах харилцаанд зохих хяналт, мониторинг хэрэгжүүлж, тэдгээрийн гүйцэтгэлд тогтмол хяналт тавих
- Бүх бэлтгэн нийлүүлэгчдийн өмнөх түүх баталгаатай бөгөөд санал болгож буй бараа, үйлчилгээг хүргэхэд шаардлагатай нөөц, туршлагатай эсэхийг нягталж байх

4. Ашиг сонирхлын зөрчил

Ажилтан, бэлтгэн нийлүүлэгч, гүйцэтгэгчийн хооронд нягт уялдаа холбоо, хамаарал байгаа тохиолдолд хахууль, авлигын эрсдэл нэмэгдэж болзошгүй байдаг. Муугаар бодоход хамаатан садан, найз нөхдийн харилцаа нь гаргах шийдвэрт саад болж, байгууллагын ашиг сонирхолд нийцэхгүй, буруу шийдвэр гаргахад хүргэж болзошгүй юм. Үүний зэрэгцээ энэ байдал нь авлига бий болох нөхцөлийг бүрдүүлэх магадлалтай.

Ажил, гүйлгээ, томилгоонд ажилтны хувийн болон эдийн засгийн ашиг сонирхол байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй. Тэд хувийн ямар харилцаатай вэ? Тэдэнд ойр дотно холбоо харилцаа байгаа юу? Зарим бэлтгэн нийлүүлэгчтэй холбоотойгоор ажилтнуудын зан байдал өөрчлөгддөг үү? Тэд сэжигтэй бөгөөд ердийн бус үйлдэл гаргаж байна уу? Ажилтан дангаараа тодорхой бэлтгэн нийлүүлэгчтэй харилцахыг шаардсан уу? зэрэг асуултын хариултыг олсноор ашиг сонирхлын зөрчлийг тогтоох боломжтой.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Ажилтнуудын сонирхлын зөрчлийг бүртгэх системийг хэрэгжүүлэх;
- Томилгоо хийж, шийдвэр гаргахаас өмнө ашиг сонирхлын зөрчлийг заавал шалгаж байх
- Бэлтгэн нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч, зөвлөхийг ажиллуулахаас өмнө тэднийг судалж, шалган, хэн болохыг нь сайтар шалгах
- Мерит зарчимд үндэслэн томилгоо хийж, худалдан авалтын шийдвэр гаргах
- Бэлтгэн нийлүүлэгчтэй хувийн дотно харилцаатай, эсвэл холбоотой ажилтнуудыг шийдвэр гаргах үйл явцад оролцуулахгүй байх
- Хэт нэг талыг баримталсан хандлага (жишээлбэл, хэт магтах, ойр дотно байх, ухамсаргүй хэвийх)-аас зайлсхийж, энэ нь шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлж болохыг анхаарах. Шийдвэр гаргахад олон хүнийг татан оролцуулснаар хэт нэг талыг баримталсан хандлага болон хэвшмэл хандлагыг багасгаж чадна. Гэхдээ хамтын шийдвэр гаргалтыг анхаарах хэрэгтэй.

5. Шаардлага хангаагүй гуравдагч этгээд

Хахууль, авлига нь зуучлагч, төлөөлөгчөөр дамжин гарч болзошгүй байдаг.

Аливаа аж ахуйн нэгж, байгууллагатай харилцаж байгаа гуравдагч этгээд нь гэрээ байгуулсан ажлыг гүйцэтгэх чадваргүй, үйл ажиллагаа явуулж буй салбартаа туршлагагүй, ажил гүйцэтгэхэд шаардлагатай байгууламж, нөөцгүй, гадаадын төрийн албан тушаалтны санал болгосны дагуу гэрээ байгуулсан, хууль эрх зүй, төрийн албаны шат дарааллыг хялбар даван туулах чадвартай юм шиг санагдаж байвал сэжигтэй байдгийг анхаарах хэрэгтэй.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Бэлтгэн нийлүүлэгч, гэрээт гүйцэтгэгч, зөвлөхийг ажиллуулахаас өмнө тэднийг судалж, шалган, хэн болохыг нь сайтар шалгах
- Хэрэв ямар нэгэн зүйл ул үндэслэлгүй санагдвал асууж, лавлаж байх (харалган байдал нь хамгаалалт биш юм)

6. Бүрэн бус томилолт ба зардал

Хахууль, авлигын төлбөрийг томилолтын зардал, хөнгөвчлөх төлбөр байдлаар нууж болно. Аливаа зардлыг зөвхөн холбогдох баримтад үндэслэн гаргадаг.

Холбогдох дагалдах баримт байхгүй, эсвэл ул үндэслэлгүй нөхцөлд томилолтын болон бусад зардлыг анхаарч үзэх хэрэгтэй. Энэ нь байгууллагын дотоод дахь залилан, эсвэл байгууллагын мөнгийг зохисгүй зүйлд ашиглаж байгаа гэх зэрэг илүү том хэргийн шинж тэмдэг ч байж болох юм.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ:

- Томилолт болон бусад зардлын төлбөрийг ажилтанд олгохдоо шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлж, тухайн орон нутгийн удирдлагаар баталгаажуулсан байх
- Зардлын бодлого боловсруулж, тодорхой босгыг тогтоох ба үүнийгээ байнга таниулан ойлгуулах
- Асууж лавлаж байх, ялангуяа, үндэслэлгүй зардал, эсвэл давтан гарсан зардлын талаар асууж байх

Хахууль, авлигын болзошгүй шинж тэмдгүүдийн талаар мэдэж авснаар аж ахуйн нэгж, байгууллагыг хуулийн хариуцлагаас хамгаалж, нэр хүндээ хамгаалахад чухал ач холбогдолтой юм. Хүмүүс дээрх шинж тэмдгийг мэдэж байхын зэрэгцээ зохих арга хэмжээг авж хэрэгжүүлдэг байх нь авлигаас урьдчилан сэргийлэх эхний алхам болно.

Цар тахлын үед авлигыг бууруулах 5 хэрэгсэл²⁷³

2021.02.04. Цар тахал дэлхий дахинд зөвхөн эрүүл мэнд, эдийн засаг, боловсролын хямрал үүсгээд зогсохгүй, өнөөдрийг хүртэл зохих анхаарал хандуулаагүй байсан дөрөвдэх хямралыг өдөөх магадлалтай байна.

Дэлхийг хамарсан цар тахал эрүүл мэнд, эдийн засаг, боловсролын салбарын сул талуудыг гаргаж ирсэнтэй адил мөн төрийн санхүүгийн удирдлагын сул талуудыг ч ил гаргалаа. Дэлхийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр засгийн газрууд хэрхэн шударга, ил тод байдал болон хурд хоёрын хооронд тэнцвэр олохыг хичээж буй талаарх мэдээлэл дүүрэн байна. Тэдгээр мэдээлэлд вирусний эсрэг вакцин худалдан авах нууц гэрээнүүд, нийлүүлэлтийн хэт өндөр үнэ болон тусламжийн хөрөнгийн зарцуулалт дахь авлигын талаар дурдагдаж байна.

Мэдээжийн хэрэг, удирдлагын сул тал, төсвийн хөрөнгийн үр ашиггүй удирдлага, төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглах асуудал нь шинэ зүйл бус юм. Гэвч цар тахлын үед авлигын асуудал чухал болж байна. КОВИД-19-тэй тэмцэх хүчин чармайлт гаргаж буй яг энэ мөчид бид хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй гурван зүйл байна. Үүнд: 1) нэн яаралтай, хууль

²⁷³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://blogs.worldbank.org/governance/five-tools-reducing-corruption-during-covid-19>

ёсны зардлууд, тухайлбал, тусламжийн багц санхүүжүүлэхэд бараа, бүтээгдэхүүн хэт өндөр үнээр худалдан авах, хурдтай хорогдож буй багавтар нөөцийг зориулалтын бусаар ашиглах; 2) стандартын бус тоног төхөөрөмж, эсхүл төрийн үйлчилгээнд гарч болох доголдлууд олон нийтийн аюулгүй байдалд аюул учруулах талтай; 3) мөн хамгийн чухал нь засгийн газарт итгэх олон нийтийн итгэлийг төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласнаар алдах явдал юм. Тухайлбал, засгийн газарт итгэх итгэл алдарснаар вакцин хийлгэхээс татгалзах иргэдийн тоо өсөж болзошгүй ба энэ нь вакцины үр ашгийг бууруулах аюултай юм. Гэтэл эдгээр шинж тэмдэг ажиглагдаад эхэлжээ.

Бид засгийн газарт үл итгэх байдлыг залруулах, удирдлагыг боловсронгуй болгох чиглэлээр арга хэмжээ авах шаардлагатай байна. Олон нийтийн итгэл нь зөвхөн цар тахлыг амжилттай даван гарахад төдийгүй нийгмийн нэгдмэл байдлыг хадгалан авж үлдэх хамгаалалтын хана юм.

Төсвийн хөрөнгийн удирдлагыг боловсронгуй болгох, ингэснээр өнөөгийн хямралд нөлөөлөх арга хэмжээнүүдийг сайжруулах, практикт үр дүнгээ өгөх, засгийн газруудад олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд ашиглаж болох хэрэгслүүд олон улсын болон иргэний нийгмийн байгууллага, буяны байгууллага зэрэгт байдаг.

1. Ил тод байдлыг нэмэгдүүлэх

Ихэнх засгийн газрууд интернет, цахим орчинд ил тод байдлыг дээшлүүлэх платформуудыг хөгжүүлээгүй. Тухайлбал, бүх төсөв, худалдан авалтын бүх гэрээ хэлцлүүдийг цахимжуулах шаардлагатай. Энэ нь маш хялбар бөгөөд аль эрт хийх ёстой байсан юм. Засгийн газрууд маш их мэдээллийг дотоод хэрэгцээнд, эсхүл хандивлагч байгууллагуудад гаргаж өгдөг. Гэвч эдгээр мэдээлэл олон нийтэд ил болдоггүй. Энэ бол техникийн гэхээсээ илүү улс төрийн асуудал юм.

Төрийн худалдан авалтын гэрээ, хэлцэл, төсвийн хөрөнгийн зарцуулалтыг ил тод байлгах шинэчлэл - “Нээлттэй гэрээний хамтын ажиллагаа” ([Open Contracting Partnership](#))-г олон улс оронд ашигладаг. Тухайлбал, Парагвай, Украин зэрэг улсыг дурдаж болно. Бусад улс орнууд ч эдгээрийг хэрэгжүүлэх ёстой.

2. Иргэний нийгмийн байгууллагуудаар дамжуулах

ТИ байгууллагын сүүлийн судалгаагаар хариуцлагын арга хэмжээнүүд байгаа нөхцөлд ил тод байдал нь үр ашигтай хэрэгсэл болдог байна. Бид төрийн үйлчилгээ хүргэж буй байдал, төрийн зардлыг хянах иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдийн хүчин чармайлтыг дэмжих ёстой юм.

Иргэний нийгмийн байгууллагуудад засгийн газрын хариуцлагатай байдлыг хангах, иргэдтэй хамтран ажиллах загвар, хэрэгслүүд байдаг. Тухайлбал, Өмнөд Африкийн бүх нутгаар албан бус 200 гаруй суурингуудад Олон улсын төсвийн хамтын ажиллагааны нөхөрлөл, тэдний гишүүд цар тахлын үеийн төрийн чухал үйлчилгээний талаарх мэдээллийг гар утсаар авч буй асуулгын тусламжтайгаар цуглуулж байна.

3. Технологийг ашиглах

Технологи нь авлигыг бууруулах боломжтой юм. Цахим худалдан авалт, төсвөөс гадна мөнгөн гүйлгээг технологийн тусламжтай хянаснаар өнөөгийн хямралын үед хөрөнгийг хамгийн их шаардлагатай байгаа эмзэг бүлгийнхэнд аюулгүй, үр ашигтайгаар хүргэх явдал юм.

Энэтхэгт биометрик хэмжээсээр таних төлбөрийн систем авлигыг бууруулсан ба төрийн нийгмийн хөтөлбөрүүдийг сайжруулсан байна.

4. Төрийн зохих байгууллагуудыг оролцуулах

Төрийн аудитийн байгууллага нь төрийн санхүүгийн хариуцлагыг хангах байгууллага ба хуулиар эрх нь олгогдсон. Гэвч хараат бус байдал, чиг үүрэг, нөөцийн хувьд хязгаарлагдмал байдаг. Бид эдгээр байгууллагуудыг бэхжүүлэх боломжийг эрэлхийлж байх ёстой юм.

5. Олон улсын байгууллагууд

ОУВС, ДБ болон бусад олон улсын байгууллагууд туслах боломжтой.

ДБ-ны Дэлхийн засаглал хариуцсан захирал Эд Олово-Окере “*цар тахалд үзүүлж буй хариу үйлдэл авлигын эрсдлийг нэмэгдүүлж байна*” хэмээн тэмдэглэсэн байна. Иймд ДБ эдгээр эрсдлээс

зайлсхийхийн тулд улс орнуудад зориулан КОВИД-19-ийн эсрэг арга хэмжээнүүдэд ил тод байдлыг хангах талаар зөвлөмж боловсруулсан.

Баримтыг хадгалах нь хангалтгүй гэдгийг бид мэднэ. Иргэний нийгмийн байгууллагууд, хяналтын байгууллагуудад эдгээр баримтууд нээлттэй байх ёстой. Энэ нь шаардлагатай байгаа хариуцлагатай байдлыг бий болгоно.

“Энэ хямралын цаг үед шаардлагатай байгаа бол зарцуул, харин ухаалгаар зарцуулж бүх баримтаа хадгал” хэмээн ОУВС-гийн гүйцэтгэх захирал Кристалина Георгиева хэлсэн байна.

Бид бүгд засгийн газруудад өөрийн боломжийг үр ашигтайгаар, төрийн хөрөнгийн шударгаар зарцуулах, олон нийтийн итгэлийг олж авах, хадгалахад туслах боломжтой юм.

Мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд туслах 4 зөвлөгөө²⁷⁴

2021.04.11. АНУ, Канад, Их Британи, Австрали улсын алинд байгаагаас үл хамааран санхүүгийн чиглэлийн томоохон байгууллагууд мөнгө угаах талаар бодохдоо ихэвчлэн жижиг, дунд бизнес эрхлэгчдийг туршлагагүй, гэмт хэргийн талаар мэдлэггүйг далимдуулан тэднийг гэмт хэргийн золиос болгох магадлал өндөр байдаг. Иймээс мөнгө угаах гэмт хэргийн эрсдлийг найдвартай үнэлэх нь бүх шатны бизнес эрхлэгчдэд чухал ач холбогдолтой юм.

Жижиг, дунд бизнес эрхлэгчид эргэлзээтэй хүмүүсээс сонирхол татахуйц саналыг хүлээн авдаг. Эдгээр санал нь ихэвчлэн бизнесээ өөрийн мэдэлгүй мөнгө угаах зорилгоор ашиглахад хүргэдэг. Эзэмшигч нь үүнийг мэдэхээс өмнө тэд гэмт хэрэгт холбогдож, хууль эрх зүйн хувьд ноцтой асуудалд орж болзошгүй юм.

Та томоохон корпорацад хамаардаг, эсвэл жижиг, дунд бизнес эрхэлдэг байхаас үл хамааран, хууль бус мөнгө угаах хэрэгсэл болгон ашиглах гэсэн гэмт хэрэгтнүүдээс өөрийгөө болон компаниа хамгаалах зөв арга замыг мэддэг байх нь чухал юм.

Өөрийн бизнесээ мөнгө угаах гэмт хэрэгт холбогдохоос урьдчилан сэргийлэхийн тулд дараах дөрвөн зөвлөмжийг санаж байх хэрэгтэй.

1. Мэдлэгтэй бай

Бизнесүүд цахим платформд илүү их найдаж, гүйлгээ нь ихэвчлэн интернетэд суурилдаг болсноор энгийн хэрэглэгчдийн хувьд тааламжтай болсон. Харамсалтай нь, энэхүү хурд, тааламжтай байдал нь нэлээд өндөр өртөгтэй байдаг. Гэмт хэрэгтнүүд цахим гэмт хэрэг үйлдэхэд хялбар болсон бөгөөд мөнгө угаах илүү шинэлэг хэлбэрүүд бий болж байна.

Та мөнгө угаах хамгийн сүүлийн үеийн схемийн талаар мэдлэгтэй байх ёстой бөгөөд бусад ажилтнуудаа илүү сайн мэдээлэлтэй, юунд анхаарч ажиллахаа мэддэг болгохын тулд энэ төрлийн мэдээллийг түгээх хэрэгтэй. Жишээлбэл, урьдчилсан төлбөрт зээлийн картыг ихэвчлэн мөнгө угаах гэсэн гэмт хэрэгтнүүд ашигладаг тул танай ажилтнууд үүнийг ашиглаж болзошгүй үйлчлүүлэгчидтэй илүү сонор сэрэмжтэй хандах ёстой.

2. Сонууч бай

Танд үйлчлүүлэгч, бизнесийн түнш, хөрөнгө оруулагч, тэр ч байтугай ханган нийлүүлэгчийн зүгээс гэнэт их хэмжээний мөнгө санал болговол сонор сэрэмжтэй байх ёстой.

Тухайн хүмүүсийг урьд нь ямар нэгэн гэмт хэрэгт холбогдож байсан, эсхүл ямар нэгэн хэрэгт шалгагдаж байсан эсэхийг нягталж үзээрэй. Гэрээ байгуулахаасаа өмнө холбогдох бүх хүнийг мэддэг байх нь чухал юм.

3. Шаардлагатай тохиолдолд лавлаж байх

Хэрэв хэн нэгэн танд болон танай бизнест санал тавьсан тохиолдолд хууль ёсны эсэх, эсвэл мөнгө угаах боломжтой эсэхийг шалгахын тулд хэд хэдэн зүйлийг баталгаажуулах хэрэгтэй. Нэгдүгээр алхам бол үүнд оролцсон бүх хүний талаар болон мөнгөний эх үүсвэрийг олж мэдэх явдал юм. Хэрэв хариулт нь эргэлзээтэй санагдаж байвал энэ нь асуудал дагуулах болно. Хоёрдугаарт танай бизнест их хэмжээний хөрөнгө оруулалт хийхийг хүсэж байгаа хүн гарч ирж болно. Энэ нь зарим

²⁷⁴ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.cofmag.com/2021/04/4-tips-to-help-prevent-money-laundering/>

нэг гүнзгий мөрдөгчийн ажлыг шаарддаг. Эцэст нь хэлэхэд, таны боломжит хөрөнгө оруулагчид зөвхөн бэлэн мөнгөөр харьцахыг шаардвал болгоомжлох хэрэгтэй. Үүний шалтгааныг заавал олж мэдээрэй. Хэрэв тэдний хариулт эргэлзээтэй санагдвал саналаас татгалзах нь зүйтэй.

4. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх өөрийн бодлого, хөтөлбөрийг бий болгох

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх бодлого нь зөвхөн томоохон бизнес эрхлэгчдээр хязгаарлагдахгүй бөгөөд мөнгө угаах боломжтой үйл ажиллагаанаас хамгаалах үүднээс жижиг компаниуд үүнийг хэрэгжүүлэх ёстой юм. Үүнийг хэрэгжүүлэх хамгийн сайн арга бол эхлээд мөнгө угаах үйл ажиллагааны эрсдлийн үнэлгээг хийх явдал юм. Энэ нь танай компанийг мөнгө угаах зорилгоор ашиглах эрсдэл, магадлалыг үнэлэх системчилсэн үйл явц юм.

Эрсдлийн үнэлгээ нь өөрийн компанийн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх үндсэн суурь болно. Та өөрийн компанийн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хөтөлбөрийг бий болгосны дараа ч эрсдлийн үнэлгээг тогтмол хийж байх ёстой бөгөөд ингэснээр компанийнхаа эрсдэлд өртөж болзошгүй байдлыг байнга мэдэж байх болно.

[КОВИД-19 тахлын эдийн засгийн үр дагаврыг даван туулахдаа авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхийг ГРЕКО улс орнуудад уриалав²⁷⁵](#)

2021.04.15. КОВИД-19 цар тахлын эсрэг онцгой арга хэмжээ авах, түүний нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулах зорилгоор эдийн засагт их хэмжээний хөрөнгө оруулах зэргээс үүссэн авлигын эрсдлийг засгийн газрууд хатуу хянах ёстой гэж Европын зөвлөлийн авлигын эсрэг байгууллага ГРЕКО-гийн гаргасан жил тутмын тайланд дурджээ.

Жил гаруйн хугацаанд засгийн газрууд эрх мэдлийн төвлөрөл, үндсэн эрхийн доройтол зэрэгт яаралтай арга хэмжээ авах шаардлагатай бөгөөд дутуу үнэлж болохгүй, авлигын эрсдэлтэй зэрэгцэн оршиж буй асуудал болохыг ГРЕКО онцолж байна. Эдгээр эрсдэл нь ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын дарамт үзүүлэх гэх мэт асуудлаар төрийн худалдан авах ажиллагааны тогтолцоонд илт мэдрэгддэг.

Ерөнхий нарийн бичгийн дарга Мария Пейчинович Бурич “*Бидний өмнө тулгараад байгаа хүнд хэцүү цаг үед засгийн газрууд нийгмийн эрүүл мэндийн асуудал, эдийн засгийн хямралыг шийдвэрлэхэд чиглэсэн бүхий л бодлого, үйл ажиллагааг авлигын эсрэг стандартад нийцүүлэхийн тулд хүчин чармайлтаа нэмэгдүүлэх ёстой. Авлигатай тэмцэх хууль тогтоомж, институцийн тогтолцоо хангалтгүй байна. Эдгээр стандартыг практик дээр үр дүнтэй хэрэгжүүлж байгааг бид харах ёстой бөгөөд засгийн газрууд ил тод, хариуцлагатай ажиллах ёстой*” гэжээ.

Энэхүү тайланд ГРЕКО-гийн Ерөнхийлөгч Марин Мрчела цар тахлын үед авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэхийн тулд улс орнуудыг 2020 онд ГРЕКО-гоос гаргасан удирдамжийг чанд мөрдөхийг уриалав. “*Онцгой байдлын үед бүх шийдвэр, үйл ажиллагааг ил тод, шударга, хариуцлагатай байдлаар боловсруулах нь нэн чухал юм*” гэж тэр хэлжээ.

ГРЕКО-гийн 2020 оны тайланд үндэслэн тэрээр “*Зарим гишүүн орнууд гүйцэтгэх засаглал, эсвэл хууль тогтоох эрх мэдлээр далайлгаж “Мэдэгдэхүйц хандлага” гарган, шүүх засаглалыг айлган сүрдүүлэх, эрхшээлдээ оруулах зорилгоор ашиглаж байгаад харамсаж байна*”, “*Авлигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авж хэрэгжүүлэхдээ авлигатай тэмцэх нь шүүхийн хараат бус байдлаас тусдаа, тэр ч байтугай эсрэг зүйл гэж үзэх ёсгүйг санаж байх хэрэгтэй*” гэжээ.

2020 онд ГРЕКО-гийн гишүүн орнууд парламентын гишүүн, шүүгч, прокурортой холбоотой авлигаас урьдчилан сэргийлэх зөвлөмжийнхөө бараг 40%-ийг бүрэн хэрэгжүүлжээ. Парламентын гишүүдийн талаар гаргасан зөвлөмжийн 30% нь бүрэн хэрэгжсэн нь хамгийн бага үзүүлэлт байгаа бол шүүгчтэй холбоотой зөвлөмжийн 41%, прокурортой холбоотой зөвлөмжийн 47% нь бүрэн хэрэгжсэн байна.

²⁷⁵ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.coe.int/en/web/human-rights-rule-of-law/-/greco-urges-states-to-prevent-corruption-risks-in-measures-aimed-at-tackling-the-economic-impact-of-the-covid-19-pandemic>

Тус тайланд авлигатай тэмцэх үйл ажиллагаа болон хууль дээдлэх ёсыг сахих нь хэрхэн зэрэгцэн явагдаж байгааг онцолсон бөгөөд авлигатай тэмцэх нэрийн дор хууль дээдлэх ёс, шүүхийн хараат бус байдлыг хэзээ ч унагах ёсгүйг онцолжээ.

Авлигын эсрэг иргэдийн оролцоог дэмжих зах зээлийн судалгааны арга хандлага²⁷⁶

2021.07.13. Torplus Yomnak, Jake Pattaratanakul, Apichart Kanarattanavong, Thanee Chaiwat, Charoen Sutuktis. Чулалонгкорны их сургуулийн²⁷⁷ судлаачдын баг саяхан авлигын эсрэг тэмцэлд олон нийтийн оролцоог нэмэгдүүлдэг хүчин зүйлийг судлах, ингэснээр олон нийтийн оролцоог дэмжих чиглэлээр илүү үр дүнтэй харилцааны стратеги боловсруулах зорилгоор судалгааны төсөл хэрэгжүүлжээ. Энэхүү судалгаанд маркетингийн судалгаанд ашигладаг “сегментчилэл” гэсэн ойлголтыг ашигласан бөгөөд энэ нь тодорхой төрлийн мэдээлэлд илүү хариу үйлдэл үзүүлдэг хүмүүсийн далд бүлгийг янз бүрийн шинж чанар, үзүүлэлтээр ангилж, тодорхойлохыг зорьдог арга зүй юм. Маркетингийн судалгааг хийх үед маркетингийн зарим стратегид хамгийн их хариу үйлдэл үзүүлдэг боломжит хэрэглэгчдийг үүгээр тодорхойлдог. Үүнтэй нэгэн ижил судалгааны аргыг ашиглаж, авлигын эсрэг мэдээлэлд хариу үйлдэл үзүүлэх олон нийтийн янз бүрийн хэсэг буюу сегментийг тодорхойлж болно.

Энэхүү судалгааны төсөл нь хоорондоо хамааралтай боловч бие даасан хоёр судалгааг хамруулсан. Эхний судалгаа нь улсын хэмжээнд явуулсан судалгаа бөгөөд 720 оролцогчийг насны ангилал, оршин суугаа бүсээр нь жигд хуваарилж, авлигын эсрэг үйл ажиллагаанд хамгийн их оролцсон хүмүүсийг тодруулсан байна. Уг судалгаанд хамрагдсан хүмүүсийн авлигатай тэмцэх сонирхол, амлалтыг дөрвөн үзүүлэлтээр хэмжихийг зорьсон. Үүнд, нэгд, авлигын асуудал байгааг ухамсарлах байдал, хоёрт, авлигын үйл ажиллагаанд оролцохгүй байх хувийн амлалт, гуравт, авлигатай тэмцэх талаарх мэдээллийг бусадтай хуваалцаж, шударга байхыг уриалах байдал (“харилцаа холбоо ба урьдчилан сэргийлэх”), дөрөвт, тухайн хүн мэдэж байгаа авлигын талаар мэдээлэхэд бэлэн байдал болон авлигын эсрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцдог байдал (“идэвхтэй оролцоо”). Эдгээр хэмжигдэхүүн тус бүрийг тус тусад нь үнэлж, дараа нь “авлигын эсрэг чиг баримжаа” гэсэн нэгдсэн хэмжигдэхүүн болгон үнэлэв.

Судалгаанд оролцогчийн хүн ам зүйн үзүүлэлт (нас, хүйс, ажил мэргэжил, орлого гэх мэт) болон сэтгэлзүйн далд үзүүлэлтийг хэмжихэд зориулагдсан асуултууд мөн уг судалгаанд багтсан. Судлаачид дараа нь авлигын эсрэг тууштай чиг баримжаанд хамгийн их хамааралтай хүчин зүйлсийг тодорхойлсон бөгөөд ингэхдээ уламжлалт зах зээлийн судлаачид бүтээгдэхүүний хамгийн өндөр эрэлт хэрэгцээтэй хэрэглэгчдийг тодруулахад ашигладаг хэрэглэгчийн сегментийн арга техниктэй ижил төстэй аргыг ашигласан. Авлигын эсрэг тууштай чиг баримжаатай хүмүүсийг тодорхойлоход ашиглагдсан хүчин зүйлс нь хүн ам зүйн хүчин зүйл болохгүй бөгөөд уламжлалт хүн ам зүйн үзүүлэлттэй харьцангуй сул хамааралтай байв. Дараах хүмүүсийн хувьд авлигын эсрэг чиг баримжаа хүчтэй байв. Үүнд, нэгдүгээрт, хахууль өгсөндөө гэмших мэдрэмж их төрдөг хүмүүс, хоёрдугаарт амьдралдаа тохиолдсон үйл явдлын үр дүнг хянах чадвар сайтай гэдэгт итгэдэг хүмүүс, гуравдугаарт заавар журмыг чанд сахих хандлагатай хүмүүс, дөрөвдүгээрт “хувиа хичээсэн” бус харин “нийтэч” хүмүүс (өөрөөр хэлбэл бүлгийн сайн сайхныг хувь хүнийхээс илүү чухалчилдаг), тавдугаарт нийгмийн тэгш байдлыг дэмждэг хүмүүс (орлогын тэгш байдал ба жендэрийн тэгш байдал хоёул хамарна). Энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан хүн амыг дөрвөн сегментэд хуваасан ба эдгээр нь галын шугам дахь хүмүүс (судалгаанд оролцогчдын ~17%), үлгэр жишээ хүмүүс (~28%), масс хүмүүс (~45%), хувиа хичээсэн хүмүүс (~10%) зэрэг юм. Галын шугам дахь хүмүүс ба үлгэр жишээ хүмүүс авлигын эсрэг чиг баримжааны ерөнхий түвшин ижил төстэй байдаг боловч “идэвхтэй оролцоо” эхнийхэд нь өндөр ба “мэдээлэх болон урьдчилан сэргийлэх” нь хоёр дахь сегментэд өндөр байдаг. Нөгөө хоёр сегмент нь авлигын эсрэг чиг баримжааны хувьд харьцангуй бага боловч сэтгэлзүйн үзүүлэлтээрээ ялгаатай байдаг.

²⁷⁶ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж:

<https://globalanticorruptionblog.com/2021/07/13/guest-post-a-market-research-approach-to-encouraging-citizen-participation-in-anticorruption/?fbclid=IwAR2P8oEldcmWl6d7tVbiLA7NUH1T2v59iVbX1VG6dfglB5MeFAi2MNpcTFI>

²⁷⁷ Тайландын төрийн, бие даасан судалгааны их сургууль.

Энэхүү анхны судалгаагаар авлигын эсрэг чиг баримжааны сэтгэлзүйн онцлогийг тодорхойлж чадсан боловч эдгээр мэдээллийг дангаар нь ашиглаж, хүмүүсийг авлигын эсрэг үйл ажиллагаанд оролцуулах стратегийг тодорхойлоход хангалттай биш юм. Тиймээс хоёр дахь судалгаагаар лабораторийн туршилт хийж, их сургуулийн 240 оюутнаас түүвэрлэн, ялгаатай өнгө аяс, хүрээтэй мэдээлэл ялгаатай нөлөөлөл үзүүлэх эсэхийг тогтоосон.

Оролцогч бүрд эхлээд танилцуулга мэдээллийг уншуулж, дараа нь янз бүрийн нөхцөл байдалд хэрхэх талаар хэд хэдэн асуулт тавьсан. Эхний судалгаанд ашигласан дөрвөн хэмжээсийн дагуу хариулт авах зорилгоор асуултуудыг боловсруулсан. Жишээлбэл, зарим төрлийн авлигын шинжтэй үйлдлийг хүлээн зөвшөөрч болох эсэх, өөрсдөө тодорхой нөхцөл байдалд хахууль өгөхөд бэлэн байгаа эсэх, авлигын эсрэг мэдээллийг өөрсдийн харьяалагддаг хүрээлэлд түгээх эсэх, авлигын хэргийг мэдээлэх эсэх гэх мэт асуултуудыг оролцогчдоос асуусан. Танилцуулга мэдээллийг оролцогчдод санамсаргүй байдлаар хүргэсэн. Бүх мэдээллийн агуулга ижил төстэй бөгөөд судалгааг бөглөх зааварчилгаа төдийгүй авлигын эсрэг зарим мэдээллийг багтаасан боловч контентийг хүргэх дууны өнгө, цар хүрээ ялгаатай байв. Оролцогчдын талд нь нухацтай бөгөөд захиран тушаасан өнгө аясаар илэрхийлсэн авлигын эсрэг мэдээг хүргэсэн ба *“Та авлигын асуудлыг нухацтай авж үзэх хэрэгтэй!”*, *“Хэрэв бид одоо үүнийг засахгүй бол улс үндэстэн маань сөнөх болно!”*, *“Бид буруутныг шийтгэх хэрэгтэй, хэрэв үгүй бол манай нийгэм сүйрэх болно”*, *“Энэ судалгаанд оролцогчид дүрмийг ямагт чанд дагаж мөрдөх ёстой!”* гэх зэрэг өгүүлбэрийг хэлж байсан. Оролцогчдын нөгөө хагаст зөөлөн өнгө аястай, *“гуйя”*, *“баярлалаа”*, *“үүнийг хамтдаа хийцгээе”* гэх мэт үгсийг оролцуулан *“Авлига бол бэрхиээл, гэхдээ шийдэл байгаа”*, *“Авлигыг шийдэж, улс орноо хөгжүүлэхэд бид хамтарч ажиллах ёстой”* гэх зэрэг өгүүлбэрийг хэлж байсан. Хоёр долоо хоногийн дараа дээрх оролцогчдыг дахин туршилтад хамруулж, анхны мэдээллээс ялгаатай мэдээллийг хүргэсэн.

Аль болох бага хүчилсэн болон бага захиран тушаасан өнгөөр хүргэсэн танилцуулга мэдээлэл хүлээн авсан оролцогчдын авлигын эсрэг чиг баримжаа өндөр байсан ба тэр дундаа тэдний идэвхитэй оролцооны хэмжүүр дунджаас дээгүүр түвшинд байсан нь сонирхолтой бөгөөд таамаглахын аргагүй үр дүн байсан. Түүнчлэн, эхний удаагийн туршилтад нухацтай бөгөөд захиран тушаасан өнгөөр хийсэн мэдээлэл, дараагийн туршилтад зөөлөн өнгө аястай мэдээлэл авсан хүмүүсийн авлигын эсрэг чиг баримжаа өмнөхөөсөө нэмэгдсэн байв. Харин үүний эсрэгээр, эхлээд зөөлөн аястай мэдээлэлтэй танилцаад дараа нь захиран тушаасан мэдээлэл үзсэн хүмүүсийн авлигын эсрэг чиг баримжаа өмнөхөөсөө буурсан байв. Эндээс дүгнэхэд, аль болох бага хүчилсэн болон бага захиран тушаасан өнгөөр хүргэсэн авлигын эсрэг мэдээлэл оролцогчдын авлигын эсрэг үйл ажиллагаанд идэвхтэй оролцохыг ятгах магадлал өндөр байна.

Дээрх байдал нь авлигын эсрэг олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үр дүнтэй харилцааны стратеги боловсруулахад нөлөөлж байна. Авлигатай тэмцэх ихэнх байгууллагууд, ялангуяа, хөгжиж буй улсуудын авлигатай тэмцэх агентлагуудад сурталчилгаа, маркетингийн ажил хийх нөөц хомс байдаг тул авлигын эсрэг санаачилгыг илүү идэвхтэй хэрэгжүүлэхийг ятгаж болохуйц хүн амын хэсэгт кампанит ажлаа чиглүүлэх нь чухал юм. Авлигын эсрэг мэдээллийг авлигын эсрэг чиг баримжаа өндөртэй хүмүүст чиглүүлэх ёстой бөгөөд ингэснээр авлигын эсрэг чиг хандлага хамгийн ихээр нэмэгдэх болно. Тайланд улсын хувьд авлигын эсрэг мэдээллийг үлгэр жишээ хүмүүсийн сегмент илүү их мэдэрч, тэдний авлигын эсрэг чиг баримжаа нэмэгдсэн байх магадлалтай тул энэ сегментэд чиглэсэн мэдээлэл чухал байна. Үүнээс гадна, хүргэж буй мэдээллийн төлөв байдал, дууны өнгийг сонгохдоо зорилтот бүлэгт итгүүлэх чадварыг дээшлүүлэхэд анхаарах хэрэгтэй. Хүчтэй, захиран тушаасан, ёс суртахуунтай үг хэллэг ашигласан мэдээлэл нь хүмүүс авлигыг анхааралдаа авж, түүнтэй тэмцэхэд тусална гэж үзэх хүн байж болох юм. Гэхдээ, Тайланд улсын хувьд, дээр дурдсан судалгаанаас үзэхэд ятгаж болох хүн амын нэлээд хэсэг нь хүчилсэн, хүчтэй, захиран тушаасан үг хэллэгээс зайлсхийж, үүний оронд, илүү зөөлөн бөгөөд урам зориг хайрласан үг хэллэг ашиглах нь илүү үр нөлөөтэй байж болохоор байна.

2021.12.09. НҮБ. НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 2003 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 58/4 дүгээр тогтоолоор жил бүрийн 12 дугаар сарын 09-ний өдрийг Авлигатай тэмцэх олон улсын өдөр болгон тэмдэглэж байх шийдвэр гарсан. АЭНҮБК болон авлигын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх зорилгоор энэхүү шийдвэрийг гаргажээ.

Тухайн үед АЭНҮБК-д аль болох хурдан гарын үсэг зурж, соёрхон батлахыг бүх улс орнууд болон бүс нутгийн эдийн засгийн интеграцийн эрх бүхий байгууллагуудад НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас уриалсан байна.

НҮБ-ын МБГХТА-наас 2004 оны авлигатай тэмцэх кампанит ажлыг “Авлигын үед хүн бүр төлөөс төлдөг” уриатай явуулсан. Энэхүү кампанит ажил нь авлигын янз бүрийн хэлбэр, хэр өргөн тархсан талаар олон нийтэд сурталчлах, шударга бус үйлдлийг таслан зогсооход хувь хүн бүр идэвхтэй оролцох боломжтой гэдгийг онцлон харуулах зорилготой байв. Үүнээс хойш:

- 2005-2006 онд “Та авлигыг зогсоож чадна”²⁷⁹
- 2007-2010 онд “Авлигад Таны үгүй гэж хэлэх чухал”
- 2011-2012 онд “Авлигын эсрэг үйлдэл өнөөдөр”
- 2013 онд “0 авлига –100% хөгжил”
- 2014-2015 онд “Авлигын сүлжээг таслах нь”
- 2016-2017 онд “Хөгжил, энх тайван ба аюулгүй байдлын төлөө авлигын эсрэг нэгдэе”
- 2019 онд “Авлигын эсрэг нэгдэе”
- 2020 онд “Шударга ёсоор сэргээе”
- 2021 онд “Таны эрх, таны оролцоо: Авлигад үгүй гэж хэлье”.

НҮБ-ын МБГХТА 2021 онд “Таны эрх, таны оролцоо: Авлигад үгүй гэж хэлье” гэсэн уриа гарган дараах 6 чиглэлээр арга хэмжээ зохион байгуулав:

- Боловсрол болон залуучууд
- Спорт
- Жендерийн асуудал
- Хувийн салбар
- Ковид-19
- Олон улсын хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр авлигын хор хөнөөлийг ухуулан таниулах

Долоо хоног бүрийн кампанит ажлыг дээрх сэдвүүдийн хүрээнд авлигаас урьдчилан сэргийлэх, тэмцэх сайн туршлага, жишээг дэлхий даяар хуваалцах; бусад төрлийн гэмт хэрэгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэх; хулгайлагдсан эд хөрөнгийг эргүүлэн авах, буцааж өгөх; шинэлэг шийдлүүдийг боловсруулах; боловсролоор дамжуулан урьдчилан сэргийлэх ажлыг ахиулах; залуучуудын оролцоог нэмэгдүүлэх; иргэний нийгэм, шинжлэх ухаан, хувийн хэвшлийг татан оролцуулахыг зорьж байна.

²⁷⁸ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: https://web.archive.org/web/20051214142145/https://www.un.org/depts/dhl/events/anti_corruption/index.html, <https://www.unodc.org/unodc/en/anticorruptionday/index.html>

²⁷⁹ <https://dayfinders.com/international-anti-corruption-day/>

4. АВЛИГЫГ МЭДЭЭЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Папуа Шинэ Гвинейн парламент шүгэл үлгээгчийн хуулийг батлав²⁸⁰



Порт Морсби дахь Папуа Шинэ Гвинейн парламентын байр. (Фото: RNZ Pacific / Корой Хокинс)

2020.02.19. Папуа Шинэ Гвинейн парламент шүгэл үлгээгчийг хамгаалах хуулийг батлаад байна. Мягмар гарагт Шүгэл үлгээгчийн хууль (2020)-ийн төслийг парламентын гишүүн бүр дэмжиж санал өгсөн юм.

Хууль зүйн сайд бөгөөд Ерөнхий прокурор Дэвис Стивэний өргөн барьж байсан уг хууль нь төрийн байгууллага дахь авлигын талаар шүгэл үлгээгчийг хамгаалах зорилготой юм.

“Энэ улс дахь авлигатай тэмцэх зорилгоор засгийн газраас хэрэгжүүлж буй олон арга хэмжээний зөвхөн нэг нь энэ хууль” юм хэмээн ноён Стивэн мэдэгдсэн юм.

Мөн Авлигатай тэмцэх бие даасан хороо байгуулах хуулийн төслийг мягмар гарагт парламентад өргөн барьсан байна. Уг хуулийн төслийг парламентаар хэлэлцэхээс өмнө парламентын хороогоор хэлэлцэх ёстой.

Өмнө нь Авлигатай тэмцэх бие даасан хорооны хуулиар авлигачдад хариуцлага тооцохын тулд улс төрийн нөлөөллөөс ангид бие даасан институцийг байгуулах болно хэмээн Ерөнхий сайд Жеймс Марапе (James Marape) мөн мэдэгдэж байсан билээ.

Авлигыг илчилснийхээ төлөө 53 удаа ажил нь өөрчлөгдсөн Энэтхэгийн төрийн албан хаагчийн талаар ном бичжээ²⁸¹

2020.02.21. Одоо 53 настай Ашок Хемка Энэтхэгийн төрийн албанд 26 жил ажиллахдаа 53 удаа ажил нь өөрчлөгджээ. Түүний энэхүү хувь заяа муутай албан тушаалын замналын талаар 2

²⁸⁰ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.rnz.co.nz/international/pacific-news/409811/png-parliament-passes-whistle-blowers-bill>

²⁸¹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.theguardian.com/world/2020/feb/21/indian-civil-servant-moved-53-times-for-exposing-corruption-to-be-immortalised-in-book>

сэтгүүлч ном бичсэн нь дараа сард хэвлэгдэн гарах гэж байна. Улс төрчдийн авлигын талаар дуугүй байж чаддаггүй болохоор нь түүний албан тушаалыг байнга өөрчилж байжээ.

Авлигад автсан улс төрчид болон төрийн өндөр албан тушаалтнууд мужид нь Хемка шилжин ирж байгааг дуулмагцаа л хэрхэн буцаан шилжүүлж явуулах талаар бодож эхэлдэг байв. Нэг албан тушаал дээр хамгийн удаан ажилласан хугацаа нь 1 жил 7 сар байсан бол хамгийн богино нь 7 хоножээ. Тэрээр дунджаар 6 сар тутамд өөр жилд шилжсэн байна.

Хемка 2012 онд Конгресс намын тэргүүн Сониа Гандигийн хүргэн Роберт Вадрагийн хууль бус газрын наймааг хүчингүй болгосон гэдгээрээ хүмүүсийн дунд алдартай болсон. Одоо харин тэрээр, өөрийнх нь хэлснээр, Харияана мужийн Археологи, музейн асуудал эрхэлсэн газарт “зэвэрч” байгаа ажээ.

Сэтгүүлч Бавдип Канг, Намита Кала нар түүний амьдралын замналын талаар “Just Transferred: The Untold Story of Ashok Khemka нэртэй ном бичээд байна.

Хахуулийн талаар мэдээлснээр хэр их мөнгө авж болох вэ?²⁸²

2020.03.02. Умард Казахстан мужийн оршин суугчид авлигын талаарх мэдээллийг зохих байгууллагад өгснийхөө шанд нэг жилийн хугацаанд 1.3 сая гаруй тэнгэ²⁸³ шагнал болгон авжээ.

Бүс нутгийн авлигатай тэмцэх хэлтсийн дарга Ернар Баянгазин “энэ жилээс авлигын гэмт хэрэгтэй холбоотой мэдээлэл өгсөн хүн уг хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэний дараа хахуулийн үнийн дүнгийн 10 хувийг авах боломжтой” гэсэн байна.

Хэрэв хахуулийн хэмжээ, учруулсан хохирол, олгосон хөнгөлөлт болон үзүүлсэн үйлчилгээний үнийн дүн 2,651,000 тэнгэгээс хэтрэхгүй бол шагналын дүн нь гэмт хэргийн төрлөөс хамааран 79,530 - 265,100 тэнгэ байна. Хэрвээ илүү байвал мэдээлэгч нь заасан дүнгийн 10 хувийг авна, гэхдээ энэ нь 10,604,000 тэнгэгээс хэтрэхгүй байна.

Энэхүү шинэчлэл авлигын эсрэг тэмцэлд иргэдийн оролцоог бодитойгоор нэмэгдүүлэхэд тодорхой түлхэц өгөх ёстой гэж Ернар Баянгазин үзэж байна. “Гэхдээ миний итгэл үнэмшилээр бол, иргэд эдгээр баримтуудыг зөвхөн мөнгөний төлөө бус, харин эх оронч сэтгэлийн үүднээс мэдээлэх ёстой. Энэ нь хүн бүрийн хувьд хэвшил, иргэний байр суурь болох ёстой” гэжээ.

Судалгааны дүнгээс харахад орон нутгийн гүйцэтгэх байгууллагууд дотроос ойн аж ахуй, боловсрол, орон сууц, нийтийн аж ахуйн салбарт авлигын гэмт хэрэг түлхүү гардаг байна.

Авлигыг илчилсэн сэтгүүлчийг Беларусийн хуулийн байгууллага баривчлав²⁸⁴



Сацук эрүүл мэндийн тогтолцооны талаар судалгаа хийхээр Белсат сувагт 03 дугаар сарын 21-нд ярилцлага өгсөн юм.
(Фото: Белсат)

2020.03.30. Беларусийн Санхүүгийн гэмт хэрэг мөрдөх газраас эрэн сурвалжлах сэтгүүлч Сиархей Сацукийг өчигдөр баривчилсан талаар EJ.by цахим хуудас мэдээллээ.

Цар тахлын эсрэг засгийн газраас авж хэрэгжүүлж байгаа арга хэмжээг шүүмжлэн өгүүлэл бичсэн түүнийг бусдаас хахууль авж эрүүл мэндийн салбар дахь авлигын талаар түүх зохион бичсэн гэж буруутгажээ. Тухайлбал, Беларусийн Эрүүл мэндийн яамны өнгөрсөн онд эм худалдан авсан үйл ажиллагаанд авлига байсан талаар

²⁸² Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: https://express-kz/news/na_mestakh/skolko_deneg_mozhno_poluchit_soobshchiv_o_vzyatke-155568

²⁸³ 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн Монголбанкны ханшаар 1 тэнгэ 6.57 төгрөгтэй тэнцэж байна.

²⁸⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.occrp.org/en/daily/11949-belarus-detains-journalist-who-exposed-corruption>

бичиж, 5,000 ам.долларыг хахуульд авсан гэж түүнийг буруутгаж байгаа боловч түүнд хэн хахууль өгсөн болон ямар шалтгаанаар ийм үйлдэл хийсэн талаар Санхүүгийн гэмт хэрэг мөрдөх газраас тодорхой тайлбар өгөөгүй байна. Беларусь улсад хахууль авсан гэмт хэрэгт 3-10 жилийн хорих ял шийтгэдэг.

С.Сацук эртнээс Беларусийн эрүүл мэндийн тогтолцоон дахь авлигын талаар ил тод байдлаар шүүмжилж ирсэн. Коронавирусний цар тахал дэгдэж эхэлснээс хойш тахлын дэгдэлтийн талаарх мэдээллийг засгийн газар олон нийтээс нуун дарагдуулж байгаа талаар тэрээр удаа дараа өгүүлэл бичиж шүүмжилсэн билээ.

АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо нэг шүгэл үлээгчид 5 сая доллар олгоно²⁸⁵

2020.04.20. АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо нь мөрдөн шалгах ажиллагаанд үнэ цэнтэй мэдээлэл өгсөн нэгэн шүгэл үлээгчид 5 сая долларын урамшуулал (шагнал) олгох болсноо зарлалаа. Уг шүгэл үлээгч нь мөрдөн шалгах ажиллагаанд зарцуулах байсан цаг хугацаа, нөөцийг хэмнэх чухал ач холбогдол бүхий мэдээлэл өгсөн байна.

“Өнөөдрийн шүгэл үлээгчийн урамшуулал бол өнгөрсөн сард шүгэл үлээсэн хувь хүмүүст Үнэт цаасны хорооноос олгож байгаа долоо дахь удаагийн урамшуулал юм. Эдгээр урамшуулал нь зах зээл, хөрөнгө оруулагчдыг хамгаалахын тулд шүгэл үлээгчдийн өгч буй үнэ цэнтэй дэмжлэгийн хэмжээг харуулж байгаа юм. Бид үнэт цаасны хууль тогтоомж зөрчсөн байж болзошгүй талаарх мэдээлэл бүхий хүмүүсийг дэмждэг” хэмээн тус хорооны Шүгэл үлээгчийн газрын дарга Жейн Норберг мэдэгдсэн юм.

Тус байгууллагаас 2012 онд анхны урамшуулал олгож эхэлснээс хойш 80 хувь хүнд ойролцоогоор 430 сая долларын урамшуулал олгоод байгаа юм. Урамшууллын мөнгийг Конгрессоос байгуулсан Хөрөнгө оруулагчдыг хамгаалах сангаас гаргадаг бөгөөд уг санг үнэт цаасны хууль тогтоомж зөрчсөн этгээдүүдээс Үнэт цаасны хороонд төлсөн мөнгөн торгуулиас бүрдүүлдэг. Мөрдөн шалгах ажиллагаанд чухал ач холбогдолтой, цаг үеэ олсон, үнэн бодит мэдээллийг сайн дурын үндсэн дээр өгсөн шүгэл үлээгч урамшуулал авах боломжтой юм. Тухайн мэдээллийн дагуу оногдуулсан мөнгөн торгуулийн хэмжээ 1 сая доллароос их бол шүгэл үлээгчийн урамшуулал нь тухайн мөнгөн дүнгийн 10%-30%-тай тэнцүү байдаг.

Додд-Франкын хуульд заасны дагуу Үнэт цаас, биржийн хороо нь шүгэл үлээгчийн нууцлалыг хамгаалдаг бөгөөд тухайн шүгэл үлээгчийг тодорхойлж болохуйц мэдээллийг ил тод болгодоггүй ажээ.

Авлигын талаарх мэдээлэл бэлтгэхийн тулд сэтгүүлчид илүү ихийг золиосолсоор...²⁸⁶

2020.05.04. 05 дугаар сарын 03-ны өдөр Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр тохиож, эрэн сурвалжлах сэтгүүлчид авлигыг таних, илрүүлэх, илчлэхэд чухал үүрэг гүйцэтгэж байгааг онцлон тэмдэглэх завшаан гарлаа.

Энэ нь дэлхий даяар сэтгүүлчид болон хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд авторитар дэглэм, зохион байгуулалттай гэмт хэрэг, нөлөө бүхий хүмүүстэй холбоотой авлигын гэмт хэргийн талаарх мэдээллийг ил болгоход илүү аюултай нөхцөл үүсэн нэмэгдэж байгааг хүлээн зөвшөөрөх боломжит үе юм.

Мальта болон Словак улсад авлигыг илчилснийхээ төлөө Дафне Каруана Галициа (Daphne Caruana Galizia), Жан Күшиак (Ján Kuciak) зэрэг сэтгүүлчид амиа алдсан ноцтой хэрэг гарсан.

ЕХ-ны төв хэсэгт гарсан дээрх аллага олон нийтийн дургүйцлийг ихэд төрүүлж, гэмт хэрэг үйлдэгчдийг шүүхээр болсон байна. Хууль эрх зүйн орчин сул, авлигын түвшин өндөртэй улс орнуудад энэ төрлийн хэргийг шүүх нь илүү бэрхшээлтэй байх болно. Бодит байдал дээр АТИ-ээр авлигын түвшин өндөр гэж тооцогддог улс орнуудад хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн хамгаалалт сул байгаа хандлага анзаарагдаж байна.

²⁸⁵ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.sec.gov/news/press-release/2020-91>

²⁸⁶ Эх сурвалж: <https://www.transparency.org/en/news/the-high-costs-journalists-pay-when-reporting-on-corruption#>

Өмнөх судалгаанаас харахад авлигын түвшин өндөр улсад 7 хоног бүрд дунджаар хамгийн багадаа нэг сэтгүүлч амиа алдаж байгаа бол авлигын талаарх мэдээлэл бэлтгэж байхдаа 5 сэтгүүлч бүрийн нэг нь амиа алддаг гэх тоон үзүүлэлт байна. Дэлхийн өнцөг булан бүрд сэтгүүлчид өөрсдийн ажлаа хийж гүйцэтгэснийхээ төлөө өдөр тутам амь насаа эрсдэлд оруулсаар байна.

Зарим засгийн газар, улс төрчид шүүмжлэлт дуу хоолойг дарахын тулд хууль эрх зүй болон айлган сүрдүүлэх арга хэлбэрийг ашигладаг. Жишээ нь, Монгол Улсад төр засаг нь худал мэдээлэл тараахыг зогсоох арга хэмжээ авсан (гэмт хэрэгт тооцсон) нь хэвлэлийн эрх чөлөөг эрс хязгаарласан юм. Юу нь баримт, юу нь зохиомол болохыг дураараа шийдвэрлэх боломжтой байх нь сэтгүүлчид ихээхэн хэмжээний торгууль, эсхүл нийтэд тустай ажил хийх, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ял авах боломжтой болгож байна.

Хэдийгээр ташаа мэдээллийн тархалтыг таслан зогсоох нь чухал бөгөөд бидний судалгаагаар засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагууд хуурамч мэдээтэй тэмцэхэд хэд хэдэн арга замыг харуулж байгаа ч бодит байдал дээр Монгол Улс үг хэлэх эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчдэд хатуу шийтгэл ногдуулахын тулд хуулийг ашиглаж байна.

Худал мэдээлэл тараахыг таслан зогсоох нь чухал. Засгийн газар болон иргэний нийгмийн байгууллагууд худал мэдээлэлтэй тэмцэх хэд хэдэн арга зам байдгийг бидний судалгаа²⁸⁷ харуулж буй хэдий ч Монгол Улс үг хэлэх эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчдэд хатуу шийтгэл оногдуулахын тулд хуулийг ашиглаж байна.

Жишээлбэл, Монголын чөлөөт сайт Uug.mn-ийн сэтгүүлч У.Болортуяа Монголын хамгийн том төрийн өмчит зэсийн компани болох Эрдэнэтийн авлигыг ил болгохоор ажиллаж байсан бөгөөд түүнийг дуугүй болгох гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсаны дараа тус компанийн нэгэн ханган нийлүүлэгч У.Болортуяагийн эсрэг шүүхэд нэхэмжлэл гаргасан байдаг.

Энэ бол Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөнд халдсан хамгийн сүүлийн тохиолдол юм. Zarig.mn-ийн сэтгүүлч Н.Өнөрцэцэгийн хувьд гэхэд 2019 онд 12 удаа, 2020 онд 4 удаа хэн нэгнийг гүтгэсэн гэх шалтгаанаар буруутгагдсан. Эдгээр хэргийг түүний мэдээнд нэр нь дурдагдсан улс төрчид өдөөсөн юм. Хэдийгээр, тэрээр энэ бүгдийг амжилттай даван гарсан ч түүний эсрэг гаргасан нэг нэхэмжлэлд Монголын жирийн сэтгүүлчийн 2 сарын дундаж цалинтай тэнцэх хэмжээний /800 ам.доллар/ торгуулийг төлөх ёстой хэвээр байгаа юм.

Египтэд төр засаг нь хэвлэл мэдээллийн байгууллага дахь хяналтыг нэмэгдүүлэх, мөн худал мэдээлэл тараасан сэтгүүлчдийг хорихын тулд КОВИД-19-ийг ашиглаж байна. Эмнести интернэшнл олон улсын байгууллагын мэдээлснээр төрөөс гаргасан тодорхой дүрэм, журмыг мөрдөөгүй хараат бус, чөлөөт хэвлэл мэдээллүүдэд ажлаа алдах, эсхүл улам дордуулж байцаалт өгөх, шоронд хоригдох эрсдэл бий болж байна гэсэн юм.

Бенин дэх Игнасе Соссу (Ignace Sossou) шиг зарим сэтгүүлч ажлынхаа явцад төрийн албан хаагчийг дурдсаныхаа төлөө хоригдож байгаа талаар Сэтгүүлчдийг хамгаалах хорооноос мэдээлж байна.

Сэтгүүлчийн эсрэг үйлдэж буй гэмт хэрэг дэлхий дахинд өсөж байгаа бөгөөд засгийн газрууд сэтгүүлчдийг хамгаалахын тулд нэн даруй арга хэмжээ авах шаардлагатай байна. Хамгийн гол нь, бид бүхний амьдралд хор хөнөөл учруулж буй авлигыг илчлэхийн тулд ажиллаж буй сэтгүүлчидтэй бид нэгдмэл байгаагаа илэрхийлэх ёстой юм.

Украины Авлигатай тэмцэх товчоо Ерөнхий прокурорт хэрэг үүсгэв²⁸⁸

2020.05.05. Украины Авлигатай тэмцэх үндэсний товчоо тус улсын Ерөнхий прокурор Ирина Бенедиктонад эрүүгийн хэрэг үүсгэсэн талаар РБС-Украин мэдээллийн агентлаг мэдээлж байна.

Украины Авлигатай тэмцэх Дээд шүүх авлигын эсрэг иргэний тэмцэгч Сергей Стерненкогоос ирүүлсэн гомдлыг авж үзээд, Ерөнхий прокурорыг хөрөнгө, орлогын мэдүүлгээ худал мэдүүлж,

²⁸⁷ <https://www.transparency.org/en/news/fighting-corruption-in-the-age-of-fake-news>

²⁸⁸ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://news.am/eng/news/576581.html>



(Фото: Armenia News - NEWS.am)

мэдүүлэх ёстой хөрөнгийг нуун дарагдуулсан үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэж шалгахыг Авлигатай тэмцэх үндэсний товчооны мөрдөгчдөд даалгажээ.

Ирина Бенедиктова нь энэ оны 03 дугаар сарын 17-нд Ерөнхийлөгч Володимир Зеленскигийн зарлигаар тус улсын Ерөнхий прокуророор томилогджээ. Тэрээр Украины түүхэн дэх анхны эмэгтэй Ерөнхий прокурор болсон боловч хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ 10 мянган еврогийн үнэтэй цаг болон “Харьковын эрх зүйн төв” байгууллагын гишүүнчлэлийн талаар мэдүүлээгүй нь эрүүгийн хэрэгт татагдах үндэслэл болжээ.

Шүгэл үлээгчийн гомдолд Трампын засаг захиргааны хэрэгжүүлж байгаа цар тахлын эсрэг үйл ажиллагаан дахь авлига болон гажуудлыг илчилжээ²⁸⁹

2020.05.07. Коронавирусний эсрэг вакцин гаргаж авах ажлыг зохион байгуулах чиг үүрэг бүхий засгийн газрын агентлагийн дарга асан, доктор Рик Брайт мягмар гарагт 89 хуудас бүхий гомдол гаргав. Шүгэл үлээгчийн гомдолд Трампын засаг захиргаа хэрхэн вирусний хор аюулыг дарагдуулсан, тархалтыг нь зогсоох үр дүнтэй арга хэмжээ авахаас цааргалсан тухай болон засгийн газраас Трампын гэр бүлтэй холбоотой компаниуд болон бусад компаниудтай худалдан авалтын гэрээ байгуулахдаа авлига, ашиг сонирхлын зөрчилтэй байдал бий болгосон тухай дэлгэрэнгүй жагсаан бичсэн байна.



Доктор Рик Брайт. Фото: Wikipedia

Брайт нь 2016 оноос эхлэн Биоанагаах ухааны ахисан түвшний судалгаа, хөгжүүлэлтийн газар (BARDA)-т захирлаар ажиллаж байгаад Ройтерс агентлагийн сурвалжлагчид мэдээлэл задруулсан асуудлаар энэ оны дөрөвдүгээр сард ажлаасаа халагдсан юм. Тэрээр Цагаан ордон болон Эрүүл мэндийн яамны өндөр албан тушаалтнуудаас корона вирусний эмчилгээнд гидроксихлороквин эмийг санал болгосныг эсэргүүцэж байгаа талаараа Ройтерст мэдэгдсэн бөгөөд 04

дүгээр сард Ройтерс засгийн газар дахь ашиг сонирхлын зөрчлийн талаар өгүүлэл нийтэлсэн байна.

Шүгэл үлээгчийн гомдлыг Тусгай консулын газар хүлээн авсан бөгөөд энэ газар нь шүгэл үлээгчдийг засгийн газрын өндөр албан тушаалтнуудаас хамгаалах үндсэн үүрэгтэй байгууллага юм. Брайт гомдолдоо мөн хуучин албан тушаалдаа томилуулах, түүнийг ажлаас халсан шийдвэртэй холбогдох мөрдөн шалгалтыг эхлүүлэх хүсэлт гаргажээ.

Тэрээр энэхүү вирус АНУ-ын хүн амд аюул учруулж болзошгүй нөхцөл байдал болон амны хаалт зэрэг чухал хэрэгцээт зүйлсийн дутагдалд орох эрсдлийн талаар нэгдүгээр сараас эхлэн удаа дараа сануулж байсан тухайгаа тодорхой дурджээ.

Бразил улс шүгэл үлээгчийн тогтолцоогоо сайжруулж байна²⁹⁰

2020.06.12. Rodrigo Telles de Souza. Авлигын хэрэг нь ихэвчлэн нууц хэлбэрээр, оролцогчдыг олж тогтооход төвөгтэй байдлаар явагддаг тул авлигыг үр дүнтэй шийдвэрлэхэд ихэвчлэн

²⁸⁹ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.wsws.org/en/articles/2020/05/07/brig-m07.html>

²⁹⁰ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/06/12/improving-brazils-whistleblower-regime/#more-15747>

мэдээллийн эх сурвалжид ойр этгээдээс нотлох баримт олж авах шаардлагатай байдаг. Тиймээс шүгэл үлээгчдийг зохих журмын дагуу хамгаалах, урамшуулал өгөх нь нэн чухал юм. Бразилд бусад олон улсын адилаар шүгэл үлээгчтэй холбоотой соёл, уламжлал байдаггүй бөгөөд авлигын талаар нотлох баримтаар хангасан хүнийг хамгаалах, урамшуулах хууль эрх зүйн тогтолцоог илүү боловсронгуй болгох нь чухал юм. Сүүлийн хэдэн жилд Бразил улс энэ чиглэлээр чухал ахиц дэвшил гаргаж байгаа хэдий ч хийх зүйл их байна.

Хоёр жилийн өмнөөс эрүүгийн хэргийн талаар мэдээлэл өгсөн хүмүүсийг тодорхой хууль тогтоомжийн дагуу урамшуулах практикийг нэвтрүүлсэн. Энэ хууль тогтоомжоор Бразилийн муж улсуудад хууль бус үйлдлийн талаар мэдээлэх утасны шугам бий болгохоос гадна засгийн газрын бүх түвшинд гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хэргийг илрүүлэх, шийдвэрлэх явцад мэдээлэл өгсөн хүмүүст урамшуулал олгохыг зөвшөөрөв. Тус хууль тогтоомж нь сайн алхам болсон хэдий ч тодорхойгүй, дутуу үлдсэн зүйлүүд байсан юм.

Өнгөрсөн оны сүүлчээр Бразил улс гэмт хэрэгтэй тэмцэх тухай хууль баталсантай холбогдуулан шүгэл үлээгчийн хуулиа шинэчлэх чиглэлээр бас нэгэн чухал алхам хийсэн. Энэ хуульд үндэсний болон муж улсын засаг захиргаа, тэдгээрийн агентлаг, компаниудын төрийн захиргааны эсрэг гэмт хэрэг, зөрчил, олон нийтийн эрх ашиг, сонирхолд харшлах аливаа үйл ажиллагааг мэдээлэх боломжийг хангах үүднээс гомдлыг шийдвэрлэх алба байгуулахыг шаардсан. Энэ хуульд шүгэл үлээгчийг (санаатайгаар болон худал мэдээлэл өгснөөс бусад тохиолдолд) эрүүгийн болон иргэний хэргийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар тусгасан.

Тус хуульд шүгэл үлээгчдэд санхүүгийн шагнал олгох талаар тодорхой заалтууд оруулсан бөгөөд төрийн захиргааны эсрэг авлигын гэмт хэргээс олсон орлогын талаар мэдээлэл өгсөн хүнд тухайн гэмт хэргээс хураан авсан хөрөнгийн 5-аас доошгүй хувийн санхүүгийн урамшуулал олгохоор заасан.

Ийнхүү ахиц дэвшил гарч байгаа хэдий ч Бразилд шүгэл үлээгчийн талаарх хууль эрх зүйн орчин дутагдалтай хэвээр байгаа бөгөөд цаашид сайжруулах шаардлагатай байна.

Нэгдүгээрт. Шүгэл үлээгч нэрээ нууцлах асуудал хангалттай тодорхой болоогүй хэвээр байна. Одоо мөрдөгдөж байгаа хууль тогтоомжид шүгэл үлээгч өөрийн хувийн мэдээллийг хамгаалах эрхтэй гэж заасан байдаг боловч шинэ хуульд шүгэл үлээгч өөрийн хувийн мэдээллийг өгөхийг шаардаж байна. Шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг тодруулах нь олон нийтийн эрх ашиг, сонирхолд нийцсэн, эсвэл мөрдөн шалгах ажиллагааны явцад тодорхой ашиг тустай эсэхийг тодорхой болгох хэрэгтэй. Мөн шүгэл үлээгч нэрээ нууцлахыг хүссэн тохиолдолд дараагийн мөрдөн шалгах ажиллагааг зогсоох эсэх, шүгэл үлээгчийн хэн болохыг үнэхээр нууцалж чадах эсэх нь тодорхой бус хэвээр байна.

Хоёрдугаарт. Шүгэл үлээгчдэд санал болгосон санхүүгийн урамшуулал хэтэрхий бага бөгөөд эргэлзээтэй байна. 2019 оны хуульд урамшууллыг шүгэл үлээгчийн өгсөн мэдээллээс олсон орлогын 5 хувиас хэтрэхгүй байхаар хязгаарласан. Энэ хувь хэмжээ 20%, эсвэл 30%-аас их байх хэрэгтэй бөгөөд зөвхөн нөхөн төлсөн орлогод биш, ногдуулсан торгуулийн мөнгийг оруулан тооцох шаардлагатай юм.

Хятад: Авлигыг илчилснийхээ төлөө гурван сэтгүүлч хорих ял авлаа²⁹¹

2020.07.31. Төрийн албан хаагчдын оролцсон авлигын баримтыг илчилснийх нь төлөө Хятадын гурван сэтгүүлчийг 12-18 сарын хорих ялаар шийтгэсэн явдлыг Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллага буруушааж байна.

Хятадын төрийн мэдээллийн хэрэгслээс хараат бус, Хонконгод бүртгэлтэй авлигын эсрэг мэдээллийн эх сурвалж болох The China News Agency-ийн үүсгэн байгуулагч Ван Хонгкуан болон түүний ажилтан Тан Юнли, Ли Хеде нарыг 2020 оны 06 дугаар сарын 09-ний өдөр Хятадын Жансу мужийн Ляннюнганг хотын Ганю дүүргийн шүүхээс “хэрүүл үүсгэж, өдөөн хатгасан” хэрэгт буруутган дээрх ялыг оногдуулсан юм. Дээрх хоёр ажилтан нь шүүхээс тогтоосон ялын

²⁹¹ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://rsf.org/en/news/china-three-journalists-handed-jail-terms-reporting-corruption-0>

хугацаанаас илүү хугацаанд саатуулагдсан байсан тул шүүхийн шийдвэрийн дараа суллагдсан бол Ван Хонгкуаныг үргэлжлүүлэн хорьсон юм.

“Авлигыг мэдээлэх нь гэмт хэрэг биш. Сэтгүүлчдийг яллах ёсгүй байсан” хэмээн Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллагын Зүүн Азийн товчооны тэргүүн Седрик Алвиани мэдэгдсэн байна.

Авлигын асуудлаар бичдэг сурвалжлагчийг хөнөөжээ²⁹²



Пакистанд сэтгүүлчдийн амийг хөнөөхийг эсэргүүцсэн жагсаал Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан тавдугаар сарын 03-нд Исламабад хотноо болсон. (Фото: Фарук Наим / AFP / Getty Images)

2020.08.03. Сэтгүүлчдэд хамгийн аюултай газар болох Пакистан улсын баруун Балочистан мужийн Баркан хотын сэтгүүлч алагдсаны улмаас эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөөд байна. 07 дугаар сарын 23-ны орой түүнийг мотоциклтэй явж байхад хоёр этгээд буудан амийг нь хөнөөжээ. Түүнийг амь үрэгдсэний дараа мянга мянган хүн хотын гудамжинд гарч, уг хэргийг шударгаар шалгахыг шаардаж байна. Улмаар эсэргүүцлийн үйл ажиллагаа тус бүс нутгийн нийслэл болох Куэтта, аж үйлдвэрийн хот Гвадар зэрэгт өрнөөд зогсохгүй, цахимаар “Анвар Жанд шударга ёсоор хандая” хэмээх хөдөлгөөн өрнөөд байна.



Анвар Жан 07 дугаар сарын 23-нд Бархан хотод зэвсэгт этгээдийн гарт амиа алдсан юм.

(Фото: Anwar Jan/Twitter)

Тэрээр Naveed-e-Pakistan өдөр тутмын сонинд ажиллаж байсан бөгөөд нийгмийн сүлжээнд авлигын асуудлаар нийтлэл бичдэг байсан юм. Түүний үхлийн шалтгааныг хараат бусаар шалгахыг Хил хязгааргүй сэтгүүлчид байгууллага уриалсан байна. Тэрээр албан тушаалтнуудын авлигын үйлдлийн талаар мэдээлдэг байсан тул түүнийг санаатайгаар хөнөөсөн байж болзошгүй хэмээн тус байгууллагын Ази-Номхон далайн бүс нутгийн захирал Даниэль Бастард хэлсэн. Бид алуурчид болон захиалагчид хариуцлага тооцохын тулд шударга, хараат бусаар шалгах ажиллагаа явуулахыг Балочистан мужийн захирагч Жам Камал Ханд уриалж байна гэжээ.

²⁹² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.theguardian.com/world/2020/aug/03/killing-pakistani-anti-corruption-journalist-protests-anwar-jan>

Пакистан бол сэтгүүлчдэд хамгийн хэцүү орнуудын нэгд тооцогддог. 180 улс хамрагдсан Хэвлэлийн эрх чөлөөний 2020 оны индексээр тус улс 145 дугаарт бичигджээ. Пакистаны сонины редакторуудын холбооны мэдээллээр, тус улсад өнгөрсөн жил 7 сэтгүүлч амиа алдсан байна. Ялангуяа Балочистан муж аюултай газар юм. Энэ нутагт гадаадын сэтгүүлчдийг айлган сүрдүүлж, харин дотоодын сэтгүүлчид хүчирхийлэлд өртөж байсан байна. Пакистанд үг хэлэх эрх боомилогдож, сэтгүүл зүй ноцтойгоор хумигдан, хэвлэлийн байгууллагуудын сүлжээг зарим байгууллага гутаасан хэмээн Пакистан улсын Сэтгүүлчдийн холбооны ерөнхийлөгч Шахзада Зулфикар (Shahzada Zulfiqar) онцолсон.

Хэдийгээр сэтгүүлчдийн амь насыг хөнөөх, хулгайлах зэрэг үйлдэл гарч байсан ч улсын хэмжээнд цөөн хэдэн сэтгүүлч эдгээрээс айхгүй, ажилласаар байна. Пакистаны нийслэл Исламабад хотод сэтгүүлч Матиулла Жаныг (Matiullah Jan) хулгайлснаас хойш хэд хоногийн дараа ийнхүү Жаны амийг хөнөөсөн байна. Хэдийгээр Матиулла Жаныг хулгайлснаас хойш 12 цагийн дараа чөлөөлсөн боловч энэ нь сэтгүүлчдэд өгсөн анхааруулга байсан гэж үзэж болохоор байна.

Орон нутгийн томоохон нэр нөлөө бүхий этгээдтэй Хүнс, нийгмийн халамжийн сайд Сардар Абдул Рехман Кетраныг холбоотой гэх мэдээлэл гарсны дараа Кетран түүнийг алах тушаал өгч алуулсан гэж Жаны гэр бүлийнхэн мэдэгдсэн. Жаныг алахаас өмнө сүрдүүлж байсан хэмээн түүний ах Гулам Сарвар мэдэгдсэн байна. Харин Кетран энэ аллагад ямарч холбоогүй гэж мэдэгдэж байгаа юм.

КОВИД-19 халдварын үеэр шүгэл үлээгчид нэмэгдсэн байна²⁹³

2020.09.22. ӨАБНУ дахь олон нийтийн өмч хөрөнгө, үйлдвэрчний эвлэлийн хөрөнгө, сугалаа, хандивын хөрөнгө зэргийг хамарсан авлигын хэргийг хянах төрийн бус байгууллага болох Авлигын харуул байгууллага 2020 оны Авлигын чиг хандлагын тухай судалгааны тайлангаа өнөөдөр олны хүртээл болголоо. ӨАБНУ дахь авлигын хэрэг улам ихээр нэмэгдэж байгааг уг тайланд дурджээ. Түүнчлэн цар тахал гарсан байсан ч ард иргэд авлигачдыг илрүүлж, тэдний тарьсан балгийг таслан зогсоохыг эрмэлзсэн хэвээр байгааг уг тайлангаар харууллаа.

Оны эхний хагаст 2,000 орчим хүн авлигын талаар мэдээлэл өгсөн ба энэ нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 400 гаруй мэдээллээр илүү байгаа юм. Эндээс дүгнэхэд, авлигачид дэлхийг хамарсан цар тахлаас амьд гарахыг хичээж буй жирийн хүмүүсийн дургүйцлийг хүргэж байна.

“Бидэнд ирсэн мэдээлэл засгийн газрын бүхий л салбарт илэрсэн, хувийн хэвшлийн оролцоотойгоор хийгдсэн, манай нийгмийн олон салбарыг хамарсан авлигын дүр зургийг харуулж байна. Авлига нь нийгэмд чимээгүй боловч үхлийн аюул тарьж байдаг бөгөөд авлигачдын үйлдлийн улмаас хамгийн их хохирч байгаа хүмүүс бол эмзэг, ядуу бүлгийнхэн юм” гэж энэ тайлангийн анхан шатны судлаач Мелуси Нкала хэлсэн байна.

Авлигын талаарх мэдээллийн бараг 55% нь тус улсад 03 дугаар сарын дундуур үндэсний хэмжээний гамшгийн нөхцөл байдал зарласны дараа иржээ. Үүнээс, 13% нь ӨАБНУ-ын цагдаагийн албан дахь авлигын хэргийг нотолж байгаа бол 5% нь хотын захиргааны байгууллага, сургууль, замын хөдөлгөөний болон лицензийн төвүүдтэй холбоотой, харин 4% нь эрүүл мэндийн салбарт хамааралтай байжээ. Эдгээр нь нийлээд тухайн хугацаанд хүлээн авсан нийт мэдээллийн гуравны нэг орчим болж байна. Үүний зэрэгцээ цагдаагийн байгууллагын авлига энэ жагсаалтыг хоёр дахь жилдээ тэргүүлж байна.

Авлигын чиг хандлагын хувьд авж үзвэл зохисгүй удирдлага, тэр дундаа засгийн газрын үйл ажиллагааг санаатайгаар тасалдуулах буюу үл тоомсорлосон тохиолдол нийт мэдээллийн 19% - ийг эзэлж байна. Үүний дараа нөөцийг зүй бусаар ашиглах явдал орж байна. Үүнд, хулгай, нийтийн албаны машин, техник хэрэгсэл, цаг хугацаа, хөрөнгийг хулгайлах, зүй бусаар ашиглах, шамшигдуулах, үргүй зарцуулсан тухай мэдээлэл 14% байна. Худалдан авах ажиллагааны зөрчил нийт мэдээллийн 14%-ийг эзэлж байгаа нь хахууль өгөх замаар тендер шалгаруулалтад нөлөөлж байсантай холбоотой юм.

²⁹³ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.corruptionwatch.org.za/cw-report-shows-whistle-blower-increase-during-covid-19/>

Тоглогч авлигын талаар мэдээлсний дагуу Пакистаны крикетийн байгууллагыг шалгахаар болов²⁹⁴

2020.10.16. Т20 үндэсний цомын тэмцээнд оролцож буй нэгэн тоглогч Равалпинди²⁹⁵ дахь тэмцээний үеэр нэгэн бооцоо зохион байгуулагчийн сэжигтэй үйлдлийн талаар мэдээлжээ. Пүрэв гарагт Пакистаны крикетийн зөвлөл (ПКЗ)-ийн авлигатай тэмцэх нэгж Холбооны мөрдөн шалгах газарт²⁹⁶ хүсэлт өгөхөөсөө өмнө мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн байна.

“Би тухайн тоглогчтой уулзаж, ПКЗ-ийн Авлигын эсрэг дүрмийг дагаж мөрдөн, авлигатай тэмцэх нэгжийн албан тушаалтанд тухайн хандлагыг мэдээлсэнд талархал илэрхийлсэн” гэж ПКЗ-ийн Авлигатай тэмцэх, аюулгүй байдлын газрын захирал Асиф Махмуд мэдэгдэлдээ дурджээ.

Мөн тэрээр *“Энэ бол бид авлигын эсрэг тогтмол сургалт явуулж байгаагийн, мөн тоглогч дүрэм болон ийм нөхцөл байдалд хүлээх үүрэг хариуцлагын талаар тодорхой ойлголттой болсны нэг илрэл”* гэв.

ПКЗ нь уг тоглогчийг тодорхойлоогүй буюу түүний талаар нэмэлт мэдээлэл өгөөгүй байна.

Энэ оны Пакистаны супер лигийн Т20 тэмцээний өмнө авлигын хэрэгт холбогдсон хандлагын талаар мэдээлээгүй тул цохиурчин Умар Акмалын тоглох эрхийг хориглосон юм. Долдугаар сард хараат бус шүүхээс түүний гурван жилийн хоригийг хоёр дахин багасгасан билээ.

Данске банкны шүгэл үлээгч Олон улсын шударга байдлын төлөөх Аллардын шагналыг хүртэв²⁹⁷



2020.10.21. Өнөөдөр Олон улсын шударга байдлын төлөөх Аллардын шагнал гардуулах ёслолын үеэр Данске банкны шүгэл үлээгч Ховард Вилкинсоныг 2020 оны шагналын хамтран ялагчаар зарлав. Аллардын шагналыг авлигын эсрэг, хүний эрхийг хамгаалахын төлөө тэмцдэг хүмүүст олгодог юм.

Энэ бол авлигын эсрэг тэмцэгчдэд зориулсан дэлхийн хамгийн том шагналуудын нэг бөгөөд 100,000 канад доллар²⁹⁸ олгодог юм. Энэ жил 80 орны 525 нэр дэвшигчийн дунд сонгон

²⁹⁴ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/10/16/pakistan-cricket-body-to-probe-after-player-reports-corruption>

²⁹⁵ Равалпинди буюу Пинди нь Пакистаны Пенжаб мужид байрладаг Равалпинди дивизийн хот, нийслэл юм.

²⁹⁶ Federal Investigating Agency (FIA)

²⁹⁷ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://whistleblowersblog.org/2020/10/articles/featured-story/danske-bank-whistleblower-wins-allard-prize-for-international-integrity/>

²⁹⁸ 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Монголбанкны ханшаар тооцвол 216,999,000 төгрөгтэй тэнцэнэ.

шалгаруулалт зохион байгуулсан байна. Мальтагийн эрэн сурвалжлах сэтгүүлч, Мальтад авлига, гэмт хэргийн талаар блог хөтөлдөг байсан Дафне Каруана Галиция мөн 2020 оны ялагчаар тодорчээ. Галиция 2017 онд автомашинд бөмбөг дэлбэрсний улмаас алагдсан юм. Гуравдугаарт Гватемал дахь Ял завшихын эсрэг Олон улсын хороо²⁹⁹-г нэрлэв.

Вилкинсон Балтын Данске банкны³⁰⁰ худалдааны нэгжийн даргын үүрэг гүйцэтгэж байх үедээ багадаа 230 тэрбум долларын өртөгтэй, түүхэн дэх хамгийн том мөнгө угаах схемийн талаар мэдээлсэн ажээ. ОХУ-аас рубль шилжүүлж, Данске банкны Эстони дахь салбарт доллар болгон хөрвүүлэн, улмаар гурван харилцагч банк (Bank of America, JP Morgan, Deutsche Bank)-ны тусламжтайгаар долларыг Нью Йорк руу шилжүүлсэн тухай мэдээ 2018 оны 09 дүгээр сарын 19-нд цацагдсан юм.

Мөнгө угаахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хийсэн бүх дотоод хяналтаа бүтэлгүй болсныг Данске банк хүлээн зөвшөөрсөн юм. Гэвч дөрвөн жилийн өмнө нэгэн шүгэл үлээгч энэхүү схемийг банкны дээд түвшинд мэдээлж байсныг олж мэджээ. Шүгэл үлээгчийг нууцлах шаардлагатай байсан хэдий ч хэдхэн хоногийн дотор Вилкинсоны нэр олон нийтэд ил болов.

Аллардын шагналын вэбсайт³⁰¹-д “Өөрт нь болон гэр бүлийнхэнд нь ихээхэн эрсдэлтэй хэдий ч Вилкинсон Европын парламентын өмнө мэдүүлэг өгч, мэдээлэгчдийг илүү их хамгаалж, ил тод байдлыг дэмжих шинэ зохицуулалтын загварыг санал болгов. Энэхүү шуугиан нь Европ даяар олон тооны мөрдөн шалгах ажиллагаа, эрүүгийн хэрэг үүсгэж, Данске-ийн гүйцэтгэх захирал огцорч, Эстони дахь салбар нь хаагдахад хүргэсэн юм” хэмээн онцолсон байна.

Вилкинсон шагналаа гардан авахдаа “Шүгэл үлээгчид бол яг үнэндээ бол хамгийн үнэнч ажилтнууд юм. Шүгэл үлээгчдийн гол зорилго бол нөхцөл байдлыг сайжруулах явдал. Заримдаа иргэд бидний хувьд засгийн газар юмуу бусад байгууллагад найдаж, тэдэнд даатгаад орхих аргагүй зүйлс байдаг. Тийм зүйлсийг иргэд бид өөрсдөө хийх хэрэгтэй болдог” хэмээв. Вилкинсон шүгэл үлээгчийн хууль эрхзүйн орчин сайжирч байгаа хэдий ч цаашид хийх зүйл их байгааг тэмдэглэсэн бөгөөд Нэгдсэн Вант Улсын Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх тухай хууль (Public Interest Disclosure Act)-аас жишээ татан, энэхүү хууль нь “хуучирсан бөгөөд зорилгодоо нийцэхээ байсан” гэв. Тэрбээр Аллардын шагналд талархлаа илэрхийлж, “Шүгэл үлээх нь чухал төдийгүй, бид бүгдээрээ амьдрахыг хүсэж буй тэр нийгмээ байгуулахад шүгэл үлээгчид үнэ цэнтэй байх ёстой” гэж хэлсэн байна.

2020 оны “Шилдэг хуульч” жагсаалтад Phillips & Cohen-ийн хоёр түнш багтжээ³⁰²

2020.12.02. Вашингтон ДС. Мэдээлэгч буюу шүгэл үлээгчийг төлөөлж ажилласных нь төлөө Филипс энд Коэний түншүүд болох Эрика Келтон, Питер Чатфилд нарыг *Washingtonian* сэтгүүл “Шилдэг хуульч” жагсаалтдаа оруулжээ.

Келтон, Чатфилд нар томоохон эвлэрлүүдэд³⁰³ ялалт байгуулж, шүгэл үлээгч үйлчлүүлэгчиддээ үлэмж хэмжээний шагнал урамшуулал олгох зэргээр шүгэл үлээгчийг төлөөлөх үйл ажиллагаанд ихээхэн амжилт гаргасан байна. Мөн тэд шүгэл үлээгчийн эрх ашиг хийгээд хамгаалалтыг сайжруулах бодлогыг дэмжсээр ирсэн бөгөөд хоёулаа *Washingtonian* сэтгүүлийн “Шилдэг хуульч” жагсаалтад олон жилийн турш тогтмол нэрлэгддэг байсан юм.

Келтон бол АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (ҮЦБХ)-ноос шүгэл үлээгчдэд олгодог хамгийн том шагналын нэгийг хүртсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шүгэл үлээгчийн хуульч юм.

²⁹⁹ The International Commission against Impunity in Guatemala (CICIG)

³⁰⁰ Danske банк бол 1871 оны 10 дугаар сарын 05-нд Den Danske Landmandsbank, Hypothek- og Vexelbank i Kjøbenhavn (Данийн Фермерүүдийн Банк, Копенгагены Моргеж ба Биржийн Банк) нэртэйгээр байгуулагдсан Данийн банк юм.

³⁰¹ <https://www.allardprize.org>

³⁰² Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.phillipsandcohen.com/top-lawyers-2020-list-for-whistleblower-attorneys-includes-two-phillips-cohen-partners/>

³⁰³ *Settlement* буюу *эвлэрэл* нь шүүхийн эцсийн шийдвэрийг хүлээхгүйгээр нэхэмжлэлийг (эсвэл гомдол, өргөдөл гаргахаас өмнөх хууль зүйн маргааныг) шийдвэрлэх үйл явц юм. Ихэнхдээ өмгөөлөгчид (заримдаа даатгалын зохицуулагчид) болон талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр эвлэрлийг байгуулдаг байна. Шүүх хурал болохоос хэдэн долоо хоногийн өмнө шүүгч, эсвэл томилогдсон өмгөөлөгч нартай тохиролцоонд хүрэхийн тулд эвлэрлийн хурлыг АНУ-ын олон муж улс шаарддаг. Мөн шүүх хуралдааны өмнө болон хуралдаан эхэлсний дараа ч эвлэрэл байгуулж болдог байна.

Тэрээр өнөөдрийг хүртэл ҮЦБХ-оос шүгэл үлээгчдэд олгодог 6 шагналыг хүртсэн бөгөөд үүнд ҮЦБХ-ны хамгийн том шагнал болох олон улсын шүгэл үлээгчдэд олгодог шагнал багтсан төдийгүй түүний нэг үйлчлүүлэгч CFTC³⁰⁴-ийн шүгэл үлээгчийн шагнал хүртсэн байна.

Тэрбээр эрүүл мэндийн салбар дахь хууран мэхлэлтийн хамгийн том хэрэг болох GlaxoSmithKline³⁰⁵ (3 тэрбум доллар), Pfizer³⁰⁶ (2.3 тэрбум доллар) зэрэг хэргийн шүгэл үлээгчийг төлөөлөн ажиллаж байжээ.

Чатфилдийн амжилттай хэрэгжүүлсэн qui tam³⁰⁷ тохиолдлуудад АНУ-ын хамгийн том эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгч HCA³⁰⁸-ийн эсрэг 881 сая доллароор шийдэгдсэн хэрэг, Старкийн хуулийг³⁰⁹ зөрчсөн Адвентист эрүүл мэндийн системийн эсрэг 118.7 сая доллароор шийдэгдсэн хэрэг багтаж байна.

Чатфилд эм үйлдвэрлэгч Cephalon-ы эсрэг qui tam хэрэгт шүгэл үлээгч үйлчлүүлэгчийнхээ хамтаар CBS телевизийн Whistleblower нэвтрүүлэгт оролцсон бөгөөд шүгэл үлээгчийн нэхэмжлэлд аюултай унтуулагч бүтээгдэхүүн болон бусад жороор олгодог эмийг жоргүйгээр хэрэглэхийг сурталчилсан гэж мэдэгдсэн юм. Cephalon уг шүгэл үлээгчийн нэхэмжлэл болон бусад хэргийг шийдвэрлэхэд 425 сая доллар төлсөн байна.

Washingtonian сэтгүүл “Шилдэг хуульч” жагсаалтаа Колумбийн тойргийн 1,000 орчим өмгөөлөгчдөөс авсан санал асуулгад үндэслэсэн бөгөөд жагсаалт хараахан эцэслэж гараагүй байгаа ба эцсийн жагсаалтыг гаргахын тулд нэмэлт судалгаа, сурвалжлага хийдэг ажээ.

[Авлигын талаар мэдээлэх төрийн албан хаагчид тун цөөхөн байна гэж Малайзын Авлигатай тэмцэх хороо үзэж байна](#)³¹⁰

2020.12.08. Малайз улс 1.6 сая орчим төрийн албан хаагчтай бөгөөд тэдгээрээс ердөө 0.01% нь өөрийн ажилладаг яам, агентлагийнхаа үйл ажиллагаан дахь авлигын талаар мэдээлэх зоригтой байдаг талаар тус улсын Авлигатай тэмцэх хороо /АТХ/-ны орлогч дарга, тэргүүн дэд комиссар Шамшун Бахарин Мохд Жамил (Shamshun Baharin Mohd Jamil) хэлэв. Мэдээлэх зориг гаргасан албан хаагчдад олон төрлийн урамшуулал олгосон хэдий ч энэ үзүүлэлт бага хэвээр байгааг мөн нэмж хэллээ.

АТХ-ны мэдээллийн сангаас харахад 2012 оноос 2019 оны хооронд ердөө 343 төрийн албан хаагч авлигын талаар мэдээлсэн байна.

“Төрийн албан хаагч хахууль авах нь гэмт хэрэг гэдгийг ойлгох хэрэгтэй ба тэдэнд хахууль өгөхийг санал болгосон талаар мэдээлснээр холбогдох арга хэмжээг авах боломжтой юм. Төрийн албан хаагчид ийнхүү мэдээлснээр зохих журмыг зөрчин зөвшөөрөл олгох, давуу байдал олгох явдлаас сэргийлнэ. Төрийн албан хаагчдад аливаа авлигын талаар мэдээлэх соёл суулгахыг зорьж байгаа ба ингэснээр төрийн албанд авлига, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглах явдлыг арилгах юм” хэмээн Дэйли Экспресст өгсөн ярилцлагынхаа үеэр хэлжээ.

Ноён Шамшун Бахарин Мохд Жамил авлигын талаар мэдээлсэн төрийн албан хаагчдыг урамшуулахыг зөвшөөрөх тухай засгийн газрын Хэрэг эрхлэх газраас 2011 онд гаргасан удирдамжаас эш татан, авлигын талаар мэдээлсэн төрийн албан хаагчид тухайн санал болгосон хахуулийн хэмжээтэй ижил дүнтэй мөнгөн урамшуулал авах болно гэжээ.

³⁰⁴ Commodity Futures Trading Commission буюу Ирээдүйн хөрөнгийн арилжааны зөвлөл.

³⁰⁵ Энэ тухай “Glaxo settles record whistleblower case for \$3 billion – Medicare fraud alleged” нэртэй нийтлэлийг <https://www.phillipsandcohen.com/whistleblowers-played-major-role-in-glaxo-case-leading-to-glaxo-s-record-settlement/> -аас үзнэ үү.

³⁰⁶ Энэ тухай “Bextra whistleblower case leads to record-setting Pfizer settlement” нэртэй нийтлэлийг <https://www.phillipsandcohen.com/bextra-whistleblower-case-leads-record-setting-pfizer-settlement/> -аас үзнэ үү.

³⁰⁷ qui tam гэдэг нь яллах ажиллагааны улмаас нөхөн төлсөн хохирол буюу санхүүгийн шийтгэлийг бүхлээр нь, эсвэл зарим хэсгийг прокурорт тусалцаа үзүүлсэн хувь хүн өөртөө авах боломжтой тухай шүүхийн тогтоол юм.

³⁰⁸ Hospital Corporation of America 1968 онд байгуулагдсан, АНУ-ын анхны эмнэлгийн компанийн нэг.

³⁰⁹ Старкийн хууль бол тодорхой төрлийн өвчтөнүүдийг эрүүл мэндийн үйлчилгээ авхуулахаар тухайн өвчтөнийг хариуцсан эмч өөрөө (эсвэл гэр бүлийн гишүүд нь) санхүүгийн харилцаатай байгууллагадаа (тухайлбал, эмнэлэгт) шилжүүлэхийг хориглодог Холбооны багц хууль юм.

³¹⁰ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.dailyexpress.com.my/news/162866/very-few-civil-servants-brave-enough-to-report-on-corruption-macc/>

Өнгөрсөн онд авлигын талаар мэдээлэл өгсөн 343 төрийн албан хаагчид АТХ-ноос 600,000 малайз рингит (147.3 мянган ам.доллар) олгожээ.

Түүний хэлснээр, төрийн албан хаагчид авлигын талаар мэдээлэх үүрэгтэй бөгөөд энэ үүргээ биелүүлээгүй албан хаагч гэм буруутай нь тогтоогдвол Авлигатай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлд зааснаар 100,000 Малайз Рингит (24,545 доллар) хүртэлх хэмжээгээр торгох, эсвэл 10 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгүүлнэ.

Өнгөрсөн 12 дугаар сарын 02-ны өдөр Куала Лумпурын шүүхээс Сангийн яамны 5 ажилтанд 1,500-2,000 малайз рингит (368-490 доллар)-ийн торгууль ногдуулсан нь дээрх хуулийг хэрэгжүүлсэн анхны тохиолдол байв.

Авлигаас ангид нийгмийг бий болгохын тулд яам, агентлагууд авлигыг илчилсэн ажилтан, албан хаагчдаа хамгаалах, дэмжлэг үзүүлэх үүргээ хэрэгжүүлэх хэрэгтэй байгааг онцолсон ба 2010 оны Шүгэл үлээгчийг хамгаалах тухай хууль, 2009 оны Гэрчийг хамгаалах тухай хуулийн дагуу АТХ нь авлигын талаар мэдээлсэн албан хаагчдыг хамгаална гэж амлажээ.

АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо шүгэл үлээгчдэд 1.1 сая гаруй долларын шагнал өгдөг³¹¹

2021.01.11. АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (ҮЦБХ) нь гурван тусдаа шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдуулан шүгэл үлээгчдэд нийт 3.6 сая гаруй доллар олгож байгаагаа мэдэгдэв.

Эхний шүгэл үлээгч нь хууль бус үйл ажиллагааны талаар чухал мэдээлэл өгснийхөө төлөө 1.8 сая гаруй доллар авсан. Шүгэл үлээгч нь хөрөнгө оруулагчдад учирсан хохирлыг бууруулах арга хэмжээг нэн даруй авж, чухал баримт бичиг болон бусад мэдээллийг өгөх, ҮБЦХ-ны цаг хугацаа, нөөцийг хэмнэж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зэргээр томоохон туслалцаа үзүүлсэн.

ҮБЦХ нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг амжилттай явуулахад туслалцаа үзүүлэх мэдээлэл өгсөн хоёр дахь шүгэл үлээгчийг 1.2 сая гаруй доллароор шагнажээ.

Гурав дахь шүгэл үлээгчийг 500 мянга гаруй доллароор шагнажээ. Мэдээлэгч нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг амжилттай явуулахад чухал мэдээллээр хангаж, байнгын туслалцаа үзүүлсэн. Шагнал олгохдоо ҮЦБХ нь хэргийн өвөрмөц баримт, нөхцөл байдлыг үндэслэн өргөдөл, гомдлыг хүлээн авахад шаардагдах мэдээллийг бүрэн хэрэгжүүлэхгүй байж болно гэж үзжээ.

ҮЦБХ нь хараат бус дүн шинжилгээ хийж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг амжилттай явуулахад чухал мэдээлэл өгсөн бас нэг шүгэл үлээгчийг 100 мянга гаруй доллароор шагнажээ. Мэдээлэгч нь олон нийтэд нээлттэй мэдээллийг ашиглан компанийн чухал хэмжигдэхүүнийг тодорхойлсон дүн шинжилгээ хийсэн бөгөөд үүний үр дүнд тухайн хэмжигдэхүүний талаарх компанийн тодруулга үндэслэлгүй болохыг харуулсан байна. Энэ нь 2021 оны санхүүгийн жилд бие даасан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шагнал хүртэж байгаа тав дахь хүн юм.

ҮЦБХ-ны Шүгэл үлээгчийн газрын дарга Жейн Норберг “Эдгээр шагналууд нь ҮЦБХ-ны мөрдөн шалгах ажиллагаанд компанийн дотоод ажилчид болон компанид хамааралгүй шүгэл үлээгчид эерэгээр нөлөөлж чадах өргөн боломжийг харуулж байна. Шүгэл үлээгчдийн хийсэн дүн шинжилгээ, мэдээлэл нь мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлэх болон одоо хийж байгаа мөрдөн шалгах ажиллагааг үр дүнтэй ахиулахад хүргэсэн тохиолдолд шагнал авах боломжтой юм.” гэжээ.

Одоогийн байдлаар тус байгууллага 2012 онд анхны шагнал гардуулснаас хойш нийт 133 хүнд 737 сая гаруй долларын шагнал олгожээ. Шагналын төлбөрийг Конгрессоос байгуулсан хөрөнгө оруулагчдыг хамгаалах сангаас гаргадаг. Тус санг аюулгүй байдлын тухай хуулийг зөрчсөний шийтгэлд ҮЦБХ-нд төлсөн мөнгөөр санхүүжүүлдэг байна.

³¹¹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: https://www.leaprate.com/financial-services/rules-and-regulation/sec-awards-whistleblowers-more-than-1-1-million/?fbclid=IwAR2E9Y_cBxhbjkkOnR43jZO0ishKQldV7DzzJXQL1E_kyT12fSpu16ljo1w



Оросын сөрөг хүчний удирдагч Алексей Навальныйгийн Авлигатай тэмцэх сан энэ үйлдлийг “асар том цохилт” гэж нэрлэв. (Фото: Александр Земляниченко / AP)

2021.04.27. ОХУ-ын шүүх шоронд хоригдож буй сөрөг хүчний удирдагч Алексей Навальныйгийн Авлигатай тэмцэх сан (АТС)-д өргөн хэмжээний хориг тавилаа гэж тус сангийн захирал мэдэгдэв. Иван Жданов шүүх АТС-г интернетэд контент байрлуулах, төрийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглах, эсэргүүцлийн жагсаал зохион байгуулах, сонгуульд оролцох, банкны хадгаламж ашиглахыг хориглолоо хэмээн мягмар гарагт олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдэгдэв.

Гэсэн хэдий ч, энэхүү шийдвэр нь АТС-ийн ажилд “нөлөөлөхгүй” гэж тэрээр нэмж хэлсэн байна.

АТС-д “зарим үйл ажиллагааг хориглох”-ыг шүүгч зөвшөөрсөн хэмээн хэргийг хаалттай хэлэлцэж байгаа тул ямар байдалтай байгааг тодруулалгүйгээр Москва хотын шүүхийн хэвлэлийн алба мягмар гаргийн өглөө сэтгүүлчдэд мэдээлжээ.

Шүүх АТС болон Навальныйгийн бүс нутгийн оффисуудын үндэсний сүлжээг “хэт даврагч” байгууллага гэж үзэж, тэднийг ISIL³¹³ (ISIS³¹⁴) болон Аль-Каидатай зэрэгцүүлэн хориг тавилаа. Тэд мөн даваа гарагт Навальныйгийн бүсийн оффисуудад ажлаа зогсоохыг даалгасан шүүхийн шийдвэрийг дагаж мөрдөж эхэлсэн байна.

ОХУ-ын эрх баригчид нууц мэдээлэл агуулсан гэж мэдэгдсэн тул шүүх уг хэргийг хаалттай хэлэлцсэн аж.

Навальныйгийн баг Кремльтэй холбоотой өрсөлдөгчөө ялахад хамгийн тохиромжтой нэр дэвшигчдэд сонгогчдыг саналаа өгөхөд нь чиглэсэн Ухаалаг санал өгөх стратегийг дэмжиж буй бүс нутгийн албадынхаа эсрэг шүүхийн шийдвэрийн талаар бүдэг бадаг ойлголтыг даваа гарагт авсан байна.

³¹² Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2021/4/27/russian-court-imposes-bans-on-navalys-anti-corruption-group>

³¹³ Islamic State of Iraq and the Levant

³¹⁴ Islamic State of Iraq and Syria

АТС энэ алхмыг “хүнд цохилт” гэж нэрлэсэн бөгөөд албан байгууллагууд ажилчид, дэмжигчдээ хамгаалахын тулд үйл ажиллагаагаа даруй зогсоох болно гэжээ. Гэвч тэд авлига, эрх баригч Нэгдсэн орос нам, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин нартай “хувийн байр сууринаас” үргэлжлүүлэн тэмцэхээ амлав.

Мягмар гарагт АТС твиттерт “дахин хориг тавьсан”-тай ижил сонсогдож байна хэмээн жиргэжээ.

“Өчигдөр тэд биднийг хязгаарласан бол нөгөөдөр биднийг бүрэн хориглох болно. Тиймээс энэ цаг үед таны санаж байх ёстой чухал мэдээлэл бидэнд бий” хэмээн бүлгийн гишүүд мэдэгдсэн байна.

Дарамт шахалт нэмэгдсээр байна

Улс орныг тогтворгүйжүүлж, “үндсэн хуулийн байгууламжийн үндэс суурийг” өөрчлөхийн төлөө ажиллаж байгаа тул Навальнийгийн бүлэглэлүүдэд “хэт даврагч” гэсэн шошго зүүх болохыг энэ сард прокуророос мэдэгдсэн юм.

Хэрэв “хэт даврагч” гэж тогтоосон тохиолдолд бүлэглэлийн гишүүд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулснаар урт хугацааны хорих ял оноож магадгүй бөгөөд эрх баригчид банкны дансыг царцаах хууль ёсны эрх мэдлийг хэрэгжүүлэх бөгөөд уг сүлжээ үйл ажиллагаагаа зогсоох, эсвэл далд хэлбэрээр явуулахад хүрэх юм.

Путины дотоодын хамгийн алдартай шүүмжлэгч Навальный 2011 онд АТС-г байгуулжээ. Тус бүлэглэл нь засгийн газрын бүх түвшний албан тушаалтнуудын холбогдсон авлигын хэргийг тогтмол мөрдөж, ихэвчлэн Youtube-ийн видеог нь дагадаг байна.

Тэрбээр 44 настай бөгөөд хэдэн сарын турш хордлогын эмчилгээ хийлгээд Германаас Орост ирснийх нь дараа баривчилсан билээ. Түүнийг хордуулсан хэмээн засгийн газрыг буруутгадаг боловч Кремль энэ мэдэгдлийг үгүйсгэсээр буй юм.

Навальний өмнө нь залилангийн хэрэг хийж, тэнсэн харгалзах хугацааг зөрчсөнийхөө төлөө Москвагаас зайтай шоронд хоёр жил хагасын хугацаатай хорих ялаар шийтгэгдэн хоригдож байгаа бөгөөд өөрөө болон түүний холбоотнууд үүнийг улс төрийн шалтгаантай гэж үзэж байгаа юм.

Тэрээр шоронд нуруу нь хүнд өвдөж, гар хөл нь мэдээ алдсан ч шаардлагатай эмчилгээг хийлгэхээс татгалзсан гэж мэдэгджээ.

Өнгөрсөн долоо хоногт тэрээр иргэний эмнэлэгт үзлэгт орсныхоо дараа 24 хоногийн өлсгөлөнгөө зогсоосон юм. Түүнчлэн эрх баригчид түүнийг оргох эрсдэлтэй хүн гэж үзсэн тул шөнийн турш цаг тутамд сэрээж “эрүүдэн шүүж” байна гэсэн гомдол гаргасан байна.

Түүний хамгаалалтын баг шүүхэд хорих байгууллагын эсрэг нэхэмжлэл гаргасан бөгөөд түүнийг баривчлагдсаны дараа анх хоригдож байсан ОХУ-ын нийслэл дэх цагдан хорих төвийг мөн шүүхэд өгсөн болохыг Москвагийн шүүхээс Интерфакс агентлагт мягмар гарагт мэдэгджээ.

Эрх баригчид Навальныйг Орост буцаж ирснээс хойш түүний холбоотнуудын эсрэг шахалтыг эрчимжүүлснээр олон шилдэг дагагчид нь эх орноо орхин гарсан буюу гэрийн хорионд байгаа юм.

**Аэробус компанийн салбар авлигын хэрэгт
буруутгагдаж, 28.1 сая фунт стерлингээр
торгуулав³¹⁵**

2020.04.29. Өнгөрсөн лхагва гарагт Аэробус компанийн салбар Английн засгийн газраас Саудын Араб улсын батлан хамгаалахад үзүүлэх үйлчилгээний гэрээтэй холбоотойгоор авлигын хэрэгт буруутгагдаж, 28.1 сая фунт стерлингийн торгууль төлөхөөр болсон. Онц ноцтой луйврын алба (ОНЛА³¹⁶)-наас тус компанийн 2008-2010 онд Саудын Арабтай хийсэн гэрээнүүдийг шалгасны үндсэн дээр Европын аэро-сансрын группийн хуучин охин компани болох GPT Тусгай төслийн удирдлагыг авлигын асуудалд Southwark Crown шүүхээс буруутай гэж үзэв.

³¹⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.ft.com/content/694d26a2-7144-4bfa-b01a-d1371ebb33d3>

³¹⁶ Serious Fraud Office нь онц ноцтой буюу нарийн төвөгтэй луйвар, хахууль, авлигын хэргийг мөрдөн шалгаж, ялладаг байгууллага юм (X.O).

Саудын Арабын Үндэсний батлан хамгаалах салбарт нийлүүлсэн харилцаа холбооны үйлчилгээтэй холбоотой 2 тэрбум фунт стерлингийн гэрээ ОНЛА-ны анхаарлыг татсан. Тус компани 7.5 сая фунт стерлингээр торгуулж, 20.6 сая фунт стерлингийг хураалгахаас гадна шүүхийн хураамж болох 2.2 сая фунт стерлингийг төлөхөөр болжээ.

Шүүхийн шийдвэрийг танилцуулахдаа “Тус компани харилцаа холбооны салбарт ашигтай гэрээ хэлцэл олж авахын тулд өндөр албан тушаалтнуудад их хэмжээний хахууль төлсөн ... Авлига бол нийгмийн хавдар юм” хэмээн шүүгч Брайн мэдэгдсэн байна.

Их Британийн армийн дэд хурандаа асан Ян Фоксли шүгэл үлээж, GPT-тэй холбоотой гомдол гаргасны дагуу тус компанид мөрдөн шалгах ажиллагаа явуулж эхэлснээс хойш 8 жилийн дараа GPT-д ял төлөвлөж байна хэмээн ОНЛА мэдэгдсэн юм.

Их Британийн компанийн хувьд шүүхийн тогтоол гаргах нь маш ховор тохиолдол бөгөөд уг тогтоолыг авлигын асуудалд буруутгагдаад байсан Аэробус компанитай ОНЛА өнгөрсөн жил 3.6 тэрбум еврогийн хэлцэл хийсний дараа гаргасан юм.

Тус байгууллагаас 3 этгээд буюу GPT компанийн гүйцэтгэх захирал асан Жефри Күүк, компанийн туслан гүйцэтгэгч хоёр компанийн санхүүгийн менежер Жон Майсон болон Батлан хамгаалах салбарын албан тушаалтан Теренс Дороти нарт ял төлөвлөөд байгаа аж. Эдгээр гурван этгээдийг мөрдөн шалгах ажиллагаа дуусаагүй байгаа юм.

GPT компанийн Батлан хамгаалах яамтай байгуулсан арван жилийн гэрээ нь өнгөрсөн жил дуусгавар болсноор тус компани идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй байгаа ч шүүхээс компанийг нь хэрэгт холбогдуулан татах боломжтой байгаа аж.

Тус компани нь мөрдөн шалгах ажиллагаатай идэвхтэй хамтран ажилласан тул шийтгэлийг хөнгөлсөн хэмээн шүүгч Брайн мэдэгдсэн бол компанийн хуульч Хьюго Кейт шүүхэд мэдүүлэхдээ “Аэробус болон GPT компаниуд нь гэмт үйлдлийн үр дагавраас зугтах ямар нэгэн үйлдэл хийгээгүй” гэжээ.

Улс хоорондын дипломат харилцааны асуудлаар зөвшөөрөл өгөх гэх зэрэг зарим нэг асуудлаар Ерөнхий прокурорын газраас зөвшөөрөл хүлээгдэж байсан тул GPT компанитай холбоотой хэрэг хэдэн жилийн өмнө Ерөнхий прокурорын газарт очсоноос хойш 2020 он хүртэл нэг хэсэг зогсонги байдалд байсан аж.

Энэхүү хэрэг нь ОНЛА-ны “амаргүй, гайхалтай ялалт” байв хэмээн Авлигын эсрэг гэрэл бүлгийн гүйцэтгэх захирал Сьюзан Хоули мэдэгджээ.

GPT компанийн дээрх хэрэг нь 2020 оны 01 дүгээр сард Аэробус компанийн охин компаниудын авлигын асуудалтай холбоотойгоор АНУ, Франц улсын эрх бүхий байгууллагууд, Их Британийн ОНЛА-ны зүгээс тус компанитай тохиролцоонд хүрсэн асуудалд огт хамааралгүй хэрэг байсан юм.

GPT компани болон ОНЛА-ны хоорондын хамтын ажиллагаа “өнгөрсөн алдаа, дутагдлаас сургамж авах, түүний эсрэг зогсох, хууль тогтоомжийг дагаж мөрдөх чиглэлээр хэрэгжүүлсэн ихээхэн хэмжээний арга хэмжээнд тулгуурласан” хэмээн Аэробус компани мэдэгдсэн байна. Мөн GPT компанийн шийдвэр нь ОНЛА-наас Аэробус компанийг шалгах ажиллагааны төгсгөлийн үе шат байсан юм. “Батлан хамгаалах ажиллагаа нь ямар нэгэн залилан, авлига, хахуулийг үл тэвчих ёстой” хэмээн Батлан хамгаалах яамнаас мэдэгдсэн байна.

[Авлигыг илчилж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудад олгох мөнгөн шагнал](#)³¹⁷

2021.07.12. Jennifer Kline. Эрэн сурвалжлах сэтгүүлчид авлигыг илчлэхэд гол үүрэг гүйцэтгэдэг. Ихэнх тохиолдолд хэвлэл мэдээллийн хэрэгслээс ил болгосны үр дүнд засгийн газар ихээхэн хэмжээний хөрөнгөө буцаан авах боломжтой болсон. Хэдэн жишээ дурдъя. 2011 онд Лос Анжелес Таймс сонинд Калифорни мужийн жижиг хотын албан хаагчид өөрсөдөө хэт өндөр цалин хөлс зүй бусаар олгосныг нийтэлж, үүнтэй холбоотой хэргүүдийг шүүсэн шүүхийн

³¹⁷ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/07/12/breaking-news-without-breaking-the-bank-monetary-rewards-for-media-organizations-that-expose-corruption/?fbclid=IwAR2hE3XJzwTheTZnv8ofkm5QU85TY5YA9yAcUrgcs52ZcDQGxSQtdEXseJY>

шийдвэрээр 20 сая орчим долларын хохирол барагдуулжээ. 2012 онд Нью Йорк Таймс сонинд Уолмарттай холбогдуулан Мексикт өргөн тархсан хахуулийг илчилсэн ба эцэст нь тус компани ГАҮАТХ-ийг зөрчсөн эсэхийг долоон жил мөрдөн шалгах явцад 282 сая долларын торгууль төлөхөөр болов. 2017 онд ОУЭССК-д хамааралтай сэтгүүлчид Панамын баримт бичгийг дэлгэж, дэлхийн удирдагчид, хар тамхины наймаачид, алдартнуудын их хэмжээний луйвар, татвараас зайлсхийсэн хэргийг илчилж, дэлхий нийтийг цочроосон. ОУЭССК-ын мөрдөн шалгалтын үр дүнд дэлхийн улс орнуудын засгийн газрууд гэмт хэрэгтнүүдээс 1.28 тэрбум долларыг нэхэмжилж авав. Малайз гаралтай Британийн сэтгүүлчийн мөрдөн байцаалтын үр дүнд Малайзын хөгжлийн төслүүдийн дуулиан хэмээх одоогоор дэлхийн хамгийн том клептократ схем гэгдэж буй, ГАҮАТХ-ийн зөрчилд 2.9 тэрбум орчим долларын торгууль ногдуулсан хэргийн анхны баттай нотолгоо болсон.

Сэтгүүлчид авлигыг илрүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь хэвлэл мэдээллийн үйлдвэрлэлд эрсдэлтэй хөрөнгө оруулалт болдог. Тухайлбал, энэ төрлийн эрэн сурвалжлах сэтгүүл зүй нь шууд сурвалжлага хийхээс хамаагүй илүү цаг хугацаа, нөөц шаарддаг бөгөөд олон ч мөрдлөг үр дүнгүй хоцордог. Мөн эрх мэдэлтэй, хүчтэй хүмүүсийн буруутай, хууль бус үйлдлийн нотлох баримтыг олж илрүүлснээ хэвлэн нийтлэх нь хууль зүйн болон улс төрийн хувьд эрсдэл дагуулж болзошгүй байдаг. Тийм ч учраас, хэдийгээр амжилттай мөрдөлтийн үр дүнд үзэлт, хандалт, нэр хүнд зэрэг хэлбэрийн урамшуулал хүртдэг ч ашиг орлого улам буурч, дайсагнасан орчинтой тулгарч буй хэвлэл мэдээллийн үйлдвэрлэл авлигын хэргийн мөрдөлтөд нийгмийн хувьд ашигтай байж болох хэмжээний хөрөнгө оруулалт хийхгүй байж магадгүй юм.

Энэ асуудлаас зайлсхийх үүднээс, миний бие хэвлэл мэдээллийн байгууллагууд дээрх төрлийн эрэн сурвалжлах сэтгүүлзүйд хөрөнгө оруулах хүчтэй хөшүүрэг бий болгох арга замыг санал болгож байна. Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд авлига, түүнтэй адилтгах хууль бус үйлдлийг ил болгосноор гэм буруутай аж ахуйн нэгж, хувь хүмүүст мөнгөн шийтгэл оногдуулсан бол тухайн хэвлэл мэдээллийн байгууллага засгийн газрын нөхөн төлбөрийн тодорхой хувийг авах ёстой. Энэ санал нь шүгэл үлээгчийг урамшуулах хөтөлбөрөөс санаа авсан ба уг хөтөлбөрийг маш олон засгийн газрууд аль хэдийн хэрэгжүүлж байна. Жишээлбэл, АНУ-д Үнэт цаасны тухай хуулийн зөрчилтэй холбоотой эх сурвалж болсон мэдээллийг сайн дураараа Үнэт цаас, биржийн хороонд гаргаж өгсөн хувь хүнд түүний мэдээллийн ач холбогдлыг харгалзан ногдуулан авсан нийт торгуулийн 10% - 30% -ийг шагнал болгон өгөх боломжтой байдаг. Үүнтэй нэгэн адил “Хэвлэл мэдээллийн урамшууллын хөтөлбөр” нь авлигыг илчлэх, таслан зогсооход эрэн сурвалжлах сэтгүүлзүйн үр нөлөөт байдлыг ихээхэн нэмэгдүүлэх боломжтой юм.

Томоохон хэмжээний авлигын хэргийг мөрдөхөд санхүүгийн нэмэлт урамшуулал шаардлагагүй байж болох юм гэдгийг үндэсний хэмжээний томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ урамшууллын хөтөлбөр нь үндэсний болон дэлхийн хэмжээний хэвлэл мэдээллийн хэрэгслийн анзаардаггүй орон нутгийн улс төрчид, компаниудыг мөрдөн сурвалжлахад бодит бэрхшээлтэй тулгараад байгаа олон нийтэд суурилсан хэвлэл мэдээллийн байгууллагуудад шаардлагатай эх сурвалж, урамшууллыг санал болгож буй юм. Орон нутгийн мэдээллийн хэрэгслүүдэд мөнгөн шагнал өгөх нь тухайн орон нутгийн мэдээний сувагт татаас өгөхөөс гадна ард иргэдэд хамгийн их хэрэгцээтэй байгаа мэдээ мэдээлэлд татаас өгч байгаа хэрэг юм. Олон нийтийн сайн сайхны төлөө оруулсан хувь нэмрийг харгалзан хэвлэл мэдээллийн байгууллагууд шагнал авах боломжийг олгодог хөтөлбөр нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд итгэх итгэлийг бэхжүүлж, сүүлийн арван жилд маш их суларч байсан итгэлийг олж авахад туслах болно. Хэргийг яллах ажиллагаа амжилттай явагдсаны дараа л шагналыг өгөх тул хэвлэл мэдээллийн байгууллагаас мэдээлсэн авлигын хэргийг шүүхээр баталж, хэвлэл мэдээллийн хэрэгслийн оруулсан хувь нэмэр, мэдээлсэн хэргийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг төрийн эрх бүхий байгууллага албан ёсоор баталгаажуулж, шагналыг олгох болно.

Хэвлэл мэдээллийн урамшууллын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд зарим нэг асуудал, бэрхшээл тулгарч болох бөгөөд тухайн нөхцөл байдалд тохируулан өвөрмөц хөтөлбөрүүд боловсруулах шаардлагатай ч байж магадгүй юм. Хөтөлбөрүүд нь ерөнхийдөө хэд хэдэн хязгаарлалт болон шаардлагыг агуулсан байх ёстой. Жишээлбэл:

- Шагналыг сэтгүүлчдэд бус хэвлэл мэдээллийн байгууллагад өгөх ёстой. Тухайн хэвлэл мэдээллийн байгууллага нь хөтөлбөрийн хүрээнд шагнал авсан мөрдөн шалгах ажиллагаанд оролцсон сэтгүүлчдэд тусгай урамшуулал олгохыг хориглох хэрэгтэй. Энэхүү хориг нь

сэтгүүлч нотлох баримт цуглуулж, үнэлэхдээ хэт нэг талыг барих хандлагаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ уг сэтгүүлчийг ажиллуулдаг хэвлэл мэдээллийн байгууллагад томоохон шагнал урамшуулал олж авах эрэн сурвалжлах ажилд их хэмжээний хөрөнгө оруулалт хийх санхүүгийн илүү хүчтэй хөшүүрэг болно. Түүнчлэн, эх сурвалж болсон мэдээллийг байнга хэвлэн нийтэлдэг хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг л уг хөтөлбөрт хамруулах ёстой. (Энд ташаа мэдээлэл цацах магадлал өндөртэй, мөн мэдээллийн найдвартай эх сурвалж болохуйц хангалттай давтамжтайгаар нийтлэх магадлал багатай иргэний сэтгүүлчдийг³¹⁸ хамруулахгүй.)

- Ард иргэдэд чирэгдэл учруулж болзошгүй доод түвшний авлигын хэргийг мөрдөн шалгах ажиллагааг хамруулахгүйн тулд урьдчилан тогтоосон босгоос давсан мөнгөн дүнг буцаан олсон тохиолдолд орон нутгийн мэдээллийн байгууллагад шагнал өгөх ёстой. (Үнэт цаас, биржийн хорооны Шүгэл үлээгч хөтөлбөр нь хуулийн дагуу хүлээх шийтгэл нь дор хаяж 1 сая доллар байх тохиолдолд л урамшуулал олгодог)
- Шагнал өгөх боломжтой хэргийн нөхөн олговрын хувь хэмжээг прокурорын байгууллага, хараат бус сэтгүүлзүйн байгууллага, эсвэл зохистой харьцаагаар байгуулсан ажлын хэсэг тодорхойлох ба хууль бус үйлдлийг илрүүлэхэд оролцсон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдол, мэдээллийн чанар зэрэг хэд хэдэн хүчин зүйлийг харгалзан шударга мэргэжлийн бүрэлдэхүүн тогтооно. Сэтгүүл зүйн мөрдлөгийн талаарх мэдлэг нь авлигын хэрэгт холбогдсон этгээдийг засгийн газарт өөрийгөө урьдчилан илчлэхэд хүргэж болзошгүй учир уг мэдээг нийтлэхээс өмнө засгийн газар мэдээлэл авсан нь хэвлэл мэдээллийн байгууллагын урамшуулал авах эрхийг үгүйсгэхгүй.
- Хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлчийн ёс зүйн дүрмийг дагаж мөрддөг үед шагнал авах эрх үүсдэг байх ёстой. Хууль зөрчсөн үйлдлийг мэдээлсэн сэтгүүлч ёс зүйгүй үйлдэл гаргасан, хууль бусаар мэдээлэл олж авсан, төлбөртэй захиалгат мэдээллийн эх сурвалж ашигласан, засгийн газрын явуулсан мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулсан тохиолдолд өгөх шагналыг багасгах эсвэл зогсоох хэрэгтэй.

Хэвлэл мэдээллийн урамшууллын хөтөлбөр бол, энгийнээр хэлэхэд, дасал болсон зүйл биш юм. Гэхдээ ийм хөтөлбөр нь авлига, хахуулийг илчлэх замаар үнэлж баршгүй хувь нэмрийг төрд оруулдаг хэвлэл мэдээллийн байгууллагуудад татаас өгөх, хэвлэл мэдээллийн байгууллагууд нөөцөө эрэн сурвалжлах сэтгүүлзүйн төрлүүдэд илүү хуваарилах хүчтэй хөшүүрэг болох болно. Өмнө тохиолдож байсан болон орчин үеийн жишээнүүдээс харахад ийм арга хэрэгслийг зөв ашиглавал улс төрийн орчныг өөрчлөх боломжтой юм.

³¹⁸ Энэ ойлголтын талаар дараах холбоосоор нэмэлт мэдээлэл авч болно:

https://www.academia.edu/36102616/%D0%98%D0%A0%D0%93%D0%AD%D0%9D%D0%98%D0%99_%D0%A1%D0%AD%D0%A2%D0%93%D2%AE%D2%AE%D0%9B_%D0%97%D2%AE%D0%99_%D0%91%D0%90_%D0%9C%D0%AD%D0%A0%D0%93%D0%AD%D0%96%D0%9B%D0%98%D0%99%D0%9D_%D0%A1%D0%AD%D0%A2%D0%93%D2%AE%D2%AE%D0%9B_%D0%97%D2%AE

5. АВЛИГЫН ЭСРЭГ ХУУЛЬ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Австрали ба далайн орнууд

Австрали: Иракийн газрын тосны хахуулийн хэргээр эрэн сурвалжлагдаж байсан этгээдүүдийг баривчиллаа³¹⁹

2020.11.18. Иракийн албан тушаалтнуудын олон сая ам.долларын хахуулийн хэрэгт холбогдуулан Австралид нэг хүнийг баривчилж, өөр хоёр хүнийг эрэн сурвалжилж байгаа талаар тус улсын цагдаагийн байгууллагаас мэдээлсэн байна.

Дээрх баривчилгаа нь АНУ-ын болон Их Британийн эрх бүхий байгууллагаас 9 жилийн турш мөрдөн шалгаж байгаа, Иракийн Газрын тосны яамны албан тушаалтнуудын авлигын хэрэгтэй холбоотой юм. Тэдгээр албан тушаалтнууд Эх газар болон далайд газрын тос дамжуулах хоолойг боловсруулж, суурилуулах гэрээ байгуулах явцад гуравдагч этгээдээр дамжуулан ойролцоогоор 77.6 сая ам.долларын хахууль авсан нь тогтоогдсон байна.

Австралийн Цагдаагийн газар, АНУ-ын ХМТ, Хууль зүйн яам болон Их Британийн эрх бүхий байгууллагууд хамтран дээрх гэрээ, төслүүдтэй холбоотой 2 сая гаруй баримт бичгийг хураан авж, 10 гаруй улсаас нотлох баримт цуглуулжээ.

Шүүхээс энэ хэрэгт холбогдуулан гурван этгээдийг баривчлах шийдвэр гаргасан ба лхагва гарагт тэдний нэгийг гадаад улсын албан тушаалтныг хахуульдах хэрэгт холбоотой гэсэн үндэслэлээр Брисбэн хотод баривчилжээ. Мөн түүнийг компанийн санхүүгийн талаар санаатайгаар худал мэдүүлсэн хэрэгт давхар буруутгасан байна.

Ази тив

Хятадын төв банк мөнгө угаахын эсрэг хяналтаа хангалтгүй хэрэгжүүлсэн санхүүгийн гурван байгууллагыг торгов³²⁰

2020.02.18. Үйлчлүүлэгчийн мэдээлэл, мөнгөн гүйлгээний тайлан, бүртгэл хөглөхдөө алдаа гаргасан Хятадын Minsheng Bank, Everbright Bank, Huatai Securities-т нийтдээ 52 сая юанийн торгуулийг Хятадын төв банк буюу Хятадын Ардын банк (ХАБ)-наас оногдуулаад байна.

Дээрх санхүүгийн гурван байгууллагын хувьд үйлчлүүлэгчийн мэдээллийг тодорхой болгох үүрэг, өндөр үнийн дүнтэй болон сэжигтэй гүйлгээний талаар мэдээлэх үүргээ биелүүлээгүй, мөн хувийн мэдээлэл нь тодорхой бус үйлчлүүлэгчийн гүйлгээг хийсэн шалтгааны улмаас торгуулсан байна.

ХАБ-наас мэдээлснээр холбогдох хууль тогтоомжид заасны дагуу үйлчлүүлэгчийн мэдээлэл болон гүйлгээний мэдээллийг хадгалахдаа алдаа гаргасан Minsheng Bank-нд 23.6 сая юанийн торгууль, мөн тус банкны 12 ажилтанд 10-70 мянган юанийн торгууль оногдуулсан байна³²¹.

Дээрх шалтгаанаар Everbright Bank-нд 18.2 сая юанийн торгууль, тус банкны 8 ажилтанд 10-35 мянган юанийн торгууль тус тус оногдуулжээ. Харин нөгөө байгууллага болох Huatai Securities-т 10.1 сая юанийн торгууль, мөн 4 ажилтанд нь 35-45 мянган юанийн торгууль оногдуулсан байна.

Saixin агентлагийн мэдээлж байгаагаар, энэ нь зөрчил гаргасан этгээдүүдийн нэр, шийтгүүлж буй шалтгааны талаарх мэдээллийг ХАБ-наас анх удаа ил болгож байгаа тохиолдол аж. Мөн энэ удаагийн торгууль нь төв банкнаас 10 сая юаниас дээш хэмжээтэй оногдуулсан хамгийн анхны торгууль болж байна.

³¹⁹ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/asia-pacific/australia-man-arrested-2-wanted-for-iraqi-oil-bribes/2047724>

³²⁰ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://ficed.com/china-fines-three-fi-lax-aml-controls/>

³²¹ <https://www.caixinglobal.com/2020-02-17/central-bank-ramps-up-punishment-for-turning-a-blind-eye-to-money-laundering-101516703.html>

Энэхүү өндөр торгууль нь өнгөрсөн оны 04 дүгээр сард гарсан ФАТФ-ын үнэлгээний тайланд мөнгө угаахтай холбоотой зөрчлүүдэд ХАБ-наас сүүлийн жилүүдэд дунджаар 41 сая юанийн торгууль оногдуулж ирсэн нь банк болон бусад санхүүгийн институцийн цар хүрээний хувьд “үр дүнгүй, сул, зохих хэмжээнд бус байна” гэж дүгнэсний дараагаар болж байна.

Үүнээс өмнө, өнгөрөгч 12 дугаар сард мөнгө угаахтай холбоотой асуудлаар Хятадын Construction Bank-ны салбарт 4 сая юанийн торгууль оногдуулсан нь ХАБ-наас оногдуулсан хамгийн өндөр торгууль болж байв.

Энэ оны эхээр Хятадын банк, даатгалын зохицуулах хорооноос мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөрийн үр дүнг нэмэгдүүлэх асуудлаар банк болон даатгагчдад мэдэгдэл хүргүүлсэн байдаг.

Уг мэдэгдлээс өмнө банкуудын дотоод хяналтыг нэмэгдүүлэх, хяналтын механизмыг бэхжүүлэх зэрэг асуудлыг багтаасан удирдамжийг санхүүгийн институцүүдэд хүргүүлж байсан аж.

Өмнөд Солонгосын давж заалдах шатны шүүхээс Ерөнхийлөгч асан Ли-д авлигын хэргээр 17 жилийн хорих ял оногдууллаа³²²

2020.02.19. Лхагва гарагт Өмнөд Солонгосын давж заалдах шатны шүүхээс тус улсын Ерөнхийлөгч асан Ли Мён Бак (Lee Myung-bak)-д хөрөнгө завших, авлига, хахуулийн хэрэгт буруутган 17 жилийн хорих ял оногдуулаад байна.

Тус улсын төрийн тэргүүний албан тушаалыг 2008-2013 онд хашиж байсан Ли-д Сөүл хотын Дээд шүүхээс мөн 12 тэрбум вон (10.9 сая ам.доллар)-ын торгууль оногдуулсан юм.

Энэхүү ялын хэмжээ нь өмнөх шатны шүүхээс оногдуулж байсан 15 жилийн хорих ялаас их байгаа юм. Гэвч прокурорууд 20 жил хорих, 15 тэрбум воны торгууль оногдуулах ялыг шаардаж байсан билээ.

Өнгөрөгч оны 03 дугаар сард батлан даалтаар шоронгоос суллагдаад байсан Ли-г шүүх хурлын дараа дахин шоронд шилжүүлсэн байна.

Ерөнхийлөгч асныг нууц нэрээр хувьцааг нь эзэмшдэг автомашины сэлбэг үйлдвэрлэгч DAS компаниас олон арван сая долларын хөрөнгө завшсан хэрэгт буруутай гэж үзсэн байна. Мөн түүнийг тус улсын хамгийн том гэр бүлийн групп болох Samsung Group-ээс олон сая ам.долларын хахууль авсан хэрэгт буруутай болохыг нь тогтоосон байна.

Иракийн авлигатай тэмцэх байгууллага 2019 онд 2 тэрбум гаруй ам.долларыг төрийн санд төвлөрүүлэв³²³

2020.02.20. Иракийн авлигатай тэмцэх байгууллага 2019 онд төрийн санд 2.84 их наяд ирак динар (2.38 тэрбум ам.доллар)-ыг төвлөрүүлсэн болохыг тус байгууллагын жилийн тайланд дурдсан байна.

Авлигатай тэмцэх байгууллага буюу Холбооны шударга ёсны хороо (The Federal Commission of Integrity)-ны тайланд дурдсанаар тус байгууллага төрийн бусад байгууллагатай нягт хамтран ажилласан бөгөөд Холбооны Ерөнхий аудитын зөвлөл (Federal Board of Supreme Audit)-тэй хамтран авлигатай тэмцэх үндэсний стратеги боловсруулсан байна.

Тус хорооноос 2019 онд 26,163 мэдээлэл, эрүүгийн хэргийг шалгахад оролцсон бөгөөд эдгээрт холбогдсон 10,143 хүнийг шүүхээс гэм буруутай гэж үзсэн гэж тус байгууллагын тайланд онцолсон байна. Дээрх хүмүүсээс 50 нь засгийн газрын сайд болон түүнтэй адил түвшний албан тушаалтай хүмүүс байсан аж.

Дээрх хэргээс авлигын хэрэгт буруутай нь тогтоогдсон 1,231 этгээдтэй холбоотой 931 шүүхийн шийдвэр гарсан байна.

³²² Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: http://www.xinhuanet.com/english/2020-02/19/c_138798361.htm

³²³ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.middleeastmonitor.com/20200220-iraq-anti-corruption-agency-restored-more-than-2bn-to-treasury-in-2019/>

Арменийн Ерөнхийлөгч асан авлигын хэргээр шүүхэд дуудагдав³²⁴

2020.02.26. Арменийн Ерөнхийлөгч асан Серж Саргсяныг дотны найзынхаа хамаарал бүхий компанид давуу байдал үүсгэхийн тулд тендер будлиулж, улсад 1 сая ам.долларын хохирол учруулсан гэж үзэж байна. Ерөнхийлөгч асантай хамт Хөдөө аж ахуйн сайд асан, Хөдөө аж ахуйн дэд сайд асан, Хөдөө аж ахуйн яамны Газар тариалангийн газрын дарга асан болон хөргөсөн хийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компанийн захирал нар мөн сэжигтнээр татагджээ. Саргсян нь 2008 онд Армени улсын Ерөнхийлөгчөөр сонгогдож, 2018 онд өргөн хүрээний эсэргүүцэл, тэмцлийн улмаас албан тушаалаасаа зайлуулагдсан юм.



Арменийн Ерөнхийлөгч асан Серж Саргсян. (Фото: European People's Party (CC BY 2.0))

Ерөнхийлөгч асан Саргсян энэхүү авлигын хэрэгт буруутай болох нь тогтоогдвол 8 хүртэл жилийн хорих ялаар шийтгүүлнэ.

Филиппиний криптовалютын зохицуулагчийг олон сая долларын авлигын хэрэгт сэжиглэв³²⁵

2020.02.28. Филиппин улсын криптовалютын биржүүдэд тусгай зөвшөөрөл олгодог Кагаяны эдийн засгийн бүсийн захиргаа³²⁶ (КЭЗБЗ)-ны захирал Раул Ламбиногийн хувийн хөрөнгө тодорхойгүй шалтгаанаар хэдэн арван сая доллароор өссөнийг Манила Таймс мэдээлэв.

Үндэсний тагнуулын ерөнхий газар³²⁷ (ҮТЕГ)-ын тайлантай танилцах эрхтэй уг хэвлэлийн агентлагаас Ламбиног тус улсын хамгийн их авлигад идэгдсэн удирдах ажилтнуудын нэгээр нэрлэсэн байна.

КЭЗБЗ нь 25 криптовалютын биржид ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл олгожээ. ҮТЕГ-ын тайлангийн дагуу эдгээр биржүүд лицензийн төлбөрт 100,000 ам.доллар, өргөдлийг нь хэлэлцүүлэхэд мөн ийм хэмжээний төлбөр төлсөн байна. Гэтэл үүнээс Ламбино ердөө 3,000 ам.долларыг бүртгээд, бусад төлбөрийг өөртөө авдаг байсан байна.

Үүнээс гадна эдийн засгийн онцгой бүсэд үйл ажиллагаа явуулдаг компаниуд Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурахаасаа өмнө өөрсдийн хөрөнгийн 10 хувийг КЭЗБЗ - т шилжүүлсэн байжээ.

“Бид Филиппинийг залилан мэхлэгчдийн орогнох газар болгохыг хүсэхгүй байна. Тиймээс бид шударга ёс, ёс суртахуунлаг байдлын төлөө хөрөнгийн биржүүдэд шалгалт хийнэ” гэж Ламбино 2018 онд мэдэгдэж байсан юм.

Тус бүсэд бүртгэлтэй криптовалют болон мөрийтэй тоглоомын компаниуд Ламбино болон түүний туслахад долоо хоногт 5 сая песо (ойролцоогоор 98 мянган ам.доллар) төлдөг гэж ҮТЕГ мэдэгдэв.

Мөн тагнуулынхан Ламбиногийн өмнө ажиллаж байсан зохицуулагч тухайн захиргааны дансанд үлдсэн 2 тэрбум орчим песо (39 сая гаруй ам.доллар)-г өөртөө завшсан гэж сэжиглэж байгаа юм байна.

³²⁴ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.occrp.org/en/daily/11694-former-armenian-president-on-trial-for-corruption>

³²⁵ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://forklog.com/glavu-kriptovalyutnogo-regulyatora-filippin-zapodozrili-v-korrupsii-na-milliony-dollarov/>

³²⁶ The Cagayan Economic Zone Authority (CEZA)

³²⁷ National Intelligence Coordinating Agency (NICA)

Ламбино 2017 онд төрийн албанд орохоосоо өмнө хөдөө тосгоны өмгөөлөгч, “дунджаас доогуур давхарга”-д харьяалагддаг нэгэн байжээ.

2018 онд криптовалютын салбарыг зохицуулах хууль журмыг Филиппиний төр засаг баталж, криптобиржүүдэд зөвшөөрөл олгох ажлаас 67 сая ам.доллар олно гэж төлөвлөсөн байжээ.

Цагдаагийн 12 алба хаагчийг хахуулийн хэргээр шүүхэд шилжүүлэв³²⁸

2020.03.11. Малайзын Авлигатай тэмцэх хороо³²⁹ (АТХ)-ноос тус улсын Замын цагдаагийн хэлтсийн дарга зэрэг замын цагдаагийн нийт 12 албан хаагчийг хахуулийн хэрэгт сэжиглэн баривчилж Пенан арлын Жоржтаун хотын анхан шатны шүүх (Magistrate's Court)-д шилжүүллээ. Сэжигтнүүдийг цагдан хорьж шалгах ба тэднийг мягмар гарагт Малайзын АТХ-ны албан хаагчид баривчилсан юм.

Замын цагдаагийн албан хаагчид хүнд даацын ачааны авто машинуудад хяналт тавихдаа их хэмжээний хахууль авсан хэмээн сэжиглэж байгаа юм.

Өнгөрсөн жил Малайзын АТХ Автотээврийн газрын 70 гаруй албан хаагчийг даац хэтрүүлсэн хүнд даацын ачааны автомашины эсрэг арга хэмжээ аваагүйнхээ төлөө сар бүр 10,000-36,000 малайз ренгитгийн хахууль авж байсан хэрэгт баривчилж байсан юм.

Хятадын үүрэн телефоны ZTE компани хахуулийн хэрэгт шалгагдаж байгаа талаар NBC агентлаг мэдээллээ³³⁰

2020.03.13. Хятадын үүрэн телефоны ZTE компани дэлхийн зах зээлд давуу байдал олохын тулд гадаадын албан хаагчид хахууль өгсөн хэрэгт сэжиглэгдэн АНУ-ын Хууль зүйн яаманд шалгагдаж байгаа талаар NBC агентлаг мэдээллээ.

Дээрх мэдээлэлтэй холбогдуулан Хууль зүйн яамны хэвлэлийн төлөөлөгч болон тус компаниас хараахан тайлбар хийгээгүй байна.

ZTE компани нь АНУ-ын хориг арга хэмжээнээс зайлсхийх зорилгоор америк тоног төхөөрөмжийн бүрдлийг худалдан авж, угсарч, хууль бусаар Иран руу тээвэрлэсэн нь мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсоны дараагаар гэм буруутайгаа 2017 онд хүлээн зөвшөөрч 900 орчим сая доллар төлж байсан.

Түүний дараа жил хориг зөрчсөн 35 ажилтандаа арга хэмжээ авсан талаар ZTE компани хуурамч мэдээлэл өгсөн гэж үзэн Америкийн компаниудыг тус компанид бараа бүтээгдэхүүн нийлүүлэхийг Цагаан ордоноос хориглосон юм.

Дээрх хоригийг АНУ-ын төсөвт тус компани 1 тэрбум ам.долларын торгууль төлсний дараа цуцалсан байна.

ZTE компани нь дэлхийн хамгийн том харилцаа холбооны тоног төхөөрөмж үйлдвэрлэгч Хятадын Хуавэй компанийн өрсөлдөгчдийн нэг юм.

Хуавэй компани өнгөрөгч 05 дугаар сараас хойш АНУ-ын Худалдааны яамны аж ахуйн нэгжийн жагсаалт (Commerce Department's entity list)-д байгаа бөгөөд уг жагсаалтад орсноор АНУ-ын компаниуд тус компанид бараа болон технологи худалдахыг хориглосон гэсэн үг юм.

³²⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.msn.com/en-my/news/national/12-cops-brought-to-court-over-alleged-bribery/ar-BB11135h>

³²⁹ Anti-Corruption Commission

³³⁰ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.reuters.com/article/us-usa-zte-justice/chinas-zte-subject-to-new-u-s-bribery-investigation-nbc-news-says-idUSKBN2102BW>

Нетаньяхугийн холбогдсон авлигын хэргийн шүүх ажиллагааг коронавирусний улмаас хойшлуулав³³¹

2020.03.15. Израил улсын Ерөнхий сайд Биньямин Нетаньяхугийн холбогдсон авлигын гурван хэргийн шүүх ажиллагаа товлосон хугацаанаасаа хоёр сар гаруй хугацаагаар хойшиллоо. Учир нь Израилд коронавирусний халдварын дэгдэлтийн улмаас шүүхүүдийн үйл ажиллагааг хязгаарласан байна.



(Фото: vesti.ru)

Израилийн Ерөнхий прокурор Авихай Мандельблит нэгдүгээр сард Нетаньяхугийн

эсрэг яллах дүгнэлтийг танилцуулсан. Тэрээр Ерөнхий сайдыг “4000” гэх хэрэгт хахууль авсан гэж буруутгасан. Энэ хэрэг нь Израилийн цахим орчинд алдартай “Walla!” порталд Нетаньяху өөрийнхөө талаар эерэг хандлага үүсгэсний хариуд тус улсад томд тооцогдох харилцаа холбооны “Безек” группийн төлөө лоббидсонтой холбоотой юм.

Мөн түүнийг “2000”, “1000” гэх хэргүүдэд буруутгаж байна. “2000” гэх нэртэй хэрэг нь Ерөнхий сайд Нетаньяху өөрийн засгийн газрын үйл ажиллагааг эерэгээр мэдээлэх талаар хэвлэл мэдээллийн томоохон группийн эзэнтэй тохиролцох оролдлоготой холбоотой юм.

“1000” гэх хэрэг нь Нетаньяху продюссер Арнон Мильчинээс өндөр зэрэглэлийн оргилуун дарс, навчин тамхи зэрэг үнэтэй бэлэг авсантай холбоотой юм. Израилийн Ерөнхий сайд авсан бэлгийнхээ хариуд олигархийн хувийн болон бизнесийн ашиг сонирхлыг хамгаалан лоббидсон нь мөрдөн байцаалтаар тогтоогдсон.

Нетаньяхугийн эдгээр хэргүүдийг шүүх ажиллагаа 03 дугаар сарын 17-ны өдрөөс 05 дугаар сарын 24-ний өдрийн хугацаанд явагдахаар хойшлогдсон талаар The Times of Israel³³² сонинд мэдээлжээ.

Хууль зүйн сайд Амир Охана коронавирусний улмаас тус улсын шүүхийн үйл ажиллагаа онцгой байдлын дэглэмд шилжин явагдах болсон, мөн тулгарсан нөхцөл байдалд авах арга хэмжээ, хэрхэн ажиллах талаар шийвэрлэх тухайгаа мэдэгдсэн байна.

Хэргүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаа бараг зогссон. Гэхдээ баривчлах, цагдан хорих, батлан даалтад гарах, түүнчлэн онцгой байдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зэрэг яаралтай асуудалд шүүх ажиллагаа явуулах, шүүх хурлыг зохион байгуулахаар шийдсэн байна.

Израилд КОВИД-19-ээр өвдсөн хүний тоо 200 хүрсэн. Хоёр өвчтөний биеийн байдал хүнд, 11 нь дунд зэрэг, бусад өвчтөнд халдварын хөнгөн шинж тэмдэг илэрсэн байдалтай байна. Үүний зэрэгцээ 40 мянга орчим израилчууд гэрийн хорионы дэглэмд байна. Улсын хэмжээнд коронавирусийг илрүүлэх 6,800 гаруй шинжилгээ хийсэн тухай Израилийн Эрүүл мэндийн яамнаас мэдээлжээ.

³³¹ Орчуулсан: А.Золзаяа.Эх сурвалж: <https://www.vesti.ru/doc.html?id=3248145>

³³² <https://www.timesofisrael.com/netanyahus-trial-delayed-by-over-2-months-as-court-activity-limited-over-virus/>

Саудын Арабт төрийн олон зуун албан хаагчийг саатууллаа³³³

2020.03.16. Саудын Арабын авлигатай тэмцэх байгууллагаас арми болон аюулгүй байдлын албаны ажилтнууд зэрэг төрийн албан хаагч 298 хүнийг хахууль, хөрөнгө шамшигдуулсан болон албан тушаалаа ашигласан гэмт хэрэгт буруутган баривчилжээ.

Ням гарагт Саудын Арабын Авлигатай тэмцэх үндэсний хороо³³⁴ (АТҮХ)-ноос гаргасан мэдэгдэлд тус хорооны мөрдөгчид цагдан хоригдож буй тэдгээр албан хаагчдыг шалгаж, хариуцлага хүлээлгэх болно гэжээ.

2017 онд өндөр түвшний албан тушаалтнуудын хүнд суртал, хахуультай тэмцэх зорилгоор Саудын Арабын аюулгүйн албанаас хаант улсын ханхүү, улс төр, бизнесийн элитүүдийг баривчилж байсан юм.

Тэдгээр баривчлагдсан хүмүүсийг Рияд хот дахь тансаг зэрэглэлийн Риц-Карлтон (Ritz-Carlton) зочид буудалд хэдэн долоо хоногийн турш хорьсон бөгөөд баривчлагдсан хүмүүстэй бие махбодийн хувьд зүй бусаар харьцсан гэж зарим албан хаагчид мэдүүлж байжээ.

Салман хааны угсаа залгамжлагч ханхүү Мухаммед Бин Салман (Mohammed bin Salman) улс төрд аюул учруулж болзошгүй хүмүүсийг зайлуулах зорилготой явуулсан байж болзошгүй хэмээн дээрх ажиллагааг шинжээчид дүгнэдэг.

Хааны шүүхээс өнгөрсөн жил дээрх компани ажил 15 сарын дараа аажмаар зогсож байгаа гэж хэлж байсан ч, дараа нь хууль сахиулах байгууллагууд төрийн албан хаагчдын авлигыг шалгаж эхэлснээ мэдэгдсэн билээ.

Баривчлагдаад байгаа тэдгээр 298 албан хаагчдыг хахууль, хөрөнгө шамшигдуулах, эрх мэдлээ урвуулан ашиглах зэрэг нийтдээ 398 сая риал /101 сая ам.доллар/-ийн гэмт хэрэгт яллах болно гэдгийг АТҮХ олон нийтийн твиттер сүлжээнд ням гарагт мэдэгдсэн юм.

Хэрэгт татагдсан хүмүүсийн 8 нь 2005-2015 оны хооронд засгийн газрын гэрээтэй холбоотой хахууль, мөнгө угаах гэмт хэрэгт сэжиглэгдээд байгаа Батлан хамгаалах яамны албан хаагчид бол 29 нь зүүн нутгийн Дотоод хэргийн яамны ажилчид, түүний дотор 3 хурандаа, хошууч генерал, бригадын генерал зэрэг албан хаагчид багтжээ.

Рияд хотын Алмарифа их сургууль (Riyadh's Almaarefa University)-ийн авлигын хэрэгт буруутгагдсан 9 албан тушаалтны хамт авлигын хэргээр 2 шүүгч баривчлагдсан талаар АТҮХ мөн мэдээллэсэн.

Тус газраас тухайн хэргийн талаарх бусад мэдээлэл болон албан тушаалтны нэрийг мэдээлээгүй юм.

Гүлнара Каримова авлига, эдийн засгийн гэмт хэргээр дахин ял сонслоо³³⁵

2020.03.19. Узбекистаны Ерөнхийлөгч асан Ислам Каримов (Islam Karimov)-ын ууган охин, одоо хорих ял эдэлж байгаа Гулнара Каримова (Gulnara Karimova) болон түүний хамсаатнуудад сүүлийн шүүх хурлын үеэр 13 жил 4 сар хорих ял нэмж эдлүүлэхээр шийдвэрлэлээ.

Узбекистаны Дээд шүүхээс 03 дугаар сарын 18-нд Каримовад авлига, мөнгө угаах, бусдын эд хөрөнгийг шамшигдуулсан гэмт хэрэг, эдийн засгийн болон бусад гэмт хэрэг үйлдсэн хэмээн буруутгаж бусад 5 шүүгдэгч нарын хамт ял сонгосон талаар мэдээллээ.

2019 оны 03 дугаар сараас хойш Ташкентийн шоронд хоригдож байгаа Каримова 01 дүгээр сарын 08-ны өдөр тус шүүх хуралд ирж оролцсон байна.

³³³ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/03/saudi-arabia-detains-hundreds-government-officials-200316073516389.html>.

³³⁴ Saudi's National Anti-Corruption Commission (Nazaha)

³³⁵ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.rferl.org/a/gulnara-karimova-sentenced-again-for-corruption-financial-crimes/30495071.html>

Тэрээр өнгөрсөн сард Ерөнхийлөгч Шавкат Мирзиёев (Shavkat Mirziyoev)-д хандан захидал илгээсэн ба тус захидалд түүний шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй болгож өгвөл улсын төсөвт 686 сая ам.долларыг буцааж өгөх саналтай байгаа талаар дурджээ.

Улсын ерөнхий прокурорын газраас Гулнара Каримоваг улсын өмчит цементийн 2 үйлдвэрийн хувьцааг хууль бусаар худалдан авж, түүнийгээ гадны бизнесмэнүүдэд зарсан гэх асуудалтай холбоотой шинэ хэргийн талаар 08 дугаар сард мэдэгдэж байсан юм.

Эцгийнхээ өв залгамжлагч гэж тодорхойлогдож байсан 47 настай Каримова Швед болон Швейцари улсад мөнгө угаасан хэрэгт холбогдон шалгагдсан.

Гулнарагийн эцэг улсаа удирдаж байх үедээ 2014 онд түүнийг Ташкент дахь гэрт нь хорионд оруулсан юм. Ислам Каримовыг 2016 онд нас барсны дараа одоогийн Ерөнхийлөгч Мирзиёев залгамжилсан.

2017 онд Гулнараг 10 жил хорих ялаар шийтгэсэн боловч түүнээс хэдэн сарын дараа ялыг нь 5 жилээр богиносгож, гэрийн хорионд байлгахаар шийдвэрлэжээ. 2019 оны 03 дугаар сард гэрийн хорионд байх нөхцөл, журмыг зөрчсөний улмаас түүнийг шоронд хорьсон байна.

Мөн түүнчлэн 2019 оны 03 дугаар сард АНУ-ын Хууль зүйн яамнаас Каримоваг олон улсын хахуулийн томоохон сүлжээний нэг хэсэг хэмээн тодорхойлж, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн гэж буруутгаад байна.

[Хоригдож буй Ерөнхий сайд асан Каледиа
Зиа-г гэрийн хорионд байх нөхцөлд 6
сарын хугацаагаар суллаж болох талаар
Бангладеш улсын засгийн газар мэдэгдэв](#)³³⁶

2020.03.24. Бангладеш. Ерөнхий сайд асан Каледиа Зиа (Khaleda Zia)-г гэртээ, хилийн чанадад явахгүй байх гэсэн нөхцөлтэйгээр 6 сарын хугацаагаар суллах талаар Хууль зүйн сайд мэдэгдэв.

Түүний өндөр насыг харгалзан үзэж, хүмүүнлэгийн үүднээс суллах шийдвэр гаргажээ. Зиа 74 настай юм. Тэрээр сөрөг хүчний удирдагч байсан бөгөөд авлигын хоёр хэргээр 17 жилийн хорих ял авсан билээ. Улс төрийн шалтгаантай хэргүүд хэмээн түүний Бангладешийн үндэсний намаас мэдэгдсэн байсан юм. Мөн Зиагийн өрсөлдөгч, Ерөнхий сайд Шейх Хасина (Sheikh Hasina)-гийн засгийн газар дээрх шийдвэрийг эсэргүүцдэг. Зиа-г амьсгалын замын болон архаг үе мөчний хүнд өвчтэй хэмээн түүний намынхан мэдэгдсэн. Тэрээр одоогоор Дака дахь Бангабанду Шейх Мужиб анагаахын их сургууль (Bangabandhu Sheikh Mujib Medical University)-ийн шоронгийн өрөөнд эмчлүүлж буй юм.

Түүний нас, хүмүүнлэгийн үүднээс суллаж эмчилгээг гэрийн нөхцөлд авж болох юм гэж засгийн газар шийдвэрлэсэн хэмээн Хууль зүйн сайд Анисул Хук (Anisul Huq) мэдэгдсэн байна. Өнгөрсөн хоёр сард архаг үе мөчний өвчнөө Англид эмчлүүлэх Зиа-гийн давж заалдах өргөдөлд Дээд шүүхээс татгалзсан хариу өгсөн билээ.

Зиа-г асрамжийн газрын зориулалтаар өгсөн 250,000 ам.долларын хандивыг хувьдаа ашигласан хэргээр 2018 онд ялласан юм. Зиа, Хасина нар улс төрчдийн удмын хүмүүс юм. Зиа нь 1981 онд алагдсан генерал-Ерөнхийлөгч Зиаур Рахман (Ziaur Rahman)-ы бэлэвсэн эхнэр аж. Харин Хасина нь тус улсын анхны Ерөнхийлөгч, 1975 онд алагдсан Шейх Мужибур Рахман (Sheikh Mujibur Rahman)-ы охин ажээ.

Бангладеш нь Пакистантай эрх чөлөөний төлөө 9 жилийн турш дайн хийсний үр дүнд бие даасан улс болсон түүхтэй.

³³⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://abcnews.go.com/International/wireStory/bangladesh-release-jailed-prime-minister-69766225>

Хонконгийн хөрөнгийн биржийн ажилтан асан IPO-тэй холбоотой хахуулийн хэрэгт буруутгагдав³³⁷

2020.03.25. Хонконгийн Авлигын эсрэг бие даасан хороо³³⁸ (АЭБДХ) 03 дугаар сарын 25-ны өдөр Хөрөнгийн биржийн ажилтан асныг 2017 онд оёдол, сүлжмэлийн утас үйлдвэрлэгч Шэн Юү Холдинг Лимитэдээс IPO гаргах хүсэлттэй нь холбоотойгоор хахууль авсан болон эрх мэдлээ урвуулан ашигласан хэрэгт татлаа.

АЭБДХ мэдэгдэлд дурдсанаар Еүжен Ёо нь үнэт цаас гаргах хүсэлтийг нааштайгаар шийдэх нэрийдлээр тус холдингийн зөвлөхөөс бэлэн мөнгө авсан байна.

Тухайн үед Ёо нь Хонконгийн бирж болон клиринг дэх IPO-г хянах багийн нэгдсэн удирдлагын албан тушаалыг хашиж байсан бөгөөд биржид гарах жагсаалтын дүрмийг даган мөрдүүлэх, хөрөнгийн жагсаалтын хороод буюу эцсийн шийдвэр гаргагчдад зөвлөмж өгөх эрх мэдэлтэй байжээ. Тэрээр 2019 оны 05 дугаар сард ажлаа хүлээлгэн өгсөн.

Ёо-гийн хувьд түүний өмгөөлөгчтэй холбогдох хүсэлт бүхий LinkedIn мессежинд тэр даруй хариу өгөөгүй бол Хөрөнгийн биржийн хэвлэлийн төлөөлөгч “Өөрийнх нь өмнөх ажилтантай холбогдсон хэргийн мөрдөн шалгах ажилд цаашид ч АЭБДХ-той хамтран ажиллана” гэдгийг мэдэгдсэн байна.

АЭБДХ-ны мэдэгдэлд дурдсанаар Ёо нь зөвлөх Ричард Ламаас түүний эхнэрт шилжүүлсэн гэх 9.15 сая хк.долларын дүнтэй гүйлгээг нуун дарагдуулсан байна. Мөн 2 сая хк.доллар бүхий хоёр гүйлгээ нь Шэн Юү Холдингийн IPO-тэй холбоотой гэв.

Нийтийн албаны ажилтнуудад давуу байдал бий болгохыг санал болгож байсан гэх Лам болон түүний өмгөөлөгчийн хувьд холбоо тогтоож, мэдүүлэг тайлбар авахад мөн л хугацаа шаардагдах юм.

АЭБДХ нь өнгөрөгч оны 06 дугаар сард IPO гаргахад ивээн тэтгэдэг, удирдан чиглүүлдэг 2 фирм, жагсаалтад орсон 2 компанийн ажилчдад нэгжлэг хийж 3 хүнийг баривчилсан байна.

Харин одоогоор Хонконгийн Үнэт цаас болон фьючерсийн хороонд биржийн арилжааг хянах ажил үргэлжилж байна гэлээ.

Индонез авлигын хоригдлуудыг суллах төлөвлөгөөгүй байна³³⁹

2020.04.05. Индонезийн засгийн газраас КОВИД-19 цар тархалтаас урьдчилан сэргийлэх зорилгоор хоригдлуудыг суллах төлөвлөгөө гаргасан байна.

Уг төлөвлөгөөнд авлигын гэмт хэрэг болон террор, хар тамхитай холбоотой гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудыг суллах асуудал одоогоор тусгагдаагүй гэдгийг тус улсын Улс төр, эрх зүй, аюулгүй байдлын асуудал хариуцсан зохицуулагч сайд Мохаммед Махфуд МД ням гарагт хийсэн мэдэгдэлдээ онцлон тэмдэглэв.

Европол, Сингапурын цагдаа нар коронавирусын асуудалтай холбоотой 6 сая еврогийн мөнгө угаах схемийн сэжигтнийг баривчлав³⁴⁰

2020.04.07. ЕХ-ны хууль сахиулах байгууллагын нэгдэл буюу Европолоос 04 дүгээр сарын 06-ны өдөр гаргасан хэвлэлийн мэдээнд дурдсанаар 6 сая еврогийн эрүүл мэндийн бүтээгдэхүүн

³³⁷ Орчуулсан: А.Билгүүн. Эх сурвалж: <https://www.straitstimes.com/asia/east-asia/former-hong-kong-bourse-official-charged-with-bribery-relating-to-ipo>

³³⁸ The Independent Commission Against Corruption (ICAC)

³³⁹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.thestar.com.my/news/regional/2020/04/05/minister-indonesia-has-no-plan-to-free-corruption-inmates-despite-covid-19>

³⁴⁰ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://securityboulevard.com/2020/04/europol-and-singapore-police-arrest-suspect-behind-e6-million-coronavirus-money-laundering-scheme/>

худалдан авахтай холбоотой залилан хийсэн хэргийн сэжигтэн 39 настай эрэгтэйг Сингапур улсад баривчилсан байна.

Хууль сахиулах байгууллагуудын мэдэгдэж байгаагаар уг сэжигтэн нь Европ дахь нэгэн эмийн компанид FFP2 мэс заслын баг болон гар ариутгагч нийлүүлэхээр санал болгосон хууль ёсны компанийн дүр эсгэсэн байна.

Мэдэгдэлд дурдсанаар “дээрх эмийн компани Сингапур дахь банкны дансанд мөнгө шилжүүлсний дараа захиалсан бүтээгдэхүүнээ хүлээн авах, мөн холбоо барих боломжгүй болсон” аж.

Эмийн компаниас 6.64 сая еврог залилан энэхүү мөнгө угаах схемийн талаар Европолоос Сингапурын хууль сахиулах байгууллагуудтай холбогдсоны дараа гүйлгээг зогсоосон байна. Азаар тэдний хүчин зүтгэл үр дүнд хүрсэн юм. Орон нутгийн цагдаа сэжигтнийг тодорхойлон, 03 дугаар сарын 25-ны өдөр саатуулсан аж.

Энэхүү и-мэйл ашигласан залилан эмийн компанитай холбоотой байгаа нь коронавирусийг ашигласан гэмт хэрэг нэмэгдэх, мөн гэмт хэрэгтнүүд эмнэлгийн бүтээгдэхүүний хомсдолыг ашиглах хандлагатай байгааг харуулж байна.

Хятадын СИТИС банкны ерөнхийлөгч асныг хахуулийн хэргээр баривчлав³⁴¹

2020.04.08. Хятадын СИТИС банкны Ерөнхийлөгч асан Сун Дэшун (Sun Deshun)-ыг хахууль авсан хэрэгт холбогдуулан баривчилсан болохыг тус улсын Шаньдун мужийн Ардын прокуророос лхагва гарагт мэдээллээ.

Үндэсний хянан шалгах хороо (National Supervisory Commission)-ноос түүний хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, яллах дүгнэлт үйлдүүлэхээр прокурорын байгууллагад шилжүүлээд байсан аж.

Баривчлах шийдвэрийг Шаньдун мужийн нийслэл Жинань хотын Ардын прокурор гаргасан аж.

Цагдаагийн 8 албан хаагчийг авлигын хэргээр албан тушаалаас нь түдгэлзүүллээ³⁴²

2020.04.13. Пакистан. Бямба гарагт цагдаагийн хэвлэлийн төлөөлөгч “Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга (гүйцэтгэх ажиллагаа хариуцсан) Вакар Уддин Сэйд нь авлигын хэргээр цагдаагийн 8 албан хаагчийг албан тушаалаас нь түдгэлзүүлсэн” хэмээн мэдэгдлээ.

Тэрээр хэлэхдээ цагдаагийн нэг удирдах албан тушаалтан, нэг ажилтан, зургаан дэд байцаагчийг албан тушаалаас нь түдгэлзүүлсэн гэжээ.

Тэдгээр цагдаа нарын авлигын талаарх гомдлыг хүлээн авсан бөгөөд нарийвчлан шалгуулахаар холбогдох цагдаагийн дарга нарт нь хүргүүлсэн байна.

Цагдаагийн дарга нар гомдол шалгасан тухай тайланг 48 цагийн дотор гаргах ёстой бөгөөд тайланд үндэслэн тэдний эсрэг дараагийн арга хэмжээг авах юм.

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга Вакар Уддин Сэйд хэлэхдээ авлигын хэрэг нь улс оронд ноцтой хохирол учруулж, доройтуулж байдаг учраас Исламабадын Цагдаагийн ерөнхий газар нь авлигын эсрэг хатуу чанд бодлого баримталдаг гэсэн юм.

Цагдаагийн дарга буюу Цагдаагийн ерөнхий байцаагч Мухаммед Амир Зульфикарын зааврын дагуу Исламабадын цагдаагийн газраас албан хаагчдынхаа ажлын гүйцэтгэлд хяналтын систем нэвтрүүлсэн бөгөөд албан тушаалаа урвуулан ашигласан, хайхрамжгүй байдал гаргасан, мөрдөн шалгах ажиллагааг муу хийсэн, ажлаа тасалсан, авлигын хэрэгт холбогдсон албан хаагчдад сахилгын арга хэмжээ авж байгаа юм.

³⁴¹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: http://www.xinhuanet.com/english/2020-04/08/c_138958580.htm

³⁴² Орчуулсан Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.thenews.com.pk/print/642982-eight-cops-suspended-over-corruption>

Цагдаагийн ерөнхий байцаагчийн орлогч хэлэхдээ хариуцлагын тогтолцоо нь аль ч хэлтсийн үйл ажиллагааг сайжруулахад туслах бөгөөд ажилчдынхаа ажлыг үнэлэхэд хялбар байдаг гэжээ. Энэ хариуцлагын тогтолцоо цаашид ч үргэлжлэх бөгөөд сайн ажиллаж байгаа ажилчдаа урамшуулах болно гэжээ.

Мальдивын Авлигатай тэмцэх хороо КОВИД-19-тэй холбоотой авлигын хэргийг шалгаж байна³⁴³

2020.04.14. Мальдивын Авлигатай тэмцэх хороо (АТХ) КОВИД-19-тэй холбоотой чиг үүргээ гүйцэтгэх явцдаа авлигын хэрэгт холбогдсон зарим төрийн байгууллагуудыг шалгаж байгаа талаар мэдэгдэв.

Даваа гарагт АТХ-ноос гаргасан мэдэгдэлд коронавируст цар тахлын дэгдэлтийн үед засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээнд олон нийт ихээхэн санаа зовниж байгааг тэмдэглэжээ. Цар тахлын эсрэг үйл ажиллагаатай холбоотой аливаа авлигыг арилгахын тулд АТХ холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байгаа аж. Мөн цаашид олон нийтийн сүлжээ болон бусад мэдээллийн хэрэгслээр гарч буй асуудлуудад үндэслэн мөрдөн шалгах ажиллагааг санаачлан эхлүүлэх юм.

Одоо шалгагдаж буй хэд хэдэн хэрэг байгаа бөгөөд тэдгээр хэргийн нэг нь цар тахалд зориулагдсан эрчимт эмчилгээний тасагт ашиглагдах амьсгалын аппаратыг худалдан авсан арга замынхаа талаар байцаагдаж байгаа хүмүүсийн хэрэг юм. КОВИД-19-ийн эсрэг хийгдэж буй үйл ажиллагаан дахь авлигын талаарх мэдээллийг нотлох баримтын хамт ирүүлэхийг АТХ уриалж байна.

Саудын Арабын авлигатай тэмцэх байгууллага авлигач шүүгч болон түүний хамтрагчдыг баривчилжээ³⁴⁴

2020.04.14. Бямба гарагт Саудын Арабын авлигатай тэмцэх байгууллага³⁴⁵ шүүгч хахууль авж байгаа тухай мэдээллийг хүлээн авсны дараа хэргийг мөрдөн шалгасан болохоо мэдэгдлээ.

Мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд дээрх мэдээлэл батлагдсан тул түүнийг баривчилжээ. Мөн мөрдөн шалгах ажиллагаагаар тус шүүгч нь хахууль авахын тулд гуравдагч этгээд буюу хурандаа цолтой өөрийн ахыг, хэд хэдэн бизнесмен, нэгэн хуульчийг хууль бус ажиллагаандаа татан оролцуулж, хахууль авах, мөнгө угаах, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашигласан нь тогтоогдсон байна.

Шүүгч баривчлагдсан бөгөөд бусад хэрэгтнүүд бүгд өөрсдийн гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн байна. Тэдний хэргийг зохих журмын дагуу шүүхэд шилжүүлнэ.

Энэ шүүгчийн үйлдлээр тус улсын шүүгчдийг ажил, үүргээ гүйцэтгэхдээ шударга бус хандаж, эрх мэдлээ урвуулан ашигладаг гэж дүгнэж болохгүй хэмээн авлигатай тэмцэх байгууллагаас мэдэгдсэн юм.

Малайзын төрийн сангаас хулгайлагдсан 300 сая долларыг АНУ тус улсад буцаан өглөө³⁴⁶

2020.04.15. Авлигын сүлжээгээр дамжин хулгайлагдсан 300 сая долларыг АНУ Малайзад буцаан өгсөн талаар хууль сахиулах байгууллагаас мягмар гарагт мэдээллээ.

Энэ мөнгө өнгөрсөн жил Лос Анжелес дахь холбооны мөрдлөгийн үеэр санхүүч Жо Лоу-гаас хураан авсан хөрөнгө ажээ. Уг хөрөнгөд Манхэттэний пентхаус, Беверли Хиллсийн харш,

³⁴³ Орчуулсан Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://avas.mv/en/81190>

³⁴⁴ Орчуулсан Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.arabnews.com/node/1657176/saudi-arabia>

³⁴⁵ Control and Anti-Corruption Authority

³⁴⁶ Орчуулсан Р.Энх-Амгалан. Эх сурвалж: https://www.japantimes.co.jp/news/2020/04/15/asia-pacific/crime-legal-asia-pacific/u-s-returns-300-million-stolen-funds-malaysia/?fbclid=IwAR17Of3K77yXdLvHQ7hx_uPxZ58pvr3derTMnlmfQU-l3eie0WcAbhjqQ#.Xpkr4sgzbIV

Беверли Хиллс дэх зочид буудал, тансаг зэрэглэлийн тийрэлтэт онгоц болон Винсент Ван Гог, Клод Моне нарын уран зураг зэрэг хөрөнгө багтжээ.

Жо Лоу болон түүний гэр бүл 700 гаруй сая долларын хөрөнгийг хураахыг зөвшөөрсөн бөгөөд өнөөдрийг хүртэлх хугацаанд АНУ-аас Малайзад 600 гаруй сая долларыг буцаан олгоод байна гэж АНУ-ын Хууль зүйн яамны мэдэгдэлд дурджээ.

Лоу Так Жо буюу Лоу нь иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагааны үед гэм буруутайгаа хүлээн зөвшөөрөөгүй билээ. Харин түүнийг хахууль, мөнгө угаасан хэрэгт холбогдуулан Нью Йоркод эрүүгийн хэрэг үүсгэн шалгасаар байгаа юм.

Лоу Малайзын төрийн сангийн зөвлөхөөр ажиллаж байсан бөгөөд прокурорууд түүнийг сангийн хөрөнгөөр гадаадын албан тушаалтнуудад хахууль өгсөн, АНУ-д тансаг зэрэглэлийн үл хөдлөх хөрөнгө, уран зураг, үнэт эдлэл худалдаж авсан, Холливудын “Уолл Стрийтийн чоно” киног санхүүжүүлсэн гэж буруутгаж байгаа ажээ.

2009 онд тухайн үеийн Ерөнхий сайд Нажиб Разак “IMDB” санг эдийн засгийн хөгжлийг дэмжих зорилгоор байгуулсан. Тус сан ихэнхдээ хөрөнгө оруулалт болон эдийн засгийн хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд Малайзын засгийн газрын өндөр албан тушаалтнууд хянадаг байсан гэж шүүхийн баримтад дурджээ.

Тус сангаас хамгийн багадаа 4.5 тэрбум доллар хулгайлагдсан бөгөөд Нажибын хамтран ажиллагчид энэ мөнгийг угаасан гэж АНУ-ын мөрдөгчид үздэг.

Авлигаас шалтгаалсан олон нийтийн уур бухимдал 2018 оны 05 дугаар сард Нажибын удаан хугацааны засаглалыг ялагдалд хүргэсэн. Нажиб өөрөө тус сангаас мөнгө завшсан авлигын хэрэгт шалгагдаж байгаа юм.

Батлан хамгаалах салбар дахь өргөн хэмжээний авлигын хэргийг Хойд Солонгост илрүүлэн шалгаж эхэллээ³⁴⁷

2020.04.28. Хойд Солонгосын эрх баригчдийн зүгээс тус улсын батлан хамгаалах салбар дахь авлигын асуудлаар өргөн цар хүрээтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулж, хууль бус үйлдэлтэй холбоотой тодорхой нотлох баримт олж авсны дотор армийн хамгийн элит хүчнийхэнтэй холбоотой баримт ч байгаа гэдгийг Дэйли НК олж мэдлээ.

Дөрөвдүгээр сарын эхээр эхэлсэн энэхүү мөрдлөгийг Хойд Солонгосын Зэвсэгт хүчний Жанжин штабт шууд харьяалагддаг тусгай үүргийн ажлын хэсэг гардан гүйцэтгэж байгаа гэж арми дахь эх сурвалж мэдээлсэн байна.

Мөрдлөгийн явцад тогтоогдсон баримтаас үзвэл “байлдааны бэлтгэл сургуулилтад оролцохоос зайлсхийх” нь арми дахь авлигын хамгийн түгээмэл хэлбэр юм. Түүнчлэн байлдааны бэлэн байдлыг шалгах чиг үүрэг бүхий офицерууд шаардлага хангаж чадаагүй анги, нэгтгэлийн удирдлагаас цагаан будаа, мах, тамхи зэрэг эд зүйлийг хахуульд авж, хангалттай үнэлгээ өгдөг байсан нь илэрчээ.

Армийн хамгийн элит хэсэг болох Долдугаар хорооны зарим офицерүүд авлигад холбогдсон нь хэргийг мөрдөж байгаа мөрдөгч нарыг хүртэл цочролд оруулжээ.

³⁴⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.dailynk.com/english/north-korean-probe-military-uncovers-vast-levels-corruption/>

Бенгал мужийн засаг захиргаанаас 300 орчим хүнс түгээгчийг авлигын хэрэгт буруутган баривчилж, хулгайлагдсан хүнсний зүйлийг буцаан гаргуулахаар боллоо³⁴⁸

2020.05.04. Энэтхэг. Баруун Бенгал мужийн засаг захиргаанаас КОВИД-19 цар тахлын хөл хорионы үед хүнсний түгээлт хийж байсан 300 орчим түгээгчийг авлигын хэрэгт буруутган баривчлаад байна.

“Иргэдэд хүнс түгээх систем”-ийг Бенгал мужид хэрэгжүүлж байгаатай холбогдуулан тогтоосон дүрэм журмыг хүнс түгээгчид дагаж мөрдөхгүй байгаа тул дээрх арга хэмжээг авж хэрэгжүүлсэн юм.

Үүнийг ТМС намын удирдлагын дэмжлэгийг авсан зарим нэг түгээгч нар “Иргэдэд хүнс түгээх систем”-д зориулагдсан хүнсний үр тариаг хууль бусаар цуглуулсан, хар зах дээр худалдсан хэмээн сөрөг хүчний зүгээс буруутгаж байна.

Баруун Бенгалын Хүнс хангамжийн сайд Жиоти Приа Маллик Ньюс 18 мэдээллийн агентлагт өгсөн ярилцлагадаа “*Урьд өмнө ард иргэдэд хүнс тараахад ямар нэг асуудал үүсч байгаагүй боловч энэ удаа зарим түгээгчид хууль зөрчиж, буруу үйл ажиллагаанд оролцсон байна. Үүнийг бид анхаарлын төвд авж, цаашид тэдэнд хатуу арга хэмжээ авах болно*” гэжээ.

Мөн тэрээр нэмж хэлэхдээ дээрх түгээгчид хүнсний бүтээгдэхүүнийг байх ёстой хэмжээнээс 50-100 граммаар багаар түгээдэг байсан гэв.

Үүнтэй холбоотойгоор тэдгээр түгээгчдийн нэрийг жагсаалтаар гаргасан бөгөөд нийт 272 түгээгчийг саатуулан заримыг нь торгож, баривчилсан байна.

Ням гарагт гэхэд 14 сая гаруй хүнд хоол хүнс түгээсэн бөгөөд дээрх тоог өдөр бүр нэмэгдүүлж байна. Үүний өмнө буюу 04 дүгээр сарын 16-нд мужийн захирагч Мамата Банержа хүнсний талон эзэмшигчдэд бүтэн сарын турш аливаа хүнсний тусламж үйлчилгээ очоогүй байсан гэх шалтгаанаар Хүнс, хангамжийн газрын нарийн бичгийн даргыг албан тушаалаас нь чөлөөлж байгаагаа зарласан.

Бүх Энэтхэгийн шудрага үнэ, худалдаачдын холбооны ерөнхий зохицуулагч Бисвамбар Басу-тай энэ асуудлаар холбогдож асуухад тэдгээр түгээгчдэд ял оногдуулаад зогсохгүй хууль бусаар хадгалсан хүнсний бүтээгдэхүүнийг буцаан олгуулж, хохиролгүй болгох хэрэгтэй гэжээ. Өнөөдрийн байдлаар тус муж даяар 20.3 мянган хүнсний түгээгч байдаг ба бид газар дээрх шалгалтыг хийж гүйцэтгэж байна, одоогоор Бенгалд үүнээс өөр асуудал гараагүй байна гэж тэрээр нэмж тодотгосон.

КОВИД-19 цар тахлын улмаас хүмүүс өөрсдийн амжиргааны талаар санаа зовниж байхад ТМС намын удирдагчид хүнсний түгээлтэд хяналтаа тогтоосон. Бид үүнийг буруушааж, уг авлигын хэрэгт холбогдсон хүмүүст хатуу арга хэмжээ авахыг шаардах болно гэж ВЖР намын нарийн бичгийн дарга Рахул Синха хэллээ.

Вьетнамын Барилгын яамны Ерөнхий хянан шалгагч нарын хахуулийн дуулиан³⁴⁹

2020.05.04. Өнгөрсөн жил доод албан тушаалтнууд нь хахууль шаардсан хэрэгт холбогдсоны дараа Барилгын яамны одоогийн болон өмнөх Ерөнхий хянан шалгагч нар шийтгүүлээд байна.

Вьетнам Улсын Хянан шалгах төв хорооноос тус яамны Хяналт шалгалтын газрын Коммунист намын хороонд гарсан дээрх зөрчлийг шалгаж, холбогдох албан хаагчдад шийтгэл хүлээлгэх шийдвэр гаргаснаар тус 2 албан тушаалтанд сахилгын арга хэмжээ оногдуулсан талаар ням гарагт гаргасан мэдэгдэлд дурджээ.

³⁴⁸ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://in.news.yahoo.com/bengal-govt-cracks-down-nearly-093300000.html>

³⁴⁹ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://e.vnexpress.net/news/news/construction-ministry-chief-inspectors-disciplined-in-bribery-scandal-4093641.html>

Намын нарийн бичгийн дарга, Барилгын яамны Хянан шалгах газрын дарга асан Пам Гиа Иенийг Коммунист нам дахь бүхий л албан тушаалаас нь чөлөөлсөн бол түүний залгамж халаа болох одоогийн намын нарийн бичгийн дарга, Барилгын яамны Хянан шалгах хэлтсийн дарга Нгуен Нгок Туанд сануулах арга хэмжээ авсан байна.

Дээрх 2 албан тушаалтныг тус яамны Хяналтын газрын Намын хорооны зүгээс Барилгын яам, хяналт шалгалтын салбар болон намын нэр хүндэд сөргөөр нөлөөлж олон нийтийн итгэлийг алдагдуулсан зөрчил үйлдсэн гэж буруутгаж байгаа юм.

Барилгын яамны Хянан шалгах газрын Намын хороонд 2015–2020 онд гарсан зөрчлүүдэд арга хэмжээ авах ёстой талаар Хянан шалгах төв хорооноос шаардлага хүргүүлээд байна. Хяналтын газрын Намын хэлтэс холбогдох дүрэм журмыг дагаагүй, хяналт шалгалтыг хийж гүйцэтгээгүй, зөрчил гарах боломжийг бий болгосон зэрэг олон алдаа дутагдал гаргаад байгаа гэж Төв хяналтын хорооноос дүгнэсэн байна.

Хахуулийн хэрэгт холбогдуулан яамны Хяналтын газрын албан хаагчид болох Ньюэн Ти Ким Ан болон Дан Хай Ан нарыг намаас хөөж, нэр бүхий 4 албан тушаалтанд сануулга өгсөн байна. Вьетнамын Коммунист нам гишүүддээ донгодох /зэмлэх/, сануулах, тушаал бууруулах, намаас хөөх гэсэн 4 төрлийн /сахилгын/ арга хэмжээ авдаг юм.

Цагдаагийн байгууллагын мэдээлснээр Хяналтын газрын 6 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг өнгөрсөн жилийн 06 дугаар сард барилгын компанийн албан хаагчдаас 3,900 ам.доллар авж байгаад баригдсан бол мөн өдөр тэдний удирдах албан тушаалтнууд орон нутгийн төсөл, хөтөлбөрийн 2 нягтлан бодогчоос хахууль авж байгаад баригдсан талаар мэдээлсэн байна.

Дээрх 2 нягтланг тухайн өдөртөө баривчилсан бөгөөд 3 дахийг нь хэд хоногийн дараа баривчилсан байна. Цагдаагийн байгууллагын нэгжлэгээр тухайн барилгын компанийн байрнаас хэрэгт холбогдох файл, 14,400 ам.долларыг илрүүлжээ. Тухайн хэргүүдэд өнгөрсөн оны 06 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Индонезийн парламентын гишүүн асан саримсны импортын зөвшөөрөлтэй холбоотой авлигын хэрэгтээ 7 жилийн хорих ял авлаа³⁵⁰

2020.05.07. Жакарта хотын Авлигын шүүхээс парламентын гишүүн асан Ниоман Дхамантрад долоон жил шоронд хорих ял оноолоо.

Индонезийн Авлигыг устгах хорооны хэвлэлийн төлөөлөгчийн хэлснээр Ардчилсан намыг төлөөлөн парламентад сууж байсан Ниоман нь 2001 оны Авлигын хуулийн 12 дугаар зүйлд заасан “нийтийн албан тушаалтан болон төрийн албан хаагч хахууль авах” гэмт хэрэг үйлдсэн тул ийнхүү хорих болон торгох ялаар шийтгүүлжээ. Хэрэв тэрээр торгуулийн 500 сая рупиг (32,878 ам.доллар) төлж чадахгүй бол түүний торгох ялыг гурван сарын хорих ялаар солих болно.



Ниоман Дхамантра шүүх хурал дээр

Шүүгдэгчийн нийтийн албанд сонгогдох болон томилогдох эрхийг дөрвөн жилийн хугацаагаар хасжээ.

Авлигыг устгах хорооны прокурорын зүгээс шүүгчдэгчийг 10 жил хорих ял болон 1 сая рупигээр торгох ялаар шийтгэхийг санал болгосон боловч шүүгч энэ хэмжээнд хүртэл ял өгсөнгүй.

³⁵⁰ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.thejakartapost.com/news/2020/05/07/former-pdi-p-lawmaker-sentenced-to-seven-years-in-prison-in-garlic-import-permit-bribery-case.html>

Халдварт өвчний үед ядуу өрхүүдэд зориулсан цагаан будааг шамшигдуулсан асуудалд буруутгагджээ³⁵¹

2020.05.10. Бангладеш. Улсын хэмжээнд эмзэг бүлгийнхэнд зориулсан нийгмийн халамжийн хөтөлбөрийн цагаан будаанаас ашиглан шамшигдуулсан хэд хэдэн паришадын³⁵² зөвлөлийн дарга болон гурван гишүүн, зөвлөлийн нарийн бичгийн дарга нартай холбоотой гурван хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Эхний хэрэгт холбогдсон хүмүүс нь 1,050 кг цагаан будаа, хоёр дахь хэрэг дээр 10,260 кг цагаан будаа, гурав дахь хэрэг дээр 510 кг цагаан будааг шамшигдуулсан байна. Үүний өмнө мөн зөвлөлийн дарга албан тушаалтай 6 хүн, зөвлөлийн гишүүн 6 хүн, хүнсний захын борлуулагч 2 хүнтэй холбоотой 11 хэргийг Авлигын эсрэг хороо шалгаад байсан юм.

Нико компанитай холбоотой шүүх хурал эхлээгүй ч байгалын хий алдсаныхаа төлөө Бангладеш улсад нөхөн олговор төлөхөөр болов³⁵³

2020.05.10. Олон улсын шүүхийн шийдвэрээр Бангладеш улс байгалийн хий олборлогч Канадын Нико компаниас 2005 оны хийн талбайн ослийн нөхөн олговор авахаар болов. Гэтэл тус улсын Ерөнхий сайд асан албан тушаалаа ашиглан байгалийн хий олборлогч компанид давуу байдал олгосноос төр хохирсон асуудлыг шийдвэрлэх шүүх хурал эхлээ ч үгүй байна.

Авлигын эсрэг хороо 2007 оноос эхлэн Бангладешийн үндэсний намын тэргүүн Каледа Зиа болон бусад арван хүнтэй холбоотой, хийн 3 орд газрыг байгалийн хий олборлох компанид хямд зарж, улсад 137.77 тэрбум такагийн хохирол учруулсан хэргийг шалгаж байгаа юм.

12 жилийн өмнөөс шалгаж эхэлсэн ч өнөөдрийг хүртэл шүүх хурлыг хийж чадахгүй байна. Гол хэрэгтэн болон Ерөнхий Сайд асан Халеда Зиа хэд хэдэн удаагийн шүүх хуралд ирээгүйн улмаас шүүх хурал хойшлогдсоор байна гэж прокурорууд мэдэгдсэн бөгөөд Зиа-гийн өмгөөлөгчдийн зүгээс түүнийг өвчтэй байгаа гэж хэлжээ.

Тус хэргийг зогсоох Дээд шүүхийн шийдвэрийг 2017 онд цуцалснаар шүүх ажиллагааг дахин сэргээх боломж гарсан хэмээн Авлигын эсрэг хорооны зөвлөх Мошараф Хосейн Кажол (Mosharraf Hossain Kajol) мэдэгдсэн. Шүүх хурлын товыг хэд хэдэн удаа зарласан ч Зиа өвчтэй гэсэн улмаас хойшлоод байна.

Харин нөхөн олговрын хувьд Канадын компани Сунамганж Чатак (Chhatak Sunamganj) дахь Тенгратила (Tengratila) ордод болсон дэлбэрэлтэд хариуцлага хүлээх ёстой тул Нико компанийг Петробангла (Petrobangla) компанид нөхөн олговор олгох шийдвэрийг Хөрөнгө оруулалтын маргаан шийдвэрлэх олон улсын төвөөс хоёрдугаар сарын 28-ны өдөр гаргасан юм. Хөрөнгө, байгалийн хийн нөөцийн хохиролд нэг тэрбум ам.долларыг нөхөн олговорт авах байх хэмээн Бангладеш улс найдаж буй юм.

Авлигын хэргийн улмаас олон арван төрийн албан хаагчийг баривчлав³⁵⁴

2020.05.10. Сири. Алеппо хотын засаг захиргаанаас асар их хэмжээний хөрөнгө мөнгийг авлига, итгэл эвдэх замаар ашиглан завшсан олон тооны албан тушаалтнуудыг саяхан баривчиллаа.

³⁵¹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://tbsnews.net/bangladesh/crime/rice-embezzlement-acc-sues-chairman-member-and-secretary-79732>

³⁵² Бангладеш Улсын орон нутгийн засаг захиргааны хамгийн жижиг нэгж

³⁵³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.dhakatribune.com/bangladesh/corruption/2020/05/10/niko-graft-trial-yet-to-kick-off-as-bangladesh-wins-compensation-for-blowouts>

³⁵⁴ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: https://npasyria.com/en/blog.php?id_blog=2503&sub_blog=12&name_blog=Aleppo:%20Government%20authorities%20arrest%20dozens%20on%20charges%20of%20corruption%20and%20fraud

Эрүүгийн цагдаагийн газар (ЭЦГ)-аас одоо авлигын хэрэгт холбогдон шалгагдаж байгаа 26 хүн дээр нэмээд нэгэн дүүргийн захирагчийг баривчилснаас гадна дөрвөн өөр дүүргийн захирагч нарыг эрэн сурвалжилж байна.

ЭЦГ-аас хэд хэдэн дүүргийн захирагчийг коронавирус тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх ариутгалын материал, хөрөнгө мөнгө хулгайлсан, барилга барих хууль бус зөвшөөрөл олгосон зэрэг асуудалд буруутгаж буй юм.

Түүнчлэн ЭЦГ-аас авлигын асуудалд холбогдсон хүмүүстэй холбоотой цахим хуудсууд болон нийгмийн сүлжээний бүртгэлүүдийг хааж, өмчлөгчдийг баривчилжээ. Цахим сайт эзэмшигчдийн зарим нь Сирийн сөрөг хүчнийхэнтэй мөн холбоотой байжээ.

Өнгөрөгч есдүгээр сард Сирийн засгийн газраас гурван зуун тавин тэрбум сири паундтай тэнцэх хэмжээний авлигын хэрэгт холбогдсон Боловсролын сайд асан Хазван ал-Ваз (Hazwan al-Wazz) болон түүний эхнэрийн өмч хөрөнгийг хураан авсан бөгөөд мөн 87 төрийн албан хаагчтай холбоотой авлигын хэргийг шийдвэрлэсэн.

Сирийн засгийн газар авлигатай тэмцэнэ хэмээн тунхаглаж хөтөлбөр, төлөвлөгөө гаргадаг ч үр дүнг нь олон нийтэд мэдээлэхгүй өнгөрдөг.

ТИ байгууллагын авлигын төсөөллийн жил бүрийн судалгааны үр дүнгээр Сири улс нь араасаа дэд байр эзэлж зөвхөн Сомали улсын өмнө орсон.

Шэньси мужийн Коммунист намын хорооны дарга асны хахууль авсан хэргийн шүүх хурал болов³⁵⁵

2020.05.11. Шэньси мужийн Коммунист намын хорооны дарга, мужийн хурлын дарга асан Зао Зэнгёонгийн хахууль авсан хэргийн шүүх хурал Тянжины Ардын анхан шатны шүүхэд өнгөрсөн даваа гарагт эхлэв.

Зао нь 2003-2018 оны хооронд эрхэлж байсан албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, төсөл хэрэгжүүлэх гэрээ, хэлэлцээр хийх зэрэг бизнес болон бусад асуудлаар буюу албан тушаал дэвших, шилжин ажиллахаар бусад байгууллага, этгээдэд давуу байдал олгосон хэрэгт буруутгагдаад байгаа юм.

Зао 717 сая юань (101.32 сая ам.доллар)-ийн хахууль авсан ба үүнээс 291 сая юанийг нь авж амжаагүй хэмээн прокурор мэдэгдсэн байна. Шүүх хурлын явцад Заогийн хахууль авсныг нотлох баримтуудыг прокурорууд гаргаж, эдгээртэй өмгөөлөгчид танилцан, хоёр тал өөрсдийн санаа бодлыг илэрхийлж мэтгэлцэв.

Зао буруугаа хүлээсэн ба шүүхийн эцсийн шийдвэр гараагүй байна. Шүүх хуралд хуульчид, улс төрийн зөвлөхүүд, хэвлэл мэдээллийн хэрэгслийн болон олон нийтийн төлөөлөл оролцов.

Булакан тосгоны 3 албан тушаалтан авлигын хэрэгт холбогджээ³⁵⁶

2020.05.14. Филиппин. КОВИД-19 цар тахалд нэрвэгдсэн иргэдэд олгож буй мөнгөн тусламжийг хуваарилах явцад хахууль авсан асуудалд Булакан дахь тосгоны 3 албан тушаалтнуудыг буруутгаад байна. Мөдөн шалгах үндэсний товчоо (МШҮТ) Кагавад Данило Флорес, Ричард Баугиста болон түүний эхнэр Жейсон Мендоза нарт авлига, хахуулийн хэрэг нээгээд байна. Тусламжийн 6,500 песогоос хувь нэхсэн тухай гурван гомдол гаргагч хандсан талаар МШҮТ мэдэгдсэн байна.

Тэдний мэдээллээр Флорес 4,000 песо нэхсэн гэсэн ба гэрчүүдийн мэдүүлгээр тэрээр 117,000 песо авж Баугиста болон түний эхнэрт дамжуулсан гэсэн байна. Гэрчүүдийн мэдүүлгээр Мендоса нь өөрийн албан тушаалтны хийж буй үйлдлийг мэдэж байсан хэмээн МШҮТ-ны мэдэгдэлд дурджээ. Иймд Дотоод хэргийн яамнаас гамшгийн үеийн тусламжийн хөрөнгийн зарцуулалтыг сайжруулах талаар орон нутгийн 43 захирагчид тушаал явуулахаар болжээ. Дэлхийг хамарсан

³⁵⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: http://www.china.org.cn/china/2020-05/11/content_76031905.htm

³⁵⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://cnnphilippines.com/news/2020/5/14/SAP-cash-aid-distribution-Hagonoy-Bulacan-corruption.html>

хямралын үед ядуу, эмзэг өрхүүдэд зориулсан нийгмийн халамжийн хөтөлбөрийн хөрөнгийг ашигласан албан тушаалтнуудыг баривчлах, хэргийг шалгах талаар засгийн газраас тусгайлан чиглэл хүргүүлээд байгаа юм.

Нийгмийн халамж, хөгжлийн газрын мэдээллээр энэхүү хөрөнгийн хуваарилалттай холбоотой 183 албан тушаалтан авлигын асуудлаар шалгагдаж байгаа аж. Авлига, хүний нөөцийн дутмаг байдлын улмаас гэсэн шалтгаантайгаар Ерөнхийлөгч Родриго Дутерте нарийн бичгийн даргадаа үүрэг өгч энэхүү нийгмийн халамжийн хөрөнгийн хуваарилалтыг бэлнээр олгоход цэргийнхний тусламжийг авж буй юм.

Пусан хотын орлогч даргыг Сөүл хотын шүүх авлигын хэргээр шийтгэсэн байна³⁵⁷

2020.05.22. Сөүл хотын шүүхээс Пусан хотын Эдийн засгийн асуудал хариуцсан орлогч дарга Ю Чжэ Су-г авлигын хэрэгт буруутган 1.5 жилийн хугацаатай тэнсэн харгалзах ял оногдуулж, 90 сая вон (73 мянган ам.доллар)-ы торгууль оногдуулсан тухай Өмнөд Солонгосын KBS агентлаг мэдээлсэн байна.

Тэрээр БНСУ-ын Санхүүгийн хороо болон Пусан хотын захиргаанд 2010-2018 онуудад ажиллаж байхдаа 47 сая вон (38 мянган ам.доллар)-ы авлига авсныг прокурорын байгууллагаас нотолсон байна.

Уг хэргийн шүүх хурал прокурорын яллах дүгнэлт гарснаас 5 сарын дараа болсон байна.

Биньямин Нетаньяхугийн хэргийн шүүх хурал эхэллээ³⁵⁸

2020.05.24. Албан үүргээ гүйцэтгэж буй Израилийн Ерөнхий сайд Нетаньяхугийн шүүх хурал өнгөрсөн ням гарагт эхлэв.

Түүнийг хахууль, луйвар, итгэл алдсан хэрэгт буруутгаж буй бөгөөд тэрээр шүүх хурлын танхимд орохоос өмнө өөрийгөө буруугүй гэж мэдэгдсэн юм. Долоо хоногийн өмнө тэрээр Ерөнхий сайдын албан тушаалд 5 дахь удаагаа ажиллахаар тангараг өргөсөн юм. Нетаньяху энэ жилийн 3 дараалсан сонгуулийн үр дүнд тус албан тушаалд очсон ба улс төрийн тавцанд хэрхэн үлдэж чадахыг өөрийн гол өрсөлдөгчтэй эрх мэдлийг хуваах санаанд оромгүй хэлцэл хийснээр харуулсан нэгэн. Түүнийг саятан найзуудаасаа бэлэг авдаг, үйл ажиллагаагаа эерэгээр харуулах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслийн магнатуудад хөнгөлөлт олгодог зэрэг асуудалд өнгөрсөн арван нэгдүгээр сард хэрэгт татсан.

Тэрээр Иерусалимын тойргийн шүүхэд ирэхдээ барууны чиглэлийн Ликуд намын сайд нарын хамт иржээ. Шүүхийн танхимд Нетаньяху болон шүүгчид амны хаалттай байв. Яллах дүгнэлтийг ойлгосон эсэх талаар шүүгчийг асуухад тэрээр ойлгож байгаагаа илэрхийлэв. Дараагийн шүүх хуралдааныг 06 дугаар сарын 19-нд зарласан байна. Израилийн шинжээчдийн үзэж байгаагаар шүүх хурал олон сар, жилээр үргэлжлэх боломжтой ажээ. Хахуульд 10 хүртэл жилээр хорих, эсхүл, торгох ял, харин луйвар, итгэл алдсан хэрэгт 3 хүртэл жилээр хорих ял оногдуулах боломжтой ажээ.

Зочид буудлуудыг хөл хорионы төв болгон сонгох явцад хахууль нэхсэн асуудлыг шалгаж эхлэв³⁵⁹

2020.05.26. Тайланд. Бангкок. Зочид буудлын эздээс буудлыг нь хөл хорионы төв болгож өгнө хэмээн мөнгө нэхсэн этгээдүүдийг эрэн сурвалжилж эхэлсэн талаар Батлан хамгаалах яам (БХЯ) мэдэгдэв. Зочид буудлуудаас ирсэн мэдээллийн дагуу шалгах хангалттай үндэслэл байгаа талаар тус яамны хэвлэлийн төлөөлөгч Конгчийп Тантраванич мэдэгдсэн байна.

³⁵⁷ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/2958144.html>

³⁵⁸ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.wionews.com/world/defiant-netanyahu-goes-on-trial-in-israel-charged-with-corruption-300799>

³⁵⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.bangkokpost.com/thailand/general/1924056/quarantine-hotels-graft-probe-begins>

Тэрээр “Зүүн бүсийн зочид буудлын нийгэмлэгийнхэн хөл хорионы төв болгож өгнө хэмээн мөнгө нэхсэн асуудлыг хөндсөн” гэв. Тэрээр батлан хамгаалах салбарын болон Нийтийн эрүүл мэндийн яам (НЭМЯ)-ны нэг ч албан хаагч энэхүү үйл ажиллагаанд холбогдоогүй, хэрэв ийм асуудал гарсан нөхцөлд хатуу арга хэмжээ авна гэжээ. Хэрэв эдгээр байгууллагын албан хаагчтай холбоотой асуудал байвал сахилгын болон эрүүгийн хариуцлага тооцох асуудал гарна гэдгийг тэрээр тэмдэглэв.

Тай медиагийн мэдээллээр бол хэд хэдэн сэжигтэн Паттая дахь зочид буудлын үйлчилгээ эрхлэгчдэд хандан хэрэв зочид буудал нь сонгогдсон нөхцөлд төрөөс олгож буй мөнгөний үнийн дүнгийн 40 хүртэл хувийг зуучилсны хөлсөнд авахаар ярьсан гэжээ. Хөл хорионы төв болгон ашиглаж буй зочид буудлуудад өдөрт нэг хүний 1,000 бат олгож буй юм. Тус улс 14 хоногийн хөл хорионы дэглэм мөрдөж байгаа ажээ. БХЯ болон НЭМЯ 02 дугаар сараас хойш хилийн чанадаас ирж буй иргэдийнхээ 14 хоногийн хөл хорионы асуудлыг зохицуулж байгаа юм.

Өнөөдрийн байдлаар коронавирусний дэгдэлтийн улмаас хилийн чанадаас 80,000 гаруй иргэдээ татан авж, хөл хорионы төвүүдэд байршуулаад байгаа юм. Шалгалтын ажиллагааг урагшлуулахад бизнесийн төлөөллийнхөн мэдээлэл өгөхийн чухлыг НЭМЯ-ны сайд Анутин Чарнвиракул онцлов.

Киргиз улсын Ерөнхий сайд асанд авлигын хэргээр 18 жилийн хорих ял оногдуулав³⁶⁰

2020.06.09. Киргиз улсын Ерөнхий сайдаар 2017-2018 онд ажиллаж байсан Сапар Исаковыг авлигын хэрэгт буруутган шүүхээс 18 жил хорих ял оногдуулав.

Түүхийн музей болон Чолпон-Ате амралт, зугаалгын газрыг засварлах, тэдгээрт зориулан тоног төхөөрөмж худалдан авахдаа төсвийн хөрөнгийг хууль зөрчин зарцуулсан асуудлаар 2018 оны зун эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Сапар Исаков уг хэргийн гол эзэн, буруутан нь болсон байна.

Ерөнхий сайд асан болон бусад албан тушаалтнуудын хамсан үйлдсэн хэргийн улсын төсөвт учруулсан хохирлын хэмжээ 307.7 сая сом /ойролцоогоор 306 сая рубль/ болох нь мөрдөн шалгалтын явцад тогтоогдсон байна.

Шүүхийн шийдвэрийн дагуу тэрээр улсын төсөвт 250 сая сом /ойролцоогоор 249 сая рубль/ төлнө.

С.Исаков өмнө нь нийслэлийн Дулааны цахилгаан станцын шинчлэлтэй холбоотой эрүүгийн хэрэгт холбогдон, шүүхээс 15 жилийн хорих ял сонсоод байсан юм.

Японы Kansai Electric компани өмнөх удирдлагуудаа хахуулийн хэргээр шүүхэд өглөө³⁶¹

2020.06.16. Японы цахилгаан эрчим хүчний Кансай компани өнгөрсөн мягмар гарагт хахуулийн асуудлаар өмнөх таван удирдлагынхаа эсрэг хохирол барагдуулах нэхэмжлэл гаргаж, шүүхэд өгсөн гэдгээ мэдэгдэв.

1.94 тэрбум иен (18 сая ам.доллар)-ий уг нэхэмжлэлд тус компанийн атомын цахилгаан станцуудын нэг байршиж буй нэгэн хотын орлогч даргатай холбоотой хахуулийн асуудал багтаж байгаа юм.

Фукуи мужийн Такахама хотын орлогч даргад Кансай Электрик компанийн удирдлага болон ажилтнууд хахууль өгч, өөрийн холбоотой компаниуддаа ажил олж авдаг байсан нь өнгөрсөн 09 дүгээр сард тогтоогдсоноос хойш Осака хотод байрлах компани нь шүүмжлэлд өртөж эхэлсэн юм.

³⁶⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://rg.ru/2020/06/09/eks-premer-kirgizii-prigovoren-k-18-godam-zakliucheniiia-po-delu-o-korrupcii.html>

³⁶¹ Орчуулсан Р.Энх-Амгалан. Эх сурвалж: http://www.xinhuanet.com/english/2020-06/16/c_139144005.htm?fbclid=IwAR3T1HiH1zYANRqUeqSCpMJ85z4ILuZeBSdJTOVhOGP8G4A5doHA9o6O9gc

Нэр бүхий таван хүн ТУЗ-ийн үүргээ гүйцэтгэж чадаагүй гэсэн дүгнэлтийг даваа гарагт болсон хурлаар тус компанийн аудитын зөвлөлөөс танилцуулсны дараа уг нэхэмжлэлийг Осака хотын шүүхэд гаргасан байна.

Шүүхэд гаргасан нэхэмжлэлийн хариуцагчаар компанийн дарга асан Макото Яги, ерөнхийлөгч асан Шигеки Иване болон Шосукэ Мори зэрэг хүмүүс дурдагдсан байна.

Тус компани уг хэргийн улмаас тендерийн үйл ажиллагааг түдгэлзүүлэхтэй холбоотой үйл ажиллагаанд зарцуулсан 879 сая иен (8.19 сая ам.доллар), олон нийтийн итгэлийг сэргээх зорилгоор зар сурталчилгаанд зарцуулсан 284 сая иен (2.64 сая ам.доллар)-ийг хохиролд тооцон тусгасан байна.

Такахама хотын орлогч дарга Иижи Мориамад 1987 оноос хойш гуч гаруй жилийн хугацаанд нийтдээ 360 сая иен (3.35 сая ам.доллар)-ий дүн бүхий бэлэн мөнгө, бэлэг, хувцасны ваучер, сумогийн тасалбар өгч байсан гэсэн дүгнэлтийг хөндлөнгийн шинжээчид 03 дугаар сард гаргасан.

Тус компани өмнө ажиллаж байсан болон одоо ажиллаж байгаа 93 удирдах ажилтан, ажиллагчдаа хахуультай холбоотой хэргээр хариуцлага хүлээлгэсэн байна.

БНХАУ-д төрийн албан тушаалтанд авлигын хэргээр ял оногдуулжээ³⁶²

2020.06.19. БНХАУ-ын төвийн бүсэд байрлалтай Хунань мужийн Чэнжоу хотын Ардын шүүхээс тус улсын чанарын хяналт шалгалт, хорио цээр хариуцсан төрийн төв байгууллагын дэд дарга асан Вэй Чуаньжунуг авлигын хэргээр бүх насаар нь хорих шийтгэл оногдуулсан талаар 06 дугаар сарын 19-нд Синьхуа агентлаг мэдээлсэн байна.

Шүүхээс түүний бүх эд хөрөнгө, олсон орлогыг хураан авж, улсыг хохиролгүй болгох шийдвэр гарсан. Тэрээр уг албан тушаалыг хашиж байхдаа хууль зөрчин тусгай зөвшөөрөл олгосон, худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтад оролцсон, мөн хууль бус томилгоо хийж байсан үйлдлийнхээ төлөө нэг биш удаа бэлэн мөнгө, бэлэг авж байжээ.

Ардын шүүхээс Вэй Чуаньжуну нь нийт 123 сая юань /17.3 сая гаруй ам.доллар/-ийг авлигын замаар олсныг тогтоожээ.

Ял шийтгэлтэй этгээдийг Хууль зүйн сайдын зөвлөхөөр томилох гэж байгааг Тайландын Авлигатай тэмцэх үндэсний хороо эсэргүүцлээ³⁶³



(Фото: nationthailand.com)

2020.06.22. Тээврийн яамны төрийн нарийн бичгийн дарга асан, хорих ял шийтгэл эдэлж байгаад өнгөрсөн онд суллагдсан Супож Саплом (Supoj Saplom)-ыг Хууль зүйн сайдын зөвлөхөөр томилох гэж байгааг Тайландын Авлигатай тэмцэх үндэсний хороо (АТҮХ) хатуу эсэргүүцсэн байна.

Томилгоотой холбогдуулан АТҮХ-ноос 2020 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Хууль зүйн сайд Сомсак Тепсутин (Somsak Thepsuthin)-д хандан захидал

хүргүүлэн, Хууль зүйн яам бол нийгэмд шударга ёсны үлгэр дууриал болох ёстой бөгөөд тус яамны гишүүнээр томилогдсон ямар ч хүн гэмт хэргийн бүртгэлтэй байх ёсгүй хэмээн мэдэгджээ. Мөн тус захидалд, хоригдлуудыг хөгжүүлэх, хүмүүжүүлэх үйлдвэрлэлийн бүсийг судлах үүрэг

³⁶² Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://regnum.ru/news/polit/2987438.html>

³⁶³ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.nationthailand.com/news/30390075>

бүхий дэд хорооны гишүүнээр элсүүлэхээр авлигын хэргээр хоригдож буй хүнийг урьсан гэх мэдээллийг АТҮХ хүлээн зөвшөөрөхгүй гэж мэдэгджээ.

Сулож нь үйлдвэрийн үл хөдлөх хөрөнгийг эрхлэн зохицуулах журмыг боловсруулах ажлыг хариуцан ажилладаг байсан бөгөөд хөрөнгийн мэдүүлэгтээ Волксваген Каравэл маркийн тээврийн хэрэгслээ мэдүүлээгүй гэх үндэслэлээр 10 сарын хорих ялаар шийтгэгдэж байжээ.

Батлан даалтад байсан Малайзын парламентын гишүүн болон түүний ах хахууль, мөнгө угаасан хэргээр давж заалдах шатанд гаргаад байсан гомдлоо буцаан татлаа³⁶⁴



Парламентын гишүүн Абдул Азез Абдул Рахим 5.2 сая юанийн хахууль авсан гурван хэрэг, 140 сая орчим малайз ринггитийн мөнгө угаасан есөн хэрэгт холбогдсон байна. (Фото: freemalaysiatoday.com)

2020.06.22. Батлан даалтад байсан Малайзын парламентын гишүүн Абдул Азез Абдул Рахим болон түүний ах Абдул Латиф нар хахуулийн мөнгийг шилжүүлсэн, мөнгө угаасан хэрэгт холбоотойгоор Дээд шүүхэд гаргасан гомдлоо буцаан татсан байна. UMNO /Нэгдсэн малайз үндэсний байгууллага/-ын намын гишүүн Абдул Азез нь Перак болон Кедан дахь автозамын төслүүдээс нийтдээ 5.2 сая малайз ринггитийн /3,428,048,000 төгрөг/ хахууль авсан 3 хэрэгт холбогдож, нийтдээ 140 сая малайз ринггитийг /92,293,600,000 төгрөг/ угаасан 9 удаагийн үйлдэлд холбогдсон бол түүний ах хахууль авахад хамтран оролцсон гэх 2 хэрэгт холбогджээ.

3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр тэдний хүсэлтийг хэлэлцэж хэргийг шүүхэд хэвээр үлдээхээр болж шийдвэрлэлээ гэж шүүх хуралдаан даргалагч Якоб дурджээ. Дээрх 2 хэргийг тус тусад нь өнөөдөр шүүх хуралдаанаар хэлэлцэж байгаа бөгөөд 53 настай Азез болон 62 настай Латиф нар нь өнөөдрийн шүүх хуралдаанд биеэр оролцохгүй байхаар болсон байна.

Ерөнхий прокурорын танхим шүүх хуралдаанаас хэргийг Дээд шүүх руу шилжүүлэх хүсэлт гаргасан бөгөөд дээрх прокурорын хүсэлт дэмжигдсэн талаар өмгөөлөгч нь мэдэгджээ. Тэд

³⁶⁴ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.freemalaysiatoday.com/category/nation/2020/06/22/baling-mp-brother-withdraw-appeals-over-transfer-of-bribery-money-laundering-charges/>

өнгөрсөн оны 11 дүгээр сарын 28-нд хэргийг Дээд шүүхэд шилжүүлэх тухай прокурорын хүсэлтийг хэрэгсэхгүй болгох тухай Дээд шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн давж заалдсан.

Азез нь замын тендерийн ажилд оролцоход давуу байдал үзүүлснийхээ төлөө Мохаммедаас талархал болгон 4 сая малайз ринггит /2,636,960,000 төгрөг/ бэлнээр хүлээн авахад зуучилсан хэрэгт Латифийг буруутгаад байна. Шүүх хуралдаан 08 дугаар сарын 18-нд болохоор товлогдсон бол улсын яллагчаар Улсын орлогч прокурор Хау Мэй Линг оролцохоор болсон байна.

Казахстаны гааль, хорио цээрийн албан хаагчдыг авлигын хэргээр саатуулаад байна³⁶⁵

2020.08.11. Нур жолы боомтын гааль, хорио цээрийн албаны албан хаагчдыг хахууль авсан хэргээр саатуулаад байгааг Төмөр замын прокурорын байгууллагаас мэдээлэв. Төмөр замын прокурорын санаачилгаар Авлигатай тэмцэх албаны Алма-Атагийн салбарынхан саатуулсан юм байна. Дээр дурдсан байгууллагын албан хаагчид улсын хилээр ямар нэгэн саадгүй нэвтрүүлнэ хэмээн хахууль авдаг байжээ. Одоогийн байдлаар 8 хүнийг саатуулаад байна. Казахстан, БНХАУ-ын хил дээр урт дараалал үүсч байгаа талаар уртын тээврийн жолооч нар өнгөрсөн 06 дугаар сарын эхнээс гомдол гаргаж эхэлсэн байна. Казахстаны Сангийн яамны Улсын орлогын хороо, Хилийн алба, Аж үйлдвэрийн яам зэрэг нь автотээврийн Нур жолы боомтын үйл ажиллагааг зохицуулахаар арга хэмжээ авж байна гэж удаа дараа мэдэгдэж байсан ч нөхцөл байдал дээрдээгүй байна.

Авлигын асуудалд холбогдсон албан хаагчдад 7 жилийн ял оноожээ³⁶⁶

2020.08.17. Иракийн Шударга байдлын хороо 7 сая гаруй динар (5.8 сая ам.доллар) хувьдаа завшсан хоёр албан хаагчид 7 жилийн ял оноосон талаар мэдэгдэв. Багдадаас 30 км-т орших Агергугф сүмийн сэргээн засварлах хөрөнгөөс Мартурс сангийн удирдлагын зөвлөлийн гишүүд хөрөнгө завшсан байна. Төрийн санхүүгийн хяналтын хорооны шалгалтын материал, Эрүүгийн хуулийн 340 дүгээр зүйл зэргийг үндэслэн холбогдсон этгээдүүдэд ял оноохоор шийджээ. Хорооноос холбогдсон этгээдүүдийг баривчлах болон хөрөнгийг битүүмжлэх тогтоол гаргаснаа мэдэгдэв. Иракийн төрийн байгууллагууд дахь авлигын асуудал тус улсын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна. Саяхан болж өнгөрсөн үндэсний хэмжээний эсэргүүцлийн жагсаал цуглаан нь амьдралын түвшиний доройтол, авлига зэрэгтэй холбоотой юм.

Голдман Сакс групп 3.9 тэрбум ам.долларын тооцоог Малайз улстай хийж дуусгалаа³⁶⁷

2020.08.19. Малайзын төрийн сан дэлхийн авлигын томоохон хэрэгт холбогдож, өмнөх засгийн газраа огцруулахад хүрсэн. IMDb-ийн дуулиантай холбоотой 3.9 тэрбум ам.долларын төлбөр тооцоог эцэслэх гэрээнд Голдман Сакс групп болон Малайз улс гарын үсэг зурав. Ийнхүү 2.5 тэрбум ам.долларыг 10 хоногийн дотор бэлэн мөнгөөр, 1.4 тэрбум ам.долларыг дэлхийн өнцөг буланд царцаагаад байсныг буцаан олгохоор болж эцэслэв. Харин Малайзын засгийн газар Голдман Сакс банкны эсрэг гаргасан нэхэмжлэлээ татаж авахаар болсон байна.

Энэхүү хэлцэл нь хоёр талд харилцан ашигтай юм. Санхүүгийн хямралаас хойш ийм хүнд байдалд ороогүй байсан банкны хувьд нөхцөл байдлаа сайжруулах, харин Малайзын засгийн газрын хувьд төрийн сангаас алдсан 4.5 тэрбум ам.доллараас ихэнх хэсгийг нь олж авж буй хэрэг юм.

Уг хэргийг шалгах ажиллагаа сүүлийн арван жил үргэлжилж, Ази, АНУ, Европ тивүүдийг хамарч байсан ба үүнийг дэлхийн хамгийн том “дээрэм”-ийн хэрэг гэж үзэж байсан юм. Малайзын

³⁶⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://informburo.kz/novosti/na-tamozhennom-postu-nur-zholy-proshlo-massovoe-zaderzhanie-sotrudnikov--109870.html>

³⁶⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.middleeastmonitor.com/20200817-iraqi-officials-sentenced-to-7-years-over-corruption-charges/>

³⁶⁷ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/ajimpact/1mdb-goldman-sachs-finalises-39bn-settlement-malaysia-200819033455074.html>

төрийн сангаас гарсан хөрөнгө өндөр үнэтэй үл хөдлөх хөрөнгө, усан онгоц, уран зургийн эд зүйл болон хувирсныг олох гэж мөрдөгчид олон жилийг зарцуулсан юм.

Малайзын төрийн Берхад сангийн хөрөнгийг тус улсын Ерөнхий сайд асантай холбоотой хүмүүс шамшигдуулсан гэдэг. Голдман Сакс банкны хувьд 2012-2013 онд Малайзын төрийн Берхад санд 6.5 тэрбум ам.доллар босгох ажил хийж байсан юм. Тухайн үед Голдман Сакс группийг одоогийн гүйцэтгэх захирал Давид Соломон удирдаж байв.

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд Хятадын цагдаагийн 19 ажилтныг албан тушаалаас нь чөлөөлөв³⁶⁸

2020.08.24. Харбин хотын цагдаагийн 19 ажилтныг авлигатай тэмцэх үйл ажиллагааны хүрээнд шийтгэл оногдуулжээ. Тэднийг Коммунист намаас хөөн, албан тушаалаас нь чөлөөлж, хууль тогтоомжийг ноцтой байдлаар зөрчсөн хэргээр шалгаж байна.

Улсын аюулгүй байдлыг хангах байгуулагын орон нутаг дахь салбарын удирдах албан тушаалд ажиллаж байсан хүмүүсийн ихэнх нь хахууль авах, бизнест хувийн хөрөнгө оруулалт хийх, данс бүртгэлийг санаатайгаар устгах, хувьдаа ашиг олох зорилгоор эрх мэдлээ урвуулан ашиглах, галт зэвсэг хууль бусаар эзэмших зэрэг хууль бус үйлдэлд холбогдоод байна.

Харин доод албан тушаал хашиж байсан хүмүүсийн хувьд орон нутгийн зохион байгуулалттай гэмт бүлэглэлтэй хамтран биеэ үнэлэлт, мөрийтэй тоглоом, дээрэм, айлган сүрдүүлэлт, луйврын үйл ажиллагаа хийх зэрэг гэмт хэрэгт оролцсон, зохион байгуулсан асуудлаар баривчлагджээ.

Дээрх арга хэмжээ нь Хятадын Коммунист намын Төв хорооны Улс төр, эрх зүйн хорооноос энэ оны 07 дугаар сарын 08-ны өдрөөс эхлүүлсэн үндэсний хэмжээний кампанит ажлын нэг хэсэг юм. Уг кампанит ажил нь улс төр, шүүхийн системээс гадна цагдаа, хорих, аюулгүй байдлын байгууллагуудыг хамарч байна.

Казахстанд авлигын хэргийн илрүүлэлт нэмэгджээ³⁶⁹

2020.08.25. Казахстанд 2020 оны эхээс авлигын хэргийн тоо 76 хувиар нэмэгдсэн талаар тус улсын Дотоод хэргийн яамнаас мэдээлжээ.

Уг мэдээлэлд 2015-2019 онд авлигын хэргийн тоо дөрөв дахин буурсан талаар дурдсан бөгөөд энэ нь авлигын хэргийн асуудалд шинэ хандлагыг хэрэгжүүлсэнтэй холбоотой байсан гэж Дотоод хэргийн яамнаас тайлбарласан байна.

Мөн 2019 онд улсын төсвийн хөрөнгийг шамшигдуулсан хэрэг бүртгэгдээгүй бөгөөд төрийн албан хаагчдын жижиг хэмжээний авлигын хэргүүдийг илрүүлсэн. Төрийн албан хаагчдад хахууль авахгүй, авлигаас ангид байх хүмүүжлийг төлөвшүүлэх ажлыг зохион байгуулсаар байгаа талаар тус яамнаас мэдээлжээ.

Саудын Арабын Зэвсэгт хүчний командлагч авлигын хэрэгт сэжиглэгдэн албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна³⁷⁰

2020.09.01. Саудын Арабын Зэвсэгт хүчний Жанжин штабын командлагч Фахд бен Турк Ал Сауд, Эль-Жауф мужийн захирагчийн орлогч болон Батлан хамгаалах яамны хэд хэдэн ажилтан, албан хаагч, офицерууд хахууль авсан хэрэгт сэжиглэгдэж албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна. Тус улсын хаан Сальман бен Абдель Азиз тэднийг албан тушаалаас чөлөөлөх зарлигийг гаргажээ.

Дэслэгч генерал Фахд бен Туркийг тэтгэвэрт гарсан, хэрэгт татагдан шалгагдаж байгаа болон Эль-Жауф мужийн захирагчийн орлогч, ханхүү Абдель Азиз бен Фахд Алийг албан тушаалаас нь чөлөөлөх шийдвэрийг гаргасан тухай хэвлэлийн SPA агентлаг мэдээлсэн байна. Зэвсэгт

³⁶⁸ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.globaltimes.cn/content/1198674.shtml>

³⁶⁹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/3044154.html>

³⁷⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.kommersant.ru/doc/4475017>

хүчний Жанжин штабын шинэ командлагчаар орлогч дэслэгч генерал Мутлак бен Салем ал-Азимыг томилсон байна.

Тус улсад энэ оны 03 дугаар сард мөнгө угаах, албаны эрх мэдлээ урвуулах, хэтрүүлэх, авлигын хэргээр 198 хүнийг баривчилсан юм.

Тэдгээрийн дунд Рияд хотын их сургууль, Эрүүл мэндийн яам, Дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яамны албан тушаалтнууд багтсан байна.

11 жилийн хорих ял авсан Киргизийн Ерөнхийлөгч асан Атамбаев өөрийн гэм бурууг хүлээгээгүй байна³⁷¹

2020.09.02. Авлига, гэмт хэрэгтнүүдийн толгойлогч Азиз Батукаевийг хууль зөрчин шоронгоос сулласан хэрэгт Киргиз улсын Ерөнхийлөгч асан А.Атамбаевийг буруутган 11 жил, 2 сарын хорих ял оногдуулсан бөгөөд тэрээр өөрийн гэм бурууг нотлогдоогүй гэж үзэж байна.



(Фото: haqqin.az)

“Эрүүгийн хэргийн материал, гэрчүүдийн мэдүүлэгт авлигын болон гэмт хэргийн шинжтэй үйлдлийг нотолсон баримт байхгүй байсан” гэж А.Атамбаев мэдэгдсэн талаар Интерфакс агентлагийн мэдээнд дурджээ.

Түүнчлэн, тэрээр Киргиз улсын өмнөх Ерөнхийлөгч асан Курбанбек Бакиевийн төрсөн ах Жаныш Бакиевийг гадаадаас эх оронд нь буцааж авчрах арга хэмжээг 2011 оноос авж байсан тухайгаа мэдэгдсэн байна.

“Эрх баригчдын шийдвэрээр шүүх хурлыг хаалттай зохион байгуулсан, миний нэр төрийг гутаах, ард түмнээс үнэнийг нуун дарагдуулах зорилгоор хэргийн материалыг нууцын зэрэгт оруулсан. Улсын үндэсний аюулгүй байдлын хорооны үйл ажиллагааг дэмжин, гэмт хэрэгтнийг эх орондоо авчиран, шударга шийтгэл

оногдуулахаар явсныхаа төлөө 11 жил хорих ял авлаа” гэж А.Атамбаев бас хэлжээ.

БНХАУ-д төрийн шинжлэх ухааны сэтгүүлийн Ерөнхий редакторт авлигын хэргээр 10 жил хорих ял оногдуулсан байна³⁷²

2020.09.02. Вань Шитун нь төрийн Жэньминь Жибао хэвлэлийн газрын харьяа шинжлэх ухааны The Press сэтгүүлийн Ерөнхий редактораар ажилладаг байжээ.

Түүнийг 900 гаруй өгүүлэл, материал нийтлэхдээ төлбөр авсан хэрэгт буруутгасан бөгөөд тэрбээр 2014-2019 онд нийт 8.24 сая юань (1.2 сая ам.доллар)-ийн хахууль авсан байна. Түүнд 10 жил хорих болон 500 мянган юань (73 мянган ам.доллар)-ийн торгох ял оногдуулжээ.

The Press нь олон нийтэд хуулийн салбарын мэдээ мэдээлэл хүргэх, хууль тогтоомжийн чиглэлийн материал нийтлэх, судалгаа хийх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэвлэлийн байгууллага юм.

³⁷¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://haqqin.az/news/188089>

³⁷² Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://ekd.me/2020/09/novosti-kitaya-utro-borba-s-otmyvaniem-deneg-i-gazoximiya-v-rossii/>

СИАА албан тушаалтнуудыг хахуулийн хэргээр баривчлав³⁷³

2020.10.18. Балба. Эрх мэдлээ урвуулан ашигласан хэргийг шалгах хороо (Commission for the Investigation of Abuse of Authority /СИАА/) Бутвалын³⁷⁴ Цагдаагийн газрын дарга Шива Чандра Сахани болон түүний эхнэр Нирмала Кеват нарыг иргэдээс хахууль авж байх үед нь баривчилжээ.

Тус Хорооны Бутвал дахь салбарын мэдээллийн ажилтан Суреш Бхусалийн ярьснаар Цагдаагийн дарга Шива Чандра Сахани болон түүний гэргий Нирмала Кеват нар иргэдийг батлан даалтад гарахад нь тусласныхаа хариуд хахууль нэхсэн болох нь мөрдөн байцаалтын явцад тогтоогджээ³⁷⁵.

Эрх мэдлээ урвуулан ашигласан хэргийг шалгах хорооны мэдээлснээр Сахани, Кеват нар тухайн иргэдээс 400,000 рупи³⁷⁶ авж байгаад баригдсан байна. Мөн Хороо нь Мургиа³⁷⁷ дахь ойн хэлтсийн байгаль хамгаалагч Прем Чандра Бисвокармаг иргэдээс 12,000 рупийн³⁷⁸ хахууль авж байхад нь баривчилжээ.

Авлигын эсрэг чангатгасан үйл ажиллагааны хүрээнд шилдэг их сургуулийн 30 гаруй албан хаагч шалгагдав³⁷⁹

2020.10.20. БНХАУ их сургуулийн авлигатай тэмцэх үйл ажиллагааг сайжруулах хүрээнд шилдэг их сургуулийн 30 гаруй албан хаагчийг 2020 онд авлигатай холбогдуулан шалгажээ.

БНХАУ-ын Анхуй мужийн Уламжлалт анагаах ухааны их сургуулийн Эрхлэгч асан Ван Жиан 6 тэрбум гаруй юаний хахууль авсан хэргээр 10 жилийн ял авсан байна.

Ван Жиан нь Ёс зүйн төв хорооноос авлигын хэргээр сэжиглэгдэн шалгагдсан их сургуулийн 30 гаруй албан тушаалтны нэг ажээ. Тэдгээрийн 70 гаруй хувь нь сургуулийн Намын нарийн бичгийн дарга болон эрхлэгч албан тушаалтай байсан бөгөөд судлаачид их сургуулийн удирдах албан тушаалтны дунд авлига байгаа нь энэ төрлийн авлигын онцлог шинж чанар гэдгийг дурдав.

Ван Жиан нь инженерийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бизнес эрхлэгчтэй хамтран хэрэгжүүлэх сургуулийн төсөл, хөтөлбөр болон албан хаагчдыг тушаал дэвшихэд нөлөөлж хахууль авсан нь тогтоогдсон байна.

Их сургуулийн авлига нь албан тушаалтан томилох, ажилд авах, оюутан элсүүлэх, шалгалт авахаас гадна судалгаа шинжилгээг санхүүжүүлэх, сургуулийн барилгын дэд бүтэц, ложистикийн асуудал, бусад байгууллагатай хамтран ажиллах хүрээнд ихэвчлэн тархсан талаар Бээжингийн их сургуулийн Төрийн нэгдмэл байдлын Судалгаа шинжилгээний төвийн дэд дарга Жуан Дөшүй мэдээлжээ.

Үүнээс гадна Өвөр Монголын Үндэсний их сургуулийн Намын хорооны дэд дарга асан Шио Жианпин бүс нутгийн барилгын компаниас сургуулийн шинэ барилгын төсөлд дэмжлэг үзүүлэхээр 300 мянган юаний хахууль авсан бөгөөд ажиллаж байх хугацаандаа нийт 2.75 сая юаний хахууль авсан нь илэрч 5 жилийн хорих ял авжээ.

БНХАУ их сургуулийн авлигатай тэмцэх ажлын хүрээнд, Хяналт шалгалтын ажилтанд тусгай өрөө гаргаж өгөх, бүс нутгийн захиргааны удирдлагаас ёс зүйн байцаагч томилох зэргээр ёс зүйн хяналт шалгалт болон хяналт шинжилгээнд шинэчлэл хийж байна.

Тухайлбал, Бээжин хотын 33 их сургуульд 177 ёс зүйн байцаагч томилогдсон нь энэхүү шинэчлэлийн өмнөх үеэс 30 гаруй хувиар өссөн үзүүлэлт юм.

³⁷³ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.peoplesreview.com.np/2020/10/18/ciaa-nabs-officials-for-bribery/>

³⁷⁴ Балбын Лүмбини мужийн Рупандехи дүүргийн томоохон бөгөөд хөгжиж буй хот.

³⁷⁵ <https://english.khabarhub.com/2020/16/135723/>

³⁷⁶ Монголбанкны 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ханшаар тооцвол 9,728,000 төгрөг болно.

³⁷⁷ Балбын Рупандехи дүүргийн нэгэн тосгон.

³⁷⁸ Монголбанкны 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ханшаар тооцвол 291,840 төгрөг болно.

³⁷⁹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.globaltimes.cn/content/1204004.shtml>

Их сургуулийн авлигаас гадна БНХАУ-ын авлигын эсрэг тэмцэл нь бусад салбарт ч мөн адил эрчимтэй хэрэгжиж байна. Засгийн газрын зургаан өндөр албан тушаалтныг өмнөх долоо хоногт ёс зүйн зөрчилтэй холбогдуулан шалгажээ.

Киргизийн Гаалийн албаны дэд дарга асан Матраймовыг авлигын хэрэгт холбогдуулан баривчилжээ³⁸⁰

2020.10.20. Сэтгүүлчдийн төвлөрсөн шалгалтын үр дүнд хэдэн зуун сая ам.доллар улсаас гаргасан авлигын сүлжээг илрүүлж, Гаалийн албаны дэд дарга асан Раймбек Матраймовыг баривчилжээ.

Киргизийн Үндэсний аюулгүй байдлын улсын хороо (ҮАБУХ) Матраймовыг 2020 оны 10 дугаар сарын 20-ны өдөр баривчилсан талаар мэдэгдсэн байна.

ҮАБУХ-ны шинээр томилогдсон удирдлага Матраймов болон түүний хамтрагчдын улсын сан хөмрөгт их хэмжээний хохирол учруулсан үйлдлийг шалгаж байгаа талаар 10 дугаар сарын 17-ны өдөр мэдэгдэж байсан юм.

RFE/RL's Киргиз болон Клоор мэдээний цахим хуудас хамтран Матраймовт төвлөрсөн шалгалт хийсний үр дүнд, 2019 оны 11 дүгээр сард Истанбул хотноо бусдад хорлогдсон Уйгар бизнес эрхлэгч Аиеркен Саймайтигаар дамжуулан улсаас мөнгө гаргасан авлигын сүлжээг илрүүлжээ.

Саймайти нь бусдад хорлогдохоосоо өмнө Киргиз улсаас хэрхэн мөнгө гаргаж байсан талаар санхүүгийн тайланг сэтгүүлчдэд гаргаж өгсөн.

Матраймов болон түүний гэр бүлийн гишүүд Саймайтитэй ямар нэгэн холбоогүй бөгөөд Гаалийн албанд холбогдох ямарваа авлигад хамааралгүй хэмээн гомдол гаргажээ.

Одиша мужийн засгийн газрын гүйцэтгэх инженерийн туслах 48 орон сууцтай байжээ³⁸¹

2020.10.22. Энэтхэг. Бхубанесвар³⁸². Одиша мужийн Цагдаагийн газрын авлигын хэргийн мөрдөгчид нэгэн инженерийн туслах 48 орон сууц зэрэг 6.53 крор³⁸³ рупи³⁸⁴-гээр хэмжигдэх хөрөнгөтэй байсныг илрүүлэн, лхагва гарагт баривчилжээ.

Мөрдөгчид мягмар гарагт инженерийн туслах Рабиндра Нат Прадханыг орлогынхоо эх үүсвэртэй үл дүйцэх хөрөнгийг олж авсан гэх үндэслэлээр Бхубанешвар болон бусад газрууд дахь түүний эд хөрөнгөд нэгэн зэрэг нэгжлэг хийсэн юм.

Прадханы өмчлөлд хоёр давхар байшин 2 ширхэг, нэг өрөө хувийн орон сууц 1 ширхэг, найман газар, дөрвөн дугуйт 2 ширхэг, янз бүрийн банканд дахь хадгаламж, даатгалын гэрээнд оруулсан хөрөнгө оруулалт, алт, мөнгөн эдлэл, бэлэн мөнгө, ахуйн эд зүйл ч мөн байжээ. “Ингээд Бхубанешварын GPH (General Public Health) II албаны гүйцэтгэх инженерийн туслах Рабиндра Нат Прадхан болон түүний гэр бүлийн гишүүдийн нийт хөрөнгийг 65,386,710 рупи гэж тооцсон болно” хэмээн Цагдаагийн газрын Авлигатай тэмцэх албанаас мэдээлжээ.

Албан тушаалтны хэлснээр түүний хүү гурван компанийн захирлаар ажилладаг гэж бүртгэгдсэн байсан ба эдгээрийн хоёр нь үл хөдлөх хөрөнгө, барилгын чиглэлээр, гурав дахь нь хүнс боловсруулалт, хадгалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж. Мөн түүний хүү хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг түншлэлийн компанитай байжээ.

³⁸⁰ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.timesca.com/index.php/news/23050-kyrgyzstan-former-deputy-customs-chief-matrainov-detained-on-corruption-charges>

³⁸¹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.news18.com/news/india/odisha-govt-assistant-executive-engineer-owns-48-one-bedroom-flats-police-2991761.html>

³⁸² Энэтхэгийн Одиша мужийн нийслэл бөгөөд хамгийн том хот(Bhubaneswar).

³⁸³ Энэтхэгийн тооллын системд арван сая(10,000,000 буюу 10⁷)-ыг крор гэдэг. 1 крор нь 100 лактай тэнцүү. Харин 1 лак нь 100,000-тай тэнцүү. Өөрөөр хэлбэл, монгол тооллын бум(100,000), живаа(10,000,000)-тай ижил тоон утгатай юм.

³⁸⁴ 6.53 крор нь 65,300,000-тай тэнцүү бөгөөд 2020 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн Монголбанкны ханшаар тооцвол 2,531,681,000 төгрөгтэй тэнцэнэ.

Прадханыг Бхубанешварын Тусгай шүүхэд хүргэсэн бөгөөд түүнийг 11 дүгээр сарын 03-ны өдрийг хүртэл цагдан хорьж, батлан даалтад гарах хүсэлтэд нь татгалзсан хариу өгчээ.

Одиша хотын Цагдаагийн газрын Авлигатай тэмцэх албаны ажилтан Радхакришна хэлэхдээ “Ийм их хэмжээний үл хөдлөх хөрөнгө эзэмшиж байсан төрийн албан хаагчтай хэзээ ч таарч байсангүй” гэжээ.

Төрийн 21 албан хаагч авлигын гэмт хэрэгт холбогдон ял авахаар боллоо³⁸⁵

2020.10.26. Афганистаны төрийн 21 албан хаагчтай холбоотой авлигын хэрэг шүүхэд шилжсэний дараа ял авах нь тодорхой болжээ.

Херат хотын Захирагч Абдул Вахид Катали, Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Абдул Хаким Тамана, бүс нутгийн зөвлөлийн гурван гишүүнээс гадна хэрэгт холбогдсон бусад төрийн албан хаагчийн хэргийг Тусгай Прокурорын албанаас шүүхэд шилжүүлжээ.

Эдгээр албан хаагчид нь Афганистаны КОВИД-19 цар тахалтай тэмцэх ажиллагаанаас мөнгө завшсан хэргээр шалгагдаж, онц ноцтой авлигын хэрэг үйлдсэн тул прокуророос шүүхэд шилжүүлсэн байна.

Тус албан хаагчид нь 20 сая афгани буюу 260 гаруй мянган ам.долларыг КОВИД-19 цар тахалтай тэмцэх хөтөлбөрийн төсвөөс завшсан бөгөөд Тусгай Прокурорын албанаас мөрдөн шалгалт хийсний үр дүнд ял оногдуулахаар шүүхэд шилжүүлсэн талаар Ерөнхий Прокурорын газрын Хэвлэлийн төлөөлөгч Жамшид Расули мэдээлэв.

Мөн өмнө нь Ерөнхийлөгчийн мөрдөн шалгах агентлагаас төрийн албанд ажилладаг болон ажлаас гарсан 44 иргэнийг авлига, КОВИД-19 цар тахалтай тэмцэх хөтөлбөрийн төсвөөс хөрөнгө завшсан хэрэгтэй холбогдуулан Ерөнхий Прокурорын газарт ханджээ.

Улсын хөрөнгийг хувьдаа завшсан хэргээр Хорватын Ерөнхий сайд асанд 8 жилийн хорих ял оноолоо³⁸⁶



2020.11.13. Өнгөрсөн баасан гарагт Хорват улсын шүүх Ерөнхий сайд асан (2003-2009 онд) Иво

³⁸⁵ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.khaama.com/special-prosecutor-office-introduces-21-corrupt-officials-to-attorney-general-8787699/>

³⁸⁶ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.dw.com/en/croatia-former-pm-sanader-found-guilty-of-corruption-again-sentenced-to-8-more-years/a-55595471>

Санадэрыг зар сурталчилгааны компанийг ашиглан улсын хөрөнгө хувьдаа завшсан гэх үндэслэлээр 8 жилийн хорих ял оноосон байна.

Тэрээр улсын хөрөнгийг хувьдаа завшиж, Ардчилсан холбоог санхүүжүүлэхээс гадна хууль бус хандив авсан, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулсан хэрэгт шалгагдан шийтгэгджээ. Дээрх хэрэгт Ардчилсан холбоог гэм буруутай гэж үзэн 3.5 куна (460-540 мянган евро)-гаар торгосон байна.

Хятад улс оргон зугтсан 7,831 иргэнийг буцаан авчирлаа³⁸⁷

2020.11.16. БНХАУ-ын авлигатай тэмцэх байгууллагаас 2014-2020 онд авлигын хэрэгт шалгагдаж байх хугацаандаа гадаад улс руу оргон зугтсан 7,831 иргэнийг эх оронд нь буцаан авчирсан байна.

Эрх бүхий байгууллагын мэдээлж байгаагаар, 120 улс орноос дээрх иргэдийг авчирсан ба эдгээр хүмүүс дунд Хятадын Коммунист намын гишүүн бөгөөд төрийн албан хаагч 2,075 хүн байжээ.

Тус улсаас Олон улсын цагдаагийн байгууллага-Интерполын улаан мэдэгдэлд 348 хүнийг бүртгүүлэн зарлуулсан байна.

Мөн энэ хугацаанд 3 тэрбум орчим ам.долларыг хураан авах замаар эргүүлэн авчирч чаджээ.

Тайландын Аялал жуулчлалын газрын дарга асанд 50 жилийн хорих ял оноолоо³⁸⁸

2020.11.16. Өнгөрсөн даваа гарагт Тайландын Аялал жуулчлалын газрын даргаар ажиллаж байсан Жутамас Сириван 2000-аад оны эхээр зохион байгуулагдсан олон улсын кино фестивалийн зохион байгуулагчдаас хахууль авсан хэрэгтээ 50 жилийн хорих ялаар шийтгүүлээ.

Доод шатны шүүхээс түүнийг үгсэн хуйвалдсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, хахууль авсан зэрэг 11 үйлдэлд гэм буруутай гэж үзэн оноогоод байсан ялыг ийнхүү Дээд шүүхээс хэвээр үлдээжээ.

Түүний хэргийг шалгах үйл ажиллагаанд АНУ-ын ХМТ болон Хууль зүйн яам хамтран оролцсон юм.

БНХАУ-ын авлигатай тэмцэх байгууллагаас АНУ-ыг авлигын гэмт хэрэгтэй тэмцэхийг уриалжээ³⁸⁹

2020.11.18. Хятадын авлигатай тэмцэх байгууллагаас тус улсын засгийн газрыг АНУ-д амьдарч буй тэрс үзэлтнүүдийг намнаж байна гэсэн гүтгэлгийг няцаажээ.

АНУ-ын сүүлийн үед хэрэгжүүлж буй арга хэмжээ нь БНХАУ-ын эсрэг улс төрийн зорилготой бөгөөд авлигатай тэмцэх, оргодлыг олж илрүүлэх, алдагдсан хөрөнгийг эргүүлэн авах Хятадын үйл ажиллагаанд саад учруулах зорилготой байгаа талаар тус улсын Үндэсний хяналтын хорооны цахим хуудсанд 11 дүгээр сарын 18-ний өдөр мэдэгдэв.

Шү Жин болон түүний эхнэр Лиу Фан нар нь авлигын хэрэгт холбогдон эрэн сурвалжлагдаж буй хэрэгтнүүд юм. Тэд 2011 онд хуурамч бичиг баримт ашиглан АНУ-руу зугтсан талаар мөн энэхүү мэдэгдэлд тусгажээ.

Америк Хятадын хооронд ялтан шилжүүлэх гэрээ байгуулагдаагүй тул гадаад улсыг төлөөлж тодорхой албан тушаалтан Америкийн Ерөнхий прокурорын газарт бүртгүүлж, мэдэгдэх

³⁸⁷ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: http://www.china.org.cn/china/2020-11/16/content_76913735.htm

³⁸⁸ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.khaosodenglish.com/news/crimecourtscalamity/2020/11/16/former-tourism-chief-gets-50-years-in-jail-for-bribery/>

³⁸⁹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://news.cgtn.com/news/2020-11-18/Chinese-officials-slam-U-S-political-manipulations--VwGAhZOKCQ/index.html>

шаардлагатай байдаг байна. Иймд АНУ авлигач албан тушаалтнуудын зугтах дуртай улсын нэг болдог талаар Хятадын авлигатай тэмцэх байгууллагаас мэдээлжээ.

Үндэсний хяналтын хороо нь 2018 онд байгуулагдсан бөгөөд Хятадын Коммунист намын Ёс зүйн төв хороотой хариуцлага, зохион байгуулалтын хувьд нэгдмэл байдлаар ажилладаг байна. Тус хорооноос 11 дүгээр сарын 09-ний өдөр Хятад улс авлигын эсрэг олон улсын хамтын ажиллагааг идэвхтэй сурталчилж, дэлхийн өнцөг булан бүрээс оргодол, алдагдсан хөрөнгийг олж илрүүлж буй талаар мэдэгджээ.

2014 оноос 2020 оны 06 дугаар сарын хооронд 120 гаруй улсаас 7,831 оргодлыг баривчилж, Хятад улсад эргүүлэн авчирч, 3 тэрбум гаруй ам.долларын хууль бус хөрөнгийг хураасан байна. 11 дүгээр сарын 11-ний өдөр холбогдох байгууллагаас Хятад улс нь оргодол шилжүүлэх, шүүхийн туслалцаа үзүүлэх, хөрөнгө буцаан авах зэрэг хэлэлцээрийг нийт 81 улстай байгуулсан талаар мэдэгдэв.

Шү Жин нь Хубэй мужийн Ухань хотын Хөгжил, шинэтгэлийн хорооны даргаар ажиллаж байжээ. Тэрээр өөрийн эрх мэдлийг урвуулан ашигласан, мөн хахуулийн хэрэгт сэжиглэгдэж байгаа юм. Хятадын засгийн газрын мэдээлснээр 2010 онд Шү Жин нь хуурамч бичиг баримт ашиглаж АНУ-ын ногоон карт авсан бөгөөд 2011 онд эхнэрийн хамт зугтсан байна. Түүний эхнэр Лиу Фан нь Чайна Лайф Даатгал корпорацын Хубэй муж дэх салбарын дэд захирлаар ажиллаж байсан ба мөн адил авлигын гэмт хэрэгт сэжиглэгдэж байна.

2012 оноос хойш Хятадын эрх баригчид АНУ-ын талд эрүүгийн шүүхийн туслалцаа хүссэн гурван хүсэлт гаргаж, Шү Жин, Лиу Фан нарын сэжиглэгдэж буй авлигын гэмт хэргийн мэдээлэл, нотлох баримтаас гадна хууль бус мөнгө шилжүүлсэн үйлдэл болон цагаачлалын бичиг баримт хуурамчаар үйлдсэн байж болзошгүй үйлдлийн талаар мэдээлэл хүргүүлсэн байна. Гэвч АНУ-ын тал шаардлагатай дэмжлэг үзүүлээгүй талаар мэдэгдэлд тусгажээ.

АНУ нь хэдийгээр энэхүү гэр бүлийн үйлдсэн гэмт хэргийн талаар бүрэн мэдээлэлтэй байгаа боловч Хятад улсыг “тэрс үзэлтэн” намнаж байна хэмээн буруутгаж байна. Мөн одоогоор 20 оргодол АНУ-д орогнож байгаа бөгөөд АНУ-ыг олон улсын өмнө хүлээсэн үүргээ ухамсарлаж амлалтаа биелүүлэхийг уриалж байгаа талаар нэмж мэдэгджээ.

Киргиз улсын халамж, татварын байгууллагын албан хаагчид оролцсон авлигын сүлжээг илрүүлсэн байна³⁹⁰

2020.11.27. Киргиз улсын нийгмийн халамжийн болон татварын байгууллагын албан тушаалтнууд оролцсон авлигын сүлжээг тус улсын санхүүгийн цагдаагийнхан илрүүлээд байна. Энэхүү хууль бус бүлэглэлийн үйл ажиллагааны уршгаар улсын төсөвт 112 сая ам.долларын хохирол учирчээ.

Хэрэгт холбогдсон хүмүүс хувьдаа ашиг хонжоо олох зорилгоор алт олборлогч компанид давуу байдал олгосон нь Киргиз улсын Эрүүгийн хуулийн 319 дүгээр зүйлд заасан хахуулийн гэмт хэрэгт тооцогдож байгаа тул Гэмт хэрэг, зөрчлийн нэгдсэн бүртгэлд оруулан бүртгэсэн гэдгийг хэвлэлийн албанаас мэдээлжээ.

2 сая ам.долларын хахууль авсан хоёр этгээдийн хорих ялын хэмжээг шүүхээс бууруулж 201 мянган ам.долларын торгууль ногдуулжээ³⁹¹

2020.12.03. Сингапур. Анхан шатны шүүхээс Япон улсын хоёр иргэнд 5.6 жилийн хорих болон 200,944 ам.долларын торгуулийн ял оногдуулаад байсныг 12 дугаар сарын 02-ны өдөр болсон хяналтын шатны шүүхээс өөрчилсөн байна. Кагутоши Ишибэ (55 настай) болон Такааки Масуй (57 настай) нарт 3 жил, 7 сар, гурван долоо хоногийн хорих болон торгуулийн ял оногдуулахаар

³⁹⁰ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://tj.sputniknews.ru/asia/20201027/1032155406/Kyrgyzstan-korrupsionnaya-skhema-112-millionov-dollarov.html>

³⁹¹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.straitstimes.com/singapore/courts-crime/court-cuts-jail-term-for-duo-who-extracted-2m-in-bribes-imposes-nearly-201000>

болсон байна. Хоёр япон иргэнийг хахуульд авсан мөнгөний хэмжээгээр буюу 1 сая ам.долларын торгууль тус бүрдээ төлөхийг шаардсан байна.



Кацүтоши Ишибе (зүүн талд), Такааки Масуй нарт тус бүр нэг сая долларын торгууль төлөхийг үүрэг болгов. (Фото: ST FILE)

Торгуулийг төлөхгүй бол хорих ялын хэмжээ нэмэгдэхийг тэдэнд анхааруулсан байна. “Сингапурын хувийн салбар дахь хамгийн жигшүүртэй хэрэг” хэмээн 199 хуудас бүхий ялын тогтоолыг танилцуулахдаа шүүгч Чан Сенг Онн онцлов.

Масуй болон Ишибэ нарыг Сингапур улсын иргэн Ко Пи Чангаас 2004-2007 онд хахууль авсан хэргийг 28 зүйлээр зүйлчлэн анхан шатны шүүхийн шийдвэрийг 2018 онд гаргасан юм.

Дээрх хоёр иргэн Нишо Ивай корпорацийн (Nissho Iwai Corporation) Сингапур дахь салбарт томилогдон ажиллаж байсан юм.

Узбекистан улсын Ерөнхийлөгч асны охины хөрөнгийг царцаасан шийдвэрийг цуцлахаар болов³⁹²

2020.12.03. Узбекистан улсын Ерөнхийлөгч асан Каримовын охин Гулнара Каримовагийн 350 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг царцаасан шийдвэрийг цуцлах тухай шийдвэрийг Швейцарийн шүүх гаргав.

Бараг 1 тэрбум ам.долларын авлигын хэрэгтэй холбоотой 2018 оны шүүхийн тогтоолоор 350 сая ам.долларын хөрөнгийг царцаасан байсныг Холбооны хяналтын шатны шүүх авж хэлэлцээд нэхэмжлэгчийн гаргасан нэмэмжлэлийн дагуу Гибралтар дахь Такилант ХХК-ийг хууль ёсны ашиг хүртэгч нь мөн гэж шийдвэрлэсэн байна.

Энэ хэрэг 2012 оноос эхтэй юм. Каримова болон хэд хэдэн узбек иргэний мөнгө угаах, хахуулийн хэрэгтэй холбоотой ихээхэн хэмжээний мөнгө Швейцарийн банканд төвлөрсөн юм. 2013 оноос Каримоваг шалгаж эхэлсэн. “Швейцарийн прокуроруудад энэхүү 350 сая ам.доллар хууль бусаар олсон гэдгийг нотлох баримт байхгүй” хэмээн Каримовагийн өмгөөлөгч Мангеат мэдэгдэж байв.

Энэхүү шийдвэр Узбекистан улсад бус, харин Каримовад мөнгөө буцаан авахад хэрэгтэй том ялалт буюу эрх зүйн хамгаалалт юм. Өнгөрсөн есдүгээр сард Швейцарийн прокурорын байгууллагаас Узбекистан улсад 131 сая швейцари франк (146 сая ам.доллар) төлөхийг зөвшөөрсөн юм. Энэ нь тус хэргийн холбогдогч өөр нэг хүнтэй холбоотой бөгөөд тус улсын хэд хэдэн банканд ойролцоогоор 650 сая швейцари франк царцагдсан байгаа юм.

Каримова 6 жилийн турш ямар нэгэн эрх зүйн туслалцаа авах боломжгүй, гэр бүлийнхэнтэйгээ уулзахгүй, хорионд байгаа юм хэмээн түүний өмгөөлөгч Мангеат онцолсон юм. Ийм байдалд байлгаж байгаа нь түүнийг үндсэн эрх, эрх чөлөөгөө эдлэх эрхийг нь хязгаарлах шалтгаан болохгүй хэмээн тэрээр нэмж мэдэгдсэн.

Энэ оны гуравдугаар сард Узбекистаны Дээд шүүх Гулнараг мөнгө угаасан хэрэгт буруутайд тооцон 13 жилийн хорих ял оноогоод байсан юм.

Төв азиас БНХАУ руу баригдаж буй хийн хоолой барих ажлаас хэдэн арван саяар тоологдох мөнгө завшсан байна³⁹³

2020.12.03. Казахстан улсын Ерөнхийлөгч асан Назарбаевын хүргэн Тимур Кулибаев хийн хоолой барих төслөөс мөнгө завшсан асуудлыг Financial Times сонин мэдээлжээ. Кудибаев нь Казахстаны хамгийн баян бөгөөд нөлөө бүхий хүмүүсийн нэг юм.

³⁹² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/economy/2020/12/3/bbdaughter-of-late-uzbek-president-gets-shot-at-frozen-fortune>

³⁹³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://rus.azattyk.org/a/30982211.html>

“Клептокопия: хэрхэн “бохир мөнгө” дэлхийг эзэлж буй тухай” номд Казахстан дахь авлигын асуудлыг хөндсөн байна. Мөн 2004-2014 онд цахим харилцааны алдагдсан мэдээлэлд үндэслэн хэрхэн Кулибаев ЕТК компаниар дамжуулан мөнгө завшсан асуудлыг гаргасан байна. Тус номыг Бержес бичсэн байна.

Файнэншл таймс сонины мэдээлж буйгаар ЕТК компани нь Украин болон ОХУ-ын үйлдвэрүүдэд ган нийлүүлэн, хэт өндөр үнээр хоолой худалдан авсан байна. БНХАУ-ын Жиансу Шанганг компаниас нэг тонныг 935 ам.доллараар авж, оросын үйлдвэрт нийлүүлэхдээ нэг тонныг нь 1,500 ам.доллараар нийлүүлж байсныг номд дурджээ. Энэхүү схемийн үр дүнд ЕТК компани 75 сая ам.доллар олсон байна.

Файнэншл таймс сонины онцолсноор энэхүү мөнгөний ихэнх хэсгийг ЕТК-ийг тэргүүлэгч, оросын бизнес эрхлэгч Александр Карманов бус, харин Тимур Кулибаев авж байсан байна.

Энэхүү схемийн үр дүнд ашгийн 70 хувийг буюу 53 сая ам.долларыг Кулибаев авах ёстой байсан талаар нийтлэлд дурджээ. ЕТК-ийн удирдлагад Кулибаев өөрийн итгэмжлэгдсэн хүнийг оруулах тухай цахим захидлууддаа дурдсан байсан ба 2012 оны 12 дугаар сард ЕТК-ийн хувь нийлүүлэгчдийн эгнээнд Казахстаны бизнес эрхлэгч Мурат Балапанов орж ирсэн ба улмаар тус компанийн ерөнхийлөгч болсон байна.

Дээрх асуудлуудыг Назарбаевын ач хүү Айсултан Назарбаев нас нөгчихөөсөө өмнө “ОХУ болон Казахстан улсын хоорондох өргөн хүрээний авлигын асуудал” хэмээн өөрийн фэйсбүүк хуудсанд нийтэлж байжээ. Айсултан Назарбаев 2020 оны наймдугаар сард Лондон хотноо нас барсан байдалтай олдсон юм. Задлан шинжилгээний хариу кокаин хэтрүүлэн хэрэглэсэн гэж гарч байжээ.

Индонезийн сайдыг цар тахлын үеийн тусламжтай холбоотой авлигын хэргээр баривчиллаа³⁹⁴

2020.12.06. Индонез улсын Нийгмийн асуудал эрхэлсэн сайд Жулиар Батубараг коронавирусний цар тахлын гамшигт нэрвэгдсэн хүмүүст үзүүлэх хүнсний тусламжаас 1.2 сая доллар завшсан гэх үндэслэлээр өнгөрсөн ням гарагт баривчиллаа.

Тус улсын авлигатай тэмцэх байгууллагын ажилтнууд бямба гарагт явуулсан тусгай ажиллагааныхаа үеэр 1.2 сая доллартой тэнцэх хэмжээний бэлэн мөнгөтэй чемодан, үүргэвч, дугтуй зэргийг хураан авжээ.

Тэрбээр ням гарагт авлигатай тэмцэх байгууллагад хэргээ хүлээснээр сүүлийн хэдэн долоо хоногт Ерөнхийлөгч Жожо Видодогийн засгийн газрын гишүүдээс баривчлагдаж байгаа хоёр дахь сайд болж байгаа юм.

“Энэ бол ард түмний мөнгө... КОВИД-19 цар тахалтай үед хэрэгтэй, бас үндэсний эдийн засгийг сэргээхэд шаардлагатай тусламж юм” гэж Жулиар Батубараг баривчлагдсаны дараа Ерөнхийлөгч Жожо Видодо хэлээд авлигачдыг хамгаалахгүй гэдгээ мэдэгдсэн.

Зүүн өмнөд Азийн бүс нутагтаа хамгийн томд тооцогддог Индонезийн эдийн засаг цар тахлын үед хамгийн ихээр хүндэрсэн бөгөөд засгийн газраас тусламж нэн хэрэгцээтэй иргэдэд хүртээх хүнсний багц зэрэг тусламжийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн юм.

Батубараг дээрх тусламжийн хөтөлбөртэй холбоотой хахуулийн хэрэгт оролцсон хэрэгт буруутгаж буй юм.

Тэрээр цар тахалд нэрвэгдсэн иргэдэд хүргэх хүнсний багцыг нийлүүлэх гэрээ байгуулсан хоёр талаас 1 сая гаруй доллар авсан бөгөөд багц бүрээс 0.71 доллар авахаар тохиролцсон талаар албаны хүмүүс мэдээлсэн.

Гэм буруутай нь тогтоогдвол түүнд 20 жилийн хорих ял, 70 мянган долларын торгууль ногдуулж магадгүй юм.

³⁹⁴ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.france24.com/en/live-news/20201206-indonesia-minister-arrested-over-pandemic-aid-corruption>

Ин Ли группийн гүйцэтгэх захирлыг
хахуулийн хэрэгт холбогдуулж
саатууллаа³⁹⁵

2020.12.07. Олон улсын үл хөдлөх хөрөнгийн Ин Ли группийн Ерөнхий гүйцэтгэх захирал Ху Бинийг Бээжин хотын эрх бүхий байгууллага хажуулийн хэрэгт сэжиглэн саатуулсан байна.

Тус компанийн хуулийн зөвлөх Бээжин хотын Олон нийтийн аюулгүй байдлын хорооноос мөрдөн байцаалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл авж, тодруулах болно гэжээ.

Энэ асуудал нь компанийн өдөр тутмын үйл ажиллагаатай холбоогүй бөгөөд компанийн хэвийн үйл ажиллагаанд нөлөөлөх ёсгүй гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс мэдэгджээ.

12 дугаар сарын 07-ны өдрийн байдлаар мөрдөн шалгах ажиллагаа үргэлжилж явагдах бөгөөд ноён Ху-г гүйцэтгэх захирлын албан тушаалаас нь чөлөөлж, удирдах хорооноос өөр хүн нэр дэвшүүлэх юм байна.

Одоогоор компанийн хараат бус захирал Ян Хайшан гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэх болно хэмээн ТУЗ-өөс мэдээлжээ.

Дээрх үйл явдалтай холбоотойгоор даваа гаргийн өглөө тус группийн хувьцаа 0.6-0.7 хувиар унасан байна.

Саудын Араб авлигатай хатуу тэмцэж
байна³⁹⁶

2020.12.13. Саудын Араб даяар авлигын эсрэг томоохон кампанит ажил өрнүүлж эхэлжээ. 120 хэрэгт мөрдлөг явуулж эхэлсэн талаар Саудын Арабын Авлигатай тэмцэх хорооны албан ёсны эх сурвалж мэдэгдэв.

Томоохон хэргүүдээс дурдвал:

1. Орон нутгийн захиргааны албан тушаалтан арилжааны хэд хэдэн байгууллагад хууль бусаар 110,006,545 риал (ойролцоогоор 29,328,820 ам.доллар) олгосон. Одоогоор 38,378,411 риал (ойролцоогоор 10,232,059 ам.доллар)-ыг нөхөн төлүүлсэн бөгөөд үлдсэн мөнгийг төлүүлэхээр ажиллаж байна.
2. Мужийн Худалдааны танхимын захирлуудын зөвлөлийн даргыг танхимын данснаас 8,000,000 риал (ойролцоогоор 2,132,878 ам.доллар)-ыг шилжүүлж, уг мөнгийг иргэний санхүүгийн нэхэмжлэлийн төлбөрийг төлөх зорилгоор гүйцэтгэх шүүхэд чек гаргаж өгсөн хэрэгт буруутган үүрэгт ажлаас нь чөлөөлжээ.
3. Иргэний хамгаалалтын ерөнхий газрын ажилтан болон аюулгүй байдлын компанид ажиллаж байсан араб хүмүүсийг баривчилсан. Тус албан хаагчид цагаачлан амьдардаг иргэний нэрийг ашиглан аюулгүй байдлын компани байгуулсан бөгөөд тэд аюулгүй байдлын лиценз авахыг хүссэн компаниудад хүндрэл учруулж, өөрсдийн компанитай гэрээ байгуулахыг шаардаж байжээ. Тэднийг 5,948,572 риал (ойролцоогоор 1,585,947 ам.доллар) залилан мэхэлж цуглуулсан гэж үзэж байна.
4. Дотоод хэргийн яаманд ажилладаг нэгэн дэд хурандаа шаардлагатай тусгай зөвшөөрлийг авахад нь туслалцаа үзүүлэхээр нэгэн компанийн эзнээс 2,000,000 риал (ойролцоогоор 533,219 ам.доллар) авсан гэх хэргээр баривчлагдсан байна.
5. Замын хөдөлгөөний ерөнхий газарт ажилладаг 3 албан хаагч, өмнө нь даатгалын газарт ажиллаж байсан 6 ажилтан болон 5 иргэнийг хуурамч зам тээврийн осол зохиож, даатгалын компаниас 1,918,167 риал (ойролцоогоор 511,402 ам.доллар)-ын нөхөн төлбөрийг залилан авсан гэх үндэслэлээр ажлаас нь чөлөөлжээ.

³⁹⁵ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.business-times.com.sg/companies-markets/ying-li-group-ceo-detained-in-china-in-bribery-probe>

³⁹⁶ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://gulfnews.com/world/gulf/saudi/saudi-arabia-cracks-down-on-corruption-1.75865946>

6. Ази гаралтай 3 эрэгтэй гаалийн байгууллагад хураалгасан эд зүйлсээ буцаан авахын тулд 1,590,000 риал (ойролцоогоор 157,299 ам.доллар)-ын хахууль өгөхийг санал болгосон хэргээр баривчлагджээ.
7. Нотариатын ажилтныг 33 итгэмжлэлийг хууль бусаар олгосон гэх үндэслэлээр түдгэлзүүлж, түүний эсрэг гомдол гаргаагүйнх нь хариуд эдгээр итгэмжлэлийг авсан хүмүүсийн нэгэнд 1,500,000 риал (ойролцоогоор 399,914 ам.доллар)-ын хахууль санал болгосон.
8. Мужийн Эрүүл мэндийн газрын орлогч дарга болон түүний ажилтан нар орлогч даргын хадам эхийн эзэмшлийн компаниаар 204,000 риал (ойролцоогоор 54,388 ам.доллар)-ыг зарцуулах эрх бүхий гэрээ байгуулсан, тухайн компанийн гүйцэтгээгүй ажлыг гүйцэтгэсэн болгож буруу мэдээлэл оруулсан, албан ёсны бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн гэх үндэслэлээр баривчлагджээ.
9. Мужийн Хар тамхитай тэмцэх ерөнхий газрын ажилтан хилийн хориг тавигдсан иргэний хоригийг цуцалж өгөхийг амлан 5,000 риал (ойролцоогоор 1,333 ам.доллар) авсан гэх үндэслэлээр баривчлагджээ.

Тайпэй хотын зөвлөлийн гишүүн асан авлигын хэрэгт холбогдож 7.5 жилийн хорих ял сонслоо³⁹⁷

2020.12.23. Тайпэй хотын зөвлөлийн гишүүн асан Лай Су-Жуг 2013 онд авлигын хэргээр ялласан шийдвэрийг лхагва гарагт Дээд шүүх хэвээр үлдээлээ.

Дээд шүүхээс Лай Су-Жугийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгож, доод шатны шүүхээс шийдвэрлэсэн хорих ялыг хэвээр үлдээж, гэмт хэргийн замаар олсон 35,460 ам.долларыг түүнээс мөн хураан авсан байна.

2013 онд Тайпэйн прокурорын газраас Лай Су-Жуг яллагдагчаар татсан бөгөөд 2014 онд Тайпэйн дүүргийн шүүхээс түүнийг Тайпэй хотын төмөр замын буудлын ойролцоох газарт Тайпэй ихэр цамхаг барих төслийг шалгах явцад давуу байдал олгож, Тайпэй Гэйтвэй Интернэшнл корпорацаар удирдуулсан бүлэглэлээс хахууль авсан гэмт хэрэгт гэм буруутайд тооцсон юм.

Лай Су-Жу нь тухайн үед хотын зөвлөлийн гишүүний хувьд Тайпэй хотын Шуурхай тээврийн системийн газраас хэрэгжүүлж буй хөгжлийн төслийг хянах үйл ажиллагааг хэрэгжүүлж байжээ. Шүүхээс Лай Су-Жуг 1 сая тайвань долларын хахууль авсан хэрэгт гэм буруутайд тооцож ял оноосон байна.

Дүүргийн шүүхээс түүнд 10 жилийн хорих ял оноосон боловч Лай Су-Жу шүүхийн шийдвэрийг эсэргүүцэн давж заалдсан бөгөөд давж заалдах шатны шүүхээс түүнд 9 жилийн хорих ялыг 2016 онд оногдуулжээ. Гэвч Лай Су-Жу Дээд шүүхэд гомдол гаргаснаар түүний хорих ял 7.5 жил болж буурсан байна.

Лай Су-Жу өмнө нь үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн, гэмт хэргийн үйл ажиллагаанаас олсон орлогыг нуун дарагдуулсан гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байсан боловч гэм буруутай нь нотлогдоогүй байна.

Пакистаны авлигатай тэмцэх байгууллага сөрөг хүчний удирдагчийг баривчлав³⁹⁸

2020.12.30. Пакистаны авлигатай тэмцэх байгууллага тус улсын сөрөг хүчний удирдагчийг өөрийн орлогын эх үүсвэрээс илүү хэмжээний хөрөнгө, орлоготой байсан гэсэн үндэслэлээр 2020 оны 12 дугаар сарын 29-ний өдөр баривчилсан байна.

Тус улсын улс төрийн сөрөг хүчний зүгээс Ерөнхий Сайд Имран Ханыг 01 дүгээр сарын 31-ний өдрөөс өмнө албан тушаалаас огцор, эсхүл, нийслэл Исламабад хотод урт хугацааны

³⁹⁷ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://focustaiwan.tw/society/202012230018>

³⁹⁸ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/12/30/pakistan-anti-corruption-body-arrests-key-opposition-leader>

эсэргүүцлийн жагсаалтай нүүр тулах болно хэмээн шаардсаны дараагаар Гадаад харилцааны сайд асан Хаважа Асифыг баривчилжээ.

Улс төрийн сөрөг хүчний намууд Ерөнхий сайд Имран Ханыг улс орны эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулж чадаагүй хэмээн албан тушаалаас огцрохыг шаардаж орон даяар жагсаал зохион байгуулсаар байгаа юм.

Гадаад харилцааны сайд асан Хаважа Асифыг мэдэгдэж буй орлогын эх үүсвэрээс илүү хэмжээний хөрөнгө, орлоготой хэмээн баривчилсан талаар Үндэсний хариуцлагын товчооны хэвлэлийн төлөөлөгч Навазиш Али мэдэгджээ.

Хаважа Асиф нь одоогоор Лондон хотод амьдарч буй Ерөнхий сайд асан Наваз Шарифын даргалдаг Пакистаны Лалын лигийн намын удирдагчдын нэг бөгөөд Ерөнхий сайд Имран Ханы үйл ажиллагааг ихээхэн шүүмжилдэг байжээ. Ерөнхий сайд асан Наваз Шариф авлигын гэмт хэрэгт холбогдож, эх орондоо эргэн очихоос зайлсхийсэн тул оргодол хэмээн зарлагдсан байна.

Наваз Шариф авлигын хэрэгт холбогдсаны улмаас 2017 онд шүүхийн шийдвэрээр албан тушаалаасаа огцорсон бөгөөд төрсөн дүү Шахбаз Шариф нь мөн авлигын гэмт хэрэгт холбогдон баривчлагдсан.

Улс төрийн сөрөг хүчний зүгээс тус баривчлах ажиллагааг улс төрийн зорилготой хэмээн үзэж байгаа бол Ерөнхий сайд Имран Хан тус ажиллагааг авлигатай тэмцэх ажиллагаа гэж нийтэд зарласан байна.

[Афганистаны Эрүүл мэндийн сайд авлигын хэрэгт холбогдож албан тушаалаасаа огцорчээ](#)³⁹⁹

2020.12.31. Афганистаны Эрүүл мэндийн сайдын дүү болон хэд хэдэн хамаатан садан авлигын гэмт хэрэгт холбогдсон тул сайдыг албан тушаалаас нь огцруулсан талаар 12 дугаар сарын 31-ний өдөр Ерөнхийлөгчийн Тамгын газраас мэдэгдэв.

Ерөнхийлөгчийн Тамгын газрын хэвлэлийн төлөөлөгчийн орлогч Дава Хан Менапал нь Эрүүл мэндийн сайд Ахмад Жавад Усмани албан тушаалаас огцорсон талаар мэдээллийн Анадолу агентлагт мэдээлжээ.

Олон нийтийн мэдээллийн хэрэгсэлд Эрүүл мэндийн сайдын огцрох хүсэлтийг зөвшөөрсөн тухай Ерөнхийлөгч Мохаммад Ашраф Ганийн зарлиг цацагдсан байна.

Эрүүл мэндийн яамны дөрвөн албан хаагч яамны ажилчдаас хахууль авсан гэмт хэрэгт холбогдон баривчлагдсан талаар Ерөнхий прокурорын газраас мэдэгдсэнээс хойш 4 хоногийн дараа Эрүүл мэндийн сайдын огцорсон тухай мэдээлэл нийтэд цацагджээ.

Ерөнхий прокурорын газрын хэвлэлийн төлөөлөгч Жамшид Расулигийн мэдээлснээр тус албан хаагчдыг Хяналт, шалгалтын хэлтсээс баривчилсан бөгөөд одоогоор цагдан хоригдож байгаа гэв. Цагдан хоригдсон албан хаагчдын мэдээллийг одоогоор нийтэд зарлаагүй байна.

Гэвч орон нутгийн “Салам Афганистан” радиогийн мэдээлснээр тус цагдан хоригдож буй албан хаагчид нь Эрүүл мэндийн сайдын дүү болон үеэл байсан гэв.

Үүний зэрэгцээ Ерөнхийлөгч түүнийг огцрохыг шаардсан талаар Эрүүл мэндийн сайд асан Усмани мэдээлжээ. Түүнчлэн “*Ерөнхийлөгч намайг өчигдөр албан тушаалаас огцрохыг хүссэн. Хэдийгээр Ерөнхийлөгчид миний бие үргэлжлүүлэн ажиллахад аливаа хууль, эрх зүйн саад*



Сөрөг хүчнийхэн баривчилгааг улс төрийн зорилготой гэж үзэж байгаа ч Ерөнхий сайд Хан үүнийг авлигын эсрэг мөрийн хөтөлбөрийнхөө нэг хэсэг гэж мэдэгджээ. (Фото: Александр Земляниченко / AP)

³⁹⁹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/middle-east/afghan-health-minister-resigns-amid-corruption-charges/2095000#>

бэрхшээл тулгарахгүй талаар мэдэгдсэн боловч өнөөдөр намайг албан тушаалаас огцрохыг шаардлаа. Миний бие огцох хүсэлт өгөөгүй боловч Ерөнхийлөгчийн Тамгын газраас намайг Эрүүл мэндийн сайдын албан тушаалаас огцруулсан шийдвэрийг баталсан талаар албан бичиг ирлээ. Үүнийг миний бие улс төрийн хуйвалдаан гэж үзэж байна” хэмээн Усмани мэдэгдэв.

Энэ долоо хоногийн эхээр Афганистаны хуулийн байгууллагаас парламентын Авлигатай тэмцэх хорооны гурван гишүүнийг 40 мянган ам.долларын хахууль авсан хэрэгт холбогдуулан баривчилсан тухай мэдээлжээ. ТИ байгууллагын АТИ-ээр Афганистан улс хамгийн их авлигатай улс орны жагсаалтын тавдугаар байрт эрэмбэлэгдэж байна.

Хятадын банкир асан авлига, хахуулийн хэрэгт холбогдон цаазаар авах ял сонсов⁴⁰⁰

2021.01.05. БНХАУ-ын төрийн мэдлийн хөрөнгийн менежментийн томоохон фирмийн гүйцэтгэх захирал асан Лай Шиаомин авлигын гэмт хэрэг болон 260 сая ам.долларын хахууль авсан гэмт хэрэгт холбогдож 01 дүгээр сарын 05-ны өдөр цаазаар авах ял сонслоо. Коммунист намын гишүүн байсан түүний гэм буруугаа хүлээн мэдүүлж байгааг төрийн мэдлийн CCTV телевизийн сувгаар дамжуулан үзүүлсэн байна.



Телевизээр мөн түүний Бээжин хот дахь орон сууцнаас олдсон бэлэн мөнгөөр дүүрсэн сэйф, шүүгээний бичлэгийг нийтэд дамжуулсан байна. Лай Шиаомин нь 2018 он буюу түүнийг гэмт хэрэгт холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа эхлэх хүртэл “Чайна Хуарон хөрөнгийн менежмент” компанийн даргаар ажиллаж байжээ.

Тяньжинь хотын шүүхээс түүнийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, шунахайн сэдлээр “онц их хэмжээний хөрөнгө хууль бусаар олох” хэрэг үйлдсэн хэмээн үзжээ. Түүнчлэн энэхүү үйлдэл нь “үндэсний санхүүгийн аюулгүй байдал, санхүүгийн тогтвортой байдалд аюул учруулсан” гэж шүүхээс тогтоосон байна. Үүний дараагаар Хятадын Коммунист намаас түүний гишүүнчлэлийг цуцалжээ.

2018 оны 04 дүгээр сард түүнийг ажлаас халсан тухай шийдвэрийг гаргаж, БНХАУ-ын Дарга Ши Жиньпиний авлигын эсрэг уриалгын дагуу намын албан тушаалаас огцруулсан байна.

Лай Шиаомин нь CCTV телевизийн сувгаар дамжуулан гэм буруугаа хүлээх үедээ “энэ мөнгөнөөс миний бие нэг ширхэг ч юань зарцуулаагүй бөгөөд ердөө хадгалж байсан. Би тус хөрөнгийг зарцуулж зүрхэлсэнгүй” хэмээн хэлжээ. Мөн тус телевизийн сувгаар түүний хахуульд авсан тансаг зэрэглэлийн автомашин болон алтан гулдмай зэргийг нийтэд харуулсан байна.

Төрийн мэдээллийн CCTV телевизийн сувгаар шүүх хуралдаанд оролцохын өмнө гэм буруугаа хүлээн зөвшөөрч буй яллагдагчтай хийсэн ярилцлагыг нийтэд дамжуулдаг байна. Хүний эрхийн хуульчид энэхүү үйлдлийг яллагдагчдад дарамт шахалт учруулан гэм бурууг нь хүлээлгэх үйл ажиллагаа хэмээн үздэг байна.

Шүүхээс Лай Шиаоминий эд хөрөнгийг хураан авж улс төрийн эрхийг нь түдгэлзүүлэхээр шийдвэрлэжээ. Энэхүү шийтгэх тогтоол гарснаар Хятад улсын санхүүгийн томоохон гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагаа дуусгавар боллоо. Корпорацийн гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд Хятад улс хатуу байр суурь баримтлан ажиллаж байна. БНХАУ 2016 оноос хойш төрийн өндөр албан тушаалтан нэг хүнийг цаазалсан юм. Мөн Коммунист намын гурван удирдах албан тушаалтанд цаазаар авах ял оноосон боловч тэдний ялыг гүйцэтгэх ажиллагааг түр хугацаагаар хойшлуулдаг байна.

⁴⁰⁰ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.dw.com/en/china-sentences-ex-banker-to-death-for-corruption-bribery/a-56132658>

Израилын алмазны магнат Бени Штайнметцын холбогдсон авлигын хэргийн шүүх хурал Женев хотод болно⁴⁰¹



Бени Штайнметц. (Фото: Getty Images / AFP)

2021.01.08. Олон улсын хэмжээнд удаан хугацаанд явуулсан мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд Франц-Израил гаралтай алмазны магнат Бени Штайнметц-д холбогдох авлигын гэмт хэргийн шүүх хурал ирэх долоо хоногт Женев хотод болохоор товлогджээ.

Даваа гарагт эхэлж хоёр долоо хоногийн турш үргэлжлэх энэ шүүх хурлаар Гвиней улсад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл авах зорилгоор тус улсын төрийн өндөр албан тушаалтнуудад олон сая

ам.долларын хахууль өгсөн үйлдлийг шүүн таслах юм. 64 настай тэрбумтан, бизнесмен Бени Штайнметц нь шүүх хуралд оролцохоор Израилаас Швейцарит ирсэн хэмээн түүний өмгөөлөгч Марк Боннант мэдэгджээ.

Зургаан жилийн турш хэд хэдэн улс орныг хамран үргэлжилсэн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд Женевийн Прокурорын газраас Бени Штайнметцыг Гвиней улсын уул уурхайн тусгай зөвшөөрөл авах зорилгоор төрийн албан хаагчдад хахууль өгсөн болон хуурамч бичиг баримт үйлдсэн гэмт хэрэгт гэм буруутайд тооцож 2019 оны 08 дугаар сард яллах дүгнэлт үйлдсэн байна.

Швейцарийн прокурорууд Штайнметц болон түүний хоёр хамтрагчийг дэлхийн хамгийн том ашиглагдаагүй төмрийн хүдрийн орд байдаг Симандоу мужид уул уурхайн тусгай зөвшөөрөл авах зорилгоор Гвинейн Ерөнхийлөгч асан Лансан Контегийн эхнэр болон холбогдох бусад этгээдэд хахууль өгсөн хэрэгт гэм буруутайд тооцжээ.

Бени Штайнметц өөрт нь тулгаж буй авлигын хэргийг үндэслэлгүй бөгөөд түүнийг хохироох гэсэн улс төрийн дайснуудын үйлдэл хэмээн мэдэгдэж байв.

Прокурорын газраас түүнийг Швейцарийн банкны дансаар дамжуулан 10 сая гаруй ам.долларын хахууль өгсөн бөгөөд 2008 онд уул уурхайн тусгай зөвшөөрөл авсан талаар мэдээлжээ.

Мьянмар улсын нисэх хүчний дарга авлигын хэрэгт холбогджээ⁴⁰²

2021.01.12. Зам тээвэр, харилцаа холбооны яамны менежерийг хахууль авсан байж болзошгүй гэсэн үндэслэлээр Мьянмар улсын Авлигатай тэмцэх хороо (АТХ) шүүхэд өгчээ.

Авлигын талаар мэдээлэл хүлээн авсны дараа Иргэний нисэхийн газрын ерөнхий менежер У Со Пингэд холбогдуулан мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн гэдгийг АТХ-ноос мэдээлэв.

У Со Пингийг Нислэгийн хөдөлгөөний удирдлагын хяналтын газрын дарга, Агаарын навигацийн хяналтын хэлтсийн ерөнхий менежерээр ажиллаж байхдаа албан тушаалаа урвуулан ашигласан гэж буруутгаж байгаа юм.

АТХ-ны мэдээлснээр яллагдагч нислэгийн зөвшөөрөл тус бүрд гадаадын агент, оператор компаниудаас 100 хүртэл доллар (134,000 кят) шаардсан байна.

Ерөнхий менежер өөрийн нэр дээрх гадаадын банкны дансыг ашиглан гадаадын 12 оператор компаниас нийт 72,000 доллар (96 сая кят) хахууль шаардсан гэж сэжиглэж байна.

⁴⁰¹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.france24.com/en/live-news/20210108-israeli-magnate-set-for-corruption-trial-in-geneva>

⁴⁰² Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.irrawaddy.com/news/burma/myanmar-aviation-chief-charged-with-corruption.html>

АТХ Авлигын эсрэг хуулийн 56 дугаар зүйлд заасны дагуу 10 жил хүртэл хугацаагаар хорих ял бүхий гэмт хэрэгт холбогдуулан Янгон хотын Мингаладон тосгоны цагдаагийн газарт хэрэг үүсгэн шалгаж байгаа гэдгээ мэдэгджээ.

Авлигын эсрэг дэлхий нийтийн эвсэл болох ТИ байгууллагаас 11 дүгээр сард АТХ-г өндөр түвшний албан тушаалтнуудтай тэмцсэн, олон нийтийн итгэлийг олж авсан явдлыг сайшаажээ.

АТХ-ны дарга 74 настай У Аун Ки бясалгалд анхаарлаа хандуулахыг хүсэж байгаагаа илэрхийлээд 12 дугаар сарын эхээр албан тушаалаасаа огцорчээ.

Одоогоор АТХ-ны даргын үүргийг нарийн бичгийн дарга нь түр орлон гүйцэтгэж байна.

Туркийн тагнуулын алба батлан хамгаалах салбар дахь авлигын хэргийг шалгах явцдаа зургаан хүнийг баривчилжээ⁴⁰³

2021.01.14. Туркийн Батлан хамгаалах аж үйлдвэрийн тэргүүлэх зөвлөлийн ажилтнуудыг оролцуулан зургаан сэжигтнийг авлигын хэргээр баривчилсан тухай шүүхийн байгууллагаас мэдээлэв.

Баривчлах ажиллагаа нь Туркийн Үндэсний тагнуулын газар болон цагдаагийн байгууллагын хамтарсан ажиллагааны хүрээнд батлан хамгаалах салбарт хууль бус үйл ажиллагаа явуулж байсан бүлэглэлийн эсрэг авсан арга хэмжээний нэг хэсэг байсан гэж нийслэл Анкара хотын Ерөнхий прокурорын газраас мэдэгдэв.

Жилийн турш үргэлжилсэн мөрдөн шалгах ажиллагааны явцад Туркийн эрх бүхий байгууллагууд батлан хамгаалах салбарын зарим ажилтнууд голчлон санхүүгийн асуудал, эх үүсвэрийн талаар төслийн мэдээллийг мөнгө олох зорилгоор гадаадын батлан хамгаалахын компаниудад задруулсан болохыг тогтоожээ.

Сэжиглэгдэж буй албан тушаалтнуудыг олон сарын турш мөрдөн шалгаж, батлан хамгаалах салбарын тендерийн авлигын хэрэгт хяналт тавьж байжээ.

Мэдээлэлд дурдсанаар сэжигтнүүдийн албан өрөө болон оршин суугаа газруудад нэгжлэг хийх явцад их хэмжээний гадаад валют, дижитал материалыг хураан авсан байна.

Ли Жэ Ён: Самсунг компанийн өв залгамжлагч хахуулийн хэргээр хорих ял авжээ⁴⁰⁴



Ли Жэ Ён. (Фото: Getty Images)

2021.01.20. Өмнөд Солонгосын Дээд шүүх Самсунг компанийн өв залгамжлагч Ли Жэ Ёнд хоёр жил зургаан сарын хорих ял оноолоо.

Түүний оролцсон хахуулийн хэрэг хахууль, авлигын хэргээр шоронд хоригдсон тус улсын Ерөнхийлөгч асан Пак Гын Хэгийн өмнөх хэрэгтэй холбогдсон юм.

Ли 2014 оноос хойш Самсунг Электроникс компанийн де-факто удирдлагаар ажиллаж байгаа ба шүүхээс гаргасан энэ

⁴⁰³ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.trtworld.com/turkey/turkish-intelligence-arrests-six-in-defence-corruption-probe-43213>

⁴⁰⁴ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://www.bbc.com/news/business-55674712?fbclid=IwAR2MqUnsyFKivNQc58bEySI-tforavgkymhZYWDlsuxm70WZN_CfhpVKDc

шийдвэр нь технологийн аварга компанид түүний гүйцэтгэх үүргийн цаашдын ирээдүйд балаг болох магадлалтай юм.

Шүүхийн шийдвэрийн тухай мэдээллийн улмаас Самсунг электроникс компанийн хувьцааны ханш 4%-аар буурсан байна.

Лиг шоронд хорих нь, наанадаж, түүний бизнесийн нэгдэлтэй холбоотой шийдвэрт түр зуур саад болох бөгөөд мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар энэхүү ял шийтгэл нь манлайллын хоосон орон зайг бий болгож, Самсунг компанийн ирээдүйн томоохон хөрөнгө оруулалтын талаар шийдвэр гаргахад саад учруулж болзошгүй юм.

“Энэ үйл явдал Самсунг компанийн хувьд үнэхээр том цохилт, том хямрал болж байна” хэмээн Сежоны их сургуулийн бизнесийн профессор Ким Дэ Жон мэдээллийн агентлагт хэлсэн байна.

Түүний эцэг Ли Кун Хи 2014 онд зүрхний шигдээсийн улмаас эмнэлэгт хэвтэхэд Ли компанийн удирдлагыг авж эхэлсэн. Түүний эцэг өнгөрсөн жил нас барсан бөгөөд өв залгамжлагчид нь өв залгамжлалын татварын асар их төлбөрийг төлөхийн тулд хөрөнгөө зарж борлуулах, эсвэл ногдол ашиг төлөхөөс өөр аргагүйд хүрсэн тул Самсунг компанид өөрчлөлт гарна гэсэн таамаг дэвшүүлж байсан юм.

Шүүхийн шийдвэрт дурдсанаар Ли нь Самсунг компанийн зүгээс “хахуулийг идэвхтэй өгч, Ерөнхийлөгчөөс өөрийн хүч чадлыг ашиглан түүний залгамж халаанд туслахыг илт хүссэн” ажээ.

Шилдэг компани, дэлхийн шинийг санаачлагч Самсунг компани улс төрийн эрх мэдэл солигдох бүрд гэмт хэрэгт удаа дараа холбогддог нь маш харамсалтай юм.

Шүүхийн зүгээс Лигийн хахуульд өгсөн 8.6 тэрбум вон (7.8 сая ам.доллар)-той тэнцэх хэмжээний зүй бус орлогыг нуун дарагдуулсан хэргээр буруутгаж, өнгөрсөн оны эхээр байгуулсан Самсунг компанийн бие даасан комплаенсийн хороог бүрэн зохион байгуулагдаагүй байна гэж мэдэгджээ.

“Энэ хэргийн цаана өмнөх ерөнхийлөгч албан тушаалаа урвуулан ашиглаж, компанийн эрх чөлөө, өмчийн эрхийг зөрчиж байгаа явдал нуугдаж байна. Энэ байдлыг харгалзан үзвэл шүүхээс гаргасан шийдвэр эргэлзээтэй байна” гэж Лигийн өмгөөлөгч Ли Ин Жэ сэтгүүлчдэд мэдээлэв.

Лигийн хоригдох ялын хугацаа эхэлсэн бөгөөд 18 сарын хугацаа үлдсэн гэж үзэж байгаа.

Ли дэлхийн технологийн аварга компанийн удирдагч болохоор дөнгөж эхэлж байхад ч хууль эрх зүйн асуудалтай тулгарсан байдаг. Тэрээр анх 2017 оны 02 дугаар сард Өмнөд Солонгосын тухайн үеийн Ерөнхийлөгч Пак Гын Хэтэй холбоотой улс төр, аж ахуйн нэгжийн дуулианд оролцсон гэх хэргээр баривчлагдаж байсан юм.

Самсунг компани улс төрийн дэмжлэг авахын тулд Ерөнхийлөгч Пакын найз Чой Сун Силийн удирддаг ашгийн бус хоёр санд 43 тэрбум вон (37.7 сая ам.доллар) өгсөн бөгөөд үүний хариуд маргаан дагуулсан Самсунг компанийн бизнесийн нэгдэлд дэмжлэг үзүүлсэн ба Ли эцэст нь нэгдмэл компанийг удирдах болно гэж буруутгагдаж байв.

Лигийн эсрэг үүсгэсэн хэрэгт хахууль, бусдын эд хөрөнгийг шамшигдуулсан, хилийн чанад дахь хөрөнгөө нуусан, худал мэдүүлэг зэрэг гэмт хэрэг багтсан ба харин Самсунг компани эдгээрийн эсрэг няцаалт гаргаж байсан юм.

Мөрдөх төв товчоо төмөр замын ахлах албан тушаалтан болон өөр хоёр этгээдийг 1 крор рупийн хахуулийн хэргээр баривчлав⁴⁰⁵

2021.01.17. Энэтхэгийн Мөрдөх төв товчоо (МТТ) өнгөрөгч ням гарагт Зүүн хойд Хилийн төмөр замын захиргааны албаны даргыг (барилга угсралтын) хувийн компанид ашигтай гэрээ

⁴⁰⁵ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.ndtv.com/india-news/cbi-arrests-senior-railways-official-in-alleged-rs-1-crore-bribery-case-2353846>

байгуулахад нь давуу тал олгосны төлөө 1 крор рупи⁴⁰⁶ авсан хэргээр баривчилсан нь хахуулийн хамгийн том хэргийг илрүүлсэн тохиолдол боллоо хэмээн албаны хүн мэдэгдсэн байна.

Энэтхэгийн Төмөр замын инженерийн үйлчилгээний 1985 дугаар ангийн албан тушаалтан Махендер Сингх Чаухан (Mahender Singh Chauhan)-ыг Ассам мужийн Гувахати хотын Малигаон дүүргээс⁴⁰⁷ баривчилсан бол нөгөө хоёр этгээд болох ABCI Infrastructures Private Limited компанийн ажилтан Бхупендра Рават (Bhupendra Rawat), Индра Сингх (Indra Singh) нарыг Чауханы зааврын дагуу хахуулийг дамжуулсан Уттараканд мужийн Дерадун хотод саатуулсан байна.

МТТ 2.14 крорыг⁴⁰⁸ бэлнээр, 1 крорыг Дерадунаас, 54 лакыг⁴⁰⁹ нэгжлэгийн явцад, бас өмнө нь хахуульд төлсөн 60 лакыг⁴¹⁰ тус тус хурааж аваад байна гэж албаны хүн мэдээлэв.

Мөн тус агентлаг төмөр замын ажилтнууд болох Хэм Чанд Бора (Ерөнхий инженерийн орлогч), Лаксми Кант Верма (гүйцэтгэх инженерийн туслах), ABCI Infrastructures Private Limited компанийн захирал Паван Бэйд нарыг нотлох баримттайгаар баривчилсан байна.

Чаухан (58 настай) Зүүн хойд Хилийн төмөр замын олон төслийн гэрээг байгуулахдаа хэрэгт сэжиглэгдэж буй компаниудад давуу байдал үзүүлэхийн тулд хахууль нэхсэн хэмээн буруутгагдаж байгаа бөгөөд “Хууль бус шан харамжийн хариуд гэрээ байгуулах, дараагийн төлбөр тооцоог хийх, төлбөрөөс чөлөөлөгдөх гэх мэт хөнгөлөлтүүдийг гэрээлэгчид авж байсан” хэмээн МТТ-ны хэвлэлийн төлөөлөгч Жоши мэдэгдэлдээ дурджээ.

Тус агентлагаас хувийн компанийн захирал Бэйдийг Зүүн хойд Хилийн бүс нутагт хэрэгжиж буй янз бүрийн төслүүдтэй холбоотойгоор Чайухантай хамааралтай гэж мэдэгдсэн байна.

“Түүнчлэн түүний (Чауханы) нэхсэний дагуу Дерадун дахь байрандаа өөрийн ажилтнаар дамжуулан захиргааны албаны даргын хамаатанд (хувь хүнд) нэг крор рупийн хахууль өгсөн нь батлагдсан” хэмээн дээрх мэдэгдэлд дурджээ.

МТТ шаардлагатай мэдээллийг олж авсны дараа Уттараканд болон Ассам дахь хэд хэдэн байршилд багуудаа байршуулж, отолт хийсэн байна. Хахуулийн мөнгө хүргэгдэж, сэжигтэн отолтод орж ирмэгц нэг баг дайрч оржээ. Улмаар байцаалт, нэгжлэг хийсний дараа Чауханыг мөн баривчилжээ.

МТТ-ны багууд Дели, Уттараканд, Трипура, Баруун Бенгал, Ассам гэсэн таван мужийн 21 байршилд өргөн цар хүрээтэй шалгалтын ажиллагааг эхлүүлээд байна. Агентлаг нь Зүүн хойд Хилийн төмөр замын төслийн гэрээнүүдтэй холбоотой хахуулийн хэмжээ болон бусад бичиг баримтыг олж тогтоосон гэж мэдэгдэлд дурджээ.



⁴⁰⁶ Энэтхэгийн тооллын системд 100,000-ыг 1 лак, 100 лак буюу арван сая(10,000,000 буюу 10⁷)-ыг 1 крор гэдэг. 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Монголбанкны ханшаар тооцвол 391,400,000 төгрөгтэй тэнцэнэ.

⁴⁰⁷ Энд Зүүн хойд Хилийн Төмөр замын удирдах төв байрладаг.

⁴⁰⁸ 21,400,000 рупи буюу 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Монголбанкны ханшаар 837,596,000 төгрөг.

⁴⁰⁹ 5,400,000 рупи буюу 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Монголбанкны ханшаар 211,356,000 төгрөг.

⁴¹⁰ 6,000,000 рупи буюу 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Монголбанкны ханшаар 234,840,000 төгрөг.

Мөрдөх төв товчоо өөрийн 2 ажилтныг хахуулийн хэргээр баривчлав⁴¹¹

2021.01.20. Мөрдөх төв товчоо (МТТ) өөрийн хоёр албан тушаалтан болох цагдаагийн ахлах офицер РК Риши, мөрдөгч Капил Данкад нарыг хахуулийн хэрэгт холбогдуулан баривчилжээ. Зээлийн дефолт нь хэдэн мянган крор рупи хүрээд байгаа хоёр компанийн эсрэг явагдаж буй банкны луйврын мөрдөн шалгах ажиллагаанд нөлөөлөхийг оролдсон гэж тэднийг буруутгажээ.

Түүнчлэн эдгээр компанийн нэгийг төлөөлж байсан өмгөөлөгчийг баривчилсан байна.

Хэрэгт буруутгагдаад буй компаниудад туслах зорилготойгоор тус Товчооны дотор үүссэн хахуулийн бүлэглэлд холбоотой байж болзошгүй гэх хэрэгт холбогдуулан МТТ өөрийн дөрвөн албан тушаалтан, хувийн гурван компани, тэдний хоёр өмгөөлөгчийг нотлох баримттайгаар энэ сарын 12-ны өдөр баривчлаад байсан аж.

МТТ-ноос гаргасан Анхдагч мэдээллийн тайлан (The First Information Report (FIR))-д өөрийн агентлагийн албан тушаалтнууд болох цагдаагийн дэд ахлагч Сангван, Риши, мөрдөгч Капил Данкад, стенографч Самир Кумар Сингх нарыг нэрлэжээ. Мөн Shree Shyam Pulp and Board Mills компанийн захирал Мандип Каур Диллон, Frost International компанийн захирлууд болох Сужай Десай, Удай Десай, эдгээр компанийн өмгөөлөгчид болох Арвинд Кумар Гупта, Манохар Малик нарыг нэрлэсэн байна.

Хэрэгт буруутгагдаад буй МТТ-ны албан тушаалтнууд тухайн компаниудын банкны зээлээ төлөөгүйтэй холбоотой мөрдөх ажиллагаанд нөлөөлөх зорилгоор 2018 оноос хойш эдгээр өмгөөлөгчдөөр дамжуулан 55 гаруй лак рупийн⁴¹² хахууль авсан хэмээн тус агентлагаас гаргасан Анхдагч мэдээллийн тайланд дурджээ.

Товчоо яллагдагчдын орон байр болон МТТ-ны төв байрт байрлах ажлын байранд нэгжлэг хийсэн бөгөөд тэндээс яллах нотлох баримтууд олж авсан гэжээ. Мөн лхагва гарагт ноён Rishi-гийн Уттар Прадеш дахь ажлын байранд үргэлжлүүлэн нэгжлэг хийлээ гэж эх сурвалжууд нэмж хэлэв.

“МТТ эдгээр мөрдлөгийн дараа Риши, Капил Данкад нарыг өмгөөлөгч Манохар Маликийн хамт баривчилсан” хэмээн агентлагийн албан тушаалтнууд NDTV сувагт мэдээлсэн байна.

Капил Данкад, Самир Кумар Сингх нарыг МТТ-ноос саатуулах үеэр тус агентлаг цагдаагийн өөр хоёр өндөр албан тушаалтанд мөн ижил арга хэмжээ авах санал гаргасан бөгөөд тэд Дели хотоос гарахаар төлөвлөсөн байжээ.

Хятадад төрийн өмчит компанийн даргыг авлигын хэргээр цаазлав⁴¹³

2021.01.29. Төрийн өмчит Чайна Хауронг Ассет Менежмент компанийн тэргүүн асан Лай Сяомин авлигын хэрэгт буруутгагдаж, мөн хөрөнгө шамшигдуулсан, олон эхнэр авсан хэргээр цаазлуулсан болохыг БНХАУ-ын төв телевиз мэдээлжээ.

Шүүхийн тогтоолыг 01 дүгээр сарын 29-ний өдөр гүйцэтгэсэн байна. Тогтоол гүйцэтгэхийн өмнө түүнийг төрөл төрөгсөдтэй нь уулзуулжээ.

Цаазлах шийдвэрийг 01 дүгээр сарын сарын 05-ны өдөр гаргасан юм. Түүнийг 25



(Фото: Шу Жан/Reuters)

⁴¹¹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.ndtv.com/india-news/central-probe-agency-cbib-arrests-two-of-its-own-officials-in-bribery-case-2355462>

⁴¹² 5,500,000 рупи буюу 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Монголбанкны ханшаар 215,270,000 төгрөг.

⁴¹³ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://lenta.ru/news/2021/01/29/kaznili/>

сая гаруй юань буюу 3.9 сая ам.долларын хөрөнгө шамшигдуулсан, 1.79 тэрбум юань буюу 280 сая орчим ам.долларын хахууль авсныг шүүхээс тогтоожээ. Түүнчлэн авааль эхнэрээсээ гадна олон эмэгтэйтэй хамтран амьдарч байсныг илчилсэн байна.

Сяоминий гэрт нэгжлэг хийх явцад хахуульд авсан бэлэн мөнгөө хийсэн төмөр хайрцаг олдсон талаар өмнө нь мэдээлсэн бөгөөд уг хайрцагт нийт 200 сая юань бэлнээр байжээ.

Тэрээр хахуульд авсан мөнгөө байрандаа авчирч хадгалж байсан тухайгаа мэдүүлсэн байна. Сяоминий хэлж буйгаар хахууль авах түүний хувьд хятадын жирийн иргэд сүлжээ дэлгүүр орохтой адил энгийн зүйл байжээ. Мөнгөө үрэлгүй хүүхэддээ зориулан хадгалж байснаа тэрээр хүлээсэн байна.

Казахстанд таван дэд сайдыг авлигын хэрэгт буруутгажээ⁴¹⁴

2021.01.29. Казахстаны авлигатай тэмцэх газраас тус улсын 5 дэд сайдад холбогдох эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж байгаа талаар 01 дүгээр сарын 29-ний өдөр хэлтсийн дарга Алик Шпекбаев мэдээлжээ.

Тэрээр 2020 онд албан тушаалын бүх төрлийн ангилал зэрэглэлд хамаарах 210 удирдах албан тушаалтан эрүүгийн хэрэгт холбогдсон, мужийн нэг дарга (аким), дөрвөн орлогч дарга, хоёр хорооны дарга, нэг элчин сайд, таван шүүгч зэрэг 722 албан тушаалтанд ял оногдуулсан байна гэжээ.

Одоогийн байдлаар 5 хорооны дарга, тэдгээрийн орлогчид болон томоохон компанийн удирдах 5 албан тушаалтанд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна.

Тус улсын Карагандын Казыбекби дүүргийн шүүхээс 01 дүгээр сарын 26-ны өдөр төсвийн хөрөнгийг хууль бусаар зарцуулсан хэрэгт сэжиглэгдэж байсан Эрчим хүчний дэд сайд асан Анатолий Шкарупаг цагаатгасан талаар Регнум агентлаг мэдээлжээ.

Нетаньяхугийн шүүх хурал сонгууль болохын өмнөхөн товлогдлоо⁴¹⁵

2021.02.08. Хэдхэн долоо хоногийн дараа болох сонгуулийн өмнө Израил улсын Ерөнхий сайд Нетаньяхугийн шүүх хурал товлогдсон тул тэрээр авлигын хэрэгт буруугуй хэмээн мэдэгдээд байна.

Цар тахлын улмаас бараг хагас жил завсарлаад байсан шүүх хурал өнгөрсөн даваа гарагт эхэлсэн байна.

Шүүх хурлын үеэр Нетаньяху мэс заслын амны хаалттай байсан бөгөөд шүүгчид түүнээс өмгөөлөгчийн бичгээр гаргасан өмгөөллийг хүлээн зөвшөөрч буй эсэхийг тодруулсан болно. Тэрээр хүлээн зөвшөөрч буйгаа шүүгчдийн бүрэлдэхүүнд илэрхийлсэн.

Шүүхийн танхимын гадна Нетаньяхугийн эсрэг жагсагчдын хашгирах дуу чимээ сонсогдож байв. Тэрээр шүүх хурал эхэлснээс хойш хагас цагийн дараа танхимыг орхин явсан ба өмгөөлөгчид нь шүүгчдийн асуултад хариулж байв.

Түүнийг хэдэн зуун мянган фунт стерлингийн үнэ бүхий бэлэг сэлтийг чинээлэг найзуудаасаа авсан, үйл явдлыг өөрт ашигтайгаар мэдээлэх давуу байдлыг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс олж авсан зэрэг асуудалд буруутгагдаж байгаа юм.

Нетаньяху бүрэн эрхийнхээ хугацаанд шүүхийн өмнө зогсож буй тус улсын анхны Ерөнхий сайд юм. Тэрээр улс төрийн хэрэг хэмээн мэдэгддэг.

Шүүх дээр тогтмол ирэх нь түүний нэр хүндэд асуудал үүсгэж байна. Мөн тэрээр цар тахлын үеийн өөрийн үйл ажиллагаанд ч сэтгэл хангалуун бус байгаа аж. Израил улс 9 сая хүн амтай ба халдвар авагсдын тоо болон амь эрсэдсэн хүмүүсийн тоо харьцангуй өндөр байгаа юм.

⁴¹⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/3176593.html>

⁴¹⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.theguardian.com/world/2021/feb/08/netanyahu-corruption-trial-resumes-weeks-before-israeli-election>

Тэрээр цар тахлын эсрэг дэлхийн хэмжээнд авж хэрэгжүүлж буй арга хэмжээ болох хүн амаа вакцинжуулах үйл ажиллагаанд ихээхэн найдаж буй юм. Тус улс 16 наснаас дээш насны бүх иргэдээ өнгөрсөн долоо хоногоос вакцинжуулж эхэлсэн. Сонгууль гуравдугаар сарын 23-нд болно. Одоогоор гурван иргэний нэг нь вакцинжуулалтад хамрагдаад байна.

Сүүлийн хоёр жилийн хугацаанд тус улсад улс төрийн хямрал нүүрлээд буй юм. Хамтарсан засгийн газар байгуулах хүчин чармайлт удаа дараа амжилтгүй болсон. Гурван сард болох сонгууль нь энэ хугацаанд болж буй дөрөв дэх сонгууль юм.

Афганистан улсын 321 албан тушаалтан авлигын хэргээр халагджээ⁴¹⁶

2021.02.21. Афганистан цагдаа болон гаалийн 321 ажилтныг авлигын хэрэгт буруутган ажлаас нь халсан тухай ням гарагт албаныхан мэдэгдлээ.

Дотоод хэргийн яамны мэдээлснээр хурдны замаар зорчиж байгаа тээврийн хэрэгслийн жолооч нараас хахууль авсан, айлган сүрдүүлж мөнгө нэхсэн хэрэгт буруутгагдаж байгаа албан тушаалтнуудын хэрэгт нэмэлт мөрдөн байцаалт явуулахаар Улсын ерөнхий прокурорын газарт шилжүүлжээ.

Авлигач албан тушаалтнуудыг боловсролтой, чадварлаг ажилтнуудаар солино хэмээн Дотоод хэргийн дэд сайд, хошууч генерал Абдул Сабур Кане мэдэгджээ.

Авлига, хахуульд дургүйцсэн тээвэрчид гурван долоо хоног ажил хаялт зарласны дараа эдгээр албан тушаалтнуудыг ажлаас халах шийдвэрийг гаргажээ.

Тээвэрчдийн үйлдвэрчний эвлэлийн дарга Тала Мохаммад “Бидэнд амласан шинэчлэл хийгдэхгүй бол дахин ажил хаялт хийх талаар уриалах болно” гэж Анадолу агентлагт өгсөн ярилцлагадаа хэлсэн байна.

Мөн тэрээр “Эцсийн дүндээ энгийн иргэд барааны хомсдолд орж, захууд хаагдахаас болж шаналах болно гэдгийг бид ойлгож байгаа тул засгийн газраас бидэнд өгсөн баталгааг үл харгалзан ажил хаялтаа зогсоосон” гэжээ.

2020 онд 24 албан хаагчтай холбоотой авлигын асуудлыг шалгажээ⁴¹⁷

2021.03.15. Хятадын Коммунист намын Сахилгын төв хорооноос даваа гарагт нийтэлсэн тайлангаас үзэхэд тус хороо болон бусад хяналтын байгууллага 2020 онд улсын хэмжээнд 618 мянган авлигын хэргийг шалгаж, 604 мянган хүнд шийтгэл ногдуулснаас 9,420 нь санхүүгийн салбарынхан байжээ. Мөн төрийн төв байгууллагуудын 24 албан хаагчийг шалгасан байна.

Өнгөрсөн жил 16 мянган хүн сайн дураар өөрийн гэм бурууг хүлээж тус байгууллагад ханджээ. Авлигын гэмт хэрэг үйлдээд оргон зайлсан 1,421 хүнийг гадаадаас олж ирснээс 21 нь онц ноцтой гэмт хэрэгтнүүд байсан. Мөн 2.95 тэрбум юань (454 сая ам.доллар)-ийн хууль бус орлогыг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Саудын Арабт хэдэн зуун хүнийг авлигын хэрэгт холбогдуулан саатуулаад байна⁴¹⁸

2021.03.15. Хахууль авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, бичиг баримт хуурамчаар үйлдсэн зэрэг хэргийг шалгах хүрээнд сүүлийн нэг сарын хугацаанд зохион байгуулсан 263 удаагийн ажиллагааны явцад дотоод хэргийн асуудал, эрүүл мэнд, хот суурин болон орон нутгийн асуудал, орон сууц, боловсрол, хүний нөөц, нийгмийн хөгжил, гааль, шуудангийн асуудал хариуцсан яамны ажилтан 241 хүнийг саатуулаад байгаагаа Саудын Арабын Хяналт шалгалт, авлигатай тэмцэх газар (Nazaha)-аас мэдэгдсэн байна.

⁴¹⁶ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://nation.com.pk/21-Feb-2021/321-officials-of-afghanistan-sacked-for-corruption>

⁴¹⁷ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: http://www.xinhuanet.com/english/2021-03/15/c_139812450.htm

⁴¹⁸ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2021/3/15/saudi-arrests-241-employees-in-multiple-corruption-cases>

Дээрх асуудалтай холбоотой, хахууль өгсөн иргэд, авсан албан хаагч зэрэг нийт 757 хүний асуудал байгаа бөгөөд зохих журмын дагуу шалгаж, шүүхэд шилжүүлэх аж.

Арабын ертөнцийн томоохон эдийн засагтай улсын нэг Саудын Араб сүүлийн жилүүдэд авлигатай идэвхтэй тэмцэж байгаа юм. Өнгөрсөн оны нэгдүгээр сард хууль бусаар 3.1 тэрбум ам.доллар шилжүүлсэн хэргийг шалгах явцад 32 хүнийг баривчилсан байна.

Хяналт шалгалт, авлигатай тэмцэх газрын мэдээллээр төв банкны албан хаагчид тус улсад оршин суудаг гадаадын иргэд болон бизнес эрхлэгчдийн зохион байгуулалттай бүлэглэлээс хахууль авж, эх сурвалж нь тодорхойгүй мөнгийг банкаар дамжуулан гадаад руу шилжүүлж байжээ.

Нетаньяху авлигын хэрэгт холбогдон дахин шүүхэд дуудагдав⁴¹⁹

2021.04.05. Израилийн Ерөнхий сайд Нетаньяхугийн авлигын гэмт хэргийн шүүх хурал 04 дүгээр сарын 05-ны өдөр үргэлжлэв. Шүүх хуралд Ерөнхий сайдын гэр бүлийг магтаж, улс төрийн өрсөлдөгчийнх нь нэр хүндийг унагаах зорилгоор Израилийн нэр хүнд бүхий цахим мэдээллийн хэрэгсэлд нийтлэх мэдээг бэлтгэж байсан этгээд гэрчээр оролцсон байна.

Өнгөрсөн сарын парламентын сонгуулийн дараагаар хийгдсэн Ерөнхийлөгч болон тус улсын улс төрийн нөлөө бүхий этгээдийн хоорондын уулзалтын үр дүнд Ерөнхий сайд Нетаньяху тус албан тушаалд улиран томилогдох эсэх нь эргэлзээтэй болсон талаар гэрчийн мэдүүлэгт тусгагджээ.

Биньямин Нетаньяху үндэсний телевизэд өгсөн ярилцлагынхаа үеэр прокурорууд сонгогчдын хүсэл зоригийг хөсөрдүүлж, албан тушаалаас нь огцруулах зорилгоор түүнийг хавчин боогдуулж буй талаар мэдээлжээ. “Төрийн эргэлт хийх гэсэн оролдлого ийм байдаг” хэмээн тэрээр мэдэгдсэн байна.

Шүүхийн мэдүүлэг болон улс төрийн зөвлөлдөх уулзалтын үр дүн нь Биньямин Нетаньяху өөрийн улс төрийн албан тушаалын төлөө бүх боломжоор тэмцэж буйг харуулж байгаа юм.

Сонгуулийн дараа зохион байгуулагддаг зан үйлийн үеэр Ерөнхийлөгч Реувен Ривлин шинэ засгийн газрын бүрэлдэхүүнийг томилохоор парламентын суудалтай намын төлөөлөлтэй уулзсан. Парламентын гишүүдийн олонх нь Ерөнхий сайд Биньямин Нетаньяхуг улируулан томилохыг эсэргүүцэж байсан бөгөөд Ерөнхийлөгч Ривлин шинэ Ерөнхий сайдыг ойрын хугацаанд томилж магадгүй байна.

“Зөвлөлдөх уулзалтууд Ерөнхий сайд Нетаньяхуг улируулан томилоход улам бүр хүндрэлтэй байдал үүсгэж байна” хэмээн Израилийн Ардчилсан институтийн ерөнхийлөгч Ёханан Плеснер хэлэв. Мөн тэрээр “Нетаньяху парламентын 120 гишүүний олонхын дэмжлэгийг авахад тун хүндрэлтэй байдал байна” гэж мэдээлжээ.

Ерөнхий сайд Нетаньяху залилан, итгэл алдах болон гурван удаагийн үйлдлээр хахууль авсан гэх хэрэгт холбогдон шалгагдаж байна. Энэ сарын 05-ны өдрийн шүүх хуралдаанаар шүүн таслах ажиллагааны нотлох баримттай танилцах ажиллагаа эхэлсэн бөгөөд Ерөнхий сайдын эсрэг байр сууриа илэрхийлэхээр гэрчийн урт цуваа бий болжээ.

Түүний холбогдсон хамгийн ноцтой гэмт хэрэгт холбогдуулан энэ удаагийн шүүх хурлаар шүүн таслах ажиллагааг эхлүүлжээ. Ерөнхий сайд Нетаньяху “Bezeq” компанийн нэр хүнд бүхий цахим хуудас болох Walla-д өөрийн талаар эерэг мэдээ нийтлүүлэх зорилгоор тус компанид олон зуун сая ам.долларын орлого олгох журмыг эрх мэдлээ ашиглан сурталчилсан хэрэгт холбогдон шалгагдаж байгаа юм.

Walla цахим хуудсын ахлах редактор асан Илан Ешуаны мэдээлснээр “Bezeq” компанийн эзэн Шаул болон Ирис Элович нар түүнийг Нетаньяхугийн талаар эерэг мэдээ нийтэлж, улс төрийн өрсөлдөгчийнх нь нэр хүндийг унагахыг удаа дараа шаардаж, шахалт үзүүлсэн байна.

“Ерөнхий сайд ингэхийг хүссэн” хэмээн Шаул болон Ирис Элович нар хэлжээ. Мөн Илан Ешуагийн хэлснээр энэхүү дарамт шахалт олон жилийн турш үргэлжилж байгаа аж. Тус гэмт

⁴¹⁹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.marketwatch.com/story/netanyahu-back-in-court-for-corruption-trial-01617642208>

хэрэгт яллагдагчаар татагдсан Шаул болон Ирис Элович нар мэдээний гарчиг, үгийн сонголт, нийтлэх зураг болон бусад агуулгыг сонгон нийтэлдэг байжээ.

Мөн Ерөнхий сайдын улс төрийн өрсөлдөгчийн нэр хүндэд халдсан өгүүлэл нийтэлж, тааламжгүй хоч өгч байхыг Илан Ешуад даалгасан байна. Ерөнхий сайд Нетаньяхугийн холбоотон асан Нафтали Беннеттийг түүний өрсөлдөгч болсон даруй “Сахилгагүй шүтлэгтэн”, Хойд Африк гаралтай Сангийн сайд асан Моше Кахлоныг “Инээмсэглэл”, “Араб” гэх мэтээр хочилж мэдээ бэлтгэж байжээ.

Илан Ешуа Нетаньяхутай биечлэн уулзаж байгаагүй бөгөөд тус хүсэлтийг түүний туслах Нир Хефетз зэрэг зуучлагчид уламжилдаг байсныг мэдээлжээ. Нир Хефетз нь энэхүү шүүх хуралд гэрчээр оролцож Нетаньяхугийн эсрэг мэдүүлэг өгч байгаа билээ.

“Нир Хефетзийн хүсэлтийн дагуу Ерөнхий сайдын эерэг мэдээг нийтэлж, сөрөг мэдээллийг устгах шаардлагатай байсан” хэмээн Илан Ешуа хэлсэн байна. Түүний ажилтнууд Ерөнхий сайдын дарамт шахалтад ихээхэн сэтгэл дундуур байсан бөгөөд Хойд Солонгосын удирдагчтай зүйрлэж түүнд “Ким” гэх хочийг хүртэл өгчээ.

Түүнчлэн Нетаньяху Холливудын кино магнат Арнон Милчан, Австралийн тэрбумтан Жеймс Пакер зэрэг этгээдээс олон зуун мянган ам.долларын үнэ бүхий бэлэг хүлээн авсан хэрэгт холбогдон шалгагдаж байна. Ерөнхий сайд Нетаньяху тус хэргүүдийг няцааж байгаа юм.

Телевизэд өгсөн мэдэгдэлдээ Нетаньяху *“Тэд гэмт хэргийг мөрдөн шалгаагүй. Тэд гэмт хэрэг хайгаагүй. Харин тэд намайг агнаж байна”* хэмээн мэдээлжээ. Даваа гаргийн шүүх хуралдааны үеэр прокурорын танилцуулсан яллах дүгнэлтэд “Нетаньяху болон яллагдагчид хооронд буй харилцаа нь мөнгөн тэмдэгт болсон ба цаашид арилжаалагдах шинжтэй болсон. Энэхүү мөнгөн тэмдэгт нь төрийн албан хаагчийн шийдвэр гаргах ажиллагаанд нөлөөлж болзошгүй юм” хэмээн тусгагдсан байна.

Шүүх хуралдааны танхимын гадна Ерөнхий сайдын дэмжигч, эсэргүүцэгчид цугларч цагдаагийн албан хаагчдын өмнө эсэргүүцэл илэрхийлжээ. Энэхүү эсэргүүцэл Израилийн гүн хагарлыг илтгэсэн байна.

Шүүхийн шийдвэр эцэслэн гарахад урт хугацаа шаардагдах боловч шүүх хуралдаан долоо хоног бүр 3 удаа хуралдах бөгөөд Ерөнхий сайд Нетаньяхугийн хувьд ичгүүртэй, цаг хугацаа шаардсан, үр дүнтэй ажиллах нөхцөл боломжийг сарниулж байгаа юм. Энэ бүхэн нь Нетаньяхуг албан тушаалаас огцроход улам бүр ойртуулж болзошгүй билээ.

03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдсан сонгууль Нетаньяхугийн Засгийн газарт өгч буй ард иргэдийн үнэлгээ гэж харагдаж байгаа юм. Гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй этгээд Ерөнхий сайд байх нь тохиромжгүй талаар улс төрийн сөрөг хүчин санал бодлоо илэрхийлсэн байна. Сүүлийн 2 жилийн хугацаанд зохион байгуулсан 4 дэх сонгууль дахин мухардалд орлоо.

Нетаньяху эрх мэдэл, албан тушаалаа ашиглан прокурорыг дарамтлан, шахалт үзүүлэх, цаашлаад хууль зүйн халдашгүй байдал олох зорилгоор засгийн эрхэд үлдэх зорилготой байгаа юм. Гэвч даваа гаргийн шүүх хурлын дараагаар түүний энэхүү зорилго биелэхэд хүндрэлтэй харагдаж байна.

Нетаньяхугийн холбоотон болон сөрөг хүчин парламентад олонх болсонгүй. Түүний хувь заяа аль нэг эвсэлд нэгдээгүй баруун жигүүрийн Ямина намын дарга Беннетт, Арабын исламын намын дарга Мансур Аббас нараас шууд хамаарах юм.

Даваа гарагт Ямина намын дарга Беннетт өөрийгөө Ерөнхий сайдад нэр дэвшүүлж, Израилийн улс төрийн мухардлыг гүнзгийрүүлж, Нетаньяхугийн улиран сонгогдох боломжийг хязгаарлажээ. Гэвч Нетаньяхугийн гол өрсөлдөгч төвийн үзэлтэн Яир Лapid мөн олонхын дэмжлэгийг авахаар ажиллаж байгаа юм.

Ямина нам нь парламентад долоон суудалтай байгаа тул засаглалын эвсэл байгуулах боломж тун хомс байгаа юм. Намын дарга Беннетт улс төрийн өрсөлдөгч талуудын хоорондох үл ойлголцлыг арилгаж чадах зөвшилцлийн нэр дэвшигч болж чадна гэдэгт найдаж байгаагаа илэрхийлжээ.

Ерөнхий сайдад нэр дэвшигчийг Ерөнхийлөгч Ривлин сонгох ёстой бөгөөд тус нэр дэвшигч нь зургаан долоо хоногийн хугацаанд эвсэл байгуулах шаардлагатай юм. Хэрэв Ерөнхий сайдад

сонгох нэр дэвшигч байхгүй гэж үзвэл Ерөнхийлөгч парламентад хандаж, гишүүдийн нэгийг томилох, эсхүл, дахин сонгууль явуулахыг шаардаж болно.

Израилийн хуулийн дагуу Ерөнхий сайд нь гэмт хэрэгт холбогдсон тохиолдолд албан тушаалаас огцрохыг шаардахгүй бөгөөд Нетаньяху мөн огцрохоос татгалзсан юм. Ерөнхий сайд Нетаньяхугийн зарим өрсөлдөгчид гэмт хэрэгт холбогдон, яллагдагчаар татагдсан этгээд Ерөнхий сайдын албан тушаал хаших эрхийг хязгаарлах хууль санаачилсан байна.

Малайзын Ерөнхий сайд асан **Нажиб Разак**
олон нийтийн хөгжлийн сангийн хөрөнгийн
мөнгө угаасан хэрэгт гэм буруутай нь
тогтоогдсон тул давж заалдах шатны
шүүхэд гомдол гаргажээ⁴²⁰



Нажиб Разак. (Фото: © WikiMedia (Firdaus Latif))

2021.04.06. Малайзын Ерөнхий сайд асан Нажиб Разак “1Малайзын хөгжлийн берхад” (1MDB) компанитай холбоотой хэргийн талаар 2020 онд гарсан шүүхийн шийдвэрийг эсэргүүцэж, давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасны дагуу шүүх хурал Путражая дахь Хууль зүйн ордонд эхлэв.

Нажиб Разак итгэл алдаж, эрх мэдлээ урвуулан

ашиглаж, төрийн бие даасан баялгийн сангаас олон зуун сая ам.долларыг угааж, өөрийн хувийн банкны дансанд шилжүүлсэн байна.

Малайзын олон нийтийн хөгжлийн сангийн хөрөнгө нь АНУ зэрэг дэлхийн олон орноос цугларсан хөрөнгө бөгөөд Нажиб Разакийн хүргэн Риза Азиз зэрэг ойрын хамаарал бүхий төрийн албан хаагчид хамтран тус хөрөнгийг шамшигдуулжээ.

АНУ-ын Хууль зүйн яамнаас тус санд оруулсан өөрийн улсын хөрөнгийг мөрдөн шалгаж 60 гаруй сая ам.долларыг 2020 онд эргүүлэн татсан байна. Нажиб Разак долоон төрлийн гэмт хэрэгт гэм буруутай нь тогтоогдож 12 жилийн хорих ял, 50 гаруй сая ам.долларын торгуулийн ял авсан байна.

Авлигын хэргээр эрэн сурвалжлагдаж
байсан этгээд хууль бус орлогоо хүлээлгэн
өгөхөөр Хятад улсад эргэн иржээ⁴²¹

2021.04.30. Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж хахууль авсан этгээд хууль бус орлогоо төрд буцаан өгөхөөр Хятадад эргэн ирсэн талаар мэдээллийн Синьхуа агентлагаас мэдээлсэн байна.

Өмнөд Хятадын Гуандун мужийн Жянмэнь хотын Коммунист намын тойргийн хорооны орлогч дарга асан Сянь Голян 2016 оны 04 дүгээр сард гадаад руу оргон зайлсан талаар Синьхуа агентлагаас мэдээлж байсан бөгөөд уг мэдээллийг Хятадын авлигатай тэмцэх бүлгийн бүрэлдэхүүн болох оргосон иргэдийг буцаан авчрах, хөрөнгийг нь буцааж авах үүрэг бүхий хууль сахиулах байгууллагын ажилтан хийсэн юм.

2016 оны 06 дугаар сард Прокурорын газраас түүний хэрэгт мөрдөн шалгалт явуулж, 2019 оны 05 дугаар сард Интерполын улаан жагсаалтад оруулсан.

⁴²⁰ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.jurist.org/news/2021/04/former-malaysia-pm-najib-razak-appeals-corruption-conviction-over-laundering-public-development-funds/#>

⁴²¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/3257702.html>

“Сянь бууж өгсөн нь хууль зөрчсөн хэрэгт сэжиглэгдэж буй албан тушаалтнуудыг илрүүлэхэд Хятад улсын зүгээс сүүлийн үед гарсан ололт амжилтыг харуулж байна” гэж мэдээллийн агентлагаас мэдэгдсэн бөгөөд “цаашид энэ чиглэлээр олон улсын хамтын ажиллагааг эрчимжүүлж, оргодол болон сэжигтнүүдэд шахалт үзүүлэх болно” гэжээ.

Ливаны Төв банкны ерөнхийлөгчийг
авлигын хэрэгт буруутгалаа⁴²²



Ливаны Төв банкны ерөнхийлөгч Риад Салема 2019 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр Ливаны нийслэл Бейрут хотноо хэвлэлийн бага хурлын үеэр. (Фото: Reuters/Мохамед Азакир/)

2021.05.03. Авлигын эсрэг бүлэг нь гадаадын хөрөнгө оруулалт, тэр дундаа олон сая еврогоор тоологдох өмч, хөрөнгийн асуудлаар Ливаны Төв банкны ерөнхийлөгчийн талаарх гомдлыг Франц улсад гаргасан. Эдийн засгийн гэмт хэргийн хохирогчийг хамгаалах Шерпа гэх төрийн бус байгууллагын мэдэгдсэнээр тэрээр Франц дахь үл хөдлөх хөрөнгийг “сэжигтэйгээр” худалдан авсан байна.

Риад Салеме (Riad Salameh) Төв банкны ерөнхийлөгчийн албан тушаалыг 1993 онд хашиж эхлэхээс өмнө олж авсан хөрөнгийн эх үүсвэрийн талаар олон баримт гаргаж өгч байсан хэмээн Ройтерс агентлагийн сурвалжлагчид мэдэгдсэн.

“Франц дахь үл хөдлөх хөрөнгөө тус албан тушаалд очихоос өмнө авсан байсан, үүнийгээ мэдүүлсэн” хэмээн тэрээр мэдэгдсэн байна.

Дээрх гомдолд Салемегийн ах, хүү, хамтрагчид ч бас багтсан хэмээн Шерпагийн хууль бус санхүүгийн урсгалын хөтөлбөрийн тэргүүн Лаура Руссо мэдэгдэв.

“Францад олсон хууль бус орлого, тус улс дахь түүний хөрөнгийн сэжигтэй эх үүсвэр, ялангуяа их хэмжээний гадаадын хөрөнгө оруулалтын асуудлуудыг илчлэх зорилгоор бид ажиллаж байна” хэмээн Руссо Ройтерс агентлагт мэдэгджээ.

⁴²² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.reuters.com/world/europe/activists-file-legal-complaint-over-lebanon-corruption-france-2021-05-03/>

Ливаны санхүүгийн болон улс төрийн томчуудыг зүй бус удирдлага, авлига, олон улсын тусламж авах асуудалд саад тотгор учруулж буй хэмээн олон жилийн турш буруутгаж буй юм.

Салеме дээрх асуудлыг өөрийнх нь эсрэг гүтгэлэг хэмээн мэдэгдсэн байна.

Франц улсад гаргасан 81 хуудас бүхий уг гомдолд Саламегийн гэр бүл, хамтрагчидтай холбоотой олон жилийн туршид Ливанаас хууль бусаар зувчуулан, европ даяар байршуулсан хэдэн зуун сая еврогийн хөрөнгө, компани, хөрөнгө оруулалтын хэрэгслүүдийн талаар хөндсөн байна.

Ливаны залилан, гэмт үйлдлийн хохирогчдын хамтарсан нийгэмлэгийн гомдолд Францын үндэсний санхүүгийн прокуророос ямар нэгэн тайлбар өгөөгүй байна.

Энэхүү гомдолд Ливаны төрийн томоохон 20 өндөр албан тушаалтныг дурдсан байсан ба цаашид банкны эзэд, хувь нийлүүлэгчдэд хамааралтай асуудлыг хөндөх болно гэжээ.

Киргизийн экс Ерөнхий сайдыг уул уурхайн авлигын хэргээр саатуулав⁴²³

2021.05.31. Киргиз улсын аюулгүй байдлын албаныхан тус улсын хамгийн том татвар төлөгч болох асар том алтны уурхайтай холбоотой авлигын хэргийг мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан экс Ерөнхий сайдыг саатуулжээ.

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан мэдэгдэлд 2011-2012 онд Ерөнхий сайдаар ажиллаж байсан Омурбек Бабановыг яллагдагчаар татаж болзошгүй талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй байна.

Энэ хэрэгт холбогдуулан экс Ерөнхийлөгчийн ах Асылбек Жээнбековыг даваа гарагт саатуулсан гэж хэвлэлүүд мэдээлэв.

Мөрдөн шалгах ажиллагаа Кумторын алтны уурхайд гол анхаарлаа хандуулж байгаа ба энэ үйл ажиллагаа нь байгаль орчныг бусниулсан гэх шалтгаанаар удаан хугацааны турш маргаантай байсан бөгөөд засгийн газар тус уурхайг улсын өмч болгох ёстой гэсэн хатуу байр суурь баримталж байна.

Энэ оны 05 дугаар сарын эхээр парламентаас Канадад төвтэй оператор компани болох Centerra-гаас уг уурхайг гурван сарын хугацаанд хяналтдаа авахыг төрд зөвшөөрсөн хууль баталж, байгаль орчныг хамгаалах чиглэлээр гаргасан нэхэмжлэлийн дагуу шүүхээс тус компанид гурван тэрбум долларын торгууль ногдуулсан байна.

Centerra компанийн мэдээлснээр тус уурхай нь хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан Төв Азийн энэхүү орны эдийн засгийн 12-оос илүү хувийг эзэлж байна.

Төрийн албан тушаалтнууд хахуульд виски, хонины мах, сари, ширээний сэнс шаарджээ⁴²⁴

2021.07.04. Энэтхэг. Өнгөрсөн 5 дугаар сард хөдөө аж ахуйн нэгэн фермд үдэшлэг зохион байгуулж байсныг Булдана дахь Авлигатай тэмцэх товчоо (АТТ)-ны ажилтнууд “тараасан” байна. Энэхүү үзэшдэг ердийн нэг үдэшлэг, эсвэл хар тамхитай холбоотой үдэшлэг ч биш, харин өөрсөддөө зориулж үдэшлэг зохион байгуулахыг шаардсан төрийн хоёр албан тушаалтны эсрэг гомдлыг хүлээн авсны дараа АТТ-оос тавьсан нэгэн төрлийн урхи байв.

Саяхан худалдаж авсан газрынхаа бичиг баримтыг авах гэтэл тойргийн ажилтан Вилас Хедекар, талати(тосгоны нягтлан бодогч) Бабуроо Мор нар түүнээс 10,000 рупийн⁴²⁵ хахууль нэхсэн хэмээн гомдол гаргагч мэдэгдсэн байна. Яарч байсан тул гомдол гаргагч уг мөнгийг төлсөн байна. Гэтэл Хедекар, Мор нар бичиг баримтыг нь өгөлгүйгээр, тэдэнд зориулж виски, хонины мах, загасаар дайлах үдэшлэг зохион байгуулах хэрэгтэй гэсэн жигтэй шаардлага тавьжээ.

⁴²³ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.clickorlando.com/business/2021/05/31/kyrgyzstan-detains-ex-prime-minister-in-mine-corruption-case/>

⁴²⁴ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://indianexpress.com/article/cities/mumbai/anti-corruption-bureau-cases-bribes-demanded-by-govt-officials-whiskey-mutton-sarees-table-fan-7387953/>

⁴²⁵ 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Монголбанкны ханшаар 1 рупи 38,19 төгрөгтэй тэнцэж байна.

Үүнд бухимдсан гомдол гаргагч АТТ-нд хандсан аж. Энэ явдал нь Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн хүрээнд хамаарах эсэхийг АТТ хэлэлцэж, улмаар хууль бус шан харамж мөн гэдэг дээр санал нэгдсэн байна.

АТТ-ны ажилтан Вишал Гайквад “Хахуульд өгдөг валютын дэвсгэрт дээр бид ихэвчлэн антрацены нунтаг⁴²⁶ түрхдэг юм. Гэм буруутай этгээд мөнгийг хүлээж авсан тохиолдолд гэрчийг байлцуулан гар дээрээс нь нунтгийг сэргээн бэхжүүлж авдаг. Гэхдээ энэ тохиолдолд бид гэм буруутай этгээдийн бичлэг, дуу хоолойны дээжид л найдах хэрэгтэй болж байна” гэжээ.

Мөнөөх тойргийн ажилтан болон талатид зориулсан үдэшлэгийг 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулахыг АТТ гомдол гаргагчаас хүссэн байна. Уг үдэшлэгийн үеэр хоёр шил Imperial Blue виски, 2 кг хонины мах, 3 кг загасан бүтээгдэхүүнээр тэдэнд үйлчилжээ.

Үдэшлэгийн үеэр АТТ-ны ажилтнууд газар дээр нь очиж Хедекар, Мор нарыг баривчилж, вискиний шил, хонины мах, загасан бүтээгдэхүүнийг нотлох баримт болгон хураан авсан байна.

Дээрх хоёр этгээдийг гурав хоног баривчлаад батлан даалтад гаргасан бөгөөд АТТ тэднийг яллах нотлох баримт цуглуулж байгаа аж. Өнгөрсөн долоо хоногт дуу хоолойн сорьцийг баталгаажуулахын тулд тэдний дуу хоолойны дээж болон бусад дижитал нотлох баримтыг шүүх шинжилгээний лабораторид шинжлүүлэхээр илгээсэн болохыг нэгэн алба хаагч хэллээ.

Сүүлийн хэдэн жилийн хугацаанд төрийн албан хаагчид зөвхөн мөнгө нэхэхээс өөр хэд хэдэн тохиолдол бүртгэгдсэн, “Саяхан нэгэн төрийн албан хаагч гомдол гаргагчаас мөнгөнөөс гадна эхнэр, бэр хоёртоо сари⁴²⁷ авж өгөхийг шаардсан” гэж АТТ-ны ахлах ажилтан хэлж байна.

Зарим тохиолдолд төрийн албан хаагчид албан өрөө тасалгаандаа ашиглах боломжтой хэвлэгч, ширээний сэнс зэрэг эд зүйл шаарддаг байна.

Энэтхэгийн Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуульд авлигыг төрийн албан хаагч албан ажлаа гүйцэтгэхийн тулд шаардаж буй хууль бус шан харамж гэж тодорхойлдог болохыг АТТ-ны хуулийн ажилтан хэллээ. “Шан харамж нь мөнгөн хэлбэртэй байх ёстой гэж уг хуульд заагаагүй. Тиймээс, шан харамжийн ямар ч хэлбэртэй байсан, энэ тохиолдолд виски, загас, хонины мах гэх мэт нь энэхүү хуулийн үйлчлэлийн хүрээнд багтана” хэмээн тэрээр нэмж хэлэв.

КОВИД-19 цар тахалтай холбогдолтой авлигын хэргээр Индонезийн сайд асан 12 жилийн хорих ял сонсжээ⁴²⁸



Индонезийн Нийгмийн асуудал эрхэлсэн сайд Жулиари Батубара 2020 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Индонезийн Жакарта дахь Авлигатай тэмцэх хорооны төв байранд хүрэлцэн ирэх үеэр. (Фото: Хафидз Мубарак / Reuters)

2021.08.23. Индонезийн Нийгмийн хамгааллын сайд асан Жулиари Батубара КОВИД-19 цар тахалтай холбоотой олон сая долларын авлигын хэргийн улмаас 12 жилийн хорих ял сонссон болохыг Жакарта хотын Авлигын гэмт хэргийн шүүх байгууллага даваа гарагт мэдээлэв. Түүнийг цар тахалтай тэмцэхэд зориулагдсан бараа, бүтээгдэхүүн худалдан авах ажиллагааны үеэр бусдаас 32.4 тэрбум рупигийн (2.25 сая доллар) хахууль авсан “авлигын гэмт хэрэгт гэм буруутай” болохыг тогтоосон хэмээн шүүгч мэдэгдсэн юм.

Тендер сонгон шалгаруулалтад хөндлөнгөөс нөлөөлсөн түүнд шүүхээс мөн 500 сая рупигийн торгууль оногдуулж, хувьдаа завшсан 14.5 тэрбум рупийг буцааж төлүүлэх шийдвэр

⁴²⁶ Wikipedia: Антрацен нь ууссан бензолын гурван цагирагаас бүрдэх C₁₄H₁₀ томьёотой хатуу полициклик үнэрт нүүрсустөрөгч юм. Энэ нь нүүрсний давирхайн бүрэлдэхүүн хэсэг юм. Антраценийг улаан өнгийн ализарин болон бусад будагч бодис үйлдвэрлэхэд ашигладаг. Антрацен нь өнгөгүй боловч хэт ягаан туяаны нөлөөн дор цэнхэр (400-500 нм) флюоресценц (өнгө) харуулдаг.

⁴²⁷ Энэтхэг эмэгтэйчүүдийн уламжлалт хувцас.

⁴²⁸ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.reuters.com/world/asia-pacific/ex-indonesian-minister-jailed-12-years-over-covid-19-graft-scandal-2021-08-23/>

гаргажээ. Мөн Жулиариг хорих ял эдэлсний дараа дөрвөн жилийн хугацаанд төрийн албанд ажиллах эрхийг хассан шүүхийн шийдвэр гарчээ.

Жулиари өөрийгөө гэм буруутайг хүлээн зөвшөөрөхгүй байгаа юм. Даваа гарагт түүний өмгөөлөгч Макдир Исмаил прокурорын яллах дүгнэлтэд дурдсан ялын хорих ялын хэмжээг нэг жилээр нэмэгдүүлж хорих ял оноосон явдлыг хэт хатуу гэж тодорхойлж, давж заалдах эсэх асуудлаар шийдвэр гаргахаа мэдэгджээ.

Индонезийн Авлигатай тэмцэх хороо (АТХ)-ноос 2020 оны 12 дугаар сард Жулиариг дөрвөн хүний хамт энэ хэрэгт сэжигтнээр татаад байсан юм. Тухайн үед АТХ-ны мөрдөн байцаагчид Нийгмийн хамгааллын сайд Жулиарийг баривчлахаас нэг өдрийн өмнө түүний нуун далдалсан 1 сая гаруй ам.долларыг илрүүлж байсан юм.

Ерөнхийлөгч Жоко Видодо 2014 онд авлигын эсрэг тэмцэхээ амлан сонгогдсон бөгөөд түүнээс хойш хэд хэдэн өндөр түвшний улс төрчид авлигын хэргээр хорих ял сонсоод байна. Гэсэн хэдий ч тус улсын АТХ-ны эрх, нөлөө суларсан юм.

БНХАУ-ын Хууль зүйн сайд асан Ши Жиньпиний авлигын эсрэг кампанит ажлын бай болсон бололтой⁴²⁹

2021.10.02. БНХАУ-ын Нийгмийг аюулаас хамгаалах яам (НАХЯ)-ны дэд сайд асан Фу Зэнгуа нь намын сахилгын хууль, дүрмийг удаа дараа ноцтой зөрчсөн тул шалгагдаж байгаа гэж бямба гарагт Коммунист намын Төв хорооны Сахилгын хороо мэдэгдсэн байна. Дэлгэрүүлж ямар нэгэн тайлбар өгөөгүй ба нэг өгүүлбэр бүхий мэдэгдэл интернэтэд гарсан.

Яагаад 66 настай Фу кампанит ажлын бай болсон нь тодорхойгүй байна. Тэрээр Бээжингийн Олон нийтийн аюулгүй байдлын албаны даргын албан тушаалыг олон жил хашсан ба 2013-2018 онд НАХЯ-ны дэд сайд, 2018-2020 онд Хууль зүйн яамны сайдын албан тушаалыг хашиж байв.

Авлигын эсрэг кампанит ажлын явцад яллагдсан хамгийн өндөр албан тушаалтан болох Жоу Ёнканьг шалгаж байхад тэрээр Дотоод хэргийн яамны дэд сайд байсан юм. Жоу Ёнкан нь Ши Жиньпины өмнөх удирдагч Ху Жинтаогийн үед БНХАУ-ын Намын улс төрийн товчооны 9 гишүүний нэг, НАХЯ-ны сайд байсан юм.

Хахууль авсан, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, төрийн нууц задруулсан хэргээр Жоуд 2015 онд бүх насаар нь хорих ял оноосон билээ.

Ши Жиньпиныг авлигын эсрэг кампанит ажлаар далимдуулан улс төрийн өрсөлдөгчдөө намнасан асуудалд буруутгадаг ба Жоуг унагаснаар Коммунист нам дахь нэлээд нөлөө бүхий фракцыг булшилсантай адилтгадаг.

Цар тахлын үед ажлаа орхисон, авлигын хэрэгт холбогдсон хэргээр НАХЯ-ны өөр нэг орлогч болох Сунь Лижуньг Намын сахилгын хороо ажлаас огцруулснаас хоёр хоногийн дараа Фуг шалгах болсон тухай мэдэгдэл дурджээ.

Энэтхэгийн Махараштра мужийн Дотоод хэргийн сайд асан Анил Дешмухтай холбоотой авлигын хэрэг дээр Мөрдөн шалгах товчоо эхний баривчилгааа хийлээ⁴³⁰

2021.10.31. Махараштра мужийн Дотоод хэргийн сайд асан Анил Дешмухтай холбоотой авлигын хэрэгт холбогдуулан Сантош Жагтапыг ням гарагт саатуулсан нь олны анхаарлыг татсан авлигын хэргийн анхны баривчилгаа болсон талаар албаны хүмүүс мэдэгджээ. Тус агентлаг Махараштрагийн Тане хотоос зуучлагч гэх Жагтапыг баривчилсан бөгөөд хэрэгтэн өнгөрсөн сард түүнийг баривчлах тушаал гарсны дараа ч мөрдөн шалгах ажиллагаанаас зайлсхийсэн

⁴²⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.ctvnews.ca/world/china-investigates-ex-official-who-led-major-corruption-case-1.5608584>

⁴³⁰ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: https://economictimes.indiatimes.com/news/politics-and-nation/cbi-makes-first-arrest-in-corruption-case-against-ex-maharashtra-home-minister-anil-deshmukh/articleshow/87440241.cms?utm_source=contentofinterest&utm_medium=text&utm_campaign=cpps



Мөрдөн шалгах төв товчоо 08 дугаар сард Жагтапын байранд нэгжлэг хийж, 9 сая рупи бэлнээр хураан авсан гэж албаны хүмүүс мэдэгдэв.

(Фото: economictimes.indiatimes.com)

болохыг албаныхан онцлов. Мөрдөн шалгах товчоо өнгөрсөн 08 дугаар сард Жагтапын байранд нэгжлэг хийж, 9 сая рупи бэлнээр хураан авсан байна.

Тус байгууллага Энэтхэгийн Эрүүгийн хуульд заасан үгсэн хуйвалдах гэмт хэрэг болон Авлигаас урьдчилан сэргийлэх тухай хуулийн заалтын дагуу “төрийн чиг үүргээ шударга бусаар гүйцэлдүүлснийхээ төлөө хууль бус давуу байдал олж авахыг оролдсон” гэсэн үндэслэлээр Дешмух болон бусад “нэр нь үл мэдэгдэх” яллагдагчдыг баривчилжээ.

Парам Бир Сингхийг Мумбай хотын Цагдаагийн комиссарын албан тушаалаас огцруулсны дараа Махараштрагийн сайд Уддхав Таккарейд бичсэн захидалдаа Дешмух

нь Васад хотын бар, ресторанаас сард 1 тэрбум гаруй рупи авж байх талаар хүссэн гэж мэдэгдсэн байна. Өөрөөр хэлбэл, өөрийн албан тушаалын давуу байдал, эрх мэдлийг урвуулан ашиглаж буйн тод илрэл гэж болно. Энэ хэрэгт тухайн үеийн Махараштрагийн Дотоод хэргийн сайд Анил Дешмух болон бусад нэр бүхий этгээдүүд албаны эрх мэдлээ зүй бусаар ашиглан, хүлээсэн үүргээ биелүүлсний төлөө бусдаас хууль бус үйлдэл хийхийг шаардах, улмаар давуу байдлаа ашиглан эрх мэдэл, хөрөнгө мөнгө олж авахыг завдсан нь ийнхүү эл гэмт хэрэгт холбогдох гол үндэслэл болсон талаар анхан шатны мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоосон болохыг Мөрдөн шалгах товчоо (МШТ)-ныхон онцолжээ.

Үнэндээ, МШТ-ны удирдамжийн дагуу уг мэдэгдлүүд нь бүрэн мөрдөн шалгах ажиллагаа явуулахын тулд хангалттай хэмжээний материал бүрдүүлж, улмаар мөрдөлтийн явцад илэрсэн нотлох баримтыг үнэлж ийнхүү урьдчилсан мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлж буйг албаны хүмүүс мэдэгджээ. Мөрдөн шалгах ажиллагааны явцад цагдаагийн байгууллагад 15 гаруй жил ажиллаагүй Вазег Мумбай хотын Цагдаагийн газрын цагдаагийн туслах байцаагчаар томилсон нь тогтоогдсон. Тодруулбал, түүнийг Мумбай хотын цагдаагийн албанд бүртгэгдсэн ихэнх дуулиантай болон онц ноцтой хэрэгт буруутгаж байсан бөгөөд тухайн үеийн Дотоод хэргийн сайд Дешмух үүнийг мэдэж байсан аж. Гэвч Дешмух болон “түүний хамсаатнууд” аливаа нэг албан тушаалтныг шилжүүлэх, томилоход зүй бусаар нөлөөлөхийн сацуу тэдний ажил үүргийн гүйцэтгэлд шударга бус хандаж, өөрсдийн нөлөөллөө үзүүлдэг байсан нь мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдсон байна.

Америк тив

Мексикийн Ерөнхийлөгч асан Пена Нието авлигын хэргээр шалгагдаж байна⁴³¹

2020.02.19. Мексикийн хууль сахиулах байгууллагууд авлигын хэрэгт холбогдуулан Ерөнхийлөгч асан Энрике Пена Нието (Enrique Pena Nieto)-г шалгаж байна хэмээн “Wall Street Journal” лхагва гарагт мэдээллээ.

Мексикийн төрийн өмчит газрын тосны “Petróleos Mexicanos PEMX.UL, буюу Pemex” компанийн гүйцэтгэх захирал асан Эмилио Лозоя (Emilio Lozoya)-г шалгах мөрдөн шалгалтын ажиллагаанд холбогдуулан Пена Ниетог шалгаж байгаа аж.

⁴³¹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.nasdaq.com/articles/former-mexico-president-pena-nieto-investigated-in-corruption-probe-report-2020-02-19>

Бразилийн барилгын компани “Odebrecht SA ODBES.UL”-тай холбоотой хахууль, мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой асуудлаар Лозаяг буруутгасан бөгөөд түүнийг өнгөрөгч долоо хоногт Испаниас баривчилсан билээ.

Дээрх асуудлын талаар Мексикийн хууль сахиулах байгууллагууд ямар нэгэн тайлбар, мэдэгдэл хийгээгүй байна.



Энрике Пена Нието. (Фото: nasdaq.com)

Харин 2012-2018 онд тус улсын Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашиж байсан Пена Нието “Odebrecht” компаниас хахууль авсан эсэх асуудлыг удаа дараа үгүйсгэж байсан юм.

Эквадорын экс Ерөнхийлөгч Корреаг авлигын хэргээр эчнээ шийтгэв⁴³²



Шүүгч коронавирусний халдварын улмаас маск зүүсэн байна. (Фото: AFP)

2020.04.09. Эквадорын дээд шүүхээс тус улсын Ерөнхийлөгч асан Рафаэль Корреаг авлигын хэрэгт буруутган 8 жилийн хугацаанд шоронд хорих шийдвэрийг эчнээгээр гаргав.

Корреа нь Бельги улс руу дүрвэх хүртлээ буюу 2017 он хүртэлх 10 жилийн хугацаанд тус улсыг удирдаж байсан юм.

Корреа болон бусад 19 шүүгдэгчийг гэрээ байгуулсныхаа хариуд хувийн компаниудаас 7.5 сая ам.доллар хахуульд авсан хэрэгт буруутай болохыг шүүхээс тогтоосон байна.

Дээрх этгээдүүдийг мөн ямар нэгэн улс төрийн албан тушаал хашихыг 25 жилийн хугацаанд хориглосон шийдвэр гаргасан байна. Эдний дунд Бразилийн “Odebrecht” компаниас хахууль авсан хэрэгтээ 6 жилийн хорих ял эдэлж буй тухайн үеийн дэд ерөнхийлөгч Хорхе Глас багтаж байгаа аж.

Шүүхийн шийдвэртэй холбогдуулан Корреа: *“Энэ бол тэдний хүсээж байсан зүйл. Сонгуулийн санал хураах хайрцагаар хэзээ ч олж авж чадахгүй зүйлээ авахын тулд шүүхийг ашиглаж байна. Би зүгээр. Хамт ажиллаж байсан нөхөддөө санаа зовж байна. Бид олон улсын түвшинд ялах нь гарцаагүй. Учир нь энэ бүгд инээдтэй байна, гэхдээ хугацаа шаардана”* хэмээн нийгмийн сүлжээгээр жиргэсэн байна.

Гватемалын эрүүл мэндийн ажилтнууд халагдаж, авлигын хэргээр шалгагдаж байна⁴³³

2020.04.22. Гватемал улсын Эрүүл мэндийн яамны Техникийн асуудал хариуцсан дэд сайд Родолфо Галдамез (Rodolfo Galdamez) болон Захиргааны асуудал хариуцсан дэд сайд Хектор Маррокин (Hector Marroquin) нар даваа гарагт ажлаасаа халагдав.

⁴³² Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.bbc.com/news/world-latin-america-52208588>

⁴³³ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/4/21/guatemala-health-officials-fired-investigated-for-corruption>

Коронавируст цар тахлын үеэр эрүүл мэндийн салбарын 8 албан тушаалтан төрийн хөрөнгийг луйвардахын тулд хуйвалдаан зохион байгуулсан хэмээн тус улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх авлигын эсрэг хорооноос мэдэгдсэн юм.

Тус хорооноос холбогдох баримтыг даваа гарагт Авлигын эсрэг тусгай прокурорын товчоонд хүргүүлсэн байна. Хорооноос мэдэгдсэн дээрх 8 албан тушаалтны дунд Галдамез болон Маррокин нар багтаж байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Уг асуудалд эрүүгийн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа тулд ямар нэг мэдээлэл өгөх боломжгүй болохыг тус улсын Эрүүл мэндийн яамны хэвлэлийн төлөөлөгч Ал Жазира агентлагт мэдэгдсэн.

Холбогдох этгээдүүдийн талаарх мэдээлэл ил болоогүй байгаа ч тус улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх авлигын эсрэг хорооны Комиссар Оскар Давила (Oscar Davila) дээрх найман хүний дунд албан тушаалаасаа халагдсан хүмүүс орж байгааг мэдэгдсэн юм.

“Төрийн хөрөнгийн зарцуулалтыг хатуу хянаж байх ёстой энэ цаг үед улсын ашиг сонирхлын эсрэг луйвар хийх зорилгоор хүчээ нэгтгэхийг оролдсон бүтцийг Эрүүл мэндийн яамны дотор илрүүлсэн” хэмээн тус улсын Ерөнхийлөгч Александро Жиамматтей даваа гарагт мэдэгдсэн юм.

Бямба гарагт онлайн мэдээний Plaza Publica цахим хуудсанд Галдамез нь албан тушаалаа хашиж байх хугацаандаа худалдан авах ажиллагаанаас ашиг хүртэж байсныг илчилсэн юм.

[Авлигын хэрэгт ялагдсан Филадельфи хотын Тойргийн прокурор асан хугацаанаасаа өмнө шоронгоос суллагдав](#)⁴³⁴

2020.04.30. Тус хотын Ерөнхий прокуророор 2010 оноос 2017 он хүртэл ажиллаж байгаад авлигын хэргээр 5 жилийн хорих ял авсан Сет Уилиамс Холбооны шоронд хоригдож байгаад хугацаанаасаа өмнө суллагдаж байна.

Түүний өмгөөлөгчийн хэлснээр Уилиамс хоригдож байхдаа мансууруулах бодисын хамаарлаас ангижруулах хөтөлбөр болон дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх зорилгоор зохион байгуулдаг бусад хөтөлбөрүүдэд хамрагдсаныхаа дараа ийнхүү хугацаанаасаа 2 жилийн өмнө суллагджээ.

Уилиамс нь Хотын Ерөнхий прокуророор ажиллаж байхдаа бэлэн мөнгө болон бусад хэлбэрээр хахууль авах, хөрөнгө завших зэрэг гэмт хэрэг үйлдсэн бөгөөд шүүх хурлын явцад гэм буруугаа хүлээн зөвшөөрч албан тушаалаасаа огцорсон. Мөн тэрээр үйлдсэн хэргээ хүлээсний үндсэн дээр тохиролцоо хийж, харьцангуй хөнгөн буюу 5 жилийн хорих ялаар шийтгүүлсэн. Тухайн үед шүүгч энэ хэргийн талаар “шүүгдэгч албан тушаалаа “шимэгчдэд” худалдсан” гэж тодорхойлж байв.

[Алексион Фармасевтикалс хахуулийн хэрэгтээ 25 сая доллар төлөх тохиролцоонд хүрэв](#)⁴³⁵

2020.05.06. Бостонд байдаг Алексион Фармасевтикалс Инк. Компани хахуулийн эсрэг хуулийг зөрчсөн асуудлаа хүлээн зөвшөөрч, 25 сая ам.доллараар торгуулах тохиролцоонд хүрлээ.

АНУ-ын Үнэт цаас, биржийн хорооноос 2015 оны 05 дугаар сараас эхлэн тус компанийг гадаадын хэд хэдэн, тухайлбал Бразил, Колумб, Япон, ОХУ зэрэг улс дахь үйл ажиллагаа нь ГАҮАТХ-ийг зөрчсөн үндэслэлээр шалгаж байсан бөгөөд мөн оны сүүлээс АНУ-ын Хууль зүйн яам мөрдөн шалгалтыг давхар эхлүүлээд байсан.

Компанийн зүгээс засгийн газартай тохиролцоонд хүрснээр Хууль зүйн яамны мөрдлөгийг хаасан байна.

⁴³⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.beaumontenterprise.com/news/article/Ex-Philadelphia-DA-leaves-prison-early-in-15237423.php>

⁴³⁵ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.wsj.com/articles/alexion-pharmaceuticals-strikes-tentative-25-million-bribery-settlement-11588785508>

2020.05.13. Хуулийн Моррисон ба Фоерстер компаниас энэ оны дөрөвдүгээр сард болж өнгөрсөн авлигатай тэмцэх чиглэлийн үйл ажиллагаануудаас хамгийн чухал ач холбогдолтой арвыг нь онцлон нэрлэж байна.

1. *ЭЗХАХБ дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас авлигын эрсдэл нэмэгдэж байгааг анхааруулав*

Дөрөвдүгээр сарын 22-ны өдөр тус байгууллагын Хахуулийн асуудлаарх Ажлын хэсгээс “Коронавирусний эсрэг авж хэрэгжүүлж байгаа дэлхий нийтийн хүчин чармайлт нь хахуулийн улмаас саарах ёсгүй. Энэхүү цар тахал нь авлигад таатай хөрс суурь болж байна. Одоогоор мэдэгдээд байгаа хил дамнасан олон тооны авлигын хэргүүд эрүүл мэндийн салбарт гарсан. Хахуулийн улмаас хүн амын эрүүл мэндэд зайлиггүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл хүрэх ёстой газартаа хүрч чадахгүй байгааг анхааралдаа авах хэрэгтэй байна. Эрүүл мэндийн бүтээгдэхүүн болон эмийн түгээлтийн үйл ажиллагаанд хууль дүрмийг чандлан сахиж, ил тод байдлыг хангах шаардлагатай байна” гэж мэдэгдсэн.

2. *Италийн газрын тосны компани хахуулийн хэргээ шийдвэрлүүлэх тохиролцоонд хүрэв*

Италийн газрын тосны Eni S.p.A. компани ГАҮАТХ-ийн нягтлан бодох бүртгэл болон дотоод хяналттай холбоотой заалтуудыг зөрчсөн зөрчлөө шийдвэрлүүлэхээр АНУ-ын Үнэт цаас, биржийн хороо (ҮЦБХ)-той тохиролцоонд хүрсэн талаар тус хорооноос 2020 оны 04 дүгээр сарын 17-нд мэдэгдэл хийлээ.

ҮЦБХ-ны шийдвэрт дурдсанаар Eni-гийн охин компани Алжир улсын төрийн өмчит газрын тосны компанитай гэрээ байгуулахад тусалсан зуучлагчид 2007-2010 оны хооронд ойролцоогоор 198 сая еврог шилжүүлжээ. Энэ мөнгөний тодорхой хэсэг Алжирийн төрийн албан тушаалтанд очсон нь Италийн компанийг буруутгах үндэслэл болсон байна.

3. *Санхүүгийн үйлчилгээний компанийн гүйцэтгэх захирал асныг ҮЦБХ хахуулийн хэрэгт татав*

Англид байрлан үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн үйлчилгээний компанийн гүйцэтгэх захирал асан Асанте Берко ГАҮАТХ-ийн хахуулийн эсрэг заалтууд болон холбооны үнэт цаасны хуулиудыг зөрчсөн тул хэрэгт татаад байгааг АНУ-ын ҮЦБХ 2020 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр зарлав.

Гана улсад цахилгаан станц барих тендер авахад нь Туркийн эрчим хүчний компанид туслахын тулд Берко 2015-2016 онд Ганын засгийн газрын албан тушаалтнуудыг хахуульдах үйл ажиллагааг санаачлан зохион байгуулжээ.

4. *Эрчим хүчний компанийн борлуулалтын менежер асан гадаадын төрийн албан хаагчийг хахуульдсан хэрэгт ял сонсов*

Эрчим хүчний Алстом компанийн Коннектикат муж дахь салбарын бүс нутгийн борлуулалтын менежер асан Ларри Пукетт 100 цагийн нийтэд тустай ажил хийх болон 5,000 доллароор торгох ялаар шийтгүүлэв. Тэрээр Алстом компанийн гүйцэтгэх захирал асан Лоренс Хоскинс болон бусад хүмүүстэй хамтран Индонезийн засгийн газраас зарласан цахилгаан станцын тендерт ялахын тулд тус улсын төрийн албан тушаалтнуудыг хахуульдахаар үгсэн хуйвалдсан буруутай гэдгээ 2013 онд бүрэн хүлээн зөвшөөрсөн юм.

Пукетт нь хамт хэрэг үйлдсэн Хоскинсийн талаар шүүх хуралд мэдүүлэг өгснөөр 2019 оны 11 дүгээр сард Хоскинсод 15 сарын хорих ял оноох боломжтой болсон юм. Коронавирусний цар тахлын дэгдэлтийн улмаас Пукеттийн шүүх хурлыг зайнаас, видеогоор явуулжээ.

5. *Олон улсын хөлбөмбөгийн холбоо (ОУХБХ)-ны хахуулийн хэрэг дээр зарим шийдвэр гарав*

⁴³⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.jdsupra.com/legalnews/top-10-international-anti-corruption-68995/>

ОУХБХ-ны хахуулийн хэрэгт хэвлэл мэдээлэл, спортын маркетингийн компаниудын албан тушаалтнууд нэмж татагдан, банкууд, үндэсний хөлбөмбөгийн холбоодын албан тушаалтнуудтай холбоотой шийдвэр гарлаа.

АНУ-ын 21 дүгээр зуун Фокс Инк компанийн Спортын маркетингийн захирал асан 2 хүн, Испанийн мэдээллийн компанийн гүйцэтгэх захирал асан, Уругвай улсын спортын маркетингийн компанийн гүйцэтгэх захирал асан хүмүүс мөнгө угаасан, залилан мэхэлсэн болон авлигын бусад хэргээр шалгагдаж эхлэв.

Израилийн хамгийн том банк болох Банк Напоалим Б.М. болон түүний Швейцари дахь салбар нь спортын маркетингийн компаниудаас ОУХБХ-ны албан тушаалтнуудыг хахуульдахын тулд ашигласан 20 сая долларыг угаасан хэрэгт буруутай болохоо хүлээн зөвшөөрч, 20.7 сая долларыг хураалган, 9.3 сая доллароор торгууллаа.

6. *Лондонгийн шүүхээс улс төрд нөлөө бүхий этгээдийн өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэр гаргав*

2018 оны 01 дүгээр сараас хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Хууль бус санхүүжилтийн тухай 2017 оны хуулиар Нэгдсэн Вант Улсын нутаг дэвсгэр дэх эх үүсвэр нь тодорхой бус хөрөнгийн эх үүсвэрийг тайлбарлуулах, ингэж чадахгүй бол хураах шийдвэр гаргаж болох зохицуулалтыг бий болгосон юм.

Авлигын хэрэгт холбогдсон этгээдээс хөрөнгийн эх үүсвэрээ тайлбарлахыг шаарддаг энэхүү зохицуулалт улс төрд нөлөө бүхий этгээдэд холбогдох 50 мянган фунтээс дээш хэмжээний хөрөнгөд хамаардаг.

Энэ хууль хүчин төгөлдөр болсноос хойш хэд хэдэн тохиолдол дээр хэрэглэсэн байна.

2020 оны 04 дүгээр сарын 08-нд Английн Эрүүгийн хэрэг мөрдөх газраас гаргасан захирамжийг Лондонгийн шүүх хүчингүй болгожээ. Энэхүү захирамжийг Казахстан улсын Ерөнхийлөгч асан Нурсултан Назарбаевийн хамаатнуудтай холбоотой Лондон дахь гурван үл хөдлөх хөрөнгийг эзэмшдэг компаниудтай холбогдуулан гаргасан байсан юм. Хууль сахиулах байгууллагын зүгээс нийт 80 сая фунтын үнэ бүхий эдгээр үл хөдлөх хөрөнгө нь хууль бус эх үүсвэртэй гэж үзсэн боловч шүүхийн зүгээс нотлох баримт хангалтгүй байна гэж үзжээ.

7. *АНУ-ын Хууль зүйн яам Малайзын баялгийн сангийн 300 сая долларыг улс оронд нь буцаан шилжүүлэх шийдвэр гаргав*

Хууль зүйн яам 2020 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр Малайз цлсын Хөгжлийн сангаас хууль бусаар завшсан 300 сая долларыг буцаан өгч байгаагаар зарлав. Хууль зүйн яамны мэдэгдэлд дурдсанаар Малайзын Хөгжлийн сангаас ашиглан завшсан нийтдээ 1 тэрбум орчим долларын хөрөнгийг АНУ-ын нутаг дэвсгэрт илрүүлэн, битүүмжилсэн бөгөөд үүнээс 600 орчим сая долларыг Малайзад эргүүлэн өгсөн байна.

8. *Интер-Америкийн Хөгжлийн банк Бразилийн барилгын компанид хориг тавив*

Интер-Америкийн Хөгжлийн банкны санхүүжилттэйгээр Бразилд хэрэгжүүлсэн дөрвөн төслийг гүйцэтгэх явцдаа авлигын шинжтэй үйл ажиллагаа явуулсан тул Andrade Gutierrez Engenharia S.A. (AG Engenharia) компанид тус банкнаас 37 сарын хориг тавилаа. Төсөл гүйцэтгэгчийн эрхийг олж авахын тулд засгийн газрын эрх бүхий албан тушаалтнуудад хахууль өгсөн гэдгээ компанийн зүгээс хүлээн зөвшөөрсөн бөгөөд хахуулийн хэмжээ нь 60 сая долларт хүрч магадгүй байна.

Тус компани энэхүү хууль бус үйл ажиллагаанаас гадна өөр хэргүүдэд холбоотой бөгөөд тухайлбал, “Машин угаалга” ажиллагааны дүнд илэрсэн авлигын хэрэгт холбоотой юм. 2018 онд тус компанийн өмнө үйлдсэн авлигын хэрэг дээрээ торгууль төлөх тохиролцоонд хүрч засгийн газарт 381.5 сая доллар төлж байсан.

9. *АХБ-наас Авлигатай тэмцэх үйл ажиллагаа ба шударга байдлын 2019 оны тайланг гаргалаа*

АХБ-ны Авлигатай тэмцэх ба Шударга байдлын газраас 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдөр 2019 оны жилийн тайлангаа нийтэд танилцуулав.

Тайланд тусгаснаар, АХБ-наас 2019 онд тус банкны Авлигын эсрэг бодлогыг зөрчсөн үндэслэлээр 69 компани болон 62 хувь хүнд хориг тавьжээ.

10. Колумб улс ЭЗХАХБ-д албан ёсоор нэгдэн оров

Колумб улс 2012 оны 01 дүгээр сард ЭЗХАХБ-ын Хахуулийн эсрэг конвенцод нэгдэж, Хахуулийн асуудлаарх ажлын хэсгийн гишүүн болоод байсан. Гэхдээ тус улс ЭЗХАХБ-ын бүрэн хэмжээний гишүүнчлэлийн эрхтэй болоогүй байв.

Колумб 37 дахь гишүүн улс болсныг тус байгууллагаас 2020 оны 04 дүгээр сарын 28-нд албан ёсоор зарлав. Ингэснээр Мексик, Чилийн дараа Латин Америкийн гурав дахь улс тус байгууллагын гишүүн болж байна.

Венесуэлийн авлигачдын 2 сая долларыг угаасан хэрэгт Америкийн профессор гэм буруугаа хүлээн зөвшөөрөв⁴³⁷

2020.06.01. Венесуэлийн төрийн албан тушаалтны авлига, хахуулийн сүлжээний үйл ажиллагаанаас олсон 2 сая гаруй ам.долларыг Флорида дахь компани болон хувийн дансаа ашиглан угаасан хэрэгт ял сонсоод байсан Майамигийн Их сургуулийн профессор Брюс Багли гэм буруугаа хүлээн зөвшөөрөв.

Хар тамхи, мөнгө угаах асуудлаар олон улсын хэмжээний эрдэмтэн гэгддэг Багли 2019 оны 11 дүгээр сард баривчлагдсаныхаа дараа буруугүй болохоо илэрхийлж байсан ч өнгөрөгч 03 дугаар сард мэдүүлгээ өөрчлөх тухай өргөдөл гаргаад байсан юм.

“Хар тамхины худалдаа, зохион байгуулалттай гэмт хэргийн асуудлаар ном бичсэн Брюс Багли гэмт хэргээ хүлээн зөвшөөрлөө” хэмээн АНУ-ын Нью Йорк хотын Өмнөд дүүргийн прокурор Жеффри С.Берман хэвлэлийн бага хурлын үеэр мэдэгдсэн байна.

73 настай профессорт ял оногдуулах шүүх хурал 10 дугаар сарын 01-ний өдөр товлогдсон байсан бөгөөд мөнгө угаасан хэрэг тус бүрд хамгийн ихдээ 20 жилийн хорих ял оногдуулах боломжтой.

“Өнөөгийн Америк дахь мансууруулах бодисын худалдаа, зохион байгуулалттай гэмт хэрэг, хүчирхийлэл” зэрэг хэд хэдэн ном бичсэн Багли өөрийнхөө байгуулсан компанийн дансаар Швейцари, Арабын Нэгдсэн Эмират улсаас сар бүр 200,000 ам.долларын хадгаламж хүлээн авж байсан хэмээн шүүхийн баримтад дурдсан байна.

2017 оны 11 дүгээр сараас 2018 оны 10 дугаар сарын хооронд түүний компанийн дансанд гадаадаас ойролцоогоор 2.5 сая ам.доллар шилжин оржээ.

Эквадор улсын Ерөнхийлөгч асан эм, эмнэлгийн хэрэгсэл худалдан авахтай холбоотой авлигын хэргээр гэрийн хорионд орсон байна⁴³⁸



Абдала Букарам. (Фото: fiscalia.gob.ec)

2020.06.05. Ерөнхийлөгч асан Абдала Букарамд гэрийн хорио тогтоосон талаар Эквадор улсын Ерөнхий прокурорын газраас мэдээлсэн байна.

Тус улсын хууль хяналтын байгууллагын ажилтнууд түүнийг нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлдэг эмнэлэгт зориулан эм, эмнэлгийн хэрэгсэл өндөр үнээр худалдаж авсан гэж

⁴³⁷ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: https://www.bakersfield.com/ap/national/professor-pleads-guilty-to-laundering-2-million-in-proceeds-from-venezuelan-corruption/article_15096d49-ccfd-554f-9b9f-a14a4c04a3e6.html

⁴³⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://focus.ua/world/456752-eks-prezident-ekvadora-otpravlen-pod-domashnii-arest-po-delu-o-korrupsii-pri-zakupke-medikamentov>

үзэн мөрдөн шалгах ажиллагааны хүрээнд гэрт нь нэгжлэг хийсэн байна.

Нэгжлэгийн явцад хайрцагтай эм бэлдмэл (5,000 амны хаалт, КОВИД-19-ийг илрүүлэх 2,000 ширхэг түргэвчилсэн шинжилгээ) болон зөвшөөрөлгүй гар буу, хэд хэдэн хайрцаг сумыг илрүүлэн, хураан авсан байна. Иймд хууль бусаар галт зэвсэг эзэмшсэн хэрэгт холбогдуулан дахин мөрдөн шалгах хэрэг нээсэн бөгөөд Ерөнхийлөгч асанд 5-7 жилийн хорих ял оногдуулах магадлалтай гэсэн байна.

Прокурорын байгууллага Ерөнхийлөгч асныг баривчлах зөвшөөрөл хүсэн шүүхэд хандсан бөгөөд сэжигтэн 68 настай, эрүүл мэндийн хувьд асуудалтай тул түүнийг 30 хоног гэрийн хорионд байлгах шийдвэр гаргасан байна.

Абдала Букарам нь 1996-1997 онд Эквадорын Ерөнхийлөгчийн албан тушаалыг хашиж байсан. 1997 оны 02 дугаар сард түүнийг буруутган ял тулгасан. Эквадор улсын Үндэсний Конгресс (парламент) түүнийг “оюун ухааны хомсдолтой” гэж буруутгасан бөгөөд түүхэнд анх удаа оюун ухааны хомсдолтой гэсэн үндэслэлээр төрийн тэргүүнээ албан ёсоор буруутгасан байна.

Букарам нь Ерөнхийлөгчөөр томилогдсоныхоо дараа боловсролын систем, нийгмийн халамжийн тогтолцоог сайжруулах талаар өгсөн амлалтаа биелүүлж байгаа учир дуу дуулж, хөл бөмбөг тоглож, зах дээр очин хоол идэж байгаад санаа зовох хэрэггүй гэж мэдэгдэж байжээ. Тэрээр концертоо үргэлжлүүлэн тоглож, цомог гаргаж, Цэргийн нисэх хүчний онгоцны нисгэгч болж, зурагтын цэнгээнт нэвтрүүлэгт тогтмол оролцож, өөрийгөө өдөр бүрийн гол мэдээний эх сурвалж болгож байв.

Букарам засгийн газрын хурал, уулзалтаа янз бүрийн хотуудад ээлжлэн зохион байгуулж, ард түмэнд ойртож очин мэндэлж, тэвэрч, олон түмэнд ойр улс төрчийн дүрийг бүрдүүлж байсан юм. Тэрээр нийслэл Кито хот дахь Ерөнхийлөгчийн ордонд амьдрахаас татгалзаж Гуаякилья хотод байх өөрийн гэртээ амьдардаг байв.

Ард иргэд түүнийг янз бүрийн өнцгөөс олон талаас нь шүүмжилж байсан. Түүнийг ах дүү, төрөл саднаа төрийн албанд оруулсан гэж буруутгасан. Тэрээр ахыгаа сайдаар, хүүг нь Гаалийн газрын даргаар томилсон, хэд хэдэн найзууд нь сайд болсон байна.

Удалгүй улс оронд нь хүнд хямрал үүссэн. 1997 оны 01 дүгээр сард Ерөнхийлөгч Букарамыг эсэргүүцэж зүүнтнүүд, консерваторууд, уугуул иргэд нэгдэв. Эсэргүүцлийн үйл ажиллагаанд өмнөх ерөнхийлөгчид, хотуудын захирагч нар мөн нэгдсэн байна. Хоёр сая гаруй хүн оролцсон томоохон хэмжээний эсэргүүцлийн жагсаалын дараа 1997 оны 02 дугаар сарын 06-нд тус улсын Үндэсний Конгресс Букарамыг эмнэлгийн дүгнэлтгүйгээр “оюун ухааны хомсдолтой” гэсэн дүгнэлт гаргаж, түүнд итгэл үзүүлэх эсэх асуудлаар санал хураалт явуулсан байна.

Тус улсын үндсэн хуулийн цэц уг санал хураалтыг хууль зөрчсөн гэж үзсэн боловч Ерөнхийлөгчийг эсэргүүцэгчид уг шийдвэрт анхаарал хандуулаагүй байна.

“Миний тэмцэж чадахгүй байгаа олигархиуд намайг Ерөнхийлөгчийн албан тушаалаас зайлуулсан” гэж Букарам мэдэгдэв. Тэрээр тус улсаас зугтаж хөрш Панамд очин улс төрийн орогнол авсан байна. Букарам нь улсын хөрөнгийг шамшигдуулсан хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссаны дараа 2017 онд эх орондоо буцаж ирсэн юм.

АНУ-ын Дээд шүүх Макаогийн тэрбумтаны давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгов⁴³⁹

2020.06.29. АНУ-ын Дээд шүүхээс даваа гарагт Макаогийн тэрбумтан, үл хөдлөхийн бизнес эрхлэгч Нг Лап Сенг-ийн давж заалдсан гомдлыг хэрэгсэхгүй болгов. Олон тэрбум долларын өртөг бүхий уулзалтын танхим барих зорилгоор НҮБ-ын хоёр элчин сайдад хахууль өгсөн хэргээр түүнийг 4 жилийн хугацаанд хорих ялыг 2019 онд оногдуулсан билээ.

⁴³⁹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.nytimes.com/reuters/2020/06/29/world/asia/29reuters-usa-court-ng.html?auth=login-facebook>

Прокуророос Нг Лап Сенг-ийг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн тэргүүн, Антигуа-Барбудагийн элчин сайд асан Жон Эш болон НҮБ-ын Доминикан улс дахь элчин сайдын орлогч асан Фрэнсис Лоренцо нарт хахууль өгсөн хэрэгт буруутгаж байсан билээ.

Нг Лап Сенг нь Пенсильвани мужийн шоронд хоригдож байгаа бөгөөд 2022 оны 01 дүгээр сараас суллагдах боломжтой юм.

[Панамын Ерөнхийлөгч асан Рикардо Мартинелли авлигын хэрэгт холбогдлоо](#)⁴⁴⁰



Рикардо Мартинелли 2019 онд улс төрийн өрсөлдөгчөө тагнаж чагнасан хэрэгтээ ялаас чөлөөлөгдсөн боловч түүнд авлигын хэргээр шинээр ял тулгав. (Фото: AFP / Маурисио Валензуела)

2020.07.01. Улс төрийн өрсөлдөгчөө тагнасан асуудлаар шалгагдан цагаадаад байсан Панамын Ерөнхийлөгч асан Рикардо Мартинеллиг ердөө 8 сарын дараа авлигын хэргээр шалгаж эхэлснийг түүний өмгөөлөгчдийн нэг лхагва гарагт мэдээллээ.

Нийслэл Панама хот дахь прокурорын байрны гадаа Мартинеллигийн өмгөөлөгч сэтгүүлчдэд хандан мэдэгдэл хийхдээ “Тэд түүнийг буруутгасан” хэмээн мэдэгдсэн юм.

Тус улсын Ерөнхийлөгчийн албан тушаалыг 2009-2014 оны хооронд хашиж байсан Мартинелли 2015 онд АНУ руу зугтсан бөгөөд түүнийг 2018 онд шилжүүлэн авж, саатуулан шалгаж байсан билээ.

[АНУ-ын Охайо мужийн хууль тогтоох байгууллагын даргыг авлигын хэргээр баривчилсан байна](#)⁴⁴¹

2020.07.22. Охайо мужийн хууль тогтоох байгууллагын доод танхимын дарга Ларри Хаусхолдерийг авлигын хэрэгт буруутган баривчилсан талаар тус мужийн Өмнөд тойргийн Холбооны прокурорын газрын хэвлэлийн албанаас 07 дугаар сарын 21-ний өдөр мэдээлсэн байна.

⁴⁴⁰ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.ibtimes.com/panama-ex-president-martinelli-facing-corruption-charges-3004043>

⁴⁴¹ Орчуулсан: Л.Анхныбаяр Эх сурвалж: <https://regnum.ru/news/accidents/3016332.html>

ХМТ-ны ажилтнууд Хаусхолдерийн туслах болон өөр 3 этгээдийг мөн баривчилсан талаар Прокурорын газрын мэдээлэлд дурджээ. Хууль сахиулах байгууллагуудын мэдээлснээр дээрх этгээдүүдийг тус муж улсад байрлах цөмийн 2 цахилгаан станцад 1 тэрбум орчим ам.долларын санхүүгийн дэмжлэг үзүүлэх төлөвлөгөөг хууль тогтоогчдоор батлуулах зорилготой хуйвалдаанд оролцсон гэж үзсэн байна. Бүгд найрамдах намын гишүүн болох Хаусхолдерийг цөмийн цахилгаан станцад санхүүгийн дэмжлэг үзүүлэхийг дэмжиж байсан компаниудаас олон саяын хахууль авсан гэж сэжиглэж байгаа юм.

Баривчлагдсан этгээдүүдийг 2017 оны 03 дугаар сараас 2020 оны 03 дугаар сарын хооронд 60 хүртэлх сая ам.долларын өртөг бүхий хахууль авсан байж болзошгүй хэмээн сэжиглэсэн байна. Хахууль авсан нь нотлогдвол 20 хүртэлх жилийн хорих ял оногдуулах юм байна.

Хотын зөвлөлийн гишүүнд хахууль өгснөө хүлээн зөвшөөрөв⁴⁴²

2020.08.06. АНУ. Холбооны засгийн газрын тэтгэмж авахын тулд Даллас хотын зөвлөлийн гишүүнд хахууль өгснөө үл хөдлөх хөрөнгийн бизнес эрхэлдэг 44 настай Девин Халл хүлээн зөвшөөрсөн тухай АНУ-ын Техас мужийн Хойд дүүргийн Ерөнхий прокурор Ерин Нэлий Кокс мэдэгдэв. *“Бид авлигатай бүх талаар тэмцэнэ хэмээн зарласан. Хахууль өгөгч, авагч, зуучлагч гэх мэт бүх талуудтай тэмцэнэ. Энэ хэрэг авлигаар улс төрийн нөлөөллийг худалдан авсан этгээд ба татвар төлөгчдийн мөнгөөр халаасаа зузаатгахыг хүссэн хотын зөвлөлийн гишүүнд хамаарах хэрэг юм. Даллас хотын иргэдийн итгэлийг олж, сонгогдсон хүмүүс “зөвхөн” хотын эрх ашгийг сэтгэлийн гүндээ эрхэмлэсэн ба төсвийн хөрөнгийн зарцуулалтад саад болсон эсэхийг сонгогчид мэдэж байх эрхтэй. Бид хотын захиргаа авлигаас ангид болох хүртэл ХМТ-той хамтран авлигатай тэмцэх болно”* хэмээн тэрээр нэмж хэлэв.

“Татвар төлөгчид болон бизнес эрхлэгчид төрийн худалдан авалтын ажиллагаа шударга, ямар нэгэн нөлөөлөлгүйгээр явагдана гэсэн хүлээлттэй байдаг. ХМТ-ны хувьд төрийн авлигатай тэмцэх явдал тэргүүлэх чиглэл байх болно. Бид цаашид ч олон нийт, хамтрагчдын оролцоотойгоор төрийн албан хаагчдад нөлөөлөхийн тулд хахууль хэрэглэж буй этгээд, байгууллагыг илрүүлж, хариуцлага тооцох чиглэлээр ажиллах болно” хэмээн ХМТ-ны Далласын салбарын ажилтан Мэтью Десарно мэдэгдэв.

Девин Халлыг 2013-2015 онд Даллас хотын зөвлөлийн гишүүнд 8,000 ам.доллар төлсөн асуудалд буруутайд тооцсон. Тэрээр уг хэргийн шүүх хурлыг хүлээж буй бөгөөд Холбооны хорих ангид 5 хүртэл жилээр хоригдох ял авж болзошгүй байна.

Авлига, хахуулийн асуудалд холбогдсон 1,040 төрийн албан хаагчийг ажлаас чөлөөлжээ⁴⁴³

2020.08.17. Мексикийн Үндэсний харьяатын газрын Дотоод хяналтын албаны шалгалтаар хахууль, авлигын асуудалд холбогдсон 1,040 албан хаагч ажлаасаа халагдсан хэмээн тус байгууллагын дарга мэдэгдэв.

Үндэсний харьяатын газрын албан тасалгаанд нууц камер байрлуулсан ба сонирхолтой үйлдлүүдийг илрүүлсэн хэмээн тус байгууллагын дарга Франциско Гардуно ярив. Албан тушаалтнууд үйлчлүүлэхээр ирсэн иргэдээс мөнгө нэхэх, төрийн үйлчилгээ авахад бөглөдөг маягтуудыг зарах (үнэгүй байдаг), виз мэдүүлэх, сунгуулахад мөнгө нэхэх, гадаадын иргэдийн өмнөөс маягт бөглөх, үйлчилгээ авахаар хандах гадаадын иргэдэд үйлчлэх хүмүүс мөнгө нэхэх зэрэг үйлдлүүд байгааг илрүүлсэн хэмээн тэрээр мэдэгдсэн байна. Албан ёсоор цагаачлахаар ирсэн гадаадын иргэдэд *“бид анхаарал хандуулах ёстой”* хэмээн тус байгууллагын дарга Гардуно мэдэгдэв.

⁴⁴² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.justice.gov/usao-ndtx/pr/real-estate-developer-admits-bribing-city-council-member>

⁴⁴³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.borderreport.com/hot-topics/immigration/mexico-sanctions-1040-immigration-officers-for-corruption/>

Хотын хуучин дарга, түүний туслах нарын авлигын хэргийг 01 дүгээр сард шүүнэ⁴⁴⁴

2020.10.16. Авлигын хэрэгт буруутгагдаад буй Массачусетс мужийн Фолл Ривер хотын захирагч асан болон түүний Тамгын газрын даргыг шүүх хурал ирэх оны эхээр товлогджээ.

Нэгдсэн Улсын Дүүргийн шүүхийн шүүгч Дуглас Вудлок энэ долоо хоногт болсон шүүх хуралдааны үеэр Фолл Ривер хотын захирагч асан Жэсиел Корреиа ба Ген Андраде нарын шүүх хурлыг 01 дүгээр сарын 13-нд эхлүүлэхээр төлөвлөж байна гэж хэлснийг Herald News мэдээлэв.

Өмгөөлөгчдийнх нь эсэргүүцлийг үл харгалзан тэднийг хамтад нь шүүж байгаа бөгөөд шүүх хурлыг 05 дугаар сард хийх байсан боловч КОВИД-19 цар тахлын улмаас хойшилсон юм.

Захирагч Корреиад холбооны хуулийг үндэслэн нийт 24 ял⁴⁴⁵ сонгосон ба прокуроруудын зүгээс түүнийг хотод нь бизнес эрхлэх гэж байсан марихуаны наймаачдаас 600,000 ам.долларын⁴⁴⁶ хахууль авсан, гар утасны аппликейшний компанийнхаа хөрөнгө оруулагчдаас 300,000 орчим ам.доллар луйвардсан гэж нотлож буй юм.

Андрадегийн хувьд марихуаны худалдаа болон хахуулийн хэрэг үйлдэхэд нь захирагч Корреиад Тамгын газрын даргынхаа хувиар туслалцаа үзүүлсэн хэргээр зургаан зүйл ангиар ял сонсоод байна.

Тэд хоёулаа энэхүү мэдэгдлийг удаа дараа няцааж, энэ нь улс төрийн зорилготой хэмээж байв.

Андрадегийн өмгөөлөгч Чарльз Ранкин, Корреиагийн өмгөөлөгч Кевин Реддингтон нар коронавирусын эрсдэл үргэлжилсээр байгааг харгалзан шүүх хурлыг хойшлуулахыг хүссэн байна.

60 сая долларын хахуулийн хэрэгт холбогдсон гүйцэтгэх захирал үүрэгт ажлаасаа халагдлаа⁴⁴⁷

2020.10.31. АНУ. Охайо мужийн хамгийн хүчирхэг улс төрчдийн нэгтэй холбоотой 60 сая долларын хахуулийн сүлжээ гэмт хэрэгт оролцсон хэргээр шалгагдаж байгаа эрчим хүчний компани дотоод хяналт, шалгалт хийснийхээ дараа гүйцэтгэх захирлаа ажлаас нь чөлөөлжээ.

First Energy компанийн хийсэн дотоод шалгалтаар гүйцэтгэх захирал Чак Жонс болон бусад 2 албан тушаалтан байгууллагын бодлого, ёс зүйн дүрмийг зөрчсөн нь тогтоогдсон тул пүрэв гарагт ажлаас нь халж байгаагаа мэдэгдлээ.

Компанийн зүгээс хийсэн шалгалт нь засгийн газраас явуулж буй мөрдөн шалгах ажилтай холбоотойгоор хийгдсэн гэж мэдээлсэн ч дотоод шалгалтын явцад илрүүлсэн зүйлсийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй байна.

Өмнө нь First Energy компанийн эзэмшиж байсан олон жил ашигласан цөмийн 2 цахилгаан станцыг авж үлдэхэд чиглэсэн хуйвалдаанд оролцсон 2 албан тушаалтан гэм буруугаа хүлээн зөвшөөрснөөс хэдхэн цагийн дараа тус компани гүйцэтгэх захирлаа халж байгаагаа мэдэгджээ.

Өнөөг хүртэл First Energy компани болон тэдний удирдлагууд хууль зөрчсөн үйлдлээ хүлээн зөвшөөрөөгүй бөгөөд тэдэнд одоог хүртэл эрүүгийн хариуцлага хүлээлгээгүй байсаар байна. Мөрдөгчид тус компани болон түүний хамтрагчид ашиггүй ажиллаж байсан цөмийн 2 станцад нэг тэрбум долларын тусламж үзүүлэх нэрийдлээр нууцаар сая, сая долларыг завшсан бөгөөд First Energy Solutions нэртэй бие даасан охин компани ажиллуулж байсан талаар мэдэгджээ.

First Energy компани баасан гарагт АНУ-ын Үнэт цаас, биржийн хороонд гаргасан өргөдөлдөө Жонс болон бусад хоёр албан тушаалтанд янз бүрийн урамшууллын нөхөн олговрыг олгохгүй байх, олгох эрхийг нь хязгаарлах талаар тусгажээ. Мөн ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдсэн

⁴⁴⁴ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://apnews.com/article/trials-massachusetts-marijuana-courts-fall-river-734adbe7b5585ba6f969c74e0ec61780>

⁴⁴⁵ Мужийн эрүүгийн хуулиар биш, харин холбооны эрүүгийн хуулиар тулгасан ял.

⁴⁴⁶ Монголбанкны 2020 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн ханшаар тооцвол 1,711,656,000 төгрөг болно.

⁴⁴⁷ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.republicworld.com/world-news/us-news/ohio-utility-at-center-of-60-dollars-million-bribery-case-fires-ceo.html>

хахуулийн хэргийг шалгаж буй хорооноос “*Бусад буцалтгүй тусламж, шагнал, нөхөн олговрыг эргүүлэн авах, бууруулах, эсвэл хураахыг баталгаажуулах боломжтой эсэхийг хэлэлцэж байна*” гэж мэдэгдэлд дурджээ.

Мөн First Energy компанийн дотоод шалгалт үргэлжилсээр байгаа юм байна.

Жонс хөрөнгө оруулагчдад хандан “*Охайо мужийн цөмийн үйлдвэрүүдийг дэмжих нь манай бизнесийг зөв зохистой явуулах ёс зүйн үүргээ биелүүлэхэд саад болж, хөндлөнгөөс нөлөөлөөгүй гэдгийг би тодорхой хэлье*” хэмээн 07 дугаар сард мэдэгдэж байв.

Баасан гарагт Жонсоос тайлбар авах боломжгүй байгаа бөгөөд түүнд өмгөөлөгч байгаа эсэх нь тодорхойгүй байна.

Мөн First Energy компани пүрэв гарагт компанийн ерөнхийлөгч Стивен Страхыг гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгчээр томилсноо мэдэгдэв.

Рио-де-Жанейро хотын даргыг авлигын гэмт хэрэгт холбогдуулан баривчилжээ⁴⁴⁸

2020.12.23. Рио-де-Жанейро хотын дарга Марсело Кривелла 2020 оны 12 дугаар сарын 22-ны өдөр буюу бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болохоос 9 хоногийн өмнө авлигын гэмт хэрэгт холбогдон баривчлагджээ.

Тус хэргийн мөрдөн шалгах ажиллагааг удирдаж буй шүүгч Роза Хелена Маседа Гуйта “*Марсело Кривелла бол хууль бусаар ашиг хонжоо олох зорилгоор Рио хотын даргын албан тушаалд томилогдсон гэмт бүлэглэлийн толгойлогч юм*” хэмээн мэдэгдсэн байна.

Хоёр цаг гаруй хугацаанд үргэлжилсэн шүүн таслах ажиллагааны дараа шүүхээс Марсело Кривеллаг цагдан хорих шийдвэр гаргасан ба түүнийг хотын хойд хэсэгт байрлах хорих ангид шилжүүлж буй дүрс бичлэг нийтэд цацагдсан байна.

Үүнээс хэдэн цагийн дараа хотын даргыг гэрийн хорионд байлгах зөвшөөрлийг шүүхээс олгожээ. Гэвч Марсело Кривелла нь байршил тогтоогч электрон бугуйвч зүүж, өөрийн эзэмшилд байгаа бүх утас болон компьютерыг хураалган, гуравдагч этгээдтэй холбоо тогтоохгүй байх үүрэг хүлээсэн байна.

Хотын даргыг өглөөний 6 цагийн үед гэрээс нь баривчилж буй бичлэгийг GloboNews телевизийн суваг нийтэд цацсан байна. Марсело Кривелла энэ үеэр “*Миний бие Рио-де-Жанейро хотод авлигын эсрэг хамгийн их үйл ажиллагаа явуулсан хотын дарга бөгөөд шударга ёсыг тогтоож өгөхийг хүсэж байна*” хэмээн мэдэгджээ.

Марсело Кривелла өнгөрсөн сард орон нутгийн сонгуулийн үеэр Ерөнхийлөгч Болсонарогийн дэмжлэгийг авсан боловч сонгуульд ялалт байгуулж чадаагүй билээ. Тус авлигын хэрэгт холбогдуулан бизнес эрхлэгч Рафаел Алвес, хотын даргын сан хөмрөгийн эрхлэгч асан Мауро Мачеда зэрэг хэд хэдэн этгээдийг мөн баривчилсан байна.

2018 онд эхэлсэн энэхүү мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд олж тогтоосноор Риотур орон нутгийн аялал жуулчлалын агентлагтай гэрээ байгуулах сонирхолтой компаниуд Рафаел Алвесд хахууль өгдөг байжээ. Ерөнхий прокурорын орлогч Рикардо Рибейро Мартинс “*Бидний олж тогтоосноор энэхүү гэмт бүлэглэл 10 сая гаруй ам.долларын хахууль авсан байна*” гэж олон нийтэд зарласан байна.

Марсело Кривелла өмнө нь сүмийн пастор байсан бөгөөд хотын даргаар ажиллаж байх хугацаанд сүмийн гишүүдэд давуу эрх олгож байсан хэрэгт холбогдон мөн шалгагдаж байжээ. Прокурорын газраас түүнийг сүм хийдийн үйл ажиллагааг ашиглан мөнгө угаасан үйлдэлд мөн сэжиглэн шалгаж байгаа билээ.

2014 оны Хөлбөмбөгийн дэлхийн аварга болон 2016 оны Олимпын наадмыг зохион байгуулсны дараагаар Рио-де-Жанейро хот улс төрийн болоод санхүүгийн гүн хямралд орсон билээ. Рио мужийн захирагч Вилсон Витзел мөн авлигын хэрэгт холбогдож энэ оны наймдугаар сард албан

⁴⁴⁸ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.france24.com/en/americas/20201223-bolsonaro-ally-and-rio-de-janeiro-mayor-arrested-for-corruption>

тушаалаасаа огцорсон юм. Түүний өмнө мужийн захирагчаар ажиллаж байсан таван албан хаагч мөн гэмт хэрэгт холбогдон мөрдөн шалгагдсанаас одоогоор дөрөв нь хорих ял эдэлж байна.

Айова хотын удирдлага олон жилийн турш
үргэлжилсэн авлигын гэмт хэрэгт
холбогдон баривчлагдав⁴⁴⁹



(Фото: <https://www.thegazette.com/>)

2021.02.16. АНУ-ын Айова муж улсын Армстронг суурингийн захирагч, цагдаагийн дарга зэрэг таван албан тушаалтныг олон жил үргэлжилсэн авлигын гэмт хэрэгт холбогдуулан баривчилсан талаар тус мужийн Аудитын газар болон Прокурорын газраас мэдээлжээ.

Армстронг суурингийн албан тушаалтнууд олон арван сая долларын төсвийн хөрөнгийг шамшигдуулсан, мөн хэргээ нуун дарагдуулах зорилгоор хуурамч бүртгэл хөтөлсөн, суурингийн хөрөнгийг хувийн хэрэгцээнд ашигласан гэмт хэрэг үйлдсэн талаар прокурорын яллах дүгнэлтэд дурджээ.

Миннесота мужтай хил залгаа бөгөөд аялал жуулчлалын алдартай газар болох Окобожи амралтын бүсээс 40 милийн⁴⁵⁰ зайд орших суурингийн ард иргэдийг энэхүү баривчилгаа гайхшируулжээ.

Шүүгдэгчийн өмгөөлөгч тус албан хаагчдыг 2021 онд эрх бүхий байгууллагаас шалгаж буй талаар үндэслэл тайлбар авахаар ажиллаж буй талаар мэдээлжээ. Учир нь тус албан хаагчдын шалгагдаж буй зарим гэмт үйлдлийг 2017 оны 09 дүгээр сард хийсэн аудитын тайланд дурдаж, олон нийтэд ил болгосон байна.

“Мужийн аудитын тайланг үндэслэн энэ төрлийн гэмт хэрэгт албан тушаалтныг холбогдуулан шалгах нь төдийлөн түгээмэл биш юм. Иймээс энэхүү хэрэгт ямар учир шалтгааны улмаас албан тушаалтныг холбогдуулан шалгаж буй талаар би сайн ойлгохгүй байна” хэмээн тус хотын нарийн бичгийн ажилтан асан Конни Такери, Мэри К.Статон нарын өмгөөлөгч Эд Бьёорнстад мэдээлжээ.

35 настай Мэри К.Статоныг өөрийн үйлдсэн хүндэтгэр гэмт хэрэгт холбогдуулан 02 дугаар сарын 26-ны өдөр эрх бүхий байгууллагад ирж хэргээ хүлээхийг шүүгч зөвшөөрсөн тул тэрээр барьцаа хөрөнгө байршуулж, суллагдсан байна.

Харин Армстронг хотын захирагчаар сүүлийн арван жилийн ихэнх хугацаанд ажиллаж байсан 69 настай Грег Бум, түүний хүргэн бөгөөд цагдаагийн дарга Крейг Меррилл, 2016 онд тэтгэвэрт гарсан Таккери болон тус хотын нарийн бичгийн ажилтан Трейси Ланг нарыг баривчилжээ.

⁴⁴⁹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.thegazette.com/subject/news/leaders-of-iowa-town-jailed-in-long-running-corruption-case-20210216>

⁴⁵⁰ 64.4 км

Грег Бум, Таккери, Трейси Ланг нарыг 02 дугаар сарын 12-ны өдөр баривчилсан байна. Тус гэмт хэрэгт холбогдон шалгагдаж, баривчлагдсан явдалд сэтгэл дундуур байгаа Таккериг батлан даалтаар гаргахаар ажиллаж буй талаар түүний өмгөөлөгч Эд Бьёорнстад мэдээлжээ.

Мөрдөгчид 43 настай Крейг Мерриллийг Миннесота мужийн хил дээр баривчилсан байна. Түүнийг шилжүүлэн авах хүртэл Миннесота мужийн Мартин хотын шоронд саатуулжээ.

Айова мужийн Ерөнхий прокурорын газрын хэвлэлийн төлөөлөгч Линн Хикс тус хэргийг олон жилийн турш мөрдөн шалгаж буй талаар мэдээлсэн байна.

Грег Бум, Таккери, Крейг Меррилл нар 2014 оноос 2020 оны хооронд санхүүгийн ашиг олох зорилгоор үргэлжилсэн гэмт хэрэг үйлдсэн бөгөөд 25 жил хүртэл хорих ял сонсож болзошгүй талаар прокурорын яллах дүгнэлтэд тусгагджээ.

Прокурорын газраас мэдээлснээр Грег Бум, Крейг Меррилл нарыг 10 гаруй мянган ам.долларын чекийг завшуулсан хэргээр нэгдүгээр зэргийн хулгайн гэмт хэрэгт холбогдуулан яллагдагчаар татсан байна. Грег Бум, Таккери нар нь төлбөрийн чекийг тус хотын бусад албан хаагч болон зээлийн картан компанид илгээсэн гэмт хэрэгт холбогдон мөн яллагдагчаар татагдсан юм. Энэхүү гэмт хэргийн нийт хохирол одоогоор тогтоогдоогүй байна.

Цагдаагийн газрын дарга Крейг Меррилл нь мөн хоёр удаа цагдаагийн албан хаагчийн зэвсэг, хэрэгслийг албан бус зорилгоор бусдын эсрэг ашигласан хэрэгт холбогдон шалгагдаж байна.

2016 онд зохион байгуулагдсан хандив цуглуулах үдэшлэгийн үеэр Крейг Меррилл нь хотын засвар үйлчилгээний ажилтан болон ойролцоо байсан нэг иргэнийг “цахилгаан гүйдлээр цохигч” ашиглан гэмтээжээ. Түүнчлэн тэрээр тус үйл ажиллагаанаас цуглуулсан хандивын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан, мөн Айова мужийн хуулийг зөрчиж, хотоос гадуур цалинтай амралт авсан байна.

Трейси Ланг 2017 онд иргэдээс ирсэн өргөдөл, хотын гудамжтай холбоотой санхүүгийн тайлан, хотын зөвлөлийн хуралдааны баримт бичгийг хуурамчаар үйлдсэн гэмт хэрэгт шалгагдаж байна.

2017 оны мужийн аудитын тайланд тайлбарласнаар хотын санхүүгийн менежмент шаардлагад нийцээгүй. Мөрдөгчдийн олж тогтоосноор нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөрийн олон арван мянган ам.долларыг тооцоолоогүй, эсхүл, зохих ёсоор төлөөгүй байсан бөгөөд мөн зохисгүй цалин хөлсний зардал, татварын торгууль буруу ногдуулсны улмаас олон мянган ам.долларын зардал гаргасан байна.

Тус хотын албан хаагчид компьютерын алдаанаас шалтгаалан 2016 онд санхүүгийн тайлан болон нийтийн аж ахуйн үйлчилгээний ашиглалтын бүртгэл устгагдсан талаар Аудитын газарт мэдэгджээ. Үүнээс шалтгаалан нийтийн аж ахуйн үйлчилгээний ашиглалтын зардлыг тооцоолох боломжгүй болж, ус ашиглалтын төлбөр аваагүй, мөн зарим хэрэглэгчдээс бохир усны татварыг зохих ёсоор цуглуулаагүй үйлдлийг Аудитын газраас тогтоосон байна.

Аудитын газраас шалгалт хийх явцад зохих ёсоор байршуулаагүй олон тооны төлбөрийн чек хотын захиргааны байрны өрөөний шалан дээр байсныг олжээ. Нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөр төлөгдөөгүй талаар хэд хэдэн албан тушаалтан гомдол гаргасны дагуу Цагдаагийн газраас шалгалт хийсний үр дүнд хотын захиргааны байгууллагаас их хэмжээний хөрөнгө хураасан байна.

Грег Бум, Крейг Меррилл болон зарим албан хаагчид түүнийг байхгүй тохиолдолд хотын захиргааны санхүүгийн мэдээлэлд нэвтрэх боломжтой талаар хотын нарийн бичгийн ажилтан асан Мэри К.Статон Аудитын газарт мэдэгджээ. Түүний тайлбарлаж буйгаар цахим шуудан болон төлбөрийн хөрөнгө олон тохиолдолд алга болсон байна.

Грег Бум 2013 онд хотын захирагчаар сонгогдсон бөгөөд 2 жилийн дараа ажлаасаа чөлөөлөгджээ. Гэвч 2016 оны ээлжит бус сонгуулиар дахин сонгогдож, 2017 болон 2019 онуудад мөн сонгуульд ялалт байгуулсан юм.

Санхүүгийн тайланд тусгаснаар 2020 оны санхүүгийн жилд тус хот 1.4 сая ам.долларын орлого олж, 1.1 сая ам.долларын зарлага гаргасан байна.

Трейси Ланг ямар хэрэгт буруутгагдаж буй талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсэж байгаа бөгөөд нэмэлт тайлбар өгөхгүй талаар түүний өмгөөлөгч Бетани Брандс мэдээлжээ. Харин Грег Бумын өмгөөлөгч тайлбар өгөөгүй байна.

Португалийн Ерөнхий сайд асныг мөнгө угаасан хэргээр шүүхээр болжээ⁴⁵¹

2021.04.10. Португалийн Ерөнхий сайд асан Хосе Сократыг шүүгч Иво Розагийн шийдвэрийн дагуу мөнгө угаасан, бичиг баримт хуурамчаар үйлдсэн гэмт хэрэгт буруутгасан хэрэгт холбогдох шүүх хурал боллоо. Тэрээр дурдсан хэрэгт буруутгагдаж байгаа тус улсын анхны засгийн газрын тэргүүн болсон юм.

Гэсэн хэдий ч баасан гарагт “Шүүгдэгч нарт холбогдох хэргийн баримтууд нь хахууль авсан хэрэгт яллах дүгнэлт үйлдэхэд хангалтгүй байна” гэх үндэслэлээр авлигын хэргийг хэрэгсэхгүй болгосон гэж Синьхуа агентлаг мэдээлэв.

2005-2011 оны хооронд Ерөнхий сайдаар ажиллаж байсан Сократыг долоон жил үргэлжилсэн шүүхийн энэ процесс хахууль авсан, мөнгө угаасан, баримт бичиг хуурамчаар үйлдсэн, татварын залилан хийсэн зэрэг 31 гэмт хэрэгт буруутгаж байсан юм.

Тэрээр 2014 онд Португалийн хамгийн том мөрдөн шалгах ажиллагааны үеэр Лиссабон хотын нисэх онгоцны буудлаас баривчлагдаж байжээ.

Прокурорууд Сократыг 2005-2015 оны хооронд компаниудаас 34 сая орчим евро (40 сая доллар) авсан гэж мэдэгджээ.

Одоогийн Ерөнхий сайд Антонио Коста баасан гарагт өөрийн “найз” гэж нэрлэж байсан Сократтай холбоотой шүүх хурлын талаар тайлбар өгөхөөс татгалзсан. Тэрээр “*Надад зургаан жилийн өмнө энэ асуултад хариулах боломж байсан. Мөн хэлсэн зүйл дээрээ нэмж хэлэх зүйл байхгүй*” гэж хэвлэлд өгсөн мэдэгдэлдээ дурджээ.

2014 онд Антонио Коста шоронд хоригдож байсан Сократтай очиж уулзахдаа “*Шударга ёс хэрэгжиж, гэм буруугүй нь нотлогдож, хүмүүсийн өөрийгөө хамгаалах эрх хэрэгжих болно*” гэж найдаж байгаагаа мэдэгджээ.

Португалийн Прокурорын газраас Сократад холбогдох авлигын хэргийг хэвээр үлдээхийн тулд шүүгч Иво Розагийн шийдвэрийг давж заалдах болно гэдгээ мэдэгдсэн юм.

Венесуэлийн газрын тос, байгалийн хийн төрийн өмчит компанийн албан хаагчид хахуулийн хэргээр 2 жилийн хорих ял оноожээ⁴⁵²

2021.05.06. Холбооны мөрдөн шалгах “Мөнгөний нислэг” арга хэмжээний хүрээнд Майамид хэрэгжүүлсэн арга хэмжээний үеэр Венесуэлийн төрийн өмчит газрын тос, байгалийн хийн компанийн албан хаагч асан Абрахам Ортегад 12 тэрбум ам.долларын хахууль авсан хэргээр шүүхээс ял оноосон байна.

Шалгах ажиллагаа Уго Чавесын эхлүүлсэн Боливийн хувьсгалчидтай холбоотой “Боличикос” гэж нэрлэгддэг бизнес эрхлэгч нарын мэдээлэлд үндэслэн эхэлсэн байна. Энэ нь нэг шөнийн дотор үлэмж хэмжээний ашиг орлого авчирдаг Венесуэлийн төрийн өмчит газрын тос, байгалийн хийн компанитай хуурамч валютын болон бусад санхүүгийн хэлцлүүд хийх зорилготой үлэмж хэмжээний хахууль өгдөг асуудлыг шалгах явцад илэрсэн байна.

Шүүгч Кэтлин Уиллиамс түүнд 28 сарын хорих ял оногдуулсан нь прокурорын төлөвлөсөн ялын талаас ч бага байгаа юм. Ортега 2014-2016 онд Венесуэлийн газрын тос, байгалийн хийн компанийн санхүүгийн захирлаар ажиллаж байсан ба гэмээ хурдан ухамсарлаж, шалгах ажиллагаанд идэвхтэй хамтран ажилласан байна.

⁴⁵¹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.daijiworld.com/news/newsDisplay?newsID=822501>

⁴⁵² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://abcnews.go.com/International/wireStory/venezuela-oil-official-prison-years-bribes-77519152>

Оросын банканд төлөх ёстой хугацаа хэтэрсэн төлбөрийг эхэлж хийлгэхийн тулд тус хэрэгт хамт яллагдсан бизнес эрхлэгч Франциско Конвит нь Ортегад 2 сая ам.долларын хахууль өгснийг Ортега хүлээн зөвшөөрсөн байна. Харин Конвитын өмгөөлөгч ямар нэгэн тайлбар өгөхөөс татгалзсан байна.

Нэрийг нь дурдаагүй мэдээлэгчээр дамжуулан төлбөрийг хийдэг байсан ба уг мэдээлэгч нь Ортега болон бусад хамсаатнуудын хоорондын яриаг холбооны мөрдөгчдийн зааврын дагуу бичиж байсан юм.

Венесуэлийн төрийн өмчит нефть, байгалийн хийн компанийн хуурамч зээлийн болон валютын гэрээний схемтэй холбоотойгоор 10 сая ам.долларын хахууль авснаа Ортега мөн хүлээн зөвшөөрчээ.

Ортега уг хахуулиар олсон орлогынхоо хэсгийг Густаво Хернандес Фриеригийн тэргүүлдэг Майамид байрлах хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан угаасан байна. Фриерид шүүгч Уиллиамс 4 жилийн хорих ял оноожээ.

Прокурор Бахамын арлууд болон Швейцарийн банканд дахь Ортегагийн дансны хөрөнгийг царцаах талаар хөөцөлдөж буй юм. Үүнээс гадна Манхэттэнд байрлах дарс импортлогч Домайн Селект Вайн энд Спиритс компанид оруулсан 2 сая ам.долларыг буцааж авах сонирхолтой байгаа ажээ. Хернандес тус компанийн хөрөнгө оруулагч юм. Түүнийг баривчлагдсаны дараа компанийг худалдаж, нэрийг нь өөрчилсөн байна.

Мөнгөөр дүн тавьдаг байсан Балтиморын математикийн профессор нэг жилийн хорих ялаар шийтгэгджээ⁴⁵³



Эдвард Эннелс (зогсож байгаа нь), 2014 он. (Фото: Patrick Semansky / AP)

2021.08.05. Прокуроруудын үзэж байгаагаар профессор Эдвард С.Эннелсийн Балтимор хотын коллежид (Baltimore City Community College) заасан математикийн хичээл маш энгийн зүйл байв: С үнэлгээ 150 доллар; В үнэлгээ 250 доллар; А үнэлгээ 500 доллар.

Зарим хичээлийн хувьд А үнэлгээ 300 долларын үнэтэй ч байж болно.

⁴⁵³ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.nytimes.com/2021/08/05/us/math-professor-bribe-baltimore.html>

Мэриландын Ерөнхий прокурор Брайн Э.Фрош пүрэв гарагт хийсэн мэдэгдэлдээ ноён Эннелс (45 настай) өнгөрсөн жилийн сургалтын долоон сарын хугацаанд 112 оюутнаас хахууль шаардаж, есөн оюутнаас нийт 2,815 долларын 10 удаагийн төлбөр авсан хэмээн дурджээ.

Мөн ноён Эннелс оюутнуудад сургалтын материалыг үзэх, даалгавраа хаах боломж олгодог онлайн нэвтрэх кодыг зарсан гэж прокурорууд хэлэв. Тэрээр 2013-2020 он хүртэл 694 удаагийн хандалтын код тус бүрийг 90 орчим доллароор зарсан байна.

Прокурорын болон шүүхийн цахим тэмдэглэлд дурдсанаар тус коллежид 15 жил ажилласан, мөн факультетын сенатын Ёс зүй, байгууллагын шударга байдлын хороонд ажиллаж байсан профессор Эннелс пүрэв гарагт Балтимор мужийн тойргийн шүүхэд хахууль, албан тушаалын ёс зүй зөрчсөн гэх мэт 11 гэмт хэрэгт гэм буруутайгаа хүлээн зөвшөөрсөн байна.

Түүнд 10 жилийн хорих ял оноосон бөгөөд нэг жилээс бусад хугацааг нь түдгэлзүүлж, орон нутгийн шоронд 1 жил хорих ял оноожээ. Түүнчлэн нөхөн төлбөрт 60,000 доллар төлүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд суллагдсаных нь дараа таван жилийн хугацаанд тэнсэн харгалзах юм байна.

Фрош мэдэгдэлдээ Эннелс өөрийгөө далдлахын тулд олон янзын хуурамч нэр ашиглах зэргээр “оюутнуудынхаа давуу талыг ашиглахын тулд гэмт хэргийн нарийн схем боловсруулсан” гэжээ.

Эннелс 2020 оны 03 дугаар сард “Берти Бенсон” хэмээх нууц нэр ашиглан өөрийнхөө өөр нэг нууц нэр болох “Аманда Вилберт” рүү имэйл илгээсэн байна. Тус имэйлд “Бенсон” нь “Вилбертийн” математикийн даалгаврыг гүйцэтгэхийг санал болгож, түүнд 300 доллароор А үнэлгээ авж өгөх баталгаа өгчээ.

Эннелс тэр имэйлийг өөрийн хичээл зааж байсан 112 оюутанд “Вилберт”-ийн нэрээр дамжуулсан байна. “Эннелс хахуулийн хэмжээг оюутнуудтай ихэвчлэн тохиролцож, курс, ангиас хамаарч өөр өөр үнэ тогтоодог байсан” гэж мэдэгдэлд дурджээ.

Ихэнх оюутнууд хахууль өгөхөөс татгалзаж байсан боловч ноён Эннелс “хахуулийн хэмжээг бууруулж, эсвэл төлбөрийн төлөвлөгөөг санал болгон байнга шаардаж байсан” байна.

Мэдэгдэлд дурдсанаар, нэгэн оюутан А үнэлгээг 500 доллароор худалдаж авахаас татгалзаж “Өө, надад наадах чинь байхгүй ээ, уучлаарай. Би хичээлээ судалж, шалгалтаа амжилттай өгч чадна” гэхэд Эннелс “Чи хэдийг өгч чадах юм?” гэж асуусан байна.

Тухайн оюутан эцэст нь хахууль өгсөн боловч чухам хэдийг төлснийг прокурор хэлээгүй байна.

Эннелсийн өмгөөлөгч Бенжамин Ж.Хербст пүрэв гаргийн орой өгсөн ярилцлагадаа ноён Эннелс “мөрийтэй тоглоомонд донтсон учраас л ийм зүйл хийсэн бөгөөд шунахайн сэдэл байгаагүй. Тэр бас тансаг амьдарч байгаагүй, хожим хэрэглэхээр ч хадгалаагүй” хэмээн ноён Хербст хэлсэн байна. Мөн “Тэр бол сайн хүн, ажилдаа, оюутнууддаа хайртай байсан”, “Тэр үүнийг даван туулах болно” гэжээ.

Олон улсын хөлбөмбөгийн холбооны
авлигын хэрэгт Эл Сальвадорын
Хөлбөмбөгийн холбооны Ерөнхийлөгч асан
гэм буруугаа хүлээв⁴⁵⁴

2021.08.23. Эл Сальвадорын Хөлбөмбөгийн холбооны Ерөнхийлөгч асан даваа гарагт Олон улсын хөлбөмбөгийн холбоо (ОУХБХ)-ны авлигын хэрэгт холбоотойгоор хөлбөмбөгийн тоглолт дамжуулах үйл ажиллагааны үеэр хахууль авсан үйлдэлд гэм буруутайгаа хүлээн зөвшөөрөв.

⁴⁵⁴ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.reuters.com/lifestyle/sports/ex-el-salvador-soccer-chief-pleads-guilty-fifa-corruption-probe-2021-08-23/>

Эл Сальвадорын Хөлбөмбөгийн холбооны Ерөнхийлөгч асан 65 настай Рейналдо Васкес өөрийн орчуулагчаар дамжуулан АНУ-ын дүүргийн шүүгч Памела Чений өмнө гэм буруугаа хүлээсэн байна.

Васкес 2012 онд хөлбөмбөгийн нэвтрүүлэг дамжуулах эрх олгох үеэр АНУ-д байрладаг Media World байгууллагаас 350 мянган ам.долларын хахууль авсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн байна. Мөн Васкес 360 мянган ам.доллар төлөхөөр болсон байна.

Гэм буруутай этгээдэд оногдуулах ялыг энэ оны 12 дугаар сарын 16-ны өдөр шийдвэрлэх бөгөөд түүний өмгөөлөгч энэ талаар тайлбар хийгээгүй байна. 2019 онд Васкесд ОУХБХ-ноос 500 мянган Швейцари франкийн торгууль оногдуулж, хөлбөмбөгийн арга хэмжээнд оролцох эрхийг нь насан туршид нь хассан юм.

Олон улсын хөлбөмбөгийн холбоо авлигын гэмт хэргийн хохиролд 201 сая гаруй ам.долларын нөхөн төлбөр авахаар болжээ⁴⁵⁵

2021.08.25. Дэлхийн хөлбөмбөгийн удирдах байгууллага болох Олон улсын хөлбөмбөгийн холбоо авлигын сүлжээний хохирлын төлбөрт 201 сая ам.долларын нөхөн олговор авах болно гэж АНУ-ын Хууль зүйн яамнаас мягмар гарагт мэдээлэв.

Энэхүү нөхөн төлбөрийг уг схемд оролцсон хуучин албан тушаалтнуудын банкны данснаас хураан авжээ. Хууль зүйн яамнаас тус авлигын хэргийг 2015 онд шалгаж эхэлснээс хойш 50 гаруй этгээд ял сонсоод байгаа юм. Мөн 27 хүн, 4 аж ахуйн нэгж, байгууллага гэм буруугаа хүлээсэн байна.

“Хөлбөмбөгийн авлигач албан тушаалтнууд, спортын маркетингийн удирдлагууд авлига, шунахай байдлаар хулгайлсан хөрөнгийг буцаан өгч, тус хөрөнгийг спортын ашиг тусын тулд хэрэглэгдэх болно гэдгийг өнөөдрийн мэдэгдэл баталж байна” хэмээн Нью Йоркийн Зүүн дүүргийн прокурорын үүрэг гүйцэтгэгч Жаклин Касулис хэлсэн байна.

Энэхүү мөрдөн шалгах ажиллагааг гэм буруутай этгээдийг яллах, хууль бусаар алдагдсан хөрөнгийг сэргээн хөлбөмбөгийн ашиг тусын тулд ажилладаг хүмүүст өгөхөд чиглэгдэж ирсэн байна.

23 насандаа сонгогдож байсан хотын дарга асан авлигын хэрэгт холбогдон 6 жилийн хорих ял авлаа⁴⁵⁶

2021.09.21. Дөнгөж 23 насандаа сонгогдож, ардчиллын шинэ залуу төлөөлөгчөөр нэрлэгдэж байсан Массачусетс мужийн Фалл Ривер хотын дарга асан Жэсиел Корреиа өөрийнх нь хотод үйл ажиллагаа явуулахыг хүссэн өвсний төрлийн хар тамхи худалдаалдаг этгээдүүдээс олон зуун мянган ам.долларыг хахуульд авсан авлигын хэрэгт гэм буруутай нь тогтоогдож 6 жилийн хорих ял сонслоо.

Ийнхүү авлигын хэрэгт гэм буруутай нь тогтоогдож, шүүхээс ял сонгох үед өдгөө 29 настай Корреиа ямар нэгэн сэтгэл хөдлөл харуулаагүй байна.



Эл Сальвадорын Хөлбөмбөгийн холбооны ерөнхийлөгч асан Рейналдо Васкесийг баривчилсны дараа хэвлэл мэдээллийнхэнтэй ярилцаж байна. 2015 оны 12 дугаар сарын 16. (Фото: Reuters/Хосе Кабезас)

⁴⁵⁵ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.reuters.com/lifestyle/sports/fifa-receive-over-201-million-forfeited-funds-corruption-probe-2021-08-24/>

⁴⁵⁶ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.local10.com/news/politics/2021/09/21/ex-mayor-elected-at-age-23-gets-6-years-in-corruption-case/>

АНУ-ын дүүргийн шүүгч Даглас Вудлок хотын дарга асан Корреиагийн үйлдлийг олон нийтийн татварын хөрөнгийг хулгайлсан авлигын үйлдэл гэж тодорхойлсон бөгөөд Корреиагийн хяналт дор “Хотын захиргааны бүрэн эрхийг буруугаар ашиглаж байсан” гэж хэлээд түүнийг “харамсах сэтгэлгүй этгээд” гэж шүүмжилжээ.

Мөн “Бид бие биедээ итгэж чадахгүй, төрдөө итгэж чадахгүй бол бид хаана байна вэ?” хэмээн шүүгч асуусан байна.

Африк тив

Суданы Ерөнхийлөгч асан Баширыг авлигын шинэ хэрэгт буруутгаад байна⁴⁵⁷

2020.02.16. Суданы Ерөнхийлөгч асан Омар ал-Баширыг авлигын хэрэгт буруутган өнгөрөгч 12 дугаар сард 2 жилийн хорих ял оногдуулсан билээ.

Тус улсын Ерөнхий прокурорын мэдэгдэж байгаагаар авлига, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлсэн шинэ гэмт хэрэгт Баширыг буруутгаад байна.

“Лалын ахан дүүсийн байгууллага болон бусад олон улсын террорист агентуудыг санхүүжүүлсэн” асуудлаар зарим албан тушаалтнуудыг мөрдөн шалгах ажиллагаанд холбогдуулан ал-Башираас мэдүүлэг авсан. Түүнийг мөн гадаадын хөрөнгө оруулагчдад “Mobitel”, “MTN” компаниудыг худалдах үйл ажиллагаанаас хууль бусаар ашиг хүртсэн, мөнгө угаасан хэрэгт буруутган байцааж байгаа гэж Ерөнхий прокурор ням гарагт мэдэгдсэн.

Судан улсыг 1989 оноос хойш удирдсан ал-Баширыг 2019 оны 04 дүгээр сард албан тушаалаас нь зайлуулсан юм.

Өнгөрөгч 7 хоногт Суданы шилжилтийн засгийн газар баруун Дарфур мужид дайны гэмт хэрэгт холбогдуулан ал-Баширыг Олон улсын Эрүүгийн шүүхэд хүлээлгэн өгөхөөр болсон билээ.

Египетийн парламентын гишүүнийг хахуулийн хэргээр баривчилжээ⁴⁵⁸

2020.03.09. Египетийн Захиргааны хяналтын газар (ЗХГ)-аас даваа гарагт нийслэл Каир хотод хэрэгжих төсөлд зөвшөөрөл олгохдоо үл хөдлөх хөрөнгийн нэгэн компаниас 300,000 египет фунт (19,070 ам.доллар)-ийн хахууль өгөхийг шаардаж, авсан асуудлаар парламентын гишүүнийг баривчилсан байна.

Парламентын гишүүн Гамал Ал-Шоуэйх (Gamal Al-Showeikh) нь Next Home компанийн 7.5 сая орчим египет фунт (477,447 доллар)-ийн өртөгтэй өрөмдлөгийн ажлын горимыг хөнгөвчилсэн хэмээн төрийн албан хаагчтай холбоотой асуудлыг шалгах чиг үүрэг бүхий ЗХГ-аас гаргасан мэдэгдэлд онцолжээ.

Өнгөрөгч ням гарагт Гамал Ал-Шоуэйх мөрдөн шалгах, хуульд заасан арга хэмжээ авахыг зөвшөөрсөн шийдвэр парламентаас гаргахаас өмнө тэрээр гишүүний халдашгүй эрхтэй байсан юм.



Парламентын гишүүн Гамал Ал-Шоуэйх.
(Фото: egypttoday.com)

⁴⁵⁷ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/africa/sudans-bashir-faces-new-corruption-charges/1735775>

⁴⁵⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.egypttoday.com/Article/1/82466/Egyptian-Parliament-member-arrested-on-bribery-charges>

Үндсэн хуулийн 113 дугаар зүйлд зааснаар парламентын гишүүнийг парламент зөвшөөрөл олгоогүй нөхцөлд гэмт хэргийн газарт нотлох баримттай нь баривчлахаас бусад тохиолдолд ямар нэгэн эрүүгийн хариуцлагад холбогдуулан шалгах, баривчлах боломжгүй байдаг.

ЗХГ Ерөнхий прокурорын шийдвэрт үндэслэн дээрх компанийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгохдоо 1.5 сая египет фунт (95,489 доллар)-ийн хахууль авсан Каир хотын Мугаттам дүүргийн хэд хэдэн албан тушаалтныг баривчлах тогтоол өмнө нь гаргасан юм.

Энэ оны 01 дүгээр сард хахууль авсан хэрэгт буруутган Татварын газрын дарга Абдел Азим Хуссейнийг баривчлах шийдвэрийг ЗХГ-аас гаргаж байсныг мөн тус улсын хэвлэлээр мэдээлж байсан.

Албан ёсоор бичигдсэн уулзалтын тэмдэглэл болон түүний утасны ярианд хяналт хийх замаар Хуссейныг хахуульд мөнгө, бэлэг хүлээн авсан болохыг мөрдөн шалгах ажиллагааны явцад тогоосон.

Тус улсын Ерөнхийлөгч Абдель Фатта ал-Сиси (Abdel Fattah al-Sisi) аливаа хэрэг, зөрчил, ялангуяа авлигыг таслан зогсоох зорилгоор төрийн байгууллагуудад хатуу арга хэмжээ авж байхыг удаа дараа мэдэгдэж байсан.

Мөн хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааг нэвтрүүлэхийн тулд хахууль авсан асуудлаар 2018 оны 07 дугаар сард Гаалийн газрын даргыг тус байгууллага баривчилж байсан юм.

Эрүүл мэндийн сайд асанд авлигын хэргийн улмаас 5 жилийн хорих ял оноожээ⁴⁵⁹

2020.03.23. Конго улсын Эрүүл мэндийн сайд асанд даваа гарагт 5 жилийн хорих ял оноожээ. Оли Илунга Каленга Оли Илунга (Oly Ilunga Kalenga Oly Ilunga)-г өнгөрсөн 09 дүгээр сард баривчилсан ба Эбола вирустэй тэмцэхэд АНУ-аас олгосон 4.3 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгийг зүй бусаар зарцуулсан асуудалд буруутгасан байна.

Тэрээр 2016 оноос өнгөрсөн оны 07 дугаар сар хүртэл Эрүүл мэндийн сайдын үүргийг гүйцэтгэж байсан. Шүүхээс түүнийг төрийн албанд ажиллах эрхийг хязгаарласан ба тэнсэн харгалзах болон ялын хугацаанаас бууруулахыг хориглох шийдвэр гаргажээ. Конго улсад хэд хэдэн удаа Эболагийн вирус дэгдэж байсан юм.

Хууль бус баривчилгааны хохирогчдод тус бүр 15 сая шиллингийн нөхөн төлбөр өгөхөөр шүүх шийдвэрлэв⁴⁶⁰

2020.05.04. Уганда. Төрийн ордны Авлигатай тэмцэх алба (State House Anti-corruption Unit) шалгагдаж байгаа 4 хүнд тус бүрд нь 15 сая шиллингийн (4 мянга орчим ам.доллар) нөхөн төлбөр олгох шийдвэрийг Нийслэл Кампала хотын Давж заалдах шатны шүүхээс гаргав.

Шийдвэр гаргасан шүүгчийн хэлснээр дээрх 4 сэжигтнийг нийслэлийн нэгэн цагдаагийн хэлтэс дээр 5 хоног хорьж саатуулсан бөгөөд энэ нь хүнийг 48 цагаас илүү хугацаагаар хорьж саатуулахгүй байх тухай Уганда улсын Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн байна. Үндсэн Хуулийн 23 дугаар зүйлд зааснаар баривчлан саатуулсан хүнийг 48 цагийн дотор шүүхэд хүргэж холбогдох шийдвэрийг гаргуулах ба хууль бусаар баривчилсан, эсхүл, саатуулсан бол түүнд нөхөн төлбөр олгох ёстой.

Эдгээр хүмүүс мужийн газрын албанд ажилладаг бөгөөд албан тушаалаа ашигласан хэргээр тус албанд шалгагдаж байгаа юм. Тэдний зүгээс хууль бусаар саатуулагдсан, Ерөнхий прокурорын гаргасан шийдвэрээр хүний эрх болон Үндсэн хуулийн эрх нь ноцтой байдлаар зөрчигдсэн, эрүүдэн шүүгдсэн гэсэн гомдлыг шүүхэд гаргажээ.

⁴⁵⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/africa/dr-congo-ex-health-minister-jailed-over-corruption/1776603>

⁴⁶⁰ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://thetowerpost.com/2020/05/04/court-awards-four-suspects-shs15m-each-over-illegal-detention/>

Гомдол гаргагчдад хууль бусаар цагдан хоригдсонд нь тус бүр 10 сая шиллинг, хүний эрх, Үндсэн хуулийн эрх нь зөрчигдсөний төлөө тус бүр 5 сая шиллингийг нөхөн төлбөр болгон өгөхөөр шүүхээс шийдвэрлэсэн бөгөөд эрүүдэн шүүсэн талаарх гомдлыг нотлох баримт хангалтгүй байна гэсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгожээ.

Гомдол гаргагчдын зүгээс мөн тэдэнд холбоотой авлига, албан тушаалын хэргийн мөрдлөгийг зогсоохыг хүссэн боловч шүүгчийн зүгээс хүний эрх зөрчигдсөн, хууль бусаар саатуулагдсан зэрэг асуудал нь иргэний журмаар шийдвэрлэгдсэн бөгөөд энэ нь авлигын гэмт хэргийг мөрдөн шалгах шүүхийн үйл ажиллагаанд саад учруулах үндэслэл болохгүй гэж үзсэн байна.

Уганда улсын Давж заалдах шатны шүүх нь найман салбар шүүхээс бүрддэг бөгөөд эдгээрт Иргэний шүүх, Эрүүгийн шүүх, Авлигын хэргийн шүүх, Гэр бүлийн шүүх, Газар, үл хөдлөх хөрөнгийн шүүх, Худалдааны шүүх, Хил дамнасан гэмт хэргийн зэрэг шүүхүүд багтдаг.

Конго улсын Ерөнхийлөгчийн ойрын туслах 50 сая ам.долларын авлигын асуудалд холбогджээ⁴⁶¹

2020.05.12. Конго улсын Ерөнхийлөгч Феликс Цисекеди (Felix Tshisekedi)-ийн ойрын туслах Витал Камере, Ливаны бизнес эрхлэгч болон Ерөнхийлөгчийн ажлын албаны өөр нэг ажилтан нар дэд бүтцийн хөтөлбөрөөс 50 сая ам.доллар шамшигдуулсан асуудлаар шүүхийн өмнө очихоор болоод байна.

Камерег баасан гаргаас эхлэн хориод байгаа юм. Шүүх хурлыг үндэсний хэмжээнд телевизээр үзүүлэх юм. Энэ хэрэг тус улсын улс төрийн хүрээг цочроосон асуудал болжээ.

Конго улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга хахууль авсан асуудлыг шүүх хурлын эхэнд үгүйсгэв⁴⁶²

2020.05.12. Конго улсын Ерөнхийлөгчийн ойрын хүн болох Камерегийн улсын төсвийн 50 сая ам.доллартой тэнцэх хэмжээний хөрөнгө шамшигдуулсан хэргийн шүүх хурлын явцыг үндэсний телевизээр шууд дамжуулж байна. Өндөр түвшний авлига ихээхэн түгээмэл Конго улсад Витал Камере нь хахуулийн асуудлаар шүүх дээр ирээд буй хамгийн өндөр албан тушаалтан болж байна. Тэрээр ирэх 2023 оны Ерөнхийлөгчийн сонгуульд дэмжинэ гэсэн Феликс Цисекедийн амлалтын дагуу Ерөнхийлөгчийн 2018 оны сонгуульд түүнийг дэмжсэн. Дөрөвдүгээр сарын 08-нд болсон түүний баривчилгаа засгийн эрхэд буй улс төрийн эвслийг цочролд оруулсан асуудал байв. Хэрэв Камере буруутайд тооцогдвол 20 хүртэл жилийн хорих ял авах ба дараагийн сонгуульд оролцох боломжгүй болох юм.

Шүүх дээр Ерөнхийлөгч Цисекедийн нийгмийн халамжийн санхүүжилтийн хүрээнд 100 өдрийн хөтөлбөрийн хөрөнгөд гар хүрээгүй хэмээн 61 настай Камере мэдэгдсэн. “Конго улсын ард түмний боловсрол, эрүүл мэнд, дэд бүтцийн салбарын хэрэгцээг хангахад чиглэгдсэн ажлууд хэрхэн явагдаж буйд би Ерөнхийлөгчийн нэрийн өмнөөс хяналт тавьж оролцсон” хэмээн тэрээр мэдэгдсэн. Түүнээс гадна хэд хэдэн төрийн өндөр албан тушаалтан тус асуудалд холбогдоод буй юм. Камерегээс гадна Ливаны бизнес эрхлэгч, Цисекедийн ахлах туслах Жеанот Мухима нар тус хэрэгт холбогдоод байна. Тэрээр буруугүй хэмээн мэдэгдэж байгаа ба шүүх хурал 05 дугаар сарын 25-нд үргэлжилнэ. Камере батлан даалтад гарах хүсэлт гаргасан тул шүүх 48 цагийн дотор энэ талаар шийдвэр гаргах ёстой болоод байна. Үндэсний Ассамблейн дарга асан Камерегийн баривчилгаа түүний Цисекедитэй байгуулсан эвслийн гүнзгий ан цавыг ил болгов. Цисекеди боломжит өрсөлдөгчөө устгаж буй асуудал хэмээн Камерегийн зарим хамтрагч мэдэгдэв. Ерөнхийлөгч үүнд ямар нэгэн тайлбар хийгээгүй. Авлига ихээхэн түгээмэл байсан өмнөх Ерөнхийлөгч Жосеф Кабилагийн үетэй харьцуулахад тус шүүх хурал Цисекедийн авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлийг илэрхийлнэ хэмээн авлигын эсрэг тэмцэгчид тэмдэглэж буй юм. Зэс, кобальт, алтны асар их нөөцтэй Конго улс нь дэлхийн хамгийн ядуу улс орны нэг бөгөөд

⁴⁶¹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/05/vital-kamerhe-top-aide-drc-president-trial-corruption-200511101934960.html>

⁴⁶² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://uk.reuters.com/article/uk-congo-politics/congo-presidents-chief-of-staff-denies-graft-charges-as-trial-begins-idUKKBN22N2MD>

дотоодын болон гадаадын байгууллагууд тус улсын төрийн өндөр түвшнийхэн авлигад ихээр автсаныг нэг бус удаа онцолж байсан.

Сахилгын хяналт шалгалтын дагуу авлигын 139 тохиолдлыг илрүүлэв⁴⁶³

2020.05.13. Өмнөд Африк. Йоханнесбург. Суурьшлын асуудал, ус хангамж, ариутгалын яаманд авлигын 139 тохиолдол гарсныг сайд Линдивэ Сисулу өнгөрсөн лхагва гарагт мэдэгдэв. Тус яамны хэд хэдэн газрын хийсэн сэжигтэй зарлагын улмаас 6 тэрбум ранд⁴⁶⁴-ын хөрөнгө алдсаныг Ерөнхий аудиторын шалгалтаар тогтоосон байна. Буруутай этгээдийг ажлаас чөлөөлнө хэмээн Сисулу мэдэгдсэн ба түүний баг тус яаман дахь авлигын асуудалтай тэмцэж буй юм.

“Бидний хүсээж буй хэмжээнд ажиллахын тулд буруугүй нэгний ажлыг нь хийлгээж, буруутай этгээдэд зохих шийтгэлийг ногдуулж цэвэрлэх шаардлагатай” хэмээн тэрээр мэдэгдсэн ба хяналт шалгалтын дагуу 139 албан тушаалтан буруутай нь тогтоогдсон байна. *“Эдгээр сэжигтэй үйл ажиллагаанд буруутайд тооцогдсон этгээдүүдээс заримынх нь хэргийг шалгах, заримыг нь ажлаас халах, гурван сарын хугацаатай ажлаас нь цалингүй чөлөөлөх зэрэг арга хэмжээ авсан, харин зарим нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн”* хэмээн Ерөнхий захирал Скуэр Махлангу мэдэгдэв.

Зимбабве улсын авлигатай тэмцэх байгууллага чинээлэг иргэдийг шалгаж эхэллээ⁴⁶⁵

2020.06.21. Зимбабве улсын хууль сахиулах байгууллагууд шүүхээс авлигын хэргийг нь хэрэгсэхгүй болгосон ч хөрөнгийн эх үүсвэрээ хангалттай тайлбарлаж чадахгүй байгаа иргэдийн хөрөнгийг хураахаар болсныг зарлаад байна.

Шинэ ажиллагааг “Баячуудын өдөр тутмын амьдрал дахь шалгалт” гэж нэрлэж байгааг Зимбабвегийн Авлигатай тэмцэх хорооны дарга, шүүгч Матанда Моя мэдэгдэв.

Тус улс сүүлийн арав гаруй жилийн хугацаанд эдийн засгийн хамгийн хүнд хямралтай нүүр тулаад байгаа бөгөөд төрийн үйлчилгээний хүртээмжгүй байдал болон авлига зэргээс болж олон нийтийн бухимдал ихээр нэмэгдэж байгаа юм.

Энэхүү ажиллагаа бол зарим баячуудын өдөр тутмын амьдралд хийж байгаа эрчимжүүлсэн шалгалт бөгөөд тэдгээр баячууд бараа, үйлчилгээний тооцооны хуудсаа үзүүлж, шалгуулах хэрэгтэй ба тэдгээрийн олсон хөрөнгө, орлоготой тохирч байх шаардлагатай юм. Мөн тэдгээр хүмүүс болон тэдний бизнес нь татвар төлж байсан эсэхийг давхар шалгах болно гэж Матанда Моя өдөр тутмын хэвлэлд өгсөн ярилцлагадаа дурджээ.

Энэ ажиллагаа 2019 оны 07 дугаар сард Авлигатай тэмцэх хорооны олж авсан тайлбар шаардах эрхийг ашиглаж байгаа бөгөөд “тайлбарлагдаагүй эд баялаг” гэж нэрийдсэн баялгаа хүмүүс хэрхэн цуглуулсан үндэслэлээ тайлбарлах ёстой болж байгаа юм.

Зимбабве дахин мөхлийн ирмэг дээр ирээд байна уу?

Хүмүүс мөрдөн шалгах ажиллагааны үед өөрсдийн эд хөрөнгөө тайлбарлахын тулд Дээд шүүхэд хандаж болох бөгөөд тайлбарлаж чадаагүй тохиолдолд шууд хураагдах юм. Гэвч Зимбабве хувь хүний хөрөнгийн эх үүсвэрийг нотлохыг шаардаж байгаа анхны улс бас биш юм. Ирланд болон Их Британи улсууд 2017 онд энэ талаарх өөрчлөлтийг хуульд оруулж байсан юм.

ТИ олон улсын байгууллага Зимбабве улсын коронавирүсний эрүүл мэндийн бүтээгдэхүүнийг нийлүүлэх худалдан авах ажиллагааг авлигын эрсдэл өндөртэй гэж саяхан онцолсон. Тус байгууллагын онцолсноор эм, эмнэлэгийн хэрэгслийн үнийг нэмэгдүүлсэн нь авлигын эрсдэлтэйг илтгэж байгаа аж. Уг үйл явдлын дараа буюу бямба гарагт тус улсын эрүүл мэндийн

⁴⁶³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://ewn.co.za/2020/05/13/139-officials-found-guilty-of-corruption-after-disciplinary-action-sisulu>

⁴⁶⁴ Өмнөд африкийн мөнгөн тэмдэгт, 1 ранд /код нь ZAR/ нь 0.0539 ам.доллартой тэнцэнэ.

⁴⁶⁵ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.bbc.com/news/world-africa-53128604>

сайд Обадиа Мояг албан тушаалын байдлаа урвуулан ашигласан хэрэгт буруутгасан байна. Түүнийг энэ 07 дугаар сард шүүхэд дахин дуудахаар болсон байна.

Зимбабвегийн зарим баримт



Тус улс 15.6 сая хүн амтай, 63% нь ядуу, хүүхдүүдийн 23% нь өсөлтийн хоцрогдолтой. Энэ оны 05 дугаар сард жилийн албан ёсны инфляци 785.5%, гуравдугаар сараас хойш коронавирусний халдварын тохиолдол 387 болж, 4 хүн нас бараад байна.

Конго улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга авлигын хэргээр ял сонслоо⁴⁶⁶

2021.06.21. Конго улсын шүүхээс тус улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Витал Камерег авлигын хэрэгт гэм буруутай гэж үзэн 20 жил хүнд хөдөлмөр эрхлэх, хэдэн сая долларын торгууль төлөх ял оноосон байна.

Камере нь улсын дэд бүтцийн төсөл, хөтөлбөрөөс 50 сая гаруй ам.доллар хулгайлсан нь шүүхээр тогтоогдсон ч тэрээр шүүх хурал дээр Ерөнхийлөгчийг шүүмжлэгчдийн улс төрийн гүтгэлэг хэмээн үзэж, тайлбар өгөхөөс татгалзжээ.

Дээрх хэрэг явдал нь Конгогийн ард иргэдийн анхаарлыг маш ихээр татаж байсан бөгөөд тухайн шүүх хурлыг даргалах байсан шүүгчийг гадны нөлөөгүйгээр нас барсан гэж Хууль зүйн сайд зарласан ч шүүх шинжилгээгээр гадны нөлөөтэй болох нь тогтоогдож, мөрдөн шалгах ажиллагааг эхлүүлсэн байна.

Камере 15 жилийн хугацаанд эрх мэдэлтэй улс төрч байсан ба Ерөнхийлөгч асан Жосифыг 2006 онд анхны сонгуульдаа ялалт байгуулахад нь тусалж, өөрөө Үндэсний Ассамблейн тэргүүнээр сонгогдож байсан юм.



Камере бол БНАКУ-д авлигын хэргээр ял сонссон хамгийн ахмад улстөрч юм. (Фото: Baz Ratner/Reuters)

⁴⁶⁶ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.riskscreen.com/kyc360/news/aide-to-congo-president-sentenced-to-20-years-for-corruption/>

Тэрээр 2023 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшихээр төлөвлөж байсан хэдий ч ийнхүү ял шийтгэлтэй учраас нэр дэвших боломжгүй болохоос гадна сонгуульд санал өгөх, төрийн албанд ажиллах эрхийг нь 10 жилээр хязгаарлажээ.

Авлигач цагдаа нарын хувьд хар баасан гараг болж өнгөрлөө⁴⁶⁷

2020.08.08. Өмнөд Африкийн Цагдаагийн алба хулгай, дээрэм, хар тамхины наймаа, хууль зөрчих зэрэг гэмт хэрэгт холбогдсон 23 цагдаагийн ажилтныг өнгөрсөн баасан гарагт баривчлав.

Баривчлагдсан хүмүүсийн 12 нь 30-51 насны албан хаагчид байсан ба ОР Тамбо олон улсын нисэх онгоцны буудал дахь авлигатай холбоотой гэмт хэргийн гурван жил үргэлжилсэн мөрдөн байцаалтын үр дүнд тэднийг баривчилжээ.

Цагдаагийн албаны хэвлэлийн төлөөлөгч хурандаа Катлего Могалегийн хэлснээр сэжигтнүүдийн нэгнийх нь гэрээс 1 сая орчим рандыг бэлнээр хураан авсан байна. Цаашид энэхүү цагдаагийн албаны таван албан хаагчийг нэмж баривчлах ба тэдгээрийн нэг нь хөл хорионд тусгаарлагдсан байгаа ажээ. “Сэжигтнүүд ОР Тамбо олон улсын нисэх онгоцны буудалд хураан авсан хар тамхи, мансууруулах бодисоос хулгайлсан гэдгээ хүлээсэн. Үүнтэй холбоотойгоор өнөөдрийг хүртэл нийт 20 авлигын хэргийг бүртгэсэн” гэж хурандаа Могале мэдэгдсэн.

Үүний зэрэгцээ Тшване хотын цагдаагийн албаны 32-49 насны 11 цагдаагийн офицерыг мөн баасан гаргийн өглөө баривчилжээ. Эдгээр 1 эмэгтэй, 10 эрэгтэй албан хаагчийг 2018 оны 11 дүгээр сараас эхэлсэн мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд баривчилсан бөгөөд тэд замын хөдөлгөөний зөрчилтэй холбоотойгоор хахууль авсан болохоо хүлээн зөвшөөрсөн ажээ. Тэдний үйлдсэн гэмт хэргийн улмаас тус улсын авто зам дээр шаардлага хангахгүй тээврийн хэрэгсэл жолоодсон болон зам тээврийн ноцтой хэрэг үйлдсэн этгээдүүд шийтгэлгүй үлдэх болно гэж хурандаа Могале хэлэв.

Эдгээр гэмт хэргийн шүүх хурлыг энэ долоо хоногийн мягмар гарагт хийх ажээ.

Өмнөд Африкийн эрх баригч намын өндөр албан тушаалтан авлигын хэрэгт холбогджээ⁴⁶⁸



(Фото: nytimes.com)

2020.11.14. ӨАБНУ баригч Африкийн үндэсний конгресс нам (АҮКН)-ын өндөр албан тушаалтан Ерөнхийлөгч асан Жейкоб Зумагийн удирдлага дор төсвийн хөрөнгө шамшигдуулсан авлигын хэрэгт холбогдон 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр шүүхэд дуудагджээ.

Намын ерөнхий нарийн бичгийн дарга Эйс Магашүлэ хууран мэхэлсэн, мөнгө угаасан болон авлигын зэрэг нийт 21 гэмт хэрэгт холбогдож Блумфонтайн хотын шүүхэд дуудагдсан боловч батлан даалтаар суллагдсан байна.

Ноён Эйс Магашүлэ нь Африкийн үндэсний конгресс намын “Том зургаа” ӨАБНУ-ыг 1994 оноос хойш удирдсан намын хамгийн нөлөө бүхий гишүүдийн нэг юм. Тэрээр намын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулдаг бөгөөд ийнхүү баривчлагдсан явдал нь зарчмын хувьд нөлөө бүхий байр сууриа орхиход хүргэж магадгүй юм.

⁴⁶⁷ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.thesouthafrican.com/news/police-corruption-in-south-africa-2/>

⁴⁶⁸ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.nytimes.com/2020/11/13/world/africa/anc-corruption-south-africa.html>

Энэ оны эхээр тус намаас авлигын гэмт хэрэгт холбогдсон гишүүдийг хэрэг шийдэгдэж дуустал өөрсдийн албан тушаалыг орхихыг хүссэн боловч энэхүү хүсэлт нь дунд түвшний албан хаагчдад хараахан хэрэгжиж амжаагүй байгаа юм. Гэвч энэхүү хэрэг нь ноён Эйс Магашүлэ болон АҮКН-д томоохон үр дагавартай юм.

Тэрээр хоёр жилийн өмнө сонгогдсон Ерөнхийлөгч Сирил Рамафосагаас хойш гэмт хэрэгт холбогдсон хамгийн нөлөө бүхий улс төрч юм. Ноён Магашүлэ Ерөнхийлөгч Рамафосагийн улс төрийн өрсөлдөгч бөгөөд Ерөнхийлөгч асан Зумагийн дэмжигч байжээ.

Ноён Магашүлэ 2014 онд засгийн газраас байгуулсан бага орлоготой иргэдийн орон сууцыг судлах 14 сая гаруй ам.долларын өртөгтэй гэрээтэй холбогдох хэрэгт шалгагдаж байгаа юм. Хэдийгээр 6 жилийн хугацаа өнгөрсөн боловч ямар нэгэн судалгаа хийгдээгүй талаар иргэд мэдэгджээ.

Прокуророос тус гэрээг байгуулсан компаниуд нь үндсэн өртгийн багахан хэсгийг ашиглан гуравдагч этгээдээр холбогдох ажлыг гүйцэтгүүлж, АҮКН-ын хамаарал бүхий этгээдийн дансанд олон сая доллар шилжүүлсэн гэж үзэж байна.

Түүнчлэн Прокурорын газраас мэдээлснээр Ноён Магашүлэ 3,431 ам.долларын хахууль бизнес эрхлэгчээс авж, өөрийн туслахын сургалтын төлбөрийг төлсөн, намын гишүүдийн Куба улсад хийх аяллыг санхүүжүүлэх зорилгоор аяллын компанид 16 мянган ам.доллар төлөхийг шаардсан үйлдэлд мөн шалгагдаж байна. Ноён Магашүлэ 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр шүүх хуралд ирсэн бөгөөд түүний олон мянган дэмжигч гадаа нь жагсжээ.

Үүнээс өмнө тус намын гишүүд болон хамаарал бүхий этгээдүүд коронавирусний цар тахалд нэрвэгдсэн хүмүүст зориулсан сангаас хөрөнгө завшсан бөгөөд энэ нь олон нийтийн дургүйцлийг хүргээд байгаа юм. Түүнчлэн Ерөнхийлөгч Рамафоса нь авлигын эсрэг хөдөлгөөнийг эрчимжүүлжээ. Засгийн газрын тооцоолсноор 32 тэрбум ам.долларыг Ерөнхийлөгч асан Зумагийн үед системийн авлигын замаар албан хаагчид завшсан байна. Зума 1999 онд дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байх хугацаандаа байгуулсан зэвсгийн гэрээтэй холбоотой авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдаж байгаа юм.

Ноён Магашүлэ өнгөрсөн хугацаанд хэд хэдэн авлигын хэрэгт холбогдсон юм. Жишээлбэл, Вреде сүүний фермийн хэрэг буюу фермийн үйл ажиллагаа эрхэлж буй хар арьст иргэдэд 21 сая ам.долларын тусламж үзүүлэх хөрөнгө нь АҮКН-ын улс төрийн холбоотнуудын халаасанд орсон байна. Гэвч энэ хэрэгт Ноён Магашүлэг хамааруулж шалгаагүй юм.

[Авлигын хэрэгт буруутгагдаад байсан Шелл, Эни компаниудыг шүүхээс цагаатгасанд Нигери улс сэтгэл дундуур байна](#)⁴⁶⁹

2021.03.17. Газрын тос олборлох салбарын томоохон авлигын хэрэгт холбогдоод байсан Эни болон Шелл компаниудыг Италийн шүүх лхагва гарагт болсон хурлаар цагаатгалаа. Удаан үргэлжилсэн энэхүү хэрэг нь 2011 онд есөн тэрбум баррель түүхий нефтийн нөөцтэй гэж тооцоолсон Нигери дэх аварга том газрын тосны ордыг Эни болон Шелл компаниуд худалдан авсантай холбоотой юм.

Эдгээр компаниуд тус ордыг баталгаатай ашиглах үүднээс хахууль өгч байсан хэмээн прокурорууд буруутгасан. Тэд Нигерийн газрын тосны сайд асан Дан Этете (Dan Etete)-гийн эзэмшиж байсан газрын тосны ордыг худалдаж авах OPL 245 лицензийн⁴⁷⁰ төлбөрт 1.3 тэрбум доллар төлжээ.

Худалдан авсан үнийн дүнгийн 1.1 тэрбум доллар нь Этете зэрэг зуучлагч, улстөрчдөд очсон хахууль байсан гэдэгтэй тэд маргасан байна.

⁴⁶⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.africanews.com/2021/03/17/nigeria-disappointed-as-shell-eni-acquitted-in-oil-corruption-case/>

⁴⁷⁰ OPL – Oil Prospecting Licence буюу Газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрөл

Мөнгийг Лондон дахь Нигерийн засгийн газрын дансанд шилжүүлсэн боловч прокуроруудын үзэж байгаагаар 1.1 тэрбум ам.доллар нь Нигерийн улс төрчид, зуучлагчдын халаасанд орсон гэж үздэг. Үүн дотор сайд асан Дан Этете ч байгаа юм.

Гэвч Миланы шүүгчид Эни, Шелл болон 13 яллагдагчийг, үүн дотор Эни компанийн Гүйцэтгэх захирал Клаудио Дескалзи (Claudio Descalzi) болон түүний өмнө тус албыг хашиж байсан Паоло Скарони (Paolo Scaroni) нарыг цагаатгасан талаар Эни компанийн хэвлэлийн төлөөлөгч мэдэгдсэн байна. Прокуророос удирдлагуудыг хорих, компанийг торгох, 1.1 тэрбум ам.долларыг хураан авах саналтай байжээ.

Прокурорууд давж заалдах эрхтэй юм.

Тус шүүхийн шийдвэр гурван жил үргэлжилсэн нийт 74 удаагийн шүүх хуралдааны дараа гарсан юм.

Харин Нигерийн засгийн газар ямар хариу үйлдэл үзүүлэв?

Гаргасан шийдвэрт сэтгэл дундуур байгаагаа илэрхийлээд, давж заалдах асуудлыг авж үзнэ хэмээн засгийн газраас мэдэгдсэн байна.

“Холбооны Бүгд Найрамдах Нигери Улс шүүгчдийн өнөөдрийн шийдвэрт сэтгэл дундуур байгаа боловч Италийн прокуроруудын хүчин чармайлтад талархаж байна. Засгийн газар цаашид ч OPL 245-тай холбоотой гэмт хэрэгтнүүдэд хариуцлага тооцох ажлыг үргээжлүүлнэ” хэмээн тус улсын засгийн газрын хэвлэл мэдээллийн албанаас мэдэгдсэн байна.

Эни, Шелл компаниуд ямар хариу үйлдэл гаргав?

Дээрх хоёр компани яллах асуудлыг үгүйсгэдэг.

“Клаудио Дескалзигийн мэргэжлийн ур чадвар болон Эни бол том компани гэсэн нэр хүндийг шүүхийн шийдвэр сэргээлээ” хэмээсэн өмгөөлөгч Паола Севериногийн үгийг ANSA мэдээллийн агентлаг эш татжээ.

Ройял Датч Шелл компанийн Гүйцэтгэх захирал Бен ван Бёрден *“2011 оны төлбөр тооцоо хууль ёсных байсан гэдгийг бид ямагт нотолж байсан бөгөөд 10 жил үргэлжилсэн хууль эрх зүйн маргааныг шийдвэрлэж, OPL 245-ыг гацаанаас гаргахыг зорьж байсан. Үүний зэрэгцээ энэ явдал бидэнд томоохон сургамж болсон. Шелл компани шударгаар, хууль ёсны дагуу ажиллахаас гадна олон нийтийн хүлээлтэд хүрэхийн тулд өдөр бүр хүчин чармайлт гарган ажилладаг”* хэмээн хэлж, шүүхийн шийдвэрийг баяртайгаар хүлээн авсан байна.

Энэ долоо хоногийн эхээр Эни үүнийг мэдэгдсэн бөгөөд Нигери улс ордыг ашиглах эрх олгоогүй цагт Шелл OPL 245-ын гэрээнд ялагдал хүлээх болно. *“Эдгээр 2 компани тус ордод 2.5 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн боловч ямар ч ашиг олоогүй ба ирэх 05 дугаар сард тусгай зөвшөөрлийн хугацаа дуусаж байгаа. Тэгэхээр, үнэндээ бол, тус хоёр компани энэ хэргийн хохирогч юм”* хэмээн Эни компанийн хэвлэлийн төлөөлөгч afr.com сайтад ярьсан байна.

Олон арван машин, байшин цуглуулсан бие хамгаалагч⁴⁷¹

2021.03.24. Малави. Норман Чисале олон жилийн турш Малави улсын Ерөнхийлөгч асан Питер Мутарикагийн аюулгүй байдлын удирдлагыг ахлан ажиллаж ирсэн нэгэн билээ. Одоо тэр авлигын хэрэгт татагдаад байна.

Норман Чисалег Малавийн Ерөнхийлөгч асан Питер Мутарикагийн “хамгийн итгэлтэй бас хамгийн айдас төрүүлэм” бие хамгаалагч хэмээн нэрлэдэг байв. Тэр бас хамгийн баян нэгэн байсан аж.

Малавичуудын гайхширлыг төрүүлсэн мэдээнд дурдсанаар тус улсын эрх баригчид өнгөрсөн сард Чисале болон түүний ойрын хамтрагч, хамаатнуудаас ойролцоогоор 2.2 сая долларын үнэтэй эд хөрөнгийг хураан авжээ.

⁴⁷¹ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2021/3/24/malawi-state-moves-to-seize-property-of-ex-presidents-bodyguard>



Малави улсын Ерөнхийлөгч асан Питер Мутарика (голд) болон түүний бие хамгаалагч Норман Чисале (зүүн талд) нар 2018 оны тусгаар тогтнолын ойн арга хэмжээнд оролцож байгаа нь.
(Фото: Амос Гумулира / AFP)

Хураан авсан өндөр үнэ цэн бүхий хөрөнгө дотор Мерседес Бенз, Рэйнж Ровер, Ланд Круйзер, Жийп Вранглер зэрэг 80 гаруй автомашин, орон сууц, худалдаа, үйлчилгээний зориулалттай барилга зэрэг 21 үл хөдлөх хөрөнгө байна. Түүнчлэн Чисалегийн нэр дээр бүртгэлтэй, ойролцоогоор 150,000 ам.доллартой банкны хоёр дансыг битүүмжилжээ.

Тус улсын авлигатай тэмцэх үйл ажиллагаа явуулдаг прокурор болон мөрдөн байцаах байгууллагаас 45 настай Чисалег 2017-2018 онд цемент импортлох олон сая долларын үнэ бүхий гэрээ хэлцэл хийх үедээ Ерөнхийлөгч Мутарикагийн нэр дээр байдаг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн дугаарыг хууран мэхлэх замаар ашигласан гэж буруутгаж байна.

Эд хөрөнгө битүүмжлүүлэхээр Малави улсын Ерөнхий прокурорын газар болон Авлигатай тэмцэх товчооны хамтран гаргасан хүсэлтэд *“эдгээр хөрөнгийг гэмт хэргийн замаар олсон орлого гэж үзэх хангалттай үндэслэлүүд байна”* гэжээ.

Гэвч Чисалегийн өмгөөлөгч Чанси Гондве хэлэхдээ, түүний үйлчлүүлэгч пүрэв гарагт эрх баригчдад эд хөрөнгийг хураахыг зөвшөөрсөн Блантайрын Дээд шүүхийн шийдвэрийг давж заалдах болно гэж мэдэгдэв.

Гондвэ Ал Жазира агентлагийн сурвалжлагчид хэлэхдээ *“жагсаалтад багтсан хөрөнгүүд нь түүнд хамааралгүй учир энэхүү шийдвэрийг гаргуулахын тулд төрийн байгууллагаас шүүхэд хангалттай үндэслэл гаргаж өгсөн гэдэгт бид итгэхгүй байна, ер нь ч тэгээд аливаа хөрөнгийг импортлож оруулж ирэх, өмчлөх гэдэг чинь тусдаа ойлголт шүү дээ”* гэв.

Харин Чисале өөрийн ярилцлагадаа *“энэ бүх зүйл үндэслэлгүй бөгөөд эдгээр тээврийн хэрэгслийг Ерөнхийлөгч Мутарикад бусдаас бэлэглэсэн бөгөөд миний хувьд эдгээр автомашинуудыг зөвхөн хүлээн авж, дараа нь Ерөнхийлөгчийн өг гэсэн хүнд хүлээлгэн өгөх үүрэгтэй байсан”* гэж мэдэгдсэн байна. Тэрбээр яг хэдэн тээврийн хэрэгсэл өөрт нь харьяалагддаг болохыг хэлээгүй аж.

Ерөнхийлөгч асан Мутарика өөрийн бие хамгаалагчийн хууль бус үйлдэлд ямар нэг байдлаар оролцож байгаагүй бөгөөд энэ талаар мэдээгүй гэв.

Чисалегийн их хэмжээний хөрөнгө баялаг ийнхүү ил болсон нь тал хувь нь ядуу зүдүү амьдардаг малавичуудыг цочирдуулж байна. Ялангуяа дийлэнх хэсэг нь газар тариалан эрхэлдэг, хүн амын ихэнх хэсгийг бүрдүүлдэг залуучуудын хувьд энэ мэдээ тун цочирдом зүйл болж байна.

Чисале цэргийн тагнуулын албанаас карьераа эхлүүлсэн бөгөөд 2009 оноос эхлэн Петер Мутарикагийн талийгаач ах болох, тухайн үеийн Ерөнхийлөгчийн албыг хашиж байсан Бингу ва Мутарикагийн үйлчлэгчээр ажиллаж эхэлжээ.

Бингу ва Мутарикаг 2012 онд албан үүргээ гүйцэтгэж байгаад нас барсны дараа Чисале түүний дүү Петер Мутарикад хүчин зүтгэж эхэлсэн. Петер Мутарика 2014 оноос өнгөрсөн оны 06 дугаар сар хүртэл Ерөнхийлөгчийн алба хашсан.

Петер Мутарикаг Ерөнхийлөгчийн суудалд суухаас өмнө түүний хувийн бие хамгаалагч Чисале олны танил олон нийтийн зүтгэлтэн ч биш, бас баян нэгэн ч байсангүй. Гэвч Мутарика Ерөнхийлөгч болсны дараа бүх зүйл маш хурдан өөрчлөгдсөн байна.

Тухайлбал, жирийн нэгэн бие хамгаалагч Чисале Төрийн ордонд хэт хүчирхэг болсныг олон хүн шүүмжилж эхэлсэн байна. Мутарикагийн харьяалагддаг намын гишүүдийн зүгээс тэднийг Ерөнхийлөгчтэй уулзахад нь саад хийдэг гэж буруутгасан ба улмаар тэдний зарим нь аюулгүй байдлын “шунахай” туслахыг албан тушаалаас нь чөлөөлөөгүй тохиолдолд намаасаа гарна гэж сүрдүүлж байжээ.

Чисале 2019 онд тээврийн хэрэгслийн албан татвараас хууран мэхлэх аргаар зайлсхийсэн хэрэгт нэр холбогдон сонин хэвлэлийн нүүрэнд гарч байсны дээр өөрийн төрсөн нутагт сүм бариулахдаа асар их хэмжээний хөрөнгө мөнгө зарцуулсан тухай хэвлэлийн мэдээ гарахад тун гайхсан царай гаргаж байжээ.

Энэ бүхнийг Ерөнхийлөгчийн албанд ажиллаж байхдаа авдаг байсан татварын дараах орлого болох сарын 1,500 орчим ам.долларын цалингаар амжуулсан байж таарах гээд байгаа юм.

“Унаа, хоолны мөнгө, бусад хэрэглээний зардалд зориулан олгодог мөнгийг нь оролцуулаад түүний сарын орлогыг 6.2 сая квача (8,000 орчим ам.доллар) болгож өсгөлөө ч гэсэн түүнд одоо байгаа энэ бүх хөрөнгийг бий болгоход 274 жил шаардагдах байсан” хэмээн Mail & Guardian сэтгүүл энэ сарын эхээр мэдээлсэн байна.

Мутарика 2020 оны 06 дугаар сард болсон сонгуульд ялагдаж түүний оронд Ерөнхийлөгч болсон Лазарус Чаквера “авлигын нурангиас эх орноо цэвэрлэнэ” хэмээн мэдэгдсэн.

Тун удалгүй Чисале цагдаагийнхны анхааралд өртжээ. Түүнийг одоогоор Авлигатай тэмцэх товчооны захирлын амь насыг бүрэлгэсэн, хүний амь хөнөөсөн, албан тушаалаа урвуулан ашигласан зэрэг хэд хэдэн хэрэгт ял тулгаж байна.

Тэр батлан даалтад байгаа бөгөөд шүүх дээр ирэх үедээ ихэнхдээ Библи барьж явдаг байна.

Улс төрийн тоймч Шериф Кайси сүүлийн үед дуулиан болж буй энэхүү авлигын хэрэг Малави улсад ямархуу хүнд ноцтой байдал нүүрлэснийг илтгэн харуулж, дэлхийн хамгийн ядуу орнуудын нэг Малавид нэг хүн хэрхэн, яаж ийм их баялаг хуримтлуулж чадсан талаар олон асуулт дэвшүүлж байна гэв.

Тэрбээр Ал Жазирад ярилцлага өгөх үедээ энэ бүх нөхцөл байдлыг дүгнэн “төр хүртэл энэ бүх баялгийг хараад дагжин чичирч байна. Гэхдээ энэ бол зөвхөн далайн нэгээхэн дусал юм” хэмээн мэдэгдсэн байна.

Малави улс ТИ байгууллагын АТИ-ээр өнгөрсөн жил 180 орноос 129-д жагсаж, 2012 оноос хойш долоон байраар ухарчээ.

Өмнөд Африкийн Зума шоронд хоригдохоор болов⁴⁷²



Жейкоб Зума 05 дугаар сард Өмнөд Африкийн Питермарицбург хотын шүүх хурал дээр.
(Фото: Фил Магакое / AFP / Getty Images)

2021.06.29. Арав орчим жилийн хугацаанд Өмнөд Африкийг удирдаж байх хугацаандаа улсын хөрөнгийг тоноход гар бие оролцсон гэх Жейкоб Зума авлигын хэргийн мөрдөн шалгах ажиллагааг үл тоомсорлосон асуудлаар 15 сарын хугацаанд шоронд хоригдох ял авав.

Тус улсын Үндсэн хуулийн цэцээс 01 дүгээр сард шүүгч Рэймонд Зондо (Raymond Zondo)-ийн удирдсан шүүх бүрэлдэхүүний асуултад Зума хариулах ёстой гэсэн шийдвэрийг гаргаад байсан юм. Гэвч 79 настай Зума шүүх болон Зондог хэт нэг талыг баримталсан хэмээн буруутгаж байсан бөгөөд нэг сарын дараа болсон шүүх хуралд оролцоогүй юм. Улмаар шүүх бүрэлдэхүүн түүний эсрэг үл тоомсорлосон гэх нэхэмжлэл гаргаад байсан билээ.

“Үндсэн хуулийн цэцийн эрх мэдэл хязгаарлагдмал, гэхдээ ноён Зума шүүхийг үл хүндэтгэсэн хэрэгт буруутай гэсэн дүгнэлтэд хүрсэн. Ноён Гедлейхлекиса Зумаг 15 сарын хугацаанд хорих ял оногдуулсан” хэмээн тэргүүн шүүгчийн албан тушаалыг орлон гүйцэтгэгч Сиси Хампеле мягмар гарагт мэдэгдсэн юм.

Өмнөд Африкийн засгийн газраас Зумагийн засаглалын үед төрөөс 500 гаруй тэрбум ранд (35 тэрбум доллар) хулгайлагдсан гэж тооцдог бөгөөд Ерөнхийлөгч асныг уг хэрэгт холбоотой хэмээн үзэх 40 гаруй гэрч байгаа юм.

Тунис улсын авлигатай тэмцэх байгууллагын дарга асныг гэрийн хорионд оруулсан байна⁴⁷³

2021.08.20. Авлигын эсрэг үндэсний хороо (АЭҮХ)-ны дарга асан Чавки Табиб (Chawki Tabib) гэрийн хорионд байгаагаа хүлээн зөвшөөрөв. Баасан гарагт өөрийн Facebook-ээр дамжуулан

⁴⁷² Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.bloomberg.com/news/articles/2021-06-29/zuma-is-jailed-for-shunning-south-african-corruption-inquiry>

⁴⁷³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aa.com.tr/en/middle-east/former-head-of-tunisia-s-anti-graft-body-placed-under-house-arrest/2342201>

“Манай гэрийн гадаа байгаа харуул намайг гэрийн хорионд байгааг хэлсэн” хэмээн мэдэгдсэн. Тэрээр энэхүү хууль зөрчсөн үйлдлийг буруушаагаад өөрийн эрх ашгаа хамгаалуулах зорилгоор зохих байгууллагад хандахаа мэдэгдсэн байна.

Тунис улсын Ерөнхийлөгч Кайс Сайед баасан гарагт АЭҮХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга Ануар Бен Хассан (Anouar Ben Hassan)-ыг ямар нэгэн тайлбаргүйгээр албан тушаалаас нь халсан байна. Харин Дотоод хэргийн сайд Рида Гарсаллауи (Ridha Gharsallaoui) албан тушаалаасаа огцрох шийдвэр гаргасан талаар хэвлэл мэдээллээр гарсан байна.

АЭҮХ 2011 онд Тунис улсын өмнөх Ерөнхийлөгч Зин ал-Абидин Бен Алиг огцруулсны дараа байгуулагдсан юм.

Ерөнхийлөгч Кайс Сайед 07 дугаар сарын 25-нд засгийн газрыг огцруулж, парламентын үйл ажиллагааг зогсоож, засаглалын үйл ажиллагааг өөртөө төвлөрүүлээд байгаа юм. Эдгээр үйл ажиллагаа нь тус улсыг “аврах” зорилготой хэмээн тэрээр мэдэгдэж байгаа ч төрийн эрх мэдлийг эзлэн авлаа хэмээн түүнийг шүүмжлэгчид буруутгаж буй юм.

Тунис бол Египет, Ливи, Йемен зэрэг эрх баригч дэглэмийг түлхэн унагах хувьсгалын жишээ болж буй Арабын орнуудын дунд ардчилсан шилжилтийг амжилттай хийсэн цорын ганц улс гэж үздэг.

Мали улсын Ерөнхий сайд асан Бубэй
Майга авлигын хэрэгт холбогдон
баривчлагджээ⁴⁷⁴



Мали улсын Ерөнхий сайд асан Бубэй Майга баривчилжээ. (Фото: Микеле Каттани / AFP)

2021.08.26. Мали улсын Ерөнхий сайд асан Бубэй Майга (Boubeye Maiga) албан тушаалаасаа огцорсон Ерөнхийлөгч Ибрахим Бубакар Кейта (*Ibrahim Boubacar Keita*)-гийн засаглалын үед ерөнхийлөгчийн нисэх онгоц худалдан авахад оролцсон тул баривчлагдсан болохыг түүний өмгөөлөгч мэдэгдлээ.

⁴⁷⁴ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2021/8/26/mali-ex-pm-boubeye-maiga-arrested-over-corruption-claims>

Хэдийгээр баривчлагдсан шалтгааныг албан ёсоор зарлаагүй боловч 2014 онд 40 сая ам.доллараар нисэх онгоц худалдаж авсантай холбоотой гэж түүний өмгөөлөгч Кассум Тапо пүрэв гарагт Ройтерс агентлагтай утсаар ярихдаа хэлсэн байна.

“Бид хавтаст хэрэгтэй танилцаагүй, танилцах хүртлээ мэдээлэл өгөх боломжгүй байна” гэж тэр хэлсэн байна. Хууль зүйн яам уг асуудалд ямар нэг тайлбар, мэдэгдэл хийгээгүй байгаа юм.

Тухайн үеийн шүүмжлэгчид Кейтагийн засаг захиргаа нисэх онгоцыг хэт өндөр үнээр худалдан авсан үйлдэл нь авлигын гэмт хэргийн шинжтэй гэж дүгнэдэг юм. Улмаар энэ нь Кейтагийн Ерөнхийлөгчийн албан тушаалд нөлөөлж, зээлдүүлэгчдийг айлгасан улс төрийн үйл явдал болж байсан юм. Үр дүнд нь ОУВС, Дэлхийн банк баруун Африкт орших тус улсад үзүүлэх санхүүжилтээ зогсоосон билээ.

Прокурорын байгууллагад тус гэмт хэрэгт холбогдолтой нотлох баримт байгаа эсэх, түүнийг ямар шалтгааны улмаас одоо баривчилсан нь тодорхойгүй байна. Тэрээр 2017-2019 онд Ерөнхий сайдаар ажилласан бөгөөд 2022 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших боломжтой улс төрчдийн нэг юм.

Тус улсын төрийн эргэлтийг удирдаж байсан, одоо түр ерөнхийлөгчөөр ажиллаж байгаа хурандаа Ассими Гоита (Assimi Goita) энэхүү шилжилтийн үеийг тэргүүлж байгаа юм.

Өмнөд Африкийн Ерөнхийлөгч асан Зумагийн авлигын хэргийн шүүх хурал 10 дугаар сарын 26-ны өдөр хүртэл хойшиллоо⁴⁷⁵

2021.09.22. Өмнөд Африкийн Ерөнхийлөгч асан Жейкоб Зумагийн засгийн газрын хоёр тэрбум долларын зэвсгийн наймаатай холбоотой авлигын хэргийн шүүх хурлыг 10 дугаар сарын 26-ны өдөр хүртэл хойшлуулсан гэж шүүх хуралдааны даргалагч 09 дүгээр сарын 22-ны өдөр мэдэгджээ.

1990 оны үед болсон уг асуудалтай холбоотой шүүх хуралдаан энэ оны 05 дугаар сард эхлэх ёстой байсан ч хуулийн үндэслэл болон Зума шүүх хуралдаанд хүрэлцэн ирээгүй гэх зэрэг шалтгааны улмаас хэд хэдэн удаа хойшлоод байна.

79 настай Зума нь 09 дүгээр сарын 21, 22-ны өдрүүдэд болох ёстой байсан шүүх хуралд эрүүл мэндийн шалтгааны улмаас оролцоогүй юм. Тэрээр өнгөрсөн 08 дугаар сард хагалгаанд орсон гэх боловч, ямар шалтгааны улмаас хагалгаанд орсон нь одоог хүртэл тодорхойгүй байна.

Тэрээр зэвсгийн наймаатай холбоотой авлига болон мөнгө угаасан гэмт хэргийн үйлдэлд оролцоогүй гэдгээ тухай бүр илэрхийлж иржээ. Ялангуяа Францын зэвсгийн Thales группийг эрх бүхий хуулийн байгууллагын шалгалтаас хамгаалсны хариуд хахууль авсан хэрэгт буруутгаж байгаа бөгөөд мөн л энэ гэмт хэрэгт гар бие оролцоогүй гэж мэдэгдсэн байна.

Авлигын асуудалд холбогдсон уул уурхайн компанийн захирлыг ажлаас нь чөлөөлөв⁴⁷⁶

2021.12.03. Конго улсын төрийн өмчит уул уурхайн компанийн захирал Алберт Юма Мулибийг компанийн ашиг орлогоос олон тэрбум долларын хөрөнгө алга болсон асуудалд буруутган, баасан гарагт албан тушаалаас нь чөлөөлжээ. Энэ алхам нь дэлхийн цэвэр эрчим хүчний хувьсгалд Конго улс улам бүр чухал болж байгаа тул авлигатай тэмцэх зорилготой хэмээн албаны эх сурвалж мэдэгдэв. Учир нь Конго дахь кобальт бол дэлхийн цэвэр эрчим хүчний хувьсгалын чухал нөөц юм.

Алберт Юма Мулиби 2010 оноос хойш тус компанийн захирлын албан тушаалыг хашиж байгаа бөгөөд түүнтэй холбоотой авлигын асуудлын тухай Нью Йорк Таймс сонинд нийтлэл гарснаас

⁴⁷⁵ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.reuters.com/world/africa/corruption-trial-former-safrica-president-zuma-postponed-oct-26-2021-09-22/>

⁴⁷⁶ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.nytimes.com/2021/12/03/world/congo-cobalt-albert-yuma-mulimbi.html>

хэд хоногийн дараа тус улсын Ерөнхийлөгч Феликс Цисекеди албан тушаалаас нь чөлөөлөх шийдвэр гаргасан байна.

Ашиг малтмал олборлохтой холбоотой томоохон хэлцлүүдийг олон улсын компаниудтай хийхэд Юма нь захирлын албан тушаалгүй болсон тул ач холбогдол багатай болов.

“Энэхүү үйл явдлын ач холбогдлыг дутуу үнэлж болохгүй. Энэ нь тус улсад авлигатай тэмцэхэд чухал алхам болж буй юм. Тус улсын байгалийн баялаг, улс төр, эдийн засгийн эрх мэдлийн чухал албан тушаал” хэмээн нэгдүгээр сарыг хүртэл АНУ-ын Төрийн департаментын Төв Африкийн асуудлыг хариуцаж байсан Ж.Питер Фам мэдэгдэв.

Юма нь кобальт олборлох бичил, жижиг уурхай, үйлдвэрлэлийн бус аргаар олборлож буй нөхцөл байдлыг хянах эрхээ хадгалж үлдэнэ хэмээн тус салбарын удирдлагуудын нэг мэдэгдэв. Тэрээр бичил уурхайчид гэгддэг албан бус уурхайчдаас кобальт худалдаж авах, үнийг зохицуулахаар төлөвлөж буй юм. Гар аргаар кобальт олборлох явдал Конго улсад тус салбарын олборлолтын гучин хувийг эзэлдэг байна.

Үйлдвэрлэлийн бус аргаар олборлолтын аюулгүй ажиллагаанд анхаарал хандуулахаа Юма мэдэгдээд байгаа юм. Олборлолт явуулахтай холбоотой хүүхдийн хөдөлмөр эрхлэлт, бэртэж гэмтэх, нас барах зэрэг нь олон улсын анхаарлыг татаж, АНУ-ын шинэ хөрөнгө оруулагчид, зарим автомашин үйлдвэрлэгчид Конго улсаас кобальт худалдаж авахаас татгалзахад хүргэсэн.

Дэлхийн кобальт олборлолтын гуравны хоёрыг Конго олборлодог ба мөн зэсийн томоохон үйлдвэрлэгч юм. Сүүлийн жилүүдэд үнэ огцом өссөн ч гадаадын уул уурхайн компаниуд, үүн дотор БНХАУ-ын засгийн дэмжлэгтэй компаниудтай хийж байсан гэрээ хэлцлийг Юма хариуцаж байхад Жекаминес (Gécamines⁴⁷⁷) шүүмжлэлд ихээр өртөж байв. Учир нь тус улсын ер бусын ашигт малтмалын баялгийг гадаадынханд ашигтайгаар өгөх боломж олгож байсан аж.

АНУ-ын Төрийн департаментын албан тушаалтнууд Байдены засаг захиргааг Юмагийн эсрэг хориг арга хэмжээ авахыг уриалсан бөгөөд тэрээр өнгөрсөн жилүүдэд уул уурхайн орлогоос 8.8 тэрбум ам.долларыг өөр өөр зүйлд зарцуулсан хэмээн буруутгагдаж байгаагаа “Таймс” сонинд өгсөн ярилцлагадаа дурджээ.

Юмаг АНУ-д нэвтрэхийг 2018 онд хориглож байсан ба тэрээр олон улсын банкууд дахь хөрөнгийг нь царцаах, бусад хориг арга хэмжээний эсрэг Вашингтонд хуульчид болон лобби хийх хүмүүсийг хөлсөлж байсан юм.

Юма нь Конго улсын хамгийн баян хүмүүсийн нэг бөгөөд улс төрийн тоглогч юм. Тэрээр баасан гарагт ярилцлага өгөх хүсэлтэд хариу өгөөгүй юм. Тэгэхдээ сүүлийн саруудад Таймс сонинд өгч байсан хэд хэдэн ярилцлагад өөрийг нь буруутгаж байгаа хэргийг Конго улсын бүрэн эрхт байдлыг алдагдуулахыг зорьж буй гадны өдөөн хатгагчдын явуулга гэж байсан юм.

Жекаминес хэдэн арван жилийн турш Конго улсын хамгийн том орлогын эх үүсвэрийн нэг байсаар ирсэн бөгөөд олон улсын томоохон уул уурхайн компаниудад олгосон концессыг хянаж, тэднээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр авдаг байв. Өнгөрсөн жил тус компани 324 сая ам.долларын орлого олжээ.

Юмаг Ерөнхийлөгч асан Жосеф Кабила томилсон бөгөөд Ерөнхийлөгчийн гэр бүлийг баяжуулах, тус агентлагийн хөрөнгийг улс төрд ашиглах зорилготой байсан хэмээн америкийн албаны хүмүүс үздэг.

Тэрээр 2019 онд Феликс Цисекеди Ерөнхийлөгчөөр сонгогдсон жил дахин томилогдсон. Тус жил түүний нэр Конго улсын Ерөнхий сайдын албан тушаалд яригдсан. Юмаг Кабилагийн итгэмжлэгдсэн төлөөлөгч болох нь хэмээн энэ томилгоог АНУ-аас эсэргүүцсэн байна.

Юмагийн оронд гурван жилийн өмнө Жекаминесийн захиргааны зөвлөлийн гишүүн болсон Капуто Калуби Алфонсе (Caputo Kalubi Alphonse) томилогдох болсныг Ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч баасан гарагт үндэсний телевизээр зарласан юм.

⁴⁷⁷ La Générale des Carrières et des Mines гэдэг үгийн товчлол. Конго улсын Катанга муж дахь Лубумбаши хотод төвтэй түүхий эдийн худалдаа, уул уурхайн компани.

Европ тив

Красноярскийн депутат авлигын хэргээр 8 жилийн хорих ял авлаа⁴⁷⁸

2020.02.28. ОХУ. Красноярскийн депутат Сергей Титов их хэмжээний хахууль авсан хэргээр 8 жилийн чанга дэглэмтэй хорих ангид хоригдох ял авав.

“Красноярск хотын Төмөр замын дүүргийн шүүхээс ОХУ-ын Эрүүгийн хуулийн 290-ийн 6 дугаар зүйлд заасан гэмт хэрэгт буруутгагдсан С.С.Титовт холбогдох эрүүгийн хэрэгт чанга дэглэмтэй засан хүмүүжүүлэх хорих ангид 8 жилийн хорих ял эдлүүлэх шийдвэр гарсан. Шүүхийн шийдвэр албан ёсоор хүчин төгөлдөр болоогүй” гэж шүүхийн цахим сайтад бичсэн байна.

Красноярск бүсийн хууль тогтоох байгууллагын гуравдугаар хурлын депутатад хамаарах их хэмжээний залилангийн хэрэгт 2019 оны зун эрүүгийн хэрэг үүсгэсэн талаар Регнум өмнө нь мэдээлж байсан.

Уг депутат дулааны эрчим хүчний үнэ тарифтай холбоотой төрийн эрх баригчдын шийдвэрт эрх мэдлээрээ нөлөөлөхөөр эрчим хүчний компанийн захиралд амласан байна. Энэ шийдвэр нь тус компанид их хэмжээний татаас авах боломжийг олгох ёстой байжээ.

Дулааны эрчим хүчний компанийн захирал уг депутатад 2018 оны 05 дугаар сараас 2019 оны 06 дугаар сар хүртэлх хугацаанд тохиролцсоны дагуу 4 саяаас багагүй хэмжээний рублийг хэсэг хэсгээр хуваан өгсөн байна.

Прокурор их хэмжээний хахууль авсан хэрэгт сэжиглэгдэж байна⁴⁷⁹

2020.02.28. Казахстан. Талдыкорган хотын Тээврийн прокурорын газрын ахлах прокурор, Алмата хотын Эдийн засгийн судалгааны газрын ахлах мөрдөн байцаагч, Улсын орлого төлөвлөлтийн газрын ерөнхий мэргэжилтэн нарыг их хэмжээний хахууль авсан хэрэгт сэжиглэж байгаа талаар Казинформ мэдээллийн агентлаг мэдээллээ.

“Алмата мужийн Авлигатай тэмцэх алба Казахстан улсын Ерөнхий прокурорын газрын Дотоод мөрдөн шалгах хэлтсийн ажилтнуудтай хамтран зохион байгуулсан тусгай мөрдөн шалгах цогц арга хэмжээний үеэр Талдыкорган хотын Тээврийн прокурорын газрын ахлах прокурор, Алмата мужийн Эдийн засгийн судалгааны газрын ахлах мөрдөгч, Улсын орлого төлөвлөлтийн газрын ерөнхий мэргэжилтэн нар нь урьдчилан тохиролцсоны дагуу хэсэг бүлэг хүмүүсээс их хэмжээний хахууль авсан нь тогтоогдсон” гэж Авлигатай тэмцэх албаны шуурхай хуралдаан дээр Казахстаны Авлигатай тэмцэх газрын нэгдүгээр хэлтсийн мөрдөгч Кайсар Баржаксынов мэдээллээ.

Түүний хэлснээр эдгээр албан тушаалтнууд нь компанийн захирлаас түүний санхүүгийн хууль бус ажиллагаатай холбоотой эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосны төлөө 30 мянган ам.долларын хахууль авсан хэрэгт сэжиглэгдэж байгаа юм.

“Сэжигтнүүдийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 128 дугаар зүйлд заасны дагуу баривчилж Талдыкорган дахь түр хорих төвд хорьсон. Одоогоор мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байна” гэж нэмж хэлэв.

⁴⁷⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/2870584.html>

⁴⁷⁹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://kokshetau.asia/proisshestviya-mobile/52066-v-poluchenii-krupnoj-yzyatki-podozrevayut-prokurora>

Гүрж улсын Боржоми хотын дарга болон захиргааны зөвлөлийн дарга нар авлигын хэргээр баривчлагдав⁴⁸⁰



(Фото: anticorr.media)

2020.03.02. Тбилиси хотын шүүх авлигын хэрэгт буруутгагдаж байгаа Боржоми хотын дарга Левана Липартия болон хотын захиргааны зөвлөлийн дарга Георгий Гогичаишвили нарт урьдчилсан байдлаар хорих ял оноосон байна.

Энэ тухай сөрөг хүчний Мтавари архи телевизээс мэдээлжээ.

Сэтгүүлчдийн мэдээлж байгаагаар захиргааны зөвлөлийн даргыг 7.2 мянган ам.доллартой тэнцэх 20 мянган лари авж байхад нь Улсын аюулгүй байдлын албаны Авлигатай тэмцэх газрын ажилтнууд саатуулжээ.

Мөрдөн шалгах ажиллагаагаар энэ нь хахуулийн зөвхөн нэг хэсэг бөгөөд нийт дүн нь 200 мянган лари (72 мянган ам.доллар) байх ёстой гэж үзэж байна. Тэрээр энэ мөнгийг Бакуриани (цанын бааз) амралтын бүсэд барилга барих зөвшөөрөл хууль зөрчин олгосныхоо төлөө авсан байна.

Хотын дарга Липартия нь ойролцоогоор 10.5 мянган лариг (3.5 мянган ам.доллар) хахуульд авсан. Түүний үүрэг бол барилгын ажилд дэмжлэг үзүүлэх явдал байжээ. Нэгжлэгийн үеэр хотын даргад бүртгэлгүй буу зэвсэг байсныг олж илрүүлсэн байна.

Энэ хоёр улс төрч нь эрх баригч Гүржийн мөрөөдөл намын гишүүд юм. Шүүгдэгч нар өөрсдийгөө гэм буруутай гэж хүлээн зөвшөөрөөгүй байна.

Дэлхийн банк авлигын улмаас Шведийн компаниудыг хар жагсаалтад оруулав⁴⁸¹

2020.03.03. Авлигын хэрэгт сэжиглэгдэж байсан Шведийн компаниудын авлигын баримтууд уг аж ахуйн нэгжүүдийн өөрсдийнх нь ажилтнуудын мэдээллийн ачаар ил болжээ. Тиймээс эдгээр

⁴⁸⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <http://anticorr.media/v-gruzii-arestovali-mera-i-predsdatel'ya-parlamenta-borzhomi-po-obvineniyu-v-korrupcii/>

⁴⁸¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/economy/2872805.html>

компаниуд ДБ-ны хар жагсаалтад орсон байна. Энэ тухай 03 дугаар сарын 02-ны өдөр Шведийн СВТ Нихетер сэтгүүл мэдээлэв.

Эрчим хүч, дижитал аюулгүй байдал, олон улсын зөвлөх үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Шведийн компаниуд энд яригдаж байна. Тэдний заримыг нь хэдэн жилийн хугацаатайгаар хар жагсаалтад оруулсан бол заримыг нь 900 гаруй жилийн хугацаатай буюу 2999 он хүртэл ийнхүү хар тамга даржээ. Энэ хугацаанд тэд ДБ-наас санхүүжүүлсэн ямар ч төсөлд оролцох боломжгүй болж байгаа юм.

Эдгээр аж ахуйн нэгжийн хахуулийн талаарх мэдээлэл бүхий баримтууд хар жагсаалтад оруулах гол шалтгаан болжээ. Тодруулбал, Литвийн дулааны цахилгаан станцуудын угаарын хийг цэвэрлэх гэрээ, хахуульд өгөхөөр бэлдсэн бэлэн мөнгө, мөн Лаосын өндөр албан тушаалтанд зориулж шинэ машин худалдаж авахтай холбоотой мэдээллийг дурдсан байна.

“Авлига бол нийгмийн хөгжил, ядууралтай тэмцэхэд хамгийн ноцтой аюул заналхийллийн нэг болж байна гэж Дэлхийн банк үзэж байна” хэмээн Шведийн Авлигатай тэмцэх институтгийн Ерөнхий нарийн бичгийн дарга Натали Энгстам Фален мэдэгдэв.

Дэлхийн банкны үзэж байгаагаар авлигыг илрүүлэх хөдөлшгүй баримт олж авах нь асуудлын гол хүндрэл гэжээ.

Мөн нийтийг хамарсан томоохон хэмжээний мөрдөн шалгах ажиллагааг хэдэн жилийн турш явуулах болсон тухайгаа ДБ зарласан боловч эцсийн дүндээ хууль зөрчсөн бүх баримтыг илрүүлэх боломжгүй гэдгийг санхүүгийн байгууллагын ажилтнууд хүлээн зөвшөөрч байна.

Албани улсын Ерөнхий прокурор асан авлигын гэмт хэрэгт буруутгагдаж байна⁴⁸²

2020.03.09. Албанийн прокурорууд даваа гарагт тус улсын Ерөнхий прокурор асныг хууль бусаар эзэмшсэн хөрөнгөө нуун дарагдуулсан гэх асуудлаар буруутгаад байна.

Ерөнхий прокурор асан Адриатик Лаллаг хөрөнгөө нуусан, мэдүүлээгүй тул хэргийг шүүхэд шилжүүлнэ хэмээн Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх тусгай прокурор (СПАК) мэдэгдэв.

Лаллаг албан тушаал хашиж байх хугацаандаа үл хөдлөх хөрөнгө хууль бусаар худалдан авсан асуудлаар мөрдөн шалгасан юм. Тэрээр Албани улсын Ерөнхий прокурорын албан тушаалыг 2017 оны 12 дугаар сард хүлээлгэн өгсөн.

Албанийн нийслэл Тирана хотод байрлах Лаллагийн орон сууц, түүний эзэмшлийн хоёр га (5.4 акр) газар буюу нийтдээ 98 сая лек (906,000 доллар)-тэй тэнцэх хэмжээний хөрөнгийг прокурорууд 2018 онд хураан авсан.

Хэрэв гэм буруутай нь нотлогдвол 3 хүртэлх жилийн хорих ял оногдуулах юм. Энэ хэрэг нь өндөр албан тушаалтны эсрэг СПАК-аас үүсгэсэн анхны хэрэг юм.

Барселоны тоглогч асан Роналдиног мөнгө угаасан хэрэгт холбогдуулан шалгаж эхэллээ⁴⁸³

2020.03.16. Барселоны од асан Роналдиног Парагвай улсын хууль сахиулах байгууллагууд мөнгө угаасан байж болзошгүй гэж үзэн шалгаж байгаа талаар Ройтерс агентлаг мэдээллээ.

Мөрдөгчид Роналдино болон түүний менежерээр ажиллаж байгаа төрсөн ах Роберто дэ Ассис (Roberto de Assis) нарын гар утсан дахь захидал болон баримт бичгүүдийг шалгахаас ажлаа эхэлнэ гэж дээрх мэдээлэлд дурдсан байна.

⁴⁸² Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.nytimes.com/aponline/2020/03/09/world/europe/ap-eu-albania-corruption.html>

⁴⁸³ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.football-espana.net/2020/03/16/former-barcelona-star-ronaldinho-being-investigated-for-money-laundering>

Роналдино ахынхаа хамт Парагвай улс руу хуурамч гадаад паспорт ашиглан нэвтэрсэн бөгөөд одоогоор тэндээ саатуулагдаад байгаа юм. Мөрдөн шалгах ажиллагаа шинэ шатанд шилжсэн тул шүүх хуралдаан болох хүртэл суллагаагаар гаргасан хүсэлтийг нь цуцлаад байна.

Хэргийг шалгах ажиллагааг удирдаж буй прокурор Осмар Легал (Osmar Legal) Ройтерс агентлагт өгсөн ярилцлагадаа Роналдино, Роберто нарыг Парагвайн нийслэл Асуньсон (Asuncion) хотын нисэх онгоцны төв буудалд угтаж авсан бизнес эрхлэгч эмэгтэй Далиа Лопез (Dalia Lopez) тэдэнтэй ямар харилцаатай болохыг шалгаж байгаа бөгөөд тэр эмэгтэй мөнгө угаах гэмт хэргийн хамсаатан байж болзошгүй гэжээ. Роналдино болон энэ гэмт хэрэгт холбоотой байж болох бусад хүмүүсийг ч мөн бид шалгах хэрэгтэй байгаа гэж нэмж хэлэв.

Тэд хуурамч баримт бичиг бүрдүүлэн, түүнийгээ ашиглан хил нэвтэрсэн нь илэрсэн бөгөөд хууль бус худалдаа болон хөрөнгө оруулалтад дээрх хуурамч баримт бичгүүдийг ашиглаж байсан байж болзошгүй хэмээн сэжиглэж байгаа юм.

Марко агентлагийн мэдээлснээр Роналдиногийн хил нэвтэрсэн паспорт дээр бичигдсэн төрсөн газар, огноо, овог нэр нь ямар нэг асуудалгүй байсан боловч иргэншлийг нь Парагвай улс гэж бичсэн нь зөрчилтэй байжээ.

Бямба гарагт шүүх хурал болох хүртэл цагдан хорих шийдвэрийг шүүхээс хэвээр үлдээсэн байна.

Роналдино Парагвай улсын эмзэг бүлгийн хүүхдүүдэд эмнэлэгийн тусламж үйлчилгээ үзүүлдэг сайн үйлсийн сангаа сурталчилах болон өөрийн бичсэн “Амьдралын суу билиг”(Genio de la vida) нэртэй номыг танилцуулах зорилгоор тус улсад иржээ.

Роналдино Бразилийн засгийн газарт татварын болон торгуулийн нийтдээ 2 сая гаруй еврогийн өртэй бөгөөд өнгөрсөн зун түүний 57 үл хөдлөх хөрөнгө болон Бразил, Испанийн гадаад паспортуудыг хураан авсан юм.

Роналдино Порто Алегре (Porto Alegre) хотод байрлах өөрийн нуурын байшиндаа зөвшөөрөлгүйгээр усан онгоцны зогсоол барьж 2.2 сая еврогоор торгуулсан талаар орон нутгийн хэвлэл болох Фола дэ Сао Паулаас мэдээлж байсан.

[Молдавын иргэн хахууль өгөхийг завдсан хэргээр Латвид торгуулийн ял авлаа⁴⁸⁴](#)

2020.03.27. Молдав улсын иргэн Латвийн хилийн цэрэгт 5 еврогийн⁴⁸⁵ хахууль өгөхийг завдсан хэргээр 4,300 еврогийн⁴⁸⁶ торгуулийн шийтгэл хүлээсэн талаар Tvnet.Lv портал мэдээлэв.

Латвийн эрүүгийн хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтанд хахууль өгөхийг завдах нь хүнд гэмт хэрэгт тооцогддог бөгөөд хахууль өгсөн этгээдэд торгох ялаас гадна засан хүмүүжүүлэх ажил хийлгэх болон 5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэдэг.

[Испанийн засгийн газарт 20 сая еврогийн үнэтэй амны хаалт зарсан компанийг авлигатай тэмцэх байгууллагаас шалгаж байна⁴⁸⁷](#)

2020.04.16. БНХАУ-аас их хэмжээний эмнэлгийн хэрэгсэл, амны хаалт худалдан авахаар засгийн газартай гэрээ байгуулсан дээрх компанийг Испанийн авлигатай тэмцэх байгууллагаас шалгаж байна.

Ерөнхий сайд Педро Санчесийн удирдсан засгийн газар коронавирусний үед хэрэглэх амны хаалтыг 20 сая еврогоор худалдан авах гэрээг “Soluciones de Gestión y Apoyo a Empresas SL” компанитай байгуулсан бөгөөд тус компани өнгөрсөн 06 дугаар сард Ангол дахь авлигын хэргийн талаарх Guardia Civil⁴⁸⁸-ийн бэлтгэсэн тайланд дурдагдаж байжээ.

⁴⁸⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/2897704.html>

⁴⁸⁵ 16,000 орчим төгрөг.

⁴⁸⁶ 14,000,000 орчим төгрөг.

⁴⁸⁷ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.euroweeklynnews.com/2020/04/16/anti-corruption-squad-investigates-the-company-that-sold-20-million-euros-worth-of-masks-to-the-spanish-government/>

⁴⁸⁸ Испани улсыг бүхэлд нь хамарсан хамгийн эртний цагдаагийн байгууллага

Тус компани ердөө таван ажилтантайгаар үйл ажиллагаагаа ихэнхдээ Африкт явуулж байсан бөгөөд 2017 оноос хойш санхүүгийн тайлангаа мэдээлээгүйгээс үзвэл үйл ажиллагаа нь зогссон болохыг харуулж байна.

Хахууль авж байгаад газар дээрээ баривчлагдсан хяналтын хоёр ажилтанд 10 жил хорих ял тулгаж байна⁴⁸⁹

2020.04.25. Прокурорын зүгээс тэдэнд албан ёсны ял тулгаж байгаа ч тэд одоогоор сэжигтэнд тооцогдож байна.

Молдавын Дотоод хэргийн яамны харьяа Гадаадын иргэн, орогнолын асуудал хариуцсан бүс нутгийн товчооны дарга, ажилтан 2 хүнийг хахууль авсан хэрэгт сэжиглэж байгаа талаар Үндэсний авлигатай тэмцэх төвөөс мэдээллээ.

Үндэсний авлигатай тэмцэх төвийн офицерууд прокурорын ажилтнуудтай хамтран дээрх хоёр албан тушаалтныг 40 мянган лейгийн хахууль авж байхад нь баривчилжээ.

Молдав улсын нутаг дэвсгэрт оршин суух журмыг зөрчсөн асуудалд нь хэрэг үүсгэхгүй гэж дарамталж, гадаадын иргэнээс 2 мянган евро өгөхийг шаардсан хэрэгт дээрх хоёр албан тушаалтан сэжиглэгдэж байна. Тэдний авлигын хэрэг нь дам хахууль авах гэсэн зүйл ангид хамаарагдаж байгаа юм байна. Сэжигтнүүд 72 цаг саатуулагдсан бөгөөд прокурорууд тэдэнд албан ёсны ял тулгаж, цагдан хорих асуудлыг шийдвэрлэнэ.

Шүүхээс тэднийг буруутай гэж үзвэл 10 жил хорих, торгууль төлөх, түүнчлэн төрийн албан тушаал хашихыг хориглох ял хүлээж байна.

Приморийн хязгаар дахь төмөр замын өртөөний даргыг авлигын хэрэгт буруутгаж байна⁴⁹⁰

2020.04.27. Владивостокийн төмөр замын Мыс Чуркин өртөөний даргын хэргийг шүүхэд шилжүүлсэн талаар ОХУ-ын Мөрдөн шалгах хорооны Алс Дорнодын тээврийн мөрдөн байцаах газраас мэдээлснийг Регнум-ийн сэтгүүлч олон нийтэд хүргэлээ.

Түүнийг хахууль авсан хэрэгт буруутгажээ. Тэрээр 2016, 2017 онд хуулийн этгээдүүдээс нийт 345 мянган рубль авсныг мөрдөн шалгалтаар тогтоожээ.

“Гэмт этгээд нь төмөр замын өртөөнд ирж байсан вагонуудын барааг буулгах ажлыг түргэвчилснийхээ төлөө хахууль авж байжээ” гэж мэдээлсэн байна.

Албанийн Авлигатай тэмцэх прокурорын тусгай албанаас засгийн газрын хүнсний тусламжийн 1.5 сая еврогийн тендерийг шалгаж байна⁴⁹¹

2020.05.06. Албани улсын Авлигатай тэмцэх прокурорын тусгай алба (СПАК)-наас засгийн газрын 1.5 сая еврогийн тендерийг мөрдөн шалгаж эхлэв. Энэхүү тендер нь цар тахлын үед хүнсний дутагдалд орсон гэр бүлүүдэд хүргэх хүнс нийлүүлэх тендер юм.

Тендерийн хэрэгт Батлан хамгаалахын сайд, тендерийн үнэлгээний хороо, тендерт ялсан компанийн удирдлагуудыг шалгаж эхэлсэн бөгөөд хахууль өгсөн, авсан, албан тушаалаа орвуулан ашигласан, тендерийн тэгш оролцоог алдагдуулсан гэм буруутай гэж үзэж байна.

⁴⁸⁹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://ru.sputnik.md/moldova/20200425/30014557/popalis-s-polichnym-dvoim-chinovnkam-grozit-do-10-let-tyurmy-za-vzyatku.html>

⁴⁹⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/2929839.html>

⁴⁹¹ Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://exit.al/en/2020/05/06/albanian-special-anti-corruption-office-investigating-eur-1-5-million-government-food-aid-tender/>



(Фото: UNIAN)

2020.05.06. Украин улсын Авлигатай тэмцэх прокурорын тусгай газраас тус улсын Ерөнхий прокурор асан Руслан Рябошаккад эрүүгийн хэрэг үүсгэв. Прокурорын газраас мэдэгдсэнээр уг хэргийн шүүхийн өмнөх мөрдөн шалгах ажиллагааг Украины Авлигатай тэмцэх үндэсний товчоо явуулна.

Ерөнхий прокурор асныг Украины Эрүүгийн хуулийн 368 дугаар зүйлийн 4-т заасан “албан тушаалтан хахууль авсан, эсхүл, хахууль өгөх тухай санал, амлалтыг хүлээн зөвшөөрсөн” гэмт хэрэг болон мөн хуулийн 366-1 дүгээр зүйлд заагдсан “худал мэдээлэл өгсөн” гэмт хэрэгт холбогдуулан шалгах ажиллагааг эрүүгийн хэрэг үүсгэсэн талаар Ерөнхий прокурорын газрын хэвлэлийн алба мэдээлэв.

Руслан Рябошаккаг Украины Дээд Рада буюу парламентын санал хураалтаар Ерөнхий прокурорын албан тушаалаас чөлөөлсөн бөгөөд тэрээр одоо гэр бүлийн хамт Францын Страсбург хотод байгаа юм.

**Албани улсын шүүгч, прокуророор
ажиллаж байсан 20 хүнийг авлигын хэрэгт
буруутгажээ⁴⁹³**

2020.05.09. Өмнө нь авлигын эсрэг болон мэргэжлийн хэм хэмжээг сахиж буй байдлыг шалгасан шалгалтын үр дүнгийн дагуу ажлаас нь халаад байсан 20 шүүгч, прокурорт авлигын хэрэг нээснийг прокуророос мэдэгдэв.

Авлигын хэрэг шалгадаг тусгай хэсгийн мэдэгдэлд дурдсанаар тэднийг итгэл эвдсэн, шуудан ашигласан, хууль бусаар олсон хөрөнгө, орлогоо нуусан зэрэг асуудалд буруутгажээ.

⁴⁹² Орчуулсан: А.Золзаяа. Эх сурвалж: <https://www.unian.info/politics/riaboshapka-sapo-opens-criminal-case-against-ex-prosecutor-general-10986779.html>

⁴⁹³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://apnews.com/e0e5f6c1f9cc91ce854d6b0cb26afa94>

Дээд шүүх болон Үндсэн хуулийн шүүхийн шүүгч нарын асуудлыг авлигыг шалгадаг тусгай хэсгийн прокурорууд өөрсдөө шалгах юм.

Бусад хүмүүс нь нийслэл, дүүргийн шүүх, прокурорт ажиллаж байсан тул тэдгээрийг тухайн дүүргийн прокурорууд шалгана. Нэрсийг ил зарлаагүй байгаа бөгөөд ийм төрлийн гэмт хэрэгт 8 хүртэл жилээр хорих ял ногдуулдаг байна.

Энэ оны эхээр мөн Ерөнхий прокурорыг хууль бусаар олсон хөрөнгөө нуусан асуудалд буруутгасан юм.

ЕХ, АНУ-ын шинжээчдийн тусламжтай боловсруулсан шүүх, прокурорын байгууллагын хахуультай тэмцэх, бие даасан, хараат бус байдлыг хангах шинэ хуулийг хууль тогтоох байгууллага 2016 онд санал нэгтэй баталсан юм.

Тус улсын 800 орчим шүүгч, прокурорын дөрөвний нэгийг сүүлийн хоёр жилийн хугацаанд шалгасан ба ихэнх нь ажлаасаа чөлөөлөгдсөн байна. Шүүгчгүй болсон учраас Дээд шүүх ажиллаж чадахгүй болжээ.

ЕХ-нд элсэх хүсэлтэд шүүхийн байгууллагын авлигын асуудал, шүүхийн шинэчлэл хийх шалгуур тавьсны дагуу шүүх, прокурорын байгууллага энэхүү шинэчлэлийг эхлүүлсэн. Одоогоор ЕХ-нд элсэх хүсэлтийн дагуу яриа хэлэлцээр хийх тодорхой хугацааг заагаагүй байгаа юм.

Башкирт цагдаагийн ажилтанд хахууль өгсөн үндэслэлээр торгосон байна⁴⁹⁴

2020.05.12. Башкир улсын Прокурорын газрын хэвлэл мэдээллийн албанаас цагдаагийн албан хаагчид хахууль өгөхийг оролдсон үйлдэлд 300 мянган рублийн торгууль оногдуулсан тухай 05 дугаар сарын 12-ны өдөр мэдээлсэн байна.

Белорецк хотын 42 настай иргэн ойд хууль бусаар мод бэлтгэж байсан үйлдэлд нь хойшлуулшгүй ажиллагаа явуулсан цагдаагийн ажилтанд хахууль өгөхийг завдсан байна.

Тэрээр хуулийн хариуцлагаас зугтахын тулд цагдаагийн ажилтанд 50 мянган рубль санал болгож, хэрэг үүсгэхгүй байхыг гуйсан байна.

Цагдаагийн ажилтан хуульд заасан чиг үүргийн дагуу хахууль авахаас татгалзаж, удирдлагадаа тухайн гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдлын талаар танилцуулсан байна. Улмаар, хахууль өгөхөөр завдсан иргэний үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

Уг этгээд гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн бөгөөд шүүхийн шийдвэрээр түүнийг 300 мянган рублиар торгож, хахуульд өгөхийг завдсан 50 мянган рублийг улсын орлого болгожээ.

Сайд Криклийн нууц эхнэр болон олон саяын өмч хөрөнгийг сэтгүүлчид олж илрүүлжээ⁴⁹⁵



(Фото: beztabu.net)

2020.05.22. Украины Дэд бүтцийн сайд Криклий албан ёсоор бараг ядуу хүнд тооцогдож байна. Түүний хөрөнгө, орлогын мэдүүлэгт үнэтэй эд хөрөнгө байхгүй бөгөөд тэрээр албан ёсны эхнэрийнхээ талаарх мэдээллийг мэдүүлэгтээ дурдаагүй байна.

“Авлигыг зогсооё” төслийн сэтгүүлчид Дэд бүтцийн сайдтай арваад жил холбоотой байгаа Татьяна Декало гэдэг бүсгүйн талаар мэдсэн байна. Татьяна Декало нь сэтгэл зүйчээр ажилладаг, их

⁴⁹⁴ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://regnum.ru/news/society/2947176.html>

⁴⁹⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: https://beztabu.net/zhurnalisty-nashli-nezadeklarirovannuyu-zhenu-krikliya-s-mnogomillionnym-imushchestvom-video_n70314

хэмжээний гэж тооцогдохооргүй орлоготой боловч өмч хөрөнгийн тухайд байдал өөр байна. Криклийн албан тушаалын дэвшсэн байдлыг түүний эхнэрийн эзэмшиж байсан тээврийн хэрэгслээр нь мэдэж болох юм. Нөхөр нь албан тушаал дэвших бүрд Татьяна Декало илүү их үнэтэй машин унадаг байна. Тэрээр одоо 100 мянган ам.долларын үнэтэй, тансаг зэрэглэлийн Mercedes GLC загварын машин унаж байна. Тэдний гэр бүл үнэтэй, шинэ хороололд 355 мянган ам.долларын байранд амьдарч байна. Криклийн эхнэр сэтгүүлчидтэй харьцаж дасаагүй бөгөөд нөхөр Криклий нь өөрийн орлогоо нуудаг гэдгийг хүлээн зөвшөөрчээ.

Дэд бүтцийн сайд Криклий 12 удаагийн хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ эхнэрийнхээ талаар дурдаагүй. Мөн эхнэрийн хамт хуримтлуулсан өмч хөрөнгө нь Украин улсын Авлигатай тэмцэх үндэсний товчоо, Цагдаагийн газар, Үндэсний авлигатай тэмцэх асуудал хариуцсан газарт өгч байсан хөрөнгө, орлогын талаарх мэдээлэлтэй таарахгүй, зөрүүтэй байгаа талаар “Авлигыг зогсоо” ТББ-ын хуулийн хэлтсийн дарга Роксолана Арийончик мэдэгдсэн байна.

Мөнгө угаах асуудалд холбогдсон төрийн банкийг Польш улс шалгаж байна⁴⁹⁶

2020.05.26. Польшийн өмнөд хэсэгт орших Катовице дахь бүсийн прокурорын газраас төрийн өмчит банкийг мөнгө угаасан асуудалд буруутган шалгаж эхлэв.

Базелийн засаглалын хүрээлэнгээс гаргадаг Мөнгө угаах эрсдлийн 2019 оны судалгааны тайлангийн үр дүнгээс үзэхэд Польш улс 125 улсаас 102 дугаарт жагссан байна. Тус судалгааны үр дүнгээс үзэхэд Польш улс мөнгө угаах эрсдэл харьцангуй багатайд тооцогдоно. Мөнгө угаах асуудлаас урьдчилан сэргийлэх нь Европын хувьд чухал юм. Энэ нь 2017 онд Эстони улс мөнгө угаах томоохон асуудалд холбогдсонтой холбоотой юм.

Эстони, Мальта, Латви, Кипр, Нидерланд зэрэг улсад мөнгө угаахтай холбоотой шуугиан гарсны дараагаас санхүүгийн салбарын хяналт, шалгалтыг хэрхэн сайжруулж байгааг нь ЕХ ажиглах болсон юм. ЕХ-ноос эдгээр улсууд мөнгө угаах асуудлаас урьдчилан сэргийлэх чиглэлээр банкуудад арга хэмжээ авахыг яарахгүй байна гэж үздэг. Учир нь банкууд мөнгө угаах асуудлыг хөхүүлэн дэмждэг, эсхүл хориглодоггүй юм.

Молдавт хүмүүнлэгийн тусламж үзүүлэхдээ хахууль авсан гэж Румыны эрх баригчдыг буруутгаж байна⁴⁹⁷

2020.06.05. Румыны эмнэлгүүдэд хэрэглэхээ больж, акталсан тоног төхөөрөмжийг Молдавт өгөхдөө албан ёсны гэрээ хийлгүйгээр шилжүүлсэн талаар тус улсын парламентын гишүүн Эмануэль Унгуриану мэдэгдсэн байна.

Румын улсын төрийн өмчит Юнифарм компани КОВИД-19 цар тахалтай тэмцэх ажлын хүрээнд хамгаалалтын хэрэгсэл худалдан авах зориулалтаар төрийн сангаас авсан мөнгөөрөө чанар муутай амны хаалт, эмнэлгийн тоног төхөөрөмж худалдаж авсан талаар дээрх парламентын гишүүн нотолж байна.

Тус улсын эмнэлгүүд уг амны хаалт, тоног төхөөрөмжийг авахаас татгалзсан байна. Гэвч Юнифарм компани Эрүүл мэндийн яамаараа дамжуулан уг бараа бүтээгдэхүүнийг дахин худалдан авж, Молдав руу илгээсэн байна гэж хэвлэлийн libertatea.ro агентлаг мэдээлсэн байна.

“Чанарын шаардлага хангаагүй амны хаалтууд худалдан авж, бохир мөнгө угаах ажлыг төрийн өмчит Юнифарм С.А компани гүйцэтгэсэн байна. Румын улсын төр Эрүүл мэндийн яамаар дамжуулан “мөнгө угаах” энэ ажлыг хийлгэсэн нь дипломат асуудал үүсгэсэн.

Румын улсын эмнэлгүүд авахаас татгалзсан чанарын шаардлагад нийцээгүй амны хаалт, эмнэлгийн чанаргүй тоног төхөөрөмжийг Молдав улсад тусламж болгон өгч, авахаас өөр аргагүй байдалд оруулсан байна” гэж тус улсын парламентын Эрүүлийг хамгаалах хорооны дэд дарга Унгуриану мэдэгджээ.

⁴⁹⁶ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://uk.reuters.com/article/uk-eu-moneylaundering-banks-poland/poland-investigates-money-laundering-at-state-bank-media-idUKKBN2321QI>

⁴⁹⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <http://alfanews.md/index.php?newsid=16904>

Дээрх хууль зөрчсөн асуудлыг тус улсын авлигатай тэмцэх байгууллага шалгаж эхэлсэн талаар Унгуряну нэмж хэлжээ. Тэрээр Юнифармын захирал Адриана Ионелегийн эсрэг мэдүүлэг өгч: “Би зарим мэдээллийг өгсөн байгаа, одоо үүнтэй холбоотой илүү дэлгэрэнгүй мэдээлэл, чанарын наад захын шаардлага хангаагүй эдгээр амны хаалтыг хүлээн авсан эмнэлгүүдийн нэрийг нэмж мэдээлэх болно” гэж хэвлэлийнхэнд мэдэгдсэн байна.

Түүнчлэн Румыны Эрүүл мэндийн яам болон Юнифарм компани холбогдох гэрээгээ тухайн цаг хугацаандаа байгуулаагүй гэсэн байна.

“Миний буруутгаж байгаа хоёр дахь асуудал нь Эрүүл мэндийн яамнаас Юнифармтай байгуулсан эдгээр тоног төхөөрөмжийг худалдах, худалдан авах гэрээтэй холбоотой юм. Юнифарм компаниас Эрүүл мэндийн яамны худалдан авсан хамгаалалтын хэрэгслийг Молдав улсад хүргэж байгаа тухай хэвлэл мэдээллээр мэдээлж байх үед Эрүүл мэндийн яам болон Юнифарм компанийн гэрээн дээр гарыг үсэг зурагдаагүй байсан. Өөрөөр хэлбэл, тэд баталгаажуулаагүй худалдах, худалдан авах гэрээгээр эмнэлгийн чанаргүй барааг гадаад оронд нийлүүлсэн” гэж Унгуряну мэдэгдсэн.

Молдав улс КОВИД-19-ийн өвчлөлөөр дэлхийн дундаж үзүүлэлтээс 3 дахин их байгаа талаар өмнө нь мэдээлж байсан. Олон улсын сувилагчдын зөвлөлөөс мэдээлснээр дэлхийн хэмжээнд эмнэлгийн ажилтнуудын дунд энэ өвчлөл дунджаар 7 хувиас бага байхад Молдавт энэ үзүүлэлт 19%-тай байна.

Одесс хотын захирагч Трухановын хөрөнгө, орлогын мэдүүлгийн хяналт шалгалт дууссан байна⁴⁹⁸

2020.06.05. Украины Авлигатай тэмцэх үндэсний товчооноос Одесс хотын захирагч Геннадий Трухановыг 2017 оны хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв, бодитой мэдүүлээгүй үндэслэлээр түүний мэдүүлгийг хянан шалгасан талаар тус байгууллагын хэвлэл мэдээллийн албанаас мэдээлсэн байна. Түүнийг 16.3 сая гривний үнэлгээ бүхий эд хөрөнгөө нуун дарагдуулсан гэж буруутгасан байна.

Сэжигтнээр тооцогдсон хотын захирагчийн өмгөөлөгч түүний үйлдсэн эрүүгийн хэргийн талаарх материалыг нийтэд мэдээлсэн байна.



(Фото: Геннадий Труханов / Facebook)

Украин улсын Эрүүгийн хуулийн 366 дугаар зүйлийн 366.1-д албан тушаалтны үйлдсэн гэмт хэрэгт /иргэдийн татвараас доогуур орлогын доод хэмжээг 250 хүртэл хувиар торгох, тухайн албан тушаалыг эрхлэх болон тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг 3 хүртэлх жилийн хугацаагаар хориглох/ гэж заасан байна.

Труханов нь 2015-2016 оны мэдүүлэгтээ хамт амьдарч байсан өмнөх эхнэрийн нийт 51 сая гривний үнэлгээ бүхий эд хөрөнгийг мэдүүлээгүй талаар Авлигатай тэмцэх үндэсний товчооноос мэдээлсэн байна.

“Одесс хотын захирагч нь мэдүүлэгтээ орон сууц, машины зогсоол, зуслангийн байр, тээврийн хэрэгсэл 2, компанийн хувьцаа, хадгаламжийн хүүгийн орлогыг тус тус мэдүүлээгүй. 2017 оны

⁴⁹⁸ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://gordonua.com/news/politics/nabu-zavershilo-rassledovanie-v-dele-o-deklarirovanii-nedostovernoy-informacii-truhanovym-1503034.html>

мэдүүлэгтэй нийт 16.3 сая гривний хөрөнгө, орлогоо мэдүүлээгүй байна. Дээр дурдсан мэдүүлээгүй хөрөнгө, орлогыг хяналт шалгалтын явцад илрүүлсэн” талаар хэвлэлийн мэдээнд дурдсан.

Түүнд хоёр дахь удаагаа Эрүүгийн хуулийн 366 дугаар зүйлийн 366.1-д заасны дагуу шийтгэл оногдуулж байгаа бөгөөд урьд нь 2015-2016 оны мэдүүлгээ худал мэдүүлсэнтэй холбоотойгоор 2019 оны 03 дугаар сард уг шийтгэлийг оногдуулж байсан.

[Москва хотын Прокурорын газраас тус хотын Төрийн Думын дарга, тэрбумтан Алексей Шапошниковын хөрөнгө, орлогын мэдүүлэгт шалгалт явуулж байна](#)⁴⁹⁹

2020.06.09. Москва хотын Төрийн Думын дарга Алексей Шапошниковын 1.9 тэрбум рублийн орлого мэдүүлсэн 2019 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг тус хотын Прокурорын газраас шалгаж байна. Хотын парламентын гишүүн, Яблоко жигүүрийн гишүүн Максим Кругловоос хяналт шалгалтын байгууллагад гаргасан хүсэлтийн дагуу уг шалгалтыг явуулсан байна.

Тэрээр “*Москва хотын Төрийн Думын дарга Алексей Шапошников нь хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуулийн дагуу үнэн зөв мэдүүлсэн эсэх, мэдүүлэг дэх хөрөнгө, орлогын эх үүсвэр нь бодитой эсэхийг хянан шалгаж өгнө үү*” гэсэн хүсэлт гаргажээ.

Өмнө нь Москва хотын Төрийн Думын 9 гишүүн (Яблоко бүлэг, ОХУ-ын Коммунист нам, Шудрага Орос нам) А.В.Шапошников (Нэгдсэн Орос нам)-т үл итгэж байгаагаа илэрхийлсэн үйл ажиллагааг зохион байгуулж байсан.

Тэд А.В.Шапошниковыг өнгөрсөн онд олсон 1.9 тэрбум рублийн эх үүсвэрийг тайлбарлахаас татгалзсантай холбоотойгоор дээрх хүсэлтийг гаргасан байна.

Төрийн Думын нэр бүхий гишүүд уг хүсэлт, мэдэгдлийг дэмжин гарын үсэг зурсан байна.

Энэ оны 06 дугаар сарын эхээр Алексей Навальныйн удирддаг Авлигатай тэмцэх сан нь Төрийн Думын хамгийн баян гишүүн, Нэгдсэн Орос намын гишүүн Алексей Шапошниковын 2018 оны хөрөнгө, орлогын мэдүүлэг бодит байдалтай огт нийцэхгүй байгааг мэдээлж байсан.

Түүний 2019 оны мэдүүлэг дэх орлого 1,951,949 мянган рубль бөгөөд нийслэлийн Төрийн Думын бусад гишүүдийн орлогоос хамаагүй их, мөн өмнөх оны орлогоос 80 дахин нэмэгдсэн байна. 2018 онд тэрээр 24.4 сая рублийн орлого мэдүүлсэн байна. Тэрээр 2019 онд олсон 1.9 тэрбум рублийн талаар “Думын гишүүнээр сонгогдохоосоо өмнө Захирлын зөвлөлийн даргаар нь ажиллаж байсан Северянин ХК-ийн хувьцааг 100% борлуулснаас олсон орлого” гэж тайлбарласан байна.

Түүний хөрөнгө, орлогын талаар Алексей Навальныйгийн хийсэн мэдээлэл, телевизийн нэвтрүүлэгтэй холбоотой асуудлаар А.Шапошников шүүхэд хандахаа илэрхийлсэн байна.

[Беларусийн Ерөнхийлөгчийн хамгаалалтын албаны дарга асан хахуулийн хэргээр 12 жилийн ял авлаа](#)⁵⁰⁰

2020.07.27. Тус улсын дээд шүүхээс хамгаалалтын албаны дарга асан Андрей Утсюринд дээрх ялыг оногдуулж, мөн төрийн албанд ажиллах эрхийг нь 5 жилээр хасч, хурандаа цолыг нь хураасан байна.

Мөн шүүхээс А.Утсюрингийн хахуульд авсан 192,000 ам.долларыг хураан авах шийдвэр гаргажээ.

⁴⁹⁹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: https://www.znak.com/2020-06-09/prokuratura_moskvy_proverit_deklaraciyu_spikera_milliardera_alekseya_shaposhnikova

⁵⁰⁰ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.rferl.org/a/belarusian-president-s-ex-security-chief-gets-12-years-in-prison-for-bribery/30749528.html>

Гурван талт хэлэлцээр нь Украины авлигатай тэмцэх үйл ажиллагаанд шинэ боломж авчирна⁵⁰¹

2020.07.27. Украин. Швейцарийн Ерөнхийлөгчийн Киевт хийсэн айлчлалын үеэр Швейцари, Украины прокурорын газрууд болон Украины Авлигатай тэмцэх үндэсний товчоо хамтран гурван талт харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан байна.

“Энэхүү санамж бичиг нь хулгайлагдсан мөнгийг Украинд буцаан авах ажиллагааг эрчимжүүлнэ гэж үзэж байна. Санхүүжилт шаардлагатай байгаа энэ үед уг мөнгийг чухал үйлчилгээнд зориулан ашиглах боломжтой” хэмээн Базелийн засаглалын институтын захирал Грета Феннер хэлсэн байна.

Испани улсын хаан асан авлигын асуудал дэгдсэн үеэр улсаа орхин явахаа мэдэгдээд байна⁵⁰²

2020.08.04. Саудын Араб дахь хурдны галт тэрэгний тендертэй холбогдуулан тус улсын хаан Абдуллагаас 100 сая ам.долларыг Испанийн эзэн хаан асан Хуан Карлос I авсан тухай мэдээлэл Швейцарийн Ла Трибюн де Женев сонинд гарсны улмаас уг асуудлыг Испани улсын Дээд шүүх шалгаж эхэлсэн байна.

Хуан Карлостой холбоотой асуудлыг Испанийн Ерөнхий сайд Педро Санчес “түвэгтэй” асуудал гэжээ. Испани улс дарангуйлагч Франсиско Франкогийн дэглэмийг 1975 онд халснаас хойш тус улсад ардчилал тайван замаар хөгжихөд Испанийн хаан асан 82 настай Хуан Карлос ихээхэн хувь нэмэр оруулсан гэж үздэг. Гэвч түүнтэй холбоотой авлигын асуудлаас үүдэн 2014 онд хаан ширээнээсээ татгалзаж, өөрийн хүү Фелипе IV-ийг хаанд өргөмжилснөөр Испанийн Үндсэн хуулиар олгосон халдашгүй дархан байдлаа алдсан юм.

Саудын Арабаас хаан асан Хуан Карлост өгсөн бэлэг болох 65 сая еврогийн (76 сая ам.доллар) дансны эзэмшигч нь түүний хүү Фелипе хэмээн хэвлэл мэдээллийн хэрэгслээр яригдах болсон. Фелипе нь хаан эцгээс өвлөгдөн ирэх өв залгамжлалаас татгалзсан бөгөөд өөрийн эцгийн жилийн 194,232 еврогийн (228,000 ам.доллар) тэтгэмжийг цуцлах шийдвэр гаргаж байсан.

Хааны ордныхон Фелипег өөрийн эцгийн санхүүгийн зөрчлийн талаар мэдээгүй гэж мэдэгдэж байсан юм.

Украины Батлан хамгаалах салбарын авлигын асуудалд холбогдсон этгээд хахууль өгсөн байж болзошгүй байна⁵⁰³

2020.08.20. 2019 оны 03 дугаар сард тухайн үеийн Ерөнхийлөгч Петр Порошенкогийн ойрын хүмүүс батлан хамгаалах салбарт хөрөнгө шамшигдуулж буй асуудлыг Bihus.info мэдээлсэн. Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах зөвлөлийн нарийн бичгийн даргын хүү, өөрийн найз Рогоза, Жуков нартай хамтран ОХУ-аас хууль бусаар, өндөр үнээр сэлбэг авахдаа Оптимумспецдеталь компанийг ашигласан байна.

Украин улсын цэргийн техникийн зарим хэсгийг ОХУ-аас хууль бусаар авж байсныг тухайн үеийн Ерөнхий прокурор Юрий Луценко нотолсон. Тус хэрэгт холбогдсон В.Жуковыг хахууль өгсөн байж болзошгүй гэж Үндэсний авлигатай тэмцэх хороо үзэж байгаа юм. 2020 оны намар гэхэд батлан хамгаалах салбарт оршиж байсан авлигын сүлжээг бүрэн илрүүлж, хэргийн нөхцөл байдлыг тодорхой болгоно хэмээн Үндэсний авлигатай тэмцэх хорооны дарга А.Сытник мэдэгдэв. Шалгах ажиллагаа 3 жил гаруй хугацаанд үргэлжилж байна. Рогоза болон Жуков нарыг татвараас зайлсхийсэн, мөнгө угаасан, хахууль өгсөн зэрэг асуудалд буруутгаж байгаа юм.

⁵⁰¹ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.baselgovernance.org/news/tripartite-agreement-brings-fresh-potential-fight-against-corruption-ukraine>

⁵⁰² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/08/spain-king-leave-country-corruption-claims-200803170631909.html>

⁵⁰³ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.pravda.com.ua/rus/news/2020/08/20/7263561/>

ОХУ-ын Ненецийн дунд сургуулийн захирал асныг хахууль авсан хэрэгт сэжиглэж байна⁵⁰⁴

2020.08.26. Ненецийн өөртөө засах тойргийн дунд сургуулийн захирал асныг хахууль авсан хэрэгт сэжиглэж байна.

Ненецийн өөртөө засах тойргийн дунд сургуулийн захирал 2018-2019 онд боловсролын байгууллагын хэрэгцээнд зориулсан бараа бүтээгдэхүүн худалдан авж, нийлүүлэх гэрээ байгуулсан хоёр хуулийн этгээдээс тухайн гэрээний үнийн дүнгийн 10%-тай тэнцэх хэмжээний буюу 200 мянга гаруй рублийн хахууль авсан талаар Холбооны Мөрдөн шалгах хорооны Мөрдөн шалгах газрын Архангельск муж болон Ненецийн өөртөө засах тойргийн газраас мэдээлсэн байна.

Мөн хахууль авахад зуучилсан түүний танил эмэгтэй болон хахууль өгсөн 2 этгээдэд эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа талаар мэдээлжээ.

Жолооч замын цагдаад хахууль өгөхийг завджээ⁵⁰⁵

2020.08.26. ОХУ-ын Москва хотод жолооч замын цагдаад 40 мянган рублийн хахууль өгөхийг завдсан талаар тус улсын Мөрдөн шалгах хорооны нийслэл дэх Мөрдөн шалгах ерөнхий хорооны даргын ахлах туслах Юлия Иванова мэдээлжээ.

Авто тээврийн байцаагч, цагдаа замын хөдөлгөөнд оролцож байсан тээврийн хэрэгслийг зогсоон жолоочид согтууруулах ундаа болон хар тамхи хэрэглэсэн эсэхийг шалгуулах шаардлага тавихад уг жолооч хахууль өгөх санал тавьсан тул түүнийг баривчилсан байна.

Уг жолоочид эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд тэрээр гэм буруугаа хүлээжээ.

Төрийн Думын гишүүн тэрбумын хахууль авсан хэргийг шүүхээр болжээ⁵⁰⁶

2020.08.28. ОХУ-ын Ерөнхий прокурорын газар тус улсын Төрийн Думын гишүүн Вадим Белоусовыг их хэмжээний хахууль авсан хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн байна (ОХУ-ын Эрүүгийн хуулийн 290 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг).

В.Белоусов нь 2010-2014 онд зам, барилгын нэгэн компаниас 3.2 тэрбум рублийн хахууль авсан бөгөөд түүний дэмжлэгээр уг компани зам, барилгын ажлын худалдан авах ажиллагаанд олон удаа шалгарч байсан талаар Ерөнхий прокурорын газраас мэдээлжээ.

Төрийн Думын гишүүн В.Белоусовын хахууль авсан хэрэгт Челябинск мужийн захирагч асан Михаил Юревич, төрийн өмчит Первый хлебокомбинат компанийн Ерөнхий нягтлан бодогч Маргарита Бутакова нар холбогдсон байна.

Урьдчилсан мөрдөн шалгах ажиллагааны явцад ОХУ-ын Ерөнхий прокурорын газраас гаргасан В.Белоусовын гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлыг түдгэлзүүлэх хүсэлтийн дагуу Төрийн Думаас зөвшөөрөл авж, түүнд эрүүгийн хэрэг үүсгэсэн талаар мэдээнд дурджээ.

Челябинск мужийн захирагч асан мөрдөн шалгах ажиллагаанаас оргон зугтсан бөгөөд түүнийг олон улсын хэмжээнд эрэн сурвалжилж байна.

⁵⁰⁴ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/accidents/3044963.html>

⁵⁰⁵ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://ren.tv/news/kriminal/740547-v-moskve-voditel-pytalsia-dat-vziatku-sotrudnikam-dps>

⁵⁰⁶ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.vesti.ru/article/2450489>

ОХУ-ын Мособлэнерго компанийн удирдлагыг баривчилжээ⁵⁰⁷

2020.08.30. Мособлэнерго компани (Москва хотын цахилгаан сүлжээ)-ийн Ерөнхий захирал Алексей Брижань, нэг дүгээр орлогч Алексей Астапов нарыг том барилга байгууламжийн цахилгаан сүлжээг холбох ажлыг гүйцэтгэхдээ илүү мөнгө шаардсан хэрэгт сэжиглэн 08 дугаар сарын 28-ны өдөр баривчилжээ. Тэд үнэтэй автомашин болон ойролцоогоор 4 сая рублийн үйлчилгээг хахуульд авсан байна.

Цагдаа болон Мөрдөн шалгах хорооны ажилтнуудын хамтарсан ажиллагааны үр дүнд Мособлэнерго компанийн удирдлагыг баривчилсан талаар Россия 24 телевизийн сувгаар мэдээлжээ.

Оросын Эрчим хүчний дэд сайд авлигын хэргээр баривчлагджээ⁵⁰⁸



Анатолий Тихоновыг 7.9 сая ам.долларын төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан хэрэгт буруутгаж байна. (Фото: Максим Шеметов / ТАСС)

2020.09.09. ОХУ-ын Эрчим хүчний дэд сайд төсвийн мөнгөнөөс 600 гаруй сая рубль завшсан хэрэгт сэжиглэгдэн баривчлагдсан болохыг мөрдөгчид лхагва гарагт мэдээллээ. Эрчим хүчний сайд Александр Новакын найман дэд сайдын нэг Анатолий Тихонов мэдээллийн технологийн шинэ системд зориулсан 7.9 сая доллар орчим төсвийн хөрөнгийг зүй бусаар ашигласан хэрэгт буруутгагдаад байгааг тус улсын гэмт хэрэгтэй тэмцэх хамгийн том байгууллага болох Мөрдөн шалгах хорооноос мэдэгдсэн юм.

Тихонов нь 2013-2015 оны хооронд Оросын Эрчим хүчний агентлагийг удирдаж байх үедээ дээрх мөнгийг завшсан болохыг мэдээний Коммерсантъ агентлаг мэдэгдэв.

ОХУ-д авлига ихээхэн түгээмэл бөгөөд авлигатай тэмцэх Ерөнхийлөгч В.Путины амлалтын хүрээнд сүүлийн жилүүдэд тус улсын хэд хэдэн сайд, дэд сайд, өндөр албан тушаалтнууд саатуулагдаад байгаа билээ.

⁵⁰⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.vesti.ru/article/2451040>

⁵⁰⁸ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.themoscowtimes.com/2020/09/09/russian-deputy-energy-minister-arrested-for-alleged-corruption-a71393>

Чехийн цагдаа нар хөлбөмбөгийн авлигын хэрэгт холбогдуулан шалгахаар 20 хүнийг саатуулжээ⁵⁰⁹

2020.10.16. Авлигын хэргээр баривчлагдсан 20 хүний нэг болох Чехийн Хөлбөмбөгийн холбоо (ЧХБХ)-ны орлогч дарга Р.Бербр хоёр, гуравдугаар хэсэгт тоглолтын тохиролцоо⁵¹⁰ хийсэн байж болзошгүй хэргээр шалгагдаж байна.

Чехийн цагдаа нар орон даяар ажиллагаа явуулж, авлига, тоглолтын тохиролцоонд оролцсон хэргээр ЧХБХ-ны орлогч дарга тэргүүтэй 20 хүнийг ийнхүү баривчилжээ.

Улсын дээд прокурор Ленка Брадакова баасан гарагт Ройтерс агентлагт мэдээлэхдээ “Цагдаагийнхан өнөөдөр 20 хүнд ... хөлбөмбөгийн тэмцээний үр дүнг засварлах зорилгоор авлигын хэрэг үйлдсэн зохион байгуулалттай гэмт бүлэглэлд эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна” гэжээ.

ЧХБХ-ны хэвлэлийн төлөөлөгч Майкл Юрман энэхүү ажиллагааг баталгаажуулан “Өглөөнөөс хойш цагдаа нар ажиллагаа явуулж, холбооны төв байранд нэгжлэг хийсэн болохыг бид баталж чадна. Бид цагдаагийн байгууллагатай дээд зэргээр хамтран ажиллаж байна” гэж хэлэв.

Орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр саатуулагдсан хүмүүсийн дунд ЧХБХ-ны орлогч дарга Бербр багтсан гэж мэдэгдсэн боловч Брадакова албан тушаалтан буруутгагдсан, эсвэл саатуулагдсан эсэхийг хэлэхээс татгалзсан юм. Журман ч мөн уг мэдээний талаар тайлбар өгөхөөс татгалзсан байна.

Чехийн хөлбөмбөгийн хоёр, гуравдугаар хэсэгт тоглолтын тохиролцоо явагдсан гэж үзэж буй бөгөөд хэд хэдэн шүүгчийг мөн шалгаж байгаа гэж Seznam Zpravy мэдээллийн сайт мэдээлэв.

Бербр энэ албан тушаалаа 2013 оноос хойш хашиж байгаа. Шүүгч асан, 66 настай, коммунизмын үед цагдаагийн нууц ажилтан байсан тэрбээр ЕХ-ны гишүүн орнуудын анхны эмэгтэй шүүгч Дагмар Дамковатай гэрлэсэн юм.

Хэвлэл мэдээллийнхэн Бербрийг авлигын хэргүүд болон ЧХБХ-н дахь танхай балмад явдалтай холбон онцолж байсан боловч түүнийг хэзээ ч яллаж байгаагүй билээ.

Түүний хуучин дарга Мирослав Пелта 2017 онд хахууль, эрх мэдлээ хэтрүүлсэн хэргээр саатуулагдах хүртлээ ЧХБХ-г удирдаж байв. Одоо явагдаж буй шүүх хуралдаанаар гэм буруутай нь тогтоогдвол түүнийг 12 жилийн хорих ялаар шийтгэх юм.

Нижний Новгород мужийн Сангийн яамны албан тушаалтныг авлигын хэргээр саатуулжээ⁵¹¹

2020.10.26. Эрх бүхий албан тушаалтнууд Арзамас дахь зөрчлийг нуун дарагдуулахыг оролджээ.

Нижний Новгород мужийн Сангийн яамны ажилтнууд энэ оны 09 дүгээр сараас 10 дугаар сар хүртэлх хугацаанд Арзамас хотын соёл, урлагийн байгууллагад хөндлөнгийн шалгалт хийжээ. Шалгалтаар төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан болох нь тогтоогдсон байна.

Мөрдөн шалгах явцад хөндлөнгийн шалгалт хийсэн ажлын хэсгийн удирдлага тухайн байгууллагын захиралд төсвийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан зөрчлийг 500 мянган рублиэр нуун дарагдуулахыг санал болгожээ. Санал болгосон мөнгийг өгсөн тохиолдолд тайланд дээрх зөрчлийг тусгахгүй талаар амласан байна.

Уг мөнгийг зуучлагчаар дамжуулан 250 мянган рублиэр хоёр удаа хуваан 10 дугаар сарын 22-нд авжээ. Бүс нутгийн Мөрдөн шалгах хорооны ажилтнууд болон Дотоод хэргийн яамны

⁵⁰⁹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2020/10/16/czech-police-detain-20-in-soccer-corruption-probe>

⁵¹⁰ “Match-fixing” буюу “тоглолтын тохиролцоо” гэдэг нь тэмцээний дүрэм болон хуулийг зөрчиж, үр дүн нь бүрэн буюу хэсэгчлэн урьдчилан тогтоогдсон тоглолтын үед бий болдог ажээ.

⁵¹¹ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж:

https://www.nn.ru/news/more/posle_zaderzhaniya_za_vzyatku_u_chinovnika_nizhegorodskogo_minfina_nashli_marikhu_anu/69517635/

удирдлагын хамтарсан үйл ажиллагаагаар Үйлдвэрлэлийн салбар, зорилтот хөтөлбөрийн хяналт хариуцсан албаны ахлах мэргэжилтэн болон зөвлөхийг тус тус саатуулсан байна.

Тэднийг ОХУ-ын Эрүүгийн хуулийн 290 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн а, в-д заасны дагуу (Эрх бүхий албан тушаалтан бүлэглэн онц их хэмжээний хахууль авсан) буруутгасан байна.

Зөвлөх албан тушаалтан нь хэргээ хүлээж, гэрийн хорионд орсон бол ахлах мэргэжилтэн хэргээ хүлээгээгүй байна. Мөрдөгчөөс гаргасан хүсэлтийг үндэслэн Москва хотын дүүргийн шүүх ахлах мэргэжилтнийг 12 дугаар сарын 22-ны өдрийг хүртэл хоёр сар түр саатуулахаар болжээ.

Түүнчлэн нэгжлэг хийх үед ахлах мэргэжилтний гэрээс их хэмжээний хар тамхи олдсон талаар Бүс нутгийн Мөрдөн шалгах хорооноос мэдээлсэн бөгөөд түүнд ОХУ-ын Эрүүгийн хуулийн 228 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Хар тамхи хууль бусаар олж авсан, хадгалсан)-т заасныг үндэслэн эрүүгийн хэрэг үүсгэсэн байна.

Сибирийн хотын захирагчийг авлигын хэрэгт холбогдуулан баривчилж, албан тушаалаас нь чөлөөлөв⁵¹²



Томск хотын дарга Иван Кляин. (Фото: ТАСС)

2020.11.18. ОХУ-ын Томск хотын захирагч Иван Клианыг эрх мэдлээ урвуулан ашигласан хэрэгт холбогдуулж өнгөрсөн долоо хоногт баривчилсан ба түүнийг албан тушаалаас чөлөөлөхөөр шүүх шийдвэрлэсэн байна.

Томск хотын Киров дүүргийн шүүхээс 11 дүгээр сарын 18-ны өдөр Клианыг өөрийн гэр бүлийн аж ахуйн нэгжийн ойролцоо барилга барих зөвшөөрөл олгохоос хууль бусаар татгалзсан үйлдэлд холбогдуулан мөрдөн шалгах хугацаанд цагдан хорихоор шийдвэрлэжээ. Тэрээр 11 дүгээр сарын 13-ны өдөр цагдан хоригдсон бөгөөд 2 сар гаруй хугацааг өнгөрүүлж магадгүй байгаа юм. Түүний өмгөөлөгч цагдан хорих шийдвэрийг давж заалдсан талаар мэдэгджээ.

Түүний эхнэр Галина Клайндыг цагдаагийн үйл ажиллагаанд саад учруулсан үндэслэлээр мөн мэдүүлэг авахаар дуудсан байна. Хэрэв Галина Клайн мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулсан нь тогтоогдвол 10 хүртэл жилээр хоригдож магадгүй талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бичжээ.

⁵¹² Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.rferl.org/a/mayor-of-siberian-city-arrested--corruption-charge-suspended-post/30956880.html>

Мөрдөн шалгах хорооноос мэдээлснээр Иван Клайн 2016-2017 оны хооронд өөрийн эзэмшдэг Томск шар айрагны компанийн ойролцоо барилга барих зөвшөөрлийг олгохоос хууль бусаар татгалзсан үйлдэлд холбогдон шалгагдаж байна.

61 настай Клайн 2013 оноос тус хотын захирагчаар ажиллаж байгаа юм. Үүнээс өмнө тэрээр бүс нутгийн томоохон үйлдвэрийн нэг болох Томск шар айрагны компанийн ерөнхий захирлаар 1994 оноос хойш ажиллаж байжээ.

Түүнийг хотын захирагчаар томилогдсоны дараагаар эхнэр Галина Клайн нь Томск шар айрагны компанийн Байгууламж хариуцсан ерөнхий захирлаар сонгогдсон байна.

2013 онд Коммерсант сонинд Клайн тус компанийн 51 хувийг, түүний эхнэр 20 хувийг тус тус эзэмшдэг талаар мэдээлжээ. Иван Клайн нь 2006 оноос хойш авлигын гэмт хэрэгт холбогдон шалгагдаж буй Сибирийн хотын 3 дахь захирагч юм.

Австри улсын Сангийн сайд асанд авлигын хэрэгт холбогдуулан 8 жилийн хорих ял оногдуулжээ⁵¹³



(Фото: ТАСС / ЕРА / Роланд Шлэйгер)

2020.12.05. Венийн Эрүүгийн хэргийн шүүхээс Австри улсын Сангийн сайд асан Карл-Хайнц Грассерыг төрийн орон сууцны BUWOG компанийн орон сууцны санг хувьчлах явцад хахууль авсан хэргээр найман жил хорих ял оногдуулсан тухай тус улсын хэвлэл мэдээллийн агентлаг мэдээлсэн байна.

Сайд асан албан тушаалаа хаших хугацаандаа албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж бэлэг, шан харамж авсан, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн хэрэгт буруутгасан талаар мэдээнд дурджээ. Түүнийг орон сууцны сангийн гэрээнд оролцсон нэр бүхий гурван компаниас нийт 9.6 сая евротой тэнцэх хэмжээний хахууль авсаныг шүүхээс тогтоосон байна.

Түүнчлэн уг хэрэгт үгсэн хуйвалдах байдлаар оролцсон хэд хэдэн бизнесмэн буруугаа хүлээжээ. Сангийн сайд асан шүүхийн шийдвэрийг давж заалдахаар холбогдох шатны шүүхэд гомдол гаргасан байна.

⁵¹³ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://iz.ru/1096172/2020-12-05/eks-ministra-finansov-avstrii-prigovorili-k-8-godam-tiurmy-za-korruptciiu>

Мөрийтэй тоглоом эрхлэгчид болон төрийн албан хаагчид холбогдсон дээрх авлига, хахуулийн хэргийн хүрээнд Австрийн Эрх чөлөөний намын удирдагч, Бүгд найрамдах улсын дэд канцлер асан Хайнц-Кристиан Штрахын гэрт 08 дугаар сард нэгжлэг хийсэн байна.

ОХУ-ын төрийн албан хаагч асан авлигын хэрэгт холбогдож 15 жилийн хорих ял сонслоо⁵¹⁴



Александр Шестун түр саатуулах байранд. (Фото: Михаил Почуев / ТАСС)

2020.12.25. Москва хотын төрийн албан хаагч асанд шүүхээс 12 дугаар сарын 25-ны өдөр чанга дэглэмтэй хорих ангид 15 жилийн хорих ял оноолоо.

Москва хотын Серпухов дүүргийн дарга асан Александр Шестун нь хахууль авсан, залилан хийсэн, мөнгө угаасан, бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хууль бусаар оролцсон гэмт хэрэгт гэм буруутай нь тогтоогдсон талаар төрийн мэдээллийн РИА Новости агентлагт мэдээлжээ.

Подолск хотын шүүхээс түүнд 15 жилийн хорих ялаас гадна хорих ял эдэлж дууссанаас хойш 8 жилийн хугацаанд төрийн албанд дахин томилогдохгүй байх, 49 сая рубль (661,000 ам.доллар)-ийн торгууль төлөх шийтгэл ногдуулжээ.

Прокурорын газраас түүнд чанга дэглэмтэй хорих ангид 20 жил хорих ял оноохоос гадна 50 сая рубль (675,000 ам.доллар)-ийн торгууль төлүүлэх яллах дүгнэлт үйлдсэн байсан.

Александр Шестун өөрийгөө улс төрийн хэргийн золиос болсон гэж үзэж байгаа бөгөөд хуулийн байгууллагад баривчлагдахын өмнө Ерөнхийлөгч Владимир Путинд хандан өөрт тулгарч буй заналхийлэл, дарамт шахалтыг тайлбарласан бичлэг хийсэн байна. Энэхүү бичлэгт холбогдуулан Ерөнхийлөгч Путины хэвлэлийн төлөөлөгч Дмитрий Песков “Тус сэдэвт холбогдуулан хэлэх зүйлгүй” хэмээн мэдэгдсэн байна.

2019 оны 06 дугаар сард болсон шүүх хуралдааны үеэр Александр Шестун тус гэмт хэргийг Холбооны аюулгүй байдлын албаны Санхүүгийн сөрөг тагнуулын хэсгийн дарга Иван Ткачевын өшөө авалт гэж хэлжээ. Үүний дараагаар тэрээр бугуйгаа нэг удаагийн сахлын хутгаар зүсэж амиа хорлохыг завдсан байна. 2018 оны 06 дугаар сараас хойш цагдан хоригдож буй Шестун хэд хэдэн удаа өлсгөлөн зарлаж байжээ.

⁵¹⁴ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.themoscowtimes.com/2020/12/25/russia-jails-ex-official-15-years-in-high-profile-corruption-case-a72486>

Александр Шестун өөрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан хувийн хэвшлийн 47 компани байгуулж, өрсөлдөөний үйл ажиллагааг зөрчиж, тэдгээр компанид нийтийн эзэмшлийн газар олгосон бөгөөд төсвийн сангийн зээл бага хүүтэйгээр зээлдүүлсэн үйлдлийн талаар мөрдөгчид олон нийгэд мэдээлжээ. Үүний дараагаар мөрдөгчид түүнийг 9.4 сая рубль (146,000 ам.доллар)-ийн хахууль авсан хэрэгт буруутгасан юм.

Айварс Лембергс: Латви улсын хамгийн баян хүмүүсийн нэг хахууль, мөнгө угаах хэргээр шоронд хоригдож байна⁵¹⁵



Айварс Лембергс Ерөнхий сайдад нэр дэвшиж байв.
(Фото: Илмарс Знотинс / AFP 2006)

2021.02.23. Латви улсын улс төрийн хамгийн нөлөө бүхий хүмүүсийн нэг авлигын хэрэгт холбогдон таван жилийн хорих ялаар шийтгүүлжээ.

Айварс Лембергс нь 1988 оноос хойш Вентспилс хотын захирагчаар ажиллаж байсан бөгөөд даваа гарагт Рига хотын шүүхээс түүнийг хахууль авсан, мөнгө угаасан хэрэгт буруутгажээ.

Шүүхийн шийдвэр гарсны дараа чинээлэг бизнесменийг шууд баривчилж, нэмэлт 20,000 еврогийн торгууль ногдуулжээ.

Шүүхээс түүнийг хэд хэдэн хувь хүн болон урьдын бизнесийн өрсөлдөгч нарт учруулсан хохирлыг төлөх ёстой гэж үзэн Лембергсийн хэдэн сая еврогоор үнэлэгдэх хөрөнгийг хураан авсан байна.

Шүүхээс хураан авсан эд хөрөнгөд оффшор бүсийн компаниуд, хувьцаа, банкны данс, үл хөдлөх хөрөнгө, автомашин, үнэт эдлэл, түүний тээврийн хэрэгслийн жижиг чиргүүл багтсан гэж мэдээлжээ. Энэ шийдвэр нь Латвийн орчин үеийн түүхэн дэх хамгийн удаан хугацаанд үргэлжилсэн эрүүгийн хэрэгт цэг тавьсан юм.

Лембергс шүүхийн шийдвэрийг няцааж, уг шүүх хурлыг улс төрийн шинжтэй гэж үзэн давж заалдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.

Латвийн хууль сахиулагчид 67 настай олигархийг анх 2007 оноос шалгаж эхэлсэн бөгөөд түүнийг 40 гаруй авлигын хэрэгт буруутгаж байжээ.

Лембергс нь Латвийн хамгийн баян хүмүүсийн нэгд тооцогддог бөгөөд Ногоонтнууд ба фермерүүдийн холбооноос Ерөнхий сайдад удаа дараа нэр дэвшиж байжээ.

2019 онд АНУ-ын Сангийн яамнаас Лембергсийг олон нийтийн гэрээ болон түүний хувийн өмчтэй холбоотой хахуулийн хэрэгт “шууд болон дам байдлаар” холбоотой гэж үзэн Вентспилс боомтын захиргаанд хориг арга хэмжээ авсан юм. Даваа гарагт болсон шүүх хурлаар түүнийг 40 хэргээс 19-т нь буруутай гэж шийдвэрлэсэн.

Лембергсийн хүү Анрийж болон түүний бизнесийн хамтрагч Ансис Сормулис нарыг луйврын ажиллагаанд оролцож, хууль бусаар олж авсан мөнгийг угаасан хэргээр хоёр жилийн хорих ял оноож, хөрөнгийг нь хураан авсан байна.

⁵¹⁵ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://www.euronews.com/2021/02/23/aivars-lemberts-one-of-latvia-s-richest-men-is-jailed-for-bribery-and-money-laundering>

Военторга компанийн Ерөнхий захирлын
орлогч асан Тейф буруугаа хүлээсэн бөгөөд
5 жилийн хорих ял оногдуулжээ⁵¹⁶

2021.03.20. Военторга компанийн Ерөнхий захирлын орлогч асан Тейф хуурамч баримт бичиг бүрдүүлэн татварын тайлан гаргасан, виз авахдаа хууран мэхэлсэн болон хахууль өгсөн гэм буруугаа хүлээсэн байна. Түүнийг аллага хийхийг завдсан, хууран мэхлэх үйл ажиллагаа явуулсан үйлдэлд буруутган ажлаас нь чөлөөлсөн бөгөөд 2018 оноос цагдан хоригдож байгаа юм.

ОХУ-ын Батлан хамгаалах яамны харьяа Военторга компанийн ерөнхий захирлын орлогч асан Леонид Тейф нь АНУ-д үүсгэсэн эрүүгийн хэрэгт буруутайгаа хүлээсэн бөгөөд 5 жилийн хорих ялаар шийтгүүлсэн талаар телевизийн CBS суваг мэдээлжээ.

2018 оноос АНУ-ын Хойд Каролинад амьдарч буй Тейф болон түүний эхнэр асан Татьяна нарыг Америкийн эрх баригчдын зүгээс аллага захиалсан, визний баримт бичиг хуурамчаар бүрдүүлсэн, авлига, залилан зэрэг гэмт хэрэгт буруутгасан байна.

Баасан гарагт Хойд Каролина мужийн Зүүн тойргийн холбооны шүүхэд 59 настай Тейфийн шүүх хурал болсон бөгөөд тэрээр төрийн албан хаагчдад хахууль өгсөн, визний залилан хийсэн болон хуурамч бичиг баримтаар татварын тайлан гаргаснаа хүлээжээ.

Военторга компанийн хахууль ба халдлага: АНУ Леонид Тейфийг юунд буруутгаж байгаа вэ?

Мөрдөгчийн олж тогтоосноор, Тейф гэрийнхээ үйлчлэгчийн хүүг Америкийн нутаг дэвсгэрээс албадан гаргах шийдвэрийг гаргуулахын тулд Дотоодын аюулгүй байдлын яамны ажилтанд 10 мянган ам.долларын хахууль өгчээ. Тэрээр түүнийг эхнэртэй нь нууц харилцаатай болсон гэж харджээ.

Тейфийн 43 настай салсан эхнэр АНУ-д цагаачлах виз мэдүүлэхдээ баримт бичиг хуурамчаар бүрдүүлсэнээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд түүний 6 сая ам.долларын өртөг бүхий хөрөнгийг битүүмжилсэн байна. Мөнгө угаасан, хууль бус цагаачдыг орогнуулсан, аллага захиалсан хэрэгт Оросын иргэнийг буруутгасан юм.

Леонид, Татьяна Тейф нарын хэд хэдэн хамтрагчийг мөрдөх ажиллагаа 2018 оноос эхэлсэн юм. 2010-2012 онд Военторга компанийн Ерөнхий захирлын орлогчийн албыг хашиж байхдаа Тейф нь ОХУ дахь авлигын сүлжээнд оролцож, 150 орчим сая ам.долларын хахууль өгч, авж, гадаадын дансанд байршуулсан гэж АНУ-ын эрх баригчид үзжээ.

Америкийн прокурорууд Оросын Военторга компанийн Ерөнхий захирлын орлогч асны хахуулийн тухай олж мэджээ.

Оффшор данснаас түүний эхнэрийн Америкийн банкан дахь дансруу мөнгө ордог байжээ. Хэргийн материалд багадаа 70 данснаас 300 орчим удаагийн гүйлгээгээр нийт 40 сая ам.доллар шилжүүлсэн талаар дурдсан байна. Мөн АНУ-ын нутаг дэвсгэрт компани байгуулах замаар мөнгө угаажээ.

Түүнчлэн Тейфийг эхнэрийнхээ нууц амрагийг алахаар оролдсон хэрэгт буруутгасан байна. Тэрээр нууц амрагийг нь АНУ-аас албадан гаргах зорилгоор хахууль өгөхийг оролдсон. Оросын иргэний 10 мянган ам.доллар санал болгосон төрийн албан хаагч нь ХМТ-ны нууц ажилтан байжээ. Албадан гаргах төлөвлөгөө нь нурсны дараа Тейф эхнэрийнхээ нууц амрагийг алахаар завдан, тусгай албанд ажилладаг хүнд 25 мянган ам.доллар санал болгосон байна. Түүнийг 2018 оноос цагдан хорьж байгаа билээ.

⁵¹⁶ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.rbc.ru/society/20/03/2021/605529de9a794723be7f5266>

Польшид хахууль өгөхийг завдсан Украины иргэнийг сатуулжээ⁵¹⁷

2021.03.17. Польш улсын Авлигатай тэмцэх товчооны ажилтнууд орон нутгийн Хил хамгаалах албатай хамтран 03 дугаар сарын 16-ны өдөр Польшийн гаалийн ажилтанд хахууль өгөхийг завдсан Украины иргэнийг саатуулсан талаар Polskie Radio мэдээлжээ.

Украин улсын иргэнийг Польш-Украины хилийн Корчево шалган нэвтрүүлэх цэг дээр саатуулсан бөгөөд түүнийг орон нутгийн прокурорын байгууллагад аваачсан байна.

Одоогоор түүнийг мөрдөн шалгах ажиллагаа явагдаж байгаа бөгөөд шүүхээс гэм буруутай нь тогтоогдвол 10 хүртэлх жилийн хорих шийтгэл оногдуулах юм байна.

Авлигатай тэмцэх ажилд ЕХ гар дүрэхгүй байхыг Монтенегро улс уриалав⁵¹⁸

2021.03.26. Монтенегрогийн шинэ засгийн газар тус улс дахь ЕХ-ны дэмжлэгтэй тусгай прокурорыг одоогийн Ерөнхийлөгч Мило Джуканович (Milo Đukanović)-тай холбоотой авлигын хэргийг шалгах ажиллагааг зогсоосон хэмээн буруутгажээ.

Тус улсын эвслийн засгийн газрын Ерөнхий сайдын орлогч Дритан Абазович 2020 оны 08 дугаар сард болсон парламентын сонгуульд ялагдал хүлээсэн Социалистуудын Ардчилсан нам (САН)-ын удирдагч, одоогийн Ерөнхийлөгч Джукановичыг авлига, албан тушаалын дөрвөн хэрэгт холбогдуулан шалгах ажиллагааг түр зогсоож байгааг буруутгаж буйгаа Euronews-т өгсөн ярилцлагадаа онцлон тэмдэглэсэн байна. Тэрээр цааш нь хэлэхдээ, тусгай үүрэг бүхий прокурор Миловое Катничийг огцруулах талаар шинэ засгийн газар туйлын хүчин чармайлт гарган ажиллаж буйгаа онцолжээ.

САН нь Монтенегро улсын засгийн эрхийг сүүлийн 30 жил барьсан бөгөөд өнгөрсөн жил ЕХ-ны талыг баримтлагч либералчууд болон сербчүүдийг дэмжигч үндсэрхэг үзэлтнүүдийн эвсэл сонгуульд ялалт байгуулснаар тус нам засгийн эрх барих эрхээ алдсан байна. Одоогийн Ерөнхийлөгч Джуканович 2023 оны сонгууль хүртэл тус улсын Ерөнхийлөгчийн албыг хашна.

Өнгөрсөн сард Монтенегро улсын парламентад тус улс дахь тусгай прокурорын газрыг татан буулгах тухай шинэ хуулийг өргөн барьсан явдал Брюссельд шүүмжлэл дагуулах болов. Учир нь уг албыг Балкан муж дахь авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх зорилгоор байгуулсан аж.

Европын Зөвлөлийн хэвлэлийн төлөөлөгч “Тусгай прокурорын байгууллагын бие даасан үйл ажиллагаа, бүрэн бүтэн байдал нь Монтенегро улсын хууль дээдлэх салбарт ахиц дэвшил гаргахад чухал үүрэг гүйцэтгэнэ” хэмээн мэдэгдэв. Гэтэл Ерөнхий сайдын орлогч Абазович Брюссел дэх Euronews-т өгсөн ярилцлагадаа “одоогийн прокурортой авлигатай тэмцэх боломжгүй хэмээгээд Монтенегро дахь 30 жилийн турш төрийн эрх барьсан САН-ын тогтоосон дэглэмийг хүчингүй болгохын төлөө одоогийн засаг захиргаа хүчин чармайлт гаргаж байгаа тул Европын хууль тогтоогчдоос шинэ засгийн газрын гарыг хүлэхгүй байхыг хүсье” хэмээн уриалж буйгаа мэдэгдсэн байна. Тэрбээр цааш нь хэлэхдээ “[Бид Миловое Катнич]-д дургүйдээ эсвэл мэргэшсэн прокурорын үзэл баримтлалд дургүйцсэндээ бус, гагцхүү үр дүнд хүрэхийг хүсэж байгаа учраас тухайн байгууллагад шинэ удирдлага хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, бидэнд шинээр эхлэх зоригтой хүмүүс хэрэгтэй байна, энэ бол улс төрийн зорилгоор хэн нэгнээс хариугаа авж буй өс хонзон (реванизм) биш, харин үүрэг хариуцлага юм” хэмээн хэлсэн байна.

Абазович хэлэхдээ “Джукановичийн эсрэг авлигын дөрвөн хэрэг ноён Катничийн ширээн дээр байгаа боловч өнөөдрийг хүртэл эрхэм прокурор тэдгээр хэргүүдийг нэгийг ч нээж үзээгүй” гэсэн байна. Түүнчлэн тусгай үүрэг бүхий прокурор Катнич Euronews-т өгсөн ярилцлагадаа Джукановичийг мөрдөн байцаах ажиллагаанд хөндлөнгөөс хориг тавьж байгаа гэсэн мэдээлэл өгсөн нь худал зүйл гэжээ. Мэргэшсэн прокурорын байгууллагаас Ерөнхийлөгч болон түүний гэр бүлийн гишүүдийн эсрэг 18 авлигын хэрэг үүсгэсэн боловч тэдгээрээс 12-ыг нь нотлох

⁵¹⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://regnum.ru/news/3217623.html>

⁵¹⁸ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.euronews.com/2021/03/24/montenegro-urges-eu-not-to-tie-its-hands-in-anti-corruption-fight>

баримтгүй хэмээн цуцалсан. Мөн цагдаагийнхан дөрвөн хэргийг үргэлжлүүлэн шалгаж байгаа бөгөөд өөр хоёр хэргийг бусад прокурорт шилжүүлээд байна. Үнэндээ, хуулиар бол эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь тухайн этгээд нь хэн болох, нийгэм дэх [тэдний] статус ямар байхаас үл хамааран явагддаг учиртай. Энэ байгууллага Мило Джуканович болон түүний хамаарал бүхий бусад олон иргэдэд эрүүгийн хэд хэдэн хэрэг үүсгэсэн байна. Нөгөөтээгүүр, аливаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хэрхэн явагдах нь тухайн этгээдийг гэм буруутай гэдгийг нотлох баримтаас хамаардаг талаар прокурор Катнич хэлжээ.

Тэрээр мөн *“Ноён Джуканович бид хоёрт ямар ч найрсаг, ажил хэрэгч, өөр ямар ч холбоо байхгүй. Би аль ч улс төрийн намын гишүүн биш, би САН-ын гишүүн биш, эсвэл ноён Жукановичийн сонгогч ч биш”* гэж Euronews агентлагт ярьжээ.

Авлигын хэрэгт холбогдсон Украины шүүгчийг хулгайлж, эх оронд нь буцаасан талаар Молдав улс мэдээлэв⁵¹⁹

2021.04.05. 2016 онд авлигын хэрэгт холбогдон, эх орноо орхин дүрвэсэн Украин улсын шүүгчийг эх оронд нь хулгайлан авчирсан талаар Молдав улсын Дотоод хэргийн сайд энэ оны 04 дүгээр сарын 05-ны өдөр мэдээлэв.

Шүүгч Микола Чаус (Mykola Chaus)-ыг 5 жилийн өмнө Украины хууль сахиулах байгууллагаас 150 мянган ам.долларын хахууль авж, өөрийн цэцэрлэгт нуун дарагдуулсан хэрэгт холбогдуулан буруутгаж байсан юм. Түүнийг зохиомол авлигын хэрэгт буруутгаж байна хэмээн түүний гэргий Свитлана (Svitlana) мэдээлжээ.

Түүний өмгөөлөгч Иулиан Балан (Iulian Balan) Ройтерс агентлагт өгсөн ярилцлагадаа *“Микола Чаус нь Молдавын нутаг дэвсгэрт ямар нэгэн гэмт хэрэгт холбогдоогүй бөгөөд түүний оршин суугаа газрын мэдээлэл зөвхөн тус улсын холбогдох байгууллагад байсан”* хэмээн мэдээлжээ.

Хуулийн халдашгүй байдлыг нь парламентаас хүчингүй болгосны дараагаар Микола Чаус Молдав улсад улс төрийн орогнол, тус улсын иргэншил хүсэж эх орноосоо дүрвэсэн юм. Молдавын төрийн байгууллага түүнд улс төрийн орогнол олгохоос энэ оны 03 дугаар сард татгалзжээ.

“... Украины шүүгч Чаус нь Молдавын хилийг давж, Украины нутаг дэвсгэрт нэвтэрсэн” хэмээн Дотоод хэргийн сайд Павел Войку (Pavel Voicu) мэдээлсэн байна.

Цагдаагийн байгууллагаас Микола Чаус болон түүний бие хамгаалагч нарын ашиглаж байсан автомашиныг олсон бөгөөд түүнийг хулгайлсан хүмүүс Украин хэлээр ярьж байсан талаар мөн Дотоод хэргийн сайд дурджээ.

Микола Чаусыг шалгаж байсан Украины авлигатай тэмцэх байгууллага тайлбар өгөхөөс татгалзсан байна. Украины олон нийтийн дунд явуулсан санал асуулгад шүүх байгууллагад итгэх иргэдийн итгэл хамгийн бага байсан бөгөөд тус улсын удирдагчид шүүх байгууллагын авлигыг үндсээр нь устгах талаар мэдэгджээ. Түүнчлэн авлига нь гадаадын хөрөнгө оруулалтыг хязгаарлаж буй томоохон хүчин зүйл болсон байна.

2016 онд Украин улсын тухайн үеийн Ерөнхийлөгч Петр Порошенкогийн засгийн газраас тус улсын улс төрчид, төрийн албан хаагчид болон шүүгчид өөрсдийн хөрөнгө, орлогын мэдүүлгийг цахим санд нээлттэй байдлаар байршуулахыг хуульчилсан байна.

Энэхүү цахим санд дурдсанаар жилийн орлого нь 10-13 мянган ам.долларын орлоготой шүүгчид өөрийн эзэмшилд өндөр үнэтэй автомашин, бугуйн цаг, их хэмжээний бэлэн мөнгөтэй талаар мэдүүлэгтээ тусгаж байсан юм.

⁵¹⁹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.reuters.com/article/us-ukraine-moldova-judge/judge-accused-of-corruption-was-kidnapped-and-taken-back-to-ukraine-moldova-says-idUSKBN2BS0XR>

ОХУ-д авлигатай тэмцэх үүрэг бүхий албан тушаалтан хахууль авсан байна⁵²⁰

2021.05.08. Якут улсын Мөрдөн шалгах албанаас Дотоод явдлын яамны орон нутгийн удирдах ажилтныг их хэмжээний хахууль авсан хэрэгт буруутгажээ. Тэрээр орон нутгийн авлигын эсрэг, эдийн засгийн аюулгүй байдлын хэлтэст ажилладаг.

ОХУ-ын Бүгд Найрамдах Саха /Якут/ Улс хариуцсан Аюулгүй байдлын албанаас хяналт шалгалт явуулан, эрүүгийн хэрэг үүсгэжээ.

Якутск хотын худалдааны төвийн павильонд хяналт шалгалт хийх явцдаа уг ажилтан хууль бус хэлцэл хийхийг оролдсон нь мөрдөн шалгах ажиллагааныявцад тогтоогджээ. Тэрээр бизнес эрхлэгчээс барааны дээжийг хураан авж, 300,000 рублиэр шалгалтын үйл ажиллагааг зогсоож болох тухай санал тавьсан байна.

Бизнес эрхлэгч Дотоод явдлын яамны ажилтанд шаардсан мөнгийг шилжүүлсэн бөгөөд цагдаа нар ажилтныг саатуулжээ. Тэрээр гэм буруугаа хүлээн зөвшөөрч, мөрдөн шалгах ажиллагаанд хамтарч ажилласан байна. Цагдаагийн байгууллагаас түүнийг гэрийн хорионд байлгаж байна.

Хорватын авлигатай тэмцэх цагдаа нар төрийн телевизийн захирлыг баривчилжээ⁵²¹

2021.06.30. Хорват улсын авлигатай тэмцэх цагдаа (USKOK⁵²²) лхагва гарагт төрийн телевизийн HRT компанийн захирал зэрэг хэд хэдэн хүнийг баривчилсан тухай орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлэв.

Тэдний мэдээлснээр Загреб хотын хуучин Зөвлөлийн зургаан хүнийг авлигын хэрэгт сэжиглэж баривчилсан байна. Баривчлагдсан хүмүүсийн дунд HRT компанийн захирал Казимир Бакич (Kazimir Basic) байжээ.

Цагдаа нар Загреб хотын зөвлөлд мөрдөн шалгах ажиллагаа эхлүүлсэн болохыг өнгөрсөн сард сонгогдсон Загреб хотын дарга Томислав Томашевич (Tomislav Tomasevic) баталсан юм.

Албани улсын Ерөнхий прокурор асан авлигын хэрэгт холбогдож хорих ял сонсжээ⁵²³

2021.09.23. Албани улсын Давж заалдах шатны шүүх 09 дүгээр сарын 22-ны өдөр тус улсын Ерөнхий прокурор асныг хууль бусаар эзэмшиж байсан мөнгөө нуун дарагдуулсан хэрэгт гэм буруутайд тооцож хоёр жилийн хорих ял сонсгож, хууль бусаар олсон хөрөнгийг нь хураан авах шийдвэр гаргажээ.

2012-2017 оны хооронд Албанийн Ерөнхий прокуророор ажиллаж байсан Адриатик Ллалла (Adriatik Llalla)-ийн хэргийг шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн тогтоолыг давж заалдах шатны шүүхээс хэвээр үлдээжээ. Өндөр түвшний албан тушаалтнуудын авлигын хэргийг хянан шийдвэрлэх шүүхээс түүнийг жил бүр гаргадаг хөрөнгө, орлогын мэдүүлгээ худал мэдүүлсэн, хөрөнгөө нуусан үндэслэлээр энэ оны 05 дугаар сард ял сонсгоод байсан юм.

Давж заалдах шатны шүүхийн шүүгч Нертина Косова “*Адриатик Ллалла эрүүгийн хэрэг үйлдсэн тул түүнд хариуцлага тооцох ёстой*” гэж хэлсэн байна.

⁵²⁰ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://secretmag.ru/criminal/v-rossii-borec-s-korrupciei-popalsya-na-vzvatke-on-potreboval-u-biznesmena-300-tysyach-rublei.htm>

⁵²¹ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.reuters.com/world/europe/croatian-anti-corruption-police-arrest-state-tv-head-media-2021-06-30/>

⁵²² Ured za suzbijanje korupcije i organiziranog kriminaliteta буюу Хорватын Улсын Прокурорын Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигатай тэмцэх газар буюу Авлига, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газар

⁵²³ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.ekathimerini.com/news/1168377/albania-s-ex-top-prosecutor-jailed-for-corruption/>

Мөн түүнд таван жилийн турш нийтийн албан тушаал хашихыг хориглосон бөгөөд Ллалла шүүхийн шийдвэрийг сонсох ажиллагаанд өөрийн биеэр оролцоогүй юм. Ялыг шууд эдэлж эхлэх ёстой байсан ч Ллаллагийн одоо байгаа байршлыг түүний өмгөөлөгч мэдэгдээгүй байна.

Өөрөөр хэлбэл, өмгөөлөгч Соко Хазижаж хэлэхдээ Ллалла эмнэлэгт байгаа гэсэн боловч Албани, эсхүл, гадаад улсын нутаг дэвсгэрийн хаана байгааг тодорхой хэлээгүй юм.

Ллалла 5.4 акр газар худалдан борлуулсан, орон сууц худалдаж авсныхаа эх үүсвэрийг мэдүүлээгүй, мөн АНУ, Герман дахь гэр бүлийнхээ зардлын эх үүсвэрийг тайлбарлаж чадаагүй хэрэгт гэм буруутайд тооцогдсон юм.

Ллалла бол авлигатай тэмцэх зорилгоор шинээр бүрэлдсэн шүүхийн тогтолцоогоор шийтгүүлсэн анхны өндөр албан тушаалтан бөгөөд авлига, үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн гэх үндэслэлээр олон шүүгч, прокурорыг ажлаас нь чөлөөлөөд байгаа юм.

АНУ, ЕХ-ны оролцоотойгоор 2016 онд батлагдсан шүүхийн шинэтгэлээр шүүгч, прокурорын өмч хөрөнгө хууль ёсны эсэх, авлигын эсрэг болон мэргэжлийн стандартад нийцсэн эсэхийг тогтоохын тулд шалгалт явуулж эхэлсэн билээ.

2018 онд авлигын хэрэгт холбогдсон гэх асуудлаар сэжиглэгдэж байснаас үүдэлтэйгээр Ллаллаг АНУ-д нэвтрэхийг хориглосон юм. Мөн энэ оны 05 дугаар сард АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Антони Блинкен Албани улсын Ерөнхий сайд асан Сали Беришаг “их хэмжээний авлигын” хэрэгт буруутган, түүний эхнэр, хүүхдүүдийг нь тус улсад нэвтрэхийг хориглосон байна.

Австри улсын канцлер хахуулийн асуудалд сэжиглэгдэн шалгагдаж байна⁵²⁴



Прокурорууд Канцлер Себастьян Курц болон өөр есөн хүн, мөн гурван байгууллагыг уг хэргийн талаар шалгаж байгаа гэж мэдэгдэв. (Фото: Леонхард Фоегер / Reuters)

2021.10.06. Шар сонинд эерэг мэдээлэл гаргуулж байх зорилгоор төсвийн хөрөнгө ашигласан асуудалд Австрийн канцлерийг шалгаж буй талаар прокурорын байгууллага мэдэгдсэн байна. Энэ нь Курц болон түүний Ардын намын хувьд толгойны өвчин болоод байна. Тус асуудалд хоёр ч яам холбогджээ.

Сангийн яам шалгалтад хамрагдсаныг Сангийн сайд Гернот Блюмель хүлээн зөвшөөрсөн ба харин хэвлэл, мэдээллийн хэрэгслээр канцлерын ажлын алба ч

шалгалтад өртсөнийг онцлов. Тус хэрэгт Курц болон өөр 9 этгээд, гурван байгууллагыг шалгаж байна.

Сангийн яамны төсвийн хөрөнгөөр 2016-2018 онд улс төрийн намын ашиг сонирхлын үүднээс олон нийтийн санаа бодлыг тодорхойлох судалгааг санхүүжүүлсэн хэмээн прокурорууд мэдэгдсэн байна. Ингэхдээ судалгааны үр дүнд нөлөөлж байжээ.

Тухайн үед Курц Ардын намын дарга болж, барууны чиглэлийн Эрх чөлөөний намтай нэгдэн эвслийн засгийн газар байгуулсан юм. Энэхүү олон нийтийн санал асуулгын судалгааны үр дүнг “нийтэлсний хөлс” авдаг байсан мэдээллийн компанийн нэрийг прокурорууд дурдаагүй юм.

⁵²⁴ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.aljazeera.com/news/2021/10/6/austria-kurz-under-investigation-bribery-corruption>

Хэдийгээр прокурорууд албан ёсоор нэрийг нь дурдаагүй ч энэ бол Австрийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн Oesterreich гэх өдөр тутмын хэвлэл байсан юм.

Санал асуулга явуулах, судалгааны үр дүнг зарлахад ямар нэгэн зөрчил гаргаагүй хэмээн Oesterreich компанийн удирдлага мэдэгдсэн байна. Тус компани олон нийтийн санаа бодлыг тодорхойлох судалгаа явуулан, үр дүнг мэдээлэхдээ Курцын намыг нэлээн эерэгээр харуулдаг байсан хэмээн Ал Жазирагийн сурвалжлагч Доминик Кейн онцолсон. Oesterreich сонины тодорхой хүмүүст зарим нэг компанийн удирдах зөвлөлийн гишүүний албан тушаал өгсөн хэмээн Кейн ярьсан. Тэрээр холбооны төсвийн хөрөнгө, өөрөөр хэлбэл, татвар төлөгчдийн мөнгийг зарцуулсан хэмээн прокурорууд үзэж байна. Авлигын асуудалд буруутгагдсан Курц анх удаа шалгагдаж байгаа нь энэ юм хэмээн сурвалжлагч Кейн нэмэж явив.

Боловсролын дэд сайд асан Раковаг залилангийн хэрэгт буруутгажээ⁵²⁵

2021.10.07. ОХУ. 50 сая рубль шамшигдуулсан асуудалд Боловсролын дэд сайд асан Марина Раковаг буруутгасан талаар РИА Новости мэдээлсэн байна. Түүнийг 2019 онд төсвийн хөрөнгийг өөрийнхөө Боловсролын шинэ хөгжил санд шилжүүлэхээр лобби хийсэн, судалгаа шинжилгээний тайланг хуурамчаар үйлдсэн зэрэг асуудалд буруутгажээ.

Тус хэрэгт 10 хүртэл жилийн хорих ял ногдуулдаг байна. Өмнө нь түүний нөхрийг залилангийн асуудалд буруутгаж байсан.

Швейцарийн прокурор Испани улсын цөлөгдсөн хаан Хуан Карлосын авлига, хахуулийн хэргийг хэрэгсэхгүй болгожээ⁵²⁶

2021.12.06. Швейцарийн прокурор авлига, хахуулийн хэрэгт буруутгагдаж байсан Испанийн хаан асан Хуан Карлосын мөрдөн шалгах ажиллагааг зогсоолоо. 2018 онд эхэлсэн мөрдөн шалгах ажиллагааг Швейцарийн прокурор энэ долоо хоногт дуусгасан байна. Түүнийг ямар нэгэн гэмт хэрэгт “хангалттай” холбож чадаагүй ба тэрээр 83 настай.

Хуан Карлосыг Саудын Арабад өндөр хурдны төмөр зам барих гэрээг баталгаажуулсны төлөө хахууль авсан гэж буруутгаж байсан юм.

2008 онд Саудын Арабын хаан Швейцарийн банканд дахь Абдуллагийн дансанд орсон 100 сая ам.долларыг Хуан Карлостой холбоотой гэж сэжиглэж байсан юм.

Гэвч мөрдөгчид энэ мөнгө болон галт тэрэгний гэрээ хоёрын хооронд ямар нэгэн тодорхой хамаарал байгааг нотолж чадаагүй байна.

Хаан Хуан Карлосын санхүүгийн асуудал хэдэн жилийн турш хянагдаж байсан ч тэрээр ямар ч буруутай үйлдлийг үргэлж үгүйсгэсээр ирсэн

Испанийн хааны шүүх энэ талаар тайлбар өгөхөөс татгалзаж байсан. Мөн АНЭУ-д цөллөгт амьдарч байгаа хаан Хуан Карлос ч өмгөөлөгчөөрөө дамжуулан өөрийг нь буруутгаж байгаа талаар тайлбар өгөхөөс татгалзаж байгаагаа илэрхийлсэн ба Хуан Карлосыг хэд хэдэн санхүүгийн гэмт хэрэгт сэжиглэн Испанид мөрдөн шалгах ажиллагаа явуулсаар байгаа юм.

Арваннэгдүгээр сард Португалийн сонинууд хаан Хуан Карлосыг Европ руу буцах боломжтой гэж мэдээлсэн. Португалийн хэвлэлүүд, мөн Испанийн зарим эх сурвалж Хуан Карлосыг Мадридаас хол байгаа, түүнийг байшинтай болгох талаар судалж байгаа гэж мэдээлсэн. Ялангуяа Португалийн Эсторил дахь Испанийн хааны гэр бүлийн Вилла Жиралдагийн гэрт ажилчид харагдсаны дараа Португалийн хэвлэл анхаарлаа хандуулж эхэлсэн байна.

⁵²⁵ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://radiosputnik.ria.ru/20211007/rakova-1753531916.html>

⁵²⁶ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://royalcentral.co.uk/features/king-carl-xvi-gustaf-travels-to-dubai-to-visit-expo-169807/>

6. НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, УЛС ТӨРИЙН АМЬДРАЛ БА АВЛИГА

Бэлгийн сүрдүүлэг: Авлига эмэгтэйчүүдэд өвөрмөцөөр нөлөөлдөг болох нь⁵²⁷

2015.01.02. Sarah Gitlin. Сьерра Леон дахь дүрвэгсдийн хуаранд байсан өсвөр насны охин зайлшгүй шаардлагатай, амьд үлдэхэд нь хэрэгцээтэй хоол хүнс, саван, эм тарианыхаа талаар хуарангийн захирагчид ханджээ. Тэрбээр охинд “*чиний нэр жагсаалтад ороогүй байна*” гэж худлаа хэлсэн бөгөөд мөнгө нэхэхийн оронд авлигын сонгодог үйлдэл болох бэлгийн харилцаанд орохыг шаардсан байна. Охинд үүнийг биелүүлэхээс өөр арга байсангүй.

Авлигажсан бэлгийн хүчирхийлэл (Олон улсын шүүгч эмэгтэйчүүдийн холбоо⁵²⁸ “sextortion” буюу бэлгийн сүрдүүлэг гэж нэрлэдэг) нь таамаг төдий зүйл биш бөгөөд бас ховор ч зүйл биш юм. Жишээлбэл, Хүний эрхийн харуул (Human Rights Watch) байгууллагын өнгөрсөн 09 дүгээр сарын тайланд дурдсанаар Сомалид Бурунди, Уганда цэргүүд “байнгын, зохион байгуулалттай” бэлгийн мөлжлөг хийдэг болохыг тогтоожээ. Сьерра Леон дахь нэгэн дүрвэгч “*Хэрвээ ТББ-ын ажилчдад санал болгох эхнэр, эгч, охин байхгүй бол тусламж авах боломжгүй*” гэсэн бол өөр нэг дүрвэгч “*Энд хэн ч бэлгийн харьцаанд орохгүйгээр CSM [шар буурцгийн тэжээллэг бодис] авах боломжгүй*” гэж хэлж байна. ТИ-ээс мэдээлсэнчлэн⁵²⁹ “Эмэгтэйчүүд хахуульд өгөх мөнгө байхгүй учраас тэднээс төлбөр нэхдэггүй гэсэн ойлголт байж болох юм ... гэтэл төлбөр нь мөнгө биш, бэлгийн харилцаанд орох хэлбэртэй байж болзошгүй” юм. Авлигажсан бэлгийн мөлжлөг нь маш их хүчирхийлэлтэй, хүний нэр төр⁵³⁰, эрхэд байнга халдаж байдгаас гадна өвчин тусах, жирэмслэх, нийгмээс гадуурхагдах, хохирогч буруутгагдах, гэрлэх боломж алдагдах гэх мэтээр хохирогчдод мөнгөн авлигаас хол илүү сөрөг нөлөө үзүүлдэг.

Гэсэн хэдий ч авлигын эсрэг тэмцэгчид авлигажсан бэлгийн мөлжлөгийн талаар үе үехэн дуугарч, авлигатай тэмцдэг томоохон байгууллагуудын ихэнх нь энэ сэдвийг үл тоомсорлож, мөнгөний авлигад илүү анхаарал хандуулдаг. Энэ бол алдаа юм. Авлигатай тэмцэх нийгэмлэгүүд бэлгийн сүрдүүлэг болон авлигын шинжтэй бэлгийн хүчирхийллийн бусад хэлбэрийг авлигын онцгой, гамшигт төрөл гэж хүлээн зөвшөөрч, онцгой анхаарал хандуулан, зохих ёсоор тохирсон хариу арга хэмжээг авах ёстой.

Авлигатай тэмцэх томоохон бүлэглэлүүд асуудлыг үл тоомсорлодог гэсэн гомдол эхэндээ шударга бус санагдаж магадгүй. Учир нь уг асуудлыг бүхэлд нь орхигдуулчихаагүй нь үнэн юм. Жишээлбэл, ТИ байгууллагаас “бэлгийн сүрдүүлэг нь жендэрт суурилсан авлигын хүчтэй жишээ мөн” гэдэгтэй санал нэг байгаа бөгөөд “эмэгтэйчүүдийг авлига хамгийн ихээр хохироож байна” гэжээ. Гэвч цөөн тохиолдох иймэрхүү мэдэгдэл нь янз бүрийн салбар дахь авлигын талаарх ерөнхий хэлэлцүүлэгт ихэвчлэн тусгагдахгүй байна. Жишээлбэл, ТИ “бэлгийн харилцааны хариуд багш нар сайн дүн санал болгодог” бөгөөд Ботсвана дахь эмэгтэй оюутнуудын 10% нь ийм тохиолдолд бэлгийн харилцаанд ордог гэсэн дүгнэлт гаргасан⁵³¹ боловч тэдний боловсролын үндсэн цахим хуудсанд⁵³² зөвхөн “дүнг худалдаж авах боломжтой” гэж л дурдсан байна. ТИ-ийн ашигласан энэ хэллэг хохирогчид учруулсан дарамтыг үлэмж бууруулж илэрхийлж байгаа юм. “Сайн үнэлгээг багш нар санал болгодог” гэдэг нь багш нар оюутнуудад өгч байгаа бэлэг, эсвэл оюутнууд сайн дураараа биеэ үнэлж байгаа мэт сонсогддог. Харин “Багш нар дүнгийн оронд оюутнуудаас бэлгийн харилцаа шаарддаг” гэх нь илүү оновчтой хэллэг юм.

Авлигын эсрэг бүлгүүд *quid pro quo* буюу *давуу байдлаар солих* бэлгийн сүрдүүлгийн талаар хааяахан дурдахаас гадна бэлгийн болон хүчирхийллийн замаар эмэгтэйчүүдэд хохирол учруулдаг авлигын өөр хэд хэдэн хэлбэрт анхаарал хандуулахгүй байна. Уламжлалт мөнгөний

⁵²⁷ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2015/01/02/beyond-sextortion-how-corruption-uniquely-affects-women/>

⁵²⁸ <https://www.iawj.org/>

⁵²⁹

https://issuu.com/transparencyinternational/docs/2010_wp_genderinservicedelivery_en?mode=window&backgroundColor=%23222222

⁵³⁰ Манай улсын Үндсэн хуульд “хүний нэр төр”, “хүний алдар хүнд”, “хүний нэр төр, алдар хүнд” гэх мэтээр янз бүрээр орчуулан хэрэглэж байгаа human dignity гэдэг ойлголтыг доктор(Ph.D), профессор Я.Долгоржав “хүний сүр сүлд” гэж ойлгох ёстой гэсэн байр суурь илэрхийлдэг (Х.О).

⁵³¹ Нийтлэлийн эх дээрх холбоос устгагдсан байна.

⁵³² Нийтлэлийн эх дээрх холбоос устгагдсан байна.

авлигын үүднээс бол цагдаагийн алба хаагч дэлгүүрт ороод эзэнд нь “*Хэрэв та бизнес эрхлэх зөвшөөрлөө хадгалахыг хүсвэл надад 100 доллар төл*” гэж хэлвэл энэ авлига мөн. Бас нөгөө офицер зүгээр л дэлгүүрт ороод касснаас 100 долларыг *quid pro quo* -гүй авбал угтаа энэ нь цаад утгаараа *quid pro quo* нь “*надад үүнийг өг, би чамд төвөг удахгүй*” гэсэнтэй адил тул мөн л авлига. Үүнтэй адил, цагдаа, цэрэг, төрийн захиргааны байгууллагын хэн нэгэн албан тушаалтан хохирогчийн хүртэх эрхтэй бараа, үйлчилгээний хариуд бэлгийн харилцаа шаардах, мөн довтлогч этгээд нь эрх мэдэлгүй байсан бол яах байсан бэ гэдгээс илүүтэйгээр энэ тухай эсэргүүцэх, мэдээлэхээс айж эмээж буй эмэгтэйг төрийн эрх мэдэл бүхий албан тушаалтан хүчиндэх нь авлигажсан бэлгийн хүчирхийлэл юм. Бэлгийн мөлжлөгт өртөх үед “*ТББ-ын ажилчид маш их эрх мэдэлтэй тул хүмүүс тэднийг эсэргүүцэж чаддаггүй*” хэмээн Гвиней дэх дүрвэгсдийн удирдагч ярьж байна. Үүнтэй адил, гэр бүлийн зарим төрлийн хүчирхийлэл, ялангуяа, хууль сахиулагчид, эсвэл бусад эрх мэдэл бүхий албан тушаалтны хүчирхийллийг, наад зах нь, тэдний хохирогчид хүчирхийллийн талаар мэдээлэх, хэрвээ мэдээлсэн тохиолдолд түүнд итгэх эсэх, эсвэл зугтахад маш хэцүү гэдгийг эдгээр албан тушаалтнууд тооцоолж байгаа тохиолдолд үүнийг авлига гэж тооцох ёстой.

Авлигатай тэмцэх нийгэмлэг эмэгтэйчүүд авлигад өртөх олон төрлийн хэлбэрийг хүлээн зөвшөөрч, эрэмбэлж чадаагүй байгаа нь биднийг бэлгийн сүрдүүлэг, хүчин, бэлгийн хүчирхийлэлтэй үр дүнтэй тэмцэхэд саад болж байна. Мөнгөний авлигатай тэмцэх ихэнх аргууд (мөнгөний урсгалыг мөшгих гэх мэт) нь бэлгийн сүрдүүлэгтэй тэмцэх шууд үр дагаваргүй байдаг. Үүний зэрэгцээ, энэ асуудлыг *авлигын* (системийн) хэлбэр (зөвхөн хүчирхийлэл, дарамтын бие даасан гэмт хэрэг гэж биш) гэж үзэх нь бидэнд асуудлыг шийдвэрлэх шинэ арга хэрэгслийг бий болгоход туслах болно. Жишээлбэл, ярилцлага хийх, эсвэл нэрээ нууцлан мэдээлэхийг хүмүүсээс хүсэх замаар бэлгийн авлигад автсан албан тушаал, байгууллагын “зураглал” гаргаж болно. Хувь хүмүүсийг яллах хангалттай баримт нотолгоо байхгүй байсан ч бид хаана мөнгө төвлөрүүлэхээс зайлсхийх талаар сангууд болон засгийн газруудад дохио өгч, зорилтот бүлгүүдэд бэлгийн сүрдүүлгийн гэмт хэргийг таслан зогсоох хөшүүрэг өгч болох юм. Мэдээжийн хэрэг, авлига багатай байгууллагыг тогтоож өгөх гэх мэтээр үйлчилгээ шаардлагатай эмэгтэйчүүдэд сөргөөр нөлөөлөхгүй арга замыг олох хэрэгтэй. Авлигын асуудал болох бэлгийн сүрдүүлэгтэй тэмцэх бүтээлч арга замыг хайж олох нь эмэгтэйчүүдийн аюулгүй байдал, сайн сайхан байдалд тодорхой нөлөө үзүүлнэ.

Авлигын нийгмийн сэтгэл зүй⁵³³

2015.08.28. Anusha Pamula. Авлигын шалтгааны талаарх соёлын тайлбарлалаас эхлээд эдийн засгийн загварууд гээд өдий төдий онол бий. Гэхдээ авлигын нийгэм-сэтгэлзүйн шалтгаанд, ялангуяа хувь хүний түвшинд харьцангуй бага анхаарал хандуулж иржээ⁵³⁴. Социологич Марина Залозная саяхны нэгэн нийтлэлдээ итгэлтэйгээр хэлсэнчлэн, хэрвээ бид авлигатай үр дүнтэй тэмцэх л гэж буй бол авлигач зан байдлын хувь хүний нийгмийн сэтгэл зүй (the individual social psychology)-д илүү их анхаарал хандуулах хэрэгтэй байна⁵³⁵. Хүн яагаад шударга бус үйлдэл хийдэг, ялангуяа хувь хүний авлигад өртөмтгий байх хандлага нь тухайн хүний ёс суртахууны шинж чанар болон хүрээлэн буй орчны нөхцөл байдлаас ямар хамааралтай болохыг судалж үзсэн цөөн тооны боловч өсөн нэмэгдэж буй эмпирик судалгаанууд (өмнө нь энэ⁵³⁶ блог дээр ярилцсан зарим сэдвийг оруулаад) мэдээж байгаа. Хэдийгээр, бидний ойлгохгүй байгаа зүйл олон бий ч, энэхүү судалгаа зарим ойлголтыг бидэнд санал болгож буй юм.

Ихэнх хүмүүс, системчилсэн авлигад автсан орнуудад ч гэсэн, авлигыг хүлээн зөвшөөрдөггүй гэж нотолдог. Тэгвэл авлига яаж ийм өргөн тархав аа? Зарим судалгаа ёс суртахууныг чөлөөлөх замаар ердийн ёс суртахуунгүй үйлдлийг ёс суртахуунлаг гэж ойлгож хүлээн авж болохыг ч харуулж байна⁵³⁷. Энэ нь хэд хэдэн янзаар тохиолдож болох бөгөөд тухайн хүн өөрийн үйлдлийн

⁵³³ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2015/08/28/the-social-psychology-of-corruption-lack-thereof/>

⁵³⁴ <https://onlinelibrary.wiley.com/doi/abs/10.1111/soc4.12120>

⁵³⁵ <https://clas.uiowa.edu/sociology/people/marina-zaloznaya>

⁵³⁶ <https://globalanticorruptionblog.com/2014/06/26/the-importance-of-personnel-selection-in-promoting-government-integrity-some-evidence-from-india/>

⁵³⁷ <https://www.pin1.harvard.edu/cas/login?service=https%3A%2F%2Fkey-idp.iam.harvard.edu%2Fidp%2FAuthn%2FExternal%3Fconversation%3De1s1%26entityId%3Dezprod1.hul.harvard.edu%2FIts%2Fzproxyprod%2Fsp>

үр дагаврыг харж чадаж байгаа эсэхтэй холбоотой юм. Авлигын хор уршиг өөрөөс нь хол, эсвэл хийсвэр байх тохиолдолд хувь хүмүүс уг үйлдлийг ёс суртахуунлаг бус зүйл гэж үзэх нь бага байдаг байна. Энэхүү ерөнхий үзэл баримтлалтай уялдаатай бусад судалгаагаар зарим хүмүүс авлигач үйлдлийг ёс суртахууны асуудал гэж үздэггүйгээс үүдэн авлигач зан байдал ихэвчлэн гардаг болохыг олж тогтоожээ⁵³⁸.

Үүнээс ч илүү сонирхолтой, чухал зүйл бол авлига бүлэг юмуу байгууллагуудад өргөн тархаж буй сэтгэл зүйн динамиктай холбоотой байж болох юм. (Энд хийсэн судалгаатай уялдаатай, авлигад идэгдсэн байгууллагуудын соёлын шинж чанарын талаарх өмнөх хэлэлцүүлгийг Алисон Тейлорын нийтлэлээс⁵³⁹ үзнэ үү.) Байгууллагын зарим хүмүүс авлигад автсан тохиолдолд бусад нь ч тэднийг дуурайж болзошгүй юм, учир нь тэд авлигач зан авирыг хүлээн зөвшөөрч болохуйц зүйл гэж ойлгож эхэлдэг, ядаж л, *бүгд л ингэдэг юм байна* гэж боддог. Зарим судалгаа үнэнч байх утгыг онцолдог. Юу гэвэл, авлигач үйл ажиллагаа, авлигын хэрэгт нь биечлэн оролцоогүй боловч түүнийг үйлдсэн нэг хүн юмуу, бүлэг хүмүүст үнэнч хүмүүс дор хаяж чимээгүй байх үүргийг мэдэрдэг байна.

Бүлгийн гишүүн болсноор зарим хүний зан чанар, ёс суртахууны хандлага, байр суурь өөрчлөгддөг нь их сонирхолтой, бас сэтгэл түгшээсэн зүйл юм. Тухайн хүн тэр бүлэгт хамрагдахаасаа өмнө ямар нэг үйлдлийг ёс суртахуунлаг бус гэж боддог байсан ч дараа нь тухайн бүлэгт давамгайлдаг адилсалд нийцүүлэн хувийн шинж чанараа өөрчилдөг болохыг Нийгмийн адилслын онол сануулдаг. Судалгаанаас харахад энэхүү нийгмийн адилсалын онол нь анхны авлигач этгээд үгүй болсноос хойш удаан хугацаа өнгөрсний дараа ч авлига системд яагаад байсаар байдгийг тайлбарлаж магадгүй юм⁵⁴⁰.

Хэрэв энэ судалгаа үнэн зөв бол авлигатай тэмцэх стратегид хэрэг тустай ямар зүйлийг бидэнд хэлж байна вэ? Мэдээжийн хэрэг маш төвөгтэй боловч урьдчилсан хэдэн бодлыг энд оруулав:

- Энэтхэг дэх авлигын эсрэг хөдөлгөөн шиг олон хөдөлгөөн улс төрийн асуудалд төвлөрч, тодорхой хууль тогтоомж, эсвэл хэргийн эргэн тойронд л идэвхждэг. Эдгээр хүчин чармайлтыг авлигач ёс суртахуунд чиглэсэн нийгмийн кампанит ажлуудаар нөхөн баяжуулж, асуудлыг хувь хүний түвшинд илүү хүмүүнлэг болгох хэрэгтэй юм.
- “Бүлгийн зан байдал”-тай тэмцэх нэг арга бол гадны хүмүүсийг татан оролцуулах явдал юм. Жишээлбэл, нэгэн туршилтад оролцогчид бүлэг дотор уг бүлэгт хамаагүй гадны ажиглагч байгаа үед бүлгийн гишүүдийн гэм буруутай үйлдлийн эсрэг үйлдэл хийх магадлал өндөр байв⁵⁴¹. “Бүлэгт гадны ажиглагч байх нь бүлгийн гишүүдийн гэм бурууг хувь хүнд хандуулдаг өөрийгөө ангилах үйл явцыг өдөөдөг байна.” Энэ төрлийн хөндлөнгийн хяналтыг төрийн байгууллагуудаас эхлээд хувийн бизнес эрхлэгчид хүртэл хэрэгжүүлж болох боловч өртөг өндөртэй байдаг.
- Сонирхолтой нь, бүлгийн адилслын өөр өөр шинж, талуудыг хувь хүмүүст сануулах нь тэдний ёс суртахууны зөн, зан авирыг өөрчилдөг байна. Энэ нь илүү ёс суртахуунлаг зан үйлийг төлөвшүүлэх зорилготой дүрс, тэмдэг, бүлгийн адилслын бусад шинж чанарыг онцолсон (эсвэл үл онцолсон) хөндлөнгийн оролцоо байж болох юм.

Эдгээр санаанууд нь зөвхөн урьдчилсан таамаглал төдий юм. Хамгийн чухал нь, авлигын ёс суртахуун, сэтгэлзүйн асуудлын талаар хувь хүний түвшинд илүү их судалгаа хийхгүй л бол бид тогтвортой шийдэл бүхий авлигын эсрэг стратеги боловсруулж чадахгүй юм.

[Авлигад автсан институц шударга хүмүүсийг хэрхэн эвддэг вэ?](#)⁵⁴²

2017.08.15. Matthew Stephenson. Авлигатай, ялангуяа, байгууллага буюу институцийг бүхэлд нь хамарсан системийн авлигатай тэмцэх явцад учирдаг томоохон бэрхшээлүүдийн нэг бол эгэл жирийн, шударга хүмүүс илэрхий ёс суртахуунлаг бус, хууль бус үйл ажиллагаанд хэрхэн

⁵³⁸ <https://heionline.org/HOL/LandingPage?handle=hein.journals/brklr70&div=40&id=&page=>

⁵³⁹ <https://globalanticorruptionblog.com/2015/07/02/guest-post-the-characteristics-of-corrupt-corporate-cultures/>

⁵⁴⁰ <https://media.8chan.co/pdfs/src/1419190510244.pdf>

⁵⁴¹ <https://www-2.rotman.utoronto.ca/facbios/file/Contagion%20or%20Restitution%20JESP.pdf>

⁵⁴² Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2017/08/15/how-corrupt-institutions-corrupt-decent-people/>

татагдан орох болсныг олж мэдэх явдал байдаг. Тийм ээ, зарим шунахай социопатууд⁵⁴³ байдаг, гэхдээ ихэнх хүмүүс ядаж өөрсдийгөө сайн хүмүүс гэж бодох дуртай байдаг. Бас, заримдаа социопатууд хамтын ажиллагаа, дуулгавартай байдлыг тогтоох асах их хүчийг эзэмшиж байдаг ч ихэнх тохиолдолд өөрсдийгөө сайн хүн гэж боддог олон хүн эцэст нь (дор хаяж л тэвчин өнгөрүүлж, далдуур дэмжиж) учир утгагүй, ёс суртахуунлаг бус авир үйлдэл гаргадаг учраас л системийн авлига бий болдог.

Бид өмнө нь энэ сэдвээр цөөн хэдэн нийтлэл бичиж байсан (жишээлбэл, эндээс⁵⁴⁴, эндээс⁵⁴⁵ харна уу), мөн энэ асуудлыг судалдаг сэтгэл судлал, байгууллагын социологи гэх мэт салбарын шинжлэх ухааны бүтээлүүд ч нэмэгдэж байна. Би тэдгээр бүтээлүүд дээр үргэлжлүүлэн ажиллаж байгаа бөгөөд, магадгүй, дараагийн бичлэг дээр судалгааны үр дүнгийн талаар саналаа хэлнэ. Харин өнөөдөр би өөр нэг сэдвийн тайлбараас үүдэлтэй асуултын талаарх үзэл бодлоо хуваалцахыг хүссэн юм. Тэр нь профессор Дэвид Лубан⁵⁴⁶ болон миний хамтран зүтгэгч профессор Жек Голдсмит⁵⁴⁷ нарын бичсэн сайн, шударга хүмүүс Трампын засаг захиргаанд ажиллахыг зорих хэрэгтэй эсэх талаарх бичлэгүүд юм. (Профессор Лубаны нийтлэл сонгуулийн дараахан хэвлэгдсэн, профессор Голдсмитийн нийтлэл өнгөрсөн тавдугаар сард Трамп ХМТ-ны дарга Жеймс Комиг гэнэт халсантай холбогдуулан нийтлэгдсэн.) Профессор Лубан, Голдсмит нарын бүтээлүүд авлигын тухай биш, харин улс төрийн бодлогын хувьд консерватив хандлагатай боловч цаашид томилогдох олон хүнд тэвчихийн аргагүй санагдах бодлого дэвшүүлж чадах Ерөнхийлөгчийн төлөө ажиллахад тулгарч буй бэрхшээлтэй холбоотой илүү өргөн хүрээний асуудлууд юм. Гэсэн хэдий ч эдгээр нийтлэлүүдийг уншиж байхдаа, жаахан л тодруулчихвал, авлигад идэгдсэн байгууллагад (төрийн болон хувийн хэвшлийн) орж ирсэн шударга хүмүүс эцэст нь тэрхүү шударга байдлаа алдахтай хэчнээн их хамаатай нь намайг гайхшируулсан юм.

Доор би авторитаризм, радикал бодлоготой гэхээсээ илүү авлигатай (төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын) холбоотой ажиглалт хийх үүднээс багахан засвартайгаар зөвхөн холбогдох хэсгүүдийг эш татъя.

Эхнийх нь, профессор Лубанаас:

[Байгууллагад] орж ирсний дараа таны харилцан хамаарлын хүрээ өөрчлөгддөг. Ажил бол сорилт, эрч хүч, дэвшилт юм. Хамт ажиллаж байгаа ихэнх хүмүүс тань аятайхан, сайн хүмүүс юм гэж танд бодогдоно. Ийм сайхан төлөв хүмүүс зохисгүй зүйл хийхгүй дээ гэж та өөртөө хэлнэ. Аажмаар таны ёс суртахууны луужин тэднийхтэй нэгдэж эхэлнэ Багийн мөн чанарыг улам хөгжүүлж, багаа ичгэвтэр байдалд оруулахыг хүсэхээ байна; та бүх зүйлээс татгалзагч байж чадахгүй шүү дээ. Та хил хязгаарын мэдрэмжээ алдах бөгөөд угтаа энэ нь ямар нэгэн хэвийн бус зүйлийг хараад бидний мэдэрдэг тэр мэдрэмж юм. Хэвийн бус зүйл ердийн хэвшил болсон тохиолдолд хил хязгаар бүдгэрч арилдаг.

Дараагийнх нь, профессор Голдсмитээс:

... Олон хүн албан тушаалд очоод ямар нэгэн улаан шугамыг давахаас татгалзсанаар л мэргэжлийн нэр хүнд, шударга байдлаа хадгалчихаж чадах юм шигээр боддог [Гэхдээ] энэ бол хэтэрхий энгийн загвар. Энэ хэтэрхий энгийн байгаагийн нэг шалтгаан бол ихэнх хугацаанд, ялангуяа, эхэндээ [] асуудлууд тийм ч илэрхий тодорхой байдаггүй Ийм нөхцөлд [шинээр томилогдсон] хүн урьдчилан төсөөлсөн улаан шугамыг даваагүй ч гэсэн сэтгэл түгшээх [шийдвэр гаргалтад] [оролцож] магадгүй юм. Загвар хэтэрхий энгийн байгаагийн бас нэг шалтгаан бол шийдвэрүүд бодит цаг хугацаанд, [байгууллага эсвэл түүний удирдлагад] үнэнч байхын ... тулд хийсэн ямар нэгэн өчүүхэн буулт хэрхэн нэр

⁵⁴³ Социопат гэдэг нь нийгмийн эсрэг зан чанарын эмгэг буюу antisocial personality disorder (ASPD) өвчтэй хүнийг тодорхойлоход хэрэглэдэг нэр томъёо юм. ASPD өвчтэй хүмүүс бусдын мэдрэмж, үзэл бодлыг ойлгох чадваргүй бөгөөд өөрсдийн учруулах хор уршиг, гэм бурууг үл ухамсарлан хууль дүрмийг зөрчиж, цочмог шийдвэр гаргадаг. ASPD өвчтэй хүн ууртай, их зантай, хүссэн зүйлээ олж авахын тулд ухаалаг жүжиглэдэг, бусдын эрхийг зөрчдөг, ашигладаг, гуйвуулдаг, хулгай хийдэг, байнга хууль зөрчдөг, гэм буруугаа нуудаг, өөрт учирсан асуудалд бусдыг буруутгадаг гэх мэт шинжүүд илэрдэг байна. (X.O)

⁵⁴⁴ <https://globalanticorruptionblog.com/2015/08/28/the-social-psychology-of-corruption-lack-thereof/>

⁵⁴⁵ <https://globalanticorruptionblog.com/2015/07/02/guest-post-the-characteristics-of-corrupt-corporate-cultures/>

⁵⁴⁶ <https://www.justsecurity.org/34404/case-serving-trump/>

⁵⁴⁷ <https://www.lawfareblog.com/lawyerly-integrity-trump-administration>

хүнд, шударга байдлаа золиосолж төгсөхийг олж харах боломжгүйгээр, аажмаар гарч ирдэг

Багтаа үнэнч байх хатуу шаардлага, харилцан хамаарлын дотоод өөрчлөлт, цаг хугацаанд хавчигдах юмуу, илэрхий эргэлзээтэй шийдвэр гаргах дарамт шахалт нь хүнийг нэр төр, шударга байдлаа эрсдэлд оруулахуйц жижиг буланд хүчээр шахдаг. [Шинээр томилогдсон хүний] хийсэн зарчмын багахан буулт нь түүнийг илүү их буулт хийн гулсаж уруудахад хүргэх магадлал [байгууллага] бүрд бий. Гэхдээ хэм хэмжээг зөрчдөг [удирдагч] [байгууллага] дахь аюулыг улам өндөрсгөж байдаг Ийм тохиолдолд улаан шугам давахаас зайлсхийх нь тийм ч чухал шийдвэр биш байж магадгүй. Үүний оронд, энэ ажилд орох эсэхээ эхлээд шийдэх ёстой байсан ч байж болох юм.

Энэ бүхэн надад үнэн сонсогдоод байгаа юм. Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дахь системийн авлигын талаар миний уншиж, сонссон түүхүүдтэй яв цав таарч байна. Эдгээр ажиглалтыг илүү системчилсэн судалгаагаар баталгаажуулсан эсэхийг би эрдэм шинжилгээний бүтээлүүдээс үргэлжлүүлэн судлах болно. Харин энэ удаад би ажигласан зүйлээ GAB(<https://globalanticorruptionblog.com/>)-ийг уншигчидтай хуваалцаж, дээрх тайлбарууд та бүхний сайн мэддэг авлигажсан байгууллагууд дахь динамикийг яг таг илэрхийлж чадаж байгаа эсэхийг асууж буй юм.

Нөхцөл байдлыг бүхэлд нь тольдохуй:
Санхүүгийн нууцлалын индекс ба АТИ⁵⁴⁸

2020.02.19. Өнгөрсөн сард ТИ байгууллагаас 2019 оны АТИ-ийг зарласан билээ. Энэхүү индексээр улс орнуудын нийтийн албан дахь авлигын хэлбэрүүдийн талаарх төсөөллийг илтгэн харуулдаг. Засгийн газрын тендерт ялах, тусгай зөвшөөрөл авахын тулд хахууль өгөх, эсхүл улс төрийн хэлхээ холбоо ашиглах зайлшгүй шаардлагатай болдог улс орнуудыг энэхүү АТИ-ээр нийтэд ил зарладаг юм. Гэхдээ энэ индекс авлигын нөхцөл байдлыг бүрэн хэмжээгээр тодорхойлж чаддаггүй. Авлигын болон мөнгө угаах үндэстэн дамнасан үйл ажиллагаа, эсхүл авлигачдаас гэмт хэргийн замаар олсон хөрөнгөө нууж далдлах, зарцуулах боломжийг бүрдүүлэхэд оруулж буй хувийн хэвшлийн үүрэг оролцоо зэргийг АТИ бүрэн дүүрэн харуулж чаддаггүй.

Ангол улсын засгийн газар болон тус улсын төрийн өмчит газрын тосны компанитай ажил гүйцэтгэх гэрээ хэлцэл хийх, компанийн жинхэнэ өмчлөгчийг нууцлахын тулд Мальта, Мавритан зэрэг улсуудад бүртгэлтэй олон тооны халхавч компаниудыг ашигласан болох нь Луанда Лийкс (Luanda Leaks)-тэй холбоотой мөрдлөгийн явцад тодорхой болсон юм. Түүнчлэн, хахууль өгөх болон завшсан, хулгайлсан мөнгийг угаахын тулд Португал, АНЭУ зэрэг улсуудад байгаа өмчлөгч нь тодорхой бус дансыг ашигласан байна. Одебрехт компани ч мөн иймэрхүү механизмийг ашиглажээ. Тус компани Латин Америк даяар болон африкийн 2 улсын төрийн албан тушаалтнуудад хахууль өгөхийн тулд оффшор бүс дэх 42 дансыг ашигласан байна.

Хэдийгээр, авлига, хахуулийн үйл ажиллагаанд ашиглагддаг хуулийн этгээдийн бүтэц, санхүүгийн суваг маш олон янз байдаг ч эдгээр нь нэг шинж чанараараа өөр хоорондоо төстэй. Энэ бол нууцлаг байдал юм.

Нууцлаг байдал нь хууль бус, хуулиар хүлээн зөвшөөрөгдөх боломжгүй санхүүгийн гүйлгээний үндсэн нөхцөл юм. Татварын шударга байдлын сүлжээ байгууллагаас өчигдөр зарласан Санхүүгийн нууцлаг байдлын индексийн үр дүнгээс харвал улс орнуудын нууцлаг байдал хавтгайдаа өндөр түвшинд хэвээр байна. Санхүүгийн нууцлаг байдлын индексийн суурь үзүүлэлт нь Нууцлалын оноо (Secrecy Score) бөгөөд энэ үзүүлэлтээр хууль бус санхүүгийн гүйлгээ хийх боломжийг олгож байгаа эрх зүйн болон зохицуулалтийн системийг 0 (бүрэн ил тод) -ээс 100 (бүрэн нууцлаг) оноогоор үнэлдэг. Нууцлалын онооны байдлыг авж үзвэл, ихэнх улс орнуудын хувьд санхүүгийн салбарын ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд их зүйлийг хийх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Тухайлбал, эцсийн өмчлөгчийн (компанийг хэн өмчилдөг болон хянадаг) талаарх мэдээллийн ил тод байдал, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөлийн

⁵⁴⁸ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://voices.transparency.org/what-the-financial-secrecy-index-tells-us-that-the-corruption-perceptions-index-doesnt-6c8d4bf5c06d>

талаарх мэдээлэл, мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомж болон олон улсын хамтын ажиллагааны асуудлаар тодорхой арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Санхүүгийн нууцлаг байдлын индексэд нийтдээ 133 улс орныг хамруулсан бөгөөд дундаж оноо нь 63.9 байна. Санхүүгийн нөхцөл байдлыг нь ил тод гэж ямар ч улс орныг тодорхойлох аргагүй байна. Словени улс авах ёстой 100 онооноос 37.55 оноо авсан бөгөөд энэ үзүүлэлтээрээ хамгийн нууцлаг санхүүтэй улс болж байна.

Улс орнуудыг үндсэн 2 бүлэгт хувааж болохоор байна. Үүнд:

1. Нууцлаг байдал маш өндөр, авлига ихтэй

Ангол, Гамби, Мальдив, Венесуэл зэрэг энэ төрлийн улс орнуудад авлига нь тогтолцооны шинжтэй болсон бөгөөд эрх мэдэлд ойр байдаг хэсэг бүлэг хүмүүс л өөрсдийн эрх ашигт нийцүүлэн бүх тоглолтын дүрэм, журмыг зохиож, хэрэгжүүлж, хамгаалж, үр шимийг хүртэж байдаг.

Эдгээр улс орнуудад нууцлаг байдал маш өндөр бөгөөд улсын хөрөнгө, мөнгөнөөс илүү их хувь хүртэх боломжийг дээрх хүмүүст олгож байдаг. Гэхдээ хямрал тэмцэл, улс төрийн тогтворгүй байдал болон хууль дүрэм сул хэрэгждэг байдлаас нь болоод эдгээр улсуудыг аливаа хууль бус хөрөнгийг байршуулах, угаах сонирхол бүхий этгээдүүд төдийлөн сонирхдоггүй. Чухам энэ нь эдгээр улсууд Санхүүгийн нууцлаг байдлын индексийн өөр нэг үзүүлэлт болох нууцлаг байдлын нөлөөллийн үзүүлэлтээр харьцангуй доогуур байдгийг тайлбарлаж байгаа юм.

Авлига ихтэй, санхүүгийн нууцлаг байдал өндөртэй улс орнуудыг мөн “уламжлалт” хэлбэрийн татварын таатай орчин бүхий улс орнууд гэж үзэж болно. Эдгээр улсууд нь гадаадын иргэдэд компанийн нууцлал болон татварын таатай нөхцөлийг давхар санал болгодог. Жишээлбэл, Багамын арлууд, Панам, Сейшел, Мавританийг нэрлэж болно. Кипр, Латви, Мальта улсуудад мөн авлига, мөнгө угаахтай холбоотой хэрэг гарч, ихээхэн дуулиан шуугиан болоод удаагүй байна. Эдгээр улсад санхүүгийн нууцлаг байдлыг бизнесийн загвар болгодог бөгөөд эдийн засгийн чухал хэсэг нь компанийн бүртгэлийн үйл ажиллагаа болдог. Тиймээс ил тод байдлыг дэмжиж, хуулийн зөрчлийг таслан зогсоох явдал төдийлөн дэмжлэг авдаггүй. Эдгээр улс орнууд дахь авлига болон хууль, дүрэм журам сул хэрэгждэг байдал нь хууль бус үйлдлийг таслан зогсоож, хариуцлага тооцох боломжийг бууруулж, авлигатай холбоотой компаниуд болон улс төрчдөд ашигтай байдал бий болгож, дэлхий даяар явагддаг нууцлаг хэлцлүүдийн нөхцөлийг бүрдүүлдэг.

2. Нууцлаг байдал өндөр, авлигын түвшин бага

Өөр нэг бүлэг улс орнууд бол Хонконг, Люксембург, Сингапур, Швейцари, АНЭУ, АНУ, Их Британи зэрэг санхүүгийн нууцлаг байдал өндөр бөгөөд нийтийн албан дахь авлигын түвшин багатай улсууд юм. Эдгээр улс нь компанийн болон санхүүгийн нууцлаг байдал өндөртэй төдийгүй бохир мөнгийг байршуулах сонирхолтой хүмүүсийн сонирхлыг их татдаг. Тэдний зүгээс үл хөдлөх болон бусад тансаг эд зүйл худалдан авах, хөж сангууд зэрэг хөрөнгө оруулалтын сангуудад хөрөнгө оруулах, банканд хадгалах зэрэг хэлбэрээр мөнгөө байршуулдаг. Эдгээр улсад нийтийн албан дахь авлига нь хахууль болон төрийн өмч, хөрөнгийг шууд байдлаар ашиглан завших хэлбэртэй байх нь ховор боловч авлигын бусад хэлбэр, тухайлбал, хууль бус нөлөөлөл, явцуу ашиг сонирхолд хөтлөгдөх зэрэг хэлбэрүүд нь нууцлаг байдалд оршихдоо улам цэцэглэн хөгждөг санхүүгийн үйлчилгээний салбаруудыг үйл ажиллагаагаа саадгүй үргэлжлүүлэх, орон орны авлигачдын хүслийг гүйцэлдүүлэх боломжийг бүрдүүлдэг.

Эдгээр улсуудын зарим нэг нь, тухайлбал АНУ, Их Британи, Люксембург, Швейцари зэрэг улс нууцлаг байдлыг багасгах зарим нэг арга хэмжээ авж байна. Гэсэн хэдий ч, хангалттай хэмжээний цоорхой үлдсэн учраас эдгээр улс руу авлигачдын мөнгө урссаар байна.

Санхүүгийн нууцлаг байдлын индекс нь авлигын гэмт хэрэгтнүүд болон бусад гэмт хэрэгтнүүдийн хувьд хууль бусаар олж авсан мөнгө, хөрөнгөө нуух, угаах өргөн боломж байсаар байгааг анхааруулах бас нэг анхааруулга болж байна.

2020.04.09. Компанийн нууцад салхи оруулсан Панамын баримт дэлгэгдсэнээс хойш энэ долоо хоногт дөрөв дэх жил нь тохиож байна. Тэгш бус байдлыг дэвэргэсэн, авлигыг өөгшүүлсэн дэлхийн санхүүгийн систем дэх сул талын талаар 2016 онд олон нийт мэдэх болсон юм.

Энэ дөрвөн жилийн хугацаанд тоймгүй олон дуулиант явдал, Холливүүдын кино хүртэл гарч ихээхэн дэвшил бий болж байгаа ч татварын шударга байдал, компанийн нууц тулгамдсан асуудал хэвээр байна.

Нууцлаг халхавч компаниудыг зүй бусаар ашиглах нь КОВИД-19 цар тахалтай нүүр тулж буй олон улс оронд өнөөдрийн томоохон бэрхшээлийн нэг шалтгаан болж байна. Олон жилийн хугацаанд эдгээр компаниудаар дамжуулан авлига, луйвар, татвараас зайлсхийх боломжийг олгосон юм. Энэ нь эрүүл мэндийн системийг бэхжүүлэхэд зарцуулах ёстой байсан татвар, төсвийн хөрөнгө зорилтот хэсэгтээ очоогүй, эсхүл нийтийн хөрөнгөөс завшсан гэсэн үг болж байна.

Жишээлбэл, нөөц арвин Африк бол эдийн засгийн өсөлтийн хувьд дэлхийн хоёр дахь хамгийн хурдтай өсөж буй бүс нутаг боловч жил бүр үндэсний хөрөнгөөс 50 тэрбум ам.доллар гадагш гарахад оффшор бүс нутгууд түлхэц болж байна.

Панамын баримтаас хойш нууцлаг компаниудын жинхэнэ эзэмшигчийн талаарх мэдээллийг цуглуулах улс орнуудын хүсэл улам бүр эрчимжиж байна. Улмаар, энэ талаар зарим ахиц дэвшил гарч байгаа боловч хурд нь хэтэрхий удаан байна.

Энэ бүхэн панамын хуулийн фирм Моссак Фонсекагаас авсан 11.5 сая баримтыг германы хэвлэл мэдээллийн байгууллага Süddeutsche Zeitung-д илчилснээс эхэлсэн юм. Уг баримт дахь гэрээний хуулбар, банкны гүйлгээ болон цахим шуудангууд дээрх фирм дэлхий дахинд буй нууцлаг оффшор компаниудад хэрхэн үйлчилж байсныг илчилсэн юм. Улмаар ОУЭССК-аас дэлхийн 80 гаруй улсын 400 сэтгүүлчтэй хамтран дээрх мэдээлэлд шинжилгээ хийх асар том ажиллагааг зохион байгуулсан.

Уг шинжилгээний үр дүн цочирдохуйц байсан бөгөөд дэлхийн санхүүгийн нууцын харанхуй торон дахь 12 улсын удирдагч, алдартан болон бусад олон нийтийн зүтгэлтнүүдийг ил болгож, олон нийтийн эсэргүүцэл, албан ёсны шалгалтыг эхлүүлэхэд хүргэсэн билээ.

Жишээлбэл, хүүхдүүд нь Лондонд тансаг зэрэглэлийн орон сууц эзэмшдэг оффшор компанитай холбоотой болох нь илчлэгдсэний дараа буюу 2018 онд Пакистаны Ерөнхий сайд асан Наваз Шариф авлигын хэргээр 10 жил хорих, 10.6 сая ам.долларын торгох ялаар шийтгүүлсэн.

Мөн тухайн онд дээрх баримтаар Петроэквадор-ын хахуулийн схемд Эквадор улсын өндөр түвшний албан тушаалтнууд холбоотой болохыг илчилсний дараагаар тэднийг баривчилж байсан юм.

2019 оны байдлаар компанийн жинхэнэ эздийн талаарх Панамын баримтын мэдээлэл нь засгийн газрууд хөрөнгө хураах, торгууль оногдуулах, аудит хийх замаар 1.2 тэрбум гаруй ам.долларыг олж авахад дэмжлэг болсон байна.

Хэдийгээр, энэ чиглэлд дэлхийн түвшинд томоохон эерэг өөрчлөлт гарч байгаа ч компанийн ашиг хүртэгч жинхэнэ эзнийг бүртгэх үйл ажиллагаа жигд бус, олон улс орон амлалтдаа хүрч чадахгүй байна. Үүний шалтгаан нь холбогдох бизнесүүдийн хүчтэй лобби, улс төрийн хүсэл зориг дутах, техникийн чадавх бүрдээгүй зэрэг олон хүчин зүйлээс үүдэлтэй байна.

ЕХ-ны хэмжээнд Мөнгө угаахтай тэмцэх 5 дугаар удирдамжид 2020 оны 01 дүгээр сар гэхэд бүх гишүүн улс орнууддаа жинхэнэ ашиг хүртэгч эздийн бүртгэлийг бий болгохыг үүрэг болгосон юм. Харин Global Witness байгууллагаас хийсэн судалгаагаар ихэнх улс орнууд дээрх үүргийг биелүүлээгүй байна. Ялангуяа, оффшор бүс нутгууд компанийн эздийн талаарх мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд ихээхэн хойрго хандаж байна. Хэдийгээр Их Британи энэ хүрээнд идэвхтэй ажиллаж байгаа боловч түүний харьяаны оффшор бүс нутгууд туйлын хангалтгүй

⁵⁴⁹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж:

https://www.transparency.org/news/feature/panama_papers_four_years_anonymous_companies_corporate_secretcy

байна. Зөвхөн Жерси, Гернси, Мэн арлууд дээрх бүртгэлийг бий болгосон ч 2023 оноос олон нийтэд ил тод болгохоор төлөвлөж байна.

Одоогоор ФАТФ гэмт хэрэгтэн, авлигач нарт хууль бус орлогоо нуух, угаах боломж олгосон улс орнуудад хориг тавих эрх бүхий дэлхийн хэмжээний цор ганц байгууллага юм. Иймд иргэний нийгмийн түншүүдтэйгээ хамтран бид ФАТФ-ыг дэлхийн стандартад яаралтай шинэчлэлт хийх, ашиг хүртэгч эздийн талаарх нэгдсэн мэдээллийг баталгаажуулсан, төв бүртгэлтэй болохыг шаардаж байна. Энэ бүртгэл нь олон нийтэд ил тод, онлайн, нээлттэй өгөгдөл хэлбэртэй байх ёстой юм.

Хятадын арми дахь авлига болон Донгфенг компанийн чанаргүй автомашин Галван хөндий дэх цэргийн албан хаагчдыг үхэлд хүргэсэн⁵⁵⁰

2020.08.11. 06 дугаар сарын 15-ны шөнө 20 энэтхэг цэргийг тамлан зовоож, 40-50 хятад цэрэг алагдсан үйл явдал болсон юм. Гэвч БНХАУ яг хэдэн хятад цэргийн амь Галваны хөндийд эрсэдсэнийг дэлхийн олон нийтээс нууж байна. Хэрэв хэн нэгэн энэ талаар яривал хятадуудын зүгээс хатуу арга хэмжээ авж байна. Цзоу Лийинг гэгч Галваны хөндийд болсон явдлын талаар олон нийтийн сүлжээнд пост оруулсны дараа цагдаагийнхан түүнийг цуурхал тараасан асуудлаар баривчилжээ. Тэрээр өөрийн постонд цэргийн автомашин үйлдвэрлэгч Донгфенг компанийн чанаргүй автомашинуудын улмаас БНХАУ болон Энэтхэг улсын хоорондын хилийн зурваст болсон мөргөлдөөнд хятадын цэргүүд амь эрсэдсэн талаар нийтэлсэн. Одоогоор Хятадын арми 500 автомашиныг буцаагаад байна. Энэхүү постын дараа түүний талаар дээрх компани гомдол гаргасан ба өнгөрсөн долоо хоногт түүнийг баривчлаад байгаа аж. Цагдаагийн байгууллага түүгээр уучлалт гуйсан захидал үйлдүүлсэн байна. Энэ талаар chinamail.com цахим сайтад нийтэлжээ. Уучлалт гуйсан уг захидалд “*согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ энэ талаар пост хийсэн тул хүлээл очье*” гэжээ. Энэ нь Галваны хөндийд болсон үйл явдлын талаарх Хятадын засгийн газрын худал мэдээллийг ч илчилж буй юм. Үүнээс харахад, БНХАУ-ын засгийн газар бодит мэдээллийг өгөхгүй байгаа ч хүмүүс энэ үйл явдлын талаар мэдсэн гэж ойлгогдож байна. Энэтхэг болон БНХАУ-ын хилийн зурвас дахь хурцадмал байдлын талаарх бичлэг саяхан цахим орчимд вирус мэт тарсан. Энэхүү бичлэгт энэтхэгийн цэргүүд байшингийн цонх хагалан, Хамви нэртэй хятад хүнийг зодож байдаг. Хилийн зурвас дахь маргаантай асуудалд Энэтхэгийн арми ямар нэгэн хамааралгүй гэдгээ илэрхийлсэн. Гэвч энэхүү бичлэгт хятадын цэргийн автомашины чанар маш тод харагддаг. Хятадууд өөрсдөө ч иймэрхүү чанартай автомашин цэргүүдийн амийг аварч чадахгүй нь тодорхой харагдах ба үүнд авлигыг буруутгаж байна.

Автомашин үйлдвэрлэгч Донгфенг компанийг Хятадын армиас урвасан гэсэн нийтлэл хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд гарсаар байна. Авлигатай тэмцэж буй БНХАУ-ын хувьд энэ асуудал бол чухал юм. Батлан хамгаалах салбарын худалдан авалтын үйл ажиллагаанд авлига байгаагийн улмаас чанаргүй гангаар үйлдвэрлэсэн автомашин цэргийн албан хаагчдын аминд хүрсэн гэж үзэж байгаа юм.

Санхүүгийн зөрчил гаргасан асуудлаар тус компанийн нэгэн ажилтныг шалгаж буй талаар нэгэн цахим сайт мэдээлсэн. Гэвч тус мэдээлэлд Энэтхэг болон БНХАУ-ын хоорондын маргааны асуудлаар дурдаагүй юм. Донгфенг компанийн 2 удирдах албан хаагчийг авлигын асуудалд буруутган шалгаж буй талаар Sohu цахим сайт нийтэлсэн ба мөн л Энэтхэг, Хятадын маргаантай асуудлын талаар дурдаагүй байна.

Донгфенг мотор групп нь Хятадын төрийн оролцоотой компани юм. Тус компанитай холбоотой энэ удаагийн авлигын асуудал анхных бус юм. 2015 онд тус компанийн албан хаагчтай холбоотой авлигын асуудал мөн дэгдэж байсан. БНХАУ-ын төрийн эрхэд Ши Жинпин ирснээр авлигатай тэмцэхээ амлаж сая гаруй албан хаагчийг ажлаас нь халсан. Хэдийгээр халсан хүмүүсийн оронд тэрээр өөрийн хүмүүсийг томилсон ч энэ нь авлигыг бүрэн устгаж чадсангүй.

⁵⁵⁰ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://zeenews.india.com/world/corruption-in-chinas-army-substandard-dongfeng-military-vehicle-led-to-death-of-its-soldiers-at-galwan-valley-2301960.html>

Мөнгө угаалт, банк, криптовалютын цаана нуугдаж байгаа үнэн⁵⁵¹

2020.09.27. Өнгөрсөн долоо хоногт FinCEN файлууд гэгддэг баримтууд нийтэд дэлгэгдэж, дэлхийн зарим том банкууд террорист ажиллагааны сэжигтэн, улс орныхоо эд баялгийг хулгайлан дээрэмдсэн байж болзошгүй улс төрчид, хар тамхины наймааны сэжигтэн этгээдүүдийн дансанд их наяд долларын сэжигтэй гүйлгээ хийсэн талаар дэлгэрэнгүй мэдээлсэн. АНУ-ын засгийн газар ч уг гүйлгээг зогсоож чадаагүй байна.

Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх сүлжээ (FinCEN) нь АНУ-ын Сангийн яамны харьяа агентлаг бөгөөд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон бусад санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг хүлээж ажилладаг. “Сэжигтэй үйл ажиллагааг мэдээлэх” нь санхүүгийн авлигыг үүсгэж, засгийн газрууд үүнийг хэрхэн зогсоох боломжгүй, эсвэл хүсэхгүй байгааг харуулдаг. Хар тамхины аюулт дайны ашиг, хөгжиж буй орнуудаас завшсан хөрөнгө, Понзигийн схемээр хулгайлагдсан хуримтлалын хөрөнгө зэрэг нь банкны ажилтнуудын сэрэмжлүүлгээс үл хамааран санхүүгийн байгууллагуудаар дамжин урсдаг.

АНУ-ын хууль сахиулах байгууллагууд болон бусад улс орнуудын санхүүгийн тагнуулын албад энэ тайланг авж үзэх боломжтой.

Мөнгө угаалт нь санхүүгийн гэмт хэргээс илүү хор хохиролтой байдаг. Энэ нь хар тамхины наймаанаас авхуулаад улс төрийн гэмт хэрэг гэх мэт бусад бүх гэмт хэргийн нөхцөлийг бүрдүүлж байдаг хэрэгсэл юм. Үүнд банкууд томоохон үүрэг гүйцэтгэдэг. Одоогийн мөрдөн байцаалтын дүнгээс харахад алдартай ЖПМорган Чейз, ЭйчЭсБиСи, Стандарт Чартеред, Дойчэ банк, Банк оф Нью Йорк Меллон зэрэг банкууд бүгд гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийн дансанд мөнгө шилжүүлсэн болохыг харуулж байна.

Одоогийн санхүүгийн систем нь дийлэнхдээ банкууд болон түүний захирлуудыг эрүүгийн хэрэгт яллахаас хамгаалсан байдаг тул эрүүгийн үйл ажиллагааг дэмжих боломжийг олгодог байж болзошгүй гэсэн мэдээлэл FinCEN-д ирдэг. Сэжигтэй үйл ажиллагааг сэрэмжлүүлэхгүй бол банкны үйлчилгээг хэн бүхэн чөлөөтэй авах боломж бүрдэх юм. Тиймээс хууль бус сангууд бидний итгэж найдаж байсан банкуудаар дамжин газрын тос, соёл урлаг, үл хөдлөх хөрөнгө гэх мэт төрөл бүрийн салбаруудад хүрч, баян ядуугийн заагийг улам бүр их болгож байна.

НҮБ-ын мэдээлж байгаагаар нэг жилийн хугацаанд дэлхий даяар угаасан бохир мөнгөний тооцоолсон дүн нь дэлхийн ДНБ-ий 2-5% буюу 800 тэрбумаас 2 их наяд доллартой тэнцэж байгаа бөгөөд одоогийн байдлаар мөнгө угаалтын 90%-ийг илрүүлээгүй байна.

Үүний зэрэгцээ криптовалютын салбар нь мөнгө угаах хэрэгсэл болсон боловч харамсалтай нь статистик мэдээлэл үүний эсрэг гардаг. Криптовалютын бүх гүйлгээний зөвхөн 1.1% нь хууль бусаар хийгддэг гэсэн тооцоо байдаг. Биткойн нь эхэндээ зэвсэг, хууль бус мансууруулах бодисыг нэрээ нууцлан худалдаж авах боломжтой онлайн худалдаанд хэрэглэгддэг байсан.

Гэхдээ биткойн сүлжээний хэрэглээ улам бүр нэмэгдэж, 42 сая биткойн түрийвч хэрэглэгдэж байгаатай холбогдуулан олон нийтийн блокчэйн дэх гүйлгээг хянах боломж улам бүр нэмэгдэж байгаа бол хувийн банкны гүйлгээг ингэж хянах боломжгүй хэвээр байна.

Дэлхийг хамарсан татварын зөрчлүүд, мөнгө угаах гэмт хэрэг, авлига зэрэг нь дэлхийн ядуу иргэдэд хамгийн их хохирол учруулдаг гэж НҮБ-ын тайланд дурджээ⁵⁵²

2020.09.28. Дэлхийн улс орнуудын засгийн газар, банкууд тэгш бус байдлыг бий болгож, ард иргэдийг ядууралд унагаж буй дэлхийн санхүүгийн систем дэх татварын зөрчил, мөнгө угаах

⁵⁵¹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://www.forbes.com/sites/tatianakoffman/2020/09/27/the-hidden-truth-behind-money-laundering-banks-and-cryptocurrency/?fbclid=IwAR33UH-ueeIePa4vxEknBVpaztob-XGkETykZ727CZq9w573Lzkwsscw0MI#647461d7b37a>

⁵⁵² Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://www.riskscreen.com/kyc360/news/global-tax-abuses-money-laundering-and-corruption-take-heaviest-toll-on-the-worlds-poor-un-report-says/?fbclid=IwAR1QvM0DuqVsWqBkz9IRg9koKIPv1TtIXs2XpbSdKWNfuxkLBJ_dyhJ1Yzg

гэмт хэрэг, авлигатай тэмцэх талаар дорвитой арга хэмжээ авахгүй байна гэж НҮБ-ын дээд түвшний зөвлөл дүгнэв.

Засаг удирдаж байсан хүмүүс, Төв банкны Ерөнхийлөгч асан, бизнесийн болон иргэний нийгмийн удирдагчид, нэрт эрдэмтэн судлаачдаас бүрдсэн Олон улсын санхүүгийн хариуцлага, ил тод, ёс зүйтэй байдлын зөвлөлийн завсрын тайланд тэмдэглэснээр хуучирсан санхүүгийн хяналт нь даяаршиж, дижиталчлагдсан ертөнцөд хөл нийлүүлэн алхаж чадаагүй байна.

“Маш олон банк хоорондоо хуйвалдсан байдаг бол түүнээс дутахгүй тооны засгийн газар өнгөрсөн үедээ гацсан байна. Бид бүгдээрээ дээрэмдүүлж байна, ялангуяа дэлхийн ядуучууд” хэмээн тус зөвлөлийн дарга, Литвийн Ерөнхийлөгч асан Даля Грибаускайте мэдээндээ дурджээ.

Хөгжиж буй орнуудад өргөн тархсан хуулийн зөрчлийг шийдвэрлэхийн тулд цогц арга хэмжээ авахыг уг тайланд уриалав. Мөн КОВИД-19 нь дэлхийн тэгш бус байдлыг улам бүр нэмэгдүүлж, шинэчлэлийг нэн яаралтай хийх ёстойг сануулж байна.

“Бид тогтолцоог илүү өргөн цар хүрээтэй, бат бөх болгохын тулд шинэ, бүтээлч шийдлүүдийг судалж, эцэст нь ил тод, хариуцлагатай, ёс зүйтэй байдлыг хангах байгууллагуудын уялдаатай экосистемийг бий болгох хэрэгтэй” хэмээн уг тайланд дүгнэсэн байна.

ОУЭССК-аар ахлуулсан төслүүд, түүний дотор энэ долоо хоногийн FinCEN файлууд болон 2016 оны Панамын баримт бичиг зэрэг төслүүдээр төлөөлүүлэн “бохир мөнгийг зохицуулах системд томоохон цоорхой байгаа” тухай жишээ татав.

“Санхүүгийн ёс зүйг дэмжих хариуцлагатай, ил тод тогтолцоо бий болгоход шаардлагатай үндэсний улс төрийн тогтвортой хүсэл зоригийг бий болгодог байгууллагуудын экосистемийн чухал үүргийг сэтгүүлчид гүйцэтгэдэг” гэж уг тайланд дурджээ.

Хэдийгээр өмнө нь хууль зөрчсөн үйлдэл илчлэгдэж байсан ч шинэчлэл удаан явагдаж, эсвэл огт хийгдэхгүй байна гэж уг зөвлөл мэдээлэв.

“Томоохон банкууд бараг бүгдээрээ хэрэг төвөгт холбогдсон тул энэ салбарын нэр хүндийн төлөө санаа тавихгүй хүн байхгүй боллоо гэж үзэж болохоор байна” хэмээн тайланд дурджээ. *“Томоохон банкуудын комплаенсийн хэлтсүүд олон нийтийн дунд шуугиан үүсэхээс өмнө эрсдэлтэй гүйлгээ болон харилцагчдыг тэмдэглэж авж болох боловч анхааруулгын шинжтэй ийм үйлдлийг буруугаар ойлгож, санаатайгаар үл тоомсорлож, эсвэл банкны удирдлага хүлээн зөвшөөрөхгүй байж болзошгүй”* юм.

Корпорацын ашгийг шилжүүлсний улмаас засгийн газрууд жилд 500 тэрбум доллар алдаж, 7 их наяд долларын хувийн өмч баялгийг татвараас бултуулсан, дэлхийн ДНБ-ий 10% орчим нь оффшор бүсэд байршиж, жил бүр 1.6 их наяд долларын бохир мөнгийг угаасан байдаг тухай уг тайланд дурджээ.


Авлига болон авлигатай тэмцэх үйл ажиллагааны чиг хандлагаас бид юу суралцав?⁵⁵³

2020.10.30. Jim Anderson. Авлига нь хор хөнөөлтэй, хөрөнгө оруулалтыг бууруулж, ядуурлыг улам даамжруулдаг гэсэн ерөнхий санал нэг байгаа ч үүнд үнэхээр ямар нэгэн зүйл хийж болох уу? Өнгөрсөн сард ДБ-наас гаргасан “Засгийн газрын үр нөлөөт, ил тод байдлыг нэмэгдүүлэх: Авлигатай тэмцэх нь” хэмээх тайланд авлигыг хязгаарлах янз бүрийн арга хэрэгсэл, салбарын хандлагын нарийвчилсан судалгааг харуулсан. Авлигыг хорт хавдар гэж тодорхойлсон илтгэл тавигдсанаас хойш хорин дөрвөн жил өнгөрсний дараа авлигын тухай ойлголт хэрхэн өөрчлөгдсөн бэ?

Энэхүү тайланд дурдсанаар авлигыг хянах бодлого болон энэ чиглэлийн байгууллагуудын тухайд ихээхэн ахиц дэвшил гарсан байна. Засгийн газрын мэдээллийг олон нийтийн хүртээл болгох ба нээлттэй байдлыг дэмжих нь түгээмэл болсон. Мэдээлэл авах эрхийн тухай хуулийг мөрдөж буй улс орнуудын тоо нэмэгдэж, хуулийн чанар сайжран, технологи хөгжсөнөөр

⁵⁵³ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://blogs.worldbank.org/governance/what-can-we-learn-trends-corruption-and-anticorruption>

мэдээлэл авах боломж улам бүр хялбар болсон. Олборлох салбараас эхлээд зохицуулалтын үйл явц хүртэлх олон салбарт ил тод байдлын олон улсын стандарт үйлчилж байна.



Хариуцлагын тогтолцоо бас хүчтэй байдаг. Төрийн албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлэг авах явдал түгээмэл байдаг бөгөөд ихэнхдээ уг мэдээлэл олон нийтэд нээлттэй байх нь өмнөх үетэй харьцуулахад нэмэгдсэн бөгөөд зарим улс дээрх мэдээллийг мэдүүлэх, баталгаажуулахдаа цахим системийг ашигладаг болжээ. Технологийн дэвшил нь төрийн санхүүгийн менежментийг бэхжүүлэх, үр бүтээлгүй ажиллагчдыг хязгаарлах, дэд бүтцийн төслүүдийн хяналтыг сайжруулах, төрийн худалдан авах ажиллагааны ил тод байдал, үр ашгийг бэхжүүлэхэд тусалж байна.

Авлигын тухай бидний ойлголтод ч ахиц гарсан. Олон асуудлаар маргаан байгаа боловч АЭНҮБК-ыг мөрдөх, гадаадын албан тушаалтны хахуулийн тухай хууль тогтоомжийг батлах, жинхэнэ эзнийг ил тод байлгах хэрэгцээ шаардлагыг хүлээн зөвшөөрөх зэрэг асуудалд олон улсын зөвшилцөлд хүрсэн нь харагдаж байна.


Гэхдээ дээрх хөгжил дэвшлийн улмаас авлига доод түвшинд хүрч буурсан уу?

Авлигын шинж чанар болон авлигын янз бүрийн хэлбэрээс шалтгаалан энэ асуултад хариулт өгөхөд бэрхшээлтэй болдог.

Авлигын эсрэг хэрэгжүүлж буй арга хэмжээ янз бүр байдаг боловч эдгээрээс маш цөөхөн нь тухайн нөхцөл байдалд тохирсон байдаг. Энэхүү тайланд хэт нэг талыг баримталсан байж болох шинжээчдийн үнэлгээ, авлигын зарим ерөнхий ойлголт, эсвэл чиг хандлагын талаар голчлон судалсан судалгааг багтаахаас зайлсхийсэн. Авлигын мөн чанарыг ойлгож мэдэх нь тустай ба үүний зэрэгцээ бодит туршлагыг судлах нь мөн чухал ач холбогдолтой.

Авлигатай тэмцэх үйл ажиллагааны туршлагыг цаг хугацааны хувьд харьцуулах боломжийг олгосон системтэй арга замаар мэдээлэл цуглуулдаг системийн нэг нь ДБ-ны аж ахуйн нэгжийн судалгаа (WBES) юм. Энэхүү судалгаанд өргөн хүрээтэй асуудал хамрагддаг бөгөөд зохистой түүвэрлэлтэд ихээхэн анхаарал хандуулдаг онцлогтой. Сайн мэдээлэл хямд олддоггүй тул судалгааны цаг хугацаа, зардлаас шалтгаалан дээрх судалгааг тогтсон хугацаанд давтамжтайгаар гүйцэтгэдэг боловч хамруулж буй улс орныг өөрчилж байдаг юм.

Энэ зуны байдлаар 2006 оноос хойш 96 улс орноос дор хаяж хоёр удаа судалгаа авсан гэсэн статистик гарсан. Авлигын чиг хандлагыг ойлгоход хамгийн хэрэгтэй асуудал гэж үзээд татвар, худалдан авалттай холбоотой албан бус төлбөр (“бэлэг” гэх мэт)-ийг судлав. Энэ хоёр асуудлын дундаж хандлага улс орнуудад бараг ижил байв. Ихэнх улс орны хувьд авлигын улмаас бизнес эрхлэхэд ихээхэн бэрхшээл тулгардаг гэж үзсэн аж ахуйн нэгж, байгууллага цөөн байсан.



Дээрх чиг хандлага нь судалгаанд хамрагдсан захиргааны авлигыг зөвхөн тусгасан байна. Төрийг удирдах, их хэмжээний мөнгө шамшигдуулах, нарийн сүлжээ энд тусгагдаагүй. Гэвч зарим ахиц дэвшил гарч байгаа нь харагдаж байна.

Гэсэн хэдий ч, авлига бэрхшээлтэй асуудал хэвээр байна. Захиргааны авлигыг бууруулах дундаж хандлага зөв чиглэлд байсан хэдий ч улс орон бүрийн хувьд энэ хандлага хадгалагдахгүй байна. Дээрх судалгаанд багтсан улс орнуудын гуравны нэгд нь хахууль өгсөн гэж мэдээлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудын хувь өсжээ. Авлигатай тэмцэх бодлого, түүнийг хэрэгжүүлэгч байгууллагуудыг бэхжүүлэх хүчин чармайлтыг ёс зүйгүй албан тушаалтан, бизнес эрхлэгчид замхруулдаг бөгөөд авлигын томоохон дуулиан шуугиан өдөр бүр гарсаар байна.

КОВИД-19 цар тахлын эсрэг яаралтай хариу арга хэмжээ авж буй өнөөгийн нөхцөлд байдал улам бүр дордож, ил тод, нээлттэй байдал алдагдах эрсдэл их байна. КОВИД-19-ээс өмнө ч олон улс оронд иргэний нийгмийн орон зай хумигдаж, эрх баригчдын зохисгүй үйлдэл гарч байсан.

Гэхдээ авлигатай тэмцэх үйл ажиллагаанд хийгдэх шинэчлэл амжилттай хэрэгжиж болохыг мэдэж байгаа нь урам зориг өгч, энэхүү судалгаанд багтсан жишээг илүү гүнзгий судлах хэрэгтэй болж байна. Хэдийгээр, тухайлсан нэг жишээ нь аль нэг улс орны нөхцөл байдалд хамаарах боловч засгийн газар болон иргэний нийгмийн шинэчлэлтэй холбогдуулан авлигатай тэмцэх тухайд анхаарлаа төвлөрүүлэхэд туслах болно. Энэ утгаараа уг тайланг загварчилсан гэж хэлж болно.

Амжилттай жишээг анхаарах нь зарим хүмүүс нөхцөл байдалыг судлахгүйгээр, уг хандлагыг гэнэн байдлаар дуурайх эрсдэл үүсгэдэг. Аливаа арга хандлагыг амжилтад хүргэсэн шалтгаан, нөхцөл байдлыг эрэлхийлж, тайлбарлахыг энэхүү судалгаа эрмэлзсэн. Уг судалгаа нь загварчлан хийгдсэн ажил боловч хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалт биш юм.

Авлига нь хөгжил дэвшил, шударга ёсны саад тотгор болсоор байгаа боловч үүнийг хязгаарлах арга хэмжээ авах боломжтой бөгөөд энэ нь олон улс орны жишээгээр харагдаж байна.

Судалгааны тайланг татах: https://documents.worldbank.org/en/publication/documents-reports/documentdetail/235541600116631094/enhancing-government-effectiveness-and-transparency-the-fight-against-corruption?cid=gov_tt_gov_en_ext

Корпорацийн авлигын талаар судалгаа хийх шаардлага их байна⁵⁵⁴

2020.11.05. Armando Castro, Nelson Phillips. Сүүлийн арван жилд корпорацийн авлигын хэргүүдийн дуулиан тасралтгүй гарч байна. Гэвч авлигын талаарх ихэнх судалгаанууд төрийн байгууллагын үйл ажиллагаанд чиглэсэн байдаг. Сүүлийн үед хийгдсэн нэгэн шинэ судалгаагаар корпорациудын авлигын талаарх судалгааг нэгтгэж, илүү их анхаарал хандуулах шаардлагатай байгаа чиглэлийг тодорхойлсон байна.

Корпорацийн авлига нь бизнест итгэх итгэлийг бууруулж, өрсөлдөөнт зах зээлийн хэвийн ажиллагаанд саад учруулж болзошгүй, шийдвэрлэгдээгүй асуудал болсоор байна. Сүүлийн хэдэн жилд Airbus, Goldman Sachs, McKinsey, Novartis, Siemens, Rolls Royce зэрэг корпорацийн удирдлага авлигын хэрэгт холбоотой болохыг олж илрүүлсэн. Энэ бүгдээс дүгнэхэд сүүлийн үед корпорацийн авлигаас урьдчилан сэргийлэх тухайд ахиц бага гарсан боловч харин ийм хэргийг илрүүлэхэд ахиц дэвшил илүү сайн гарсан байна.

КОВИД-19 цар тахлын үр дагавар болон түүнээс үүдсэн эдийн засгийн хямралтай холбоотойгоор авлигын хэргүүд цаашид илэрч, томоохон дуулиан дэгдэж болзошгүй гэж бид үзэж байна. Уоррен Баффет 2001 онд Berkshire Hathaway корпорацийн хувьцаа эзэмшигчдэд зориулан илгээсэн захидалдаа дурдсанаар “Далайн түрлэг татрах үед л хэн нүцгэн сэлж байгааг олж мэдэж болно”. Эдийн засаг сайн байх үед бизнесийн хүрээний зохисгүй үйлдлийг нуун дарагдуулах боломж их байдаг. Тухайлбал, авлигач удирдлага өөрсдийн ёс зүйгүй үйлдлээ нуухад нь эдийн засгийн нөхцөл байдал тус болж байдаг. Харин эдийн засгийн уналт, эдийн засгийн удаашрал зэрэг нь уг зохисгүй үйлдлийг илрүүлэн гаргах боломжийг олгож байдаг. Жишээлбэл, 2008 оны санхүүгийн хямралын үр дүнд Madoff-ын хөрөнгө оруулалтын шуугианыг илрүүлэх боломж бүрдсэн байдаг. Үнэхээр ч сүүлийн 20 жилийн хугацаанд гарсан корпорацийн авлигын хамгийн том дуулианыг эдийн засгийн уналтын дараа бүгд мэдсэн байдаг. Үүний нэг жишээ нь Enron, WorldCom корпорациудын хэрэг юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээлэл төдийгүй судалгаа шинжилгээний ажилд ч төрийн байгууллагын үйл ажиллагааны авлигыг илүү их анхаарсан байдаг. Европын Зөвлөлийн 2017 оны тайланд “ЕХ-ны бизнес эрхлэгчдийн 37%-д авлигын улмаас бэрхшээл тулгарсан” гэж дурдсан.

ДБ-ны мэдэгдсэнээр “аливаа бизнесийн үйл ажиллагааг авлигын түвшин багатай улсаас авлигын түвшин дунд, эсвэл авлига өндөртэй улс руу шилжүүлэхэд авлигын үр нөлөө нь 20 хувийн татвар ногдуулж байгаатай дүйцэхүйц болох нь тогтоогджээ”. Гэхдээ түгээмэл ажиглагддаг нэг асуудал бол ёс зүй муутай корпораци авлигыг хүлээн зөвшөөрөхөд бэлэн байдаг явдал юм. Европын Зөвлөлөөс 2014 онд бизнес эрхлэгчдийн дунд явуулсан судалгаагаар 60% нь хахууль өгөх болон танилын харилцааг ашиглавал төрийн зарим үйлчилгээг авахад илүү хялбар болдог гэж хариулжээ. Тиймээс бодит байдал дээр авлига нь ихэнхдээ төсөөлж байгаагаас ч илүү төвөгтэй байдаг.

Энэхүү судалгаагаар бизнес дэх авлигын талаар одоогоор хийгдсэн судалгааны ажлуудыг нэгтгэн дүгнэж, корпорацийн авлигыг тусдаа нэг төрлийн авлига гэж хүлээн зөвшөөрч, цаашид судлах хэрэгтэй гэж үзсэн. Иймээс корпорацийн авлигыг “корпорацийн төлөөлөл болсон, эсвэл корпорацийн үр өгөөжийг хүртэгч албан тушаалтан өөрийн эрх мэдлийг зохисгүй байдлаар ашиглах явдал юм” гэж тодорхойлж, авж үзсэн.

Холбогдох судалгааны ажилд үндэслэн корпорацийн авлигын дөрвөн үндсэн хандлагыг тодорхойлсон. Үүнд: 1) авлигыг үүссэн нөхцөл байдлын хувьд хамгийн зохистой шийдэл гэж үзэх хандлага; 2) авлигыг тогтсон практик гэж үзэх хандлага; 3) авлигыг соёлын хэм хэмжээ гэж үзэх хандлага; 4) авлигыг ёс зүйн алдаатай үйлдэл гэж үзэх хандлага.

Бизнесийн сургуулийн судлаачид корпорацийн талаар гүн гүнзгий мэдлэгээ ашиглан корпорацийн авлигын талаарх ойлголтыг боловсруулвал зохицуулах байгууллагууд, корпорацийн удирдлагууд болон корпорацийн авлигын асуудлыг шийдвэрлэхийг зорьж буй бусад хүмүүст ач холбогдолтой

⁵⁵⁴ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://promarket.org/2020/11/05/need-research-corporate-corruption-firms-entrepreneurship/?fbclid=IwAR2Mz-ZGrI3MqLTvbV_x2v1hSHei4gUmb5-Umpq_380ocqDGRbI-BKu3gFs

байх болно гэж энэхүү судалгаанд дүгнэсэн байна. Тиймээс корпорацийн авлигын талаарх ойлголтыг бий болгохын тулд дээрх сэдвийг судлах нь нэн чухал юм.

Авлигын талаарх сүүлийн үеийн судалгаануудын үр дүнд авлигын шалтгаан, түүнээс урьдчилан сэргийлэх асуудалд чиглэгдсэн байдаг. Үүний зэрэгцээ одоо хийгдэж буй судалгаанууд засгийн газрын авлигын асуудалд төвлөрч байна. Төрийн байгууллага дахь авлигын судалгааны ихэнх нь авлигад өртөж байгаа үйл ажиллагааг илүү хялбаршуулах, төрийн албан тушаалтанд зохисгүй урамшуулал олгох, эсвэл төр, хувийн хэвшлийн хоорондох хил хязгаарыг ямар нэгэн байдлаар ашиг олох зорилгоор ашиглах асуудалд чиглэгддэг. Харин эдгээр төрлийн авлигыг судлахдаа корпорацийн удирдлагын оролцох оролцоонд анхаарал хандуулдаггүй.

Цаашилбал, авлигын томоохон тохиолдлууд том, жижиг аль аль нь пүүсүүдийн дотор болон тэдгээрийн хооронд гардаг. Тиймээс корпорациуд дахь авлигын асуудалд анхаарлаа хандуулах нь засгийн газрын авлигатай тэмцэх ажлыг нөхөх, авлигыг ерөнхийд нь ойлгох чухал хэтийн төлөв юм. Тиймээс аж ахуйн нэгжийн авлигын асуудалд анхаарлаа төвлөрүүлэх нь онцгой чухал бөгөөд засгийн газар болон корпорацийн авлига хоёулаа эрх мэдэл, албан тушаал бүхий хүмүүсийг эрх мэдлээ хэтрүүлэн ашигласан хэрэгт татан оролцуулдаг тул хүчирхийлэл үйлдэгдэж буй нөхцөл байдал үндсэндээ өөр өөр байдаг.

Корпорацийн авлигын хэргүүд дийлэнхдээ том, жижиг корпорациудын дотоодод, эсвэл тэдгээрийн хооронд гарсан байдаг. Тиймээс корпорацийн авлигын асуудалд анхаарлаа хандуулахын тулд авлигын тухай ерөнхий ойлголтыг тодорхойлж, тэр дундаа төрийн байгууллага дахь авлигатай тэмцэх ажлыг ойлгож мэдэх хэрэгтэй. Корпорацийн болон төрийн байгууллагын аль алиных нь хувьд авлига нь албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглаж байгаа явдал юм.

Төрийн үйл ажиллагаа нь байгууллагын соёл, цалин урамшууллын систем, засаглал, логикийн хувьд корпорациас ялгаатай байдаг тул авлигын боломж, авлигад автсан шийдвэр гаргах байдал, авлигын практик зэрэг нь эрс ялгаатай байдаг. Корпорац өрсөлдөөний дарамттай тулгардаг бөгөөд энэ нь удирдах албан тушаалтнууд хахууль авахад нөлөөлж болзошгүй юм. Хүчтэй өрсөлдөөний улмаас корпорац өрсөлдөгчдөө ялах зорилгоор авлигыг дэмждэг.

Эцэст нь дүгнэхэд корпорацийн авлига нь бизнесийн байгууллагууд, тэдгээрийн хөрөнгө оруулагчид, төр засагт туйлын сөрөг нөлөөтэй байдаг тул энэ нь нийгэмд шууд нөлөө үзүүлж болох томоохон асуудал юм. Корпорацийн авлигыг төрийн байгууллага дахь авлигатай адилхан авж үзэх ёстой боловч корпорацийн онцлогоос шалтгаалан ихээхэн ялгаатай байж болох бөгөөд улмаар үүнд засгийн газрын авлигатай тэмцэх арга замыг ашиглахад тохиромжгүй байж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

Голдман Сакс ба эдийн засагт үзүүлэх авлигын нөлөөлөл⁵⁵⁵

2020.11.11. Michael Volkov. АНУ-ын Хууль зүйн яам, Үнэт цаас, биржийн хорооноос гаргасан ГАҮАТХ-ийн дагуу авж үзвэл Голдман Сакс корпорацийн авлигын асуудал нь авлигыг бууруулах чухал зорилтыг эргэн сануулсан. Авлига нь эмзэг эдийн засгийн хөгжилд хор хөнөөлтэй нөлөө үзүүлж, олон мянган гэмгүй энгийн иргэдэд хор хохирол учруулж байгаа нь мэдээжийн хэрэг юм. Энэхүү хор хөнөөлийг хөгжиж буй орнуудад үүсэж буй хүндрэл бэрхшээлийн цар хүрээгээр илэрхийлдэг.

Улс төр, эдийн засгийн авлига нь засгийн газрын зүгээс хязгаарлагдмал нөөцийг ард иргэдийн ашиг тусын тулд хуваарилж буй хуваарилалтад саад учруулдаг. Зохих шалгуурыг хангаагүй корпорациуд хахууль өгөх замаар засгийн газартай гэрээ байгуулдаг. Авлигын улмаас эдийн засгийн хөгжлийг дэмжих зах зээлийн хүчин зүйлийн ажиллагаа алдагддаг тул хувийн бизнес эрхлэгчид үнэтэй хөрөнгө оруулалт, эдийн засгийн боломжоо алддаг. Эцэст нь эдгээр бүх хүч нэгдэж, төрийн чухал байгууллагуудыг доройтуулж, улмаар амьдралын түвшин буурдаг.

⁵⁵⁵ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://www.jdsupra.com/legalnews/goldman-sachs-and-the-economic-impact-67866/?fbclid=IwAR1eI_4UjF4TSPNuLnIZF95nd5SPatMfgw9GAeaWXuSzmqcZC4YQXTeYwQ

ДБ-ны тооцооллоор авлига ихтэй орнуудын дундаж орлого авлигын түвшин багатай орнуудын дундаж орлогын гуравны нэг орчим болж байна. Ийм улс орнуудад нялхсын эндэгдэл ойролцоогоор 3 дахин их, бичиг үсэг тайлагдсан иргэдийн харьцаа 25%-аар бага байна.

Авлигад идэгдсэн улс орнууд авлигын түвшин багатай улсуудтай харьцуулахад гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ бага байдаг. Хөрөнгө оруулагчид өндөр эрсдэлтэй, авлигад автсан орнуудад хөрөнгө оруулах дургүй байдаг.

Хөгжиж буй эдийн засагтай улс орнууд дийлэнхдээ авлигад нэрвэгдэж, эдийн засгийн хөгжил удааширсан байдаг. Авлигын нөлөөгөөр аливаа нөөц үр ашиггүй байдлаар хуваарилагдаж, зах зээлийн харилцаанд бэрхшээл гарч, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар мууддаг.

Малайз улсын эдийн засаг сүүлийн арван жилд тасралтгүй өсөж, 2010 оноос хойш дунджаар 5.4%-ийн өсөлттэй байна. Малайз хөдөө аж ахуй, түүхий эдэд суурилсан эдийн засгаас үйлдвэрлэл, үйлчилгээнд суурилсан эдийн засагт шилжиж байгаа. Малайз улс одоогоор цахилгаан хэрэгсэл, электроникийн эд ангийн экспортоор тэргүүлэгч улс болжээ.

Тус улсад орлогын тэгш бус байдал тулгамдсан асуудал хэвээр байна. Иргэдийнх нь 40% нь хүн амын 60%-тай тэнцэх хэмжээний ашиг орлого олж чаддаггүй ажээ. Малайз улс нь ажилах хүчний эрүүл мэнд, хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэхийн тулд боловсрол, эрүүл мэнд, хоол тэжээлийг анхаардаг.

Голдман Сакс корпорацийн шуугиантай холбогдуулан тус улсын анхны удирдагч авлигын хэргээр ял авсны улмаас Малайзад авлигыг ихээхэн анхаарах болжээ.

Ерөнхий сайд асан Нажиб Разак 2009 оноос 2018 он хүртэл ажиллахдаа Малайз улсын баялгийн сан (1MDB)-гаас хөрөнгө шамшигдуулсан хэрэгт буруутгагдсан. Түүний үйлдсэн хэргийн улмаас ноён Нажиб болон Малайз улс Их Британиас тусгаар тогтносон цагаас эхлэн 61 жилийн турш тус улсыг удирдаж байсан түүний эрх баригч намаас Малайзын ард түмэн татгалзсан юм.

Энэхүү авлигын хэргийн гол буруутан нь Голдман Сакс корпораци байв. Уг хэргийг Голдман Сакс корпорацийн хуучин удирдлагууд, Малайз болон Абу Дабигийн засгийн газрын албан тушаалтнууд гүйцэтгэж, Малайзын баялгийн сангаас 6.5 тэрбум гаруй долларын хөрөнгө хулгайлжээ.

Малайз улс 2018 оноос хойш эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлж эхэлсэн. 2019 онд тус улс авлигын индексийн хамгийн өндөр буюу 53 оноо авсан. Малайз улс авлигатай тэмцэх агентлаг байгуулж, засгийн газрын шударга байдлыг нэмэгдүүлэх таван жилийн зорилт дэвшүүлжээ. Үүний хүрээнд 1,500 орчим хүн авлигын хэрэгт холбогдсон байна.

[Дэлхий дахинаараа сэргээгдэх эрчим хүч рүү шилжихэд авлига саад болж байна⁵⁵⁶](#)

2020.12.03. Maurice Oniango. Авлига нь цаг уурын нөхцөл байдлыг сайжруулахын тулд хэрэгжүүлж байгаа арга хэмжээнд хамгийн их заналхийлж, дэлхийн хэмжээнд нүүрс зэрэг чулуужсан түлшээс сэргээгдэх эрчим хүч рүү шилжихэд саад болж байна.

Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн (NRGI) зөвлөх Александра Гиллисийн хэлснээр ашигт малтмалын түлш үйлдвэрлэгч компаниуд болон үйлдвэрлэгч орнуудын засгийн газрууд олон арван жилийн турш үүнээс ашиг хүртсэн хэр нь ашигт малтмалын түлшнээс татгалзах хүчин чармайлтад саад учруулсаар байна.

Тэрээр Олон улсын авлигын эсрэг 19 дүгээр чуулганы “Climate Action: Time for Integrity” хэсэгт оролцож үг хэлэхдээ: “*Эрх мэдэл, эд хөрөнгөөр өөрсдийн ашиг сонирхлоо хамгаалах гэсэн зарим хүмүүсийн явцуу сонирхол цаг уурын өөрчлөлтийг шийдвэрлэх дэлхий нийтийн хүчин чармайлттай зөрчилдөж магадгүй юм*” гэжээ.

Цаг уурын талаарх бодлогод ашиг сонирхол хэрхэн нөлөөлж байна вэ?

Үүний цаана олон улсын (хувийн) нефтийн компаниуд, газрын тосоор баялаг нөөцтэй орны засгийн газрууд, үндэсний газрын тосны компаниуд гэсэн гурван үндсэн буруутан бий гэж

⁵⁵⁶ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://iacccseries.org/blog/corruption-is-hindering-the-global-transition-to-renewable-energy/>

Гиллис үзэж буй бөгөөд эдгээр нь эдийн засгийн ашиг сонирхлоо нэмэгдүүлэхийн тулд хууль ёсны хийгээд хууль бус аргуудыг аль алиныг нь ашигладаг байна. Тэд хандивын кампанит ажил, лоббидох гэх мэт янз бүрийн аргаар зохисгүй нөлөөг бий болгодог ба тэдний олон арга техник саарал бүсэд хамаардаг учир зарим шүүхийн өмнө хууль ёсны байж ч болзошгүй юм.

Газрын тосны зах зээлийн хөгжил нь чулуужсан түлшний салбар дахь лоббитой холбоотой авлигыг өдөөж болохыг Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн төлөөлөгч онцлон тэмдэглээд: “Ялангуяа үнэ огцом унасан үед авлига маш олон төрөлтэй болж байна. Хямрал цохрол, эдийн засгийн хүнд хэцүү цаг үе өөрөө авлигын элдэв янзын төрлүүдийг өдөөдөг” гэжээ.

Газрын тос, байгалийн хийн компаниудын улс төрийн хөндлөнгийн оролцоо нь уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах чиглэлээр явуулж буй байгууллага хийгээд засаглалын үйл ажиллагааны явцыг сулруулж байгаа тул тэд санхүүжилтийн хомсдолтой тэмцэхийн зэрэгцээ бодлого, зохицуулалт дахь эдгээр нөлөөлөлтэй ч тэмцэх шаардлагатай болж байгаа аж.

Тогтвортой хөгжлийн олон улсын хүрээлэнгээс гаргасан тайланд дурдсанаар, чулуужсан түлшний салбар жилд 370 тэрбум гаруй долларын дэмжлэг авдаг бол сэргээгдэх эрчим хүч 100 тэрбум долларын дэмжлэг авдаг ажээ. 2016 оны 11 дүгээр сард Парисын хэлэлцээрт гарын үсэг зурснаас хойш хоёр жилийн хугацаанд ашигт малтмалын түлшинд дэлхийн 33 том банк нийт 1.9 их наяд гаруй долларын санхүүжилт хийснийг ДЭЗФ-аас мэдээлсэн байна.

КОВИД-19 - уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд хамтрах уу?

Засгийн газраас явуулж буй КОВИД-19-ийн хямралын хариу арга хэмжээ нь мөн уур амьсгалын өөрчлөлтөд эерэг нөлөө үзүүлж байх шиг байна. Коронавирусний цар тахлын үед засгийн газрууд вирусний эсрэг арга хэмжээ авж байх үеэр хүлэмжийн хийн ялгаралт түр зуур буурсан тухай Дэлхийн нүүрстөрөгчийн төсөл (GCP) мэдээлжээ. Гэсэн хэдий ч энэ хямралын дараах засгийн газрын үйл ажиллагаа, эдийн засгийн хөшүүргүүд дэлхийн хүлэмжийн хийн ялгаруулалтад хэдэн арван жилийн туршид нөлөөлөх магадлалтайг Дэлхийн нүүрстөрөгчийн төсөл анхааруулж байгаа юм. 2019 онд цэвэр эрчим хүчний хөгжилд гайхалтай ахиц дэвшил гарсан хэдий ч дэлхийн чулуужсан түлшний эргэлтийн хэмжээ нэмэгдсэнийг харгалзан үзвэл энэхүү нөлөөллийн чиглэл тодорхойгүй байгаа юм.

Ил тод гэрээ, хүртээмжтэй мэдээлэл

Гиллисийн хэлснээр, чулуужсан түлшнээс амжилттай ангижрахын тулд илүү ил тод байдал шаардагдаж байна. Ялангуяа, төлбөр, гэрээний ил тод байдал нь сэргээгдэх эрчим хүчинд шилжихэд саад учруулж буй авлигатай тэмцэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Ингэснээр хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах боломж нэмэгддэг байна. Ил тод бус бодлого нь ихэвчлэн нууцлал, засгийн газрын үйл ажиллагааны талаар мэдээлэл олж авах боломжгүйгээс үүдэлтэй байдаг. Чулуужсан түлштэй холбоотой ашиг сонирхлын зүй бус нөлөөллийг бодлого, шийдвэрт тусгахгүйн тулд холбогдох мэдээлэл олон нийтэд нээлттэй байх ёстой.

Цар тахлын үеийн авлига⁵⁵⁷

2021.01.28. ТИ байгууллагаас 2020 оны АТИ-ийг танилцуулсан байна.

Дэлхий нийтээрээ КОВИД-19 цар тахлын нөхцөлд амьдарч буй 2020 онд авлига улам бүр даамжирчээ. Авлига зөвхөн “коронавирустэй хийж буй дэлхий дахины тэмцэлд аюул учруулаад зогссонгүй, ардчиллын хямрал гүнзгийрэхэд ч нөлөөлсөөр байна”. Уг дүгнэлтийг олон улсын ТИ байгууллага АТИ-ийн талаарх тайландаа дурджээ.

ТИ байгууллагаас жил бүр АТИ-ийг танилцуулдаг бөгөөд энэ удаа уламжлал ёсоор олон орны төрийн салбар дахь авлигын түвшинд шинжилгээ хийжээ. Дэлхий дахины 2020 оны нөхцөл байдлыг тооцон үзсэний эцэст ТИ байгууллагын шинжээчид эрүүл мэндийн тогтолцоонд үзүүлэх авлигын нөлөөлөл, олон улс орон дахь хямралын нөхцөл байдалтай хийж буй тэмцэлд уг нөлөөний үзүүлэх үр дагаврыг судалсан байна.

Улс оронд авлига хэдий чинээ бага байна, цар тахалтай хийх тэмцэл төдий хэрээр үр дүнтэй байгаа аж.

⁵⁵⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://www.kommersant.ru/doc/4663780>

АТИ-ийг өмнөх оны адил 180 орны төрийн салбарын авлигын төсөөллийн хэмжээг шинжээчид болон бизнес эрхлэгчдийн үнэлгээнд тулгуурлан гаргасан байна. Үр дүнг 0-100 оноогоор үнэлжээ. Оноо өндөр байх тусам авлигын түвшин доогуур байгааг илтгэнэ. 2020 оны индексэд хамрагдсан улс орнуудын гуравны хоёр нь 50-аас бага оноотой байсан тул дундаж оноог 43 гэж ТИ тэмдэглэсэн байна. Сүүлийн арван жилийн хугацаанд олон тооны улс орнуудын авлигын нөхцөл байдал мууджээ.

Индексийн эхний 10 байрт уламжлал ёсоор ЕХ, Баруун Европын орнууд жагссан байна.


- 2020 онд Дани болон Шинэ Зеланд улс 88 оноогоор тэргүүлжээ.
- Финланд, Сингапур, Швед, Швейцари тус бүр 85 оноо авж удаалсан байна.
- Норвеги, Нидерланд, Герман, Люксембург улсууд эхний аравт багтжээ.

АНУ 67 оноо авж, 25 дугаар байрт жагссан бөгөөд энэ нь тус улсын хувьд уг индексийг тооцож эхэлснээс хойших хугацаанд авж буй хамгийн бага оноо болохыг ТИ дурджээ. АНУ 2017 онд 75, 2018 онд 71, 2019 онд 69 оноо тус тус авж байжээ. Хятад улс мэдэгдэхүйц урагшилж, 2014 онд 36 оноотой байснаа 2020 онд 42 оноо авсан байна. Сомали, Өмнөд Судан улсууд 12 оноогоор индексийн 179 дүгээр байрт бичигджээ.

ОХУ 30 оноо авж, Азербайжан, Габон, Малави, Мали улстай зэрэгцэн 129 дүгээр байрт оржээ. 2018, 2019 онд тус бүр 28 оноогоор 138, 137 дугаар байрт орж байжээ. Тус улсад 2020 онд болсон үнэлгээнд нөлөөлөхүйц үйл явдлын ихэнх нь энэ удаагийн индексэд тооцогдоогүй бөгөөд үндсэндээ 2019 оны ихэнх баримт, мэдээллийг ашигласан талаар тайлан боловсруулагчид дурдсан байна.

ОХУ авлигын индексээр бага оноо авсан нь “Авлигатай тэмцэх нэгдсэн бодлого, тогтолцоо байхгүй”, “хууль тогтоомжийн холбогдох хэсэгт өөрчлөлт ордог” зэрэгтэй холбоотой болохыг ТИ дурджээ.

АТИ болон КОВИД-19 цар тахалтай хийж буй тэмцлийн үр дүн харилцан хамааралтай болохыг тогтоосон бөгөөд авлига бага байх нь эрүүл мэндийн салбарт илүү их хөрөнгө оруулалт хийх, мөнгөн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах боломжийг олгож байна.



Латин Америкийн орнуудаас хамгийн өндөр 71 оноо авж, 21 дүгээр байрт орсон Уругвай улсыг ТИ-ийн шинжээчид жишээ болгон дурдсан. Тус улсад “Эрүүл мэндийн салбартаа ихээхэн хэмжээний хөрөнгө оруулалт татаж, халдвар судлалын найдвартай тогтолцоо бүрдүүлэн” КОВИД-19 төдийгүй Зика вирус, шар халуурал зэрэг өвчинтэй үр дүнтэй тэмцэх боломжийг олгосон байна.

Үүний эсрэг, сөрөг жишээнд Бангладеш, АНУ-ыг тайлан боловсруулагчид багтаасан байна.

Бангладеш улсад “Цар тахлын нөхцөлд эмнэлгүүд хахуульд автахаас эхлээд хүмүүнлэгийн тусламжийг завших, эрүүл мэндийн салбар дахь худалдан авах үйл ажиллагаагаар дамжуулан хулгайлах зэргээр авлига үлэмж хэмжээгээр нэмэгдэж” байна. Эдгээр нь өвчлөлийн нөхцөлд

сөргөөр нөлөөлж байна. Тус улсад КОВИД-19 цар тахлаар өвчлөгчдийн тоо хагас саяд хүрч, нас барагчид 8 мянгыг давжээ.

АНУ-ын хувьд “Дээд түвшний авлига, ашиг сонирхлын зөрчил, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах байдал”, түүнчлэн КОВИД-19 цар тахалтай тэмцэхэд зориулсан 1 их наяд ам.долларын зарцуулалтын хяналт сул байгаа зэргийг ТИ онцолсон байна. Эдгээр нь “Засгийн газартаа хариуцлага тооцох, ардчиллыг мөхөөн ухрааж, нийгэмд тайван бус байдал үүсэхэд” хүргэж байна гэж шинжээчид үзжээ.

Эмзэг улсууд дахь авлига: АТИ-ийн илэрхийлж чаддаггүй зүйлс⁵⁵⁸

2021.02. Timipere Allison. АТИ нь улс орнуудын авлигын түвшнийг хэмжих хамгийн чухал хэмжүүр хэвээр байна. Гэсэн хэдий ч энэхүү индексийн арга зүй болон хөгжиж буй орнуудын гадаадын хөрөнгө оруулалт, тусламжийг татах чадварт учруулж буй сөрөг үр дагавар хүчтэй шүүмжлэлд өртөж байна. Энэхүү өгүүлэлд Нигери дэх авлигын талаарх зохиогчийн докторын судалгааны ажлын үзэл санааг илэрхийлсэн болно. Уг өгүүлэлээр АТИ-ийн өөр нэг дутагдалтай тал болох авлига ихтэй, эмзэг улс орнуудын авлигатай хийж буй тэмцлийн талаар юу ч илрүүлж, харуулдаггүй тухай асуудал дээр анхаарлаа хандуулж байгаа юм. Засаг захиргаа, улс төрийн тогтвортой байдлаа хадгалахад учирдаг сөрөг үр дагавраас шалтгаалан эдгээр улс орнуудын авлигатай тэмцэх хүчин чармайлт буурдаг байна.

АТИ бол жил бүр улс орнуудын авлигыг хэмждэг, ТИ байгууллагын нэрийн хуудас юм. Энэхүү индекс 180 орчим улс, нутаг дэвсгэр дэх бизнесийн шинжээчдийн төсөөллийн судалгаанд үндэслэдэг бөгөөд тэдгээр судалгааны дагуу улс, нутаг дэвсгэрүүдийг тэг (маш их авлигатай)-ээс 100 (цэвэр) оноогоор үнэлэн эрэмбэлдэг.⁵⁵⁹ АТИ нь 1995 онд анх гарсан цагаасаа хойш бодлого боловсруулагч, судлаач, хөрөнгө оруулагч болон төрийн бус байгууллагууд авлигын эсрэг тэмцэлд хөрөнгө оруулалт хийхдээ ашигладаг чухал лавлах эх сурвалж хэвээр байна.

2020 оны АТИ-ээс харахад авлигатай тэмцэх чиглэлээр, ялангуяа өндөр авлигатай гэж аль хэдийн нэрлэгдсэн улс орнуудад ахиц дэвшил төдийлөн гараагүй байна. Тогтмол өндөр үзүүлэлттэй байдаг Шинэ Зеланд, Дани, Швед, Финланд, Швейцари гэх мэт улсууд индексийн тэргүүлэгч байр сууриа хэвээр хадгалсан бол хамгийн муу үзүүлэлттэй Сомали, Өмнөд Судан, Сири, Йемен, Венесуэл гэх мэт улсууд мөн л сүүл мушгижээ. 2020 оны индексээс харахад улс орнуудын тал орчим хувьд нь арваад жилийн хугацаанд ямар нэгэн ахиц дэвшил гараагүй байна. ТИ энэхүү баргар бодит байдлыг муу үзүүлэлттэй улсууд дахь авлигын үндсэн шалтгааныг арилгаж чадаагүй засгийн газрын алдаа дутагдалтай холбон тайлбарлаж байна.⁵⁶⁰

АТИ нь судалгаа, хөрөнгө оруулалтын чиглэл болон авлигын эсрэг нөөц аль улс оронд хамгийн их хэрэгцээтэй байгааг тодорхойлоход чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч маш их шүүмжлэл дагуулсан хэмжүүр хэвээр байна. Энэхүү индекс хөгжлөөр доогуур түвшинд байгаа, хөгжиж буй орнуудын хувьд шударга бус байж болзошгүй нь хамгийн том шүүмжлэл юм. Ялангуяа, уг индекс дээр суурилан улс орнуудын нэр хүндийг авлигын хэмжээгээр эрэмбэлэх үндэслэл нь эргэлзээтэй асуудал юм. Энэ үзэл бодлыг дэмжигчид хөгжиж буй, авлигын түвшин өндөртэй орнуудад энэхүү гамшигтай тэмцэхэд нь туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд АТИ сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үздэг.⁵⁶¹ Харин бусад нь АТИ эдгээр улс орнуудад ‘авлигын урхи’ үүсгэх боломжийг онцолдог. Үүний шалтгаан нь, хөгжлийн аливаа тусламж нь эхний ээлжинд тусламжгүйгээр хэрэгжүүлэхэд бэрх шинэчлэл (ялангуяа, авлигыг хязгаарлах замаар) хийж байгаа эсэхийг нотлох баримтаас ихэвчлэн хамаардаг.⁵⁶²

⁵⁵⁸ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж:

https://www.academia.edu/45249024/Corruption_in_Fragile_States_What_the_Corruption_Perceptions_Index_does_not_Reveal

⁵⁵⁹ Transparency International. (2021, January 28). 2020 Corruption Perceptions Index reveals widespread corruption is weakening Covid-19 response, threatening global recovery. <https://www.transparency.org/en/press/2020-corruption-perceptions-index-reveals-widespread-corruption-isweakening-covid-19-response-threatening-global-recovery>

⁵⁶⁰ Ibid

⁵⁶¹ Chaikin, D., & Sharman, J.C. (2009). Corruption and money laundering: A symbiotic relationship. Palgrave Macmillan.

⁵⁶² Andersson, S., & Heywood, P.M. (2009). The politics of perception: Use and abuse of Transparency International’s approach to measuring corruption. *Political Studies*, 57(4), 746-767. <https://doi.org/10.1111/j.14679248.2008.00758.x>

Эдгээр шүүмжлэлээс гадна, муу үзүүлэлттэй орнууд дахь авлигатай хийж буй тэмцлийн бодит байдлыг АТИ олж хардаггүй. Эдгээр улс орнуудын хувьд авлига бол тэдний эрхэмлэдэг зүйл биш; тэнд авлигын сөрөг нөлөөллийн талаарх мэдлэг ойлголт байхгүй ч юм уу, авлигын дэглэмийг нураах хүсэл эрмэлзэл байхгүй хэрэг биш юм. Харин авлигатай тэмцэх гэсэн оролдлогууд нь 'авлигын эсрэгийн эсрэг' ('anti-anti-corruption') хүчтэй хариу үйлдлийн дарамтад хялбархан өртдөг байна. Авлигын эсрэг арга хэмжээнүүдийг дагаж мөрдөхгүй байгаагаас илүү муу зүйл бол тасралтгүй өсөх авлигын эсрэг хүчин чармайлтыг зогсоохын тулд авлигыг дэмжигч хүчнүүдийн зүгээс гаргадаг авлигын эсрэгийн эсрэг хүчтэй хариу арга хэмжээ юм. Эдгээр хүчнүүд авлигатай хатуу тэмцэл явуулж буй засаг захиргааны болон улс төрийн тогтвортой байдлыг алдагдуулах ч чадвартай. Эдгээр улс орнуудын нийтлэг шинж чанар бол тэд “эмзэг улсууд” гэдэг ангилалд багтдаг явдал юм.

Эмзэг төр бол засаглалын үндсэн чиг үүрэг(үүнд төрийн алба болон нийгэмд дагаж мөрдөх дүрмийг хэрэгжүүлэх явдал багтана)-ийг хэрэгжүүлэх, төр ба нийгмийн харилцан уялдаатай байдлыг хангах чадваргүй төр юм.⁵⁶³ Ерөнхийдөө эмзэг улсууд тогтворгүй байдлын сүүдэрт оршдог, эсвэл төрөөс илүү хүчтэй нийгмийн хүчнүүдээс шалтгаалсан тогтворгүй байдлыг мэдэрч байдаг аж.⁵⁶⁴ Эдгээр хүчнүүд тогтвортой байдлыг бий болгох, хадгалах нөхцөлийг зааж, тодорхойлдог. Аливаа хэлбэрийн засаглалыг хэрэгжүүлэх нь төрийн бүрэн эрх мэдлийг (энэ нь дотооддоо хүрэлцдэггүй) хэрэгжүүлэх чадвар дээр бус, харин аюулгүй байлгах, хамгаалах тогтолцоонд тулгуурладаг. Тиймээс төр ба нийгмийн харилцаа нь нийгмийн хүчийг давамгайлж төрийн хөрөнгийг аливаа хязгаарлалтгүйгээр хууль бусаар хуримтлуулах дэглэмийг хадгалахад чиглэсэн шинж чанар бүхий харилцан хамааралтай байдаг.⁵⁶⁵ Энэ байдал нь авлигын эсрэг үйл ажиллагааны хэрэгжилтэд хэрхэн нөлөөлж байгааг төдийлөн олж хардаггүй байна. Эдгээр улсуудын засаг захиргаа авлигын дэглэмийг үргэлжлүүлэн тогтвортой байдлаа хадгалах, эсвэл тэнцвэрийг алдагдуулах эрсдлийг үүрч авлигатай тэмцэх, өөрөөр хэлбэл, авлигатай “хамтрах, эсвэл тэмцэх” гэсэн сонголттой тулгардаг. Аль ч сонголтөөс ямар нэг үр дагавар гардаг. Хулгай хийхийг зөвшөөрөх нь хөгжлийг доройтуулна, авлигатай тэмцэх нь засаг захиргааны наслалт, тогтвортой байдалд сөргөөр нөлөөлнө.

Үүний жишээ нь Нигери юм. Нигери нь Йемен, Сомали, Өмнөд Судан, Сири гэх мэт хамгийн эмзэг улсуудын ангилалд хараахан ороогүй ч ороход их ойрхон байгаа юм.

Хөгжиж буй орнууд дахь авлигын сэтгэлзүйн өртөг⁵⁶⁶

2021.05.17. Smriti Sharma, Finn Tarp, Saurabh Singhal. Авлига бол эдийн засгийн өсөлтийг удаашруулж, хөгжлийг доройтуулж, тэгш бус байдлыг үүсгэдэг гэмт хэрэг юм. Авлига дэлхийн эдийн засагт жилд ойролцоогоор 2.6 их наяд долларын хохирол учруулдаг бөгөөд ихэвчлэн улс төр болон томоохон корпорацуудын арилжаа наймаатай холбоотой байдаг. Тухайлбал, Панамын баримт нь санхүүгийн өргөн цар хүрээтэй, хүчирхэг нууц салбарыг илчилсэн билээ.

Гэхдээ хөгжиж буй орнууд дахь авлигын үлэмж хэсэг нь орон нутгийн засаг захиргааны албан тушаалтнуудад “гар цайлгах мөнгө” төлөх буюу албан бус төлбөрийн хэлбэртэйгээр оршин тогтнож байдаг⁵⁶⁷. Хүмүүс цахилгаан эрчим хүч хэрэглэх болон жолооны үнэмлэх авах, эмнэлэгт үзүүлэх зэрэг өдөр тутмын наад захын бараа, үйлчилгээ авахдаа ийм төлбөрийг тогтмол төлдөг байна.

Иймэрхүү төрлийн жижиг авлига хүмүүст мөнгө санхүүгийн хувьд нөлөөлөхөөс гадна шууд мэдрэгддэггүй, ихэвчлэн далд байдаг өртөг нь сэтгэлзүйд учруулж байгаа хор хөнөөл юм. Бидний судалгаа хөгжиж буй орнуудын иргэдэд тулгардаг өдөр тутмын авлига тэдний сэтгэцийн эрүүл мэндэд хэрхэн хор хөнөөл учруулж байгааг тодруулах зорилготой юм⁵⁶⁸.

⁵⁶³ Grimm, S., Lemay-Hébert, N., & Nay, O. (2014) 'Fragile states': Introducing a political concept. Third World

⁵⁶⁴ Migdal, J. S. (1988). Strong societies and weak states: State-society relations and state capabilities in the Third World. Princeton University Press.

⁵⁶⁵ de Waal, A. (2016). Introduction to political market place for policymakers. The Justice and Security Research Programme, Policy Brief, 1. <http://www.lse.ac.uk/internationalDevelopment/research/JSRP/downloads/JSRPPBrief1.pdf>

⁵⁶⁶ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://phys.org/news/2021-05-psychological-corruption-countries.html>

⁵⁶⁷ <https://www.annualreviews.org/doi/full/10.1146/annurev-economics-080511-110917>

⁵⁶⁸ <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0167268121000639>

Хохирол хэд хэдэн хэлбэртэй байж болно. Жишээлбэл, хахуулийн хэмжээ болон давтамж нь санхүүгийн зардал үүсгэж, улмаар сэтгэлийн зовуурь бий болгодог бөгөөд ялангуяа, ядуу өрхүүд үүнд маш их өртөхийн хамт илүү эмзэг байдаг байна.

Авлига нь эрүүл мэнд, боловсролын дэд бүтэц зэрэг төрийн гол гол үйлчилгээнүүдийн буруу гажуу хуваарилалтын шалтгаан болдог. Эдгээр үйлчилгээнүүд нь хүний бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэндэд нэн чухал үүрэг гүйцэтгэдэг хэдий ч төлбөр төлөх хүсэлтэй хийгээд чадвартай хүмүүст л ихэвчлэн хялбар, боломжтой байдаг. Түүнчлэн, амьдралын хэрэгцээт бараа, үйлчилгээ (хуулиар тогтоосон) авахын тулд хахууль төлөх нь тухайн хүнд арга мухардсан, эрх чөлөөгүй мэт сэтгэгдэл төрүүлдэг байна⁵⁶⁹.

Дэлхийн хүн амын 10 орчим хувь нь сэтгэцийн эрүүл мэндийн эмгэгтэй байдаг бөгөөд ялангуяа, ядуу буурай хүмүүс үүнд илүү өртөмтгий байдаг⁵⁷⁰. Судалгаанаас харахад өндөр орлоготой хүмүүсийг бодвол бага орлоготой хүмүүсийн сэтгэл гутрал, сэтгэлийн хямралд өртөх эрсдэл илүү байна⁵⁷¹.

Сэтгэлийн хямрал

Бидний судалгааны ажлын судлагдахуун болох Вьетнам улс нь төрийн салбарын ил тод байдлын үзүүлэлтээр 180 орноос 104-г жагсаж байна⁵⁷². Авлига нь Вьетнамд бизнес эрхлэхэд⁵⁷³ гардаг ердийн нийтлэг зардал гэж тооцогдсон хэвээр байгааг судалгаа баталж байна⁵⁷⁴.

Бид Вьетнамын хөдөө нутагт хоёр том судалгаа явуулсан бөгөөд Center for Epidemiological Studies Depression-ийн шатлалыг ашиглан үнэлсэн болно⁵⁷⁵. Сэтгэл гутралын шинж тэмдгийг хэмжих өргөн тархсан энэхүү судалгааны хэрэгсэл нь судалгаанд хамрагдаж буй хүмүүсээс хэр олон удаа уйтгар гуниг, найдваргүй байдал мэдэрдгийг болон анхаарал сарнилт, нойргүйдэл хэр зэрэг байгааг нь тодруулдаг юм. Эцэст нь, үр дүнг авлигын хэмжүүртэй харьцуулсан болно.

Эхний судалгаанд авлигын хэмжүүр нь хүмүүс өдөр тутамдаа төрийн салбарын авлигад (барилга барих зөвшөөрөл авах, төрийн албанд ажилд орох, эмчилгээ хийлгэхийн тулд хахууль төлөх) өртөж буй байдал дээр суурилсан байв. Харин хоёр дахь судалгаанд орон нутгийн аж ахуйн нэгжид авлига хэр зэрэг нөлөө үзүүлж буйг айл өрхүүдээс асуусан юм.

Жижиг авлигад өдөр бүр өртөх нь сэтгэцийн эрүүл мэндэд ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг талаар бид тодорхой бөгөөд үнэмшилтэй нотолгоо олсон юм⁵⁷⁶. Эмэгтэйчүүд голчлон ар гэртээ анхаарал халамж тавих хандлагатай байдаг тул гэр бүлдээ зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тэд ихэвчлэн хөөцөлддөг байна. Бидний олж мэдсэн үр дүнгээс харахад авлига газар авсан газрууд дахь төрийн үйлчилгээнээс хараат байдал нь эмэгтэйчүүдийн сэтгэцийн эрүүл мэндэд эрэгтэйчүүдтэй харьцуулахад илүү их нөлөөлсөн болохыг харуулж байна.

Түүнчлэн, авлигад өртөх нь орон нутгийн иргэд болон байгууллагуудад итгэх итгэлийг бууруулж, улмаар орлого буурахад хүргэдэг бөгөөд энэ нь эргээд сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлдөг байна.

Авлигыг таслан зогсоох нь

2016 онд Вьетнамын Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга Нгуен Фу Тронг авлигын эсрэг томоохон кампанит ажил эхлүүлсэн юм⁵⁷⁷. 2016 оны 01 дүгээр сараас 2018 оны 08 дугаар сарын хооронд 56 төрийн албан тушаалтанд авлигын хэргээр сахилгын шийтгэл оногдуулж, бусад хэд хэдэн хүнд эрүүгийн хэрэг үүсгэсэн гэж мэдээлжээ⁵⁷⁸.

⁵⁶⁹ <https://core.ac.uk/download/pdf/213950214.pdf>

⁵⁷⁰ <https://ourworldindata.org/mental-health>

⁵⁷¹ <https://www.science.org/doi/10.1126/science.aay0214>

⁵⁷² <https://www.transparency.org/en/cpi/2020/index/vnm>

⁵⁷³ <https://onlinelibrary.wiley.com/doi/full/10.1002/jid.2997>

⁵⁷⁴ <https://www.journals.uchicago.edu/doi/abs/10.1086/664022>

⁵⁷⁵ <https://www.apa.org/pi/about/publications/caregivers/practice-settings/assessment/tools/depression-scale>

⁵⁷⁶ <https://www.sciencedirect.com/science/article/pii/S0167268121000639>

⁵⁷⁷ <https://www.bbc.com/news/world-asia-55883535>

⁵⁷⁸ <https://e.vnexpress.net/news/news/corruption-dwindling-in-vietnam-asserts-party-leader-3793508.html>

Үүний дараа зарим ажиглагчид уг кампанит ажил нь авлигын түвшнийг бууруулсан гэж үзжээ⁵⁷⁹. Бидний судалгаагаар, авлигын эсрэг амжилттай тэмцэж чадсан бүс нутагт сэтгэцийн эрүүл мэндийн түвшин мөн дээшилж байгааг олж тогтоосон.

Сүүлийн үед цар тахлын улмаас зайлшгүй шаардлагатай үйлчилгээ, бараа бүтээгдэхүүний эрэлт нийлүүлэлтээс хамаагүй илүү байх магадлалтай тул авлига цэцэглэх өргөн нөхцөл бүрдэж буй нь эргэлзээгүй юм. Эрүүл мэнд, хүмүүнлэгийн тусламжаас хамаарсан КОВИД-19-тэй холбоотой авлигын талаарх мэдээллүүд гарсаар байна⁵⁸⁰. Энэ өвчин урт хугацааны тэгш байдал болон нийгмийн хөдөлгөөнд аль хэдийн нөлөөлж, ядуу, гадуурхагдсан бүлгүүдийг улам хүчгүйдүүлж байна⁵⁸¹.

Цар тахлын дараах сэргээн босголтын үйл явцыг хангахын тулд авлигатай тэмцэх, засаглалын бүтцийн ил тод байдлыг дээшлүүлэх үүрэг амлалт нэн шаардлагатай. Дэлхийн хамгийн ядуу хүмүүсийн хувьд мөнгө, хоол хүнс, аюулгүй байдлаа хангах тулгамдсан хямрал өдөр бүр тохиолддог. Энэ бол урт удаан хугацаанд үргэлжилсэн авлигаас болж улам дордсон тэдний бие бялдарын хийгээд оюун санааны эрүүл мэндэд хор учруулах, улигт тэмцэл юм.

Эрүүл мэндийн салбар дахь авлига нь өвчтөнүүдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн чанарыг улам бүр доройтуулдаг⁵⁸²

2021.06.01. Эрүүл мэндийн салбар дахь хахууль нь үйлчилгээний чанар муу байгаатай холбоотой асуудлыг шийдэж чадахгүй, улам бүр дордуулж байна гэж судлаачид үзэж байна. Өвчтөнүүд өөрсдийн сайн сайхан байдал, эрүүл мэндийн талаар үнэлэхдээ мөн үүнтэй ижил бодолтой байна. Өөрөөр хэлбэл, чанартай үйлчилгээ үзүүлэхгүй, үр дүнд хүрэхгүй байгаагийн шалтгаан нь эрүүл мэндийн салбар дахь хахууль юм. Ийм дүгнэлтийг олон улсын судлаачдын баг, түүний дотор нийтлэлийн зохиогч, Уралын холбооны их сургуулийн дэд профессор Ольга Попова хийсэн байна.

Судлаачид Төв болон Зүүн Европ, ОХУ зэрэг 28 орны 41 мянган иргэний дунд судалгаа хийсэн. Судалгааны үр дүнг Харьцуулсан эдийн засаг сэтгүүлд нийтэлсэн байна. Ольга Попова “*Ерөнхийдөө хүмүүсийн эрүүл мэндийг доройтуулдаг авлигын механизм дараах байдалтай байна*”. “*Өдөр тутмын практик үйлдлээс харахад хүн амын хамгийн ядуу давхарга эрүүл мэндийн хувьд хамгийн их асуудалтай байна. Тэд эмнэлгийн үйлчилгээг илүү их ашигладаг бөгөөд хахуулийн тусламжтайгаар асуудлаа шийдвэрлүүлэхээр хандах нь бусад хүмүүсээс илүү байна*” гэж хэллээ.

Эрүүл мэндийн ажилтнууд албан бус цалин хөлс авахын тулд үйлчилгээний чанарыг санаатайгаар бууруулж чаддаг нь авлигыг улам бүр өдөөж байна гэж судлаачид таамаглаж байна.

“*Тэсэн хэдий ч эрүүл мэндийн салбарын хүнд хэцүү нөхцөл байдал, хүн амын ядуу бүлгийг үл тоомсорлож, хариуцлагагүй хандах хандлага зэргийг хахууль өгснөөр шийдвэрлэж чадахгүй*” гэж Ольга Попова хэллээ.

“*Эмч нар байнга, шалтгаангүйгээр ажил хийдүүлэх, үйлчилгээг удаан хугацаагаар хүлээлгэх, ажилтнуудын зүгээс үл хүндэтгэсэн байдал гаргах, эм тарианы дутагдал, бохир заваан ажлын байр зэрэг бусад асуудлууд шийдэгдэхгүй байна. Хахууль өгсний дараах үр дагавар болон хахууль өгөх үеийн хүлээлт хоёрын зөрүүтэй байдал, баригдах эрсдэл нь хахууль өгсөн өвчтөнүүдийн аж амьдрал, сэтгэл санааны байдлыг муудахад хүргэдэг*”.

Зөвхөн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэлтгүй төрийн аливаа үйлчилгээнд хахууль өгөх нь ижил сөрөг үр дагавартай болохыг судлаачид онцолж байна.

Өөр нэг дүгнэлт бол хахууль өгсөн хүмүүс бусдаас илүү эрүүл мэнд нь муудах эрсдэлтэй тулгардаг. Учир нь хахууль нь хувийн болон гэр бүлийн төсвөөс хороож, хэвийн хоолны дэглэмийг алдагдуулж, мах, тахиа, загас, эсвэл түүнтэй адилтгах хоолыг тогтмол хэрэглэх боломжийг бууруулдагтай холбоотой юм.

⁵⁷⁹ <https://thediplomat.com/2021/02/the-rise-and-rise-of-nguyen-phu-trong/>

⁵⁸⁰ <https://www.transparency.org/en/citizens-report-COVID-19-corruption>

⁵⁸¹ <https://blogs.worldbank.org/voices/what-covid-19-can-mean-long-term-inequality-developing-countries>

⁵⁸² Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: https://www.eurekaert.org/pub_releases/2021-06/ufu-cih060121.php

Эрүүл мэндийн салбарын хахуулийн хэмжээ Словени, Эстони, Польш, Гүрж, Чехэд хамгийн бага байдаг бол Азербайжан, Молдав, Тажикстан улсуудад хамгийн өндөр байна. Орос улс жагсаалтын дунд хэсэгт байгаа бөгөөд Литва, Босни ба Герцеговинагийн түвшинтэй ойролцоо байна.

Судалгаанд хамрагдсан орнуудын оролцогчдын дунджаар 17% нь нийтийн эрүүл мэндийн тогтолцооны хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа хахууль өгч байсан гэж мэдээлсэн. Судалгаанд оролцогчдын гуравны нэг орчим нь төрийн бусад үйлчилгээг авахдаа хахууль өгч байсан гэжээ. Молдав, Тажикстаны өвчтөнүүдийн бараг тэн хагас нь хахууль өгч байсан бол Украин, Азербайжан улсын гуравны нэг орчим нь авлигын асуудалд оролцож байсан байна.

Авлигын тархалт, түүний дотор эрүүл мэндийн салбар дахь авлигаар Европын пост-коммунист орнууд Сахарын өмнөд Африкийн дараа, хоёрдугаарт ордог. Судлаачид үүнийг гамшиг гэж нэрлэж, авлигатай тэмцэхийг уриалж байна. Төрийн албан хаагчдын цалин хөлс, хууль сахиулах үйл ажиллагаа, нийгэм дэх үл тэвчих байдлыг нэмэгдүүлэх кампанит ажил нь асуудлыг шийдвэрлэхэд туслах болно.

Нийгмийн харилцаанд зай барьснаар авлига ч мөн буурчээ⁵⁸³

2021.07.07. Richard Messik. Бостоны их сургуулийн профессор Раймонд Фисман Хятадын хоёр судлаачтай хамтран нийгмийн харилцаанд зай барьснаар үүсэх ач холбогдлын талаарх хамгийн сүүлийн үеийн нотолгоог гаргасан байна. “Америкийн эдийн засгийн сэтгүүл: Хэрэглээний эдийн засаг”-ийн 07 дугаар сарын дугаарт нийтэлсэн тэдний судалгаа нь жижиг улс орнууд (Гватемал), жижиг хотууд (Фолл Ривер Массачусетс), мэргэжлийн жижиг хүрээлэл (Чикагогийн шүүгчид) зэрэгт хамаарах кейс судалгааны үр дүнд анх удаа хийсэн тоон шинжилгээ юм. Авлигын эсрэг хуулийг хэрэгжүүлж байгаа болон түүнийг зөрчих магадлалтай хүмүүсийн хоорондын зай их байх тусам уг хуулийг хэрэгжүүлэх магадлал өндөр байна.

Нийгмийн эрүүл мэндийн байгууллагуудын хувьд “нийгмийн харилцаанд зай барих” гэдэг нь COVID-19 цар тахал тархахаас урьдчилан сэргийлэхийн тулд хувь хүмүүс бусдаас тодорхой зайнаас харилцахыг хэлнэ (Энэ нь Америкт 6 фут, бусад улсад 2 метр). Фисман болон түүний хамтрагчдын олж тогтоосон зүйл нь мөрдөгч, прокурор, аудитор болон авлигын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэгтэй бусад хүмүүс хууль журмыг сахиулж буй хүмүүсээс бие махбодын хувьд хэр хол зайнаас харилцах ёстойг харуулсан байна.

Профессор Фисман ба түүний хамтрагч Чу, Тан, Ван нар Хятадын аудиторуудын дунд хийсэн судалгаанаас олж тогтоосон зүйлийг авж үзье.

Тэд Хятад дахь мужийн ахлах аудиторууд төрөлх хотынхоо мужийн захиргаанд илүү хялбар ажилладаг эсэхийг судлав. Бусад бүх нөхцөл адилхан боловч төрөлх хотдоо ажиллаж буй аудиторууд уг хотод хамааралгүй хүмүүстэй харьцуулахад 38 хувиар бага зардал гаргаж байсан гэж тогтоосон. “Энэхүү нутаг усны гарал үүслийн үр нөлөө нь аудиторын ажиллах хугацаанд байнга гарч байсан ба харин мужийн Зохион байгуулалтын газрын тушаалаар хотын дээд албан тушаалтнууд өөрчлөгдөхөд уг үр нөлөө багасч байв”. Нийгмийн харилцаанд зай барих эсэх нь аудитын стандартыг мөрдөх үйл ажиллагаанд нөлөөлж байгааг орон нутгийн өмчит бизнесийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн практик үйл ажиллагаатай танилцах замаар нотолж байна. Төрсөн хотдоо ажиллаж буй аудитор зүй бус үйлдэл ихээр гаргадаг ажээ.

Нийгмийн харилцаанд зай барих нь авлигын эсрэг хууль тогтоомжийг мөрдүүлэхэд ямар нөлөө үзүүлж байгааг харуулахын тулд дээрх судлаачид эмпирик өгөгдлийг ашигласан нь шинэлэг байв.

Массачусетс мужийн Фолл Ривер хэмээх жижиг хотод (89,388 хүн амтай) хууль тогтоомжийг харилцан сахиулах ёстой хотын албан хаагчид хоорондоо ойр дотно харилцаатай байсны улмаас авлига газар авжээ. Мөн Гватемал хэмээх жижиг улс (16 сая хүн амтай) болон Чикагогийн

⁵⁸³ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж:

https://globalanticorruptionblog.com/2021/07/07/social-distancing-reduces-corruption-too/?fbclid=IwAR1DIEFAob0hTtiGT_UN3Wfad_ViLS_B58ww5IjJ8NQ0E6_08V_RUDLyrEw

шүүгчдийн хүрээлэл (360 хүнээс бүрдсэн) аль алинд нь нийгмийн харилцаанд зай барьснаар авлигыг бууруулж чадсан байна.

Америкийн нийгмийн эрүүл мэндийн салбарын төлөөлөл болсон Доктор Энтони Фаучи цар тахлын үед иргэд нийгмийн харилцаанд зай барихын чухлыг ойлгуулахын тулд бусдаас илүү их чармайсан юм. Харин одоо авлигатай тэмцэх салбарт бас нэг Фаучи хэрэгтэй байна.

Үндэстэн байгуулах ажиллагаа ба авлига: Франц Вьетнамын сануулга⁵⁸⁴

2021.07.30. Michael Glanzel. Үндэстэн байгуулах үйл ажиллагаа нь барууны улс орнуудын хувьд урт хугацааны туршид ихээхэн алдартай төсөл байсаар ирсэн. Үндэстэн байгуулах ажиллагаа нь олон төрлийн санал бодол, нөхцөл байдлыг тэнцвэржүүлж, зарим тохиолдолд ямар салбарт анхаарал хандуулан ажиллах вэ гэдэг хэцүү сонголт хийх шаардлага үүсгэж байдаг нарийн төвөгтэй үйл ажиллагаа юм. Үүнээс шалтгаалан авлигатай тэмцэх үйл ажиллагааг орхигдуулах, эсхүл үл тоомсорлох үйлдэл зарим тохиолдолд гардаг байна. Гэвч энэ нь үндэстэн байгуулах ажиллагаанд гаргадаг томоохон алдаа юм. Хяналтгүй орхисон авлига нь үндэстэн байгуулахад ихээхэн хор хөнөөл учруулах боломжтой. Түүхийн хуудаснаас харахад авлигыг тэвчих үзэл нь үндэстэн байгуулах үйл ажиллагааг хэрхэн төөрөгдүүлэх боломжтойг харж болно. Үүний нэг томоохон жишээ нь Анхны Индо-Хятадын дайны дараах Францын туршлага юм.

Хэдийгээр Франц нь Вьетнамыг 19 дүгээр зууны дунд үеэс Дэлхийн хоёрдугаар дайны эхэн үе хүртэл эрхшээлдээ байлгасан боловч, дайны дараах үед Францад ихээхэн асуудал үүсгэж байлаа. Хо Ши Миний удирдсан Вьет Мин хүчин нь бүс нутагт тогтоосон Францын түрэмгийлэлтэй тэмцэж, эцэст нь Хятад болон ЗХУ-ын дэмжлэгийг авж байв. 1950 оны эхэн үед Хо Ши Миний удирдсан зэвсэгт хүчний эсрэг Францын армийн үйл ажиллагаа үр дүнд хүрэхгүй байсан учир Францын төрийн удирдах албан тушаалтнууд Вьетнамыг колони хэвээр эрхшээлдээ байлгахын оронд бие даасан Вьетнам улс байгуулахаар шийдсэн байна. Энэхүү шинэ улсыг байгуулах оролдлогын хүрээнд Францын удирдлага “Пиастрын хэрэг” (“Piastres Affair”) хэмээх хожим энэхүү үйл ажиллагаанд ихээхэн асуудал үүсгэх авлигын томоохон сүлжээг үл тоомсорлосон юм.

Энэхүү авлигын сүлжээ нь Францын дэмжлэгтэй Индо-Хятадын валют болох пиастр мөнгөн дэвсгэртэй холбогдолтой тул ийнхүү нэршилтэй болсон байна. 1920 оноос эхлэн пиастрыг Францын франкийн ханшаар тооцож эхэлсэн ба Францын төсвийн сангаас тус хоёр валютын солилцоог хийж, баталгаажуулж байсан юм. 1945 онд Вьетнам дахь Францын Тэргүүн комиссар нэг пиастрын ханшийг 17 франкаар тогтоожээ. Гэвч энэхүү ханш нь тус валютыг хэтэрхий өндөр үнээр тогтоосон бөгөөд зах зээлийн ханшаар 10 франктай тэнцэж байсан юм. Вьетнамын иргэд болон тус улсад амьдарч байсан Франц иргэд энэхүү нөхцөл байдлыг түргэн хугацаанд ашиглан хар захаас их хэмжээний пиастр солиулан авж, Францын засгийн газарт худалдан ашиг олж эхэлсэн байна. Энэхүү ажиллагааны улмаас пиастр худалдсан этгээдүүд их хэмжээний ашиг олсон бол, эсрэгээрээ, Францын татвар төлөгчдөд үнэмлэхүй их дарамт учруулжээ. Энэхүү арилжааны оргил үе буюу 1953 онд Францын улсын төсөв өдөрт 500 сая франк буюу ойролцоогоор 1.4 сая ам.доллар алдаж байв.

Пиастрын хэрэг нь хар захын худалдаа наймаанаас эхэлж санхүүгийн хямрал үүсэхэд хүргэсэн бөгөөд үүний гол хүчин зүйлд Вьетнамын төрийн албан хаагчдын үйл ажиллагаа салшгүй холбоотой юм. Төрийн албан хаагчид энэхүү худалдаа арилжааг хориглох ямар нэгэн арга хэмжээ аваагүй бөгөөд бүр төрийн өндөр албан тушаалтнууд хүртэл энэхүү арилжаанд оролцож ашиг олдог байв. Олон улсын зөрчлөөс шалтгаалан нөөц бололцооны гачигдалд орсон улсын хувьд, Вьетнамын удирдагчид тансаг амьдрах нөхцөл бололцоо тун хязгаарлагдмал байв. Пиастрын хэрэг энэхүү асуудлын гол хариулт болж чадсан юм. Вьетнамын удирдагчид тус улсад амьдарч байсан Франц иргэдтэй хамтран хууль бус арилжаа хийж өөрсдийн тансаг амьдралын хэв маягийг хэвээр авж үлддэг байв. Францын татвар төлөгчдийн мөнгө тус албан хаагчдын үдийн зоог, үдэшлэг, үнэтэй орд харш болон хувирч байв. Энэхүү үйл ажиллагаанаас хамгийн их ашиг олсон этгээд нь Францын томилсон Вьетнамын хаан байсан бөгөөд олон тэрбум франкийн мөнгө угааж, түүний язгууртан амьдралыг санхүүжүүлсэн байна.

⁵⁸⁴ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/07/30/nation-building-and-corruption-a-warning-from-french-vietnam/>

Үүнээс гадна, Пиастрын хэрэг Хо Ши Миний удирдсан коммунист хувьсгалчдад эерэгээр нөлөөлжээ. Хо Ши Миний холбоотнууд бүс нутгийн төрийн албан хаагчдын үйл ажиллагааг нарийвчлан хянаж байсан бөгөөд тус хэргийг ашиг олох боломж гэж харсан байна. АНУ-ын Тагнуулын төв газрын тайланд дурдсанаар коммунист этгээдүүд Францад очиж пиастрыг франкаар сольж олсон хөрөнгөөр алт худалдан авдаг байжээ. Энэхүү худалдан авсан алтыг Хятадад илгээж, сар бүр 500 гаруй зэвсэг техник худалдан авж, Вьет Мин бүлэглэлд хүргүүлдэг байв. Үүний үр дагаварт, Францын татвар төлөгчид өөрсдийн дайсныг санхүүжүүлсэн байна. Вьетнамын ширэнгэн ойд Франц цэргийн аминд хүрэх зэвсэг техникийг Францын татвар төлөгчид өөрсдөө санхүүжүүлжээ.

Олон жилийн турш Францын удирдлагууд энэхүү хууль бус үйл ажиллагаанд анхаарал хандуулаагүй юм. 1953 онд Дэлхий гэх дотоодын нэр хүндтэй хэвлэлд энэ талаар мэдээлсний дараа тус улсын ард иргэд мэдэх болов. Энэхүү мэдээ ард иргэдийн дунд багагүй үймээн самуун үүсгэсэн бөгөөд Вьетнам үндэстэн байгуулах, тус улсад Франц цэрэг байршуулах ажиллагаанд ард иргэд дургүйцэж эхэлсэн юм. Иймд Пиастрын хэрэг нь Вьет Мин бүлэглэлийг санхүүжүүлээд зогсохгүй, Францын ард иргэдийн итгэл үнэмшлийг мөн доройтуулсан юм. 1953 оны 05 дугаар сард Францаас пиастрын ханшийг унагах арга хэмжээ авсан боловч хэтэрхий оройтсон байжээ. Үүнээс ердөө ганцхан жилийн дараа Францын цэргүүд Вьетнамын газар нутгаас гарсан юм.

Хэдийгээр Францын албан хаагчид энэхүү хууль бус арилжааг олон жилийн өмнөөс мэддэг байсан боловч арга хэмжээ авалгүй өнгөрүүлсэн байв. Яагаад? Францын засгийн газар энэхүү үйлдэл нь Вьет Миний бүлэглэлийг санхүүжүүлж байсныг мэдээгүй байна. Гэсэн хэдий ч тус улсын засгийн газар олон сая франкийн хохирол учруулж байсан энэхүү хууль бус арилжааг яагаад зогсоогоогүй юм бэ?

Үүний нэг хариулт нь Францын засгийн газар Вьетнамын эрх баригчидтай зөрчилдөхийг хүсээгүй байж болзошгүй юм. Франц нь тус бүс нутагт нэр хүнд, нөлөөллөө алдаад байсан бөгөөд эрх баригчидтай зөрчилдөх нь улс төрийн хувьд зохимжгүй үйлдэл байсан юм. Үүнээс гадна, Францын засгийн газарт хууль бус арилжаанаас илүүтэй анхаарал хандуулах олон асуудал байсныг үгүйсгэхгүй. 1953 онд Францаас олон зуун цэргийг үр дүн нь тодорхой болсон дайнд илгээж байсан. Түүнчлэн, Дэлхийн хоёрдугаар дайны дараах Франц улс улс төрийн тогтворгүй байдалтай байв. Энэхүү батлан хамгаалах болон дотоодын нөхцөл байдлаас шалтгаалан тус хууль бус арилжаанд анхаарал хандуулах боломжгүй байсан байж болзошгүй юм.

Гэвч жижиг асуудал мэт энэхүү хууль бус арилжааг үл тоомсорлосон нь залруулахын аргагүй алдаа байжээ. Авлига нь үндэстэн байгуулах ажиллагаанд эсрэг хүчний дайралт, зэвсгээс ялгаагүй хор хөнөөлтэй гэдгийг Пиастрын хэрэг харуулсан юм. Авлига эсрэг хүчнийг санхүүжүүлэхээс гадна өөрсдийн иргэдийн тэмцэх хүсэл эрмэлзлийг унтраах хүчтэй байдаг ажээ. Пиастрын хэрэг нь Афганистанд үндэстэн байгуулах АНУ-ын үйл ажиллагаатай ихээхэн төстэй. Францын татвар төлөгчдийн хөрөнгөөр эсрэг хүчнийг санхүүжүүлж байсан үйлдэлтэй адил авлигач Пакистаны эрх баригчид АНУ-ын тусламж, дэмжлэгийг Афганистан дахь Талибаны хүчинд олгож байна.

АНУ болон Пакистан хоорондын харилцаанд сэв суулгахаас зайлсхийж АНУ-ын эрх баригчид энэхүү үйлдлийг мөн таслан зогсоох арга хэмжээ авахгүй байна. Хэдийгээр, Ерөнхийлөгч Байдены засаглал дор АНУ-ын зэвсэгт хүчин тус бүс нутгаас гарахаар бэлтгэж байгаа хэдий боловч Пакистанд их хэмжээний хөрөнгийн дэмжлэг өгсөн хэвээр байгаа юм. Энэхүү хөрөнгө нь урдын адил Талибанчуудыг санхүүжүүлэхэд ашиглагдаж байгаа билээ. Хяналтгүй орхисон авлигын үйлдэл нь урт хугацаанд сөрөг нөлөөтэй байдаг бөгөөд үндэстэн байгуулах ажиллагааг амжилтгүй болгодог гэдгийг Пиастрын хэрэг харуулж байна. Хэрэв АНУ бүс нутагт тогтоосон амжилтаа зэвсэгт хүчин ашиглалгүй хадгалж үлдэхийг хүсэж байвал Пакистаны авлигач үйлдэлд анхаарал хандуулах шаардлагатайг Пиастрын хэрэг сануулж байгаа юм.

Улс төрч ба бизнес эрхлэгчдийн харилцан хамаарлын харанхуй хэвлий: үүнийг эвдэж болох уу?⁵⁸⁵

2021.08.01. Abiral Gautam. Улс төрийн нам болон хувийн хэвшлийн хоорондын хор хөнөөлтэй хэлэлцээрийг шалгах эрх бүхий төрийн байгууллага одоогоор байхгүй байна. Үүний үр дүнд, танил талаа албан тушаалд томилох (кронизм) болон төрийн эрх мэдлийг ашиглан ашиг олох үйл ажиллагаа бидний системийн салшгүй нэг хэсэг болжээ.

2021 оны 03 дугаар сарын 19-ний өдөр 200 гаруй бизнес эрхлэгч Балбын Коммунист нам (БКН)-д элссэн юм. Энэ нь улс төрийн намд хувийн хэвшлийнхэн бүлэглэн нэг дор элссэн анхны үзэгдэл болж тус улсын түүхэнд үлдсэн юм.

Тэд БКН-ын дарга, Ерөнхий сайд асан К.П.Шарма Оли болон намын бусад удирдах албан хаагчдын нөлөөлөлд орж ийнхүү тус намд элсжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлж буйгаар Олигийн кабинетэд Үйлдвэр, худалдаа, хангамжийн сайдаар ажиллаж байгаад Ерөнхий сайд К.П.Олигийн Эдийн засгийн тусгай зөвлөхөөр томилогдсон Моти Лал Дугар нь тус хувийн хэвшлийнхний дэмжлэгийг авахад ихээхэн нөлөөлөл үзүүлжээ.

Тэдгээр бизнес эрхлэгчдийн зарим нь ирээдүйд тус намыг удирдах сонирхолтой байсан бол зарим нь өөрсдийн зорилгыг нийтэд мэдээлэхээс татгалзсан байна. Балбын Худалдаа аж үйлдвэрийн танхимын холбоо, Балбын Аж үйлдвэрүүдийн холбоо зэрэг хувийн хэвшлийн холбоод хүртэл энэхүү асуудлын талаар чимээгүй байгаа юм.

Хагас жил хүрэхгүй хугацааны дотор Балбын Конгресс (өмнө нь сөрөг хүчин байсан, одоогоор эрх баригч нам) хувийн хэвшлийн бизнес эрхлэгчийг сайдын албан тушаалаар шагнах нь ямар нэгэн өөрчлөлт авчрахгүй гэдгийг харуулсан байна. Хувийн боловсролын бизнесийн магнат Умеш Шрестаг сайдын албан тушаалд томилсон үйлдэл нь олон хүний гайхширлыг төрүүлсэн юм.

2017 онд БКН-аас гарсны дараа Конгрессын гишүүн болсон ам.долларын тэрбумтан Бинод Чаудхари мөн сайдын албан тушаалд томилогдохоор эрэлхийлж байгаа гэдэгт олон хүн итгэлтэй байгаа юм.

Ил тод нууц

Өнөөдөр Балба улсад хувийн хэвшлийнхэн бизнесийн дүрэм, ёс зүйг дагах бус, тодорхой нэг улс төрчийг дагаж үйл ажиллагаагаа эрхэлж байна. Бизнес, улс төр хоорондын харилцан хамаарал хэтэрхий гүнзгий байна. Энэхүү мэдээлэл нь ил тод нээлттэй боловч нууц юм. Улс төрчид бизнес эрхлэгчдийг ил тод, нээлттэйгээр дэмжиж байгаа явдал нь нээлттэй байдал юм.

Гэвч тус бизнес эрхлэгчдээс улс төрчдөд өгч буй мөнгөн дэмжлэг, энэхүү дэмжлэгийн эх сурвалж нь нууц билээ. Бизнес эрхлэгчид улс төрчдөд үзүүлсэн дэмжлэгийн хариуд юу авах вэ? Томоохон бизнес эрхлэгчид өөрсдийн хүмүүсийг улс төрийн намд байршуулах нь ямар ашигтай вэ?

Дээр дурдсан улс төрд орсон бизнес эрхлэгчид өөрсдийн буруутай үйл ажиллагаанд ямар нэгэн хариуцлага хүлээдэггүй гэдэг нь мөн адил нээлттэй нууц юм. Бизнес эрхлэгч болон улс төрчдийн хоорондын хуйвалдаан нь энэхүү нууцад мөн хамаарна. Балбад 2011 онд нэмэгдсэн өртгийн албан татвартай холбогдох хувийн хэвшлийн 518 байгууллагын залилан, болон бусад гэмт хэргийн үйлдлийг мөрдөн шалгаж илрүүлсэн бөгөөд үүнээс хойш дахин бизнес эрхлэгчдийг хамруулсан томоохон мөрдөн шалгах ажиллагаа хийгээгүй юм.

Хувийн хэвшлийн болон төрийн байгууллагын хууль бус үйлдлийг мөрдөн шалгаж, таслан зогсоох эрх бүхий засгийн газрын агентлагуудын үйл ажиллагаа зогсонги байдалд орсон. Хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх бүхий байгууллагууд болох Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах газар, Орлого хянан шалгах газар, Хүнсний технологи, чанарын хяналтын газар, Балба улсын Стандарт, хэмжил зүйн товчоо зэрэг байгууллагууд арав гаруй жилийн турш дорвитой үйл ажиллагаа гүйцэтгэлгүй зогсонги байдалд оржээ.

⁵⁸⁵ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.nepalivetoday.com/2021/08/01/the-dark-underbelly-of-politician-businessman-nexus-can-it-be-ever-broken/>

Үл хөдлөх хөрөнгийн салбар нь бизнес эрхлэгчид болон улс төрчдийн харилцаа хамаарлыг хамгийн ихээр харах боломжтой салбарын нэг юм. Үл хөдлөх хөрөнгийн салбарт хийгдэж буй мөнгө угаах, татвараас зайлсхийх үйлдлийн талаар агентуудаас удаа дараа мэдээлж байгаа боловч засгийн газраас тус гомдлыг үл тоомсорлож, мөрдөн шалгах ажиллагаа хийхээс татгалзаж байгаа юм.

Мөнгө угаах гэмт хэргийг мөрдөн шалгах газрын нэрээ нууцалсан албан хаагчийн мэдээлж буйгаар улс төрчид үл тоомсорлох замаар тус салбарт мөнгө угаах ажиллагааг дэмждэг бөгөөд зарим тохиолдолд татвараас зайлсхийх, мөнгө угаах үйлдэл болон бусад хууль бус үйлдлийг эрчимжүүлдэг байна. *“Бизнес эрхлэгчид их хэмжээний хөрөнгийг хүчирхэг улс төрчид болон тэдний хамаарал бүхий этгээдэд өгч засгийн газраас бодлогын түвшинд дэмжлэг авдаг”* хэмээн тус албан хаагч мэдээлжээ.

Үл хөдлөх хөрөнгийн агентийн мэдээлснээр улс төрчид тус салбарт хөрөнгө оруулж, үр ашгийг нь өөрсдийн түншүүдээр дамжуулан авдаг байна. Өнгөрсөн долоо хоногт Ерөнхий сайд Гер Бахадур Деубын Эрүүл мэндийн сайдаар томилсон Умеш Шреста нь Катманду хотын хойд хэсэгт тосгоны иргэдийг хуурч мэхлэн, газар авсан гэх үйлдэл олны анхаарлыг татах болсон.

Өөр нэгэн анхаарал хандуулах шаардлагатай салбар нь бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээнд тавих хяналт юм. Хэдэн сарын өмнө цагдаагийн албан хаагчид шоколад дүүрэн байшинд гэнэтийн шалгалт хийсэн тухай мэдээ олон нийтэд цацагдсан боловч энэхүү хэрэг мөн л хэрхэн шийдвэрлэгдсэн нь тодорхойгүй намжсан байна. Төрийн байгууллагууд чанарын шаардлага хангахгүй бараа бүтээгдэхүүнтэй холбогдох арга хэмжээг төдийлөн хэрэгжүүлэхгүй байгаа юм.

Үүнтэй адилаар, засгийн газраас хувийн хэвшлийг бүлэглэл байгуулж, үнийн хөөрөгдөл үүсгэхийг зөвшөөрчээ. Агаарын тээврээс барилгын материалын үнэ хүртэл хувийн хэвшлийн бүлэглэлийн үйл ажиллагаанаас хамаарч үнийн хөөрөгдөл үүсч байна. Хэдийгээр хувийн хэвшлийн бүлэглэлийн аль ч төрөл нь чөлөөт, өрсөлдөөнт зах зээлийн үндсэн зарчимд үл нийцэх боловч засгийн газраас үүнтэй тэмцэх ямар нэгэн арга хэмжээ авсангүй.

Харилцаа хамаарлын сөрөг тал энд хүрээд дууссангүй. Зарим томоохон корпорацууд хувийн хэвшлийн салбарыг бүхлээр нь удирдаж байна. Тэд мөн банк болон даатгалын компаниудыг ч тойрон өнгөрсөнгүй. Гэсэн хэдий ч засгийн газраас хувийн хэвшлийн компани нэг салбарыг, тэр тусмаа банк болон даатгалын үйлчилгээг дангаар удирдаж байгаа энэхүү үйлдлийг зогсоох тухай бодсонгүй. *“Банкны удирдлага улс төрчидтэй сөргөөцөлдөхөөс эмээж байна”* хэмээн Балба Растра банкны албан хаагч мэдээлжээ.

Өмнө нь, Балба Расрта банкны албан хаагчид одоогийн нөхцөл байдалтай харьцуулахад ур чадвар өндөртэй байсан, одоо улс төрийн шалтгаанаар томилогдсон албан хаагчид тэдгээр улс төрчдөөс зөвшөөрөл авахгүйгээр ямар ч шийдвэр гаргаж чадахгүй байгаа талаар тус албан хаагч мөн хэлжээ.

Хувийн хэвшилтэй адилгүй

Балбад үйл ажиллагаа эрхэлж буй томоохон бизнесүүд “тоглоомын дүрэм”-ээр тоглохоос татгалзаж байна. Учир нь тус хувийн хэвшлийн байгууллагууд зах зээлд шинэ өрсөлдөгч гарч ирж тэдний бизнесийн үйл ажиллагаатай өрсөлдөхийг хүсэхгүй байгаа юм.

Энэ хүрээнд, тэд өндөр түвшний улс төрчид болон улс төрийн намтай адил шинж чанартай юм. Улс төрчид шинэ өрсөлдөгчтэй нүүр тулж, өөрсдийн олж авсан статусыг алдахаас сэргийлж тус салбарт шударга өрсөлдөөн бий болгохоос зайлсхийдэг. Иймээс байр сууриа олж авсан улс төрчдийн талд зогсож тэдэнд санхүүгийн дэмжлэг үзүүлснээр бизнес эрхлэгчид өөрсдийн үйл ажиллагааг төрийн бодлогын түвшинд дэмжих боломжтой хэмээн Балбын Хэрэглэгчийн эрхийг хамгаалах форумын Ерөнхий нарийн бичгийн дарга Бишну Тимилсина хэлжээ.

Байр сууриа тогтоосон бизнес эрхлэгчдийн хувьд шударга өрсөлдөөн гэдэг нь ердөө л олон нийтэд хэлдэг сурталчилгааны үг болсон билээ. Тэд төрийн шийдвэр гаргах түвшний албан хаагчдад хандив, дэмжлэг үзүүлэх замаар өөрсдийн талд тоглоомын дүрмийг өөрчлөх боломжтой учраас эдийн засгийн энэхүү зарчим хэрэгжихийг хүсэхгүй байна.

“Улс төрийн намууд сонгуульд ялахын тулд их хэмжээний мөнгө хэрэгтэй гэдгийг мэддэг бөгөөд бизнес эрхлэгчид тэдний санхүүгийн гол эх сурвалж байсаар ирсэн” хэмээн Тимилсина хэлжээ.

Тэрээр мөн бизнес эрхлэгчид ба улс төрчдийн хоорондын харилцаа хамаарал эцэс төгсгөлгүй гинжин сүлжээ болсон талаар дурджээ.

Жишээлбэл, “2016 онд алдартай эм худалдаалагч этгээд засгийн газрын тогтоосон үнээс хэт өндөр үнээр эм худалдаалсан хэргээр ял сонссон юм. Гэвч тус этгээдийг бизнес эрхлэгчдийн дарамт шахалтын улмаас тэр даруй сулласан” гэж тэрээр мөн мэдээлжээ.

Ямар үр дүнд хүргэх вэ?

Улс төрчид хүчин чармайлт гаргахгүйгээр их хэмжээний мөнгө олж байгаа бөгөөд энэхүү нөхцөл байдал нь бизнес эрхлэгчдийн хувьд мөн адил таатай байна. Учир нь бизнес эрхлэгчид ард түмэн болон тогтолцооны өмнө хариуцлага хүлээх шаардлагагүй бөгөөд төрийн хяналтгүйгээр ёс зүйтэй болон ёс зүйгүй бизнес эрхлэх боломжтой юм.

Иймээс, энэхүү нөхцөл байдал олон нийтийн дарамт шахалт болон бодлогын шинэчлэл хийхээс нааш өөрчлөгдөхгүй талаар улс төрийн шинжээч Тара Натх Дахал мэдээлжээ.

Танил талаа албан тушаалд томилох болон төрийн эрх мэдлийг ашиглан ашиг олох ажиллагаа зуршил болсон байна. Бизнес эрхлэгчид ба улс төрчдийн харилцаа хамаарал нь холбооны тогтолцоо болон ардчилалд шууд нөлөөлдөг. Учир нь, ард иргэд тус хууль бус үйл ажиллагааг тогтолцооны гажуудлын үр дүн гэж хардаг билээ. Мэргэжилтнүүдийн санал нийлж байгаагаар, ардчилалд итгэдэг удирдагчид болон ард иргэд улс төрчдийн хөрөнгө, орлогыг нягтлан шалгахыг шаардах ёстой.

Бизнес эрхлэгчид улс төрийн намд элсэх хандлага Үндсэн хуулийн хоёр дахь Чуулганы сонгуулийн өмнөөс эхэлжээ. “Улс төрчид сонгуульд мөнгө хэрэгтэй гэдгийг мэддэг. Иймээс зар сурталчилгаанд маш олон бизнес эрхлэгчид оролцдог юм” хэмээн Дахал нэмж хэлэв. Түүнчлэн, өмнө нь бизнес эрхлэгчид парламентын гишүүнээр сонгогддог байсан бол одоо сайдын албан тушаалд томилогддог болсон талаар тэрээр мөн мэдээлсэн байна.

Тара Натх Дахалын итгэж буйгаар, хатуу чанга зохицуулалттай хууль баталж, тус хуулийг бүх хүнд тэгш хэрэгжүүлснээр бизнес эрхлэгчид ба улс төрчдийн хоорондын харилцан хамаарлыг таслан зогсоох боломжтой юм.

Авлигатай тэмцэх ажиллагаа бол пуужин хөөргөх шинжлэх ухаан биш⁵⁸⁶

2021.08.02. Jaylia Yan. Сансрын орон зайг судлах нь хямдхан ажиллагаа биш гэдэг нь тодорхой. Пуужин хөөргөлт, даалгавар бүрд хэрэглэх судалгаа, материал зэрэг нь олон тэрбум долларын зарлагатай байдаг. Үүнээс шалтгаалан төрийн сансар судлалын байгууллагуудын авлигын эрсдэл өндөр байдаг юм. Эдгээр байгууллагын үйл ажиллагаанд холбогдох хороо хяналт тавьдаг боловч тэдгээр албан хаагчдад хөрөнгө завших үйл ажиллагааг хянах шинжлэх ухааны ноу-хау мэдлэг дутмаг байдаг. Хөрөнгө шамшигдуулах, хэтрүүлэн зарцуулах, хахууль болон бусад гэмт хэргийг илрүүлэлгүй алдах нь элбэг юм. Авлигын хэргийг хүнд суртал болон техникийн нарийн зүйлсээс шалтгаалан тун хялбар нуух боломжтойгоос гадна энэ төрлийн хэрэг маш өндөр зарлагатай бөгөөд өндөр өртөгтэй техник хэрэгсэл болон хүний аминд хүрэх боломжтой байдаг. Хэдийгээр авлигаас шалтгаалан техникийн асуудал үүсэж, даалгавар амжилтгүй болсон ч сансар судлалын ажиллагаа хэт өндөр эрсдэлтэй, нарийн үйл ажиллагаатай тул энэхүү авлигын хэргийг илрүүлэх боломж хомс байдаг юм.

Авлигын хор хөнөөлийг бид ОХУ-ын сансрын нислэгийн төрийн өмчит Роскосмос компанийн туршлагаас харж болно. Олон жилийн турш тус компанийн хөрөнгийг албан хаагчид хуурамч гэрээ байгуулах, үнийг хуурамчаар өсгөх замаар хахууль авж шамшигдуулжээ. Үүний үр дүнд олон зуун сая ам.доллар агаарт хийсэж, хэд хэдэн Союз пуужин ослын улмаас дэлбэрсэн байна (2014 онд тус байгууллага авлигын улмаас 1.8 тэрбум ам.доллар алджээ). ОХУ-ын авлигын эсрэг идэвхтэн Алексей Навальный Восточный сансрын төвийн авлига, хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулж буй үйлдлийг нийтэд зарласан бөгөөд үүний дагуу хэд хэдэн эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг гүйцэтгэж, 58 албан хаагчийг эрх мэдлээ урвуулан ашигласан зэрэг гэмт хэрэгт буруутайд тооцож, ял оногдуулжээ.

⁵⁸⁶ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/08/02/fighting-corruption-isnt-rocket-science/>

АНУ-ын Сансар судлалын агентлаг (NASA)-ийн түүх ч мөн адил цэвэр биш юм. Тус байгууллагатай гэрээ байгуулж буй хувийн хэвшлийн компаниудын хахуулийн шинж чанартай байж болзошгүй үйлдлүүд олон жилийн турш иргэдийн анхаарлыг татаж ирсэн. Жишээлбэл, 1990 оны дунд үед, ХМТ-ны мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд NASA-д туршилт хийх сонгон шалгаруулалтад оролцож сонгогдохоор NASA-ийн албан хаагчдад хахууль өгсөн олон арван хувийн хэвшлийн байгууллагыг илрүүлж байсан.

Төлөөлөгчдийн танхим дахь засгийн газрын үйл ажиллагааны хороог тухайн үед даргалж байсан Жон Кониерс уг авлигын хэргийг NASA-ийн гэрээ байгуулах менежмент болон санхүүгийн алдаатай зохицуулалтаас шалтгаалсан гэж онцолж байв. Гэвч энэхүү асуудал өнөөдрийг хүртэл шийдвэрлэгдээгүй ба 2020 онд NASA-ийн сансрын нислэгийн туслах зохицуулагч Дуг Ловерро тус төвийн саран дээр буух хөтөлбөрийн хүрээнд гэрээ байгуулах ажиллагаанд Бойнг компанитай зохимжгүй харилцаа тогтоосон шалтгаанаар албан тушаалаас чөлөөлөгдсөн байна. NASA-ийн Хяналт шалгалтын газраас Taurus XL даалгавар амжилтгүй болсон шалтгаан нь тус төвийн худалдан авах ажиллагааны систем бөгөөд 700 сая ам.долларын өртөгтэй хөнгөн цагааны бүтээгдэхүүнийг гэрээлэгч байгууллагаас олон мянган хуурамч гэрчилгээ үйлдэж, чанарын шаардлага хангахгүй материал нийлүүлсэнтэй холбоотой гэж үзжээ.

Үүний дараагаар, NASA авлигатай тэмцэх хэд хэдэн арга хэмжээ хэрэгжүүлсэн боловч авлигын эрсдэл өндөр хэвээр байна. NASA даалгавар биелүүлэхээр тэрбум ам.долларын гэрээ байгуулахаар төлөвлөсөн нь мөн энэхүү эрсдлийг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ. Тус төвийн төсөв хасагдсан тул хувийн салбартай байгуулах гэрээнээс байгууллагын үйл ажиллагаа улам бүр хараат болж байгаа нь мөн үүнд сөрөг нөлөөтэй юм. Иймд, худалдан авах ажиллагааг авлигаас ангид байлгахын тулд NASA дараах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай юм. Үүнд:

- *Нэгдүгээрт*, гэрээ байгуулах сонгон шалгаруулалтыг улам нээлттэй болгох шаардлагатай. NASA-ийн сонгон шалгаруулалтад ихэвчлэн тус төвөөс өгсөн урилгын дагуу хувийн байгууллагууд оролцдог. Түүнчлэн, нууцын чанартай гэрээг нийтэд зарлалгүй хувийн байгууллагатай хийдэг нь ашиг сонирхлын зөрчлийн шинжтэй байж болзошгүй нөхцөл байдал үүсгэдэг. Ерөнхийдөө, NASA гэрээ байгуулах ажиллагааг улам нээлттэй болгоход шаардлагатай дүрэм, журмыг баталж, тогтвортой сайжруулах шаардлагатай юм.
- *Хоёрдугаарт*, тус төвийн хяналт шалгалтыг сайжруулах шаардлагатай байна. Хэдийгээр Хяналт шалгалтын газраас 74 сая ам.доллар хүртэлх өртөгтэй авлигын хэрэг болон бусад хэд хэдэн хэргийг илрүүлэн чухал ач холбогдолтой ажил гүйцэтгэсэн боловч бусад агентлагийн Хяналт шалгалтын газартай харьцуулахад хангалтгүй ажиллаж байна. АНУ-ын холбооны агентлагуудын Хяналт шалгалтын газар нь үйл ажиллагаандаа зарцуулсан 1 ам.доллар тутамд 9.59 ам.долларыг эргүүлэн олж, хууль бус үйлдлийг илрүүлж байхад тус төвийн Хяналт шалгалтын газар 1 ам.доллар тутамд 0.35 ам.долларыг эргүүлэн олж байгаа нь хангалтгүй юм. Түүнчлэн, төлөвлөгөөт аудитын хяналт шалгалтаар тус төвд олон тооны зөвлөмжийг тогтмол өгдөг боловч холбогдох газраас тус зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хангалттай ажиллаж чадсангүй.

Хэрэв NASA болон сансрын орон зай судлах бусад улсын байгууллагууд нийтийн болон хувийн салбар хоорондын хамтын ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байвал авлига болон бусад хууль бус үйл ажиллагааны эсрэг арга хэмжээг сайжруулах шаардлагатай юм.

АНУ-ын хөлбөмбөгийн дээд лиг: гэмт бүлэглэлийн үндсэн бай эсэх?⁵⁸⁷

2021.08.06. Ubong Udoeyo. Спортын авлига нь хэдийгээр шинэ асуудал биш боловч авлигатай тэмцэх байгууллага болон спорт хороодын санааг зовниулж буй асуудал байсаар ирсэн. АНУ-ын хувьд спортын авлигатай холбоотой асуудал, үйл ажиллагаа нь ихэвчлэн тус улсын хамгийн алдартай спортын үйл ажиллагаа буюу их сургуулийн америк хөлбөмбөг, их сургуулийн сагсан бөмбөг болон мэргэжлийн сагсан бөмбөгтэй холбогдолтой байсан. Гэвч өндөр түвшний бусад спортын үйл ажиллагаа мөн адил авлигын эрсдэлд өртөөд байна. Түүнчлэн, АНУ-ын спортын

⁵⁸⁷ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/08/06/major-league-soccer-a-prime-target-for-organized-crime-groups/>

салбарт хийсэн судалгааны дагуу авлигын хамгийн өндөр эрсдэлтэй спортын нэг нь Хөлбөмбөгийн дээд лиг⁵⁸⁸ (ХДЛ) байжээ.

Энэ нь уншигчдыг гайхшируулж магадгүй юм. Хэдийгээр, хөлбөмбөг дэлхийн хамгийн өндөр авлигын эрсдэлтэй спорт боловч АНУ-ын хувьд ХДЛ-тэй холбогдолтой авлигын үйлдлийн талаар анхаарал татахуйц мэдээлэл бага билээ. 2015 онд ХДЛ-ийн комиссар Дон Гарбер тус лигийг 100 мянган хувь цэвэр гэж мэдээлж байсан. Гэвч авлигын үйлдэл тогтоогдоогүй нь авлига байхгүй, эсхүл ирээдүйд бий болохгүй гэсэн үг биш юм. ХДЛ-ийн үйл ажиллагаанд спортын авлигын эрсдлийн хэд хэдэн хүчин зүйл байгаа нь тус лигт авлига байж болзошгүй гэх дүгнэлтэд хүргэлээ. Үүнээс гурван хүчин зүйл анхаарал татаж байна. Үүнд:

- *Нэгдүгээрт*, гэмт бүлэглэлүүд харьцангуй бага цалинтай тамирчдыг өөрсдийн бай болгодог. Учир нь тус тамирчид авлигын үйл ажиллагаанд оролцох боломж ихтэй байдаг. ХДЛ-ийн тамирчид бусад мэргэжлийн спортын тамирчидтай харьцуулахад бага цалинтай (ХДЛ-ийн доод цалин 2019 онд 56,250 ам.доллар, харин медиан цалин 175,285 ам.доллар байсан).
- *Хоёрдугаарт*, өндөр түвшний спортын авлига иргэдийн анхаарлыг ихээр татаж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шуугих явдал цөөнгүй тул авлигачид харьцангуй доогуур түвшний спортыг сонгон авж үйл ажиллагаа явуулдаг. Хэдийгээр хөлбөмбөг нь олон улсын түвшинд алдартай бөгөөд тус улсад нэр хүндээ тогтвортой нэмэгдүүлж байгаа боловч ХДЛ-ийн тоглолт хэвлэл мэдээллийн хэрэгслээр хязгаарлагдмал цацагддаг ба олон нийтийн анхаарлын төвд төдийлөн өртдөггүй юм.
- *Гуравдугаарт*, тамирчид болон албан хаагчдыг хахуульдаж тоглолтын үр дүнд нөлөөлөхөөс гадна, гэмт бүлэглэлүүд спортын клубийн франчайзын тодорхой хэсгийг өөрсдийн өмчлөлд авж, илүү түрэмгий стратеги ашиглан авлигын үйлдэл хэрэгжүүлдэг байна (Спортын клубийг шууд болон шууд бусаар өмчлөлдөө авснаар тоглогчдын солилцоо наймааг ашиглан өөрсдийн гэмт үйлдлийг гүйцэтгэх тамирчдыг худалдан авж, тоглолтын үр дүнд нөлөөлөх ажиллагааг хялбаршуулдаг). Энэхүү стратегийг ашигладаг гэмт бүлэглэлүүд ихэвчлэн санхүүгийн хүнд байдалд буй спорт клубийг бай болгодог юм. Цаашлаад, ХДЛ-ийн ихэнх клуб санхүүгийн хүндрэл бэрхшээлтэй нүүр тулгараад байна. (Нөгөөтээгүүр, ХДЛ-ийн нэг удирдлагатай систем нь гэмт бүлэглэлүүд өөрсдийн хүссэн тоглогчийг худалдан авах эрсдлийг бууруулж байна. Учир нь тус лигт тоглож буй бүх тамирчдын гэрээг зөвхөн ХДЛ-тэй шууд байгуулдаг.)

АНУ-ын спортын мөрийг хуульчлахыг дэмжиж буй мужуудын тоо нэмэгдсэн болон энэхүү эрсдлийн нөхцөл байдлууд нь ХДЛ-ийн тоглолтод мөрий тавих ажиллагаа авлигад өртөх эрсдлийг нэмэгдүүлж байна. Иймээс ХДЛ-ийн удирдлагууд АНУ-ын хөлбөмбөгийн спортын шударга байдлыг хамгаалж, үр дүнтэй арга хэмжээ хэрэгжүүлж, нийтэд ил тодоор зарлах шаардлагатай юм.

Нэн түрүүнд, ХДЛ мөрийг хянаж шалгах систем нэвтрүүлж, анхаарал татахуйц мөрий тавьж буй үйл ажиллагааг шалган тогтоох хэрэгтэй (ХДЛ энэхүү системийг шинээр бий болгох шаардлагагүй. Учир нь худалдааны хяналтын системийг тус байгууллага ашигладаг ба мөрийний үйл ажиллагаа эрхэлдэг компаниудаас шаардлагатай мэдээллийг хүлээн авж, тус системийг ашиглан хянах боломжтой). Түүнчлэн, ХДЛ-ээс сэжигтэй үйлдлийг илрүүлсэн тохиолдолд хэрэгжүүлэх шийдвэр гаргах түвшний арга хэмжээг тодорхойлж, нэвтрүүлэх ёстой. Цаашлаад, ХДЛ-ийн албан хаагчдыг мөрий тавихыг хориглох, аливаа клуб болон тамирчны нууц мэдээллийг задруулахыг хориглосон бодлого баримтлах хэрэгтэй. Энэхүү зөвлөмжийг өгөх нь илүүц мэт боловч албан хаагчид нь энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх нь хориотой эсэх талаар тус байгууллагаас ямар нэгэн мэдээллийг нийтэд мэдээлээгүй юм. Мөн ХДЛ-ийн дүрмийн дагуу тоглогч худалдан авахад ихэвчлэн хийдэг процессыг гажуудуулж, өөр арга замаар худалдан авсан тоглогчдыг шалгаж, авлигын шинж чанартай үйлдэл байгаа эсэхийг тогтоох дүрэм, журмыг батлан хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Европ болон Ази тивийн хөлбөмбөгийн спортын авлигын хүнд нөхцөл байдлыг харгалзан үзвэл, АНУ-ын хөлбөмбөгийн спорт авлигад өртөх нь ердөө цаг хугацааны асуудал юм. ХДЛ-ийн удирдлагууд дээр дурдсан авлигын эрсдлийг арилгахад шаардлагатай арга хэмжээг нэн даруй

⁵⁸⁸ Major League Soccer (MLS)

хэрэгжүүлж, авлигын үйл ажиллагааг үл тоомсорлох явдлыг зогсоох хэрэгтэй. Цаашлаад, ХДЛ нь өөрсдийн баримталж буй бодлого болон мөрдөж буй дүрэм, журмыг нийтэд ил тод мэдээлэх ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Авлигач бөгөөд хүчирхэг: Хятад улсын эдийн засгийн өсөлтийн парадокс⁵⁸⁹

2021.09.02. Хятадын алтлаг үе дэх эдийн засгийн өсөлт ба авлигын харилцан хамаарал

ТИ байгууллагын АТИ-д дурдсанаар Хятадын авлигын түвшин Энэтхэг улстай ижил хэмжээнд байна. Тэгвэл яагаад авлига нь Хятадаас илүүтэй Энэтхэгийн эдийн засагт их хэмжээний хор хохирол учруулж байна вэ? Хэдийгээр судлаачид Хятадын авлигын түвшин бүхий л салбарт өндөр байгаад санал нийлж байгаа боловч эдийн засгийн өсөлт хэрхэн энэхүү өндөр түвшинд хүрсэн бэ? Энэхүү асуултын хариултыг бидэнд дэлгэхээр “Хятадын алтлаг үе: Эдийн засгийн өсөлтийн парадокс ба их хэмжээний авлига” номын зохиолч Мичиганы их сургуулийн улс төрийн шинжлэх ухааны профессор Юэн Юэн Анг-ийн сэтгүүлч Кайсер Куотой ярилцсан подкастыг товчлон хүргэж байна.

Кайсер Куо: Хүрэлцэн ирсэнд баярлалаа. Юэн Юэн Анг

Юэн Юэн Анг: Намайг хүлээн авж уулзаж байгаад баярлалаа.

Кайсер Куо: Хятад улс хэдийгээр авлигын өндөр эрсдэлтэй улсын нэг боловч эдийн засгийн маш түргэн өсөлтийг бий болгож, ДНБ-ээс гадна ам.долларын нөхцөлийн хувьд мөн өндөр өсөлттэй байна. Иймээс авлига эдийн засагт хэрхэн нөлөөлдөг талаар та мэдээлэл өгнө үү.

Юэн Юэн Анг: Авлига эдийн засгийн өсөлтөд үргэлж сөргөөр нөлөөлж байдаг гэдэгтэй шинжээчид санал нийлдэг. Энэ нь хувийн салбарын хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлдөг бөгөөд олон улсын нөхцөл байдлаас харахад ядуу улс орнуудын авлигын түвшин ихэвчлэн мөн өндөр байдаг. Гэвч Хятад улс АТИ-ийн дагуу Өмнөд Африкаас өндөр хэмжээний авлигатай боловч олон арван жилийн турш эдийн засаг нь тасралтгүй үсрэнгүй хөгжиж байна. Энэ л асуудлыг бид Хятадын парадокс гэж нэрлээд байгаа юм.

Кайсер Куо: 1990 оны сүүлээр миний эцэг Хятадад бизнес хийж байсан. Тухайн үед Хятадад бизнес эрхлэхэд авлигатай тогтмол тулгарч буй талаар үргэлж гомдоллож байв. Би эцгээсээ “Хятадад гүүр барихад авлига яагаад саад болдоггүй юм бэ?” гэж асууж байсан юм. Хэрэв Энэтхэг, эсхүл Орост байсан бол бүтээн байгуулалт хийх хөрөнгө нь алга болно, эсхүл хугацаанаасаа маш хожуу баригдаж дуусна шүү дээ. Та өөрийнхөө номд авлигыг дотор нь хэсэгчлэн ялгаж салгасан байсан. Ингэхдээ авлигыг хар тамхи, эмийн бүтээгдэхүүнтэй зүйрлэж ангилсан нь ихээхэн сонирхол татсан шүү.

Юэн Юэн Анг: Тиймээ. Таны хэлсэнчлэн судлаачид авлигыг хэмжээгээр нь жижиг ба өндөр хэмжээний, төвлөрсөн болон алслагдсан гэж ангилж ирсэн. Гэсэн хэдий ч, зарим төрлийн авлига бусдаасаа онцгой шинж чанартай гэдгийг үгүйсгэх аргагүй. Иймээс би авлигыг дөрвөн төрөлд хувааж, хар тамхи, эмийн бүтээгдэхүүнтэй зүйрлэсэн. Эхний хоёр төрлийг би *авлигын хулгай* гэж нэрлэсэн, учир нь төрийн албан хаагч төсвийн хөрөнгийг хулгайлж өөрийнхөө халаасанд хийж буй үйлдэл юм. Тэрээр ийнхүү хулгай хийсний хариуд ямар ч үр нөлөө үзүүлэхгүй, хэнд ч туслахгүй. Энэ төрлийн авлигыг жижиг буюу цагдаагийн албан хаагч албаны эрх мэдлээ ашиглан иргэдээс 100 ам.доллар авах, эсхүл өндөр хэмжээний буюу төрийн өндөр албан тушаалтан өөрийн оффшор данс руу төсвийн олон сая ам.долларыг шилжүүлэхийг ойлгоно. Тэгэхээр энэ хоёр төрлийн авлигаас хүлээх үр дүн байхгүй бөгөөд авлигын хэмжээнээс хамаарч их, багаар нь ялгаж байгаа юм.

Энэхүү хоёр төрлийн авлигыг би хортой хар тамхи гэж дүгнэдэг. Тэгэхээр кокаин, героин, мөс зэрэг хар тамхи хүний эрүүл мэндэд их хэмжээний хор учруулахаас өөр үр дүнгүй байдагтай адил энэ төрлийн авлига эдийн засагт мөн хохирол учруулж байдаг. Энэ нөхцөл байдлыг бид төсвийн хөрөнгийг хувьдаа завших үйлдлээр гаршсан Нигери улсаас харж болно, төрийн албан хаагчид нь улс, орноо дээрэмдээд байхаар энэ улс хөгжихгүй шүү дээ. Харин гурав дахь төрлийн авлига буюу *хариутай авлига* нь хахууль өгсөн хүнд хариуд нь үйлчилгээ үзүүлж байгаа юм. Энэ

⁵⁸⁹ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://supchina.com/2021/09/02/corrupt-and-competent-unpacking-the-relationship-between-corruption-and-economic-growth-in-chinas-gilded-age/>

төрлийн авлигыг *хурдан хахууль* гэх ба доод, дунд шатны төрийн албан хаагчдад хахууль өгч хариуд нь үйлчилгээ түргэн хугацаанд авах, хүнд суртлыг даван туулдаг байдлаар нь ялгаж болно. Тухайлбал, гадаад паспорт, тусгай зөвшөөрлийг түргэн хугацаанд гаргуулж авахыг хэлнэ. Ерөнхийдөө, хурд худалдаж авж байна гэсэн үг. Үүнийг би өвчин намдаагчтай зүйрлэж байгаа. Өвчин намдаагч нь тухайн үед биеийг зовоож байгаа өвчнийг түр хугацаанд арилгадаг шүү дээ.

Дөрөвдүгээр төрөл нь хамгийн сонирхолтой буюу *нэвтрэх авлига* юм. Энэ төрлийн хахуулийг өндөр түвшний хүчирхэг албан тушаалтнуудад өгч хариуд нь нэвтрэх эрх буюу тусгай гэрээ, хууль, эрх зүйн зохицуулалт, монополи эрх зэрэг их хэмжээний мөнгө олох тусгай эрх, боломж худалдан авж байгаа юм. Үүнийг би капитализм дахь стероид гэж нэрлэж байгаа. Стероид нь булчингийн үйл ажиллагааг үлэмж хэмжээнд түргэн хугацаанд нэмэгдүүлдэг боловч урт хугацаандаа хүний биед маш их хор хөнөөлтэй байдаг.

Кайсер Куо: Ийнхүү авлигыг хар тамхи, эмийн бүтээгдэхүүнтэй зүйрлэсэн нь авлигыг ойлгоход дөхөм болгож байна гэж харлаа. Таны хэлснээр баян улс орнууд авлигатай байгаа, гэхдээ тэр авлига нь *нэвтрэх авлига* гэж хэллээ. Эдийн засгийг хөгжүүлдэг юм бол энэ төрлийн авлига сайн зүйл үү?, эсвэл авлига гэдэг утгаараа муу зүйл үү?

Юэн Юэн Анг: Энэ төрлийн авлига тогтворгүй, эрсдэлтэй эдийн засгийн өсөлтийг Хятадад бий болгосон байгаа юм. Гэсэн хэдий ч, иргэд миний номд бичсэн энэ томьёоллын “тогтворгүй, эрсдэлтэй” гэх хоёр үгийг арилгаад “Авлига нь эдийн засгийг хөгжүүлдэг” гэж цахим сүлжээнд бичиж байгаа асуудал байна. Зарим тохиолдолд академик түвшинд хүртэл ийнхүү бичих юм. Авлигыг хар тамхи, эмийн бүтээгдэхүүнтэй зүйрлэсэн нь авлига ямар ч тохиолдолд сайн зүйл биш, гэхдээ түүний нийгэмд үзүүлж буй хариу үйлдлийг судлах зорилгыг илэрхийлж байгаа юм. Одоогийн Хятад нь XIX зууны АНУ-ын “Алтлаг үе”-тэй ойролцоо нөхцөл байдалтай байна. Энэ үед нийгэмд зонхилох авлига нь *нэвтрэх авлига* байсан. Цаашлаад эдийн засгийн тэнцвэргүй, эрсдэлтэй өсөлтийг бий болгосон. Ийм ч учраас Ерөнхийлөгч Ши Жиньпин нэгдмэл хөгжлийн төлөө ажиллах ёстой талаар хэлж байна. Учир нь тус улсын ард иргэдийн эрх тэгш байдалд маш ноцтой асуудал үүссэн.

Кайсер Куо: 2007 онд Вен Жиабao нийгэм тэнцвэргүй байгаа талаар мэдээлж байсан.

Юэн Юэн Анг: Тиймээ. Энэ асуудал эртнээс байсан. Хятадын удирдагчид эдийн засгийн өсөлт нь тодорхой хор уршиг дагуулж байсныг үргэлж мэддэг байсан.

Кайсер Куо: Нийгмийн тодорхой, цөөн тооны этгээд банкнаас их хэмжээний зээл авч, засгийн газрын маш өндөр дүнтэй гэрээнд тогтмол сонгон шалгарч байгаа нь ийнхүү тэнцвэргүй байдал үүсгэхэд хүргэсэн нь харагдаж байна. Таны номд дурдсанаар ТИ байгууллагын АТИ-ийг алдаатай үнэлгээ гэж дүгнэсэн байсан. Та тус индексийн аргачлалыг өөрчлөх талаар холбогдох хүмүүстэй ярилцсан уу? Түүнчлэн Авлигын барометр судалгаа мөн таны хэлснээр, *хурдан авлигын* нөхцөл байдлыг үнэлж байгаа мэт харагдаж байна.

Юэн Юэн Анг: Тиймээ.

Кайсер Куо: Тус байгууллагаас боловсруулж буй судалгаанд зориулж энгийн иргэдээс авсан асуулгад Энэтхэг, Хятадын олон нийт маш ялгаатай байдлаар хариулсан байгаа юм. Гэвч АТИ-ээр энэ хоёр улсын авлигын хэмжээг жил бүр ойролцоо нөхцөл байдалтайгаар үнэлдэг. Тэгэхээр энэ судалгаа хангалттай нарийвчлалтай биш, ямар нэгэн асуудалтай байна гэдгийг харуулж байна.

Юэн Юэн Анг: Авлигын индексийг боловсруулснаар авлигын нөхцөл байдалд олны анхаарлыг татдаг сайн талтай. Гэхдээ алдаа дутагдалтай үнэлгээний систем боловсруулснаар авлигыг бодит байдлаас маш ноцтой асуудал гэх итгэл үнэмшлийг олон нийтэд олгож байгаа юм. Ингэснээр ард иргэдийн болон улс төрийн өндөр албан тушаалтны хүртэл авлигын талаарх санал бодолд нөлөөлдөг. Цаашлаад, хүн бүр аль улс хамгийн их авлигатай байгаа талаар мэдэх хүсэл сонирхолтой болж байна, гэвч хүмүүс аль улсад ямар төрлийн авлига зонхилж байгаа талаар мэдэхийг хүсдэггүй. Хүмүүс авлигын талаар нарийвчлан зөвлөлдөөгүй л бол энэ талаар асуудаггүй. Яг таны өөрийн эцэгтэйгээ ярилцаж байсан шиг.

Иймээс АТИ-ийг боловсруулахад илүү нарийвчилсан аргачлал ашиглах хэрэгтэй гэж би боддог. Гэхдээ Авлигын барометр судалгаагаар жижиг хэмжээний авлигын нөхцөл байдлыг тодорхойлсон нь АТИ-ийн ижил оноотой улс орнуудад өөр өөр төрлийн авлига зонхилсон

байдгийг харуулсан. Орчин үед хүмүүс хэрэглэхэд хялбар үнэлгээ гаргахыг шаардаж байгаа нь аливаа индексийг тоон утгаар боловсруулахад хүргэж байна. Үүнээс гадна, бид аливаа зүйлийг харьцуулах дуртай, Америкийг Хятадтай, Хятадыг Энэтхэгтэй зэрэг байдлаар харьцуулж, аль нь сайн, мууг мэдэхийг хүсэж байна. Гэвч бодит байдалд Хятадыг шууд Энэтхэгтэй харьцуулж дүгнэх боломжгүй. Үүнээс шалтгаалан илүү нарийвчлал, мэдээлэлтэй судалгаа хийхэд хүндрэл бэрхшээл үүсэж байна гэж би боддог.

Кайсер Куо: Та 15 орны Авлигын дэлгэрэнгүй индекс боловсруулахаар ажилласан тань ихээхэн сайшаалтай байна. Энэхүү судалгааны хүрээнд дээрх дөрвөн төрлийн авлигын түвшнийг хэрхэн боловсруулсан бэ?

Юэн Юэн Анг: Тиймээ. Би АТИ-ээс гадна авлигын түвшнийг үнэлдэг дахин нэг индекс боловсруулахыг хүссэн. Үүний хүрээнд би АТИ-ийг боловсруулахад ашигладаг аргачлал буюу шинжээчдийн дүгнэлтийг үндэслэн үнэлгээ боловсруулах аргачлалыг ашигласан. Тэгэхээр би Хятад, Тайланд, Индонез зэрэг улсын талаар мэргэшсэн судлаач шинжээч нарт хандаж тус улсын авлигын түвшнийг үнэлэхийг хүссэн юм. Тэгээд тэдний үнэлгээг нэгтгэж, нийт авлигын оноо, авлигын дөрвөн төрлийн түвшнийг үнэлсэн оноог боловсруулсан. АТИ нь олон байгууллагын судалгаа, шинжилгээний дүнд тулгуурладаг бол энэ судалгааг бид өөрсдөө хийж гүйцэтгэснээр давуу талтай байсан. Учир нь АТИ нь олон эх сурвалж ашигладаг тул ямар эх сурвалж ашиглаж байгаагаас шалтгаалан индексийн оноо нь тодорхой шалтгаангүй өсөж, буурдаг. Түүнчлэн мэргэшсэн судлаачийн санал бодлыг илэрхийлдэггүй. Тэгэхээр АТИ-ийн эх сурвалжийг ажиглавал, хүмүүсээс их ерөнхий асуулт асуусан байдаг. Тухайлбал, “АНУ-ын авлигын түвшнийг 0-10 оноонд үнэлнэ үү” гэдэг тэгээд та энэ асуултыг уншаад “Сайн мэдэхгүй юм даа. 7.5 оноо байх” гэж хариулна, яагаад 7.5 оноо өгсөн талаар хэн ч мэддэггүй.

Кайсер Куо: Тиймээ.

Юэн Юэн Анг: Тэгэхээр би энэ судалгааг илүү нарийвчлахаар хэд хэдэн үнэлгээ нэмсэн юм. Үүний дагуу улс орон бүрд ямар төрлийн авлига зонхилж байгаа талаар мэдэх боломжтой болсон.

Кайсер Куо: Та судалгаанд оролцож буй хүмүүст ямар зураглал ашигласан бэ?

Юэн Юэн Анг: Тэгэхээр хэсэг бүрд 5 зураглал ашигласан. *Нэвтрэх авлигын* хувьд ашигласан зураглалын нэг нь Бө Шилай юм. Тэгэхээр бодит амьдралын жишээг би зураглалдаа ашигласан. Бө Шилай гэх төрийн өндөр албан тушаалтантай нягт харилцаатай байснаар танай компани засгийн газраас зарласан тендерт тогтмол сонгон шалгарна. Энэхүү харилцаа хэр түгээмэл бэ? гэх асуулт жишээлбэл хэрэглэсэн.

Түүнчлэн барууны улс орнуудад элбэг байдаг үйлдэл буюу улс төрчид хувийн болон нийтийн салбарын хооронд тогтмол шилжиж ажилладаг үйлдлийг үнэлгээндээ багтаасан.

Кайсер Куо: АНУ-д хамгийн ихээр харагддаг “Эргэдэг хаалга” буюу албан тушаалтнууд хувийн болон нийтийн салбарын хооронд тогтмол шилжин ажилладаг. Ерөнхийдөө, хууль санаачлагчид албан тушаалаас буусны дараагаар хувийн салбарын лобби группд ажилд орж, тодорхой асуудлаар хууль санаачлагчдад лобби хийдэг, зарим тохиолдолд бүр лобби группийн албан тушаалтан хууль тогтоох албан тушаалд сонгогдоод, тус лобби хийж байсан асуудлыг шийдвэрлэх албан тушаалд очих тохиолдол гардаг. Тэгвэл АНУ-ын энэхүү практик нь Бө Шилайн авлигын хэргээс ямар ялгаатай юм бэ?

Юэн Юэн Анг: Тэгэхээр *нэвтрэх авлигыг* хууль ёсны болгосон тохиолдолд, ашиг сонирхлын зөрчил маш ихээр үүсдэг. Тухайлбал, АНУ-ын санхүүгийн хямралаас шалтгаалан их хэмжээний ашиг олсон хүмүүс байгаа шүү дээ, тэдгээр хүмүүс хуулийн ямар ч хариуцлага хүлээдэггүй. Тиймээс миний хувьд АНУ-ын энэхүү үйлдлийг авлигын шинж чанартай гэж үздэг.

Цаашлаад, бид авлигын талаар ийнхүү ярихад их хүндрэлтэй болж ирдэг, тиймээс ядуу буурай орны авлига, эсхүл Хятадын Бө Шилайн авлигын хэрэгтэй адил тодорхой албан тушаалтны үйлдэлд тулгуурлан авлигыг ярих нь илүү ойлгомжтой.

Кайсер Куо: Та өөрийн судалгааны хүрээнд Хятадыг бусад оронтой харьцуулахад ямар нөхцөл байдал ажиглагдсан бэ?

Юэн Юэн Анг: Тэгэхээр Хятад, Энэтхэг хоёрыг харьцуулан үзэхэд тус улсын авлигын нийт хэмжээ нь ижил түвшинд байсан. АТИ-д мөн адил ийм үр дүнтэй байгаа. Гэвч тус хоёр улсад буй авлига нь ялгаатай юм. Энэтхэгт хамгийн түгээмэл авлигын хэлбэр нь *хурдан авлига* бөгөөд төрийн албаны хүнд суртлыг даван туулахын тулд хахууль өгдөг. Харин Хятадад хамгийн түгээмэл буй нь *нэвтрэх авлига*, тэгэхээр иргэд аливаа зүйл олж авах, үйл ажиллагаанд нэвтрэх зорилгоор хахууль өгч байгаа юм.

Кайсер Куо: Хөрөнгө оруулагч Жим Рожерс өөрийн номдоо нэгэн сонирхолтой зүйл дурдсан байдаг. Аливаа улсын нисэх онгоцны буудалд буухад тухайн улсын авлигын нөхцөл байдлыг шууд харж болдог талаар бичсэн байсан. Виз, гадаад паспорт шалгах процесс нь ямар нөхцөл байдалтай байна, албан ёсны таксины зогсоолд хувийн автомашинтай иргэд үйлчилгээ үзүүлж байна уу гэх мэт зүйлээс дүгнэх боломжтойг дурдсан байдаг.

Юэн Юэн Анг: Аливаа улсад нэвтрэхэд авлигын нөхцөл байдлыг нь шууд харж болдог гэдэгтэй би санал нийлж байна. Би анх Нигери улсад газардаад, онгоцноос буусан даруй надаас хахууль нэхсэн, хахууль өгөхгүй бол тус улсад нэвтрэх боломжгүй байв. Төрийн албан хаагч надаас ил тодоор авлига шаардсан хамгийн анхны тохиолдол болсон юм. Үүнээс л тус улсын авлигын нөхцөл байдал шууд харагдаж байгаа юм. Тэд зүгээр л ил тодоор шууд нэхэж байсан. Харин Энэтхэг улсын төрийн албан хаагчид арай зөөлөн арга ашигладаг, Виз хариуцсан ажилтан нь надаас “Та яагаад Энэтхэгт дуртай болсон юм бэ?” гэж асууна, хариуд нь “Тиймээ, би танай улсад маш их хайртай” гэж хэлнэ, тэгээд би хахууль өгөхгүй бол миний паспортад штамп дарж өгдөггүй, би хахууль өгөөгүй учир дарааллын төгсгөлд буцаж очоод дахин хүлээсэн. Дахиж уулзаад “Та штамп дарж өгсөнгүй шүү дээ” гэж хэлэхээр маш дургүй дарж өгдөг. Хэрвээ Шанхайн нисэх онгоцны буудалд газардах юм бол та ердөө 2 минутын дараа гэхэд төв гудамжинд гараад ирсэн байна. Тэгээд танд үйлчилсэн төрийн албан хаагчийг үнэлхийг хүсдэг, мэдээж ийм түргэн үйлчилгээ авсан болохоор хамгийн сайн гэж л үнэлнэ шүү дээ. Иймээс ердөө онгоцны буудлаар үйлчлүүлэхэд тухайн гурван улсын ялгааг харж болно.

Кайсер Куо: Тиймээ, Таны номд эдийн засагт авлига нь төрлөөсөө хамаарч үзүүлэх нөлөө ялгавартай байдгийг дурдсан. Тэгвэл аливаа улс оронд аль төрлийн авлига яагаад их байдгийг тодорхойлсон онол бий юу? Уламжлал, соёл, зохион байгуулалтаас хамаарч ийнхүү өөр өөр төрлийн авлига давамгайлж байна уу? Энэ талаар та тайлбар хэлнэ үү.

Юэн Юэн Анг: Энэ асуултад хариулахад ихээхэн хүндрэлтэй. Миний номд дурдсанаар, нэгдүгээрт, улс төрийн дэглэмээс ихээхэн хамаардаг. Би нэг жишээ дурдая, хэрвээ та Дели хотод томоохон төрийн албан тушаалтантай уулзлаа гэхэд танд тэрээр “Би чиний асуудлыг хурдан шийдвэрлэж чадахгүй, харин шийдвэрлэлтийг зогсоож бол чадна” гэж хэлнэ. Эсрэгээрээ, Хятадын намын өндөр албан тушаалтантай холбоотой бол та ямар ч хүсэлт тавих шаардлагагүй. Намын нарийн бичгийн дарга нь гараараа ширээгээ цохиод л шууд шийдвэрлэдэг. Тэгэхээр ардчилсан улсад төрийн эрх баригчид аливаа шийдвэрийг эсэргүүцэх эрхтэй, тус эрх нь тэдний хамгийн том хүч болж байдаг. Иймээс тэд аливаа асуудлыг царцааж чадаж байгаа юм. Тэд хэдийгээр хурдан шийдвэрлэхийг хүссэн ч улс төрийн олон нөхцөл байдлаас шалтгаалан чадахгүй.

Харин Хятадад төрийн эрх мэдэл цөөн хэдэн этгээдийн гарт төвлөрдөг. Тэгэхээр хэрэв та зөв хүмүүстэй нөхөрлөж чадвал маш олон боломж нээгдэнэ гэсэн үг.

Кайсер Куо: Тэгвэл яагаад АНУ болон Хятадын нийгэмд адил төрлийн авлига зонхилдог юм бэ? Энэ хоёр орны улс төрийн дэглэм нь маш их ялгаатай шүү дээ.

Юэн Юэн Анг: Сайн асуулт байна. Энэтхэг улс АНУ-тай харьцуулбал төрийн чадавх, нөөц бололцоо бага, хөгжиж буй орон. Харин АНУ-ын төрийн чадавх, нөөц бололцоо маш сайн, тэд өөрсдийн тавьсан бодлогыг хэрэгжүүлж ажиллах чадамжтай улс. Тухайлбал, тус улсад татвар төлөхөөс зайлсхийх ямар ч арга байдаггүй.

Түүнчлэн эрх зүйн тогтолцоо нь боловсронгуй тул төсвийн сангаас завших зэрэг *авлигын хулгайн* үйлдлийг үр дүнтэй хянаж, таслан зогсоож чаддаг. АНУ-ын дундаж давхаргын иргэн гудамжаар явж байхад цагдаагийн албан хаагч түүнийг баривчилж, мөнгө шаардана гэсэн асуудал огт байдаггүй. Тиймээс миний өмнө дурдсанчлан *нэвтрэх авлига* тус улсад зонхилдог. Цаашлаад, тус авлигын хэлбэр хуульчлагдсан бөгөөд салбарын түвшинд хэрэгждэг. Харин Хятад бол капиталист эдийн засгийн хувьд шинэ тоглогч юм.

Кайсер Куо: Та Хятадын шилжилтийн үеийг цаг хугацааны үед хуваасан байсан. Тухайн үед ямар авлига зонхилж байсан бэ?

Юэн Юэн Анг: Тэгэхээр би өөрийн хичээлдээ тайлбарладагаар 1949 оноос хойш нэг Хятад улс бус харин хэд хэдэн Хятад улс оршин тогтносон. Тэгэхээр Хятад үргэлж нэг нөхцөл байдал, бодлоготой байгаагүй. Тус улс 1980 оноос хойш эрчимтэй шинэчлэл хийсэн юм. 1980 онд Хятад нь дэлхийн бусад улс орнуудтай адил энгийн хөгжиж буй орон шиг харагдаж байсан, тухайн үед жижиг хэмжээний авлига ихсэж, төрийн хүнд суртал өндөр хэмжээнд байсан буюу бүхий л төрлийн авлига зонхилж байв. Тухайн үеийн утга зохиолд энгийн ард иргэдэд тулгарч буй хүндрэл бэрхшээлийг их тодоор тусгасан байдаг. Тухайлбал, төрийн албан хаагчид тариаланчдыг дарамталдаг байсан. Цаашлаад үндэстэн дамнасан корпорацууд хүртэл авлигатай зохицож ажиллахаас өөр аргагүй байв. Цагдаагийн албан хаагчид Макдоналд түргэн хоолны газар очоод шууд л мөнгө нэхдэг байсан. Энэ нөхцөл байдал 1980-1990 оны хооронд түгээмэл байв. Харин 1998 оноос эрх баригчид Хятадын төрийн чадавхыг нэмэгдүүлэх чиглэлд эрчимтэй ажилласан.

1998 оноос хойш төсвийн хөрөнгийг завших, дарамтлах, жижиг хэмжээний авлигын үйлдэл нэг ёсондоо алга болсон. Тэгэхээр төрөөс маш энгийн зохицуулалтыг хийж эхэлсэн юм. Иргэд ямар нэгэн торгууль, хураамж төлөх тохиолдолд бэлэн мөнгө ашигладаг байсныг таслан зогсоож, бэлэн бус гүйлгээгээр төлбөр төлөх бодлого баримталсан төдий. Энэхүү энгийн техникийн реформ авлигыг хэд дахин багасгасан.

Цаашлаад, 2000 оноос дэд бүтцийн салбар эрчимтэй хөгжсөн. Хятад нь улс төрийн эдийн засгийн шинэ эринд шилжиж, мужийн захиргааг тус бүс нутгийн газрыг түрээсэлж олсон хөрөнгийг ашиглах эрхийг хуульчилсан. Үүний дагуу бүс нутгийн удирдлагууд хот төлөвлөлт, барилга, хот байгуулалтын салбарт тулгуурласан эдийн засгийн өсөлтөд бүх анхаарлаа хандуулж эхэлсэн юм. Ерөнхийдөө, мужийн газрыг хувийн салбарт маш их хэмжээгээр зарж борлуулж, олсон орлогыг бүхэлд нь дэд бүтэц хөгжүүлэхэд ашигласан юм. Тэгэхээр одоогийн Хятадын гайхалтай дэд бүтэц нь дөнгөж саяхан буюу 2010 оноос хойш л бий болсон зүйл. Үүнээс хойш шинэ барилга, гүүр, нисэх буудлууд ээлж дараалан баригдах болж, Хятадын эдийн засгийн өсөлтөд ихээхэн дэмжлэг үзүүлсэн. Гэвч нөгөөтээгүүр, санхүүгийн эрсдэл, засгийн газрын өр, өндөр эрсдэлтэй *нэвтрэх авлигыг* бий болгосон юм. Хувийн салбарынхан газар ашиглан их хэмжээний орлого олох боломжтой шүү дээ.

Кайсер Куо: Та судалгаандаа Хятадын талаарх ямар тоон мэдээлийг ашигласан бэ?

Юэн Юэн Анг: Нэгдүгээрт, авлигын хэргийг хянан шийдвэрлэсэн албан ёсны тоон мэдээг ашигласан. Ингэхдээ авлигын хэлбэрээс шалтгаалан олон төрөлд хувааж нягталсан. 2000 оноос хойш төсвийн хөрөнгийг завших гэмт хэрэг огцом буурсан байдаг. Эсрэгээрээ, өндөр хэмжээний авлига нэмэгдсэн. Хоёрдугаарт, хэвлэл мэдээллийн хэрэгслийн авлигын талаар мэдээлж буй байдлыг нягталсан, 2000 оноос хойш мөн л хэвлэл мэдээллийн хэрэгслээр авлигын хэргийн талаар мэдээлэх нь багассан байгаа юм.

Эсрэгээрээ, 2000 оноос хойш *нүцгэн албан хаагч* гэх нэршил олон нийтийн дунд дэлгэрэх болсон. Гадна талаасаа ядуу мэт харагдах боловч гадаад улсад их хэмжээний хөрөнгө, баялагтай төрийн албан хаагчийг хэлж байгаа юм. Түүнчлэн, *дэгжин хахууль* буюу мөнгө бус, урлагийн бүтээлийг хахуульд өгөх байдал дэлгэрсэн. Тэгэхээр урлагын бүтээлийн үнэлгээ субъектив учраас хуулийн байгууллагад мэдүүлэг өгөхдөө тус бүтээлийг хямдхан, эсхүл үнэтэй гэдгийг мэдээгүй гэх мэт зүйл хэлдэг. Чунчин хотын цагдаагийн албан хаагчийг мөрдөн шалгахад маш өндөр үнэтэй хувийн уран зургийн галлерэйтэй байсан тохиолдол гарсан. Бүр улсын музейд байдаггүй өндөр үнэтэй бүтээл хүртэл байсан. Үлэг гүрвэлийн өндөг хүртэл байсан гээд бод доо.

Кайсер Куо: Тэгэхээр Хятадад орлогыг хэрхэн хуваарилдаг талаар та мэдээлэл өгөөч.

Юэн Юэн Анг: Ши Жинпин төрийн эрхэд гарахаас өмнөх үеийн нөхцөл байдлыг би танд тайлбарлая. Учир нь одоогийн Хятад улсын нөхцөл байдал ихээхэн өөрчлөгдсөнийг та мэдэж байгаа. Тэгэхээр төрийн албан тушаалтан өөрийн байгууллагын үйл ажиллагаатай холбогдох хувийн байгууллагад хувьцаа эзэмшдэг байсан. Сумын жижиг компаниас эхлээд улсын сургуульд хүртэл тодорхой өмчлөлтэй байдаг.

Бө Шилайн түвшний албан тушаалтны хувьд түүний цалин, урамшуулал түүний анхаарлыг татдаггүй байсан. Учир нь түүний орлогын эх үүсвэр биш юм. Орлогын эх үүсвэр нь хувийн компаниудаас түүний гэр бүлд өгч буй бэлэг, хөрөнгө байсан.

Түүнчлэн, доод шатны албан тушаалтнууд тушаал дэвшихээс татгалзаж, бүр эсэргүүцдэг болсон. Учир нь тэд төрийн өндөр албан тушаалтан болж чадахгүй гэдгээ мэддэг бөгөөд байгууллагаас нь хангалттай урамшуулал, нэмэгдэл олгож байгаа тохиолдолд аливаа хариуцлага хүлээдэггүй доод шатны албан тушаалдаа удаан хугацаанд ажиллаж, хөрөнгө олох зорилготой болдог. Хятадын төрийн албан хаагч өөрсдийн энгийн цалингаар нэг өрөө байр ч түрээсэлж амьдарч чадахгүй. Тиймээс байгууллагаасаа авах урамшуулал, нэмэгдэл зэрэг нь маш чухал. Цаашлаад өөрсдийн төрсөн нутагтаа ажиллах сонирхол ихтэй байдаг.

Хятад нэг намын тогтолцоотой учир төрийн өндөр албан тушаалд томилогдоход маш их өрсөлдөөнтэй. Иймээс удирдах төрийн албан хаагчид нь маш өндөр чадварлаг, алсын хараатай ажилладаг. Үүнийг л би авлигач бөгөөд хүчирхэг гэж нэрлээд байгаа юм.

Цар тахал ба авлига 2021 онд⁵⁹⁰

2021.12.09. Дэлхий дахинаа 2021 оныг дараах хүндхэн нөхцөл байдалтайгаар үдэж байна. 262 сая гаруй хүн КОВИД-19 цар тахлын халдвар авж, 5.2 сая иргэн нас барж, Омикрон хувилбар олон улс оронд тархаад байна. Олон улсын түвшинд 8.2 тэрбум вакцин тараагдсанаас ердөө 5.8% нь хөгжил буурай оронд хуваарилагджээ. 2 жил гаруйн хугацаанд үргэлжилж буй цар тахлын дараагаар Африк тив дэх 4 эмч тутмын ердөө нэг нь вакцинд хамрагдаж, үлдсэн эмнэлгийн ажилчдыг халдварын өндөр эрсдэлтэй нөхцөл байдалд ажиллуулж байна.

Вакциныг шударга бусаар хуваан авсан талаар олон иргэн, байгууллага шүүмжилж байгаа бөгөөд вакцин тарих үндэсний сул дорой арга хэмжээ болон вакцин хийлгэхээс зайлсхийх байдал нь одоогийн эрүүл мэндийн салбар дахь нөхцөл байдлыг дээрдүүлсэнгүй. 2021 оны 11 дүгээр сард ДЭМБ-ын удирдах байгууллага болох Дэлхийн эрүүл мэндийн ассамблейд дэлхийн удирдагчид уулзаж цар тахалтай тэмцэх, хариу арга хэмжээ авж, эм тариа, вакцин, тестийг улс орнуудад тэнцвэртэйгээр тараах олон улсын баримт бичиг байгуулахаар хэлэлцэв.

Гэсэн хэдий ч цар тахлын үе дэх авлигын талаар ихэнх байгууллага, удирдагчид ам нээгээгүй бөгөөд авлигаас шалтгаалан цар тахлын нөхцөл байдал дордож байгаа талаар хэн ч авч хэлэлцсэнгүй. Авлига нь цар тахлын үе дэх нөөц бололцоог шаардлагатай газарт хуваарилахад хүндрэл учруулж, эрүүл мэндийн салбарын болон үндэсний вакцинжуулах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, олон нийтийн итгэлийг бууруулж, вакциныг зөв зохистой хуваарилахад саад учруулсан юм.

Одоогоор дэлхий дахинаа авлигаас шалтгаалж цар тахлын дараах нөхцөл байдал илрээд байна. Үүнд:

- Вакцин ба шинжилгээний хуурамч хариу зардаг хууль бус зах зээл бий болсон
- Цар тахлын үед төсвийн хөрөнгийн худалдан авалт, гэрээ байгуулах үйл ажиллагаанд авлига ихээр гарах болсон
- Вакцинжуулалт болон бусад эмчилгээний ил тод байдалд сөргөөр нөлөөлж, худал мэдээлэл түгээх болсон
- Цар тахалтай тэмцэх төсөв, вакцин болон эрүүл мэндийн багаж хэрэгслийг шамшигдуулах, хулгайлах үйлдэл ихээр гарах болсон
- Цар тахлын улмаас нас барсан болон халдвар авсан иргэдийн тоог хуурамчаар үйлдэх болсон
- Өндөр түвшний авлига дэлгэрч цар тахалтай холбогдуулан түүнийг мөрдөн шалгах ажиллагаа удааширснаар хариуцлагаас зайлсхийх соёлыг бий болгосон
- Эрүүл мэндийн салбар дахь жижиг хэмжээний авлигын хэмжээ ихэссэн.

Цар тахлын үед олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мөн дараах авлигын хэргүүд ил тод болжээ. Үүнд:

- Кени улсын Эрүүл мэндийн яамны албан тушаалтнууд бүлэглэн гадаад улсаас хандивласан вакциныг нэг бүрийг нь 177 ам.долларын үнэтэйгээр худалдан борлуулсан байна.
- Их Британийн засгийн газраас эрүүл мэндийн хамгаалах хэрэгсэл худалдан авах нийт гэрээний 66 гаруй хувь нь ВИП замаар буюу холбогдох хууль, журамд заасан ажиллагааг хийлгүйгээр, цөөн тооны компанитай байгуулагджээ.
- Өмнөд Африкийн 11 компани засгийн газарт эрүүл мэндийн хамгаалах хэрэгсэл худалдаж олсон орлогыг татварын албанд мэдээлээгүй боловч төрийн байгууллагатай гэрээ хийсэн хэвээр байна.

⁵⁹⁰ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.u4.no/blog/covid-19-corruption-in-2021-the-pandemic-rages-on>

- Цар тахалтай тэмцэх төсвөөс их хэмжээний хөрөнгийг шамшигдуулсан байна. Тухайлбал, ОУВС-гаас Афганистанд 27 мянган ам.доллар, Конгод 357 сая ам.доллар олгосон боловч албан тушаалтнууд шамшигдуулсан байна.
- Модерна болон Файзер компаниуд цар тахлын нөхцөл байдлаас ашиг олж байгаа талаар шүүмжлэл олон улсад дэлгэрэв. Мөрдөн шалгалтын явцад гэрээний нууцлалтай холбоотой зохицуулалт нь Файзер компанийг вакциныг үйлдвэрийн үнээс маш өндөр үнээр буюу нэг бүр нь 1 ам.доллороор худалдах боломжийг олгосон байна. Модерна компани зөвхөн чинээлэг улсуудад вакцин худалдаалж, ядуу буурай орнуудад вакциныг маш өндөр үнээр худалдан борлуулж байгаа талаар шүүмжлэл ихэд гарах болов.
- Файзер компанид ажиллаж байсан судлаач тус компанийг эрүүл мэндийн мэдээллийг хуурамчаар үйлдсэн талаар шүтэл үлээв.
- Хуурамч вакцин худалдаалагдаж эхлэв. 2021 оны 11 дүгээр сард хуурамч АстраЗенека вакцин Иран улсад олдсон байна.
- Сомали улсаас зарласан нийт нас барагчдын тоо бодит байдлаас 30 дахин бага байсныг илрүүлэв.
- Лесото улсад эрүүл мэндийн ажилчид вакцины гэрчилгээг нэг бүрийг нь 20 фунтын үнэтэйгээр худалдаалсан бол Австрали улсад иргэд хуурамч вакцины гэрчилгээ авахаар эмч нарт олон мянган австрали долларын хахууль санал болгож байна.
- Африк болон Зүүн Өмнөд Азийн улс орнууд вакцин хийлгүүлэхээс татгалзаж байна. Учир нь тус улс орнуудад авлигын түвшин өндөр учраас ард иргэд нь засгийн газарт итгэх итгэл буурч, вакцинд хамрагдахаас зайлсхийх болжээ.

Цар тахлын үе дэх авлигын нөхцөл байдал нь КОВИД-19-тэй тэмцэх, хариу арга хэмжээ авах ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Авлига нь эрүүл мэндийн салбарыг доройтуулж, өндөр ач холбогдол бүхий нөөц бололцоог үгүй хийж, цар тахлыг бидний бодсоноос урт хугацаагаар үргэлжлэх орчныг бүрдүүлжээ. Иймээс олон улсын түвшинд мэдээллийн ил тод байдал, эгэх хариуцлага, шударга ёсыг бататгах чиглэлд анхаарал хандуулж, 2022 онд өмнөх алдаагаа давтахаас зайлсхийх хэрэгтэй юм.

7. СУДАЛГАА, НИЙТЛЭЛ, ӨГҮҮЛЭЛ

Эрүүл мэндийн салбар дахь авлигатай тэмцэх нь - Афганистаны таван сургамж⁵⁹¹

2018.03.29. Mark Puman, Hussain Reza. Афганистанд айдас төрүүлэм үйл явдлуудын зэрэгцээ авлигатай тэмцэх талаар сонирхолтой зүйлс өрнөж байна. 2016 оны 06 дугаар сараас хойш боловсрол, худалдан авах ажиллагааны талаарх ахиц дэвшлээс гадна эрүүл мэндийн системд авлигын эсрэг томоохон санаачилга гарч байна. Энэхүү хүнд хэцүү нөхцөлд авлигын эсрэг амжилтад хүрсэн туршлага нь бусад орны авлигатай тэмцэгчид болон эрүүл мэндийн сайд нарт дараах таван сургамжийг өгч байгаа юм.

Нэгдүгээрт, улс төрийн хүчтэй, зоригтой манлайлал зайлшгүй шаардлагатай боловч ширүүн эсэргүүцлийг өдөөдөг. 2015 онд доктор Фероззудин Фероз Афганистаны Нийгмийн эрүүл мэндийн сайд болсон бөгөөд өөрийг нь авлигын хэрэгт буруутгаж байсныг ч үл харгалзан тэр даруй авлигын эсрэг зогсож, энэ талаар хэд хэдэн захирамж гарган, авлигын эрсдлийн хараат бус үнэлгээ хийлгэхийг хүссэн юм. 2016 оны 06 дугаар сард Хяналт шинжилгээ, үнэлгээний хороо эрүүл мэндийн салбар дахь авлигын асуудлыг шийдвэрлэж чадаагүй Яамыг маш их шүүмжилж, зуу гаруй зүйлийн өөрчлөлт



Доктор Фероззудин Фероз.
(Фото: blogs.lshtm.ac.uk)

⁵⁹¹ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2018/03/29/guest-post-tackling-health-sector-corruption-five-lessons-from-afghanistan/>

шинэчлэл хийхийг зөвлөсөн хараат бус тайлан гаргахад сайд уг тайланг ил тодоор дэмжиж байв.

Хэдийгээр парламентын гишүүдийн зүгээс маш их дарамт шахалт ирж байсан ч тэрээр импичментээр албан тушаалаас нь огцруулах гэсэн парламентын оролдлогыг даван гарсан юм. Афганистан дахь асуудлын нэг хэсэг нь парламентын гишүүд бөгөөд тодорхой хүмүүсийг, тэр дундаа эрүүл мэндийн салбарт ажилд авахыг яамнаас шаардаж, албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж гэрээ байгуулахад нөлөөлөхийг оролддог. Сайдын энэхүү хатуу байр суурь нь аюултай боловч зайлшгүй шаардлагатай байсан юм.

Хоёрдугаарт, эрүүл мэндийн салбар дахь авлигатай тэмцэх талаар хэсэгчилсэн бус, цогц, иж бүрэн арга хэмжээ авах нь зүйтэй. Хяналт шинжилгээ, үнэлгээний хорооны тайлан болон түүнээс урган гарсан шинэчлэлийн хүчин чармайлтын ялгагдах нэг зүйл бол түүний өргөн цар хүрээ байв. Энэхүү тайлан непотизм хайх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэхэд хүний эрхийг зөрчих, мөнгө нэхэх, залилан мэхлэх, үнэмлэх, диплом хуурамчаар бүрдүүлэх, ашиг сонирхлын зөрчил, төрийн өмчийг шамшигдуулах, хувьдаа завших, хахууль зэрэг эрүүл мэндийн салбарын авлигын асуудлуудыг бүхэлд нь хамарсан байна.

Дараа нь сайд Фероззудин Фероз эрүүл мэндийн тогтолцооны зургаан хэсэг болох (1) эрүүл мэндийн зохицуулалтын удирдлага, (2) эрүүл мэндийн үйлчилгээ, (3) бүтээгдэхүүний түгээлт, хадгалалт, (4) эрүүл мэндийн бүтээгдэхүүний маркетинг, (5) худалдан авах ажиллагаа, (6) санхүү, ажиллах хүчний менежмент дэх авлигатай тэмцэх дөрвөн үндсэн элемент болох (i) зохицуулалт, (ii) урьдчилан сэргийлэх, (iii) шийтгэх, (iv) олон нийтийн оролцоонд чиглэсэн авлигын эсрэг цогц стратегийг боловсруулсан байна.

Гуравдугаарт, бодлогын үр ашигтай багц шинэчлэл бүрэн хангалттай биш бөгөөд стратегийг хэрэгжүүлэх бат бөх бүтэц болон үйл явцыг бий болгож, түүнийг тайлагнах нь бас чухал юм. Афганистаны эрүүл мэндийн салбар дахь авлигатай тэмцэх хүчин чармайлтын хувьд эрүүл мэндийн салбарын оролцогч талууд болон яамны дотоод удирдах албан тушаалтнуудаас бүрдсэн удирдлагын хамтын ажиллагааны бүлгийг байгуулав. Мөн тэрбээр Ерөнхийлөгчийн идэвхтэй дэмжлэгийг авж, яамны ажилтнуудад зөвлөмжийг хэрэгжүүлэхийг даалгаж, эсэргүүцсэн зарим хүмүүсийг албан тушаалаас нь түдгэлзүүлсэн байна.

Зохион байгуулалтын хамгийн гол өөрчлөлтүүд нь Үндэсний анагаах ухаан, эрүүл мэндийн бүтээгдэхүүний зохицуулах газрыг шинээр байгуулсан (эмийн сан, эм импортлогч компани, лабораториудад аудит, хяналт шалгалтыг нэмэгдүүлж, лицензгүй олон зуун компанийг хар жагсаалтад оруулсан), мөн яамны бүтцэд Өргөдөл, гомдлыг хянах алба байгуулсан явдал байв.

Дөрөвдүгээрт, бодитой, нягт нямбай хяналт шинжилгээг хүрэлцээтэй нөөцөөр хангах нь амин чухал юм. Афганистаны эрүүл мэндийн салбарын хувьд Хяналт шинжилгээ, үнэлгээний хороо хяналтын дараах шинэ хэлбэрийг бий болгов. Зөвлөмжүүд хэрэгжиж дууссан эсэхийг уламжлалт маягаар зөвхөн дөрвөлжин нүдэнд тэмдэглэхийн оронд эрүүл мэндийн гурван байгууллага бүрд нэг сарын хугацаатай ажиллаж, шаардлагатай арга хэмжээ хэрэгжиж байгаа эсэх талаар эрүүл мэндийн ажилтнууд, өвчтөнүүд, эмч нартай ярилцах тус бүр хоёр хүний бүрэлдэхүүнтэй баг байгуулав. Энэхүү идэвхтэй хяналт нь нэлээд өртөг өндөртэй боловч энэ талбарт үнэхээр юу өөрчлөгдөж байгаа талаар Хяналт шинжилгээ, үнэлгээний хороо болон Яам хараат бус мэдээллээр хангагдах анхны алхам болсон юм.

Одоогийн байдлаар тус Хороо нь хяналтын энэхүү хэлбэрийг бүх яамд дээр томоохон дүн шинжилгээ хийхдээ ашиглаж байна. (Хяналт шинжилгээ, үнэлгээний хороо улирал тутмын тайлангаа нийтэлдэг бөгөөд эндээс⁵⁹² үзэх боломжтой.)

Тавдугаарт, олон нийт болон орон нутгийн удирдагчидтай зарим талаар ил тод байдал, санал хүсэлтийг нь хангах, зарим талаар найдвар хүлээлтийг нь зохицуулах зорилгоор ажиллах. Афганистаны эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд үүссэн нэг асуудал бол гэрээт эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх талаарх олон нийтийн хүлээлт болон яам, ТББ-уудын чадварын хоорондын үл нийцэх байдал юм. Энэхүү зөрүүтэй байдал нь олон нийтийн дунд үл итгэх байдал, яамны талаарх сөрөг ойлголтыг бий болгож, улмаар яам нь ТББ-уудыг хүмүүсийн хэрэгцээг хангахын тулд “хүчилдэггүй”, өөрийн үйлчилгээ үзүүлэх тогтолцоог завхруулсан гэсэн ойлголтыг өргөнөөр бий болгожээ. Энэ бол ноцтой асуудал бөгөөд Сайдын стратеги нь 12-18

⁵⁹² <https://mec.af/reports/follow-up-reports/>

сарын хугацаанд авлигын эсрэг шинэчлэлийг эхлүүлэх, дараа нь олон нийтийн уулзалт, үйл ажиллагаагаар хөндөгдөж буй асуудлуудад анхаарал хандуулах болно. Тэгэхээр энэ нь үр дүнд хүрэх эсэхийг хэлэхэд нэлээн эрт байгаа юм.

Дэлхийн авлигатай тэмцэх байгууллагуудын зураглал (тойм) нэртэй тайлан гарчээ

2020.05.14. Францын Авлигатай тэмцэх байгууллага ГРЕКО, ЭЗХАХБ болон Авлигаас урьдчилан сэргийлэх байгууллагуудын сүлжээтэй хамтран улс орнуудын авлигатай тэмцэх байгууллагын талаар судалгааны төсөл хэрэгжүүлсэн бөгөөд төслийн тайланг “Дэлхийн авлигатай тэмцэх байгууллагуудын зураглал” нэртэйгээр гаргасан байна.

Уг тайланг дэлхийн 114 улс орны 171 байгууллагад хийсэн онлайн судалгаанд үндэслэн гаргасан байна. Төслийн зорилго нь дэлхийн улс орнуудад байгуулагдсан авлигатай тэмцэх олон төрлийн байгууллагуудын талаарх мэдээллийг цуглуулах, төвлөрүүлэх, тархаах байсан юм. Өргөн хүрээний мэдээлэл цуглуулалтын зорилго нь авлигатай тэмцэх байгууллагуудын шинж чанар, тэдний шаардлагын талаар авлигатай тэмцэх чиглэлийн судлаачдын ойлголтыг нэмэгдүүлэхэд туслах, мөн түүнчлэн, эдгээр байгууллагуудын нийтлэг хандлага, сорилт бэрхшээлийг тодорхойлох, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх явдал байсан аж.

Судалгааны тайланд дүгнэхдээ, ерөнхий байдлаар, улс орнуудад авлигатай тэмцэх чиг үүрэг бүхий нэг байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү байгууллага нь ихэнхдээ хуулийн этгээдээс илүүтэйгээр хувь хүнтэй холбоотой мөрдөн шалгах болон/эсхүл яллах чиг үүрэгтэй байна. Авлигатай тэмцэх байгууллагуудаас хариуцлага хүлээлгэх механизм нь ихэвчлэн захиргааны шинж чанартай байна. Ихэнх авлигатай тэмцэх байгууллагууд нь үндэсний авлигатай тэмцэх стратегийг боловсруулахад оролцсон байгаа бол бага хувь нь хөрөнгө болон ашиг сонирхлын мэдүүлгийн үйл ажиллагааг зохицуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын 39% нь өөрийн авлигатай тэмцэх байгууллага нь удирдах албан тушаалтнуудын хөрөнгө болон/эсхүл ашиг сонирхлын мэдүүлгийн үйл ажиллагааг зохицуулах чиг үүрэгтэй байна.

Тайланг үзэх холбоос: https://www.agence-francaise-anticorruption.gouv.fr/files/files/NCPA_Analysis_Report_Global_Mapping_ACAs.pdf

Их сургууль дахь авлига: мөсөн уулын орой юу?⁵⁹³

2020.06.27. Goolam Mohamedbhai. “Дээд боловсролын салбар дахь авлига: Дэлхий дахины сорилт ба хариу арга хэмжээ” хэмээх ном хэвлэгдэн гарсан байна. Энэхүү номд 2016-2018 онд гарсан нийтлэлүүдийг нэгтгэн гаргасан бөгөөд нийтдээ 30 орчим улсын жишээ, 25 сэдвийг хамруулсан байна.

Авлигын цар хүрээ

Дээд боловсролын салбар дахь авлига дэлхий дахины асуудал болсон бөгөөд өндөр хөгжсөн болон хөгжиж буй улс орнуудад ялгалгүй гарч байгааг энэ номд харуулсан байна. Швед, Швейцари, Япон зэрэг улс орнуудын дээд боловсролын салбар дахь авлигын талаар номд авж үзсэн нь зарим уншигчдын хувьд цочирдохуйц зүйл байж болох юм. Авлигын шинж чанар, ач холбогдол нь бүс нутгийн хувьд харилцан адилгүй байна.

Номд хэд хэдэн удаа гарч ирж буй нэг асуудал бол бид авлига гэдгийг яг юу гэж үзэх вэ гэсэн асуудал байв. “Авлига” гэсэн нэр томъёог нарийн тодорхойлох нь төвөгтэй юм. Жишээлбэл, зарим улс оронд бусдын бүтээлийн хулгай (plagiarism), албан тушаалын байдлаа ашиглан гэр бүлийн гишүүдээ ажилд оруулах, зүй бусаар давуу байдал олгох (nepotism) явдлыг авлига гэж үзэж байхад зарим улс оронд байж болох зүйл гэж хүлээн зөвшөөрч байна. Мөн түүнчлэн, шалгалтдаа хуулах, их сургуулийн дипломыг хуурамчаар үйлдэх зэрэг ёс зүйгүй явдлын талаар хоёрдмол утга байж болохгүй билээ.

⁵⁹³ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.universityworldnews.com/post.php?story=20200624152823873>

Номыг уншиж байхад дээд боловсролын салбарт авлига хэр гүнзгий нэвчсэн байгааг ойлгох болно. ТИ байгууллагаас 2013 онд “зарим тохиолдолд авлига нь дээд боловсролын бүхий л тогтолцоог эзэлсэн” гэж онцолж байсан нь үнэн болж байна. Номоос харахад энэ байдал дор хаяж Орос, Украин, Энэтхэг улсын хувьд үнэний ортой байж болохоор байна. Магадгүй бид мөсөн уулын зөвхөн оройг харж байх болох талтай.

Дээд боловсролын салбар дахь авлигыг судлах, эсхүл мөрдөн шалгахад маш хүнд байдаг. Их сургуулиуд авлигын хэргийг бараг л хэзээ ч мэдээлэхгүй, мөн түүнчлэн, нэр хүндээ алдахаас сэргийлж хэвлэл мэдээлэлд мэдэгдэх явдлыг хязгаарлах оролдлогыг тогтмол хийдэг. Тиймээс ихэнх улс орнуудын дээд боловсролын салбар дахь авлигын бүрэн цар хүрээ тодорхойгүй байна. Мөн улс орнуудын, ялангуяа хөгжиж буй улс орнуудын дээд боловсролын систем хөгжсөнөөр авлига улам нэмэгдэх магадлалтай.

Авлигын шалтгаан

Яагаад дээд боловсролын салбарт авлига тархсан байна вэ? Номд тусгагдсан хэд хэдэн бүлэгт шалтгааныг тодорхойлох оролдлого хийсэн байна.

Оюутнуудын талаас харахад үндэсний болон олон улсын сайн их сургуульд орох явдал хязгаарлагдмал байдаг бөгөөд чадавч муутай оюутнууд сургуульд элсэхийн тулд сургуулийн ажилтан болон хөндлөнгийн зууч этгээдүүдтэй хуйвалдаан зохион байгуулдаг. Улмаар сургуульд элсэж орсноор эдгээр оюутнууд ажилд ороход зайлшгүй шаарддаг зүйл болох эрдмийн зэргээ хамгаалахын тулд бүхий л боломжит ёс зүйгүй аргуудыг эрэлхийлдэг.

Харин багш нарын хувьд ихэнхдээ цалин багатай байдаг бөгөөд сургуулийн үйл ажиллагаа болон сургуулиас гадуур бусад үйл ажиллагаанаас орлогоо нэмэгдүүлэх арга замыг хайж байдаг. Эсхүл тэд богино хугацаанд тушаал дэвших, нэр хүндтэй сэтгүүлд бүтээлээ нийтлэх, сайн үр дүн гаргаж авахын тулд судалгааны мэдээллээ хуурамчаар үйлдэх зэрэг оролдлого гаргадаг.

Энэ номд дурдаагүй нэг хүчин зүйл бол улс төрийн нөлөө юм. Хөгжиж буй улс орнуудад улсын сургуулийн Удирдах зөвлөлийг засгийн газраас томилдог бөгөөд засгийн газрын нөлөө уг Зөвлөлд их байдаг.

Их сургууль нь оршин буй тухайн нийгэм, улс орны тусгал болдог гэсэн баримт ч байдаг. Өөрөөр хэлбэл, авлига бүх салбарт нь тархсан улс орны хувьд дээд боловсролын салбар нь ч мөн авлигад автсан байдаг.

Авлигыг устгах

Дээд боловсролын салбар дахь авлига ихээхэн төвөгтэй бөгөөд засгийн газар, хууль тогтоох байгууллага зэрэг олон талууд уг үйл ажиллагаанд оролцож байдаг. Энэ байдал нь авлигыг устгахад хүндрэлтэй болгодог.

Авлигыг устгах олон санал санаачилга байдаг бөгөөд тэдгээрийн заримаас дээрх номд тусгасан байна.

Санал нэгдэж болох нэг санаа бол авлига юунаас бүрддэг талаар нийтлэг ойлголтыг бий болгохын тулд оюутан, багш нарт зориулан ёс зүйн чиг баримжаа олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэх явдал юм.

Өөр нэг үр дүнтэй санаа бол хуурамч баримтыг устгахын тулд диплом, дүнгийн мэдээллийг үүсгэхдээ блокчэйн технологийг ашиглах явдал юм.

Зарим их сургуулиуд ёс зүйн дүрэм, авлигын эсрэг бодлогын баримт бичиг бий болгосон ч хэрэгжилт хангалтгүй байна. Мөн шүгэл үлээх асуудлыг дэмжсэн байдаг ч оюутнуудын нэгдмэл байдал, багш нар удирдлагаас хариу дарамтад орохоос айх айдас зэргийн улмаас хэрэгжилт муу байна.

Цор ганц, эсхүл богино хугацаанд үр дүнг бий болгох шийдэл байхгүй юм. Хэдий тийм ч аль болох олон талуудыг хамруулсан сайтар төлөвлөсөн арга хэмжээг урт хугацаанд хэрэгжүүлэх нь үр дүнтэй байхаар байна.

Мэдээллийг түгээж, оролцогчдын дунд ухамсрыг нэмэгдүүлж, байгууллагууд туршлагаа хуваалцах нь авлигатай тэмцэх өөр нэг үр дүнтэй арга болдог. Тиймээс энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг талуудад уг номыг санал болгож байна.

Узбекистаны их, дээд сургуулиадад
авлигын шалтгаан, нөхцөлийг тодруулах
үүднээс судалгаа зохион байгуулсан
байна⁵⁹⁴

2020.06.29. Узбекистан улсын Ерөнхий прокурорын газарт авлигатай тэмцэх, шүүх эрх зүйн асуудлаар зөвөлгөөн болсон талаар тус байгууллагын хэвлэлийн мэдээнд дурдсан байна.

Тус улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу дээд боловсрол, барилга, эрүүл мэндийн салбарт “Авлигын эсрэг салбар” төслийг хэрэгжүүлэхээр баталжээ. Уг ажлын хүрээнд дээд боловсролын байгууллагуудад олон нийтийн зөвлөл байгуулж, авлигын шалтгаан, нөхцөлийг тодорхойлох зорилгоор асуулга, судалгаа явуулсан байна. Түүнчлэн тухайн салбарын яам, байгууллагын удирдлагад нэрээ нууцлан цахимаар хандах боломжийг олгожээ.

Ташкент хотод хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын салбарт “Барилгын хяналт” дэд төслийг хэрэгжүүлсэн бөгөөд үйл ажиллагааны явцад холбогдох баримт бичгийг цахимаар танилцуулж байхаар төлөвлөсөн байна.

Эрүүл мэндийн салбарт хэрэглэгчдийг хүнсний бүтээгдэхүүнээр хангах, цагаан хэрэглэлийн цэвэрлэгээ, барилга байгууламжийн засвар үйлчилгээ, тэдгээрийн инженер техникийн засварыг гүйцэтгэх, мөн эмнэлгийн тоног төхөөрөмжийн засварын үйлчилгээ үзүүлэх ажлыг хуулийн этгээдэд шилжүүлэх боломжтой болсон.

Мөн авлигатай тэмцэх чиглэлээр хэрэгжүүлж буй цогц арга хэмжээний хүрээнд тус улсад авлигын эсрэг орчин үеийн цахим тогтолцоог нэвтрүүлэх, авлигатай тэмцэх ухуулга сурталчилгааг эрчимжүүлэхэд олон нийтийг оролцуулах, хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглах талаар тусгасан байна.

Авлигын эсрэг үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлэх, тодорхой арга хэмжээ авах уг шинэ төслийн талаар 2019 оны 10 дугаар сард хууль хяналтын байгууллагуудад танилцуулж байсан. Уг төсөл нь НҮБХХ-ийн дэмжлэгтэйгээр хэрэгжсэн байна. Төслийн зорилго нь яам, төрийн байгууллагын үйл ажиллагаанд авлигын эсрэг тогтолцоог бий болгох, нэвтрүүлэхэд чиглэжээ.

Үзэл бодол: Эрүүл мэндийн салбар дахь
худалдан авах ажиллагааны авлигыг хэрхэн
хязгаарлах вэ⁵⁹⁵

2020.07.01. Нийтлэлийг бичсэн: *ТИ байгууллагын эрүүл мэндийн санаачилгын төслийн ахлах ажилтан Шон Дарби, мөн төслийн ахлах судлаач, ухуулга нөлөөллийн ажилтан Том Райт*

Чанаргүй амьсгалын аппарат, хэт өндөр үнэтэй тоног төхөөрөмж, худалдан авалтын өндөр ашигтай гэрээг маш бага, эсхүл огт чадваргүй компаниудтай байгуулж байна. Энэ бүхэн бол Их Британи, АНУ, Бразил, Словени зэрэг улсаас КОВИД-19 цар тахлын үеэр бидний харсан нийтлэг зүйлсийн цөөн хэд нь билээ.

Ердийн үед жил бүр төрийн худалдан авах ажиллагааны гэрээний үнийн 10%-25% нь авлигын улмаас алдагддаг.

Гэвч одоо тайван цаг үе биш. Яаралтай хэрэгцээ, нийлүүлэлтийн хомсдол, хэт ачаалалтай эрүүл мэндийн тогтолцоо, авлигад өргөн боломж өгч буй засгийн газрууд зэргээс үүдэлтэй коронавирусын цар тахлын үед дээрх тоо хэмжээ илүү өндөр байгаа гэдийг хялбар таамаглах боломжтой.

Хэрхэн ийм зүйл болов?

Дэлхийн улс орнуудын засгийн газрууд худалдан авах ажиллагааны хяналт, тэнцвэртэй байдлаа сулруулан энэхүү онцгой байдалд хариу арга хэмжээ авж байна. Ихэнх нь онцгой нөхцөл байдлын үеийн хууль тогтоомжийг уриалж, өрсөлдүүлэхийн тулд нээлттэй тендер шалгаруулалт

⁵⁹⁴ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://uz.sputniknews.ru/society/20200629/14442832/V-vuzakh-Uzbekistana-proveli-anonimnye-oprosy-dlya-vyyavleniya-prichin-korrupsii.html>

⁵⁹⁵ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.devex.com/news/opinion-how-to-tackle-corruption-in-health-procurement-97575>

явуулах ёстойг байдаг ч, оронд нь “шууд гэрээ” гэж нэрлэгдэх аргаар нэг нийлүүлэгчийг шууд сонгож байна.

Жишээлбэл, Их Британид NHS London Procurement Partnership зэрэг захиалагч байгууллагууд коронавирустэй холбоотой тоног төхөөрөмжийг худалдан авахдаа тендерээ нээлттэй зарлах шаардлагыг хэрэгжүүлэхгүйгээр нийлүүлэгч талуудтай шууд хэлэлцээр хийж байна. Эрсдэл нь юу вэ? Нягтлан шинжих буюу өртөг, тоо хэмжээ, чадварын харьцуулалт хийхгүйгээр цөөн тооны бүлэг хүмүүс сонголтыг хийж байна.

Зах зээлд эрэлт өндөр байгаа нь засгийн газруудыг өмнө нь хэзээ ч хамтран ажиллаж байгаагүй компани, эсхүл мэргэжлийн түвшний эрүүл мэндийн бүтээгдэхүүн нийлүүлж байсан түүхгүй талуудтай гэрээ байгуулахад хүргэж байна.

Үнэ зохиомлоор өсөх, зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүний хомсдол үүсэх зэрэг нь мөн ердийн үзэгдэл болчихоод байна. Ийм байдал АНУ, Герман, Бразил болон бусад улс орнуудад бий болсон. Уганда дахь ТИ байгууллагын ажилтнууд онцгой байдлын үеийн хоолны үнэ зохиомлоор өссөн болохыг гэрчилж байгаа бөгөөд үүнд Ерөнхий сайдын удирдлагад ажиллаж байгаа хүмүүс хувьдаа ашиг олох зорилгоор зохион байгуулсан гэж буруутгах явдал гарч байна.

Бусад засгийн газрууд мэдээлэл авах эрхийн дагуу гаргаж буй хүсэлтэд хариулах үүрэг хариуцлагаа сулруулчихаад байна. Италийн засгийн газар энэ төрлийн тодорхой хүсэлтийг хүлээн авахгүй байгаа бол Румыны засгийн газар цар тахал дууссанаас хойш 30 хоног хүртэл дээрх төрлийн хүсэлтэд хариу өгөх явдлыг хойшлуулаад байна. Мэдээлэл авах эрхийн дагуу хүсэлт гаргах гэдэг нь авлигын эсрэг үр дүнтэй арга хэрэгслийн нэг болж ирсэн бөгөөд эрүүл мэндийн салбар дахь худалдан авалт шиг зарим талаараа ил тод бус байгааг ил тод болгоход чиглэсэн цорын ганц алба ёсны механизм болдог.

КОВИД-19 шиг дэлхийн эрүүл мэндийн хямрал нь худалдан авалтын хяналт, тэнцвэрийг сулруулж, авлига цэцэглэн хөгжих боломжийг гарцаагүй бий болгодог уу? Бид хариулт нь үгүй гэдэгт итгэж байна.

Эрүүл мэндийн салбарын худалдан авалтад ил тод байдлыг нэмэгдүүлэх

Төрийн худалдан авалтууд тэр дундаа эрүүл мэндийн салбарын худалдан авалт яагаад авлигад өртөмтгий байгаагийн үндсэн шалтгаан бол энэ худалдан авалт нь ихэнх тохиолдолд ил тод бус, хаалттай байгаа явдал юм.

Бид эрүүл мэндийн салбарын худалдан авах ажиллагаан дахь авлигыг бууруулах арга зам байгаа гэдэгт итгэдэг. Энэ бол нээлттэй тендер шалгаруулалт юм.

Нээлттэй тендер шалгаруулалт нь худалдан авах ажиллагааны үе шат бүрд төрийн байгууллагуудыг хариуцлагатай байлгахын тулд иргэний нийгэм, бизнес эрхлэгч нар хамтран ажиллах боломжийг үүсгэх зорилгоор ил тод байхад тулгуурладаг. Үр дүнд нь мөнгөний урсгалыг хянаж, эрүүл мэндийн салбарын худалдан авалтад хариуцлагатай байдлыг бий болгодог.

Энэ үе шат нь үнийн харьцуулалт хийх боломжийг олгох бөгөөд үнийг зохиомлоор өсгөх, хууль бусаар үнэ тогтоох, хэт их төлбөр хийхийг хязгаарладаг.

Цар тахлын үед авлигын боломжийг хэрхэн арилгах вэ

ТИ байгууллагын эрүүл мэндийн салбарт нээлттэй тендер шалгаруулалтыг бий болгох ОС4Н төслөөс онцгой байдлын үеийн нөхцөл байдлыг хувийн зорилгоор ашиглах явдалтай тэмцэх иргэний нийгмийн боломжуудыг санал болгож байна. Үүнд:

1. КОВИД-19-ийн хяналт, нөлөөллийн асуудлаар чадавхаа бэхжүүлэх;
2. Онцгой байдалтай холбоотой зардал дахь авлигыг эрсдлийг хэрхэн удирдах талаар үндэсний болон олон улсын түвшинд мэдлэг дээшлүүлэх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах;
3. Онцгой байдлын үеийн худалдан авалтын талаарх мэдээллийг цуглуулах, КОВИД-19-ийн худалдан авалтыг хянах арга хэрэгслийг бий болгох;
4. Цуглуулсан мэдээлэл, дүн шинжилгээгээ ашиглан засгийн газар ба иргэний нийгмийн хоорондын яриа хэлэлцээг бий болгох.

2020.07.13. Гай Рубинштайн. Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил Израил улс ажлын байран дээрх хууль бус үйлдлийн талаар мэдээлж, илчилдэг шүгэл үлээгчдийн үнэ цэнийг эртнээс хүлээн зөвшөөрсөөр ирсэн. Жишээлбэл, эдгээр шүгэл үлээгчгүйгээр Израилийн иргэд болон хууль сахиулагчид тус улсын татварын байгууллага, хотын захиргаа болон бусад байгууллагатай холбоотой авлигын хэргүүдийн талаар хэзээ ч олж мэдэхгүй байсан. Шүгэл үлээгчдийг илүү их дэмжихийн тулд Израил улс Хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалах хууль зэрэг хууль тогтоомжийг гаргасан байдаг. Хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалах хууль нь анх 1997 онд батлагдсан бөгөөд үүнээс хойш гурван удаа нэмэлт өөрчлөлт орсон. Уг хуулиар ажил олгогчдыг ажилтнуудаа шүгэл үлээсний төлөө хариу арга хэмжээ авахыг хориглож, ажилчдад ээлтэй механизмыг бий болгосон. Энэ асуудалтай холбоотой хэрэг, маргааныг Израилийн хөдөлмөрийн маргааныг дагнасан шүүх шийдвэрлэдэг. Шүүх нөхөн олговрын хохирлыг барагдуулахаас гадна ажил олгогчдод хохирол барагдуулах талаар шийдвэрлэх эрхтэй бөгөөд нэхэмжлэгчийг ажлаас халсныг хүчингүй болгох, эсхүл шүгэл үлээгчдийг ажлын байранд “өөр зохих албан тушаалд” шилжүүлэх шийдвэр гаргах эрхтэй байдаг. Хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалах тухай хууль нь шүгэл үлээгчдэд хүчтэй хамгаалалт мэт боловч түүний үр дүнг ихээхэн алдагдуулдаг хоёр том сул талтай. Шүгэл үлээгчийг зохих ёсоор хамгаалахын тулд эдгээр асуудалд анхаарал хандуулах шаардлагатай.

Нэгдүгээрт: Хөөн хэлэлцэх хугацаа маш богино байна. Хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалах тухай хуульд иргэний нэхэмжлэлийг тухайн үйлдэл гарснаас хойш 12 сарын дотор гаргах ёстой. Энэ нь Израилийн бусад хууль тогтоомжид заасан хөөн хэлэлцэх стандарт хугацаа 7 жил байдагтай харьцуулахад харьцангуй богино хугацаа юм. Израил болон дэлхийн бусад улс орнуудад шүүхэд нэхэмжлэл гаргах хугацаа богино байх нь тийм ховор тохиолдол биш ч дээрх хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа бол үндэслэл муутай, сөрөг үр дагавартай юм. Шийтгэл хүлээсэн (хүлээх боломжтой) шүгэл үлээгч гэдэг бол ажил олгогчоосоо сул байр сууринд байдаг. Шүгэл үлээгч нь хуулийн талаарх мэдлэг дутмаг байдаг бөгөөд ажил олгогч нь хууль бус байдлаар ажлаас халсан, эсхүл зүй бус харьцсан талаар, магадгүй, шууд танин мэдэх боломжгүй байдаг. Хөөн хэлэлцэх хугацаа богино байх нь өөр бусад хууль ёсны ажиллагаа явуулах боломжийг хязгаарладаг. Шүүхэд нэхэмжлэл гаргах нь шүгэл үлээгч болон ажил олгогчийн хоорондын муу харилцааны эцсийн цэг бөгөөд тэдний маргааныг хууль зүйн бус арга замаар шийдвэрлэх аливаа оролдлогод төгсгөл болдог. Хөдөлмөр эрхлэлтийн талаарх сөрөг үйлдлээс хойш 12 сарын дотор тухайн ажилтан шүүхэд нэхэмжлэл гаргахыг дэмжих нь бүх талуудад ашигтай байх шүүхийн бус арга замаар асуудлаа шийдвэрлэх боломжийг ихэнхдээ арилгадаг. Эцэст нь дээрх хөөн хэлэлцэх хугацааг сунгах талаар санал гаргасан парламентын гишүүдийн дурдаж байгаагаар шүгэл үлээгчдийн гаргаж буй иргэний маргаанд хөөн хэлэлцэх хугацаа 12 сар байх нь шүгэл үлээгчийг хамгаалах бусад хуулийн зохицуулалт болон Омбудсмэнд гомдол гаргах боломж зэрэгтэй нийцэхгүй байгаа юм. Омбудсмэн бол төрийн байгууллагад ажиллаж буй шүгэл үлээгчдийн гомдлыг шалгах эрхтэй бөгөөд хохирлыг барагдуулах, ажилд нь дахин томилуулах зэрэг шийдвэр гаргах боломжтой байгууллага юм. Хэдий тийм ч, Омбудсмэнд гомдол гаргасан бол дээрх хуулийн хөөн хэлэлцэх хугацааг зогсоодоггүй. Үр дүнд нь төрийн байгууллагад ажиллаж буй шүгэл үлээгч шүүхэд нэхэмжлэл гаргах, эсхүл нэгэн зэрэг Омбудсмэнд гомдол гаргах шаардлага гардаг. Гэвч Омбудсмэнд хандсан нь илүү сайн хувилбар болдог.

Хоёрдугаарт: Хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалах тухай хуулийн дагуу шүгэл үлээгч шүүхэд нэхэмжлэл гаргахад хэтэрхий их нотлох баримт шаарддаг хэвээр байна. Энэ тал дээр хэд хэдэн зүйлээр дэвшил гарч байна. Уг хуулийн анхны хувилбараар шүгэл үлээгчдэд өөрийн хийж буй шүгэл үлээх үйлдлийн үндсэн шалтгааныг нотлоход хүндрэлтэй байсан учраас үр дүн багатай байсан. Парламентаас нотлох баримт бүрдүүлэх дарамтыг багасгах зорилгоор хуульд нэмэлт өөрчлөлт оруулсан. Одоогийн байдлаар шүгэл үлээгчид урьдчилсан байдлаар тодорхой түвшинд мэдээллээр хангавал хууль зөрчөөгүй гэдгээ нотлох ажиллагаа ажил олгогч руу шилждэг. Энэхүү өөрчлөлт нь шүгэл үлээгчдэд ээлтэй мэт харагдаж байгаа боловч нягтлан авж үзвэл уг нэмэлт өөрчлөлт нь шүгэл үлээгчдэд дарамт учруулж байна. Нэгдүгээрт, нотолгооны дарамтыг шилжүүлэхийн тулд тухайн шүгэл үлээгч өөрт нь сөрөг үр дагавар авчрах, эсхүл ажлаас

⁵⁹⁶ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/07/13/two-legal-changes-which-would-bolster-israels-protection-of-whistleblowers/#more-16134>

халагдахгүй байх шалтгаан болсон ямар нэг зан байдал, эсхүл үйлдэл гаргаагүй гэдгээ нотлох шаардлагатай болдог. Бодит байдалд хуульд 2013, 2019 онд саналаа бүрэн тусгаж чадаагүй хүмүүсийн үзэж байгаагаар анхны хуулийн дагуу шүгэл үлээгчдийн нотлох ёстой асуудлаас эрс өөрчлөлт гараагүй байна.

Шүгэл үлээгчдийг илүү үр дүнтэй хамгаалахын тулд Израилийн парламент дээрх дутагдалтай талуудыг арилгахад чиглэсэн нэмэлт өөрчлөлтүүдийг хийх шаардлагатай. Израилийн хэд хэдэн хууль тогтоогч энэ төрлийн өөрчлөлтийг хийхээр ажиллаж байна. Жишээлбэл, хөөн хэлэлцэх хугацааг сунгах, зогсоох зэргээр асуудлыг шийдвэрлэх хуулийн төсөл санал болгосон байна. Мөн дээрх хуульд нотолгоотой холбоотой заалтуудад өөрчлөлт орох ёстой. Өмнө нь дурдсанчлан, уг хуулийн өөрчлөлт амжилт олоогүй ч, өөрчлөлтийг тасралтгүй хийх ёстой. Шүгэл үлээгчдийг үр дүнтэй байдлаар хамгаалахгүйгээр шүгэл үлээх боломжгүй. Энэ нь авлига илрэх боломжийг бууруулна.

БНХАУ болон Казахстан улс авлигатай хэрхэн тэмцэж байгаа талаар харьцуулалт хийсэн байна⁵⁹⁷

2020.07.16. Авлига бол өнөө цагийн засаглал, нийгмийн гамшиг юм. Дэлхийн улс орнуудад авлигын хэрэгт төрөл бүрийн шийтгэл оногдуулж байгаа бөгөөд тухайлбал БНХАУ-д 3 сая юаниас дээш хэмжээний хахууль авсан нь тогтоогдвол цаазын ял оногдуулдаг байна.

Казахстан улсад дээр дурдсан хахууль авсан хэрэгт торгууль төлөх, эд хөрөнгийг нь хураах, эрх чөлөөг нь тодорхой хугацаагаар хязгаарлах, төрийн албанд ажиллах эрхийг бүх насаар нь хасах зэрэг шийтгэл оногдуулж байна.

Авлигын хэргийн нөхцөл байдлыг бодитой харуулах зорилгоор 2019 онд БНХАУ болон Казахстан улсад үйлдэгдсэн авлигын хэргийн тоон үзүүлэлтийг Казахстаны хэвлэл мэдээллийн NV.kz агентлагийн сурвалжлагч харьцуулан судалжээ.

БНХАУ

БНХАУ-д 1982 оноос аливаа авлига, хахуулийн хэрэгт цаазын ял оногдуулдаг болсон. Цаазын ялыг гүйцэтгэхдээ буудан хороодог байсан бол 2008 оноос үхэлд хүргэдэг тариа ашигладаг болсон байна. 2000 оноос хойш авлигын гэмт хэргээр 120,000 орчим албан тушаалтан цаазын ялаар шийтгүүлжээ.

Авлигын хэрэгт оногдуулдаг ялыг зөөлрүүлж, 2016 оноос хулгайлсан буюу хахуулиар авсан эд хөрөнгийн хэмжээ нь 3 сая юаниас /ойролцоогоор 177 сая тэнгэ/ илүү тохиолдолд цаазын ял оногдуулдаг болсон байна.

2019 оны эцсээр Хятадын Коммунист намын төв хорооноос авлигатай тэмцэх чиглэлээр явуулж буй үйл ажиллагааны тоон үзүүлэлтийг танилцуулсан. Үүнд:

“2019 оны 01 дүгээр сараас 11 дүгээр сар хүртэлх хугацаанд авлигатай холбоотой 70,800, нийгмийн халамж, ядууралтай тэмцэх үйл ажиллагаанд зөрчил гаргасан 86,400 хэргийг шийдвэрлэсэн байна. Авлигын хэргээр 99,000, ядууралтай тэмцэхэд зөрчил гаргасан 110,000 этгээдэд тус бүр шийтгэл оногдуулжээ”.

Дээрх тоон үзүүлэлтээс харахад, 2019 онд БНХАУ-д авлигын хэргээр 99,000 этгээд шийтгэгдсэн байна.

Казахстан улс

2019 оны байдлаар Казахстан улс АТИ-ээр 180 орноос 113-т бичигдсэн байна.

Казахстаны Авлигатай тэмцэх газрын дарга Алик Шпекбаев 2019 оны байдлаар авлигын хэргээр 1,002 албан тушаалтанд шийтгэл оногдуулсан талаар 2019 оны тайлангийн хурлын үеэр мэдээлжээ.

⁵⁹⁷ Орчуулсан: Л.Анхныбаяр. Эх сурвалж: <http://regtv.kz/2020/07/16/ent-kak-boryutsya-s-korruptsiej-v-kazahstane-i-kitae.html>

Тэрээр “2019 онд авлигатай холбоотой 1,717 хэрэг бүртгэгдсэний талаас илүү хувийг хахуулийн хэрэг эзэлж байна. Үүнээс 1,002 албан тушаалтанд шийтгэл оногдуулсан” гэжээ.

БНХАУ болон Казахстан улсад авлига, хахуулийн хэрэгт хүлээлгэх шийтгэлийг харьцуулбал:

БНХАУ-д 100 мянган юаны (ойролцоогоор 5 сая тэнгэ) хахууль авсан этгээдэд хөдөлмөрийн засан хүмүүжүүлэх лагерьт 10 жил ажиллуулах, бүх насаар нь шоронд хорих ял оногдуулдаг байна.


Гэтэл Казахстанд Нур-Султан хотын дүүргийн дарга 2019 онд 5 сая тэнгэгийн хэмжээтэй хахууль авсан хэрэгт 3 жилийн хорих ял оногдуулсан байна. Казахстаны авлигачдад оногдуулж байгаа шийтгэлийг сонсоод цаазын ял авсан Хятадын авлигачид агаархаж байгаа.

Таргалалттай улс төрчид авлигын шинж болохыг судалгаа харуулав Хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан авлига ихтэй улс орнууд тарган улс төрчидтэй⁵⁹⁸

2020.07.27. Авлигыг хэмжих нь туйлын бэрх шинжлэх ухаан. Авлига нь шинж чанарын хувьд далд байдаг. Хулгай хийсэн, эсхүл хууль бус үйлдэл хийсэн улс төрчид өөрийн үйлдлээ нуухын тулд олон төрлийн арга хэмжээ авсан байдаг. Хэдий тийм ч, тэдэнд нууж чадахгүй нэг зүйл байна.

Францын Монпелье их сургууль (University of Montpellier)-ийн эрдэмтэн Павло Блаватскы (Pavlo Blavatsky) н хийсэн судалгаагаар хуучин социалист системд байсан, авлига ихтэй улс орнууд тарган улс төрчидтэй байна.

П.Блаватскы нь 2017 онд хуучин социалист системд багтаж байсан 15 улсын засгийн газрын 299 гишүүний биеийн жинг ТИ-ийн авлигын индекс болон ДБ-ны авлигын үзүүлэлтүүдтэй харьцуулж үзсэн байна.



“Бидний тооцсоноор сайдуудын биеийн жингийн индексийн дундаж хэмжээ авлигыг хэмждэг бусад индексийн дүнтэй ихээхэн хамааралтай гарсан. Нуугдмал өндөр түвшний авлигыг төрийн

⁵⁹⁸ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://eurasianet.org/obese-politicians-signal-corruption-study-finds>

өндөр албан тушаалтнуудын гэрэл зургаас шууд харах боломжтой” гэж П.Блаватский хэлсэн байна.

Төрд итгэх олон нийтийн итгэл алдарч байна⁵⁹⁹

2020.09.04. Украинчуудын 78% нь төрийн байгууллага, албан тушаалтнуудад итгэхгүй байгааг Разумов төв болон Илко Кучеривын ардчилсан санаачилгын сангаас хамтран зохион байгуулсан судалгааны дүн харууллаа. Өөрөөр хэлбэл, судалгаанд оролцогчдын 36.5% нь төрийн байгууллага, албан тушаалтанд “огт итгэдэггүй” гэж хариулсан бол 41.2% нь “бараг л итгэдэггүй” гэж хариулсан байна.

Төрийн байгууллага, албан тушаалтанд итгэх хүмүүсийн итгэлийн түвшин өмнөх судалгааны дүнтэй харьцуулахад буурах хандлагатай байгааг судалгааг зохион байгуулагчид онцолсон байна.

Судалгааны дүнгээс харахад иргэд хууль, шүүхийн байгууллагын үйл ажиллагаанд итгэх итгэл доогуур байна. Дээд шүүхэд итгэхгүй гэж 69% нь хариулсан бол, прокурорын байгууллагад 73%, Үндэсний авлигатай тэмцэх товчоонд 73%, Авлигын эсрэг тусгай прокурорын газарт 70.5%, Авлигын эсрэг дээд шүүхэд 70%, Авлигаас урьдчилан сэргийлэх үндэсний газарт 70% нь итгэхгүй байгаагаа илэрхийлсэн байна.

Судалгааг 07 дугаар сарын 03-09-ний хооронд Украин улсын хэмжээнд насанд хүрсэн 2,022 иргэнээс авсан бөгөөд Крым, Донецк, Луганскийн бүс нутгийг хамруулаагүй байна.

Бизнес дэх хахуулийн нөлөөллийн талаарх судалгаа⁶⁰⁰

2020.09.07. Кембрижийн Бизнесийн сургууль (Cambridge Judge Business School)-ийн профессор Рагу Рау (Raghu Rau) болон бусад судлаачдын хамтран явуулсан судалгаагаар хахуульд зарцуулсан 1 доллар нь хахууль өгсөн компанийн үнэ цэнийг 6-9 доллароор өсгөх хамаарал байгааг тогтоосон бөгөөд уг судалгаа нь хахуулийн талаарх нийтлэг итгэл үнэмшилд эргэлзээ төрүүлээд байна.

Хахууль бол дэлхийн улс орнууд болон компаниудын анхаарлын төвд байдаг нэгэн чухал асуудал. Сүүлийн жилүүдэд Siemens, BAe Systems, Lockheed Martin, Halliburton зэрэг үндэстэн дамнасан томоохон компаниуд төрийн албан хаагчдад хахууль өгсөн талаарх мэдээллүүд гарсан. Улмаар тухайн компаниуд ихээхэн хэмжээний торгууль төлөх тохиролцоонд хүрч холбогдох хэргийг шийдвэрлэж байна.

Гэвч компаниуд хахуулиас олох үр ашгийг юу тодорхойлдог вэ?

Энэ судалгаагаар хахуулийн хэмжээ болон компанийн авах үр ашгийн хоорондын хамаарлыг тогтоох зорилгоор сүүлийн 40 гаруй жилд ил болсон 200 орчим хэргийг судалж үзэхэд хахуульд өгсөн 1 доллар нь тухайн компанийн зах зээлийн үнэлгээг 6-9 доллароор нэмэгдүүлсэн дүнтэй байна. Энэхүү дүгнэлт зарим нийтлэг итгэл үнэмшлийг үгүйсгэж, мөн хахуулийн хэмжээ нь хахууль өгөгч компанид ирэх ашгийн хэмжээнээс хамааралтай, эсхүл хахуулийн эсрэг хууль сахиулах ажиллагаа нь компаниудын олох ашгийн хэмжээг бууруулдаг гэсэг таамаглалуудыг дэмжихгүй байна.

Хахууль нь хууль бус, далд үйлдэгддэгтэй холбоотойгоор өмнө нь хийгдэж байсан ихэнх судалгаанууд асуулга болон макро түвшинд авлигын төсөөллийн судалгаануудыг ашигласан байдаг. Хэдий тийм ч, эдгээр судалгаанд оролцсон компаниуд асуулгад үнэн зөв хариулахгүй байх, эсхүл авлигын төсөөлөлд хэвлэл мэдээллийн нөлөө орох боломж өндөр билээ.

Энэ удаагийн шинэ судалгаагаар хахуулийн талаарх нийтлэг таамаглалуудыг шалгахын тулд хахуулийн талаарх баримтжуулсан мэдээллийг ашиглан хахуулийн үр ашгийг микро түвшинд судлахын тулд өмнөхөөс өөр арга зүйг ашигласан байна. Менежментийн шинжлэх ухаан (Management Science) сэтгүүлд удахгүй нийтлэгдэх уг судалгаагаар 40 гаруй жилийн (1975-

⁵⁹⁹ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.unian.info/society/trust-in-government-poll-reveals-public-attitudes-in-ukraine-11135681.html>

⁶⁰⁰ Орчуулсан: Б.Баярсайхан. Эх сурвалж: <https://www.cambridgenetwork.co.uk/news/study-examines-bribery>

2015) хугацаанд 60 улс оронд албан тушаалтнуудыг хахуульдсан 24 хөрөнгийн зах зээлд бүртгэлтэй 195 томоохон компанийн хахуулийн мэдээллийг судалж үзсэн байна. Судалгаанд ашигласан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, компанийн мэдэгдэл, төрийн байгууллагууд дахь баримт зэргээс гарган авсан байна.

Судалгаагаар, хахуульд холбогдсон томоохон гэрээний талаарх мэдэгдэл гарсан үеийн зах зээл дэх компанийн үнэ цэнийг харьцуулсан байна. Үүний үр дүнд хахуульд зарцуулсан нэмэлт 1 доллар нь тухайн компанийн үнэ цэнийг 6-9 доллароор нэмэгдүүлж байгааг тогтоосон бөгөөд энэ нь хахуулийн хэмжээ болон хүртэх үр ашгийн хэмжээний хооронд хамаарал байгааг илэрхийлж байна.

Жишээлбэл, 1999 онд Өмнөд Африкт сөнөөгч онгоц нийлүүлэх 2.5 тэрбум долларын гэрээний асуудлаар Британийн батлан хамгаалахын гэрээлэгч BAe Systems компанийн оролцсон хахуулийн мэдээллийг судалж үзэхэд BAe Systems-ийн хувьцаа эзэмшигчид өөрийн өгсөн 1 долларын хахууль тутмаас 8.3 долларын ашиг хүртсэн байна (Зах зээл дэх компанийн үнэ цэнийн өсөлтийг өгсөн хахуульд нь харьцуулсан). Энэ хэрэг олон улс орон дамнасан мөрдөн шалгах ажиллагаа явагдсаны эцэст 2010 онд хуурамч мэдүүлэг, нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудлаар BAe Systems компани нь АНУ-ын Хууль зүйн яам, Их Британийн Онц хүнд гэмт хэргийг мөрдөх газарт 400 сая доллар төлөх тохиролцоог хийснээр эцэслэсэн байдаг.

Судалгааны дүнгээр зарим таамаглалыг шалгасан байна. Тухайлбал, хахуулиас олж буй үр ашиг нь тухай улсын институцийн чанартай холбоотой эсэх талаарх таамаглалуудыг шалгахад харилцан адилгүй үр дүнтэй байв. Харин улс төрчдийн орлогын их үүсвэр нь олон нийтэд ил мэдээлэгддэг улс оронд хахуулиас олох үр ашиг харьцангуй бага байв. Үүний эсрэг, авлига өндөртэй, эсхүл ерөнхийдөө хууль сахиулах үйл ажиллагаа нь үр дүн багатай улс оронд хахуулиас олох үр ашиг нэмэгдэж байв. Харин тодорхой төрлийн хахуулийн эсрэг хууль сахиулах ажиллагаа явуулдаг, эсхүл дэглэмийн шинж (ардчилсан, эсхүл автократ) нь хахуулиас олох үр ашигт нөлөөгүй байна.

Мөн үр ашиггүй хүнд суртлын улмаас зогсонги байдалд орсон төрийн үйлчилгээг хахууль хурдасгаж, үр ашиггүй зардлыг бууруулж чаддаг гэсэн таамаглал ч дэмжигдсэн байна.

Подкастыг сонсох: <https://link.chtbl.com/Ue9CNVug>

Жеймс Вассерстромын оролцсон шинэ подкаст цуврал⁶⁰¹

2020.09.22. Дэлхийн авлигын эсрэг подкастын энэ долоо хоногийн дугаарт Жеймс Вассерстромтой ярилцлага хийсэн юм. Ноён Вассерстром нь НҮБ-аас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд 2007 онд НҮБ-ын Косово дахь төлөөлөгчийн газарт томилогдон ажиллаж байгаад одоогоор авлига, ил тод байдлын асуудлаар хувийн зөвлөх хийж байна.

Тэрээр НҮБ-ын өндөр албан тушаалтнуудын авлигын хэргийг илрүүлснээр түүний НҮБ-ын карьерт гэнэтийн эргэлт гарсан. Олж илрүүлсэн үр дүнгээ НҮБ-д мэдээлсэн боловч энэ нь гэмт хэрэгтнүүдэд ил болж, түүнээс өшөө авах үйл ажиллагаа өргөнөөр өрнөжээ.

Уг асуудлаар өргөн цар хүрээтэй шүүх ажиллагаа явуулсны эцэст түүнтэй зүй бусаар харьцсан нь тогтоогдсон хэдий ч НҮБ-аас түүнд хоёрдмол утгатай журмыг үндэслэн нөхөн төлбөр олгохоос татгалзсан юм.

Ноён Вассерстром НҮБ-тай хийсэн маргааны үеэр болон дараа нь ч НҮБ-ын институтийн болон шударга байдлын шинэчлэлийг гол дэмжигч байсаар ирсэн. Мөн 2009-2014 онуудад Афганистан дахь АНУ-ын Элчин сайдын яаманд авлигын эсрэг тусгай зөвлөхөөр ажиллаж байжээ.

Бид энэ удаа Ноён Вассерстромын НҮБ-ын мэдээлэгчээр ажиллаж байсан туршлага болон НҮБ-ын мэдээлэгчийг хамгаалах системийн алдаа дутагдлын талаар ярилцлаа. Мөн дайсагнасан орчинд мэдээлэгчдэд олон улс илүү их дэмжлэг үзүүлж байх талаар болоод “Шударга байдлын ариун газар” хөтөлбөрийн талаарх түүний шинэ саналуудыг ярилцсан болно.

⁶⁰¹ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/09/22/new-podcast-episode-featuring-james-wasserstrom/>

2020.11.05. Эрика Босио⁶⁰³, Симеон Джанков⁶⁰⁴, Эдвард Глейзер⁶⁰⁵, Андрей Шлейфер⁶⁰⁶

Хураангуй

Төрийн худалдан авах ажиллагаан дахь болгоомжтой хянуур байдал нь нийгэм, эдийн засгийн хувьд оновчтой худалдан авалт хийх боломжийг төрийн албан тушаалтнуудад олгодог боловч энэ нь авлига үүсэх нөхцөлийг нэмэгдүүлдэг. Үүний улмаас төрийн худалдан авах ажиллагааны эрх чөлөө болон авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны хоорондын тэнцвэрийг хангах асуудал тулгарч байна. Энэхүү судалгаанд 2019 оны 187 улсын төрийн худалдан авах ажиллагааны тухай хууль болон практикийн талаарх судалгааны тоо мэдээллийг ашиглан эдгээрийн хамаарлыг судалсан. Судалгааны үр дүнгээс харахад засгийн газрын үйл ажиллагааны үр ашиг бага байх үед худалдан авах ажиллагааг зохицуулах нь тустай, харин үйл ажиллагааны үр ашиг өндөр байх үед худалдан авах ажиллагааг зохицуулах нь ач холбогдол бага байсан.

Төрийн худалдан авах ажиллагаа (ХАА) авлигад өртөмтгий байдаг. ХАА-н дахь авлигын дүн нь худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний үнийн дүнгийн 8%-25% хооронд хэлбэлздэг тухай судалгаанууд байна. ХАА-тай холбоотой авлига, хахууль түгээмэл байсаар иржээ (Ди Телла ба Шаргородский 2003 он, Олкен 2007 он, Коллиер ба бусад 2016 он, Колоннелли ба Прем 2020 он, Личанд ба Фернандес 2019 он). Түүнчлэн, худалдан авалттай холбоотой гэрээг шинэчлэн байгуулах үед авлига, хахууль ихээр гардаг байна (Декароли 2014 он, Декароли ба Пламбо 2015 он, Кампос ба бусад 2019 он).

ХАА-ны шийдвэр гаргах эрх чөлөө их байх хэрээр авлига өргөн тархсан байх нь түгээмэл байдаг. Тиймээс ХАА-ны байгууллагуудын сонголтыг хязгаарлаж, зохицуулалтыг нэмэгдүүлснээр энэ байдлыг өөрчилдөг. Гэхдээ ийнхүү ХАА-г хязгаарлах нь нийгэм, эдийн засгийн хувьд оновчтой худалдан авалт хийхэд төрийн албан тушаалтнуудад саад болдог сул талтай. Тиймээс эдгээрийн тэнцвэрийг хэрхэн хангахыг тодорхойлох шаардлага гарсан тул бид энэ судалгааг хийв.

2019 оны 187 улсын ХАА-ны хууль тогтоомж, практикт Босио болон бусад судлаачид (2020 он) дүн шинжилгээ хийсэн байна. Бид төрийн худалдан авах үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжилтнүүд, хуульчдаас стандарт асуулгаар дамжуулан тоон мэдээлэл цуглуулсан. Уг асуулгын асуултууд нь 2.5 сая долларын өртөгтэй төсөөллийн замын төслийн худалдан авалтын ажиллагааг бүхэлд нь хамарсан. Улс бүрийн судалгаанд хамрагдсан хүмүүст 2.5 сая долларын өртөг бүхий зам засварын төслийг танилцуулаад, уг төслийн худалдан авалтыг зохион байгуулах дүрэм журмын талаар асуусан. Тэдний хариултад үндэслэн бид ил тод байдал, өрсөлдөөн, тендерт оролцогчдод тавигдах шаардлага, гэрээний шударга байдал зэргийг багтаасан худалдан авах ажиллагааны хууль тогтоомжийн хэмжүүрийг боловсруулсан. Судалгаанд оролцогчид мөн ХАА-ны практик нь хуулиас ялгаатай эсэх болон ямар ялгаа байгааг тайлбарласан нь практиктай холбоотой хэмжүүрийг бий болгох боломжийг бидэнд олгосон.

Зураг 1-д үзүүлснээр ХАА-ны тухай хуулийн зохицуулалт нь түүний практик үйл ажиллагааг төсөөлж байгааг бид тогтоосон ба өөрөөр хэлбэл, хуулийн зохицуулалт их байх хэрээр албан тушаалтнууд өөрсдийн дураар зохицуулах практик бага байсан. Түүнчлэн, бидний таамаглаж байгаагаар худалдан авалтад практик ажиллагаа бага байх хэрээр үр дүн илүү сайн байх болно. Өөрөөр хэлбэл, ХАА-ны практик нь авлигын бага түвшин, хэн нэгэн этгээдэд давуу байдал олгох индекс, хуйвалдаан, өрсөлдөөнгүй байдал, зардал хэтрэлтийн индекс, цаг хугацааны хоцрогдол, чанар муу байх зэргийг хамарсан индекстэй холбоотой байдаг. Харин ХАА-ны хууль тогтоомжийг худалдан авалтын үр дүнтэй холбон таамаглах боломжгүй байдаг аж. Өөрөөр хэлбэл, зохицуулалт нь худалдан авалтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэхэд хангалтгүй юм.

Зураг 1. Худалдан авах ажиллагааны тухай хууль тогтоомж ба практикийн харилцан уялдаатай байдал


⁶⁰² Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://voxeu.org/article/corruption-public-procurement>

⁶⁰³ Дэлхийн банкны судлаач

⁶⁰⁴ Лондонгийн Эдийн засгийн сургуулийн Санхүүгийн зах зээлийн группийн бодлогын захирал

⁶⁰⁵ Харвардын их сургуулийн эдийн засгийн профессор

⁶⁰⁶ Харвардын их сургуулийн эдийн засгийн профессор



Эх сурвалж: Босио ба бусад (2020 он)

Энэхүү нөхцөл байдалд шийдэл гаргахын тулд ХАА-ны дүрэм журмын өртөг ба үр өгөөжийн хоорондын зохистой тэнцвэрийг тогтооход төрийн байгууллагын чадавх чухал гэж бид үзэж байна. Хэрэв байгууллагын чадавх сул бол хүнд сурталтнууд хахуулийг нэмэгдүүлэх болно. Энэ тохиолдолд худалдан авалт хийж буй байгууллагад олгогдож буй эрх чөлөөг хязгаарлах замаар авлигыг бууруулах боломж ихээр гарч байна. Харин төрийн байгууллагын чадавх өндөр байгаа нөхцөлд худалдан авалтын эрх чөлөөг хязгаарласнаар авлигыг бууруулахгүй боловч гарах зардал чирэгдэл нэмэгдэх болно. Улсын секторын чадавхыг хэмжихийн тулд ДБ-наас гаргадаг Хүмүүн капиталын индекс (Ангрис ба бусад, 2019 он) болон Засгийн газрын үр нөлөөт байдлын үзүүлэлт зэргийг ашигласан.

Бидний хийсэн дүн шинжилгээгээр дээрх хандлага батлагдаж байна. ХАА-ны хууль тогтоомжийн үр дүнд авлигын тохиолдол буурах нөлөө нь засгийн газрын чадавх багатай улсуудад (-0.13, статистикийн ач холбогдлын түвшин 5%) өндөр, засгийн газрын чадавх өндөртэй улсуудад (-0.06, статистикийн ач холбогдлын түвшин 10%) харьцангуй бага байна. Энэхүү үзэл баримтлалын дагуу хүмүүн капиталтай холбоотойгоор хууль тогтоомжийн дундаж индекс ба практикийн дундаж индексийн хооронд статистикийн ач холбогдол ялгаатай байгааг өгөгдөл бас харуулж байна. Өөрөөр хэлбэл, хүмүүн капиталын түвшин доогуур улсуудад худалдан авалтын практик бус, харин илүү хатуу заалттай хууль тогтоомж үйлчилдэг бол хүмүүн капиталын түвшин өндөртэй улсуудад эсрэгээрээ байдаг. Эндээс дүгнэхэд, улсын секторын чадавх багатай улсуудад хууль тогтоомжоос илүү сайн практикийг хэрэгжүүлэх боломжгүй гэдэг нь харагдаж байна. Улмаар засгийн газрын үр ашиг бага байх үед ХАА-г чөлөөтэй байлгах нь ашиг тустай бол харин засгийн газрын үр ашиг өндөр байх үед ХАА-г чөлөөлөх нь хор хохирол ихтэй гэж нотоллоо.

Мэргэжилтнүүдийн дунд явуулсан санал асуулгад үндэслэн бид судалгааны зорилгоор ХАА-ны төслийн чанарын индексийг тодорхойлсон. Зураг 2 ба 3 -аас харахад хүмүүн капиталын түвшин багатай улсуудад ХАА илүү хатуу зохицуулалттай үед бүтээгдэхүүний индекс өсдөг бол харин хүмүүн капиталын түвшин өндөр улсуудад энэ нөхцөлд бүтээгдэхүүний индекс буурч байна. Баримт нотолгооноос дүгнэхэд ХАА-ны зохицуулалт нь авлигад ихээхэн нөлөөтэй байгаа боловч энэ дүгнэлт нь зөвхөн улсын секторын чадавх багатай улсуудад л тохирч байна.

- Angrist, N, S Djankov, P Goldberg and H Patrinos (2019), “Measuring Human Capital”, World Bank Working Paper No. 8742.
- Bosio, E, S Djankov, E Glaeser and A Shleifer (2020), “Public Procurement in Law and Practice”, NBER Working Paper No. 27188.
- Campos, N, E Engel, R D Fischer and A Galetovic (2019), “Renegotiations and Corruption in Infrastructure: The Odebrecht Case”, Working paper.
- Collier, P and M Kirchberger (2016), “The Cost of Road Infrastructure in Low- and Middle-Income Countries”, World Bank Economic Review 30(3): 522-548.
- Colonnelli, E and M Prem (2020), “Corruption and Firms”, Working paper.
- Decarolis, F (2014), “Awarding Price, Contract Performance, and Bids Screening: Evidence from Procurement Auctions”, American Economic Journal: Applied Economics 6(1): 108-132.
- Decarolis, F and G Palumbo (2015), “Renegotiation of Public Contracts: An Empirical Analysis”, Economics Letters 132(C): 77-81.
- Di Tella, R and E Schargrodsky (2003), “The Role of Wages and Auditing During a Crackdown on Corruption in the City of Buenos Aires”, Journal of Law and Economics 46(1): 269–292.
- Lichand, G and G Fernades (2019), “The Dark Side of the Contract: Do Government Audits Reduce Corruption in the Presence of Displacement by Vendors?”, University of Zurich, Switzerland, mimeo.
- Olken, B (2007), “Monitoring corruption: Evidence from a field experiment in Indonesia”, Journal of Political Economy 115(2): 200-249.
- World Bank (2020), Worldwide Governance Indicators, Washington, DC.

Цар тахал авлигыг газар авхуулж байна.

Эрэн сурвалжлах сэтгүүлчид мөшгиж чадах уу?⁶⁰⁷

2020.12.02. Damilola Banjo. Коронавирусний цар тахлын улмаас засгийн газрууд хөл хорио зарласан даруйд зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэлүүд нөхцөл байдлыг өөрсөддөө ашигтай байдлаар ажиллаж эхлэв. Үүссэн нөхцөл байдал нь авлига, зохион байгуулалттай гэмт хэргийг мөрдөн сурвалжлах сэтгүүлчдэд шинэ сорилт бий болгож байна.

“Вирус бид бүгдэд нөлөөлж байна. Бид үл мэдэгдэх зүйлээр аялж байна”, “Вирусний удирдлага ба буруу удирдлага аль аль нь сэтгүүлчдэд, ялангуяа эрэн сурвалжлах сэтгүүлчдэд магадлах ёстой зүйлс юм” хэмээн Олон улсын авлигын эсрэг 19 дүгээр чуулганы Коронавирусний үеийн эрэн сурвалжлах сэтгүүл зүй сэдэвт хэлэлцүүлгийн үеэр чөлөөт сурвалжлагч Франческа Борри хэлсэн байна.

Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигыг мэдээлэх төслийн (OCCRP) захирал, хамтран үүсгэн байгуулагч Пол Раду *“бидэнд илүү ил тод байдал, мөрдөн шалгах хүчин чармайлт хэрэгтэй”* гээд дэлхийн нийлүүлэлтийн гинжин хэлхээнд өөрсдийгөө оруулах гэсэн “гэмт хэргийн гарааны бизнесүүд”(“Criminal startups”) огцом нэмэгдэж байгааг тайлбарлав. Тэд эмнэлгийн тоног төхөөрөмж, эдийн засгийн тусламжийг халаасандаа хийж, олон нийтийг хуурч, цар тахлыг улам даамжруулж байна. Радугийн тайлбарласнаар эдгээр гэмт хэрэгтнүүд хүмүүсийн онлайн үйлчилгээ, харилцаа холбооноос хамаарах хамаарал улам бүр нэмэгдэж байгааг далимдуулж байгаа ажээ.

Мөн Раду *“Хямралын үе бүр бизнесүүд зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигад хүрэх томоохон боломж байдаг”, “Бидний хийж чадсан зүйл бол ур чадвараа шууд ашиглаж, мөнгийг хэрхэн мөшгихөө мэддэг болсон явдал юм”* гэв. Жишээлбэл, Румын дахь Зохион байгуулалттай гэмт хэрэг, авлигыг мэдээлэх төслийн сурвалжлагчдын баг эмнэлгийн амны хаалттай холбоотой хар захын өргөн наймааг илрүүлсэн байна.

⁶⁰⁷ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://iacccseries.org/blog/pandemics-spread-corruption-can-investigative-journalists-keep-up/>

Ялангуяа, эрэн сурвалжлах сэтгүүлчдийн үйл хөдлөлийг ч мөн хязгаарлаж буй хөл хорионы үед гэмт хэргийг илрүүлэх, мөшгихөд сорилт бэрхшээл тулгарч байна. “Энэ үед сэтгүүлчдийн хамгийн чухал дайсан бол мэдээллийн хомсдол юм. Энэ нь тэднийг өндөр чанартай сэтгүүл зүйн бүтээл гаргахад саад болж байна” хэмээн Дэлхийн эрэн сурвалжлах сэтгүүлзүйн сүлжээний бүс нутгийн редактор Маждолин Хасан хэлсэн байна.

Хөрөнгө буцааж авах иргэний форумын эрэн сурвалжлах хөтөлбөрийн зохицуулагч Александер Брутелле хэлэхдээ сэтгүүлчид эрэн сурвалжлах үр дүнтэй мэдээлэл бэлтгэхийн тулд нэгэнт бэлэн байгаа багаж хэрэгсэл, хөрөнгийг л ашиглах хэрэгтэй болж байна гэв.

Нийгмийн хэм хэмжээ авлигад боломж олгодог, гэхдээ залуу идэвхтнүүд үүнийг эсэргүүцэж байна⁶⁰⁸

2020.12.03. Patrick Egwu. Олон улсын авлигын эсрэг 19 дүгээр чуулганы Бидний ирээдүйг буцааж өг! арга хэмжээнд оролцсон идэвхтнүүд, шинжээчдийн үзэж буйгаар нийгмийн хэм хэмжээ нь авлигад боломж олгодог ажээ.

Хэлэлцүүлэгт оролцогчид хувь хүмүүс хийгээд институцууд, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд дахь авлигын шинжтэй зан байдалд нийгмийн хэм хэмжээ хэрхэн нөлөөлж байгааг хэлэлцжээ. Тэд мөн залуучуудаар манлайлуулсан идэвхтнүүд үүнийг хэрхэн эсэргүүцэж чадах вэ гэдэгт анхаарлаа хандуулсан байна

Нийгмийн хэм хэмжээ гэдэг бол нийгэмд биеэ авж явах зөв аргын харилцан хүлээлт юм. Энэ нь авлигатай нягт холбоотой байдаг. “Нийгмийн хэм хэмжээ нь албан ёсны дүрмийг үл хэрэгсээд ирэхээр авлигын үйлдлүүд гарч эхэлдэг” хэмээн Базелийн засаглалын хүрээлэнгийн ажилтан Саба Касса хэлэв. Уг хүрээлэнгээс саяхан явуулсан авлигын зан үйл, хөдөлгөгч хүчнүүдийн талаарх судалгаанд жижиг авлигыг бий болгоход нийгмийн хэм хэмжээ, нийгмийн итгэл үнэмшлийн үүргийг авж үзсэн байна. Энэхүү судалгаа нь Зүүн Африкийн Уганда, Руанда, Танзани гэсэн гурван улсын эрүүл мэндийн үйлчилгээнд төвлөрсөн аж.

Судалгаанаас харахад хүмүүс эрүүл мэндийн үйлчилгээ авахдаа тулгарч буй бэрхшээлийг даван туулахын тулд нийгмийн харилцааны сүлжээгээ ашигладаг аж. Энэ нь эмч, эсвэл эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчийг таньж мэддэг найзтайгаа холбоо барихад хүргэж болох боловч, бас бэлэг хэлбэрээр өгсөн хахуулиар дамжуулан төлөвлөгөөтэйгөөр сүлжээ бий болгож байж магадгүй юм.

“Тэгэхээр, бүлэг дотор эв нэгдэлтэй байх, эсвэл бэлгийн хариу барих байдлаар бие биедээ туслах хэм хэмжээ байдаг байна. Энэ нь ихэвчлэн давуу байдал олгосон үйлчилгээ, давуу эрх олгох явдал болж хувирдаг. Эдгээр нь авлигын хэлбэрүүд юм” хэмээн Касса тайлбарлажээ. Ийм үйлдлүүд нь эрүүл мэндийн үйлчилгээнд хандах нийтлэг хандлагыг гажуудуулж, үр дүнд нь илүү сайн сүлжээтэй хүмүүс, эсвэл хахууль өгөх хангалттай чинээлэг хүмүүсийг илүүд үздэг онцгой үйлчилгээ бий болдог болохыг тэрээр онцолсон байна.

U4 авлигын эсрэг нөөцийн төвийн судлаач Женни Бентли “системүүд үүргээ гүйцэтгэж чадахгүй, засгийн газраас үзүүлэх дэмжлэгийн механизм бүрдээгүй үед” нийгмийн хэм хэмжээ нь авлига цэцэглэх хөрс болдог гэжээ.

Гэхдээ дэлхийн өнцөг булан бүрд залуучууд авлига хийгээд түүнийг бий болгож буй нийгмийн хэм хэмжээтэй тэмцээр байна. Томоохон жишээ бол өргөн тархсан авлига, эрх мэдлээ хэтрүүлэн ашигласны хариу үр дүн болох, ихэвчлэн залуу хүмүүс удирдсан Арабын хавар⁶⁰⁹ хэмээн нэрлэгдсэн хөдөлгөөн юм. Авлигын эсрэг хөдөлгөөн гэж ойлгодог Тунисын хувьсгалын дараа Тунисын иргэний хөдөлгөөний идэвхтэн Ачраф Ауади ТИ байгууллагын орон нутгийн бүлэг болон авлигын эсрэг хяналтын байгууллага болох I-WATCH-ийг байгуулжээ.

“50 гаруй жилийн дарангуйлал, хувьсгалын дараа ардчилалд шилжсэн нь төрийг ямар нэгэн байдлаар сулруулсан” гэж Ауади хэлэв. Мөн тэрээр “Сул дорой төртэй байх үед хүмүүс авлигын

⁶⁰⁸ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://iacseries.org/blog/social-norms-enable-corruption-but-young-activists-are-standing-up-to-it/>

⁶⁰⁹ 2010 оны 12 дугаар сараас эхлэн Тунист засгийн газрын эсрэг эсэргүүцлийн жагсаал өрнөв. 2011 оны эхээр Арабын хавар гэж нэрлэгдэх болсон эсэргүүцэл, бослого, үймээн самууны давалгаа Хойд Африк, Ойрх Дорнод дахь араб хэлээр ярьдаг орнуудад тархав. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хурдацтай тархсан ардчиллын төлөөх эсэргүүцлийн хөдөлгөөн Тунис, Египет, Ливи, Йемений засгийн газруудыг унагасан юм.(Х.О)

талаар чөлөөтэй ярих боломжтой байдаг тул авлигын талаарх ойлголт төсөөлөл өсдөг. Мөн төр сул байх үед албан тушаалтнууд боломжийнхоо хэрээр нөөц баялгийг тонох хандлагатай байдаг. Тэдгээр хүмүүс авлигын хэргээс мултарч байгааг иргэд харсаар байдаг ч энэ нь ял завших явдал хийгээд авлигыг өдөөж байдаг юм” гэлээ.

Ауади болон түүний баг авлигын талаарх мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор нутгийн рэпперүүдтэй хамтран залуучуудын дунд жил бүр арга хэмжээ зохион байгуулдаг. Тэдний итгэж, таньдаг хүмүүсээр дамжуулан авлигын эсрэг мессежийг залуучуудад хүргэх нь түүний зорилго аж. Мөн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр нөлөөлөгчид (Social media influencer) авлигын эсрэг мессежийг залуу хүмүүст түгээхэд тусалдаг байна. “Саяхан авлигын талаарх видео бичлэг хийсэн бөгөөд 24 цаг хүрэхгүй хугацаанд 270,000 үзсэн” гэж тэр ярьж байна.

Залуучууд авлигын эсрэг өөрчлөлтийг жолоодож, авлигыг идэвхжүүлдэг нийгмийн хэм хэмжээтэй нийгмийн сүлжээг ашиглан тэмцэж байна гэж Касса үзэж байна. Сонгууль будилаантуулсан гэсэн үндэслэлээр аравдугаар сард өрнөж, Киргизстан улсыг цочроосон томоохон эсэргүүцлийн жагсаалын талаар тэрбээр: “Болсон явдлаас бидний олж мэдсэн зүйл бол залуу хүмүүс хэрхэн хүчээ дайчлан, системийг бүрэн цэвэрлэхийг дэмжихийн тулд янз бүрийн платформ ашиглан нийгмийн хөдөлгөөнийг бий болгож чадаж байгаа тухай асуудал юм. Энэ бол төрд үзүүлж буй томоохон өөрчлөлт, шахалтыг өдөөх хүчин зүйл болох хөшүүргийн гайхалтай жишээ юм” гэжээ.

Авлигын хохирогч хэн болохыг танин мэдэхүйд гарсан ахиц⁶¹⁰

2020.12.17. Richard Messik. Нью Йоркийн Зүүн дүүрэг дэх Нэгдсэн Улсын дүүргийн шүүхийн шийдвэрээр⁶¹¹ хахуулийн улмаас хохирсон компанийн хувьцаа эзэмшигчдийг “авлигын хохирогч” гэж тооцон, 135 сая долларын хохирлыг баталгаажуулсан захирамж гаргасан нь чухал жишиг тогтоосон билээ. Энэхүү шийдвэр, захирамжийг ГАУАТХ-ийг зөрчсөн OZ Africa Management компанийг яллах ажиллагааны үеэр гаргасан юм. АНУ-ын эрсдлийг удирдах сан (U.S. hedge fund)-ийн охин компани болох OZ нь Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсын ашигт малтмалын нөөцийг хянахын тулд Израилийн тэрбумтан Дэн Гэртлэрийн бий болгосон хахуулийн схемд оролцсон гэм буруутай болохоо шүүхэд мэдүүлсэн билээ. Хэрэг хаагдахын босгон дээр хахуулийн уршигаар ашигт малтмалын эрх нь үнэгүйдсэн Канадын Africo компанийн хувьцаа эзэмшигчид эрүүгийн хэргийн яллагдагч үйлдсэн хэргийнхээ хохирогчид нөхөн төлбөр олгохыг шаардсан хууль болох Хохирогчийн эрхийг заавал сэргээх тухай хууль (Mandatory Victim Restitution Act⁶¹²)-ийн дагуу хохирол нөхөн төлүүлэх тухай нэхэмжлэл гаргасан байдаг.

OZ болон хэргийн прокурорууд аль аль нь хувьцаа эзэмшигчдийн энэхүү нэхэмжлэлийг эсэргүүцэж байв. Хуульд заасны дагуу, нэхэмжлэл гаргасан хүмүүс гэмт хэргийн улмаас “шууд, зайлшгүй хохирсон” болохоо нотлон харуулах ёстой аж. Гэвч OZ-ийн хахууль ба Africo-гийн хувьцаа эзэмшигчдэд учирсан хохирлын хоорондох шалтгаант холбоог бүдгэрүүлсэн хэд хэдэн үйл явдал болж өнгөрсөн байдаг. Эдгээр хөндлөнгийн үйл явдлууд л хувьцаа эзэмшигчдийг чухамдаа авлигын шууд бус хохирогч болгосон хэмээн засгийн газар ч, OZ ч мэдэгдэв. Мөн аль ч тохиолдолд хохирол нь хахуулиас хол хөндий байсан тул хахууль тэдэнд шууд, зайлшгүй нөлөөлсөн гэж хэлэх боломжгүй байв. Эцэст нь, хувьцаа эзэмшигчдэд учирсан хохирол болон уурхайг ашиглах боломжоо алдсаныг хялбар тодорхойлох боломжгүй хэмээн OZ маргаж, хэрэгт холбогдолтой аливаа шийдвэрийг “төсөөлөл”, “таамаглал” гэж үзэв.

Авлигын хор уршгийг илчлэн харуулахад тулгарч буй гол бэрхшээл бол “шууд”(direct) ба “зайлшгүй”(proximately) шалтгаан бөгөөд хохирлыг ийнхүү нарийвчлан тооцоолох нь Америкийн хууль тогтоомжийн дагуу авлигын нөхөн төлбөр авахыг хүсэж буй хүмүүст л зөвхөн саад тотгор болж буй зүйл хараахан биш юм. АЭНҮБК-ын 35 дугаар зүйлд⁶¹³ заасны дагуу

⁶¹⁰ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2020/12/17/a-breaththrough-in-recognizing-who-is-a-corruption-victim/>

⁶¹¹ <https://casetext.com/case/united-states-v-oz-africa-mgmt-gp-llc>

⁶¹² <https://www.law.cornell.edu/uscode/text/18/3663A>

⁶¹³ Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний Байгууллагын конвенц. 35 дугаар зүйл. Хохирлыг нөхөн төлөх. “Оролцогч улс бүр авлигын үйлдлийн улмаас хохирсон хуулийн этгээд буюу хувь хүн хохирлоо нөхөн төлүүлэхийн тулд уг

дэлхийн бүх улс оронд авлигын гэмт хэргийн хохирогчид гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн барагдуулахыг хүссэн нэхэмжлэл шүүхэд гаргах эрхтэй боловч хохирогчид хохирол барагдуулах нэхэмжлэл гаргадаггүйн үндсэн шалтгаан хэмээн эдгээрийг эш татсаар ирсэн билээ. OZ Africa Management-ийн шүүх хурал нь зөвхөн АНУ-ын хуулийг сурталчилан таниулсан явдал болсон төдийгүй, түүний үндэслэл нь иргэд нь авлигын улмаас хохирсон тохиолдолд хохирлыг барагдуулах жишгийг бусад улсын шүүхэд санал болгож буй юм.

Авлигын бүдүүвч

Africo-ийн хувьцаа эзэмшигчдийг хохироосон авлигын хэрэг 2006 оноос эхэлсэн юм. Africo-гийн ажилтан байсан нэгэн хүн тус улсын зүүн өмнөд хэсэгт орших зэс, кобальтын баялаг судал бүхий Калукунди уурхайн Africo-гийн эзэмшдэг хувийг өөртөө шилжүүлэх нууц шийдвэрийг Конго улсын шүүхээс авлигын аргаар гаргуулав. Africo 2007 оны 04 дүгээр сард уг шүүхийн шийдвэрийн талаар мэдсэн даруйдаа хүчингүй болгуулахаар нэхэмжлэл гаргасан байдаг. Уг уурхай тус компанийн цорын ганц чухал хөрөнгө байсан бөгөөд эрх нь сэргэх хүртэл уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэхэд бэрхшээл тулгарсан байна.

Africo-гийн нэхэмжлэл БНАКУ-ын шүүхүүдээр дамжин явж байх тэр үед OZ тус улсын Ерөнхийлөгч Лорэнс Кабилагийн итгэлийг олсон хүн болох Гэртлэрийн эрдэс баялгийн давуу эрх олж авахын тулд байгуулсан корпорацад хөрөнгө оруулж эхэлсэн байдаг. Төлөвлөгөөнд Калукунди уурхайд хяналтаа тогтоох зорилготой OZ Africa үйл явцад оролцож эхлэхийнхээ өмнө хийсэн эхний алхам нь мөнөөх хуучин ажилтанд нууц тогтоол гаргуулахын тулд БНАКУ-ын шүүгчдийг хахуульдах явдал байв. OZ Africa хөрөнгө оруулагч болсны дараа ч авлига үргэлжилсэн юм. Гэртлэр Africo-гийн нэхэмжлэлийг гацааж удаашруулахын зэрэгцээ Africo-г өөрийн болгохоор тохиролцохын тулд шүүгч, шүүхийн ажилтнууд болон БНАКУ-ын Ерөнхий прокурор нарыг хахуульдахад OZ-ийн хөрөнгө оруулалтаар орж ирсэн мөнгийг ашигласан байдаг. Дампууралд хүргэж болзошгүй бэлэн мөнгөний хямралтай тулгарсан тул хожим Калукундигийн үйл ажиллагааг гацаахад ашигласан хяналтын багцыг түүнд (Гэртлэрт) зарахаас өөр сонголт Africo-д үлдээгүй байна.


Хувьцаа эзэмшигчид хохирсон шалтгаан

Авлигын улмаас Калукундигийн үйл ажиллагаа уналтад орсон тул түүнээс хүртэх байсан бүхий л ашгаа алдсан гэдэг нь хувь нийлүүлэгчдийн хохирлын нэхэмжлэлийн гол утга санаа байв. Хохирол нь ашиглагдаагүй байгаа уурхайн өнөөгийн үнэ цэн болон хэрвээ ашигласан бол ямар үнэ цэнтэй байх байснаас хамаарна хэмээн тэд үзсэн бөгөөд тус бүрийн тооцоо үнэлгээг хөлсний мэргэжилтнээр бэлтгүүлэн ирүүлсэн байв.

Шууд хохирол

Хувьцаа эзэмшигчдийн хүлээн зөвшөөрсөнчлөн, тэд өөрсдөө уурхайн эрхийг шууд эзэмшдэггүй байсан юм. Харин OZ-гийн материалуудаас авсан доорх зурагт үзүүлсэнчлэн Канадын нээлттэй хувьцаат компани болох Africo компанийн хувьцааг эзэмших байдлаар дам эзэмшиж байв. Энэ компани нь эргээд Конго улсын траст компанийн хувьцааг эзэмшдэг Канадын хувийн корпорацад хувьцаа эзэмшиж байв. Тэрхүү траст компани нь ашигт малтмалын орд газар дахь Калукунди уурхайг өмчлөх зөвшөөрөл бүхий Конгийн корпорацын хувьцаа эзэмшигч байсан аж. Хувьцаа эзэмшигчдэд шууд хохирол учруулсан гэсэн аливаа нэхэмжлэлийг энэхүү өмчлөлийн урт гинжин хэлхээ үгүйсгэж байна хэмээн OZ маргаж байсан юм. Мөн АНУ-ын хуулийн дагуу “корпорацын хохирол нь хувьцаа эзэмшигчдэд “шууд” нөлөөлдөггүй, харин тэдэнд хэд дахин бага хохирол учруулдаг” хэмээн нотлон мэдэгдэж байв.

хохирлыг хариуцах этгээдийн эсрэг эрх зүйн ажиллагаа эхлүүлэх эрхтэй байх явдлыг хангах үүднээс шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо зарчимд нийцүүлэн авна.



Уурхайд оруулсан хувьцаа эзэмшигчдийн хувийг “биет бус” өмчлөх эрх гэж үзэн, дээрх үндэслэлийг шүүхээс няцаав. Ингэснээр дээрх хахууль нь хувьцаа эзэмшигчид болон уурхайн хоорондох зуучлагчдын урт гинжин хэлхээнд төдийгүй тэдний эрхийн үнэ цэнд “шууд” нөлөөлсөн гэж үзэхэд хүргэсэн юм. Гэвч хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуульд юу ч байхгүй, энэ хууль нь биет бус өмчийн эрх эзэмшигчдэд учирсан хохирлыг нөхөн төлөхөөс татгалзах агуулгатай гэдгийг шүүхээс сануулсан байна. Иймээс хувьцаа эзэмшигчид хахуулийн улмаас “шууд хохирсон” болохоо албан ёсоор нотлох шаардлагатай нүүр тулав.

Зайлшгүй шалтгаан

“Зайлшгүй шалтгаан” гэдэг нь нэг хүний үйлдэл нөгөө хүнд учирсан хохиролтой хангалттай холбоотой байгаа тохиолдолд тухайн үйлдлийг хийсэн этгээд хохирлыг хариуцах ёстой гэдгийг илэрхийлэхэд Америкийн хууль тогтоомжид ашигладаг нэр томьёо. Энэ бол физикийн хуулиар тодорхойлогдсон бодит асуудал биш бөгөөд Америкийн хуулийг тайлбарлах байгууллагын тайлбарласны дагуу “логик, эрүүл саруул ухаан, шударга ёс, бодлого, жишгийг нэгэн зэрэг эргэцүүлсэн”-ий үндсэн дээр шийдвэрлэдэг асуудал юм.

Прокурор OZ-ийн санхүүжүүлсэн хахууль нь хувьцаа эзэмшигчдийн хохирлын зайлшгүй шалтгаан биш, тэдний алдагдлыг өдөөсөн хахууль бол Калукунди дахь Africo-гийн эрхийг авах нууц шүүхийн шийдвэрийг худалдаж авсан явдал бөгөөд энэ нь OZ Гэртлэрт хөрөнгө оруулахаас өмнө болсон явдал гэж үзэж байв. Мөн хахууль өгөхөөс өмнө ч Africo уурхайг ашиглах хөрөнгөгүй байсан, улмаар хангалттай санхүүжилт олж авахын тулд хяналтын багцаа зарах шаардлагатай болсон хэмээн OZ онцолж байв. Үүнээс гадна, хахууль өгсний дараа өрнөсөн хэд хэдэн үйл явдал Калукунди уурхайг ашиглах эрхийн үнэ цэнд нөлөөлсөн, мөн иргэний дайн, эдийн засгийн уналт, орон нутгийн үймээн самуун зэрэг олон санамсаргүй тохиолдлууд ч үүнд нөлөөлөх боломжтой байсан. Төвчхондоо, хахууль ба алдагдлын хооронд шууд шалтгаант холбоо байхгүй гэж байв.

Эдгээр хөндлөнгийн үйл явдлууд зайлшгүй шалтгааныг үгүйсгэж байна гэдэгт шүүх автагдаагүй юм. Үүнээс гадна, хэдийгээр OZ нь Afrisco-гийн эрхийг анх хулгайлсны дараа холбогдсон ч уг хулгайн учруулсан хохирлыг хариуцах ёстой. Шүүгдэгч гэмт хэргийн хуйвалдаанд нэгэнт нэгдэн орсон тохиолдолд Америкийн хууль тогтоомжийн дагуу тэрээр хуйвалдааны бүхий л үйлдлийг хариуцах бөгөөд энэхүү зарчим нь гэмт хэргийн хуйвалдааны улмаас учирсан хохирлыг нөхөн төлөхөд хүргэж байна. Afrisco-гийн эрхийн анхны хулгай нь түүний санхүүгийн асуудлыг улам хурцатгасан боловч шаардлагатай санхүүжилт олж авахын тулд компанийн хяналтын багцыг зарахаас өөр аргагүй байдалд хүрсэн эсэхийг мэдэх арга байхгүй юм, гэвч “*ямар ч тохиолдолд үйл ажиллагаагаа шударгаар явуулах боломжоо алдсан нь [хохирогчдын хохирлыг барагдуулах тухай хуулийн дагуу] нөхөн төлөгдөх хохирол мөн*” хэмээн шүүхээс мэдэгдсэн байна. Хэдийгээр, шүүхээс батлан мэдэгдээгүй боловч энэ хэргийн явцад ер бусын их хэмжээний буюу Кабилад өгсөн 20 сая гаруй долларын хахуулийг илрүүлсэн нь энэхүү зайлшгүй шалтгааныг олж тогтооход нөлөөлсөн байж болох юм. Учир нь, шүүгдэгчийн зан байдал хэчнээн буруушаагдах тусам нэхэмжлэгчийн хохирлын зайлшгүй шалтгаан мөн гэж шүүх үзэх магадлал өндөр байдаг нь Америкийн иргэний эрхийн зөрчлийн эрх зүйд нийтлэг юм (эндээс⁶¹⁴ болон эндээс⁶¹⁵ үзнэ үү). Улс үндэстний удирдагч болон шүүх засаглалын системийн ялзралаас илүү буруушаагдах үйлдлийг төсөөлөхөд ч бэрх ажгуу.

Хохирлын хэмжээг тогтоох нь

Хувьцаа эзэмшигчид хахуулийн улмаас алдагдсан байр сууриа сэргээж, хохирлоо барагдуулах эрхтэй болов. Ингээд хохирлын хэмжээг тодорхойлохын тулд шинжээчид 2008-2018 оны хооронд хүдрийн үнэ хэрхэн өөрчлөгдсөн, хувьцааны ханш ямар байх байсан, мөн уурхайн ашиглалт, түүнээс олох байсан ашигт нөлөөлж болох байсан бусад хүчин зүйлийг тооцоолох шаардлагатай болсон байна. Засгийн газар хэд хэдэн үүрэг хүлээх болов. Шалтгаант холбоог бүдгэрүүлсэнтэй адил тодорхойгүй байдал нь хувьцаа эзэмшигчдэд учирсан “төсөөллийн, таамаглалт”, “бодит бус” хохирлын хэмжээг тооцоолоход хүргэсэн хэмээн OZ маргаж байв.

Хувьцаа эзэмшигчдийн нөхөн төлүүлэх эрхтэй болсон хохирлын хэмжээг тооцоолох нь зарим талаар маш төвөгтэй ажил байсан ч энэ нь тэдний эрхийг нөхөн сэргээхээс шүүх татгалзах ёстой байсан гэсэн үг биш юм. Энэхүү нотолгоог шүүх хүчтэй үндэслэлээр няцаасан байдаг. Хохирлыг яв цав тогтооход хөндлөнгийн бэрхшээл учирч байгаа тохиолдолд үндэслэл бүхий тооцоо хангалттай болохыг Америкийн хууль тогтоомжид тодорхой хуульчилсан байдаг. АНУ-ын Дээд шүүхийн 1931 оны шийдвэрт⁶¹⁶ тайлбарласнаар:

“Иргэний эрхийн зөрчил нь өөрөө хохирлын хэмжээг баттай тогтооход саад учруулах шинж чанартай байгаа бол, хэдийгээр барагцаалж буй боловч, нотлох баримт хохирлын хэмжээг шударга, үндэслэлтэй илэрхийлж байгаа тохиолдолд хангалттай байна.

Гэм буруутай этгээд өөрөө хохирлын хэмжээг тооцох үүрэг хариуцлага хүлээснээс бусад тохиолдолд хохирлын хэмжээг нарийвчлан гаргах боломжгүй гэж гомдол гаргах эрхгүй.”

Шүүхийн шийдвэрийн сайн үндэслэл хийгээд Америкийн хэргүүдийг мөрдөхөд ямарваа байдлаар хязгаарлалт болохгүйгээс бусдаар OZ Africa Management-ийн шүүхийн шийдвэрт онцгой зүйл байхгүй байж магадгүй юм. Шүүхээс авлигын хор уршгийг бодитойгоор үнэлж, хохирлыг нөхөн төлүүлэх шаардлагатай байгааг АЭНУБ-д бичсэн байдаг. Хахууль болон авлигын бусад хэлбэрээр хохирсон хүмүүс хохирлоо барагдуулахыг хүссэн тохиолдолд аливаа шүүх уг Конвенцын хэм хэмжээг дагаж мөрдөх ёстой.

⁶¹⁴ https://scholarship.law.upenn.edu/cgi/viewcontent.cgi?article=8593&context=penn_law_review

⁶¹⁵ https://scholarcommons.sc.edu/cgi/viewcontent.cgi?article=2039&context=law_facpub

⁶¹⁶ <https://supreme.justia.com/cases/federal/us/282/555/>

Лондон хотын тансаг байшингуудын арилжааны цаана бохир мөнгөө нууж байна⁶¹⁷

2020.12.21. Лондон дахь өндөр үнэтэй тансаг байшингууд нь бохир бэлэн мөнгийг нуух зорилготой эрүүгийн хэрэгтнүүдийн сонирхлыг төрүүлэх болсон тул Их Британийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлд мөнгө угаах гэмт хэргийн эсрэг тэмцэх зорилт тавигдаж байна.

Их Британийн засгийн газраас энэ онд хийсэн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үнэлгээний 12 дугаар сарын тайланд дурдсанаар хууль бус үйл ажиллагааг далдлах зорилгоор үл хөдлөх хөрөнгийн худалдан авагчид нэмэгдсэн байж болзошгүй байдал нь холбогдох эрсдлийг нэмэгдүүлжээ.

“Гэмт хэрэгтнүүд Лондон, Эдинбург, эсвэл их сургуулиудын хотхон зэрэгт байрлах өндөр үнэ цэнтэй үл хөдлөх хөрөнгийг илүүд үздэг бөгөөд ялангуяа Лондонд гадаадын аж ахуйн нэгжүүд байрлах болон үйл ажиллагаа явуулахад тааламжтай байдаг гэж уг тайланд дурджээ.

КОВИД-19 цар тахлын улмаас энэ салбар бохир мөнгөнд илүү өртөмтгий болсон. Гарцаагүй байдалд орсон, эсвэл дампуурсны улмаас худалдан борлуулж буй үл хөдлөх хөрөнгийг гэмт хэрэгтнүүд олж авахыг эрмэлздэг ба орон сууцны зориулалттай үл хөдлөх хөрөнгө нь арилжааны хөрөнгөөс илүү өндөр эрсдэлтэй гэж үздэг боловч хэлцлийг хийхэд хурдан, хялбар байдаг онцлогтой.

Авлигатай холбоотой үл хөдлөх хөрөнгийн дөрөвний гурвыг Кайманы арлууд гэх мэт татварын диваажин болсон байршилд бүртгэлтэй компаниуд эзэмшдэг гэж ТИ мэдээлсэн.

Тус байгууллагын олж тогтоосноор Их Британид сэжиг бүхий эх үүсвэрээс худалдаж авсан 500 гаруй үл хөдлөх хөрөнгө байгаа бөгөөд эдгээрийн нийт үнэлгээ нь 5 тэрбум фунт стерлинг буюу 6.6 тэрбум доллар болжээ. Энэ нь Их Британийн үл хөдлөх хөрөнгөд нуугдсан бохир мөнгөний бодит үнэлгээний зөвхөн нэг хэсэг байж магадгүй юм.

Азербайжаны шоронд хоригдож буй банкирын эхнэр нийт 22 сая гаруй фунт стерлингийн үнэтэй Лондонгийн гадна тансаг зэрэглэлийн гольфын клуб болон Харродс дэлгүүрийн ойролцоо орон сууцны байшингийнхаа тухай мэдээллийг Их Британийн эрх бүхий байгууллагад өгөөгүй. Тус улсын Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх газраас мэдээлснээр тэрээр эдгээр үл хөдлөх хөрөнгөө бусдад худалдан борлуулах болон шилжүүлэх боломжгүй болсон ажээ.

Үндэсний гэмт хэрэгтэй тэмцэх газраас явуулсан ажиллагааны үр дүнд Английн Лидс хотын бизнесмэн Мансур Махмуд Хуссейн Их Британид байршилтай 45 үл хөдлөх хөрөнгийнхөө эх үүсвэрийг тайлбарлаж чадахгүй байсан ба үл хөдлөх хөрөнгийн багцыг бий болгох гэмт хэрэгт холбогдсон гэх үндэслэлээр нийт 9.8 сая фунт стерлингийн хөрөнгийг энэ 10 дугаар сард хураан авсан юм.

Банкны дээрэмчин болгонд зугтах машин хэрэгтэй: Банкны удирдах ажилтан мөнгө угаасан хэргээр шалгагдаж байна⁶¹⁸

2021.01.13. Emile Van Der Does De Willebois. Өнгөрсөн сард Нидерландын давж заалдах шатны шүүхээс тус улсын хамгийн том банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан хүнд эрүүгийн хэрэг үүсгэн шалгахыг улсын прокурорт үүрэг болгожээ. Шүүхээс Ральф Хэмерсийг Амстердамд төвтэй ING банкны гүйцэтгэх захирлаар 7 жил ажиллах хугацаандаа мөнгө угаасан болон бусад гэмт хэрэгт буруутган шалгах ажиллагаа явуулахыг үүрэг болгосон байна. Санхүү, хууль эрх зүйн мэргэжилтнүүд өөрсдийн үйлдсэн хэргийнхээ төлөө яллагдагчаар татагдах нь ховор байдаг бөгөөд удирдах албан тушаалтнууд онилогдох нь бүр ч ховор байдаг. Энэхүү шийдвэрээс өмнө

⁶¹⁷ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://www.bloomberg.com/news/articles/2020-12-21/london-luxury-homes-are-a-prime-location-to-hide-dirty-money?fbclid=IwAR3kbqMAOanuIwgehlxaFQcxCxNMQNI3a2j_EpgF4ZGWp1UYKE1FdRx3Wms

⁶¹⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/01/13/guest-post-every-bank-robber-needs-a-getaway-car-banker-held-accountable-for-money-laundering/#more-17504>

Голдман Саксын банкируудыг IMDb-ийн дуулианд оролцсон хэрэгт буруутгаж байсан нь хамааралгүй зүйл байсан.

“Тэнд” гарч буй авлигад “энд” байгаа банкирууд, хуульчид, нягтлан бодогчид болон бусад зуучлагчдын үйлчилгээ шаардлагатай байдаг гэдгийг бид бүгд мэднэ. Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын санхүүгийн төвүүд дэх санхүүгийн болон корпорацын үйлчилгээнүүд нь хөгжиж буй орнуудын ихэнх хэсэгт илэрсэн авлигад түлхэц болж байгаа талаар бид ярьдаг.

Гэхдээ авлигын эсрэг ажиллаж байгаа хүмүүс энэ ойлголттой санал нийлэх эсэх нь өөр асуудал юм. ТИ байгууллагын АТИ-ийг харахад хөгжингүй орнууд авлигатай сайн тэмцэж байгаа гэсэн ойлголтыг төрүүлдэг бөгөөд хүснэгтийн доод хэсгийг харвал авлига нь хөгжиж буй орнуудад үнэхээр асуудал болж байна. Бид Панамын баримт бичиг, IMDb, Danske банк болон FinCEN файлуудын талаарх асуудлуудаас бүрэн сургамж аваагүй бөгөөд энэ нь авлигын хэрэг гарахад банкууд, хуульчид болон бусад мэргэжилтнүүдийн үзүүлж буй үйлчилгээ нөлөөлж байгааг харуулж байна.

Асуудлын нэг хэсэг нь санхүүгийн болон компанийн үйлчилгээ эрхлэгчдийн авлигад эзлэх үүрэг оролцоо аюултай түвшинд хүрснийг олж харахгүй байгаа явдал юм.

Мөнгө угаагчдын үйлчилгээ нь зохион байгуулалттай гэмт хэрэг, эсвэл авлигын гэмт хэрэгтэй салшгүй холбоотой болохыг ойлгох нь чухал юм. Бид хахууль болон эд хөрөнгө ашиглан шамшигдуулах нь мөнгө угаах хэргээс өөр зүйл гэж үздэг боловч эдгээр нь хоорондоо уялдаа холбоотой байдаг. Мөнгө угаах нь зөвхөн мөнгө хулгайлсан хүнд үзүүлж буй дараагийн бодит тусламж биш юм. Энэ бол бүхэл бүтэн схемийн нэг хэсэг бөгөөд нэг нь нөгөөгүйгээр оршин тогтнох боломжгүй юм. Банкны дээрэмчид хэзээ ч гарахгүй болтлоо дээрэм хийхээр төлөвлөхгүй – түүнд зугтах машин хэрэгтэй, эс тэгвээс түүний төлөвлөгөө амжилтгүй болно. Үүнтэй адилаар бусад газарт үйлдсэн авлигын үйлдлүүдэд барууны банкирууд болон компанийн үйлчилгээ эрхлэгчдийн санал болгодог зугтах машин хэрэгтэй юм. Хууль эрх зүйн хувьд тэдгээрийг хоёр тусдаа гэмт хэрэг гэж үздэг ч бодит байдал дээр нэг зоосны хоёр тал болохыг нуух ёсгүй.

2018 онд дэлхийн хэмжээний санхүүгийн системийн нөлөө бүхий ING банк нь мөнгө угаах хэрэгтэй тэмцэх хяналтын сул байдлыг ашиглан, дансаараа дамжуулан олон удаа мөнгө угаасан болохыг Нидерландын прокурорын газраас хянан шийдвэрлэжээ. Уг банк 675 сая еврогийн торгууль болон хууль бусаар олсон 100 сая еврогийн хураамж, нийт 775 сая еврог төлсөн байна. Үндэсний болон Европын зохицуулагчид тус банканд удаа дараа анхааруулж байсан ч анхааруулгыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Прокурорын байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэх хангалттай нотлох баримт байхгүй гэж үзсэн тул нэг ч хүнд эрүүгийн хэрэг үүсгээгүй. Давж заалдах шатны шүүхийн шийдвэр энэ тооцоог өөрчилж байна. Үүнээс дөрвөн зүйлийг онцлон тэмдэглэе.

- Уг үйл явцыг гуравдагч этгээд болох SOBI (компанийн мэдээллийг мөрдөн шалгах сан) санаачилсан бөгөөд тус сан нь хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор байгуулагдсан юм. Уг байгууллага тухайн хэргийг сонирхсон гуравдагч этгээдээс эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхлэх хүсэлтийг прокурорын байгууллагад гаргах боломжийг олгодог хуулийн заалтыг ашигласан байна. Сангийн дүрмийн нэг заалтад “Компанийн шударга байдлыг сайжруулах хүчин чармайлтыг хянах” тухай заасан байдаг тул SOBI уг хэргийг сонирхож байсан аж.
- ING банк гэмт хэрэг үйлдсэн болон ашиг орлогодоо онцгой анхаарсан гэм буруутай үйлдлийн талаар гаргасан прокурорын дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн юм.
- Гүйцэтгэх захирал бол гэмт хэргийн шинжтэй үйлдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах эрх бүхий албан тушаалтан бөгөөд үүрэг хүлээсэн хүн гэж дүгнэсэн. Тэрээр хууль бус үйлдэл гарах магадлал өндөр байгааг мэдсээр байж арга хэмжээ авахаас татгалзсан.
- Гүйцэтгэх захирал өөрийн хийсэн үйлдлийнхээ төлөө хариуцлага хүлээдэггүй. Хувьцаа эзэмшигчдийнхээ зардлаар томоохон гэрээ хэлэлцээр хийж, хүлээсэн үүрэг хариуцлагаа умартаж байгаа нь ёс суртахуунгүй хэрэг гэж үзсэн. Тиймээс шүүх SOBI-ийн гомдлыг үндэслэлтэй гэж үзээд ноён Хэмерсийг эрүүгийн хариуцлагад татах ёстой гэж дүгнэсэн.

Банкны удирдлагууд хориглосон үйл ажиллагааг үнэхээр удирдаж ажилласан бол ял шийтгэлгүй үлдэхгүй байх дүрмийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тусгасан байх нь чухал юм.

Энэ шийдвэрийн эцэст ноён Хэмерс гэм буруутай нь тогтоогдох болно гэсэн үг биш бөгөөд үүнийг эрүүгийн хэргийн шүүх ажиллагаа шийдвэрлэх болно.

Гадаадын албан тушаалтны хахуулийн хэрэгт хохирол барагдуулах зарчим⁶¹⁹

2021.01.25. Sam Hickey. Гадаадын хахууль нь хөгжиж буй орнуудын иргэд, засгийн газарт хор хохирол учруулдаг гэдэгтэй бүгд санал нийлдэг. Гэхдээ ихэнх тохиолдолд хахууль өгсөн талын харьяалагддаг улсын шийдвэр гүйцэтгэх байгууллагууд нь гадаадын албан тушаалтнуудад хахууль өгсөн гэж буруутгагдсан компанитай шүүхээс гадуур тохиролцсон үед уг хахуулийг авсан талын харьяалагддаг улсын засгийн газар, эсвэл иргэдтэй тохиролцоо хийж, төлбөр тооцооны асуудал яригддаггүй. Авлигын учруулж буй хор уршгийг зөв тогтооход бэрхшээл тулгарч байдаг тул энэ нь гайхмаар зүйл биш юм. Эрдэмтэн судлаачид, нийгэм, улс төрийн идэвхтэй тэмцэгчид хахууль өгсөн талын хуулийн байгууллагууд болон хахуулийг өгсөн компанийн хооронд тохиролцоо хийлгэж, улмаар гадаадын хахуулийн улмаас хохирсон этгээдүүдийг хамгаалахыг шаарддаг боловч АНУ-ын Хууль зүйн яам (ХЗЯ) болон Их Британийн Онц ноцтой луйврын алба (ОНЛА) зэрэг хууль, шүүхийн зарим байгууллага дээрх асуудалд маш бага анхаарал хандуулдаг. Түүнчлэн, энэ чиглэлээр ямар нэгэн өргөн хүрээтэй бодлогын хөтөлбөр, зарчмын үзэл баримтлалгүй өнөөг хүрчээ.

Энэхүү нийтлэлд илүү тогтвортой үр дүнд хүрч, шилдэг туршлагыг хөгжүүлэх жишиг болгон ашиглаж болох үзэл баримтлалыг санал болгож байна. Гэхдээ авлигын хохирогч болсон гадаадын иргэдийн хувийн эрх ашиг болон олон улсын хууль тогтоомжид заасан үүргийг үүгээр хөндөөгүй. Авлигын үйл явдал газар нутаг дээр нь хэрэгжиж, түүнд холбогдох тохиролцоог хууль шүүхийн байгууллагын үзэмжээр хийж байгаа асуудалд бид анхаарал хандуулсан.

Хууль, шүүхийн байгууллагын анхаарч үзэх ёстой хүчин зүйлсийн талаар авж үзэхээс өмнө хор хохирлын талаарх 2 өөр ойлголт, хохирогчтой холбоотой 2 ойлголтыг хооронд нь ялгаж салгах нь чухал бөгөөд эдгээр нь эргээд энэ нийтлэлд багтсан хоёр хэлбэрийн хамгаалалтын ялгааг тодорхойлоход ач холбогдолтой юм.

Нэгдүгээрт, бид шууд ба шууд бус хор хохирлыг ялгах хэрэгтэй. Хохирогчид учруулсан хохирол нь гэмт хэрэгтний буруутай үйл ажиллагаатай шууд холбоотой байх тохиолдолд шууд хохирол гэж үзнэ. Гадаадын хахуулийн улмаас шууд хохирол учруулж буйн жишээ болгон Их Британийн ОНЛА болон Стандарт банкны хооронд хийсэн тохиролцоог тайлбарлая. Стандарт банкны охин компани Танзанийн засгийн газарт төлөх байсан 6 сая долларыг хахуульд өгсөн байна. Стандарт банкны уг хахуулийн улмаас Танзани улсын засгийн газар шууд хохирол амсав. Хэрэв уг хахуулийг өгөөгүй байсан бол тэрхүү 6 сая долларыг Танзанийн засгийн газар авах байсан. Тиймээс Стандарт банкны охин компанийн зүгээс Танзанийн засгийн газарт 6 сая доллар төлөхийг дээрх тохиролцоогоор шаарджээ. Харин шууд бус хор хохирол нь гадаадын хахуулийн сөрөг үр дагавар бөгөөд түүний хохирогч нь ард иргэд гэж хэлж болох юм.

Шууд болон шууд бус хор хохирлыг ийнхүү ялгаатай авж үзсэнээр авлигын янз бүрийн хохирогчдыг хооронд нь ялгаж авж үзэхэд чухал ач холбогдолтой байдаг. Энд “нэгдүгээр зэргийн” хохирогчид гэж шууд хохирол амссан хохирогчид, харин хоёрдугаар зэргийн хохирогчид нь “хоёрдугаар эрэмбийн” хохирогчид юм. Эдгээр ялгаа нь эргээд гадаадын хахуулийн хор хохирлыг арилгах нөхөн төлбөр олгох ба тусламж үзүүлэх гэсэн хоёр арга замыг тайлбарлахад дөхөмтэй болно. Нөхөн төлбөр олгох арга нь нэгдүгээр зэргийн хохирогчид учирсан шууд хохиролтой аль болох тэнцэх хэмжээний нөхөн төлбөр өгөхийг ойлгоно. Дээр дурдсан Стандарт банкны хийсэн тохиролцоо нь нөхөн төлбөрийн жишээ юм. Тусламж үзүүлэх арга зам нь авлигын шууд бус хор хохирол учирсан хоёрдугаар эрэмбийн хохирогчдод зориулагдсан байдаг. Жишээлбэл, аливаа хариуцагч компани хахуулийн хохирогч болсон улсын дэд бүтцийн санаачилга, эсвэл буяны үйлсэд зориулан санхүүжилт гаргах тухай асуудлыг хахуулийн тохиролцооны нөхцөлд багтаахыг Их Британийн ОНЛА, АНУ-ын ХЗЯ шаарддаг.

⁶¹⁹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/02/25/principles-for-victim-remediation-in-foreign-bribery-cases/?fbclid=IwAR264QP39CnpKztKrRdmlmdjWmGdoZMWijvSEAgmXnTbrxV6CSvSNNEq2ro>

Хууль, шүүхийн байгууллагууд дээрх ялгаатай байдлыг харгалзаж нөхөн төлбөр олгох ба тусламж үзүүлэх арга замын аль тохиромжтойг хэрэглэхээ шийдвэрлэнэ.

Нөхөн төлбөрийн хувьд хууль шүүхийн байгууллага дараах хүчин зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр тохиролцооны нөхцөлд багтаах эсэхийг шийдвэрлэнэ:

- Нэгдүгээрт, нэгдүгээр зэргийн хохирогчийг ялган таних боломжтой эсэх;
- Хоёрдугаарт, хохирогчид учирсан хохирлын хэмжээг хэр зэрэг үндэслэлтэй тогтоосон байдал;
- Гуравдугаарт, хохирогчид нөхөн төлбөр төлснөөр (ялангуяа, хохирогч гадаадын засгийн газар байх үед) нэмэлт авлига үүсэх эрсдэлтэй эсэх. Тухайлбал, нөхөн төлбөрийн мөнгийг авлигын зорилгоор ашиглаж болзошгүй гэсэн эрсдэл байгаа эсэх, хэрэв ийм эрсдэл байгаа бол уг эрсдлийг маш сайн бууруулж байж арга хэмжээ авах.
- Дөрөвдүгээрт, нөхөн төлбөр олгох нь ач холбогдолгүй, эсвэл шаардлагагүй эсэх. Тухайлбал, хохирогчид туслах бусад боломж байгаа эсэх, эсвэл тусламж авах хүсэлгүй чинээлэг засгийн газрын хувьд ийм шийдвэр гаргаж болзошгүй юм.

Шууд бус хохирол нь дам байдалтай бөгөөд түүнийг тодорхойлоход хэцүү байдаг тул тусламж үзүүлэхдээ дээрхийн нэгэн адил хохирогчийг тогтоох, хор хохирлын хэмжээг тогтоох зэрэг нарийвчилсан арга хэмжээ авах шаардлагагүй. Харин дараах хүчин зүйлийг харгалзан үзсэний үндсэн дээр тусламж үзүүлэх арга хэмжээг тохиролцооны нөхцөлд багтаах эсэхийг шийдвэрлэнэ:

- Нэгдүгээрт, тусламж үзүүлэх нь нөхөн төлбөрөөс ялгаатай боловч шууд бус хохирлын шинж чанар ба үзүүлэх тусламжийн хэлбэрийн хооронд ямар нэгэн уялдаа холбоо байх ёстой. Жишээлбэл, мужийн нийгмийн эрүүл мэндийн салбар дахь монопол эрхийг хангахын тулд өгсөн хахуулийн улмаас тухайн салбарын үйлчилгээ доголдсон бол тусламжийг эмнэлэг, эмнэлгийн хэрэгсэл болон эрүүл мэндийн салбарын бусад зүйлсэд зориулах хэрэгтэй. Хууль, шүүхийн байгууллагын өнөөг хүртэл хийсэн тохиролцоонд дээрх холбоо хамаарлыг харгалзан үзээгүй байна.
- Хоёрдугаарт, хууль, шүүхийн байгууллагууд нөхөн төлбөрийн нэгэн адил тусламжийн хувьд дахин давтан авлига гарах эрсдлийг харгалзан үзэх ёстой. Гэхдээ тусламжийн хөрөнгийг ашиглаж буй байгууллага нь олон нийтэд хүртээмжтэй бүтцийн тусламжтайгаар тараасан хөрөнгийг авлигын зорилгоор ашиглахгүй байх нөхцөлийг хангах тул энэхүү эрсдлийг үнэлж, улмаар бууруулах нь тусламж үзүүлэх тохиолдолд илүү төвөгтэй байдаг. АНУ, Их Британи энэхүү эрсдлийг удирдах янз бүрийн арга хэмжээг авж хэрэгжүүлдэг. АНУ-ын ХЗЯ-ны хийсэн тохиролцоо нь оролцогч талуудад үүрэг хүлээлгэж, тусламжийн хөрөнгийг юунд зарцуулж болох, юунд зарцуулж болохгүйг заасан байдаг. Их Британийн ОНЛА үүнтэй ижил төстэй нөхцөлүүдийг тавьдаг боловч тусламжийн хөрөнгийг удирдах эрхийг төрийн бусад байгууллагад өгдөг.
- Гуравдугаарт, хууль, шүүхийн байгууллагууд нөхөн төлбөрийн нэгэн адил тусламж нь нөхцөл байдалд нийцэн, тохирч байгаа эсэхийг харгалзан үзэх ёстой.

Хахууль өгсөн талд илүүтэй анхаарал хандуулдаг гадаадын төрийн албан тушаалтны хахуулийн гэмт хэргийн олон улсын тогтолцоо нь энэ төрлийн авлигын улмаас хамгийн их хохирсон хөгжиж буй орнуудад хэрхэн тусалж чадахыг эрдэмтэд болон бодлого боловсруулагчид анхаарах хэрэгтэй. Гэхдээ энэ практик нь түр зуурын, тууштай бус хэлбэрээр явагдахаас илүүтэй тодорхой зарчим, шилдэг туршлагын дагуу хэрэгжих ёстой.

Мөнгө угаалт: Дэлхийн оффшор санхүүгийн системийн бараан тал – дүн шинжилгээ⁶²⁰

2021.02.27. Thalif Deen. Нью Йорк хотын хувцас угаалгын газрын гадаах самбар дээр “Бид бохир мөнгө биш, бохир хувцас угаадаг” гэсэн хөнгөн хуумгай уриа өлгөсөн байсан. Мөн Пулитцерийн шагнал хүртсэн зохиолч Жейк Бернштейний “Нууцлалын ертөнц” номоос сэдэвлэн бүтээсэн “Угаалгын газар” нэртэй кино нь мөнгө угааж буй ертөнцийг илчилсэн юм.

⁶²⁰ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://www.eurasiareview.com/27022021-money-laundering-darker-side-of-worlds-offshore-financial-system-analysis/?fbclid=IwAR0PfAJaR9g92VMEaEaX25dWrppd-3epj_n2tcQaD6J3ny9z-xrAnVwoD0

Энэ бол дэлхийн санхүүгийн системийн нууцлаг бараан тал юм. Олон сая долларын хууль бус ашиг олж, оффшор бүсэд аюулгүй байршуулсан нь дэлхийн хэмжээнд үйлдэгдсэн гэмт хэрэг хэмээн НҮБ-ын Олон улсын санхүүгийн хариуцлага, ил тод байдал ба шударга байдлын дээд түвшний зөвлөл (ОУСХИТБШБЗ)-ийн 2030 хөтөлбөрт дурдсан.

Мөнгө угаах, авлига, татварын хууль бус үйлдэл болон банкир, нягтлан бодогч, хуульчийн хууль бус үйлдлийг таслан зогсоох нь бүх нийтийн сайн сайхны төлөө дэлхийн эдийн засгийг өөрчлөх алхам болж байгааг ОУСХИТБШБЗ-ийг хамтран даргалагч, Нигери улсын Ерөнхий сайд асан Ибрахим Маяки тэмдэглэв.

Дэлхийн удирдагчид, Төв банкны ерөнхийлөгчид, бизнесийн болон иргэний нийгмийн тэргүүнүүд, эрдэмтэн судлаачдаас бүрдсэн уг Зөвлөлийн мэдэгдсэнээр дэлхийн ДНБ-ий 2.7%-тай тэнцэх хөрөнгийг жил бүр угаадаг бол татваргүй улс оронд үйл ажиллагаа явуулахыг эрмэлздэг корпорациуд жил тутам 600 тэрбум доллар хүртэлх хохирлыг засгийн газруудад учруулдаг хэмээн дээрх Зөвлөлийн илтгэлд дурджээ.

КОВИД-19 цар тахлын улмаас 131 сая хүн ядууралд орсон боловч тэрбумтнуудын хөрөнгө 27.5%-аар өссөн ба дэлхийн баялгийн аравны нэг нь оффшор дахь санхүүгийн хөрөнгө хэлбэрээр байршиж байгаа тул засгийн газрууд татвараа шударгаар бүрдүүлэх боломж хумигдаж байна гэж уг илтгэлд тусгасан.

Жишээлбэл, татвараас зайлсхийхээс үүдсэн жилийн алдагдлыг нөхсөнөөр Бангладеш улс нийгмийн хамгааллын сүлжээг 9 сая гаруй ахмад настанд хүргэх боломжийг олгож, Чад улс 38,000 анги танхимыг байгуулж, Герман улс 8,000 салхин цахилгаан үүсгүүр барьж байгуулах болно.

Дэлхийн хөгжлийн эдийн засгийн судалгааны хүрээлэнгийн захирал, профессор Кунал Сений хэлснээр: *“Цар тахлын улмаас үүссэн эдийн засгийн хямралаас шалтгаалан хөгжиж буй орнуудад татварын орлого огцом буурч байгаа үед хууль бус санхүүгийн урсгалын улмаас улс орнуудын төсөв санхүүд үүссэн их хэмжээний алдагдлыг шийдэх арга замыг эрэлхийлэх шаардлага гарч байна. Энэ асуудал нь улс орнууд боловсрол, эрүүл мэнд, дэд бүтэц зэрэг төрийн чухал үйлчилгээг үзүүлэхэд ч хамаарна.”*

“Дэлхийн аж үйлдвэржсэн Их 7-гийн улсуудаар удирдуулсан татвараас зайлсхийх, мөнгө угаах явдлыг хязгаарласан татварын бодлогын дэлхийн зохицуулалт нь цаг үеийн шаардлага юм” гэж тэр тэмдэглэв.

НҮБ-ын дээд түвшний зөвлөлийн шинэ илтгэлийг таатай хүлээн авж байгаа боловч энэ нь биднийг хааш нь аваачих вэ гэж бодох шалтгаан болно гэж Дэлхийн бодлогын форумын гүйцэтгэх захирал асан Жеймс А.Пол хэлсэн байна.

“Уг илтгэл нь авлигад идэгдсэн дэлхийн санхүүгийн тогтолцооны тухай аймшигтай дүн шинжилгээг харуулж, санхүүжүүлэгчдийн зүгээс сайн сайхан байдал, шударга ёс, хууль ёсны байдлыг хэрхэн доройтуулж байгааг дүгнэсэн”.

Түүний үзэж байгаагаар тогтолцооны бүтэц, дүрэм журмууд нь тогтвортой хөгжлийг хэрэгжүүлэхэд саад болж байгааг уг тайлан нотолжээ.

“Сүүлийн хэдэн арван жилийн хугацаанд дэлхийн санхүүгийн системд шүүмжлэлтэй хандаж байсан хүмүүс үүнтэй санал зөрөлдөхгүй ч шинэлэг зүйлийг олж мэдэх болно” гэж *“Үнэг ба тахиа”* - НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн Олигархи ба Глобал хүч номны зохиолч Пол хэлжээ.

“Тиймээс дэлхийн хамгийн баян гэр бүл, улс үндэстнүүд энэ тогтолцооны үндсэн ашиг хүртэгчид байсан ба тэд улс төрийн нөлөө ихтэй бөгөөд мөн ямар нэгэн зүйлийг өөрчлөх хүсэлгүй байгаа нь удаан хугацааны туршид тодорхой байсаар ирсэн” хэмээн тэрбээр онцолсон юм.

Ялангуяа, дэлхийн авлигын мафийн удирдагчид бол санхүүгийн байгууллагууд, олигархиараа дэлхийн хамгийн хүчирхэг улс болох АНУ, Их Британийн иргэд юм гэж тэр нэмж хэлэв.

“Тэд дэлхийн санхүүгийн системийг удаан хугацаанд удирдаж ирсэн бөгөөд энэхүү дээд түвшний зөвлөлийн дэвшүүлж буй “шударга ёс”, “ил тод байдал”, бусад сайн сайхан бүхний төлөө чиглэсэн шинэчлэлийн эсрэг зогсож байна” гэж Пол хэлэв.

Мөн тэр хэдийгээр, НҮБ-ын Ерөнхий Ассемблей болон Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн Ерөнхийлөгчид энэхүү зөвлөлийг байгуулж, дэлхийн олигархиуд авлигад сүйрлийн хэмжээнд хэрхэн автаж байгааг дахин сануулсанд баяр хүргэе гэв.

Дээрх илтгэлийн зохиогчид үүнээс цааш судлах боломжгүй ба энэ нь ч гайхах зүйл биш юм.

“Бидэнд санхүүгийн олигархи тогтолцооноос чөлөөлөгдөж, эцэст нь хүмүүсийн өөрсдийн хэрэгцээ, хүсэл эрмэлзлээр удирдуулсан дэлхийн ардчилсан дэг журмыг баримтлах төлөвлөгөө илүү хэрэгтэй байна”

Гана улсын иргэн НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Кофи Аннан нэгэнтээ хэлсэнчлэн *“Африкийн зарим удирдагчид олон тэрбум долларын төсвийн хөрөнгийг үрэн таран хийсээр байна. Гэтэл зам нурж, эрүүл мэндийн систем доголдож, сургуулийн хүүхдүүд ном сурах бичиг, ширээ сандал, багшгүй байсаар байгаа ба утаснууд ч ажиллахгүй байна”*.

Үндэсний татварын суурийг өөрчлөх, төсвийн зарлагын чухал төслүүдийн мөнгийг шилжүүлэх, татварын хууль бус ашиглалт, авлига, мөнгө угаах нь дэлхийн аюулгүй байдал, шударга ёсонд хор хөнөөл учруулж, гэмт хэрэгтнүүд болон олон улсын террористуудын үйл ажиллагаанд дэм болж, харилцан хамааралтай өнөөгийн дэлхийн эдийн засагт аюул учруулах болно гэж Вашингтон хотын Стимсон төвийн Дэлхийн засаглал, шударга ёс, аюулгүй байдлын хөтөлбөрийн ахлах ажилтан, захирал, доктор Ричард Понзио хэлсэн байна.

Санхүүгийн шударга байдлыг тогтвортой хөгжүүлэх тухайд санал болгож буй дэлхийн хэмжээний хэлэлцээр нь Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсгийг (1989 онд Их 7-гийн улс байгуулсан ба дараа нь хэдэн арван улс нэгдэн орсон) өөрчлөн өргөжүүлж, дэлхийн мөнгө угаахтай тэмцэх ажилтай уялдуулах ёстой гэж тэрээр үзэж байна.

Корпорацийн залилан ба авлига 2021⁶²¹

2021.04.17. Аж үйлдвэрийн салбар, хууль эрх зүйн тогтолцооноос үл хамааран аливаа бизнесийн үйл ажиллагаанд луйвар залилан, авлигын шинж тэмдэг оршиж байдаг. Компаниуд энэ эрсдэлд чиглэсэн томоохон арга хэмжээг хэрэгжүүлж байсан ч КОВИД-19 цар тахлын улмаас энэ зарчим өөрчлөгдсөн. Цар тахлын улмаас ажилтнууд зайнаас ажиллах хэлбэрт шилжих болсон нь тэдэнд тавих хяналтыг бууруулж байна. Одоо компаниуд залилангаас боломжийн хэрээр урьдчилан сэргийлэх стратегийг урьд өмнөхөөс илүү хэрэгжүүлэх шаардлага гарч байна. Залилангийн үйл ажиллагааг танихад нь туслах сургалтыг ажилтнуудын дунд тогтмол явуулах нь эргээд эрсдэл гарахад ажилтнуудын зүгээс мэдэгдэх боломжийг бүрдүүлнэ. Нэр нууцалсан мэдээлэл авах тогтолцоо нь ажилтнуудад мэдээлэл өгч байхыг шаарддаг. Хэрэв залилангийн гэмт хэрэг илэрсэн бол нарийвчилсан мөрдөн шалгах ажиллагаа хийж, эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллах шаардлага гарна.

АНУ

Кобре & Ким, олон улсын хуулийн фирм

“Байдены засаг захиргаа санхүүгийн болон корпорацийн залилангийн хэрэгтэй тэмцэх илүү түрэмгий байр суурь баримтлах төлөвтэй байгаа ба энэ нь Обамагийн засаг захиргааны баримталж байсан чиг шугамд нийцэж байгаа юм. Трампын үед корпорацийн захирлуудыг мөрдөн шалгах ажиллагаа ихэссэн хэдий ч корпорациуд болон банкуудын эсрэг хуулийн дагуу хэрэгжүүлж буй арга хэмжээ суларсан гэж хүмүүс үзэж байгаа. Энэ байдал Ерөнхий прокурор Меррик Гарландын удирдлага дор өөрчлөгдөх төлөвтэй байна. Үүнтэй холбоотойгоор залилан болон авлигын асуудалд ийнхүү илүү эрс шийдэмгий хандсанаар цар тахалтай холбоотой залилангийн хэрэгт ч анхаарал хандуулах боломжтой болно.”

БРАЗИЛ

BDO, олон улсын аудитын фирм

“”Машин угаах ажиллагаа” буюу төрийн өмчит газрын тосны Петробрас компанийн удирдлагууд, улс төрчид, нийтийн албаны томоохон албан тушаалтнууд, мужийн захирагчид, томоохон бизнес эрхлэгчдийг хамарсан тус улсын түүхэн дэх хамгийн том авлигын мөрдөн

⁶²¹ Орчуулсан: Л.Хангарьд. Эх сурвалж: https://www.financierworldwide.com/indepth-feature-corporate-fraud-corruption-2021?fbclid=IwAR1xv_R1dj5-GPw7PDISlhmfJJx1xNQsJe_CCy_uC3sbk36s0FoAgpv3U#.YH4qmJMzOS

шалгах ажиллагааг дууссанаас хойш Бразил улсад залилан, хахууль, авлигын түвшин мэдэгдэхүйц буурсан гэж үздэг. Энэхүү ажиллагаа болон холбооны цагдаагийн газрын бусад ажиллагаатай холбоотойгоор тус улс шинэ үе шатанд орж байна. Түүнчлэн, ЭЗХАХБ-ын зүгээс Бразил улсын авлигын асуудалд анхаарал хандуулсан мониторингийн байнгын бүлгийг байгуулжээ. Үүний зэрэгцээ цар тахлын улмаас нийтийн эрүүл мэндийн худалдан авалтын шаардлага нэмэгдэж байгаатай холбогдуулан залилан болон амьсгалын аппарат, цар тахалтай холбоотой эмчилгээ, хамгаалах хэрэгслийн үнэ хэт өндөр байгаа тухайд маш олон мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.”

ИХ БРИТАНИ

Корпорацийн судалгаа, шинжилгээний компани, олон улсын судалгааны байгууллага

“КОВИД-19 цар тахал нь дэлхий даяар залилан хийх боломжийг нэмэгдүүлж байна. Харамсалтай нь Их Британи улсад ч энэ байдал илэрч байгаа бөгөөд цар тахлын улмаас ердийн хамгаалалт, эрсдлийн удирдлагын хяналт алдагдаж, хүчгүйдэж байна. Сүүлийн нэг жилийн хугацаанд бүртгэгдсэн залилан, авлигын хэргийн тоо өсжээ. Залилангийн хэргээр мэргэшсэн судлаачдын холбооноос хийсэн судалгаагаар 2020 оны наймдугаар сарын байдлаар залилангийн чиглэлээр мэргэшсэн хүмүүсийн 77% нь залилангийн хэрэг нэмэгдэх хандлагатай байгаа гэж үзсэн байна. Магадгүй хамгийн их анхаарлын төвд байгаа асуудалд кибер луйвар багтаж байгаа бөгөөд ажилгүйдлийн залилан ч мөн өссөн байна.”

ИРЛАНД

Грант Торнтон, олон улсын аудитын фирм

“Эдийн засгийн гэмт хэрэг, залилан, корпорацийн гэмт хэрэг, цагаан захтнуудын гэмт хэрэг гэсэн ойлголтууд ижил утгатай хэрэглэгддэг. Ерөнхийдөө эдгээр нэр томъёо нь хууль бус үйл ажиллагаа гэсэн ангилалд багтдаг бөгөөд үүнд хөрөнгө завших, хахууль, авлига, корпорацийн болон хувийн залилан, мөнгө угаах зэрэг гэмт хэрэг багтдаг. Ирландын Мэргэшсэн нягтлан бодогчдын байгууллагын хийсэн 2019 оны эдийн засгийн гэмт хэргийн судалгааны үр дүнгээс харахад Ирландад бүртгэгдсэн эдийн засгийн гэмт хэрэг, залилангийн түвшин өссөн байна. Залилангийн гэмт хэрэгт хамаарах сэжиг бүхий зүйлийг мэдээлж байх шаардлагыг хуульд оруулсан нь үүний нэг шалтгаан болж байна гэж үзэж байгаа юм.”

ПОРТУГАЛ

Морайс Лейтон, Галвон Телис, Суарес да Силва Ассоциадос, олон улсын хуулийн фирм

“Сүүлийн жилүүдэд Португал улсын улс төр, нийтийн алба, спортын салбарыг хамарсан авлигатай холбоотой мөрдөн шалгах ажиллагаа, гэмт хэргийн шинжтэй хэргүүдийн тоо өсөж, энэ талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр ч байнга яригдах болсон байна. Энэ нь олон улсын худалдаа, хувийн хэвшилтэй холбоотой авлигын хэргүүдийн мөрдөн шалгах ажиллагааны ач холбогдлыг бууруулж байна. Гэвч КОВИД-19 цар тахал гэх мэт эдийн засгийн хямралын дараах үр дагаврын улмаас эрх баригчид найдвартай нотлох баримтгүй томоохон мөрдөн шалгах ажиллагаа явуулж, шүүх дээр шийдэгддэг хэргүүдийг урагшлуулахад нөлөөлж болох бөгөөд ингэснээр Португал улс авлигын хэрэгт хэтэрхий зөөлөн хандсан хэвээр байна гэсэн ойлголтыг төрүүлж байна.”

ОРОСЫН ХОЛБООНЫ УЛС

BDO, олон улсын аудитын фирм

“ОХУ-д корпорацийн залилан, хахууль, авлигын хэргийн түвшинд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй. Гэхдээ үүнтэй холбоотой эрсдэл бусад улстай харьцуулахад харьцангуй өндөр хэвээр байна.”

ЭНЭТХЭГ

BDO, олон улсын аудитын фирм

“Энэтхэг дэх корпорацийн залилан урт бөгөөд баялаг түүхтэй. Уламжлалын дагуу худалдан авалт, гуравдагч талтай холбоотой залилан анхаарлын төвд хэвээр байгаагаас гадна КОВИД-19 цар тахалтай холбоотойгоор кибер гэмт хэрэг 100 гаруй хувиар өссөн байна. Бизнесийн үйл

ажиллагаанд саад учруулж байгаа хамгийн гол зүйл нь залилан мэхлэгчдэд өртөж болзошгүй нөхцөл байдал юм.”

ХЯТАД, ХОНКОНГ

Алварез & Марсал, Маргаан, мөрдөн шалгалт, зөвлөх үйлчилгээний компани

“Компаниуд цар тахлын үр дагаврыг арилгахаар ажиллаж байгаа тул өмнө нь нуун дарагдуулсан залилан, хахууль, авлигын асуудлууд илэрч байгааг бид харж байна. Санхүүгийн тайлангийн улирал эхлэхэд энэ хандлага үргэлжлэх болно гэж найдаж байна. Эх газрын Хятад болон Хонконгийн эрх баригчид аль аль нь сүүлийн үед авлигатай тэмцэх талаар хатуу байр суурь баримталж, олон хахууль, авлигын хэргийг илчилсэн. Энэ байр сууриа хадгалж, цар тахлын улмаас үүсэж буй эрсдлийг хүлээн зөвшөөрснөөр ирэх хэдэн жилд хэргүүдийг нэмж илрүүлэх болно гэдгийг бид урьдчилан харж байна.”

САУДЫН АРАБ

BDO, олон улсын аудитын фирм

“Саудын Араб АЭНҮБК болон Их 20-ийн авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд гарын үсэг зурж нэгдэн, залилан болон авлигатай тэмцэх чиглэлээр олон арван арга хэмжээ авж хэрэгжүүлжээ. Тухайлбал, Авлигатай тэмцэх үндэсний хороо байгуулж, улсын сектор, 25 ба түүнээс дээш хувийн төрийн эзэмшил бүхий бүх компаниудын үйл ажиллагаанд хяналт тавих болсон. Тус Хороо нь улсын хаанд шууд тайлагнадаг хараат бус байгууллага юм. Түүнчлэн тус улс сүүлийн хэдэн жилд ТИ байгууллагын АТИ-ээ ахиулж, дэвшил гаргасаар байна.”

АРАБЫН НЭГДСЭН ЭМИРАТ

Корпорацийн судалгаа, шинжилгээний компани, олон улсын судалгааны байгууллага

“АНЭУ нь Ойрх Дорнод ба Хойд Африкийн бүс нутаг дахь авлига хамгийн бага улс хэвээр байна. Ийм учраас жил гаруйн өмнө НҮБ-ын Ерөнхий Ассемблей АНЭУ-д авлигын эсрэг бага хурлаа зохион байгуулсан байж болох юм. Энэхүү чуулганы төлөөлөгчид авлигын эсрэг тогтоолын төслийг боловсруулж, авлигын эсрэг НҮБ-ын Ерөнхий Ассемблейн удахгүй болох тусгай чуулганд бэлтгэх зорилгоор хөрөнгө буцаан олгох ажиллагаа, олон улсын хамтын ажиллагаа болон бусад асуудлыг хэлэлцсэн.”

ӨМНӨД АФРИК

Өмнөд Африк дахь KPMG компани, олон улсын аудитын фирм

“КОВИД-19 цар тахлын үр нөлөөгөөр бидний өнгөрсөн жилийн турш ажигласан залилан, авлигын чиг хандлагад тодорхой өөрчлөлт гарсан нь дамжиггүй юм. Засгийн газар, хувийн хэвшлийн компаниуд хувийн хамгаалалтын хэрэгсэл болон холбогдох үйлчилгээг худалдан авахад илүү их анхаарч, цар тахалтай тэмцэж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхэд бүх нийтийн анхаарлыг хандуулж байсан. Засгийн газар өнгөрсөн онд хувийн хамгаалалтын хэрэгсэл худалдан авахад олон тэрбум ранд зарцуулсан. Иймд компаниуд болон хувь хүмүүс уг үйл ажиллагаанд оролцож, тодорхой ашиг хүртэх сонирхол байгаа нь мэдээж юм. Одоогийн байдлаар Өмнөд Африк улсын хууль сахиулах байгууллагууд хувийн хамгаалалтын хэрэгслийн худалдан авах ажиллагаатай холбоотой луйвар залилангийн нэлээд олон мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна.”

Цагдаагийн байгууллага дахь авлигын асуудлыг мэдсэнээр донор байгууллага юу ойлгов⁶²²

2021.05.03. Гадаадын тусламжийг төлөвлөх асуудлыг хариуцдаг Төрийн департаментын Хууль сахиулах, олон улсын хар тамхитай тэмцэх газар (ХСОУХТТГ) нь дэлхийн хэмжээнд хууль ёсыг хэрэгжүүлэх салбарын шинэчлэлийн чухал оролцогч юм. Хууль сахиулах салбарын шинэчлэлд үүсч буй үндсэн саад тогторын эсрэг ХСОУХТТГ болон уг байгууллагын хамтрагчид авлигатай тэмцэх хөтөлбөрүүдийг боловсруулан, хэрэгжүүлж байна.

⁶²² Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://sites.tufts.edu/ihs/actionable-evidence-what-a-donor-learnt-about-addressing-police-corruption/>

Энэ ажлын хүрээнд ХСОУХТТГ-ын шинээр байгуулагдсан Мэдлэгийг удирдах хэлтэс нь эмпирик судалгаагаар шалгагдсан эрдэм шинжилгээний бүтээлүүд болон хөтөлбөрийн үнэлгээний тайлан гэх мэт “арилжааны бус материал”-д тулгаарлан цагдаагийн байгууллага дахь авлигатай тэмцэх үр нөлөөтэй арга хандлагын чиглэлээр нотолгоонд тулгуурласан мэдээллийг цуглуулсан байна.

Уг хэлтсийн цуглуулсан мэдээлэл нь доноруудын хэрэгжүүлж буй хөтөлбүүдэд хэрэгцээтэй гэж үзэж байсан асуудлаас гадна эрдэмтэн, судлаачдын ажил хэрхэн хууль сахиулах салбарын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нарт илүү үр дүнтэй байхыг ойлгуулан, цаашдын судалгааны зарим чиглэлийг тодорхойлжээ.

ХСОУХТТГ-ын Мэдлэгийг удирдах хэлтсийн олж илрүүлсэн зүйлсийн хамгийн сонирхолтой, хэрэгцээтэй гэж үзсэн асуудлууд болон цаашид тус байгууллагад ач холбогдолтой байж болох судалгааны чиглэл, арга зүйн талаар уг хэлтсийн гишүүн Шулер Миллертэй хийсэн ярилцлагыг та бүхэнд хүргэе.

1. ХСОУХТТГ-ын Мэдлэгийг удирдах хэлтсийн талаар болон цагдаагийн байгууллага дахь авлигатай тэмцэх асуудлаар ярина уу?

Миний ажилладаг Төрийн департаментын ХСОУХТТГ нь хилийн чанад дахь тогтворгүй байдал, гэмт хэрэг, хууль бус хар тамхины наймаатай тэмцэхэд дипломат харилцаа, гадаадын тусламжийг ашигладаг. ХСОУХТТГ нь 2019 онд Мэдлэгийг удирдах хэлтсийг байгуулж, өөрийн хэрэгжүүлж буй хөтөлбөрүүд болон дипломат харилцааг ойлгуулах болон эдгээрийн үр дүнг дээшлүүлэхэд бидний хүчин чармайлтыг чиглүүлсэн.

Манай хэлтэс ХСОУХТТГ-ын удирдлагыг илүү үр ашигтай бөгөөд үр нөлөөтэй хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгосон. Эдгээр бүтээгдэхүүний нэг бол өргөн хүрээнд тархсан авлигын чухал хоёр төрөл болох хахууль авах болон айлган сүрдүүлж хахууль авах асуудалтай цагдаагийн байгууллага хэрхэн тэмцсэн талаарх нотолгоонд суурилсан үнэлгээ, шинжилгээ юм.

Энэхүү бүтээгдэхүүнийг боловсруулахын тулд манай баг хөтөлбөрийн үнэлгээнээс эхлэн санамсаргүй түүврийн аргын туршилтын хяналт хийх хүртэлх бүх материалд дүн шинжилгээ, үнэлгээ хийсэн. Бид 7 мэдээллийн сан, вэб сайтууд, мэргэжилтнүүдийн зөвлөмж зэрэгт түлхүүр үгээр хайж, тус асуудалтай холбоотой 200 гаруй материалыг олж авж судалсан. Улмаар манай баг эдгээр материалыг шалгуур үзүүлэлтээр системтэйгээр шалгаснаар аргачлалын стандарт, судалж буй асуудалд хамаарах 49 нийтлэлийг гаргаж ирсэн. Бидний цуглуулсан нотолгооны материалуудыг эндээс⁶²³ олж болно.

2. Шинжилгээ, үнэлгээний үр дүнгээс хамгийн ихээр гайхшируулсан зүйл юу байв? Хамгийн хэрэгцээтэй нь юу байв?

ГАЙХШИРУУЛСАН ЗҮЙЛ: Цагдаагийн албан хаагчдын цалинг нэмэх нь авлигыг нэмэгдүүлдэг.

Цалин бага байх нь жижиг хахуулийн шалтгаан болдог гэсэн өргөн тархсан ойлголт байдаг. Бодит байдал дээр Гүрж, Македон улсын баримтаас үзэхэд иж бүрэн шинэчлэлийн хүрээнд цалин нэмэх нь цагдаагийн байгууллагын авлигыг бууруулсан. Гэвч бидний хийсэн шинжилгээ, үнэлгээнээс ийм дүгнэлт гаргах амаргүй байсан. Цагдаагийн албан хаагчдын зөвхөн цалинг нэмэх нь авлигыг бууруулдаггүй. Үнэн хэрэгтээ цалин нэмэх нь авлигыг нэмэгдүүлсэн. Тухайлбал, Гана улсад цагдаагийн албан хаагчдын цалинг 2010 онд 2 дахин нэмэгдүүлэхэд цагдаагийн албан хаагчийн нэг газраас авах хахуулийн хэмжээ 25%-28%-аар буюу 25 центээр нэмэгдсэн судалгааны дүн байна. Энэ нь хэдийгээр давтамж нь буурсан ч цагдаагийн албан хаагчдад бүхэлд нь өгдөг хахуулийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.

ГАЙХШИРУУЛСАН ЗҮЙЛ: Авлигын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх ажил буруугаар эргэж болзошгүй

Олон улсын байгууллагууд авлигын талаарх олон нийтийн ойлголтыг дээшлүүлэхэд анхаардаг ч авлигын талаарх нэмэлт мэдээлэл нь иргэдийн хахууль өгөх хүслийг нэмэгдүүлдэг талаар бид олж мэдээд гайхсан. Тухайлбал, цагдаагийн албан хаагчдын авлигын талаарх статистик мэдээлэлтэй гарын авлагыг уншсаны дараа Коста Рикад цагдаагийн албан хаагчид хахууль өгөх

⁶²³ <https://sites.tufts.edu/ihs/files/2021/04/Police-Corruption-Bibliography.pdf>

иргэдийн хүсэл 28%-аар нэмэгдсэн судалгааны дүн гарсан. Авлигын талаарх статистик мэдээллийг олон нийтэд түгээхдээ авлигын чиглэлээр ажиллагчид боломжит эрсдлийг тооцох ёстойг анхаарах, авлигын эсрэг нэмэлт мэдээллийг бодолцох хэрэгтэй юм.

ХЭРЭГТЭЙ СУРГАМЖ: Цагдаагийн байгууллагын хариуцлагын механизм

Цагдаагийн байгууллагын гадаад болон дотоод хариуцлагыг дэмждэг хэд хэдэн тодорхой механизмыг манай судалгаа тогтоосон. Шагнал өгөх, эсхүл үр дагаврыг харгалзсан шинэчлэлийг цагдаагийн байгууллагын удирдлагад хэрэгжүүлснээр цагдаагийн байгууллагын үйл ажиллагаа сайжирсныг Энэтхэгийн Ражастан дахь цагдаагийн байгууллагад хийсэн шинэчлэлийн талаарх тоон судалгаагаар тогтоосон. Тухайлбал, үр дүн, гүйцэтгэлд тулгуурлан албан тушаал ахиулах шагналын хэлбэр байж болно. Дэс дараатай “хэвтээ шинэчлэл”-ийн бодлогын үр дүнд Колумбын Богота дахь цагдаагийн байгууллагын хариуцлагатай байдал нэмэгдсэн талаар чанарын судалгаа байна. Энэхүү шинэчлэл нь эхлээд цагдааг ойлгох, татан оролцуулах талаарх иргэдийн чадавхыг дээшлүүлэх (цагдаагийн байгууллагын талаарх статистик мэдээлэл, бусад мэдээлэл ашиглан), улмаар цагдаагийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг боловсруулан мөрдүүлсэн байна. Энэхүү хандлага нь цаашид шинэчлэлийг үргэлжлүүлэх урам зоригийг нэмэгдүүлсэн юм.

3. Судалгааны үр дүнг донор байгууллагуудад илүү ач холбогдолтой болгохын тулд судлаачид юу хийх ёстой вэ?

Судлаачид судалгааны үр дүнг донор байгууллагуудад ач холбогдолтой болгохын тулд дараах асуултад хариулт өгөх ёстой: Өөрчлөлт хийхийн тулд бид ямар үйл ажиллагааг дэмжих ёстой вэ? Ямар арга хэмжээ үр дүнд хүрч байгаа, ямар арга хэмжээ үр дүнгүй байна гэдгийг ойлгох нь хангалтгүй бөгөөд донор байгууллагууд хэрхэн, яаж, яагаад, хэзээ тухайн арга хандлагыг ашиглах вэ гэдгийг мэдэхийг хүсэж байгаа.

Тус судалгааны явцад чухал гэж үзсэн дараах хоёр чиглэлийг тодорхойлсон:

Тусгай арга хэмжээний үр дүнд бий болсон өөрчлөлтийг хэмжих: Тодорхой арга хэмжээ авж хэрэгжүүлсний дараа авлигын талаарх цагдаа, эсхүл иргэдийн үзэл хандлагын өөрчлөлтийг хэмжих оролдлого хийсэн судалгаанууд ихээхэн ач холбогдолтой байсан. Учир нь, ийм судалгаа нь ХСОУХТГГ-ын хөтөлбөрүүдийн хүчин чармайлттай холбоотой бодит өөрчлөлтийг тодорхойлно. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлд орсон өөрчлөлтийг нээлттэй мэдээлэл, эсхүл бүтээлч хэрэгслүүдийг ашиглан хэмжиж болно. Тухайлбал, ёс зүйн стандартад нийцэх мэдээллийг нууцаар цуглуулж болно. Гана улсын⁶²⁴ цагдаагийн албан хаагчдын цалингийн тухай судалгаанд замын цагдаад төлсөн хахуулийн талаарх иргэдийн мэдээллийг ашигласан. Энэтхэгийн цагдаагийн байгууллагын⁶²⁵ шинэчлэлийн судалгааг хийхдээ цагдаагийн хэргийг шалгах ажиллагаанд цагдаагийн албан хаагчид өөрсдөө иргэн мэтээр оролцож мэдээлэл цуглуулсан байна.

Шалтгаан, үр дагаврын харилцааг судлах, шалгах: Бидний танилцсан хэд хэдэн нийтлэлд цагдаагийн байгууллагын авлигатай холбогдуулан авсан арга хэмжээ болон бий болсон өөрчлөлт хоёрын хоорондох шалтгаан, үр дагаврыг судлах, ойлгох, нягтлах оролдлого хийгээгүй байна. Бид шалтгаан үр дагаврын харилцааг туршиж, судлахдаа бусад хүчин зүйлсийг авж үзсэн ба зарим тохиолдолд өөрчлөлтийг хэрхэн, яаж, яагаад хийсэн талаар тайлбарлаж болох байсан. Энэ бүхэн нь авсан арга хэмжээ болон түүний үр дүнгийн үзүүлэлтүүдийн гол онцлогуудын хоорондын харилцан хамаарлын талаар судлаачид дүгнэлт гаргахад ач холбогдолтой байдаг. Донор байгууллагууд зорилтот үйл ажиллагаанд анхаарал хандуулан, төслүүдийг санхүүжүүлдэг тул эдгээр тусгай үзүүлэлтүүд ихээхэн ач холбогдолтой юм.

4. Цагдаагийн байгууллагын авлигын асуудлаар тодорхой судлагдаагүй үлдсэн асуудал байсан уу?

Манай төслийн явцад цагдаагийн байгууллагын авлигыг бууруулахад шаардлагатай 3 асуудлаар нэмэлт нотолгоо шаардлагатай гэж үзсэн:

⁶²⁴ <https://www.theigc.org/publication/do-higher-salaries-lower-petty-corruption-a-policy-experiment-on-west-african-highways/>

⁶²⁵ <https://www.nber.org/papers/w17912>

- *Цагдаагийн сургалт*: мэдлэг, ур чадвар, авлигад хандах хандлагыг дээшлүүлэх чиглэлээр цагдаагийн байгууллагын албан хаагчдыг сургах үйл ажиллагааг донор байгууллагууд ихээр дэмждэг ч энэ талаарх судалгаа маш бага байна. Тус салбарт ямар арга хандлага илүү зохимжтой талаар донор байгууллагуудын хөрөнгө оруулалтаар нэмэлт судалгаа явуулах хэрэгтэй байна.
- *Дотоод хяналтын шинэчлэл хийх*: Цагдаагийн байгууллагын авлигыг бууруулах стандарт хэрэгсэл буюу дотоод хяналт шалгалт зэргийг ашиглан хахууль авах, айлган сүрдүүлж хахууль авах хэргийг бууруулах тухайд цөөн хэдэн судалгаанд хөндсөн байна. Энэ чиглэлээр бидний хийсэн судалгаа ирээдүйтэй санагдсан ч илүү их судлах шаардлага байна.
- *Нийгмийн хэм хэмжээг програмчлах*: Нийгмийн хэм хэмжээ авлигач зан байдалд нөлөөлдөг болохыг бидний олж авсан нотолгоо баталж байна. Гэвч цагдаагийн байгууллага, эсхүл иргэдийн нийгмийн хэм хэмжээг өөрчлөх арга хэмжээний үр нөлөөт байдлыг нэмж судлах хэрэгтэй байна.

Судалгаа: Аж ахуйн нэгжүүд ил тод байдал, авлигын эрсдлийн асуудлаар илүү ихийг хэрэгжүүлэх хэрэгтэй⁶²⁶

2021.05.21. Matthew Stephenson. Ирландын аж ахуйн нэгжүүд авлигатай холбоотой эрсдлийг даван туулахын тулд илүү ихийг хэрэгжүүлэх хэрэгтэй байгааг шинэ судалгаа харуулав. Уг судалгаагаар энэ төрлийн эрсдэл учрахад цөөн хэдхэн л аж ахуйн нэгж бэлтгэлтэй байгаа нь тогтоогдсон байна.

ТИ Ирланд байгууллага тус улсад үйл ажиллагаа эрхэлдэг, тэргүүлэгч 30 компанийн ил тод байдлын туршлагад үнэлгээ хийж Үндэсний шударга байдлын индексийг гаргаад байгаа юм.

The Irish Times сониноос гаргадаг шилдэг 1,000 компанийн жагсаалтад багтсан аж ахуйн нэгжүүдээс сонгосон түүврийн дагуу судалгааг хийж, индексийг тооцсон. Уг үзүүлэлт нь хувийн компаниудын олон нийтэд ил болгож буй мэдээлэлд үндэслэн эрсдлийг арилгахад хэр зэрэг бэлэн байгааг илтгэж буй үзүүлэлт юм.

Хэдийгээр ихэнх компаниуд авлигатай тэмцэх болон шүгэл үлээгчийн бодлогоо ил тод болгож байгаа ч, судалгааны үр дүнгээр компанийн бүтэц, улс төрч болон нийтийн албан тушаалтнуудтай харилцах харилцааны талаар харьцангуй бага мэдээлэл гаргадаг, санхүүгийн талаарх илүү их мэдээллийг ил болгох боломжтой байна.

AIB компани 68%-тай тэргүүлсэн бөгөөд нэг ч компани 70-аас дээш хувь аваагүй нь судалгаанд хамрагдсан компаниуд бүгд ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлигатай холбоотой эрсдлийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай байгааг харуулж байна.

DCC компани 68%-тай 2 дугаар байрт жагссан бол 62%-тай Ирландын банк, Ирланд лайф, Керри, Трэйн технологи, Туллов ойл гэсэн таван компани 3 дугаар байр эзэлсэн байна.

“Авлига дэлхийн хамгийн том бэрхшээлүүдийг шийдэхэд саад болдог. Тухайлбал, уур амьсгалын өөрчлөлт, сүүлийн үеийн цар тахалтай тэмцэхэд саад болж байна. Хэдийгээр авлигын эсрэг шинэ хууль, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа ч Ирландын компаниуд сонирхлын зөрчлийг илрүүлэх, шүгэл үлээгчийг хамгаалж чадахгүйгээс үүдэлтэй авлигын эрсдэлтэй тулгарч байна” хэмээн ТИ Ирланд байгууллагын судалгааны зохицуулагч Кэтрин Лаулор (Catherine Lawlor) онцолсон юм.

“Судалгаагаар Ирландын компаниудын удирдах албан тушаалтнуудын багагүй хувь нь бизнесээ хадгалж үлдэх, эсхүл бизнесээ амжилттай явуулахын тулд хууль бус, ёс зүйгүй үйлдэл хийхэд бэлэн байгааг тогтоосон. Иймд Ирландын компаниуд дотоод хяналтыг нэвтрүүлэх, амжилтнуудынхаа ёс зүйгүй хандлагыг хянах, энэ талаар мэдээлэл цуглуулах, эдгээр эрсдлийг бууруулах амлалтынхаа талаар илүү ихийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна” гэж тэрээр нэмж хэлсэн юм.

⁶²⁶ Орчуулсан: Ц.Бадам. Эх сурвалж: <https://www.irishtimes.com/business/businesses-need-to-do-more-on-transparency-and-corruption-risks-study-1.4570358>

ТИ Ирланд байгууллагаас онлайнгаар ил тод болгох бодлогоо өргөжүүлэх, байгууллагын бүтэц, санхүүгийн талаарх мэдээллийн ил тод байдлын түвшнийг нэмэгдүүлэхийг компаниудад уриалсан зөвлөмжүүдийг гаргасан юм.

Мөн хүмүүнлэгийн хандив, олон нийтэд зориулсан сайн дурын үйл ажиллагааны талаарх мэдээллийг ил болгох, шүгэл үлээгчийн бодлогоо дахин үнэлэх болон улс төрийн үйл ажиллагаанд оролцох журмаа ил тод болгохыг тус байгууллагаас уриалсан байна. Үүнээс гадна тус байгууллагаас шүгэл үлээгчийн мэдээг хүлээн авсан болон хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний талаарх мэдээллийг ил тод болгохыг уриалжээ.

Олон улсын авлигын талаарх статистик мэдээллийн үнэн зөв байдал хэр баталгаатай вэ?⁶²⁷

2021.05.06. Matthew Stephenson. Авлигатай тэмцэх салбарт ажилладаг хүмүүс авлигын хэмжээ, олон улсын түвшин дэх нөлөөллийг харуулсан глобал тоон мэдээний ойлголттой байдаг. Тэр ч утгаараа авлигын холбогдолтой асуудлын талаарх тайлан, мэдээ, албан тушаалтны ярилцлагын эхлэлийн үг хэлбэрээр тогтмол хэрэглэгддэг билээ. Жишээлбэл, жил бүр 1 их наяд ам.доллар авлигын улмаас алдагдаж байна, авлига нь дэлхийн эдийн засагт 2.6 их наяд ам.доллар (дэлхийн ДНБ-ий 5%), жил бүр төрийн байгууллагын худалдан авах ажиллагааны 10%-25% авлигын үйл ажиллагаанд алдагддаг зэрэг болно. Тэгвэл эдгээр тоон мэдээ нь хэр үнэн зөв бэ? Энэ талаар бид өмнө блогт хэлэлцэж байсан билээ.

Хэдэн жилийн өмнө миний бие энэхүү 1 их наяд ам.доллар болон 2.6 их наяд ам.долларын талаарх мэдээллийн баталгаат байдалд эргэлзэж байсан талаар нийтлэл байршуулж байсан, үүнийг дагаад Global Anticorruption Blog-ийн ахлах мэдээ нийтлэгч Рик Мессик болон зочин нийтлэгч Маяа Форстатер нараас хэд хэдэн шүүмжлэл хэлсэн юм.

Өнгөрсөн жил, миний бие U4 авлигын эсрэг эх сурвалжийн төвийн Сесиле Ватне (ахлах зөвлөх асан)-тай хамтран “Авлигын статистик мэдээллийн үнэн зөв чанар: Олон улсын 10 статистик мэдээг дүгнэх нь” нэртэй судалгааны ажил хийсэн юм. Судалгааны хүрээнд бид олон улсын түвшинд хамгийн өргөн хэрэглэгддэг авлигын тоон мэдээний үнэн зөв чанарыг дүгнэж, тус мэдээллийн эх үүсвэрийг олж тогтоон, баталгаат байдлыг тодорхойлсон юм. Бид судалгааны хүрээнд статистик мэдээний баталгаат чанарыг баталгаатай, асуудалтай, баталгаатай гурван төрөлд ангилан ялгасан болно.

Харамсалтай нь, бидний судалсан хамгийн өргөн хэрэглэгддэг 10 статистик тоон мэдээнд баталгаатай ангилалд орох мэдээлэл байгаагүй юм. (Ердөө хоёр тоон мэдээ энэ ангилалд хамаарахад ойрхон байсан) 6 статистик мэдээ асуудалтай, харин үлдсэн 4 тоон мэдээ бүхэлдээ ямар ч үндэслэлгүй байсан. Энэхүү судалгааг сонирхсон иргэд, судлаачид эх тайлантай танилцах боломжтой бөгөөд судалгааны хураангуй дүгнэлтийг та бүхэнд танилцуулж байна.

Судалгааны хүрээнд дараах дүгнэлтийг хийв.

1. Статистик: Дэлхийн хэмжээнд жил бүр авлигын улмаас 1 их наяд ам.доллар хохирол учирдаг

Үнэлгээ: Асуудалтай

Дүгнэлт: 2000 оны эхэн үеийн зарим тоон баримтууд авлигын үйл ажиллагаанд жил бүр 600 тэрбумаас 1.76 их наяд ам.доллар алдагддаг талаар олж тогтоосон нь энэхүү тоон мэдээлэлтэй хамгийн ойролцоо тоон мэдээлэл юм. Гэвч энэхүү тоон мэдээллээс жил бүр 1 их.наяд ам.доллар алдагддаг гэх тооцоолол хийх нь тийм ч оновчтой биш юм. Хамгийн сүүлд энэхүү тоон мэдээг шинэчлэх зорилгоор тооцоолол хийсний үндсэнд 1.5-аас 2 их наяд ам.доллар төлөгддөг талаар бичсэн байна. Гэвч ийнхүү шинэчлэхдээ тооцооллын ямар арга ашигласан нь тодорхойгүй болно.

2. Статистик: Жил бүр төсвийн хөрөнгийн 2.6 их наяд ам.доллар авлигын улмаас шамшигддаг

Үнэлгээ: Асуудалтай

Дүгнэлт: Олон улсын хэмжээнд ямар нэгэн байгууллага болон судлаач төсвийн хөрөнгөөс 2.6 их наяд ам.доллар жил бүр шамшигддаг талаар судалгаа, тоон мэдээлэл боловсруулаагүй болно.

⁶²⁷ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/05/06/how-reliable-are-global-quantitative-corruption-statistics-a-new-u4-report-suggests-the-need-for-caution/>

Ойрын хугацаанд энэхүү тоон мэдээ хурал, тайланд хэрэглэгдэж эхэлсэн нь 2018 оны НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргын хэлсэн үгийг буруугаар тайлбарласан шалтгаантай юм.

3. Статистик: Авлига дэлхийн эдийн засагт 2.6 их наяд ам.доллар буюу ДНБ-ий 5%-тай тэнцэх хохирол учруулдаг

Үнэлгээ: Батлагдаагүй

Дүгнэлт: Энэхүү тоон мэдээ нь ямар нэгэн эх сурвалж, судалгаанд тулгуурлаагүй бөгөөд өөр сэдэвт асуудлын хүрээнд боловсруулсан судалгааг буруугаар тайлбарлаж ашигласан байж болзошгүй. Иймд ямарваа байгууллага, эсхүл зөвлөх энэхүү тоон мэдээг ямар ч нөхцөл байдалд дурдах, ашиглахад тохиромжгүй юм.

4. Статистик: Авлига, татвараас зайлсхийх, хууль бус санхүүгийн урсгал нь хөгжиж буй улс орнуудад 1.26 их наяд ам.долларын хохирол жил бүр учруулдаг

Үнэлгээ: Асуудалтай

Дүгнэлт: Энэхүү тоон мэдээ нь Глобал санхүүгийн шударга байдлын байгууллага (Global Financial Integrity)-аас хөгжиж буй улс орнуудын хууль бус хөрөнгийн урсгалын талаар 2008 онд боловсруулсан судалгаанд тулгуурлажээ. Гэвч энэ тоон мэдээ зөвхөн хууль бус санхүүгийн урсгалд хамаарах мэдээлэл бөгөөд авлига болон татвараас зайлсхийх үйлдэлд хамаарахгүй юм. Түүнчлэн, энэхүү тоон мэдээ нь тухайн цаг үе дэх нөхцөл байдлаас маш ихээр нэмэгдэж тооцоологдсон байгаа юм. Хэрэв аливаа байгууллагаас Глобал санхүүгийн шударга байдлын байгууллагын мэдээллийг ашиглаж илүү нарийвчилсан тоон мэдээлэл боловсруулсан тохиолдолд хөгжиж буй орнууд хууль бус санхүүгийн урсгал, авлига болон бусад хууль бус үйл ажиллагаанаас шалтгаалан жил бүр 660 тэрбум ам.долларын хохирол хүлээдэг болох нь харагдах юм.

5. Статистик: Жил бүр төрийн байгууллагын худалдан авах ажиллагааны зардлын 10%-25% авлигын улмаас алдагддаг

Үнэлгээ: Асуудалтай

Дүгнэлт: Хэдийгээр энэхүү тоон мэдээ үнэмшилтэй харагдаж байгаа боловч холбогдолгүй тоон мэдээг субъектив байдлаар тайлбарлаж боловсруулсан статистик юм. Олон улсын хөгжлийн албан хаагчид 2000 оны эхээр төрийн худалдан авах ажиллагааны зардлын 10%-15% авлигын үйл ажиллагаанд алдагддаг талаар таамаглаж байсан гэдгийг дурдах шаардлагатай.

6. Статистик: Төсвийн хөрөнгөөс санхүүжилт авсан дэд бүтцийн үйл ажиллагаанд жил бүр авлигын улмаас 10%-30%-ийн хохирол учирдаг

Үнэлгээ: Баталгаагүй

Дүгнэлт: Энэ тоон мэдээг нэр хүнд бүхий олон байгууллага дурдаж байсан боловч эх сурвалжийн талаар дурдаж байгаагүй. Хэдийгээр бид боломжтой хэд хэдэн эх сурвалжийг тодорхойлсон боловч энэхүү статистик мэдээллийг баталгаажуулах мэдээ оллоогүй болно.

7. Статистик: Усны салбарт зарцуулсан хөрөнгийн 20%-40% жил бүр авлигын улмаас алдагддаг

Үнэлгээ: Баталгаагүй

Дүгнэлт: Хэдийгээр ус болон ариутгалын салбарт авлигын үйл ажиллагаанд алдагдаж буй хөрөнгийн хэмжээ энэ хүрээнд байх боломжтой боловч энэ сэдвээр хийсэн судалгаа байхгүй бөгөөд бусад холбогдох сэдвийн хүрээнд хийсэн судалгааны үр дүнгээс тааварлаж тооцоолсон үнэлгээ юм.

8. Статистик: Хөгжлийн хүрээнд олгосон тусламжийн 30 хүртэлх хувь нь жил бүр авлига болон залилангийн улмаас алдагддаг

Үнэлгээ: Асуудалтай

Дүгнэлт: Бид энэ мэдээллийн баталгаат эх сурвалжийг олж тогтоож чадаагүй. Гэвч энэхүү тоон мэдээлэлтэй хамгийн ойролцоо мэдээлэл нь НҮБ-ын Глобал Сангийн аудит хийсэн үр дүн юм. Аудитын үнэлгээг хөгжлийн хөтөлбөрийн тусламжийн 30 хүртэлх хувь нь авлигын үйл ажиллагаанд алдагддаг хэмээн тайлбарлах нь зохимжгүй юм. НҮБ-ын Глобал Сангийн

санхүүжилтээр бие даасан аудитын ажиллагаа хийсэн бөгөөд ДОХ, сүрьеэ болон хумхаа өвчинтэй тэмцэх сангийн 30%-67% хувь нь ихэнх тохиолдолд авлигаас шалтгаалан зориулалтын бусаар зарцуулагдсан байсан.

9. Статистик: Гаалийн үйл ажиллагаатай холбогдох авлига нь Дэлхийн Гаалийн байгууллагын гишүүн орнуудад жил бүр 2 тэрбум ам.доллараас багагүй хохирол учруулдаг

Үнэлгээ: Асуудалтай

Дүгнэлт: Хэдийгээр энэхүү судалгааг академик түвшинд боловсруулсан боловч тоон мэдээг тооцсон аргачлалыг тодорхой дурдаагүй бөгөөд үнэлгээний хувьд асуудалтай байж болзошгүй юм. Тус тоон мэдээллийг дурдаж буй байгууллагаас энэхүү статистикийн тодорхойгүй байдлыг хүлээн зөвшөөрч, Дэлхийн худалдааны байгууллага болон ЭЗХАХБ зэрэг олон улсын байгууллагыг эх сурвалжаар дурдахгүй байх шаардлагатай.

10.Статистик: Дэлхийн хэмжээнд 5-аас доош насны хүүхдийн нас баралтын 1.6% (жил бүр 140 мянга гаруй нас баралт) нь авлигын үйл ажиллагаанаас тодорхой хэмжээнд хамааралтай

Үнэлгээ: Асуудалтай

Дүгнэлт: Энэхүү статистик мэдээлэл хэтэрхий тодорхой байдалтай байгаа нь үнэлэмжийг баталгаатай бус, асуудалтай хэмээн үнэлэх нөхцөл болсон. Хэрэв “Авлигын үйл ажиллагаа нь бага насны хүүхдийн нас баралтын хувийг нэмэгдүүлдэг нь судалгаанаас батлагдав” гэх агуулгатай байсан тохиолдолд энэхүү мэдээг баталгаатай хэмээн үнэлэх байв.

Энэхүү судалгааны хүрээнд авлигын үйл ажиллагаанд холбогдох статистик тоон мэдээллийг олон нийтэд түгээх тайлан болон мэдэгдэлд хэрэглэх тохиолдолд баримтлах шаардлагатай 5 зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

1. Тоон мэдээллийн эх сурвалжийг үргэлж шалгаж байх

Олон нийтэд түгээх баримт бичиг, эсхүл мэдэгдэлд статистик тоон мэдээлэл дурдахаас өмнө тус мэдээллийн эх сурвалжийг заавал шалгах шаардлагатай. Зарим тохиолдолд эх сурвалжийг “А” баримт бичгээс, “А” баримт бичиг нь “Б” баримт бичгээс зэрэг байдлаар дурдсан тохиолдол байдаг. Иймээс үндсэн эх сурвалжийг ашиглаж тоон мэдээллийг дурдах нь зүйтэй бөгөөд дундын эх сурвалжийг ашиглах нь тохиромжгүй юм. Дундын эх сурвалж нь тоон мэдээг оновчгүй дурдсан байж болзошгүй. Хэрэв эх сурвалжийг тодорхойлох боломжгүй бол тус мэдээллийг дурдах нь зохимжгүй. Түүнчлэн, эх сурвалж нь “судалгаанаас харахад...” хэмээн тоон мэдээг онцолж, тодорхой судалгааг дурдаагүй тохиолдолд мөн тус мэдээллийг дурдах нь оновчгүй. Жишээлбэл, эх сурвалж нь “Дэлхийн банкны судалгааны дагуу” гэсэн боловч тус байгууллагын тодорхой баримт бичгийг дурдаагүй бол энэхүү тоон мэдээг ашиглах нь зохимжгүй болно.

2. Эх сурвалжийг анхааралтай унших

Мэргэжлийн бус хүн эх сурвалжийг академик судлаач адил шалгах шаардлагагүй. Авлига зэрэг далд үйл ажиллагааг үнэлж дүгнэх хүндрэлтэй байдлыг харгалзан үзэж, судалгааны аргачлалыг олон нийтэд нээлттэй шүүмжилж, дүгнэж байх шаардлагатай юм. Гэвч зарим тохиолдолд олон нийтэд нээлттэй мэдээллийг эх сурвалжаар ашиглаагүй байдаг нь энэхүү ажиллагаанд хүндрэл учруулдаг. Иймээс аливаа байгууллага, эсхүл түүний ажилтан статистик тоон мэдээллийг дурдахаас өмнө тус байгууллагын өөр холбогдох албан хаагч энэхүү мэдээг сайтар уншиж танилцан, тоон мэдээ нь ойлгомжтой, учир холбогдолтой байгааг нягтлах шаардлагатай. Хамгийн багадаа, тус тоон мэдээг судалгааны хүрээнд олж мэдсэн бөгөөд субъектив байдлаар таасан мэдээ биш гэдгийг батлах хэрэгтэй юм. Түүнчлэн, судалгааны зүйлийг нарийвчлан харах шаардлагатай, жишээлбэл, авлигын үйл ажиллагааны улмаас дэлхийн эдийн засагт учирч буй хохирлыг тодорхойлоход мөнгө угаах үйл ажиллагааны улмаас учирч буй хохирлын хэмжээг ашигласан байж болохгүй. Нарийвчилсан академик судалгаа шаардлагагүй боловч заавал хийх шаардлагатай үндсэн судалгааг хийх нь оновчтой юм.

3. Зохиогчийн байгууллагын хамаарлыг тус байгууллагын албан ёсны судалгааны ололттой бүү хутга

Судалгааны тайланг олон улсад нэр хүндтэй байгууллага боловсруулсан тохиолдолд түүний баталгаат чанар зохиомлоор нэмэгддэг, жишээлбэл, ДБ, ОУВС зэрэг байгууллагын судалгаанд иргэд, судлаачид итгэх итгэл өндөр байдаг. Гэвч бодит байдалд тус судалгааг тухайн

байгууллагын гэрээт ажилтан, эсхүл зөвлөх байгууллага гүйцэтгэсэн байдаг. Иймээс тус байгууллагын судалгааны тайланд байгаа тоон мэдээг дурдах тохиолдолд “Дэлхийн банкны олж тогтоосноор” бус харин “Дэлхийн банкны судалгааны тайланд дурдсанаар” хэмээн дурдаж байх нь зүйтэй юм.

4. Тодорхой байдал, нарийвчлал, ерөнхий байдлыг хэтрүүлж болохгүй

Хялбаршуулах нь зөвлөх болон бодлого боловсруулах ажиллагаанд шаардлагатай байдаг боловч хэт хялбаршуулах нь асуудал дагуулдаг. Ихэнх тохиолдолд авлигын талаарх статистик нь тодорхой цаг хугацаа, байршил, салбарыг заасан байдаг. Түүнчлэн, эх сурвалж нь судалгааны тодорхойгүй байдлыг хүлээн зөвшөөрсөн байдаг (эсхүл тодорхойгүй байдлыг хүлээн зөвшөөрөөгүй боловч ойлгомжтой байдаг). Статистик тоон мэдээ судалгаанаас судалгаанд дамжин дурдагдах явцад энэхүү тодорхойгүй байдал нь гээгдэж, үл ойлголцол үүсгэдэг байна. Энэхүү үл ойлголцлыг судалгааны тодорхойгүй байдлыг хүлээн зөвшөөрч, судалгаанд дурдсанаар зайлсхийх боломжтой. Ингэснээр авлигын холбогдолтой цөөн тооны үнэн зөв статистик тоон мэдээлэл олон улсын түвшинд ашиглагдах юм. Бид авлигын хор уршгаас хамааран дэд бүтцийн салбарт жилд учирч буй хохирлыг нарийвчлан хэлэх боломжгүй, гэвч тодорхой улс болон хөтөлбөрийн хүрээнд авлигын үйл ажиллагаанд алдагдсан хохирлыг тооцоолох боломжтой юм. Ийнхүү тодорхой жишээнд тулгуурлан боловсруулсан тоон мэдээлэл нь авлигын хор хөнөөлийг таниулахад хангалттай баримт мэдээ болно.

5. “Сүржигнэсэн” статистикээс зайлсхийж, чухал үр дагаврыг харуулсан нотлох баримтад анхаарал хандуулах

Энэ нь бидний зүгээс хүргэж буй хамгийн ерөнхий бөгөөд шүүмжлэл дагуулах зөвлөмж юм. Олон улсын байгууллага, донор агентлаг, иргэний нийгмийн бүлэг болон бусад холбогдох байгууллагыг зуршил болсон “сүржигнэсэн” статистикээс зайлсхийхийг зөвлөж байна. Тайлан болон мэдэгдэлд их хэмжээний тоон мэдээ, хувь дурдахын оронд нөлөө бүхий эдгээр байгууллага нь авлига болон бусад холбогдох зүйлийн холбоо хамаарлыг харуулсан эмпирик нотолгоонд илүү анхаарал хандуулах шаардлагатай. Авлигын хор хөнөөлийг нарийвчлан тогтоох бус, жишээлбэл, дэлхийн эдийн засагт жил бүр учруулж буй хохирол (туйлын тодорхой, эсхүл хувиар илэрхийлсэн дүн гаргах)-ыг тооцоолох бус, харин эдийн засагт их хэмжээний хохирол учруулж, нэг хүнд ноогдох ДНБ-ийг бууруулдаг, эрх тэгш байдлыг доройтуулдаг, макро эдийн засагт сөргөөр нөлөөлдөг талаар тодорхой мэдэгдэж байх шаардлагатай. Бид авлигын үйл ажиллагааны улмаас хэдэн хүүхэд нас бардаг талаар нарийвчлан мэдэх боломжгүй боловч хүүхдийн нас баралт болон авлигын хор уршгын холбоо хамаарлыг тайлбарлаж чадна. Баталгаагүй статистик тоон мэдээлэлд анхаарал хандуулахын оронд авлигын хор хөнөөлийг нотолсон эмпирик нотлох баримтад анхаарал хандуулснаар асуудлыг тайлбарлахад хүчин чармайлт гаргах бус, харин үр дагавар, шалтгаан, нөхцөлийг арилгах арга хэмжээ авахад хүчин чармайлт гаргахад эерэгээр нөлөөлөх юм.

Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд хиймэл оюун ухаан нөлөөлж чадах уу?⁶²⁸

2021.05.31. Mayze Teitler. Авлигатай тэмцэхэд, ялангуяа, томоохон хэмжээний авлигатай тэмцэхэд сэжигтэй гүйлгээг үр дүнтэй бөгөөд зөв тодорхойлж чадах мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үр дүнтэй систем шаардлагатай байдаг. Сэжигтэй гүйлгээг тодорхойлох, тайлагнах үүрэгтэй санхүүгийн байгууллагууд улаан тэмдэглэгээ бүхий гүйлгээнүүдийг (гүйлгээний дүн, байршил, үйлчлүүлэгчийн ердийн үйл ажиллагаанаас хазайсан шинжтэй) тодорхойлох автоматжуулсан системийг ашигладаг бөгөөд уг автоматжуулсан систем нь тухайн гүйлгээг улаан тэмдэглэгээ бүхий гүйлгээ гэдгийг автоматаар тодорхойлж, цаашид нарийвчлан шалгах нөхцөлийг бий болгодог. Гэвч өдөр бүр хийгдэж буй санхүүгийн гүйлгээний хэмжээ, нарийн төвөгтэй байдал болон улаан тэмдэглэгээ бүхий гүйлгээнээс зайлсхийхийн тулд улс төрийн бүлэглэлүүд, гэмт бүлэглэлүүд болон бусад хүмүүсийн хууль бус үйл ажиллагаагаа далдлах арга улам нарийсаж, боловсронгуй болж байгаа нь үнэхээр сэжигтэй гүйлгээг тодорхойлоход туйлын

⁶²⁸ Орчуулсан: Р.Энх-Амгалан. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/05/31/ml-for-aml-is-artificial-intelligence-up-to-the-task-of-anti-money-laundering-compliance/#more-17995>

хэцүү болж байна. Ухаалаг системийг хөгжүүлэгчид ч гэсэн боломжит бүх улаан тэмдэглэгээ бүхий гүйлгээг автоматжуулсан системээр таньж чадна гэж найдахгүй байна.

Гэмт этгээдүүдээс нэг алхам түрүүлж алхахын тулд мэдээлэл боловсруулах технологийн шинэ дэвшил нь сэжигтэй гүйлгээг үр дүнтэй илрүүлэх системийг бий болгоход хэрхэн тусалж чадах талаар илүү сонирхох болсон. Технологи сонирхогчид мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны хүрээнд хиймэл оюун ухаан (ХОУ)-ыг гүнзгийрүүлэн судлах, Machine learning-ийн (ML) хүрээнд багтдаг сонгодог алгоритмуудыг ашиглахыг хүсэж байна. ML болон ХОУ нь тодорхой цогц өгөгдлөөс хэв маягийг тодорхойлж, ямар өгөгдлийн хэв шинж нь аль ангилалд холбогдохыг суралцдаг систем юм. И-мэйлийн спам шүүлтүүр бол үүний энгийн жишээ юм. Ангилал гэж нэрлэгддэг процессыг явуулахын тулд спам шүүлтүүр нь оролтын хувьсагчдыг спам болон спам биш гэсэн 2 ангилалд ангилдаг. Энэ нь и-мэйлийг хувийн шинж чанарт (илгээж буй хүн, үндсэн текст гэх мэт) нь тулгуурлан ангилж байгаа процесс юм. Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх хүрээнд санхүүгийн гүйлгээний талаарх өгөгдлөөр алгоритмуудыг сургаж, уг систем нь улаан тэмдэглэгээ байхгүй тохиолдолд сэжигтэй гүйлгээг олж илрүүлэх системд “суралцах” юм. ML болон ХОУ системийг “хуурамч эерэг” (сэжигтэй гэж тэмдэглэгдсэн гүйлгээнүүдийг шалгаж үзэхэд ямар нэгэн асуудалгүй байх магадлалтай – бүх тэмдэглэгдсэн гүйлгээний 99%), мөн хүний олж чадаагүй залилангийн шинжтэй “хуурамч сөрөг” гүйлгээнүүдийг шүүж гаргахад аль алинд нь ашиглаж болно. Үнэндээ салбарын мэргэжилтнүүд ХОУ зардлыг бууруулж, нарийвчлалыг сайжруулна гэдэгт маш их итгэлтэй байдаг бөгөөд ХОУ нь мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд үр дүнтэй түлхүүр байх болно хэмээн баталж, банкнуудыг мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх шинэ зэвсгийг атгах ёстой гэж уриалдаг.

ХОУ-ы хэрэгслээр одоо ашиглагдаж буй автоматжуулсан системийг сайжруулж чадвал нэг алхам урагшлах юм. Гэвч ML болон ХОУ-ы системийн мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэхэд чиглэсэн загвар нь зарим бэрхшээлийг бий болгодог.

Нэгдүгээрт, ML загварууд нь дор хаяж бодит утгыг мэддэг өгөгдлүүдийг шаарддаг. Спам шүүлтүүрийн жишээнээс харахад, ML загварыг спам болон спам биш гэсэн өгөгдлүүдээр сургаж болох бөгөөд ингэснээр машин өөрөө шинж чанаруудаас хамаарч спам болон спам биш и-мэйл гэдгийг мэдэж болно. Хэрэв загвар нь шалгагддаггүй бол машин ямар нэгэн ангилагдаагүй өгөгдлийг цуглуулж, янз бүрийн буруу зөрүү гүйлгээнүүдийг хамтад нь гаргаж, дараагийн шатны хяналтад өгнө. Судлаачид ML загвараар тодорхойлогдсон сэжигтэй гүйлгээ нь мөнгө угаах тохиолдлыг бодитоор илрүүлсэн эсэхийг тодорхойлох боломжтой байх шаардлагатай юм. Товчхондоо мөнгө угаах магадлалтай гүйлгээг тодорхойлох загварыг сургахын тулд загварыг “мөнгө угаасан”, “мөнгө угаагаагүй” гэсэн ангилалд багтаасан томоохон гүйлгээнүүдээр сургасан байх ёстой. Өгөгдлийг зөв ангилж чадахгүй бол судлаачид загвараа сайн сургаж чадахгүй байх, эсвэл үр дүнг нь шалгаж чадахгүй байх тохиолдол гардаг. Харамсалтай нь хууль бус үйл ажиллагаатай холбоотой тийм ч олон гүйлгээ байхгүй байж болох юм. Мөн судлаачид улаан тэмдэглэгээтэй гүйлгээ үнэхээр сэжигтэй эсэхийг тогтоож чадахгүй байж болох юм. (Эрх бүхий байгууллага нь мөрдөн шалгах ажиллагааны хязгаарлагдмал нөөцтэй тул зөвхөн хамгийн сэжигтэй гүйлгээний араас хөөцөлддөг. Санхүүгийн байгууллагууд олж илрүүлсэн сэжигтэй тохиолдлуудаас аль нь яг мөнгө угаах гэмт хэрэгтэй холбоотой байсныг баталгаажуулж өгөх нь ховор байдаг.) Тухайн байгууллагын гүйлгээний урьдчилсан эрсдлийн оноог ашиглан алгоритмыг сургах арга байдаг. Гэхдээ энэ арга нь үнэлгээний үнэн зөв байдлыг шаарддаг бөгөөд тодорхой асуудлуудыг үүсгэдэг. Хангалтгүй, буруу ангилагдсан өгөгдлөөр загварыг сургавал уг загвар нь эдгээр алдаануудыг давтах болно.

Хоёрдугаарт, ML болон ХОУ-ы загварууд нь маш ховор тохиолдлыг үнэн зөв тодорхойлоход бэрхшээлтэй байдаг. Мөнгө угаах гэмт хэрэг нь санхүүгийн үйл ажиллагаануудын хувьд нэлээд ховор тохиолддог (бидний мэдэж байгаагаар). Улс төрийн гэмт бүлэглэл гэх мэтийн хууль бус санхүүгийн үйл ажиллагааны хамгийн хор хөнөөлтэй хэлбэрүүд нь бүр ч ховор байдаг. Санхүүгийн байгууллагуудын хууль бус гүйлгээнүүдийг найдвартай тодорхойлж чадаж байсан ч сэжигтэй гүйлгээг үнэн зөв тодорхойлохын тулд зарим төрлийн ML болон ХОУ-ы системийг сургахад хангалттай биш байж магадгүй юм. Нэг банкны харилцагчийн мэдээлэлд тулгуурласнаас олон төрлийн мэдээллийн эх үүсвэрт тулгуурласан датабаазыг бүтээх нь энэ асуудлыг шийдэхэд туслах боловч мөнгө угаахтай холбоотой гэмт хэргийн мэдээллийг цуглуулахад хүндрэлтэй байдаг бөгөөд дийлэнх тохиолдолд олон нийтэд нээлттэй байдаггүй. Энэ нь байгууллагууд дотоод гүйлгээний мэдээлэлдээ найдах хэрэгтэй гэсэн үг бөгөөд зарим

төрлийн загварыг сургахад хангалттай хэмжээний мөнгө угаасан өгөгдөл байхгүй байж болох юм.

Гуравдугаарт, дээр дурдсан асуудлуудтай холбоотойгоор ML систем нь болзошгүй хууль бус үйлдлийн талаар үндэслэлтэй нотолгоонд тулгуурлаж байгаа эсэх, эсвэл өгөгдлийн хангалтгүй байдлаас болж алгоритм нь мөнгө угаахтай хамааралгүй шинж чанаруудтай холбогдож сурсан эсэхийг үнэлэхэд маш хэцүү байж болох юм. Эдгээр асуудлууд нь, ялангуяа, гүнзгий шалгагддаг загваруудад тулгардаг. Системүүдийн нарийн төвөгтэй байдлаас шалтгаалж эдгээр загварууд хэрхэн шийдвэр гаргахад тодорхойлоход туйлын хэцүү байдаг. Судлаачид ML систем нь хуурамч, эсвэл хамааралгүй ангилалд найдаж байгаа эсэхийг шалгах тодорхой арга техникийг боловсруулсан. Гэвч эдгээр техник нь ерөнхийдөө системийн инженерүүд загвараас ямар төрлийн мэдээллийг ач холбогдол бүхий алдаа гэж үзэх талаар таамаглал дэвшүүлж байхыг шаарддаг.

Эдгээр шалтгааны улмаас ML болон ХОУ-ы загварууд нь алдааг бууруулах, үр ашгийг нэмэгдүүлэх гэсэн амлалтдаа хүрэх эсэх нь одоогоор тодорхойгүй байна. Хэрэв эдгээр хэрэгслүүд нь зөв ангилагдсан цогц өгөгдлүүдээр бүтээгдэхгүй бол ямар нэгэн үр дүн гарахгүй (хог цуглуулж, хог гаргана гэсэн хуучны сургаалыг сануулна). Үүнээс гадна, ХОУ-ыг хөгжүүлэх хүсэл эрмэлзэл нь төгс төгөлдөр бус хэрэгсэлд хэт найдахад хүргэж болзошгүй бөгөөд байгууллагын аюулгүй байдалд хуурамч мэдрэмж төрүүлэх эрсдэлтэй юм. Мэдээж эдгээр асуудлуудыг зохих арга хэмжээг (синтетик өгөгдөл, эсвэл ховор тохиолдлыг урьдчилан таамаглах тусгай загвар ашиглах) авах замаар арилгаж болох бөгөөд ML болон ХОУ-ы системүүд нь одоо байгаа автоматжуулсан тойм систем дээр улам бүр сайжирч байгаа. Гэхдээ мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх нөхцөлд бат бөх загвар боловсруулахад тулгардаг бэрхшээлүүд нь илүү болгоомжтой байх шаардлагатайг харуулж байна.

Дэлхийн авлигын хэмжүүр судалгаа - ЕХ:
албан тушаалын байдлаа урвуулан ашиглах
явдал хяналтгүй байгаад олон нийт сэтгэл
зовниж байна⁶²⁹

2021.06.15. ТИ. ЕХ-ны улс орнууд бол баян чинээлэг, тогтвортой, ардчилсан гэгддэг улсууд юм. Гэвч бүс нутгийн тэгш бус байдал, авлигатай холбоотой хууль дээдлэх ёс алдагдсан зэргээс үүдэлтэйгээр энэхүү цэвэрхэн нэр хүнд үгүй болж байна. ТИ байгууллагаас гаргасан Дэлхийн авлигын хэмжүүр-ЕХ 2021 оны судалгаа нь ЕХ-н дахь авлигын талаарх хүмүүсийн үзэл бодол, туршлагын талаарх хамгийн том бөгөөд нарийвчилсан судалгаа юм.

Тус судалгаанд ЕХ-ны 27 улсын 40 мянга гаруй иргэн хамрагдсан. Судалгаанд хамрагдсан хүмүүсийн бараг гуравны нэг нь улс оронд нь авлигын нөхцөл байдал муудсан хэмээн хариулжээ. Судалгаанд оролцогчдын 44% нь нөхцөл байдал цаашид сайжрахгүй гэсэн байна. Төрийн авлигын талаарх төсөөлөл үү, хууль бус үйлдэлд хариуцлага хүлээхгүй байх явдал уу, төрийн үйлчилгээг танил талаар олж авах явдал уу, ямартаа ч ЕХ-ны цэвэр гэсэн нэр хүнд эргэлзээ төрүүлж байна. Энэ байдал нь нэн яаралтай, нэгдсэн арга хэмжээ авахыг шаардаж байна.

Судалгаанд бизнесийн салбар болон улс төрчид хамрагджээ

ЕХ-ны иргэд бизнес төрийн харилцааг илүү нягт ажиглаж байна. Бодлого боловсруулагчид бизнес эрхлэгчидтэй ямар холбоотой байдаг нь тодорхойгүй байгаа тохиолдолд олон нийтийн нийтлэг эрх ашгаас илүүтэй хувийн явцуу ашиг сонирхлын үүднээс бодлого боловсруулах, зохицуулалт хийх эрсдэлтэй байдаг.

Судалгаанд оролцогчдын гуравны нэгээс (30%) бага хувь нь засгийн газар шийдвэр гаргахдаа олон нийтийн санаа бодлыг харгалзан үздэг гэжээ. Засгийн газрын ашиг ихтэй гэрээ хэлцлийг олж авахын тулд бизнес эрхлэгчид хахууль, харилцаа холбоог ашигладаг ба томоохон компаниуд татвараас зайлсхийдэг хэмээн судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь хариулсан байна.

Иймд ЕХ-ны иргэдийн талаас илүү хувь нь засгийн газраа хувийн ашиг сонирхолд хөтлөгддөг гэж боддог нь гайхах зүйл биш юм.

⁶²⁹ Орчуулсан: Д.Жаргалан. Эх сурвалж: <https://www.transparency.org/en/news/gcb-eu-2021-survey-people-worry-corruption-unchecked-impunity-business-politics>

Хэн хамгийн ихээр авлигад автсан бэ?

ЕХ-ны иргэдийн бараг гуравны нэгээс илүү хувь нь засгийн газрыг хамгийн их асуудалтай гэжээ. Энэ нь авлигын асуудалд хариулага хүлээхгүй байна гэсэн ойлголтыг улам бүр гүнзгийрүүлж байна. Судалгаанд оролцогчдын зөвхөн 21% нь л авлигад холбогдсон албан тушаалтнууд хариуцлага хүлээдэг гэжээ.

Авлигад автсан байгууллагуудыг тодруулах явцад иргэдийн санал бодол хуваагдсан байна. ЕХ-ны улсуудын тал нь Ерөнхий сайд, парламентын гишүүд авлигад хамгийн ихээр автсан гэж, харин нөгөө тал нь бизнесийн удирдлагууд болон банкуудыг нэрлэсэн байна.

Тэгсэн ч цагдаагийн байгууллага, орон нутгийн засаг захиргаа, шүүх зэрэгт итгэх итгэл тус бус нутагт өндөр байна. ЕХ-ны иргэдийн 60 илүү хувь нь дээрх байгууллагуудад итгэдэг гэжээ.

Нийтийн үйлчилгээг хүртэх тэгш эрх ямар түвшинд вэ?

Хэдийгээр, хахуулийн түвшин 7% буюу доогуур байгаа ч эрүүл мэнд, боловсрол болон бусад үйлчилгээг авахдаа хувийн харилцаа ашигладаг хэмээн арван хүн тутмын нэг нь хариулсан байна. Энэ нь тус бүс нутгийн 106 сая хүн гэсэн үг юм.

Өнөөгийн эрүүл мэндийн салбар бол авлигын гол цэг юм. Ялангуяа, иргэдэд эрүүл мэндийн яаралтай тусламж, үйлчилгээ, вакцин шаардлагатай байгаа КОВИД-19-ийн нөхцөл байдлын үед онцгой анхаарал хандуулах асуудал юм. Хэдийгээр, ЕХ-ны оршин суугчдын 6% нь эрүүл мэндийн үйлчилгээ авахад хахууль өгсөн гэсэн ч 29% нь хувийн харилцаа ашигласан гэжээ.

“Эрүүл мэндийн салбарын хямралын үед хувийн харилцаа ашиглан нийтийн үйлчилгээ авж байгаа нь хахууль өгч буйтай адил юм. Яаралтай тусламж илүүтэй хэрэгтэй байгаа иргэдээс түрүүлэн КОВИД-19-ийн вакцин, эсхүл үйлчилгээ авах нь тэдгээр иргэд амь насаа алдахад хүргэж болзошгүй юм. ЕХ-ны засгийн газрууд үргэлжилж буй цар тахлын үед шударга, тэгш байдлыг сэргээхэд хүчин чармайлтаа хоёр дахин нэмэгдүүлэх нь маш чухал юм” хэмээн ТИ байгууллагын тэргүүн Делиа Феррейра Рубио онцлов.

Дэлхийн авлигын хэмжүүр -ЕХ 2021 судалгаа нь албан тушаалын байдлаа ашиглан бэлгийн ашиг хонжоо, эсхүл давуу байдал олж авах асуудлыг тодруулсан. Энэ нь эрүүл мэнд, боловсрол зэрэг нийтийн үйлчилгээ хүртэх явцад ихээхэн тохиолддог. ЕХ-ны оршин суугчдын 75% нь заримдаа тохиолдсон гэж хариулсан бол судалгаанд оролцогчдын 7% нь биеэр амссан, эсхүл хэн нэгнийг мэднэ гэжээ. Нийтийн үйлчилгээ авахад бэлгийн дарамтад орсон түвшнээр Болгар, Хорват, Румын тэргүүлсэн байна.

Авлигын талаар мэдээлэх нь аюултай эсэх талаарх үзэл бодол дээр ЕХ-ны улс орнуудын хэмжээнд санал зөрүүтэй байна. Судалгаанд оролцогчдын тал орчим хувь нь авлигын талаар мэдээлсэн тохиолдолд аюулд өртөнө гэж үзсэн бол тал нь үүнийг аюулгүй гэжээ.

Гэхдээ тус бүс нутгийн иргэд итгэл найдвар дүүрэн байна. ЕХ-ны оршин суугчдын бараг гуравны хоёр нь авлигын эсрэг тэмцэлд жирийн иргэд ямар нэгэн зүйл хийж чадна гэжээ.

Зөвлөмж

Хэдийгээр нэр цэвэр гэгддэг ч ЕХ-ны улсуудад авлига нь ноцтой асуудал юм. Бүс нутгийн засгийн газрууд болон ЕХ-ны байгууллагууд энгийн иргэдийн амьдралыг авлигаас ангид байлгахын тулд нэгдсэн хүчин чармайлтыг нэн даруй гаргах шаардлагатай юм. Иймд:

1. Шийдвэр гаргах явцыг бүрэн ил тод болгох, засгийн газруудад хариуцлага тооцох боломжийг иргэдэд олгох замаар хүмүүсийн итгэл, оролцоог бий болгох.
2. Бүх гишүүн орнуудад 2021 оны 12 дугаар сар гэхэд ЕХ-ны Шүгэл үлээгчийг хамгаалах зааврыг бүрэн шилжүүлэн өгөх замаар авлигыг мэдээлэгчдийг хамгаалах.
3. Лобби хийх үйл ажиллагааны ил тод байдлыг дээшлүүлэх, албан тушаалтнуудын дундах ашиг сохирлын зөрчлийг шийдвэрлэх замаар улс төр дэх хэт их нөлөөллөөс хамгаалах.
4. Корпорацийн авлигын эсрэг стандартыг бэхжүүлэх замаар хувийн хэвшлийн шударга байдлын стандартыг бий болгох.

5. ЕХ-ны аж ахуйн нэгжийн татварын дүрэм, журмыг цаашид уялдуулах замаар байгууллагын татварын ил тод байдлыг дээшлүүлж, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх.
6. Төрийн худалдан авах ажиллагааны мэдээллийн чанар, чанарыг дээшлүүлэх, компаниудын ашиг хүртэгч өмчлөлийн бүртгэлд олон нийт нэвтрэх боломжийг бүрдүүлэх замаар төрийн худалдан авалт дахь авлигыг бууруулах.
7. Эрх мэдлээ урвуулан ашигласан, тэр дундаа засгийн газар хууль дээдлэх ёсыг зөрчсөн тохиолдолд үр дүнтэй хяналт тавих, хууль сахиулах замаар хариуцлага тооцох.

Эрдэмтэн, судлаачид авлигатай тэмцэх чиглэлд бүтэлгүйтэж буй гурван шалтгаан: Ротштайны өгүүлэлд тайлбар өгөх нь⁶³⁰

2021.09.29. Matthew Stephenson. *Авлигатай тэмцэх салбарт нэр хүндтэй судлаачдын нэг болох Профессор Бо Ротштайн өнгөрсөн долоо хоногт “Эрдэмтэн, судлаачид авлигатай тэмцэх чиглэлд бүтэлгүйтэж буй гурван шалтгаан”⁶³¹ сэдэвт өгүүллийг нийтэлжээ. Энэхүү өгүүлэл нь дотоодын шинэчлэгчид болон олон улсын хөгжлийн байгууллагуудын дэмжлэгтэй хийгдэж буй авлигын эсрэг хүчин чармайлт, үйл ажиллагаа яагаад “томоохон бодлогын алдаа” болон хувирч байгаа талаар нарийвчлан тайлбарласан байна. Авлигын эсрэг үйл ажиллагааг амжилтгүй болгож буй гурван шалтгаанд 1) авлигын талаарх буруу тодорхойлолтыг ашиглах 2) нийгмийн шинжлэх ухааны буруу онолыг ашиглаж авлигыг судлах, анализ хийх 3) авлигыг “нийгмийн буруу газраас” хайх гэсэн асуудлыг дурджээ.*

Миний бие профессор Ротштайны бичсэн өгүүлэлтэй санал нийлэхгүй байгаа бөгөөд хэдийгээр профессор Ротштайн одоогийн нөхцөл байдалд тулгамдаж буй хэд хэдэн шалтгаант асуудлыг тодорхойлсон боловч үндсэн асуудлыг орхигдуулсан байна. Түүний бичсэн академик судалгааны материалд гурван нийтлэг хандлага илэрч байгаа юм. Үүнд: 1) Авлигын тодорхойлолтын талаарх эрүүл бус, ашиг тусгүй хэнээрхэл 2) Нийгмийн шинжлэх ухааны үзэл баримтлалыг буруу ойлгох, буруу ашиглах, ялангуяа онолын ойлголтын талаар 3) Өмнөх судалгаа, материалыг үл тоомсорлосон байна.

1. Тодорхойлолтын талаарх ашиг тусгүй хэт хэнээрхэл

Авлигыг нарийвчлан тодорхойлох нь амаргүй үйлдэл, гэвч үүнийг цаашид нарийвчлан судлах, тайлбарлах нь зохимжгүй бөгөөд олон жилийн турш маш олон судалгааг энэ чиглэлд хийж одоогийн нөхцөл байдалд хүрээд байгаа юм. Авлигын тодорхойлолт нь ялгаатай үзэл баримтлалд мөн адил ялгаатай байдлаар тайлбарлагддаг. Гэвч авлигатай тэмцэх салбарт авлигыг “өөрт олгогдсон эрх мэдлийг хувийн ашиг сонирхлын үүднээс урвуулан ашиглах” гэж ойлгодог. Хэдийгээр энэхүү тодорхойлолт нь хэд хэдэн тодорхой бус байдал бий болгодог боловч (урвуулан ашиглана гэж юу гэсэн үг вэ? хувийн ашиг сонирхол гэдэгт юуг ойлгох вэ?) хүмүүс авлигын талаар ярих үедээ тодорхой нэг ойлголтыг төсөөлж байдаг, тухайлбал, хахууль, төсвийн хөрөнгийг шамшигдуулах, танил талаа ажилд томилох гэх мэт. Зарим тохиолдолд аливаа тодорхойлолтыг ойлгох өндөр нарийвчлалтай томъёолол шаардлагатай болдог, жишээлбэл, тоон судалгаанд аливаа үйлдлийг нарийвчлан тодорхойлох, эсхүл авлигатай тэмцэх эрх бүхий байгууллагын харьяаллын хэрэг мөн эсэхийг тогтооход ашиглах боловч ерөнхийдөө олон нийтийн дунд авлигын талаарх ойлголт нэгдмэл байгаа юм.

Эрдэмтэн, судлаачид шинэ санаа, арга хэмжээ олж чадахгүй байдалд хүрсэн үедээ үргэлж тухайн зүйлийн тодорхойлолтыг үнэн зөв эсэх талаар маргалдаж эхэлдэг билээ. Ийнхүү нэр томъёоны асуудалд анхаарал хэт хандуулснаар ихэвчлэн ямарваа нэгэн нотлох баримтгүйгээр тус асуудлыг шийдвэрлэж чадахгүй байгаа явдлыг нэр томъёоны буруу ойлголттой холбон тайлбарладаг. Тухайлбал, энэ тохиолдолд авлигын эсрэг тэмцэл үр дүн муутай байгаа нь авлигыг зөв тодорхойлж чадаагүй гэх шалтгаантай хэмээн тайлбарласан байна. Профессор Ротштайн мөн авлигыг буруу тодорхойлсон нь ийнхүү бүтэлгүйтэлд хүргэсэн гэж бичсэн байгаа юм.

⁶³⁰ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://globalanticorruptionblog.com/2021/09/29/three-reasons-anticorruption-academics-fail-a-commentary-on-rothstein/>

⁶³¹ <https://www.corruptionjusticeandlegitimacy.org/post/three-reasons-anti-corruption-programs-fail>

Түүнийхээр “урвуулан ашиглах” гэх үйлдлийг тодорхойлж чадаагүй нь асуудлын эх үүсвэр гэжээ.

Профессор Ротштайны хэлж буй санаанд зарим нэг үнэн зүйл байгаа боловч “урвуулан ашиглах” үйлдэл нь эрх мэдлийг зохистой хэрэгжүүлж байгаа эсэх талаарх нийтлэг ойлголтоор тодорхойлдог. Авлигатай тэмцэх салбарын судлаач, албан хаагчид сүүлийн 40 жил ийнхүү тус үйлдлийг ойлгож ирсэн. Эрх мэдлээ урвуулан ашиглах үйлдлийг гурван үзүүлэлтээр тодорхойлох боломжтой талаар авлигатай тэмцэх салбарт ойлгодог. Нэгдүгээрт, албан ёсны зохицуулалт (эрүүгийн хууль болон бусад хууль, тогтоомж), хоёрдугаарт, олон нийтийн санал бодол ба нийгмийн хүлээлт, гуравдугаарт, шударга байдлын объектив стандарт буюу зохимжтой засаглал юм. Эдгээр үзүүлэлт бүр нь өөрсдийн гэсэн давуу ба сул талтай. Гэвч практикт энэ тодорхойлолт тийм ч чухал зүйл биш юм. Учир нь авлигын үндсэн үйлдлийн талаар нийтлэг ойлголт байдаг юм (хахууль, төсвийн хөрөнгийг шамшигдуулах зэрэг).

Профессор Ротштайны бичсэн өгүүлэлд дурдсанаар авлигатай тэмцэх бодлогын бүтэлгүйтэл нь түүнийг зөв тодорхойлоогүй үйлдлээс шалтгаалсан хэмээн дүгнэсэн нь ихээхэн учир дутагдалтай байгаа юм. Энэ дүгнэлтийн талаар тэрээр нарийвчлан тайлбар хийгээгүй бөгөөд ердөө хувийн үзэмжээр ийнхүү дүгнэжээ. Тус дүгнэлт нь учир дутагдалтай гэхээс илүүтэйгээр инээдэмтэй дүгнэлт юм. Энэхүү дүгнэлтийг практикт ойлгохоор нэг жишээ татаж үзье. Тухайлбал, ОУВС болон ЕХ-ноос төв Европын улс орнуудыг авлигатай тэмцэх шинэ дагнасан шүүх байгуулахыг шаардаж, тус шүүхэд “авлига”-ын гэмт хэргийг(хахууль, мөнгө угаах гэх мэт) шүүн таслахыг зохицуулжээ. Хэдэн жилийн дараагаар тус шүүх байгууллага тийм ч сайн үр дүнтэй ажиллаж чадахгүй байв. Хэдийгээр нотлох баримт хангалттай байгаа боловч шүүн таслах ажиллагаа сунжирч, гэм буруутай нь тогтоогдох шүүгдэгч цөөн байлаа. Олон улсын ивээн тэтгэгчид болон дотоодын шинэчлэгчид үүний цаад учир шалтгааныг ойлгохыг хүсэж, хэн нэгэн албан тушаалтнаас тодруулга авав. Гэвч тухайн албан тушаалтан өндөр эрх мэдэлтэй албан тушаалтнуудтай нэг ширээний ард суугаад “*Авлигатай тэмцэх шүүх нь үр дүн багатай ажиллаж байгаа нь авлигыг зөв тодорхойлж чадаагүй явдалтай холбоотой*” гэж хэлвэл тус албан тушаалтнууд юу гэж бодох вэ? Тийм ч таатай хүлээж авахгүй. Авлигатай тэмцэх үйл ажиллагааны үр дүнгүй байдал нь түүний тодорхойлолтоос үүдэлтэй гэдгийг нотолсон судалгаа одоогоор дэлхийд байхгүй билээ.

Мэдээж авлигыг шинэчлэн, нарийвчлан тодорхойлох оролдлого цөөнгүй хийгдсэн боловч ихэнх тохиолдолд тодорхойлолтыг илүү дордуулж байсан юм. Профессор Ротштайн өөрийн өгүүлэлд энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал бичжээ. Нэгдүгээрт, авлигын эсрэг ойлголтыг тодорхойлох шаардлагатай, хоёрдугаарт, авлигын эсрэг ойлголтыг “төрийн чадавх” (“quality of government”) гэж тодорхойлсон ба үндсэн хэм хэмжээ нь төрийн албан хаагчдын шударга байдал гэсэн байна. Тэгэхээр, авлигын эсрэг ойлголт нь шударга байдал (impartiality) байна. Тэгвэл авлига гэх ойлголтыг тодорхойлохын тулд бид шударга байдлыг тодорхойлох шаардлага тулгарч байгаа юм. Гэвч шударга байдлын эсрэг ойлголт нь давуу байдал олгох (favoritism) юм гэж тодорхойлсон байдаг. Тэгэхээр давуу байдал олгох нь авлига гэсэн үг үү? Үгүй юм, учир нь авлигын үндсэн хэрэгслийн нэг нь давуу байдал олгох бөгөөд үүнээс олон үйлдлийг мөн авлигад хамааруулан ойлгодог билээ. Түүнчлэн давуу байдал олгох нь зарим тохиолдолд авлигын шинж чанаргүй байдаг. Ингээд үзэхээр бид буцаад л авлигын ерөнхий ойлголтод очиж байна.

Дахин хэлэхэд, тодорхойлолтын талаар хэт хийрхэх нь тухайн судлаач ямарваа шинэ санаагүй, тулгамдсан асуудлыг шийдэх арга хэмжээний санаачилгагүй байдлыг илэрхийлдэг юм.

2. Нийгмийн шинжлэх ухааны үзэл баримтлалыг буруу ойлгох, буруугаар ашиглах

Нийгмийн шинжлэх ухаан судлаачид тус салбарын нарийн төвөгтэй асуудлыг судлах хэд хэдэн онол боловсруулсан байдаг. Эдгээр онолыг судалж, танин мэдэх нь судлаачдад ихээхэн ашиг тустай юм. Гэвч эрдэмтэн судлаачид аливаа нэг асуудлыг шийдвэрлэх арга зам нь нийгмийн шинжлэх ухааны “Х” онол бөгөөд “У” онолыг ашиглаж болохгүй хэмээн дүгнэх нь тун аюултай үзэгдэл юм. Цаашлаад, судлаачид өөрсдийн бүрэн ойлгоогүй тодорхойлолт, томъёоллыг ашиглахгүй байх шаардлагатай. Ялангуяа, тодорхой асуудлын хүрээнд илт харагдаж буй алдаа дутагдлыг шүүмжлэхэд ийнхүү томъёоллыг ашиглах нь учир дутагдалтай байдаг. Ихэнх тохиолдолд судлаачид өөрсдийн ашиглаж буй тодорхойлолтыг бүрэн ойлгоогүйгээс шалтгаалж буруу дүгнэлтэд хүрдэг. Үүнээс аюултай нь судалгааг хийх аргачлалыг сонгоход өөрсдийн бүрэн ойлгоогүй тодорхойлолтыг ашиглах явдал юм.

Авлигын эсрэг шинэчлэл нь “Удирдагч-Төлөөлөгчийн онол”⁶³² (“principal-agent theory”)-ыг ашигласан учраас амжилтгүй байсан хэмээн профессор Ротштайн мэдэгдсэн. Түүний хэлснээр, “Удирдагч-Төлөөлөгчийн онолыг ДБ-наас эхлээд хөгжлийн бүхий л байгууллагууд авлигын эсрэг тэмцэлд ашиглаж ирсэн нь тулгамдаж буй асуудлыг буруугаар ойлгоход хүргэсэн” ажээ. Энэ бол авлигатай тэмцэх бодлогын бүтэлгүйтлийн хамгийн чухал шалтгаан гэж тодорхойлсон байна.

Удирдагч-Төлөөлөгчийн онолыг хөдөлмөрийн харилцааг зохицуулах шаардлагаар эдийн засагчид боловсруулсан байдаг. Тус онолыг тайлбарлавал, тодорхой этгээдийг төлөөлж шийдвэр гаргах этгээд өөрийн хувийн ашиг сонирхлын үүднээс ажиллаж, төлөөлж буй этгээдийн сонирхолтой үл нийцэх шийдвэр гаргахыг хэлдэг. Удирдагч нь төлөөлөгчийн үйлдлийг удирдахыг хүсэх боловч дараах шалтгааны улмаас гүйцэтгэх боломжгүй болдог. Удирдагч нь төлөөлөгчийн шийдвэрийг хянах боломжгүй нөхцөл байдал үүсэх, цаашлаад ямар шийдвэр нь удирдагчийн сонирхолд нийцэж байгаа, ямар шийдвэр нь нийцэхгүй байгааг ялган зааглах аргагүй байдал бий болох юм. Хэдийгээр удирдагч нь төлөөлөгчтэй өөрийн сонирхлыг хамгаалах зорилгоор харилцаагаа загварчлахыг хүсэх боловч дээр дурдсан шалтгааны улмаас шаардлагад нийцэх харилцааг тогтоох боломжгүй болдог. Энэ асуудлыг шийдвэрлэх арга замыг олон судалгааны баримт бичигт тусгасан байдаг.

Эдийн засагчид авлига бол энэхүү Удирдагч-Төлөөлөгчийн онолын асуудал гэдгийг эртнээс мэддэг байсан. Мэдээж энэ онол авлигын тодорхойлолтод өөрийн байр суурийг бататгасан байдаг. Авлига нь өөрт оногдсон эрх мэдлийг хувийн ашиг сонирхолд урвуулан ашиглах буюу тус албан хаагч нь хэн нэгний төлөөллийг хэрэгжүүлж байгаа бөгөөд өөрийн хувийн ашиг сонирхлын үүднээс ашиглаж байгааг илэрхийлж байна. Энэ тохиолдолд удирдагч гэдэг нь нийгмийн бүх гишүүд бөгөөд төлөөлөгч нь нийтийн ашиг сонирхолд үйлчлэх ёстой этгээдүүд юм. Энэхүү онол нь тус асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар судалдаггүй. Тулгамдаж буй асуудлаас шалтгаалан авах хариу арга хэмжээ нь ялгамжтай байдаг. Үүнд, нэгдүгээрт, үндсэн асуудалд анхаарлаа хандуулах, хоёрдугаарт, тус асуудлыг яагаад шийдвэрлэх нь хүндрэлтэй болох, тухайлбал, төлөөлөгчийг нарийвчлан хянах нь түүний үр бүтээмжид сөргөөр нөлөөлнө гэх мэт, гуравдугаарт, тодорхой байгууллагын бүтэц нь асуудал үүсгэж буй талаар тайлбарлах, дөрөвдүгээрт, тодорхой арга хэмжээнд үзүүлэх хариу үйлдлийг төсөөлөх, тавдугаарт, байгууллагын асуудлыг шийдвэрлэх шинэлэг, онцлог арга хэмжээг санал болгох болно.

Профессор Ротштайны хэлж буйгаар Удирдагч-Төлөөлөгчийн онол нь авлигын эсрэг үйл ажиллагаанд Сомали улсыг Дани болгоход саад тогтор учруулсан болж байгаа юм. Энэ онолын дагуу, хэрэв үнэнч удирдагч (хотын дарга г.м) өөрийн төлөөлөгчийн (ЗДТГ-ын албан хаагчид) шударга бус байдлыг залруулах урамшууллын систем нэвтрүүлж чадвал төлөөлөгчийн авлигаас ангид үйлдэл нь тэдний ашиг сонирхолд нийцэж, цаашлаад авлигач үйлдлийг арилгаж болно гэж үзжээ. Гэвч энэ нь буруу юм. Хэдийгээр эдийн засагчид урамшууллын механизм шаардлагатай гэж үздэг боловч энэ механизмаар авлигыг устгаж болно гэдэгт итгэдэг эдийн засагч нэг ч байхгүй. Эдийн засагчид энэ асуудлыг судалдаг цорын ганц шалтгаан нь энэхүү асуудлыг шийдвэрлэхэд ихээхэн хүндрэл бэрхшээлтэй байдагтай л холбоотой юм.

Түүний хэлснээр урамшууллын механизмыг бий болгосноор авлигыг үгүй хийх боломжтой байсан бол авлига аль эрт устаж үгүй болох ёстой байсан гэжээ. Тиймээс Удирдагч-Төлөөлөгчийн онол зөв байсан бол авлигатай тэмцэх ажиллагаа ихээхэн хялбар байх байсан юм. Авлигатай тэмцэх зорилгоор улс төр болон төрийн албанд урамшууллын механизм бий болгох талаар хангалттай их судалгаа, мэдээлэл одоогоор байхгүй байна. Цаашлаад авлигын эсрэг үр дүнтэй шинэчлэлд тулгамддаг үндсэн хүндрэл бэрхшээл нь ихэнх тохиолдолд техникийн асуудал биш, харин улс төрийн шинжтэй асуудал байдаг билээ.

Профессорын авсан жишээнд хотын дарга нь удирдагч байхаар тусгасан боловч тэрээр хотын дарга мөн л төлөөлөгч байх нөхцөлийг тооцоолоогүй юм. Түүний тодорхойлсноор улс төрийн нөлөө бүхий улс төрчид бүгд удирдагчид байх ба тэдгээрийн шударга бус үйлдлийг таслан зогсоосноор төлөөлөгчдийн авлигач үйлдлийг зогсоох боломжтой гэсэн нь алдаа дутагдалтай юм. Энэхүү онолын нэгэн томоохон үзэл баримтлал нь удирдагч нь төлөөлөгчийн үр бүтээмжийг боломжит өндөр түвшинд байлгахад оршдог бөгөөд ийнхүү зөв харилцаа тогтооход хоёр асуудал үүснэ.

⁶³² <https://globalanticorruptionblog.com/2015/04/09/corruption-is-both-a-principal-agent-problem-and-a-collective-action-problem/>

Нэгдүгээрт, профессор Ротштайны ойлгож буйгаар ямар ч авлигад автагдсан системд удирдагчид нь авлигын эсрэг шинэчлэл хийхэд нээлттэй байдаг. Тухайлбал, Украин, Бразил, Индонез зэрэг улсын түүхийг харвал зарим улс төрчид авлигатай тэмцэх шинэчлэлд эерэг хандлагатай байгааг харж болно. Гэвч зарим тохиолдолд клептократууд өөрсдийн олох ашгийг нэмэгдүүлэх зорилгоор энэхүү шинэчлэлийг хэрэгжүүлдэггүй. Энэ нь дараагийн асуудалд хүргэж байгаа юм. Ротштайны хэлж буйгаар авлигын эсрэг үйл ажиллагаанд Удирдагч-Төлөөлөгчийн онолыг ашиглахаа зогсоож, “Нийгмийн гэрээний онол”-ыг ашигласнаар илүү их амжилтад хүрэх боломжтой гэжээ. Ийнхүү онолыг ашигласнаар хяналт шалгалтад тулгуурласан арга хэмжээнээс татгалзаж ард түмний хүсэж буй зүйлийг (дэд бүтэц, боловсрол, эрүүл мэнд г.м) тэдэнд өгдөг төрийг бий болгох боломжтой гэж үзжээ. Удирдагч-Төлөөлөгчийн онолыг хэрэглэхгүй байх шалтгаан нь зарим нийгмийн удирдагчид хэт авлигач учраас аливаа шинэчлэл хийхийг хүсдэггүй байдалтай холбон тайлбарласан юм. Тэгвэл яагаад Нийгмийн гэрээний онолын дагуу тэдгээр улс төрчид, удирдагчид өөрсдийн олох ашгийг багасгаж, ард иргэдэд зориулан дэд бүтэц, боловсролын салбар зэргийг хөгжүүлэх юм бэ? Энэ хоёр ойлголт хоорондоо зөрчилдөж байна шүү дээ. Онцгой нөхцөл байдлын улмаас эдгээр удирдагчид ард иргэдийн сайн сайхны төлөө дэд бүтэц, үйлдвэр, сургууль барихаар шийдлээ гэж төсөөлөхөд доод, дунд шатны авлигач нөхцөл байдлаас шалтгаалан тухайн бүтээн байгуулалт хийгдэхэд хүндрэлтэй байдал үүснэ. Тэгэхээр удирдагч арга барилаа өөрчилж, авлигатай тэмцэх өндөр хүсэл эрмэлзэлтэй болсон тохиолдолд хэрхэн нийгмийн авлигыг устгах талаар профессор Ротштайн тайлбарлаагүй байна.

Тэгэхээр энэхүү онол нь авлигын эсрэг тэмцэлд тийм ч ач тустай зүйл биш юм. Гэхдээ түүнд нэгэн чухал санаа байсан нь авлигын эсрэг шинэчлэл нь техникийн шинж чанар (ямар бодлого үр дүнтэй вэ?)-аас илүүтэй улс төрийн шинж чанар (шинэчлэгчид хэрхэн эрх бүхий албан тушаалтнуудыг үр дүнтэй бодлого баримтлахад хүргэх вэ?)-тай асуудал юм. Хэдийгээр авлигатай тэмцэх чиглэлд маш өргөн хүрээний судалгааг дэлхийн олон эрдэмтэн, судлаачид хийсэн боловч үүнийг тойрсон улс төрийн асуудлыг төдийлөн сайн судлаагүй байна.

3. Өмнөх судалгааны баримт бичгийг үл тоомсорлох

Эрдэмтэн, судлаачид өмнөх судалгааны баримт бичгийг шүүмжлэх, залруулах тохиолдол цөөнгүй байдаг. Ингэснээр судалгааг илүү зөв, үр дүнтэй дүгнэлтэд хүрэхэд тустай юм. Залуу судлаачдад өгөх сайн зөвлөгөөний нэг нь “*Хэн нэгэн чухал этгээд ямар нэгэн чухал зүйлийн талаар буруу бодсон гэдгийг судалгаанд нотлох нь ихээхэн чухал*” юм. Гэвч ийнхүү өмнөх судалгааны баримт бичгийг шүүмжлэхэд болгоомжтой хандах шаардлагатай ба түүнд холбогдох өөр онол, дүгнэлтийг холбогдуулан үгүйсгэх тохиолдол гардаг юм. Профессор Ротштайн “*авлигын эсрэг үйл ажиллагааны бүтэлгүйтэл нь эрх зүйн асуудал биш юм. Учир нь ихэнх авлигын түвшин өндөр улс орнууд авлигатай тэмцэх маш сайн эрх зүйн тогтолцоотой байдаг*” гэж мэдэгдсэн. Гэвч бодит амьдрал дээр аливаа хууль, тогтоомжийг сайн, муу гэж дүгнэх нь хүндрэлтэй байдаг. Зарим улс оронд үндэслэлгүйгээр хөрөнгөжих үйлдлийг хориглосон байхад зарим оронд энэ асуудлыг зохицуулаагүй, зарим улсад ашиг сонирхлын зөрчлийн эсрэг маш хатуу зохицуулалт байхад, бусад улсад байдаггүй зэрэг олон ялгавартай эрх зүйн систем байдаг билээ.

Гэвч, профессор Ротштайны хэлж буй санаанд нэгэн оновчтой зүйл байсан нь эрх зүйн шинэчлэл нь авлигын эсрэг үйл ажиллагаанд төдийлөн чухал зүйл биш, учир нь бүхий л улс орнууд хахууль, төрийн хөрөнгийг шамшигдуулахын эсрэг хууль, журамтай байдгийг дурджээ. Тиймээс одоогоор хэрэгжиж байгаа энэхүү хууль журам нь авлигыг устгаж чадаагүй учраас дахин эрх зүйн ямар ч шинэчлэл хийсэн төдийлөн үр дүнтэй биш гэдгийг илэрхийлж байгаа юм.

Эцэст нь, энэхүү шүүмжлэлийг дүгнэхэд, нэгдүгээрт, аливаа тодорхойлолтын зөв, буруугийн талаар маргалдах нь зохимжгүй бөгөөд ийм мэтгэлцээн практикт төдийлөн ач холбогдолтой биш гэдгийг ойлгох хэрэгтэй, хоёрдугаарт, нийгмийн шинжлэх ухааны арга, техникийг тодорхой хүрээнд боломжтой үед ашиглах шаардлагатай боловч аливаа асуудлыг шийдвэрлэхэд зарим онолыг зохимжтой, үлдсэн онолыг үр дүн муутай гэж дүгнэх нь учир дутагдалтай байдаг, гуравдугаарт, холбогдох чиглэлийн хүрээнд хийсэн өмнөх судалгааны материалыг шүүмжлэх тохиолдолд тус салбарын хамгийн сайн судалгааг жишиг болгож дүгнэх нь зүйтэй, ингэснээр тус судалгааны ололтыг бүрэн дүүрэн ойлгох, шүүмжлэх боломжтой юм.

2021.10.18. “U4” авлигын судалгааны төвөөс эрхлэн гаргасан “Татварын салбар дахь авлигын эрсдэл” сэдэвт судалгааны ажлыг товчлон хүргэж байна. Энэхүү судалгааг ТИ байгууллагын зөвлөх, улс төрийн ухааны профессор Милош Расмич бичжээ.

Татварын салбар дахь авлигын эрсдэл нь ойлгомжгүй, нарийн төвөгтэй хууль, татварын байгууллагын эрх мэдлийн байдал, хариуцлага тооцох чадамжгүй сул дорой дэглэм, мерит зарчмаас гадуур томилогдсон албан хаагч, мэргэжлийн ёс зүйн дутагдал болон татварын хэмжээг дур мэдэн тогтоож буй замбараагүй байдлаас шалтгаалан үүсдэг. Тэгвэл энэхүү асуудлыг иргэд, албан тушаалтан хоорондын тогтмол биечлэн уулздаг байдал улам дордуулдаг байна.

Татварын салбар дахь авлигын эрсдлийн тухай

Орлого зохицуулах алба нь орлогын албан татвар, гаалийн татвар болон төрийн өмчит хуулийн этгээдийн орлогыг цуглуулах зэрэг дотоодын орлогыг зохицуулж, цуглуулах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Татварын албаны үйл ажиллагаа доголдолгүй байх нь бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтыг дэмжих, эдийн засгийн өсөлтийг хангаж эрүүл мэнд, боловсрол, дэд бүтэц зэрэг нийгмийн онц чухал ач холбогдол бүхий салбарыг санхүүжүүлэх чухал ач холбогдолтой байдаг.

Татварын албаны үйл ажиллагаа доголдох нь татвар төлөгч ба албан тушаалтны хооронд зөрчилдөөн үүсгэж, улмаар төрд итгэх иргэд, бизнес эрхлэгчдийн итгэлийг дордуулж, татвар төлөх хүсэл сонирхлыг бууруулдаг байна. Харамсалтай нь, татварын салбар авлигын хамгийн өндөр эрсдэлтэй төрийн үйлчилгээний нэг юм. Тухайлбал, ТИ байгууллагаас эрхлэн гаргасан 2017 оны Авлигын барометр судалгаанд дурдсанаар судалгаанд хамрагдсан нийт иргэдийн 32% нь татварын албыг хамгийн их авлигач гэж үзсэн байна. (Хүснэгт 1-т харуулав)

Хүснэгт 1. 2017 оны Барометр судалгааны үр дүн



Хуулийн ойлгомжгүй байдал, татварын албан хаагчийн дур мэдэн шийдвэр гаргах эрх мэдэл, хүний нөөц, шагнал, урамшууллын талаарх мэдээллийн хаалттай байдал, хангалтгүй цалин, татварын албаны хянан шалгах үйл ажиллагааны хангалтгүй байдал болон хууль, журмыг зохих ёсоор хэрэгжүүлдэггүй нөхцөл байдал нь тус салбарын авлигын эрсдлийг нэмэгдүүлэхэд зонхилон нөлөөлж байна. Тухайлбал, татварын албаны ажилтнууд иргэд, бизнес эрхлэгчдээс ашиг хонжоо олох зорилгоор өөрсдийн бие даан шийдвэр гаргах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор ойлгомжгүй, ээдрээ төвөгтэй хууль, журмыг хэвээр үлдээдэг байна. Түүнчлэн,

⁶³³ Орчуулсан: О.Эрхэмжаргал. Эх сурвалж: <https://www.u4.no/publications/corruption-risks-in-tax-administration.pdf>

татварын салбарын бүхий л үйл ажиллагаа авлигын өндөр эрсдэлтэй гэдгийг ойлгох хэрэгтэй. Үүнд, татвар төлөгчийн бүртгэл, татварын зөрчлийг илрүүлэх, хариуцлага ногдуулах үйл ажиллагаа зэрэг хамаарна.

Татварын салбар дахь авлига нь аливаа улсын эдийн засагт ихээхэн хор хохирол учруулдаг. Жишээлбэл, далд эдийн засгийн хэмжээг тэлэх, төрийн байгууллагад итгэх иргэдийн итгэлийг бууруулах зэрэг. Судалгаагаар хөгжингүй болон хөгжиж буй орны авлигын нөхцөл байдал нь тус улсын татварын орлогод сөргөөр нөлөөлдөг болохыг тогтоожээ. Ялангуяа, ДБ-ны Засаглалын индексийн “авлигыг хянах чадвар” болон “засгийн газрын үр дүнтэй байдал”-ын үнэлгээ нь татвар цуглуулах үйл ажиллагаатай шууд харилцан холбоотой байдаг. Либерти улс иргэний дайны дараагаар, 2004 онд өөрсдийн татварын орлогыг нэмэгдүүлэх чиглэлд тодорхой амжилт гаргасан боловч татварын салбарын авлигын өндөр эрсдэл нь өөрчлөгдөөгүй байна. Үүнийг Глобал Барометр судалгааны дүнгээс мөн харах боломжтой. Тус улсын иргэдээс авсан “Татварын албаны нийт хэдэн албан хаагч авлигын хэрэг үйлдсэн бэ?” гэх асуултад судалгаанд оролцогчдын 68% нь “бүгд”, эсхүл “ихэнх нь” гэж хариулсан нь бүс нутгийн дүнгээс даруй 2 дахин өндөр үзүүлэлт юм. Авлигын энэхүү өндөр түвшин нь татварын байцаагчдад хахууль өгөх соёл нийгэмд бий болсон байдлаас шууд харагдаж байгаа юм. Африк тивд авсан санал асуулгаар төрийн үйлчилгээ авсан иргэдийн 28% нь сүүлийн 12 сарын хугацаанд ямар нэгэн байдлаар хахууль өгсөн гэж хариулсан бол Либерти улсын иргэдийн 53% нь ийнхүү хариулжээ.

Татварын салбар дахь авлигын гол хүчин зүйлс

Татварын салбар дахь авлигын эрсдлийг тодорхойлоход оновчтой загварчлал ашиглах шаардлагатай. Ихэнх эрсдлийн үнэлгээний загвар дараах шат дамжлагатай байдаг. Үүнд:

- Авлига тодорхой салбарт хэрхэн бий болж буй талаар дүн шинжилгээ хийх;
- Энэхүү нөхцөл байдал үүсэхэд хүргэж буй хүчин зүйлсийг тодорхойлох;
- Хэрэгжиж буй эрх зүйн орчин, бодлого, байгууллага, хяналт шалгалт болон байгууллага хоорондын хамтын ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх;
- Дээрх үнэлгээ, дүн шинжилгээний үр дүнд тулгуурлан авлигын эрсдлийг бууруулах арга хэмжээ авах зэрэг болно.

Түүнчлэн татварын салбар дахь авлигын эрсдлийг тодорхойлоход албан болон албан бус институцийн хоорондын харилцааг анхааралтай ажиглах шаардлагатай. Либертийн шинжээчидтэй хийсэн ярилцлагын үр дүнд татварын албаны өргөн хүрээний харилцааг давхар судлах шаардлагатай гэдгийг тогтоосон байдаг. Тухайлбал, татварын алба, парламент болон Хууль зүйн яамны хоорондын харилцааг зайлшгүй судлах хэрэгтэй. Уганда улсын мэдээ мэдээлэл энэ үзэл баримтлалыг баталсан байдаг. Учир нь тус улсад татварын албаны шинэчлэл хийхдээ нийгмийн хэм хэмжээг орхигдуулсан нь тус шинэчлэлийг үр дүнгүй болгоход хүргэсэн байна. Цаашлаад, албан бус харилцаанд анхаарлаа хандуулах шаардлагатай гэдгийг судлаачид баталсаар байна. ТИ байгууллагаас зарласнаар, авлига үүсэж болзошгүй гурван түвшин байдаг. Үүнд:

- Бодлого тодорхойлох ажиллагаа;
- Байгууллагын нөөц бололцоог зохицуулах;
- Үйлчлүүлэгчтэй харилцах харилцаа;

Бодлого тодорхойлох үйл ажиллагааны авлигын эрсдэл хоёр төрлөөр илэрдэг. Нэгдүгээрт, өндөр түвшний авлигын хэлбэрээр илэрч, албан тушаалтнууд нийтийн эрх ашгийг бус, байгууллагын эрх ашгийг хамгаалсан бодлого тодорхойлох, хоёрдугаарт, хууль бус нөлөөллийн замаар илэрч, бизнес эрхлэгч, иргэд төрийн албан хаагчдад хахууль өгөх замаар хуулийн үүрэг, хариуцлагаас зайлсхийдэг.

Байгууллагын түвшинд, төсөв, бараа бүтээгдэхүүний зэрэг нөөцийг зохицуулах үйл ажиллагаанд хяналт шалгалт хангалтгүй байх нь авлигын эрсдлийг нэмэгдүүлж, удирдах албан тушаалтан эрх мэдлээ урвуулан ашиглах боломжийг бий болгодог. Тухайлбал, непотизм нь албан тушаалтан томилох, тушаал дэвшүүлэх, шагнаж урамшуулах болон хариуцлага тооцох ажиллагаанд илэрч

эхэлдэг. Энэ түвшинд төсвийн хөрөнгийг шамшигдуулах зэрэг авлигын маш олон үйлдэл илэрдэг байна.

Үйлчлүүлэгчтэй харилцах түвшин буюу татварын байцаагч, татвар төлөгч нарын харилцаанд ихэнх тохиолдолд хахууль, эсхүл дарамт шахалт түлхүү анзаарагддаг. Цаашлаад, энэ түвшинд тулгарч буй авлигын эрсдлийг төрийн үйлчилгээг цахимжуулах замаар шийдвэрлэх боломжтой байдаг.

Татварын салбар дахь авлигын хэлбэрийг далд хамтарсан авлига болон дарамт шахалтын үүднээс шаардсан авлига гэж хоёр төрөлд ангилах боломжтой. Далд хамтарсан авлига гэдэгт татвар төлөгч болон татварын байцаагч нар нь хамтран тохиролцож хууль бус төлбөр хүлээн авсны үндсэн дээр татварын хэмжээг бууруулж тогтоохыг хэлнэ, харин дарамт шахалтын үүднээс үүсэх авлига нь татварын байцаагч өөрийн эрх мэдлийг ашиглаж, хахууль өгөхийг татвар төлөгчөөс шаардахыг ойлгоно.

Хүснэгт 2. Татварын албан дахь авлигын үндсэн хэлбэр

№	Хэлбэр	Тайлбар
1.	Хахууль	Татвараас зайлсхийх зорилгоор татварын байцаагчид өгч буй хууль бус төлбөр
2.	Орлогын дүнг хуурамчаар зарлах	Татварын байцаагч татвар ногдуулах орлогын үнийн дүнг хууль бусаар бууруулж зарлах
3.	Хөрөнгө шамшигдуулах	Татварын байцаагч өөрийн ашиг сонирхлын үүднээс хөрөнгийг өөрт хуваарилах
4.	Дарамт шахалт	Татварын байцаагч эрх мэдлээ ашиглан татвар төлөгчийг дарамталж, хууль бус төлбөр нэхэх
5.	Хууль, журмыг өөрт ашигтайгаар зохицуулах	Бизнес эрхлэгчид хувийн харилцаа, хууль бус төлбөр ашиглан өөрсдийн үйл ажиллагаанд хамаарах татварын хэмжээг багасгаж зохицуулах
6.	Эргэдэг хаалга	Төр, хувийн салбарын албан хаагчид салбараа тогтмол сольж албан тушаалд томилогдох. Татварын байцаагч албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа санхүүгийн хувийн фирмд ажиллах зэрэг
7.	Улс төрийн авлига	Улс төрчид өөрсдийн хамаарал бүхий бизнесийн салбарын татварыг бууруулах, улс төрийн өрсөлдөгчийн бизнесийг онилж татварыг нэмэгдүүлэх

Татварын салбар дахь авлигын үндсэн хүчин зүйлс

Тухайн салбарт авлигыг үүсгэж буй хүчин зүйлсийг зөв тодорхойлох нь авлигатай тэмцэх үр дүнтэй стратеги боловсруулж, арга хэмжээ авахад нэн чухал үүрэгтэй.

Бодлого тодорхойлох түвшинд

Бодлого тодорхойлох хүрээнд хамгийн их тулгардаг авлигын 4 хүчин зүйл байна. Үүнд:

- Нэн төвөгтэй, ойлгомжгүй, эсхүл тогтворгүй хууль тогтоомж;
- Эрх бүхий байгууллагын бүрэн эрх ойлгомжгүй байх болон нэг бүрэн эрхийг хэд хэдэн байгууллага хэрэгжүүлэх;
- Татварын алба хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай хангалттай эрх мэдэлгүй байх;
- Хяналт шалгалтын механизм хангалтгүй байх, хариуцлагын сул дорой систем зэрэг болно.

Нэгдүгээрт, ойлгомжгүй хууль, тогтоомж нь түүнийг төрөл бүрээр тайлбарлаж, авлигын үйлдэл хийх нөхцөл бололцоог бүрдүүлж өгдөг байна. Энэ нөхцөл байдал нь гадаад улсын бизнесийн байгууллагыг татвараас чөлөөлөх тохиолдолд ихээхэн хэрэглэгддэг. Судалгаагаар Африкийн улс орнууд жилд дунджаар ДНБ-ий 2.4%-тай тэнцэх татварыг дээрх үйлдлээс шалтгаалан алддаг болохыг тогтоожээ. Түүнчлэн, энгийн, ойлгомжтой татварын тогтолцоо нь авлигын эрсдлийг бууруулдаг байна.

Хоёрдугаарт, төрийн байгууллагын бүрэн эрх давхардах, эсхүл ойлгомжгүй байх нь улс төрийн нөлөөлөлд орох том эрсдлийг бий болгодог. Тухайлбал, улс төрийн албан тушаалтнууд татварын албанд нөлөөлж, хуулийн этгээдийг татвараас чөлөөлөх, улс төрийн өрсөлдөгчийг онилж тогтмол аудитын шалгалт хийлгэх эрсдэл үүсдэг байна.

Гуравдугаарт, хяналт шалгалт хангалтгүй байдал, хариуцлага тооцох сул дорой систем нь татварын албанд авлигын үйлдэл гаргах соёлыг бий болгох эрсдэлтэй байдаг. Африкийн улс орнуудад авлигыг мөрдөн шалгаж, ял оноох тогтолцоо хангалтгүй байдаг нь тус улсад авлига цэцэглэх нөхцөл байдлыг бий болгодог.

Байгууллагын түвшинд

Байгууллагын түвшинд авлига үүсгэгч дараах хүчин зүйлс байдаг. Үүнд:

- Байгууллагын бүтэц, үр дүнтэй байдал хангалтгүй байх;
- Байгууллага доторх авлига, залилангийн үйлдлийг илрүүлэх, хариуцлага оногдуулах сул дорой механизм;
- Шийдвэр гаргах үйл ажиллагаа хаалттай байх;
- Хүний нөөцийн үйл ажиллагаа хаалттай байх;
- Авлигын эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажил үүргийг хооронд нь солбидог байдал;
- Мэргэжлийн ёс зүй, шударга ёсны хангалтгүй байдал хамаарна.

Нэгдүгээрт, байгууллагын бүтэц, үр дүнтэй байдал хангалтгүй байх нь татварын албаны албан хаагчдын үйл ажиллагааны, төсвийн захиран зарцуулалтын дотоод хяналтыг үр дүнгүй болгож, улмаар төсвийн хөрөнгийг шамшигдуулах, авлигач үйлдэл хийх болон татвар төлөгчийн орлогыг хууль бусаар бууруулж мэдээлэх зэрэг үйлдэл гаргах эрсдлийг нэмэгдүүлдэг.

Хоёрдугаарт, хариуцлага тооцох механизм сул дорой байх нь тус байгууллагад авлигач соёл бий болох үндсийг үүсгэдэг байна.

Гуравдугаарт, шийдвэр гаргах үйл ажиллагаа ил тод бус байх нь дээд шатны албан хаагчдын авлигын үйлдлийг нуун далдлах, цаашлаад, авлигач үйлдлийг дэлгэрүүлэх шалтгаан болдог.

Дөрөвдүгээрт, хүний нөөцийн үйл ажиллагаа хаалттай байснаар албан хаагчид өөрсдийг нь дэмждэг удирдах албан тушаалтны хууль бус шийдвэрийг гүйцэтгэх, тэдгээрийн авлигач үйлдлийг хийх хэрэгсэл болж хувирах нөхцөлийг бүрдүүлдэг.

Тавдугаарт, албан хаагчдын ажил үүргийн хуваарийг солихгүй байх нь авлигач сүлжээ үүсгэх, энэхүү сүлжээнд элсэн орох эрсдлийг нэмэгдүүлдэг байна.

Эцэст нь, татварын албаны албан тушаалтнууд мэргэжлийн тодорхой ёс зүй, шударга ёсны стандарттай байх ёстой бөгөөд энэхүү стандартыг зөрчсөн тохиолдолд хүлээх тодорхой хариуцлагатай байх шаардлагатай. Ингэснээр авлигын үйлдэл гарахаас албан хаагчдыг урьдчилан сэргийлэх юм.

Үйлчлүүлэгчтэй харилцах харилцааны хүрээнд

Энэ хүрээнд авлигын эрсдэл үүсгэдэг үндсэн 3 хүчин зүйл бий. Үүнд:

- Татвар авах механизм (биеэр, цахимаар, бэлэн мөнгөөр, эсхүл банкаар, гуравдагч этгээдээр дамжуулан гэх мэт)
- Сул дорой хяналтын тогтолцоо

- Татвар төлөх үйл ажиллагааны процессын талаарх мэдээлэл хаалттай байх, татвар төлөгч болон татварын байцаагч нарын хооронд үл ойлголцол үүсэх

Нэгдүгээрт, судалгаагаар татвар төлөгч болон татварын байцаагч нарын биечлэн уулзах цагийг багасгаснаар авлигын эрсдлийг бууруулдаг болохыг тогтоосон. Үүнийг ерөнхийдөө татвар төлөх үйл ажиллагааг автоматжуулснаар гүйцэтгэх боломжтой. Жишээлбэл, Афганистаны таван мужид татварын цахим систем нэвтрүүлснээр татварын хэмжээг нэмэгдүүлж, авлигын түвшнийг бууруулжээ. Шинэ системийн хүрээнд татвар төлөгчид өөрсдийн төлөх шаардлагатай татварын хэмжээг цахимаар хүлээн авж төлсөн байна.

Хоёрдугаарт, татвар төлөх үйл ажиллагаанд автомат систем хангалтгүй ашиглах нь хяналт шалгалтын механизмыг сул дорой болгоход хүргэдэг. Татварын байцаагчид тодорхой бүс нутагт томилогдон ажилладаг бөгөөд тус хэсэгт өөрийн монопол бүрэн эрхийг тогтоож, хууль, журмыг өөрт ашигтайгаар тайлбарлан, хууль бус төлбөр хураамж иргэдээс шаарддаг.

Гуравдугаарт, татвар төлөлтийн процессын талаарх мэдээлэл хангалтгүй байснаар татвар төлөгчдийн мэдээлэлгүй байдлыг албан хаагчид ашиглаж хууль бус төлбөр, хураамж авдаг.

Хариуцлагын механизм сул дорой байснаар иргэдээс татварын албанд итгэх итгэл буурдаг.

Гаалийн алба

Гаалийн байгууллага төсвийн хөрөнгийг бүрдүүлэх, иргэд, бизнес эрхлэгчдээс их хэмжээний орлого цуглуулах чиг үүргийг гүйцэтгэх эрх бүхий байгууллагын хувьд мөн авлигын эрсдэлд өртдөг. Энэ салбарт авлига үүсгэх 5 хүчин зүйл байдаг. Үүнд:

- Техникийн үйл ажиллагааны монопол эрх;
- Гаалийн татвараас чөлөөлөх олон үндэслэл болон хүнд суртал;
- Их хэмжээний хууль бус хөрөнгө;
- Бүс нутгийн гаалийн албыг хянах сул дорой тогтолцоо;
- Цагдаа, тээвэр, иргэний харьяатын зэрэг төрийн бусад байгууллагатай хамтран ажилладаг нь тус байгууллагын үйл ажиллагааг хянахад илүү хүндрэлтэй болгох нөхцөл байдал хамаарна.

Ойлгоход хүндрэлтэй хууль, журам болон өндөр хэмжээний гаалийн татвар нь бизнес эрхлэгч, иргэдийг гаалийн байцаагчид хахууль өгч татварын хэмжээг бууруулахыг хүсэх шалтгаан болдог.

Бүс нутгийн онцлог шинж чанарт анхаарал хандуулах нь авлигын эрсдэл бий болгох хүчин зүйлстэй үр дүнтэй тэмцэх стратеги төлөвлөгөө боловсруулахад нэн чухал ач холбогдолтой болохыг шинжээчид хэлж байна. Хэдийгээр хууль, журмыг энгийн ойлгомжтой болгож, үр дүнтэй эрх зүйн орчин бий болгох шаардлагатай боловч үүний зэрэгцээ авлигын хүчин зүйлстэй тэмцэх арга хэмжээг авах нь зүйтэй юм. Албан бус харилцаанд дагаж мөрддөг нийгмийн хэм хэмжээг энэ арга хэмжээнд зайлшгүй анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал, Гүрж болон Руанда улс дээрх зарчмыг баримталж гаалийн салбар дахь авлигатай тэмцсэн байдаг. 2003 оноос Гүрж авлигын эсрэг иж бүрэн шинэчлэл хийж татварын салбар дахь авлигатай тэмцэх чиглэлд эрх зүйн болон техникийн арга хэмжээ авсан. Жишээлбэл, татварын хуулийг хялбаршуулж, хуулийн цоорхойг нөхсөн, мөн нэг цэгийн үйлчилгээний төвүүд нээж татварын үйл ажиллагааг иргэдэд хялбаршуулсан байна.

[Гана улс дахь хувийн хэвлэл мэдээллийн зарим байгууллага юуны учир авлигатай тэмцэж байна вэ? Шалтгаан, дүрэм, нөөц](#)⁶³⁴

2021.10.22. Joseph Yaw Asomah. Итгэмжлэгдсэн эрх мэдлээ хувийн зорилгодоо урвуулан ашиглах явдал болох авлига нь нийгэмд ноцтой үр дагавар учруулдаг. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга асан Бан Ги Муны хэлсэнчлэн, “*Хувийн ашиг сонирхлын үүднээс улсын мөнгийг*

⁶³⁴ Орчуулсан: Х.Оюунбаатар. Эх сурвалж: <https://theconversation.com/why-some-of-ghanas-private-media-fight-corruption-reasons-rules-and-resources-169254>

хулгайлснаар сургууль, эмнэлэг, зам, ус цэвэршүүлэх байгууламж барих нөөц багасна гэсэн үг ... Авлига нь хуурамч буюу чанаргүй эмийг зах зээлд гаргах, аюултай хог хаягдлыг хогийн цэг, далай тэнгист хаях боломжийг олгодог.”

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг авлигатай тэмцэх чухал институт гэж үздэг. Гана улсын хэвлэл мэдээллийн зарим байгууллага авлигын хэргийг мөрдөж, илчилж буй талаар би өмнөх бүтээлдээ⁶³⁵ бичсэн билээ. Тэд авлигын хор уршгийн талаарх ойлголт мэдлэгийг бий болгож, хэлэлцүүлгийн платформоор хангаж, хариуцлага хүлээлгэхийг шаарддаг.

Мөн “Шударга ёсны төлөөх мөнгө”⁶³⁶ (*Cash for Justice*), “Худалдах гэрээ”⁶³⁷ (*Contracts for Sale*) зэрэг эрэн сурвалжлах баримтат кинонууд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл авлигыг илчлэхэд хэрхэн туслах боломжтой, бас хэрхэн хариуцлага тооцож, шинэчлэл хийх талаар шахалт үзүүлж болохыг харуулж байна.

Гэвч Гана улсын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Дөрөв дэх Бүгд Найрамдах Улс⁶³⁸ дахь хяналтын чиг үүргээ үндсэндээ алдсан байна. Тэдний зарим нь авлигатай тэмцэхээс илүүтэй түүнд тусалдаг болохыг миний судалгаа⁶³⁹ харуулсан билээ. Энэ нь намчирхсан сурвалжлага, чадваргүй сэтгүүл зүй хосолсны үр дагавар юм.

Хамгийн сүүлд хийсэн судалгаандаа⁶⁴⁰ миний бие Гана улсын хувийн хэвшлийн зарим хэвлэл мэдээллийн хэрэгсэл улс төрийн авлигыг илчилж байхад зарим нь яагаад илчилдэггүй талаар судалж байгаа юм. Үүнийг тайлбарлахын тулд Британийн социологич, онолч Энтони Гидденсийн бүтээлд тулгуурлаж байна.

Гидденс нийгмийн үйл ажиллагааг бүрдүүлдэг дараах гурван зүйлийн талаар ярьдаг:

- хувь хүний үйлдэл хийх чадвар
- тэдгээрийн шалтгаан (сонирхол болон сэдэл)
- тэдгээрийн бүтцийн орчин (нөөц ба дүрэм).

Гана улсын хэвлэл мэдээллийн ажилтнууд, эрдэмтэн судлаачид, улс төрчид, авлигын эсрэг тэмцэгчидтэй хийсэн ярилцлага маань авлигатай тэмцэхэд эдгээр хүмүүс ямар үүрэг гүйцэтгэж байгааг харуулсан юм.

Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд авлигын эсрэг үйл ажиллагаа явуулах сэдэл хийгээд нөлөөллийг нэмэгдүүлэхийн тулд юу хийж болохыг энэхүү судалгааны үр дүн харуулж байгаа юм.

Оролцох шалтгаан

Энэхүү судалгаа⁶⁴¹ нь хэвлэл мэдээллийн байгууллагууд улс төрийн авлигыг илчлэх асуудалд тухайн харилцаанд оролцогч бүр өөр өөр сэдэлтэй байдгийг харуулсан. Үүнд хэвлэл мэдээллийн эзэд, сэтгүүлчид, улстөрчид багтана.

Зарим хэвлэл мэдээллийн эзэд, менежерүүд пүүсүүдээ хараат бус, авлигын эсрэг тууштай байхыг хүсдэг байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл бас стратегийн шалтгаантай байж болно. Зарим хэвлэл мэдээллийн фирмүүд шударга, тэнцвэртэй үйл ажиллагаагаар нэр хүндээ бий болгохыг эрмэлздэг гэж ихэнх оролцогчид хэлсэн юм. Энэ нь тэдэнд үзэгчдийг татах, сурталчилгаа хийх боломж олгодог байна.

Улс төрийн авлигатай тэмцэж буй цөөн хэдэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгэмд өөрчлөлт хийх гэсэн сэдэлтэй байсан. Жишээлбэл, нэгэн эрэн сурвалжлах сэтгүүлч өөрийн шийдэмгий

⁶³⁵ <https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/01436597.2020.1806707?journalCode=ctwq20&>

⁶³⁶ <https://www.ghanaweb.com/GhanaHomePage/NewsArchive/Government-sacks-State-Attorney-implicated-in-Adeti-s-Cash-for-Justice-documentary-1243084>

⁶³⁷ <https://www.pulse.com.gh/news/local/contracts-for-sale-expose-nana-addo-sacks-ppa-boss/bn078yt>

⁶³⁸ 1993 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр хүчин төгөлдөр болсон Бүгд Найрамдах Гана Улсын 1992 оны Үндсэн хууль нь тус улс 1957 онд тусгаар тогтнолоо олж авснаасаа хойш бүгд найрамдах ардчилсан засаглал тогтоохыг дөрөв дэх удаагаа оролдсоны үр дүн болсон тунхаг бичиг аж. <http://countrystudies.us/ghana/100.htm> (X.O)

⁶³⁹ <https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/15295036.2020.1774069?journalCode=rasm20>

⁶⁴⁰ <https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/00207659.2021.1881871?journalCode=mjjs20>

⁶⁴¹ <https://www.tandfonline.com/doi/abs/10.1080/00207659.2021.1881871?journalCode=mjjs20>

байдал нь Гана улсад хүмүүс зовлон зүдгүүрт өртөж буйгаас үүдэлтэй юм хэмээн тайлбарлаж байв.

Бас нэг сэтгүүлч хэдий ядуу зүдүү боловч түүнийг дуугүй болгохын тулд тавьсан авлигад идэгдсэн улстөрчдийн саналаас (бэлэн мөнгө, эд зүйл) татгалзсан тухайгаа ярих.

Судалгаанд хамрагдсан авлигатай тэмцэгчид болон хэвлэл мэдээллийн мэргэжилтнүүд энэхүү хувийн туршлага, авлигатай тэмцэх тууштай байдлаа баталж байв.

Бүтцийн нөхцөл

Тухайн харилцаанд оролцож буй хүмүүсийн үйл ажиллагааны сэдэл нь бүтцийн нөхцөл байдлаас мөн шалтгаалж байв.

Гидденсийн үзэж байгаагаар бүтцийн хамгийн чухал элементүүд нь институцийн дүрэм ба нөөц юм. Дүрэм нь тухайн улс төрийн нийгэмлэгийн хүрээнд хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн нийгэм, эдийн засаг, улс төрийн харилцааг тодорхойлж, удирдан чиглүүлдэг. Эдгээр дүрмүүд нь албан ба албан бус байж болох ба сул, эсвэл хүчтэй мөрдөгдөж болно.

Гана улсын 1992 оны Үндсэн хууль⁶⁴² нь ардчилсан эрх чөлөөг⁶⁴³ тогтоосон байна. Судалгаанд оролцогчдын нэг болох сэтгүүл зүй, харилцааны судлаач энэ тухай “*иргэний нийгэм, иргэд, хэвлэл мэдээллийнхэнд ажиллах боломжийг олгодог улс төрийн таатай орчин юм*” хэмээн ярьсан.

Мөн хэвлэл мэдээллийн ажилтнууд ч 1992 онд Гана улс ардчилсан засаглалд шилжсэн нь шүүмжлэлт сэтгүүл зүйд тус дөхөм болсон гэж үзэж байна. Тэд энэхүү өөрчлөлтөөр бий болсон эрх чөлөө нь дур зоргоороо баривчлах, яллах, шоронд хорихоос айхгүйгээр улс төрийн удирдагчдад хариуцлага тооцох таатай нөхцөлийг бүрдүүлсэн гэв.

Гэвч авлигатай тэмцэж буй хэвлэл мэдээллийн ажилтнуудад хүчирхийллийн аюул байсаар байна. Эрэн сурвалжлах сэтгүүлч Ахмед Хуссейн Суалегийн амь насыг 2019 онд хөнөөсөн хэрэг цочирдом жишээ юм⁶⁴⁴.

Нөөц бас чухал. Нийгмийн оролцогчдын эрх мэдэл нь тэд материаллаг болон хүний нөөцийг хэр зэрэг хянаж буйгаас хамаарна. Гана улсын Ерөнхий аудиторын газар зэрэг авлигатай тэмцэх төрийн байгууллагуудын үйл ажиллагаа нь хувийн хэвшлийн зарим хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг улс төрийн авлигын талаар шүүмжлэлтэй мэдээлэхэд түлхэц өгч байна.

Редакторынх нь онцлон тэмдэглэсэнээр: “*Ганын улсын нөөцийг төрийн зарим албан тушаалтнууд хэрхэн үргүй зарцуулж буйг Ерөнхий аудиторын жилийн тайлан*⁶⁴⁵ *харуулж байна. Хэвлэл мэдээллийнхэн эдгээр тайланг хэлэлцэж, хариуцлага тооцохыг шаардах замаар олон нийтэд түгээхэд тусалдаг*” байна.

Эдгээр мэдээллүүд нь цаашид мөрдлөг явуулах нэн шаардлагатай хүрээг тодорхойлох боломжийг сэтгүүлчдэд олгодог байна.

Нэмж дурдахад, төрийн яам, агентлагууд улс төрийн авлигын талаарх мэдээллийг хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулахад тусалдаг байна.

Харин хувийн хэвшлийн хэвлэл мэдээллийнхэн авлигатай тэмцэхэд тэдэнд нөөц хэрэгтэй байна. “*Авлигын хэргийг мөрдөхөд цаг хугацаа, зардал их шаарддаг*” гэдгийг хэвлэл мэдээллийн ажилтан онцолж байв.

Судалгаанаас харахад авлигатай тэмцэх хэвлэл мэдээллийнхний ажилд ардчилсан эрх чөлөө дангаараа хангалттай хамгаалалт болж чадахгүй байна. Бүтцийн нөхцөл нь энэхүү харилцаанд оролцогчдыг дэмжих нөөц болон дүрэм журмаар хангаж болно. Гэхдээ тэд өөрсдийн ашиг сонирхолд үндэслэсэн тодорхой зорилгод хүрэхийн тулд хүч болон нөөцөө хэрхэн ашиглахаа шийддэг байх ёстой.

⁶⁴² https://www.constituteproject.org/constitution/Ghana_1996.pdf

⁶⁴³ <https://www.grin.com/document/338932>

⁶⁴⁴ <https://www.bbc.com/news/world-africa-47002878>

⁶⁴⁵ <https://www.graphic.com.gh/news/general-news/auditor-general-presents-12-statutory-reports-to-parliament-first-in-10-years.html>

Иймд авлигатай тэмцэх ажиллагаа нь зөвхөн бүтцийн нөхцөл төдийгүй оролцогчдын зан төлөвт чиглэх ёстой ажээ.

Цаашид

Авлигыг мөрдөх, илрүүлэхэд оролцож буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон бусад оролцогчдыг төр, хэвлэл мэдээллийн эзэд, иргэний нийгмийн зүгээс дэмжих ёстой.

Эрэн сурвалжлах сэтгүүлчдийг хамгаалахын тулд санхүү, тогтолцоо, хууль эрх зүй, аюулгүй байдлын дэмжлэг хэрэгтэйг оролцогчид хэлж байна. Жишээлбэл, мөрдөх ажиллагаа явуулсныхаа төлөө шүүхэд дуудагдсан хэвлэл мэдээллийн байгууллага болон ажилтанд Гана улсын Хуульчдын холбоо үнэ төлбөргүй хууль эрх зүйн дэмжлэг үзүүлэх боломжтой юм.

Засгийн газар эрэн сурвалжлах хэвлэл мэдээллийн хэрэгслийг дэмжих зорилгоор хараат бус удирдлага бүхий сан байгуулж болно. Эрэн сурвалжлах ажлынхаа улмаас халдлагад өртөх аюул тулгарсан хэвлэл мэдээллийн байгууллага болон ажилтныг Аюулгүй байдлын агентлагууд хамгаалах боломжтой.

Эдгээр дэмжлэг, орчныг бүрдүүлэхгүй бол хувийн хэвшлийн цөөн хэдхэн хэвлэл мэдээллийн компани, ажилтнууд л авлигыг мөрдөн мөшгих, илчлэх зэрэг шүүмжлэлт сэтгүүл зүйд үнэнчээр зүтгэсэн хэвээр үлдэх болно.

ИНДЕКС

- Apple компани, 48, 49
CROOK, 52, 53
FinCEN файлууд, 309, 310
FinCEN файлуудын, 357
NASA, 328
TRACE, 7, 93, 94
TRACE-ийн, 93, 94
Авлига багатай, 91
Авлига ихтэй, 306
авлигаас урьдчилан сэргийлэх, 21, 23, 30, 54, 56, 57, 64, 66, 69, 74, 141, 155, 156, 160, 164, 165, 168, 171, 172, 175, 178, 181, 313, 347
Авлигаас урьдчилан сэргийлэх, 21, 64, 66, 67, 69, 119, 127, 136, 158, 167, 178, 244, 246, 338, 345
Авлигад автсан улс төрчид, 35, 183
авлигажсан, 53, 130, 301, 302, 305
авлигатай тэмцэх, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 15, 16, 17, 18, 20, 21, 22, 23, 24, 28, 31, 32, 33, 34, 36, 38, 41, 42, 44, 45, 46, 49, 50, 52, 53, 55, 56, 59, 61, 62, 65, 66, 67, 68, 70, 71, 73, 75, 76, 80, 83, 84, 86, 88, 92, 93, 94, 95, 106, 109, 111, 112, 115, 116, 119, 120, 123, 127, 128, 129, 137, 140, 141, 143, 145, 146, 148, 149, 150, 156, 158, 160, 161, 162, 163, 164, 165, 167, 168, 169, 170, 171, 172, 178, 179, 180, 181, 182, 183, 190, 194, 200, 204, 208, 219, 221, 224, 225, 227, 229, 230, 237, 238, 239, 241, 249, 254, 265, 266, 271, 273, 275, 280, 281, 284, 285, 287, 289, 296, 297, 298, 299, 302, 303, 310, 312, 314, 315, 318, 319, 321, 323, 328, 336, 337, 338, 339, 340, 343, 345, 363, 364, 366, 374, 375, 376, 377, 380, 382, 383, 384, 385
Авлигатай тэмцэх, 4, 5, 7, 8, 10, 11, 12, 16, 17, 21, 25, 26, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 37, 39, 40, 42, 52, 53, 55, 56, 57, 58, 66, 71, 74, 80, 81, 82, 84, 90, 92, 95, 96, 100, 106, 115, 116, 117, 119, 120, 124, 125, 126, 127, 128, 129, 131, 149, 156, 157, 158, 159, 160, 161, 164, 165, 167, 171, 178, 180, 181, 182, 185, 190, 192, 193, 194, 200, 202, 204, 208, 216, 218, 219, 222, 223, 228, 231, 243, 245, 250, 264, 266, 271, 272, 277, 278, 279, 281, 282, 284, 285, 286, 287, 296, 301, 302, 310, 311, 312, 317, 327, 338, 343, 363, 367, 374, 375, 376
авлигатай тэмцэх ажиллагаа, 5, 61, 230, 376, 385
авлигатай тэмцэх байгууллагын, 6, 7, 15, 35, 80, 83, 94, 109, 169, 227, 273, 338
Авлигатай тэмцэх газар, 32, 119, 156, 167
Авлигатай тэмцэх үйл ажиллагаа, 52, 250
авлигатай тэмцэх үйл ажиллагааг, 53, 56, 221, 323
Авлигатай тэмцэх хороо, 11, 26, 28, 29, 30, 33, 164, 192, 202, 208, 245
Авлигач, 4, 15, 17, 33, 42, 52, 57, 59, 238, 268, 330
авлигыг бууруулах, 10, 23, 40, 167, 175, 176, 312, 314, 341, 348, 366, 374
авлигыг мэдээлэх, 66, 172, 350
Авлигыг хэмжих, 344
авлигын гэмт хэргийг, 22, 72, 126, 265
Авлигын гэмт хэрэг, 106, 238
Авлигын нөлөөгөөр, 315
Авлигын соёл, 141
Авлигын улмаас, 29, 68, 314, 353
Авлигын харуул, 107, 112, 113, 189
Авлигын хор уршгийг, 352
авлигын хор уршгийн, 383
Авлигын хохирогч, 352
авлигын хэргийн улмаас, 12, 15, 33, 87, 212, 244, 264
авлигын хэрэгт, 7, 8, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 33, 34, 44, 47, 59, 60, 63, 71, 80, 88, 89, 92, 93, 100, 101, 102, 103, 118, 126, 190, 195, 198, 200, 201, 204, 207, 208, 209, 210, 213, 214, 215, 219, 222, 224, 229, 230, 232, 233, 236, 237, 238, 239, 242, 245, 246, 247, 250, 253, 256, 261, 262, 263, 267, 268, 269, 270, 274, 278, 281, 282, 290, 291, 292, 293, 294, 297, 298, 299, 303, 313, 315, 336, 343, 362
авлигын эрсдлийг, 9, 32, 68, 76, 153, 154, 160, 176, 178, 329, 378, 379, 380, 381, 382
Авлигын эрсдлээс, 32, 381
Авлигын эсрэг, 3, 4, 5, 7, 9, 10, 12, 20, 22, 23, 24, 26, 27, 30, 31, 35, 42, 43, 44, 45, 48, 53, 64, 65, 67, 69, 72, 76, 85, 93, 100, 119, 129, 133, 137, 141, 143, 145, 148, 150, 159, 165, 166, 168, 170, 179, 180, 181, 190, 196, 206, 212, 221, 233, 242, 245, 248, 250, 273, 301, 311, 319, 322, 340, 345, 351, 352, 374, 376
Авлигын эсрэг хуулийг, 44, 322
Авлигын эсрэг хуулийн, 4, 5, 27, 43, 44, 67
Авлигын эсрэг хууль, 43, 44, 119
авлигын эсрэг шинэчлэл, 52, 377
Австралийн, 4, 25, 73, 148, 199, 240
Австри, 16, 17, 23, 292, 299
Австрийн, 293, 299, 300
авторитаризм, 304
ажлаас нь чөлөөлжээ, 228, 255
Азербайжан, 87, 156, 317, 322
Азербайжаны, 6, 86, 137, 356
Ази тивийн, 329

Ази-Номхон далайн, 7, 93, 94, 188
 албан тушаалаа урвуулан ашиглах, 87, 140, 158
 албан тушаалын хэрэг, 84
 Албани, 15, 16, 17, 279, 281, 282, 298, 299
 амлалт, 4, 21, 28, 35, 66, 84, 111, 179, 321
 Амстердамд, 356
 амьсгалын аппарат, 340, 362
 Ангол, 7, 106, 107, 280, 305, 306
 АНУ, 3, 5, 6, 7, 9, 10, 11, 12, 13, 14, 17, 21, 36, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 55, 56, 57, 58, 59, 60, 65, 71, 77, 80, 83, 98, 99, 101, 104, 106, 107, 125, 135, 136, 137, 141, 153, 154, 156, 162, 166, 167, 177, 184, 186, 191, 192, 193, 196, 197, 199, 202, 205, 208, 209, 218, 224, 225, 241, 248, 249, 250, 251, 252, 253, 254, 255, 257, 262, 263, 264, 276, 283, 294, 295, 299, 306, 309, 314, 317, 318, 324, 328, 329, 331, 332, 333, 340, 341, 346, 352, 353, 355, 358, 359, 360, 361
 АНУ-ын, 36, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 55, 56, 57, 58, 59, 71, 80, 83, 98, 101, 104, 106, 107, 125, 135, 136, 153, 162, 167, 184, 186, 191, 192, 193, 199, 202, 205, 209, 224, 225, 241, 248, 249, 250, 251, 252, 253, 254, 255, 257, 262, 263, 276, 283, 294, 295, 299, 309, 314, 318, 324, 328, 329, 331, 332, 333, 346, 352, 353, 355, 358, 359
 АНЭУ, 3, 95, 108, 300, 305, 306, 363
 арбитрын, 53, 54
 Аргентин, 59, 160
 Аргентины, 59
 ардчилал, 21, 52, 55, 63, 104, 105, 113, 139, 167, 287
 ардчиллыг, 52, 56, 59, 104, 106, 318
 ардчилсан улс, 96, 104
 АТИ, 3, 6, 7, 17, 60, 64, 66, 71, 74, 75, 79, 91, 92, 93, 94, 128, 133, 146, 184, 231, 272, 305, 316, 317, 318, 319, 330, 331, 332, 333, 343, 357, 363
 АТИ-ээр, 71, 75, 91, 93, 128, 133, 184, 231, 272, 305, 331, 343
 АТМ, 5, 41
 аудитын шалгалт, 32, 381
 Афганистан, 13, 84, 93, 159, 230, 231, 238, 324, 337, 346
 Афганистанд, 324, 336
 Афганистаны, 6, 13, 17, 84, 223, 230, 231, 336, 337, 382
 Африкийн, 3, 5, 8, 15, 49, 50, 59, 63, 107, 108, 110, 111, 112, 123, 128, 154, 176, 268, 273, 275, 276, 322, 335, 351, 361, 363, 381
 ашиг сонирхлын зөрчил, 68, 73, 75, 82, 129, 178, 318, 332, 337
 ашиг сонирхлын зөрчлийг, 40, 174
 АЭНҮБК-ыг, 22, 311
 АЭНҮБК-ын, 9, 21, 23, 24, 67, 162, 352
 Багамын арлууд, 306
 Байденy, 7, 47, 48, 55, 56, 101, 106, 276, 324, 361
 Балба, 159, 221, 325, 326
 Балбад, 325, 326
 Бангладеш, 11, 12, 85, 86, 205, 212, 317, 360
 баримтууд, 35, 39, 100, 177, 236, 259, 278, 279, 309, 367
 Башкир, 283
 Беларусь, 65, 137, 184
 бизнесийн, 22, 30, 38, 40, 44, 46, 50, 67, 73, 79, 80, 87, 102, 110, 123, 138, 148, 154, 155, 161, 164, 177, 203, 204, 215, 234, 294, 306, 310, 313, 314, 318, 322, 325, 326, 360, 361, 372, 373, 378, 380, 381
 биткойн, 41, 146, 309
 биткойны, 5, 41
 БНУУ, 32
 БНХАУ, 3, 4, 12, 13, 14, 18, 30, 31, 53, 62, 93, 94, 95, 110, 130, 131, 136, 153, 154, 162, 216, 218, 220, 221, 222, 224, 226, 227, 231, 236, 245, 276, 280, 308, 343, 344
 бодлого, 5, 6, 9, 23, 27, 31, 32, 48, 55, 57, 65, 73, 75, 80, 82, 128, 141, 150, 162, 164, 175, 178, 207, 255, 304, 310, 312, 316, 317, 318, 329, 330, 334, 354, 359, 370, 372, 377, 379
 бодлогын, 31, 48, 52, 56, 65, 66, 112, 141, 142, 149, 150, 160, 304, 326, 327, 337, 339, 347, 358, 360, 365, 374, 375, 376
 Бразил, 5, 7, 10, 43, 45, 46, 80, 99, 101, 102, 186, 187, 248, 280, 340, 341, 362, 377
 Бразилийн, 5, 41, 43, 44, 45, 53, 80, 99, 100, 101, 102, 103, 187, 247, 250, 280
 Бруней, 84
 бэлгийн сүрдүүлэг, 301, 302
 виртуал, 41, 138
 Вьетнам, 84, 93, 159, 210, 320, 323, 324
 Вьетнамын, 12, 17, 210, 211, 320, 323, 324
 гаалийн, 62, 88, 141, 150, 157, 166, 229, 238, 296, 378, 382
 Габон, 317
 газрын тосны, 11, 49, 100, 109, 199, 246, 249, 269, 305, 315, 316, 361
 Гамби, 306
 Гана, 18, 249, 361, 364, 365, 382, 383, 384, 385
 ГАҮАТХ, 3, 44, 45, 46, 50, 53, 125, 173, 197, 248, 249, 314, 352
 Гватемал, 59, 106, 191, 247, 322
 Герман, 8, 9, 41, 70, 77, 91, 126, 137, 299, 317, 341, 360
 Германы, 41, 70, 92, 123, 137
 Глобал Барометр, 379
 Гондурас, 59, 97, 106
 ГРЕКО, 3, 9, 10, 65, 67, 69, 137, 155, 156, 160, 161, 178, 338

Гүрж, 8, 15, 120, 159, 278, 322, 364, 382
 гэмт бүлэглэлүүд, 329, 370
 гэмт хэргийг мөрдөн шалгах, 22, 36, 37, 43,
 46, 97, 99, 265, 325, 326
 далд эдийн засагтай, 31, 34, 35
 далд эдийн засгийн, 34, 35, 379
 Дани, 91, 171, 317, 318, 376
 ДНБ, 3, 29, 50, 56, 61, 65, 97, 112, 309, 310,
 330, 360, 367, 368, 370, 381
 Думын, 16, 67, 69, 115, 117, 129, 134, 135,
 286, 288
 дуулиан, 12, 77, 197, 210, 272, 306, 312, 313
 дүн шинжилгээ, 6, 18, 50, 54, 57, 58, 81, 158,
 193, 337, 347, 359, 364, 379
 дэд ерөнхийлөгч, 7, 60, 93, 99, 101, 109, 247
 дээд боловсролын, 338, 339, 340
 Дээд шүүхийн, 27, 29, 30, 35, 36, 59, 102,
 103, 104, 105, 119, 163, 212, 218, 271, 355
 Дээд шүүхээс, 8, 35, 36, 59, 101, 103, 118,
 200, 204, 205, 224, 229, 252
 Европын, 3, 5, 6, 9, 31, 41, 59, 64, 65, 68, 70,
 96, 120, 121, 123, 126, 133, 137, 160, 161,
 166, 178, 191, 195, 284, 296, 313, 317, 322,
 357, 375
 Европын Зөвлөлийн, 65, 296, 313
 Европын Зөвлөлөөс, 31, 313
 Египет, 274, 351
 Египетийн, 15, 263
 Ерөнхий прокурор, 15, 16, 17, 35, 70, 90,
 101, 122, 133, 163, 170, 182, 185, 186, 203,
 254, 261, 263, 279, 282, 287, 298, 353, 361
 Ерөнхий прокурорыг, 104, 185, 283
 Ерөнхий прокурорын, 8, 20, 85, 114, 115,
 117, 121, 136, 196, 217, 224, 230, 233, 251,
 256, 258, 263, 264, 271, 277, 279, 282, 288,
 340
 Ерөнхий сайд, 7, 11, 12, 13, 14, 15, 21, 37,
 66, 70, 77, 78, 80, 87, 91, 96, 114, 120, 125,
 126, 127, 133, 134, 138, 139, 170, 182, 203,
 205, 209, 212, 214, 215, 219, 223, 230, 237,
 239, 240, 241, 259, 274, 280, 287, 299, 307,
 315, 325, 326, 360, 373
 Ерөнхий сайдаар, 89, 215, 243, 259, 275
 Ерөнхий сайдын, 20, 21, 63, 80, 114, 134,
 139, 214, 239, 240, 241, 276, 296, 341
 Ерөнхийлөгч, 5, 6, 7, 11, 12, 13, 14, 15, 20,
 21, 31, 32, 33, 34, 37, 38, 39, 42, 45, 47, 55,
 56, 59, 60, 61, 65, 67, 70, 71, 83, 84, 86, 88,
 89, 90, 98, 99, 100, 101, 102, 103, 104, 105,
 106, 107, 109, 111, 126, 127, 129, 133, 143,
 145, 164, 170, 171, 178, 186, 195, 200, 201,
 204, 205, 207, 214, 220, 226, 227, 230, 232,
 233, 234, 239, 240, 245, 246, 247, 248, 250,
 251, 252, 253, 256, 261, 262, 263, 264, 265,
 267, 268, 269, 270, 271, 272, 273, 274, 275,
 276, 287, 289, 293, 296, 297, 310, 324, 331,
 353
 Ерөнхийлөгчийн, 7, 15, 16, 34, 40, 42, 45,
 55, 56, 58, 59, 65, 66, 88, 89, 90, 99, 101,
 102, 103, 104, 107, 111, 117, 127, 128, 130,
 134, 223, 230, 231, 243, 247, 248, 252, 253,
 265, 267, 268, 271, 272, 275, 276, 286, 287,
 296, 304, 337, 340
 ёс суртахуунлаг бус, 149, 303
 ЕХ, 3, 8, 17, 18, 51, 64, 66, 67, 68, 90, 96,
 111, 114, 119, 120, 121, 123, 125, 127, 128,
 131, 133, 152, 153, 154, 162, 167, 184, 206,
 283, 284, 290, 296, 299, 307, 313, 317, 372,
 373, 374, 375
 ЕХ-ноос, 90, 120, 123, 284, 375
 жагсаал, 20, 26, 113, 133, 162, 194, 218, 230,
 351
 жагсаалт, 9, 59, 95, 106, 122, 145, 192, 202,
 312
 жагсаалтыг, 5, 8, 31, 59, 62, 79, 95, 106, 121,
 135, 150, 153, 171, 189, 192
 жагсаалын, 8, 43, 130, 132, 252, 352
 Женев, 13, 55, 232, 287
 завших, 49, 56, 81, 154, 200, 248, 306, 317,
 327, 330, 333, 334, 337, 352, 362
 Зайлшгүй шалтгаан, 354
 Зимбабве, 15, 95, 266
 зохион байгуулалттай гэмт хэрэг, 168, 184,
 251, 298, 350, 357
 зохион байгуулалттай гэмт хэрэгтэй, 41,
 279, 296, 298
 зөвлөмж, 9, 66, 73, 111, 156, 158, 159, 160,
 162, 177, 206, 364, 370
 Зума, 15, 269, 273, 275
 зуучилсан, 118, 218, 288
 Зүүн Тимор, 84, 93
 зэвсэгт хүчний, 83, 87, 323
 Йемен, 95, 274, 318, 319
 Израил, 18, 203, 232, 237, 342
 Израилийн, 47, 203, 214, 239, 240, 241, 250,
 342, 343, 352
 ил тод байдал, 18, 24, 26, 37, 57, 59, 61, 65,
 67, 85, 94, 120, 138, 153, 169, 170, 175,
 176, 305, 311, 316, 336, 337, 347, 350, 360,
 366
 Индонез, 4, 5, 11, 29, 30, 38, 84, 93, 94, 143,
 144, 145, 149, 159, 206, 227, 332, 377
 Индонезийн, 12, 13, 14, 26, 38, 39, 141, 143,
 144, 145, 149, 206, 211, 227, 244, 245, 249
 институцийг, 59, 141, 182, 303
 институцийн, 40, 57, 65, 71, 96, 143, 159,
 167, 178, 200, 346, 379, 384
 институцууд, 57, 106, 351
 Йордан, 4, 28, 29
 Иракийн, 11, 199, 200, 218
 иргэний нийгэм, 55, 57, 94, 96, 172, 181,
 341, 384
 Ирланд, 266, 366, 367
 Ирландын, 362, 366

Испанийн, 16, 41, 99, 163, 250, 280, 287, 300
Итали, 22, 99, 123
Италийн, 123, 249, 269, 270, 341
итгэл, 18, 56, 68, 72, 73, 74, 75, 78, 95, 96,
127, 155, 168, 176, 183, 212, 214, 239, 241,
252, 282, 297, 324, 331, 336, 345, 351, 369,
373, 382
Их 20, 4, 10, 22, 167, 168, 363
Их Британи, 7, 77, 91, 95, 173, 177, 266, 306,
307, 340, 359, 362
Их Британиас, 95, 315
Их Британид, 139, 341, 356
Их Британийн, 9, 60, 92, 95, 138, 173, 196,
199, 335, 346, 356, 358, 359, 360
их сургуулийн, 12, 27, 30, 49, 78, 85, 97,
103, 179, 180, 221, 234, 321, 322, 328, 330,
338, 347
Казахстан, 4, 7, 9, 18, 31, 65, 80, 81, 82, 87,
156, 159, 169, 171, 183, 218, 226, 227, 250,
277, 343, 344
Казахстанд, 7, 12, 13, 87, 219, 237, 344
Казахстаны, 6, 12, 31, 32, 79, 88, 218, 226,
227, 237, 277, 343, 344
Кайманы арлууд, 55, 356
Камбож, 84, 159
кампанит, 14, 33, 74, 86, 87, 101, 105, 132,
141, 142, 143, 180, 181, 219, 228, 245, 303,
316, 320, 321, 322
Канад, 40, 41, 91, 98, 177
Канадад, 41, 243
Канадын, 21, 41, 212, 352, 353
Катар, 7, 98
кибер гэмт хэрэг, 79, 362
кибер луйвар, 362
Кипр, 8, 10, 130, 170, 171, 284, 306
Киргиз, 12, 13, 215, 220, 222, 225, 243
Киргизийн, 12, 13, 14, 220, 222, 243
клептократ, 45, 52, 53, 197, 377
КОВИД-19, 6, 7, 9, 10, 11, 14, 29, 33, 36, 39,
61, 67, 70, 73, 84, 85, 86, 97, 101, 105, 110,
130, 131, 153, 154, 155, 158, 160, 164, 165,
166, 167, 168, 170, 171, 172, 175, 177, 178,
185, 189, 203, 206, 208, 210, 213, 223, 227,
244, 252, 255, 284, 285, 307, 310, 312, 313,
316, 317, 318, 321, 322, 335, 336, 340, 341,
356, 360, 361, 362, 363, 373
комиссар, 2, 21, 25, 26, 33, 68, 76, 192, 248,
323, 329
комплаенсийн, 10, 32, 165, 166, 234, 310
Конго, 15, 47, 91, 264, 265, 267, 275, 276,
352, 353
коронавирусний, 7, 11, 73, 85, 91, 99, 101,
109, 113, 132, 154, 186, 203, 206, 215, 227,
255, 266, 267, 269, 280, 340
корпорацийн, 17, 18, 33, 40, 46, 225, 226, 231,
310, 313, 314, 315, 353, 357, 361, 362, 363,
373
Косово, 125, 346
крипто, 41
Криптовалютыг, 69
криптовалютын, 11, 17, 41, 201, 202, 309
Куба, 269
Лаос, 84
Латви, 8, 9, 16, 120, 121, 136, 137, 156, 158,
159, 160, 284, 294, 306
Латвийн, 9, 136, 280, 294
Латин Америкийн, 46, 99, 123, 156, 251, 317
Либериа, 379
Ливи, 8, 113, 274, 351
Лобби, 66, 67, 373
Лондон, 18, 59, 90, 95, 227, 230, 250, 270,
356
Лондонд, 95, 307, 356
Люксембург, 91, 306, 317
Мавританийг, 306
Македон, 146, 364
Малави, 270, 271, 272, 317
Малайз, 12, 30, 33, 84, 192, 193, 197, 218,
250, 315
Малайзын, 6, 11, 12, 14, 30, 33, 80, 161, 192,
197, 202, 208, 209, 217, 218, 219, 241, 250,
315
Мали, 15, 274, 317
Мальдив, 93, 94, 159, 306
Мальдивын, 11, 94, 208
Мальта, 8, 123, 162, 184, 284, 305, 306
мансууруулах, 76, 95, 248, 251, 268, 309
Мексикийн, 7, 14, 100, 246, 247, 254
Молдав, 17, 71, 280, 281, 284, 285, 297, 322
Монгол, 4, 7, 28, 89, 90, 159, 185
Монгол Улс, 4, 28, 89, 185
Монтенегро, 17, 296
Монтенегрогийн, 296
мөнгө угаасан, 6, 12, 14, 15, 18, 51, 71, 83,
94, 102, 118, 205, 209, 217, 226, 241, 250,
251, 256, 259, 263, 268, 275, 279, 284, 287,
293, 294, 356, 357, 371, 372
Мөнгө угаах, 10, 16, 18, 31, 41, 64, 95, 138,
147, 177, 178, 284, 325, 326, 357, 360, 370,
371
мөнгө угаах гэмт хэргийг, 43, 169
мөнгө угаахын, 11, 91, 199
мөнгөн шагнал, 11, 124, 196, 197
мөрдөн шалгах, 5, 22, 23, 25, 26, 28, 35, 36,
37, 38, 39, 42, 44, 45, 46, 47, 57, 62, 63, 75,
80, 83, 87, 94, 96, 98, 103, 106, 124, 125,
126, 131, 132, 159, 184, 187, 190, 191, 193,
196, 197, 198, 202, 206, 207, 208, 209, 223,
228, 231, 232, 233, 236, 243, 245, 246, 248,
252, 255, 256, 259, 262, 263, 264, 266, 267,
268, 273, 277, 279, 282, 288, 291, 296, 298,
300, 325, 326, 327, 328, 335, 338, 346, 350,
357, 361, 362, 363, 371

мөрдөн шалгах ажиллагааг, 22, 26, 35, 36,
 37, 39, 46, 83, 125, 187, 190, 193, 198, 207,
 208, 232, 256, 262, 267, 273, 279, 282, 300,
 327, 362
 мөрдөн шалгах ажиллагаанд, 22, 23, 26, 36,
 38, 44, 46, 106, 125, 184, 193, 197, 198,
 236, 263, 291, 298
 Мьянмар, 13, 84, 93, 94, 126, 159, 232
 Мэдээллийн эрх чөлөөний, 68
 Мэдээлэгч, 191, 193
 Нажиб Разак, 14, 209, 241, 315
 непотизм, 337, 379
 Нетаньяху, 13, 203, 214, 237, 239, 240, 241
 Нигери, 5, 15, 60, 61, 62, 80, 269, 270, 318,
 319, 330, 333, 360
 Нигерийн, 59, 60, 61, 62, 63, 150, 269, 270
 Нидерланд, 91, 284, 317, 356
 Нийгмийн адилслын онол, 303
 нийгмийн халамжийн, 91, 99, 112, 189, 212,
 214, 225, 251, 252, 265
 нууцлаг байдал, 305, 306
 НҮБ, 3, 4, 9, 10, 17, 20, 21, 22, 40, 45, 60, 83,
 84, 109, 111, 120, 152, 162, 164, 165, 170,
 171, 173, 181, 252, 253, 309, 310, 346, 360,
 361, 363, 368, 382
 НҮБ-ын, 3, 20, 21, 22, 60, 83, 109, 120, 152,
 162, 164, 165, 170, 171, 181, 252, 253, 309,
 310, 346, 360, 361, 363, 368, 382
 НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга,
 4, 20, 83, 84, 161, 170, 178, 274, 279,
 320, 326, 361, 382
 Одебрехт, 53, 54, 305
 олон нийтийн итгэлийг, 35, 56, 170, 171,
 176, 177, 211, 216, 335
 олон улсын худалдаа, 362
 олон улсын эрүүгийн шүүхийн, 22
 Омбудсмэн, 342
 Омбудсмэний, 20, 34
 Орос, 7, 8, 9, 66, 98, 117, 120, 128, 135, 136,
 286, 322, 339
 Оросын, 3, 11, 16, 115, 120, 129, 130, 135,
 194, 260, 289, 295
 ОУВС, 3, 66, 67, 127, 176, 177, 275, 336,
 369, 375
 ОУЭССК, 3, 197, 307, 310
 оффшор, 18, 56, 66, 156, 294, 305, 307, 310,
 330, 359, 360
 ОХУ, 3, 6, 8, 16, 17, 52, 53, 66, 67, 69, 70, 95,
 114, 115, 117, 118, 121, 122, 123, 128, 129,
 131, 133, 134, 136, 156, 191, 194, 195, 227,
 248, 277, 281, 286, 287, 288, 289, 291, 293,
 295, 298, 300, 317, 321, 327, 362
 ӨАБНУ-ын, 20, 22, 61, 107, 110, 112, 189
 Өмнөд Африк, 7, 60, 107, 111, 266, 363
 Өмнөд Африкийг, 273
 Өмнөд Африкт, 112, 113, 346
 Өмнөд Солонгос, 8, 37, 77, 89, 116
 өндөр албан тушаалтнуудыг, 87
 өндөр албан тушаалтнуудын, 8, 37, 38, 52,
 84, 86, 91, 120, 345, 346
 Өндөр албан тушаалтнуудын, 37
 өндөр түвшний албан тушаалтнууд, 307
 өндөр эрсдэлтэй, 93, 94, 95, 152, 315, 327,
 329, 330, 334, 335, 356, 378, 379
 Пакистан, 6, 7, 83, 91, 95, 188, 189, 207, 324
 Пакистанаас, 95
 Пакистанд, 95, 189, 324
 Пакистаны, 11, 13, 83, 95, 189, 190, 229, 230,
 307, 324
 Панам, 99, 306
 Панамын баримт, 197, 307, 310, 319, 357
 Парагвай, 176, 279, 280
 парламент, 6, 10, 25, 38, 60, 67, 77, 127, 137,
 182, 252, 264, 343, 379
 парламентад, 26, 35, 64, 66, 69, 111, 125,
 127, 182, 211, 240, 241, 296
 парламентыг, 35
 парламентын, 9, 12, 15, 25, 60, 65, 67, 73, 77,
 78, 84, 87, 89, 96, 129, 131, 132, 137, 138,
 159, 161, 170, 178, 182, 191, 211, 217, 231,
 239, 263, 264, 274, 282, 284, 286, 296, 327,
 337, 342, 373
 Перу, 5, 53, 54, 99, 104, 105, 106
 Пиастрын хэрэг, 323, 324
 Польш, 16, 121, 162, 284, 296, 322
 Польшийн, 284, 296
 Португал, 46, 120, 121, 305, 362
 прокурор, 14, 17, 22, 37, 38, 58, 59, 66, 99,
 125, 160, 164, 207, 213, 218, 248, 251, 261,
 271, 277, 279, 280, 290, 296, 300, 322
 профессор, 14, 15, 74, 78, 85, 103, 120, 142,
 234, 251, 260, 261, 301, 304, 321, 322, 330,
 345, 347, 360, 374, 376, 377, 378
 Руандагийн, 22
 Румын, 162, 284, 350, 373
 Румыны, 16, 284, 285, 341
 С.Батболд, 89, 90, 91
 сайн засаглалыг, 9, 30, 53, 56, 80, 161
 Сан Марино, 22, 65
 Санамж бичиг, 5, 55, 56
 Санхүүгийн гэмт хэргийн, 30, 125, 126
 Санхүүгийн үйлчилгээний, 51, 80, 249
 санхүүгийн хяналт, 310
 Саудын Араб, 13, 107, 195, 228, 239, 287,
 363
 Саудын Арабын, 12, 109, 196, 204, 208, 219,
 228, 238, 300
 сахилгын шийтгэл, 87, 123, 320
 Сейшел, 306
 Сингапур, 71, 84, 207, 225, 226, 306, 317
 Сири, 22, 91, 95, 212, 213, 318, 319
 Солонгос, 3, 6, 22, 37, 38, 40, 83, 89, 94
 Солонгосын, 5, 11, 40, 83, 88, 89, 117, 200,
 209, 214, 233, 234, 240

сонирхлын зөрчлөөс, 40, 116, 155, 161
статистик, 8, 18, 43, 54, 81, 114, 118, 119,
140, 309, 311, 364, 365, 367, 368, 369, 370
стратегии, 4, 5, 6, 24, 32, 35, 55, 64, 65, 66, 83,
107, 143, 148, 155, 165, 168, 179, 180, 200,
303, 329, 337, 380, 382
стратегид, 66, 179, 303
судалгаа, 17, 18, 23, 34, 43, 50, 57, 65, 81, 89,
90, 92, 100, 121, 140, 141, 142, 144, 146,
149, 151, 153, 156, 160, 166, 167, 179, 185,
186, 192, 220, 221, 269, 300, 302, 303, 311,
312, 313, 318, 319, 320, 321, 322, 327, 331,
332, 340, 344, 345, 351, 362, 363, 365, 366,
367, 368, 369, 372, 373, 374, 375, 376, 383
судалгаанд, 9, 32, 50, 66, 73, 79, 91, 92, 120,
121, 124, 128, 137, 151, 152, 155, 156, 173,
179, 180, 311, 312, 314, 318, 320, 331, 332,
338, 345, 347, 351, 365, 366, 368, 369, 370,
372, 373, 374, 377, 378, 379
судалгааны үр дүнгээс, 38, 49, 79, 157, 284,
362, 368
Судан, 91, 108, 263, 317, 318, 319
Суданы, 15, 108, 263
сургуулийн, 81
сургууль, 4, 18, 27, 49, 73, 79, 82, 145, 146,
151, 157, 179, 189, 204, 205, 220, 338, 339,
344, 345, 377, 383
Сьерра Леон, 301
сэжигтэй гүйлгээг, 109, 370, 371
тагнуулын, 13, 39, 46, 56, 57, 58, 63, 96, 105,
129, 201, 233, 272, 293, 309
Тажикстан, 6, 86, 322
тайланд, 10, 17, 30, 41, 45, 46, 61, 62, 65, 66,
73, 74, 76, 77, 80, 84, 95, 96, 107, 108, 112,
113, 123, 125, 137, 138, 153, 154, 155, 159,
161, 165, 166, 168, 173, 178, 179, 189, 200,
207, 236, 257, 258, 280, 290, 301, 309, 310,
311, 313, 316, 324, 338, 356, 368, 370
Тайланд, 73, 84, 159, 166, 180, 214, 250, 332
Тайландын, 12, 13, 159, 179, 216, 224
Танзанийн, 358
татвараас зайлсхийсэн, 29, 90, 197, 287
тендер, 29, 61, 107, 125, 128, 150, 151, 161,
189, 201, 249, 281, 340, 341
тендерийн будилаантай, 44
Тенсент, 7, 92, 93
терроризмыг, 7, 41, 64, 95, 138, 159, 200,
263, 309, 356
технологи, 9, 10, 51, 79, 88, 132, 146, 147,
150, 151, 154, 168, 169, 171, 202, 310, 325,
366
технологийн, 32, 41, 92, 93, 146, 147, 148,
150, 151, 176, 234, 289, 311, 371
ТИ, 3, 6, 7, 27, 38, 53, 60, 66, 67, 71, 73, 74,
79, 81, 86, 91, 93, 94, 99, 114, 115, 116,
130, 133, 138, 146, 155, 156, 176, 213, 231,
233, 266, 272, 301, 305, 316, 317, 318, 330,
331, 339, 340, 341, 344, 351, 356, 357, 363,
366, 367, 372, 373, 378, 379
тоон мэдээ, 123, 151, 367, 368, 369, 370
тоон мэдээлэл, 347, 367, 368, 369, 370
торгуулийн, 15, 25, 30, 31, 51, 64, 184, 187,
197, 211, 225, 241, 280
торгууль, 13, 30, 43, 46, 48, 51, 53, 71, 118,
125, 185, 193, 195, 197, 199, 200, 202, 214,
225, 226, 227, 243, 244, 250, 258, 262, 267,
281, 283, 293, 294, 307, 334, 343, 345, 357
Төв банкны, 14, 32, 67, 242, 310, 360
төлбөр, 15, 49, 53, 79, 90, 115, 123, 128, 136,
162, 173, 175, 201, 218, 220, 235, 258, 261,
262, 264, 265, 270, 276, 301, 311, 316, 320,
334, 341, 346, 352, 358, 359, 380, 382
төрийн албан хаагч, 16, 29, 33, 40, 49, 95,
105, 140, 192, 204, 211, 224, 244, 293, 295,
330, 335
төрийн албан хаагчид, 4, 11, 33, 48, 49, 52,
67, 71, 74, 75, 86, 119, 129, 140, 192, 193,
241, 244, 293, 297, 330, 333, 334, 335
төрийн байгууллага, 4, 32, 34, 35, 38, 140,
150, 157, 182, 297, 314, 325, 345
төрийн өмчит, 13, 14, 35, 38, 49, 57, 96, 119,
166, 185, 224, 236, 246, 249, 259, 260, 275,
284, 288, 305, 327, 361, 378
төсвийн хөрөнгийн зарцуулалтад, 32, 254
тусгай зөвшөөрөлтэй, 62
Уганда, 95, 264, 265, 301, 341, 351, 379
Удирдагч-Төлөөлөгчийн онол, 376
удирдах албан тушаалтан, 71, 81, 87, 92, 93,
207, 237, 379
удирдлагууд, 30, 82, 86, 87, 92, 127, 132,
255, 262, 313, 315, 324, 329, 334, 357, 361,
373
Узбекистан, 4, 13, 32, 34, 226
Узбекистаны, 18, 204, 226, 340
Украин, 6, 8, 9, 58, 65, 66, 67, 69, 70, 101,
126, 131, 132, 151, 176, 185, 227, 282, 284,
285, 287, 296, 297, 322, 339, 345, 377
Украинд, 6, 9, 65, 70, 71, 124, 132, 287
Украины, 5, 6, 8, 10, 16, 17, 64, 65, 66, 67,
69, 70, 101, 124, 127, 131, 132, 151, 156,
185, 186, 282, 283, 285, 287, 296, 297
улс төрийн авлигыг, 27, 35, 38, 383
улс төрийн хяналт, 39
улс төрч, 26, 38, 63, 78, 102, 143, 267, 269,
278, 366
улс төрчидтэй холбоотой, 36, 119
урамшуулал, 77, 140, 184, 187, 191, 192,
197, 198, 314, 334, 335
урамшууллын механизм, 376
урьдчилан сэргийлэх мехнизм, 40
үл итгэлцэл, 87
Үндсэн хуулийн, 8, 30, 39, 58, 60, 67, 105,
106, 126, 127, 264, 265, 273, 283, 327
Үндэслэлгүйгээр хөрөнгөжих, 58, 59

Үндэсний Ассамблейн, 37, 88, 265, 267
 Үндэсний аюулгүй байдлын, 55, 56, 58, 222, 243
 үндэстэн дамнасан, 21, 22, 46, 52, 57, 80, 165, 305, 334, 345
 ФАТФ, 3, 51, 95, 138, 200, 308
 Филипин, 78, 79
 Филиппиний, 11, 33, 78, 79, 142, 201, 202
 Финланд, 71, 91, 121, 317, 318
 Франц, 17, 40, 154, 165, 196, 232, 242, 243, 323, 324
 Францын, 137, 243, 275, 282, 323, 324, 338, 344
 халдашгүй эрх, 5, 59, 60
 хамтын ажиллагаа, 3, 21, 22, 44, 50, 162, 163, 165, 167, 176, 181, 196, 304, 363
 хар тамхи, 146, 168, 262, 268, 288, 291, 330, 331
 хариуцлага тооцох механизм, 381
 хахуулийн хэмжээ, 33, 79, 100, 154, 183, 235, 250, 320, 322, 345, 346, 364
 хахууль авах, 54, 81, 87, 118, 124, 141, 192, 208, 211, 219, 237, 248, 281, 364, 366
 хахууль авсан, 12, 13, 15, 16, 17, 54, 80, 88, 93, 98, 107, 118, 125, 137, 184, 199, 200, 202, 203, 206, 207, 213, 217, 218, 219, 220, 221, 224, 225, 226, 229, 230, 231, 232, 236, 238, 239, 241, 244, 247, 254, 255, 256, 259, 261, 262, 264, 265, 268, 275, 277, 281, 282, 284, 288, 291, 292, 293, 294, 298, 300, 343, 344
 Хахууль авсан, 54, 118, 238, 245, 254
 хахууль өгдөг, 43, 79, 117, 136, 154, 256, 259, 333
 хахууль өгөх, 8, 35, 54, 62, 113, 114, 120, 136, 152, 154, 165, 189, 282, 288, 305, 313, 314, 321, 351, 364, 379
 хахууль өгсөн, 16, 37, 43, 44, 53, 54, 79, 98, 184, 202, 209, 232, 235, 239, 250, 252, 253, 261, 280, 281, 283, 287, 288, 295, 312, 321, 328, 330, 345, 358, 359, 373, 379
 хахуульд идэгдсэн, 35
 хиймэл оюун ухаан, 18, 370, 371
 ХМТ, 3, 5, 45, 46, 199, 224, 254, 295, 304, 328
 Хонконг, 93, 94, 95, 142, 306
 Хонконгийн, 11, 94, 141, 206, 363
 Хорват, 121, 155, 223, 298, 373
 хорио цээрийн, 12, 218
 хотын дарга, 15, 60, 170, 256, 262, 263, 278, 298, 376
 хохирлыг нөхөн барагдуулахыг, 353
 хохирлын хэмжээг, 355, 359, 369
 хохирол барагдуулах, 18, 215, 342, 353, 358
 хөгжиж буй улс орнуудын, 51, 339, 368
 хөл хорио, 84, 171, 350
 Хөл хорионы, 215
 хөрөнгө шамшигдуулах, 37, 113, 204
 хөрөнгө, орлогоо, 31, 67, 116, 282, 286
 хөрөнгө, орлогын мэдүүлгийг, 32, 67, 69, 115, 127, 170, 286, 297
 хөрөнгө, орлогын мэдүүлэг, 4, 9, 31, 116, 133, 286, 311
 хөрөнгө, орлогын мэдүүлэгт, 16, 27, 32, 67, 68, 70, 283, 286
 хөтөлбөр, 3, 23, 24, 37, 57, 130, 143, 144, 145, 146, 151, 197, 198, 213, 221, 248, 358, 364
 хөтөлбөрт, 37, 52, 53, 55, 64, 79, 82, 83, 145, 198, 360
 хувийн мэдээллийг, 79, 92, 187
 хувьцаа эзэмшигчдийг, 352, 353
 худалдан авалт, 4, 32, 33, 39, 61, 79, 120, 121, 152, 159, 168, 171, 172, 176, 335, 341, 347, 348, 362, 374
 худалдан авалттай, 33, 109, 110, 153, 311, 347
 худалдан авалтын, 33, 61, 67, 69, 79, 96, 111, 112, 151, 152, 153, 158, 168, 172, 173, 174, 176, 186, 254, 308, 340, 341, 347, 348, 362
 худалдан авах ажиллагаа, 60, 122, 128, 131, 149, 166, 337, 347
 худалдан авах ажиллагааны, 18, 90, 99, 113, 151, 160, 178, 216, 244, 311, 328, 336, 340, 341, 347, 367, 368, 374
 хурдасгах, 54, 88
 хуулийн хариуцлага, 36, 44, 60
 хууль дээдлэх, 20, 52, 53, 55, 56, 68, 84, 90, 133, 160, 164, 179, 296, 372, 374
 Хууль зүйн яам, 32, 34, 57, 76, 125, 160, 199, 216, 224, 248, 250, 275, 314, 346, 358
 хууль санаачилагчид, 87, 129
 хууль сахиулах, 20, 21, 22, 33, 36, 43, 44, 46, 51, 55, 57, 68, 72, 75, 80, 91, 123, 141, 143, 158, 162, 204, 206, 207, 208, 241, 246, 247, 266, 279, 297, 309, 322, 345, 346, 363, 364, 374
 хууль сахиулах алба, 43
 хууль сахиулах байгууллагуудтай, 36, 207
 хууль тогтоомж, 5, 49, 50, 52, 64, 65, 74, 75, 81, 92, 106, 113, 119, 165, 178, 184, 187, 203, 303, 306, 347, 348, 349, 380
 хуурамч баримт бичиг, 280, 292, 295
 Хүний наймаа, 52
 хүний эрхийг, 8, 21, 60, 110, 111, 159, 164
 хүчин зүйлсийн, 71, 138, 358
 хяналт шалгалт, 6, 16, 29, 76, 85, 92, 95, 112, 122, 124, 216, 221, 285, 298, 366, 379, 381
 хяналт шалгалтыг, 96, 211, 328, 337
 хяналт шинжилгээ, 87, 336, 337
 Хятад, 3, 9, 10, 13, 14, 17, 80, 91, 95, 145, 162, 187, 224, 225, 231, 241, 242, 317, 322, 323, 330, 331, 332, 333, 334, 335, 363

Хятадын, 6, 7, 11, 12, 13, 17, 77, 83, 87, 88,
 92, 96, 162, 187, 199, 200, 202, 207, 219,
 224, 225, 231, 238, 241, 308, 322, 323, 330,
 331, 332, 333, 334, 335, 343, 344
 Цагдаагийн газрын, 124, 221, 222, 223, 246,
 258
 цалин хөлс, 50, 196, 321, 322
 цар тахлын, 6, 8, 10, 13, 33, 36, 47, 52, 66,
 67, 83, 97, 99, 109, 110, 111, 112, 130, 131,
 133, 152, 154, 160, 164, 165, 166, 167, 168,
 172, 175, 176, 178, 186, 208, 210, 227, 237,
 238, 248, 249, 255, 281, 312, 313, 316, 321,
 323, 335, 336, 340, 350, 356, 360, 361, 362,
 363, 373
 Чехийн, 16, 114, 290
 Швед, 6, 71, 72, 91, 156, 205, 317, 318, 338
 Шведийн, 15, 21, 71, 278, 279
 Швейцари, 71, 91, 137, 138, 151, 205, 250,
 251, 262, 287, 306, 317, 318, 338
 Швейцарийн, 17, 125, 226, 232, 260, 287,
 300
 Ши Жинпиний, 93
 Шинэ Зеланд, 74, 75, 91, 93, 317, 318
 Шинэ Зеландын, 6, 73, 74, 75
 шинэчлэл, 4, 5, 6, 24, 28, 50, 52, 53, 57, 60,
 65, 67, 70, 71, 104, 127, 143, 176, 183, 221,
 238, 283, 310, 312, 318, 327, 334, 337, 365,
 366, 376, 377, 379, 382, 383
 Шри Ланка, 7, 96
 шударга байдал, 26, 65, 71, 78, 100, 149,
 307, 347, 375
 шударга байдлын, 11, 72, 140, 141, 149, 156,
 164, 190, 250, 261, 305, 346, 360, 366, 368,
 373, 375
 шударга ёсны, 32, 35, 40, 73, 84, 159, 161,
 200, 216, 312, 381
 шударга ёсыг бий болгох, 20
 шууд бус хор хохирлыг, 358
 Шууд бус хохирол, 359
 шууд хохирол, 353, 358
 Шүгэл үлээгч, 187, 193, 198, 342
 шүгэл үлээгчид, 10, 11, 184, 189, 191, 193,
 342
 шүгэл үлээгчийг, 74, 154, 182, 184, 187, 191,
 192, 193, 197, 342, 366
 Шүгэл үлээгчийн, 10, 170, 182, 184, 186,
 187, 193
 шүүгч, 12, 16, 21, 22, 29, 37, 38, 39, 42, 59,
 90, 102, 103, 104, 105, 106, 126, 160, 164,
 178, 191, 194, 196, 204, 208, 211, 226, 237,
 244, 248, 255, 256, 257, 259, 260, 262, 263,
 266, 273, 282, 283, 290, 297, 298, 299, 301,
 353
 шүүхийн шийдвэр, 102, 114, 123, 193, 200,
 245, 270, 352, 357
 шүүхийн шийдвэрийн, 35, 188, 194, 353
 эдийн засгийг, 8, 35, 50, 66, 83, 105, 110,
 111, 112, 167, 227, 331, 360
 Эдийн засгийн гэмт хэрэг, 362
 ЭЗХАХБ, 3, 10, 32, 40, 44, 45, 46, 75, 91,
 160, 165, 166, 172, 249, 251, 338, 362, 369
 ЭЗХАХБ-ын, 10, 40, 44, 45, 46, 75, 91, 165,
 172, 251, 362
 Эквадор, 14, 46, 251, 252, 307
 Эл Сальвадорын, 7, 15, 59, 104, 105, 106,
 261, 262
 Энэтхэг, 4, 6, 26, 27, 35, 36, 37, 80, 145, 153,
 210, 222, 243, 244, 303, 308, 330, 331, 333,
 339, 362
 Энэтхэгийн, 4, 9, 10, 14, 26, 27, 35, 36, 132,
 140, 182, 210, 222, 234, 235, 244, 245, 246,
 308, 330, 365
 Энэтхэгт, 36, 140, 141, 153, 176, 333
 эрсдэл, 7, 18, 38, 51, 60, 76, 82, 92, 94, 95,
 99, 125, 133, 138, 148, 152, 156, 160, 164,
 166, 172, 174, 178, 185, 197, 249, 255, 266,
 284, 312, 320, 321, 327, 328, 334, 359, 361,
 362, 366, 378, 379, 381, 382
 эрүүгийн хариуцлага, 30, 37, 215, 255
 эрүүл мэндийн, 3, 8, 14, 52, 85, 86, 97, 99,
 109, 111, 125, 128, 137, 142, 151, 152, 153,
 154, 155, 160, 168, 170, 171, 172, 178, 183,
 184, 189, 192, 206, 215, 223, 247, 248, 249,
 252, 266, 275, 307, 315, 316, 317, 320, 321,
 322, 323, 335, 336, 337, 340, 341, 351,
 359, 361, 362, 363, 373
 Эрүүл мэндийн салбар, 6, 17, 18, 85, 86, 97,
 152, 157, 158, 321, 335, 336, 340
 эрх чөлөө, 68, 92, 94, 104, 164, 167, 234, 347,
 384
 Эрэн сурвалжлах сэтгүүлчдийг, 385
 Эстони, 121, 156, 191, 284, 322
 эх сурвалж, 90, 187, 197, 198, 209, 228, 239,
 252, 275, 300, 318, 325, 326, 332, 368, 369,
 370
 эх сурвалжийг, 28, 332, 368, 369
 Югослав, 22
 Якут, 298
 Япон, 25, 225, 248, 338
 Японы, 4, 6, 12, 25, 77, 78, 215

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

aa.com.tr/en
abc.net.au
abcnews.go.com
academia.edu
acrc.go.kr
africanews.com
alfanews.md
aljazeera.com
anticorr.media
apnews.com
apsny.ge
arabnews.com
avas.mv/en
bakersfield.com
balkaninsight.com
bangkokpost.com
baselgovernance.org
bbc.com
beaumontenterprise.com
beztabu.net
blogs.worldbank.org
bloomberg.com
bnn-news.ru
borderreport.com
business-standard.com
businesstech.co.za
businessstimes.com.sg
caixinglobal.com
cambridgenetwork.co.uk
capital.ua/ru
carnegieendowment.org
china.org.cn
citizen.co.za
citizenmatters.in
clickorlando.com
cnnphilippines.com
coe.int/en
cofmag.com
cointelegraph.com
corruptionwatch.org.za
csce.gov
ctvnews.ca
dabangasudan.org/en
daijiworld.com
dailyexpress.com
dailynk.com
delo.ua
democracywithoutborders.org
devex.com
dhakatribune.com
dknews.kz
dtnext.in
dw.com
e.vnexpress.net
eastasiaforum.org
economictimes.indiatimes.com
egypttoday.com
ekathimerini.com
ekd.me
en.mercopress.com
eng.lsm.lv
euractiv.com
eurasianet.org
eurasiareview.com
eurekalert.org
euronews.com
europeanwesternbalkans.com
euroweeklynews.com
ewn.co.za
exit.al/en
express-k.kz
fcced.com
fcpablog.com
financierworldwide.com
focus.ua
focustaiwan.tw
football-espana.net
forbes.ru
foreignassistance.gov
forklog.com
france24.com
freemalaysiatoday.com
ft.com
gazetadopovo.com.br
geo.tv
geopoliticalmonitor.com
globalanticorruptionblog.com
globaltimes.cn
goal.com
gordonua.com
gulfnews.com
haqqin.az
iaccseries.org
ibtimes.com
in.news.yahoo.com
in-cyprus.philenews.com
indianexpress.com
indiatoday.in
informburo.kz
intellinews.com
internationalbanker.com
irishtimes.com
irrawaddy.com
iz.ru
jakartaglobe.id
japantimes.co.jp
jdsupra.com
jurist.org
justice.gov
justsecurity.org
khaama.com
khaosodenglish.com
kokshetau.asia
kommersant.ru
kp.ru
leaprate.com
lenta.ru
lexology.com
liter.kz
local10.com
lt.sputniknews.ru
lv.sputniknews.ru
malaymail.com
marketwatch.com
mb.com.ph/
menafn.com
middleeastmonitor.com
miragenews.com
mmtimes.com
msn.com/en
nasdaq.com
nation.com.pk
nationthailand.com
ndtv.com
nepallivetoday.com
news.am/eng
news.cgtn.com
news.un.org
news18.com
nn.ru
novos.mk.ru
npasyria.com
nytimes.com
occrp.org
oecd-ilibrary.org
pasmi.ru
peoplesreview.com.np
phillipsandcohen.com
philstar.com
phys.org
pkzsk.info
podrobno.uz
politics.nur.kz
pravda.com.ua
pravo.ru
prnewswire.co.uk
promarket.org
radiosputnik.ria.ru
rbc.ru
regnum.ru
regtv.kz
ren.tv

republicworld.com
researchgate.net
reuters.com
review.chicagobooth.edu
rferl.org
rg.ru
ria.ru
riskscreen.com
rnz.co.nz
royalcentral.co.uk
rsf.org
ru.sputnik.md
rus.azattyk.org
russian.rt.com
scoop.co.nz
search.coe.int
sec.gov
secretmag.ru
securityboulevard.com
sevastopol.su
sgp.fas.org
share.america.gov
sites.tufts.edu
skillcast.com
solomontimes.com
straitstimes.com
strana.ua

supchina.com
sv.usembassy.gov
swissinfo.ch/eng
taiwannews.com.tw/en
tass.ru
tbsnews.net
theconversation.com
theedgemarkets.com
thegazette.com
theguardian.com
thehill.com
thehindu.com
thejakartapost.com
themoscowtimes.com
thenationalnews.com
thenews.com.pk
thesouthafrican.com
thestar.com
thetowerpost.com
thisdaylive.com
timesca.com
timeslive.co.za
timesofisrael.com
tj.sputniknews.ru
transparency.org
trtworld.com
u4.no

ukrinform.net
undp.org
unian.info
universityworldnews.com
unodc.org
upi.com
uzdaily.uz
vesti.ru
voanews.com
voices.transparency.org
volbusiness.ru
voxeu.org
warren.senate.gov
washingtonpost.com
web.archive.org
whistleblowersblog.org
whitehouse.gov
wionews.com
worldbank.org
worldjurist.org
wsj.com
wsws.org/en
xinhuanet.com/english/
zeenews.india.com
znak.com